*Уул уурхайтай холбоотой өнөөгийн бодлогын баримт бүчгүүд нь уул уурхайн салбарт тааламжтай хөрөнгө орууламтын орчныг бүрдүүлэхэд л анхаарлаа хандуулж байна.* Эдгээр баримт бичгүүд байгаль орчны асуудалд бага анхаарал хандуулж байна. Уул уурхайн бүсийн хаягдсан болон эвдэрсэн газрын асуудлыг шийдвэрлэх, нөхөн сэргээх тухай тусгайлсан бодлогын баримт бичиг байхгүй байна. Үүнтэй адилаар албан бус бичил уурхай эрхлэгчдэд өөр салбарт ажил хөдөлмөр эрхлэх боломж олгох зорилт дэвшүүлсэн бодлогын баримт бичиг мөн байхгүй байна.

*Байгаль орчин, аялал жуулчлалын яамны өмнө тулгарч байгаа гол асуудлуудын нэг нь ажилтнуудын халаа сэлгээ болж байна.* Ажилтнуудын халаа сэлгээ өндөр байгаа нь байгаль орчин, ногоон хөгжлийн асуудлаарх бодлогыг уялдаатайгаар боловсруулж, хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж, байгууллагын үйл ажиллагааны ой санамж алдагдахад хүргэж байна.

*Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг Ерөнхий сайдын дэргэд 2003 онд байгуулсан нь бодлого боловсруулах үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, мөрдүүлэх үйл ажиллагаанаас салгах боломж олгосон байна.* Энэ арга хэмжээний сайн тал нь нөөцийг илүү үр дүнтэй ашиглах болж, салбар бүрийн байцаагчдын ажлын уялдаа, харилцаа холбоог бэхжүүлсэн явдал юм. Гэвч шинэ тогтолцоон дахь МХЕГ болон БОАЖЯ-ны хамтын ажиллагааны түвшин хангалтгүй, харилцаа холбоо сул байна. Байгаль орчны байцаагч нар сумын Засаг даргаас хамааралтай байгаа нь бас нэг анхаарах асуудал болж байна.

## **Зохицуулах болон хэрэгжилтийг баталгаажуулах механизм**

*Байгаль орчны салбарын олон нийттэй харьцах ажиллагаа, нэмэлт бохирдуулагчийн эх үүсвэр болон байгаль сүйтгэх бусад үйл ажиллагаануудтай уялдан зөвшөөрөл болон лицензи олгох тогтолцоо улам өргөжих явц үргэлжилж байна. Гэвч зарим үйл ажиллагааны хэрэгжилтийн зохицуулалтууд байхгүй буюу бүрэн бус байгаа нь зөвшөөрөл олгоход хийдэл гаргахад хүргэж байна. Энэ байдал агаарт бохирдуулагч ялгаруулах болон бохир усны хаягдал дээр мэдэгдэхүйц ажиглагдаж байна.*

*Монгол улсын байгаль орчны нөлөөллийн үнэлгээний процедур өргөн хүрээтэй, БОНУ-ний арга хэрэгсэлийг хэрэглэх талаар Монгол улс баялаг туршлага хуримтлуулсан байна. Бодит байдал дээр лицнз бүхий байгууллагууд үүргээ муу хэрэгжүүлж, үр дүн муутай, хайнга хандаж байгаагаас БОНУ –г дутуу үнэлэх явдал байсаар байна. БОНУ-ний тогтолцоонд олон нийтийн үүрэг хариуцлага доогуур байна. Хуримтлагдах үнэлгээ хийх процедур хууль тогтоомжид тусгагдсан боловч түүний практик хэрэглээ хязгаарлагдмал байна.*

*БОНУ-ний 2012 онд нэмэлт хийсэн хуулиар биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах боломж нээгдсэн байна. Биологийн олон янз байдлыг хэрхэн дүйцүүлэн хамгаалах болон газрын нөхөн сэргээлтийг өөр газар хийх талаархи санал бодол Засгийн газрын ажилтнууд, Олон улсын болон Монголын ТББ-ууд, идэвхтэнүүдийн дунд ихээхэн ялгаатай байна. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах болон өөр газар нөхөн сэргээлт хийх тухай удирдамж, гарын авлага хангалтгүй байна.*

*Байгаль орчны аудит хийх ажлыг 2012-2013 онд нэвтрүүлсэн нь байгаль орчны менежментийн тогтолцоонд чухал нэмэлт болсон байна. Байгаль орчны аудит хийх ажлыг амьдрал дээр хэрэгжүүлэх явдал ихээхэн удаашралтай явагдаж, өнөөдрийн байдлаар туршлага хязгаарлагдмал байна. Аудитын үйл ажиллагаа нь хуулийн хүрээнд хийгдэж байгаа гэхээс илүүтэй сайн дурын үүрэг эсвэл хөрөнгө оруулагчийн шахалтаар хийгдэж байна.*

*Олборлох аж үйлдвэрийн ил тод байдлын санаачлага (ОАҮИТБС)-ыг хэрэгжүүлэх Засгийн газрын үүрэг хариуцлага нь компаниудыг тогтвортой үйл ажиллагаа болон тогтвортой байдлын мэдээллийг ТХЗ-ын Зорилго 12.6 –ийн дагуу тайлан гаргах үйл ажиллагаатай уялдуулах явдлыг хөхиулэн дэмжихэд ахиц гаргахад маш чухал юм. Монголын ОАҮИТБС нь ил тод байдлын бүтцийг бий болгож энэ нь гадаадын хөрөнгө оруулагчдад лицензийн шударгаар олгох боломж олгох болно. Гэвч, байгууллагуудаас ОАҮИТБС-ийг хангаж байгаа мэдээлэл нь томоохон асуудал болж байна.*

*Байгаль орчны менежментийн системийг нэвтрүүлэхэд сүүлийн үед ахиц дэвшил гарч байгаа ч өнөө хүртэл маш цөөн тооны компаниуд MNS ISO 14001 стандартын дагуу сертификат авсан байна. Засгийн газрын стандартын мөрдөлтийг хөхиулэн дэмжих хүчин чармайлт хангалтгүй байна. Бизнесийн хүрээнд нөөцийн хэмнэлттэй, цэвэр бүтээгдэхүүнийг дэмжихэд чиглэсэн системтэй хүчин чармайлт хэрэглэхгүй байна.*

### **Эдийн засгийг ногооруулах нь**

*Эдийн засгийн өсөлтийг ногооруулах нь улс орны хөгжлийн бодлоын гол түлхүүр зорилт юм. Салбаруудын бодлогыг 2014 оны Ногоон хөгжлийн бодлого болон Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 –тай уялдуулан шинэчлэх ажил хийгдэж байна. Гэвч, холбогдох олон тооны зорилтууд болон арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийт өртөг зардлыг тооцоолоогүй байна.*

*Байгаль орчны үйл ажиллагааны зардал болон холбогдох үндэсний хөтөлбөрүүдийн санхүүжилт нь үндсэндээ улсын төсвийн хувиарлалт болон гадаадын зээл, буцалтгүй тусламжаас хамаарч байна. Байгаль орчин, уур амьсгалын сангийн байгаль орчинтой холбоотой Үндэсний хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулан хувиарласан хөрөнгө маш бага хэвээр байна. Орон нутгийн удирдлага байгаль орчны зардлыг өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс гаргах ёстой боловч тэдний олгосон санхүүжилт маш багассан байна.*

*Байгаль орчны доройтлоос (ТХЗ Зорилго 8.4) болоод эдийн засгийн ямар өсөлт буурсан хэмжээг харуулах ногоон өсөлтийн шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох статистик мэдээллийг хөгжүүлэх*



*явдал бас нэг саад бэрхшээл болж байна.* Энэ чиглэлээр хийсэн анхны алхам бол Ногоон хөгжлийн 38 шалгуур үзүүлэлтийг Үндэсний статистикийн хороо 2017 оны 7 дугаар сард баталсан явдал юм.

*Бохирдуулагчдын амьдралын хэв маягийг өөрчлөхөд чиглэсэн үр дүнтэй санаачлагуудыг бий болгох эдийн засгийн хөшүүргийн үүрэг роль дунд зэрэг хэвээр байна.* Агаарын бохирдлын татварын 4 бүрэлдэхүүн хэсэгт хэрэглэж байгаа татварын хувь хэмжээ нь тодорхой үр дүнд хэрэхүйц хэмжээтэй биш, маш бага байна. Ус бохирдуулсаны төлбөрийн асуудал хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай холбогдох хоёрдогч хууль тогтоомж батлагдахыг хүлээсэн байдалтай байна. Машины түлшний татвар нь бензин болон дизелийн түлшийг үр ашигтай хэрэглэх хөшүүрэг байдлаар ашиглагдахгүй байна.

*Усан хангамж болон эрчим хүчний тариф нь эдгээр нөөцийг зохистой ашиглах хангалттай хөшүүрэг болж чадахгүй байна.* Зардлаа нөхөхөд ч хангалтгүй тарифууд нь эдгээр үйлчилгээг үзүүлэхэд хувийн салбарыг өргөнөөр татан оролцуулахад саад тогтор болж байна.

*Байгаль орчны хохирлын нөхөн олговор олгоход суурь түвшин байдлаар ашиглах байгалийн нөөцийн мөнгөн үнэ цэнийг үнэлэх үнэлгээний аргачлалыг Монгол улс боловсруулан, хэрэглэж байна.* Гэвч төлбөрийн хэмжээг бий болгосон арга зам, мөн чанар бүрэн ил тод бус, иймд цаашид түүнийг дэмжихэд бэрхшээлтэй юм. Ийм байдал мөн орон нутгийн удирдах байгууллагын түвшинд тогтоосон өөр олон онцгой төрлийн байгалийн нөөцөд тогтоосон төлбөрт мөн хамаарна.

*Уул уурхайн компаниуд үйл ажиллагаа хаагдсаны дараа уул уурхайн газрын нөхөн сэргээх, хэвийн байдалд нь оруулахын тулд санхүүгийн нөөцийг бий болгох үүргийг хүлээдэг.* Гэвч эдгээр сангууд нь бэлэн байгаа уул уурхайн салбарын олон улсын сайн арга ажиллагаатай тохирсон тийм үйл ажиллагааг санхүүжүүлэхэд хангалттай эсэх эргэлзээтэй байна.

*Монгол улс нь нар, салхины бүтээгдэхүүний арвин их нөөцтэй орон юм. Иймд энэ салбар дахь ашиг сонирхол өсөн нэмэгдэж байгаа бөгөөд гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгалд тусгалаа олж байна.* Гэвч сэргээгдэх эрчим хүчний салбарыг хөгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх тусгай тариф болон саяхан нэвтрүүлсэн урамшууллын тарифын систем үйлчилж байгаа ч гэсэн сэргээгдэх эрчим хүчний асар их нөөцийг ашиглахад томоохон саад бэрхшээлүүд тулгарсаар байна.

### **Байгаль орчны мониторинг болон мэдээлэл**

*Байгаль орчны мониторингийн сүлжээ нь байгаль орчны бүх үндсэн сэдвүүдийг хамарч байна.* Гэвч үүнийг цаашид бэхжүүлэх хэрэгтэй байгаа бөгөөд зарим үзүүлэлтүүд цуглуулах болон тайлагнахад дутагдал байсаар байна. Ялангуяа, дуу чимээ болон чичиргээний хяналт, мониторинг байхгүй байна. Янз бүрийн биомын зүйлийн нийт улс орныг хамарсан сүүлийн үнэлгээ 2010 онд хийгдэж, төсвийн хүндрэлтэй байдлаас болоод 2014 онд дахин хийгдээгүй байна. Цаг уур, орчны шинжилгээний газар (ЦУОШГ)-ын лабораториуд чадавхи муутай, зарим аймгийн лабораторын гол параметруудийг тодорхойлохгүй байна.

*Дотоод мониторинг хийхийг хуулиар заасан байна.* Бодит байдал дээр томоохон компаниуд тусгай нэгжтэй, тэдний дотоод мониторингийн тайлангийн чанар сайн байгаа бол жижиг болон дунд хэмжээний үйлдвэрүүд хүчин чармайлт гаргах хэрэгтэй байна.

*Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ) Байгаль орчны төлөв байдлын тайланг хоёр жил тутам гаргаж байна.* Эдгээр тайлангууд нь үзүүлэлтэд суурилсан боловч бодит хүчин зүйл, дарамт, төлөв байдал, нөлөөлөл, хариу арга хэмжээн дээр суурилагагүй байна. Тайлангуудад техникийн бус хураангуйг хийж өгдөггүй байна.

*БОАЖЯ болон Үндэсний статистикийн хороо хамтран байгаль орчны албан ёсны статистик мэдээлэл гаргаж байна.* Гэвч эдгээр байгууллагууд нь байгаль орчны сайн чанарын статистик мэдээлэл гаргах туршлага, чадваргүй байгаа нь сайн чанартай байгаль орчны тайлангууд гаргах, 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн дагуу, түүнийг үнэлэхэд шаардлагатай Байгаль орчин-эдийн засгийн тооцооны системийг хэрэгжүүлэхэд ажилд бэрхшээл учруулж байна.

## **Мэдээллийн хүрэлцээ, олон нийтийн оролцоо болон боловсрол**

*Байгаль орчны тухай мэдээлэлд хандах асуудлыг зохицуулсан хууль эрх зүйн тогтолцоо бүрдсэн, цаашид өргөжиж байна.* Гэвч, эдгээрийг хэрэгжүүлэх явдалд Засгийн газар болон олон нийт аль алинд нь саад бэрхшээл тулгарч байна. БОАЖЯ-аас бусад Засгийн газрын байгууллагуудад байгаль орчны талын мэдээллээр хангагдах өнөөгийн практик үйл ажиллагаа болон процедур нь хангалтгүй байна. Өөр нэг бэрхшээл бол байгаль орчны төлөв байдлын тухай түүхий болон боловсруулалт хийсэн, мета мэдээллийг цахим хэлбэрээр авах боломж хомс байна.

*Ус цаг уур орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн харьяанд ажиллаж байгаа Байгаль орчны мэдээллийн төв нь мэдээллийг олон нийттэй хуваалцах хүчирхэг арга хэрэгсэл юм.* Гэвч энэ төвийн мэдээлэл нь бүхэн бус, хоорондоо зөрчилдөөнтэй байна.

*Монгол улс нь байгаль орчны асуудлаар шийдвэр гаргах, түүнийг амьдрал дээр хэрэгжүүлэхэд олон нийтийг оролцуулах боломжоор хангах хууль эрх зүйн тогтолцоог боловсруулах талаар ихээхэн ахиц дэвшил гаргаж байна.* Гэвч олон нийтийг үр дүнтэй оролцуулах талаар зарим саад бэрхшээл тулгарсаар байна. Олон нийтийн дунд төлөвлөж байгаа төслүүдийн талаар хэлэлцүүлэг хийх, тодорхой хууль болон түүнийг дагалдан гарах эрх зүйн тогтолцоонд олон нийтийн саналыг авахад хангалттай хугацаа өгөхгүй байгаа бөгөөд олон нийтийн хэлэлцүүлгийг хэрхэн ашиглах талаарх орон нутгийн удирдлага, бизнесийн байгууллагуудын чадавхи, мэдлэг байхгүй байна.

*Байгаль орчны салбарын 487 ТББ-ууд байгаа боловч БОАЖЯ-ны мэдээгээр 100 орчим нь л идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.* Олон тооны байгаль орчны ТББ-уудын холбоо болон хөдөлгөөнүүд байна. Хоорондоо холбоо, хөдөлгөөн зохион байгуулах нь ТББ-уудад илүү тодорхой, зорилттой үйл ажиллагааг илүү үр дүнтэй явуулахад нь тусалж байна.

*Үйл ажиллагааных нь улмаас байгаль орчны эсрэг хохирол, дарамт учруулах тохиолдол байсаар байна.* Засгийн газрын зүгээс ийм тохиолдол гарахаас урьдчилан сэргийлэх, шаардлагатай хөрөнгө оруулалтыг баталгаажуулах талаар ямар арга хэмжээ авч байгаа нь тодорхойгүй байна.

*Олон нийт болон ТББ –уудын гишүүдээс тэдэнд байгаа санхүүгийн боломж болон мэдлэг чадвар байхгүй байгаагийн улмаас шүүхийн үйл ажиллагаанд оролцох явдал хязгаарлагдмал байна.* Байгаль орчны асуудлаар олон нийтийн зүгээс шүүхэд хандах, шүүхийн үйл ажиллагаа үүсгэх санхүүгийн зардал хэт өндөр байна. Шүүгчдэд байгаль орчны асуудлаар тодорхой сургалт хийгдэхгүй байна.

*Байгаль орчны тогтвортой хөгжлийн асуудал ерөнхий боловсролын сургуулийн сургалтанд хамрагдах болсон үеэс хойш тогтвортой хөгжлийн боловсролыг сургалтын хөтөлбөртэй уялдуулах асуудал сүүлийн жилүүдэд эрчимжиж байна.* Бүх шатны сургуулийн сургалтын хөтөлбөрийг улсын хэмжээгээр хэрэгжүүлэх, ТХБ-ыг бүх шатны сургуульд нэвтрүүлэх явдлыг цаашид өргөжүүлэх хүчин чармайлтын хүрээнд явдал одоо чухлаар тавигдаж байна. Олон арга хэмжээ байгаль орчин болон тогтвортой хөгжлийн асуудлаарх албан болон албан бус боловсролын нэг хэсэг байдлаар хэрэгжиж байна.

*Томоохон бэрхшээл нь багш нарыг сургах, холбогдох Засгийн газрын ажилтнуудын БОТХ-ын чадавхийг бий болгоход чиглэсэн улсын төсвийн нөөцөөр хангах явдал болж байна.* Засгийн газрын БО болон ТХ-ийн асуудлыг албан болон албан бус боловсролтой уялдуулахад шаардлагатай тусламжаар хангах үүрэг, харицлага нь ТХБ-ыг амжилттай хөгжүүлэх, ТХЗ-ын Зориолго 4.7 болон 12.8-ыг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл болно.

## **Олон улсын гэрээ хэлэлцээр болон түүгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт**

*Монгол улсын байгаль орчны бодлогын цөмд нь олон улсын, бус нутгийн болон хоёр талын хамтын ажиллагаа байна.* Монгол улс тогтвортой хөгжил, байгаль орчин болон ногоон хөгжлийн асуудлаарх олон улсын нийгэмлэгийн ахиц дэвшил, ололт амжилтыг хариуцлагатайгаар дагаж мөрдөн ажиллаж байна. Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 –ыг 2016 онд баталсан нь дэлхийн ТХЗ-уудыг баталсан эхний улсуудын нэг болсон байна.

*Монгол улс нь холбогдох бараг бүх дэлхийн хэмжээний Байгаль орчны олон талт гэрээ хэлэлцээр (БООТГХ)-ийн оролцогч Тал юм.* Монгол улс Мөнгөн усны тухай Минаматагийн конвенци зэрэг дөнгөж саяханы БООТГХ-ийг ч гэсэн батламжлаад байна. Гэсэн хэдийн ч бас батламжлаагүй зарим цөөн БООТГХ байгаа бөгөөд цаашид холбогдох БООТГХ –үүдийг батламжлах нь Монгол улсад байгаль орчныг хамгаалах илүү өргөн хүрээний тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэх болно.

*Олон улсын хэмжээнд хүлээсэн үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх, биелүүлэхэд асуудал, саад бэрхшээлтэй тулгарсаар байна.* Энэ нь БОАЖЯ-ны хүний нөөц, чадавхи болон санхүүжилтийн нөөц хангалтгүй байгаагай зарим талаар холбоотой байна.

*Тус улс олон улсын хэмжээнд тайлан мэдээ гаргах үүргээ биелүүлж байна.* Харин Зэрлэг ургамал, амьтны ховордсон төрөл зүйлийн олон улсын худалдааны конвенци (САЙТЕС) болон Аюултай хог хаягдал, тэдгээрийг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай конвенц (Базелийн конвенци)-ийн хүрээнд гаргах тайлан илтгэлийг бүрэн гаргаагүй байна.

*Монгол улс улам бүр нэмэгдэж байгаа хоёр талын болон олон талын хандивлагчдын зүгээс дэмжлэг авч байна.* Энэ нь тус улсын олон төрлийн стратегийн түншлэл байгуулах чадавхаар харагдаж байна. Гэсэн хэдий ч Монгол улс нь техникийн туршлага болон санхүүгийн нөөцтэй холбоотой асуудлаар олон улсын хандивлагчдаас өндөр хамааралтай байна.

*Тус улс 1990-ээд оны эхэн үеэс ус намгархаг газрын ангилал, Рамсарын конвенцийн газруудыг тодорхойлох болон менежмент, олон нийтийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх үйл ажиллагаандаа мэдэгдэхүйц амжилт олсон байна.* Рамсарын конвенцийн газрын бүс дэх зарим тусгай хамгаалалттай газрын хэмжээ тэлсэн байна. Гэвч, тодорхойлогдсон бүх Рамсарын газар менежментийн төлөвлөгөөгүй байна. Эхний ээлжинд хэрэгжүүлэх ажилд Рамсарын конвенцийн газруудын төлөв байдлыг үнэлэх, Рамсарын конвенцийн газрын мониторингийн үйл ажиллагааг сайжруулах зэрэг ажлууд орно.

*Монгол улс САЙТЕС болон Зэрлэг амьтдын нүүдлийн төрөл зүйлийг хамгаалах тухай конвенциор (Боннын конвенци) хүлээсэн үүргийн хүрээнд онцгой төрөл зүйлийг хамгаалах талаар байнгын хүчин чармайлт гаргаж байна.* Халиун буг, аргаль хонь, ирвэс, начин шонхор, хүдэр, говийн мазаалай зэрэг онцгой төрөл зүйлийг хамгаалах талаар хэд хэдэн хөтөлбөрийг баталсан байна. Гэвч, эдгээр хөтөлбөрийн үр дүнгийн талаар найдвартай, системтэй мэдээлэл хангалтгүй байна. Мониторинг хийх болон хуулидыг мөрдөх явдал тодорхой саад бэрхшээлтэй тулгарч байна.

*Тус улс озоны давхаргатай холбоотой олон улсын гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэх талаар сүүлийн 20 жилд мэдэгдэхүйц амжилт гаргасан байна.* Засгийн газар ус-хлорфторт нүүрстөрөгчийн (НСFCs) хэрэглээ 0.64 тонн-озон задлах потенциал байгаа нь тус улсын суурь хэмжээнээс 54 хувиар доогуур байна. Иймд Монгол улс нь Монреалын Протоколоор тогтсон хувиараар 2015 он гэхэд НСFC-ийн хэрэглээг 10 хувиар бууруулах зорилтыг биелүүлсэн байна.

## **Риогийн конвенциудын хэрэгжилт**

*Риогийн конвенциудын хэрэгжилтийн хоорондын уялдааг хангахад чиглэсэн тусгай механизм, эсвэл бүтэц байхгүй ч эдгээр гурван конвенциудын ерөний бодлогын тогтолцоо нь шууд болон шууд бус байдлаар эдгээр гурван баримт бичгийн хэрэгжилтийг зохицуулахад хувь нэмрээ оруулна.* Эдгээр гурван конвенцийг хэрэгжүүлэхэд бүтэц зохион байгуулал, техникийн болон санхүүгийн чадавхитай холбоотой саад бэрхшээл өөр өөр түвшинд ч гэсэн тохиолдож байна.

*Монгол улс нь биологийн олон янз байдлын талаар стратегийн төлөвлөлт хийх 20 гаруй жилийн туршилагатай бөгөөд үүний дүнд 1992 оны Биологийн олон янз байдлын тухай (БОЯБК)-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой өргөн хүрээтэй боловч зарим талаар ихээхэн сарнисан хууль эрх зүйн болон бодлогын баримт бичгүүд байна.* Үүний гол үр дүн нь улсын тусгай хамгаалалттай нутгуудыг тодорхойлж, тогтвортой ажиллуулж байгаа явдал юм. БОЯБК –ийн хэрэгжилтэд нөлөөлж байгаа саад бэрхшээл нь уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, хөдөө аж ахуйн тогтвортой бус үйл ажиллагаанаас үүдэлтэй амьдрах орчны доройтол, голын сав газар явагдаж байгаа уул уурхайн үйл ажиллагааны өсөлтийн улмаас бий болж байгаа орчны бохирдол зэрэг салбар дундын асуудлуудтай холбоотой экосистемд учруулж байгаа дарамтаас үүдэж байна.

*Биоаюулгүй байдлын тухай 2000 оны Картагены Протоколыг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль эрх зүйн болон бүтэц зохион байгуулалтын тогтолцоо ерөнхийдөө хангалттай сайн байна.* Тулгарч байгаа саад бэрхшээл нь Хувиргасан амьд организмтай (ХАО) холбоотой үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээ, мониторинг хийх чадавхи бий болгохтой холбоотой байна. ХАО болон түүнтэй холбоотой бүтээгдэхүүнийг бүртгэх үндэсний хэмжээний мэдээллийн сан байхгүй байна. Хууль эрх зүйн баримт бичгүүдийг 2010 оны Нагояа-Куала Лампурын Хариуцлага хүлээх болон нөхөн төлбөрийн тухай нэмэлт протоколтой нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

*Монгол улс нь 2010 оны Генетикийн нөөцийг ашиглах, тэдгээрийг ашигласны үр шимийг шударгаар, тэгш хувиарлах тухай Нагояагийн Протоколыг өөрийн орны генетикийн нөөцийг алдагдахаас урьдчилан сэргийлэхийн тулд яаралтай хэрэгжүүлж эхлэх сонирхолтой байна.* Гэвч шаардлагатай хууль эрх зүйн тогтолцоо бий болгохын зэрэгцээ гол саад бэрхшээл нь шаардлагатай санхүүжилт, чадавхи бий болгох, зохистой бүтэц зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлж ажиллуулахад оршиж байна.

*Монгол улс 2014 оны НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн (НҮБ-ын ЦТК) нэг Тал болсоноор ЦТК-ын 10 жилийн стратегитай уялдуулан боловсруулсан Цөлжилттэй тэмцэх 2010-2020 онуудад хэрэгжүүлэх Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.* Хангалттай стратегийн тогтолцоотой болсон нь олон улсын байгууллагууд болон хандивлагч орнуудтай хамтран ажиллаж техникийн дэмжлэгийн төслүүд хэрэгжүүлэх боломж олгож байна. Газрын доройтлын мониторингийн сүлжээг байгуулжээ.

*Хүлэмжийн хийн ялгаралтын хэмжээ 2014 оны байдлаар 34,530 Gg CO<sub>2</sub>-эжв байсан нь 1990 оны түвшингөөс 57.07 хувиар нэмэгдсэн байна.* Хамгийн томоохон ялгаруулагч нь эрчим хүч (2014 оны нийт ялгаралтын 50 хувь) болон хөдөө аж ахуйн салбар (48.44 хувь) байна. Монгол улс нь 2014 оны байдлаар нэг хүнд 7.12 тонн нүүрсхүчлийн хийн ялгаралт ноогдож байснаар нэг хүнд ноогдох CO<sub>2</sub>-ийн ялгаралтын хэмжээгээр дэлхий дээр 54 дүгээр байранд орж байна.

*Монгол улс 1992 оны НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн Тал болсоны үр дүнд уур амьсгалын өөрчлөлтийн талаар өргөн хүрээтэй, сайтар боловсруулсан стратегийн төлөвлөлт болон хэрэгцээ шаардлагын үнэлгээтэй болсон байна.* Тус улс хүлэмжийн хийн инвентори хийхэд шаардлагатай зарим мэдээллийн хүрэлцээтэй холбоотой саад бэрхшээл байгаа ч өнөөдрийн байдлаар уур амьсгалтай холбоотой 25 жилийг хамарсан мэдээллийн сантай болсон байна. Монгол улс Цэвэр хөгжлийн механизм, Хамтарсан кредит олгох механизм, Уур амьсгалын ногоон сангийн шугамаар техникийн болон санхүүгийн дэмжлэг авч үр шимийг нь сайн хүртэж байна.

*Монгол улсын 2015 оны Үндэсний хэмжээний Зорилтот хувь нэмэр (ҮЗХН- NDC) баримт бичиг нь жил тутам хүлэмжийн хийн ялгаралтаа 7,300 t CO<sub>2</sub>-eq –оор бууруулж, улмаар 2030 он гэхэд нийт хүлэмжийн хийн ялгаралтаа Газар, газар ашиглалтын өөрчлөлт, ойн (ГТАӨО) салбарыг тооцоогүй хэвийн байх нөхцөлтэй харьцуулбал 14 хувиар бууруулах зорилт дэвшүүлсэн байна.* Гэвч цаашид хэрэгжүүлэх арга хэмжээнүүдээ хараахан шийдвэрлээгүй байна. Цаашид уур амьсгалын өөрчлөлтийн стратегийн гол баримт бичгүүдэд дасан зохицох тухай асуудал тусгагдсан хэдий ч одоогоор дасан зохицох стратеги эсвэл төлөвлөгөө батлагдаагүй байна. Дасан зохицох ийм төлөвлөгөө боловсруулах нь ТХЗ-ын Зорилго 13:2 –д хүрэх чухал элемент байх болно.

## **Агаар хамгаалал**

*Одоогийн байгаа агаарын чанарын мониторингийн сүлжээний 40 мониторингийн цэг хангалттай мэт боловч тэдгээрээс зөвхөн 11 цэг нь автомат төхөөрөмжтэй байна.* Голлох бохирдуулагчдын ялгаралтын байнгын мониторингийн буюу өөрийн дотоод мониторинг байхгүй, гэр хорооллын агаарын чанарын мониторинг хангалтгүй байна. Мөн үндэсний хэмжээний агаар дахь бохирдуулагчдын ялгаралтын мэдээлэл байхгүй байна. Засгийн газрын бодлого голлон нийслэл хотод төвлөрч бусад бүс дэхь агаарын чанар муу байгааг хангалтгүй анхаарч байна.

*Агаар дахь нарийн ширхэгтэй тоосонцор (PM) нь улсын хэмжээний, ялангуяа Улаанбаатар хотын агаарын гол бохирдуулагч гэж үзэж байна.* Гэвч энэ бохирдуулагчийн агуулга болон эх үүсвэрийн тухай шинжлэх ухааны мэдлэг хязгаарлагдмал байна.



*Говь цөлийн бүсийн шороо, тоосон шуурга (ихэнхдээ шар элс) нь агаар дахь тоос шороо РМ-ийн хэмжээ эрс ихсэхэд ихээхэн нөлөө үзүүлдэг байна.* Гэвч агаарын чанарын байнгын үнэлгээнд агаар дахь элс, тоосны хэмжээ, ялангуяа РМ10 –ийн хэмжээг тооцоходоо анхаарч үзэхгүй байна.

*Засгийн газар гэр хорооллолд дулаанаар хангахын тулд түүхий нүүрс ихээр түлж байгаа нь агаар дахь тоос шорооны агууламж эрс нэмэгдэхэд хүргэж байгаа тул гэр хорооллыг цэвэр түлш болон сайжруулсан зуухаар хангахад чиглэсэн олон тооны төсөл хэрэгжүүлжээ.* Улаанбаатар хотод РМ10 –ийн жилийн агууламжийн хэмжээ тодорхой хэмжээгээр буурч байгаа боловч бодитой хэмжилт болон мэдээний дүн шинжилгээ байхгүй байгаа тул авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг тооцоолоход бэрхшээлтэй юм.

*Агаарын тухай 2012 оны шинэчилсэн хууль томоохон суурин эх үүсвэрүүд агаарын бохирдлын мониторинг хийх болон бохирдлыг бууруулах тоног төхөөрөмж суурилуулахыг үүрэг болгосон байна.* Гэвч цахилгаан станцуудын ялгаралтыг тогтмол хэмжиж хянахгүй, мөн үндэсний хэмжээний, ялангуяа томоохон нүүрс шатаадаг станцуудын ялгаралтын стандарт байхгүй байна. Хууль мөн ялгаралтын стандартыг зөрчсөн тохиолдолд оноох торгуулийг тогтоож өгсөн байна. Гэвч энэ торгуулийг хэмжээ нь бохирдуулагчийн ялгарлыг бууруулах тоног төхөөрөмж суурилуулахад хүргэх хөшүүрэг болж чадахааргүй хэтэрхий бага байна.

*Агаар бохирдуулсаны төлбөрийн тухай 2010 оны хуулийн дагуу томоохон эх үүсвэрүүдийн ялгаралтын стандартыг хэтэрсэн тохиолдолд ноогдуулах төлбөр нь учруулсан хохиролын тогтоосон хэмжээн дээр суурилж тооцоолох ёстой.* Агаарын бохирдлын байгаль орчинд учруулах хамгийн гол хохирол нь хүний эрүүл мэндэд уяруулах хор уршиг юм. Гэвч агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд уяруулах нөлөөлийн эдийн засгийн үнэлгээг тооцох болон бохирдуулагчид өртөх байдлыг үнэлэх нарийвчилсан арга зүй байхгүй байна. Мөн энэ нь Монгол улс ТХЗ –ын Зорилго 3.9 –ийг хэрэгжүүлэхтэй холбоотой агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөл болон нас баралтын тоог мэдэгдүйцээр бууруулахад бэрхшээл учруулна.

*Монгол улсын агаарын чанарын индексийн MNS 4585:2016 стандарт нь уг индексийг тооцоолох аргыг тодорхойлсон байна.* Энэхүү тодорхойлсон арга зүй нь Агаарын чанарын индексийг буруугаар тодорхойлоход хүргэж болзошгүй, учир нь ихэнх тохиолдолд энэхүү индексийн утга нь РМ10 –ийн бодит агууламжаар тодорхойлогдохоор байна.

## **Усны менежмент**

*Засгийн газар усны менежментийн тэргүүлэх зорилтуудыг 2010 оны Усны үндэсний хөтөлбөр болон 2016 оны Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 –д тодорхойлж өгсөн байна.* Гол анхаарлаа хууль эрх зүй болон болон зохицуулалтын тогтолцоог шинэчлэх, өргөжүүлэхэд хандуулж байна. Энэ ажлын гол үр дүн нь 2009 онд нэвтрүүлсэн голын эх үүсвэрийн бүсэд эрдэс баялагийн ашиглалтыг зогсоосон, мөн 2016 онд голын эхний бүсийн нийт талбайн 44.5 хувийг улсын хамгаалалтанд авсан явдал юм.

*Усны менежментийн системийн шинэчлэлийн тэргүүлэх чиглэл бол Усны нөөцийн нэгдсэн менежментийн арга зүй болж байна.* Усны нөөцийн нэгдсэн менежментийг (УННМ) амьдрал дээр хэрэгжүүлэхэд бусад голуудын сав газрын УННМ –ын төлөвлөгөөг боловсруулах, тэдгээр төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, усны менежментэд олон нийтийн оролцооны боломжийг хангахад ахиц гаргах явдал болж байна.

*Монгол улс 29 усны сав газрын 21 сав газрын захиргаадыг байгуулаад байна.* Гэвч эдгээр захиргаад нь өөрсдийн үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай туршлага байхгүй байна. Иймд эдгээр сав газрын захиргаадын ажиллагсдыг сургах, мэрэгшлийг нь дээшлүүлэх явдал тэдгээрийн хариуцсан үүргээ хэрэгжүүлэх болон ТХЗ 2030 –ийн Зорилго 6.5 –ийг хэрэгжүүлэхэд ахиц гаргах боломжтой болоход маш чухал ач холбогдолтой юм.

*Монгол улсын усны нийт нөөцийн дөнгөж 1.91 хувийг эзэлдэг газрын доорхи усаар улсын хэмжээний нийт хэрэглээний усны 95 хувь орчмыг хангаж байна.* Гадаргын ус улсын нийт нутагт жигд бус тархсан бөгөөд маш бага хэмжээгээр хэрэглэж байна.

*Усан хангамж болон ариун цэврийн байгууламжийн хүрэлцээний тухай албан ёсны мэдээ болон ТХЗ-той холбоотой шалгуур үзүүлэлтүүд өөр өөр эх үүсвэрүүдийн хувьд ихээхэн ялгаатай байна.* Хамгийн гол ялгаатай байдал нь хот суурин болон хөдөө орон нутгийн хоорондох усны хангамж болон ариун цэврийн байгууламжийн хүрэлцээ, орон нутагт маш хязгаарлагдмал айл өрх төвлөрсөн бохир усны системд холбогдсон, хөдөөийн иргэдийн маш бага хувь (зарим эх үүсвэрийн мэгээрээр 2010 оны байдлаар 5 хувиас доош) нь шаардлагатай цэвэрлэх байгууламж ашиглах боломжтой байгаа явдал байна. Ил задгай бие засах байдал байсаар байна. Иймд ТХЗ 2030 –ийн Зорилго 6.1 болон 6.2 –д хүрэхийн тулд нэмэлт хүчин чармайлт гаргах хэрэгтэй байна.

*Цэвэрлэсэн бохир усны хэмжээ 2012 онд 60 сая шоо метр (30 хувь) байсан бол 2016 онд 88 сая шоо метр (44 хувь) болж нэмэгджээ.* Цэвэрлээгүй бохир усыг шууд байгальд хаяж байгаа нь гадаргын болон газрын доорхи ус бохирдоход хүргэж байна. Санхүүгий нөөц бололцоо байхгүй байгаа нь ус цэвэрлэх байгууламжуудыг засварлах, үйлчилгээ хийх, сэргээх болон дахин барих ажлыг хойшлуулахад хүргэж байна. Энэ байдал хөдөө орон нутагт, ялангуяа алслагдсан бүсэд ихээр тохиолдож байна.

### **Хог хаягдлын менежмент**

*Хог хаягдлын тухай мэдээллийг 10 гаруй жил цуглуулж байгаа ч гэсэн тэдгээрийн чанар хангалтгүй хэвээр байна.* Аюултай хог хаягдлын жагсаалт батлагдсан боловч түүнийг амьдрал дээр ашиглахгүй байна. Өөр бусад хог хаягдлын менежменттэй холбоотой мэдээлэл байгаа боловч тэдгээрийг улсын хэмжээнд нэгтгэж дүгнээгүй байна. Хог хаягдлын тухай мэдээлэл хомс байгаа нь төсөл хөтөлбөр боловсруулах, мэдээллийг олон нийтэд хүргэхэд саад бэрхшээл болж байна.

*Хог хаягдлын менежментэд сүүлийн арван жилд тэргүүн зэргийн асуудал бол хот суурингийн хатуу хог хаягдлын менежмент болон эмнэлгийн хог хаягдлын менежментийг сайжруулах явдал байжээ.* Салбаруудын стратеги болон салбаруудын хог хаягдлын менежментийн төлөвлөгөө байхгүй байна. Цацраг идэвхит хог хаягдлын асуудалд нэг их анхаарал хандуулахгүй байна.

*Хот суурингийн хатуу хог хаягдлыг цуглуулах үйлчилгээ зөвхөн хотуудад л төвлөрч байна.* Хог хаягдлыг цуглуулах байдал хот суурин газарт 70 хувь, харин хөдөө орон нутагт 40 хувь байна гэж үзэж байна. Улаанбаатар хотод хог хаягдал цуглуулалтын хэмжээ 90-95 хувь байна гэж тооцоолсон байна.

*Хотын хатуу хог хаягдлыг суурин газрын ойролцоо байх хогийн цэгүүдэд дарж булшилж байна.* Эдгээр хогийн цэгүүд нь аяндаа бий болж зөвхөн дараа нь л хотын удирдлага түүнийг хогийн цэг гэдгийг албан ёсоор зарладаг байна. Монгол улсад нийт 3,500–4,500 га газрыг хамарсан 400 орчим албан ёсны хогийн цэг оршиж байна. Хууль бус хогийн цэгүүдийн тоог тогтоох хүндрэлтэй боловч 2006-2016 оны хооронд 500,000 га газрыг бүрхсэн 4,000 хууль бус хогийн цэгийг цэвэрлэж, 1.1 сая тонн хууль бусаар хаясан хогийг албан ёсны хогийн цэгүүд рүү зөөж шилжүүлжээ.

*Хог хаягдлыг эргүүлж ашиглах явдал метал, пластик, цаас болон картонан хатуу цаас зэрэг үнэ цэнэтэй хог хаягдалд л төвлөрч байна. Хотын хатуу хог хаягдлаас дахин ашиглаж болох хогийг ялгах ажиллагаа хог худалдаж авах цэгүүд дээр сайн хийгдэж байна.* Гэвч Монгол улсад хогийг дахин боловсруулах чадавхи байхгүй тул ихэнх дахин ашиглаж болох хог хаягдлыг экспортод гаргаж байна. Хог хаягдлыг дахин ашиглах чадавхийг бий болгохын тулд хог хаягдлын менежментийн иж бүрэн байгууламж болох Экопарк байгуулахаар төлөвлөж байна.

*Аюултай хог хаягдлын тухай мэдээлэл хязгаарлагдмал байна. Улсын хэмжээгээр жил тутам гаргасан аюултай хог хаягдлын хэмжээг 27,000–54,000 тонн орчим гэж тооцоолж байна.* Аюултай хог хаягдлын гол эх үүсвэрүүд нь арьс ширний үйлдвэрийн хаягдал, түүхий нефть боловсруулах болон ашиглах явцад гарах хаягдал, алтны хүдрийг боловсруулахад явцад гарсан цианид болон мөнгөн ус агуулсан хөрс байдаг байна. Түүнчлэн энд машины батерейг дахин боловсруулах явцад гарах хориглосон химийн бодис болон хүчил хамаарна. Монгол улс ТХЗ-ын Зорилго 12.4 –д хүрэхэд ахиц дэвшил гаргахын тулд аюултай хог хаягдлын тайлагнах механизмийг сайжруулах хэрэгтэй байна.

*Албан бус бичил уул уурхайн байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөллийн тухай мэдээлэл хязгаарлагдмал байна.* Байгаль орчны төлөв байдлын 2007 оны тайланд хууль бус алт олборлож байгаа 120 газар

байгааг тодорхойлжээ. Эдгээр хууль бус үйл ажиллагааны улмаас 203,500 шоо метр хаягдал шороо, мөнгөн ус агуулсан 53.5 га газар бий болсон байна.

### **Биологийн олон янз байдал, тусгай хамгаалалттай бүс**

*Монгол улс Зүүн Азид үлдсэн зэрлэг амьтдын төрөл зүйлсийн сүүлчийн хоргодох газрын нэг болж байгаа байгалийн онгон экосистемийг хамгаалж чадаж байна.* Гэвч сүүлийн 30 орчим жилийн туршид Монгол улсад олон тооны төрөл зүйлс, тухайлбал дэлхий нийтийн хэмжээгээр аюулд өртсөн төрөл зүйлс огцом хорогдох байдал ажиглагдаж байна. Үүний зэрэгцээ өнөөгийн байдлаар голдуу хүний хүчин зүйлийн нөлөөгөөр Монгол улсын дөрвөн үндсэн эко бүс нутаг бүрт байгалийн бүхий л экосистемийн нэгдмэл байдал аюулд өртөөд байна.

*Монгол улс 1990-ээд оны эхэн үеэс хойш 2017 оны байдлаар захиргааны ялгаатай түвшинд 47 сая га газар буюу улсын нийт нутаг дэвсгэрийн 29.91 хувийг хамарсан тусгай хамгаалалттай газар нутгийн иж бүрэн системийг хөгжүүлж иржээ.* Гэвч зэрлэг амьтдын их хэмжээний амьдрах бүс нутаг, өргөн тархалттай, дэлхий нийтийн хэмжээгээр чухал ач холбогдолтой төрөл зүйлүүдийн нүүн шилжих бүс нутаг (корридор) улсын нийт нутгийн 70 хувийг эзлэх “хамгаалагдаагүй” хэсэгт үлдэж хоцроод байна. Түүнчлэн, хамгаалалттай зарим газарт ч гэсэн өнөөгийн бүсчлэлийн байдал нь чухал ач холбол бүхий зэрлэг амьтдын амьдрах орчныг хангалттай хэмжээний хамгаалалтаар хангаж чадахгүй байна. Эдгээр саад бэрхшээл, сорилтыг шийдвэрлэх нь Монгол улс ТХЗ-ын Зорилго 15.1 болон 15.4 –д хүрэхэд нь ахиц дэвшил гаргахад чухал ач холбогдолтой байх болно.

*Төлөвлөлтийн менежментийн асуудал өнөөгийн хууль эрх зүйн тогтолцоогоор хангалттай зохицуулагдаагүй, энэхүү системийн сул тал болсоор байна.* Менежментийн үүрэг хариуцлагын асуудал ихээхэн олон талтай байна. Учир нь ДЦГ болон ҮП-дад улсын байгууллага эсвэл ТББ болон малчдын холбоодтой гэрээ байгуулан менежмент хийж байгаа бол улсын тодорхойлсон Байгалийн нөөц газар, байгалийн цогцолбор газар, мөн орон нутгийн тодорхойлсон завсрын бүс, орон нутгийн хамгаалалттай газруудад бүсийн болон орон нутгийн байгуулагууд менежмент хийж байна. ТХГ-т менежментийн төлөвлөгөө боловсруулахыг хуулиар үүрэг болгоогүй ч БОАЖЯ бүх ТХГ-ууд менежментийн төлөвлөгөөтэй байх ёстой гэж үзэж энэ үйл ажиллагаа одоо явагдаж байна.

*Улсаас санхүүждэг тусгай хамгаалалттай газрын захиргаатад төсвийн дутагдалтай байдал нийтлэг байгаа бөгөөд эдгээр захиргаад ТХГ-т нэвтэрсний хураамжийг үлдээж өөртөө ашиглах боломжгүй байна.* ТХГ-ын үйлчилгээ болон менежментэд зориулан газрын төлбөр тогтоох хууль эрх зүйн заалт байхгүй байна.

*Биологийн олон янз байдлын талаарх өнөөгийн бодлогын тогтолцоогоор хүлээсэн үүргүүдийг хэрэгжүүлэхэд одоогийн байгаа хүн хүчний, техникийн, үйл ажиллагааны болон санхүүгийн чадавхи боломж хангалтгүй байна.* БОАЖЯ-ны Тусгай хамгаалттай газрын удирдлагын газрын долоон ажилтан улсын хэмжээний ТХГ-ын системийн үр дүнтэй менежмент хийх үүрэг хүлээдэг бол 337 байгаль хамгаалагч нь 24 сая га газарт хуулийн хэрэгжилт мөрдөлтийг хангуулах үүрэгтэй байгаа нь илэрхий хангалтгүй байна. Одоогийн байгаа энэхүү чадавхийг бэхжүүлэхгүйгээр биологийн олон янз байдал болон ТХГ-ын талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх, мөн ТХЗ-ын Зорилго 15.1 болон 15.4 –д хүрэхэд энгийнээр хэлбэл боломжгүй байж болох юм.

*Олон тооны хийдэгдэл, дутагдалтай тал байсан тул ТХГ-ын тухай 1994 оны хуулийг шинэчлэх ажил хийгдэж байна.* ТХГ-ын 1998 оны Үндэсний хөтөлбөрийг орлох шинэ хөтөлбөрийг мөн боловсруулж байна. Энэхүү шинэ хөтөлбөр нь төлөвлөгдсөн ТХГ-ын улсын сүлжээг оргөжүүлэх, тэдгээрийн менежментийг сайжруулах асуудлыг шийдвэрлэх болно.

### **Газрын менежмент**

*2015 оны байдлаар нийт нутаг дэвсгэрийн 76.8 хувь нь ямар нэгэн байдлаар эвдэрч, доройтолд орсоноос 24.1 хувь нь бага зэрэг, 29.8 хувь нь дунд зэрэг, 16.8 хувь нь хүчтэй, 6.1 хувь нь маш хүчтэй доройтолд ороод байна.* Хүчтэй болон маш хүчтэй доройтолд орсон газар нь Увс нуурын сав газар, Их нууруудын хотгор, Дундговь болон Дорноговь аймгийн хуурай болон цөлөрхөг нутагт ажиглагдаж байна.

*Газрын доройтлын ихэнх нь бэлчээрт ажиглагдаж байна. Бэлчээрийн бүс нутаг 1987 онд 123.6 сая га газар эзэлж байсан бол 2016 онд 112.2 сая га болж багасчээ. Энэ хугацаанд малын тоо толгой*



*1987 онд 22.741 сая байсанаас 2016 онд 61.549 сая болж 2.7 дахин нэмэгджээ.* Үүний улмаас малын тоо толгойн нягтшил 1987 онд 100 га газарт 18 толгой мал ноогдож байсан бол энэ үзүүлэлт 2016 онд 54 толгой мал болж нэмэгдсэн нь бэлчээрт үзүүлэх дарамтыг эрс нэмэгдэхэд хүргэсэн байна. Малын тоо толгой нэмэгдэхийн зэрэгцээ сүргийн бүтэц өөрчлөгдөж, 1987 онд ямааны тоо 19.3 хувь байснаа 2015 онд 42.1 хувь болж нэмэгджээ. 2015 оны эцэс гэхэд нийт бэлчээрийн 63 хувь нь хэт бэлчээрлэлтэд өртжээ.

*Хэт бэлчээрлэлтийн зэрэгцээ уул уурхай, автомашины хатуу хучилтгүй зам болон хотжих үйл явц зэрэг хүний үйл ажиллагаа бэлчээрт ихээхэн дарамт учруулж байна.* Эдгээр дарамт нөлөөлөл байгаа хэдий ч Монгол улсад бэлчээр ашиглалтыг зохицуулах хууль байхгүй байна. Энэ хууль олон жил төсөл хэлбэрээр байсаар байна.

*Засгийн газар ТХЗ-ын Зорилго 15.3 –тай уялдуулан 2030 он гэхэд доройтсон газрын 70 –аас доошгүй хувийг сэргээх, цөлжсөн газрын хэмжээг нийт нутгийн 60 хувьд хүртэл бууруулах томоохон зорилтууд дэвшүүлсэн байна.* Хөрс хамгаалах болон цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийг 2012 онд, 2010-2020 онд хэрэгжүүлэх Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2010 онд баталсан нь хууль эрх зүй болон бодлого боловсруулах тогтолцоонд ахиц гаргасан байна. Гэвч эдгээр бодлогыг амьдрал дээр хэрэгжүүлэхэд санхүүгийн хязгаарлагдмал нөөц, байгууллагуудын хоорондын хангалттай бус зохицуулалтаас шалтгаалсан саад бэрхшээлтэй тулгарч байна.

*Монгол улсын газрын доройтол болон цөлжилтийн мониторингийн сүлжээ нийт улс даяр тархсан 1,500 цэгээс бүрдэж байна.* Газрын доройтлыг саармагжуулах гурван үзүүлэлт (газрын бүрхүүл, газрын бүрхүүлийн өөрчлөлт; газрын бүтээгдэхүүн; газрын дээрх болон доорхи нүүстөрөгчийн хэмжээ) –ийн тухай мэдээллийг одоогоор цуглуулахгүй байна.

## **Ой болон байгаль орчин**

*2016 оны байдлаар 18.45 сая га газар ойн сан бүхий газар гэж үзэж байгаа нь нийт нутгийн 11.8 хувийг эзэлж байна. Үүнээс 12.28 сая га буюу нийт нутгийн 7.85 хувь нь ойгоор бодитойгоор бүрхэгдсэн байна.* Ойн сангүй бүс (5.63 сая га) –д ой болон ойн бус үйл ажиллагаа, мал бэлчээрлэлт, түлээний мод болон дүнс бэлтгэх зорилгоор хэт их ашигласан, түймэр олонтоо гарсан, хортон шавьжинд идэгдсэн зэрэг янз бүрийн дарамтын улмаас ойгүй болсон газрыг хамруулж байна. 2016 онд батлагдсан Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 –д ойгоор бүрхэгдсэн талбайг 2030 он гэхэд нийт нутгийн 9 хувьд хүргэж нэмэгдүүлэх зорилт дэвшүүлсэн байна.

*Олон зорилтот үндэсний ойн тооллого (инвентори) (2014–2016) Монгол орны хуурай ойн ихэнх хэсэг нь ихээхэн хөгширч, нийт ой модны 74.07 хувь нь хөгширсөн, хэт хөгширсөн ангилалд хамрагдаж байгааг тогтоосон байна.* Үүний улмаас ойн бүтээгдэхүүн багасаад зогсохгүй түймэр болон хортон шавьжинд нэрвэгдэх байдал нэмэгдэж, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдал буурсан байна. Энэ нь ой доройтох, ой устаж үгүй болоход хүргэж байна. Ойн хөгшрөлт, хэт хөгшрөлтийн эсрэг менежментийн илүү идэвхтэй үйл ажиллагаа явуулах нь ойн ерөнхий төлөв байдлыг сайжруулаад зогсохгүй, орон нутагт байхгүй байгаа ажлын байр бий болгох, орлогын эх үүсвэрийг бий болгох болно.

*ТХГ-ын гадна байгаа ойн сангийн эзлэх хувь хэмжээний тухай сүүлийн үеийн мэдээ байхгүй байна.* Ойн олон зорилтот үндэсний ойн тооллого болон ЕЭЗК-ын заган ойн тооцооны дагуу өнөөдрийн байдлаар хуурай болон заган ойн нийт 3.1 сая га ой бүхий бүс ТХГ-ын гадна байгаа нь ойгоор бүрхэгдсэн нийт талбайн 25 хувьтай дүйцэж байна. Энэ нь тус улсын нийт талбайн дөнгөж 1.98 хувийг эзэлж байна.

*Ойн салбарын улсын санхүүжилтийн ихэнх нь мод тарих (ойг сэргээх болон ойжуулах), хортон шавьжны хяналтад зарцуулагдаж байна.* Гэвч ойг нөхөн сэргээх болон ойжуулалтын ажлын үр дүн, суулгасан модны амьдралтын хувийг нарийвчлан тодорхойлоогүй нь урт хугацааны бодлогод нөлөөлж байна. Ойн салбарт олгож байгаа одоогийн санхүүжилтийн хэмжээ нь ойн нөөц потенциалыг хөдөөгийн иргэдийн амьжиргааг дэмжихэд чиглүүлэн ойн менежментийг илүү үр дүнтэй явуулаад хангалтгүй байна.

*Ойн модны эрүүл байдлыг хангах, ургалтыг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй болгохын тулд байгалийн ойн арчилгааг сайжруулах, сийрэгжүүлэх шаардлага маш их байна.* Гэвч ойг сийрэгжүүлэх болон арчилгааны үйл ажиллагааны улмаас бий болсон хаягдлыг үр бүтээлтэй ашиглах тодорхой үзэл баримтлал байхгүй байна.

*Монгол улс оролцооны ойн менежментийг хөгжүүлэх талаар ихээхэн ахиц дэвшил гаргасан байна.* Ой ашиглагчдын бүлэг байгуулах нь хулгайн мод огтлох явдалтай тэмцэх болон эдгээр бүлгийн оролцоотой ойн менежмент хийх үр дүнтэй болох нь харагдаж байна. Ой ашиглагчдын бүлгүүдийн эрх зүйн статус тодорхойгүй хэвээр байна. Тэд ямар нэгэн санхүүгийн үйлчилгээ авахгүй байна. Ой ашиглагчдын бүлгийн ойн устал, ойн доройтол, ойн дагалт бүтээгдэхүүний менежмент, зэрлэг амьтан болон ургамал хамгаалал, ойн нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх зэрэгт ямар нөлөө үзүүлж байгаа тухайн мэдээлэл байхгүй байна.

## **Байгалийн, технологийн болон хүний хүчин зүйлийн гаралтай аюул гамшгийн эрсдэлийн менежмент**

*Монгол улсад байгалийн, технологийн болон хүний хүчин зүйлийн гаралтай аюул гамшигийн тоо, хамрах хүрээ, давтамж, эрчимшил, нөлөөлөл 2000–2016 оны хооронд нэмэгдсэн байна.* Энэ хугацаанд байгалийн, технологийн болон хүний хүчин зүйлийн гаралтай аюул гамшигийн учруулсан эдийн засгийн хор хохирлын хэмжээ жил бүр 76 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна. Ялангуяа 2010 онд эдийн засгийн хохиролын хэмжээ 2010 оны тогтмол үнээр тооцвол 534,796 тэрбум төгрөг хүрсэн нь ДНБ-ний 5.5 хувийн эзэлж байжээ.

*1990-ээд оноос хойш Монгол улс хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжих эрчимтэй төлөвлөгдөөгүй хөдөлгөөн явагдаж байгаа нь хотын үндсэн үйлчилгээ авч чадахгүй байх, өвлийн улиралд хотын зарим бүсэд агаарын бохирдол аюултай түвшинд хүрэх зэрэг олон саад бэршээлийг бий болгож байна.* Хотын захаар орших гэр хороолол нь үерийн аюултай эрсдэлтэй байдалд орж байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэх нь ТХЗ-ын Зорилго 1.6, 11.5 болон 11.b –д хүрэхэд ахиц дэвшил гаргахад ихээхэн саад бэрхшээл учруулах болно.

*Засгийн газрын ажилтнууд үндэсний хөгжлийн хөтөлбөрийн түүчээ хөтөлгөч хүч болох 2015–2030 онуудад хэрэгжүүлэх Гамшигийн эрсдэлийг бууруулах бууруулах Сендайн хамрах хүрээ, Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээр болон Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх хөтөлбөрийн ач холбогдол, тэдгээрийн харилцан хамаарлын тухай сайн мэдлэг, мэдээлэлтэй байна.* Гамшигийн эрсдэлийн менежмент, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болон тогтвортой хөгжлийн холбоотой ажлын тухай сайн ойлголттой байгаа ч эдгээр холбоог практик дээр хэрэгжүүлэх болон бүтэц зохион байгуулалтын уялдаа холбоо зохицуулалт хийхэд саад бэршээлтэй тулгарч байна.

*Гамшигийн эрсдэлийн менежментийн систем, түүний бэлэн байдлыг хангах болон хариу арга хэмжээний төлөвлөлтөд олон тооны бэрхшээл тулгарч байна.* Гамшигийн бэлэн байдлыг хангах болон хариу арга хэмжээний чадавхи үндэсний хэмжээнд илүү сайн хөгжсөн байна. Харин орон нутгийн төвшинд олон улсын байгууллагууд болон ТББ Засгийн газрын хүчин чармайлтад дэмжлэг үзүүлж, гамшигийн хариу арга хэмжээний үйлчилгээний техникийн тусламж хангаж байна. Байгаа санхүүгийн нөөцийн ашиглалтыг оновчтой болгоход чиглэсэн үндэсний болон орон нутгийн түвшний үйл ажиллагааны үр дүнтэй зохицуулалт нь тулгарч байгаа саад бэрхшээлүүдийн нэг юм.

*Төв орон нутгийн бүх түвшний захиргааны олонх байгууллагууд болон мэргэжилтнүүдийн гамшигийн болон уур амьсгалын эрсдэлийн тухай сайн ойлголттой байна.* Төрөл бүрийн судалгааны, техникийн байгууллагууд мэдээлэл цуглуулах болон урьдчилан мэдээлэх албан ёсны үүрэгтэй байна. Гэвч зөвхөн хэдхэн салбар эрсдэлийн үнэлгээгээ хийсэн байна.

*Дархан, Эрдэнэт, Улаанбаатар гэсэн 3 хот “Хотуудаа тэсвэр дархлаатай болгоё: Миний хот бэлэн болж байна” даян дэлхийн компанид албан ёсоор нэгдэн орсон байна.* Энэ нь эдгээр хотууд гамшигийн эрсдэлийг бууруулах асуудлыг орон нутгийн хөгжлийн бодлого, хотын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулж, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар ажиллаж байна гэсэн үг юм. Бусад орон нутгийн захиргаад гамшигийн эрсдэлийг бууруулах орон нутгийн төлөвлөгөө батлан, хэрэгжүүлж байгаа тухай мэдээлэл байхгүй байна.

## Эрүүл мэнд, хүсний баталгаатай байдал болон байгаль орчин

*Сүүлийн 20 жилийн туршид иргэдийн эрүүл мэндийн байдал сайжирсан байна.* Гэвч эрүүл мэндийн үзүүлэлтүүд бүс нутаг болон аймгуудын хооронд ихээхэн ялгаатай байна. 2000 оноос хойш, урт наслалтын түвшний хамгийн доод хэмжээ Дорнод аймаг (2000 онд 58 жил, 2010 онд 63.9 жил, 2016 онд 68.63 жил) болон Хөвсгөл аймагт (2000 онд 59 жил, 2010 онд 63.6 жил, 2016 онд 66 жил) ажиглагдаж байна.

*Сүүлийн жилүүдэд, гадна агаарын болон дотор агаарын аль алиных нь агаарын бохирдол нь хүний эрүүл мэндийн байдалд байгаль орчны хамгийн их дарамт учруулж байгаа асуудал болоод байна.* Жилийн дундаж агаар дахь нарийн ширхэгтэй тоосонцор PM<sub>2.5</sub> –ын агууламж (дундажаар 70  $\mu\text{g}/\text{m}^3$  орчим) Улаанбаатар хотод Монгол улсын агаарын чанарын стандарт (25  $\mu\text{g}/\text{m}^3$ ) болон ДЭМБ–ын Агаарын чанарын гарын авлагад заассан хэмжээнээс дээгүүр байна. 2016 онд НҮБ-ын ХС-гийн санхүүжүүлсэн “Сургуулиудын эрүүл ахуйн болон ариун цэврийн нөхцөл, дотор агаарын чанарын үнэлгээ” төслийн хүрээнд шинжилгээнд хамрагдсан сургуулиудад CO<sub>2</sub> -ийн дундаж агууламж батлагдсан стандартаас 1.6 – 1.8 дахин өндөр байгааг харуулсан байна. Мөн энэхүү судалгаагаар PM<sub>2.5</sub> -ийн дундаж агууламж эдгээр сургуулиуд дээр агаарын чанарын үндэсний стандартаас 3.1 – 10.05 дахин дээгүүр байгааг харуулсан байна.

*2017 онд батлагдсан 2017–2020 онуудад хэрэгжих Хүрээлэн буй орчны эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр нь агаар, ус, хөрсний бохирдол болон химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулахад чиглэсэн ажлыг эрэмбэлсэн байна.* Байгаль орчинтой холбоотой өөр хэд хэдэн хөтөлбөр байгаа боловч тэдгээрийн аймаг, орон нутаг дахь хэрэгжилтийн байдал, мөн тэдгээрийн сүүлчийн үнэлгээ байхгүй байна. Байгаль орчны эрүүл мэндийн үйл ажиллагааны эрэмбэ тогтоох болон нийтлэг стратегиэ тодорхойлоогүй байна. Шөрмөсөн чулуу, дотор агаарын чанар, байгаль орчны дуу чимээ зэрэг асуудлаар сэдэвчилсэн үйл ажиллагааны төлөвлөгөө байхгүй байна.

*Хэвлэл мэдээлэлд зориулсан агаарын бохирдол зэрэг байгаль орчны иргэдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн тухай мэдээлэл хангалтгүй, шөрмөсөн чулуу, дуу чимээ, химийн бодис болон бусад хүний үйл ажиллагааны хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл баримтжаагүй байна.* Аюултай бодисын (химийн бодис, аюултай хог хаягдал, шөрмөсөн чулуу, хар тугалга, радон) болон тэдгээрийн ялгаралт, байрлалын тухай мэдээллийн сан бий болоогүй байна. Эдгээр бодисын бохирдолыг илрүүлэх, тэдгээрийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тодорхойлоогүй байгаа нь бохирдлоос сэргийлэхэд бэрхшээл учруулж байна.

*Шөрмөсөн чулууг одоо ч ашигласаар байна.* Шөрмөсөн чулууг олборлох талаар ямар нэгэн стандарт, мөн хуучин барилгыг буулгахаас өмнө шөрмөсөн чулууг илрүүлэх талаар ямар нэгэн бодлого байхгүй байна. Шөрмөсөн чулууг олборлох болон холбогдох өвчлөлд мониторинг хийх юмуу бүртгэхгүй байна.

*Уул уурхайн үйл ажиллагаа сүүлийн 20 жилд эрс нэмэгдэж энэ нь байгаль орчин болон ажилчид, иргэд болон мал аж ахуйд нөлөө үзүүлж байна.* Уул уурхайн бүс дэх иргэд болон агаар, хөрс, ус, мөн малд (мал аж ахуй), цаашлаад тэдний эрүүл мэнд уул уурхайн үйл ажиллагааны хуримтлагдсан нөлөөлөлд өртөх болно. Уул уурхайн эрүүл мэндэд учруулах гамшигт шороо тоостой холбоотой амьсгалын замын өвчин болон химийн бодист хордох явдал орж байна.

*Тус улс эмнэлгийн материал дахь мөнгөн усны хэрэглээг эцэс болгох үүрэг хүлээсэн байна.* Мөнгөн усгүй эмнэлэг санаачлагыг амжилттай хэрэгжүүлж эхэлсэн байна. 2012 онд 14 эмнэлэг мөнгөн ус хэрэглэхээ больсоноо зарлажээ.

*Сургууль, цэцэрлэгт, ялангуяа алслагдал бүс нутагт сайн чанарын, аюулгүй ус хэрэглэх явдал ыгэрхшээлтэй тулгарч байна.* Энэ байдлыг сайжруулахад чиглэсэн орон нутгийн чанартай хэд хэдэн арга хэмжээг үндэсний болон олон улсын байгууллагууд авч хэрэгжүүлж байна. Гэвч энэ нь нийт улс орныг хамарч чадахгүй байна.

# ОРШИЛ

## I.1 Физик-газар зүйн нөхцөл

Монгол улс нь Зүүн Азид өмнө талаараа БНХАУ (хилийн урт 4,677 км), хойд талаараа ОХУ (хилийн урт 4,677 км)-тай хиллэдэг далайд гарцгүй орон юм. Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 1,564,116 ам дөрвөлжин км, түүний 10,560 ам дөрвөлжин км нь усаар бүрхэгдэнэ.

Нутаг дэвсгэр нь бүхэлдээ Монголын тэгш өндөрлөгийн нэг хэсэг юм. Физик газар зүйн хувьд ихээхэн ялгаатай, умард болон өрнө талаараа уул нурууд, өмнө тал нь Говь цөл эзэлнэ. Газрын гадаргын онцлог шинж нь умард болон өрнө талд орших өндөр уулсаас дорно болон өмнө талаар орших тэгш тал болон нам доор газар руу шилжиж налсан ерөнхий төлөвтэй. Умардаас өмнөд рүү газар зүйн үндсэн дөрвөн байгалийн бүсэд хуваагдана: уулын ойт хээр, уулсын тал хээр, бүүр өмнө талд заримдаг цөл болон цөлийн бүс оршино. Эдгээр нь дотроо дахин долоон төрлийн байгалийн дэд бүсэд хуваагдана. Монгол улс дунджаар далайн түвшнөөс дээш 1,580 м өргөгдсөн бол хамгийн нам цэг нь Монголын дорнод тэгш талд 518 м байна.

Тус улсад хоёр томоохон уул нурууд оршдог оос хамгийн өндөр нь Монгол орны баруун болон баруун өмнөд бүсэд баруун хойноос зүүн урагшаа сунаж тогтсон Алтайн нуруу юм. Монгол орны хамгийн өндөр цэг нь 4,374 м өндөр, байнгын цас мөсөөр бүрхэгдсэн Хүйтний оргил бөгөөд энэ нь Хятад, ОХУ-ын хилийн уулзвар дээр Монгол орны бараг хамгийн баруун цэгт Алтайн нурууны Таван богдын уулсын нэг хэсэгт оршино. Энд Таван богдын уулсын бүсийн олон мөсөн голууд байдгаас Потанины мөсөн гол 11 км үргэлжилнэ.

Хангайн нуруу нь Монгол орны төв болон төвийн нутгийн хойд хэсэгт мөн баруун хойноос зүүн урагшаа сунаж тогтоно. Эдгээр нь голдуу нэлээд хөгшин, арай нам, илүү их элэгдэлд орсон уулс оршиж, ой болон альпын нугаар бүрхэгдэнэ. Хангайн нурууны хамгийн өндөр оргил нь 4,008 м өндөр Отгон тэнгэр уул бөгөөд энэ нь Монголчуудын шүтээн уулсын нэг юм. Монгол орны баруун болон хойд хэсэг орших уулс нь газар хөдлөлийн идэвхтэй бүсэд оршиж байнгын газар хөдлөлт ажиглагддаг, олон тооны халуун рашаан, сөнөсөн галт уулуудтай.

Монголын ихэнх нутгийг өргөн уудам тал хээр, бэлчээр эзлэх бөгөөд 2016 оны байдлаар нийт нутгийн 7.85 хувийг бүхсэн ойтой. Маш бага хэмжээний, нийт нутгийн 1 хүрэхгүй хувийг эзлэх тариалангийн газартай, бусад газар нутаг нь өвст тал хээр, говь цөл эзэлнэ. Голлох үр тарианы ургамал нь улаан буудай бөгөөд түүнийг нутгийн хойд хэсгийн Сэлэнгэ мөрний сав газрын хөндийнүүдэд голдуу тариалах боловч ургац нь хур тунадас орох хугацаа болон хэмжээнээс, түүнчлэн ган, зудын байдлаас шууд хамаарах тул маш их хэлбэлзэлтэй, урьдчилан тооцоолох боломжгүй байдаг байна.

“Говь” хэмээх нэр нь Монгол хэлний үг бөгөөд цөл, нам доор газар, хужирт мараа буюу тал хээр гэсэн санааг илэрхийлж, хөхтөн амьтад, түүнчлэн тэмээ зэрэг амьтдыг хангах хангалттай өвс ногоо бүхий хуурай өвст тал хээрийг илэрхийлнэ. Нутгийн иргэд *говь* болон *цөлийг* тодорхой ялган авч үзэх боловч Монгол орны газрын бүрхэвчийн байдлын талаар тодорхой мэдээлэлгүй гадны хүний хувьд энэ ялгааг олж харахад бэрхшээлтэй. Говийн бэлчээр хээр маш эмзэг, малын хэт бэлчээрлэлт, талхлалтын улмаас доройтолд орох өндөр эрсдэлтэй, энэ нь Монголын хоёр бөхтэй тэмээ ч амьдрахад хэцүү жинхэнэ цөлийн чулуурхаг бүс тэлэхэд хүргэдэг байна.

Нуурууд нийт нутгаар жигд тархаагүй, ихэнх нуурууд, ялангуяа томоохон нуурууд баруун бүсэд орших Алтай, Хангай, Тагнын нурууны хоорондох Их нууруудын хотгорт оршино. Монгол орны усаар бүрхэгдсэн талбай харьцангуй бага, улсын нийт нутгийн 0.67 хувийг эзлэх боловч, энд Ази тивийн цэнгэг уст нуур болох Хөвсгөл нуур оршино. Хөвсгөл нуур нь Саяны нурууны өмнөд хөндийд оршиж, Монголын бүх нууруудын нийт усны нөөцөөс ч илүү устай, маш гүнзгий нуур тул улсын хэмжээний нийт цэвэр усны нөөцийн 70 хувийг дангаараа агуулдаг байна. Хамрах талбайн хувьд хамгийн том нуур бол Их нууруудын хотгорт орших Увс нуур юм. Бусад нуурууд нь уулсын хөндий төдийгүй тал хээр, говь цөлийн бүсэд орших бөгөөд бага хэмжээтэй, их гүехэн устай байдаг.



Голууд нь улс орны умард хэсэгт оршино. Хамгийн томоохон гол бол Сэлэнгэ мөрөн бөгөөд Байгаль нуураар дамжин Хойд мөсөн далайд цутгана. Мөн хойд мөсөн далайд цутгадаг Сибирийн Енисей мөрний зарим жижиг цутгалангууд Монгол улсын баруун хойд хэсгийн уулсаас эх авдаг байна. Монгол орны зүүн-хойд хэсгийн Онон гол нь ОХУ дахь Шилка голоор дамжин, цаашлаад Амар мөрөнд цутгаж Дэлхийн 10 томоохон голын нэгийг бүрдүүлэн Номхон далайн сав газар руу урсана. Баруун Монголын олон тооны голууд Төв Азийн дотогш урсацтай голуудын сав газар руу урсана. Зүүн хэсгийн цөөн тооны зарим голууд далай руу урсахгүй боловч нуурууд руу болон говь цөлийн бүс рүү урсдаг байна.

Монгол орон нь эх газрын, эрс тэс ширүүн уур амьсгалтай, хүйтэн өвөл, богино зунтай. Жилд дунджаар 257 өдөр нартай цэлмэг байх ба голдуу дэлхийн өндөр даралтын орны төвд оршдог. Ихэнх хур тунадас зуны улиралд орж, хамгийн их тунадас нутгийн хойт хэсэгт унаж, жилд дунджаар 200-350 мм хур тунадас ордог бол нутгийн өмнөд хэсэгт маш бага 100-200 мм хур тунадас ордог бол өмнө зүгийн говь цөлийн нутагт жилийн турш бараг тунадас ордоггүй байна.

Монгол орны цаг агаарын онцлог нөхцөл нь маш өндөр хэлбэлзэлтэй, зуны улиралд богино хугацаанд урьдчилан таамаглахын аргагүй хурдан өөрчлөгддөг, хур тунадас, хүйтэн өдөр, цасан шуурга болон хаврын шороон шуургатай өдрийн тооны олон жилийн хэмжээ маш өргөн хэмжээнд хэлбэлздэг байдлаар илэрхийлэгдэнэ. Ийм хувьсамтгай цаг агаар нь иргэд болон мал амьдрахад ихээхэн саад бэрхшээлийг учруулна. Монголын нийт хүн амын гуравны нэг орчим хувь нь бэлчээрийн мал аж ахуйгаас бүхэлдээ хамааралтай, тэдний амьжиргаа нь зөвхөн Монголын хувьд онцгой байгалийн гамшиг болох эдийн засгийн хямрал дагуулаад зогсохгүй хүнсний аюулгүй байдлыг бий болгодог Зуданд олонтоо өртдөг байна. Зуд нь хатуу ширүүн өвлийн цаг агаарын улмаас мал бэлчээрлэх боломжгүй болж өл хоолгүй болон, зарим тохиолдолд хэт хүйтний улмаас осгож олон тооны мал үхэх үзэгдлийг илэрхийлэх Монгол улсад хэрэглэдэг нэр томъёо юм. Хэд хэдэн төрлийн зуд тохиолддог байна, тухайлбал хэт их цас орсоноор мал өвс тэжээлээ олох боломжгүй болж, цасан бүрхүүл дээр мөсөн бүрхүүл тогтсоноор малын туруу гэмтэх үзэгдлийг цагаан зуд гэж нэрлэдэг байна (Бүлэг 14).

Монгол орны ихэнх газар нутаг үргэлжилсэн бус (өндөр өргөрөгт үргэлжилсэн) цэвдэгт хөрсөөр бүрхэгдсэн байдаг нь байшин барилга, зам барих болон уул уурхайн үйл ажиллагаанд ихээхэн хүндрэл бэрхшээл учруулна. Бүх голууд болон цэнгэг устай нуурууд өвөлдөө хөлддөг бол жижиг гол горхи ёроолдоо хүртэл хөлдөнө.

Ихэнх нутгийн жилийн дундаж температур 11 сараас 3 сарын хооронд хөлдөх цэгээс доогуур байдаг бол 10 болон 4 сард хөлдөх цэгийн орчим байна. Өвлийн улиралд шөнийн температур ихэнх жилүүдэд  $-40^{\circ}\text{C}$ -аас доош буудаг бол зуны улиралд хамгийн халуун температур өмнөдийн говь цөлийн бүсэд  $38^{\circ}\text{C}$ , нийслэл хот Улаанбаатар хотод  $33^{\circ}\text{C}$  хүрч халдаг байна.

Улаанбаатар хот нь хойд зүгийн харьцангуй чийглэг нутагт, далайн төвшнөөс дээш 1,351 м өргөгдсөн бүсэд оршино. Жилийн дундаж хур тунадас нь 310 мм, үүний ихэнх нь 7 болон 8 сард ордог байна. Улаанбаатар хотын жилийн дундаж температур  $-2.9^{\circ}\text{C}$  байдаг бол дулаан улирал нь дунджаар 5-8 сарын хооронд үргэлжилнэ.

## **I.2 Хүн ам зүй, нийгэм-эдийн засгийн байдал**

### *Хүн ам*

Монгол улс 2016 оны байдлаар 3.120 сая хүн амтай байна. Нэг хавтгай дөрвөлжин км нутагт 1.99 хүн ноогдож байгаа нь Монгол улсыг дэлхийн хамгийн тархай бутархай оршин суугчдтай улс болгож байна. Гэвч сүүлийн 15 жилийн туршид 2002 оноос хойш улсын нийт хүн ам 20.97 хувиар өсчээ. Мөн энэ хугацаанд хот суурин газрын хүн ам 58.30 хувиас 68.33 хувь болж нэмэгдсэн байна. Энэ нь 1.437 саяас 2.131 сая болж нэмэгдсэн гэсэн үг юм.

Хамгийн том хот нь Улаанбаатар бөгөөд тус хотод 2016 оны байдлаар 1.44 сая хүн буюу нийт улсын хүн амын 46 хувь нь амьдарч байна. Улаанбаатар нь тус улсын соёл, аж үйлдвэр болон санхүүгийн гол төв юм. Мөн уг хот нь улс орны авто зам, мөн ОХУ-ын Сибирийг дайран өнгөрөх төмөр зам болон Хятад улсын төмөр замын системийг холбосон замын сүлжээний төв дээр орших тээврийн чухал зангилаа хот юм.

**Фото зураг 1: Орхон голын хөндийд ундаалж байгаа адуу**

Эмэгтэйчүүдийн хүүхэд төрүүлэлтийн үзүүлэлт 2002 оноос хойш нэмэгдэж, 2016 оны сүүлийн мэдээгээр энэ үзүүлэлт 3.0 байгаа нь Европын холбооны үзүүлэлт болох 1.58, ойрын хөрш ОХУ болон Хятад улсын үзүүлэлт 1.6 –тэй харьцуулбал харьцангуй өндөр байна. 2006 оноос хойш нэмэгдэж байгаа төрөлтийн эзлэх хувь 2014 онд хамгийн дээд хэмжээндээ хүрч 1,000 хүн тутамд 28 болсон бол дараа нь бага зэрэг буурч 2016 онд 25.9 болсон байна.

Хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд 2002-2016 оны хооронд ихээхэн эерэг өөрчлөлттэй (Хүснэгт I.1) байна. Өндөр наслалтын үзүүлэлт энэ хугацаанд эрэгтэй, эмэгтэй иргэдэд аль аль нь 4.8 болон 8.6 жилээр нэмэгджээ. Нас баралтын хувь буурч, мөн нярайн нас баралтын хувь 2002 онд 1,000 амьд төрөлтөд 29.6 байсан бол 2015 онд энэ үзүүлэлт 15.0 болж бараг тал хувиар буурчээ.

*Эдийн засаг*

Монголын уламжлалт эдийн засгийн салбар нь хөдөө аж ахуй, ихэнх нь малд аж ахуй дээр суурилна. Түүнчлэн тус улс нүүрс, зэс, молибден, цагаан тугалга, вольфрам, алт зэрэг эрдэс баялагийн баялаг ордуудтай бөгөөд эдгээр нь улс орны эдийн засгийн хөгжлийн үндсэн хүчин зүйл болдог байна. 2016 оны байдлаар ХАА-ийн салбар ДНБ-ны 11.8 хувийг эзэлж, сүүлийн байгаа мэдээллээр (2015) улс орны ажиллах хүчний 28.45 хувь нь ХАА –ийн салбарт ажиллаж байна. ХАА салбар нь одоо ч гэсэн бэлчээрийн нүүдлийн мал аж ахуйгаас ихээхэн хамааралтай, нийт нутгийн 73.51 хувь нь бэлчээрийн зорилгоор ашиглагдаж байна. Аж ахуйн зорилгоор ашиглаж байгаа мал нь хонь, ямаа, үхэр, адуу, тэмээ юм. Малыг гол нь мах, сүүний зорилгоор өсгөх боловч ямааг ноолуурыг нь ашиглахын тулд өсгөж байна. Таримал ургамлын гол бүтээгдэхүүн нь үр тариа, улаан буудай, арвай, төмс юм.

Уул уурхай нь улс орны эдийн засагт маш чухал ач холбогдолтой. 2016 онд, уул уурхайн салбар ДНБ-ний 20 хувь, экспортын 85 хувь, үндэсний төсвийн нийт орлогын 30 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 70 хувийг эзэлж байна.



Нүүрс нь улс орны гол экспортын бараа юм. Зэсийн уурхай, өндөр үнэ цэнтэй үйлдвэрлэл, зэсийн эцсийн бүтээгдэхүүний үйлвэрлэлийн салбарт Монгол улсын Засгийн газар бусад орны Засгийн газар болон хувийн компаниудтай хамтарсан үйлдвэрийн газрууд байгуулан ажиллуулж байна. Эдгээрээс хамгийн томоохон нь Оюу Толгойн уул уурхайн үйлдвэр бөгөөд 2013 оноос эхлэн зэсийн баяжмал үйлдвэрлэж эхэлжээ. Оюу Толгойн хамтарсан үйлдвэр нь Монгол улсын түүхэн дэхь хамгийн томоохон санхүүгийн төсөл бөгөөд тус үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэх үед уг уурхай нь Монгол улсын ДНБ-ний 30 гаруй хувийг дангаараа гаргана гэсэн тооцоо гаргасан байна.

### *Эдийн засаг*

Монголын уламжлалт эдийн засгийн салбар нь хөдөө аж ахуй, ихэнх нь малд аж ахуй дээр суурилна. Түүнчлэн тус улс нүүрс, зэс, молибден, цагаан тугалга, вольфрам, алт зэрэг эрдэс баялагийн баялаг ордуудтай бөгөөд эдгээр нь улс орны эдийн засгийн хөгжлийн үндсэн хүчин зүйл болдог байна.

2016 оны байдлаар ХАА-ийн салбар ДНБ-ны 11.8 хувийг эзэлж, сүүлийн байгаа мэдээллээр (2015) улс орны ажиллах хүчний 28.45 хувь нь ХАА –ийн салбарт ажиллаж байна. ХАА салбар нь одоо ч гэсэн бэлчээрийн нүүдлийн мал аж ахуйгаас ихээхэн хамааралтай, нийт нутгийн 73.51 хувь нь бэлчээрийн зорилгоор ашиглагдаж байна. Аж ахуйн зорилгоор ашиглаж байгаа мал нь хонь, ямаа, үхэр, адуу, тэмээ юм. Малыг гол нь мах, сүүний зорилгоор өсгөх боловч ямааг ноолуурыг нь ашиглахын тулд өсгөж байна. Таримал ургамлын гол бүтээгдэхүүн нь үр тариа, улаан буудай, арвай, төмс юм.

Уул уурхай нь улс орны эдийн засагт маш чухал ач холбогдолтой. 2016 онд, уул уурхайн салбар ДНБ-ний 20 хувь, экспортын 85 хувь, үндэсний төсвийн нийт орлогын 30 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 70 хувийг эзэлж байна.

Нүүрс нь улс орны гол экспортын бараа юм. Зэсийн уурхай, өндөр үнэ цэнтэй үйлдвэрлэл, зэсийн эцсийн бүтээгдэхүүний үйлвэрлэлийн салбарт Монгол улсын Засгийн газар бусад орны Засгийн газар болон хувийн компаниудтай хамтарсан үйлдвэрийн газрууд байгуулан ажиллуулж байна. Эдгээрээс хамгийн томоохон нь Оюу Толгойн уул уурхайн үйлдвэр бөгөөд 2013 оноос эхлэн зэсийн баяжмал үйлдвэрлэж эхэлжээ. Оюу Толгойн хамтарсан үйлдвэр нь Монгол улсын түүхэн дэхь хамгийн томоохон санхүүгийн төсөл бөгөөд тус үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэх үед уг уурхай нь Монгол улсын ДНБ-ний 30 гаруй хувийг дангаараа гаргана гэсэн тооцоо гаргасан байна.

### Эдийн засгийн хөгжил

Монгол улсын эдийн засаг 1990 –ээд оны сүүл үед хэд хэдэн удаагийн томоохон цохилтод өртжээ. 1996 онд олон удаагийн байгалийн гамшиг тохиолдсон болон дэлхийн зах зээл дээрх зэс, ноолуурын үнэ буурсанаас эдийн засаг зогсонги байдалд оржээ. Улсын төсөв хомсдон экспортын систем задарч, түүний дараа 1998 болон 1999 онд Азийн эдийн засгийн хямрал болсон байна. Эцэст нь 1999 оны 8-9 сард ОХУ нефть, нефтийн бүтээгдэхүүний экспортын түр хориг тавьсаны улмаас улс орны эдийн засаг ихээхэн хохирол амсчээ. ДНБ –ний өсөлт 1996-1999 онуудад дунджаар 3 хувь байсан бол 2000 онд 1 хувь хүртэл унажээ.

Гэвч ДНБ –ний өсөлт 2000- аад оны эхэн үеэс эрчимжиж эхэлсэн байна. ДНБ-ний өсөлт 2002 онд 4.73 хувь байсан бол 2004 онд 10.63 хувь хүрчээ (Зураг I.1). ДНБ-ний жилийн дундаж өсөлт 2004-2008 оны хооронд 9.12 хувь байсан нь зэсийн дэлхийн зах зээлийн үнэ өндөр байсан, мөн тус улсын алтны бүтээгдэхүүн өссөнтэй холбоотой байжээ. Дэлхийн зах зээлийн хямрал 2008 онд Монголыг дахин нэрвэж, 2009 онд улс орны эдийн засаг 1.7 хувь болтлоо унасан байна.


Монгол улсыг инфляцийн бага түвшин бүхий эдийн засгийн хүчтэй, тогтвортой өсөлтөд буцааж оруулахын тулд 2009 оны эхээр Олон улсын валютгийн сангаас 232 сая америк долларын *станд-бай* хөтөлбөрийг хэрэгжүүлсэн нь амжилттай хэрэгжиж Монгол улс хямралаас хурдан гарч банкны салбар бэхжин, төсвийн менежмент сайжирсан байна.

Хүснэгт I.1: Хүн ам зүйн болон эрүүл мэндийн үзүүлэлтүүд, 2002–2016

	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Хүн ам (сая)	2,466	2,495	2,522	2,551	2,583	2,620	2,666	2,716	2,761	2,812	2,868	2,930	2,996	3,058	3,120
Төрөлтийн хувь (1,000 хүн тутамд)	19.1	18.4	18.1	17.8	19.0	21.7	24.1	25.7	23.1	25.1	26.0	27.5	28.0	27.1	25.9
Хүүхэд төрүүлэлтийн нийт үзүүлэлт	2.1	2.0	2.0	1.9	2.1	2.3	2.6	2.8	2.1	2.6	2.7	3.0	3.1	3.0	3.0
Дундаж наслалт (жил)	63.5	63.6	64.6	65.2	65.9	66.5	67.2	68.0	68.1	68.3	68.7	69.1	69.6	69.9	69.6
Эмэгтэйчүүдийн дундаж наслалт (жил)	66.5	66.5	67.8	68.6	69.4	70.2	71.0	71.8	72.3	73.8	74.3	75.0	75.5	75.8	75.1
Эрэгтэйчүүдийн дундаж наслалт (жил)	60.8	60.8	61.6	62.1	62.6	63.1	63.7	64.3	64.9	64.7	64.9	65.4	65.9	66.0	65.6
15 хүртэлх насны иргэдийн эзлэх хувь	32.6	32.6	32.6	32.6	28.5	28.5	28.1	27.6	27.2	27.6	27.0	27.3	28.0	29.5	30.0
65-аас дээш насны иргэдийн эзлэх хувь	3.5	3.5	3.5	3.5	4.1	4.1	4.1	4.0	3.9	3.8	3.8	3.8	3.9	3.7	3.7
Нас баралтын хувь (1,000 хүн тутамд)	·	·	·	·	·	·	·	·	6.7	6.9	5.9	·	5.7	5.8	5.6
Нярайн нас баралтын хувь (1,000 хүн тутамд)	29.6	23.0	22.3	20.7	19.1	17.6	19.4	20.0	20.2	16.5	15.5	14.6	15.1	15.0	·

Эх үүсвэр: УСХ, 2017.

Зураг I.1: ДНБ салбараар, өнөөгийн үнээр, 2002–2016, хувь



Эх үүсвэр: УСХ, 2017.

ДНБ 2010 онд дахин өсөх замдаа орж 2011 онд ДНБ-ний өсөлт хамгийн өндөр үзүүлэлт болох 17.29 хувьд хүрчээ. Бараа бүтээгдэхүүний экспортоор бэхжиж, улсын төсвийн зарцуулалт өндөр байсан нь эдийн засгийн жилийн өсөлт 2013 он хүртэл 10 хувиас дээш байсан байна. Энэ үеэс эхлээд дэлхий эдийн засгийн удаашрал уул уурхайн аж үйлдвэрлэлд нөлөөлөн, ялангуяа Монгол улсын экспортын гол зах зээл болох Хятад улсад өсөлт буурсан нь Монголын экспортод суурилсан экспортод нөлөөлж эхэлжээ. Иймд ДНБ-ний өсөлт 2011 оноос буурч, хамгийн сүүлийн мэдээгээр (2016) ДНБ-ний өсөлт маш сул буюу 0.98 хувь болсон байна.

2002 оноос хойш, Хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляцийн үзүүлэлт 0.5 – 25 хувийн хооронд хэлбэлзэж иржээ. Инфляцийн хамгийн өндөр үзүүлэлт 2008 онд 25.06 хувь байсан бол 2009 онд 6.28 хувь болж буурсан байна. 2009 оноос хойш хоёр удаа 2012 болон 2014 онд 14.98 болон 13.02 хувь болж хамгийн өндөр хэмжээтэй байжээ. Гэвч, хамгийн сүүлийн 2016 оны хэрэглээний үнийн индекс маш бага буюу 0.55 хувь байсан байна.

Олборлох аж үйлдвэрт оруулж байгаа гадаадын шууд хөрөнгө оруулалт нь Монгол улсын эдийн засгийг уламжлалт мал аж ахуй, хөдөө аж ахуйгаас хамааралтай байдлаас экспортоос хамааралтай эдийн засагт шилжүүлж байна. Өнөөгийн байдлаар, бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээний экспорт нь ДНБ-ний 50 гаруй хувийг эзэлж байгаа бол экспортын орлогын 44.37 хувь нь зэсийн баяжмал, алт болон нүүрсний бүтээгдэхүүн зэрэг олборлох үйлдвэрийн бүтээгдэхүүн эзэлж байна. Түүнчлэн Монгол улс нь нийт экспортын 74.76 хувийг эзэлж байгаа Хятадтай хийх худалдаанаас ихээхэн хамааралтай байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь олборлох аж үйлдвэрийг хөгжүүлэхэд маш чухал үүрэгтэй тул энэ хөрөнгө оруулалт хэлбэлзэх нь нийт улсын эдийн засгийн хөгжлийг тодорхойлж байна. Монгол улс 2009-2012 оны хоорондох дөрвөн жилд Гадаадын шууд хөрөнгө оруулалтаар 12,594 тэрбум америк долларын хөрөнгө татаж чаджээ. 2011 онд энэхүү том хэмжээний хөрөнгө оруулалтын урсгал нь ДНБ-ний 43.91 хувийг эзэлж байсан бол 2015 онд энэ эрчимтэй хөрөнгө оруулалтын урсгал зогсч, ДНБ-ний 0.8 хувийг эзлэх болтлоо буурсан байна.

Гадаадад, ялангуяа БНСУ-д олноор ажиллаж байгаа ажилчдын шилжүүлж байгаа хөрөнгө мөнгө ДНБ-д тодорхой хэмжээг нь эзлэх болсон байна. 2002-2015 оны хооронд энэхүү хөрөнгийн шилжүүлэг нь дунджаар ДНБ-ний 4.05 хувийг эзэлж байсан байна. Гэвч энэхүү хөрөнгөний ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2016 онд огцом буурч 2.33 хувийг эзэлж байна.

Ажилгүйдлийн түвшин харьцангуй бага хэмжээнд хэлбэлзэж байна. Ажилгүйдлийн хамгийн өндөр түвшин 2012 онд ажиглагдаж 8.23 хувь хүрсэн тэр үед ДНБ-ний өсөлтийн хэмжээ өндөр, 12.32 хувь хүрч байжээ. Ажилгүйдлийн түвшин нь 2006 онд хамгийн доод хэмжээдээ хүрч 3.20 хувь байжээ. 2002-2016 оны үед, жилийн дундаж ажилгүйдлийн түвшин 6.28 хувь байсан бол хамгийн сүүлийн үзүүлэлт (2016) 6.69 хувь байна.

Ядуурлын түвшин 2008 оноос хойшхи хугацаанд тогтвортой байсан бөгөөд дараа нь 2013 он хүртэл нэмэгдэх байдалтай байжээ. Улсын хэмжээний ядуурлын түвшингөөс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь 2007 онд 21.4 хувь эзэлж байсан бол 2012 онд 21 хувь болж бага зэрэг буурчээ.

### *Хүйсийн асуудал*

Монгол улс Эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн ялгаварлан гадуурхахын эсрэг Конвенцид 1981 онд нэгдэн орж, 8 болон 9 дүгээр хугацаат тайлангаа 2014 онд гаргаж өгсөн байна.

Мянганы хөгжлийн зорилтуудыг 2005 онд баталсанаар УИХ нь ажил эрхлэлт, боловсрол, улс төрийн үйл ажиллагаанд оролцох, эрүүл мэнд зэрэг асуудлаар хүйстэй холбоотой бодлогын зорилтуудыг тогтоож, МХЗ-уудад суурилсан 2008-2021 онуудад хэрэгжих Үндэсний хөгжлийн цогц бодлогыг батлах, ТХЗ-уудын зорилгуудад хүрэх явдлын баталгаажилтыг ханган ажиллаж байна. Энэхүү стратеги нь Парламентийн сонгуульд өрсөлдөх эмэгтэй нэр дэвшигчдийн тоог нэмэгдүүлэх, хүйсийн тэгш байдлын тухай тусгай хууль батлах, хүйсийн тэгш байдлын асуудлыг бүх шатны боловсролтой уялдуулах, эд хөрөнгөд эмэгтэйчүүд тэгш эрхтэй байх явдлыг хангах зэрэг үүргийг баталгаажуулсан

байна. Энэхүү стратегийг 2016 онд батлагдсан Монгол улсын тогтвортой хөгжлийн алсын хараа 2030 –аар батлагдажсан байна (Бүлэг 1).

Хүйсийн тэгш байдлыг хангах тухай 2011 оны хууль нь бүх салбарт хүйсийн тэгш байдлыг хангах талаарх төрийн байгууллагуудын үүрэг хариуцлагыг зохицуулж байна. Хууль батлагдсанаар цаашдын чухам алхам хийсэн байна. Учир нь 2011 оноос өмнө Монгол улс хүйсийн тухай тусгай хуульгүй байсан байна. Хүйсийн тэгш байдлыг хангах тухай 2011 оны хуулийг хэрэгжүүлэх 2013–2016 онуудад хэрэгжих Дунд хугацааны стратеги болон Үйл ажиллагааны төлөвлөгөө 2016 онд батлагджээ. 2015 оны Эүүгийн хууль, 2002 оны Иргэний хууль, 1999 оны Хөдөлмөрийн тухай хууль, 2016 оны Хүчирхийллийн эсрэг хууль, 2011 оны Эрүүл мэндийн тухай хууль, 2002 оны Боловсролын тухай хууль зэрэг салбарын олон тооны хуулиуд хүйсийн тэгш байдлын талаар хүлээх үүрэг хариуцлагыг баталгаажуулсан байна.

НҮБХХ-ийн 2016 оны Хүйсийн тэгш бус байдлын 2015 оны индекс 0.278 болж Монгол улс нь 188 орноос 53 дугаарт оржээ. Тэгвэл Дэлхийн эдийн засгийн форумын Хүйсийн орхигдлын илтгэлд Монгол улс 0.705 балл авсанаар 144 орноос 58 дугаар байрт оржээ.

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн байгууллагын Нийгмийн байгууллагууд болон Хүйсийн индекс нь нийгмийн байгууллагууд дахь хүйсийн тэгш бус байдлын түвшинг 0 – 1 (өндөр утга нь хүйсийн тэгш бус байдал өндөр байгааг илэрхийнэ)–ийн хооронд хэлбэлзэх 5 дэд индексийн жинлээгүй дундаж үзүүлэлтээр гаргадаг. Энэхүү үзүүлэлтийн утга Монгол улсын хувьд 0.0345 гарсан нь нийгмийн байгууллагууд дахь хүйсийн ялгаварлан гадуурхах байдал маш бага түвшинд байгаа орнуудын тоонд оруулж байна. Дэд үзүүлэлтүүдийн хувьд Монгол улс нь гэр бүлийн хүрээнд маш бага түвшинд, иргэний эрх чөлөө болон нөөц баялаг болон нийгмийн баялаг хүртэхэд бага хэмжээтэй, харин нийгмийн тэгш оролцоо болон эмэгтэйчүүдийн эсрэг үзлийн хувьд дунд зургийн түвшинд байна.

Дэлхийн банкны Хүйсийн боловсрол олох байдлын харьцааг илэрхийлэх индексийн үзүүлэлтэд Монгол улсад 2002 оноос хойш ихээхэн өөрчлөлт гарч байна. Боловсрол олох түвшингийн хувьд хүйсийн харьцааны ялгаа байсан, одоо ч зарим талаар ажиглагдаж байна. Гэвч эмэгтэйчүүдийн давамгайлах байдал үнэлгээ хийсэн хугацаанд буурсан байна. 2002 оны энэ үзүүлэлт бага сургуульд хамрагдалт 1.01 байгаа бол дунд сургуульд арай илүү 1.19, бүрэн дунд боловсролд 1.78 байсан нь эмэгтэй хүүхдүүд бүх шатны боловсролын түвшинд, ялангуяа ахлах сургуульд илүү давамгайлж байгааг харуулж байна. Нөхцөл байдал 2015 онд өөрчлөгдөж, бага сургуульд суралдцах харьцаа 0.98, дунд сургуульд арай дээгүүр 1.02, бүрэн дунд боловсролын түвшинд 1.38 болсон нь бүрэн дунд боловсрололд эмэгтэй хүүхдүүд давамгайлсан хэвээр байгаа ч 2002 оноос бага зэрэг буурсан байна.

УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл харьцангуй цөөхөн хэвээр байгаа ч 2007 оноос хойш УИХ дахь эмэгтэй гишүүдийн тоо нэмэгдэж иржээ. НҮБ-ын Статистикийн байгууллагын ТХЗ-ийн үзүүлэлтүүдийн дагуу УИХ дахь эмэгтэй хууль тогтоогчдын эзлэх хувь 1997 онд 7.9 хувь байсан бол 2015 онд 14.9 болж нэмэгдсэн байна. Сайдын алба хашиж байгаа эмэгтэйчүүд маш цөөн байгаа ч нөхцөл байдал өөрчлөгдөж байна. 2013 онд болсон Ерөнхийлөгчийн сонгуульд түүхэнд анх удаа эмэгтэй нэр дэвшигч оролцсон (сонгуулийн компани амжилтгүй болсон ч) байна.

### **I.3 Бүтэц зохион байгуулалт, засаг захиргааны хувиарлалт**

Монгол улсын Ерөнхийлөгч нь Төрийн тэргүүн, армийн командлагч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн байна. Ерөнхийлөгчийг бүх ард түмний согуулиар, 4 жилийн хугацаагаар сонгож хамгийн дээд тал нь хоёр удаа сонгогдож болох ажээ. Ерөнхийлөгч Ерөнхий сайдыг санал болгох, УИХ –ыг татан буулгах, хууль санаачлах, хуулинд хориг тавих эрхтэй. УИХ нь Ерөнхийлөгчийн хоригийг гуравны хоёрын олонхийн саналаар хүлээн авахгүй байж болно.

Ерөнхий сайдыг Засгийн газрын тэргүүн байдлаар 4 жилийн хугацаагаар томилно. Ерөнхий сайдыг Ерөнхийлөгч санал болгож УИХ хурал батална. Ерөнхий сайд Засгийн газрын гишүүдээ өөрөө сонгож УИХ-аар батлуулна.

Улсын Их Хурал нь 76 гишүүн бүхий нэг танхимтай парламент юм. Гишүүд нь сонгуулийн 76 тойргоос энгийн олонхийн саналаар сонгогдоно. Сонгуулийн тойрог бүрт бүртгэгдсэн сонгогчдын 50 –иас доошгүй хувь нь саналаа өгсөн тохиолдолд тухайн тойрогт сонгууль хүчин төгөлдөр болно. Парламентийн сонгууль 4 жил тутамд явагдана. УИХ-ын дарга болон дэд даргыг гишүүдийн нээлттэй санал хураалтаар сонгоно.

Шүүх нь анхан шатны, давж заалдах шатны болон дээд шүүх гэсэн гурван шатны шүүхийн системээс тогтох бөгөөд иргэний, эрүүгийн болон захиргааны хэргийн шүүхээс бүрдэнэ.

Дээд шүүх нь Шүүхийн дарга болон 24 гишүүнтэй. Дээд шүүхийн дарга болон шүүгчдийг Ерөнхийлөгчийн санал болгосноор УИХ-аас бүх насаар нь томилох ба Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 14 шүүгч болон шүүхийн ажилтнуудыг томилдог байна.

Үндсэн хуулийн Цэц ажиллаж янз бүрийн баримт бичиг, шийдвэр Үндсэн хуультай нийцэж байгаа эсэхийг хянаж байдаг. Цэц нь дарга болон 8 гишүүнтэй. Цэцийн гишүүдийг томилохдоо Ерөнхийлөгч, УИХ болон Дээд шүүх гурав гурван гишүүнийг дэвшүүлж, УИХ-аас томилно. Шүүхийн даргыг сонгогдсон гишүүдийн дундаас сонгоно. Томилолтын хугацаа 6 жил байна.

Давж заалдах шатны болон анхан шатны шүүхүүд аймаг, сум, сум дундын болон дүүрэг зэрэг орон нутгийн засан захиргааны бүх түвшинд байна. Захиргааны хэргийн шүүхүүд нь бүх засаг засаг захиргааны түвшинд хуваагдана.

Засаг захиргааны хувьд Монгол улс нь 21 аймаг болон нийслэл хот Улаанбаатарт хуваагдана (Хавсралт IV, Газрын зураг 1). Аймгууд нь сумдад хуваагдана. Сумд нь хамгийн жижиг засаг захиргааны нэгж болох багуудад хуваагдана (нийт 1,613 баг байна). Эдгээрийн гол ялгаа нь бүх сумд нь өөрийн засаг захиргааны төв болох байнгын суурин газартай байх бол олон баг товлосон төвгүй байна. Улаанбаатар хот нь дотроо 9 дүүрэгт хуваагдаж, дүүрэг нь нийт 152 хороодод хуваагдана.

*ХЭСЭГ I*

*БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗАСАГЛАЛ, САНХҮҮЖИЛТ*





# Бүлэг 1

## **БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО**

### **1.1 Байгаль орчин, ногоон эдийн засаг, тогтвортой хөгжлийн бодлого боловсруулах тогтолцоо**

#### *Хөгжлийн төлөвлөлтийн тогтолцоо*

Монгол улсад хөгжлийн төлөвлөлтийн тогтолцоог цогц байдлаар зохицуулдаг эрх зүйн нэгдмэл баримт бичиг 2015 он хүртэл байхгүй, төр засгийн янз бүрийн байгууллагууд хооронд, тэдгээрийн түвшинд өөр өөр арга хэлбэр, хандлагаар тодорхойлж байв. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай 2015 оны хуулиар хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, мониторинг, үнэлгээ хийх, тайлагнах явцыг зохицуулсан байна.

1987-2016 оны хугацаанд төр засгийн хэд хэдэн байгууллага хөгжлийн төлөвлөлтийг хариуцан гүйцэтгэж байв. Энэхүү үүргийг одоо Ерөнхий сайдын дэргэд 2016 оны 8 дугаар сард байгуулагдсан Үндэсний хөгжлийн газар гүйцэтгэж байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай 2015 оны хууль нь урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн тогтолцоог бүрдүүлсэн байна:

- Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал нь 15-20 жилийн хугацаанд хэрэгжих урт хугацааны бодлогын баримт бичиг юм;
- 8-10 жилд хэрэгжих дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт Төрийн бодлого; Бүсчилсэн хөгжлийн бодлого; Аймаг болон нийслэл хотын хөгжлийн алсын хараа зэрэг баримт бичгүүд хамаарна;
- 3-5 жилд хэрэгжих дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр; Аймаг, нийслэл хот, сум, дүүргийн засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр; Үндэсний болон дэд хөтөлбөрүүд; Нийгмийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр зэрэг баримт бичгүүд хамаарна;
- 1 жилийн хугацаанд хэрэгжих богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт улсын нийгэм-эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэл; Аймаг, нийслэл хот, сум, дүүргийн нийгэм эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэл; улсын болон орон нутгийн төсөв зэрэг баримт бичгүүд хамаарна.

Хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт мониторинг хийх асуудал, тухайлбал хэрэгжилтэд хөндлөнгийн аудит заавал зохион байгуулах тодорхой шаардлагатай байдаг. Ерөнхий сайдын ажлын алба нь төр, засгийн газрын мониторингийн мэдээллийн нэгдсэн системийг хариуцаж байна. Төр, засгийн бүх байгууллагад хөгжлийн бодлогын холбогдох баримт бичгүүдэд мониторинг хийх үүрэг бүхий мониторинг, дотоод аудитын нэгж ажилладаг. Засгийн газрын зөвхөн цөөн тооны яамдад тухайн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан мэдээг өөрийн цахим хуудсанд байршуулан нийтийн хүртээл болгодог байна. Ийм сайн туршлагыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны жишээнээс харж болно.

*Ногоон эдийн засаг, тогтвортой хөгжилтэй холбоотой стратегийн баримт бичгүүд*

#### Эхний жилүүд

1990-ээд он, 2000-аад оны эхэн үеийн улсын хөгжлийн алсын харааг тодорхойлсон бодлогын гол баримт бичигт Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал (1996 он); Монгол Улсын 21 дүгээр зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр (1998 он, MAP 21) болон Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (2001 он) зүй ёсоор орно. Монгол Улсын 21 дүгээр зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг НҮБ-

ын Байгаль орчин, хөгжлийн 1992 оны бага хурлын шийдвэрийг үндэслэн боловсруулсан бөгөөд энэ нь байгаль орчныг хамгаалах, дотоодын нөөцөд тулгуурлах зарчимд суурилсан анхны баримт бичиг болсон байна. “Мянганы хөгжлийн зорилтуудаас Тогтвортой хөгжлийн зорилтуудад шилжих нь” сэдэвт 2015 оны үндэсний илтгэлд тэмдэглэснээр эхний жилүүдийн бодлогын эдгээр баримт бичгүүдийг хэрэгжүүлэхэд нэлээд саад бэрхшээл, сорилттай тулгарсан бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн суурь болж чадаагүй байна. Үүнд хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд бус зах зээлийн зарчмыг нэвтрүүлэхэд гол анхаарал хандуулсан, Азийн эдийн засгийн хямрал, макро эдийн засгийн тогтворгүй байдал болон бүтэц зохион байгуулалтын алдаа, үндэсний хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, үнэлгээ мониторинг хийх нэгдсэн тогтолцоо бүрдээгүй зэрэг олон хүчин зүйлс нөлөөлжээ.

### 2008 оны МХЗ-д суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, стратеги

2008 оны МХЗ-д суурилсан, 2008-2021 оныг хамарсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (ҮХЦБС) нь урт хугацааны бодлогын анхны баримт бичиг юм. ҮХЦБ-д ТХЗ-уудыг дэлгэрэнгүй тусгаж, хөгжлийн тэргүүлэх найман тэргүүлэх чиглэл, стратегийн 124 зорилго, 523 арга хэмжээг тодорхойлсон байна. ҮХЦБ нь иргэдийн оролцоо, оролцогч талуудын түншлэл болон төр засгийн тайлагнах зарчмыг эрхэмлэсэн байна.

ҮХЦБ-ын тэргүүлэх 6 чиглэлд:

- Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, монгол хүнийг бүх талаар хөгжүүлэх;
- Экспортын баримжаатай, хувийн хэвшилд түшиглэсэн өндөр технологи, үүний дотор мэдээлэл, харилцаа холбоо, био болон нанотехнологи, дамжин өнгөрөх тээвэр, логистик, санхүүгийн зуучлалын үйлчилгээ, уул уурхай, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг гүн боловсруулахад суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж, тогтвортой, мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгох;
- Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын орд газруудыг ашиглан хуримтлал бий болгож, эдийн засгийн эрчимтэй, өндөр өсөлтийг ханган, орчин үеийн боловсруулах салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Бүс нутаг, дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгах;
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон арга хэмжээ, чадавхи бий болгохыг дэмжих, экосистемийн тэнцвэрт байдлын алдагдлыг багасгах, хамгаалах замаар хөгжлийн тогтвортой орчин бий болгох;
- Улс төрийн ардчилсан тогтолцоог боловсронгуй болгож, авлига, хүнд суртлаас ангид, ил тод, хариуцлагатай, шударга тогтолцоог бүрдүүлэх.
- ҮХЦБ-ын байгаль орчинтой холбоотой тэргүүлэх чиглэлд:
- Байгаль, хүрээлэн буй орчинд учруулсан хохирлын эдийн засгийн үнэлгээнд үндэслэн нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлэх;
- Улаанбаатар хот, бусад томоохон хотуудын агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;
- Тусгай хамгаалалттай байгалийн бүсүүдийн сүлжээг өргөжүүлэх, тэдгээрийн захиргааны бүтцийг боловсронгуй болгох;
- Олон улсын стандартад нийцсэн байгаль орчны мониторингийн тогтолцоо бий болгох;
- Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтөд дасан зохицох чадавхийг дээшлүүлэх, тэдгээрийн сөрөг үр дагаврыг бууруулах.

ҮХЦБ-ыг хоёр үе шаттай (2007-2015, 2016-2021 он) хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч 2030 он хүртэлх Монгол Улсын тогтвортой хөгжлийн алсын харааг 2016 онд баталснаар энэхүү хүчин төгөлдөр үйлчлэхээ зоссон байна.

Улсын хэмжээний хөгжлийн төлөвлөлт, мониторинг үнэлгээний боловсронгуй тогтолцоо бүрдүүлэхэд ҮХЦБ чухал үүрэг гүйцэтгэжээ. ҮХЦБ-д МХЗ-уудын ололтод үнэлгээ хийх үзүүлэлтүүд, ҮХЦБ-ыг хэрэгжүүлэхэд түлхэц өгөх үндэсний болон орон нутгийн хөтөлбөрүүдийн жагсаалт, тайлагнах тодорхой шаардлагуудыг тусгасан байдаг.

ҮХЦБ-ын хэрэгжилтэд хийсэн 2011 оны үнэлгээнд түүнийг урт хугацааны хөгжлийн гол, суурь баримт бичиг болохыг дутуу ойлгож байгааг тэмдэглэсэн байна. Түүнчлэн ҮХЦБ-ын 2014 оны үнэлгээний тайланд уг бодлогын цөөн зорилт бүрэн биелж, бусад зорилтуудыг хэрэгжүүлэхэд олон саад бэрхшээл, сорилттай учирч байна гэж дүгнэсэн байна. “Мянганы хөгжлийн зорилтуудаас Тогтвортой хөгжлийн зорилтуудад шилжих нь” сэдэвт 2015 оны үндэсний илтгэлд дараах асуудлуудыг онцолсон байна:

- Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Нийгэм-эдийн засгийн хөгжлийн жил тутмын чиглэл, салбарын болон салбар дундын хөгжлийн бодлого зэрэг дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд өөр хоорондоо зохицоогүй, тэдгээрийг ҮХЦБ-той уялдуулаагүй;
- ҮХЦБ-ыг хэрэгжүүлэхэд яам хоорондын зохицуулалт сул, салбар хоорондын зарим зорилтыг орхигдуулсан;
- Улс төрийн намуудын сонгуулийн хөтөлбөрийг ҮХЦБ-ын зорилтуудтай уялдуулаагүй байна.

#### 2010 оны Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

2010 оны Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд (УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоол) экологийн аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэсэг хэмээн тусгаж, хүний үндсэн хэрэгцээг байгалийн сэргээгдэх нөөцийн хэмжээний хүрээнд ашиглах зарчмыг баримтлах, огт сэргээгдэхгүй, удаан сэргээгдэх нөөцийг улсын хөгжлийн нэмэлт хүчин зүйлээр тооцохыг заасан байна.

#### 2012 онд баталсан 2012-2016 оны Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр

2012 онд баталсан Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт (УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол) ажил, орлоготой монгол хүн; эрүүл монгол хүн; боловсрол, мэдлэгтэй монгол хүн; монгол хүний амьдрах аюулгүй, таатай орчин бүрдүүлэх; эрх чөлөөт монгол хүн зэрэг таван зорилт дэвшүүлжээ. Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт ногоон хөгжлийн бодлогыг улсын хөгжлийн бодлогын нэг үндсэн суурь байхаар тусгасан байна.

#### 2014 оны Ногоон хөгжлийн бодлого, Ногоон хөгжлийн бодлогыг 2016-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2016 онд баталсан)

2012 оны Рио+20 бага хурлын шийдвэрийг үндэслэн Монгол Улсад Ногоон хөгжлийн бодлогыг 2014 онд баталжээ (УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоол). Уг бодлогын зорилго нь ногоон хөгжлийн эзэл баримтлал нь улсын бодлогын суурь байх зарчмыг хангах явдал байв. Энэ нь эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангах, байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зарчимд суурилсан амьжиргааны нөхцөл, чанарыг сайжруулахын тулд тухайн үеийн “Өсөлтийг эхлээд хангаж, үр дагаврыг дараа нь зохицуулах” хандлагыг өөрчлөх бодлого болохыг тодорхойлсон байна.

Засгийн газар 2016 онд Ногоон хөгжлийн бодлогыг 2016-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна (Засгийн газрын 2016 оны 35 дугаар тогтоол). Энэхүү төлөвлөгөө нь ногоон эдийн засгийн талаарх дэлхий дахины мэдлэг туршлагыг Монгол Улсын хөрсөнд буулгахад чухал ач холбогдолтой байв. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд бодлогын стратегийн 6 зорилт, 51 зорилгын хүрээнд 255 арга хэмжээг 2020, 2030 он хүртэл хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тодорхойлсон (Зураг 1.1).

НҮБ-ын системийн хүрээнд ногоон эдийн засгийн үйл ажиллагааг зохицуулах, улс орнуудад ТХЗ-д хүрэх, хэрэгжилтэд нь хяналт мониторинг хийхэд нь дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн механизм болох Ногоон эдийн засгийн үйл ажиллагааны түншлэлд (НЭЗҮАТ, PAGE) Монгол Улс 2013 оноос оролцож байна. Энэ түншлэлийн хүрээнд Монгол улс ногоон хөгжлийн бодлогод үнэлгээ хийх, ногоон хөгжлийн шалгуур үзүүлэлтүүд, арга хэмжээг хэрэгжүүлэх, ногоон ажлын байр, ногоон барилга байгууламж, төрийн тогтвортой худалдан авалт, хог хаягдлын менежмент, тогтвортой санхүүжилт, ногоон эдийн засагт суралцах, Монгол улс ногоон эдийн засагт шилжихэд худалдааны боломжийг нээхэд чухал алхамууд хийсэн байна. Өөр нэг чухал үр дүн бол ногоон хөгжлийн бодлогын (Бүлэг 3) хэрэгжилтийн

явцыг үнэлэхэд чиглэсэн ногоон хөгжлийн 38 шалгуур үзүүлэлтийг Үндэсний Статистикийн Хорооноос 2017 оны 7 дугаар сард баталсан явдал юм.

### 2016 онд баталсан 2030 он хүртэлх Монгол Улсын тогтвортой хөгжлийн алсын хараа

2016 онд батлагдсан 2030 он хүртэлх Монгол Улсын тогтвортой хөгжлийн алсын хараа (ТХАХ) нь урт хугацааны үндэсний хөгжлийн бодлогын баримт бичиг болохын хувьд ҮХЦБ-ыг орлон гарсан байна. Энэхүү баримт бичигт Тогтвортой хөгжлийн зорилтуудын (ТХЗ) зэрэгцээ үндэсний онцлог хүчин зүйл, улсын тэргүүлэх чиглэлүүдийг тусгажээ.

ТХАХ-ны зорилтуудыг 2016-2020, 2021-2025 болон 2026-2030 онд гурван үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Энд тогтвортой эдийн засгийн хөгжил, тогтвортой нийгмийн хөгжил, байгаль орчны тогтвортой байдал, тогтвортой хөгжлийн засаглалын алсын хараа болон зорилгуудыг тодорхойлсон байна.

ТХАХ-ны эдийн засгийн тогтвортой хөгжлийн стратеги нь ХАА, аялал жуулчлал, уул уурхай, аж үйлдвэр, эрчим хүч, дэд бүтцийн салбарууд, бизнесийн таатай орчин, макро эдийн засгийн салбарт төвлөрсөн байна. ТХАХ-ны нийгмийн тогтвортой хөгжлийн стратегид хүртээмжтэй өсөлтийн замаар нийгмийн тэгш байдлыг хангах; үр өгөөжтэй, чанартай, хүртээмжтэй эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлэх; мэдлэгт суурилсан нийгэм байгуулах зорилтуудыг тусгажээ. ТХАХ-ны байгаль орчны тогтвортой байдлын стратегид усны нөөцийн нэгдсэн менежмент, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, экосистемийг хамгаалах асуудалд анхаарал төвлөрүүлсэн байна (Хүснэгт 1.1). ТХАХ-ны ихэнх зорилтуудыг хэрэгжилтийн үе шат бүрийн тодорхой зорилго, дэд зорилгуудыг тодорхойлсон байна. ТХАХ-ны ерөнхий хэрэгжилтийг үнэлэх 20 шалгуур үзүүлэлтийг мөн тусгасан байна (Хүснэгт 1.2).

### 2016 онд батлагдсан 2016-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр

2016-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр нь Ногоон хөгжлийн бодлого болон 2016 оны ТХАХ-нд үндсэндээ суурилсан байна. Хөтөлбөрийн 4 дүгээр бүлэг: Байгаль орчин, ногоон өсөлтийн бодлогод ногоон өсөлтийг дэмжих олон тооны заалтууд орсны дотор байгаль хамгаалалд оролцож буй хувь хүмүүс, орон нутаг, эдийн засгийн нэгж байгууллагуудын боловсрол, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр тусгажээ.


*Байгаль орчинтой холбоотой стратегийн баримт бичгүүд:*

#### Ерөнхий

1997 онд батлагдсан Төрөөс экологийн талаар баримтлах бодлого (УИХ-ын 1997 оны 106 дугаар тогтоол) нь байгаль орчин, тогтвортой хөгжлийн урт хугацааны алсын харааг тодорхойлсон анхны баримт бичиг бөгөөд түүнийг гурван үе шаттайгаар (1997-2000, 2000-2010, 2010-2020 он) хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. “Экологийн тэнцвэртэй байдлын” үзэл баримтлалд суурилсан эл баримт бичигт ХАА, ойн аж ахуй, усны менежмент, түлш ба эрчим хүч, аж үйлдвэр ба үйлчилгээ, геологи, тээвэр, аялал жуулчлал, хот байгуулалт, эрүүл мэнд зэрэг салбарт байгаль орчинд ээлтэй хөгжлийн бодлогын чиглэлүүд, газар, ой, ус, хөрс, ургамал, зэрлэг ан амьтны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах арга хэмжээнүүдийг тусгажээ. Энэхүү бодлогод эдийн засгийн үнэлгээ, байгалийн нөөцийг ашигласны татвар хураамж, нөөцийн үр өгөөжтэй ашиглалт, уламжлалт ёс заншлыг хүндэтгэх, олон улсын хамтын ажиллагааны үр өгөөж, тухайлбал озон задалдаг бодисууд болон уур амьсгалын өөрчлөлтийн талаар дурьдсан байна. Бодлогын хэрэгжилтийн үнэлгээг гаргаагүй байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 03-03 тоот зөвлөмжийн дагуу Агаар, байгаль орчны бохирдлыг 2017-2025 онуудад бууруулах үндэсний хөтөлбөрийг хоёр үе шаттай (2017-2019, 2020-2025 он) хэрэгжүүлэхээр Засгийн газар 2017 оны 3 дугаар сард баталсан байна (Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоол). Хөтөлбөр нь агаарын бохирдлыг бууруулахад голчлон төвлөрсөн хэдий ч ус, хөрсний бохирдол, бохир усны цэвэрлэгээ, хог хаягдлыг менежмент зэрэг асуудлыг мөн хөндсөн байна. Энэ нь үндэсний хөтөлбөр боловч Улаанбаатар хотын байгаль орчны асуудалд ихээхэн анхаарал хандуулжээ.

Зураг 1.1: Ногоон хөгжлийн стратегийн бодлогын зорилгууд, Ногоон хөгжлийн бодлогыг 2016-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө



Эх сурвалж: Ногоон хөгжлийн үнэлгээ, БОАЖЯ, Улаанбаатар хот, 2016 он



### Хүснэгт 1.1: Монгол Улсын тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх алсын хараанд байгаль орчны тогтвортой байдлын талаар тусгасан зарим зорилт, зорилгууд

Зорилт	2020 оны зорилгууд	2030 оны зорилгууд
Эрүүл мэндийн стандартад нийцсэн ундны усны хангамжийг нэмэгдүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжуудын хүртээмжийг сайжруулах.	Хүн амын 80 хувийг аюулгүй ундны усаар хангах, 40 хувь ариун цэвэр, эрүүл ахуйн сайжруулсан байгууламжуудыг ашиглах.	Хүн амын 90 хувийг аюулгүй ундны усаар хангах, 60 хувь ариун цэвэр, эрүүл ахуйн сайжруулсан байгууламжуудыг ашиглах.
Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, үйлдвэрлэл, хэрэглээний нүүрсхүчлийн хийн ялгаралтыг бууруулах.	Сэргээгдэх эрчим хүчийг ашиглаж хүлэмжийн хийн ялгаруулалтыг 2 хувиар бууруулах, нүүрс, занарыг шингэрүүлэх дэвшилтэт технологи нэвтрүүлэх, байгаль орчны менежментийн багц MNS ISO 14001 стандартыг нэвтрүүлэхийг дэмжих, “стандартын гэрчилгээ” бүхий компаниудын тоог нэг дахин нэмэгдүүлэх.	Дэвшилтэт технологи, инновацийг ашигласан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүлэмжийн хийн ялгаруулалтыг өнөөгийн түвшнээс 14 хувиар бууруулах, байгаль орчны менежментийн багц MNS ISO 14001 стандартыг нэвтрүүлэхийг дэмжих, “стандартын гэрчилгээ” бүхий компаниудын тоог 10 дахин нэмэгдүүлэх.
Байгалийн төрх байдал, биологийн олон янз байдлыг хадгалах, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хангах.	Цөлжилтийг сааруулах, тусгай хамгаалалттай бүсийн талбайг нийт нутаг дэвсгэрийн 25 хувьд, ойн талбайг 8.5 хувьд хүргэх.	Цөлжилтийг сааруулах ажиллагааг үргэлжлүүлэх, тусгай хамгаалалттай бүсийн талбайг нийт нутаг дэвсгэрийн 30 хувьд, ойн талбайг 9.0 хувьд хүргэх.
Хот, суурингуудын төлөвлөлтийг сайжруулах, дэд бүтцийн байгууламжуудын чанар болон хүртээмжийг нэмэгдүүлэх, байгаль орчин ба хаягдлын менежментийн чанарыг сайжруулах.	Хот, суурингуудын ногоон байгууламжийн талбайг нийт нутаг дэвсгэрийн 15 хувь хүртэл нэмэгдүүлэх, нийт хог хаягдлын 20 хувийг дахин ашиглах, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бүрмөсөн арилгах.	Хот, суурингуудын ногоон байгууламжийн талбайг нийт нутаг дэвсгэрийн 30 хувь хүртэл нэмэгдүүлэх, нийт хог хаягдлын 40 хувийг дахин ашиглах.

### Хүснэгт 1.2: Монгол Улсын тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх алсын харааны шалгуур үзүүлэлтүүд

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2014)	Зорилтот түвшин (2030)
Эдийн засгийн жилийн дундаж өсөлт	хувь	7.8	6.6 (2016-2030 оны дундаж)
Нэг хүнд ноогдох үндэсний нийт орлого	US\$	4166	17,500
Хүний хөгжлийн индекс	эрэмбэ	90	70
Наслалт	жил	69.57	78
Ядуурлын түвшин	хувь	21.6	0
Дэлхийд өрсөлдөх чадавхийн индекс	эрэмбэ	104	70
Бизнес эрхлэлтийн индекс	эрэмбэ	56	40
Байгаль орчны үйл ажиллагааны индекс	эрэмбэ	111	90
Эдийн засгийн идэвхтэй нийт хүн амд нийгмийн даатгалтай хүмүүсийн эзлэх хувь	хувь	84.4	99
Тэгш бус байдлын Gini коэффициент	оноо	36.5	30
1,000 амьд төрөлт дахь нярайн эндэгдэл	харьцаа	15.1	9
100,000 амьд төрөлт дахь эхийн эндэгдэл	харьцаа	30.6	15
Сургуулийн ахлах ангийн сурагчдын тоо (улсын дундаж)	тоо	27.3	20
Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагаас олон улсын худалдааны зориулалтаар өвчлөлөөс чөлөөт бүсийн статусын гэрчилгээ олгосон газар нутгийн хэмжээ	хувь	0	60
Цөлжилжсөн газар нутгийн хэмжээ	хувь	78.2	60
Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ	хувь	17.4	30
Монголд зорчсон гадаадын жуулчдын тоо	сая хүн	0.392	2
Найдвартай цахилгаанаар хангагдсан өрхийн хувь	хувь	89	100
Нийт экспортод боловсруулах салбарын эзлэх хувь	хувь	17	50
Дотоодын үйлдвэрлэлээс хангасан шатахууны гол бүтээгдэхүүний эзлэх хувь	хувь	0	100

Хөтөлбөрийн зорилгууд нь:

- Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх замаар бохирдлын эх үүсвэрийг багасгах, түүхий нүүрсний ашиглалтыг шат дараатайгаар хориглох замаар бохирдол ялгаруулалтыг хязгаарлах;
- Хот байгуулалт, хөгжлийн зохистой бодлого, төлөвлөлт, дэд бүтэц, орон нутгийн хөгжил, төвлөрлийг багасгах хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, агаар болон байгаль орчны чанарыг сайжруулах;
- Автомашины бохирдуулагч бодис ялгаруулалтыг бууруулах цогц арга хэмжээ авах;
- Агаар болон байгаль орчны бохирдлыг бууруулах зорилгоор удирдлага, менежмент, санхүү, үүрэг хариуцлага, тайлан хяналтын тогтолцоог сайжруулж, эрх зүйн орчинг бэхжүүлэх;
- Байгаль орчны бохирдлыг бууруулахад оршин суугчид, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, эрүүл зан заншлыг дэмжих, байгаль орчны мониторингийн чадавхийг дээшлүүлэх, судалгааг өргөжүүлэх.

Хөтөлбөрт гэр хорооллын байгаль орчны асуудалд онцгой анхаарч, нийслэлийн гэр хорооллын тэлэлтийг хязгаарлах, нийслэл хотруу шилжих хөдөлгөөнийг багасгах, хямд үнэтэй орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэх, зээл олгох замаар гэр хороололд амины орон сууц барих дэд бүтцийг бий болгох, мөн гэр хорооллын айл өрхүүдийг орон сууцанд оруулах (2025 он гэхэд 70,000 өрхийг орон сууцанд оруулах) арга хэмжээ аваар заажээ. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг 2016 оны суурь үзүүлэлттэй харьцуулан гаргах тоон үзүүлэлтүүдийг тодорхойлсон байна.

### Агаар

1999 онд батлагдсан Агаарын чанарыг хамгаалах хөтөлбөр (ЗГ-ын 1999 оны 82 дугаар тогтоол), хавсралт үйл ажиллагааны төлөвлөгөө нь 1999-2010 оныг хамруулсан байна. Энэ баримт бичиг нь Улаанбаатар, Эрдэнэт, Дархан, Чойбалсан, Мөрөн, Сүхбаатар болон бусад хотуудын агаар болон байгаль орчны бохирдол, түүний хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөлд анхаарал хандуулсан анхны хөтөлбөрүүдийн нэг юм. Хөтөлбөрт агаар хамгаалалтын үйл ажиллагааны эрх зүй болон зохицуулалтын орчинг бүрдүүлэх; агаарын чанарын мониторинг, хяналт шинжилгээний тоног төхөөрөмжийг сайжруулах, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх; агаар хамгааллын арга хэмжээний нийгэм, эдийн засгийн үндсийг бүрдүүлэх зэрэг гурван гол зорилгыг тусгажээ. Түүнчлэн хөтөлбөрийн хэрэгжилтэд төр засаг, төрийн бус байгууллага, бизнесийн байгууллага, иргэдийн оролцоог хангах шаардлагыг онцолсон байна. Хөтөлбөр нь агаар хамгааллын эрх зүйн тогтолцоог сайжруулах, агаарын бохирдлын талаарх олон нийтийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр оруулжээ.

Агаар, байгаль орчны бохирдлыг 2017-2025 онуудад бууруулах Үндэсний хөтөлбөрийн агаарын чанартай холбоотой заалтууд нь түүхий нүүрсийг дулааны цахилгаан станцуудаас бусад зорилгоор ашиглахыг хориглох, гэр хорооллыг сайжруулсан түлшээр хангахыг дэмжих, агаарын бохирдолтой тэмцэх сан байгуулах (үнэн хэрэгтээ санг сэргээн байгуулах), агаарын чанарын мониторингийг өргөжүүлэх, гэр хороололд агаарын бохирдлын мониторинг хийх болон бусад асуудлыг хамруулсан байна.

### Уур амьсгалын өөрчлөлт

Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хөтөлбөрийн (УИХ-ын 2011 оны 2 дугаар тогтоол) зорилго нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой чадавхийг бий болгох, дасан зохицох арга хэмжээг тодорхойлоход оршиж байв. Түүнд бүтэц зохион байгуулалт, хууль эрх зүй, санхүү, чадавхи, боловсрол, олон нийтийн мэдлэг мэдээлэл, судалгаа шинжилгээний зэрэг олон асуудлыг тусгасан байна. Түүнчлэн уг хөтөлбөрт нийгэм-эдийн засгийн гол салбаруудын дасан зохицох болон хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах стратеги, арга хэмжээг тусгажээ. Хөтөлбөрийн эхний үе шатыг (2011-2016 он) хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2011 онд баталсан бөгөөд түүнд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах үндэсний чадавхийг бэхжүүлэх, эрх зүй, бүтэц зохион байгуулалт, менежментийн тогтолцоог бүрдүүлэх, ард иргэд, олон нийтийн оролцоог хангах асуудлыг хамруулсан байна.

Хоёр дахь үе шатанд (2017-2021 он) уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах үйл ажиллагааг эхлүүлэхээр заажээ. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үндсэн зарчмууд нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үйл ажиллагааг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, тогтвортой хөгжил, ногоон өсөлтийн

зорилготой уялдуулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахад шинжлэх ухааны хамгийн дэвшилтэт, байгаль орчинд ээлтэй техник технологийг нэвтрүүлэхэд суурилсан байна. 2017 оны байдлаар хөтөлбөрийг Зорилтот үндэсний хувь нэмрийн (ЗҮХН, INDC) зорилгуудтай уялдуулах шаардлагатай болж байна.

Бүтэц зохион байгуулалтын хүчтэй механизм бүрдээгүй явдал хөтөлбөрийн хэрэгжилтэд ихээхэн сөргөөр нөлөөлж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг хариуцсан салбар дундын зохицуулах алба байгуулсан хэдий ч тэр нь удахгүй ажиллагаагаа зогсоосон байна. БОАЖЯ-ны Уур амьсгалын өөрчлөлт, Олон улсын хамтын ажиллагааны газар нь үнэн хэрэгтээ уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудал болон зохицуулалтын талаар идэвхтэй ажиллахгүй байна. Иймд уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг хариуцсан өндөр түвшний үндэсний хороо байгуулах шаардлагатай байна.

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах стратеги нь (Эрүүл мэндийн сайдын 2011 оны 404 тоот тушаал) эрүүл мэндийн салбарт дасан зохицох арга хэмжээг онцлон тусгажээ.

2016 онд батлагдсан ТХАХ-нд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой зорилгыг хүлэмжийн хийн ялгаруулалтыг 2020 гэхэд 2 хувиар, 2030 он гэхэд 14 хувиар бууруулна гэж тодорхойлжээ.

### Озоны давхрага

1999-2030 оныг хамрах Озоны давхрагыг хамгаалах Үндэсний хөтөлбөр (ЗГ-ын 1999 оны 129 дугаар тогтоол) нь таван үе шаттай, сүүлчийн үе нь 2015-2030 оныг хамарч байна. Монреалийн протоколын дагуу Монгол Улс хлор-фтортнүүрстөрөгч (HCFCs)-ийн хэрэглээг бууруулах олон талын сангаас тусламж авч байгаа бөгөөд Засгийн газраас HCFC-ын импорт, экспортын зөвшөөрөл, квотын тогтолцоог хэрэгжүүлдэг байна. HCFC-ыг халах менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дулаан тусгаарлах XPS хавтан үйлвэрлэх үйлдвэрийн өөр дэвшилтэт технологи нэвтрүүлэх асуудал нэлээд бэрхшээлтэй тулгарч байна. HCFC-ын нийт хэрэглээ 2015 онд 0.64 тонн-озон задлах потенциал ын байсан нь Монреалийн протоколоор зөвшөөрөгдсөн хэрэглээний хэмжээнээс доогуур байна

### Цөлжилт

Цөлжилттэй тэмцэх анхны үндэсний төлөвлөгөөг Засгийн газар 1996 онд баталж (ЗГ-ын 1996 оны 169 дүгээр тогтоол) урьдчилан сэргийлэх, мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх арга хэмжээ болон нэгдсэн цогц хандлагын чухлыг онцолсон байна. Төлөвлөгөөг Засгийн газар 2003 онд шинэчлэн (ЗГ-ын 2003 оны 141 дүгээр тогтоол), 2003-2007, 2008-2011 онд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлжээ.

Төлөвлөгөөний хэрэгжилт нь цөлжилтийн талаарх мэдээ мэдээллийг цуглуулах, аймаг, сумдын захиргааны холбогдох санаачилгуудыг бэхжүүлэх, хяналт мониторингийн байнгын тогтолцоо байгуулахад дэмжлэг үзүүлсний зэрэгцээ хэрэгжилтийн явц нь цөлжилтийн сөрөг нөлөөллийг бууруулах чадавхи, нөлөөллийн талаарх олон нийтийн мэдлэг мэдээлэл сул дорой байгааг харуулсан байна.

Цөлжилттэй тэмцэх 2010-2020 онуудад хэрэгжих үндэсний хөтөлбөр нь байгаль орчны тогтвортой байдлыг хангах үүднээс цөлжилт, газрын доройтлоос сэргийлэх, түүнтэй тэмцэх, нөхөн сэргээх арга хэмжээг авах, хөдөө орон нутгийн хүн амын амьжиргааг дээшлүүлэх, дэлхийн ач холбогдол бүхий байгаль орчны үйлчилгээг бий болгох зорилгуудыг агуулжээ. Түүний тэргүүлэх чиглэлүүдэд бүтэц зохион байгуулалтын чадавхийг нэмэгдүүлэх; эрх зүй болон бодлогын тогтолцоог сайжруулах; шинжлэх ухаан, технологийн мэдлэгийг дээшлүүлэх; сурталчилга, мэдлэг мэдээлэл түгээх, боловсролыг нэмэгдүүлэх; анхан шатны түвшин дахь тодорхой үйл ажиллагааг идэвхжүүлэх (Бүлэг 12) асуудлууд хамрагдсан байна. Хөтөлбөр нь хоёр үе шаттай (2010-2015, 2016-2020 он) хэрэгжиж, эхний шатанд цөлжилттэй тэмцэх эрх зүйн орчинг бэхжүүлэх үйл ажиллагаа, чадавхийг бэхжүүлэх, цөлжилттэй тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хоёр дахь шатанд нөхөн сэргээх, цөлжилтийн улмаас доройтсон, эмзэг болсон газар нутгийг сэргээх зорилгуудыг дэвшүүлжээ.

## Ой

2001 онд баталсан Ойн үндэсний хөтөлбөрийн гол зорилго нь (ЗГ-ын 2001 оны 248 дугаар тогтоол) ой хамгаалах үндэсний чадамжийг 2015 он хүртэл нэмэгдүүлэх, ойн үр ашигтай хэрэглээг хангах, ойг нөхөн сэргээхэд оршиж байжээ. 2000 оноос хойш НҮБ-ын ХХААБ, АХБ, Германы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, бусад байгууллагын дэмжлэгээр Монголд ойн салбарт хэд хэдэн төсөл хэрэгжүүлсний дүнд оршин суугчид, оролцоонд суурилсан ойн менежментийг нэвтрүүлсэн байна.

2005 оны Ногоон хүрэм үндэсний хөтөлбөр (ЗГ-ын 2005 оны 44 дүгээр тогтоол) нь монголын говь, тал нутгийн хилийн бүсийг хамруулсан “ногоон бүс” байгуулах зорилготой байв. Ойжуулах үйл ажиллагаа, хүчин чармайлт нь ойн нөөцийн хорогдол тухайн үед эрчимжиж байсныг зогсоох, цөлжилт, элсний нүүдэл, элс болон шороон шуурганаас сэргийлэхэд чиглэгджээ. Хөтөлбөрийн гурван үе шатыг 30 гаруй жилийн хугацаанд хэрэгжүүлнэ. Ойжуулах, цөлжсөн газар нутагт мод тарих үйл ажиллагааг БНСУ-ын Засгийн газрын бодит арга хэмжээ болон санхүүгийн тусламжаар, 2007-2016 онд 10 сая ам.долларын төсвөөр хэрэгжүүлж байна.

Засгийн газрын 2014 онд баталсан Ой арчилгааны үндэсний хөтөлбөрийг (ЗГ-ын 2014 оны 30 дугаар тогтоол) 4 жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба түүний хүрээнд олон жилийн хугацаанд арчлаагүй Монголын ойд их хэмжээний цэвэрлэгээ хийхээр тусгажээ. Хөтөлбөрийг БОАЖЯ-ны харьяа, улсын төсвийн байгууллага болох Ойн судалгаа, хөгжлийн төв голчлон хэрэгжүүлж байна. Монгол улсын нийт 18.3 сая га ойн талбайн 2 сая га талбайг тус хөтөлбөрийн хүрээнд цэвэрлэхээр төлөвлөжээ.

Төрөөс ойн талаар баримтлах 2015 оны бодлого нь (УИХ-ын 2015 оны 49 дүгээр тогтоол) Германы олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран 2014-2015 онд хийсэн ойн улсын хэмжээний олон зорилтот тооллогын үр дүнд суурилж, Монголын ойн экологийн тогтолцоог тогтворжуулах, ойн хорогдол болон доройтлыг зогсоох, ойжуулах, нөхөн сэргээх үйл ажиллагаагаар ойн талбайг нэмэгдүүлэх, ойн тогтвортой менежментийг бүрдүүлэхэд чиглэгдсэн байна. Төрөөс ойн талаар баримтлах бодлогод 2020 он гэхэд ойн талбайг 8.3 хувь, 2030 он гэхэд 9 хувьд хүргэх зорилгыг дэвшүүлжээ. Гол анхаарлыг ойг түймэр, хортон шавьж, өвчин хортноос хамгаалах, санхүүжилтийг нэмэгдүүлэх, үрийн чанарыг сайжруулах замаар ойг нөхөн сэргээх, ойн үндэсний гэрчилгээг нэвтрүүлэх, мод орлуулах түлшийг үйлдвэрлэх, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэхэд хандуулсан байна.

2016 оны ТХАХ-нд ойтой холбоотой зорилгыг тодорхойлж 2020 он гэхэд улсын нийт нутаг дэвсгэрийн 8.5 хувийг, 2030 он гэхэд 9.0 хувийг ойжуулах зорилт дэвшүүлсэн байна.

2017 оны дунд үеийн байдлаар Монгол улсын НҮБ-РЭДД Үндэсний хөтөлбөр болон РЭДД+ Үндэсний стратегийг боловсруулаад байна.

## Биологийн олон янз байдал

Монгол Улсын Биологийн олон янз байдлын анхны үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг 1996 онд боловсруулжээ (ЗГ-ын 1996 оны 163 дугаар тогтоолоор баталсан). Энэ нь биологийн олон янз байдлыг хамгаалахын тулд байгаль орчныг хамгаалах ажлыг үндэсний хөгжлийн төслүүд, нөөц ашиглах асуудалтай уялдуулахыг заасан анхны баримт бичиг юм. Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээг Монголд хоёр удаа, 2002, 2010 онуудад хийсэн байна. Эхний үнэлгээгээр үйл ажиллагааны зохицуулалт сул, энэ нь хэрэгжилтэд ихээхэн сөргөөр нөлөөлж байгааг тэмдэглэснийг үндэслэн уг төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих хороо байгуулж, хэрэгжилтийг түргэсгэхэд дэмжлэг үзүүлэх Засгийн газрын сан бий болгожээ. Хоёр дахь үнэлгээгээр 2010 он гэхэд 1996 онд баталсан төлөвлөгөөний хүрээнд төлөвлөсөн 87 үйл ажиллагааны 96 хувь нь бүрэн хэрэгжсэн, эсвэл дуусах шатандаа байна гэж дүгнэжээ.

Биологийн олон янз байдлын конвенцид оролцогч Талуудын бага хурлын 10 дугаар хуралдаанаар 2010 онд баталсан биологийн олон янз байдлын Айчигийн зорилгуудыг үндэслэн 2015-2025 онуудад хэрэгжих Биологийн олон янз байдлын хоёрдугаар үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг (ЗГ-ын 2015 оны 325 дугаар тогтоол) (Бүлэгт 11) 2012-2015 онд хэрэгжүүлэхээр боловсруулжээ. Төлөвлөгөөнд биологийн олон янз байдлыг хамгаалах, тогтвортой ашиглалтыг хангах стратегийн 4 чиглэлийн хүрээнд 14 зорилт, 29 зорилго, хүрэх 74 үр дүнг тодорхойлсон байна (Бүлэг 11).



Түүнчлэн Засгийн газраас зарим ховордсон амьтан, ургамлыг хамгаалах хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө, тухайлбал (Аргаль хонь хамгаалах үндэсний хөтөлбөр (ЗГ-ын 2012 оны 269 дүгээр тогтоол), Ховордсон ургамлыг хамгаалах, тогтвортой ашиглах үндэсний төлөвлөгөө (ЗГ-ын 2002 оны 105 дугаар тогтоол), 2003-2010 онд Эдлэг шонхор хамгаалах үндэсний төлөвлөгөө (ЗГ-ын 2003 оны 121 дүгээр тогтоол), Агнуурын загас хамгаалах, үржүүлэх үндэсний төлөвлөгөө (ЗГ-ын 2008 оны 267 дугаар тогтоол), Ховордсон, нэн ховордсон амьтан, ургамлыг хамгаалах үндэсний хөтөлбөр (ЗГ-ын 2011 оны 277 дугаар тогтоол) зэргийг баталсан байна. Мөн УИХ-ын тогтоолоор Халиун буга хамгаалах үндэсний хөтөлбөрийг 2000 онд баталжээ. Байгаль орчны асуудал эрхэлсэн яамны түвшинд Ирвис хамгаалах үндэсний хөтөлбөр (Сайдын 2005 оны 195 тоот тушаал), 2007-2010 онд хэрэгжих Бөхөн хамгаалах үндэсний хөтөлбөр (Сайдын 2007 оны 361 тоот тушаал), 2007-2012 онд хэрэгжих Тул хамгаалах үндэсний хөтөлбөрүүдийг (Сайдын 2007 оны 361 тоот тушаал) тус тус баталжээ.

### Тусгай хамгаалалттай газар

Тусгай хамгаалалттай газрын үндэсний хөтөлбөр (УИХ-ын 1998 оны 29 дүгээр тогтоол) нь тусгай хамгаалалттай газрын (ТХГ) сүлжээг өргөжүүлэх, ТХГ-ын менежментийг сайжруулахад ихээхэн хувь нэмэр оруулсан байна. Үндэсний хөтөлбөрийн энхий үе шатыг 1998-2005 онд, хоёрдугаар шатыг 2005-2015 онд, гуравдугаар шатыг 2015 оноос хойших хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Түүний хэрэгжилтийн үнэлгээг тухайн үеийн Байгаль орчны яам ДБХС-гийн Монгол дахь газар хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд 2009 онд хийж, хэрэгжилтийн явцыг “дунд” (2.76 - 5 оноо), хэрэгжилтийн явцыг “хангалтгүй” (1.41 - 4 оноо) байна гэж дүгнэсэн байна. Гэвч хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд улсын ТХГ-ын сүлжээний талбай 2000 онд 21,731 сая га байснаас 2014 онд 27,207 сая га болтол өссөн бөгөөд одоо улсын хэмжээний ТХГ-ын талбай 27,953 сая га-д хүрч, улсын нийт нутаг дэвсгэрийн 17.87 хувийг эзэлж байна. Улсын хэмжээний ТХГ-аас гадна орон нутгийн хамгаалалттай газрууд (ОНХГ) нийт нутаг дэвсгэрийн 13 хувь гаруйг хамарч байна. ТХГ-ын сүлжээний менежментэд учирч буй гол саад бэрхшээл нь сүлжээний тогтвортой санхүүжилт, хяналт шалгалт, мониторинг, менежментийн нэгдмэл хандлагыг нэвтрүүлэх, аялал жуулчлал, ТХГ-ын газар ашиглалт зэрэг асуудлууд байна.

ТХГ-ын шинэ хөтөлбөрийг 2017 онд боловсруулахаар төлөвлөжээ. Шинэ хөтөлбөрт 2030 он гэхэд нийт нутаг дэвсгэрийн 30 хувийг (46.9 сая га) ТХГ-ын сүлжээнд хамруулах зорилт дэвшүүлснийг үндэслэн сүлжээг үлэмж өргөжүүлэх, зохистой менежментээр хангах асуудлыг төлөвлөх шаардлагатай болж байна. Өнөөгийн байдлаар нарийвчлан судалж, ирээдүйд улсын ТХГ-г авах боломжтой нийт 250 газрыг (ОНХГ-ыг оролцуулан) тодорхойлоод байна.

### Ус

2016 оны ТХАХ-нд усны нөөцийн нэгдсэн менежментийг нэвтрүүлэхийг чухалчлан, устай холбоотой хэд хэдэн зорилго, тухайлбал 2030 он гэхэд хүн амын 90 хувийг аюулгүй ундны усаар хангах, 60 хувийг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан сайжруулсан байгууламжуудыг ашиглах боломжоор хангахаар тусгажээ. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт бохир усыг дахин боловсруулах технологийг нэвтрүүлэх, бохир усыг ариутгах татуургын технологи, ногоон бүсийн усалтын зорилгоор ашиглах түвшинд цэвэршүүлэх, бохир усны төв цэвэрлэх байгууламжийн (ТЦБ) шинэчлэлийн ажлыг түргэсгэн шат дараатайгаар хэрэгжүүлэх, цэвэршүүлсэн бохир ус болон гүний усыг аж үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах боломжоор хангах зорилгыг дэвшүүлжээ.

Устай холбоотой бодлогын үндсэн баримт бичиг болох Усны үндэсний хөтөлбөрийг (УИХ-ын 2010 оны 24 дүгээр тогтоол) 2010-2015, 2016-2021 онд хоёр үе шаттай хэрэгжүүлнэ.

Усны үндэсний хөтөлбөрийн стратегийн зорилгуудад: Монгол Улсын усны нөөцийг хамгаалах, цэвэр байдал, байгалийн нөхөн сэргэх чадварыг хамгаалах; усны нөөцийн мониторингийн нэгдсэн сүлжээ байгуулах, шинэ менежмент, мэдээллийн менежментийн технологийг нэвтрүүлэх; усны нөөцийг хуримтлуулахад шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл мэндийн шаардлагад нийцсэн ундны усаар хангах, ХАА, аж үйлдвэрийн усны хангамжийг сайжруулах; усны нөөцийн менежмент, ашиглалтыг сайжруулах, ус ашиглах олон төрлийн хэрэгцээг зохицуулах зорилгоор эрх зүй болон бүтэц зохион байгуулалтын тогтолцоог хөгжүүлэх; чадавхийг дээшлүүлэх; иргэний оролцоог нэмэгдүүлэх, дэвшилтэт технологи ашиглах замаар усны нөөцийг хамгаалах, ашиглах тухай мэдээллийн олон нийтэд түгээх зэрэг асуудлуудыг тусгажээ.

Хөтөлбөрт бүтэц зохион байгуулалтын хөгжил, чадавхийг дээшлүүлэх асуудлыг чухалчлан, голын сав газрын зөвлөлүүд, “Монгол Ус” төрийн өмчит байгууллага байгуулахын чухлыг онцлон заасан байна. Хөтөлбөрийн эхний үе шатны хэрэгжилтийн гол үр дүнд нь 2009-2013 онд усны нөөцийн нэгдсэн менежментийг (УННМ) бий болгох эрх зүйн тогтолцоог бүрдүүлсэн, 2012-2016 онд 169 булаг шандыг сэргээн сайжруулсан, 2014-2016 онд мониторингийн 124 шинэ цэг байгуулсан явдал юм.

Ундны аюулгүй усаар хангах 2008 оны үндэсний хөтөлбөрийн үр дүнд (ЗГ-ын 2008 оны 84 дүгээр тогтоол) зарим аймагт бохир ус цэвэрлэх шинэ байгууламжуудыг барьж, ундны аюулгүй усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг өсгөхөд чиглэгдсэн усны судалгааг хийжээ.

2012 оны Хатан Туул үндэсний хөтөлбөрийн (ЗГ-ын 2012 оны 203 дугаар тогтоол) зорилго нь нийт 50,000 хавтгай дөрвөлжин км талбайг хамарч, Улаанбаатар хотын 7 дүүрэг, 5 аймгийн 37 сумын нутгаар урсдаг Туул голыг хамгаалах, зохистой менежментээр хангахад оршиж байна. Улаанбаатар хотын ус хангамжийн гол эх үүсвэр болох Туул гол нь дутуу, эсвэл огт цэвэршүүлээгүй бохир усаар ихээхэн бохирдсон, өдөрт Туул голд 170,000-аас 190,000 шоо метр дутуу цэвэршүүлсэн бохир ус цутгаж байна. Хөтөлбөрийг 2012-2016, 2017-2020 онд хоёр үе шатаар хэрэгжүүлж, усны чанарыг сайжруулах, усны эх булаг, Туул голд цутгаж буй жижиг гол горхийг хамгаалах ажлыг гүйцэтгэхээр заажээ.

Хатан Туул үндэсний хөтөлбөрийг 2012-2016 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд усны хангамж, байгаль орчны хамгаалал, усны чанарын мониторинг, бохир ус цэвэршүүлэх технологийн шинэчлэл, цэвэршүүлсэн усыг эргэлтэд оруулах асуудлуудыг тусгасан. Туул голын дагуух Улаанбаатар хотын бүх цэвэрлэх байгууламжуудад технологийн шинэчлэл хийгдэнэ. Туул голоос элс, хайрга олборлох ажиллагааг зогсоох, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхээр хөтөлбөрт заажээ. Туул голын сав газрын захиргаа нь Японы Засгийн газрын Ядуурлыг бууруулах сангийн дэмжлэгтэйгээр Туул голыг сайжруулах төслийг 2014 онд хэрэгжүүлжээ. 2017 оны байдлаар Улаанбаатар хотын ТЦБ-д цэвэрлэх хоёрдогч цэвэрлэгээний шинэ нэгжийг барьснаар технологийн шинэчлэл хийгдэж, “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн шинэчлэл” төслийн 2 дахь шатны хүрээнд биологийн шинэ шүүлтүүрийг байгуулсан байна.

2017 оны Агаар, байгаль орчны бохирдлыг бууруулах 2017-2025 онд хэрэгжих үндэсний хөтөлбөрт устай холбоотой дараах арга хэмжээнүүдийг тусгасан байна. Үүнд: Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж болон бусад хотуудын ус цэвэрлэх системүүдэд дэвшилтэт, байгальд ээлтэй технологи нэвтрүүлэх; арьс шир, ноос боловсруулах үйлдвэрүүд, автомашины болон барилгын материалын захуудыг аажмаар хотоос шилжүүлэн гаргах; Туул гол, түүний салаанд хамгаалалттай бүсийн дэглэмийг сахих үйл ажиллагааг хангах; үерийн аюултай бүс болон далангийн орчимд амьдарч буй өрхүүдийг аажмаар нүүлгэн шилжүүлэх бэлтгэл хангахаар заасан байна.

#### Хог хаягдал

Цуглуулсан хог хаягдлын ихэнхийг устгалд оруулж, 93.5 хувийг нь хөрсөөр дарж булшилдаг байна. 2014 оны Ногоон хөгжлийн бодлогод тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн арга хэлбэрийг хөгжүүлэх, хог хаягдлыг бууруулах зорилт дэвшүүлсэн байна.

1999-2010 онд хэрэгжүүлэх хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг 1999 онд баталсан (ЗГ-ын 1999 оны 50 дугаар тогтоол) байна. Түүнийг хэрэгжүүлэхэд олон улсын төслүүд, тухайлбал Япон улсын засгийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны агентлагийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийн тогтолцоог сайжруулах” төсөл ихээхэн хувь нэмэр оруулжээ.

2014-2022 онд хэрэгжүүлэх Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрт (ЗГ-ын 2014 оны 298 дугаар тогтоол) хог хаягдлын менежментийн талаар хэд хэдэн зорилтыг дэвшүүлсэн байна. Тухайлбал, хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах хувь 2013 онд 4.4 хувь байсан бол 2022 онд 12 хувьд хүргэх, мөн хугацаанд эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хогийн цэгийн тоог 3-аас 40 болтол нэмэгдүүлэх зорилтуудыг дэвшүүлжээ. Хөтөлбөрийн эхний үе шатанд (2014-2017 он) хог хаягдлыг бууруулах эрх зүйн тогтолцоог бэхжүүлэх, дэд бүтэц ба санхүүгийн чадавхийг хөгжүүлэх, орон нутгийн ард иргэд, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, хүн амын сэтгэхүй хандлагыг өөрчлөх асуудлыг



дэвшүүлэн байна. Хог хаягдлын менежментийн тухай хуулийг 2017 онд боловсруулж баталсан нь эхний шатны хэрэгжилтийн гол үр дүн болжээ. Хоёрдугаар шатанд (2018-2022 он) хог хаягдлын хорт бодисоор бохирдсон байгаль орчныг нөхөн сэргээх, хаягдлын зохистой менежментийн тогтолцоог бүрдүүлэх зорилтыг дэвшүүлсэн байна. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд хаягдлыг дахин боловсруулах урамшууллын тогтолцоогүй, дахин боловсруулах боломжтой хог хаягдлын ихэнх хувийг албан бус шугамаар цуглуулдаг, дотоодын дахин боловсруулах аж үйлдвэрийн технологийн болон санхүүгийн чадавхи хязгаарлагдмал зэрэг нь 3R (хогийг багасгах, дахин ашиглах, дахин боловсруулах)-ийн тогтолцоог нэвтрүүлэхэд тулгарч байгаа гол саад бэрхшээл, сорилт болж байна.

Эрүүл мэндийн салбарын хог хаягдлын менежментийн стратеги, түүнийг 2009-2013 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (Эрүүл мэндийн сайдын 2009 оны 293 тоот тушаал)-ний дагуу Улаанбаатар хотын Сонгино Хайрхан дүүрэгт эрүүл мэндийн салбарын хог хаягдлын нэгдсэн үйлдвэрийг 2009-2010 онд барьсан; эрүүл мэндийн үйлчилгээний хог хаягдлыг өндөр даралттай уураар ариутгах байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлсэн; 2011 онд Эрүүл мэндийн сайдын тушаалаар эрүүл мэндийн үйлчилгээний хог хаягдлын менежментийн олон тооны журам, зааврыг баталсан байна. ДЭМБ-аас санхүүжүүлсэн хэд хэдэн төслийн хүрээнд эрүүл мэндийн үйлчилгээний хог хаягдлын менежментийн тоног төхөөрөмж, хангалтыг олон эмнэлэг, эрүүл мэндийн төвд нийлүүлсэн байна.

Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенцийг хэрэгжүүлэх улсын хэмжээний төлөвлөгөөг 2006 онд баталж, уг конвенцид химийн шинэ бодисуудыг нэмж оруулсантай холбогдуулан улсын тооллогыг 2013 онд зохион байгуулж, үндэсний хэрэгжилтийн төлөвлөгөөг 2014 онд шинэчлэн баталсан (ЗГ-ын 2014 оны 341 дүгээр тогтоол) байна. Шинэчилсэн төлөвлөгөөнд зохицуулалтын ба хэрэгжилтийн механизмуудыг бэхжүүлэх; удаан задардаг органик бохирдуулагчид (POPs)-ын байгаль орчинд хаягдахыг багасгах, түүний хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах; санамсаргүй эх үүсвэрийн PCDD/F –ийн хаягдлыг багасгах; удаан задардаг органик бохирдуулагч пестицидээр хордсон газрын байршлуудыг тогтоож, эрүүлжүүлэх, “PCB (polychlorinated biphenyl)-ээс чөлөөт улс” болох зорилгуудыг тусгасан байна. Эдгээр үйл ажиллагааг 2014-2020, 2020-2030 онуудад хоёр үе шатаар хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Мөн PCB агуулсан тоног төхөөрөмжийг 2020 он гэхэд ашиглахыг зогсоохоор төлөвлөжээ. 2014-2030 онд үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 520 сая ам.долларын санхүүжилт шаардлагатай байгаа нь дотоодын санхүүжилтийн зэрэгцээ олон улсын санхүүгийн болон техникийн тусламж эрэлхийлэхийг шаардаж байна.

2016 оны ТХАХ-нд хог хаягдалтай холбоотой зорилгыг тодорхойлж 2020 он гэхэд хог хаягдлыг дахин боловсруулалтыг 20 хувьд, 2030 он гэхэд 40 хувьд хүргэхээр заажээ.

Агаар, байгаль орчны бохирдлыг бууруулах 2017-2025 онд хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрт хог хаягдалтай холбоотой дараах арга хэмжээнүүдийг тусгажээ. Үүнд: гэр хорооллын үнс, хатуу хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх дэд бүтцийг сайжруулах, хог хаягдлын эх үүсвэрийн (баглаа боодол, хураагуур, зай, чийдэн, дугуй, тослох материал г.м.) менежментийг зохицуулах хууль тогтоомжийг боловсруулах, батлахаар тусгасан байна.

#### *Байгаль орчинд нөлөөлж болзошгүй салбаруудын хөгжил*

ТХАХ (2016)-нд салбаруудын хөгжлийн ногоон эдийн засаг, байгаль орчны хамгаалалттай холбоотой дараах гурван зарчмыг тодорхойлсон байна. Үүнд:

- Салбар бүрт үйлдвэрлэлийн өндөр чадавхитай дэвшилтэт технологийг ашиглах, инновацийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх;
- Нөөцийн хэмнэлттэй, тухайлбал хүлэмжийн хий, бохирдолын ялгарал багатай үйлдвэрлэлийн арга хэлбэрийг дэмжих;
- Эдийн засаг, нийгмийн бүх салбарт үр ашиг, өгөөжтэй байх зарчмыг хатуу баримтлах.

БОАЖЯ-ыг 2012 онд үндсэн чиг үүргийн яамны статустай болгосон нь бусад яамдаас өөрийн гаргасан шийдвэрийг биелүүлэхийг шаардах эрхийг олгож, байгаль орчны шаардлагыг бусад яамдын бодлоготой уялдуулахад зохих хувь нэмэр оруулсан байна. Гэвч 2012 онд баталсан Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний тухай хуулинд заасан Байгаль орчны стратегийн үнэлгээг салбаруудын

бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөнд огт тусгахгүй байгаа нь байгаль орчны асуудлыг салбарын бодлогод системтэй, цогц байдлаар тусгахад ихээхэн саад бэрхшээл учруулж байна.

### Уул уурхай

Уул уурхайн салбар 2015 оны байдлаар ДНБ-ний 16.1 хувь, төсвийн орлогын 19.6 хувийг бүрдүүлсэн байна. Энэ онд 8,000 гаруй ордоос 1170 уурхайд 80 төрлийн ашигт малтмал олборлож байжээ. Хайгуулын 1,494, олборлолтын 1,835 тусгай зөвшөөрөллийг 2015 оны байдлаар олгоод байна. Хайгуулын зөвшөөрлийн талбай нийт нутаг дэвсгэрийн 0.8 хувь, олборлолтын талбай 8.11 хувийг тус тус эзэлж, зэсийн баяжмал, молибден, нүүрс, алт, хайлуур жоншны баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал зэрэг үндсэн ашигт малтмалыг олборлож байна.

Олон улсын төслүүдийн хүрээнд байгаль орчин, малчин ард иргэдэд уул уурхайн үзүүлж буй нөлөөллийн талаар зарим судалгааг хийсэн боловч төр засгийн байгууллагууд уул уурхайн байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн талаар системтэй үнэлгээг хийгээгүй байна.

Уул уурхайн салбартай холбоотой байгаль орчин, нийгмийн олон асуудлууд үүсээд байна. Улсын хэмжээгээр олон тооны том уурхайнууд ажиллаж, орон нутгийн олон иргэд бичил, хувийн уурхай эрхлэлж байгаа нь малчин ард иргэдийн амьжиргаа, амьдралд ихээхэн нөлөөлж байна. Үүнд уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй шороо тоос, усны нөөц болон бэлчээрийн өөрчлөлт, хомсдол, малчдын шилжин суурьшилт, нүүдэл зэрэг асуудлуудын зэрэгцээ хувиараа олборлолт хийж буй хүмүүсийн хувьд аюулгүй байдал, эрүүл мэнд, нийгмийн нөхцөл хамгийн тулгамдсан асуудал болжээ. Том хэмжээний уурхай, мөн бичил, хувийн олборлолт нь усны нөөцийн хэмжээ, чанарт ихээхэн нөлөөлж байгаа нь байгаль орчны хамгийн ноцтой асуудлыг бий болгож байгаа боловч энэ талаар түүхэн мэдээ баримт байхгүй, хяналт мониторинг хангалтгүй байгаа зэрэг нь уул уурхайн ажиллагааны усны нөөцөд нөлөөлж буй байдлыг үнэлэх, тодорхойлоход хүндрэл учруулж байна. Зам дэд бүтэц байхгүй байгаа байдал, мөн дэлхийн зах зээлийн үнийн хандлагын үндэслэн олон лиценз эзэмшигчид олборлолт явуулахыг хойшуулж байгаа хэдий ч тэд олборлолтоо эхэлбэл байгаль орчинд учруулах нөлөөлөл нэмэгдэх болно. Эдгээр асуудлын олонхийг өнөөгийн бодлогын баримт бичгүүдэд сул анхаарсан байна.

“Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого” (УИХ-ын 2009 оны 45 дугаар тогтоол), Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого (УИХ-ын 2012 оны 65 дугаар тогтоол) нь эдгээр асуудалтай холбоотой бодлогын баримт бичгүүд юм.

Төрөөс ашигт малтмалын салбарт баримтлах бодлогын (УИХ-ын 2014 оны 18 дугаар тогтоол) зорилго нь хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах, ашигт малтмалын олборлолт, боловсруулалт, уул уурхайд инновацийг нэвтрүүлэх, байгальд ээлтэй дэвшилтэт технологи ашиглахыг дэмжих, монголын уул уурхайн аж үйлдвэрийн олон улсын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, түүнчлэн мэргэжлийн аюулгүй байдалтай холбоотой хууль, тогтоомжийг сайжруулах, бичил, хувийн уурхайн олборлолт, хайгуулын болон олборлолтын зөвшөөрөл олгох, бусдад шилжүүлэх, ашигт малтмалын нөөцийн үнэлгээ, алтны олборлолт, маргааныг шийдвэрлэх асуудлыг зохицуулахад чиглэсэн байна.

Ногоон хөгжлийн бодлого (2014)-д уул уурхайтай холбоотой дараах арга хэмжээг тусгажээ. Үүнд:

- Ашигт малтмалын нөөцийн салбарт үр ашигтай, хаягдал багатай технологийг нэвтрүүлэх;
- Уул уурхайн салбарын үйл ажиллагаанд ил тод, хариуцлагатай байх зарчмыг нэвтрүүлэх, байгаль орчны хамгааллыг сайжруулах, нөхөн сэргээх болон дүйцүүлэн хамгаалах механизмуудын үр өгөөжийг дээшлүүлэх замаар хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах;
- Уул уурхайн салбарын орлогоос Хараат бус баялгийн сан байгуулж, урт хугацааны тогтвортой хөгжлийг хангахад зарцуулах;
- Уул уурхайн болон бусад томоохон төслүүдийг хэрэгжүүлэхийн өмнө тэдгээрийн байгаль орчин, соёл, түүхийн өвд учруулж болзошгүй эрсдэл, нөлөөлөлд үнэлгээ, дүгнэлт хийх.

ТХАХ (2016)-нд уул уурхайн салбартай холбоотой доорх 2 зорилгыг тодорхойлсон байна:

- Геологийн салбарын хөгжлийг дэмжих;
- Ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг дэмжих, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.

Хоёрдахь зорилгын хүрээнд байгальд ээлтэй дэд бүтэц, тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлэх, уул уурхайн салбарт дэмжлэг үзүүлэх найдвартай усны хангалтын эх үүсвэрийг бий болгох төслүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулах таатай орчин бүрдүүлэх, ашигт малтмалын олон улсын зах зээлд монголын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх заалт оржээ. Олборлосон ашигт малтмалыг боловсруулах, тухайлбал газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэн боловсруулах үйлдвэр барих, зэсийн баяжмалыг боловсруулах үйлдвэр барихыг дэмжих, Дархан хот, Сэлэнгэ аймагт хар төмөрлөгийн цогцолбор барих нөхцөлийг бүрдүүлэх, шингэн түлш, тослох материалын үйлдвэр барих зэрэг шинэлэг чиглэлийг хөтөлбөрт тусгажээ. Энэхүү баримт бичигт бичил хувийн уурхай, олборлолтын салбарт албан ёсны хоршоолол зохион байгуулах, уурхайг хаах, байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх тухай байгаль орчинтой холбоотой заалтууд оржээ.

Засгийн газар 2017 оны эхээр Алт-2 үндэсний хөтөлбөрийг баталжээ (ЗГ-ын 2017 оны 20 дугаар тогтоол). Өмнө нь Алт болон Алт-2000 хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн байна. Алт-2 үндэсний хөтөлбөрийн гол зорилго нь 2020 он хүртэл алтны үйлдвэрлэлийн урт хугацааны хөгжлийг хангах, олборлолтыг эрчимжүүлэх, эрх зүйн тогтолцоог хөгжүүлэхэд оршиж, түүнд байгаль орчинтой холбоотой заалтууд тусгагдаагүй байна.

НҮБ-ын Хүний эрхийн комиссын ивээл дор явагдсан Монголын бүх нийтийн ээлжит 2 дахь үнэлгээнд (2015 он) хувийн бичил уурхайн олборлолтод мөнгөн ус ашиглах талаар үндэсний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, ингэснээр ажиллагсдын эрүүл мэнд болон байгаль орчныг хамгаалах чиглэлээр гаргасан зөвлөмжийг Монголын тал хүлээн зөвшөөрч хэрэгжүүлсэн байна. Монгол Улс нь мөнгөн ус импортлох, түүнийг ашиглахыг 2007 онд хориглосон хэдий ч хувиараа алт олборлогчид мөнгөн усыг алт ялгахад хэрэглэсээр байна. Мөнгөн усны хэрэглээ буурч байгаа боловч 2017 оны дунд үеийн байдлаар хувийн бичил уурхайд мөнгөн ус ашиглахыг зохицуулах үндэсний хөтөлбөр гараагүй байна.

Уул уурхайн ажиллагаанаас сүйтсэн, эзгүйрсэн газар, тэдгээрийг нөхөн сэргээх асуудалд анхаарсан бодлогын баримт бичиг байхгүй байна. Мөн хувиараа бичил олборлолт хийж байгаа хүмүүсийн асуудалд анхаарч, тэдэнд өөр ажил эрхлэх боломжийг бий болгоход бичлэсэн бодлогын баримт бичиг байхгүй байна.

### Эрчим хүч

Эрчим хүчний салбарын 98 орчим хувийг төр өмчилдөг, зөвхөн сэргээгдэх (голдуу салхины) эрчим хүчний үүсгүүр хувийн эзэмшилд байна. Эрчим хүчний салбарыг үр ашиг багатай, хотын агаарын бохирдолд нөлөөлдөг хэмээн үздэг. Улаанбаатар хотын дулаан, цахилгааны хэрэгцээг өнөөгийн гурван дулааны цахилгаан станц (ТЭЦ-2, ТЭЦ-3, ТЭЦ-4) хангадаг ба ТЭЦ-2 хамгийн их бохирдуулж байгааг харгалзан түүнийг яаралтай зогсоох шаардлагатай байна.

Засгийн газрын мэдээллээр хотын цахилгаан, дулааны өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хуучирсан ТЭЦ-үүд хангаж чадах эсэх нь сэтгэл түгшээж буй асуудал юм. Үүнтэй холбогдуулан ТЭЦ-5-г Улаанбаатарын зүүн хэсэгт барихаар төлөвлөж байна. Улаанбаатараас бусад аймаг, сумдын ихэнх нь дулааны хангамжийн хомсдолтой, дулааныг хуучирсан техник хэрэгслээр, үр ашиг муутайгаар хангадаг. Аймаг, сумдын төвийг цахилгаанаар хангахад үлэмж дэвшил гарсан хэдий ч ихэнх багийн төвүүд цахилгааны сүлжээнд холбогдоогүй хэвээр байгаа.

**Фото зураг 1.1: Заамар сумын Хайлааст баг дахь уурхайчдын тосгон**

Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх зарим алхам хийгдэж байна. Монгол Улс нь салхины болон усны эрчим хүчний үлэмж нөөцтэй, 1999-2010 онд Засгийн газраас “100,000 нарны гэр” хөтөлбөрийг хэрэгжүүлж, айлуудыг нарны эрчим хүчний үүсгүүр, хураагуураар үнэ төлбөргүй хангасан байна. Уг хөтөлбөр амжилттай хэрэгжиж, гэр хороололд нарны үүсгүүрийг одоо болтол ашиглаж байна.

Сэргээгдэх эрчим хүчний 2005 оны үндэсний хөтөлбөрт (2005-2020 он) сэргээгдэх эрчим хүчийг 2010 онд 3-5 хувь, 2020 онд 20-25 хувь болгох зорилгыг дэвшүүлж, түүнийг 2015 оны Төрөөс эрчим хүчний салбарын талаар баримтлах бодлого (УИХ-ын 2015 оны 63 дугаар Тогтоол)- той нэгтгэсэн учир өнөөгийн байдлаар уг хөтөлбөрийг хүчин төгөлдөр гэж үзэх боломжгүй байна.

Ногоон хөгжлийн бодлогод (2014) тусгасан эрчим хүчтэй холбоотой дараах зорилгууд нь 2030 он гэхэд эрчим хүчний үр ашгийг 20 хувь болтол өсгөж салбарын хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах, сэргээгдэх эрчим хүчний нийт эрчим хүчний үйлдвэрлэлд эзлэх хувийг 2020 онд 20, 2030 онд 30 хувьд хүргэх явдал юм.

Ногоон хөгжлийн бодлогыг 2016-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт дараах үйл ажиллагааг тусгасан байна:

- 10-50 МВт-ын хүчин чадалтай нарны станцуудын төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх;
- 50-250 МВт-ын хүчин чадалтай салхины станцуудын төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх;
- Томоохон гол, нууруудад далан босгох, олон зориулалтын усан сангийн цогцолборууд барих (Эг, Сэлэнгэ голуудын сав газарт 550 МВт, Ховд голын сав газарт 150 МВт, Орхон голын сав газарт 100 МВт-ын хүчин чадалтай станц);
- Нэг хүнд ноогдох хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах, цэвэр, дэвшилтэт технологийн шаардлагыг Багануур, ТЭЦ-5, Могойн голын цахилгаан станц зэрэг шинээр баригдах станцуудад нэвтрүүлэх замаар нүүрсээр ажилладаг цахилгаан станцуудын үр ашгийг сайжруулах;
- Байгаль орчны бохирдол, хүлэмжийн хийн ялгаруулалтыг багасгаж, өнөөгийн нүүрсээр ажилладаг ДЦС-ууд, дулааны болон аж үйлдвэрийн шугамыг тогтмол шинэчлэн олон улсын стандартад нийцүүлэх;
- Эрчим хүч, дулааны алдагдлыг бууруулах арга хэмжээ, эрчим хүчний аудитыг тогтмол хийх.



Төрөөс эрчим хүчний салбарын талаар баримтлах 2015 оны бодлого (УИХ-ын 2015 оны 63 дугаар тогтоол) нь Сэргээгдэх эрчим хүчний 2005 оны үндэсний хөтөлбөр, Эрчим хүчний нэгдсэн тогтолцооны 2007 оны үндэсний хөтөлбөрийг орлон гарч, стратегийн дараах зорилгуудыг тодорхойлжээ:

- Эрчим хүчний аюулгүй, найдвартай байдлыг хангах;
- Бүс нутгийн орнуудтай эрчим хүчний чиглэлээр харилцан ашигтай хамтын ажиллагаа тогтоох;
- Эрчим хүчний салбарын хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэн сайжруулах;
- Эрчим хүчний салбарыг хувийн хэвшилд суурилсан, зохицуулалттай, өрсөлдөөнтэй зах зээлд шилжүүлэх;
- Эрчим хүчний салбарт инноваци, дэвшилтэт технологи, эрчим хүчний үр ашигтай, хэмнэлттэй ажиллах бодлогыг нэвтрүүлэх;
- Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчим хүчний салбараас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгаруулалтыг багасгах.

Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогод 2020 он гэхэд хүлэмжийн хийн ялгаруулалтыг 20 хувиар бууруулах, сэргээгдэх эрчим хүчний нийт үйлдвэрлэлд эзлэх хувийг 2023 онд 20 (бусад баримт бичигт 2020 он гэж ташаа оруулсан), 2030 онд 30 хувьд хүргэх зорилгуудыг тодорхойлжээ.

ТХАХ (2016) -нд сэргээгдэх эрчим хүчний нийт үйлдвэрлэлд эзлэх хувийг 2020 онд 20, 2030 онд 30 хувьд хүргэх, түүнчлэн цөмийн эрчим хүчний станц байгуулах бэлтгэл ажлыг хангах, цөмийн эрчим хүчнийг 2030 он гэхэд ашиглаж эхэлнэ гэж эрчим хүчний салбартай холбоотой зорилгыг тодорхойлжээ. Эрчим хүчний үр ашгийн зорилго болох дулааны алдагдлыг 2020 он гэхэд 20, 2030 он гэхэд 40 хувиар бууруулахаар тодорхойлсон байна. ТХАХ-ны нэг үндсэн зорилго нь бүх нийтийг найдвартай эрчим хүчээр хангах, найдвартай эрчим хүчээр хангагдсан өрхийн эзлэх хувь 2014 онд 89 хувь байсан хэмжээг 2030 он гэхэд 100 хувьд хүргэх явдал юм.

Агаар, байгаль орчны бохирдлыг 2017-2025 онд бууруулах 2017 оны үндэсний хөтөлбөрт эрчим хүчтэй холбоотой дараах арга хэмжээнүүдийг оруулсан байна. Үүнд:

- Дулааны цахилгаан станцуудаас бусад хот, суурин газарт түүхий нүүрс ашиглахыг үе шаттайгаар хориглох;
- Гэр хороололд сайжруулсан түлшний хэрэглээг дэмжих;
- Түүхий нүүрсийг орлуулах сайжруулсан түлшний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
- Оргил ачааллын үед гэр хорооллын өрхүүдийн цахилгааны хэрэглээнд 50-100 хувийн хөнгөлөлт үзүүлэх, 2 фазтай тоолуур тавих;
- Нүүрс боловсруулах, баяжуулах, шингэрүүлэх үйлдвэрлэлийг дэмжих;
- Улаанбаатар хотын зөвхөн дулаанаар хангах төхөөрөмжүүдийг устгах;
- Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр, хийн түлшний хангалтын мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх;
- Эрчим хүчний үр ашгийн тухай хуультай холбоотой дүрэм, журам, стандартыг боловсруулах.

Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогод (2009 онд баталсан) цөмийн энергийг энхийн зориулалтаар ашиглах, экспортлох тэргүүлэгч улс болгох зорилгыг дэвшүүлсэн байна.

### Тээвэр

Төмөр замын тээвэр хязгаарлагдмал нутагт үйлчилж, өрсөлдөх чадваргүй, ихээхэн хөрөнгө оруулалт шаарддаг, усан замын тээвэр бараг хөгжөөгүй учир авто замын тээвэр зонхилох үүрэгтэй байна. Авто замын дийлэнх нь шороон зам тул газрын доройтолд (Бүлэг 12) нөлөөлж, тоос үүсэх, шатахууны зарцуулалт нэмэгдэх, автомашины байнгын засвар үйлчилгээ хийлгэх шалтгаан болдог. 2008 онд улсын хот хоорондын нийт 49,500 км замын 2,700 орчмыг хатуу хучлагатай болгосон, 2016 онд 16 аймгийг Улаанбаатартай хатуу хучлагатай замаар холбосноор хатуу хучилттай нийт замын урт нь 7,500 км болсон байна.

ТХАХ (2016)-нд тээврийн салбартай холбоотой гол зорилгыг зам болон тээврийн логистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлж ХАА, аж үйлдвэр, уул уурхайн салбарт үйлчлэх, асфальтан хатуу

хучлагатай замыг нэмэгдүүлэх, олон улсын шаардлагад нийцсэн шатахууны гол төрлүүдийг дотооддоо үйлдвэрлэх, тухайлбал 2020 он гэхэд Евро-4 стандартыг хангасан шатахууны улсын хэрэгцээний 20 хүртэл хувийг, 2030 он гэхэд Евро-5 стандартыг хангасан шатахууны улсын хэрэгцээний 100 хувийг дотоодод үйлдвэрлэхээр тусгасан байна.

2014 оны Ногоон хөгжлийн бодлогод байгальд ээлтэй дэд бүтэц болон тээврийн сүлжээг хөгжүүлэх, “ногоон хот” үзэл баримтлалын хүрээнд хотын нийтийн тээвэр, суурьшилтад анхаарал хандуулсан байна. 2016 оны төлөвлөгөөнд ашигт малтмалын тээврийн асуудлыг байгальд ээлтэй, зохистой байдлаар шийдвэрлэх, төмөр замын сүлжээг цахилгаанжуулах, нийтийн тээврийн хэрэгслийг шинэчлэхийг онцолсон байна. Зам, тээврийн яамнаас байгалийн хийн түлш хэрэглэдэг автобусыг нийтийн тээвэрт түлхүү ашиглах, шингэрүүлсэн хийн хэрэглэдэг автомашин ашиглахыг дэмжих төлөвлөгөө боловсруулжээ. Хотын нийтийн тээврийн автобусны жолооч нарт туршилтаар эко жолооны сургалт зохион байгуулсан байна. Мөн олон жил яригдсан Улаанбаатар хотын метроны төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Хар тугалга агуулдаг зай хураагуурын асуудлыг шийдвэрлэх шаардлага тулгарч байна.

Монгол Улсын Үндэсний зорилтот хувь нэмэр (ҮЗХН, INDC), (Бүлэг 7) баримт бичигт улсын хатуу хучилттай замын сүлжээг өргөжүүлэх, хосолмол хөдөлгүүртэй хувийн автомашины эзлэх хувийг 2014 оны түвшин болох 6.5 хувиас 2030 онд 13 хувь болтол нэмэгдүүлэх, татвар болон байгаль орчныг бохирдуулсаны төлбөр хураамжийг боловсронгуй болгосноор Улаанбаатар болон аймгийн төвүүдэд шингэн шатахуунаас шингэрүүлсэн хийн түлшинд (LPG) түлш хэрэглэдэг автомашинд шилжих, Улаанбаатар хотод шуурхай автобусны үйлчилгээг нэвтрүүлэх, нийтийн тээврийн тогтолцоог сайжруулах асуудлыг тусгасан байна.

Авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 2012-2020 оны үндэсний стратеги, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2012 онд баталж (ЗГ-ын 2012 оны 146 дугаар тогтоол), 2012-2020 оны хооронд зам тээврийн ослын нас баралт, гэмтэл бэртлийг 50 хувиар бууруулах, хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийг сайжруулах, замын хөдөлгөөний төлөвлөлтийг замын сүлжээ, зорчигч болон ачаа тээврийн төлөвлөгөөтэй уялдуулах, автомашины аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөнд оролцогчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, яаралтай тусламжийн чанарыг сайжруулах зорилго тавьжээ.

Энэхүү стратегийн хэрэгжилтийг дүгнэх үндсэн шалгуур үзүүлэлтүүд нь: 10,000 тээврийн хэрэгсэл тутамд ноогдох замын ослын нас баралт 2012 онд 17.5 байсныг 2020 онд 8.8 болтол бууруулах; 10,000 тээврийн хэрэгсэлд замын ослын гэмтэл бэртэлт 2012 онд 48.1 байсныг 2020 онд 24 болтол бууруулах зорилт байна.

ДЭМБ-ын мэдээгээр 10,000 тээврийн хэрэгсэлд замын ослын гэмтэл бэртэлт 2015 онд 39.3 байв. Стратегийг хэрэгжүүлэх явцад Зам тээврийн аюулгүй байдлын тухай шинэчилсэн хуулийг 2015 батлах, 2014-2015 онд зам тээврийн аюулгүй байдлын хэд хэдэн шинэ стандартуудыг нэвтрүүлэх, гол замын дагуух хяналтгүй бүсүүдийн судалгаа хийх зэрэг арга хэмжээг авсан байна. АХБ-ны дэмжлэгтэйгээр 2017-2018 онд зам тээврийн аюулгүй байдлын бодлогын шинэ баримт бичгүүдийг боловсруулж байна.

“Монголоор дамжин өнгөрөх” хөтөлбөр (2008)-ийг 2015 он хүртэл хэрэгжүүлж, түүний хүрээнд төмөр замын тээвэрт цахилгаан зүтгүүр ашиглах боломжийн судалгаа, ТЭЗҮ хийсэн боловч төмөр замыг цахилгаанжуулах ажил төдийлөн хэрэгжээгүй байна. Гэвч хотын хойд чиглэлийн гол өртөөнүүдийн хооронд төмөр замын автобус (рэйлбас) 2015 оноос үйлчлж эхэлжээ. Төмөр замын автобус нь цахилгаанаар ажилладаггүй хэдий ч замын ачааллыг бууруулах хүчин чармайлтын нэг юм.

Агаар, байгаль орчны бохирдлыг 2017-2025 онд бууруулах 2017 оны үндэсний хөтөлбөрт зам тээвэртэй холбоотой дараах арга хэмжээнүүдийг тусгасан байна. Үүнд:

- Гүүрэн замуудыг барих, Улаанбаатарын замын хөдөлгөөний менежментийг сайжруулах;
- Стандартын шаардлагыг хангахгүй тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцохыг хориглох;
- Евро-5 стандартын шатахууны импорт, хэрэглээг дэмжих;
- Стандартын бус шатахууны импортыг үе шаттай хориглох;
- Шатахууны чанарын мониторингийг сайжруулах;
- Нийтийн тээврийн хэрэгслийг хийн түлшинд шилжүүлэх;



- Замын тоосыг зориулалтын техникээр цэвэрлэх;
- Цахилгаан болон шингэрүүлсэн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн импортыг дэмжих;
- Хуучин автомашины импортыг үе шаттайгаар хязгаарлах.

Агаар, байгаль орчны бохирдлыг 2017-2025 онд бууруулах 2017 оны үндэсний хөтөлбөрийн зорилгуудад хийн хөдөлгүүртэй автомашины тоо 2016 онд 14,500 байсныг 2025 онд 25,000 болгох; Евро-5 стандартын шатахууны нийт борлуулалтад эзлэх хувийг (бензин болон дизель) 2019 онд 50, 2025 онд 80 хувьд хүргэхээр тусгажээ.

### Хөдөө аж ахуй

Хөдөө аж ахуйн (ХАА) салбар ДНБ-ний 14 хувийг бүрдүүлдэг. Мал ахуйн (МАА) салбар нь ХАА-н үйлдвэрлэлийн 80 гаруй хувийг эзэлдэг хэдий ч МАА-д эрчимжсэн үйл ажиллагаа хөгжөөгүй, мал сүрэг өргөн уудам нутагт тархсан байна. Малчид усны эх булаг, хот суурингийн ойролцоо төвлөрдөг учир МАА нь бэлчээрийн газарт сөргөөр нөлөөлөх, бэлчээрийн даац хэтэрснээс ургамал ногооны чанар доройтох, усны нөөц хомсдох, хүртээмж багасахад хүргэж байна. Бэлчээр ашигласны татвар төлдөггүй, харин газар ашигласны татвар төлж байна (Бүлэг 3). Мал сүргийн 70 орчим хувийг гар худагаар усалдаг, усны шахуурга цөөн, бэлчээрийн даац хэтрэлтийг багасгах зорилгоор өөр газар шилжин суурьшихын тулд гар худаг болон усны шахуурга шинээр байгуулах шаардлага тулгарч байна. Ялангуяа нэн хуурай уур амьсгалтай говь, зүүн бүст ХАА-г хөгжүүлэхэд ихээхэн хүндрэлтэй. Уул уурхайн компаниуд усны хязгаарлагдмал нөөцийг ашиглаж байгаагаас шалтгаалан гүний усны нөөц хорогдож, говьд МАА-г хөгжүүлэхэд нэлээд бэрхшээлтэй болж байна. Улаанбаатар хотын хувьд арьс шир боловсруулах жижиг үйлдвэрүүд химийн бодистой, зохих ёсоор цэвэршүүлээгүй бохир усыг Туул голд цутгаж байгаагаас усны чанар ихээхэн мууджээ. Усжуулалтын системтэй газар тариалан хөгжөөгүй, хөрсний чанар муудах, тариалангийн талбай багасах нь газар тариалангийн салбарын хамгийн ноцтой саад бэрхшээл болоод байна. Хортон мэрэгч амьтны устгалыг тогтмол хийдэг хэдий ч үр дүн нь жигд бус байна.

1990-ээд оны сүүлч, 2000-аад оноос ХАА-г хөгжүүлэх үндэсний төвийн шугамаар, аймгийн төв дахь хөгжлийн төв, сум дахь бүлгээр дамжуулан малчид, тариаланчдад хөгжлийн үйлчилгээ үзүүлж эхэлсэн боловч санхүүгийн байдлаас шалтгаалан аймаг, сум болгонд нэгж байгуулаагүй байна. Төрөөс малчдын талаар баримтлах 2009 оны бодлогод (ЗГ-ын 2009 оны 39 дүгээр тогтоол) малчдын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийг сайжруулах, нийгмийн даатгалд хамруулах, малчин өрхүүдийг орлогын татвараас чөлөөлөх заалтууд орсны зэрэгцээ бэлчээр газрын үнэлгээг тогтоох боломжоор хангаж өгсөн байна.

ХАА-н үйлдвэрлэлийн зорилгыг 2009 онд баталсан Хүнсний аюулгүй байдлын 2009-2016 оны үндэсний хөтөлбөрт (ЗГ-ын 2009 оны 32 дугаар тогтоол) Монгол улсын хүнсийг органик үйлдвэрлэлийн болохыг тэмдэглэх, хүнсний үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгох, ХАА-д эрүүл ахуйн тэргүүний арга туршлагыг нэвтрүүлэх, хүнсний аюулгүй байдлын мониторингийн хяналтыг сайжруулах, хоол тэжээлтэй холбоотой өвчлөлөөс сэргийлэх, хяналт мониторинг хийхээр тусгасан. 2014 оны мониторинг үнэлгээний тайлан илтгэлд дурьдсанаар хөтөлбөрийн нэгдүгээр шатны (2009-2012 он) хэрэгжилт 78 хувьтай байжээ. Хөтөлбөрийн хүрээнд Органик хүнсний тухай хуулийн төслийг боловсруулж УИХ-аар 2016 онд батлуулжээ. Монголын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын санаачилгаар 2009 онд эхлүүлсэн Органик Монгол хөтөлбөрийн хүрээнд бичил зээлийн хөтөлбөрөөр органик үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан байна.

Монгол улс нь байгалийн болон таримал чацарганы нөөцөөр дэлхийд 5 дугаар байрт ордог. Хоёр үе шаттайгаар (2020-2012, 2013-2016) хэрэгжүүлэх Чацарганы үндэсний хөтөлбөр (ЗГ-ын 2010 оны 60 дугаар тогтоол) нь чацаргааны өрхийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлжээ. Чацаргана нь цөлжилтөөс сэргийлэх, хөрс хамгаалахын зэрэгцээ хүн амыг шаардлагатай витаминаар хангах, чацарганы тосноос зохих орлого олоход хувь нэмэр оруулсан. Хөтөлбөрийн хүрээнд чацарганы үйлдвэрлэл, борлуулалт, тариалалтын талбайг нэмэгдүүлэх, чацаргана боловсруулах үйлдвэр байгуулах, усжуулалтын систем барих, судалгаа болон сургалт зохион байгуулах ажилд зохих санхүүжилт олгосон байна. 2015 оны мониторинг үнэлгээний тайлан илтгэлд зааснаар хөтөлбөрийг 2012-2014 онд хэрэгжүүлэх явцад чацарганы нийт 6 сая бутыг үржүүлж тараасан байна. Засгийн газар саяхан “Жимс, жимсгэнэ” Үндэсний хөтөлбөрийг 2018-2022 онд хэрэгжүүлэхээр баталж (Засгийн газрын 2017 оны 223 дугаар

Тогтоол), чацаргана зэрэг жим жимсгэний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлсэн байна.

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийг 2010 онд баталсан байна (ЗГ-ын 2010 оны 23 дугаар тогтоол). Хөтөлбөр хоёр үе шаттай (2010-2015, 2016-2021 он) хэрэгжиж МАА-н салбарын тогтвортой хөгжлийн эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх; эрчимжсэн МАА-г хөгжүүлэх, эдийн засгийн үр ашиг, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх; доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, өвс тэжээлийн үйлдвэрлэл, хангалтыг сайжруулах замаар МАА-г уур амьсгалын өөрчлөлтийн эрсдлээс сэргийлэх зэрэг зорилгуудыг дэвшүүлжээ. Эрчимжсэн МАА-г хөгжүүлэх тусгай хөтөлбөрийг (ЗГ-ын 2003 оны 160 дугаар тогтоол) 2003-2015 онд хэрэгжүүлжээ.

Цаа бугын аж ахуйг сэргээх, Цаачдын амьдралын түвшинг сайжруулах хөтөлбөр (ЗГ-ын 2007 оны 255 дугаар тогтоол) нь эрүүл мэнд, боловсрол, байгаль орчин, амьжиргаа зэрэг олон салбарын санаачилга, арга хэмжээг хэрэгжүүлэх замаар цаатан иргэдийн хөгжил, чадавхийг дээшлүүлэх зорилгыг тусгажээ. Хөтөлбөрийг 2007-2011, 2012-2015 онд хоёр үе шатаар хэрэгжүүлсэн байна. Цаатан иргэдийн амьжиргааны нөхцөлийг сайжруулах, цаа бугын тоо толгойг нэмэгдүүлэх, Хөвсгөл нуур, улсын хойд бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд Засгийн газраас санхүүгийн тусламж үзүүлсэн байна.

ТХАХ (2016) -нд ХАА-тай холбоотой, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй бэлчээрийн малын удмын санг хадгалах; бэлчээрийн даацтай уялдуулан мал сүргийн зохистой бүтцийг бий болгох; эрчимжсэн МАА-г хөгжүүлэх; усжуулалтын шинэ, бүтээмжтэй технологийг нэвтрүүлэх; газар тариалангийн усжуулалттай талбайг нэмэгдүүлэх; тариан талбайд хаягдалгүй үйлдвэрлэлийн технологийг ашиглах; хөрсний доройтол, элэгдлийг бууруулах; дэвшилтэт технологи нэвтрүүлэх, цахилгаанаар хангах, түрээс, концессийн зээл олгох, санхүүгийн бусад механизмаар малчид, малчдын хоршоо, жижиг, дунд тариалан эрхлэгчдийг дэмжих зэрэг зорилгуудыг тусгасан байна.

### Фото зураг 1.2: Чацаргана



Ногоон хөгжлийн бодлогын (2014) зорилгуудыг биелүүлэхэд ХАА-н чиглэлээр ХАА-н бүтээгдэхүүний хангалтын сүлжээг сайжруулах, ХАА-н бүтээгдэхүүний хадгалалт, баглаа боодлын байгальд



ээлтэй технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн боловсруулалтыг нэмэгдүүлэх, мөн Ногоон хөгжлийн бодлогыг 2016-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд ХАА-н салбарын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратегийг тус тус тусгасан байна.

### Аялал жуулчлал

БОАЖЯ-ны мэдээгээр 2000 онд Монголд гадаадын 137,000 жуулчин ирж, эдийн засагт 95 сая ам.долларын орлого оруулж байсан бол 2016 онд 404,000 жуулчин ирж, 312 сая ам.долларын орлого оруулжээ. Энэ нь 2015 он гэхэд гадаадын жуулчдын тоог 1 сая болгох зорилгод хүрээгүй байна. Монголд ирж буй жуулчдын дийлэнх хувийг Хятад (38 хувь), Орос (18 хувь), Өмнөд Солонгос (12 хувь), Японы (5 хувь) иргэд эзэлж байна.

Аялал жуулчлалын байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн үнэлгээг улсын хэмжээгээр хийгээгүй, зөвхөн зарим ТХГ-т газар ашиглалт зэрэг хязгаарлагдмал үзүүлэлтээр нөлөөллийн үнэлгээг хийжээ. Аялал жуулчлалын салбарт ногоон гэрчилгээ олгох үйл ажиллагаа хэвшээгүй байна.

Аялал жуулчлалыг 2016-2025 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (2016) бол аялал жуулчлалын бодлогыг тодорхойлсон анхны баримт бичиг бөгөөд түүнийг 2016-2020, 2021-2025 онд хоёр үе шаттай хэрэгжүүлнэ. Хөтөлбөрт аялал жуулчлалыг улсын онцлог байдалтай уялдуулан, олон улсын стандартын дагуу хөгжүүлэх, эдийн засгийн тэргүүлэх нэг чиглэл болгох Засгийн газрын бодлогыг тусгажээ. Түүнчлэн эко болон байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалыг дэмжих, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, төлөвлөгөөт бус (саарал салбар хэмээх) жуулчлалын зохицуулалтыг сайжруулах, жуулчлалын анхаарал татсан газрууд руу зам тавих, зохих дэд бүтэц (ус, бие засах газар) бүхий тохилог замын буудлуудын тоог нэмэгдүүлэх, дотоодын жуулчид түймэр тавихаас сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зэрэг үйл ажиллагааг хөтөлбөрт заажээ. Хөтөлбөрийг жилийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж байна.

ТХАХ (2016)-нд эко жуулчлалын бүсүүд, байгаль орчин ба эрүүл мэндийн шаардлагыг хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, Монголын нүүдэлчдийн соёл болон жуулчлалын брэндийг дэлхийд таниулан хөгжүүлэх, 2030 он гэхэд гадаадын жуулчдын тоог 2 саяд хүргэх зорилгыг тодорхойлсон байна.

Эдгээр зорилгыг 2014 оны Ногоон хөгжлийн бодлогод мөн тусгасан ба Ногоон хөгжлийн бодлогыг 2016-2030 онд хэрэгжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөөнд БОАЖЯ-ны удирдлага дор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр заажээ. Үүнд: аялал жуулчлалын үйлчилгээ, дэд бүтцийн байгууламжуудыг ногоон хөгжлийн зарчимд нийцүүлэн шинэчлэн сайжруулах; байгальд ээлтэй үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад урамшуулал үзүүлэх тогтолцоо бий болгох; ТХГ-уудын хилийн бүст жижиг, дунд ААН-үүдийг байгуулж, аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх малчдын чадавхийг бүрдүүлэх заалт тусгагджээ.

### *Аймаг, сумын түвшиний стратегийн баримт бичгүүд*

Аймгуудын хөгжлийн стратегийн гол баримт бичиг нь Аймгийн хөгжлийн алсын хараа (Дунд хугацааны хөгжлийн стратеги) болон Аймгийн засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр юм. Аймгийн засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг ихэвчлэн богино хугацааны (жил тутмын) төлөвлөгөөгөөр хэрэгжүүлдэг. Тухайлбал, Сэлэнгэ аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, түүний байгаль орчинтой холбоотой заалтуудыг Шигтгээ 1.1-т харуулав.

Сэлэнгэ аймгийн байгаль орчинтой холбоотой стратегийн бусад баримт бичигт уул уурхайн бодлого; Төрийн ойн бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө; ногоон бүсийн хөтөлбөр; усны хөтөлбөр; цөлжилттэй тэмцэх хөтөлбөр; хог хаягдлын хөтөлбөрүүд орно. Эдгээр баримт бичгийг аймгийн ИТХ баталж, хэрэгжилтийг аймгийн захиргаа санхүүжүүлдэг.

**Шигтгээ 1.1: Сэлэнгэ аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр**

Сэлэнгэ аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт туссан байгаль орчны бодлоготой холбоотой хэсэгт дараах үйл ажиллагааг тусгасан байна:

- Ойн нөөцийг хамгаалж, жил тутам 2,000-аас доошгүй га талбайг сэргээн ойжуулах;
- Ногоон Сэлэнгэ кампанит ажлыг эрчижүүлж, ногоон бүсийг нэмэгдүүлэх;
- Хөрс хамгаалах, газрын доройтлоос сэргийлэх бодлого хэрэгжүүлэх, уул уурхайн олборлолтоос эвдэрсэн, сүйтсэн газрын нөхөн сэргээлтийг зохион байгуулах;
- Уул уурхайн талаар аймгаас баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, хувиараа олборлолт хийж байгаа асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах;
- Мэргэжлийн байгууллагаар байгалийн нөөц, түүний зарцуулалтын судалгаа хийлгэх;
- ‘Сэлэнгэ аймгийн есөн бахархал’-ыг тодорхойлж, түүхийн болон байгалийн үзэсгэлэнт газруудыг хамгаалах, сурталчлах;
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратегийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;
- Мэргэжлийн байгууллагаар цөлжилт, эмзэг газруудын судалгаа хийлгэх, цөлжилттэй тэмцэх арга хэмжээг эрчимжүүлэх.

Байгаль орчинтой холбоотой үйл ажиллагааг ХАА-н бодлого, аж үйлдвэр, худалдааны хөгжил, хөрөнгө оруулалт, дэд бүтэц, эрүүл мэнд, боловсрол, олон нийтийн оролцооны хэсгүүдэд мөн тусгасан байна.

Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Хэнтий, Булган, Архангай, Ховд зэрэг 4 аймаг Тогтвортой хөгжлийн зорилтууд, 2016 оны Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд суурилан өөрсдийн ногоон хөгжлийн 2016-2024 оны стратегийг боловсруулан баталсан байна. 2017 оны байдлаар, Дорноговь, Хөвсгөл, Сэлэнгэ, Орхон, Баянхонгор зэрэг өөр 5 аймаг өөрсдийг дунд хугацааны хөлжлийн стратегээ боловсруулж батлахаар ажиллаж байна. Эдгээр стратегид хот төлөвлөлт, ногоон барилга байгууламж, тээвэр, ойжуулах үйл ажиллагаа, тогтвортой бүтээгдэхүүн, хог хаягдлын менежмент, тогтвортой аялал жуулчлал, тогтвортой ХАА, ногоон хөрөнгө оруулалт, санхүүжилт, ногоон ажлын байр зэрэг аймгийн онцлог зорилгуудыг тусгажээ.

Нийслэл Улаанбаатар хотын Ногоон хөгжлийн стратегийн 2020 хүртэлх төлөвлөгөөг 2016 баталж, цэвэр агаар, тогтвортой тээвэр, хатуу хог хаягдлын менежмент, усны аюулгүй байдал, цэвэр хөрс, байгаль орчны тогтвортой байдлыг хангахад оролцоог нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх зэрэг 7 зорилгыг тодорхойлжээ. Эдгээр зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд гэр хорооллын эрүүл ахуйн асуудлыг шийдвэрлэх, утаа багатай зуух ашиглах; хотын төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх; аж үйлдвэрийн хаягдлыг нийтийн ариутгах татуургын сүлжээнд цутгахын өмнө газар дээр нь урьдчилан цэвэршүүлэх арга хэмжээ авах; Туул голын бохирдлыг бууруулах зорилгоор арьс шир боловсруулах үйлдвэрүүдийг хотын зах руу шилжүүлэх; ус татах систем, Туул голын үерийн хамгаалалтын системийг сайжруулах зэрэг хотын онцлог нөхцөлд нийцсэн зорилгуудыг тусгасан байна.

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө, 2030 он хүртэлх хөгжлийн хандлагад ногоон хот болгох олон үйл ажиллагаа, тухайлбал голыг тусгай хамгаалалтад авах, өнөөгийн хамгаалалтын бүсийг өргөжүүлэх; ногоон бүсүүдийг бий болгох; тусгай хамгаалалттай газрын хэмжээг томруулах; түүхий нүүрс шатаахыг үл дэмжих; агаар, хөрс, усны чанарын мониторингийг сайжруулах; хот болон хот орчмын олборлолт, уул уурхайн үйл ажиллагааг хязгаарлах зэргийг онцолсон байна.

Сумдын түвшинд эдийн засаг, нийгэм, байгаль орчны хөгжлийг тодорхойлсон урт хугацааны төлөвлөгөө бий. Тухайлбал Сэлэнгэ аймгийн Баянгол сум 2030 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөөг 2008 онд баталж, 2012 онд шинэчилжээ. Төлөвлөгөөнд ойг нөхөн сэргээх, газрын доройтлоотой бүсийн малын тоо, бэлчээрийн газрыг сонгох зэрэг заалтыг тодорхойлжээ. Жил тутмын төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээнүүдийг тусгаж хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг байна.

## 1.2 Тогтвортой хөгжлийн зорилтууд

### *Мянганы хөгжлийн зорилтууд*

УИХ Мянганы хөгжлийн зорилтуудыг (МХЗ) улсын хөгжлийн гол үзүүлэлт болгон 2005 онд баталсан (УИХ-ын 2005 оны 25 дугаар тогтоол) байна. Дэлхий дахины 8 зорилтоос гадна Монгол Улс нь МХЗ-ын Хүний эрх, ардчилсан засаглалыг бэхжүүлэх 9 зорилтыг хүлээн зөвшөөрсөн байна. Эдгээр 9

зорилтын хүрээнд 24 зорилгыг тодорхойлж, зорилт бүрийг хариуцах байгууллагуудыг тодорхой зааж өгсөн байна. МХЗ-уудын зорилго, үзүүлэлтүүдийг 2008 онд шинэчлэн баталсан (УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоол) байна.

Монгол Улс нь МХЗ-уудыг 2003 оны Эдийн засгийн өсөлт, ядуурлыг бууруулах стратеги, 2008 оны МХЗ-уудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод тус тус суулгаж өгсөн байна.

МХЗ-ын хэрэгжилтийн тайлан илтгэлийг 2004, 2007, 2009, 2011, 2013 онуудад 5 удаа боловсруулсан байна. “Мянганы хөгжлийн зорилтуудаас Тогтвортой хөгжлийн зорилтуудад шилжих нь” сэдэвт 2015 онд гаргасан үндэсний тайлан илтгэлд нярайн эндэгдлийг бууруулах, эхийн эрүүл мэндийг сайжруулах, ДОХ/ХДХВ-тай тэмцэх, шинэ мэдээлэл, холбооны технологи боловсруулах, мэдээлэлжсэн нийгэм байгуулах зорилтууд биелэгдсэнийг тэмдэглэсэн байна. Харин ядуурлын түвшинг 50 хувиар бууруулах зорилт биелээгүй боловч түүнийг гуравны нэгээр бууруулж чадсан байна. Ядуурлын түвшинг 50 хувиар бууруулах, залуучуудын ажилгүйдлийн түвшинг бууруулах, сүрье өвчний тархалтыг зогсоох, Улаанбаатар, бусад хотуудын агаарын бохирдлыг багасгах байгаль орчны зорилтууд биелэгдээгүй байна.

Улсын хэмжээнд бодит дэвшлийг дэмжихийн сацуу МХЗ-ууд нь Монголын үндэсний хөгжлийн төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэхэд ихээхэн нөлөөлсөн байна. МХЗ-уудын хэрэгжилтийн явцад олсон сургамжуудаас зарим зорилтын биелэлтийг дүгнэхэд мэдээ мэдээллийн хомс байдал, аргачлалын асуудлууд ихээхэн хүндрэл учруулсныг төр, засгийн эх сурвалжууд онцолсон байдаг.

*ТХЗ-уудын хэрэгжилт, мониторингийн зохицуулалтын бүтэц зохион байгуулалтын тогтолцоо*

ТХЗ-уудтай холбоотой үйл ажиллагааг 2016 оны 8 дугаар сар хүртэл Сангийн яам зохицуулж байсан бөгөөд 8 дугаар сард байгуулагдсан Үндэсний хөгжлийн газарт (ҮХГ) ТХЗ-уудын хэрэгжилт, мониторингийн зохицуулалтын үүргийг хариуцуулсан байна.

ТХЗ-ын үндэсний хороог Ерөнхий сайдын дэргэд 2016 оны эхээр байгуулж, 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдлагаар хангах өндөр түвшний төрийн байгууллага байхаар шийдвэрлэжээ. Уг хороог Ерөнхий сайд даргалж, бүрэлдэхүүнд нь яамдын сайд, төрийн нарийн бичгийн дарга нар, бусад оролцогч талуудын болон НҮБ-ын төрөлжсөн агентлагуудын төлөөлөл орсон байна.

Ерөнхий сайдын дэргэдэх ТХЗ-ын үндэсний хороо нь 9 дэд хороотой, эдгээрээс 8 дэд хороо нь ус, эрчим хүч зэрэг тодорхой чиглэлийг тухайн асуудал эрхэлсэн төрийн яамны удирдлагын дэргэд ажиллаж байна. Дэд хороодод шаардлагатай шалгуур үзүүлэлтүүд, үндэсний зорилгуудыг тодорхойлох үүрэг болгосон байна. ТХЗ-уудын үнэлгээний үзүүлэлтүүд, аргачлалын асуудал хариуцсан 9 дэд хороог Үндэсний статистикийн хороо тэргүүлж байна. Бүх дэд хороод 2016 оны турш хуралдсан хэдий ч өгөгдсөн үүргийг бүрэн биелүүлээгүй, тэд байж болох тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон боловч зорилгуудыг тогтооход дэвшил гаргаагүй байна.

Ерөнхий сайдын дэргэдэх ТХЗ-уудын үндэсний хороо 2017 оны 5 дугаар сарын байдлаар огт хуралдаагүй байна.

УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дэргэд УИХ-ын гишүүдээс бүрдсэн ТХЗ-уудын дэд хороо ажиллаж байна.

*Үндэсний бодлогын баримт бичигт ТХЗ-ууд туссан байдал.*

ТХАХ (2016)-нь ТХЗ-уудыг хэрэгжүүлтийг хангахад чиглэгджээ. Тухайлбал, ТХАХ-д хөтөлбөрийн Зорилго 9-ийн хүрээнд 2030 он гэхэд хүрэх үндэсний зорилтыг тодорхойлж өгчээ (Шигтгээ 9.2). Түүнчлэн Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр нь ТХАХ-нд суурилсан байна.

ҮХГ нь 2017 оны 5 дугаар сарын байдлаар үндэсний бодлогуудад дүгнэлт хийж, ТХЗ-уудтай нийцэж

байгаа эсэхийг үнэлэн түүндээ үндэслэн 2030 оны зорилгуудыг тодорхойлохоор төлөвлөж байна. ҮХГ-аас төрийн яамдууд, бусад байгууллагууд салбарын бодлогыг дүгнэх, зорилгыг тодорхойлоход удирдамж болох ерөнхий асуулгыг боловсруулж байна. Гэвч бүх бодлогыг ТХЗ-уудтай уялдуулах, салбарын бодлогод ТХЗ-уудыг суулгах нь нэлээд бэрхшээлтэй болох нь ойлгомжтой, үндэсний зорилгууд, үзүүлэлтүүдийг тогтоох үйл ажиллагаа 2018 оны эхээр үр дүнгээ өгнө гэсэн хүлээлттэй байна.

ТХАХ-ны хэрэгжилтийн тайлан илтгэлийг хоёр жил тутам боловсруулж УИХ-д өргөн барина. ТХАХ-ны тайлан илтгэлд ТХЗ-уудын дэлхий нийтийн үзүүлэлтүүдийн 47-г нь ашиглаж, ТХЗ-уудын үндэсний зорилго, үзүүлэлтүүдийг засгийн газар, эсвэл УИХ-ын тогтоолоор батлах, уг тогтоолд тайлагнах зарчмыг мөн тусгах төлөвлөгөөтэй байна.

### *Шалгуур үзүүлэлтүүд*

ТХЗ-уудын дэлхий нийтийн шалгуур үзүүлэлтүүдийг Монгол улсад ашиглах боломжийн талаар 2017 оны 5 дугаар сарын байдлаар 3 үнэлгээ хийгдээд байна:

- НҮБХХ-ийн тусламжтайгаар 2015 оны 11,12 дугаар сард 224 үзүүлэлтэд (тухайн үед олон улсын хэмжээнд тогтоосон) урьдчилсан үнэлгээ хийж, тэдгээрийг 8 ангилалд (бэлэн байгаа, бага зэрэг ажиллагааны дараа бэлэн болох, нэлээд ажиллагааны дараа бэлэн болох, мэдээ мэдээллийг цуглуулах байдал өөрчлөгдсөн нөхцөлд бэлэн болох, Монголын нөхцөлд нийцэхгүй, гадны байгууллагуудаас шууд авсан, тодорхой бус, ашиглахад хүндрэлтэй гэж) ангилсан байна. Тухайлбал, 13 үзүүлэлтийг Монголын нөхцөлд нийцэхгүй хэмээн үзжээ.
- Үндэсний статистикийн хороо ТХЗ-уудын үндэсний хорооны дэд хороодтой хамтран 2016 оны 5 дугаар сард хийсэн хоёр дахь үнэлгээгээр 241 үзүүлэлтийг (2016 оны 3 дугаар сард ТХЗ-уудын асуудлаарх байгууллага хоорондын шинжээчдийн бүлгээс тодорхойлсон) судалсан байна. Эдгээр үзүүлэлтээс 13-г нь Монголын нөхцөлд нийцэхгүй хэмээн үзжээ. Үлдсэн 228 үзүүлэлтийг бэлэн байгаа (60 үзүүлэлт), нэмэлт үнэлгээний дараа бэлэн болох (11), бэлэн бус (157) гэсэн 3 ангилалд хувааж үзсэн байна. Байгаль орчин болон хууль эрх зүйтэй холбоотой ихэнх үзүүлэлтүүд Монголд нийцэхгүй болохыг энэхүү үнэлгээ харуулсан байна. Түүнчлэн Монголын нөхцөлтэй холбогдох, Монголд гаргах боломжтой 74 нэмэлт шалгуур үзүүлэлтийг тодорхойлох боломжийг энэхүү үнэлгээ олгосон байна.
- Гуравдахь үнэлгээг Үндэсний статистикийн хорооны удирдлага доор 2017 оны 10 дугаар сард хийгдсэн байна. Дүн шинжилгээ хийсэн эдгээр 244 шалгуур үзүүлэлтээс 11 нь Монголын нөхцөлд хэрэглэх боломжгүй, 134 нь ашиглахад бэлэн, 99 нь бэлэн биш байгааг тодорхойлсон байна.

ТХЗ-уудын талаарх мэдээ мэдээллийг захиргааны (яамдуудын шугамаар цуглуулсан) болон ерөнхий мэдээллээр баяжуулахаар төлөвлөж байна. Үндэсний статистикийн хорооны орлогч даргаар ахлуулсан цомхон ажлын хэсэг захиргааны мэдээллийн олдцын талаар дүгнэлт гаргахаар ажиллаж байгаа бөгөөд захиргааны мэдээлэлд ТХЗ-уудын шалгуур үзүүлэлтүүдийг хэрхэн үнэлэх тухай удирдамжийг яамдуудад хүргүүлэх ажээ. Захиргааны зарим мэдээ мэдээлэлтэй холбоотой гол бэрхшээл нь энэхүү мэдээллийн үнэн зөв байдал болон цуглуулсан давтамжтай холбоотойгоор үүсч байна. Түүнчлэн олон улсын хэмжээнд боловсруулсан зарим үзүүлэлттэй холбоотой арга зүйг Монголын нөхцөл дэх ойлголт, бодит нөхцөлтэй нийцүүлэх асуудал нь томоохон саад бэрхшээл сорилт болж байна.

2017 оны 5 дугаар сард баталсан 2017-2020 онд хэрэгжүүлэх Үндэсний статистикийн стратегид тус хорооноос ТХЗ-уудын асуудлаар ажиллах, тухайлбал мэдээ мэдээллийн эх сурвалж, сурталчилгаа, аргачлалыг нэн тодорхой зааж өгсөн байна. Стратегид суурь болон тухайн жилийн шалгуур үзүүлэлтийн үнэлгээг гаргахдаа холбогдох яам, ҮХГ-тай хамтран ажиллахыг Үндэсний статистикийн хороонд даалгажээ. Зорилго, шалгуур үзүүлэлтүүдийг тогтоосны дараа Үндэсний статистикийн хороо нь мэдээ мэдээллийн урсгал, мэдээллийн сангийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай болно.

Ерөнхийдөө Үндэсний статистикийн хороо нь ТХЗ-уудын үзүүлэлтүүдийг тогтоох талаар зохих хурдацтай ажиллаж байна. Гэвч олон улсын түвшинд ашиглаж буй илүү тодорхой удирдамж, бусад орнуудтай туршлага солилцох шаардлагатай тулгарч байна.



*Мэдлэг мэдээлэл түгээх болон өмчлөл*

Монголын төр засгийн удирдлага, Засгийн газрын байгууллагууд ТХЗ-уудын талаар гүнзгий мэдлэг мэдээлэлтэй нь харагдаж байна. БОАЖЯ-наас гадна бусад яамдын мэргэжилтнүүд, орон нутгийн удирдлага, байгаль орчны байцаагчид, багш нар өөрийн ажил үүрэгтэй холбоотой ТХЗ-ууд, зорилгын талаар мэдлэг мэдээлэлтэй байгаа нь 2016 оны ТХАХ-г ТХЗ-уудтай уялдуулах үйл ажиллагааны явцад мэдлэг мэдээллийг дээшлүүлэх олон талт арга хэмжээг үндэсний түнш байгууллагууд НҮБХХ, НҮБХАС, 21 зууны Хөгжлийн төлөөх статистикийн түншлэл (PARIS21), бусад байгууллагуудын туслалцаа дэмжлэгтэйгээр зохион байгуулсны бодит үр дүн юм. ТХЗ-уудыг өөрийн болгож хэрэглэх байдал болон хичээл зүтгэл өндөр байна. Гэвч мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, ялангуяа төрийн бус байгууллагын оролцогчдод чиглэгдсэн үйл ажиллагаа зохион байгуулах шаардлагатай байгааг төрийн зарим албан хаагчид онцолж байлаа.

**1.3 Байгаль орчны стратегийн үнэлгээ***Эрх зүйн нөхцөл*

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай 2012 онд шинэчилсэн хуульд анх удаа монголын эрх зүйд Байгаль орчны стратегийн үнэлгээ (БОСҮ) гэсэн ойлголтыг нэвтрүүлсэн байна. Энэхүү хуулиар байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхээс сэргийлж БОСҮ-г үндэсний хэмжээний, бүсийн, салбарын бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд заавал тусгахыг хуульчилжээ. Өөрсдийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган БОСҮ-г санаачлан хэрэгжүүлэх үүрэг хариуцлага салбарын яамдад ноогдоно. БОАЖЯ-ны Мэргэжлийн зөвлөл (Бүлэг 2) нь (Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний зөвлөлтэй адил) тухайн БОСҮ-г Засгийн газарт оруулахаас өмнө хэлэлцэн батлах үүрэгтэй. БОСҮ-ний талаарх эцсийн дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн сайд хэлэлцэж байгаа бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг Засгийн газраар хэлэлцэх үед танилцуулна.

БОСҮ-г санаачлан хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар хуулинд заагаагүй байна. Аль нэг хууль болон холбогдох хууль эрх зүйн баримт бичигт БОСҮ хийлгэх шаардлагатай салбарын бодлого, хөтөлбөр төлөвлөгөөний талаар тусгайлан зааж өгөөгүй байна.

Байгаль орчны үнэлгээ, Байгаль орчны стратегийн үнэлгээ, Хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээний журам (Засгийн газрын 2013 оны 374 дүгээр Тогтоол)-д БОСҮ хийх процедурыг дэлгэрэнгүй тайлбарласан байна. Энэхүү журамд БОСГ хийх зарчим, дараалал болон түүний агуулгыг тодорхойлж өгчээ. БОСҮ-ний тайланд байгаль орчин, нийгэм, эрүүл мэндэд учрах сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулахад чиглэгдсэн хувилбарууд, авах арга хэмжээний саналыг дэвшүүлэхийн зэрэгцээ санал болгож байгаа бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад гарсан БОСҮ-ний зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх мониторинг болон үнэлгээний механизм, үзүүлэлтүүдийг тодорхойлсон нь нэн чухал ач холбогдолтой юм.

БОСҮ-ний тайлан илтгэлийн талаар олон нийтийн санал зөвлөмжийг авах тухай журамд тусгажээ. Байгаль орчны асуудал эрхэлсэн яамны цахим хуудсанд БОСҮ-ний баримт бичгийг (БОСҮ-ний тайлан илтгэлд дурдсан санал, зөвлөмжийг тусгасан бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний эцэслэсэн төсөл, БОСҮ-ний тайлан илтгэл) олон нийтийн санал авах зорилгоор байршуулна. Санал зөвлөмжийг ажлын 14 хоногийн турш авах бөгөөд олон нийтийн зөвлөмж, дүгнэлтийг БОСҮ-ний тайланг батлах шийдвэрийг гаргадаг Мэргэжлийн зөвлөлд танилцуулна.

Бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэхэд БОСҮ-г ашиглах талаар 2012 оны хуульд огт дурьдаагүй хэдий ч БОСҮ-ний заалтууд батлагдсан бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулахад хамаарахыг журамд заасан байна.

Байгаль орчин, Ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-03 тоот тушаалаар байгаль орчны нөлөөллийн бүх үнэлгээ, БОСҮ-нд олон нийтийн оролцоог хангах зарчмыг тодорхойлж, 2014 оны А-117 тоот тушаалаар БОСҮ боловсруулах нарийвчилсан аргачлалыг баталсан байна.

### *Практик дээр хэрэгжүүлэх*

2017 оны дунд үеийн байдлаар 2012 оны хуульд заасны дагуу нэг ч БОСҮ боловсруулаагүй байна. Монголын уул уурхайн салбарын Байгаль орчин, нийгмийн үнэлгээний төслийг Австралийн Сустайнабилити (Sustainability) байгууллага Дэлхийн банк болон Монгол улсын Засгийн газартай хамтран 2013-2014 оны хооронд хэрэгжүүлсэн боловч энэхүү туршилтын арга хэмжээ Монгол улсын баталсан БОСҮ-ний арга зүйг хэрэглээгүй байна.

Сүүлийн цөөн жилүүдэд БОАЖЯ-наас БОСҮ-ний талаарх ойлголтыг сайжруулах зорилгоор бусад яамдтай хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулсан боловч үнэлгээний талаарх ойлголт тун хязгаарлагдмал хэвээр байна. Яамдууд санхүүжилтийн хязгаарлагдмал байдлыг БОСҮ хийхгүй байгаагийн гол шалтгаан хэмээн тайлбарладаг.

БОАЖЯ-ны Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтэс 7 ажилтантай, БОНБУ, БОСҮ, байгаль орчны аудит болон БОСҮ-ний асуудлыг хариуцдаг. Өнөөгийн байдлаар яамны зүгээс эдгээр гурван баримт бичгийн практик хэрэгжилтийн байдлаас шалтгаалан БОСҮ-тэй харьцуулбал БОНУ, байгаль орчны аудитэд илүү анхаарал хандуулж байна.

Монгол Улсад хил дамнансан БОСҮ боловсруулах туршлага байхгүй, Монгол Улс Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний конвенци (Эспоо конвенци) болон БОСҮ-ний Протоколын гишүүн орнуудын Хил дамнансан үнэлгээний асуудлаарх хуралдаанд 2014, 2017 онуудад ажиглагчаар оролцсон байна.

Ногоон хөгжлийн бодлогыг 2016-2030 онд хэрэгжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөөнд байгаль орчны үнэлгээний тухай 1.3 дугаар зүйлд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх Стратегийн үнэлгээний боловсронгуй тогтолцоог бий болгох, түүний үр дүнг дээшлүүлэх үүргийг БОАЖЯ болон бусад холбогдох яамдад ноогдуулсан байна.

#### **1.4 Байгаль орчин, ногоон эдийн засаг, тогтвортой хөгжлийн эрх зүйн тогтолцоо, түүний хэрэгжилт**

##### *Байгаль орчны хуулиуд*

##### Хууль эрх зүйн тогтолцооны тойм

Байгаль орчны талаар 1994-2000 онуудад батлагдсан 17 хууль нь байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг тогтвортой ашиглах үндсийг тавьжээ. Эдгээрт 1995 оны Байгаль орчныг хамгаалах тухай суурь хууль, 1995 оны Усны тухай хууль (цаашид хүчин төгөлдөр бус), 1995 оны Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн тухай хууль (цаашид хүчин төгөлдөр бус), 1995 оны Байгалийн ургамлын тухай хууль, 1994 оны Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, 1997 оны Тусгай хамгаалалтын нутгийн Завсрын бүсийн тухай хууль, 1995 оны Ангын нөөц ашигласны төлбөр, ангын зөвшөөрөл олгох тухай хууль (цаашид хүчин төгөлдөр бус), 1997 оны Газрын төлбөрийн тухай хууль, 1995 оны Агаарын тухай хууль (цаашид хүчин төгөлдөр бус), 1995 оны Ойн тухай хууль (цаашид хүчин төгөлдөр бус), 1995 оны Мод бэлтгэх, түлшний мод ашигласны төлбөрийн тухай хууль (цаашид хүчин төгөлдөр бус) хуулиуд хамаарна.

Газрын шинэчлэлтэй холбогдуулан 2001-2009 онуудад 2002 онд Газрын тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиуд, хог хаягдалтай холбоотой 2003 оны Ахуйн болон аж үйлдвэрийн хог хаягдлын тухай, 2006 оны Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулиудыг баталсан байна.

Зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох, зарим асуудлыг олон улсын стандарттай нийцүүлэх, байгаль орчны асуудлаар шийдвэр гаргах явцад олон нийтийн оролцоог хангах зорилгоор 2012 онд байгаль орчинтой холбоотой хууль эрх зүйн баримт бичгүүдийг цогц байдлаар хянан шинэчилж, 18 хуулийн давхардал, зөрчлийг арилгах, 2 хуулийг шинээр батлах, 6 хуулийг шинэчлэн найруулах, 8 хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, 14 хуулийг цуцлах арга хэмжээ авсан байна. Ашиглалтын янз бүрийн төлбөрийг зохицуулж байсан 5 хуулийг 2012 онд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар орлуулжээ.

Хүчин төгөлдөр үйлчилж буй зарим хуульд 2012-2017 оны хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Өнөөгийн байдлаар байгаль орчинтой холбоотой нийт 26 хууль, 370 стандарт, нэмэлт 75 эрх зүйн баримт бичиг холбогдох дүрэм журам, үйл ажиллагааны процедурыг зохицуулж байна.

#### Байгаль орчныг хамгаалах хууль

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд (1995) байгаль орчны хамгаалалд төр засгийн байгууллагуудын хүлээх үүрэг, байгаль орчны үнэлгээ, мониторинг, судалгаа шинжилгээ, мэдээлэл, байгаль орчны хамгааллын үйл ажиллагаа, хяналт шалгалт, байгаль орчны хамгааллын үйл ажиллагаан дахь иргэд, ТББ-уудын оролцоо, эдийн засгийн урамшуулал, байгалийн нөөц ашигласны төлбөр, татварын асуудлыг дэлгэрэнгүй заасан байна.

Уг хуульд 2012 онд нэмэлт өөрчлөлт оруулж, байгаль орчны аудит хийх заалтыг нэмж, байгалийн нөөц ашиглаж буй бүх аж ахуйн нэгжүүдэд 2 жил тутамд байгаль орчны аудит заавал хийхийг хуульчилсан байна. Гэвч энэ үеэс хойш бодит амьдралд байгаль орчны аудитыг хэрэглэх үйл ажиллагаа удаан хэрэгжиж байна. Байгаль орчны аудитын талаарх нэмэлт баримт бичгийг (БОНХЯ-ны сайдын 2013 оны А-126 тоот тушаал, аудиторын гэрчилгээ олгох, байгаль орчны аудитын аргачлалын тухай хоёр хавсралтын хамт) 2013 онд баталсан байна. Нийт 25 орчим компани, 200 хүнд байгаль орчны аудит хийх гэрчилгээ олгосон хэдий ч компаниуд байгаль орчны аудит хийлгэхээс зайлсхийж, аудитын байгууллагуудын чадвар чадавхи эргэлзээ төрүүлж байна. Түүнчлэн 2012 оны нэмэлт өөрчлөлтөөр байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх, хууль зөрчсөн нөхцөлд торгууль ноогдуулах заалтуудыг шинэчилжээ.

#### Байгаль орчны үнэлгээ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг анх 1998 онд баталж, 2012 онд шинэчлэн найруулжээ. 2012 оны хууль 4 төрлийн үнэлгээг зохицуулж байна. Үүнд: (1) Байгаль орчны стратегийн үнэлгээ (БОСҮ) – бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулахад хийгдэнэ; (2) Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ – бүх төслийн санал, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах шатанд тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчны нөхцөл байдлыг тодорхойлохын тулд хийгдэнэ; (3) Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ (БОНУ), ерөнхий болон нарийвчилсан БОНУ–төсөл боловсруулахад (Бүлэг 2) хийгдэнэ; (4) Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ – тодорхой бүс, газар оронд хэрэгжүүлсэн төслүүдийн үр нөлөөг үнэлэх зорилгоор боловсруулахыг тус тус заасан байна. Эдгээрээс 2012 онд Байгаль орчны стратегийн үнэлгээ (БОСҮ), Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний ойлголтыг шинээр нэвтрүүлсэн байна. БОСҮ-г 2017 оны байдлаар практикт ашиглаж эхлээгүй, харин Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг хоёр тохиолдолд ашиглажээ.

Нарийвчилсан БОНУ-ний хүрээнд байгаль орчны менежментийн төлөвлөгөө хамт хийгдэнэ (бүлэг 2). Энэ төлөвлөгөөнд байгаль орчны нөхцөлийг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанаас гадна төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй сөрөг үр дагаварт мониторинг хийх асуудлыг заавал тусгасан байна. БОАЖЯ-ны Байгаль орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар байгаль орчны менежментийн жилийн төлөвлөгөөнүүдийг баталдаг.

#### Агаар хамгаалал

Агаарын тухай 1995 оны хуулийг 2012 онд шинэчлэн найруулж, агаар хамгаалал, бохирдлоос сэргийлэх, агаар бохирдуулагчийн ялгаруулалтыг багасгах, хяналт тавих асуудлыг хамруулсан байна. Хуульд гэр хорооллоос үүдэлтэй агаарын бохирдлын асуудлыг хөндөж, гэр хорооллын цахилгаан хангамжийг өргөжүүлэх, агаарын чанарыг сайжруулах бүсийг жил тутам тогтоож тодорхой хориг (тухайлбал түүхий нүүрс ашиглах) тавих, хотоос хөдөө рүү шилжин суурьшихыг дэмжих, дулаалга, сайжруулсан зуух зэрэг эрчим хүчийг хэмнэх, байгальд ээлтэй арга хэмжээ авсан айл өрхүүдэд эдийн засгийн урамшуулал олгох зэрэг үйл ажиллагааг тусгажээ.

Хууль нь Улаанбаатар болон бусад хотуудын агаарын чанарын асуудалд үндсэндээ төвлөрч, суурин эх үүсвэрүүдийн дотоод мониторингид тавигдах шаардлагууд, агаарын бохирдол үлэмж нэмэгдсэн нөхцөлд авах тусгай арга хэмжээг тодорхойлсон байна. Хуульд аж үйлдвэрийн үйл ажиллагаанд

анхаарал бага хандуулж, уул уурхайн бүсийн агаарын бохирдол, тоосжилтын онцлог асуудлыг шийдвэрлэх талаар тусгаагүй байна.

Агаарын тухай 2012 оны хуулийн дагуу байгуулсан Цэвэр агаар сан нь гэр хорооллын зууханд цэвэр нүүрс, агаарын шүүлтүүр ашиглахад дэмжлэг үзүүлэх зорилготой байв. Хожим нь тус санг татан буулгаж, сантай холбоотой хуулийн заалтуудыг 2015 онд хүчингүй болгожээ.

2010 онд батлагдсан Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд олборлосон түүхий нүүрс, үйлдвэрлэсэн болон импортлосон органик уусгагч, автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл, агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр эзэвшигчдэд агаар бохирдуулсаны төлбөр ноогдуулахаар заасан байна. Хуульд төлбөрийн хэмжээ болон хязгаар, төлбөрөөс чөлөөлөх заалтыг тусгаж өгсөн байна (Бүлэг 3).

#### Уур амьсгалын өөрчлөлт

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар тусгайлсан хууль байхгүй, Агаарын тухай 2012 оны хуульд озоны давхрагыг хамгаалах, хүлэмжийн хийн ялгаруулалтад мониторинг хийх, хүлэмжийн хийн ялгаралтын тооллого, тооцоо хийх бэлтгэл ажлын тухай заалтууд оржээ. Салбаруудын хууль тогтоомж, тухайлбал эрчим хүч, усны менежментийн баримт бичигт дасан зохицох, хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах зарим заалтууд тусгагдсан байна.

#### Газрын доройтол

Газрын тухай 2002 оны шинэчилсэн хуульд газрыг 6 ангилалд хувааж (Бүлэг 12), газрыг үр дүнтэй, зүй зохистой ашиглах, хамгаалах тухай бүлгийг нэмж оруулж өгсөн байна. Энэхүү хуульд газрыг бэлчээрийн зорилгоор ашиглах, хадлангийн газрыг ашиглах хамгаалах, тариалангийн талбайг хамгаалах, мөн газар, хөрсийг зохистойгоор ашиглах, хамгаалахын тулд БОНУ хийх тухай шаардлагуудыг тусгаж өгжээ. 2017 оны байдлаар 2002 оны Газрын тухай хуулийг шинэчлэх ажил хийгдэж байна.

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай 2012 оны хуульд ХАА, уул уурхай, зам барих ажил өргөжиж, төв суурин газрын газрын ашиглалт, мөн уур амьсгалын өөрчлөлт эрчижиж байгаагаас үүдэлтэй цөлжилтөөс хамгаалах арга хэмжээг тусгаж өгчээ. Хөрс хамгаалах арга хэмжээний хүрээнд хөрсний бохирдолтой бүсүүдийн жагсаалтыг гаргах, тэдгээрийн эрсдлийн үнэлгээг хийж холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан байна. Хөрс хамгаалах шинэ технологи нэвтрүүлсэн, цөлжилтөөс сэргийлсэн, сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлсэн хувь хүн, байгууллагад Засгийн газраас урамшуулал олгох, хувь хүн, байгууллагын хууль бус үйлдлээс үүссэн хөрсний доройтлыг багасгах, хөрсийг нөхөн сэргээх хариуцлагын асуудлыг хуулиар зохицуулжээ.

#### Байгаль хамгаалал

Байгалийн ургамлын тухай хууль (1995) нь ой, таримал ургамлаас бусад байгалийн ургамлыг хамгаалах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг зохицуулна. Энэхүү хууль нь ургамлыг гал түймэр, өвчин хортон, хөнөөлт мэрэгч амьтан, шавьж болон хүний сөрөг үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах, нэн ховор, унаган болон үлдвэр ургамлын удмын санг хамгаалах арга хэмжээг тодорхойлж өгчээ. Хуулиар байгаль хамгаалах, байгалийн тэнцвэрт байдлыг хангахад ач холбогдол бүхий хот, тосгон, бусад суурины ногоон бүс, гол, горхины эх болон нуур, цөөрмийн эргээс 2 километрийн доторхи газар, элсний нүүлтээс хамгаалах ач холбогдол бүхий газар, хөрсний элэгдлээс хамгаалах зурвас зэрэг газар нутагт ургамлын нөөцийг ашиг олох зорилгоор ашиглахыг хориглосон байна.

Хуульд сумдын засаг дарга нарыг бэлчээрийн даац, хадлангийн газрын ашиглалтыг зохистой төлөвлөх арга хэмжээ авах, нэн ховор ургамлыг хамгаалах шаардлагын үүднээс бэлчээр, хадлангийн газрыг 2 жил хүртэл хугацаагаар ашиглахыг хориглох эрхийг ИТХ-д олгосон байна. Ургамлыг ашиг олох зорилгоор ашиглахад зохих төлбөр төлнө.

Шинэчлэн найруулсан (2012) Амьтны тухай хууль (Бүлэг 11) нь 2000 оны хуулийг орлож, мал, гэрийн тэжээвэр амьтнаас бусад амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай

холбогдсон харилцааг зохицуулсан байна. Амьтныг ашиглахад хорио, хязгаарлалт тогтоох; нэн ховор, ховор амьтныг “Улаан ном”-д бүртгэх; амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах; амьтны нөөц тогтоож, ашиглалтыг зохицуулах зэрэг хамгаалалтын арга замыг ашиглана.

Иргэд, ашгийн байгууллагууд төлбөр төлж амьтны нөөцийг ашиглаж болно. Хуульд 2017 онд нэмэлт өөрчлөлт оруулж, осол гамшигт өртсөн амьтан, тухайлбал хуй салхи, ган, зуд, үер, мөндөр, түймрийн улмаас өөрийгөө хамгаалах чадвараа алдсан зэрлэг амьтан агнахыг хоригложээ.

Амьтан ангах, барихыг 2012 оны Ан агнуурын тухай хууль (2000 оны Ан агнуурын тухай хуулийг орлосон) болон 2012 оны Амьтны тухай хуулиар зохицуулна.

Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002) нь Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн (CITES) (Бүлэг 11) хэрэгжилтийг хангах, конвенцийн дагуу лиценз олгох үйл ажиллагааг зохицуулж байна.

### Хамгаалалттай газар

Хамгаалалттай газрын менежментийн хууль тогтоомж нь 1994 оны Тусгай хамгаалалттай газар (ТХГ) нутгийн тухай хууль, 1997 оны Завсрын бүсийн тухай хуульд (Бүлэг 11) суурилна. ТХН-ын өнөөгийн тогтолцоонд улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрууд (ОНХГ) хамаарна. Улсын ТХГ-ыг дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар гэж 4 ангилна. Эхний хоёр ангиллын газрыг үндэсний түвшинд удирдлагаар хангах, харин дараах 2 ангиллын газрыг үндэсний хэмжээнд тодорхойлж, харин удирдлагыг орон нутагт хариуцуулж болно. Хуульд улсын хэмжээний ТХГ-ын бүсчлэл, дэглэм, бүсийн хорио цээр, ТХГ-ын захиргаа болон байгаль хамгаалагчийн үүргийг тогтоож өгчээ. ТХГ-ын хяналт болон хуулийн хэрэгжилтийг МХЕГ, ТХГ-ын захиргаа, бүх шатны засаг дарга нар хангаж байна.

ОНХГ-т уул уурхайн зөвшөөрөл, олборлолт хийх эрхийг олгож байгаа нь ТХГН-ийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэл учруулж байна. Орон нутгийн удирдлага нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны харъяа Ашигт малтмал, газрын тосны газрыг ОНХГ-ын тухай мэдээллээр хангах үүрэгтэй хэдий ч ОНХГ байгуулсан, түүний үйлчлэх хугацаа, хугацааг сунгасан талаар мэдээлэл хүргүүлэхгүй байх тохиолдол цөөнгүй байна. Нөгөө талаар ОНХГ-ын газар зүйн зураглалыг тогтооход хүндрэл үүсч, Ашигт малтмал, газрын тосны газар, орон нутгийн зураглал зөрдөг. Эдгээр асуудлыг шийдвэрлэх зорилгоор НҮБХХ, БОАЖЯ-ны ТХГ-ын нөөцийн менежмент хамтарсан төслийн хүрээнд ОНХГ-ын мэдээллийн сан байгуулсан (<http://eic.mn/spalocal/>) байна. ТХГ-уудын төсөв 2012-2016 онуудад ихээхэн буурсан, ТХГ-ын аялал жуулчлалаас орж буй орлогыг ТХГ-ын менежмент, хөгжилд шууд зарцуулах механизм бүрдээгүй байгаа нь ТХГ-ын хуулийг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж байна.

Байгаль хамгаалагчийн хариуцах талбайг Засгийн газрын 2009 оны 87 дугаар тогтоолоор, газар орны онцлогоос шалтгаалан, тухайлбал говийн бүст 200,000, ойн бүст 40,000, өндөр уулын бүст 50,000 га байхаар тогтоосон байна. ТХГ-т аялал жуулчлал хөгжиж байгаа нөхцөлд тогтоолоор баталсан газар, талбайн хэмжээ бодит байдалтай нийцэхгүй болсныг харгалзан байгаль хамгаалагчдын тоог нэмэгдүүлэх шаардлагатай болж байна.

2017 оны дунд үеийн байдлаар ТХГ-ын эрх зүйн баримт бичгүүдийг шинэчлэх ажил явагдаж байна (Бүлэг 11). ТХН-ын шинэ хуулийн төсөл боловсруулах ажил НҮБХХ-ын төслийн дэмжлэгээр хийгдэж байна. Энэ шинэчлэлийн хүрээнд ТХГ-уудын тогтвортой санхүүжилтийг хангах, улсын төсвөөс бүрэн хамааралтай байгааг багасгах, ОНХГ-ын удирдлагыг нутгийн ард иргэдийг ТХН-ын удирдлагад оролцуулах зэрэг асуудлыг тусгасан бөгөөд хамтын удирдлага, менежментийн арга хандлагыг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх эхлэлийг тавьсан байна (Бүлэг 11). Тухайлбал Хар ямаатын байгалийн нөөц газрыг Монгол дахь ДБХС, Хустайн цогцолбор газрыг Хустайн дархан цаазат газрын үндэсний сан, Их нарт байгалийн нөөц газрыг Аргаль агнуур судлал зэрэг ТББ-ууд удирдаж байна. Гэвч энэ механизмыг зохицуулах эрх зүйн тогтолцоо бүрэн бүрдээгүй учир хуулийн энэ төсөлд тусгаж өгсөн байна.



## Ой

Ойн тухай 1995 оны хууль (хүчин төгөлдөр бус), 1995 оны Мод бэлтгэх, түлшний мод ашигласны төлбөрийн тухай хууль (хүчин төгөлдөр бус), 1996 оны Ойн түймрээс сэргийлэх тухай (хүчин төгөлдөр бус) хуулиуд ойн хамгаалал, менежментийн эрх зүйн тогтолцоог бүрдүүлдэг. 1995 оны Ойн тухай хуульд ойг эзэмших болон ашиглах, ойн төрөл, бүс (хамгаалалттай болон худалдааны зорилгоор ашиглах ой), ойн тооллого, хамгаалалтын үйл ажиллагаа, ноогдуулах торгуулийг тодорхойлсон байна, 1995 оны Ойн тухай хуулийг 2012 онд үндсэндээ шинэчлэн найруулжээ.

Ойн тухай хуулийг 2012 онд шинэчлэн найруулж мод тайрах, тусгай зөвшөөрөлгүй ойд хадлан бэлтгэх, мал бэлчээх, зөвшөөрөлгүй мод тарихыг хориглосон боловч эдгээр хоригийг хэрэгжүүлэх, мониторинг хийхэд нэлээд сорилт тулгардаг байна. Уг хуульд хууль бус мод бэлтгэлийг зөвхөн гэрээ, зөвшөөрөлгүй үйл ажиллагааг бус, зөвшөөрөлд заасан хэмжээг хэтрүүлэн мод бэлтгэснийг мөн хууль бус хэмээн тооцохоор тусгажээ.

Ойн тухай 2012 оны хуулийг хэрэгжүүлснээр ой ашиглагчдын бүлгүүдийг байгуулж, тэдний үйл ажиллагаанд олон улсын байгууллагуудын санхүүжилтээр хэрэгжүүлсэн хэд хэдэн төслөөр дэмжлэг үзүүлж тодорхой амжилтад хүрсэн байна. Ой ашиглагчдын бүлгүүд байгуулсан гэрээний дагуу ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлдэг ба тэдний хариуцдаг нутаг дэвсгэрт хууль бус мод бэлтгэл бүрмөсөн зогссон байна. Ой ашиглагчдын бүлгүүд, бусад нэгжүүдэд арга зүйн зөвлөлгөө өгөх, ойг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлж, БОАЖЯ-ны лиценз бүхий ойн мэргэжлийн 780 орчим байгууллагыг байгуулсан нь бас нэг ололт юм.

Ойн гэрчилгээний талаар 2012 оны Ойн тухай хуулинд тусгаагүй учир гэрчилгээг нэвтрүүлэх ажил удааширч байна.

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль (2009)-иар ойн бүсэд олборлолт хийх зөвшөөрөл олгохыг хориглосон байна.

## Хувиргасан амьд организм

Хувиргасан амьд организмын (ХАО) тухай хууль (2007)-иар ХАО үйлдвэрлэх, хэрэглэх, ашиглах, тэднийг хил давуулан тээвэрлэх, улсын нутаг дэвсгэрт биологийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. БОАЖЯ-ны дэргэд биологийн аюулгүй байдлын асуудлыг хариуцах Биологийн аюулгүй байдлын үндэсний хороо байгуулжээ. Тус хороо нь ХАО-г хил давуулан тээвэрлэх асуудлаар санал гаргах, ХАО-ын үйлдвэрлэлтэй холбоотой асуудлаарх БОНУ-ний дүгнэлт болон эрсдлийн үнэлгээг хянах үүрэгтэй. ХАО-ын үйлдвэрлэл, үйлчилгээний асуудлыг ерөнхий БОНУ-нд тусгахыг 2012 оны БОНУ-ний тухай хуульд зааж өгсөн байна.

## Хог хаягдал болон химийн бодис

Ахуйн болон аж үйлдвэрийн хог хаягдлын тухай хууль (2003) нь хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ахуйн болон аж үйлдвэрийн хог хаягдлыг булшлах, хоёр дахь түүхий эдийн зорилгоор дахин ашиглах асуудлыг зохицуулсан. Тус хуулийн оронд 2012 онд Хог хаягдлын менежментийн тухай хууль батлагдаж, 3R (хаягдлыг багасгах, дахин ашиглах, дахин боловсруулах)-ын зарчмыг нэвтрүүлжээ. 2012 оны хуулийг дахин 2017 онд Хог хаягдлын менежментийн тухай хуулиар шинэчилсэн бөгөөд түүнд цацраг идэвхт хаягдлаас бусад ердийн хатуу болон аюултай хаягдлыг хамруулсан (Бүлэг 10) байна.

Зарим пластик уутны хэрэглээг хязгаарлах тухай 2009 оны хуулийн дагуу импортын хүнсийг савлахад 0.025 мм-ээс бага зузаантай пластик уутны хэрэглээг хориглосон байна (одоо энэ хууль хүчин төгөлдөр бус). Энэ хориг 2012 онд гарсан Хог хаягдлын менежментийн хуулиар цуцлагдсан байна. Гэвч 2012 оны хууль 0.025 мм-ээс бага зузаантай пластик уутны хэрэглээг худалдааны үйлчилгээнд хэрэглэхийг хоригложээ. Хог хаягдлын менежментийн хууль 2017 онд батлагдсанаар пластик уутны хориг хүчингүй болсон байна.

Аюултай хог хаягдлыг импортлох, тээвэрлэх, экспортлохыг хориглох тухай 2000 оны хууль нь (одоо хүчингүй болсон) аюултай хог хаягдлын хил дамнасан хөдөлгөөнд хяналт тавих, устгах тухай Базелийн конвенцийн хэрэгжилтийг хангах зорилготой байсан бөгөөд түүнд аюултай хог хаягдлыг ашиглах, хадгалах, түр хугацаагаар байлгах, устгах зорилгоор Монголд импортлохыг хориглосон. Мөн аюултай хог хаягдлыг Монгол улсын хил дамжуулан тээвэрлэхийг хориглосон байна. Аюултай хог хаягдлын экспортыг зөвшөөрөл олгосны үндсэн дээр үйлдэж болно. Аюултай хог хаягдлыг импортлох, тээвэрлэх, экспортлохыг хориглох тухай хуулийг 2012 онд Хог хаягдлын менежментийн тухай хуультай нэгтгэсэн байна.

Химийн хорт бодисоос хамгаалах тухай 1995 оны хуулийн оронд 2006 онд Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль батлагджээ. Энэ 2006 оны хууль нь одоо химийн аюултай болон хорт бодисын импорт, экспорт, хил давуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, устгах, хэрэглэх, мониторинг хийх зэрэг бүх асуудлыг зохицуулах гол хууль эрх зүйн баримт бичиг болж байна. Түүнд химийн бодистой холбоотой бусад олон асуудлын зэрэгцээ химийн бодистой холбоотой үйл ажиллагаанд заавал эрсдлийн үнэлгээ хийхээр зааж өгчээ. Засгийн газраас хориглосон, эсвэл ашиглалтыг хязгаарласан химийн хорт, аюултай бодисын жагсаалтыг 2007 онд баталсан байна (ЗГ-ын 2007 оны 95 дугаар тогтоол). Байгаль орчин, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн яамдууд, Онцгой байдлын ерөнхий газрын хамтарсан тушаалаар 2009 онд химийн хорт, аюултай материалын хадгалалт, тээвэр, устгалын журмыг баталсан (2009 оны хамтарсан 28/40/29 тоот тушаал) (одоогоор энэ жагсаалт хүчингүй болсон) боловч сүүлд нь химийн хорт, аюултай материалын хадгалалт, тээвэр, устгалын шинэ журам гарсан байна (2017 оны хамтарсан 54/136/215 тоот тушаал).

### Ус

Усны тухай 2004 оны хуульд олон тооны нэмэлт өөрчлөлт оруулан 2012 онд шинээр баталжээ. Шинэ хууль нь Усны нөөцийн нэгдсэн менежментийн (УННМ) зарчмыг хатуу баримталж, усны ашиглалт болон судалгаа, усны мониторинг болон судалгаа, хамгаалалтын бүсүүд, ус ашиглалт ба зөвшөөрөл, усны дэд бүтцийн менежмент, усны нөөцийг ган, цөлжилт, хуурайшилтын үед хамгаалах үйл ажиллагааг зохицуулсан байна. Хуульд дотоод мониторингийн шаардлага, тухайлбал бүх ус хэрэглэгчид усны хэрэглээний тоолуур тавих, өдрийн хэрэглээ 50 шоо метрээс давсан нөхцөлд хэрэглэгчид мониторингийн тусгай төхөөрөмжийг ажиллагааны бүх хугацаанд суурилуулахаар заажээ. Хуулийг 2012 оны 5 дугаар сард батлахад Усны үндэсний газар үйл ажиллагаа явуулахыг тодорхойлж өгсөн боловч мөн оны 8 дугаар сард оруулсан нэмэлт өөрчлөлтөөр тус газрын үүргийг цуцалсан байна.

УННМ-ийн эрх зүйн болон бүтэц зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлсэн нь Усны тухай 2012 оны хуулийн хэрэгжилтийн гол үр дүн болсон байна. 2009 онд 29 голын сав газрыг тогтоосон хэдий ч Улсын хэмжээний Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг 2013 онд баталсан (ЗГ-ын 2013 оны 389 дүгээр тогтоол) байна. Усны нөөцийн менежмент, сав газрын төлөвлөгөөг боловсруулах аргачлал (БОНХ-ийн сайдын 2013 оны 187 тоот тушаал), Усны сав газрын зөвлөл байгуулах журмыг (БОНХ-ийн сайдын 2013 оны 124 тоот тушаал) 2013 онд тус тус баталжээ. 29 голын сав газрыг 21 захиргаа хариуцах болов. 2017 оны дунд үеийн байдлаар 29 сав газрын 17-гийнх нь менежментийн төлөвлөгөө батлагдаж, 8 төлөвлөгөө боловсруулах шатандаа, 6 сав газрын төлөвлөгөө зөвхөн эхлэлийн шатандаа байна. Голын зав газрын зөвлөлүүдийг ихэнх сав газарт албан ёсоор байгуулсан боловч санхүүжилтээс шалтгаалан үйл ажиллагаа явуулахгүй байна.

1995 оны Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг 2012 оны Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль зэрэг бусад хууль тогтоомжтой нэгдтгэсэн байна.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль (2012)-д зааснаар ус бохирдуулсаны төлбөрийг дараах тохиолдолд төлнө: (i) зөвшөөрөгдсөн хэмжээнд, бохир усны стандартын шаардлагыг хангасан бохир усыг байгальд шууд цутгах; (ii) бохирдуулагч бодисын агуулга стандартын шаардлагыг хангасан бохир усыг ариутгах татуурганд цутгах. Төлбөрийн дээд, доод хязгаарыг хуулиар тогтоосон бөгөөд усны нөөцийн чанар, хэмжээг харгалзан голын сав газрын төлбөрийн хэмжээг засгийн газар тусгайлан тодорхойлно. Холбогдох нэмэлт эрх зүйн баримт бичиг батлагдаагүй тул 2017 оны дунд үеийн байдлаар дээрх хууль хэрэгжиж эхлээгүй байна. Хуулийг бодит нөхцөлд илүү нийцүүлэхэд чиглэсэн нэмэлт оруулах асуудлыг хэлэлцэж байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль (2011)-иар усны байгууламжийн өмчлөл, ашиглалт, хотын хэрэглэгчдийг ундны усаар хангах, бохир усыг цэвэрлэх, зайлуулах үйл ажиллагааг зохицуулдаг. Хуулиар хотын усны хангамж, дамжуулах хоолойн ашиглалтын эрх зүйн баримт бичиг, бодлого боловсруулах үүргийг Барилга, хот байгуулалтын яаманд ноогдуулсан ба Усны үйлчилгээг зохицуулах зөвлөл хэмээх шинэ бүтэц байгуулжээ. Ундны усны төвлөрсөн, төвлөрсөн бус эх булгийн орчимд хамгаалалт, эрүүл ахуйн бүс байгуулахыг хуульчилсан байна.

#### Байгаль орчны дуу чимээ

Байгаль орчны дуу, чимээ шуугианыг Стандартчилал, хэмжил зүйн газраас тогтоосон стандартаар зохицуулдаг.

#### Байгаль орчинтой холбоотой гэмт хэрэг

Эрүүгийн хуульд байгаль орчинтой холбоотой гэмт хэргийг эртнээс тусгаж иржээ. Ой, ан ангуур, уул уурхай, ойн түймрээс хамгаалах хуулийн зөрчил хамгийн нийтлэг. Агаар, ус, хөрсийг бохирдуулах, байгаль орчныг ерөнхий бохирдолтой холбоотой хуулийн заалтууд хэрэгждэггүй гэсэн шүүмжлэл байдаг.

2015 онд батлагдсан Эрүүгийн шинэ хуулийн 24 дүгээр бүлэгт байгаль орчинтой холбоотой гэмт хэргийг тусгасан бөгөөд түүнд 2017 онд хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Байгаль орчинтой холбоотой гэмт хэргийн ангилал нь байгаль орчны бохирдол, ашигт малтмалын хууль бус олборлолт, ашиглалт, хорт болон аюултай бодисыг хууль бусаар ашиглах үйл ажиллагаа, цацраг идэвхт хаягдал болон цөмийн материал, хууль бусаар мод бэлтгэх, ойн түймэр тавих зэргээр хэвээр үлдсэн байна. Гэвч хууль бус мод бэлтгэлийн торгууль, ялыг нэмэгдүүлжээ.

#### Байгаль орчны хэрэг зөрчил

Байгаль орчны бусад хууль, салбарын хуулиудад байгаль орчны хэрэг зөрчил болон торгуулийн асуудал тусгагдаж ирсэн. Зөрчлийн тухай хууль 2017 оны 5 сард батлагдаж, түүнд байгаль хамгаалах тухай тусгай бүлэг оржээ. Энэхүү хуулиар эрүүгийн хэрэг гэж тооцогдохгүй хуулийн бүхий л зөрчлийг хуульчилж өгсөн байна.

#### *Салбарын хуулиуд дахь байгаль орчинтой холбоотой заалтууд*

#### Уул уурхай

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль (2009)-иар уул уурхайн олон төрлийн үйл ажиллагааг хориглож, илүү эмзэг усны нөөцийг хамгаалах арга хэмжээ авсан. Хуулийн дагуу засгийн газар усны ундарга, ойн бүсээс 200 метрийн дотор үйл ажиллагаа явуулах хайгуул, олборлолтын 200 гаруй зөвшөөрлийг цуцалсан нь уул уурхайн компаниудын эсэргүүцэлтэй тулгарч, уг хуулийг хүчингүй болгох оролдлого хийгдсэн боловч амжилтад хүрээгүй байна.

Цөмийн энергийн тухай хууль (2009) нь бусад олон асуудлаас гадна ураны олборлолт, баяжуулалт, ашиглалтыг зохицуулдаг бөгөөд Засгийн газарт ураны нөөцөд илүү хяналт тогтоох боломж олгосон байна.

Салбарын гол хууль бол 2006 оны Ашигт малтмалын тухай хууль бөгөөд түүнд 20 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байдаг. Хайгуулын зөвшөөрөл шинээр олгохыг хориглох хууль (2010) -иар зөвшөөрөл олгохыг түр хугацаагаар зогсоосон боловч уг хоригийг 2014 онд цуцалсан байна.

Ашигт малтмалын тухай хуульд байгаль орчинтой холбоотой хамгийн чухал нэмэлтийг 2014 онд оруулсан байна. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь уул уурхайн хайгуул, бусад ажиллагааг эхлүүлэхийн өмнө угсаатны зүй, палеонтологи, археологийн мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэж, тухайн үйл ажиллагаа нь соёлын өвд ямарваа нэгэн хохирол учруулахгүйг тогтоохоор заасан байна. Мөн зөвшөөрөл эзэмшигчид бараа худалдан авах, олборлосон, баяжуулсан, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг Монголын бизнес эрхлэгчид борлуулахыг эрхэмлэхийг нэмэлт өөрчлөлтөөр зохицуулжээ.

Ашигт малтмалын тухай хуулийн нэг чухал заалт бол бизнесийн нийгмийн хариуцлагын (БНХ) гэрээ байгуулах, зөвшөөрөл эзэмшигч нь орон нутгийн захиргаатай гэрээ байгуулж байгаль орчныг хамгаалах, уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр бий болгоход хамтран ажиллахыг заасан явдал юм. Гэвч хуулинд ямар шатны орон нутгийн захиргаатай (аймаг, сум, баг) гэрээ байгуулах, гэрээний санхүүжилтийн хэмжээг тусгаж өгөөгүй байна. Амьдрал дээр ихэнх ийм гэрээг сумын захиргаатай байгуулж байна. Байгуулсан гэрээг нийтэд танилцуулахгүй байгаа нь түүнд тусгасан тэргүүлэх чиглэлүүд, агуулгын талаар эргэлзээ төрүүлдэг. Ийм гэрээний загварыг 2016 онд баталсан (ЗГ-ын 2016 оны 179 дүгээр тогтоол) байна.

Төсвийн тухай хуульд ашигт малтмалын төлбөрийн орлогыг зохицуулсан нэмэлтийг 2015 онд оруулсан байна. Хуулийн дагуу төлбөрөөс олсон орлогын 33-аас доошгүй хувийг олборлолт явагдаж байгаа сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд, зөвшөөрлийн төлбөрийн 50-иас доошгүй хувийг зөвшөөрөл олгосон сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэхээр тусгажээ. Эдгээр зохицуулалт нь уул уурхайн салбар олборлолт явуулж байгаа орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах баталгаа болж өгсөн байна.

БОНУ-г зөвшөөрөл олгох нэлээд хожуу шатанд хийж байгаа нь байгаль орчинтой холбоотой ноцтой асуудлыг нэг юм. БОАЖЯ-наас баталдаг БОНУ нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгосны дараа хийгддэг ТЭЗҮ-гийн бүрэлдэхүүн хэсэг, нөгөө талаас уул уурхайн үйл ажиллагаа эхлүүлэх зөвшөөрлөөс өмнө хийгддэг байна. БОАЖЯ нь уул уурхайн ажиллагаа эхлүүлэх зөвшөөрөл баталдаг тусгай комиссын гишүүн боловч энэ шатанд БОНУ-ний үр дүнг холбогдох баримт бичигт суулгах боломж хязгаарлагдмал юм. БОНУ-ний үр дүнг уул уурхайн компанийн БОАЖЯ-нд жил тутам хүргэдэг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах боломжтой, компаниуд нь төлөвлөгөөний биелэлтийн тайланг БОАЖЯ-нд хүргүүлэх үүрэгтэй. БОНУ-ний механизмыг уул уурхайн зөвшөөрөл олгох шийдвэр гаргахаас өмнө үнэлгээний арга болгон ашиглах боломжгүй байна. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай 2012 оны хуульд тусгасан Хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээний механизмыг мөн ашиглахгүй байна.

Түүнчлэн уул уурхайн төслийн оролцогч талууд шийдвэр гаргах үйл явцад идэвхтэй оролцох боломж хязгаарлагдмал байгаа нь бэрхшээл учруулж байна. Тэдгээрийн шийдвэр гаргах явцад нөлөөлөл багатай БОНУ-г боловсруулахад оролцох, мөн байгаль орчны хамгааллын гэрээг компаниудтай байгуулдаг орон нутгийн захиргаанд төлөөлөл оролцуулах нөхцөл хязгаарлагдмал. БОНУ-ний судалгаанд нийгмийн асуудалд бага анхаарал хандуулдаг нь бас нэг дутагдал юм.

Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх асуудлыг Ашигт малтмалын тухай хуулийн 2014 оны нэмэлтүүд, 2012 оны БОНУ-ний тухай хууль, Уурхайг бүрмөсөн болон түр хаах журмаар (МХЕГ-ын 2003 оны 309 тоот тушаал) зохицуулж байна. Журамд гүний болон ил уурхайг бүрмөсөн болон түр хаах үйл ажиллагааны бэлтгэлийн үйл явц, холбогдох арга хэмжээг тайлбарласан хэдий ч эдгээр заалтыг хэрэгжүүлэх ажил өнөөг хүртэл ихээхэн саад бэрхшээлтэй тулгарч, зарим газрыг нөхөн сэргээлгүй орхисон, заримыг нь хууль бусаар хувийн бичил уурхай эрхлэгчид эзэмшсэн байна. 400 гаруй компаниуд нөхөн сэргээлт хийх үүрэгтэй боловч цөөн тооны компаниуд бодитоор нөхөн сэргээлт хийж, зарим нь олборлолтын ажиллагааг хэвээр үргэлжлүүлсээр байна. Ашигт малтмалын тухай хуулийн нэг чухал заалт нь ил тод байдлын тайлан мэдээлэл гаргах шаардлага юм. Монгол Улс нь 2006 оноос Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын гишүүн орон юм.

Бичил уурхайгаас ашигт малтмал олборлох журам нь (ЗГ-ын 2010 оны 308 дугаар тогтоол) хувийн болон бичил уурхайн үйл ажиллагааны эрх зүйн хүрээг тогтоож байна. Өнгөрсөн арав орчим жилийн хэрэгжилтийн тайлан мэдээнээс үзвэл техникийн шаардлага, тухайлбал гишүүдийг орон нутагт бүртгэлд хамруулах, хувийн уурхайчдын хоршоо байгуулах асуудлууд хүндрэлтэй хэвээр байна (Шигтгээ 1.2).

#### Эрчим хүч

Эрчим хүчний тухай хууль (2001)-иар сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, хуваарилалт, нийлүүлэлт, хэрэглээ болон эрчим хүчтэй холбоотой зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохицуулж байна.



**Шигтгээ 1.2: Хувийн болон бичил уурхайн үйл ажиллагааны эрх зүйн орчин**

Бичил уурхайгаас ашигт малтмал олборлох журмын (ЗГ-ын 2010 оны 308 дугаар тогтоол) дагуу хувиараа олборлолт хийж байгаа, уг журмыг мөрдөж буй уурхайчдыг зөвшөөрөгдсөн газарт олборлолт хийх, жижиг хоршоо байгуулахыг Засгийн газар дэмжиж байна. Үүнд хамрагдаагүй хууль бус уурхайчдын ажиллагааг Цагдаагийн байгууллага хориглодог.

Бичил уурхай эрхлэх зөвшөөрөгдсөн газарт уурхайчдад эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх, тэдний хүүхдийг сургууль цэцэрлэгт хамруулах үүргийг сумын засаг дарга хүлээнэ.

Журамд зааснаар хуулийн дагуу бичил уурхай эрхлэх, хоршооллын гишүүн болох, нийгмийн болон халамжийн даатгалд хамрагдахын тулд тухайн иргэд нь сумын оршин суугчаар бүртгэгдсэн байх ёстой. Алтны бичил уурхайд олборлолт хийж буй ихэнх хүмүүс тухайн сумд бүртгэгдээгүй байдаг.

Бичил уурхайгаас олборлолт хийх гэрээ байгуулах өргөдлийг хоршооны зүгээс сумын засаг даргад гаргадаг. Журамд сумын нутаг дэвсгэрт бичил уурхай хийх хоршооны талбайг 5 га-гаар, сонгосон нийт талбайн тоог 10-аас хэтрэхгүй байхаар хязгаарласан байдаг. Зарим ашигтай газарт олборлолт хийх талбай хүрэлцэхгүй байгаагаас байгуулах гэрээний тоог хязгаарлах шаардлагатай тулгарч байна.

Талбайг эргүүлж өгөхийн өмнө хоршоо нь зохих удирдамж, шаардлагын дагуу газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийж, байгаль орчны байцаагч дүгнэлт гаргасны дараа сумын засаг даргын томилсон албан тушаалтанд хүлээлгэн өгнө. 2017 оны журмын нэг шинэлэг тал нь Хэмнэлттэй, үр ашигтай нөхөн сэргээх арга зүйн дагуу нөхөн сэргээлтийн ажлыг хийхийг шаарддаг болсон явдал юм.

Хуучин болон шинэ журмуудаар хүлээх нэг чухал үүрэг бол бичил уурхайд химийн болон аюултай бодис ашиглахыг хориглосон явдал. Түүнчлэн эдгээр 2010 болон 2017 оны аль я журамд 18 нас хүрээгүй хүүхдүүдийг бичил уурхайд ажиллахыг хориглосон бөгөөд хүмүүс хүнд ажилд хүүхдийг оролцуулдаггүй учир энэ заалт үндсэндээ мөрдөгдөж байна.

2017 оны шинэ журмаар бичил уурхайн аюулгүй байдалд хяналт тавих, бичил уурхайд ажиллаж байгаа уурхайчдад өөр ажлын байр бий болгох талаарх аймгийн Засан даргын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлсэн байна.

Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль (2007) нь сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, хангалтын эрх зүйн үндсийг бүрдүүлж, төр-хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, эрчим хүчний зах зээлд чиглэсэн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор уг хуульд 2015 онд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Сэргээгдэх эрчим хүчний олон улсын агентлагийн (СЭХОУА) Сэргээгдэх эрчим хүчний 2016 оны үнэлгээгээр хуулийн хэрэгжилт нэлээд бэрхшээлтэй тулгарч, сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалт, хөгжлийн шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх явц удааширч байгааг тэмдэглэсэн байна. Тухайлбал хуульд тусгасан дэмжих тарифыг авахад: (i) дэмжих тарифын үйлчилгээний хугацаа богино, сэргээгдэх эрчим хүчний үнийн урт хугацааны баталгаа байхгүй байгаа нь хөрөнгө оруулалтын эрсдлийг нэмэгдүүлэх (энэ асуудлыг 2015 оны нэмэлт өөрчлөлтөөр зохицуулсан), (ii) валютын эрсдэл нөлөөлж байна. Ирээдүйд сэргээгдэх эрчим хүчийг төрөлжүүлэхийн тулд дамжуулах шугам сүлжээний тогтвортой байдлын үнэлгээ хийх шаардлагатайг СЭХОУА-гийн тайланд онцолсон байна. Хуульд Сэргээгдэх эрчим хүчний сан байгуулах тухай заасны дагуу ийм сан байгуулсан боловч ажиллагааг нь зогсоосон байна.

Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль (2015) нь энэ асуудлыг хөндсөн анхны хууль юм. Хуулиар Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийг байгуулж, Эрчим хүчний зохицуулах хорооны үүргийг шилжүүлжээ. Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл нь эрчим хүч хэмнэлтийн төрийн бодлого, хуулийн хэрэгжилтийг улсын хэмжээнд хангах, эрчим хүч хэмнэлтийн үндэсний хөтөлбөрүүдийг боловсруулах, эрчим хүч хэмнэлтийн аудитор, менежер нарт гэрчилгээ олгох асуудлыг хариуцана. Хуульд “үүрэг хүлээсэн хэрэглэгч”-ээр эрчим хүчний хэрэглээ нь Засгийн газраас тогтоосон хэмжээнээс давсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг тодорхойлж, “үүрэг хүлээсэн хэрэглэгч” бүрийг зөвлөлд бүртгэх, эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглэх, хэрэглээнд эрчим хүчний аудит хийлгэх, эрчим хүчийг хэмнэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, эрчим хүч хэмнэлтийн менежер томилон ажиллуулах үүргийг ноогдуулжээ. “Үүрэг хүлээсэн хэрэглэгч” нарын анхны жагсаалтыг тус Зөвлөл 2016 оны 12 дугаар сард зарласан байна. Бусад хэрэглэгчид эрчим хүч хэмнэлтийн аудитыг сайн дураар хийлгэнэ. Эрчим



хүчийг үр ашигтай, хэмнэлттэй хэрэглэж буй иргэд, хуулийн этгээд, байгууллагыг урамшуулах, дэмжих журмуудыг Зөвлөл боловсруулах шаардлагатай байна.

Цөмийн эрчим хүчний тухай хууль (ь (2009)-иар цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт, цөмийн реактор барих, ашиглах, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, хүн ам, байгаль орчныг ионжсон цацрагийн сөрөг нөлөөллөөс хамгаалах асуудлыг зохицуулан, Цөмийн энергийн газрын эрх хэмжээг тодорхойлж өгсөн байна. Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль (2000) хүчин төгөлдөр үйлчилж байна.

### Тээвэр

Монгол Улс тээврийн хэрэгсэлийн нийт шатахууны (бензин, дизель) 95 хувийг ОХУ-аас импортолж байна. Дизелийн түлшний чанарын үндэсний стандартыг (MNS 0216:2006) 2017 оны 4 дүгээр сард шинэчилсэн бөгөөд (MNS 0216:2017) түүнийг 2018 оны 10 дугаар сараас мөрдөж эхэлнэ. Стандартад түлшний чанарын 3 ангилал тогтоосон (K3-K5) байна. K5 нь хүхрийн агууламжийн хатуу шаардлагатайн (10 ppm) хувьд европын түлшний EN590: 2009 (Euro 5) стандарттай бүрэн нийцэх түвшинд хүрэх юм. Бензины хувьд (K3-K5) хар тугалганы агууламж 2.5 ppm –ээс бага байх, бензолын агууламж 1 хувиас хэтрэхгүй байх стандарт үйлчилж байна.

ТХАХ (2016)-нд Евро-4, Евро-5 стандартын шатахууны дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр заасан байна. Агаар, байгаль орчны бохирдлыг 2017-2025 онд бууруулах 2017 оны үндэсний хөтөлбөрт Евро-5 стандартад шилжихээр тусгажээ.

Засгийн газар импортоор оруулж буй автомашин, ялангуяа хуучин машины тоог хязгаарлах зорилгоор албан татварыг хөдөлгүүрийн багтаамж (шоо см) болон насжилтаар нь ялгавартай тогтоосон байна (Бүлэг 3). Хосломол хөдөлгүүртэй (гибрид), шингэрүүлсэн хийн хөдөлгүүрт, цахилгаан машиныг 2017 оны 7 дугаар сар хүртэл албан татвараас чөлөөлж байсан. Гэвч бензин, шатахууны албан татвар бага байгаа нь шатахууныг хэмнэлттэй ашиглахад саад учруулж байна (Бүлэг 3).

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг 2015 онд ихээхэн шинэчилж, хамгаалалтын бүсээ бүслээгүй зорчигчдыг торгох (жолоочид торгууль ноогдуулахын хамт), мотоцикл эзэмшигч нар заавал дуулга өмсөх, согтуугаар машин жолоодсоны торгуулийг нэмэгдүүлэх, жолоодох үед гар утас ашигласанд торгууль ноогдуулах, ядарсан үед тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх зэрэг заалтуудыг оруулсан байна.

### Хөдөө аж ахуй

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012)-иар малчид бэлчээрийг сэлгэн ашиглах, тариаланчид хөрсийг хамгаалах, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх технологи нэвтрүүлэх, талбайн орчимд салхинаас хамгаалах ойн зурвас байгуулах, тариалалтын зурвасыг 50-100 метрийн өргөн, 30-50 метрийн урттай байхаар тогтоосон байна. Хөрсний үржил шимийг суурь байдлаас доройтуулахыг хуулиар хориглосон байна.

Органик хүнсний тухай хууль (2016)-иар органик ХАА, органик хүнс, тэжээл, бордооны үйлдвэрлэл, тэдгээрийн гэрчилгээ, худалдаа, импорт, бүтээгдэхүүний шошго хэрэглэх зэрэг асуудлыг зохицуулсан. Органик үйлдвэрлэл нь хөрс, ус, агаар, ургамал, амьтан, хүний оршин тогтохуйн аюулгүй байдал, экологийн тогтолцоонд хохирол учруулахгүй байх зарчимд суурилна. Хүнс, тэжээлийн агуулгын 90 ба түүнээс дээш хувь нь органик байвал органик хүнс, тэжээл хэмээн үзнэ. Органик үйлдвэрлэлд цацраг идэвхт бодис, ахуйн болон аж үйлдвэрийн хог хаягдал, цэвэрлэх байгууламжийн лаг шавар, хувиргасан технологиор үйлдвэрлэсэн материал, ХАО ашиглахыг хориглоно. Органик үйлдвэрлэлд ойн нөөц, байгалийн ургамал ашиглахын хувьд сүүлийн гурван жилд зөвшөөрөгдсөнөөс бусад ариутгах бодис хэрэглээгүй талбайгаас хураасан байна. Органик үйлдвэрлэгчид хүнсний түүхий эд материал, бүтээгдэхүүний жинхэнэ унаган шинж чанарыг хадгалсан, хаягдалгүй, бага хаягдалтай технологийг хөгжүүлэн ашиглах, хүний болон амьтны эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй байх, усны нөөцийг хэмнэлттэй ашиглах үүргийг хүлээнэ. Органик үйлдвэрлэл болон бүтээгдэхүүний гэрчилгээ, баталгааг хоёр жил тутамд хийнэ. Органик бүтээгдэхүүнийг хамгаалах хугацааг органик

бүтээгдэхүүн бүрт түүний байршил, төрөл, БОНУ-ний дүгнэлт болон бусад үзүүлэлтийг харгалзан гэрчилгээжүүлэх мэргэжлийн байгууллага тогтооно.

Хүнсний тухай хуулийг 2012 онд шинэчлэн найруулж, хүнсний чанар, тэжээллэг болон тогтвортой байдлыг хангах, хүнсний стратегийн нөөцийг бүрдүүлэх, хүнсний үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, урамшуулах, хяналт шалгалтыг сайжруулах, хэрэглэгчдийг дэмжих асуудлыг тусгасан байна. Хуульд хоол тэжээлийн үндэсний судалгааг 5 жил тутамд хийхээр заажээ.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль (2012) -иар түүхий эд, хүнсний бүтээгдэхүүн, тэдгээрийн баглаа боодол, шошгоны аюулгүй байдал, импорт экспортод төрөөс тавих хяналтын асуудлыг зохицуулж байна.

Газар тариалангийн тухай хууль (2016)-иар ХАА-н зориулалтаар ашиглах хөрсний нөхцөл байдал, чанар, хөрсийг хадгалан хамгаалах, нөхөн сэргээх ажиллагаа, хөрсний чанарын мониторингийг зохицуулна.

Бэлчээрийн тухай хуулийн төслийг боловсруулсан боловч батлагдаагүй байна (Бүлэг 12). Хуулийн төслийн гол санаа нь илүү зохицуулалттай бэлчээрийн төлөвлөлт, менежментийн тогтолцоонд шилжих явдал ажээ.

#### Аялал жуулчлал

Аялал жуулчлалын тухай хуульд (2000) аялал, жуулчлал эрхэлдэг байгууллага, компаниуд үндэсний түүх, соёл, байгалийн үнэт, дурсгалт газруудыг хамгаалах, хадгалах шаардлагатай арга хэмжээ авах, аливаа зөрчлийг холбогдох байгууллагуудад мэдээлэх, улсын нийгэм-эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэхийг эрмэлзэх, орон нутгийн хүн амын эрүүл мэнд, зан заншил, уламжлалыг дэмжих асуудлыг тусгасан байна.

Монголд ирж буй жуулчдын 60 гаруй хувь нь тусгай хамгаалалттай газарт зорчихоор ирдэг. ТХГН-ийн тухай хууль (1994)-иар дархан цаазат газрын зарим хэсэгт, үндэсний паркуудын жуулчдын бүст аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг, зарим газарт төлбөр төлдөг хэдий ч орлогыг ТХГ-ын сүлжээний хөгжил, менежментэд зарцуулахгүй байна. ТХГН-ийн тухай хуульд ТХГ-ын хамгаалалтын санхүүжилтийг олон эх сурвалжаас, тухайлбал жуулчлалын орлогоос бүрдүүлэхийг (Зүйл 6) заасан байдаг боловч энэ заалт амьдрал дээр хэрэгжихгүй байна.

#### *Холбогдох бусад хуулиуд*

Төрийн хяналт шалгалтын тухай хууль (2003)-иар хяналт шалгалтын арга хэлбэр, төрөл, үйл ажиллагааг зохицуулж байна. Энэ хуульд хүний амь нас, эрүүл мэнд, нийгмийн болон байгаль орчны аюулгүй байдлыг хамгаалах нь хамгийн дээд үндсэн зарчим хэмээн тодорхойлжээ. Хуулиар мэргэжлийн хяналтыг төвлөрсөн удирдлагаар хангахын тулд МХЕГ-ыг байгуулж, байгууллагыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан. Уг хуульд 2010 онд нэмэлт өөрчлөлт оруулж хяналтын этгээдийн эрсдлийг бууруулах асуудлыг тусгасан байна.

Хууль тогтоомжийн тухай 2015 оны хууль (2017 оноос хүчин төгөлдөр болсон), Захиргааны ерөнхий хуулиуд нь олон нийтийн оролцооны механизм, хууль тогтоомжийн төсөл боловсруулах, захиргааны шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог идэвхжүүлэх талаар заасан байна.

Шилэн дансны тухай хуульд (2014) төр засгийн бүх байгууллагууд, төрийн оролцоотой хуулийн этгээдүүдийг төсөв, санхүү болон холбогдох бусад мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй болгохоор тусгажээ.

Аж ахуйн байгууллагын тусгай зөвшөөрлийн тухай хууль (2001)-иар тодорхой бизнес эрхлэх зөвшөөрөл олгох, үндэсний болон байгаль орчны аюулгүй байдал, олон нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, тусгай нөхцөл, мэдлэг туршлага шаардах зөвшөөрлийг зогсоох, цуцлах тухай асуудлыг зохицуулсан байна. Тухайлбал озон задалдаг бодис, аюултай болон хорт химийн бодис,

ургамал хамгаалах бүтээгдэхүүн ашигладаг үйл ажиллагаа, ашигт малтмал олборлох, нарийвчилсан БОНУ боловсруулахад тусгай зөвшөөрөл олгоно.

Тамхины хяналтын тухай хууль (2005)-ийг 2013 онд үлэмж шинэчлэн, тамхины хэрэглээ, дам тамхидалтаас үүдэлтэй сөрөг үр дагавраас хүн амыг хамгаалах зорилгоор нийтийн тээвэр, баар ресторан, худалдааны төв, цэнгээний газар, албан байгууллага зэрэг бүх олон нийтийн газарт зөвшөөрөгдсөнөөс бусад цэгт тамхи татахыг хоригложээ. Тамхины бүх төрлийн сурталчилга, тамхины хил дамнасан зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа, тамхи худалдах автомат машин ажиллуулах, интернэтээр тамхи худалдахыг хоригложээ.

### **1.5 Байгаль орчин, ногоон эдийн засаг, тогтвортой хөгжлийн чиглэлээр ажилладаг байгууллагуудын бүтэц зохион байгуулалтын тогтолцоо**

#### *Байгаль орчин, аялал жуулчлалын яам*

Байгаль орчны асуудал эрхэлсэн яамыг анх 1987 онд байгуулсан (БНМАУ-ын УИХ-ын 1987 оны 169 дүгээр тогтоол) байна. Энэ үеэс хойш төрийн яамны статустай үйл ажиллагаа явуулж иржээ. Байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага яамны түвшинд тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа нь байгаль орчны бодлого, хууль тогтоомжийг боловсруулах, хэрэгжүүлэх, салбарын яамдын бодлого, хууль тогтоомжид байгаль орчинтой холбоотой заалтуудыг суулгахад эергээр нөлөөлж байна.

1987 оноос хойш тус яам нь байгаль орчинтой холбоотой бүх асуудлууд, тухайлбал агаар, ус, ой, хөрс, цөлжилт, байгаль хамгаалал, хадгалалт, биологийн олон янз байдал, ТХГ, хог хаягдал, байгаль орчны үнэлгээг бүхэлд нь хариуцаж иржээ. 1987 оноос хойш яамны эрх үүрэгт дараах гол өөрчлөлтүүд оржээ:

- Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрыг 2002 онд байгуулснаар Байгаль орчны яамнаас газрын менежментийн үүргийг салган, яамны газрын харилцааны газрыг ГХГЗЗГ-ын харъяанд шилжүүлсэн,
- Мэргэжлийн хяналтын бүхий л салбарын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий бие даасан МХЕГ-ыг Ерөнхий сайдын дэргэд 2003 онд байгуулснаар байгаль орчны хяналт, хуулийн хэрэгжилтийг хангах үүргийг байгаль орчны асуудал эрхэлсэн яамны үүргээс хассан,
- Аялал жуулчлалын асуудлыг хариуцах үүргийг тус яаманд 2008 онд ноогдуулсан. Аялал жуулчлалын асуудлыг 2012-2014 онуудад байгаль орчны асуудал эрхэлсэн яамны үүргээс соёлын асуудал эрхэлсэн яаманд шилжүүлсэн боловч 2014 онд уг үүргийг дахин байгаль орчны асуудал эрхэлсэн яаманд буцаан шилжүүлжээ. Байгаль орчин, аялал жуулчлал хариуцсан төрийн албан хаагчид аялал жуулчлалын асуудлыг байгаль орчны асуудал эрхэлсэн яам хариуцах нь бүх талаар оновчтой, ялангуяа ТХГ-ын менежментийн хувьд ашигтай болохыг онцолдог,
- Ногоон хөгжлийн тухайн асуудлыг тухайн үеийн Байгаль орчны яаманд 2012 онд ноогдуулж, яамны нэрийг Байгаль орчин, ногоон хөгжлийн яам болгосон. Үндэсний хөгжлийн газрыг 2016 онд байгуулсанаар байгаль орчны асуудал эрхэлсэн яамны нэрээс “ногоон хөгжил” тодотголыг хассан хэдий ч ногоон хөгжлийн асуудлыг тус яам хариуцсан хэвээр байна,
- Байгаль орчны асуудал эрхэлсэн яамны шууд удирдлаган дор 2005 оноос хойш усны нөөцийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, усны зөвшөөрөл олгох зэрэг төрийн бодлогыг хэрэгжүүлж байсан бие даасан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийг 2012 онд татан буулгаж, үүргийг тухайн үеийн БОНХЯ-ны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого, зохицуулалтын газарт шилжүүлсэн байна.

БОАЖЯ-ны эрхэм зорилго нь 2017 оны байдлаар байгаль орчныг хадгалан хамгаалах, тогтвортой хөгжлийг хангах, ТХЗ-уудыг хэрэгжүүлэхийн тулд төр, иргэд, хувийн хэвшлийн болон бусад байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад оршиж байна.

Байгаль орчны асуудал эрхэлсэн яамыг 2012 оноос ерөнхий чиг үүргийн яам болгожээ. Ерөнхий чиг үүргийн яам нь салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулах, чиглэлийн бусад яамдаас өөрийн шийдвэрийг биелүүлэхийг шаардах эрхтэй байдаг. Одоогоор Хууль зүй, Сангийн, Гадаад харилцаа, Батлан хамгаалах болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамд нь ерөнхий чиг үүргийн яамны статустай байна.

БОАЖЯ, түүний харьяа байгууллагууд 2017 онд нийт 2868 ажилтантай, үүнээс 121 нь яамны төв аппаратад ажиллаж байна (Зураг 1.2). Яамны нэг тулгамдсан асуудал бол түүний ажилтнуудын тогтвор суурьшил болоод байна. Өнгөрсөн жилүүдэд засгийн газар олон удаа (дунджаар 18 сар тутамд) солигдож, солигдох тутам яамны удирдлага (сайд, дэд сайд, ТНБД), удирдах түвшний (газар, хэлтсийн дарга нар) ажилтнууд өөрчлөгдөж байгаа нь байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогыг тууштай хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

#### Цаг уур, орчны шинжилгээний газар

Цаг уур, орчны шинжилгээний газар (ЦУОШГ) нь ус, цаг уур, байгаль орчны мониторинг, ус, цаг уурын урьдчилсан төлөвийг тогтоох үүрэг бүхий төрийн гол байгууллага юм. Тус газрын үүрэгт байгалийн гамшгаас эртнээс сэргийлэх, ялангуяа хүний эрүүл мэнд болон мал сүрэгт үзүүлэх нөлөөллийг багасгах асуудал мөн хамаарна. Засгийн газрын дэргэдэх Ус, цаг уурын албыг 1976 онд Ус, цаг уур, орчны шинжилгээний ерөнхий газар болгосноор байгаль орчны мониторингийн үүргийг түүнд шилжүүжээ. Байгаль орчны асуудал эрхэлсэн яамыг 1987 онд байгуулснаар байгаль орчны мониторингийн асуудал улам шаардлагатай, илүү ач холбогдолтой болсон байна.

Өнөөдрийн байдлаар ЦУОШГ нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн статустай, БОАЖЯ-ны харьяанд ажиллаж байна. ЦУОШГ нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг тул түүний даргыг засгийн газар томилдог тул тус газар нь яамны харьяа байгууллагуудаас илүү бие даасан байдалтай ажилладаг. ЦУОШГ-ын зохион байгуулалтын бүтцэд (Зураг 4.1) Ус, цаг уур, байгаль орчны мэдээлэл, судалгааны хүрээлэн, түүний харьяанд байгаль орчны мэдээллийн төв (одоогийн байдлаар хүрээлэнгийн Байгаль орчны мэдээллийн сангийн хэлтсийн хэмжээнд ажиллах болж статус нь буурсан) зэрэг байгууллагуудтай. Аймаг бүрт ЦУОШГ-ын харьяа Ус, цаг уур, байгаль орчны шинжилгээний газар ажилладаг. ЦУОШГ нь харьяандаа 22 лабораторитай, үүнээс 21 аймаг тус бүрт нэг, төвд нэг нь ажилладаг. ЦУОШГ нь нийт 1,930 гаруй ажиллагсадтай.

#### Байгаль орчин, уур амьсгалын сан

Байгаль хамгаалах санг 1998 онд байгуулж, 2012 он хүртэл төсвөөс санхүүжүүлж ирсэн. Түүнийг 2012 онд байгаль орчны асуудал эрхэлсэн яамны харьяа бие даасан хуулийн этгээд болгосон бөгөөд, нэрийг нь 2017 онд Байгаль орчин, уур амьсгалын сан болгон өөрчилсөн. Сан нь 5 ажилтантай.


#### Усны сав газрын захиргаад

Монгол Улсад нийт 208 ажилтантай усны сав газрын 21 захиргаа ажиллаж, 29 сав газрыг хариуцаж байна. Усны сав газрын захиргааны даргыг БОАЖЯ томилж, захиргаа нь усны сав газрын менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийн зохицуулалт хийх, усны тооллого бүртгэлийг сав газрын түвшинд хийх, ус хангамж болон бохир ус зайлуулах цэгүүдийг байгуулах, сав газрын мэдээллийн сан байгуулж баяжуулах, олон нийтийг мэдээллээр хангах, усны сав газрын зөвлөл байгуулах санал дэвшүүлэх үүрэгтэй ажиллаж байна.

#### ТХГ-ын захиргаад

Монгол Улс нийт 607 ажилтантай ТХГ-ын 33 захиргаатай (гурвыг нь ТББ удирддаг), захиргаад нь БОАЖЯ-ны ТХГ-ын удирдлагын газрын удирдлага доор ажилладаг байна. Нэг захиргаа нь хэд хэдэн ТХГ-ыг хариуцдаг, ТХГ бүр өөрийн бие даасан захиргаагүй (тухайлбал, үндэсний паркууд нь өөрийн паркийн захиргаагүй), заримд нь жуулчдын төв ажилладаг. ТХГ-ын захиргаа нь байгаль хамгаалагчдыг томилон ажиллуулдаг. ТХГН-ийн тухай 1994 оны хуулиар тэдгээр байгаль хамгаалагчид нь байгаль орчны байцаагчтай адил статустай болсон байна.

Зураг 1.2: БОАЖЯ-ны төв аппаратын бүтэц, зохион байгуулалт





## Салбарын яамд

### Хүнс, ХАА, хөнгөн үйлдвэрийн яам

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ) нь мал аж ахуй (МАА), газар тариалан, хүнсний аюулгүй байдал, хөнгөн үйлдвэр (ноос, ноолуур, хэвлэл, барилгын материал, хог хаягдлыг дахин боловсруулах, баглаа боодол, гоо сайхны болон ахуйн хэрэглээний бараа г.м) болон жижиг, дунд аж ахуйн нэгж (ЖДААН)-ийн бодлого, хууль эрх зүйн баримт бичгийг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэгтэй. Яам нь бордоо, пестицидын баглаа боодол, аюулгүй хэрэглээний асуудлыг мөн хариуцаж, пестицид, химийн бодисыг ХАА-д ашиглахыг БОАЖЯ, ХХААХҮЯ, ЭМЯ хамтран зохицуулдаг байна.

ХХААХҮЯ нь үхсэн амьтны сэгийг цэвэрлэх, ХАА-н үйлдвэрлэлийн хаягдал, хөнгөн аж үйлдвэрийн хог хаягдлыг дахин боловсруулах зэрэг хог хаягдалтай холбоотой үүрэг хүлээнэ. ХХААХҮЯ нь Улаанбаатар хотын арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн хог хаягдлын менежмент, Туул голд химийн бодис цугтан усны чанарыг доройтуулж байгаа асуудлаар БОАЖЯ, Улаанбаатар хотын захиргаатай хамтран ажиллаж байна.

Хүнсний гаралтай өвчинд хяналт тавих нь ХХААХҮЯ -ны үүрэг бөгөөд яамны харъяанд Мал эмнэлэг, үржлийн газар, Мал эмнэлэг, ариун цэврийн лаборатори, Мал эмнэлгийн үндэсний хүрээлэн зэрэг мэргэжлийн байгууллагууд ажилладаг.

Гений өөрчлөлттэй организм (ГӨО)-ийн хувьд ХХААХҮЯ зөвхөн ГӨО-ийн үүсэлтэй бүтээгдэхүүнийг бүртгэдэг байна. Яамны харъяанд 1996 онд байгуулагдсан ХАА эрхлэлтийг дэмжих үндэсний төв нь бүх аймаг, олон сумдад өөрийн салбартай ба малчин, тариалагчдад бүх төрлийн дэмжлэг, үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

### Зам тээврийн хөгжлийн яам

Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамыг 2012 онд салган, Зам тээврийн хөгжлийн яам, Барилга, хот байгуулалтын яамыг тус тус байгуулсан байна. Зам тээврийн хөгжлийн яам нь замын бодлого, хуулийг боловсруулан хэрэгжүүлэх, засмал замын сүлжээг нэмэгдүүлэх, нийтийн тээвэр (байгальд ээлтэй тээврийн хэрэгсэл, эко жолоодлого), автомашины зай хураагуурыг аюулгүй байдлаар устгалд оруулах, замын аюулгүй байдлыг хариуцана.

### Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ) нь бодлогын 4 газар (геологи, уул уурхай, шатахуун, хүнд үйлдвэр), бодлогын зохицуулалтын нэгдсэн нэг газартай, байгаль орчны асуудлыг хариуцсан газаргүй хэдий ч газар бүрт тус асуудлыг хариуцдаг мэргэжилтэнтэй. Яамны үүрэгт ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, уул уурхай, бичил уурхайгаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн бодлого боловсруулах асуудал тусгагдсан байдаг байна.

Засгийн газрын 2016 оны бүтцийн өөрчлөлтөөр хүнд үйлдвэрийн асуудал тус яамны мэдэлд шилжин иржээ. Яам нь олборлосон ашигт малтмалд суурилан аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, шатахууны чанарт хяналт тавих (өмнө нь үүнийг Зам, тээврийн яам хариуцаж байсан), дотооддоо шатахуун үйлдвэрлэх зорилгыг хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагааг хариуцана.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны бодлогоор хаагдсан уул уурхай, эвдэрсэн, сүйтгэсэн газрын (хуучин цэргийн баазуудыг оролцуулан) нөхөн сэргээлтийн ажлыг БОАЖЯ тэргүүлэн, холбогдох бусад яамдын оролцоотой шийдвэрлэхийг зорьж байна.

Ашигт малтмалын газар (1997 онд байгуулагдсан) болон Газрын тосны газрыг 2016 онд нэгтгэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны харъяанд Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ) болгон байгуулсан байна. АМГТГ нь геологи, олборлолт, уул уурхайн үйлдвэрлэл болон технологи, нүүрсний судалгаа, газрын тосны олборлолт, үйлдвэрлэлийг хариуцдаг, байгууллагын ил тод байдлыг хангах зорилгоор Эрдэс баялгийн нөөцийн мэдээллийн төвийг саяхан байгуулжээ. Тус төв нь улсын төсвөөр

хийсэн геологийн судалгааны дүнг цахим хэлбэрт шилжүүлж байна. Кадастрын хэлтэс нь олборлолтын зөвшөөрөл хүссэн өргөдлийг цахимаар авах хэлбэрийг саяхан нэвтрүүлсэн байна.

#### Эрчим хүчний яам

Эрчим хүчний яам нь эрчим хүчний бодлого, хуулийг боловсруулах, хэрэгжүүлэх, эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулах шугам сүлжээ, дулаан хангамж, ДЦС-ууд, сэргээгдэх эрчим хүч, нүүрсний цэвэр технологи зэрэг асуудлыг хариуцдаг. Эрчим хүчийг үр ашигтай, хэмнэлттэй ашиглах асуудлыг яам бус, Эрчим хүчний зохицуулах хороо хариуцдаг байна.

#### Барилга, хот байгуулалтын яам

Барилга, хот байгуулалтын яамны гол үүрэг нь барилга, хот байгуулалт, газрын харилцаа, барилгын аж үйлдвэр болон материал, орон сууц, нийтийн шугам сүлжээний бодлого, хуулийг боловсруулах, хэрэгжүүлэхэд оршино.

Газрын тухай хууль (1994)-д 2002 онд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрыг (ГХГЗЗГ) байгуулсан байна. ГХГЗЗГ-г тухайн үеийн БОЯ-ны Газрын харилцааны газар, Дэд бүтцийн яамны Геодези, зураг зүйн газар, ХЗДЯ-ны Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газар зэрэг 3 байгууллагыг нэгтгэн байгуулж, 2002-2004 онд Ерөнхий сайдын эрх үүрэгт хамаарагдаж байсан боловч 2004 оноос Барилга, хот байгуулалтын яамны харъяанд шилжиж, газрын харилцаа, газрыг хувьчлах, кадастр, геодези, зураг зүй, үл хөдлөх хөрөнгийн өмчлөл, эрх үүргийн талаарх төрийн бодлогыг хариуцан ажиллаж байна.

#### Эрүүл мэндийн яам

Эрүүл мэндийн яам нь хүн амын эрүүл мэнд, эрүүл ахуй, ариун цэвэр, хүнсний үйлдвэрлэлийн аюулгүй байдлын нэгдсэн бодлогыг хариуцдаг. Яамны харьяа Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн хүний эрүүл мэнд, түүний нийгэм-эдийн засаг, байгаль орчны үзүүлэлтүүд, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ, эрүүл мэндийн асуудлаар шийдвэр гаргагчдыг мэдээ мэдээллээр хангах үүргийг хүлээдэг. 2011 оноос хүрээлэнгийн дэргэд Нийгмийн эрүүл мэндийн хяналт, мэдээллийн албыг байгуулсан байна. Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн Байгаль орчны шинжилгээний төв нь ус, хөрсний бохирдлын судалгааг эрхэлж байна.

#### Сангийн яам

Сангийн яам нь богино хугацааны бодлогын төлөвлөлт, төсвийн асуудлыг хариуцдаг.

#### Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

Сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсрол, албан бус болон насан туршийн боловсролыг хариуцдагийн хувьд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам нь тогтвортой хөгжлийн боловсролын асуудлыг бүх шатны боловсролын тогтолцоонд суулгах үүрэг хариуцлагыг хүлээдэг байна.

#### Хууль зүй, дотоод хэргийн яам

Хууль зүй, дотоод хэргийн яам нь байгаль орчинтой холбоотой болон бусад хуулийн төслийг хянах, дүгнэлт гаргах үүрэгтэй.

#### *Мэргэжлийн хяналтын ерөнхий газар*

Ерөнхий сайдын дэргэдэх Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг (МХЕГ) Ерөнхий сайдын дэргэд төрөл бүрийн салбарын хуулийн хяналтыг нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор бие даасан агентлаг байдлаар 2003 онд байгуулжээ. Тус газар нь ажлаа шадар сайдад шууд тайлагнадаг. Тус газрыг байгуулахаас өмнө яам бүр өөрийн чиглэлийн хуулийн хяналтыг гүйцэтгэдэг байжээ.

Байгаль орчны байцаагчийн ажил үүргийн хуваарьт байгаль орчны 26 хуулиар зохицуулсан ой, амьтан ургамал, биологийн олон янз байдал, ус, хөрс, агаар болон бусад асуудлууд хамаардаг. Байгаль орчны бүх байцаагч нар мэргэжлийн хяналтын гэрчилгээтэй байх ёстой.

МХЕГ-ын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын газрын 7 байцаагч байгаль орчин, аялал жуулчлалын асуудлыг хариуцан ажиллаж байна.

#### Аймгийн мэргэжлийн хяналтын газар

МХЕГ нь аймаг бүрт аймгийн мэргэжлийн хяналтын газартай. Аймгийн газрын байгаль орчны байцаагчийг (аймаг бүрт 3 орчим, аймгуудын газарт нийт 65 байцаагчтай) аймгийн засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр МХЕГ-аас томилж, байцаагч нар МХЕГ-ын удирдлаган дор ажиллаж МХЕГ-т ажлаа тайлагнадаг байна.

#### Сумдын байгаль орчны байцаагч

Сумдад байгаль орчны байцаагч ажиллах (сум бүрд голдуу 1 байцаагч) бөгөөд тэднийг сумын засаг даргын ажлын албаны дарга томилж, сумын захиргааны төсвөөс цалинжин, засаг дарга болон аймгийн мэргэжлийн хяналтын газарт ажлаа тайлагнадаг байна. Сумын байгаль орчны байцаагч нар МХЕГ-т шууд харъяалагдахгүй хэдий ч мэргэжлийн удирдамжаар хангагдана. Сумын байгаль орчны байцаагч нар засаг даргаас хамааралтай байгаа нь тогтолцооны дутагдал бөгөөд тэдэнд засаг даргаас албан үүрэгтэй нь холбоогүй үүрэг даалгавар өгөх явдал цөөнгүй гардаг байна.

#### Байгаль орчны бусад байцаагчид

МХЕГ нь сумын байгаль орчны байцаагч нараас гадна ТХГ-ын захиргаанаас томилдог байгаль хамгаалагчид, нийслэл хотын байцаагч нарыг мөн мэргэжлийн удирдамжаар хангах, яам бүрийн дотоод аудитын хэлтсийн мэргэжилтнүүдийг (дотоодын хянан шалгагч нар хэмээх) гэрчилгээжүүлэх үүрэгтэй .

2017 оны байдлаар БОАЖЯ-ны 10 ажилтан байгаль орчны байцаагчийн гэрчилгээтэй, өөрийн албан үүргийн зэрэгцээ байцаагчийн үүргийг гүйцэтгэдэг байна.

Тогтолцооны нэг онцлог бол төр засгийн байгууллагад алба хашдаггүй зарим хүмүүс байгаль орчны байцаагчийн үүрэг гүйцэтгэх эрхтэй, тухайлбал 2017 онд ТББ-ын хоёр хүнд байгаль орчны байцаагчийн гэрчилгээ олгосон байна.

#### Лабораториуд

МХЕГ-ын харьяанд 24 лаборатори ажиллах бөгөөд эдгээрээс нийслэлд 1, Налайх, Багануур, 21 аймагт тус бүр 1 лаборатори ажиллаж байна.

#### БОАЖЯ-тай тогтоосон хамтын ажиллагаа

МХЕГ-ыг 2003 онд байгуулсан нь бодлого, зохицуулалтыг хяналтын үүргээс тусгаарлах зорилготой байсан хэдий ч өнөөгийн байдлаар аймгийн байгаль орчны байцаагчийн ажилд аймгийн БОАЖГ-ын ажилтнууд оролцох, зарим тохиолдолд цагдаагийн ажилтнууд оролцох нь түгээмэл болсон байна. БОАЖГ-ын ажилтнууд байгаль орчны байцаагчийн гэрчилгээгүй боловч байцаагч нарт дэмжлэг үзүүлэх үүрэгтэй хэмээн ойлгодог, нөгөө талаар БОАЖЯ-ны зарим ажилтнууд бодлого боловсруулах, зохицуулах үндсэн үүргийн хажуугаар байгаль орчны байцаагчийн гэрчилгээтэй байна. Энэ нь бодлого, зохицуулалтыг хяналтын үүргээс тусгаарлахаар МХЕГ-ыг байгуулсан зорилготой зөрчилдөж байна.

Нөөцийг үр ашигтай зарцуулах, байцаагч нарын ажил үүргийн холбоог бэхжүүлэх (тухайлбал уул уурхайн болон байгаль орчны байцаагчийн) нь өнөөгийн тогтолцооны эерэг үр дүн боловч БОАЖЯ, МХЕГ-ын хамтын ажиллагааны түвшин хангалтгүй байгаа нь гол дутагдал юм. Хамтын ажиллагаа нь төрийн албан хаагчдын хувийн харилцаанаас голдуу шалтгаалж байгаа бөгөөд ажил аймгийн түвшинд төвөөс илүү үр дүнтэй явагдаж байна.

### Иргэд, ТББ-тай тогтоосон хамтын ажиллагаа

Байцаагч нар болон цагдаагийн байгууллагууд байгаль орчны хуулийн зөрчлийн талаар иргэд, ТББ-ууд мэдээлэх үйл ажиллагааг дэмжиж, мэдээлэгч нарт санхүүгийн урамшуулал олгох (тухайлбал ноогдуулсан торгуулийн тодорхой хэсгээр) тогтолцоо бий. Ойн тухай хууль (2012)-д гэмт хэрэг болон бусад хууль бус үйл ажиллагаанд ашигласан буу зэвсэг, тээврийн хэрэгсэл, техник төхөөрөмжийг хурааж, борлуулсан үнийн 70 хувьтай тэнцэх мөнгийг мэдээлэл өгсөн ТББ-д олгох, Амьтны тухай хууль (2012)-д аймаг, сумын засаг дарга нар учруулсан хохирлын торгууль, нөхөн төлбөрийн 15 хувийг мэдүүлэгчид олгохоор тус тус заасан байна. Хуульд мэдүүлэгчийн нууцлалыг хамгаалах заалт бий. Гэвч мэдүүлэгч нарын нууцлалтыг хамгаалахын зэрэгцээ тэдэнд санхүүгийн урамшууллыг зохих ёсоор олгох механизмыг сайжруулах шаардлагатай байна.

#### *Бусад байгууллагууд*

### Улсын Их Хурал

Улсын Их Хурал (парламент) байгаль орчинтой холбоотой хуулиуд, стратегийн зарим баримт бичгийг баталдаг. Зарим хууль байгаль орчны асуудлаар ихээхэн чухал үүрэг хариуцлагыг УИХ-д хүлээлгэдэг байна. Тухайлбал 2012 оны Усны тухай шинэчилсэн хуулиар ус ашигласны болон бохирдуулсны төлбөр тогтоох, гол мөрний урсацыг өөрчлөх шийдвэр гаргах үүрэг УИХ-д ноогдсан. УИХ нь Байгаль орчин, хүнс, ХАА болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороодтой.

### Үндэсний хөгжлийн газар

Ерөнхий сайдын дэргэдэх Үндэсний хөгжлийн газрыг 2016 оны 8 дугаар сард байгуулж, 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын дагуу бодлого, төлөвлөлтийг боловсруулах, хөрөнгө, гадаад хөрөнгө оруулалт, концесс, төр-хувийн хэвшлийн түншлэлийн бодлогын талаар Засгийн газарт зөвлөх, ТХЗ-уудын хэрэгжилт, мониторингийн үйл ажиллагааг зохицуулах үүрэгтэй болсон байна.

### Цагдаагийн ерөнхий газар

Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах газарт 2010 онд байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс байгуулсан байна.

### Онцгой байдлын ерөнхий газар

Ерөнхий сайдын дэргэдэх Онцгой байдлын ерөнхий газрыг (ОБЕГ) 2003 онд байгуулжээ. Тус газар нь ажлаа шадар сайдад шууд тайлагнадаг. ОБЕГ нь гамшгаас хамгаалах стратеги, эрх зүйн баримт бичгийг боловсруулах, гамшгийн эрсдэлд үнэлгээ хийх, гамшгаас сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хохирлыг багасгах, аврах, эрэн хайх үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй. ОБЕГ-ын харьяанд Гамшиг судлалын хүрээлэн ажиллаж байна.

### Стандартчилал, хэмжил зүйн газар

Ерөнхий сайдын дэргэдэх Стандартчилал, хэмжил зүйн газар нь ажлаа шадар сайдад шууд тайлагнаж үндэсний хэмжээний бүх стандартыг тогтоох, Монгол улсыг ISO-гийн хүрээнд олон улсын стандартчилалд төлөөлнө.

### Эрчим хүчний зохицуулах хороо

Засгийн газарт шууд харьяалагдах, бие даасан зохицуулах үүрэг бүхий байгууллага болох Эрчим хүчний зохицуулах хороог Эрчим хүчний тухай 2001 оны хууийн дагуу байгуулсан байна. ЭХЗХ нь цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэх, дамжуулах, түгээх компаниудад гэрчилгээ олгох, гэрчилгээний нөхцөлийг даган мөрдөж байгаад мониторинг хийх, аргачлалыг боловсруулах, төлбөр татварыг шинэчлэх, батлах үүрэгтэй байна.

Эрчим хүчийг хэмнэх нь тус газрын чухал үүрэг бөгөөд 2015 оны Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн дагуу эрчим хүчийг хэмнэх бодлогыг хэрэгжүүлэх тусгай нэгжийг хорооны бүтцэд байгуулсан байна. Хороо нь эрчим хүчийг хэмнэх үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр Даян дэлхийн ногоон өсөлтийн байгууллагатай 2017 онд Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан байна.

#### Усны үйлчилгээг зохицуулах комисс

Усны үйлчилгээг зохицуулах комиссыг Хот суурин газрын усан хангамж, зайлуулах системийг ашиглах тухай 2012 оны хуулийн дагуу байгуулжээ. Түүний үндсэн үүрэг нь ус, бохир усны үйлчилгээний төлбөр тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох явдал юм.

#### Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвийг ЭХЯ-ны дэргэд 2005 онд анх байгуулжээ. Засгийн газрын бүтцийн шинэчлэлийн дагуу тус төвийг ТӨХ-ны удирдлаган дор Төрийн өмчит өөрийгөө санхүүжүүлэх ААН болгосон байна.

#### Бизнесийн зөвлөл

Монгол улсын бизнесийн зөвлөл нь байгальд ээлтэй бизнесийн олон талт үйл ажиллагаа, эрчим хүчний салбарын хөгжил, мэдээлэл солилцоог дэмжих үүрэг бүхий Эрчим хүч болон Байгаль орчны хоёр ажлын хэсэгтэй ажиллаж байна.


#### *Аймаг, сумын байгаль орчинтой холбоотой байгууллагууд*

Засаг захиргааны хувьд Монгол Улс нь нийслэл хот, 21 аймаг, 330 сум дүүрэг, 1613 багт, нийслэл хот нь 9 дүүрэг, 152 хороонд хувагдана.

#### Аймгийн түвшинд

Байгаль орчны бодлого, хуулийг аймгийн түвшинд хэрэгжүүлэх, бэхжүүлэх үүрэг бүхий Байгаль орчин, аялал жуулчлалын газар аймаг бүрт ажилладаг. Аймгийн ийм газрын зохион байгуулалтын бүтцийг Зураг 1.3-т харуулав.

**Зураг 1.3: Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын бүтэц, зохион байгуулалтын зураг**



Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн БОАЖГ, 2017 он.

Тайлбар: Ажилтны тоог хаалтанд тусгав. Байгаль хамгаалагчид БОАЖГ болон сумын захиргаанд харъяалагдана.



Аймгийн БОАЖГ нь БОАЖЯ, аймгийн захиргаанд давхар харъяалагдах ба газрын даргыг засаг дарга БОАЖ-ын сайдтай зөвшилцөн томилдог, 2012 оноос газрын дарга нь сайд, засаг дарга нарт давхар шууд харъяалагддаг болсон байна. 2012 оноос өмнө тус газрыг яамнаас, түүнээс хойш аймгийн захиргаанаас санхүүжүүлдэг болсон, газрын дарга нь төсвөө шууд захиран зарцуулах эрхтэй байдаг.

БОАЖГ нь байгаль орчны улсын бодлого, хууль тогтоомжийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх, аймгийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, БОНУ-ний хуулийн дагуу ерөнхий үнэлгээг батлах, усны зөвшөөрөл олгох, мод шилжүүлэн суулгах зөвшөөрөл олгох, мод ургамал түүх зөвшөөрөл олгох, уул уурхайн үйл ажиллагааг батлахад оролцох үүрэгтэй.

ЦУОШГ-ын харьяа Ус, цаг уур, байгаль орчны шинжилгээний газар аймаг бүрт мөн ажилладаг байна.


МХЕГ нь аймаг бүрт аймгийн мэргэжлийн хяналтын газартай. Аймгийн газрын байгаль орчны байцаагчийг (аймаг бүрт 3 орчим) аймгийн засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр МХЕГ-аас томилж, тэд МХЕГ-т харъяалагддаг. Байгаль орчны байцаагч нарт учирч буй гол бэрхшээл нь тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн дутагдал, шатахууны төсөв бага байгаад оршиж байна.

Аймаг бүр УЦУОШГ, МХЕГ-ын лаборатори ажилладаг.

### Сумын түвшинд

Сумын засаг даргын ажлын албаны бүтэц зохион байгуулалтын бүтцийг Зураг 1.4-т харуулав.

**Зураг 1.4: Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтын дураг**



Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ЗД-ын Тамгын газар, 2017 он.

Тайлбар: Ажилтны тоог хаалтанд тусгав.

\* ЗД-ын зөвлөл 6 гишүүнтэй (албадын дарга, багийн ЗД).

\*\* Баянгол сум 3 багтай

Сумын байгаль орчны нэгжид байгаль орчны байцаагч 1, хэд хэдэн байгаль хамгаалагч ажиллана.

Сумдад зөвхөн 1 байгаль орчны байцаагч байгаа нь бүх төрлийн мэргэжлийн мэдлэгтэй байхыг шаарддаг, МХЕГ тэднийг мэргэжлийн удирдлагаар хангаж гэрчилгээ олгодог, харин өдөр тутмын

удирдлагаар сумын засаг дарга хангаж, хяналт хийх удирдамжийг баталдаг байна. Сумын байгаль орчны байцаагч бүр дүрэмт хувцсаар хангагдаж чадахгүй байна.

Аймгийн БОАЖГ-ын харьяа, аймгийн захиргаанаас цалинждаг байгаль хамгаалагчид байгаль орчны байцаагч нарт туслалцаа дэмжлэг үзүүлдэг. Байгаль хамгаалагчдыг аймгийн БОАЖГ-аас сумын засаг даргатай зөвшилцөн томилдог ба тэд аймгийн БОАЖГ, сумын засаг даргад ажлаа тайлагнадаг. Сум дахь байгаль хамгаалагчдын тоо нутаг дэвсгэрээс хамаардаг бөгөөд байгаль орчны байцаагч нь тэдний ажлыг удирдан хянах үүрэгтэй.

Сумын байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагчдын хангамж, хэрэгсэл дутмаг, тухайлбал Сэлэнгэ аймгийн Баянгол сумын 3 байгаль хамгаалагчдын дунд ганц мотоциклтай, байгаль хамгаалагчид өөрсдийн автомашиныг ашиглаж сумын төсвөөс шатахууны зардлыг гаргах, эсвэл сумын засаг даргын албанаас машин гаргадаг байна. Баянгол сумын байгаль орчны байцаагчид автомашин, мотоцикл байхгүй ажээ.

Сумын хог хаягдал болон үйлчилгээний асуудлыг ихэнхдээ нэг компани бүхэлд нь хариуцдаг байна.

Сумын засаг даргын зөвлөл нь байгаль орчин болон бусад асуудлаар Засаг даргад зөвлөх, сумын захиргаа уул уурхайн компаниудтай байгаль орчныг хамгаалах, дэд бүтэц байгуулах, ажлын байр бий болгох гэрээ байгуулахад зөвлөх үүрэгтэй ажилладаг байна.

#### *Босоо зохицуулалт*

БОАЖЯ, аймгийн БОАЖГ хоорондын босоо зохицуулалт харьцангуй сайн, тухайлбал аймгийн БОАЖГ-аас хууль, бодлогын төсөлд саналаа хүргүүлэх, сумдын нэгжээс санал цуглуулж яаманд хүргүүлэх ажил хэвшсэн байна. Энэ механизм нь бусад хууль тогтоомжийн хувьд үйлчилж байгаа боловч эдгээр хуулиудын талаар аймгийн БОАЖГ, сумдын нэгжээс санал авах ажил жигдрээгүй байна.

МХЕГ, аймгийн салбар газрууд, мэргэжлийн байцаагч нар хоорондын босоо зохицуулалт сайн явагдаж байгаа хэдий ч МХЕГ, сумдын байгаль орчны байцаагч нарын ажлын уялдаа холбоо хангалтгүй байна.

#### *Хэвтээ зохицуулалт*

##### Үндэсний хэмжээнд

Үндэсний хэмжээнд байгаль орчин, тогтвортой хөгжлийн хэвтээ зохицуулалтын хэд хэдэн механизм үйлчилж байна. Хэд хэдэн яамны эрх үүрэгтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх зорилгоор яамд хоорондын хороо, зөвлөл байгуулдаг боловч бусад оролцогч талуудын (ТББ, бизнес эрхлэгчид, эрдэмтэн судлаачид) төр засгийн байгууллагууд, бусад байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох оролцоог зохицуулах нэгж, байгууллага цөөн, тэдний үйл ажиллагааны талаар олон нийтийн мэдлэг, мэдээлэл хомс байна. Засгийн газар олон удаа солигдож байгаа нь эдгээр байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, үйл ажиллагааны үр өгөөжийг сааруулдаг ажээ.

Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийг 1994 онд байгуулж, 2002 он хүртэл тогтмол хуралдаж байсан боловч 2004 оноос ажиллагаагаа зогсоосон байна.

Ерөнхий сайдын дэргэд Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл ажиллаж, бүрэлдэхүүнд нь ХХААХҮЯ, Стандартчилал, хэмжил зүйн газар, ГЕГ, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах газар, МХЕГ зэрэг байгууллагын төлөөлөл орж байна.

Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороог Ерөнхийлөгчийн ажлын албаны дэргэд 2011 онд байгуулж, дараа нь 2013 оны Агаарын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсноор уг хороог Ерөнхий сайдын мэдэлд шилжүүлэн, түүний бүтэц бүрэлдэхүүнийг сүүлчийн удаа 2015 онд шинэчилжээ. Хорооны бүрэлдэхүүнд зөвхөн төр засгийн байгууллагуудын (салбарын яамд, МХЕГ, зарим аймгийн засаг дарга) төлөөлөл оржээ. Хороо нь ажлын төлөвлөгөөгөө боловсруулж, тогтмол хуралдаж байна.

Усны үндэсний хороог 2012 оны Усны тухай хуулийн дагуу байгуулж, устай холбоотой салбар хоорондын асуудлыг зохицуулах, усны нөөцийн цогцолбор менежментийг хангах, Усны үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг хүлээлгэсэн байна. Хороог БОАЖ-ын сайд тэргүүлж, байнгын үйл ажиллагааг яам хангана. Хорооны бүрэлдэхүүнд зөвхөн төр засгийн байгууллагуудын төлөөлөл орсон ба шаардлагаас хамааран хуралдааны давтамжийг зохицуулдаг байна.

Зүүн өмнөд, зүүн Азийн орнуудын байгаль орчин, эрүүл мэндийн сайд нарын бүс нутгийн 1 болон 2 дугаар чуулганы шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор тухайн үеийн БОАЖ-ын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2011 оны 32/А-28 тоот тушаалаар агаар, ус, эрүүл ахуй болон ариун цэвэр, эрүүл мэндийн үйлчилгээний хог хаягдлын менежмент, уур амьсгалын өөрчлөлт, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ зэрэг чиглэлийг хариуцсан 6 ажлын хэсэг байгуулжээ. Ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүнийг 2014 онд шинэчилсэн байна.

Аялал жуулчлалын тухай хуульд байгаль орчны асуудал эрхэлсэн яам, аялал жуулчлалын төрийн бус болон бусад байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн яамд хоорондын зөвлөл байгуулахаар заасны дагуу зөвлөл байгуулсан боловч тэр нь идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2017 оны 2 дугаар сард шинэчилсэн боловч өнөөг хүртэл хуралдаагүй байна.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын (ОУИТБС) Монголын үндэсний зөвлөлийг Ерөнхий сайд даргалдаг ба түүнд төр засаг, их хурлын 10, компаниудын 10, иргэний нийгмийн 10 төлөөлөл ордог. Зөвлөл 2006-2016 онд 15 удаа хуралдаж, ОУИТБС-ын хэрэгжилт, олборлох үйлдвэрийн салбарын (уул уурхай, газрын тос, хий) ашиг орлого, холбогдох бусад мэдээ мэдээллийг олон нийтэд түгээх замаар тус салбарын тайлагнах зарчим, сайн засаглалыг бэхжүүлэх зорилгыг хэрэгжүүлж байна. Зөвлөлийн хөтөлбөр, уулзалтуудын мэдээлэл олон нийтэд нээлттэй байдаг байна.

Монгол Улсын 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын Зорилт 17.14 -ын өнөөгийн байдлыг Шигтгээ 1.3-т харуулав.



### Шигтгээ 1.3: 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн Зорилт 17.14

**Зорилго 17: Тогтвортой хөгжлийн төлөөх дэлхий нийтийн түншлэлийг эрчимжүүлж, хэрэгжүүлэх арга механизмыг бүрдүүлэх**

**Зорилт 17.14: Тогтвортой хөгжлийн бодлогын уялдаа холбоог бэхжүүлэх.**

Энэхүү зорилго нь ТХЗ-уудыг хэрэгжүүлэх тогтолцооны нэг чухал хэсэг, тухайлбал салбар хоорондын бодлого, үйл ажиллагааны зохицуулалт, салбарын бодлого болон ТХЗ-уудтай хэрхэн уялдаа холбоотой байгаа асуудлыг хамарна. Зорилго 17.14 –ын хэрэгжилтийг тодорхойлох шалгуур үзүүлэлт нь улсын хэмжээнд бодлогыг тогтвортой хөгжилтэй уялдуулах механизм бүрдсэн эсэхтэй уялдана.

Монголд хэвтээ зохицуулалтын хэд хэдэн механизм үндэсний түвшинд үйлчилж, олон салбарыг хамарсан асуудлыг салбар хоорондын ажлын хороо, зөвлөл байгуулах арга хэлбэрээр зохицуулж байгаа боловч цөөн хороо, нэгжид төр засгийн байгууллага, бусад байгууллагуудын төлөөлөл оржээ. Зарим хороо зөвлөлийг албан ёсоор байгуулсан ч ажил нь жигдрээгүй. Жишээ нь Ерөнхий сайдын дэргэд 2017 оны 1 дүгээр сард байгуулсан ТХЗ-уудыг хэрэгжүүлэх үндэсний хороо 2017 оны 11 сарын байдлаар огт хуралдаагүй байна.

Монгол улсад бодлогын баримт бичгийн уялдаа холбоо сайн, тэдгээрт зорилт, зорилгыг зохистой тодорхойлж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгажээ. ҮХГ-ыг 2016 онд байгуулснаар бодлогын уялдаа холбоо улам бэхжих хэдий ч БОСҮ-г хийх практик арга хэлбэр дутагдаж байгаа нь ногоон хөгжил, байгаль орчны хамгаалал, тогтвортой хөгжлийн нэгдмэл бодлогыг салбаруудын бодлоготой уялдуулан холбох үйл ажиллагааг сааруулж байна.

#### Аймаг, сумын түвшин

Аймаг, нийслэл хотын тогтвортой хөгжлийн зөвлөлүүдийг (Аймаг, нийслэл хотын нийгэм, эдийн засаг, байгаль орчны зөвлөл) 1990-ээд оны дундуур байгуулсан боловч тэд 2004 оны үеэр үйл ажиллагаагаа зогсоожээ.

Өнөөгийн байдлаар аймаг, сумын түвшинд босоо зохицуулалтын албан ёсны механизм нь зарим яаралтай үйл ажиллагааны (ойн түймрээс сэргийлэх, түймэртэй тэмцэх г.м.) асуудлаар түр ажлын хэсэг байгуулах хэлбэрээр явагдаж байна. Ийм ажлын хэсэгт төрийн олон байгууллагын төлөөлөл ордог байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд байгаль орчны байцаагчид, ТХГ-ын захиргааны (Сүхбаатарын Үндэсний Паркыг хариуцах) байгаль хамгаалагчдын хамтын ажиллагаа амжилттай хэрэгжиж, эрх үүргийг тодорхой зааж өгсөн байна. Аймгийн байгаль орчны байцаагчид, ЦУОШГ-ын аймгийн Ус, цаг уур, байгаль орчны шинжилгээний газар хоорондын хамтын ажиллагаа төдийлөн идэвхтэй бус боловч тэдний авсан дээжийг (мөнгөн ус) ЦУОШГ-ын аймгийн лабораторид шинжилдэг байна. Аймгийн БОАЖГ-ын болон зарим тохиолдолд цагдаагийн ажилтнууд байгаль орчны байцаагч нарын хяналт шалгалтын үйл ажиллагаанд дэмждэг үзүүлж оролцож байгаа нь аймгийн хэмжээнд тэдний хамтын ажиллагаа идэвхтэй байгаагийн илрэл боловч ийм практик нь байцаагч нарын бие даасан байдлыг сулруулах эрсдэлтэй юм.

Аймаг бүрт адил шинжилгээ хийдэг хоёр байгууллагын (УЦУОШГ, МХЕГ) лаборатори ажиллаж байгаа нь үр ашигтай байдлын хувьд анхаарууштай.

## 1.6 Үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж

### Үнэлгээ

Монгол улс 2015 оны Хөгжлийн бодлогыг төлөвлөх тухай хуулиар зохицуулагдсан төлөвлөлт, хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийх хяналт мониторингийн шаардлагыг тодорхой тусгасан боловсронгуй тогтолцоотой байна. Бодлогын өнөөгийн баримт бичгүүд өөр хоорондоо зохистой уялдаатай, зорилт, зорилгыг цогцолбор байдлаар тусгасан, төрийн албан хаагчид бодлогын баримт бичгийн өргөн мэдлэгтэй байгаа нь харагдаж байна.

Ногоон хөгжил нь үндэсний бодлогын тодорхой чиглэл болохыг үндэсний хэмжээний алсын харааг тодорхойлсон гол баримт бичиг болох 2016 оны “Монгол Улсын 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”, ногоон эдийн засгийг онцлон тодохойлсон 2014 оны “Ногоон хөгжлийн бодлого” зэрэг бодлогын баримт бичигт тодорхой зааж өгчээ. Төлөвлөлтийн тогтолцооны сул тал нь, ялангуяа байгаль орчны хувьд БОСҮ-г салбаруудын ирээдүйн бодлогод байгаль орчны нөлөөллийн үнэлгээний арга болгон ашиглахгүй байгаад оршиж байна.

ТХЗ-уудыг хэрэгжүүлэх, мониторинг хийх ажил Монгол улсад жигдэрч, Засгийн газраас 2016 оны 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн эзэл баримтлалыг ТХЗ-уудыг хэрэгжүүлэх бодлогын суурь баримт бичиг болгон, шаардлагатай шалгуур үзүүлэлтүүдийг тогтоож өгчээ. Төрийн албан хаагчид ТХЗ-уудын талаар өргөн мэдлэгтэй байгаа нь томоохон ололт хэдий ч ТХЗ-уудын хэрэгжилт, мониторингийн зохицуулалтын бүтэц зохион байгуулалтын оновчтой тогтолцоо үгүйлэгдэж байна.

Монгол Улс нь 1987 оноос хойш байгаль орчныг хамгаалах эрх зүйн тогтвортой, харилцан уялдаатай тогтолцоог бүрдүүлж иржээ. Байгаль орчныг хамгаалах асуудлыг салбаруудын бодлогод амжилттай суулгаж, 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2016 онд, Ногоон хөгжлийн бодлогыг 2014 онд тус тус баталснаар энэхүү үйл ажиллагааг улам гүнзгийрүүлэн бэхжүүлэх нөхцөл, боломж бүрдсэн байна. Нөгөө талаар байгаль орчны хуулиудыг хэрэгжүүлэх явдал удааширч, ялангуяа энэ нь нэмэлт хуулиудыг боловсруулах, батлах ажлаас хамаарч байна. Байгаль орчны хуулиуд, салбарын хуулиудад байгаль орчны асуудлаар тусгасан заалтуудыг албадан хэрэгжүүлэх ажил ихээхэн саад бэрхшээл, сорилттай тулгарч байна.

Байгаль орчны улсын хэмжээний удирдлагын тогтвортой байдал, ялангуяа 1987 оноос яамны түвшинд үйл ажиллагаа явуулж ирсэн нь байгаль орчны бодлого, хууль тогтоомжийг зохистой боловсруулах, хэрэгжүүлэхэд эерэгээр нөлөөлж, бусад салбарын бодлого, хууль тогтоомжид тусгах ажлыг эрчимжүүлсэн байна. Гэвч яамны ажилтнуудын тогтвор суурьшил тулгамдсан нэг гол асуудал болоод байна. Өнгөрсөн жилүүдэд засгийн газар олон удаа солигдож, солигдох тутам яамны удирдлага, удирдах бүрэлдэхүүн, ажилтнууд өөрчлөгдөж байгаа нь бодлогыг тууштай хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. БОАЖЯ, аймгуудын БОАЖГ хоорондын босоо зохицуулалт харьцангуй сайн явагдаж байна.

МХЕГ-г 2003 онд байгуулсан нь бодлого, зохицуулалтыг хяналтын үүргээс тусгаарласан шинэ тогтолцоо нь нөөцийг үр ашигтай зарцуулах, төрөл бүрийн мэргэжлийн байцаагч нарын ажлын уялдаа холбоог бэхжүүлсэн боловч БОАЖЯ, МХЕГ хоорондын хамтын ажиллагааны түвшин хангалтгүй байгаа нь шинэ тогтолцооны сул тал болж байна.

*Дүгнэлт, зөвлөмж*

ТХЗ-уудыг хэрэгжүүлэх, мониторинг хийх

Үндэсний хөгжлийн газрыг (ҮХГ) ТХЗ-уудын хэрэгжилт, мониторингийг зохицуулах үүрэгтэйгээр байгуулжээ. Ерөнхий сайдын дэргэд ТХЗ-уудын үндэсний хороог 2016 оны эхээр байгуулж, түүнд 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хүчин чармайлтыг удирдах улс төрийн дээд түвшний статус олгосон боловч 2017 оны 5 дугаар сарын байдлаар уг хороо нь нэг ч удаа хуралдаагүй, төрийн албан хаагчдын дунд тус байгууллагын талаар янз бүрийн санал бодол байсаар байна. УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дэргэд УИХ-ын гишүүдээс бүрдсэн ТХЗ-уудын дэд хороо ажиллаж байна.

Дэлхий нийтийн хэмжээнд тогтоосон шалгуур үзүүлэлтүүд Монголд хэрэглэх боломжтой эсэхийн үнэлгээг Засгийн газар хийж, 157 үзүүлэлт Монголд байхгүйг тогтоожээ. Засгийн газар үндэсний зорилго, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлохоор ажиллаж, зарим зорилгыг 2016 онд баталсан 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тусгасан, мөн тодорхой зорилгуудыг боловсруулж, салбарын бодлогод тусгах ажлыг гүйцэтгэх шаардлагатай байна.

Төр засгийн байгууллага, салбарын яамд болон төрийн байгууллагууд ТХЗ-уудын талаар гүнзгий мэдлэгтэй байгаа бол төрийн бус байгууллагын оролцогчдын мэдлэг сул байна.

Зөвлөмж 1.1:

*Засгийн газар дараах арга хэмжээг хэрэгжүүлбэл зохион:*

- (a) *Ерөнхий сайдын дэргэдэх Үндэсний Тогтвортой хөгжлийн хороог үйл ажиллагаанд оруулах;*
- (b) *Хэмжигдэх боломжтой үндэсний зорилгуудыг тогтоох үйл ажиллагааг үргэлжлүүлэх;*
- (c) *Цаашид ТХЗ-уудыг орон нутгийн болон салбарын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах, уялдааг хангах;*
- (d) *ТХЗ-уудын шалгуур үзүүлэлтүүдийн мэдээлэлийн хүрэлцээний талаар олон улсын байгууллагуудаас удирдамж чиглэл авах, эл асуудлаар бусад орнуудтай туршилага солилцох;*
- (e) *Төрийн бус оролцогч талууд, ялангуяа орон нутгийн иргэдийн ТХЗ-уудын талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлэх үйл ажиллагааг үргэлжлүүлэх;*
- (f) *ТХЗ-уудын хэрэгжилтийн тайлан мэдээллийг тогтмол боловсруулах.*

Байгаль орчны стратегийн үнэлгээ

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай 2012 оны хуульд байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй үндэсний болон бүс нутгийн хэмжээний, мөн салбарын бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулахад Байгаль орчны стратегийн үнэлгээ (БОСҮ)-г заавал хийж байхаар тусгасан байна. БОСҮ-ний нэмэлт хуулийг 2013-2014 онд баталсан хэдий ч 2017 оны байдлаар нэг ч БОСҮ хийгдээгүй, БОАЖЯ-наас БОСҮ-ний механизмын сэдвээр сургалт зохион байгуулсан ч чиглэлийн яамдад энэ талаар ойлголт мэдлэг сул байна. Салбарын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөнд БОСҮ-ний тухай тусгаагүй байгаа нь байгаль орчны асуудлыг салбарын бодлогод тууштай, системтэй, цогц байдлаар тусгах үйл ажиллагааг сааруулж байна. БОСҮ-г санаачлаагүй, үйлдээгүй нөхцөлд хуулиар ямарваа нэгэн хариуцлага хүлээлгэх хуулийн заалтгүй, хууль болон нэмэлт хуульд ямар салбарын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөнд БОСҮ хийхийг тодорхойлж өгөөгүй байна. БОСҮ-г хийж туршлагажсан улс орон, тэдгээрийн олон нийтийг БОСҮ-ний үйл ажиллагаанд оролцуулах талаар хуульд тусгаагүй байна.

Зөвлөмж 1.2:

*Засгийн газар дараах арга хэмжээг хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай 2012 оны хуулийн дагуу үндэсний болон, бүс нутгийн, салбарын бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулахад БОСҮ-г заавал хийж байх;*



- (b) БОСҮ-ний талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлэх сургалтыг салбарын яамдад зохион байгуулах;
- (c) Олон улсын туршлагад үндэслэн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөнд БОСҮ-г заавал хийх салбарын жагсаалт гаргах;
- (d) БОСҮ-г хийж туршилагажсан улс орон, тэдгээрийн олон нийтийг БОСҮ-ний үйл ажиллагаанд оролцуулах боломжийг хангах хууль тогтоомжийг шинэчлэх.

#### Хэвтээ зохицуулалт:

Үндэсний хэмжээнд байгаль орчин, тогтвортой хөгжлийн асуудлаар хэвтээ зохицуулалтын хэд хэдэн механизм, жишээлбэл, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо, Усны үндэсний хороо г.м. үйлчилж байна. Хэд хэдэн яамны эрх үүрэгтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх зорилгоор голдуу яамд хоорондын хороо, зөвлөл байгуулдаг байна. Гэвч эдгээрт бусад холбогдох талуудыг (ТББ, бизнес эрхлэгчид, эрдэмтэн судлаачид г.м) оролцуулдаггүй, мөн төр засгийн байгууллагууд болон бусад оролцогч талуудын үйл ажиллагаан дахь оролцоог зохицуулах нэгж, байгууллага цөөн, тэдний үйл ажиллагааны талаар олон нийтийн мэдлэг, мэдээлэл хомс байна. Засгийн газар олон удаа солигдож байгаагаас эдгээр байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнд байнга өөрчлөлт орж байгаа нь тэдний үйл ажиллагааны үр өгөөжийг сааруулж байна. Зарим байгууллагуудын уулзалт хуралдааны давтамж алдагдсан байна. 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн Зорилго 17.14-ыг (Тогтвортой хөгжлийн бодлогын уялдаа холбоог бэхжүүлэх) хэрэгжүүлэхэд хэвтээ зохицуулалтын механизмыг бэхжүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

#### Зөвлөмж 1.3:

*Засгийн газар байгаль орчин, тогтвортой хөгжлийн хэвтээ зохицуулалтыг бэхжүүлэх талаар дараах арга хэмжээг авбал зохино:*

- (a) Яам хоорондын хороод, зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүн, гишүүнчлэлийг тогтоохдоо тэдний ажил үүрэгтэй уялдуулан шинэчлэх;
- (b) Яам хоорондын хороод, зөвлөлийн хуралдааныг тогтмол хийх боломжоор хангах;
- (c) Яам хоорондын хороод, зөвлөлийн хуралдааны тайлан мэдээллийг олон нийтэд ил тод болгох;
- (d) Яам хоорондын хороод, зөвлөлийн оролцогч талуудын гишүүнчлэлийг өргөжүүлэх.

#### Уул уурхайн салбарын хууль эрх, бодлогын орчин

Өнгөрсөн жилүүдэд Засгийн газраас байгаль орчны асуудлыг уул уурхайн хууль тогтоомж, бодлогод суулгах арга хэмжээ авч иржээ. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай 2009 оны хууль, Ашигт малтмалын тухай хуульд 2014 онд оруулсан нэмэлт өөрчлөлт нь уул уурхайн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, орон нутгийн ард иргэдийн ашиг сонирхолд үйлчлэх явдлыг сайруулсан байна. Бичил уурхайгаас ашигт малтмал олборлох журам нь зөвшөөрөгдсөн талбай дахь хувийн болон бичил уурхайн үйл ажиллагааны эрх зүйн хүрээг (ЗГ-ын 2017 оны 151 дүгээр тогтоол) тогтоож, бичил уул уурхайн үйл ажиллагааны дараа нөхөн сэргээлт хийхэд онцгой анхаарал хандуулсан байна.

Гэвч олон дутагдал оршсоор байна. БОНУ-г нэлээд хожуу шатанд, уул уурхайн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгосны дараа уул уурхайн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгохын өмнө хийж байна. Зөвшөөрөл эзэмшигч компани нь орон нутгийн захиргаатай байгаль орчныг хамгаалах, уул уурхайн ажиллагаатай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр бий болгох гэрээ заавал байгуулах ёстой боловч байгуулсан гэрээг нийтэд танилцуулахгүй байгаа нь түүнд тусгасан тэргүүлэх чиглэлүүд, агуулгын талаар эргэлзээ төрүүлдэг байна. Бичил уурхайгаас ашигт малтмал олборлох журмын техникийн шаардлага, тухайлбал гишүүдийг орон нутагт бүртгэлд хамруулах, хувийн уурхайчдын хоршооны ашиглах талбайн хязгаар, нэг сумын нутаг дэвсгэрт бичил уурхайд зориулах талбайн тоо зэрэг нь бичил уурхайн хоршоодын үйл ажиллагааг хүндрүүлж байна. Мөн уул уурхайгаас эвдэрсэн, сүйтсэн газрыг нөхөн сэргээх хууль тогтоомжийн хэрэгжилт ихээхэн бэрхшээлтэй тулгарч байна.

Өнөөгийн бодлогын баримт бичгүүд уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг

бий болгох, олон улсын зах зээл дахь өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, олборлосон бүтээгдэхүүнийг боловсруулах үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг эрмэлзэж байна. Уул уурхайн бодлогын баримт бичигт байгаль орчны асуудалд бага анхаарал хандуулсан, уул уурхайн хаагдсан, эвдэрсэн талбай, тэдгээрийн нөхөн сэргээлт, хувиараа бичил уурхай эрхлэгчдийг ажил хөдөлмөрийн өөр боломжоор хангах асуудлыг онцолсон баримт бичиг огт байхгүй байна.

#### Зөвлөмж 1.4:

*Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) Уул уурхайн компани, орон нутгийн захиргааны хооронд гэрээ байгуулах механизмыг боловсронгуй болгох, ил тод байдлыг нэмэгдүүлэх;
- (b) Уул уурхайн салбарт зөвшөөрөл олгох үйл ажиллагааг шинэчилж, БОНУ-ний дүгнэлтүүдийг анхааралдаа авах нөхцөлийг бий болгох;
- (c) Уул уурхайн төслүүдийн шийдвэр гаргах явцад бүх оролцогч талуудын оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлэх;
- (d) Бичил уурхай эрхлэх хууль эрх зүйн тогтолцоог шинэчилж, бичил уурхайчдын хоршоо байгуулах, үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хөнгөвчлөх;
- (e) Хувиараа бичил уурхай эрхлэгчдийг ажил хөдөлмөрийн өөр боломжоор хангах асуудлыг шийдвэрлэх бодлогын баримт бичгийг боловсруулах;
- (f) Уул уурхайн хаагдсан, эвдэрсэн талбайн нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах;
- (g) Байгаль орчинд уул уурхайн үзүүлж буй нөлөөллийн тухай мэдээ мэдээллийг системтэй цуглуулах, үнэлгээ хийх.

#### Байгаль орчны мэргэжлийн хяналт

Ерөнхий сайдын дэргэдэх Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг (МХЕГ) төрөл бүрийн хяналт, тухайлбал байгаль орчны хяналтыг нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор бие даасан газар байдлаар 2003 онд байгуулжээ. Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны байцаагчийг аймгийн засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр МХЕГ-аас томилдог, байцаагч нар МХЕГ-ын удирдлаган дор ажиллаж МХЕГ-т ажлаа тайлагнадаг байна. Харин сумын байгаль орчны байцаагч нар МХЕГ-т шууд харьяалагдахгүй хэдий ч мэргэжлийн удирдамжаар хангагддаг. Тэднийг сумын засаг дарга томилж, сумын захиргааны төсвөөс цалинжуулж, тэд Засаг дарга болон аймгийн мэргэжлийн хяналтын газарт ажлаа тайлагнана. Сумын байгаль орчны байцаагч нар засаг даргаас хамааралтай байгаа нь тогтолцооны дутагдал болж байна.

#### Зөвлөмж 1.5:

*Засгийн газар сумын байгаль орчны байцаагчийн бие даасан байдлыг хангах талаар дараах арга хэмжээг авбал зохино:*

- (a) Сумын байгаль орчны байцаагчийг сумын засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр МХЕГ-аас томилдог, ажлаас чөлөөлдөг болгох;
- (b) Сумын байгаль орчны байцаагч нарыг МХЕГ-аас цалинжуулах;
- (c) Сумын байгаль орчны байцаагч нар шууд МХЕГ-т ажлаа тайлагнадаг болгох.

#### Бүтэц зохион байгуулалтын ой санамж

БОАЖЯ-ны нэг тулгамдсан асуудал нь ажилтнуудын халаа сэлгээ юм. Сүүлийн жилүүдэд Засгийн газар олонтоо солигдож (дунджаар 18 сар тутамд) байгаагийн улмаас яамны удирдах (Сайд, Дэд-сайд, ТНБД) болон менежерийн түвшний (газар, хэлтсийн дарга) ажилтнууд Засгийн газар солигдох бүрд солигдож байгаа нь байгаль орчин, ногоон хөгжлийн талаарх бодлогыг тогтвортой хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж, байгууллагын ой санамж тогтворгүй болоход хүргэж байна.

#### Зөвлөмж 1.6:

*БОАЖЯ өөрийн ажилтнуудад мэргэжлийн туршилага хуримтлуулах боломж олгож, тэдний ажлын байрыг хадгалах, байгаа болон архивын мэдээ, мэдээллийг агуулсан мэдээлийн систем бий болгох замаар байгууллагын шуурхай ой санамжийг бий бий болгох талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.*

## Бүлэг 2

# ЗОХИЦУУЛАЛТЫН БОЛОН ХУУЛЬ МӨРДӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ МЕХАНИЗМ

### 2.1 Зөвшөөрөл, гэрчилгээ олгох

Монгол улсын Зөвшөөрөл, гэрчилгээ олгох тогтолцоо нь түүнд байгаль орчны бусад нэмэлт арга хэрэгсэл, бохирдуулагчийн эх сурвалжууд, байгаль орчинд хохирол учруулж буй үйл ажиллагааг нэмж анхаарах болсоноор улам боловсронгуй болж байна.

Озон задлагч бодис, үйлдвэрлэлийн явцад хорт болон аюултай химийн бодис ялгаруулах, өнөөгийн стандартад ороогүй бохирдуулагчийг агаар мандалд ялгаруулах, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОНУ) хийхэд оролцох, хортой болон аюултай химийн бодисын импорт, худалдаа, экспорт; мөн ургамал хамгаалах бараа бүтээгдэхүүн; ашигт малтмал эрэх, хайх, олборлох, ашиглах; газрын тосны үйлдвэрлэл, цацраг идэвхт эх сурвалж ашиглах зэрэг үйл ажиллагаанд гэрчилгээ, зөвшөөрөл олгож байна.

Түүнчлэн ус ашиглах, хаягдал бохир усыг нийлүүлэх (хүчин төгөлдөр бус), цооног өрөмдөх, худаг гаргах, суваг татах, агаар бохирдуулагч тодорхой эх сурвалжууд (хүчин төгөлдөр бус), хог хаягдал устгах цэгүүдийг ажиллуулах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажиллагаа, аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, эргэлтэд оруулах, устгах, экспортлох, хортой болон аюултай химийн бодисын импорт, экспорт, хил дамнасан тээвэр, ашиглалт, худалдаа, үйлдвэрлэл, устгал, амьтан болон ургамлын нөөцийг ашиглах, байгалийн аливаа нөөцийг ашиглах, БОНУ хийх үйл ажиллагаа эрхлэхэд гэрчилгээ, зөвшөөрөл авсан байх шаардлагатай байдаг байна.

Европын холбооны 2008/1/ЕС тоот захирамжаар бий болгосон бохирдлоос сэргийлэх, хяналтын механизмтэй адил үйлчилдэг механизм Монголд байхгүй.

#### *Эрдэс баялагийн нөөц*

Эрдэс баялагийн тусгай зөвшөөрлийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, түүний харьяа Ашигт малтмал, газрын тосны газар Ашигт малтмалын тухай 2006 оны хуулийн дагуу олгодог байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхэм зорилго нь хариуцлагатай, ил тод уул уурхайг хөгжүүлэхэд оршиж, ашигт малтмал, газрын тос болон хий олборлох тусгай зөвшөөрөл олгох, бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах явдал байдаг бол, Ашигт малтмал, газрын тосны газар нь яамыг төлөөлөн хайгуулын тусгай зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар олгох, мөн ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үүрэгтэй байна.

Уурхайн талбайн техникийн болон эдийн засгийн үнэлгээг мэргэшсэн мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр боловсруулж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамаар батлуулна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд техникийн болон эдийн засгийн үнэлгээнд дүгнэлт хийх тусгай комисс ажиллаж, түүний бүрэлдэхүүнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Сангийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Уул уурхайн үндэсний нийгэмлэг, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөлийн мэргэжлийн албан хаагчид ордог байна.

Техникийн болон эдийн засгийн үнэлгээ батлагдсан нөхцөлд байгаль орчны суурь судалгаа, дараа нь байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг (БОНУ) БОАЖЯ-наас хийх бөгөөд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээнд үндэслэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай эсэхийг тогтооно. БОАЖЯ-нд нарийвчилсан БОНУ-ний чанарт дүгнэлт гаргах Мэргэжлийн зөвлөл ажиллаж байна. Нарийвчилсан БОНУ-нд Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) багтана. Ямарч компани БОНУ хийхгүйгээр үйл ажиллагаа явуулах эрхгүй. Монгол Улсад уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх баримт бичигт тусгай зөвшөөрөл, нарийвчилсан БОНУ, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө багтах ёстой байдаг байна.

Ашигт малтмалын тухай хуулийн дагуу уул уурхайн кадастрын цахим системийг тус яам 2010 онд боловсруулж, 2014 онд түүнийг өргөжүүлэн тусгай зориулалтын вэб порталыг нэмж хийсэн байна. Энэхүү Кадастрын систем нь тусгай зөвшөөрөл авах, хугацааг нь сунгах, шилжүүлэх, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь, эсвэл тодорхой хэсгийг хүлээлгэн өгөх, тусгай зөвшөөрлийн бүртгэлийг хөтлөх асуудлыг олон нийтэд нээлттэй болгожээ. Порталын нэг гол зорилго нь тусгай зөвшөөрөл давхардах, тусгай хамгаалалттай бүстэй давхцахаас сэргийлэхэд оршдог байна. Энэ цахим мэдээлэлд бүртгэгдсэн ашиглагчид нэвтрэх эрхтэй байна.

#### Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга

Засгийн газрын 2006 оны 1 дүгээр тогтоолоор Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг (ОУИТБС) дэмжиж байгааг батламжилсан байна. Засгийн газрын 2007 оны 80, 2012 оны 222 дугаар тогтоолоор ОУИТБС-тай холбоотой төв болон орон нутгийн засаг захиргааны эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлж, цахим мэдээлэл, тайлангийн механизмыг 2015 онд нэвтрүүлжээ (<http://e-reporting.eitimongolia.mn>).

ОУИТБС-ын мэдээллийн санд 2017 оны нэгдүгээр сарын 17-ны байдлаар зөвшөөрөл эзэмшигч 2,256 хуулийн этгээдийн ашигт малтмал, газрын тос, хийн хайгуул, ашиглалтын 3,864 тусгай зөвшөөрөл бүртгэгдсэн нь улсын нийт нутаг дэвсгэрийн 8.78 хувийг хамарч байна. Уул уурхайн кадастрын цахим системд 2017 оны 5 дугаар сарын 29-ний байдлаар уул уурхайн нийт 3,756 зөвшөөрлөөс хайгуулын 2,164 (газар нутгийн 6.21 хувь), ашиглалтын 1,592 (газар нутгийн 0.90 хувь) тусгай зөвшөөрөл бүртгэгдсэн байна.

Газар нутгийн 30 гаруй хувийг 2008 онд хайгуулын тусгай зөвшөөрөлд хамруулаад байсан бол өнөөгийн байдлаар талбайн хэмжээг дахин 20 хувийг хамруулах зорилготой байна. Яамны тооцоогоор тусгай зөвшөөрөлтэй нийт талбайн 30 орчим хувийг ашиглаж, бусад нь бүтээгдэхүүний үнэ, дэд бүтцийн хөгжил, байгаль орчны нөлөөллийн эрсдэл зэргээс шалтгаалан зогсонги байдалд байна. Газрын тос, хий, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл даруй 2 эрэмбээр бага байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд байгаа мэдээллийг ОУИТБС-д бүрэн тусгахгүй байгаа нь (Шигтгээ 2.1) ОУИТБС-ын хүрээнд Засгийн газрын хүлээсэн үүрэг, мөн хариуцлагатай, ил тод уул уурхайг хөгжүүлэх Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны зорилгыг хэрэгжүүлэхэд саад бэрхшээл учруулж байна.

#### **Шигтгээ 2.1: Монгол улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга**

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга нь олон улсын болон дотоодын аудитын компаниудын оролцоотойгоор олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниуд төлбөр төлсөн тухай болон Засгийн газар тэдгээр компаниудаас хүлээн авсан орлогын жилийн тайлан илтгэлийг боловсруулна.

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга нь 2017 оны 1 дүгээр сард олон улсын батламж авсан боловч шаардлага хангаагүй, тухайлбал мэдээ мэдээллийн чанар, батламжийг сайжруулах нэг жилийн хугацаатай үүрэг ноогдуулсан байна. Монголын ОУИТБС нь чухал, хараат бус мэдээллийн эх сурвалж болж, олон нийтийн итгэл алдарч буй салбарын ил тод байдлыг хангахад хувь нэмэр оруулж байна.

ОУИТБС мэдээллийн системд зөвшөөрөл эзэмшигчдийн тухай, тухайлбал олгосон огноо, санхүүгийн мэдээ мэдээлэл багтдаг боловч зөвшөөрлийн дагуу гүйцэтгэсэн үйл ажиллагаа, зөвшөөрлийг олон удаа шилжүүлсэн шалтгаан, нөхцөлийг тусгадаггүй байна. Мөн УУХҮЯ-ны мэдээллийн сангийн газрын тосны тусгай зөвшөөрөлд хамрагдсан талбайд үнэлгээ хийх боломж өнөөгийн байдлаар хүндрэлтэй байна. БОАЖЯ нь банкны үйл ажиллагааны журмаар хориглосон гэх шалтгаар уул уурхайн нөхөн сэргээлтийн тусгай санд хуримтлагдсан хөрөнгийн мэдээллийг шинэчлэн оруулахаас тагталздаг. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид ОУИТБС-д мэдээлэл хүргүүлдэг хэдий ч өөрийн цахим хуудсанд мэдээлэл байршуулахад хойрго хандаж байгаа нь ил тод байдалд сөргөөр нөлөөлж байна. ОУИТБС нь ил тод байдлыг өргөжүүлэх зорилгоор өөрийн цахим мэдээллийн системийг БОНУ-ний цахим жагсаалттай холбохыг эрмэлзэж байгаа ч техникийн хувьд боломжгүй байна.



**Фото зураг 2: Заамар суман дахь уурхай***Агаар*

Агаарын тухай 2012 онд шинэчилсэн хуулиар агаар бохирдуулагч томоохон суурин эх үүсвэрүүдийг (тухайлбал дулаан болон цахилгааны үүсгүүр, аж үйлдвэр г.м.) ашиглах зөвшөөрөл олгох, бохирдуулагч бодис ялгаруулалтын түвшинг тогтоох үүргийг сум, дүүргийн Засаг даргад ноогдуулсан. Ийм зөвшөөрлийг ЦУОШГ-ын орон нутгийн байгууллагуудын дүгнэлтэд үндэслэн сум, дүүргийн Засаг дарга олгоно. Дулааны цахилгаан станцын ялгаруулалтын үндэсний стандартыг (MNS 6298-2011) батласан байна. Гэвч бохирдуулагч бодисын ялгаруулалтыг хэмжих, мониторинг хийх шаардлагатай техник төхөөрөмж байхгүй учир бодит амьдралд БОАЖЯ-наас агаарын бохирдолтой холбоотой зөвшөөрөл олгодоггүй, дулааны станц зэрэг агаар бохирдуулагч гол эх үүсвэрүүд агаар бохирдуулсны ямарваа нэгэн төлбөр төлдөггүй байна (Бүлэг 3).

*Ус, хаягдал ус*

Усны тухай 2012 оны хуульд ус ашиглагчид зөвшөөрөл авахаар заасан. Цооног өрөмдөх, худаг гаргах, суваг татах тухай өргөдлөө ус ашиглах этгээд аймаг, нийслэл хотын байгаль орчин хариуцсан байгууллагад гаргах ба тэдгээрийг бүртгэлд оруулж, зөвшөөрөл олгодог байна.

Ус ашиглалтын зөвшөөрлийг эрчим хүч, тээвэрлэлт, ашиглалтын зорилго, хэмжээнээс шалтгаалан янз бүрийн байгууллага олгоно (Хүснэгт 2.1), харин орон сууцны төвлөрсөн ус хангамжийн асуудлыг хариуцагч байгууллага нь БОАЖЯ-ны дүгнэлт, усны сав газрын захиргааны зөвшөөрлийг үндэслэн шийдвэрлэнэ.

Ус ашиглах хүсэлт гаргаж буй этгээд нь ашиглахаар төлөвлөж байгаа усны эх булгийн байршил, өдөр тутмын хэрэглээний хэмжээ, зорилго, өдөрт 100 м<sup>3</sup> дээш хэмжээтэй бол БОНУ зэрэг баримт бичиг, мэдээллийг хавсаргана. Рашааны ус ашиглахад нэмэлт баримт бичиг шаардлагатай байдаг байна.



**Хүснэгт 2.1: Ус ашиглах, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл олгодог, баталдаг байгууллагууд**

	Батлах байгууллага	Зөвшөөрөл олгох байгууллага
<b>Өдөр тутмын хэрэглээ (м<sup>3</sup>)</b>		
100-аас дээш	БОАЖЯ	Усны сав газрын захиргаа
50- 100	Усны сав газрын захиргаа	Аймаг, нийслэлийн байгаль орчин хариуцсан байгууллага
50-иас доош	Аймаг, нийслэлийн байгаль орчин хариуцсан байгууллага	Сумын засаг дарга
<b>Өдөр тутмын хаягдал ус (м<sup>3</sup>)</b>		
50-иас дээш	БОАЖЯ	Усны сав газрын захиргаа
50-иас доош	Усны сав газрын захиргаа	Сумын засаг дарга

Эх сурвалж: 2012 оны Усны тухай хууль.

Өдөрт 100 м<sup>3</sup> дээш усны нөөц ашиглах тохиолдолд БОАЖЯ-наас хүртээмжтэй усны нөөц, жишээ нь гүний усны нөөцөнд нөлөөлөх эсэхэд үнэлгээ хийнэ. Зөвшөөрөл олгох, хэрэглэгчтэй гэрээ байгуулахыг Монгол Ус төрийн өмчит ААН хариуцана. Бусад тохиолдолд гэрээг хэрэглэгч, усны сав газрын захиргаа, аймгийн захиргааны хооронд байгуулна.

Ус ашиглах зөвшөөрлийг 10 жилээр (өмнө нь 15 жил байсан) олгож, хэрэглэгч гэрээний үүргээ биелүүлж байгаа нөхцөлд зөвшөөрлийг 5 жилээр сунгах эрхтэй бөгөөд 5 жил тутамд үнэлгээ хийж шаардлагатай өөрчлөлтийг тусгана. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалтай холбоотой ус ашиглалтын зөвшөөрлийг тусгай зөвшөөрлийн ашиглалтын хугацаатай адилаар олгоно.

Байгаль орчны мэдээллийн төвийн цахим хуудсанд 2013 оны 5 дугаар сараас 2014 оны 10 дугаар сар хүртэл олгосон ус ашиглах 49 зөвшөөрлийн жагсаалтыг ашиглагчдын нэр, олгосон огноо, зөвшөөрлийн мэдээллийг оруулсан байна. Гэвч мэдээллийн санг ус ашигласан байдал, хаягдал бохир усны талаарх мэдээллийг тусгах зорилгоор байгуулсан ч эдгээр мэдээллийг оруулж ашиглахгүй байна. Усны эх булгийн газар зүйн байршлыг харуулах мэдээллийн систем ажиллахгүй байна.

Усны тухай хуульд ус ашиглах гэрээнд усны нөөцийг хамгаалах, хомсдол бохирдлоос сэргийлэх зэрэг тодорхой арга хэмжээ тусгахыг заажээ. Өдөрт 50 м<sup>3</sup> дээш ус хэрэглэх тохиолдолд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу хэрэглэгч нь усны тоолуур тавих, ус ашиглалтын менежер ажиллуулах, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл авах, хаягдал усыг стандартын дагуу цэвэршүүлэх (усны сав газарт хаягдал ус нийлүүлэх стандарт MNS-4943-2011, ариутгах татуурга, ус цэвэрлэх төв байгууламжийн системд аж үйлдвэрийн хаягдал ус нийлүүлэх хэмжээг тогтоох журам) зэрэг давхар үүргийг хүлээдэг байна.

Усны тухай хуулиар хаягдал усны зөвшөөрөл авах ёстой боловч Засгийн газар нэмэлт хууль гаргаагүй учир энэ заалт хэрэгжээгүй, мөн Ус бохирдуулсны төлбөрийн тухай 2012 оны хуулийг хэрэгжүүлэх нэмэлт хууль боловсруулаагүйн улмаас төлбөр авах механизм бүрдээгүй байна. БОАЖЯ-наас нэмэлт хууль боловсруулахаар ажиллаж, гол гол хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, нэмэлт хуулийн төслийг бусад яамтай зөвшилцөх, төлбөрийн хэмжээг бууруулах, хаягдал усыг цэвэрлэсний урамшуулал олгох зэрэг асуудлыг тохиролцож байна. Зарчмын хувьд өдөр тутмын хаягдал ус 50 м<sup>3</sup> –аас дээш, эсвэл онцлог бохирдуулагч бодис байгаа тохиолдолд зөвшөөрлийг усны сав газрын захиргаа, 50 м<sup>3</sup> –аас доош тохиолдолд сумын засаг дарга олгодог байна. Бохирдлын төлбөрийг хэмжээг бага нягттай бодис, органик бодис, эрдэс бодис, хүнд металл, аюултай бохирдуулах бодис тус бүрт тооцон гаргана.

*Хог хаягдал*

Хог хаягдлын тухай 2017 онд шинэчилсэн хуулиар аймаг, нийслэлийн засаг дарга нар хог хаягдлын цэг ажиллуулах, булшилж дарах, нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөл олгох орон нутгийн журам батлахаар заасан байна. Хог хаягдлын цэг ажиллуулах зөвшөөрөлд аюултай бус, зөвхөн ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал хамаарна.

Мөн хуулийн дагуу аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, экспортлох түр болон байнгын зөвшөөрлийг БОАЖЯ-наас хуулийн этгээд, байгууллагуудад олгоно. Түр зөвшөөрлөөс бусдыг анхлан жилийн хугацаагаар олгож, үүргийг хангалттай гүйцэтгэсэн нөхцөлд

5, дараа нь 10 жилээр сунгадаг байна. Хог хаягдлын менежментийн Шинжээчдийн зөвлөл зөвшөөрөл олгох асуудлаар яаманд үнэлгээ, мэргэжлийн зөвлөмж гаргадаг ба хуулийн этгээд, байгууллагуудын сонгон шалгаруулалтын үзүүлэлтийг яамнаас тогтоодог. Хог хаягдлын тухай хуулиар тодорхой нөхцөлийг хангасан тохиолдолд аюултай хаягдлыг экспортлох зөвшөөрөл олгохыг яаманд даалгасан байна.

Ашигт малтмалын тухай 2006 оны хуульд уул уурхайн зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах, хамгаалалтын далан барихаар зааснаас өөр уул уурхайн хаягдалтай холбоотой зүйл оруулаагүй байна.

Байгаль орчны төв мэдээллийн санд гарчиг байгаа боловч хаягдлын талаар мэдээлэл оруулаагүй байна.

#### *Аюултай бодис*

Хортой болон аюултай химийн бодисын тухай 2006 оны хуулиар химийн хортой, аюултай бодисыг экспортлох, импортлох, Монгол Улсын хилээр дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах, хяналт тавихтай холбогдсон зөвшөөрөл гаргах эрхийг БОАЖЯ-нд олгожээ. БОАЖ, Гадаад харилцааны сайдын хамтарсан 2009 оны 334/104 тоот тушаалаар зөвшөөрөл олгох, тухайлбал үйлдвэрлэх, хадгалах, худалдахад нарийвчилсан БОНУ хийхийг тусгайлан заасан байна. Ийм зөвшөөрөл 2008-2014 онд олгосон байдлыг Хүснэгт 2.2-т харуулав, хүснэгтэд 2011 оны мэдээлэл ороогүй байна.

#### **Хүснэгт 2.2: Хорт болон аюултай химийн бодисын зөвшөөрөл 2008-2014 онуудад олгосон байдал, тоогоор**

	2008	2009	2010	2011	2012	2013	2014	Бүгд
Ашиглах	59	72	268	4	224	171	243	1,041
Экспортлох	0	0	1	0	1	10	6	18
Импортлох	73	84	315	4	143	198	236	1,053
Худалдах	17	24	76	0	33	76	95	321
Үйлдвэрлэх	0	1	5	0	4	6	3	19
Хилээр дамжуулан тээвэрлэх	0	0	3	0	0	1	0	4
Бусад	76	90	340	4	255	241	330	1,336

Эх сурвалж: <http://www.eic.mn/toxic/talicense.php>, 2017.05.31

БОАЖЯ-ны цахим хуудсанд 2016 оны эхний хагаст хорт бодисын экспорт, импорт, худалдаа, ашиглалт, борлуулалтын 170 зөвшөөрөл олгосон жагсаалт, нийт төлбөрийн хэмжээг байршуулсан боловч бодисын тодорхойлолтыг зөвхөн 4 дүгээр сарын сүүлээс, мөн 5 дугаар сараас зарим бодисын нэрийг орхигдуулсан, уг жагсаалтаас харахаар тусгасан боловч хамрагдсан бодисын нэрс огт байхгүй байв. Түүнчлэн 2016 оны 1-ээс 9 дүгээр сард шинээр 164 зөвшөөрөл олгосон хэмээн цахим хуудсанд мэдээлсэн нь хугацаа, зөвшөөрлийн тооны талаар ташаа ойлголт төрүүлж байна.

Шадар сайд, БОАЖ, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 54/А/136/А/215 тоот тушаалаар химийн хаягдлыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагааны шаардлагыг тогтоож өгчээ.

Хортой болон аюултай бодисын жагсаалтыг БОАЖ, Эрүүл мэндийн сайд хамтран гаргадаг. Импорт, экспортын зөвшөөрөлд хилээр оруулж, гаргаж буй бодисын нэрийг заадаггүй, энэ нь аюулгүй байдалтай холбоотой байж болох ч олон нийтэд ил тод байх асуудал илүү ач холбогдолтой юм.

Уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагааны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөндөө хорт, хортой байж болзошгүй бодис, материалын хадгалалт, хяналтын асуудлыг тусгах үүрэгтэй байдаг байна.

#### *Озон задлагч бодис*

Агаарын тухай 2012 онд шинэчилсэн хуульд Озон задлагч бодис (ОЗБ) үйлдвэрлэгч нарт зөвшөөрөл олгохоор тусгаж, Засгийн газрын 1999 оны 104 дүгээр тогтоолоор ОЗБ-ын импорт, үйлдвэрлэл, худалдаа

болон ашиглалтын журмыг баталжээ. БОАЖЯ нь МХЕГ-ын эрүүл мэнд, ариун цэврийн байцаагч нарын саналыг үндэслэн зөвшөөрөл олгодог, ОЗБ-ын олгосон зөвшөөрлийн талаар олон нийтэд хүртээлтэй урт хугацааны мэдээ мэдээлэл байхгүй байна.

БОАЖЯ-ны цахим хуудсанд 2016 оны эхний хагаст ОЗБ агуулсан тоног төхөөрөмж, ихэнхдээ хөргөгч, хөлдөөгч, агааржуулагчийн импортын 206 зөвшөөрлийн жагсаалтыг байршуулан, жагсаалтад импортлосон зүйлсийн тоо, төлсөн төлбөрийн хэмжээг (төлбөрийг зөвшөөрөл бүрээр, зүйлсийн тоог харгалзахгүйгээр) оруулсан байна.

Түүнчлэн 2016 оны 1-ээс 9 дүгээр сард 350 зөвшөөрөл олгосон хэмээн цахим хуудсанд зөрүүтэй мэдээлэл байршуулсан байна.

*Цацраг идэвхт бодисоос хамгаалах, аюулгүй байдлыг хангах*

Цацраг идэвхт эх сурвалжийг ашиглах зөвшөөрлийн талаар олон нийтэд хүртээмжтэй мэдээлэл байхгүй байна.

*Амьтан, ургамал*

Байгалийн ургамлын тухай 1995 оны хуулийн дагуу нэн ховор ургамлыг судалгааны зорилгоор ашиглах зөвшөөрлийг БОАЖЯ, ховор ургамал ашиглах зөвшөөрлийг сумын засаг дарга олгодог байна. Сумын засаг дарга үйлдвэрлэлийн зорилгоор элбэг ургамал ашиглах, эсвэл ховор ургамал ашиглахад БОАЖЯ зөвшөөрөл олгохдоо заавал БОНУ хийдэг байна. Ургамлын экспортын зөвшөөрлийг БОАЖЯ олгоно.

Амьтны тухай 2012 онд шинэчилсэн хуульд нэн ховор амьтныг зөвхөн шинжлэх ухааны зорилгоор, БОАЖЯ-ны тусгай зөвшөөрлөөр ангах, барихаар заасан. Ховор амьтныг агнах, барих зөвшөөрлийг БОАЖЯ-наас шинжлэх ухаан, судалгаа, соёл, үзэсгэлэн болон эмчилгээний зориулалтаар, амьтны тоог зохицуулах зорилгоор хувь хүмүүст зохих төлбөртэйгээр олгоно.

Ан агнуурын тухай 2012 онд шинэчилсэн хуулиар сумын засаг даргын зөвшөөрлийн дагуу иргэд ховор бус амьтныг ахуйн зорилгоор ангах, барих, харин ховор амьтныг зөвхөн БОАЖЯ-ны тусгай зөвшөөрлөөр ангах, барихаар зохицуулсан байна. Ерөнхийдөө сумын засаг дарга нь амьтан ашиглах, өмчлөх, нэн ховор болон ховор амьтныг шинжлэх ухаан, соёл, үзэсгэлэн болон урлагийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгох эрхтэй байна. Нэн ховор амьтныг амьдаар экспортлох зөвшөөрлийг Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг зөрчихгүйгээр БОАЖЯ-наас олгодог болно.

Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенци, түүний хавсралтуудад дурьдсан жагсаалтад орсон амьтан, ургамлыг олон улсад худалдаалах гэрчилгээ авах өргөдлийг Конвенцийн үндэсний зохицуулах зөвлөлд хүргүүлэх ба ҮЗЗ нь Конвенцийн шинжлэх ухааны зөвлөлийн зөвлөмжийг харгалзан шийдвэрлэнэ.

БОМТ-ийн цахим хуудсанд 2017 оны 5 дугаар сард Байгалийн ургамлын тухай хуулийн дагуу ургамлын зөвшөөрөл олгосон талаар хязгаарлагдмал мэдээлэл, тухайлбал импорт, экспортын зөвхөн 22 зөвшөөрлийн жагсаалтыг байршуулсан байна. Гэвч 2017 оны 8 дугаар сарын байдлаар олгосон зөвшөөрлийн тоог 2017 оны 6 дугаар сараар тасалбар болгон 409 болтол өсгөжээ. Зөвшөөрлийн тоог бодитоор тусгахад ахиц гарсан хэдий ч ургамлын аймгийн мэдээллийг оруулаагүй байна. Ургамал ашиглах 75 зөвшөөрөл 2014-2016 онд олгосон боловч мөн л ургамлын аймгийг тусгаагүй байна.

Түүнчлэн 2016 оны 1-ээс 9 дүгээр сард экспортын 60, импортын 20, ашиглалтын 25 зөвшөөрөл олгосон хэмээн БОАЖЯ-ны цахим хуудсанд мэдээлсэн нь хугацаа, зөвшөөрлийн тооны талаар зөрүүтэй ойлголт төрүүлж байна.

БОМТ-ийн цахим хуудсанд 2017 оны 5 дугаар сард амьтны зөвшөөрөл олгосон талаар хязгаарлагдмал мэдээлэл, тухайлбал 2011-2015 онд импортын 2, экспортын 102 зөвшөөрлийг дурьдсан атлаа 2017 оны 8 дугаар сарын байдлаар олгосон зөвшөөрлийн тоог 2017 оны 7 дугаар сараар тасалбар болгон 233 болтол огцом өсгөжээ. Амьтны нөөц ашиглах тухай мэдээллийн сангийн хэсэг хоосон хэвээр байна. Импорт, экспортын зөвшөөрөлд амьтны аймгийг мөн л тусгаагүй байна. БОАЖЯ-ны цахим хуудсанд 2016 оны эхний хагаст олгосон экспортын 26 зөвшөөрлийг тусад нь жагсааж, харин тэдгээрт аймаг болон төлбөрийн хэмжээг оруулжээ.

Түүнчлэн 2016 оны 1-ээс 9 дүгээр сард экспортын 45 зөвшөөрөл олгосон хэмээн БОАЖЯ-ны цахим хуудсанд мэдээлсэн нь хугацаа, зөвшөөрлийн тооны талаар мөн ташаа ойлголт төрүүлж байна.

БОАЖЯ-ны цахим хуудсанд 2016 онд олгосон ангийн зөвшөөрлийн хоёр жагсаалтыг амьтны аймаг болон төлбөрийн хэмжээг тусгасан, 2015, 2016 оны загасчлалын зөвшөөрлийн тоо, төлбөрийн хэмжээг тодорхойлсон байдлаар байршуулсан боловч тэдгээр нь зөвхөн гадаадын иргэд, жуулчлалын компаниудад олгосон зөвшөөрөл, үүнд дотоодын олон тооны анчид, загасчид огт хамрагдаагүй байна. 21 дүгээр зууны эхний үеийн ан агнуур, зэрлэг амьтан ургамлын экспортын тооцоог харьцуулвал хөдөө орон нутгийн иргэдийн ихээхэн хувь нь ан хийж, олон мянган амьтан худалдаалж байсны улмаас амьтны нөөц хорогдоход хүргэсэн байна.

### *Ой*

Ойн тухай 2012 онд шинэчилсэн хуульд мод болон ойн дагалдах бүтээгдэхүүн бэлтгэх, тарьц шилжүүлэн суулгах, ойн судалгаа шинжилгээ хийх зэрэг олон үйл ажиллагаанд зөвшөөрөл авахаар тусгасан. Түлшний мод бэлтгэх зөвшөөрлийг орон нутгаас, сумын байгаль хамгаалагчаас, ой болон ойн нөөцийг иргэд, бүлэг, эдийн засгийн нэгж, байгууллагууд ашиглах зөвшөөрлийг орон нутгийн захиргаанаас олгож байна.

БОМТ-ийн цахим хуудсанд БОАЖЯ, аймаг, нийслэл хот, тусгай хамгаалалттай газраас олгох зөвшөөрөл, гэрчилгээний жагсаалтыг (гарал үүслийн гэрчилгээ, мод бэлтгэх зөвшөөрөл, бүртгэлийн гэрчилгээ) оруулахаар төлөвлөсөн боловч мэдээлэл огт байршуулаагүй байна.

### *Байгаль орчинтой холбоотой үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, гэрчилгээ олгох*

Хууль тогтоомжоор ААН, мэргэжлийн байгууллагуудад байгаль орчинтой холбоотой үйл ажиллагаа, тухайлбал нарийвчилсан БОНУ, байгаль орчны аудит хийхэд зөвшөөрөл гэрчилгээ олгохоор зохицуулсан байна. Амьтны чиглэлээр гэрчилгээ, зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллагуудын дийлэнх нь ан агнуур, загасчлал, усны чиглэлийн мэргэжлийн байгууллагууд цооног өрөмдөх, тоног төхөөрөмж ашиглах, засвар үйлчилгээг эрхэлж байна. “Ойн мэргэжлийн байгууллага”-ын гэрчилгээг 800 гаруй хувийн байгууллагад шавьж устгах, ойг сийрэгжүүлэх, ойжуулах, үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэх ажил зохион байгуулахаар олгожээ (Бүлэг 13).

ААН, мэргэжлийн байгууллагуудад “ойн мэргэжлийн байгууллага”-ын байгаль орчинтой холбоотой үйл ажиллагаа явуулахаар олгосон гэрчилгээг БОАЖЯ баталгаажуулна. Нарийвчилсан БОНУ хийх гэрчилгээ хүссэн байгууллагуудын мэргэжлийн чадавхийг БОНУ-ний Мэргэжлийн зөвлөл хянан тогтоож, ААН-ийн чадавхийг нарийвчилсан БОНУ боловсруулахад төвлөрүүлэх боломжийг тодорхойлсны үндсэн дээр яаманд зөвлөмж гаргана. Гэрчилгээг БОАЖЯ-наас гурван жилээр олгож байна. Гэрчилгээ эзэмшигчдийн мэдээллийг Хүснэгт 2.3-т нэгтгэсэн, харамсалтай нь мэдээлэл бүрэн бус, бас зөрчилтэй байна.

БОМТ-ийн цахим хуудсанд 2006-2016 онд БОНУ хийх мэргэжлийн гэрчилгээ бүхий 147 ААН байгааг харуулсан. Гэрчилгээний тоо 2015 онд огцом нэмэгдэж (Зураг 2.1), олон шинэ, туршлагагүй байгууллагуудад гэрчилгээ олгосон байна. БОМТ-ийн мэдээлэлд шинээр олгосон болон сунгасан гэрчилгээний ялгааг тусгадаггүй байна. Харин БОАЖЯ-ны цахим хуудсанд энэ ялгааг тусгаж, төлсөн төлбөрийн мэдээллийг оруулж байна.

### *Олон нийтийн оролцоо*


Зөвшөөрөл, гэрчилгээ олгоход олон нийтийн оролцоог хангах механизм байхгүй, зөвшөөрөл, гэрчилгээ олгох хүсэлт, тэдгээрт тусгах нөхцөлийн талаар өөрсдийн байр суурийг илэрхийлэх, зөвшилцөх боломжгүй, зөвхөн янз бүрийн төлөөллийн байгууллагуудаар уламжлан шууд бусаар оролцдог байна.

## Хүснэгт 2.3: Мэргэжлийн байгууллагын гэрчилгээ эзэмшигчид

	БОМТ-ийн цахим хуудас		БОАЖЯ-ны цахим хуудас	
	тоо	хугацаа (ойролцоогоор)	тоо	хугацаа (ойролцоогоор)
Ургамал	10 / 8 (2 жагсаалт)	2011-2014	19 шинэ, 2 шинэчилсэн	2016 оны 1-ээс 9 сар
Амьтан	24 / 27 (2 жагсаалт)	2011-2014	10 шинэ, 4 шинэчилсэн	2016 оны 1-ээс 9 сар
Ус	200	2011-2014	22 шинэ, 1 шинэчилсэн	2016 оны 2-оос 5 сар
			19	2016 оны 1-ээс 9 сар
Геологи	419	2011-2014	45 шинэ, 16 шинэчилсэн	2016 оны 1-ээс 9 сар
Ой	447	2010-2014	118 шинэ, 41 шинэчилсэн	2016 оны 1-ээс 9 сар
			52	2013 оны 10-2014 оны 6 сар
			93 шинэ, 12 шинэчилсэн	2016 оны 2-оос 6 сар
Уур амьсгал, байгаль орчны мониторинг	1	2014		
Батламжлагдсан аудитын компаниуд	11	2013-2014	6	2016 оны 1-ээс 9 сар
			23	
Аудиторууд (хувь хүн)			164	2013-2015 онд шинэчилсэн
Байгаль орчны мэргэжилтэн			71 шинэ, 21 шинэчилсэн	2016 оны 4-5 сар
Нарийвчилсан БОНУ	147	2006-2016	19 шинэ, 29 сунгасан	2016 оны 1-ээс 9 сар
			7 шинэ, 25 сунгасан	2016 оны 3-5 сар
			193 хүчин төгөлдөр	

Эх сурвалж: БОМТөв, БОАЖЯ-ны цахим хуудсууд, 2017 он.

## Зураг 2.1: БОНУ-ний гэрчилгээ шинээр авсан мэргэжлийн байгууллагуудын тоо, 2006-2016 он



Эх сурвалж: БОМТ, <http://www.eic.mn/eia/>

## Зөвшөөрөл, гэрчилгээний талаарх мэдээлэл

БОМТ-ийн цахим хуудсыг бүрэн, цогц, найдвартай, үнэн зөв шинэчилсэн мэдээллээр хангах нь ил тод байдлыг нэмэгдүүлэх, нөөцийн үнэлгээ гаргах, улмаар шинээр зөвшөөрөл олгох асуудлыг зохистой шийдвэрлэхэд эрх бүхий удирдах байгууллагын үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах, хөнгөвчлөхөд нэн чухал ач холбогдолтой юм. БОМТ-ийн цахим хуудас нь зөвшөөрөл, гэрчилгээний талаарх мэдээллийн үнэт эх сурвалж болдог, нэмэгдэл мэдээлэл БОАЖЯ-ны цахим хуудсанд байгаа ч энэ хоёр цахим хуудасны мэдээлэл өөр хоорондоо ихээхэн зөрчилтэй байна. Хоёр эх сурвалж мэдээ мэдээллийн цар хүрээний хувьд ялгаатай, тухайлбал БОМТ-ийн мэдээлэлд амьтан, ургамлын аймаг, бодисын нэр, төлбөрийн хэмжээ, зөвшөөрөл нь хүчин төгөлдөр эсэх, сунгасан байдал зэргийг тусгадаггүй, эх сурвалжуудын хамрах хугацааны хувьд яамны цахим хуудас нь ерөнхийдөө богино хугацааны, шинэлэг



мэдээлэлтэй, БОМТ нь шинэлэг мэдээллээр хомс байна. Бүх зөвшөөрөл, гэрчилгээг хамаарч чадахгүй байна.

Түүнчлэн БОМТ-ийн цахим хуудаснаас мэдээ мэдээллийг татах боломжгүй байгаа нь олон нийт мэдээллийг ашиглан дүн шинжилгээ хийх, нөгөө талаар БОАЖЯ бодлого, менежментийн статистикийн мэдээллийг авч ашиглах боломжийг хязгаарлаж байна.

## 2.2 Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, олон нийтийн оролцоо

### *Танилцуулга*

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тогтолцоо Монголд 1987 онд Байгаль орчны асуудал хариуцсан яам байгуулагдаж, байгаль орчны үнэлгээний ЗХУ-д хэрэглэгдэж байсантай төстэй туршлагыг нэвтрүүлснээр анх бүрдсэн байна. Байгаль орчны үнэлгээний туршлага нь техникийн үлгэрчилсэн хэлбэртэй, олон нийтийн оролцоог тооцоогүй, олон нийт өөрийн туршлагад үндэслэн үнэлгээ хийх боломжийг хязгаарласан, туршлагын хувьд олон сул талтай юм. Энэ тогтолцоог Монголд 1995 онд БОНУ-гээр сольж, 1998 онд түүнийг улам боловсронгуй болгон, 2001 онд дахин шинэчилж, улмаар БОНУ-ний тухай 2012 оны хуулиар бэхжүүлэн баталгаажуулсан байна.

Өнөөгийн хууль тогтоомжид: (1) Бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөний Байгаль орчны стратегийн үнэлгээ (БОСҮ); (2) Бүх төрлийн төслийн санал, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах шатанд тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчны нөхцөл байдлыг тодорхойлоход чиглэсэн Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ; (3) Төсөл боловсруулахад шаардагдах ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хэлбэртэй байх Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ (БОНУ); (4) Тодорхой бүс, газар оронд хэрэгжүүлсэн төслүүдийн үр нөлөөг үнэлэх зорилгоор боловсруулах Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ (ХНУ) зэрэг 4 төрлийн байгаль орчны үнэлгээг тодорхойлж өгсөн байна. БОНУ-ний тухай хуультай нийцүүлэн, Эрүүл ахуйн тухай 2012 онд шинэчилсэн хуулийн дагуу Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг 2016 онд нэвтрүүлжээ.

БОНУ-ний тухай хуулийн цар хүрээ маш өргөн, түүнд хуулийн хавсралтад дурьдсан, байгалийн нөөцийг ашиглаж буй шинэ, шинэчилсэн, өргөжүүлсэн бүх үйл ажиллагаа цар хэмжээнээс үл хамааран бүрэн хамрагдана. Жишээ нь хөнгөн үйлдвэрлэл, шатахуун түгээх станцууд, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн зэрэг төрлийг жагсаалтад оруулсан байна. Тоон босго үзүүлэлтүүдийн хэмжээг улсын, орон нутгийн захиргааны мэдэлд харьяалуулах үүднээс ялгаатай (тухайлбал, 50-иас дээш, эсвэл доош ортой зочид буудал, 1 МВ-аас дээш, эсвэл доош хүчин чадалтай цахилгаан станц г.м.) тогтоосон байна.

БОНУ-ний тухай хуулиар БОНУ-ний Мэргэжлийн зөвлөлийг БОАЖЯ-нд байгуулж, БОСҮ, ХНУ, нарийвчилсан БОНУ-г үндэслэн боловсруулсан тайлан илтгэл, зөвлөмжийг дүгнэх үүрэг ноогдуулсан байна. Зөвлөл нь нарийвчилсан БОНУ-ний тайлан илтгэлүүдийг хэлэлцэх, дүгнэлт гаргах зорилгоор сард нэгээс доошгүй удаа хуралддаг. Хуралдааны тэмдэглэлийг яамны цахим хуудсанд байршуулах ёстой боловч өнөөгийн байдлаар олон нийгэд хүргэхгүй байна.

### *Байгаль орчны ерөнхий үнэлгээ*

Ерөнхий хамрах цар хүрээг тогтоох зорилго бүхий ерөнхий БОНУ-г БОАЖЯ, аймаг нийслэлийн засаг даргын Тамгын газар (байгаль орчин, аялал жуулчлалын хэлтэс) БОНУ-ний тухай хуулийн хавсралтад заасан жагсаалтын дагуу боловсруулна. Бүх төрлийн төслийн сонгон шалгаруулалтын үзүүлэлт, босго байхгүй нь оролцогч талуудын ажлын ачааллыг нэмэгдүүлэхэд хүргэдэг. Төлөвлөсөн үйл ажиллагааны хэмжээг тоон үзүүлэлтээр тодорхойлох нь жижиг төслүүдэд нарийвчилсан БОНУ хийх шаардлагагүйг түргэн тогтоох боломжийг олгоно. Мөн сонгон шалгаруулалтын үзүүлэлт, босго байхгүй нь ямар байгууллагад харьяалуулах асуудлыг шийдвэрлэхэд хүндрэл учруулдаг байна.

Төслийг хэрэгжүүлэгч нь төслийн товч танилцуулга, ТЭЗҮ-ийн судалгаа, схем бүдүүвч, байгаль орчны суурь үнэлгээ, сумын засаг даргын бичгээр өгсөн санал, холбогдох бусад баримт бичгийг илгээж ерөнхий БОНУ хийлгэх хүсэлт гаргана. Эрх бүхий удирдах байгууллагаас томилсон үнэлгээний мэргэжилтэн шинжээч нь 14 өдрийн хугацаанд (нэг удаа 14 өдрөөр сунгах эрхтэй) баримт бичигт үнэлгээ хийж, дараах дүгнэлт саналаа албажуулан хүргүүлнэ. Үүнд:


- Төсөлд санал болгосон технологи, техник төхөөрөмж, үйл ажиллагаа нь байгаль орчинд ихээхэн хохирол учруулах, газрын менежмент, харилцааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, үйл ажиллагаа нь

төрийн бодлогод нийцээгүй, БОСҮ болон бусад хууль тогтоомжийн дүгнэлт зэргийг үндэслэн тухайн төсөлд зөвшөөрөл олгохгүй, татгалзах,

- Тусгай нөхцөл шаардлага хангасан тохиолдолд нарийвчилсан БОНҮ-гүйгээр төслийг хэрэгжүүлж болох,
- Төсөлд нарийвчилсан БОНҮ хийж, зорилго, талбай, цар хүрээ, хугацаа зэргийг тодорхойлох.


Боловсруулсан ерөнхий БОНҮ-ний тоо, гарч болох үр дүн, дүгнэлтийн тоог шийдвэр гаргасан жилээр нэгтгэн, 2012 оноос өмнө гаргах боломжтой байсан шийдвэрийн (тухайлбал нарийвчилсан БОНҮ, тодорхой нөхцөл шаардалгүйгээр хэрэгжүүлэх зөвшөөрлийг шууд гаргах) тухай мэдээллийг Зураг 2.2-т харуулав. Мэдээлэлд тодруулах шаардлагатай төслүүдийг хэрхэн шийдвэрлэсэн (ерөнхий БОНҮ боловсруулсан нийт төслийн 4 орчим хувь), эдгээр төслүүдэд татгалзсан хариу өгсөн эсэх талаар мэдээ мэдээлэл байхгүй байна. Ерөнхий БОНҮ-ний тоог төлөвлөсөн үйл ажиллагааны төрлөөр нэгтгэн Зураг 2.3-т харуулав.

**Зураг 2.2: 2000-2016 онд дүгнэлтийн дагуу боловсруулсан ерөнхий БОНҮ-ний тоо**



Эх сурвалж: БОМТ, 2017 он.

**Зураг 2.3: 2000-2016 онд төслийн төрлөөр боловсруулсан ерөнхий БОНҮ-ний тоо**



Эх сурвалж: БОМТ, 2017 он.


*Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ*

Нарийвчилсан БОНУ-г хэрэгжүүлэгчийг төлөөлөн, түүний зардлаар эрх бүхий байгууллага боловсруулах ба түүнд Байгаль хамгааллын төлөвлөгөө, мониторингийн хөтөлбөр бүхий байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ), ерөнхий БОНУ-нд тусгасан бол эрсдийн үнэлгээ, уурхайг хаах үйл ажиллагааны тайлбар, нөхөн сэргээх ажиллагааны зорилго, цар хүрээ болон үзүүлэлтүүд, газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын талбайг хадгалах арга хэмжээ, санал болгосон төсөлд хамаарал бүхий орон нутгийн захиргаа, ард иргэдтэй зөвшилцсөн тайлан мэдээлэл зэргийг хамруулна. Мөн БОАЖ-ын сайдын 2014 оны А-117 тоот тушаалаар баталсан үйл ажиллагааны удирдамжид БОНУ-ний баримт бичиг боловсруулахад хамгийн чухал, боломжтой хувилбаруудыг тогтоох асуудлыг тусгажээ.

Эрх бүхий байгууллагаас томилсон, өмнөх ерөнхий БОНУ-нд дүгнэлт гаргасан мэргэжилтэн шинжээч нь ажлын 18 өдрийн хугацаанд нарийвчилсан БОНУ-ний чанарын дүгнэлт гаргана. Шаардлагатай гэж үзвэл яамны үнэлгээний ахлах шинжээч нарийвчилсан БОНУ-ний талаар дүгнэлт гаргах шинжээчдийн бүлэг томилж болох ба хугацааг нэг удаа 18 өдрөөр сунгаж болно. Нарийвчилсан БОНУ-ний тайлан илтгэл, чанарын дүгнэлт гаргасан шинжээч болон Мэргэжлийн зөвлөлийн санал дүгнэлтийг харгалзан БОАЖЯ төслийг эхлүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

БОНУ-ний тухай хуулийн дагуу нарийвчилсан БОНУ хийх гэрчилгээтэй 200 орчим байгууллага байгаа бөгөөд 2012-2016 онд жилд дунджаар 211 нарийвчилсан БОНУ хийсэн байна (Зураг 2.4). Олон байгууллага зарим жилд нэг ч нарийвчилсан БОНУ хийгээгүй байгаа нь туршлага хуримтлуулах боломж олгохгүй байна. БОНУ-ний тухай хуульд үнэлгээ хийх гэрчилгээтэй байгууллагын гол үйл ажиллагаа нь нарийвчилсан БОНУ хийхэд оршино гэж онцлон заасан байна.

**Зураг 2.4: Нарийвчилсан БОНУ, салбараар, 1995-2016 он**



Эх сурвалж: БОМТөв, 2017 он.

Түүнчлэн дийлэнх БОНУ-г хуулбарлах маягаар үйлдсэн, үнэлгээний чанар сул, үнэлгээ нь төслийг боловсронгуй болгох, түүний тогтвортой болон үр ашигтай байдлыг хангахад төдийлөн нэмэр оруулдаггүй гэсэн нийтлэг ойлголт бий. Иймд гэрчилгээ олгох үзүүлэлт, аргыг улам боловсронгуй болгох, БОНУ-ний чанарын үнэлгээг сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүргэж байгаа боловч үүнийг өнөөгийн боловсон хүчний нөөцийн хувьд асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм.

*Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

Ерөнхий БОНУ-г хариуцсан эрх бүхий байгууллага нь санал болгосон төслийн БОМТ-г батлан, төслийг эхлүүлэх зөвшөөрөл олгоно. БОМТ-тэй холбоотой бусад асуудлууд, тухайлбал БОМТ-г

хэрэгжүүлэх баталгааны урьдчилгаа төлөх зэргийг БОНУ-ний тухай хуулиар зохицуулжээ. Ашигт малтмал олборлох, хайлуулах, боловсруулах, химийн болон коксжих химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагааны урьдчилгааг БОАЖЯ-наас нээсэн дансанд (ОУИТБС-ын хэсэгт энэ сангийн тухай дурьдсан), бусад төслийн урьдчилгааг сумын засаг даргын нээсэн дансанд тушаана.

Жил бүрийн сүүлчээр зөвшөөрөл эзэмшигч нь жилийн ажлын төлөвлөгөөг БОМТ-ний хамт УУХҮЯ-нд хүргүүлнэ. БОМТ-г давхар БОАЖЯ-нд хүргүүлнэ. Жилийн төгсгөлд зөвшөөрөл эзэмшигч нь хэрэгжүүлсэн бодит үйл ажиллагааны жилийн тайлан, БОМТ-ний биелэлтийг яаманд хүргүүлэх үүрэгтэй.

Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааны нэг хэсэг болох газрыг нөхөн сэргээх арга зам

Нөхөн сэргээлт, ялангуяа уул уурхайн нөхөн сэргээлт нь БОМТ-ний чухал хэсэг бөгөөд сүүлийн жилүүдэд биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах, өөр газарт сонгосон (альтернатив) талбайн нөхөн сэргээлтэд онцгой анхаарал хандуулж байна. Уул уурхайн улмаас эвдэрсэн газрыг бүрэн хэмжээгээр нөхөн сэргээх боломжгүй байдгийг харгалзан шинэчилсэн БОНУ-ний тухай хуульд дээрх үйл ажиллагааг зохицуулж өгсөн байна. Нөгөө талаар энэхүү заалт нь өөр байрлалд сонгосон талбайд хайгуул, олборлолт хийх, ААН нь өөрийн ажиллагааны улмаас эвдэрсэн бус, өртөг багатай илүү хялбар талбайг сонгон нөхөн сэргээлт хийх зэргээр хууль зөрчих боломжийг нээж байна. Төрийн бус байгууллагууд энэхүү биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах ажлыг хэрэгжүүлэх, орон нутгийн байгууллагуудын ийм төслийн хэрэгжилтэд мониторинг хийх чадавхи байхгүй байгааг байнга шүүмжилдэг. БОАЖЯ биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах, өөр газар соносон тайлбайг нөхөн сэргээх үйл ажиллагааны тухай гарын авлага, зааварчилгаа одоо ч гэсэн хангалтгүй байгааг хүлээн зөвшөөрдөг.

#### *Олон нийтийн оролцоо*

БОНУ дахь олон нийтийн оролцоог БОНУ-ний тухай хууль, БОАЖ-ын сайдын 2014 оны А-03 тоот тушаалаар баталсан олон нийтийн оролцооны журмаар зохицуулж байна.

Ерөнхий БОНУ хийх шатанд нийслэл, аймгийн орон нутгийн захиргаа мэдээ мэдээллийг олон нийтийн хүртээл болгох ажлыг хариуцана. Ерөнхий БОНУ-г хийхэд холбогдох сумын засаг даргын бичгээр үйлдсэн санал заавал байх ёстой ба ерөнхий БОНУ-г 14 өдрийн хугацаанд (14 өдрөөр сунгаж болно) дуусгахаар заажээ.

Нарийвчилсан БОНУ хийх шатанд, БОНУ-ний тайлан илтгэлийг боловсруулах явцад үнэлгээ хийж буй ААН нь орон нутгийн захиргаа, төслийн үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэхэд оролцох, хамрагдах орон нутгийн ард иргэдтэй зөвшилцөж, БОНУ-ний тайланд зөвшилцлийн тэмдэглэл, мэдээллийг хавсарсан байх ёстой. Хуулиар олон нийт төслийн талаар амаар, бичгээр санал дүгнэлтээ ажлын 30 өдрийн хугацаанд илэрхийлэх өргөн боломжийг олгодог байна. Олон нийтийн оролцооны журамд иргэдийн амьжиргааны болон нийгмийн асуудлууд, олон нийтийн үнэлгээний арга аргачлал, хэлэлцүүлэгт анхаарлыг төвлөрүүлэхээр тусгасан боловч хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхойлоогүй аж.

БОАЖ-ын сайдын 2014 оны А-117 тоот тушаалаар баталсан аргачлалын удирдамжид олон нийтэд ойлгомжтой, техникийн бус хэллэгтэй дүгнэлт гаргаж байхаар тусгасан боловч зөвхөн олон нийтэд зориулж тусад нь тайлан дүгнэлт гаргах эсэхийг дурьдаагүй. Мөн БОНУ-ний тухай хуульд БОНУ хийх буй этгээд нь техникийн, технологийн, бизнесийн тодорхой нууцлалыг хамгаалахаар оруулсан ба зарим байгууллагууд үүнийг өргөнөөр ашиглаж байна.

БОНУ-нд иргэдийн амьжиргаа, нийгмийн асуудалд анхаарал хандуулах талаар тодорхой заалт орсон боловч уул уурхайн орчин дахь орон нутгийн иргэдийн амьжиргаанд үзүүлж буй сөрөг нөлөөллийг төдийлөн анхаарахгүй, газрыг өмчлөөгүй, зөвхөн эзэмшиж буй ард иргэд эдийн засгийн хөгжлөөс шалтгаалан шилжин суурьших шаардлага тулгарахад тэдэнд эдийн засгийн, техникийн хувьд оновчтой хувилбар санал болгохгүй байгаа талаар ард иргэдээс олон тооны санал гомдол ирдэг байна. Мөн шууд бус сөрөг нөлөөлөлд өртсөн хүмүүсийн асуудлыг анхаарахгүй, тэднийг сөрөг нөлөөлөлд өртсөн хэмээн үзэхгүй тохиолдол байна.

Бэлэн болсон нарийвчилсан БОНУ-ний дүгнэлт, саналыг 15 өдрийн дотор багийн хурлаар оруулах үүрэгтэй. Багийн хурлыг ихэвчлэн сард нэг удаа, өвлийн улиралд түүнээс цөөн хийдэг. Төслийг хэрэгжүүлэх эхний жилд олон нийтийн зөвшилцлийг үргэлжлүүлнэ.

Олон нийтийн оролцооны журмын дагуу БОНУ-ний тайлан илтгэл, БОМТ-г төслийг хэрэгжүүлэгч компаниуд, сум, дүүрэг, баг, хороодын засаг даргын ажлын алба, аймаг хотуудын байгаль орчны хэлтсийн цахим хуудсанд олон нийтийн хүртээл болгон байршуулах ёстой. Гэвч БОМТ, орон нутгийн захиргааны цахим хуудсанд бүрэн БОНУ огт байхгүй, БОАЖЯ-ны архивт хадгалж, хүсэлт гаргасан нөхцөлд танилцуулдаг байна. Хэмжээний хувьд БОНУ-г цахим хэлбэрээр танилцуулах боломжгүй хэмээн үздэг.

#### *Хил дамнасан асуудал*

Монгол Улс хил дамнасан БОНУ-г зохицуулах эрх зүйн тогтолцоогүй. Монгол улсын мэргэжилтнүүд БОНУ-ний конвенцийн Хил дамнасан асуудлаарх хуралдаан, БНСУ-ын Байгаль орчны хүрээлэнгээс зохион байгуулсан хил дамнасан БОНУ-ний талаарх арга хэмжээнүүдэд сүүлийн жилүүдэд оролцжээ.

Монгол Улсын их сургууль Таван толгойн уурхайгаас хилийн Гашуун Сухайт боомт хүртэлх төмөр замын шугамын хил дамнасан БОНУ-ний туршилтын сургалтыг БНСУ-тай хамтран 2014 онд хийсэн байна.

Хил дамнасан усны нөөц, авто болон төмөр замаар их хэмжээний ашигт малтмал тээвэрлэх, “Нэг бүс, Нэг зам” санаачилгын хүрээнд томоохон үйл ажиллагаа явуулах зэрэг хил дамнасан хөгжлийн чухал шинэ төслүүдийг хэрэгжүүлэхэд хил дамнасан БОНУ хийх нь ихээхэн ашиг тустай байх болно.

#### *Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ*

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ нь БОНУ-ний тухай 2012 онд шинэчилсэн хуулиар анх нэвтрүүлсэн шинэ үнэлгээ бөгөөд Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолоор баталсан Байгаль орчны стратегийн үнэлгээ, Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний асуудлыг нарийвчилсан журмаар тогтоосон байна. Хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээг тодорхой талбай, эсвэл усны сав газарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн олон төслүүдийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх нийлбэр нөлөөлөлд дүн шинжилгээ хийх зорилгоор БОАЖЯ-наас хийж, түүнд хуримтлагдсан нөлөөллийн идэвхжил, цар хүрээ, тархалт, хуримтлагдсан нөлөөллийг бууруулах арга хэмжээ, зардлын тооцоо болон хувилбарууд, байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлэх хохирлын тооцоо зэргийг тусгана. Олон нийттэй зөвшилцөх тухай асуудал нь хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээний журмын нэг хэсэг юм.

Бодит байдалд хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээг хийх явдал хязгаарлагдмал, 2017 оны дунд үеийн байдлаар зөвхөн хоёр тохиолдолд хийсэн байна.

### **2.3 Байгаль орчны стандартууд**

Монгол Улсын Стандартчилал, хэмжил зүйн газраас (СХЗГ) байгаль орчинтой холбоотой 370 орчим стандарт баталжээ. Монголын үндэсний стандартууд (МҮС, MNS) нь цахим хэлбэрээр нийтэд хүртээлтэй, стандарт тогтооход олон нийт, сонирхсон бусад этгээдүүд оролцох боломжтой, шинэ стандарт боловсруулах талаар СХЗГ-ын цахим хуудсаар мэдээлдэг, стандарт тогтоох хоёр жилийн төлөвлөгөөг яамдуутай хамтран боловсруулдаг байна.

Стандарт бүр заавал, эсвэл сонгож, сайн дурын үндсэн дээр даган мөрдөнө. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай 2003 оны хуульд олон нийтийн аюулгүй байдалтай холбоотой бүтээгдэхүүний стандартыг заавал мөрдөхийг заажээ. Салбаруудын хууль тогтоомж, тухайлбал Байгаль орчныг хамгаалах тухай 1995 оны хуульд агаар, ус, хөрсөн дэх хортой болон биологийн бодисын агууламжийн хэмжээ, дуу чимээ шуугиан, чичирхийлэл, цахилгаан болон соронзон хэлбэлзэл зэрэг байгаль орчны сөрөг нөлөөлөл, цацраг идэвхийн түвшин, хүнсний бүтээгдэхүүн дэх химийн бодисын агууламж зэрэг онцлог стандартуудыг тогтоосон байна. Салбарын яамдууд стандартуудыг даган мөрдөх, хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавхийг бий болгох үүрэгтэй байна.



Хорт бодисын ялгаруулалттай холбоотой дулааны цахилгаан станцын ялгаруулалтын удирдамж (MNS 6298-2011), усны сав газарт хаягдал ус нийлүүлэх стандартыг (MNS 4943-2015 ) мөрдөж байна. Аж үйлдвэрийн хаягдал бохир усыг олон нийтийн ариутгах татуурага, төв цэвэрлэх байгууламжид нийлүүлэх бохирдуулагчийн агууламжийг тогтоосон стандарт (MNS 6561:2015 Усны чанар, ус зайлуулах сүлжээнд нийлүүлэх ус. Ерөнхий шаардлага) үйлчилж байна.

Дуу чимээ шуугиан гаргалтын стандарт байхгүй боловч автомашины дуу чимээг тогтоох, хэмжихэд MNS 0017-5-1-21-1992 стандартыг мөрдөж байна.

Байгаль орчин болон ажлын байрны аюулгүй байдлын тухай дараах стандартууд үйлчилж байна. Үүнд:

- Орчин тойрны агаарын чанарын стандарт MNS 4585-2016 (хотын болон тасалгааны агаарын бохирдолтой хамааралтай);
- Усны чанарын стандарт MNS 4586-1998;
- Ундны усны стандарт MNS 0900-1991;
- Гүний усан дахь бохирдуулагч бодисын байж болох хамгийн их хэмжээний стандарт MNS 6148-2010;
- Хөрсний чанарын стандарт MNS 5850-2008;
- Хот суурины хөрсний ариун цэврийн стандарт MNS 3297-1991;
- Ажлын байрны агаар, эрүүл ахуйн шаардлагын стандарт MNS 0012-013-1991;
- Орон сууц, иргэний барилгын дуу чимээний түвшний стандарт MNS 0012-1-009-1985;
- Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэнд, орчин, эрүүл ахуйн шаардлагын стандарт MNS 4990-2015 (тухайлбал ажлын байран дахь хорт бодисын агууламжийн хэмжээг агуулна);
- Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэнд, дуу чимээний ерөнхий шаардлагын стандарт MNS 5002-2000.

СХЗГ-аас хүүхдийн тоглоомд тавих стандартыг 2011 оноос, мөн хүнс, барилгын материалын стандартыг баталж иржээ. Монгол Улс барилгын материалын 40 орчим хувийг импортлож, тэдгээр нь муу чанартай байгааг харгалзан дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлогыг Засгийн газар баримталж байна. Европын холбооны санхүүжилтээр хэрэгжүүлсэн, барилгын блокийг дулааны цахилгаан станцын үнс ашиглан туршилтын журмаар үйлдвэрлэх SWITCH-Азийн сүлжээний байгууламж төсөл нь дотоодын үйлдвэрлэлийг дэмжих чухал арга хэмжээ болсон байна. Төслийн хүрээнд СХЗГ-тай хамтран үнсээр үйлдвэрлэх барилгын материалын стандартыг боловсруулах ажил хийгдсэн байна.

Эко-шошгожуулахтай холбоотой MNS ISO 14021-2001, MNS ISO TR 14025-2001 хоёр стандартыг баталжээ. Бизнесийн нийгмийн хариуцлагын тухай MNS ISO 26000-2012 стандартыг баталсан хэдий ч бодит амьдралд хэрэгжих явдал хангалтгүй байна.

Цаг уур, орчны шинжилгээний газар (ЦУОШГ), МХЕГ-ын харьяа, гэрчилгээ бүхий 30 гаруй лаборатори байна. Хүнсний бүтээгдэхүүн, барилгын материалын шинжилгээ хийх лабораторын гэрчилгээг СХЗГ-аас олгодог.

Импортын бүх бараанд тохирлын үнэлгээ хийж, Монголын болон олон улсын хүлээн зөвшөөрсөн стандартад нийцэж байгааг тогтоох ёстой. СХЗГ нь олон улсын хараат бус баталгаажуулах компанитай гэрээ байгуулж тохирлын үнэлгээг Дэлхийн гаалийн байгууллагын барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн (БТКУС, HS) дагуу хийлгэж, хүнс, ХАА, хими, шатахуун, газрын тос, пластик бүтээгдэхүүн, тоглоом зэрэг олон ангиллаар тогтоосон дэлгэрэнгүй жагсаалтыг харгалзан үздэг байна. Импортын бараанд шошго, хадлалах хугацаа болон бусад шаардлагуудыг тавина.

## 2.4 Хууль мөрдөх үйл ажиллагааг хангах механизм

*ААН-үүдийн дотоод хяналт шинжилгээ, мониторинг болон тайлагнах зарчим*

Байгаль орчинтой холбоотой хууль тогтоомж, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор ААН-д дотоод хяналт шинжилгээ хийх, энэ асуудлыг хариуцсан, гэрчилгээ зөвшөөрөл бүхий ажилтан томилон ажиллуулахыг үүрэг болгосон байдаг.

Жишээ нь Агаарын тухай хуульд үндэсний хяналт шинжилгээний сүлжээнд агаар бохирдуулагч ААН-үүдийн дотоод хяналт шинжилгээний цэгүүдийг нэгтгэх, ААН-үүд бохирдуулагч бодис ялгаруулалтын тайлан мэдээллийг эрх бүхий байгууллагад хүргүүлэх үүрэгтэй боловч бодит амьдралд хэрэгжиж байгааг нотлох баримт байхгүй байна. Үүнтэй адил хууль тогтоомж усны талаар гарсан. Хэрэглэгчид ус ашиглалтын тоолуур тавих, өдрийн хэрэглээ 50 м<sup>3</sup> –ыг давсан тохиолдолд ажиллагааны бүх хугацаанд ус ашиглалтыг хянах тоног төхөөрөмж суурилуулах, ус ашиглалтын менежер ажиллуулах үүрэгтэй ч амьдралд мөн л хэрэгжихгүй байна.

Жил тутмын БОМТ нь байгаль орчны хамгаалал, дотоод хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрддэг учир дотоод хяналт шинжилгээний асуудлыг төлөвлөгөөнд заавал тусгах ёстой. Дотоод хяналт шинжилгээний хөтөлбөрт үйл ажиллагааны улмаас байгаль орчинд гарсан өөрчлөлт, тайлагнах зарчим, хэрэгжүүлэх арга хэлбэр, хугацаа, тооцолсон төсөвт хяналт болон дүн шинжилгээ хийх асуудлуудыг тусгадаг.

Дотоод хяналт шинжилгээг хэрэгжүүлж буй байдлыг үзвэл томоохон компаниуд үүрэг бүхий нэгжүүдийг ажиллуулж, тэдний тайлан мэдээлэл чанартай, боловсронгуй байгаа бол жижиг, дунд компаниуд энэхүү үүргийг биелүүлэхэд хүндрэлтэй байна. МХЕГ-ын байцаагч нь шаардлага хангаагүй дотоод хяналт шинжилгээнд торгууль ноогдуулах эрхтэй байдаг.

#### *ТББ, иргэдийн хяналт мониторинг*

ТББ, орон нутгийн бүлгүүд, иргэд байгаль орчны хууль тогтоомжийн иргэний хяналтыг хэрэгжүүлдэг. ТББ-ууд нь БОМТ-нд хөндлөнгийн хяналт хийх боломжтой боловч эдгээр төлөвлөгөө нь олон нийтэд хүртээмжгүй, БОАЖ-ын сайдын 2014 оны А-03 тоот тушаалаар үүрэг болгосон яамны цахим хуудсанд байршуулж олон нийтэд нээлттэй болгох шийдвэр хэрэгжихгүй байгаа нь төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт мониторинг хийх боломжийг ихээхэн хязгаарлаж байна. ОУИТБС-ын тухай ЗГ-ын 2012 оны 222 дугаар тогтоолоор жилийн БОМТ-нүүдийг олон нийтэд нээлттэй болгох үүргийг БОАЖ-ын сайдад ноогдуулсан байна.

Зарчмын хувьд ТББ, орон нутгийн бүлгүүд, иргэд хяналт мониторинг хийх, шаардлагатай гэж үзвэл байцаагч нар, шүүх, захиргааны холбогдох байгууллагуудад үйл ажиллагааны зөвшөөрлийн нөхцөл зөрчигдөж байгаа асуудлаар гомдол гаргах, байгаль орчныг хамгаалах үүрэг бүхий ТББ-ууд байгаль орчинд учруулсан хохирлын талаар шүүхэд хандах бүрэн эрхтэй.

Гэвч ТББ-ууд нь нөөц, мэргэжлийн мэдлэг, чадвар чадавхийн хувьд хязгаарлагдмал, тэдний цуглуулсан гэрчийн баримтыг шүүх хүлээн зөвшөөрөхгүй тохиолдол олон байна. Захиргааны хэргийг аймгийн төвд байрлах захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэдэг тул түүнд малчин иргэд оролцох боломж бага. Мөн шинжээчид, шүүх байгууллага ТББ, олон нийтийн бусад байгууллагуудын гаргасан гомдол, хэрэгт шудрага бусаар хандаж байгаа нь мөн асуудал дагуулж байна.

#### *Байгаль орчны аудит*

Байгаль орчны хууль тогтоомжийг 2012 онд шинэчлэх явцад байгалийн нөөцийг ашиглаж буй бүх ААН-үүд хоёр жил тутамд байгаль орчны хараат бус хөндлөнгийн аудит хийлгэх шаардлагыг нэвтрүүлсэн нь нэн чухал ач холбогдолтой болсон байна. Байгаль орчныг хамгаалах тухай 1995 оны хуульд 2012 онд нэмэлт өөрчлөлт оруулж, байгалийн нөөцийг ашиглаж буй ААН-үүд төлөвлөгөөт аудитын тайлан мэдээллийг аймаг, нийслэлийн байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлэх, төлөвлөгөөт бус аудитыг БОАЖЯ, аймгийн засаг даргын санаачилгаар хийж байхыг заажээ. БОАЖЯ-нд аудит хариуцсан ганцхан мэргэжилтэн ажиллаж байна.

БОАЖЯ байгаль орчны аудитын ерөнхий аргачлалыг сайдын 2013 оны А-126 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар баталж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус аудит, байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлогын аудит, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, БОНУ, тэдгээрийн хэрэгжилт болон бусад үйл ажиллагааны аудитын асуудлыг зохицуулсан байна.

Практик амьдрал дээр байгаль орчны аудитыг хэрэгжүүлэх явдал тун удаан явцтай байна. Гадаадын томоохон хөрөнгө оруулалттай уул уурхайн компаниудад байгаль орчны аудитыг олон улсын стандартын дагуу хийсэн, мэдээллийг олон нийтэд түгээсэн жишээ баримт бий боловч эдгээр нь тун цөөн байна. БОАЖЯ-нд шаардлага хангах боловсон хүчний нөөц дутмаг, хуулийн заалтыг зөрчсөн нөхцөлд хариуцлага, торгууль ноогдуулах механизм байхгүй байгаа нь аудитын үйл ажиллагаа хууль тогтоомжийн хүрээнд бус, сайн дурын, эсвэл хөрөнгө оруулагчдын шахалтаар хэрэгжиж байгаагийн нотолгоо болж байна.

### *Хяналт шалгалт*

Хяналт шалгалтын үйл ажиллагааг 2013 оны Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон бусад удирдамжаар зохицуулж байна. Салбарын болон хэвлэл мэдээллийн хууль тогтоомжид үндсэндээ мониторинг, хяналт шалгалт, МХЕГ-ын эрх үүргийн талаар тусгасан байна. Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гэнэтийн, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын төрөл бүрийн арга хэмжээг иргэдийн гомдлыг барагдуулах, суурь төлөв байдлыг тогтоох, зөвлөмж гаргах зорилгоор хэрэгжүүлж байна. Олон салбар чиглэл, тухайлбал хүнсний аюулгүй байдал, ХАА, эрүүл мэнд, боловсрол, аж үйлдвэрийн аюулгүй байдал зэргийг хамарсан салбар дундын хяналт шалгалтыг МХЕГ зохион байгуулж байна. Хяналт шалгалтыг сар, улирал, жилээр төлөвлөдөг, хяналт шалгалтыг гүйцэтгэх захирамж гарган түүнд бүрэлдэхүүн, үүрэг зорилгыг тодорхойлдог ажээ.

Хяналт шалгалтын төлөвлөлтөд эрсдэлд суурилсан хандлагыг 2010-2011 оноос ашиглаж эхэлсэн хэдий ч орон даяар нэвтрүүлэх явдал одоогоор бүрэн хэрэгжээгүй байна. МХЕГ-ын байцаагчид гарын авлага, удирдамжуудыг ашиглаж, дотоодын хяналт шалгалтын тайланг баталгаажуулах үүргийг давхар хариуцдаг байна.

МХЕГ нь төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, давтан хяналт шалгалтын статистикийг 2014 оноос хойш хуримтлуулж байна. 2013-2015 оны статистикт янз бүрийн зөрчил, мөнгөн, тоног төхөөрөмж, байгалийн нөөцийн болон бусад хэлбэрийн барьцаа, нөхөн төлбөр хийх хохирол, торгуулийн хэмжээг нэгтгэн оруулсан байна. Мэдээлэл нь богино хугацааг хамарч байгаа ба сүүлийн жилүүдэд ААН, иргэдэд хийсэн хяналт шалгалтын тоо огцом буурч, 2013 онд 20,469 байснаа 2014 онд 10,263, 2015 онд 4,351 болтол буурсан байна. Мөн хугацаанд торгууль, нөхөн төлбөр 977 сая төгрөгөөс 614 сая болтол буурчээ. Хамгийн олон тооны хяналт шалгалтыг ой, газар, амьтан ургамлын салбарт, дараа нь хөрс, БОНУ, хог хаягдал, тэсрэх бодис, ашигт малтмалын салбар орж байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар хяналт шалгалтын төлөвлөлтийг сайжруулахад чиглэгдсэн бохирдуулагч эх сурвалжуудын төрийн нэгдсэн бүртгэл хөтлөхийг БОАЖЯ-нд даалгасан боловч ийм цогц бүртгэл байгааг нотлох баримт байхгүй байна.

Олон нийтийн гомдлын дагуу хяналт шалгалт хийж болно. Төрийн бүх байгууллагын нэгэн адил МХЕГ гомдлын хариуг ажлын 14 өдөрт өгөх үүрэгтэй боловч Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар гэрчийн баримт бүхий гомдлын дагуу хийх хяналт шалгалтыг ажлын 5 өдөрт эхлүүлэхээр тусгасан тул МХЕГ нь энэхүү заалтыг ерөнхийд нь даган мөрдөж байгаа ч үүнийг батлах мэдээ мэдээлэл мөн байхгүй байна.

Сүүлийн жилүүдэд МХЕГ-ын байгаль орчны байцаагчид зөвлөх үйлчилгээ үзүүлэх, бизнесийн байгууллагуудад чиглэгдсэн нээлттэй өдөр, ЖДААН-үүдэд чиглэгдсэн боловсролын арга хэмжээ зэрэг хууль сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Байгаль орчны хууль тогтоомж, шаардлагыг хэрэгжүүлэх хянан шалгах ажилд бусад байгууллагууд оролцдог байна. Тухайлбал нарийвчилсан БОНУ-ний хүрээнд хэрэгжүүлж буй БОМТ-нд янз бүрийн байгууллагууд хөндлөгийн хяналт шалгалт хийж болно. Орон нутгийн захиргаа нь ашигт малтмалын олборлолтын явцад байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа хэрэгжиж байгаа эсэхэд шалгалт хийх үүрэгтэй байдаг. Мөн ерөнхий БОНУ хийсэн байгууллага нь хөндлөнгийн хяналт шалгалтын дүгнэлтийг үндэслэн төслийн болон БОМТ-ний гүйцэтгэлийн талаар хараат бус хяналт шалгалтыг төсөл хэрэгжүүлэгчийн зардлаар хийлгэх санал гаргаж болдог байна.

### Хууль зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээ

Монголд холбогдох журам дүрмийг мөрдөх, зөвшөөрөл авах, зөвшөөрлийн нөхцөлийг сахих, ялгаруулалтын стандартыг зөрчих, байгаль орчин болон хүний эрүүл мэндэд хохирол учруулах, шаардлагатай арга хэмжээ авахаас татгалзах, тайлан мэдээллийг гаргах, хуурамч тайлан мэдээлэл гаргах, хугацаа дуусгавар болсон зөвшөөрөл ашиглах, хориотой үйл ажиллагаа явуулах, бусад үүргийг сахин биелүүлэхэд ихээхэн зөрчил гарч байна. Сүүлийн үед албан тушаалтнууд хуульд заасан үүргээ биелүүлэхгүй зайлсхийх гэмт хэрэг газар авах төлөвтэй байна. Хууль зөрчсөн этгээдэд зөрчлийн төрөл, учруулсан хохирлын хэмжээг харгалзан эрүүгийн болон захиргааны хариуцлага тооцох зарчимтай.

Байгаль орчинтой холбоотой улсын болон салбарын хууль тогтоомжид зөрчил, хариуцлага төлбөрийн талаар тусгасан байна. Зөрчлийн тухай 2017 оны 5 дугаар сард батлагдсан шинэ хуульд байгаль орчны хамгааллын бүлэг орсон байна. Хуульд цөлжилт, Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенци болон БОНУ-ний хуулиудын хэрэгжилт, агаар, ус, амьтан, ургамал, ой, хөрс, ашигт малтмал, газрын тостой холбоотой харилцааг зохицуулах заалтууд оржээ. Байцаагч зөрчлийг тогтоож, захиргааны зөрчлийн хувьд акт тогтооно. Зөрчсөн этгээд актыг хүлээн авахгүй байж болно. Тухайн этгээд зөрчлийг хүлээсэн нөхцөлд ноогдуулсан торгуулийг 14 өдрийн дотор барагдуулах үүрэгтэй байна. Түүнчлэн боломжтой нөхцөлд учруулсан хохирлыг барагдуулах, зөвшөөрөл гэрчилгээг нэн даруй цуцлах (тухайлбал хүний эрүүл мэндэд хохирол учруулах нөхцөлд) зэрэг арга хэмжээг авч болно. Тухайн этгээд зөрчлийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд хэргийг прокурорт шилжүүлж, МХЕГ холбогдох гэрчийн баримтаар хангана.

Тодорхой тохиолдолд, тухайлбал хорт болон аюултай химийн бодисыг химийн зэвсэг үйлдвэрлэх буюу алан хядах үйл ажиллагаанд ашиглах, хорт болон аюултай бодистой санамсаргүй болон санаатайгаар зүй бусаар харьцсан, үүний улмаас байгаль орчин болон хүний эрүүл мэндэд үлэмж хохирол учирсан зэргийг шууд эрүүгийн гэмт хэрэгт тооцдог байна. Эрүүгийн 2015 оны хуулиар торгууль, ял оноох, батлан даах, хорих арга хэмжээг зохицуулжээ. Хамгийн ноцтой хэрэгт ойн түймэр тавих явдал тооцогдоно. Өмнөх судалгаанаас үзвэл зэрлэг амьтантай холбоотой гэмт хэрэгт ноогдуулах ял шийтгэл аймаг, орон нутагт ялгаатай байгаа боловч мэдээ мэдээлэл дутмаг учир үүнийг магадлан харьцуулах боломжгүй байна.

Агаарын бохирдлын хувьд МХЕГ нь байгаль орчин болон хүний эрүүл мэндэд их хэмжээний хохирол учруулж болзошгүй, ялгаруулалтын стандартыг зөрчсөн суурин эх үүсвэрийн үйл ажиллагааг бүрмөсөн болон түр хугацаагаар зогсоох, ялгаруулалтын стандартыг зөрчсөн, агаарын чанарт сөргөөр нөлөөлж буй хөдөлгөөнт эх үүсвэрийн ашиглалтыг цагдаагийн байгууллагатай хамтран хязгаарлах, ялгаруулалтын стандарт, зөвшөөрөл гэрчилгээний нөхцөлийг удаа дараа зөрчиж байгаа ААН-ийн үйл ажиллагааг зогсоох, зөвшөөрөл олгогч байгууллагад үйлдвэрлэлийн арга ажиллагааг өөрчлөх санал оруулах (30 өдрийн дотор шийдвэрлэх ёстой) зэрэг өргөн цар хүрээтэй эрхтэй байна.


Уул уурхайн салбарын хувьд БОАЖЯ, УУХҮЯ хамтран уул уурхайн зөвшөөрлийг цуцлах эрхтэй, харин УУХҮЯ дангаараа ийм шийдвэр гаргах журам одоогоор байхгүй байна. Жишээ нь БОМТ-г боловсруулаагүй, төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлээгүй, сахин мөрдөж буй тайлан мэдээлэл гаргаагүй нөхцөлд зөвшөөрлийг цуцалж болно.

Аюултай хог хаягдлын хувьд ААН гэрээний нөхцөл, шаардлага, хугацааг зөрчсөн тохиолдолд үйл ажиллагаа явуулах (цуглуулах, тээвэрлэх, хадгалах, боловсруулах, устгах) зөвшөөрлийг гурван сар хүртэл хугацаагаар цуцлах, ААН зөвшөөрөл хүсэхдээ хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, эсвэл зөвшөөрлийг ноцтой зөрчсөн тохиолдолд зөвшөөрлийг бүрмөсөн цуцлах эрхийг БОАЖЯ эдэлнэ.

БОМ-ийн төвийн цахим хуудсанд байгаль орчинтой холбоотой 1,734 гэмт хэрэг, зөрчил, 415 барьцаа, эд хөрөнгө хураасан мэдээллийг оруулсан байна (2009-2016 он). Өмнөх мэдээлэлд гэмт хэрэг, зөрчил гарсан байршил, огноо, төрөл, ангилал, авсан арга хэмжээ, байдал (жишээ нь ял оноох саналын хамт прокурорын байгууллагад шилжүүлсэн) зэргийг оруулсан бол сүүлийн үеийн мэдээлэлд учруулсан хохирол болон хураан авсан эд зүйлсийн талаар нэмсэн байна. Харин хэргийг хэрхэн шийдвэрлэсэн, шийтгэл, ял оноосон талаарх мэдээлэл ороогүй. Эрүүгийн хуулийг 2011-2016 онд зөрчсөн мэдээллийг Зураг 2.5-д харуулсан бөгөөд 2009-2010 оны мэдээлэл бүрэн бус байсан болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын боловсон хүчин, төсөв дутмаг байгаа нь шүүхийн шийдвэрийг зүй ёсоор хэрэгжүүлэхэд ихээхэн бэрхшээл учруулдаг байна.

**Зураг 2.5: Байгаль орчинтой холбоотой гэмт хэрэг, зөрчлийн тоо, 2009-2016 он**



Эх сурвалж: БОМ-ийн Төв, <http://www.eic.mn/envoffence.php>, 2017 оны 8 дугаар сар.

## 2.5 Байгаль орчны хариуцлага, даатгал, нөхөн төлбөр

Байгаль орчны холбоотой хууль бүрт хуулийг зөрчсөн нөхцөл хүлээлгэх хариуцлагын талаар дурьдсан байна. Сүүлийн үеийн хууль тогтоомжид зөрчлийн торгуулийг учруулсан хохирлын хэмжээ, эсвэл сарын цалингийн доод хэмжээг үржүүлсэн байдлаар тусгасан нь зөрчсөн этгээд, тухайлбал хувь хүн, төрийн албан тушаалтан, байгууллагаас шалтгаалан ялгаатай байх бөгөөд зөрчил хүндрэх тусам торгуулийн хэмжээ нэмэгддэг зарчим үйлчилж байна. Хуулиудыг 2012 онд шинэчлэхэд торгууль шийтгэлийн хэмжээг үлэмж нэмэгдүүлсэн байна. Жишээ нь 1995 оны Усны хуулиар хуулийг сахин мөрдөөгүй тохиолдолд захиргааны торгууль 200,000 хүртэл төгрөг байсан бол 2012 оны Усны тухай хуульд 7,020,000 төгрөгийн мөнгөн торгуулиас ус ашиглах зөвшөөрлийг цуцлах хүртэл хатуу шийтгэл ноогдуулахаар заасан байна. Аж үйлдвэрийн зорилгоор ус ашиглах зөвшөөрлийн хувьд усны нөөцийг хэтрүүлэн ашигласан нөхцөлд усны төлбөрийг 50 хувь хүртэл нэмэгдүүлсэн торгууль ноогдуулна.

Тогтсон торгуулиас гадна тодорхой хуулийн дагуу байгаль орчинд учруулсан хохирлыг харгалзан торгууль ноогдуулж болно. БОНУ-ний хувьд түүнийг хийлгээгүй, эсвэл нөхцөл шаардлагыг нь мөрдөөгүй хуулийн этгээдэд мөнгөн нөхөн төлбөр ноогдуулах, харин БОНУ-г буруу хийж байгаль орчинд хохирол учруулвал БОНУ хийх эрх бүхий ААН нөхөн төлбөрийг хариуцана.

Амьтны тухай 2012 онд шинэчилсэн хуульд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг Засгийн газраас тогтоосон экологи, эдийн засгийн үнэлгээнээс нэг дахин илүү байхаар тогтоосон байна. БОАЖЯ-наас ой, зэрлэг амьтан ургамал (ховор амьтны жагсаалтын тухай 248 дугаар журам, Зэрлэг амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ, 2005 онд шинэчилсэн) зэрэг байгалийн тодорхой нөөцийн асуудлаар удирдамж заавар боловсруулсан боловч бүх асуудлыг хамраагүй учир хариуцлага тооцох механизм жигд үйлчлэхгүй байна. Түүнчлэн амьтны эдийн засгийн үнэлгээ, тэднийг хадгалан хамгаалах статус, зах зээлийн үнэлгээний хооронд ихээхэн зөрүүтэй байна (Бүлэг 3).

Торгууль, нөхөн төлбөрийн сацуу хууль тогтоомжиор шагнал урамшууллын асуудлыг тусгасан байна. Мэдээлэл өгсөн иргэнд Ан агнуурын тухай хуулинд хууль зөрчсөн этгээдэд ноогдуулсан торгуулийн 15 хувийг олгох, мөн Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцийг хэрэгжүүлэх тухай 2002 оны хуулиар буруутай этгээдээс хураасан торгууль, хохирлын 20 хүртэл хувийг олгохоор тус тус заасан байна. БОАЖЯ-наас химийн бодис



импортлон, буруу хадгаласны улмаас хөрсөнд шүүрүүлсэн компанийн жишээг тэмдэглэж, БОАЖЯ уг хэргийг шүүхэд шилжүүлж, буруутай компаниас нөхөн төлбөрт 200 сая, торгуульд 200 сая, урамшуулалд 30 сая төгрөг гаргуулахаар шийдвэрлэсэн байна.

Монголд хариуцлагын даатгалын эрх зүйн тогтолцоо байхгүй хэдий ч компаниуд сайн дураар ийм даатгал хийлгэх, хариуцлагын даатгалын үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд бий болжээ.

## 2.6 Сайн дурын урамшууллын арга хэрэгсэл

### *Байгаль орчны менежментийн систем*

Байгаль орчны менежментийн тогтолцооны MNS ISO 14001 стандартыг анх 1998 онд баталжээ. Стандартчилал, хэмжил зүйн газар нь олон улсын стандартчиллын байгууллагын (ISO) гэрчилгээ олгох байгууллагуудыг шалгаруулан эрх олгодог бөгөөд одоогоор хоёр байгууллага ISO 14001 гэрчилгээ олгох эрхтэй байна. Худалдаа, аж үйлдвэрийн үндэсний танхимаас хүнсний 3 компанид MNS ISO 14001 гэрчилгээ олгосон талаар мэдээлсэн, БОАЖЯ-наас нийт 10 гэрчилгээ олгосон хэмээн тэмдэглэсэн байна.

Гэрчилгээтэй байгууллагуудын тоог нэмэгдүүлэхэд байгууллагын бүтэц, чадавхи, зардал (олон улсын зөвлөхүүдийн), гэрчилгээг бүрдүүлэх цаг хугацааны асуудал зэрэг нь ихээхэн бэрхшээл учруулдаг байна.

Засгийн газраас ISO 14001 гэрчилгээтэй байгууллагуудын тоог нэмэгдүүлэх бодлого баримталж байгаа боловч өнөөгийн хүчин чармайлт хангалтгүй байна.

### *Экологийн шошгожуулалт, тэмдэглэгээ*

Экологийн шошгожуулалт, тэмдэглэгээний сонгомол хоёр стандартыг (Байгаль орчны тэмдэглэгээний MNS ISO 14021-2001 болон MNS ISO TR 14025-2001) баталжээ. Байгальд ээлтэй технологи ашигладаг иргэд, эдийн засгийн нэгж байгууллагуудыг урамшуулах тухай Засгийн газрын 1998 оны 95 дугаар тогтоол нь бүтээгдэхүүний аюулгүй үйлдвэрлэлийг дэмжих, экологийн тэмдэглэгээ тогтоох журам баталсан боловч холбогдох хэмжүүр, шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй байна. БОАЖ-ын сайдын 2007 оны 272 тоот тушаалаар “Байгальд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, үйлчилгээ үзүүлэгч иргэд, ААН, байгууллагуудад экологийн тэмдэглэгээний шагнал урамшуулал олгох журам”-ыг батлан, БОАЖЯ-ны дэргэд экологийн тэмдэглэгээний асуудал хариуцсан техникийн хороо байгуулжээ. Тус хороонд иргэний нийгэм болон бусад төлөөллийг оруулсан хэдий ч гишүүнчлэлийн төлбөр урамшуулалгүй учир идэвх сул, нөгөө талаас засгийн газар байнга солигдож байгаагаас үйл ажиллагаа нь идэвхжиж чадахгүй байна. Худалдаа, аж үйлдвэрийн үндэсний танхим баруун Европын арга туршлагыг судлан, Засгийн газрыг гэрчилгээ олгох үйл ажиллагаанд оролцуулахгүй байх, Засгийн газрын тогтоолыг шинэчлэх саналыг БОАЖЯ-нд хүргүүлсэн боловч тухайн үеийн Засгийн газар огцорч шийдвэр гаргаж амжаагүй байна. Стандартчилал, хэмжил зүйн газарт худалдааны зорилгоор экологийн тэмдэглэгээний гэрчилгээ олгох эрх эдлүүлэх нь асуудлыг урагшлуулах гарц байж болох талтай.

Худалдаа, аж үйлдвэрийн үндэсний танхимаас 2000-аас 2017 онд байгууллагууд, тухайлбал хий хангамжийн Юнигаз, цахилгаан тээвэр (троллейбус) компаниуд болон тэдний бүтээгдэхүүн, органик бүтээгдэхүүн (27 гэрчилгээ), ногоон зочид буудалд (14 үзүүлэлтийг үндэслэн 2 зочид буудал, 2 баазад) гэрчилгээ олгох үйл ажиллагааг дангаараа зохион байгуулсан байна. Худалдаа, аж үйлдвэрийн үндэсний танхимийн дэргэдэх Экологийн бүтээгдэхүүний зөвлөл нь өргөдлийг хянан, гэрчилгээ олгох асуудлыг шийдвэрлэж байна.

Органик хүнсний тухай 2006 оны хуулиар зөвхөн баталгаажуулалтын байгууллага органик бүтээгдэхүүний гэрчилгээ олгох эрхтэй болсон тул Худалдаа, аж үйлдвэрийн үндэсний танхим одоогоор хүнсний бүтээгдэхүүний гэрчилгээ олгох эрхгүй байна. Стандартчилал, хэмжил зүйн газар, ХХААХҮЯ-наас МАА, тариалан болон зөгийн аж ахуйн бүтээгдэхүүнд гэрчилгээ олгодог. Стандартчилал, хэмжил зүйн газар, ХХААХҮЯ нь стандарт тогтоодог IFOAM–Organics International олон улсын байгууллагын гишүүн юм.

### *Бизнесийн нийгмийн хариуцлага*

Бизнесийн нийгмийн хариуцлагын MNS ISO 26000-2012 стандартыг баталсан боловч амьдралд төдийлөн хэрэгжихгүй байна. Худалдаа, аж үйлдвэрийн үндэсний танхимын бизнесийн 32 зөвлөлийн нэг нь бизнесийн нийгмийн хариуцлагын асуудлыг хариуцдаг ба түүнд 50-100 компани сайн дурын үндсэн дээр оролцдог. Эдгээрийн дийдэнхийг банкууд, гадаадын томоохон хөрөнгө оруулалттай уул уурхайн компаниуд эзэлж байна. Монголын бизнесийн зөвлөлийн мэдээгээр дотоодын хөрөнгө оруулалттай томоохон компаниуд бизнесийн нийгмийн хариуцлагын мэдээллийг гаргадаг байна.

### *Бусад*

Нөөцийг үр ашигтай зарцуулах, цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар бизнес эрхлэгчдэд хандсан системтэй үйл ажиллагааг Засгийн газраас авч хэрэгжүүлэхгүй байна.

Худалдаа, аж үйлдвэрийн үндэсний танхим, Монголын бизнесийн зөвлөл нь өөрсдийн гишүүдийн шугамаар нөөцийг үр ашигтай ашиглах арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Түүнчлэн Монголын арилжааны банкууд уул уурхай, барилга, үйлдвэрлэл, ХАА зэрэг үндсэн 4 салбарын төсөлд зээл олгохдоо тогтвортой санхүүжилтийн зарчмыг баримтлах болж, энэ зарчмыг нэвтрүүлсэн тайлан мэдээллийг гаргаж байна.

## **2.7 Хууль эрх зүй, бодлого, бүтэц зохион байгуулалтын тогтолцоо**

### *Эрх зүйн тогтолцоо*

Монгол улсын байгаль орчны хуулиудыг 2012 оны 5 дугаар сард цогц байдлаар шинэчлэн (Бүлэг 1), зохицуулалтын болон хууль сахин мөрдөх механизмуудыг тогтоосон боловч хууль тогтоомжийг хэрэгжүүлэх олон журмыг өнөөг болтол бүрэн боловсруулж гаргаагүй байна. Хоёр тодорхой зөрчлийн талаар дээр дурьдсан. БОАЖЯ нь агаар бохирдуулагч гол суурин эх үүсвэрүүдэд агаарын бохирдлын зөвшөөрөл олгодоггүй, Усны тухай 2012 онд шинэчилсэн хуульд хаягдал ус нийлүүлэх зөвшөөрөл олгохоор заасан ч зөвшөөрөл олгох ажил хэвшээгүй, нэмэлт хууль гараагүй учир хаягдал усны төлбөр авах нөхцөл бүрдээгүй байна. Хууль тогтоомж нь үндсэндээ цогц хэлбэртэй, байнга шинэчлэгдэж байгаа нь цаашид удирдлага менежмент болон холбогдох ААН-үүдэд хүндрэл дагуулж болзошгүй юм.

БОНУ-ний тухай 2012 оны хуулийг нэмэлт олон хууль тогтоомжоор баталгаажуулсан байна. Үүнд:

- ЗГ-ын 2013 оны 374 дүгээр тогтоолоор БОНУ, БОСҮ, ХНУ-ний ерөнхий журмыг баталсан;
- Сайдын 2014 оны А-03 тоот тушаалаар БОНУ-ний олон нийтийн оролцооны журмыг баталсан;
- Сайдын 2014 оны А-04 тоот тушаалаар байгаль орчны хамгаалал, нөхөн сэргээлтийн сангийн үйл ажиллагааны журмыг баталсан;
- Сайдын 2014 оны А-05 тоот тушаалаар БОМТ-тэй холбоотой журмыг баталсан;
- Сайдын 2014 оны А-117 тоот тушаалаар БОСҮ, ХНУ, суурь судалгаа, ерөнхий болон нарийвчилсан БОНУ, БОМТ-ний аргачлалын удирдамж, холбогдох бусад журмыг баталсан;
- Сайдын 2013 оны А-126 тоот тушаалаар байгаль орчны аудитын ерөнхий аргачлалыг тус тус баталжээ.

Эрүүл ахуйн тухай 2016 оны хуулиар БОНУ-ний аргачлалыг эрүүл мэндийн салбарт ашиглах, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг нэвтрүүлэх, ерөнхий БОНУ-ний дүгнэлтээр ЭМНУ хийхийг заасан байна.

### *Бодлогын тогтолцоо*

Монгол Улсын 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн 2016 оны үзэл баримтлал зэрэг төрийн олон бодлого, хөтөлбөрт зохицуулалт, хууль сахин мөрдөх механизмуудыг тодорхойлжээ. ТХАХ-нд байгаль орчны тогтвортой байдлын хоёр зарчмыг тогтвортой байдлыг хангахад орон нутгийн ард иргэдийн өргөн оролцоог хангах, байгаль орчны нөхөн сэргээлтийг олон улсын стандартад нийцүүлэн хэрэгжүүлэх, баталгаажуулахаар тогтоосон байна. Байгаль орчны менежментийн тогтолцооны MNS ISO 14001 стандартыг 2021-2025 онд идэвхтэй нэвтрүүлэх, энэ стандартын гэрчилгээ эзэмшигч компаниудын

тоог 5 дахин өсгөх, 2026-2030 онд стандартын гэрчилгээ бүхий компаниудын тоог 10 дахин өсгөх зорилгыг дэвшүүлсэн байна.

Салбар хоорондын зохицуулалтыг бэхжүүлэх, тууштай үйл ажиллагаа явуулах замаар төрийн тогтвортой бодлогын хэрэгжилтийг хангах; хуулийг дээдлэх зарчмыг хатуу баримтлах; захиргааны ил тод байдлыг хангах; шийдвэр гаргах явцын төвлөрлийг багасгаж, оролцогч бүх талуудын оролцоог хангах; төрийн албаны ёс зүйг дээшлүүлэх, авлигыг устгах зэрэг тогтвортой хөгжлийн засаглалын бүх зарчмууд үүнд хамаарна. Үндсэндээ байгаль орчны үнэлгээний механизмыг зохистой ашиглах нь ТХАХ-нд тусгасан тогтвортой хөгжилд хүрэх урьдчилсан нөхцөлийг бүрдүүлнэ хэмээн үзэж болох талтай.

Монгол Улсын 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн алсын харааг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх стандартыг боловсруулах, батламжлах үйл ажиллагааг хангах зорилгоор Үндэсний чанарын хөтөлбөрийг (ЗГ-ын 2016 оны 344 дүгээр тогтоол) 2016 онд баталсан байна.

Ногоон хөгжлийн 2014 оны бодлогын нөөцийн хэмнэлттэй, нүүрстөрөгч багатай үйлдвэрлэл, хэрэглээг дэмжиж, хаягдлыг бууруулах, экологийн тогтолцооны тэнцвэртэй байдлыг хадгалах, байгаль орчны доройтлыг багасгах, нөхөн сэргээх болон байгаль хамгаалах үйл ажиллагааг эрчимжүүлэх стратегийн хоёр зорилго нь зохицуулалтын журам, хууль сахин мөрдөх явдлаас шууд хамаарна. Нэгдүгээр зорилгын хүрээнд олон улсын стандартад нийцсэн байгаль орчны стандарт, хэм хэмжээг нэвтрүүлэх, байгаль орчны үнэлгээний чанар, үр дүнг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадвар, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга хэмжээг авахаар төлөвлөжээ. Бодлогод MNS ISO 14000 стандартыг ААН-үүдэд мөрдүүлэх, үр ашигтай үйлдвэрлэл, хэрэглээний тэргүүн практикийг нэвтрүүлэх, уул уурхай, хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхээс өмнө эрсдлийн үнэлгээ хийх, улмаар байгаль орчин, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ авахыг онцолсон байна.

Ногоон хөгжлийн бодлогыг 2016-2030 онд хэрэгжүүлэх 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2017-2019 онд хууль зүй, байгаль орчны асуудал эрхэлсэн яамдууд улсын төсвийн санхүүжилтийг ашиглан хууль, цагдаа, зохицуулалтын нэгж байгууллага, эрх зүйн судалгааны төвийн байгаль орчинтой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх чадавхийг бэхжүүлэхээр тусгасан байна. Үүнд их хэмжээний хөрөнгө санхүүжилт шаардлагатай болно.

Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтөд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2016 онд баталсан Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт 2003 оны Стандартчиллын тухай хуулийг шинэчлэх, 2016 оны Үндэсний чанарын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ашигт малтмалын зөвшөөрөл олгох журмыг хөнгөвчлөх, уул уурхайн нөхөн сэргээх, уурхай хаах үйл ажиллагааг олон улсын стандартын дагуу гүйцэтгэхээр тусгажээ. Төрийн албан хаагчдын тогтвортой ажил эрхлэлт сүүлийн жилүүдэд хөсөрдөж байгааг харгалзан мөрийн хөтөлбөрт тэдний хариуцлага, мэдлэг чадварыг дээшлүүлэхээр заасан бөгөөд төрийн албаны тогтвортой байдлын тухай хуулийн төслийг боловсруулахаар төлөвлөж байна.

Мөн 2014 оны Төрөөс ашигт малтмалын салбарын талаар баримтлах бодлогод ОУИТБС, Хариуцлагатай уул уурхайн санаачилгыг дэмжих, нийгэм, эдийн засаг, байгаль орчны үнэлгээний журмуудыг боловсронгуй болгох, ялангуяа байгаль хамгаалал, газрын нөхөн сэргээлт, урт хугацааны хяналт шинжилгээг төлөвлөн хариуцлагатай гүйцэтгэх, байгаль орчны эмзэг бүсэд ашигт малтмалын олборлолт, боловсруулалтыг хязгаарлах, хууль журам боловсруулах, том төсөл хэрэгжүүлэхэд олон нийтийн зөвшилцөл, оролцоог хангах, ил тод байдлыг дэлгэрүүлэх эрх зүйн тогтолцоо бүрдүүлэхийг чухалчлан тусгажээ.

#### *Энэхүү бүлэгтэй холбоотой Тогтвортой хөгжлийн зорилт, зорилгууд*

Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх хөтөлбөрийн Зорилт 12.6- хэрэгжилтийн байдлыг Шигтгээ 2.2-т харуулав.

*Бүтэц зохион байгуулалтын тогтолцоо*Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)

БОАЖЯ нь хүрээлэн буй орчин, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бөгөөд зохицуулалт, хууль сахин мөрдөх үйл ажиллагааг хангах механизмууд, тухайлбал байгаль орчны хэд хэдэн үнэлгээ, зөвшөөрөл, гэрчилгээ олгох, менежмент, аудитыг хэрэгжүүлэхэд тэргүүлэх үүрэгтэй. Орон нутгийн түвшинд аймаг, нийслэлийн байгаль орчин, аялал жуулчлалын газрууд үйл ажиллагааны цар хүрээ, онцлогийг харгалзан уг асуудлыг хариуцана. Жишээ нь ерөнхий БОНУ-г БОАЖЯ, эсвэл аймаг, нийслэлийн засаг даргын Тамгын газар (байгаль орчны газар) БОНУ-ний тухай хуулийн хавсралт жагсаалтыг үндэслэн хийдэг, мөн дараа нь санал болгосон төслийн БОМТ-г батлан төслийг эхлүүлэх зөвшөөрөл олгодог байна.



### Шигтгээ 2.2: Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх хөтөлбөрийн Зорилт 12.6

#### Зорилго 12: Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийг хангах

#### Зорилт 12.6: Компаниуд, ялангуяа том болон үндэстэн дамнасан компаниудын тогтвортой үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тэдгээрийн байнгын тайланд нөөцийн үр ашигтай ашиглалтын мэдээллийг тусгахыг дэмжих.

Зорилго 12.6 -ын дэлхий нийтэд хүлээн зөвшөөрсөн шалгуур үзүүлэлт бол тогтвортой хөгжлийн тайлан мэдээлэл гаргадаг компаниудын тоо юм (Шалгуур үзүүлэлт 12.6.1). Монголд тогтвортой хөгжлийн тайлан мэдээллийн стандарт байхгүй, Худалдаа, аж үйлдвэрийн үндэсний танхимын мэдээгээр цөөн тооны компани тогтвортой хөгжлийн тайлан мэдээлэл гаргадаг бол Монголын бизнесийн зөвлөл уул уурхайн нэлээд компаниуд гаргадаг хэмээн үзжээ. Тогтвортой хөгжлийн тайлан мэдээллийг зүй ёсоор бүртгэдэг байгууллага байхгүй байна.

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал нь энэ үзүүлэлтэд хяналт тогтоох гол байгууллагууд юм. Энэ үзүүлэлтийн үндэсний статистикийн мэдээ мэдээллийг дэлхийн хэмжээнд цуглуулах ажил хоцрогдож байгааг анхаарч үзүүлэлтийн тайлан мэдээг гаргах арга хэлбэр, тогтвортой үйлдвэрлэлийн тайлан мэдээллийн тоог үзүүлэлтийг шийдвэрлэхээр ажиллаж байна.

Шалгуур үзүүлэлт 12.6.1 -тэй холбоотой хяналт шинжилгээ, тайлан мэдээ гаргах шаардлагыг хангахад засгийн газраас холбогдох стандарт, статистикийн мэдээ цуглуулах аргачлалыг бизнесийн салбар, бизнес эрхлэгчдийн нийгэмлэгүүдтэй зөвшилцсөний үндсэн дээр тодорхойлох, нэвтрүүлэх хэрэгтэй байна.

Зорилт 12.6 -ын хувьд Монгол Улсын эдийн засаг уул уурхайгаас ихээхэн хамааралтай байгааг харгалзан томоохон, үндэстэн дамнасан компаниудаас тогтвортой үйлдвэрлэлийн чиг баримжаатай байхыг засгийн газраас дэмжих нөхцөл боломж хязгаарлагдмал юм. Тогтвортой үйлдвэрлэлийн мэдээ мэдээллийг компаниудын тайлан илтгэлд тусгахад Засгийн газраас ОУИТБС-тай хамтран ажиллах нь нэн чухал болж байна. БОМ-ийн төв жилийн хэрэгжилтийн тайлан илтгэлийг компани, засгийн газрын цахим хуудсанд байршуулж олон нийтэд ил тод болгох нь тогтвортой үйлдвэрлэлийн тайлан мэдээг сайжруулахад хувь нэмэр оруулах болно.

БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар (Зураг 1.2) байгаль орчны үнэлгээ, аудит, ой, ус, ТХГ, газрын кадастрын асуудлыг хариуцаж, БОНУ-ний Мэргэжлийн зөвлөлийг удирддаг байна. БОНУ-ний Мэргэжлийн зөвлөлд уул уурхай, барилга, хот байгуулалт, ХАА, эрүүл мэнд, зам тээвэр, боловсролын асуудал эрхэлсэн яамдууд, МХЕГ, ШУА, МУИС-ийн хүрээлэнгүүдийн төлөөлөл ордог бол ТББ-ын төлөөлөл байхгүй байна.

БОАЖЯ-ны Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтэс (Зураг 1.2) БОНУ хариуцсан 6, байгаль орчны аудит хариуцсан 1 ажилтантай, тэд дунджаар ажлын 1-4 жилийн туршлагатай. БОАЖЯ нь зарчмын хувьд БОНУ-ний тайлан илтгэлд дүгнэлт хийх гадны мэргэжлийн байгууллагыг хөлсөлж болох боловч шаардлагатай төсөв санхүүжилт байхгүй байна. Зургаан ажилтан нь ажлын цагийн 40 хувийг ерөнхий БОНУ, 50 хувийг нарийвчилсан БОНУ-ний тайлан илтгэл хянах, 10 хувийг бусад ажилд зарцуулдаг, хамтдаа сар тутам 50-60 төслийн ерөнхий БОНУ, 30-40 нарийвчилсан БОНУ-нд дүгнэлт хийж хууль тогтоомжтой нийцэж байгааг нягтлан, Мэргэжлийн зөвлөл шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлж байна. Ажилтнууд БОНУ бүрт дүгнэлт гаргах ажлын маш өндөр ачаалалтай ажилладаг ба яамны боловсон хүчний тогтворгүй байдал ноцтой бэрхшээл учруулдаг байна.

ЦУОШГ-ын харьяа Ус, цаг уур, байгаль орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн бүтцэд БОМ-ийн төв ажиллаж байна.

### Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Шадар сайдын дэргэд байгуулагдсан МХЕГ нь цагдаа, прокурор, шүүх, байгаль хамгаалагчид зэрэг байгууллагуудтай хамтран хянан шалгалт, хууль сахиулах ажлыг бэхжүүлэх үүрэгтэй байдаг. МХЕГ нь салбарын яамдтай сургалт болон бусад чиглэлээр хамтран ажиллана. Байгаль орчны хяналт шалгалтыг анхлан БОАЖЯ хариуцаж байсан бол МХЕГ-ыг 2003 онд байгуулснаар уг үүргийг түүнд шилжүүлжээ. Үүрэг шилжүүлснийг нэг талаас хяналт шалгалтын хараат бус байдлыг нэмэгдүүлсэн, нөгөө талаас бүтээмж буурсан гэсэн санал олны дунд байдаг, яамны ажилтнууд, байцаагч нарын хоорондын ажлын уялдаа холбоо ихээхэн суларсан, МХЕГ нь байгаль орчны хууль сахиулах үйл ажиллагаандаа Байгаль орчин, уур амьсгалын санг ашиглах боломжгүй байна.

МХЕГ-ын хувьд шаардлагатай тоног төхөөрөмж (жишээ нь хөдөлгөөнт хяналтын төхөөрөмж), боловсон хүчин дутмаг байна. Байгаль орчин, уур амьсгалын санд торгууль, хураасан эд хөрөнгөөс төвлөрсөн мөнгийг асуудал хариуцаж байгаа нэгжид хуваарилах нь ажилтны тоог болон шаардлагатай нөөцийг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой гэж үздэг. БОАЖЯ нь сангийн мөнгийг эдийн засгийн үйл ажиллагааны үнэлгээ, мониторинг хийхэд ашиглаж болох юм. Санг шүүхийн гэрчийн баримт цуглуулахад ашиглах нь ял шийтгэл ноогдуулах, улмаар торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх, цаашдаа хуулийг сахин мөрдөхөд эергээр нөлөөлнө.

МХЕГ нь яамдын дотоод аудит, үнэлгээний нэгжийн ажилтнуудад гэрчилгээ олгох үүрэгтэй, зарим тохиолдолд дотоод аудитын тайлан мэдээлэл шаардлага хангахгүй байгаагийн улмаас гэрчилгээг шинэчлэхээс татгалздаг нь түүний хараат бус байдлын илэрхийлэл болж байна.

МХЕГ-ын Байгаль орчин, геологи, уул уурхайн хэлтэс 14 байцаагчтай, түүнээс 7 нь байгаль орчин, аялал жуулчлалын асуудлыг хариуцдаг. Аймаг бүрт 3, сум бүрт 1 байгаль орчны байцаагчтай, тэдгээрийг аймгийн засаг дарга томилж МХЕГ-аас гэрчилгээ олгодог байна. ТХГ-ын 202 байцаагчийг тухайн газрын захиргаанаас томилдог. Нийслэл хотод засаг даргын албанд байгаль орчны 8 байцаагч, 9 дүүрэгт нийт 16 байцаагч ажиллаж байна. Байгаль орчны 26 хууль, 370 стандартын хүрээнд нийт 640 орчим эрх бүхий байцаагч нар байгаль орчин, ой, уул уурхайн асуудлыг хариуцан шийдвэрлэж байна.

Сумын байгаль орчны байцаагч нарын ажлыг төв байгууллагаас ерөнхийд нь удирдаж, аймгийн байцаагч нарыг удирдлагаар хангадаг байна. Сумын байцаагч нарыг шууд хариуцахгүй байгаа нь тогтолцооны доголдол хэмээн МХЕГ дүгнэдэг, нөгөө талаас тэд хараат байдалтай, сумын засаг дарга тэднийг өөрчлөх эрхтэй нь тогтвортой ажиллахад эрсдэл дагуулдаг байна.

Байцаагч нар нь гурваас доошгүй жил ажиллаж туршлага хуримтлуулсан төрийн албан хаагч байж байцаагчийн сургалтад хамрагдана. Сургалтыг цахим, ажлын байран дээр, салбарын яамдад зэрэг олон хэлбэрээр зохион байгуулж байгаа боловч сургалтын нэгдсэн төвгүй байгаа нь ажилд ихээхэн сөрөг үр дагавартай байгааг МХЕГ-аас тэмдэглэж байна.

МХЕГ нь бараа бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах, иргэдийн гомдлыг барагдуулах талаар арга хэмжээ авсны дүнд сүүлийн жилүүдэд байгууллагын нэр хүнд олон нийтийн дунд өсөх хандлагатай байна.

### Бусад байгууллага

УУХҮЯ нь уул уурхайн салбарын бодлогыг боловсруулж АМГТГ-ын үйл ажиллагааг удирдаж байна. Тус яам байгаль орчны бие даасан нэгжгүй, харин нэгж бүрт мэргэжлийн ажилтан, бодлого зохицуулалтын газарт байгаль орчин болон бичил уурхайн асуудлыг хариуцдаг ажилтантай. АМГТГ, БОАЖЯ, Нийгмийн халамжийн яамны төрийн албан хаагч, мэргэжилтэн нараас бүрдсэн, зөвшөөрөл олгох асуудлаар зөвлөмж гаргах тусгай хороо УУХҮЯ-нд ажилладаг байна.

Стандартчилал, хэмжил зүйн газар нь стандартчилал, бүтээгдэхүүн ба үйлчилгээний чанарын гэрчилгээ



олгох, үндэсний хэмжүүрийн стандарт тогтоох, гэрчилгээ болон чанарын сургалт зохион байгуулах, байгаль орчны менежментийн тогтолцоог зохицуулах, ялгаруулалт, хүрээлэн орчны бохирдлын стандарт тогтоох, БОАЖЯ, МХЕГ-ын харьяа байгаль орчны шинжилгээний лабораториудыг баталгаажуулах үүрэгтэй ажилладаг. Баталгаажуулах үүргийг холбогдох салбарын яамдтай хамтран гүйцэтгэнэ.

Монгол Улсын хэрэгжүүлэгч агентлаг Цөмийн энергийн газар нь цацраг идэвхт нөөц ашиглагч нэгжүүдэд зөвшөөрөл олгодог байгууллага юм.

#### Орон нутгийн түвшинд

Аймаг, нийслэл хотын түвшинд байгаль орчин, аялал жуулчлалын газрууд янз бүрийн үүрэгтэй байна. Жишээ нь ашигт малтмалын зөвшөөрөл гаргахад эдгээр байгууллагууд хоорондоо зөвшилцдөг байна. Байгалийн нөөц ашигласан үйл ажиллагааны төлөвлөгөөт аудитын тайланг аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлэх ба аймгийн засаг даргын санаачилгаар төлөвлөгөөт бус аудит гүйцэтгэж болно. Аймгийн захиргаа нь өдөрт 50 м<sup>3</sup> –аас доош усны хэрэглээний зөвшөөрөл олгох явцад оролцоно.

Сумын түвшний үүрэг харьцангуй бага. БОНУ-ний журамд асуудлыг сумын захиргаатай зөвшилцөхөөр тусгасан бөгөөд орон нутгийн түвшинд ой, ан агнуур, загасчлалыг дээд байгууллагаас тогтоосон хэмжээнд зөвшөөрөх, хяналт мониторинг хийх, гэрчилгээ олгох, хаягдал усны асуудлыг шийдвэрлэхэд сумын захиргаа оролцдог байна.

Ашигт малтмалын тухай 2006 оны хуулиар орон нутгийн захиргааны эрх мэдлийг байгаль орчны нөхөн сэргээлт, ажилтан албан хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, зөвшөөрөл эзэмшигчдын төлбөрийг сумын захиргаанд төвлөрүүлэх зэргээр хязгаарласан байна. Хаягдал усны менежментийн тухай 2017 оны хуулиар орон нутгийн зарим байгууллагад хог хаягдлын менежментийн үйл ажиллагаанд хяналт мониторинг хийхээр зохицуулжээ.

#### Лабораториуд

МХЕГ-ын харьяа төв лабораторийн даргыг Шадар сайд томилдог, түүнээс гадна хотын түвшний 2 лаборатори Налайх, Багануурт, аймгийн түвшний 21 лаборатори ажиллаж байна. Улаанбаатар хотын лаборатори нь хотын байгаль орчны газарт харьяалагддаг. Түүнчлэн аймаг бүрт ЦУОШГ-ын харьяа лаборатори, нийслэлд төв лаборатори ажиллаж байна.

Төлөвлөгөөт шинжилгээний зардлыг улсын төсвөөс, гэнэтийн шинжилгээний зардлыг ААН, бизнесийн болон олон нийтийн байгууллагуудаас гаргана. Олон нийтийн гомдлын мөрөөр хийсэн шинжилгээний зардлыг тухайн бизнесийн байгууллага хариуцах үүрэгтэй боловч энэ нь ТББ-аас гаргасан мэдээлэлтэй зөрчилдөж байна. Дотоодын хяналт шинжилгээ хийдэг бизнесийн байгууллагуудын шаардлагатай шинжилгээг төлбөртэйгээр хийдэг.

Бие даасан лаборатори Монголд байхгүй.

## **2.8 Үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж**

### *Үнэлгээ*

Зохицуулах, хууль сахин мөрдөхийг хангах эрх зүйн болон бүтэц зохион байгуулалтын тогтолцоо үндсэндээ бүрдсэн гэж үзэх боломжтой. Эрх зүйн тогтолцоо нь цогц байдалтай боловч түүнд байнга жижиг өөрчлөлт оруулж байгаагаас зарим хүндрэл, бэрхшээл тулгардаг байна. Зохицуулах, хууль сахин мөрдөхийг хангах үйл ажиллагааг зохистой хэрэгжүүлэхэд БОАЖЯ хязгаарлагдмал тооны боловсон хүчинтэй байгаа нь саад бэрхшээл учруулж байна.

Зөвшөөрөл, гэрчилгээ олгох тогтолцоо өргөн хүрээг хамрах хэдий ч агаар бохирдуулагчийн ялгаруулалт, хаягдал ус нийлүүлэх зэрэг асуудалд ихээхэн дутагдал оршсоор байна. БОНУ-ний журмууд өргөн хүрээтэй хэдий ч БОНУ-ний баримт бичгийн чанар болон хэрэгжүүлэх журмын үр дүнтэй хэрэгжилтэд олон нийт шүүмжлэлтэй ханддаг байна. БОСҮ, ХНҮ-ний зэрэгцээ саяхан эрүүл мэндийн нөлөөллийн

үнэлгээ, байгаль орчны аудитыг шинээр нэвтрүүлсэн нь сайшаалтай боловч тэдгээрийг хэрэгжүүлэх туршлага мэдлэг шаардлагатай байна. Компаниуд сайн дурын механизмууд, ялангуяа байгаль орчны менежментийн системийг үйл ажиллагаандаа ашиглах нь тэдгээрийн бизнест төдийгүй байгаль орчин, нийгэмд ач тустай юм.

Байгаль орчны мэдээллийн төв нь олон нийтэд мэдээлэл түгээх чухал механизм бөгөөд байгаль орчныг хамгаалах талаар Засгийн газар, хувийн хэвшлээс авч байгаа арга хэмжээнд олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх хөшүүрэг болно. Гэвч нийтэд хүргээмжтэй мэдээ мэдээлэлд ноцтой дутагдал оршиж байгаагийн зэрэгцээ мэдээллийн цар хүрээ хязгаарлагдмал зэрэг дутагдлаас болж БОМ-ийн төвийн мэдээллийг БОАЖЯ, МХЕГ нь менежментийн зорилгоор ашиглах боломжгүй байна.

*Дүгнэлт, зөвлөмж*

#### Зөвшөөрөл

Зөвшөөрөл, гэрчилгээ олгох хууль тогтоомжийг шинэчлэх явц нь асуудлыг эрхэлж буй байгууллагуудын дотор ил тод байдал, ойлголцол хангалтгүй, тэдний чадавхи хязгаарлагдмал байгаатай холбоотой бэрхшээл бий болгож байна. Хэрэгжүүлэлтийн зарим журам дутуу боловсруулагдсан, эсвэл огт байхгүй байгаа нь зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд бэрхшээл учруулж байна.

#### Зөвлөмж 2.1:

*БОАЖЯ нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Агаарын бохирдол, хаягдал усны зөвшөөрөл олгох хууль тогтоомж болон хэрэгжүүлэх журмыг бүрдүүлэх;*
- (b) *Суурин эх үүсвэрийн агаар бохирдуулах асуудлаар хүлээсэн үүргээ биелүүлэх.*

#### Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний шалгуур үзүүлэлт, үйл ажиллагаа

Монгол Улс БОНУ-ний талаар өргөн мэдлэг туршлага хуримтлуулсан байна. Гэвч БОНУ-г төслийн үйл ажиллагааг сайжруулах, тогтвортой байдал болон бүтээмжийг дээшлүүлэх арга хэрэгсэл гэж бүх байгууллагууд бүрэн ойлгодоггүй, харин захиргааны тээг саад гэж хүлээн авах хандлага байсаар байна. Бодит байдал дээр БОНУ-г ААН-үүд зохистой хэрэгжүүлдэггүй, хяналт сул учир үр дүн муутай, олон нийтийн итгэл сул, ихэнх БОНУ-г хуулбарлах аргаар боловсруулсан, үнэлгээний чанар нь шаардлага хангадаггүй гэсэн нийтлэг ойлголт давамгайлж байна. Нарийвчилсан БОНУ хийх гэрчилгээ бүхий олон байгууллага байгаа боловч тэдгээрийн ажлын чанар, чадвар мэдлэг, туршлага асуудал дагуулсан хэвээр байна. Гэрчилгээ бүхий ААН-үүдийн ажил үүрэг, боловсруулсан БОНУ-ний чанарын асуудлыг хариуцах БОНУ-ний Мэргэжлийн зөвлөл нь бие даасан үйл ажиллагаа явуулах боломжгүй, зөвлөлийн бүрэлдэхүүнд ТББ-уудын төлөөлөл ороогүйн улмаас тэд нарийвчилсан БОНУ боловсруулах гэрчилгээ бүхий ААН-үүдэд хяналт тавих боломжгүй байна. БОАЖЯ-ны ажилтууд нарийвчилсан БОНУ бүрт дүгнэлт гаргахын тулд ажлын өндөр ачаалалтай ажилладаг, ажилтнуудын тогтвортой ажиллах явдал хурцаар тавигдаж байна. Хуулиар Хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээний журмыг гаргасан боловч бодит амьдралд хэрэгжүүлэх нь одоогоор хязгаарлагдмал хэвээр байна.

#### Зөвлөмж 2.2:

*БОАЖЯ нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Нарийвчилсан БОНУ боловсруулах ААН-үүдэд гэрчилгээ олгох шалгуур үзүүлэлт, арга хэлбэрийг шинэчлэх;*
- (b) *Гэрчилгээтэй ААН-үүдэд хөндлөнгийн аудит хийж, ААН-үүдийн чадвар, мэдлэг туршлага, ажлын чанарыг баталгаажуулж, үр дүнг нийтлэх;*
- (c) *Боловсон хүчний нөөцийг нэмэгдүүлэх, гадны мэргэжисэн шинжээчдийг хөлслөх санхүүжилтийг бүрдүүлэх, ерөнхий болон нарийвчилсан БОНУ-ний үе шатны баримт бичгийн чанарын үнэлгээг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх;*
- (d) *БОНУ-ний Мэргэжлийн зөвлөлд ТББ-уудын төлөөллийг оруулах, ил тод болон бие даасан байдлыг нэмэгдүүлэх, БОНУ-ний хөндлөнгийн хараат бус хороод байгуулах боломж, хувилбарыг судлах;*

- (e) Чанартай сайн боловсруулсан БОНУ-ний ач холбогдлыг өсгөх талаар БОНУ боловсруулдаг ААН-тэй ажиллах, ингэснээр төслийн чанар болон олон нийтийн харилцааг сайжруулах;
- (f) Хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээний журмыг нэн идэвхтэй хэрэгжүүлэх.

#### Хил дамнасан асуудлын байгаль орчны нөлөөллийн үнэлгээ

Монгол Улсад хил дамнасан БОНУ хийх эрх зүйн тогтолцоо хараахан бүрдээгүй, мэдлэг туршлага нь 2014 онд энэ сэдвээр зохион байгуулсан сургалтад оролцсоноор хязгаарлагдаж байна. Монгол Улс нь БОНУ-ний механизмыг байгаль орчинд хил дамнасан сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй төслийн талаар хөрш орнуудтай хэлэлцээ хийх арга хэрэгсэл болгон ашиглах туршлагагүй байна.

#### Зөвлөмж 2.3:

*БОАЖЯ нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) Хил дамнасан асуудлын БОНУ-г хийх зорилгоор БОНУ-ний хууль тогтоомжийг шинэчлэх;
- (b) Хил дамнасан БОНУ-ний олон улсын сайн туршилага, үйл ажиллагаанаас суралцах, хил дамнасан асуудлын Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний асуудлаарх конвенцийн хүрээнд мэдээ мэдээлэл ашиглах.

#### Өөр сонгосон газрын нөхөн сэргээлт

БОНУ-ний тогтолцоо боловсронгуй боловч Биологийн олон янз байдлыг дүйцүүлсэн хамгаалах, өөр сонгосон (альтернатив) газарт нөхөн сэргээлтийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар Засгийн газрын ажилтнууд, олон улсын болон орон нутгийн ТББ-ууд, идэвхтэнүүд ихээхэн зөрүүтэй байр суурьтай байна. Биологийн олон янз байдлыг дүйцүүлсэн хамгаалах үйл ажиллагааны талаар ихээхэн зөрчилтэй, мөн орон нутгийн байгууллагууд дүйцүүлэн хамгаалах төслийн хэрэгжилтэд хяналт мониторинг хийх чадавх хязгаарлагдмаг байгаа талаар ТББ-ууд мэдээлж байна. БОАЖЯ биологийн олон янз байдлыг дүйцүүлсэн хамгаалах, өөр сонгосон (альтернатив) газарт нөхөн сэргээлтийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх журам, процедур одоо хүртэл хангалтгүй байгааг хүлээн зөвшөөрч байна.

#### Зөвлөмж 2.4:

*БОАЖЯ нь өөр сонгосон (альтернатив) газрыг нөхөн сэргээх үйл ажиллагааг биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний нэг хэсэг байдлаар үзэж түүнийг хэрэгжүүлэх журам, удирдамжийг боловсруулах, тэдгээрт цаг хугацаа, баталгаажуулах арга хэмжээг тусгах, хуулийн энэхүү заалтууд сөрөг үр дагавар бий болгох эсэхийг тусгаж өгөх.*

#### Байгаль орчны аудит

Байгаль орчны менежментийн тогтолцоонд байгаль орчны аудитын тогтолцоог 2012-2013 онд нэвтрүүлсэн нь чухал арга хэмжээ болсон боловч одоогоор мэдлэг туршлага дутмаг хэвээр байна.

#### Зөвлөмж 2.5:

*БОАЖЯ нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) Байгаль орчны аудит хийх шаардлагыг зөрчсөний хариуцлага тооцох заалтыг хуульд нэмж тусгах;
- (b) Сайн боловсруулсан БОНУ-ний ач холбогдлыг өсгөх талаар БОНУ боловсруулдаг ААН-тэй ажиллах, ингэснээр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, эрсдлийг бууруулах;
- (c) Байгаль орчны аудитын хяналт, дүгнэлт гаргах үйл ажиллагааг МХЕГ-тай зохицуулах.

#### Зохицуулах механизмийн тухай мэдээлэл

ЦУОШГ, Ус, цаг уур, орчны судалгаа, шинжилгээний хүрээлэнгийн харьяа БОМ-ийн төв нь олон нийтэд мэдээлэл түгээх чухал хэрэгсэл хэдий ч гаргаж байгаа мэдээ мэдээлэл бүрэн бус, өөр хоорондоо зөрчилтэй байна. Засгийн газар, сайдын тушаалаар Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны цахим хуудсанд байршуулахаар шийдвэрлэсэн боловч өнөөгийн байдлаар байршуулаагүйгээс олон

нийт тэдгээрт хяналт тавих боломжгүй байна. Мэдээ мэдээллийн өнөөгийн менежмент нь Засгийн газар, олон нийт цуглуулсан мэдээллийг бүрэн хэмжээгээр ашиглахад саад болж байна. Байгаль орчны цогц мэдээ мэдээлэл нь БОАЖЯ-ны байгаль орчныг хамгаалах, хууль тогтоомж, зөвшөөрлийг даган мөрдөх үйл ажиллагааг бэхжүүлэхэд нь бүх талуудад дэмжлэг үзүүлэхэд нь ихээхэн хувь нэмэр оруулна.

Зөвлөмж 2.6:

*БОАЖЯ, ЦУОШГ нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Хоёр байгууллагын хооронд мэдээ мэдээлэл солилцох үйл ажиллагаанд дүгнэлт хийх, мэдээлэл дамжуулах механизм, хугацаа, мэдээлэл бүрэн эсэх болон шинэчлэгдсэн эсэхийг баталгаажуулах, холбогдох бүх зөвшөөрөл, гэрчилгээг хамруулах, дотоод хяналт мониторинг, аудит, бохирдуулагч бодисын ялгаруулалтын нарийвчилсан мэдээллийг бүрэн оруулах, бүх мэдээ мэдээллийг цахим хуудсанд байршуулах;*
- (b) *Хууль тогтоомжийн дагуу БОНУ-ний баримт бичиг цахим хуудсанд байршуулж байгаа эсэхийг баталгаажуулах;*
- (c) *БОАЖЯ Байгаль орчны мэдээллийн төвийн мэдээ мэдээллийг менежмент, бодлогын шинэчлэл хийх зорилгоор ашиглах боломжтой болохын тулд дүрнм журмыг бий болгох.*

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг мэдээллээр хангах

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОҮИТБС) нь зөвшөөрлийг зохистой олгож байгаа талаар гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг төрүүлэх, хариуцлагатай уул уурхайн найдвартай тогтолцоог бүрдүүлэх ил тод байдлын чухал бүтэц бөгөөд үнэт мэдээллийг түгээж байгаа боловч мэдээлэл олгогч байгууллагуудын хувьд нэлээд бэрхшээлтэй, алдаатай ташаа мэдээллээр хангаж байна. Компаниуд тогтвортой үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, ТХЗ-уудын Зорилго 12.6-ын дагуу тогтвортой үйлдвэрлэлийн тухай мэдээллийг өөрсдийн тайлан илтгэлд тусгахад Засгийн газраас ОҮИТБС-тай хамтран ажиллах нь чухал ач холбогдолтой.

Зөвлөмж 2.7:

*БОАЖЯ, УУХҮЯ нь Монголын ОҮИТБС-ыг уул уурхайн нөхөн сэргээлтийн сангийн дансанд төвлөрсөн мөнгө, газрын тосны зөвшөөрөл, ашигт малтмалын зөвшөөрөл олгосон огноо, тусгай зөвшөөрлийг олон удаа шилжүүлэх шалтгаан болон нөхцөл зэрэг мэдээ мэдээллээр нээлттэй, бүрэн хангавал зохино.*

Хуулийн мөрдөлтийг дэмжих, дотоод хяналт, мониторинг

Байгаль орчны менежментийг нэвтрүүлэх үйл ажиллагаанд ахиц дэвшил гарсан хэдий ч цөөн тооны компанид MNS ISO 14001 стандартын гэрчилгээ олгосон байна. Гэрчилгээтэй байгууллагуудын тоог нэмэгдүүлэхэд байгууллагын бүтэц, чадавхи, зардал, гэрчилгээг бүрдүүлэх зэрэгт цаг хугацааны асуудал бэрхшээл учруулдаг. 2030 он хүртэлх ТХЗ-уудын хүрээнд 2021-2025 онд MNS ISO 14001 гэрчилгээ эзэмшигч компаниудын тоог 5 дахин, 2026-2030 онд стандартын гэрчилгээ бүхий компаниудын тоог 10 дахин өсгөх зорилгыг дэвшүүлсэн боловч Засгийн газраас гаргаж байгаа хүчин чармайлт хангалтгүй байна. Нөөцийг үр ашигтай зарцуулах, цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар бизнес эрхлэгчдэд хандсан системтэй үйл ажиллагааг Засгийн газраас авч хэрэгжүүлэхгүй байна. Бизнесийн нийгмийн хариуцлагын MNS ISO 26000-2012 стандартыг баталсан хэдий ч бодит амьдралд хэрэгжих нь ховор байна.

Ерөнхийдөө том, үндэстэн дамнасан компаниудад тогтвортой үйлдвэрлэлийн хандлагыг нэвтрүүлэх, ингэснээр ТХЗ-уудын Зорилго 12.6 –ыг (Компаниуд, ялангуяа том болон үндэстэн дамнасан компаниудыг тогтвортой үйлдвэрлэлийн практикийг хэрэгжүүлэх, тайланд нөөцийн үр ашигтай ашиглалтын мэдээллийг тусгахыг дэмжих) биелүүлэхэд Засгийн газар нэлээд бэрхшээлтэй тулгарч байна.

Дотоод хяналт шинжилгээг хэрэгжүүлж буй байдлыг үзвэл томоохон компаниуд үүрэг бүхий нэгжүүдийг ажиллуулж, тэдний тайлан мэдээлэл чанартай, боловсронгуй байгаа бол жижиг, дунд компаниуд үүргийг биелүүлэхэд хүндрэлтэй байна.

Зөвлөмж 2.8:

Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:

- (a) Мэдээ, мэдээлийг сайжруулах, байгаль орчны менежментийн тогтолцоог боловсронгуй болгоход зөвлөх үйлчилгээ үзүүлэх, бизнесийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх замаар хууль даган мөрдөх байнгын урамицууллын журмыг боловсруулан хэрэгжүүлэх.
- (b) Компаниудын дотоод хяналт мониторингийг хангаж, тайлан мэдээллийг нийтлэх.



## Бүлэг 3

# НОГООН ЭДИЙН ЗАСАГ

### 3.1 Татвар болон тарифын тогтолцоог ногоон болгох нь

#### *Бохирдолын төлбөр*

#### Агаарын бохирдол

Агаарын бохирдолын төлбөр ногдуулах тогтолцоог 2010 онд анх нэвтэрүүлж, 2011 оноос хэрэгжүүлж эхэлжээ. Энэ нь Монгол улсад “бохирдуулагч нь төлөх” зарчмыг анх удаа хэрэгжүүлсэн явдал юм. Агаарын бохирдолын татварыг Засгийн газар зохицуулж, бохирдлын дараах ангилалаар татварын хувь хэмжээг тогтоосон байна:

- Түүхий нүүрс олборлогч компаниуд;
- Органик уусмал үйлдвэрлэгчид болон импортлогчид;
- Утаа ялгаруулагч суурин эх үүсвэрүүд;
- Авто машин болон өөрөө явагч тээврийн хэрэгсэл эзэмшигчид.

Түүхий нүүрс олборлогч компаниуд 1 кг тутамд 1 төгрөг буюу 1 тонн олборлосон нүүрсэнд 1,000 төгрөг төлж байгаа нь тонн тутамд дөнгөж 0.41 ам. доллар төлж байна гэсэн үг юм.<sup>1</sup> Энэ бол нүүрсийг дотооддоо эсвэл гадаадад борлуулсанаас үл хамааран бүтээгдэхүүнд ногдуулж байгаа татвар юм. Харин олборлосон түүхий нүүрсээ боловсруулдаг болон эрчим хүч үйлдвэрлэлийн салбарт ажилладаг компани татвараас чөлөөлөөлөгдөнө. Нүүрс олборлолтын хэмжээ 2010-2016 онуудад тогтворгүй байсан нь олон улсын зах зээл, ялангуяа Хятадын зах зээлийн эрэлт хэрэгцээнээс хамаарсан байна. Татвар ноогдуулсан нүүрсний хэмжээ нь 2015-2016 онуудад тухайн жилд олборлосон нүүрсний бүтээгдэхүүний 50 хувьтай дүйж байсан нь 2012 онд 72.3 хувь байсантай харьцуулбал буурсан байна. Татвар ноогдуулсан нүүрсний нийт хэмжээ нь 2014 онд тухайн жилийн нийт 24.4 сая тонн бүтээгдэхүүнтэй харьцуулахад 26 хувиар их байжээ. Энэ нь өмнөх жилийн дутуу хураагдсан татварыг нэмж тусгасан байх талтай. Онолын хувьд бол, нүүрсний татвар нь хэрэглэгчдэд очиж байгаа нүүрсний үнийг өсгөж, улмаар хэрэглээг багасгаж CO<sub>2</sub> ялгаралыг бууруулах ёстой.

Монголд дотоодын зах зээлд нийлүүлж байгаа нүүрсний дийлэнхийг төрийн өмчит нүүрсний компаниуд олборлож мөн төрийн өмчит цахилгаан, дулааны төрийн өмчит цахилгаан станцуудад нийлүүлж байгаа нүүрсний бүтээгдэхүүн эзэлж байна. Тэдгээр цахилгаан станцуудад нийлүүлж байгаа нүүрсний үнийг нүүрсний чанараас хамааран янз бүрээр тогтоож, Засгийн газар зохицуулж байна. Нүүрсний нэг тонны үнэ 2015 онд 21,060 төгрөгөөс (10.7 ам. доллар) 30,000 төгрөгийн (15.2 ам. доллар) хооронд хэлбэлзэж байжээ. Олборлох үйлвэрлэлийн ил тод байдлын санаачлагын (ОУИТБС) 2015 оны аравдугаар тайлан илтгэлээс харвал, 2015 онд нэг тонн нүүрсний үнэ 13.5 ам.доллар байсан нь нүүрс олборлох өртөгөөс доогуур байсан байна. Нүүрсэнд ногдуулсан татварын хэмжээ нь 2015 онд дотоодын зах зээлийн нүүрсний дундаж үнийн 3.8 хувьтай тэнцэж байжээ. Гэвч, дотоодын нүүрсний хэрэглээнд татаас олгож байгаа нөхцөлд одоогийн татварын хэмжээ нь хэрэглээг бууруулах хөшүүрэг болж чадах эсэх нь эргэлзээтэй байна. Ер нь ногдуулж байгаа татварын цорын ганц зорилго нь улсын төсөвт орлого бүрдүүлэхэд оршиж байж болох талтай. Түүнчлэн, Монголын олборлож байгаа нүүрсний ихээхэн хэсгийг Хятадад экспортолж, экспортын үнэ нь олон улсын зах зээлийн үнийг баримталж байна. Нүүрсний хилийн нэг тонн нүүрсний үнэ 38.5 ам. доллар байгаа нь дотоодын үнээс 25 ам. доллараар өндөр байна. Энэ нь дотоодын нүүрсний үнэд ихээхэн хэмжээний татаас олгодогыг харуулж байна.

Дотоодод үйлдвэрлэж байгаа болон импортлож байгаа (VOCs) ууршимтгай органик нэгдлийн төрлийн

<sup>1</sup> 1 ам. доллар = 2,413 төгрөг (2017 оны 5 сарын дундаж ханш)

органик уусгагчдийн төлбөрийг гурван ангилалаар тухайн бодисын хүний эрүүл мэндэд учруулах хор уршиг болон ажлын байранд бий болох эрсдлийн байдлыг нь харгалзан тогтоож байна. Үүнд:

- I ангилал (бензин г.м) нэг кг нь 30 төгрөг (0.012 доллар), тонн бүрт 12 ам. доллар
- II ангилал (хлорт нэгдлүүд) нэг кг нь 20 төгрөг (0.080 доллар), тонн бүрт 8 ам. доллар
- III ангилал (тротил, спирт) нэг кг нь 10 төгрөг (0.040 доллар), тонн бүрт 4 ам. доллар

Авто машин эзэмшигчдэд агаарын бохирдлын татварыг бензин хөдөлгүүртэй болон дизель хөдөлгүүртэй байдлаар нь ялгаатай ногдуулж байна. Бензин хөдөлгүүртэй авто машины татвар нь тухайн машины  $\text{CO}_2$  ялгаралаас (г\км) хамаарах ба энэ үзүүлэлтийг машины дагалдах баримт бичигт дурдсан байх ба машины техникийн үзлэгээр баталгаажуулна. Дизель хөдөлгүүртэй машины хувьд бол татварын хэмжээ тухайн машины хөдөлгүүрийн хэмжээнээс ( $\text{см}^3$ ) хамаарна. Энэ бол жилийн татвар бөгөөд машины ангилалаас хамаарч 1,800 төгрөгөөс (0.75 доллар) 9,500 төгрөг (3.9 доллар) байна.  $\text{CO}_2$  –ийн ялгаралт 250 г\км эсвэл 2500 $\text{см}^3$  хөдөлгүүртэй машиныг үйлдвэрлэсэний дараахь 4 жилийн хугацаанд татвараас чөлөөлж байна.

Суурин агаар бохирдуулагч (ДЦС, дулааны халаалтын зуухнууд, үйлдвэрүүд г.м) нь жилд 100 тонноос дээш бохирдуулагч эсвэл жилд 5 тонноос дээш аюултай бодис ялгаруулдаг бол утааны татвар төлнө. Агаар бохирдуулагч бодис нь эрүүл мэнд болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хэмжээнээс хамааран дөрвөн ангилалын аль нэгэнд хамрагддаг байна. Ангилал бүрт ноогдуулах татварын хэмжээ ижил байдаг. Татварын хувь хэмжээ нь СО болон гидро-нүүрстөрөгчийн нэг кг тутамд 1 төгрөгөөс эхлээд (0.04 доллар) дээд тал нь бензопирен болон давхар исэл зэрэг органик химийн бодисууд кг тутамд 10 төгрөг (4.1 доллар) байна. Нүүрсээр галладаг цахилгаан станцууд зэрэг суурин объектуудаас гарч байгаа РМ (нарийн ширхэгтэй тоос шороо)-ийн хувьд агаарын бохирдуулагч бодисын татварын жагсаалтад хамруулдаггүй (Хүснэгт 3.1) байна.

**Хүснэгт 3.1: Утаа ялгаруулах эх үүсвэр бүхий гол суурин объектын агаарын бохирдолын татварын хувь хэмжээ**

Бохирдуулагч	төг/кг	\$/тонн
<i>Нэгдүгээр зэрэг</i>		
Бензопирен	10	0.41
Органик химийн бодисууд	10	0.41
Мөнгөн ус, түүний органик бус нэгдлүүд	10	0.41
<i>Хоёрдугаар зэрэг</i>		
Азот хүчил (NOx)	5	0.21
Устөрөгч хүхэр	5	0.21
<i>Гуравдугаар зэрэг</i>		
Хүхрийн хүчил	2	0.08
Зогсоосон хатуу биетүүд	2	0.08
<i>Дөрөвдүгээр зэрэг</i>		
Нүүрсний дутуу исэл (CO)	1	0.04
Нүүрстөрөгч	1	0.04

*Эх сурвалж* : Агаар бохирдолын хураамжийн хувь хэмжээний тухай 2011 оны 3 сарын 3-ны өдрийн Засгийн газрын 92 дугаар тогтоол.

*Тэмдэглэл*: Ханш 1 доллар = 2,413.06 төгрөг (2017 оны 5 сарын дундаж ханш).

Утааг хэмжих болон хяналт тавих хэрэгсэл байхгүйгээс татварыг хэрэгжүүлж эхэлсэн үеэс л бэрхшээлтэй тулгарч ирсэн байна. Утаа ялгаруулагч гол эх үүсвэр болох дулааны цахилгаан станцууд татвар төлөхөөс татгалзаж байсан. Хураасан нийт татвар 2012 онд 25.1 сая төгрөг (18,500 доллар) байсан. Бодит байдал дээр, бохирдолын татварыг 2015 оноос хойш зарим нэг цөөн тохиолдлуудыг эс тооцвол хураагаагүй (Хүснэгт 3.2) байна. Энэ хугацаанд Япон улсын ЖАЙКА байгууллагын тусламжаар нэлээд хэдэн агаар бохирдуулагчийг ( $\text{PM}_{10}$ ,  $\text{PM}_{2.5}$ ,  $\text{SO}_2$ ) хэмжих хэрэгслийг нэг цахилгаан станцид (4 дүгээр дулааны цахилгаан станц) байршуулж, 2017 онд ажиллаж эхэлжээ. Зарчмын хувьд гэвэл, зохих хэмжих төхөөрөмжийг байршуулсан газруудад татвар төлөгдөж эхлэх ёстой. Энэ нь утаа ялгаруулагч гол гол суурин объектуудын хувьд агаар бохирдлын татварыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Дөрвөн ангилал тус бүрийн татварын хувь хэмжээ маш бага байгаа нь агаарын бохирдолын эх үүсвэрийг бууруулахад хөшүүрэг болж чадахааргүй байна. Татварын хувь хэмжээ бага байгаад зогсохгүй 2011 оны түвшингээс 2016 онд 50 хувиар өсөөд байгаа инфляцийг харгалзан ямар нэг өөрчлөлт хийгдээгүй байна. Нийт хураасан агаарын бохирдлын татвар 2011-2016 оны хугацаанд 133.5 тэрбум төгрөг буюу 53.4 сая ам. доллар байна (2016 оны дундаж ханшаар). Түүний 93.5 хувь нь нүүрс олборолтын үйл ажиллагаанаас, 64 хувь нь автомашины агаар бохирдлын татвар бүрдүүлж байна (Хүснэгт 3.2). Агаарын бохирдлын татварын гол зорилго нь улсын төсвийн орлогыг бүрдүүлж, Цэвэр агаар санд орж байсан бөгөөд уг санг 2010 онд байгуулж, 2015 онд татан буулгасан байна.

### Хүснэгт 3.2: Агаарын бохирдлын татварын орлого, 2011-2016, сая төгрөгөөр

	2011	2012	2013	2014	2015	2016
Нүүс олборлолт	19,009.85	22,452.77	23,473.97	30,720.74	12,188.73	17,701.53
Органик хатуу биетүүд		6.69	6.37	10.18	8.28	9.89
Утаа ялгаруулагч гол суурин объектууд	10.27	25.11	9.14	9.59	0.11	0.01
Автомашин	710.43	1,377.07	1,255.34	1,607.88	1,485.54	1,585.61
<b>Нийт</b>	<b>19,730.55</b>	<b>23,861.64</b>	<b>24,744.82</b>	<b>32,348.39</b>	<b>13,682.66</b>	<b>19,297.04</b>
<b>Нийт(\$ сая)</b>	<b>15.59</b>	<b>17.58</b>	<b>16.24</b>	<b>17.75</b>	<b>6.93</b>	<b>8.91</b>

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2017

Тэмдэглэл: Доллараар илэрхийлсэн тоо нь тухайн жилийн дундаж ханшаар тооцоолсон болно.

### Усны бохирдлын хураамж

Усны бохирдлын хураамжийн тухай 2012 онд баталсан хуулиар ус бохирдлын төлбөрийг тогтоож өгчээ. Усны нөөцийг бохир ус хаях замаар бохирдуулах, усны нөөц болон рашаан усны нөөцийг ашиглаж усны найрлага болон чанарт нөлөөлсөн иргэд, аж ахуйн нэгж болон байгууллагууд ус бохирдуулсаны төлбөр төлнө. Хуульд усны таван төрлийн бохирдуулагчийг тогтоож, тэдгээрт ногдуулах татварын хувь хэмжээний доод болон дээд хязгаарыг тодорхойлсон (Хүснэгт 3.3) боловч тэдгээр нь харьцангуй бага байна. Гэхдээ хуулийг хэрэгжүүлэх журмыг хараахан батлан гаргаагүй байна. Үүнд бохир усыг зайлуулах зөвшөөрөл олгох болон гол бүрийн сав газарт тусгайлан тогтоох татварын асуудал хамрагдаж байна. Ус бохирдуулсаны татварыг хэрэгжүүлж эхэлсэний дараа эндээс хуримтлагдсан хөрөнгийг Байгаль, уур амьсгалын санд оруулж, зөвхөн ус хамгаалах арга хэмжээнд зориулах юм байна.

### Хүснэгт 3.3: Ус бохирдуулсаны татварын хэмжээ

Бохирдуулагч бодис	нэгж	төгрөг		\$
		Доод	дээд	дээд
Хориглосон хатуу биет	Кг тутамд	100	500	0.231
Органик бодисууд	Кг тутамд	100	500	0.231
Минералууд	Кг тутамд	50	200	0.092
Хүнд метал	Кг тутамд	1,000	5,000	2.309
Хортой бодисууд	Грамм	1,000	5,000	2.309

Эх сурвалж: 2012 оны Усны бохирдлын төлбөрийн хуулиар тогтоосон татварын хамгийн доод, дээд хэмжээ.

Хөрвүүлгийн хэмжээ: 1 америк доллар = 2,165.4 Төгрөг (2016 оны жилийн дундаж хэмжээ).

### Хөрсний бохирдолт

Хөрс бохирдуулсаны төлбөрийг Монгол улс хараахан тогтоогүй байна.

### Тээврийн салбарын татвар, онцгой албан татвар

Монгол улс бензин болон дизель түлшний болон тусгайлсан татварыг үүнтэй ижил төрлийн түлшүүдэд ногдуулж байна.

Бензин болон дизелийн түлшинд ногдуулах онцгой албан татвар

Газрын тосны олборлолт болон экспорт сүүлийн жилүүдэд өссөөр байна. Гэвч газрын тос боловсруулах үйлдвэр байхгүйгээс Оросын Холбооны улсаас импортлож байгаа шатахуунаас бараг бүрэн хамааралтай байна. Бензин болон дизель түлшний онцгой татварын хувь хэмжээг хилийн үнээс хамаарч тогтоож байна. Энэ нь алслагдсан нутагт амьдарч байгаа иргэдэд онцгой татварыг бусад бүс нутагт амьдарч байгаа иргэдээс хямд үнээр татаастай олгох боломжийг Засгийн газарт олгож байна. Засгийн газар онцгой албан татварыг гол нь олон улсын зах зээл дээр түүхий нефтийн үнэ өсөх үед болон монгол төгрөгийн ханш буурч байгаа үед бензин, дизелийн дотоодын зах зээлийн жижиглэнгийн үнийг тогтвортой байлгахад хөшүүрэг болгон хэрэглэж иржээ. Шатахууны үнэ 2008 онд ихээхэн өсөж ирэх үед Засгийн газар түр хугацаагаар онцгой татварыг зогсоосон байна. Монгол банкнаас 2013 онд Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд шатахуун импортлогч компаниудад 192 тэрбум төгрөгийн (115 сая доллар) хөнгөлттэй зээлийг төгрөгийн ханшийн уналт болон импортын үнийг тэнцвэржүүлэх зорилгоор олгосон байна. Гэвч, төрийн зүгээс үзүүлсэн энэ дэмжлэг нь импортлогчдийн хувьд импортлолсон шатахууны агуулахын хүчин чадалд хөрөнгө оруулахад нь хүрэлцэхгүй хэмжээтэй байсан байна.

Сүхбаатар, Замын-Үүд, Алтанбулагаас бусад боомтоор орж ирж байгаа бензин, дизелийн импортын онцгой татварыг 2014 оноос тэглэсэн байна. Автомашины шатахууны дотоодын жижиглэнгийн үнийн өсөлтийг зогсоох үүднээс 2016 онд хилийн боомтуудад импортын татварыг дахин бууруулах арга хэмжээ авчээ. Нэг тонн бензиний онцгой татвар 2017 оны эхээр дөнгөж 50,000 төгрөг (20.1 доллар); нэг тонн дизелийн түлшний татвар 70,000 төгрөг (28,1 доллар) байв. Энэ нь тэдгээр шатахууний нэг литр тутамд дөнгөж 0.02 долларын татвар ногдуулж байна гэсэн үг юм (Хүснэгт 3.4). Татварыг ийнхүү бууруулсан нь төсвийн орлогод их хэмжээгээр нөлөөлснийг харгалзан, ОУВС-гийн санхүүгийн дэмжлэгийн хөтөлбөрийн хүрээнд Монголын Засгийн газар 2017 оны 5 дугаар сард төсвийн асар их алдагдлыг бууруулахын тулд тэдгээр татварыг бууруулсан хэмжээг төсвийн орлогыг тогтворжуулах үүднээс 2017 оны туршид эргүүлэн тогтоохыг зөвшөөрсөн байна.

**Хүснэгт 3.4: Импортын бензин, дизель шатахууны онцгой албан татвар**

Огноо	төг/тн		төг/литр	
	бензин	дизель	бензин	дизель
2015 -1 сар	400,000	520,000	301.20	438.45
2016-2 сар	260,000	28,000	195.78	23.61
2016-11 сар	160,000	180,000	120.48	151.77
2017 – 1 сар	50,000	70,000	37.65	59.02
		\$/t		\$/l
2015-1 сар	206.96	269.05	0.16	0.23
2017 -1 сар	20.10	28.10	0.02	0.02

Эх сурвалж: Засгийн газрын 2016 оны 109 болон 166 дугаар Тогтоол; ЕЭЗК-ын НБДГ-ын тооцоо.

Тэмдэглэгээ: Сүхбаатар, Замын үүд, Алтанбулагийн хилийн боомтод тогтоосон татвар. Бензины хөрвүүлгийн хэмжээс 1 тонн = 1,328 литр; Дизелийн хөрвүүлгийн хэмжээс 1 тонн = 1,186 литр. Америк долларын утгыг тухайн сарын дундаж хөрвүүлгийн хэмжээсийг ашиглан тооцсон болно.

Бензин болон дизель түлшний татвар

Энэ татвар нь онцгой албан татвараас өөр бөгөөд энэ татвар дээр нэмж бүх төрлийн бензин, дизельд Монголд үйлдвэрлэсэн эсвэл импортлосоноос үл хамааран ногдуулж байгаа юм. Нэг тонн тутамд ногдуулж байгаа татварын хэмжээ нь:

- Бензин (90 хүртлэх октан) : 20.350 төгрөг (8.4 доллар);
- Бензин (90 болон түүнээс дээш октан) : 25.700 төгрөг (10,6 доллар);
- Дизель: 2,140 төгрөг (0.90 доллар).

Хэдийгээр өргөн хэрэглээний үнийн индекс 2016 он хүртлэх хугацаанд гурав дахин өссөн ч 2000

оноос хойш татварын энэ хувь хэмжээ өөрчлөгдөөгүй явж ирсэн байна. Харин онцгой албан татвараас ялгаатай нь дизель түлшинд ногдуулах татварын хэмжээг бензинийхтэй харьцуулахад ихээхэн доогуур (90 орчим хувь) байгаа нь Засгийн газар бараа бүтээгдэхүүний ложистик, тээвэрлэлт зэрэг эдийн засгийн үйл ажиллагаанд татаас олгох эрмэлзэлтэй байгааг харуулж байна. Аль ч тохиолдолд, нэг литр шатахуунд ногдуулж байгаа татварын хувь харьцангуй бага буюу 1 литрт нэг цент байна. Бензин болон дизельд ногдуулж байгаа татвар нь авто машины шатахууны хэрэглээг бууруулахад хөшүүрэг болохоосоо илүү, Засгийн газарт орлогын эх үүсвэр бүрдүүлэх зорилготой байна. Гар дээр байгаа мэдээллээс харахад 2015 онд энэ татварыг огт хураагүй байна.

### Суудлын автомашины импортын онцгой албан татвар

Импортоор оруулж ирж байгаа суудлын автомашины тоо асар их нэмэгдэж байгаа нь хот суурин газрын, ялангуяа Улаанбаатар хотын агаарын бохирдол болон авто замын түгжрэлийн гол эх үүсвэр болж байна. Засгийн газрын зүгээс агаарын бохирдолд шинэ автомашинаас илүү нөлөөлж байгаа хуучин автомашины импортод хяналт тавих хэрэгсэл болгон онцгой албан татвар ногдуулжээ.

Импортын автомашинд ногдуулах онцгой албан татварын хувь нь моторын хүчин чадал ( $\text{см}^3$ ) -ээс хамраан өсөх ба мөн машины насжилтаас хамаарч байна (Хүснэгт 3.5). Импортын тариф нь доллараар тогтоогдсон. Тухайлбал,  $1,500 \text{ см}^3$  болон түүнээс бага хүчин чадалтай машинд ногдох онцгой татвар нь 500 ам. доллар байхад 10 жил болон түүнээс дээш насжилттай машинд ногдох татвар 6,000 ам. доллар байна. Суудлын машинд ногдуулах онцгой татвар 2008 оноос хойш нэлээд нэмэгдсэн. Тухайлбал, 2008 онд 4 жилээс дээш насжилттай суудлын машинд ногдуулах онцгой татвар 2,000 ам. доллар байсан бол 2017 оны татварын гуравны нэг хувьтай тэнцэж байсан.

Хос хөдөлгүүртэй машин, шингэрүүлсэн хий болон цахилгаан хэрэглэдэг машинууд энэ онцгой татвараас чөлөөгдөж байна. Гэхдээ 2017 оны 7 дугаар сараас эдгээр машинд татвар ногдуулах болсон ба татварын хэмжээ нь бусад төрлийн машинд ногдуулж байгаа татварын тэн хагастай тэнцэж байна.

### **Хүснэгт 3.5: Импортын суудлын автомашинд ногдуулж байгаа онцгой татвар, доллараар**

Моторын чадал, $\text{см}^3$	Машины насжилт (жил)			
	0-3	4-6	7-9	10 болон түүнээс дээш
0-1 500	500	1,000	2,000	6,000
1,501-2,500	1,500	2,000	3,000	7,000
2,501-3,500	2,000	2,500	4,000	8,000
3,501-4,500	4,500	5,000	6,500	10,500
Above 4,500	7,000	7,500	9,000	13,000

Эх сурвалж: Гаалийн газар ([www.customsa.gov.mn/en](http://www.customsa.gov.mn/en))

Тэмдэглэл: Насжилтыг үйлдвэрлэсэн жилээс нь тоолно

### Автомашины бүртгэлийн татвар

Автомашины бүртгэлийн татвар нь жилийн зөвшөөрлийн хураамжтай бараг адил хэмжээтэй, үүнийг аймаг болон нийслэл хотын захиргаа хурааж авдаг. Төв Засгийн газар татварын дээд, доод хэмжээг тогтоож, хот, аймгийн засаг захиргаа энэ тогтоосон хүрээнд өөрийн нутагт тогтоодог байна. Татвар 10-аас 25 хувь байдаг ба хот суурин газрын татварын хэмжээ (Улаанбаатар, Дархан Уул аймаг, Орхон аймаг) бусад сумуудтай харьцуулахад өндөр байна. Суудлын машины хувьд суурь татварыг тухайн машины моторын чадал ( $\text{см}^3$ )-ыг харгалзан тогтооно. Хамгийн өндөр хүчин чадалтай ( $3000 \text{ см}^3$ ) машины ангилалд 33 төгрөг/ $\text{см}^3$  байгаа нь жилд 45 орчим ам. долларын хураамж төлнө. Мотоцикл, жижиг болон том оврын автобусны нэг жил хураамжтай. Ачааны машины хувьд даацанд нь тулгуурлан хураамжийн хэмжээг тогтоож байна.



*Байгалийн баялаг нөөц ашигласаны төлбөр (хураамж)*Ашигт малтмал

Монгол улс ашигт малтмалаар баялаг (нүүрс, зэс, алт, төмрийн хүдэр г.м) бөгөөд сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар эдийн засгийн үндсэн гол салбар болж байна. Ашигт малтмалын ордууд төрийн өмч боловч хайгуулын болон ашиглалтын эрхийг ААН-д олгож байна. Ашигт малтмалын зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон ашигт малтмалд нөөц ашигласны төлбөр төлнө. Ашигт малтмалын нөөц ашигласаны төлбөрийн жишиг хувь хэмжээ нь тухайн бүтээгдэхүүнийг дотоодын эсвэл гадаад зах зээлд борлуулсанаас үл хамааран борлуулалтын үнийн 5 хувь байна. Нүүрс, шавар, хайрга, элс зэрэг түгээмэл тархацтай ашигт малтмалын хувьд роялти жишиг нь 2.5 хувь байна. Нэмэлт роялти татварыг 2011 оны 1 дүгээр сарын 1-нээс зэс, алтанд ногдуулж байсан гэнэтийн ашгийн татварын оронд ногдуулж эхэлжээ. Нэмэлт татварыг роялтийн жишиг хувь хэмжээнд 23 ашигт малтмалд нэмж ногдуулах болсон байна. Роялтийн нэмэлт татвар нь зах зээлийн үнийн 0-ээс 5 хувь бөгөөд харин энд зэсийн дээд хэмжээ нь 30 хувь хэмжээ хамрагдахгүй. Нэмэлт татварын хувь хэмжээ нь олон улсын зах зээлийн үнэ болон бүтээгдэхүүний боловсруулалтын түвшингээс хамаарна. Үүний гол зорилго нь ашигт малтмалыг Монголдоо боловсруулах хөшүүрэг болгоход оршино. Ашигт малтмалын тухай 2006 оны хууль, мөн 2014 онд шинэчилсэн хуулиар тусгай зөвшөөрөл эзэмшигч нь (хайгуулын болон ашиглалтын) байгаль орчныг хамгаалах, тухайлбал нөхөн сэргээлтийн тодорхой үүрэг хүлээнэ. Уул уурхайн компани байгаль орчны хувьд хүлээсэн хариуцлагынхаа дагуу байгаль орчныг хамгаалах жилийн төсвийнхээ 50 хувийг тусгай дансанд байршуулна. Байршуулсан хөрөнгийг байгаль орчныг хамгаалахад зарцуулсаны дараа Аж ахуйн орлогын албан татвараас хасаж тооцдог байна.

Газрын тосны тухай хуулийн дагуу, газрын тос болон байгалийн хийн нөөц ашигласаны татварын хэмжээ нь олборлосон түүхий тос болон байгалийн хийн үнэлгээний 5-аас 15 хувийн хооронд хэлбэлзэнэ. Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон Засгийн газар харилцан тохиролцож байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнд татварын хувь хэмжээг тодорхой зааж оруулна.

Ашигт малтмал ашигласаны төлбөр 2015 онд 544.6 тэрбум төгрөгт (275.9 сая ам. доллар) хүрч, Засгийн газрын нийт орлогын 9.4 хувийг бүрдүүлсэн байна.

*Байгалийн бусад баялаг ашигласаны төлбөр*

Байгалийн нөөц баялаг ашигласны төлбөрийн тухай 2012 оны хуулиар ойн нөөц, байгалийн өвс ургамал, амьтад, ус ашигласаны төлбөрийг зохицуулж байна. Төлбөрийн хувь хэмжээг тухайн ашигласан нөөц бүрийн эдийн засаг-экологийн үнэ цэнд тулгуурлан тогтооно. Байгалийн нөөцийн эдийн засаг-экологийн үнэлгээний үзэл баримтлалыг Монгол улсад боловсруулахдаа байгаль орчинд учирсан хохирол болон нөхөн төлбөрийн үнэлгээг хийж тухайн хохирлыг учруулсан иргэд болон хуулийн этгээдээр төлүүлэхээр заажээ. Ерөнхий утгаар нь авч үзвэл, экологи болон эдийн засгийн мөнгөөр илэрхийлэх үнэлгээг ашигласан нөөц баялагын хэмжээ, чанараар тооцох явдал юм. Байгалийн нөөц баялагын үнэлгээ хийх зохих аргачлалыг боловсруулахад шаардлагатай техникийн мэдлэг чадвар гол саад бэрхшээл болж байна. Олон төрлийн мод, өвс ургамал, ан амьтад, усны сав газрууд болон газрын ангилал зэрэгт үнэлгээ хийх аргачлал болон холбогдох мэдээлэл хомс байна. Зах зээлийн үнэ, нөөц ашиглагчид төлбөр төлөх хүсэлтэй эсэх, түүнчлэн захиргааны субъектив төлбөр тогтоох зэрэг янз бүрийн тодорхой бус асуудлууд байсаар байна. НҮБ-РЭДД (UN-REDD) хөтөлбөрийн 2013 оны тайлан илтгэлд дурдсанаар тийм үнэлгээг хийх үндэслэл бага, экосистемийн үйлчилгээний эдийн засгийн мэдээлэл хомс байна.

Мод гуалин болон ойн бусад бүтээгдэхүүн

Ойн бүх нөөц төрийн өмчинд байна. Ойн нийт сан нь тусгай хамгаалалтын болон ашиглалтын гэсэн хоёр ангилалд хуваагддаг. Ойн бүтээгдэхүүн нь нийт ойн сангийн дөнгөж 7 хувийг эзэлж байна. Ойгоос модыг тодорхой гэрээний үндсэн дээр зөвшөөрөл авч арилжааны зорилгоор төлбөр төлж огтолдог. Усны хамгаалалт, экологийн тэнцвэрт байдал зэрэг байгаль орчны асуудлыг харгалзан үзсэний үндсэн дээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас жил бүрийн хэмжээг (квотыг) аймаг бүрт олгодог. Орон нутгийн захиргаа яамнаас тогтоосон квотын түвшинд өөрийн нутаг дэвсгэрийн хэмжээнд огтлох модны

хэмжээг тогтоодог байна. Мод огтлох зөвшөөрлийг орон нутгийн захиргаа тодорхой шалгууруудын үндсэн дээр олгодог боловч ямар нэг тендерээр шалгаруулалт явуулдаггүй байна. Ойгоос огтолсон модны дийлэнхийг дотоодын хэрэгцээнд түлшинд ашиглаж, үлдсэнийг нь барилгад ашиглаж байна. Модыг хууль бусаар огтлох асуудал нэлээд түгээмэл байдаг байна. Гэвч МХЕГ-ын мэдээгээр өндөр торгууль ногдуулах болсонтой холбогдон сүүлийн үед буурч байна.

Гуалин болон түлшний модны суурь үнэ цэнийг Засгийн газар тогтооно. Аймгийн засаг захиргаа модны төрлөөс хамааран төлбөрийн хэмжээг тогтооно. Гэхдээ суурь үнэ цэнийн 6-аас 30 хувийн хооронд тогтооно. Ойн нөөцийн экологи болон эдийн засгийн үнэ цэнийг тодорхойлохын тулд хил хязгаарыг нь тодорхойлсон дөрвөн бүсэд байршил (ашиглалтын бүс, тусгай хамгаалалтын бүс) болон модний төрөл зүйлийг харгалзан хуваасан байна. Дөрвөн бүсийн мод бүрийн төрөл зүйлийн суурь үнэ цэнэ нь харилцан адилгүй (Хүснэгт 3.6). Сибирийн нарс ховордож байгааг харгалзан 2014 оноос эхлэн хураах төлбөрийг нь Сибирийн шинэсээс гурав дахин өндөр тогтоосон. Хэдийгээр эдийн засгийн өртөг зардал болон үнэ өссөн ч 2009 онд хийсэн суурь үнэ цэнэд ямар нэг өөрчлөлт ороогүй явж ирсэн байна. Шинэ үнэлгээг 2017 оны дөрөвдүгээр улиралд хийхээр төлөвлөж байна.

Гуалин болон түлээний модноос 2011 онд 1.95 тэрбум төгрөгийн орлого орсон бол 2016 онд 4.5 тэрбум төгрөгийн (1.8 сая доллар) орлого орсон байна. Орлогыг бүхэлд нь тухайн орон нутгийн төсөвт оруулдаг. Орон нутгийн засаг захиргаа зарчмын хувьд орлогын 85-аас доошгүй хувийг ойн хамгаалалт болон ойжуулах ажилд зарцуулах ёстой боловч энэ зарчмыг хэрэгжүүлж чадахгүй байна.

Гуалин мод болон ойн бусад дагалдах бүтээгдэхүүн ашигласан төлбөр нь гуалинтай адил журмаар зохицуулагддаг байна. Тэдгээр бүтээгдэхүүнийг түүж ашиглах зөвшөөрлийг хоёр жилд нэг удаа олгож байгаа нь тухайн бүтээгдэхүүн сэргэн ургах хугацаа олгоход үндэслэсэн байна. Нийт 6 тэрбум төгрөгийн (2.4 сая доллар) төлбөр 2016 онд хураасан байна. Гуалингийн мод бэлтгэх тухайд, албан ёсны зөвшөөрөлгүй асар их хэмжээгээр бэлтгэж байна. Хушны самрыг экспортод гаргахыг хориглосон байна.

#### Байгалийн ургамал

Хүнсний болон эмийн ургамалыг түүхэд тусгай зөвшөөрөл авна. Төлбөрийн хэмжээг ойн нөөцийн адил журмаар тогтооно. Засгийн газар 55 төрлийн зэрлэг ургамлыг гурван бүлэг болгон тэдгээрт ялгаатай төлбөрийг тогтоосон байна:

- Нэн ховор ургамал: суурь үнэ цэнийн 25-30 хувь,
- Ховор ургамал: суурь үнэ цэнийн 15-20 хувь,
- Түгээмэл ургамал: суурь үнэ цэнийн 5-10 хувь.

2011 онд тогтоосон суурь үнэ цэнэтэй харьцуулахад зарим нэг ургамалын суурь үнэ цэнэ 2015 онд нэлээд нэмэгдсэн (Хүснэгт 3.7) байна. Байгалийн ургамлын ашиглалтаас 2011 онд дөнгөж 30.4 сая төгрөгийн орлого орж байсан бол (0.12 сая ам. доллар) 2016 онд нийт 4.5 тэрбум төгрөгийн (1.8 сая ам. доллар) орлого хуримтлагдсан байна. Тэдгээр орлого тухайн аймагт хуваарилагдаж, орлогын 15-аас доошгүй хувийг зөвхөн ургамал хамгаалах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.

#### **Хүснэгт 3.6: Модны зарим төрөл зүйлийн гуалингийн эдийн засаг-экологийн үнэлгээ**

	1,000 төг/m <sup>3</sup>	\$ /m <sup>3</sup>
Сибирийн нарс ( <i>Pinus sibirica</i> )	89.1 - 336.6	36.9-139.4
Шотланд нарс ( <i>Pinus sylvestris</i> )	66.0 - 255.0	27.3-105.6
Гацуур ( <i>Picea obovata</i> )	81.0 - 306.0	33.6-126.8
Хус ( <i>Betula platyphylla</i> )	30.0 - 120.0	12.4-55.4

Эх сурвалж: 2009 оны Засгийн газрын тогтоол No. 394, Хавсралт 1.

Тэмдэглэл: Тодорхой төрөл зүйлүүд

Хани: \$1 = 2,413.06 төгрөг (2017 оны 5 дугаар сарын дундаж ханш).

## Хүснэгт 3.7: Зарим зэрлэг ургамалыг түүж ашиглах төлбөрийн суурь үнэлгээ, 2011, 2015

Зэрэглэл	төг/кг		\$/кг
	2011	2015	2015
Нэн ховор			
Adonis mongolica Simonovicz	25,000	64,000	26.52
Cistanche deserticola Ma	18,000	65,000	26.94
Juniperus sabina L	50,000	50,000	20.72
Ховор			
Sapshnikovia divaricata	16,000	50,000	20.72
Lactuca undulata	10,000	33,000	13.68
Pteridium aquilinum Kuhn	10,000	53,000	21.96
Түгээмэл			
Senecio vulgaris L	3,600	5,000	2.07
Stelleria chamaejasme	2,500	5,000	2.07
Tanacetum vulgare L	3,300	6,000	2.49

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2017 оны 11 дүгээр сар 20 17

Ханш: 1 доллар = 2413 төгрөг (2017 оны дундаж ханш)

#### Ан агнуур

Зориулалтаас үл хамааран бүх төрлийн (амьжиргаа эсвэл арилжааны зорилгоор ашиглах, эрдэм шинжилгээ болон эмийн зорилгоор, спорт эсвэл ан авын зорилгоор) ан хийхэд зөвшөөрөл авна. Төв Засгийн газраас тогтоосон квотын хэмжээнд орон нутгийн засаг захиргаа жил бүрийн ан агнуурын квотыг тогтооно. Ангийн жуулчлал, ялангуяа сонирхолын ан агнуур улсын секторын орлогын нэг эх үсэвэр болж байна. Төлбөр хураамжийн хувьд тухайн агнах гэж байгаа зэрлэг ан амьтаны төрөл зүйлээс хамаарна.

Шинжлэх ухаан болон соёлын зорилгоор загас барих бол кг тутамд нь төлбөр төлөх ба төлбөрийн хэмжээг орон нутгийн засаг захиргаа 700-1000 төгрөгийн хураамжийг (0.3-0.45 долларын) кг тутамд ногдуулна. Бусад ан амьтан, шувууны хувьд тухайн төрөл зүйлийн эколог-эдийн засгийн үнэлгээний 20-40 хувь байхаар тогтооно. Эзэмших, барих, тэжээх болон үржүүлэх болон амьтаны эд ангийг эмчилгээний зорилгоор ашиглахад борлуулалтын орлогын 10-20 хувийн төлбөр төлнө.

Гадаадын анчдийн хувьд тухайн ан амьтаны төрөл зүйлийн олон улсын зах зээлийн үнийн 80-90 хувийн төлбөр ногдуулна. Бодит үнийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам тогтооно. Амьтадыг амьдаар нь экспортлох тохиолдолд эдийн засаг-экологийн нэг бүрийн үнэлгээний 90-100 хувь төлбөр ногдуулна.

Ан амьтаныг агнасан болон барьж ашигласаны орлого орон нутгийн засаг захиргааны орлого болж, 2010 онд 550 сая төгрөг байсан бол 2016 онд 3.3 тэрбум төгрөг (1.5 сая доллар) болж өссөн байна. Тэдгээр орлогын 50-аас доошгүй хувийг зэрлэг ан амьтаныг хамгаалах арга хэмжээнд зарцуулна. Ойн нөөцийг ашиглаж байгаатай адил ан агнуурын ихээхэн хэсэг нь зөвшөөрөлгүй хийгдэж, тогтоосон квотоос хэтрэх болон улсын хамгаалалтад байдаг ан амьтаныг ч хамардаг байна.

#### Ус ашигласаны хураамж

Ус ашигласаны төлбөрийн гол зорилго нь усны нөөцийн тогтвортой ашиглалтыг хангахад оршино. Монголд ашиглаж байгаа усны дийлэнхи нь газрын доорхи ус байна.

Усны тухай хуульд ус хэрэглэгч ба ус ашиглагч гэж ангилан ядгавартай зааж өгсөн. Хэдийгээр ус хэрхэн хүлээн авч байгаагаас хамаарах боловч ус хэрэглэгчид нь ус ашигласны хураамж төлөхгүй, харин ус тээвэрлэлт болон түгээлтийн үйлчилгээний төлбөр төлнө. Ус хэрэглэгчдийн бүлэгт усыг ашгийн бус зорилгоор ашиглаж байгаа иргэд, аж ахуйн нэгжүүд болон байгууллагууд хамрагдана. Газар тариалан болон мал услах үйл ажиллагаа нь эдийн засгийн үйл ажиллагаа гэдэг нь тодорхой боловч энэ бүлэгт мөн фермерүүд болон малчид багтаж байна. Усыг арилжааны зорилгод ашиглаж байгаа болон үүнээс бусад үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжүүд болон бусад салбарууд төлбөр төлж байна.

Усны хураамжийн хувьд ерөнхийдөө усны нөөцийн эдийн засаг-экологийн суурь үнэ цэнэд тулгуурлах боловч энэ нь 29 усны сав газар бүрт ялгаатай байна. Гадаргын усны суурь үнэ цэнэ нь 1 м<sup>3</sup> ус 800 төгрөгөөс (0.33 доллар) 2,651 төгрөгийн (1.1 доллар) хооронд хэлбэлзэж байгаа бол гүний усны хувьд 1 м<sup>3</sup> нь 1,651 төгрөгөөс (0.68 доллар)-аас 9,440 төгрөгийн (3.9 доллар) хооронд хэлбэлзэж байна. Ийнхүү хэлбэлзэлтэй байгаа нь тухайн усны сав газарт явуулж байгаа эдийн засгийн үйл ажиллагаанаас голлон шалтгаалж байна. Туул голын сав газарт гадаргын болон газрын доорхи усны суурь үнэлгээ хамгийн өндөр байна. Улаанбаатар хотын иргэд, бараг бүх байгууллагууд, гурван дулааны цахилгаан станцыг оролцуулан, Туул голын эхийн экосистемийн усан хангамжаас хамааралтай байдаг учир энэхүү экосистем нь эдийн засгийн асар их үнэ цэнэтэй. Бүх хэрэглэгчдэд усны тоолуур тавих ажлыг дөнгөж 2016 онд дууссан байна.

Ус хэрэглэсний бодит төлбөрийн хувь хэмжээг усны сав газар дахь орон нутгийн захиргаа тогтоох ба ингэхдээ зөвшөөрөгдсөн хэмжээ буюу усны сав газрын үнэ цэнд үндэслэн 2012 оны байгалийн нөөц ашигласаны төлбөрийн тухай хуульд тодорхойлсон ус хэрэглэгч бүлэг бүрт ногдуулна. Туул голын сав газрын хэрэглэгчдэд ногдуулах төлбөр нь эдийн засгийн салбаруудын хооронд ихээхэн ялгаатай байдаг. Хамгийн өндөр төлбөрийг усыг асар их хэрэглэдэг уул уурхайн салбарт ноогдоно. Бусад ус хэрэглэгчдийн хувьд төлбөрийн хэмжээ бага байдаг. Гэхдээ 2010 онд тогтоосон хэмжээтэй харьцуулахад одоо бүх хэрэглэгч бүлгүүд хамаагүй өндөр төлбөр төлж байна (Хүснэгт 3.8). Усан цахилгаан станцууд гадаргын ус хэрэглэсний төлбөрийг тусгай хувь хэмжээгээр (борлуулсан цахилгааны хувь хэмжээгээр) төлдөг байна.

### Хүснэгт 3.8: Туул голын сав газрын газрын доорхи ус хэрэглэсний төлбөр

Ус хэрэглэсэн зориулалт	төг/м <sup>3</sup>		\$mm <sup>3</sup>
	2010	2016	2016
Ундны ус	0	0	0
Мал аж ахуй	0	0	0
Уул уурхай			
Уурхай болон ашигт малтмалын концентрат	150	1,510.4	0.63
Зэсийн концентратын баяжуулах	150	1,321.6	0.55
Хайгуулын өрөмдлөг	100	1,510.4	0.63
Хүнд үйлдвэр	50	188.8	0.08
Хөнгөн үйлдвэр	50	94.4	0.04
Барилгын ажил, барилгын маериалын үйлдвэрлэл	50	188.8	0.08
Архи, ундааны үйлдвэрлэл	50	188.8	0.08
Нарийн боовны үйлдвэрлэл	30	56.6	0.02
Цахилгааны станцууд	30	70.8	0.03
Хөдөө аж ахуй	30	94.4	0.04

Эх сурвалж: 2009 оны Засгийн газрын тогтоол № 351 (хавсралт), 2013 оны ЗГ-ын тогтоол № 302

Ханш: 1 доллар = 2413.06 төгрөг (2017 оны 5 дугаар сарын дундаж ханш)

Ус хэрэглэсний төлбөрөөс орсон орлого 2010<sup>2</sup> онд 4.7 тэрбум төгрөг (3.5 сая доллар) байсан бол 2016 онд 40.9 тэрбум төгрөг (18.9 сая доллар) болж өсчээ. Энэ нь нэг талаас усны хэрэгцээ өссөн, нөгөө талаар усны төлбөр нэмэгдсэний үр дүн юм. Орлогыг орон нутгийн засаг захиргаанд төвлөрүүлж, энэхүү орлогын 35 хувийг усны менежмент болон хамгаалалтад зарцуулахаар заасан боловч энэ заалт хэрэгжихгүй байна.

#### Газрын төлбөр

Иргэд болон хуулийн этгээдүүд, тухайлбал хувийн компаниуд, Төрийн өмчит газрыг эзэмших эсвэл ашиглах тохиолдолд газар ашиглалтын төлбөр төлнө. Газар эзэмших гэдэг нь газрыг өмчлөх гэсэн үг биш бөгөөд ашиглалтын зориулалтаар түр хугацаанд түрээслэнэ гэж ойлгоно. Ашиглалтын төлбөрийн татварын суурь нь тухайн газрын үнэ цэнэ байх ба үүнийг Засгийн газар тогтооно; энэ үнэ цэнэ нь зах зээлийн үнэ цэнийг илэрхийлэхгүй. Засгийн газар төлбөрийн дээд болон доод хязгаарыг тухайн газрын

<sup>2</sup> Америк долларын 2010 оны ханшийг 2010 оны жилийн дундаж ханшаар авав (1 ам.доллар = 1,357.90 төгрөг)

байршил болон нийгэм эдийн засаг болон байгаль орчны нөхцөл байдал зэрэг бусад параметруудийг харгалзан үзэж орон нутгийн засаг захиргаа төлбөрийн эцсийн хувь хэмжээг тогтооно. Малчдийг бэлчээр болон хадлангийн талбайн төлбөрөөс чөлөөлдөг байна.

Хот, тосгон болон бусад суурьшлийн газруудад татварын хэмжээ нь тухайн газрын үнэ цэнийн 0.01-1 хувь байдаг; тусгай хамгаалалтын газар бол 3 хүртэл хувь байдаг. Нийслэл Улаанбаатар хотын хувьд газар үнэлгээний таван бүсэд хуваагдах ба бүс бүр өөрийн үнэлгээтэй. Газрын төлбөрийг тухайн засаг захиргааны нэгжид төлнө. Ерөнхийдөө газрын төлбөр маш бага юм. Хотуудад нэг м<sup>2</sup> газрын төлбөр 44 төгрөгөөс (0.02 доллар) 440 төгрөгийн (0.18 доллар) хооронд хэлбэлзэж байна. Газар ашигласаны төлбөрт 2016 онд 17.5 тэрбум төгрөг (8.1 сая доллар) хураан авсан байна. Орон нутгийн засаг захиргааны хураан авсан газар ашиглалтын төлбөрийн арван таван хувийг иргэд, хуулийн этгээдийн эзэмшээгүй, ашиглаагүй төрийн өмчийн газруудыг хамгаалах, нөхөн сэргээх болон хамгаалалтын бусад арга хэмжээнд зарцуулах ёстой.

#### *Ахуйн үйлчилгээний төлбөрүүд*

##### Хот суурин газрын хог хаягдлын менежментийн төлбөр

Орон нутгийн захиргаа хог хаягдлыг цуглуулах, зайлуулан хаях үйлчилгээг зохион байгуулах үүрэг хүлээдэг. Хотын захиргааны өмчит компаниудаас гадна тендерийн журмаар сонгон авсан хувийн хэвшлийн компаниуд ажиллаж байна. Улаанбаатар хотын хэмжээнд хог хаягдлыг зайлуулах 19 компани ажилладагаас 9 нь хувийн хэвшлийн компани юм. Тэдгээр компаниудын хүлээх үүрэг болон үйлчилгээний төлбөрийг засаг захиргааны доод шатны нэгжүүд, Улаанбаатар хотод есөн дүүрэг, аймагт сумдын хэмжээнд гэрээний дагуу тогтоодог байна.

Тэдгээр засаг захиргааны доод шатны нэгжүүд өрхүүдээс хог хаягдлыг цуглуулан авч зайлуулах үйлчилгээний үнэ хөлсийг тогтооно. Улаанбаатар хотын хувьд, хотын захиргаа тэдгээр төлбөрийг зохицуулж, дараа нь дүүрэг бүр ёс төдий баталдаг байна. Орон сууцанд амьдарч байгаа иргэд 2013 он хүртэл сар бүр 2,000 төгрөг (1 доллар) төлж байсан ба харин Сүхбаатар дүүргийн хувьд өрх бүр сард 2,500 төгрөг төлж байжээ. Гэр хороололын өрх бүрт сард 2,500 төгрөгөөр тогтоосон. Энэ нь орон сууцанд амьдарч байгаа иргэдийн төлөх төлбөрөөс өндөр байгаа нь гэр хороололд хог хаягдлыг цуглуулах ажил харьцангуй бэрхшээлтэй байдагтай холбоотой. Тэдгээр төлбөрийн хэмжээг 2006 онд анх тогтоожээ. Эндээс орох орлого нь наад захын үйлчилгээний өртөгийг төлөхөд хангалтгүй, түүнчлэн тэр бүр нэхэмжлэн авч чаддаггүй байна. Санхүүгийн алдагдлын зарим хэсгийг хотын захиргааны төсвөөс нөхөн олгож байсан ч хог хаягдлыг зайлуулах үйлчилгээний улам бүр доройтсоор байгаа чанарт нөлөөлж чадахгүй байсан байна. Хотын өмчит компаний хог хаягдлыг цуглуулан авч тээвэрлэх машины засвар үйлчилгээг зохих түвшинд хийхэд хөрөнгө санхүүгийн хомсдолтой байжээ.

Нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны боловсруулсан хог хаягдлын төлбөрийн аргачилалыг үндэслэн хотын захиргаа өрхүүдийн хог хаягдлыг цуглуулах, зайлуулах үйлчилгээний төлбөрийг 2013 онд (2013 оны Хотын зөвлөлийн тогтоол №12\45) шинэчилсэн байна. Шинээр тогтоосон төлбөр нь хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх өртөгийг (шатахуун, жолоочийн цалин, машины засвар үйлчилгээг оролцуулан) тухайн дүүргээс хог хаягдлын цэг хүртэл тонн хог тутамд тооцоолсон байна. Өрхийн байршил хогын цэгээс холдох тусам тонн бүрийн төлбөр буурч байна (Хүснэгт 3.9). Хогийн цэгт нэвтрэх хаалга дээр хураамж төлөхгүй, хогийн гурван цэгийн жилийн үйл ажиллагааны зардал 2 тэрбум орчим төгрөгийг (0.83 сая доллар) Улаанбаатар хотын төсөвөөс бүрэн санхүүжүүлж байна.

#### **Хүснэгт 3.9: Улаанбаатар хотын хог хаягдал цуглуулах болон зайлуулах тариф**

Хогийн цэг хүрглэх зай	төг/т	\$/т
1-10 км	3,000	1.24
11-15 км	2,700	1.12
16-20 км	2,300	0.95
20 км-с дээш	1,800	0.75

*Эх сурвалж:* 2013 оны Улаанбаатар хотын зөвлөлийн тогтоол, №. 12\45

*Хани:* 1 доллар = 2413.06 төгрөг (2017 оны 5 дугаар сарын дундаж ханш)



Хог хаягдлын төлбөрийг 2013 оноос өмнө айл бүрээс хураан авч байжээ. Түүнээс хойш төлбөрийг хураах шинэ систем нэвтэрүүлж, хог хаягдлын төлбөрийг сар бүрийн ахуйн үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлд (ус, цахилгаан, дулаан) тусад нь оруулах болсон байна. Орон сууцанд амьдарч байгаа өрхүүдийн хувьд ахуйн үйлчилгээний энэ төлбөрийг 2014 оноос Улаанбаатарын Орон сууц, нийтийн үйлчилгээний компани (ОСНААГ) хурааж, хураасан үйлчилгээний төлбөрт нийт хураасан төлбөрийн 6 хувийг авдаг ажээ. Гэр хорооллын дүүргийн хувьд 2011 оноос цахилгааны төлбөртэй хамт хурааж эхэлсэн байна. Төлбөр хураалтын үйлчилгээний зардалд цахилгаан түгээх компани хураасан төлбөрийн 23 хувийг авдаг нь дэндүү өндөр байгаа юм. Шинээр нэвтэрүүлсэн нэхэмжлэлийн дагуу төлбөрийг хураах систем нь үйлчилгээнд хураах хувийг сайжруулжээ. Өрхүүдийн төлбөрийг хураасан хувь орон сууцны хувьд 2014 онд 81.5 хувь, харин гэр хорооллын өрхүүдийн хувьд дөнгөж 58 хувь байжээ

Хувийн компаниуд болон бусад хуулийн этгээдүүдийн хог хаягдлын үйлчилгээний төлбөрийг тэдгээрийн хооронд шууд байгуулсан гэрээгээр тогтоодог байна. Төлбөрийг эрхэлж байгаа үйл ажиллагааны төрөл болон үйл ажиллагааны цар хүрээ, бусад үзүүлэлтүүдэд тулгуурлан тогтоож, төлбөрийг дүүргийн татварын байгууллагууд хураадаг. Хог хаягдалын үйлчилгээнээс орсон орлогыг сум/дүүргийн төсөвт оруулж, орлогыг зөвхөн хог хаягдлын менежментийн санхүүжилтэд зарцуулдаг. Айл өрхүүд болон хуулийн этгээдүүдээс 2014-2016 онд хураасан хог хаягдлын үйлчилгээний төлбөр 12-13 тэрбум төгрөгийн (5.5-6 сая доллар) хооронд хэлбэлзэж байжээ. Гэхдээ хатуу хог хаягдлын менежментийн жилийн зардал дундажаар 23 тэрбум төгрөг (10.7 сая доллар) байгаа нь өндөр өртөг юм. Бодит орлого болон өртөг зардлын нэг жилийн зөрүү 10 шахам тэрбум төгрөгийг (4.7 сая доллар) Улаанбаатар хотын төсвөөс татаасаар хааж байна. Энэ нь Улаанбаатар хотод хатуу хог хаягдлын менежментийн үйлчилгээний санхүүжилт тогтвортой явагдахад бэрхшээлтэйг харуулж байна.

#### *Усны хангамж ба ариун цэврийн байгууламжийн тариф*

Орон нутгийн захиргааны нэгжүүд усан хангамж болон бохир усыг зайлуулах үйлчилгээг хариуцана. Нийслэл хотод, Улаанбаатарын Ус сувгийг удирдах газар (УСУГ) иргэд, бизнесийн салбар болон бусад хуулийн этгээдүүдэд усан хангамж, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг үзүүлнэ. УСУГ нь Улаанбаатар хотын бүрэн мэдэлд ажиллаж, хотын усан хангамж болон бохир усны дэд бүтцийг хариуцдаг байна. Чадавхи боломжийн хүрэлцээгүй байдлаас улбаалан орон сууцны усан хангамжийн зарим хэсгийг хотын өмчит Улаанбаатарын ОСНААГ-аар гүйцэтгүүлдэг. УСУГ усыг ОСНААГ-т бөөнөөр худалдаж, орон сууцнуудад дамжуулан хүргэх ажлыг ОСНААГ-тай байгуулсан гэрээний дагуу хувийн компаниудын ажиллуулдаг орон сууцны конторууд бие даан хариуцаж, төлбөр хураамжийг хураадаг байна. ОСНААГ хүн амын 70 орчим хувийн усны хангамжийн үйлчилгээг үзүүлж, үлдсэн хэсэгт нь УСУГ үйлчилдэг байна.

УСУГ гэр хорооллын оршин суугчдийн ус хангамжийн үйлчилгээг хариуцна. Оршин суугчдийг 550 гаруй худагаар үйлчилж, худгийн усыг төвлөрсөн ус дамжуулах хоолойгоор эсвэл усны тусгай машинаар зөөж хүргэдэг. Нийт худагны гуравны хоёр нь усны машинаар ус тээвэрлэлтээс хамааралтай байна. Худагуудын 80 гаруй хувийг УСУГ хариуцан үйлчилж, үлдсэн хувийг УСУГ-тай байгуулсан гэрээний үндсэн дээр хувийн салбар хариуцан үйлчилж байна.

Хотын захиргааны үнэ тарифын хороо тариф тогтоох асуудлыг 2011 он хүртэл хариуцаж ирсэн бөгөөд ихэвчлэн нийгэм-улс төрийн талаас нь тогтоож ирсэн нь УСУГ-ыг санхүүгийн хувьд хүндрэлд оруулж, энэ нь өртөг зардлыг тооцохгүйгээр тарифыг доогуур түвшинд тогтоож ирсэнтэй холбоотой байна. Тийм учраас орон сууцанд оршин суугчдийн усны тарифыг 2010 онд өмнөх жилтэй нь харьцуулахад 66 хувиар нэмжээ. Ус болон бохир усны тарифыг 2012 оны 5 дугаар сараас шинээр байгуулагдсан Усны үйлчилгээний зохицуулах комисс хариуцаж, 21 аймаг болон Улаанбаатар хотод ажиллаж байна. Комиссын тогтоосон тарифыг Шудрага өрсөлдөөн болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах газар хянадаг байна. Уг газрыг газрыг Шадар сайд шууд удирдаж байна.

УСУГ-ын Улаанбаатар дахь бүтэц нь оршин суугчдийн болон оршин суугчдийн бус гэсэн ангилалтай. Оршин суугчид нь дотроо 1) орон сууцны, 2) гэр хороололын гэсэн ялгаатай. Айл өрхүүдийн (гэр хороололыг оролцуулахгүй) 70 орчим хувь нь усны тоолууртай байна. 2010 онд 1м<sup>3</sup> ундны ус 286.2 төгрөг (НӨАТ оролцуулахгүйгээр) байсан бол 2017 оны эхнээс 1м<sup>3</sup> ундны усны төлбөр 550 төгрөг (0.26 доллар) болж (Хүснэгт 3.10), 92 центээр нэмэгдсэн байна. Инфляцийн түвшин асар өндөр байсан

(61.7 орчим хувь) үеийг харгалзан үзвэл усан хангамжийн тариф хэрэг дээрээ 2010 оноос хойш 18.8 центээр өссөн байна. Бохирын усыг оролцуулан тооцсоноор 1м<sup>3</sup> усны нийт тариф 2016 онд 452.96 төгрөг байсан бол 2017 онд 920 төгрөг (0.38 доллар) болжээ. Инфляцийг тооцож үзвэл энэ нь хэрэг дээрээ 10.6 хувиар нэмэгдсэн байна.

### Хүснэгт 3.10: Улаанбаатарын усан хангамж, бохир усны тариф

Хэрэглэгчдийн бүлэг	төг/м <sup>3</sup>			\$/м <sup>3</sup>
	Ус хангамж	бохир	нийт	нийт
Айл өрхүүд	550	370	920	0.38
<i>Оршин суугч бус хэрэглэгчид</i>				
Ундааны үйлдвэр	1,500	1,200	2,700	1.12
Ноос, ноолуурын үйлдвэр	1,050	1,700	2,750	1.14
Бусад хуулийн этгээдүүд	1,100	850	1,950	0.81

Эх сурвалж: 2016 оны 11 сарын 11-ний Усны зохицуулах комиссын тогтоол № 94

Тэмдэглэл: НӨАТ оролцоогүй

Хани: 1 доллар = 2,413.06 (2017 оны 5 дугаар сарын дундаж ханш)

### Фото зураг 3: Улаанбаатар хот



Улаанбаатар хотод орон сууцанд амьдарч байгаа нэг иргэний нэг өдрийн усны хэрэглээ ойролцоогоор 170 литр буюу сард 5.1 м<sup>3</sup> байна. Нэг хүний сарын усны төлбөрийн нэхэмжлэг ойролцоогоор 2,805 төгрөг буюу 1.16 доллар байна<sup>3</sup>. Үүн дээр бохир усны төлбөрийг нэмэх юм бол нэг хүн нэг сард 4,692 төгрөг (1.94 доллар) төлнө. 2016 оны байдлаар 4 ам бүлтэй хотын нэг өрхийн сарын усны төлбөр 18,768 төгрөг (7.8 доллар) буюу сарын 1,007 сая төгрөгийн (417 доллар) 1.9 хувьтай тэнцэж байна<sup>4</sup>. Энэ бол дундаж өрхийн хувьд боломжийн төлбөр боловч бага орлоготой өрхийн хувьд бол бэрхшээлтэй байж болох талтай.

<sup>3</sup> 2017 оны 5 сарын дундаж ханшийг ашигласан. US\$1 = 2,413.06 Төгрөг.

<sup>4</sup> УСГ-ын өрхийн орлогын сарын дундаж мэдээг үндэслэв.

Орон сууцанд амьдарч байгаа хэрэглэгчдийн 30 гаруй хувь нь усны тоолуургүй, жишиг тарифаар төлж байгаа нь нэг хүний усан хангамж нэг сард 4,800 төгрөг (2 доллар), бохир усны үйлчилгээнд 3,000 төгрөг (1.25 доллар) юм. Ингээд дөрвөн ам бүлтэй хотын нэг өрхийн сарын усны нэхэмжлэг нь 31,200 төгрөг (13 доллар) байх ба 2016 оны байдлаар дундаж орлоготой өрхийн орлогын 3 хувь болж байна. Ерөнхийдөө усны тоолууртай өрхийн нэг сарын усны төлбөртэй адил болж байна. Усны тоолуургүй өрхийн сарын усны хэрэглээ нь тоолууртай айлын хэрэглээтэй адил байна гэж үзвэл тэдний ундны усны тариф 941.2 төг\м<sup>3</sup> байх юм. Энэ нь тоолууртай өрхийн тарифаас 71.2 хувь илүү байгаа; бохирын үйлчилгээг нэмвэл ялгаа нь 66 хувь болно. Зарчмын хувьд, энэ нь усны тоолуур тавиулах хөшүүрэг болох юм. Гэхдээ, усны тоолуурыг авч тавиулахад гарах өртөг зардлаас хамаарна. Усыг аривлан хэмнэхийн тулд усны тоолуурыг албадан тавих эрх зүйн заалт байхгүй. Олон тооны хуучин орон сууцанд усны тоолуур тавихад бэрхшээлтэй байгаа бөгөөд өртөг зардлыг ихээхэн өсгөх талтай.

Гэр хорооллын хувьд, худагаас 1 м<sup>3</sup> ус авахад 1,000 төгрөг (0.5 доллар) төлнө. Хэдийгээр нийт инфляцийн түвшин ихээхэн өсөж ирсэн ч сүүлийн арваад жилд энэ тарифт ямар нэг өөрчлөлт оруулаагүй байна. Нэг хүний нэг өдрийн усны дундаж хэрэглээ 7-8 литр байгаа нь бага юм. Энэ нь ялангуяа өвлийн улиралд худагнаас ус зөөх нь хүндрэлтэй байдагтай холбоотой. Олонхи хүмүүс усыг жижиг тэргээр зөөдөг бол цөөн хэсэг нь машинаар зөөдөг. Гэр хорооллын хувьд бохирын үйлчилгээ гэж байхгүй; дийлэнхи нь нүхэн жорлонтой. Өдөрт 8 орчим литр ус хэрэглэх тохиолдолд нэг хүний сарын усны нэхэмжлэг 8,000 төгрөг (3.7 доллар) байх юм. Дөрвөн хүн амтай өрхийн хувьд 32,000 төгрөг (15 доллар) болох бөгөөд орлогын доод түвшинд амьдарч байгаа хүмүүсийн хувьд төлөхөд бэрхшээлтэй байдаг байна.

Хувь иргэдийн бус усны үйлчлүүлэгчдийн тарифын бүтэц гурван ангилалтай, тухайлбал, (i) ундааны үйлдвэрүүд; (ii) ноос, ноолуур, арьс ширний үйлдвэрүүд; (iii) бусад бүх хуулийн этгээдүүд. Тэдгээрт бүгдэд нь усны тоолуур байрлуулжээ. Усны тариф нь айл өрхийн усны тарифаас хоёроос гурав дахин өндөр байгаа нь айл өрхийн усны төлбөрт татаас олгодог нь харагдаж байна.

УСУГ өөрийгөө санхүүжүүлэх байгууллага байх ёстой боловч олон жилийн турш санхүүгийн хүндрэлтэй явж ирсэн нь хурааж байгаа төлбөрийн орлого нь үйл ажиллагааны зардлыг ч нөхөж чадахгүй, засвар үйлчилгээний зардлыг хаах бололцоогүй байна. Энэ нь гэр хорооллын усан хангамжийн үйлчилгээ ихээхэн алдагдалтай бөгөөд худагаар ус түгээх нэгж үнэ нь үйл ажиллагааны зардлаас нөхөж чаддаггүйтэй холбоотой ажээ. Тэдгээр нэгж үнэд нь ажиллагсадын цалин; шатахууны үнэ; болон усны машины засвар үйлчилгээ өртөг ордог бололтой. УСУГ-ны тооцоогоор, гэр хорооллын худгуудад ус түгээх нь орон сууцанд түгээх уснаас хэд дахин илүү өртөгтэй байдаг. Алдагдалд хүргэж байгаа өөр нэг шалтгаан нь усны тоолуургүй хуучин орон сууцнууд болж байна. 2015 онд нийт усан хангамжийн 14 хувь ямар нэг орлого оруулаагүй байна. Үүний тодорхой хэсэг нь техникийн алдагдал байгаа ч гэсэн санхүүгийн алдагдлын ихээхэн хэсэг нь усыг тоолуургүй ашиглаж байгаатай холбоотой.

УСУГ-аас нийлүүлсэн усыг цааш түгээх ажлыг эрхэлдэг ОСНААГ-ын конторуудын төлөх ихээхэн хэмжээний төлбөр төлөгдөхгүй удааширч байгаа нь УСУГ-н санхүүгийн байдлыг хүндрүүлэхэд хүргэж байгаа хүчин зүйл болж байна. Конторууд ч гэсэн санхүүгийн эмзэг байдалд ажиллаж байгаа нь усны тариф доогуур, ус ашигласан төлбөрийн барагдуулалт 60-80 хувьтай байгаа, асар их хэмжээний ашиггүй ус хэрэглэдэг, түүнчилэн хэт олон ажиллагсадтай байгаатай холбоотой байна. УСУГ усны тоолууртай орон сууцны төлбөр барагдуулалт өндөр хувьтай байгаа ч гэсэн конторуудын үйл ажиллагаатай холбогдон нийт төлбөр барагдуулах УСУГ-н ажилд сөргөөр нөлөөлж байна.

### Цахилгааны тариф

Ердийн эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах болон түгээх бүх байгууллага төрийн мэдэлд байна. Хуучирсан цахилгаан станцуудын үйл ажиллагаа нь цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үйлчилгээ найдваргүй болоход хүргэж байна. Нүүрсээр галладаг дулааны цахилгааны станцууд (ДЦС) 2016 оны байдлаар нийт цахилгааны 96 хувийг хангаж байна. Үлдэж байгаа 4 хувийг сэргээгдэх эрчим хүчээр, тухайлбал салхи (2.7 хувь), ус (1.5 хувь), нарны (0.005 хувь) сэргээгдэх эрчим хүчээр тус тус хангаж байна. Төвийн эрчим хүчний нэгдсэн систем нийт хэрэглэгчдийн 86 хувийг цахилгаанаар хангадаг ажээ. Эрчим хүчний хэрэглээний 20 орчим хувийг Оросын Холбооны улсаас импортлон авдаг байна. Нэг киловатцаг импортын цахилгааны дундаж үнэ 2005 онд 0.031 доллар байсан бол 2016 онд 0.08 доллар болж өсчээ. Цахилгааны дийлэнхийг (72 хувь) үйлдвэрийн газрууд болон хуулийн бусад этгээдүүд хэрэглэж байгаа бол үлдсэн 28 хувийн хэрэглэгчид нь иргэд (орон сууцны болон гэр хорооллын) эзэлж байна.



Эрчим хүчний Зохицуулалтын хороо (ЭХЗХ) эрчим хүчний үнэ тарифыг тогтоох ажлыг хариуцдаг. Хуульд зааснаар ЭХЗХ нь бие даасан хуулийн этгээд боловч тарифыг тогтоох ажилд нь Засгийн газар оролцдог байна. Цахилгаан хэрэглэгчийн үнэ тарифын бүтэц нь ихээхэн ээдрээтэй. Өрхийн тариф нь хот/бүс нутаг, эрчим хүч хэрэглэж байгаа өдрийн цаг болон нийт хэрэглэж байгаа цахилгааны хэмжээнээс хамаарч байна. Улаанбаатарын эмзэг бүлгийн хэрэглэгчдэд 2015 оноос стандарт тарифын хагас хувьтай тэнцэх хоёр-блок тарифыг тогтоожээ. Цахилгааны тоолуургүй өрхүүдийн хувьд сарын дундаж хэрэглээг нь 350 киловатцагаар тооцон төлбөр ногдуулж байна. Төлбөр барагдуулалт 10 жилийн өмнө 70 орчим хувьтай байдаг байсан бол одоо бараг 100 хувьд хүрээд байгаа ажээ.

Эрчим хүчний тухай 2001 оны хуульд 2011 онд нэмэлт өөрчлөлт оруулж, хэрэглэгчийн тарифыг аажмаар нэмэгдүүлэх замаар 2015 он гэхэд зардлаа нөхөх түвшинд хүргэхийг зорьсон. Хэдийгээр 2011 оноос тариф нэлээд хэмжээгээр нэмэгдэж ирсэн ч үйлдвэрлэл эрхэлдэг хэрэглэгчид дунджаар нэг КВЦ-т 5.3 цент, иргэд 4.9 цент төлж байна. Энэ тариф нь дэлхийн хэмжээнд хамгийн бага тариф болно. Одоогийн энэ тариф нь цахилгаан станцуудын үйл ажиллагаа болон засвар үйлчилгээний зардлын нь нэгээхэн хэсгийг л дөнгөж санхүүжүүлж байна. Өртөг зардлыг нөхөж чадахгүй байгаа энэ тариф нь эрчим хүчний компаниудыг жил бүр ихээхэн алдагдалд оруулж байгаа хэдий ч зардлын алдагдал 2011-2016 онуудад тогтвортой буурч иржээ. Энэ хугацаанд нийт алдагдал 236 сая төгрөгт (105 сая доллар) хүрсэн байна. Цахилгааны бодит үнийг цахилгаан станцуудад олгож байгаа татаас тогтворгүй байдалд оруулж байна. Цахилгаан станцууд төрийн өмчит нүүрсний уурхайнуудаас нүүрсийг олборлолтын зардлаас доогуур үнээр худалдан авч байна. Энэ нь үйлдвэрлэгч компаниудыг санхүүгийн хувьд ямар нэг хэмжээгээр тэнцвэржүүлэх арга хэмжээ болж байна. ЭХЗХ-ны мэдээгээр 2011-2015 онд эрчим хүчний компаниудад 121 тэрбум төгрөгийн (56 сая доллар) татаас олгосон байна. Зохицуулах хорооны хувьд өөр хоорондоо зөрчилдсөн хоёр зорилтыг хэрэгжүүлэх асуудалтай тулгардаг байна, тухайлбал нэг талдаа зардлаа нөхөх тариф тогтоох, нөгөө талдаа үнийн тогтвортой байдлыг хангах болон олон нийгмийн зүгээс үзүүлэх дарамтыг бууруулах явдал юм.

Өргөн уудам газар нутагтай Монгол орны хувьд нар болон салхины эрчим хүчийг ашиглах асар их нөөцтэй. Энэ салбар дахь сонирхол улам бүр өсч байгаа нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгалаас харагдаж байна. Мянганы сорилтын сангийн (МСС) санхүүжилтээр 2013 оны 7 дугаар сард анхны салхин цахилгаан станцыг нээсэн байна. Саяхан, Японы банк (SoftBank) болон ЕСБХБ салхин цахилгаан станц байгуулах ажлыг санхүүжүүлэх замаар сэргээгдэх эрчим хүчний салбарт хөрөнгө оруулсан байна. Сэргээгдэх эрчим хүчний тухай 2007 оны хуулийн сэргээгдэх эрчим хүчний салбарыг хөгжүүлэх тухай заалтын дагуу санхүүгийн хөшүүрэг үзүүлэх зорилгоор 2015 онд хөнгөлттэй тарифийг боловсруулжээ. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бүрт (ус, нар, салхи) тарифийн хязгааруудыг сүлжээний холболт болон бие даасан системтэй байгааг нь харгалзан тогтоосон байна (Хүснэгт 3.11). Гадаадын хөрөнгө оруулагчдийг ханшийн эрсдэлээс хамгаалах үүднээс тарифыг ам. доллараар тогтоож өгсөн. Салхитын салхин цахилгаан станцын хувьд хөнгөлттэй тарифыг 9.5 центээр (229 төгрөг) тогтоосон. Тарифийг ийнхүү доллараар тогтоосон нь улсын төсөвт ихээхэн нэмэлт дарамт болсон нь 2010 онтой харьцуулахад төгрөгийн ханш 2016 онд 37 хувиар буурсантай холбоотой байна. Энэ хөнгөлттэй тариф нь наад зах нь 10 жилийн баталгаатай юм.

**Хүснэгт 3.11: Сэргээгдэх эрчим хүчний тариф, ам.доллар/КВц**

Эх үүсвэр	Тариф
Сүлжээнд холбогдсон	
Салхин	0.080-0.095
Нарны	0.150-0.180
Усан (5,000 КВ хүртэл)	0.045-0.060
Холбогдоогүй	
Салхин	0.100-0.150
Нарны	0.200-0.300
Усан	
< 500 КВ	0.080-0.100
500 КВ – 2,000 КВ	0.050-0.060
> 2,000 КВ	0.045-0.050

Эх сурвалж: Сэргээгдэх эрчим хүчний тухай Монгол улсын хууль.

ЭХЗХ 2015 онд “дэмжих тариф”-г нэвтрүүлсэн бөгөөд энэ нь ердийн эх үүсвэрийн цахилгаан болон

сэргээгдэх эх үүсвэрийн цахилгааны тариф хоорондын зөрүүг санхүүжүүлэх зорилготой. Өөрөөр хэлвэл, дэмжих тариф нь сэргээгдэх эрчим хүчний хэрэглэгчдэд чиглэсэн. Эрчим хүчний 96 хувийг борлуулдаг төвийн бүсэд дэмжих тарифын нэг кВт-н үнэ 2015 оноос 3.95 төгрөг (0.2 цент) болсон. Бусад бүс нутгуудын хувьд (Алтай, Улиастай болон баруун бүсэд) нэг кВт-н дэмжих тариф нь 8.30 төгрөг (0.4 цент) юм. Хэдий чинээ олон сэргээгдэх эрчим хүчний станц сүлжээнд холбогдоно, дэмжих тариф төдийчинээ нэмэгдэхээр тооцоолж байна. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийг хэрэгжүүлэх явцад гарч ирсэн зарим нэг, ялангуяа хөрөнгө оруулагчдийн итгэлтэй холбогдсон асуудлуудыг шийдвэрлэх талаар Засгийн газар нэмэлт арга хэрэгсэлүүдийг боловсруулжээ. Хуулийн 2015 оны нэмэлт өөрчлөлтөд хөнгөлттэй тарифын үргэлжлэх хугацаатай холбогдсон асуудал тодорхой бус байсан. Эрх зүйн баримт бичиг болон эрчим хүч худалдан авах гэрээний үндсэн дээр үнийг урт хугацаанд баталгаатай хадгалах нь сэргээгдэх эрчим хүчинд оруулж байгаа хөрөнгө оруулалтын эрсдлийг бууруулахад тус дэмжлэг болох юм. Гэхдээ сэргээгдэх эрчим хүчтэй холбоо бүхий асуудалд тэргүүлэх ач холбогдох өгөх тухай хууль эрх зүйн орчин хараахан бүрэн бүрэлдээгүй байна.

### Ахуйн үйлчилгээний үнэ тарифийн боломж

Хэдийгээр хүн амын нэлээд хэсэг нь (ҮСХ-ны мэдээгээр 2016 оны байдлаар 29.6 хувь) ядуурлын түвшингөөс доогуур түвшинд амьдарч байгаа ч Монгол улс ядууст чиглэсэн орлогын зорилтот арга хэмжээ авдаг уламжлалгүй орон юм. Хүн амын янз бүрийн ангилалд хамаарах (тухайлбал олон хүүхэдтэй эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадууд, “гавьяатууд” гэх мэт) хүмүүст тэдний орлогыг үл харгалзан тарааж байгаа татаасууд, мөнгөн шилжүүлэгүүд хэрэгжиж байна. Энэ бол өндөр өртөгтэй бодлого бөгөөд ДНБ-ний 8 орчим хувийг эзлэж байна. Нийгмийн халамжийн тухай 2012 оны хуулиар одоогийн мөнгө тараах тогтолцоог нэн ядуу өрхүүдэд онилон хүргэх тогтолцоогоор сольсон байна. Хэдийгээр энэ нь нийгэм- эдийн засгийн хувьд нэн чухал асуудал боловч хэрэгжүүлэх чиглэлээр авах арга хэмжээ удааширалтай байна. Энэхүү схемийг нэвтрүүлэх тухай Засгийн газрын саналаас 2015 онд Парламент татгалзсан байна. Гэсэн хэдий ч орлогыг орлуулан тооцох механизмыг боловсруулж, 2016 оны дунд үеэс хэрэгжүүлж эхлэн зорилтот бүлгийн ядуу хүмүүст хүнсний талон тарааж эхэлжээ. Энэхүү хөтөлбөрийг өргөжүүлэн нийгмийн зорилтот бүлэгт ахуй үйлчилгээний боломжит тариф олгож болох юм. Одоогоор ийм хөтөлбөр хэрэгжээгүй байна. Харин гэр хороололын зорилтот бүлгийн өрхүүдэд, орлогыг орлуулан тооцох үндсэн дээр жилд 140,000 төгрөгийг (58 доллар) нүүрс болон түлээ худалдан авахад нь зориулж олгож байгаа бөгөөд үүн дээр “гавьяатууд” бүхий өрхүүдийг нэмбэл уг тооцоо хоёр дахин өсөхөөр байна.

### **3.2 Татаасын тогтолцоог “ногоон” болгох нь**

Монгол улс байгальд ээлтэй, байгалийн нөөц баялагын ашиглалтын үр ашигийг сайжруулах боломжтой тоног төхөөрөмжид хөрөнгө оруулалт хийж байгаа байгууллагуудыг орлогын албан татвараас чөлөөлөх зэрэг хэлбэрээр татварын хөшүүргийг хэрэглэж байна. Энэ арга хэмжээг 2013 оны Засгийн газрын 303 тоот тогтоолоор баталж, “байгаль орчинд ээлтэй, байгалийн нөөц баялагын ашиглалтын үр дүнг сайжруулах, орчны бохирдол болон хаягдлыг бууруулах тоног төхөөрөмжийн жагсаалтыг” баталсан байна. Уг жагсаалтад ус хэмнэх, эрчим хүч хэмнэх, HCFC-22-ийн хэрэглээг халахад туслах төхөөрөмж, цахилгаан мотор, салхин турбины багаж хэрэгсэлүүд, нарны эрчим хүч үйлдвэрлэгч багаж хэрэгсэлүүд, усан цахилгаан станцын тоног төхөөрөмж зэрэг 41 ангилалын тоног төхөөрөмжийг тодорхойлж өгсөн байна. Зөвхөн 2014 онд 22 байгууллагыг 2.4 тэрбум төгрөгийн (1.3 сая доллар) татвараас чөлөөлсөн байна.

Гаалийн татварын тухай 2008 оны шинэчилсэн хууль, 2015 оны 12 дугаар сард хүчин төгөлдөх болсон 2015 оны НӨАТ-н тухай хуулийн дагуу сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлд ашигладаг сэлбэг хэрэгсэлүүдийг импортын гаалийн татвар болон нэмүү өртөгийн албан татвараас чөлөөлжээ. Ийм арга арга хэмжээг 2013 онд модны импортын хувьд хэрэгжүүлж эхэлсэн нь дотоодын мод бэлтгэлийн хэмжээг бууруулах зорилго агуулсан байна.

Гэр хороололын цахилгаан тоолуур бүхий өрхүүдэд 2017 оны эхнээс шөнийн 9 цагаас өглөөний 6 цагийн хооронд цахилгаан ашиглалтын шөнийн тарифийг тэглэх арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэ татаасыг өвлийн улиралд (1-3 сар) олгох ба энэ нь агаар бохирдуулагч нүүрсээр галлах зуухны оронд цахилгаан халаалтыг ашиглах гол хөшүүрэг болох юм. Энэ хөтөлбөрт 146,000 айл өрх хамрагдаж, нийт 4.8 тэрбум төгрөгийн (2 сая доллар) хөнгөлөлт үзүүлсэн байна.



### 3.3 Байгаль хамгаалах болон ногоон эдийн засагт оруулах хөрөнгө оруулалт

*Байгаль орчны холбогдол бүхий стратеги, хөтөлбөр, төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэх өртөг зардал*

Монгол улсын Засгийн газрын эдийн засгийг ногооруулах бодлогын цөм нь 2008 оны МХЗ-уудад суурилсан 2008-2021 онуудад хэрэгжүүлэх Үндэсний хөгжлийн цогц бодлого (ҮХЦБ) юм. Гол тэргүүлэх чиглэлүүдийн нэг нь экосистемийн тэнцвэрт бус байдлыг зогсоох явдал бөгөөд байгаль орчны асуудлуудаар хэд хэдэн тусгайлсан тодорхой зорилтууд, тухайлбал байгаль орчны доройтол ба бохирдолыг хязгаарлах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Ногоон хөгжлийн бодлого 2014 оны ҮХЦБ-д тусгагдаж; Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөөг 2016 онд баталсан байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2016-2020 болон 2021-2030 онуудад хэрэгжүүлэх өргөн хүрээг хамарсан стратегийн 6 зорилго, 51 тусгай зорилт, 255 арга хэмжээг тодорхойлжээ. Байгаль орчны тогтвортой байдлыг хангах асуудлуудыг хамарсан Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 –ийг Монгол улс 2016 онд баталсан байна. Эдгээр баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх өртөг зардал болон санхүүжилтийн эх үүсвэрийг тусгаагүй байна. Түүнчлэн, тэдгээр зорилтуудыг жил жилийн болон дунд хугацааны улсын төсөв боловсруулах үйл явцтай хэрхэн уялдуулах нь тодорхой биш байна.

Үүнээс гадна ихэнх нь хэрэгжиж эхлээд явж байгаа байгаль орчны холбогдол бүхий үндэсний хэмжээний Усны Үндэсний хөтөлбөр; Хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр болон Биологийн олон янз байдлыг хамгаалах хөтөлбөр зэрэг 17 хөтөлбөр байна. Эдгээр хөтөлбөрүүдийн хувьд ч гэсэн дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх өртөг зардлын тооцоо байхгүй байна. Харин 2013 онд батлагдсан Усны менежментийн төлөвлөгөөний хувьд усны салбарын дэд бүтцийн сэргээлт болон өргөжүүлэх ажилд 2014-2016 онд 2,235 тэрбум төгрөгийн (1 тэрбум доллар), 2017-2021 онд 7,825 тэрбум төгрөгийн (3.6 тэрбум доллар) хөрөнгө оруулалт шаардагдах тооцоог хийсэн байна (Хүснэгт 3.12). Санхүүжилтийн боломжит эх үүсвэрүүдийг тодорхойлсон (улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшил, гадаадын эх үүсвэрүүд) боловч бодит зарлага болон тэдгээрийг хэрхэн санхүүжүүлэх талаар мэдээлэл хомс байна.

#### Хүснэгт 3.12: Усны салбарын дэд бүтцийн хөрөнгө оруулалтын өртөгийн тооцоо, сая төгрөгөөр

Салбар	2014-2016	2017-2021	Нийт
Ундны усны хангамж	1,288,246	2,462,377	3,750,583
Хөдөө аж ахуйн усан хангамж	136,526	423,090	559,616
Аж үйлдвэрийн усан хангамж	614,095	2,277,738	2,891,833
Усны нөөцийг хамгаалах	174,801	373,930	548,731
Усны нөөцийн менежмент	21,220	52,500	73,720
<b>Нийт</b>	<b>2,234,887</b>	<b>5,589,593</b>	<b>7,824,480</b>
<b>Нийт (сая доллар)</b>	<b>1,032.09</b>	<b>2,581.32</b>	<b>3,613.41</b>

*Эх сурвалж:* Монголын усны менежментийн нэгдсэн төлөвлөгөө. Улаанбаатар 2013; Хүснэгт 85.

*Тэмдэглэл:* Долларын дүнг 2016 оны дундас ханшаар тооцсон: 2016: 1 доллар= 2,165.4 төгрөг

Монгол улс Ногоон эдийн засгийн үйл ажиллагааны Түншлэлд (НЭЗҮАТ) 2013 оноос хойш оролцож байгаа бол (Бүлэг 1) Даян дэлхийн Ногоон өсөлт байгууллагын гишүүнээр 2014 оноос ажиллаж байна. Тэдгээр платформууд нь ногоон эдийн засгийн бодлогыг боловсруулах болон ногоон эдийн засгийн тодорхой санаачилгуудыг дэмжихэд чиглэж байна.

#### *Ногоон худалдан авалт*

Одоогийн хууль тогтоомжуудыг сайжруулах замаар төрийн худалдан авалтад олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх талаар 2008 оноос хойш тодорхой хүчин чармайлт гарган ажиллаж иржээ. Үүний илрэл нь сүүлийн жилүүдэд Улсын худалдан авалтын тухай хуульд хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт оруулсан явдал юм. Төрийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах тендерийн баримт бичигт 2017 оны 6 дугаар сарын байдлаар байгаль орчин болон нийгмийн шалгууруудыг (“тогтвортой худалдан авалт”) оруулах эрх зүйн заалт байхгүй байна. Бүтээгдэхүүний үнэ компаниудын саналд үнэлгээ хийх үндсэн шалгуур болж байна.

*Байгаль орчныг хамгаалах улсын салбарын зардал*

Улсын салбарын байгаль орчны зардлын мэдээлэл нь засгийн газрын оролцогч янз бүрийн байгууллагуудад хуваагдан тархсан байна. Засгийн газрын хариуцах үүргийн ангилалд суурилсан нэгдсэн танилцуулга нь байгаль орчныг хамгаалах зардлыг бусад үйл ажиллагааны зардлаас жичид нь ялган оруулах ёстой боловч тийм мэдээлэл байхгүй байна. Байгаль орчныг хамгаалах зардлыг нэгтгэхэд ашигласан аргачилал нь тэр бүр сайн баримжуулагдаагүй байна. Нэгдсэн танилцуулгад байгаль орчны зардлыг байгаль орчны гол асуудлуудаар, ялангуяа агаар, усны бохирдол болон хог хаягдлын менежментийн асуудлаар ялган тооцож оруулаагүй байна. Байгаль орчныг хамгаалах зардлыг хэмжих, тайлагнах олон улсын стандартыг, тухайлбал Байгаль хамгаалах үйл ажиллагаа ба зардлын ангилалыг (БХҮАЗА) Монгол улс хараахан нэвтрүүлээгүй байна.

Байгаа мэдээлэл болон ЕЭЗК-ын Нарийн бичгийн дарга нарын газрын зарим нэг тооцоогоор улсын салбарт (төв болон орон нутгийн засаг захиргаа) байгаль хамгаалах зардал 2011 онд засгийн газрын нийт зардлын 2.9 хувь байсан бол 2016 онд дөнгөж 0.7 хувь болж буурсан байна. Энэ хугацаанд, байгаль хамгаалах зардал 2011 онд ДНБ-ний 1.1 хувийг эзлэж байснаа 2016 онд 0.3 хувь болж буурсан байна. Энэ тооцоонд хаягдал усны дэд бүтцэд зарцуулж байгаа Засгийн газрын зардлыг оролцуулаагүй бөгөөд зөвхөн 2015 оны тооцоо бидэнд байгаа юм. Хэрэв энэ зардлыг оролцуулан тооцвол, Засгийн газрын 2015 оны нийт зардлын 1.7 хувь буюу ДНБ-ний 0.6 хувийг байгаль орчныг хамгаалах ажилд зарцуулсан байна. Ерөнхийд нь авч үзвэл, сүүлийн жилүүдэд байгаль орчны зардал буурч байгаа нь эдийн засгийн ноцтой хямрал Засгийн газрын санхүүжилтэд сөрөг үр дагавар авчирч, төсвийн алдагдал өссөөр байгаатай холбоотой бөгөөд төсвийн нэгдсэн хатуу арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байна.

*Засгийн газрын (төв) төсөв*Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төсөв

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төсөв 2011 онд засгийн газрын нийт зардлын 1.9 хувь байсан бол 2016 онд 0.6 хувь болж буурчээ. Төсвийн тогтворжуулалтын арга хэмжээ хэрэгжүүлж байгаа нөхцөлд 2017 онд төсвийн хуваарилалт буурах энэ хандлага үргэлжлэхээр байгаа бөгөөд энэ нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дотоод үйл ажиллагаанд мөн нөлөөлнө (Хүснэгт 3.13).

**Хүснэгт 3.13: Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төсөв, 2011-2017, тэрбум төгрөгөөр**

Зүйл анги	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Урсгал зардал	63.1	70.7	71.8	66.1	52.5	44.3	48.2
Хөрөнгийн зардал	31.0	21.3	4.4	9.3	1.3	1.0	0.8
<b>Нийт</b>	<b>94.1</b>	<b>92.0</b>	<b>76.2</b>	<b>75.4</b>	<b>53.8</b>	<b>45.3</b>	<b>49.0</b>
<b>Нийт (\$)</b>	<b>74.36</b>	<b>67.77</b>	<b>50.00</b>	<b>41.37</b>	<b>27.25</b>	<b>20.92</b>	<b>22.63</b>
<b>Засгийн газрын нийт зардалд эзлэх хувь</b>	<b>1.88</b>	<b>1.42</b>	<b>0.99</b>	<b>0.87</b>	<b>0.69</b>	<b>0.47</b>	<b>0.50</b>

*Эх сурвалж:* Байгаль орчин аялал жуулчлалын яам болон ЕСЕ-ийн тооцоо

*Тэмдэглэл:* 2017 оны төсөв батлагдсан жилийн дундаж ханшаар долларыг тооцоосон

*Байгаль орчны сангууд*Байгаль орчин, уур амьсгалын сан

Байгаль орчин, уур амьсгалын санг (БОУАС) 1998 онд байгуулсан боловч 2012 он хүртэл Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төсөвт хамрагдаж байсан. Уг сан 2012 онд яамны харьяалалд багтах, ажиллах хүчинтэй, санхүүгийн нөөцтэй, өөрийн дүрэм, журамтай бие даасан нэгж болж “Байгаль орчин, уур амьсгалын сан” нэртэй болсон байна. Сан үндсэн таван ажиллагсадтай. Төслүүдийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын удирдсан Сангийн ТҮЗ хэлэлцэж баталдаг. ТҮЗ бусад яамдын (СЯ, ХХААХҮЯ зэрэг) төлөөлөл орсон арван нэгэн гишүүнтэй. Засгийн газрын Тусгай сангийн тухай хуулиар сангийн эрх үүрэг, санхүүгийн эх үүсвэрийг зохицуулна. Одоогийн байдлаар тус санг улсын төсөв болон тусгай хамгаалалтай газруудад олгож байгаа зөвшөөрлийн хураамжаар санхүүжүүлж

байна. Мөн 2012 оны Байгалийн нөөц ашигласаны хураамжийн тухай хуульд заасны дагуу байгалийн баялагын нөөц (ой, ургамал, амьтан, ус) ашигласны хураамжаар санхүүжихаар заасан боловч одоогоор хэрэгжихгүй байна.

Байгаль орчныг хамгаалахтай холбогдсон янз бүрийн үндэсний төсөл хөтөлбөрүүдийг сангаас санхүүжүүлж байна. Санхүүгийн боломж одоогоор хязгаарлагдмал байгаа нь төсвийн тогтворжуулалтын бодлогын үр дагавар юм. 2016 онд, байгаль орчны үндэсний хөтөлбөрүүдийг дэмжихэд 1.2 тэрбум төгрөг зарцуулсан нь Засгийн газрын нийт зарлагын 0.01 хувьтай тэнцэж байна (Хүснэгт 3.14). 2014-2016 онд нийт хөрөнгийн 40.8 хувийг байгаль орчны боловсролд, 31.1 хувийг үндэсний усны хөтөлбөрт зарцуулсан байна

### Хүснэгт 3.14: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сангаас үндэсний хөтөлбөрүүдийг санхүүжүүлж ирсэн байдал, 2014-2016, сая төгрөгөөр

Үндэсний хөтөлбөр	2014	2015	2016	%
Ус	406.82	225.34	445.11	31.13
Хог хаягдлын менежмент	101.17	29.69	30.00	4.65
Тусгай хамгаалалтын газрууд	35.42	31.70	24.60	2.65
Байгалийн өвс ургамлын хамгаалалт	62.43		9.00	2.06
Ховор болон устах аюулд орсон амьтан\ ургамалын зүйл	247.12	48.86	145.14	12.75
Цөлжилтгүй тэмцэх	77.20	97.60	30.00	5.92
Экологийн боловсрол	552.46	371.61	489.68	40.85
<b>Нийт</b>	<b>1,482.62</b>	<b>804.79</b>	<b>1173.52</b>	<b>100.00</b>
<b>Нийт (\$ сая)</b>	<b>0.81</b>	<b>0.41</b>	<b>0.54</b>	
<b>Улсын төсвийн нийт зарлагад эзлэх хувь</b>	<b>0.02</b>	<b>0.01</b>	<b>0.01</b>	

Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын сан, 2017.

Тэмдэглэл: Тухайн жилийн дундаж ханшаар долларыг тооцон гаргасан.

### Цэвэр агаарын сан

Засгийн газрын тусгай сангийн нэг болох Цэвэр агаарын санг (ЦАС) агаарын бохирдолыг бууруулах арга хэмжээнүүдийг санхүүжүүлэх зорилгоор 2010 онд байгуулсан байна. Агаарын бохирдлын төлбөрөөс орсон орлогоор ЦАС-г санхүүжүүлдэг. Төсвийн хатуу бодлого барих шаардлага үүссэнтэй холбогдон 2013 оноос хойш зарлага нь огцом буурч, агаарын бохирдолын төлбөрөөс хуримтлуулсан жилийн орлогоос хамаагүй багасчээ. ЦАС-г 2015 онд татан буулгах үед зарлага нь агаарын бохирдолын нийт татварын орлогын 38.4 хувьтай тэнцэж байжээ. ЦАС-ийн нийт зарлага 2011-2015 онд 94.2 тэрбум төгрөг (66.2 сая доллар) байсан бол агаарын бохирдолын нийт хураасан татвар 114.4 тэрбум төгрөгт (74.1 сая доллар)<sup>5</sup> хүрсэн байна. Улаанбаатарын гэр хорооллын ядуу өрхүүдэд чиглэгдсэн “сайжруулсан зуухны төсөл” санхүүжүүлэхэд ЦАС ихээхэн хэмжээгээр оролцсон байна. Төслийн хүрээнд өвлийн улиралд нүүрсээр галлаж их хэмжээний утаа ялгаруулдаг зуухнуудыг сайжруулсан зуухаар сольж, агаарт ялгаруулах PM2.5 болон СО-н хэмжээг бууруулах зорилгоор айл өрхүүдэд татаас олгосон байна.

### *Байгалийн нөөцийг хамгаалах болон нөхөн сэргээх*

Дээр дурдсан хоёр сангаас гадна, байгалийн нөөцийг хамгаалах болон нөхөн сэргээх зорилгоор Засгийн газар нэмэлт хөрөнгө гаргаж ирсэн, тухайлбал тусгай хамгаалалтай газруудыг хамгаалах болон газрыг нөхөн сэргээх зорилгоор улсын жилийн төсвөөс хөрөнгө хуваарилж иржээ. Тэдгээр хөрөнгийн хэмжээ харьцангуй бага хэмжээтэй, 2008-2016 оны Засгийн газрын нийт зардлын 0.2 хувиас хэтрэхгүй байжээ (Хүснэгт 3.15).

### Орон нутгийн засаг захиргааны төсөв

Байгалийн нөөц (ус, ургамал, ой мод, ан болон загас агнуур, газар ашигласаны) ашигласны төлбөрийг орон нутгийн засаг захиргаанд хуваарилдаг. Тухайн засаг захиргаа тэдгээр орсон орлогын тодорхой

<sup>5</sup> Долларыг тухайн жилийн дундаж ханшаар тооцсон.

хувийг тухайн байгалийн нөөцийг хамгаалах болон нөхөн сэргээх арга хэмжээнд зориулах хуулийн заалтыг олон жилийн өмнө гаргасан. Одоогийн хууль эрх зүйн үндэслэл нь Байгалийн нөөц баялагыг ашигласны төлбөрийн тухай 2012 оны шинэчилсэн хууль, Байгалийн нөөц ашигласны орлогыг бүрдүүлэх, зарцуулах болон байгаль хамгаалах болон нөхөн сэргээх арга хэмжээг тайлагнах ажлыг зохицуулах тухай Засгийн газрын 2014 оны 43 тоот тогтоол юм. 2013 онд 18.9 тэрбум төгрөгийг (12.4 сая доллар) зориулалтаар ашиглах орлогыг бүрдүүлж байсан бол 2016 онд 22.9 тэрбум төгрөг (10.6 сая доллар) болж өссөн байна. Харин, тэдгээр хөрөнгийн зөвхөн зарим хэсгийг л хуульд заасан зориулалтаар байгалийн нөөц баялагыг хамгаалахад ашигласан байна. Холбогдох нийт зардлын хувь хэмжээ 2013 онд 60.5 хувь байсан бол 2016 онд 33.1 хувь болж буурсан байна (Хүснэгт 3.16). Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зориулалтаар хуваарилсан хөрөнгийг ерөнхий байдлаар байгаль хамгаалахтай холбоотой орон нутгийн захиргааны үйл ажиллагааны зардал болон орон нутгийн байгаль хамгаалагчдад зарцуулсан байна. Нийтдээ, орон нутгийн засаг захиргааны байгаль орчны холбогдолтой нийт зардал 2016 онд 9.25 тэрбум төгрөг (4.3 сая доллар) байжээ. Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны байгаль хамгаалах болон нөхөн сэргээлтэд зарцуулсан хөрөнгө 2008-2015 оны хугацаанд Засгийн газрын нийт орлогын 0.3-аас 0.4 хувьтай тэнцэж байсан бол 2016 онд 0.25 болж буурчээ (Хүснэгт 3.15).

### Хүснэгт 3.15: Байгалийн нөөц баялагыг хамгаалах, нөхөн сэргээх зардал, 2008-2016, тэрбум төгрөгөөр

Зориулалт/санхүүжилтийн эх үүсвэр	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
<b>Засгийн газрын төсөв</b>									
Байгаль хамгаалах	0.18	0.70	0.88	2.16	0.29	0.89	2.16	1.83	0.00
Тусгай хамгаалалтын газрын хамгаалалт	2.15	1.90	2.13	2.74	4.22	5.14	6.64	5.36	6.05
Ойжуулах болон ойн үйл ажиллагаа	2.58	2.29	4.98	4.99	5.79	5.22	4.25	4.04	3.03
Газрыг хамгаалах, нөхөн сэргээлт	0.04	0.00	0.90	0.89	0.23	0.29	0.49	0.49	6.37
<b>Нийт</b>	<b>4.94</b>	<b>4.89</b>	<b>8.89</b>	<b>10.78</b>	<b>10.53</b>	<b>11.53</b>	<b>13.54</b>	<b>11.72</b>	<b>15.45</b>
Орон нутгийн засаг захиргааны төсөв	2.45	2.81	2.78	4.72	12.10	10.37	12.04	16.73	9.25
<b>Төв болон орон нутгийн захиргаа</b>	<b>7.39</b>	<b>7.70</b>	<b>11.67</b>	<b>15.50</b>	<b>22.63</b>	<b>21.90</b>	<b>25.58</b>	<b>28.44</b>	<b>24.69</b>
<b>Нийт (\$ сая)</b>	<b>6.32</b>	<b>5.36</b>	<b>8.60</b>	<b>12.25</b>	<b>16.67</b>	<b>14.37</b>	<b>14.04</b>	<b>14.41</b>	<b>11.40</b>
<b>Нийт (ДНБ-ний % )</b>	<b>0.08</b>	<b>0.09</b>	<b>0.12</b>	<b>0.12</b>	<b>0.14</b>	<b>0.11</b>	<b>0.12</b>	<b>0.12</b>	<b>0.10</b>
<b>Нийт (засгийн газрын нийт зарлагын % )</b>	<b>0.30</b>	<b>0.33</b>	<b>0.38</b>	<b>0.31</b>	<b>0.35</b>	<b>0.28</b>	<b>0.29</b>	<b>0.37</b>	<b>0.25</b>

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Үндэсний статистикийн газар; ЕСЕ нбд нарын газрын тооцоо.

Тэмдэглэл: Орон нутгийн захиргааны байгаль орчны зориулалтын хөрөнгийн бусад зарцуулалтад орон нутгийн байгаль орчны байгууллагуудын ажилтнуудын цалин хөлсийг оролцуулахгүйгээр бусад үйл ажиллагааны зардал орсон. Долларыг тухайн жилийн дундаж ханшаар бодож гаргасан.

### Хүснэгт 3.16: Орон нутгийн засаг захиргааны байгалийн нөөц ашигласны төлбөрөөс бүрдсэн орлогын зарцуулалт, тэрбум төгрөгөөр

Орлогын эх үүсвэр\ зарлага	Нөөцөлсөн %	2013	2014	2015	2016
Байгалийн хөөц ашигласан төлбөрөөс орсон орлого					
Газар ашиглалт	15	16.72	16.38	17.13	17.46
Ой	85	2.96	3.03	3.66	4.47
Ан агнах, барих	50	0.52	1.00	2.38	3.24
Өвс ургамал	15	0.06	0.55	2.77	4.53
Ус	35	38.98	34.34	35.69	40.61
<b>Дээрхийн нийт дүн</b>		<b>59.24</b>	<b>55.30</b>	<b>61.63</b>	<b>70.30</b>
түүнээс: 3Г-ын 2014 оны 43 дугаар тогтоолын дагуу нөөцөлсөн		18.94	17.63	19.78	22.93

З/г-н 2014 оны 43-р тогтоолд үндэслэсэн бодит зарлага	11.47	9.84	9.33	7.58
Нөөцөлсөн нийт орлогын бодит зарлагын %	60.5	55.8	47.2	33.1
<i>Меморандум</i>				
Байгалийн хөөц ашигласаны төлбөрөөс орсон орлого (\$ сая)	38.87	30.34	31.22	32.47
Нөөцөлсөн орлого (\$ сая)	12.43	9.68	10.02	10.59
Байгаль орчны бодит зарлага (\$ сая)	7.52	5.40	4.72	3.50

Эх сурвалж: ҮСХ; Байгаль орчны байдлын тухай тайлан 2015-2016, хүснэгт 61; ЕСЕ нбд нарын газрын тооцоо. Тэмдэглэл: Байгалийн нөөцийн хамгаалалт, нөхөн сэргээлтийн зардалууд. Долларыг тухайн жилийн дундаж ханшаар тооцоолов.

### Уул уурхайн салбарын байгаль орчны зардлууд

Ашигт малтмалын тухай 2006 оны хуульд зөвшөөрөл эзэмшигчид нь (хайгуулын болон ашиглалтын) байгаль орчныг хамгаалах тодорхой үүрэг хүлээдэг, тухайлбал газрыг байгалийн болон эдийн засгийн эргэлтэд ашиглаж болох байдалд нь эргүүлэн оруулах уурхайн нөхөн сэргээлт хийх үүрэгтэй байдаг. Уул уурхайн компаниуд байгаль орчны хувьд хүлээсэн үүргээ биелүүлэх үүднээс байгаль орчныг хамгаалах жилийн төсөвийнхээ 50 хувийг холбогдох сум, дүүргийн банкны засаг даргын захиран зарцуулах тусгай дансанд байршуулна. Тэрхүү хөрөнгийг байгаль орчныг хамгаалах ажилд зарцуулсаны дараа Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хуулийн дагуу буцаан суутгана. Ямар нэг үлдэгдэл гарвал компанид нь буцаан олгоно. Харин амьдрал дээр бол тухайн жилийн үлдэгдэлийг дараа жилд нь шилжүүлэн ашиглаж байна. Байгаль хамгаалах тусгай дансны хуримтлагдсан орлого 2015 оны сүүлийн байдлаар 10.207 тэрбум төгрөгт (5.1 сая доллар) хүрчээ. Тусгай дансанд жил бүр орж байгаа хөрөнгөөр хүлээсэн үүргийн дагуу хийх нөхөн сэргээлтийн ажил хийхдээ уул уурхайн үйлдвэрлэлийн тэргүүн туршлага болон олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад хэр зэрэг нийцүүлж, түүнд тулгуурладаг эсэх нь асуудалтай юм.

Олборлох аж үйлдвэрийн ил тод байдлын санаачлага (ОАҮИТБС)-ын үзэж байгаагаар, одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид тусгагдсан уурхайн хаалтын үйл ажиллагааны тухай заалт нь хэт ерөнхий, тодорхой бус байгаагаас зарим компаниуд нөхөн сэргээлт хийх асуудлаар орон нутгийн засаг захиргаатай харилцахдаа хуулийн энэ цоорхойг ашиглах үзэгдэл ч гардаг байна. Түүнчилэн, Тусгай данс нь ил тод байдал болон хариуцлагатай байх стандартыг хангаж чадахгүй байна.<sup>6</sup> Байгаль орчны өртөг зардлын санхүүжүүлэлтийг зөвхөн тухайн жилийн төсвийн байгаль орчны зардалтай уялдуулах хязгаарлалтыг дүрэм журмаар тогтоосон. Харин илүү үр дүнтэй байж болох хувилбар бол компаниуд эскроу дансаар дамжуулан тухайн жилийн болон ирээдүйн байгаль орчны зардлыг санхүүжүүлэх явдал юм. Засгийн газар энэ чиглэлд ажиллаж эхлээд байгаа юм байна. Өмнөговь аймаг дахь зэс-алтны уурхайн гол цогцолбор Оюу толгойн Хөрөнгө оруулалтын хэлэлцээрт 2012 оны 10 дугаар сард гарын үсэг зурсан бөгөөд уг хэлэлцээрт хөрөнгө оруулагч нь уурхайн хаалтын төлөвлөгөөг боловсруулан Засгийн газрын холбогдох газраар батлуулах, татвараас чөлөөгдөх эскроу дансанд уурхайн хаалтын төлөвлөгөөг санхүүжүүлэх хөрөнгийг уурхайг хаахаас долоон жилийн өмнө байршуулна гэж заасан байна.<sup>7</sup>

Албан ёсны мэдээгээр, 2014 онд уул уурхайн компаниуд эвдэрсэн газрыг буцаан сэргээх болон биологийн нөхөн сэргээлтэд (бут сөөг, мод тарих) компаниуд нийт 20.9 тэрбум төгрөг (11.5 сая доллар) зарцуулсан байна. Тэдгээр зардал нь уул уурхайн болон ил уурхайн компаниудын нийт хөрөнгө оруулалтын 2.3 хувь болж байна. Өмнөх жилүүдэд энэ хувь хэмжээ 0.2-оос 0.9 хувийн хооронд хэлбэлзэж иржээ. Нийт зарлага 2006-2014 оны хооронд 124.6 тэрбум төгрөгт хүрч, үүний 62.3 хувийг эвдэрсэн газрыг сэргээхэд, үлдсэнийг нь биологийн нөхөн сэргээлтэд зарцуулсан байна (Хүснэгт 3.17).

<sup>6</sup> EITI 2015.

<sup>7</sup> Монголын уул уурхайн сэтгүүл, Оюу толгойн хэлэлцээрт ямар асуудлууд орсон ба энэ нь Монгол улсын хувьд ямар ач холбогдолтой болох. 2012 оны 3 дугаар сарын 23. <http://en.mongolianminingjournal.com/content/19679.shtml>  
<https://www.mof.gov.mn/wp-content/uploads/2010/07/Fiscal-regime-for-mining2.pdf>



### Хүснэгт 3.17: Уул уурхайн зөвшөөрөл бүхий компаниудын нөхөн сэргээлтийн ажлын зарлага, 2006-2014, сая төгрөгөөр

Ажлууд	Сая төгрөг									
	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2006–2014
Эвдэрсэн газрыг сэргээх	4,662	8,960	7,683	8,300	9,657	7,013	14,808	7,382	9,212	77,677
Биологийн нөхөн сэргээлт	2,488	3,501	3,592	4,158	5,708	3,323	8,597	3,876	11,683	46,926
<b>Нийт</b>	<b>7,150</b>	<b>12,461</b>	<b>11,275</b>	<b>12,458</b>	<b>15,365</b>	<b>10,336</b>	<b>23,405</b>	<b>11,258</b>	<b>20,895</b>	<b>124,603</b>
	Сая доллар									
Эвдэрсэн газрыг сэргээх	3.960	7.655	6.571	5.772	7.112	5.542	10.908	4.844	5.055	57.419
Биологийн нөхөн сэргээлт	2.114	2.991	3.072	2.892	4.204	2.626	6.333	2.543	6.410	33.185
<b>Нийт</b>	<b>6.074</b>	<b>10.647</b>	<b>9.643</b>	<b>8.664</b>	<b>11.315</b>	<b>8.168</b>	<b>17.241</b>	<b>7.387</b>	<b>11.465</b>	<b>90.604</b>
Санамж										
Нийт (далд болон ил уурхайн салбарын нийт хөрөнгө оруулалтын %)	.	.	.	0.71	0.87	0.20	0.50	0.37	2.28	

Эх сурвалж: Монголын ашигт малтмалын газар, Уул уурхай, Геодезийн статистик - 2015 оны эхний зургаан сарын мэдээ (хуудас 25). ЕСЕ нбд нарын газрын тооцоо.

Тэмдэглэл: төгрөгөөр илэрхийлсэн жилийн зарлагыг тухайн жилийн дундаж ханшаар бодож долларт шилжүүлсэн.

#### Усан хангамж болон бохир усны дэд бүтцийн хөрөнгө оруулалтын санхүүжилт

Хэдийгээр орон нутгийн засаг захиргаа усан хангамж болон муу усны үйлчилгээний асуудлыг хариуцах үүрэгтэй ч гэсэн усны салбарын дэд бүтцийг засварлах, өргөтгөхөд шаардлагатай хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхэд оролцдоггүй байна. Усан хангамж болон бохир усны дэд бүтцийн засвар үйлчилгээ, өргөтгөхөд шаардлагатай хөрөнгийг улсын төсвийн орлогоос санхүүжүүлж байна. Шаардлагатай санхүүжилтийг Барилга, хот байгуулалтын яамны төсөвт багтаан баталдаг байна. Дэд бүтэцтэй холбогдсон санхүүжилтийн бас нэг чухал эх үүсвэр нь олон улсын байгууллагын зээл, тусламж болон гадаадын бусад эх үүсвэр болж байна. Ус болон эрүүл ахуйн хөрөнгө оруулалтын дийлэнхи нь Улаанбаатар болон аймгуудын төвд төвлөрч байна.

Хот болон хөдөөгийн усан хангамж, эрүүл ахуйн дэд бүтцийн хөрөнгө оруулалтад 2015 онд улсын төсвөөс нийт 24 сая ам. доллар гаргасны 70 орчим хувь нь хотод ноогдсож байна. Гадаадын зээл, тусламжийн нэмэлт 20 сая орчим ам. долларын хөрөнгийн 82 хувь нь зээл байна (Хүснэгт 3.18). Дотоодын эх үүсвэрийн санхүүжилт нь 2015 онд засгийн газрын нийт зарлагын 0.6 хувь байж. Бохир усны цэвэрлэх байгууламжид оруулсан хөрөнгө оруулалт 2014 онд улсын төсвийн зарлагын 1.1 хувь байснаа 2015 онд 0.2 хувь болж буурчээ.

#### Хүснэгт 3.18: Усан хангамж болон бохирын дэд бүтэцэд оруулсан хөрөнгө оруулалт, 2015, сая доллараар

	Албан ёсны буцалтгүй тусламж (АЁБТ)		Нийт	АЁБТ-ийн улсын төсөвт эзлэх хувь
	Улсын төсөв			
хотод				
Усан хангамж	6.77	6.16	12.93	90.99
Эрүүл ахуй	10.26	4.02	14.28	39.18
хөдөөд				
Усан хангамж	3.19	5.21	8.4	163.32
Эрүүл ахуй	3.79	4.56	8.35	120.32
<b>Нийт</b>	<b>24.01</b>	<b>19.95</b>	<b>43.96</b>	<b>83.09</b>

Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яам, 2017. ЮНИСЕФ WASH хөтөлбөр.

Засгийн газар дэд бүтцийн шинэ төсөл хэрэгжиж дуусахад цаашид тухайн төслийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээг хариуцаад аваад явах санхүүгийн чадварыг нь тооцож харгалзахгүйгээр орон нутгийн засаг захиргаанд хөрөнгийг шилжүүлж байна. Үйлчилгээ үзүүлэгчид тэдгээр байгууламжийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээг хэвийн авч явах хөрөнгийг босгож чадахгүйд хүрэх, ялангуяа оруулсан хөрөнгийн зардлыг нөхөх болон барилга байгууламжийг барих санхүүжүүлтийг босгоход дэмжлэг болсон зээлийн хүүг төлөхөд хүрэлцэхүйц орлого олж чадахгүйд хүрч байна.

#### Сэргээгдэх эрчим хүчний сан

Сэргээгдэх эрчим хүчний санг сэргээгдэх эрчим хүчний салбарын хөгжлийг дэмжих санхүүжилтийг босгох зорилготой байгуулжээ. Түүнчлэн, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн зардал болон хэрэглэгчийн тарифын ялгааг санхүүжүүлэхээр тооцсон байна. Харин, бодит санхүүжилт нь хүрэлцээгүй байсаар сан үнэн хэрэгтээ үйл ажиллагаа эхлэн явуулж чадахгүй байсаар Засгийн газрын тусгай сангийн жагсаалтаас 2015 онд хасчээ.

#### Цэвэр хөгжлийн механизм

Киотогийн протоколийн дагуу Монгол улс Япон улстай Хамтарсан кредит олгох механизмд Цэвэр хөгжлийн механизмын хэрэгсэл болгон хамтран ажиллаж ирсэн. Нүүрстөрөгч бага ялгаруулах технологийг нэвтрүүлэх, тухайлбал үр ашиг өндөртэй халаалтын зуухыг олон нийтийн барилга байгууламжид суурилуулах төслийн өртөгийн хагасыг Япон гаргаж, түүнийгээ нүүрстөрөгчийг бууруулах кредитээс эргүүлэн авч байна.

#### *Хөгжлийн тусламж*

Монгол улс эдийн засгийн янз бүрийн салбаруудад олон талт болон хоёр талын хандивлагчдаас нэлээд хэмжээний санхүүгийн дэмжлэг тусламж авч иржээ. 2009-2015 оны хугацаанд 2.2 тэрбум долларын зээл тусламжийг хөгжлийн гол түншүүдээс авчээ. Зээл тусламжийг авч ирсэн гол салбаруудыг төслийн үнэ цэнээр нь авч үзвэл: тээвэр (40 хувь); банк санхүү (22 хувь); боловсрол (8 хувь), усан хангамж болон хотын дэд бүтэц, үйлчилгээ (8 хувь); хөдөө аж ахуй болон байгалийн нөөц баялаг (4 хувь); эрчим хүч (3 хувь); улсын секторын менежмент (3 хувь) болон бусад салбар (8 хувь) байна. Хандивлагчдийн албан ёсны зохицуулалтын хурал 2012 оны 6 дугаар сард болж, дараа нь албан бус хурлыг хандивлагчид өөрсдөө сар бүр зохион байгуулж иржээ. Эдгээр уулзалтад байгаль орчин; хотын хөгжил; хөдөө аж ахуй; болон бусад асуудлаархи ажлын хэсгүүдийн бие даасан уулзалтууд хамрагдаж байна.

Байгаль орчныг хамгаалах асуудлын хувьд, 2017 оны эхэн гэхэд 34 төсөл хэрэгжиж байгаагийн зарим нь 2011 болон 2013 оноос хэрэгжиж байгаа бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын яам тэдгээр төслүүдийн хэрэгжүүлэгч байгууллагаар оролцож байна. Зээл, тусламжийн нийт дүн нь (Засгийн газрын хамтран санхүүжүүлэгчээр оролцсоноос бусад) 139 сая ам. доллар болж байна. Санхүүжилтээр нь эрэмблэн авч үзвэл зээл тусламж авсан гол салбарууд нь: байгалийн нөөц баялагын тогтвортой менежмент (44 хувь), ойн бодлогын менежмент (22 хувь); био аюулгүй байдал ба химийн аюултай бодисын аюулгүйн менежмент (14 хувь); ногоон хөгжлийн бодлого ба үзүүлэлтүүд (9 хувь); усны бодлого ба менежмент (4 хувь) болон бусад (7 хувь) салбарууд байна.

#### *Ногоон ажил*

“Ногоон ажил, ногоон ажлын байр” гэж юу болох талаар нэгдсэн тодорхойлолт байхгүй байна. ОУХБ-ын “ногоон ажил” үзэл баримтлалд байгаль орчин болон нийгмийн асуудлын аль аль орсон байдаг. Ажил гэдэг тодорхойлолт нь байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах байгаль орчинд ээлтэй ажил, гэхдээ “ногоон ажил” гэдэг нь зөвхөн ОУХБ-ын шалгуурыг хангасан ажлыг ойлгож болно. Тухайлбал, хаягдал цахим хог хаягдлын эд ангийг дахин боловсруулах газрын хөдөлмөрийн аюулгүйн нөхцөл хангалтгүй байвал үүнийг ногоон ажил гэж үзэхгүй. Ногоон ажлын ач холбогдолыг тооцоолоход шаардлагатай мэдээ, мэдээлэл нь ямар ч эдийн засгийн салбарын хувьд бэрхшээлтэй асуудал болж байгаа бөгөөд нэгэнт эх сурвалжууд нь найдвартай байж чадахгүй тул бүх үнэлгээ бодит байж чадахгүй байх талтай. ОУХБ-аас 2014 онд Монголын эдийн засгийн есөн салбарт (мал аж ахуй, үр тарианы үйлдвэрлэл, ойн аж ахуй, эрчим хүч, усан хангамж, бохир болон муу ус цэвэрлэх байгууламж, хатуу

хог хаягдлын менежмент, тээвэр болон барилга) ногоон ажлын талаар явуулсан судалгаагаар, эдгээр салбаруудын 285,300 ажлын байрны тал орчим хувь нь “байгаль орчинд ээлтэй” ажил гэсэн зэрэглэлд орсон байна. Харин эдгээр ажлуудын мал аж ахуйн салбарын ажлын зөвхөн 16.8 хувь нь “ногоон” гэсэн зэрэглэлд тэнцэж, боломжийн ажил гэсэн шалгуурыг хангасан байна. Эдгээр бүх есөн салбарын нийт ногоон ажлыг 65,600 гэж тооцоолсон нь 2012 онд байгаа нийт ажлын 11.5 хувьтай тэнцэж байна.

### 3.4 Ногоон эдийн засгийг дэмжих төр-хувийн хэвшлийн түншлэл

Нийтийн үйлчилгээ, дэд бүтцийг сайжруулахад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа учир Монголын Засгийн газар Төр-хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)-ийг нэвтрүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгч байна. Үндэсний хөгжлийн цогц бодлого (2008)-д эдийн засгийн өсөлтийг дэмжих, эдийн засгийг төрөлжүүлэх болон ажлын байрыг нэмэгдүүлэх, хөрөнгийн эх үүсвэрийг босгох хамгийн боломжитой механизм бол ТХХТ гэж тодорхойлжээ.

Тээвэр, эрчим хүч, аялал жуулчлал, байгаль орчин зэрэг олон тооны салбарт концессоор хэрэгжүүлэх 121 төслийн жагсаалтыг Засгийн газар 2010 онд баталсан байна. Мөн 2013 оны 9 дүгээр сард 50 төслийн шинэчилсэн жагсаалтыг баталжээ. Засгийн газар 2016 оны байдлаар эрчим хүч, тээвэр, болон боловсролын салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 39 ТХХТ-ийн төсөлтэй байсан. Улаанбаатар хот 2013-2014 онд тээвэр, ус болон бохир усны менежмент зэрэг олон салбарын концессын төслүүдэд гарын үсэг зурсан байна. Засгийн газрын янз бүрийн байгууллагууд болон орон нутгийн түвшинд санал болгосон төслүүдийн олонхи нь концессийн ангилалд хамруулах боломжгүй байсан нь төслүүд эдийн засгийн хувьд ашиггүй байсантай холбоотой ажээ. ТХХТ-н төслүүдийн хувьд бэрхшээл учруулж байгаа гол хүчин зүйл бол эрчим хүч, тээвэр болон хотын дэд бүтцийн үйлчилгээний тариф хэт бага, мөн бүтээмж муутай төрийн өмчит компаниуд давамгайлж байгаа явдал юм.

Засгийн газар 2011-2015 онд долоон концессын хэлэлцээрийг эрчим хүч, тээврийн салбарт 2010 оны Концессын хуулийн дагуу эцэслэн байгуулсан байна. Эдгээрт ДЦС5 –Улаанбаатар хотод хувийн хөрөнгө оруулагчдийн консорциум “барих-ашиглах-шилжүүлэх” зарчмаар АХБ-ны зээлийг ашиглан барьж байгуулах асуудал үүнд орж байсан байна. Уг станц нь эрчим хүч үйлдвэрлэхээс гадна, үйлдвэрлэсэн дулааныг халуун усны хэлбэрээр Улаанбаатарын дулааны шугам сүлжээнд нийлүүлэхээр төлөвлөсөн байна.

Эрчим хүчний салбарын өөр нэг чухал төсөл бол Монголын анхны салхин станц болох Салхитын салхин цахилгаан станцын төсөл байсан бөгөөд уг станц 2013 оны 6 дугаар сард ашиглалтад орсон байна. Энэ төсөлд ЕСБХБ, Голландын Бизнес эрхлэлтийг хөгжүүлэх банк (FMO) –аас хувийн хөрөнгө оруулагчид олгосон зээл ба тэгштгэсэн санхүүжилт орсон байна. Мөн өөр нэг ТХХТ-ийн төсөл бол ЖАЙКА, ЕСБХБ болон хувийн хөрөнгө ороулагчдийн оролцоотойгоор Монголын говьд барьж байгуулах Цогт Цэций сумын салхин паркын ажил 2016 оны 9 дүгээр сард эхэлсэн байна. Төлөвлөж байгаа нэг төсөл бол Улаанбаатарын автобусны ТХХТ төсөл бөгөөд АХБ санхүүжүүлнэ.

Байгаль орчны салбарт, Даян дэлхийн Ногоон Өсөлтийн байгууллага, Засгийн газрын оролцогч талууд болох БОАЖЯ болон Улаанбаатар хоттой хамтран 2015 оны 9 дүгээр сараас хойш боловсролын (сургууль, цэцэрлэг) байгууллагын барилгуудыг “ногоон” болгох эрчим хүчний хэмнэлттэй системд голлон анхаарсан нийгмийн дэд бүтцэд нэвтэрүүлэх ТХХТ-ийн загварын ерөнхий чиглэлийг боловсруулж байна. Улаанбаатар хотод есөн боловсролын барилгад ТХХТ-н шинэ ногоон төслийг туршин хэрэгжүүлэхээр бэлэн болгоод байгаа бөгөөд харин эдийн засгийн хувьд хэрхэн үр ашигтай болгох нь бэрхшээл учруулж болох юм.

Хэдийгээр Концессын тухай хууль 2010 онд батлагдсанаас хойш нэлээд ахиц гарч байгаа ч гэсэн Засгийн газрын болон орон нутгийн засаг захиргааны хувьд ТХХТ-ийн төслүүдийг боловсруулах, хэрэгжүүлэхэд боломж, чадавхи нь сул, түүнчлэн ТХХТ-ийн санхүүгийн үр дагавар болон боломжийн талаархи ойлголтыг сайжруулах шаардлага тулгарч байна.

### 3.5 Эдийн засгийг “ногооруулах” эрх зүй, бодлого болон бүтэц зохион байгуулалтын тогтолцоо

*Хууль эрх зүйн орчин*

#### Эдийн засгийн арга хэрэгсэл

Татварын тухай 2008 оны ерөнхий хууль нь шинэ татвар, татварын суурь, татварын хувь хэмжээ болон төлбөрийг тогтоох суурь хууль юм.

#### Бохирдлын төлбөр

Агаарын бохирдлын төлбөрийг зохицуулах гол хуулиуд бол Агаарын тухай хууль (2012 оны шинэчилсэн хувилбар) болон 2010 оны Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль юм. Агаар бохирдуулж байгаа тодорхой үйл ажиллагаануудад ногдуулах төлбөрийн хувь хэмжээг дараах ангилалаар тогтоосон байна:

- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Зам, тээвэр, барилгын сайдын 2011 оны хамтарсан А-63\67 тоот тушаалаар авто машинд моторын хүчин чадлаас нь хамааран CO<sub>2</sub> хийн ялгарлын төлбөрийг зохицуулсан,
- Засгийн газрын 2010 оны 273 тоот тогтоолоор агаар бохирдуулагч органик уусмалуудын үйлдвэрлэл болон импортод ногдуулах төлбөрийн хувь хэмжээг баталсан (Хавсралт 2);
- Засгийн газрын 2011 оны 92 дугаар тогтоолоор цахилгаан станцууд зэрэг суурин байгууламжуудад ногдуулах агаарын бохирдолын ялгаралын төлбөрийн хувь хэмжээг тогтоосон (Хавсралт 1) байна. Ус бохирдуулсаны төлбөрийг Усны тухай 2012 оны хууль болон Ус бохирдлын төлбөрийн тухай хуульд тулгуурлан тогтоосон боловч үүнийг хэрэгжүүлэх журмыг хараахан батлан гаргаагүй байна.

#### Онцгой албан татвар

Онцгой албан татварыг Онцгой албан татварын тухай 2006 оны хуулийн дагуу ногдуулж байна. Тухайн хуулийг баталсанаас хойш хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт оруулжээ. Бензин, дизель түлш болон суудлын автомашин импортын татварыг Засгийн газрын тогтоолоор тогтоож өгсөн байна. Бензин болон дизель түлшинд ногдуулах татварыг хамгийн сүүлд 2003 онд шинэчилсэн Бензин, дизель түлшний татварын тухай 1995 оны хуульд суурилан тогтоож байна.

#### Ашигт малтмалын роялти

Уул уурхайн салбарын роялтийн төлбөрийг Ашигт малтмалын тухай 2006 оны хуулиар зохицуулж байна. Уг хуулинд хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт оруулсаны дараа хууль 2014 оны 7 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж байна. Түүнчлэн түгээмэл тархацтай ашигт малтмалыг (хайрга, элс болон шавар) Ашигт малтмалын тухай 2014 оны хуулиар зохицуулахгүй, харин 2014 оны Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулиар зохицуулахаар болсон байна. Монгол улсын УИХ-ын 2014 оны 18 тоот тогтоолоор батлагдсан 2014-2025 онд хэрэгжүүлэх Төрөөс ашигт малтмалын талаар баримтлах бодлогын зорилго нь ялгавартай татвар тогтоох замаар уул уурхайн салбарын хөгжилд хувийн хэвшлийн оролцоог дэмжихэд оршиж байна. Газрын тосны тухай хуулиар газрын тос болон байгалийн хийн ашиглалтын роялтийг зохицуулж байна.

#### Байгалийн нөөц баялагыг ашигласаны төлбөр хураамж

Байгалийн нөөц баялаг ашигласны төлбөрийг Байгалийн нөөц баялаг ашигласны төлбөрийн тухай 2012 оны хуулиар зохицуулж байна. Хуулиар орон нутгийн засаг захиргаа байгалийн нөөц ашигласны төлбөрийн хураамжаас тухайн ашигласан нөөцийг хамгаалахад зарцуулах доод хэмжээг тогтоож өгсөн байна. Энэ хууль нь 1995 онд батлагдсан байгалийн нөөц баялаг бүрийн ангилалыг тогтоосон хууль болон 2000 оны Байгалийн нөөц баялаг ашигласны төлбөрийг эргүүлэн Байгаль орчин болон Байгалийн нөөц баялагыг нөхөн сэргээхэд зориулах тухай хуулийг баталгаажуулж өгчээ. Энэхүү хуулийн дагуу “Байгаль хамгаалах болон нөхөн сэргээх арга хэмжээнд төвлөрсөн орлогыг зарцуулах болон тайлагнах” тухай Засгийн газрын 43 тоот тогтоол 2014 онд гарчээ. Байгалийн нөөц баялаг ашигласны төлбөрийн хувь хэмжээг нарийвчилан тогтоосон 2014 оны Засгийн газрын тогтоолоор ойгоос түлшний мод бэлтгэхэд ногдуулах төлбөрийн хувь хэмжээг тогтоожээ. Ан амьтаны агнуурын зөвшөөрлийн төлбөрийг 2011 оны Засгийн газрын 23 тоот тогтоолын үндсэн дээр тогтоож байна.

Гуалин болон түлшний мод бэлтгэх суурь үнэ цэнийг 2009 оны Засгийн газрын 394 тоот тогтоолоор гуалингийн модны нөөцийн эдийн засаг болон экологийн үнэлгээнд тулгуурлан тогтоожээ. Мөн 2014 оны Засгийн газрын 307 тоот тогтоолоор гуалин болон түлшний модны төлбөрийг тогтоосон байна.

Газар ашиглалтын төлбөрийг Газрын төлбөрийн тухай 1997 оны хуулиар зохицуулж байна. Засгийн газрын 1997 оны 152 тоот тогтоолоор (Хавсралт 2) газрын төлбөрийн жилийн суурь төлбөрийн дээд болон доод хязгаарыг тогтоож өгчээ. Орон нутгийн захиргаа тогтоосон хязгаарын хүрээнд газрын төлбөрийн тодорхой хувь хэмжээг тогтооно.

#### Байгалийн нөөц баялагын эдийн засаг, экологийн үнэлгээ

Байгалийн нөөц баялагын эдийн засаг, экологийн үнэлгээг Засгийн газрын тодорхой тогтоолуудаар зохицуулж байна: Үүнд:

- Ойн нөөцийн экологи, эдийн засгийн үнэлгээг батлах тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 394 тоот тушаал;
- Ан амьтаны экологи-эдийн засгийн үнэлгээний тухай Засгийн газрын 2011 оны 23 тоот тогтоол;
- Ургамалын эдийн засаг, экологийн үнэлгээний тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2015 оны тогтоол, Хавсралт А-282;
- Усны экологи, эдийн засгийн үнэ цэнийн тухай Засгийн газрын 2011 оны 302 тоот тогтоол.

#### Хот суурин газрын хог хаягдлыг цуглуулан зайлуулах хураамж

Хотын хог хаягдлыг цуглуулан зайлуулах ажлыг Хог хаягдлын менежментийн тухай 2012 оны хуулиар зохицуулж байна. Засгийн газрын 2015 оны тогтоолоор хог хаягдлын менежмент, тээвэрлэлтийн үйл ажиллагааг санхүүжүүлэх болон хог хаягдлын менежментийн үйлчилгээний төлбөрийг баталгаажуулсан байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хог хаягдлын үйлчилгээний төлбөрийг тооцоолох аргачлалыг боловсруулан гаргасан байна. Хог хаягдалыг цуглуулах тодорхой хураамжийг орон нутгийн захиргааны түвшинд тогтооно, жишээ нь Улаанбаатар Хотын Зөвлөлийн 2013 оны 1245 тоот тогтоолыг нэрлэж болно. Хог хаягдлын менежментийн тухай шинэ хуулийг 2017 онд баталсан (Бүлэг 10) байна.

#### Усан хангамж болон бохир усны тариф

Усны тухай 2012 оны хууль болон Хот, суурин газруудад Усан хангамж болон бохирын системийг ашиглах тухай 2011 оны хууль нь усан хангамж, бохир усны үйлчилгээний тарифын эрх зүйн ерөнхий суурь үндэс юм. Усан хангамж, бохирын үйлчилгээний тарифыг 2012 оноос хойш бүх хот, аймгуудад Усны үйлчилгээний Зохицуулах комисс тогтоож байна. Тогтоосон тарифыг Шудрага өрсөлдөөн, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах газар хянана. Хотын тарифын хороо нь 2011 он хүртэл үйлчилгээний тариф тогтоох асуудлыг хариуцаж байсан байна.

#### Цахилгааны тариф

Сэргээгдэх эрчим хүчийг оролцуулсан эрчим хүчний тарифыг Эрчим хүчний тухай 2002 оны хуулийн хүрээнд тогтооно. Эрчим хүчний зохицуулалтын хороо (ЭХЗХ) эрчим хүчний тарифыг тогтоох ажлыг харицана. Харин 2007 оны Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиар янз бүрийн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг дэмжих тарифыг тогтоож өгсөн байна.

#### Төр-Хувийн хэвшлийн түншлэл

Төр-хувийн хэвшлийн түншлэлийн (ТХХТ) эрх зүйн гол үндэс нь 2010 оны Концессын тухай хууль болон холбогдох дүрэм журам, мөн 2013 онд шинэчилсэн Хөрөнгө оруулалтын тухай хууль болно. 2009 оны УИХ-ын 64 дүгээр тогтоолоор “Төр хувийн хэвшлийн түншлэл”-ийн үндсэн зарчмуудыг тогтоож өгчээ. Концессын төслийг Засгийн газар болон орон нутгийн байгууллагууд хэрэгжүүлэх боломжтой. Засгийн газрын ТХХТ хариуцсан нэгж нь ТХХТ-н бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг 2011 оноос хариуцаж байгаа Уул уурхай, хүнд үйдвэрийн яаманд харьяалагдаж байснаа 2016 онд шинээр байгуулагдсан Үндэсний хөгжлийн газарт (ҮХГ) шилжсэн байна.



*Байгаль орчны холбогдолтой зардлыг санхүүжүүлэх эрх зүй болон бүтэц зорион байгуулалтын орчин*

Улсын Их Хурал бүх хууль тогтоомжууд, дунд хугацааны болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон жилийн төсвийг баталдаг. Сангийн яам бол төсвийн бодлого боловсруулах, жилийн төсвийг бэлтгэх, хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын гол байгууллага юм. Татварын ерөнхий газар болон Гаалийн ерөнхий газар нь татвар хураах үүргийг хариуцана. Сангийн яам мөн нийгэм эдийн засгийн жилийн болон дунд хугацааны бодлогыг боловсруулах болон олон улсын зээл авах асуудлаар хэлэлцээ хийх үүрэг хүлээнэ.

Улсын төсвийн санхүүгийн менежмент 2010 оноос хойш нэлээд сайжирчээ. Байгалийн баялагын ашиглалтаас ихээхэн хараат орны эдийн засгийн хөгжилд эрсдэлийг үүсгэж байгаа ашигт малтмалын үнийн савлагаа, бүтцийн сөрөг үр дагавартай («Голланд өвчин») тэмцэх үүднээс 2010 оны Төсвийн тогтвортой байдлын хуулиар төсвийн талаар баримтлах шинэ журмыг нэвтэрүүлсэн байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яам зэрэг бусад яамдын төсвийн санхүүгийн хуваарилалт нь УИХ-аас баталсан жилийн төсвийн үндсэн дээр хийгддэг. 2012 оны эхээр хүчин төгөлдөх болсон нэгдсэн төсвийн тухай 2011 оны хууль нь дунд хугацааны төсвийн бодлого болон улсын хөрөнгө оруулалтыг төлөвлөлтийг бэхжүүлэх зорилготой ажээ.

Дэд бүтцэд оруулах дийлэнхи хөрөнгө оруулалтыг Засгийн газрын түвшинд татварын тогтолцоогоор дамжуулан бүрдүүлдэг байна. Энэ асуудал яамдын, ихэнх нь Барилга, хот байгуулалтын хөгжлийн яаманд төсвийн хуваарилалтад тусгагдана. Томоохон төслүүдийн хувьд, Улсын хөрөнгө оруулалтын дөрвөн жилийн эргэлтийн хөтөлбөр (УХОХ) үйлчилдэг. Томоохон хэмжээний төслүүдийн хувьд, удаан үргэлжлэх зардлын үр дагаварыг төсвийн саналд заавал оруулах журамтай.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу Засгийн газрын төсвийн салшгүй хэсэг нь Засгийн газрын тусгай сангууд байдаг. Тэдгээр сангууд нь улсын төсвөөс хуваарилсан хөрөнгийн үндсэн дээр тусгай зориулалтын үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилготойгоор төсвийн орлого болон бусад эх үүсвэрүүдийг хуримтлуулдаг. Олон тооны тусгай сангуудын дотор Байгаль орчин, уур амьсгалын сан мөн багтана. Түүнээс гадна, Тусгай сангийн жагсаалтаас хасахаас өмнө Цэвэр агаар сан болон Сэргээгдэх эрчим хүчний сан бас энд хамаардаг байсан.


Нэгдсэн төсвийн тухай 2011 оны хуулиар орон нутгийн засаг захиргааны үүрэг хариуцлага болон санхүүгийн эх үүсвэрийг өргөжүүлж өгчээ. Хуульд зааснаар, нийслэл хот болон 21 аймаг хот нь усан хангамж, бохирын үйлчилгээ, хог хаягдлыг цуглуулан зайлуулах зэрэг үйлчилгээ, мөн нийтийн тээвэр, хотын зам гүүрүүд, нийгмийн халамжийн үйлчилгээ зэрэг хотын аж ахуйн үйлчилгээг хариуцаж байна. Орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагааг орон нутгийн түвшний олон тооны татвар төлбөр болон улсын төсвийн хуваарилалтаас санхүүжүүлдэг. Энд хамгийн гол үүргийг Сангийн яамны захиран зарцуулдаг Орон нутгийн Хөгжлийн нэгдсэн сан (ОНХНС) гүйцэтгэдэг байна. Орон нутгийн хөгжлийн сангийн тухай хуулийн дагуу ОНХНС нь төрийн татварын орлого (НӨАТ-н 25 хувь, мөн 2015 оноос ашигт малтмал ашигласан төлбөрийн 5 хувь), болон бусад эх үүсвэрээс бүрдэнэ. ОНХНС-аас жил бүр хот, аймаг бүрийн орон нутгийн хөгжлийн санд төсвийг нь шилжүүлдэг байна. Хотын дэд бүтцийн төслүүдийг энэхүү сангийн хөрөнгөөр ихэвчилэн санхүүжүүлж, дэд бүтцийг сэргээн засварлах ажлыг голлон гүйцэтгэнэ. Жил бүрийн хөрөнгийн хуваарилалтын (тэгштгэсэн сан гэж нэрлэгдэх) хэмжээг Сангийн яам тодорхойлдог бөгөөд энэ шилжүүлэх хөрөнгийн хэмжээ олон тооны үзүүлэлтүүдээс, тухайлбал хүн амын тоо, хүн амын суурьшлийн нягтрал, газар зүйн байршил (алслагдсан байдал) болон нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин зэргээс хамаардаг байна. Орон нийтийн хөгжлийн санд 2015 онд нийт 105.9 тэрбум төгрөгийг (50 сая орчим доллар) шилжүүлсэн байна. Ерөнхийд нь аваад үзвэл, Засгийн газар ОНХНС-н шилжүүлэг дээр нэмээд ихээхэн хэмжээний санхүүгийн дэмжлэгийг орон нутгийн үйлчилгээ, дэд бүтцийн төслүүдэд үзүүлж байна. Тухайлбал, 2013 онд улсын төсвийн шилжүүлэгийг оролцуулахгүйгээр орон нутгийн засаг захиргаанд очсон хөрөнгө нь улсын нийт зарлагын 8.6 хувьтай тэнцэж байгаа бөгөөд хэрэв орон нутагт ноогдож байгаа хувийг нэмж тооцвол улсын салбарын нийт зарлагын 23 хувьтай тэнцэж байна.

Хүний хөгжлийн санг (ХХС) нь олборлох үйлдвэрлэлийн салбараас (байгалийн нөөц ашигласан татварын 65 хувь, мөн газрын тос, байгалийн хийн зөвшөөрлийн төлбөр) хуримтлал бий болгож “хар өдөрт” зориулан хадгалах, нийгмийн тусламж, тухайлбал тэтгэвэр, эрүүл мэндийн даатгал, хүүхдийн

мөнгө олгох зэрэг зорилгоор 2009 онд байгуулсан байна. Харин, тэдгээр арга хэмжээг 2016 оны 6 дугаар сараас шууд улсын төсвөөс санхүүжүүлж байна.

*Энэхүү бүлэгт хамаарах Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтууд*

Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх хөтөлбөрийн Зорилт 8.3, 8.4, 12.7, 12.с –ийн хэрэгжилт Монгол улсад ямар байгааг Шигтгээ 3.1-д харуулав.

	<p>Шигтгээ 3.1: Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030-ийн Зорилт: 8.3, 8.4, 12.7 and 12.c</p>	
<p><b><u>Зорилго 8: Хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих, нийт хүн амыг бүрэн, үр бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлт, зохистой ажлын байраар хангах</u></b></p>		
<p>Ногоон өсөлт нь эдийн засаг болон байгаль орчны харилцан шүтэлцээнд төвлөрч, тогтвортой хөгжлийн салшгүй хэсэг болно. Ногоон өсөлтийн зорилго нь “ байгалийн нөөц баялаг, байгаль орчны үйлчилгээ нь бидний сайн сайхан амьдралыг тэтгэгч нөөц байхын зэрэгцээ эдийн засгийн өсөлт, хөгжлийг бэхжүүлэхэд” оршино. Эдийн засгийн өсөлт болон байгаль орчныг хамгаалах тэнцвэрийг хангах замаар ногоон хөгжилд шилжих зам нь уян хатан, эрчимтэй эдийн засгийн орчинд амжилтад хүрнэ. Үүний зэрэгцээ эдийн засгийн тогтвортой хөгжил нь нийт хүн амыг хамарсан байх ба тухайлбал баялагын хуримтлалыг мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр бүх хүн амд шударгаар хуваарилна.</p>		
<p><b><u>Зорилт 8.3: Үйлдвэрлэл бизнесийг хөгжүүлэх, зохистой ажлын байр бий болгох, бүтээлч сэтгэлгээ болон инновацийг дэмжихэд чиглэгдсэн хөгжлийн бодлого, санхүүгийн үйлчилгээнд хамрагдах замаар бичил, жижиг, дунд аж ахуйн байгууллагуудыг албажуулах, өсөлтийг хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх</u></b></p>		
<p>Зорилго 8.3-н дэлхийн шалгуур үзүүлэлтүүдэд хөдөө аж ахуйн бус салбарын албан бус ажил эрхлэлтийн эзлэх хувь, хүйсийн эзлэх хувьд (Шалгуур үзүүлэлт 8.3.1) хамааралтай. ОУХБ-ын тодорхойлолтоор албан бус секторын ажил эрхлэлт гэдэг нь үйлдвэрлэл, үйлчилгээг хөдөө аж ахуйгаас бусад салбарт эрхлэж байгаа хувь хүмүүс эсвэл бүлэг хүмүүс албан бус бүтэцтэй, албан ёсны бүртгэл болон нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил эрхлэгчдийг хэлнэ. ҮСХ-ын газраас ажиллах хүчний талаар явуулсан судалгаагаар, 2012 оны байдлаар Монгол улсад 174,500 хүн албан бус секторт ажиллаж байгаагын 44 хувь нь Улаанбаатар хотод байна. 15-аас дээш насны бүх иргэдийн 9.6 хувь нь албан бус секторт ажиллаж байна; мөн эдийн засагт ажиллаж байгаа хүмүүсийн 25.4 хувьтай (хөдөө аж ахуй, ойн аж ахуйгаас бусад) тэнцэж байна. Энэ нь Монгол улсын хувьд албан бус сектор нь эдийн засгийн өсөлтийн нэг хөдөлгөгч хүч, нийгэм, эдийн засгийн амьдралд оролцогч нь байна. Үүнээс үзэхэд, Засгийн газар хувиар аж ахуй эрхлэгчид болон эдийн засгийн өсөлтийг хангах стратеги хэрэгжүүлж, одоогийн албан бус хөдөлмөр эрхлэлтийн албажуулах, нийгмийн хамгаалалыг нь сайжруулах зохицуулах арга хэмжээ авах шаардлагатай байна.</p>		
<p><b><u>Зорилт 8.4: 2030 он хүртэл дэлхийн нөөцийн хэрэглээ болон үйлдвэрлэлийн үр ашгийг давшингүй сайжруулах, тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн 10 жилийн суурь хөтөлбөрүүдийн хүрээнд байгаль орчноос эдийн засгийн өсөлтийн хамаарлыг бууруулах арга хэмжээ авах, үүнд хөгжингүй орнууд тэрүүлэх үүрэг гүйцэтгэх</u></b></p>		
<p>Ногоон өсөлт, тогтвортой хөгжлийн бас нэг чухал хэсэг бол хэрэглээ болон үйлдвэрлэлд эдийн засгийн өсөлтийг байгаль орчны доройтлоос хамааруулахгүй авч үзэж нөөц баялагын үр өгөөжтэй ашиглалтыг давшингүй сайжруулах хэрэгтэй.</p>		
<p>Монгол улсын хувьд ч эл асуудал сорилт болж байгаа ба эдийн засаг нь эрчим хүчний өндөр хэрэглээтэй, нүүрс төрөгчийн ялгарал их, материаллаг бүтээмж ийн түвшин доогуур байна. Цахилгаан, дулааны хэрэглээ болон үйлдвэрлэлийн үр ашиг, материалын ашиглалтыг сайжруулахын тулд судалгаа, боловсруулалтад оруулах хөрөнгө оруулалт, технологийн инновацийг нэвтэрүүлэх, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх шаардлагатай байна. Эдгээр асуудлаар гарч байгаа ахиц хөгжилыг хэмжих болон бусад ногоон үзүүлэлтүүдийг хэмжих найдвартай статистикийг боловсруулах нь бас сорилт болж байна. Ногоон үзүүлэлтүүдийн статистикийг боловсруулах ажил дээр ҮСХ ажиллаж байна.</p>		

Энэ ажлыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд Үндэсний статистикийн газарт хангалттай хөрөнгө болон техникийн тусламж үзүүлэх хэрэгтэй байна. Жижиг нээлттэй эдийн засаг бүхий Монголын хувьд гол нь ногоон технологийг импортлох хангалттай хөрөнгийн эх үүсвэрийг гаргаж, тэдгээр импортолсон технологийг хөрсөндөө буулган шингээх дотоодын чадавхийг бий болгох шаардлагатай байна.

**Зорилго 12: Хариуцлагатай, тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийг дэмжих**

**Зорилт 12.7: Үндэсний бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төрийн тогтвортой худалдан авалтын үйл ажиллагааг хөгжүүлэх**

Засгийн газрын хувьд хариуцлагатай тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийг бэхжүүлэх, илүү ногоон төрийн худалдан авалтын төлөвшилийг тогтооход туслаж чадах юм. Монгол улс одоогоор байхгүй байгаа эрх зүйн хэрэгсэл болон практик ур чадварыг эдгээр асуудлаар бий болгох шаардлагатай байна.

**Зорилт 12.с: Малтмал түлшний үр ашиггүй татаасыг оновчтой болгох, үндэсний нөхцөл байдалтай уялдуулан зах зээлийн тэнцвэргүй байдлыг арилгах, татварын тогтолцоог шинэчлэх, ашиггүй хөнгөлөлтөөс татгалзах замаар үр ашиггүй зарцуулалтыг бууруулах, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзах, ингэхдээ хөгжиж байгаа орнуудын онцгой нөхцөл байдал, хэрэгцээг анхаарах, ялангуяа ядуу болон эмзэг бүлгийнхний хамгаалалд сөргөөр үйлчлэх нөлөөллийг багасгах**

Тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийг бэхжүүлэхийн тулд аажмаар малтмал түлшинд олгож байгаа татаасын хэмжээг бууруулах, яваандаа бүрмөсөн зогсоох нь зүйтэй юм. Монголын хувьд ноцтой тавигдаж байгаа асуудал бол ялангуяа түүхий нүүрсээр галладаг цахилгаан станцуудад олгож байгаа татаас болон бензин, дизельд ногдуулж байгаа онцгой татварын хэмжээ бага байгаа асуудлыг нэг тийш нь шийдэх шаардлагатай байгаа бөгөөд одоогийн байдлаар энэ нь автомашины шатахууны оновчтой хэрэглээг дэмжих хөшүүрэг болж чадахгүй байна.

### 3.6 Үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж

#### Үнэлгээ

Агаарын бохирдолын эх үүсвэрийн хэвшмэл хэрэглээг өөрчилөхөд чиглэсэн эдийн засгийн урамшууллын үр дүнтэй хөшүүргийг бий болгох асуудалд төдийлөн ахиц гараагүй байна. Агаарын бохирдол үүсгэгч үндсэн дөрвөн хүчин зүйл, тухайлбал, түүхий нүүрс, органик бохирдол, утааны ялгарал ба автомашинд ноогдуулах татварын хэмжээ хэтэрхий бага байгаа нь агаарын бохирдолыг бууруулахад нөлөөлж чадахгүй байна. Автомашины утаанд ноогдуулах татварын хувьд утааг хэмжих шаардлагатай багаж хэрэгсэлийг байршуулаагүй байгаа тул үр дүнтэй хэрэгжиж чадахгүй байна. Агаарын бохирдолтой тэмцэх татварыг ноогдуулах болсон гол зорилго нь хуримтлагдсан хөрөнгийг улсын төсөвт түр байршуулж, улмаар одоо үйл ажиллагаа нь зогсоод байгаа Цэвэр агаар санд шилжүүлэхэд оршиж байсан байна. 2012 онд ус бохирдуулсаны татварыг ноогдуулах шийдвэр гарсан боловч үүнийг хэрэгжүүлэх журмыг мөрдөж эхлээгүй байна.

Үүний нэг адил, автомашины шатахуун түлшинд ноогдуулах онцгой албан татварыг бензин болон дизель түлшний оновчтой хэрэглээг нэвтрүүлэх хэрэгсэл бус харин тэдгээр бүтээгдэхүүний дотоодын жижиглэнгийн үнийг тогтворжуулах хэрэгсэл болгосон нь импортын үнийг хөөрөгдөхөд хүргэж улмаар төгрөгийн ханшийг сулруулахад хүргэжээ. Эл байдал нь улмаар онцгой албан татварыг ямар нэг байдлаар тэглэхэд хүргэсэн нь улсын төсвийн орлогод сөргөөр нөлөөлж байна. Харин суудлын авто машины импортын татварын хувьд ухаалаг өөрчлөлт оруулж, хуучин машинд ноогдуулах татварыг өсгөж, эко машинуудыг татвараас чөлөөлжээ.

Эрдэс баялгын нөөц ашигласны роялти нь улсын төсөвт нэлээд хэмжээний орлого оруулж, түүнийг тодорхой хэсгийг орон нутгийн Хүний хөгжлийн санд нийгмийн халамж, хамгааллын санхүүжилтээр шилжүүлж байна. Нөөц ашигласны нэмэлт татвар нь эрдэс баялагыг дотооддоо боловсруулах үр дүнтэй урамшууллын хөшүүрэг болж чадаж байгаа эсэхийг харах л үлдэж байна.

Ногоон хөгжлийн бодлогын гол онцлог чанар бол байгалийн баялагыг (жишээ нь экосистем) ард иргэдийн амьдарлыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэх хүчин зүйл гэж хүлээн зөвшөөрөх явдал юм. Байгалийн нөөц баялагын (тухайлбал ой, ус г.м) мөнгөн үнэ цэнээр илэрхийлэх үнэлгээ хийх аргачлалыг

Монгол улс боловсруулан хэрэглэж байгаа бөгөөд түүнийг байгаль орчинд учруулсан хохиролын нөхөн төлбөрийг тооцох жишиг болгон ашиглаж байна. Тэдгээр үнэлгээнд хэсэгчилсэн өөрчлөлтүүдийг оруулснаар байгалийн тэдгээр баялгын үнэ цэнийг нэлээд өсгөсөн байна. Гэхдээ, тэдгээр баялагын үнэ цэнийг чухам ямар арга замаар тогтоосон нь төдийлөн ил тод биш байгаа учир талархан хүлээн авахад бэрхшээлтэй байна. Үүний нэг адил, байгалийн тодорхой төрлийн олон тооны нөөц баялагийг (гулин, ургамлын нөмрөг, амьтаны аймаг) ашигласаны төлбөр хураамжийг орон нутгийн захиргааны түвшинд тогтоож байна. Экосистемийн үйлчилгээний үнэлгээний асуудал гол бэрхшээл хэвээр байна.

Ахуйн үйлчилгээний тухайд (усны хангамж болон бохир ус; хотын хог хаягдлыг зайлуулах; эрчим хүчний хангамж) учирч байгаа бэрхшээл сорилт бол байгаа нөөц боломжийг оновчтой ашиглахын тулд өртөг зардлыг тооцсон тариф тогтоох болон үйлчилгээ үзүүлэгчдийн санхүүгийн хувьд оршин тогтох чадварыг хангах чиглэлд цаашид ч үргэлжлүүлэн ажиллах явдал болж байна. Үйл ажиллагаа болон засвар үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх орлогын эх үүсвэр хүрэлцэхгүй байгаагаас тэдгээр үйлчилгээг орон нутгийн болон улсын төсвийн татаасаар санхүүжүүлэхэд хүргэж байна.

Хэдийгээр боломжийн тариф тогтоосон ч асар их нөөц боломжтой сэргээгдэх эрчим хүчийг ашиглах асуудал бэрхшээл сорилт хэвээр байна. Энэхүү дэмжлэгийн тарифийн тогтолцоо нь эцсийн хэрэглэгчийн хувьд илүү ил тод байх нөхцлийг бүрэлдүүлж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн ашиглалт нэмэгдэх болно. Ногоон технологийг өргөжүүлэх үүднээс татаасын зарим нэг төлөвлөгөө боловсруулсан боловч хамрах хүрээ нь хязгаарлагдмал бололтой.

Үндэсний хөгжлийн бодлогын гол зорилт нь эдийн засгийн ногоон хөгжлийг хангах явдал боловч үүнтэй холбогдон гарах олон тооны саад бэрхшээл зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт өртөг зардлын тооцоог гаргаагүй байна. Байгаль орчныг хамгаалах зардлууд болон үүнтэй холбоотой үндэсний хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх асуудал үндсэндээ улсын төсвийн жилийн хувиарлалт болон гадаадын зээл тусламжид тулгуурлаж байна. Орон нутгийн засаг захиргаа байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг байгаль орчны холбогдол бүхий орлогоор санхүүжүүлж болох боловч бодит байдал дээр эл зориулалтаар зарцуулсан хөрөнгийн хэмжээ тусгасан хөрөнгийн багахан хэсгийг эзлэж байгаа нь тухайн хөрөнгийг байгаль хамгаалахаас өөр зориулалтаар ашиглаж байгааг харуулж байна. Хотын дэд бүтцийн асуудалд, тухайлбал хог хаягдлыг зайлуулах, усны хангамж, бохирын үйлчилгээнд, ялангуяа бохир усыг цэвэршүүлэхэд оруулж байгаа хөрөнгө оруулалтын тухай мэдээлэл хомс байна.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн хөрөнгөөр байгаль орчныг хамгаалах үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд зориулсан санхүүжилт хангалтгүй хэвээр байгаа нь уг Сан байгаль орчныг хамгаалахад үзүүлж байгаа нөлөө туйлын хангалтгүй байгааг харуулж байна. Байгаль орчин, уур амьсгалын сангаас санхүүжүүлсэн арга хэмжээний жилийн тайлан байхгүй байна. Төсвийн хатуу бодлого явуулах шаардлага нь эргээд байгаль орчныг хамгаалах зориулалтаар жилийн төсвийн хөрөнгө хуваарилалтад сүүлийн жилүүдэд сөрөгөөр нөлөөлсөн байна. Үүний зэрэгцээ, хотын агаарын бохирдолыг бууруулах арга хэмжээ авах зорилгоор 2010 онд байгуулсан Цэвэр агаар санг 2015 онд татан буулгасан байна.

Монгол улсын эдийн засгийн чухал хэсэг болох уул уурхайн салбарын хувьд, компаниуд уурхайн хаалтын дараа уурхайн нөлөөнд өртсөн газруудад нөхөн сэргээлтийг зохих ёсоор хийх үүрэг хүлээдэг. Харин уурхайг хаахаас өмнө эл зорилгод зарцуулахаар компаниуд жил бүр хэдий хэмжээний хөрөнгийг тусгайлан гаргаж байгаа нь эргэлзээтэй байгаа бөгөөд уул уурхайн үйлдвэрлэлийн сайн практикийн дагуу бол энэ хөрөнгө нь эвдэрсэн газрыг сэргээх, биологийн нөхөн сэргээлт хийхэд хангалттай байх ёстой байдаг.

Хотын ахуй үйлчилгээний, тухайлбал хог хаягдалын менежмент, усны хангамж, бохирын үйлчилгээний санхүүжилт болон үйл ажиллагаанд нь ТХХТ –ийн оролцооны төсөл хязгаарлагдмал байгаа нь тухайн үйлчилгээнд тогтоосон зохицуулалт бүхий хураамж бага байгаа нь ТХХТ-ийн арилжааны чадварт сөрөгөөр нөлөөлж байгаагийн үр дагавар юм. Түүнчилэн, тэдгээр төслүүдэд үр дүнтэй хяналт шаардлагатай байдаг боловч орон нутгийн захиргааны зүгээс тийм төслүүдэд оролцох чадавхи сул байна.

Төрийн өмчөөр хийх худалдан авалтын эрх зүйн орчин сайжирч, олон улсын сайн практикт улам бүр ойртож байна. Гэхдээ бараа үйлчилгээ худалдан авах тендерийн баримт бичигт байгаль орчин болон



нийгмийн шалгуурыг “тогтвортой худалдан авалт” тусган оруулах хуулийн заалт одоогоор байхгүй байна.

Байгаль орчныг хамгаалах зардлын статистик дүн шинжилгээ хэр бодит болох нь эргэлзээтэй хэвээр байгаа нь зөвхөн мэдээ мэдээлэл хомс төдийгүй Монгол улс олон улсын Байгаль орчныг Хамгаалах үйл ажиллагааны Ангилал (БХҮА) зэрэг байгаль орчныг хамгаалах зардлыг хэмжих, тайлагнах цогц аргачилалыг батлан хэрэгжүүлээгүй байгаатай холбоотой байна. Үүнтэй холбогдол бүхий статистикийн бас нэг саад бэрхшээл бол ногоон эдийн засгийг хөгжүүлэх зорилгод хүрэхийн тулд ямар ахиц дэвшил гарч байгааг тодорхой үзүүлэлтүүдээр, тухайлбал бодит бүтээмжээр хэмжих явдал бөгөөд илүү ерөнхий утгаар нь авч үзвэл байгаль орчны чанарыг доройтуулах замаар эдийн засгийн өсөлтийг хангаж байгаа эсэх нь асуудал юм.

*Дүгнэлт, зөвлөмж*

#### Байгаль орчинтой холбоотой татвар, хөнгөлөлт

Байгаль орчныг бохирдуулсаны төлбөр төлөх зарчмыг Монгол улсад үр дүнтэй нэвтрүүлээгүй байна. Агаарын бохирдолын татвар нь билэгдлийн чанартай байгаа бөгөөд гол нь засгийн газрын орлого босгоход чиглэж байна. Агаарын бохирдолын татварын хэрэгсэлийг хэрэгжүүлэхэд саад учруулж байгаа бас нэг зүйл нь агаарын бохирдолд нөлөөлж байгаа утааг хэмжих зохих хэрэгсэл дутагдаж байна. Ус бохирдуулсаны татварыг хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм журмыг батлах асуудал хүлээгдсээр байна. Байгаль орчны холбогдол бүхий татварууд, тухайлбал бензин, дизель түлшний онцгой албан татвар нь байгаль орчныг хамгаалах зорилгод төдийлөн чиглэгдэхгүй байна. Түүнээс гадна, саяхан нийгмийн шахалтаар эдгээр татварыг бараг тэглэснээр улсын төсөвт дорвитой орлого ч төвлөрөөгүй байна. Ерөнхийдөө, Монгол улсад малтмал түлшний хэрэглээнд олгож байгаа татаас нүүрсний хэрэглээг мөн хамарч байгаа нь эдгээр баялагийн хэрэглээнээс бий болох хог хаягдалаас урьдчилан сэргийлэх үүднээс ТХЗ-ын Зорилго 12.с –тай нийцүүлэн бодлогодоо шинэчлэл хийх шаардлагатай байна.

#### Зөвлөмж 3.1:

*Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Байгаль орчин бохирдуулагч компаниудын үйл ажиллагаанд өөрчлөлт хийх үүднээс агаарын бохирдолын татвар үр дүнтэй байх нөхцлийг хангах;*
- (b) *Бензин, дизель түлшний импортын татвар, түүнчлэн тэдгээр бүтээгдэхүүнийг хэмнэх үйл ажиллагаа болон цэвэр түлш импортлох, хэрэглэх явдлыг дэмжихэд чиглэсэн онцгой татварын хэмжээнд өөрчлөлт оруулах;*
- (c) *Үйлдвэрийн газрууд болон айл өрхөд олгож байгаа нүүрсний татаасны хувьд шинэчлэл хийх асуудлыг вч үзэх.*

#### Байгалийн нөөц ашигласаны төлбөр

Байгалийн нөөц ашигласаны төлбөрийг (ой; ургамал; ан агнуур; ус) ихэвчлэн эдийн засаг, экологийн хүрээний үзүүлэлтүүдийг харгалзан үзсэний үндсэн дээр нөөц баялагын мөнгөн үнэ цэний үнэлгээгээр тогтоож, харин инфляцид зохицуулан өөрчлөөгүй байна. Тэдгээр суурь үнэлгээг гол нь байгалийн нөөцөд учруулсан хохиролын хэмжээ болон хуулиар тогтоосон стандартыг зөрчсөний нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход ашиглана. Байгалийн нөөц ашигласны хураамж бол суурь мөнгөн үнэлгээний тодорхой хувь бөгөөд түүний тодорхой хэсэг нь орон нутгийн захиргаанд үлдэж байна.

#### Зөвлөмж 3.2:

*Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Байгалийн нөөцийн тогтоосон суурь үнэлгээнд тогтмол өөрчлөлт оруулж байх;*
- (b) *Байгалийн нөөц баялагын мөнгөн суурь үнэлгээг хийж байгаа одоогийн аргачилалыг инфляцийн түвшинтэй уялдуулан тогтмол хянан өөрчилж байх.*



### Олон нийтийн үйлчилгээ

Ахуйн үйлчилгээний салбарын үйл ажиллагааны санхүүгийн тогтвортой байдлыг хангах асуудал Монгол улсад ихээхэн бэрхшээлтэй байгаа бөгөөд энэ нь одоогийн мөрдөж байгаа тарифууд нь зардлаа нөхөж чадахгүй байгаатай холбоотой. Эл байдал нь тухайн салбар татаас болон орон нутаг, улсын төсвийн санхүүжилтээс хамааралтай байхад хүргэж байна. Нийтлэг тохиолдож байгаа асуудал бол засвар үйлчилгээ болон дэд бүтцийг шинэчлэхэд хүрэлцээтэй хөрөнгө санхүү хомс байна. Усан хангамж болон эрчим хүчний тариф нь тэдгээр нөөцийг оновчтой ашиглах хөшүүрэг болж чадахгүй байна. Тогтоосон тариф нь зардлаа нөхөж чадахгүй байгаа нь хувийн хэвшлийн зүгээс тэдгээр үйлчилгээнд идэвхитэй оролцоход нь саад тоггор болж байна.

#### Зөвлөмж 3.3:

*Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Өртөг зардлыг нөхөхөд чиглэсэн тарифын аргачилалыг боловсруулан хэрэгжүүлэх;*
- (b) *Тоолуур (гол нь усны) тавих ажлыг дэмжиж, тоолуурын заалтыг цуглуулах ажлын хөлсийг тооцох ажлыг сайжруулах;*
- (c) *Хотын хог хаягдлыг зайлуулахтай холбогдуулан хогийн цэгийн бие даасан татвартай болох;*
- (d) *Төлбөрийн чадваргүй ядуу иргэдийн асуудлыг шийдвэрлэхэд туслах нийгмийн зорилтот арга хэмжээ боловсруулах.*

### Байгаль хамгаалах ажлын санхүүжилт

Монгол улс ногоон хөгжлийн бодлого, болон байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, тухайлбал ус, ой болон тусгай хамгаалалтай газрын бие даасан үндэсний хөтөлбөрүүдийг батлан гаргасан байна. Тэдгээр бодлого, хөтөлбөрийн санхүүжилт гол нь жил бүрийн улсын төсвийн хувиарлалт болон гадаадын зээл тусламжид тулгуурлаж байна. Орон нутгийн засаг захиргаа өөрсдийн төсөвт хуваарилагдсан зориулалтын хөрөнгийг байгаль орчны асуудлыг санхүүжүүлэхэд зарцуулж байгаа боловч хувиарлсан хөрөнгө шаардлагатай бодит зардалд хүрэлцэхгүй байна. Ерөнхийдөө улсын салбараас байгаль орчныг хамгаалахад тун бага хөрөнгө зарцуулж байгаа нь улсын салбар ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд үр дүнтэй үүрэг гүйцэтгэнэ гэдэг нь эргэлзээ төрүүлж байна.

#### Зөвлөмж 3.4:

*Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Байгаль орчны салбарт хуваарилж байгаа хөрөнгө нь дэвшүүлсэн хөгжлийн бодлогыг, тухайлбал Монгол улсын Тогтвортой Хөгжлийн Зорилтууд 2030, Ногоон хөгжлийн бодлого болон байгаль орчныг хамгаалах үндэсний хөтөлбөрүүдэд тодорхойлсон зорилтууд болон үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгөтэй дүйцэж байх;*
- (b) *Улсын хөрөнгийн нөөц хязгаарлагдмал байгаа нөхцөлд тэргүүлэх ач холбогдол бүхий зорилтуудыг тодорхойлох;*
- (c) *Байгаль орчин болон байгаль хамгаалахад хуваарилаж байгаа хөрөнгийг орон нутгийн засаг захиргаа үр дүнтэй ашиглах.*

### Уул уурхайн газрын нөхөн сэргээлт

Монгол улсын эдийн засгийн гол салбар нь уул уурхай байна. Гэвч уул уурхай нь байгаль орчинд дарамт үүсгэх гол эх үүсвэр болж байна. Уурхайг хаасны дараа эвдэрсэн газрыг нөхөн сэргээх болон байгаль орчны нөхөн сэргээлт хийх ажлыг зохих ёсоор хийх санхүүгийн нөөцийг бүрэлдүүлэх нь уул уурхайн компаниудын үүрэг байх ёстой. Гэхдээ тэдгээр сан, эх үүсвэр нь шаардлагатай бүх ажлыг олон улсын уул уурхайн сайн туршлагын хэмжээнд хийж гүйцэтгэхэд хангалттай эсэх нь эргэлзээтэй байна.

#### Зөвлөмж 3.5

*Засгийн газарын зүгээс уул уурхайн бүх компани, нэн ялангуяа төрийн өмчит компаниуд, бодит өртөг зардалд суурилсан нөхөн сэргээлтийн цогц төлөвлөгөө боловсруулж, тэдгээр компанийн санхүүгийн*

тайланд Олон улсын Санхүүгийн тайлагнах стандартын дагуу нөхөн сэргээлтийн зардлыг тусгадаг байх арга хэмжээ авч мөрдүүлэх хэрэгтэй.

#### Байгаль орчны өртөг зардал, ногоон өсөлтийн статистик

Үндэсний Статистикийн газраас байгаль орчны холбогдол бүхий статистикийн мэдээллийг гарган тарааж байна. Тэдгээр статистик мэдээнээс харахад улсын салбарын зүгээс байгаль орчны салбарт гаргасан хөрөнгө зардал нарийвчлан тооцоогүй, бүрэн бус байна. Түүгээр ч үл барам, статистик мэдээнд хэрэглэсэн аргачлалын тухай мэдээлэл дутагдаж байгаа нь түүний үр ашиг, хэрэглээг бууруулж байна. Зарим газарт, тухайлбал агаарын бохирдолыг бууруулах арга хэмжээнүүдийн зардалыг огт тусгаагүй байна. Мөн байгаль орчныг хамгаалах зардлын хэсэгт уул уурхайн үйлдвэрүүдийг хамруулаагүй орхижээ. Үндэсний статистик мэдээг олон улсын статистиктай харьцуулах боломжийг олгох байгаль орчны зардлын олон улсын ангилалыг ҮСХ хэрэгжүүлээгүй байна. Ногоон хөгжлийн үзүүлэлтүүдийг тодорхойлох статистик мэдээлэл боловсруулах явдал ихээхэн саад бэрхшээлтэй тулгарч байна. Энэ нь байгаль орчин болон нөөцийн бүтээмж хэрхэн сайжирч байгаагийн шалгуур үзүүлэлт болж, эдийн засгийн ямар өсөлт байгаль орчны чухам ямар доройтлоос болж буурсаныг тогтоох боломж олгодог (ТХЗ: Зорилго8.4). ҮСХ 2017 оны 7 дугаар сард ногоон хөгжлийн 38 шалгуур үзүүлэлтүүдийг баталж эхний алхамаа хийсэн байна.

#### Зөвлөмж 3.6

*Үндэсний Статистикийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Олон улсын хэмжээнд одоо мөрдөж байгаа Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа болон Зардалын ангилалд (СЕРА) суурилсан байгаль орчны өртөг зардлын статистикийн мэдээллийн тогтолцоог боловсруулах;*
- (b) *Эдийн засгийн өсөлтийг ногооруулах үйл явцад гарч байгаа дэвшил болон тэдгээрийг шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчдад хүргэхэд гарч байгаа ахиц дэвшлийг үнэлэх үзүүлэлтүүдийг тодорхойлох, мэдээлэл цуглуулах арга зүйг боловсруулах;*
- (c) *Тодорхой асуудлаар шийдвэр гаргахдаа статистик мэдээллийг ашиглах, түүнд дүн шинжилгээ*

## Бүлэг 4

# БАЙГАЛЬ ОРЧНЫ МОНИТОРИНГ БА МЭДЭЭЛЭЛ

### 4.1 Байгаль орчны мониторинг

#### Мониторингийн сүлжээ

##### Агаар

Агаарын чанарт мониторинг хийх анхны хоёр станцыг Улаанбаатарт 1977 онд байгуулжээ. Дараа нь 1979 онд дөрвөн станц, 1980-аад онд дахин 13 станц, 1990-ээд онд гурван станц, 2000-2010 онд 11 станц, 2011 онд гуравыг нэмж байгуулсан байна. Цаг уур, орчны шинжилгээний газраас үйл ажиллагааг нь хариуцдаг Агаарын чанарын мониторингийн улсын сүлжээ 2017 оны байдлаар мониторингийн 36 станцтай байна. Гэхдээ, Дарханы нэг станц ажиллахгүй байгаа учир нийт 35 станц ажиллаж байна. Тэдгээр 35 станцаас зөвхөн 6 нь автомат бөгөөд бүгд Улаанбаатар хотод ажиллаж байна (Хүснэгт 8.2). Тэдгээр автомат станцыг 2010 онд олон улсын хандивлагчдын дэмжлэгээр байгуулж, 24 цагаар тасралтгүй 5-6 төрлийн агаар бохирдуулагчид хэмжилт мониторинг хийж байна. Агаарын чанарын тухай мэдээллийг Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн Байгаль орчин мэдээллийн сангаас авч болно (<http://www.eic.mn/>).

Монгол улсад шороон шуурганы мониторингийн 10 автомат станц ажиллаж байна.

Агаарын чанарын индексийг агаарын бохирдол хүний эрүүл мэндэд хэр эрсдэлтэй эсвэл хор хүргэх түвшинг тодорхойлоход ашигладаг. Энэ индекс нь хүхэрийн исэл ( $\text{SO}_2$ ); азотын давхар исэл ( $\text{NO}_2$ ); агаар дахь нарийн ширхэгт тоосонцор  $\text{PM}_{10}$ ,  $\text{PM}_{2.5}$ ; нүүрстөрөгчийн хий ( $\text{CO}$ ); болон озон ( $\text{O}_3$ ) зэрэг үзүүлэлтээс бүрдэнэ. Агаарын чанарын индексийг автомат станцуудын бичлэгийг ашиглан гаргадаг бөгөөд эдгээр бичлэг интернетэд олон нийтэд нээлттэй (<http://agaar.mn/index>) байдаг байна. Энэ вэб хуудсанд агаарын бохирдлыг бууруулахад нийгмийн янз бүрийн давхаргын оролцоотойгоор хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг мөн байршуулсан байна. Түүнчилэн, GooglePlay болон iTunes аппликайшн-ээс гар утасаараа татан авч Улаанбаатарын янз бүрийн байршлуудад агаарын чанарын индекс ямар байгааг харж болно. Мөн тооцооны өөр аргачилалыг хэрэглэдэг агаарын чанарын өөр хэд хэдэн индексүүд байдаг. Харин агаарын чанарын автомат мониторингийн станцуудын яг тухайн үеийн бодит мэдээллийг авч болох агаарын чанарын индексүүд нь зөвхөн Улаанбаатар хотод боломжтой байгаа юм (Хүснэгт 8).

Агаарын чанарын статистик мэдээллийг сар бүр гаргаж Үндэсний статистикийн хороонд хүргүүлэн, тэр нь өөрийн вэб хуудсаар дамжуулан олон нийтийн хүртээл болгодог байна (<http://www.1212.mn>). Цаг уур, орчны шинжилгээний газар (ЦУОШГ) агаарын чанарын тухай жилийн тайлан илтгэлийг үндэсний мониторингийн сүлжээний мэдээллийг ашиглан гаргадаг. Тайлан илтгэлийг <http://www.agaar.mn>, болон <http://www.tsag-agaar.mn> Вэб хуудсуудад байршуулж нийтийн хүртээл болгож байна.

##### Гадаргын ус

ЦУОШГ нь нуур, голын усны чанар болон хотын бохир хаягдал усны нөлөөлөлийг тодорхойлох зорилгоор байнгын мониторинг хийж байна. Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн нь мониторингийн мэдээллийг ЦУОШГ-ээр дамжуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлдэг байна. Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн нь гадаргын усны түвшин, гол мөрөн, нуурын усны температур, чанарт мониторинг хийхийн зэрэгцээ голын урсацад мониторинг хийдэг. Монгол улсад гадаргын усны мониторингийн 191 станцыг 94 гол, 18 нуур дээр байрлуулан ажиллаж байна.

Усны чанарт сар тутам, усны түвшин болон температурт өдөрт хоёр удаа хэмжилт хийж байна. Ажиглалтын үзүүлэлтүүд нь: усан орчны рН, температур (t), цахилгаан дамжуулах чанар (EC),  $\text{O}_2$ ,

жинлэгдэх хатуу бодис (SS); нитритийн бодисууд ( $\text{NH}_4$ ,  $\text{NO}_2$ ,  $\text{NO}_3$ , P); ууссан бодис (ууссан хүчилтөрөгч (DO), биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (BOD), химийн хэрэгцээт хүчилтөрөгч (COD); үндсэн ионууд (нийт ууссан хатуу бодис (TDS), Fe); болон хүнд металлууд (Cu, Cr, Pb, Zn, Mn, Cd) байна. Усны чанарын мониторингийг олон улсын (ISO) болон үндэсний (MNS) стандартын дагуу хийж байна. Нийтдээ 22 лабораторид тодорхой үзүүлэлтүүдийн шинжилгээ хийдэг байна.

Аймгуудын хувьд, хаягдал ус цэвэрлэх 20 байгууламжаас гарч байгаа усанд 40 цэгт хяналт тавьж байна. Улаанбаатарт 7 цэвэршүүлэх байгууламжид байрлах оролт, гаралтын 15 хяналтын цэг (тэдгээрийн 7 нь гаралтын хяналтын цэг) ажиллаж байна.

Усны чанарын мониторингийн мэдээллийг сар бүр боловсруулж, жилийн тайланг <http://www.tsag-agaar.mn> вэб хуудсаар олон нийтийн хүртээл болгож байна. Хэдийгээр сайн бүтэц бүхий мэдээллийн сан <http://www.eic.mn> вэб хуудсанд байгаа ч гэсэн усны мониторингийн бодит мэдээллийг олж авахад бэрхшээлтэй, зарим мэдээлэл байхгүй байна. Гэвч энэ санд хяналтын станцуудын байршил зэрэг ихээхэн хэмжээний туслах чанарын мэдээлэлүүд агуулагдаж байна.

### Гүний ус

Монгол улсад баталгаажсан гүний усны орд газар, ус ашиглаж болох газар олон байгаагаас 25 нь ундны усны орд, бусад нь үйлдвэрийн болон уул уурхайн зориулалтаар ашиглах боломжтой орд байна. Гүний мониторингийн 193 худаг (цооног) байгаагийн 15 нь тасралтгүй мэдээлэл өгч байх 28 автомат станц байна. Тэдгээр 28 худаг, цооногийн 10-г нь уул уурхайн компаниудад, 3-г нь Улаанбаатар хотод ундны усны зориулалтаар, 2-г нь стартегийн уул уурхай газарт ажилуулж байна. Бусад гүний худгууд нь гар ажиллагаатай бөгөөд ундны усны худагт сард нэг удаа, үйлдвэрлэлийн ашиглалтын усанд улиралд нэг удаа мониторинг хийж байна. Ундны усны хяналтын хувьд: усны түвшин, даралт, рН, температур, болон цахилгаан дамжуулах чадвар зэрэг үзүүлэлтүүдэд анхаарал төвлөрүүлдэг байна. Үйлдвэррийн ашиглалтын усны хувьд, мөн дээрх мэдээллийг гаргадаг, гэхдээ хүнд метал болон нитритийн шинжилгээ нэмж хийж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд газрын доорх усны мониторингийн систем ажиллаж, ажиллагсад нь гүний худгууд болон зарим нэг үйлдвэрийн газруудаас усны температур болон түвшингийн хэмжилтийн хамгийн сүүлийн ажиглалтын мэдээллийг авч, мэдээллийн санд автоматаар оруулж байна. Хэрэв гүний усны түвшин байвал зохих стандарт түвшинээс доош орох үед Баягаль орчин, аялал жуулчлалын яам анхаарал хандуулж, холбогдох шаардлагатай арга хэмжээ авах талаар компаниудтай зөвлөлддөг байна.

### Цэвдэгт хөрс болон мөсөн голууд

Өнөөдрийн байдлаар цэвдэгт хөрсний 100 гаруй гүний худаг дээр мониторингийн цэгийг хэд хэдэн байгууллагууд байгуулан ажиллуулж байна. Монголд байгаа таван мөсөн гол дээр зургаан автомат ажиглалтын станц ажиллаж байна. Мөсөн голуудын байдалд эрдэм шинжилгээний байгууллагууд үе үе үнэлгээ хийж, судалгааны тайлан илтгэлүүд гаргаж байна.

### Хөрс ба газрын доройтол

ЦУОШГ хөрсний чанарын мониторингийн сүлжээ байгуулж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамыг шаардлагатай мэдээллээр хангаж байна. Монголд 2000 оноос хойш, 350 газарт таван жил тутам мониторинг хийж байна. Мониторингийн үзүүлэлтүүд нь: рН; шүвтэр ( $\text{NH}_4$ ), фосфорын исэл ( $\text{P}_2\text{O}_5$ ), нитрит ( $\text{NO}_3$ ) ба хүхэрийн хүчил ( $\text{SO}_4$ ) байна. Улаанбаатарын 102 газарт жил бүр, орон нутгийн 85 газарт 2011 оноос хойш нийт 11 химийн элементийг хамруулан (кадмий, цагаан тугалга, мөнгөн ус, бром, хром, зэс, кобальт, стронций, рубидиум, циркони, хлор) хөрсний мониторингийг хоёр жил тутам хийж байна. Хөрсний мониторингийн цэгийн тоо нэмэгдэж, 2012 онд хөрсний мониторингийн агрохимийн болон химийн элементүүдийг 396 газарт (Улаанбаатарт жил бүр 102 газарт, орон нутагт 294 газарт хоёр жил тутам) хийсэн байна. Хөрсний чанарын хяналтыг үндэсний (MNS) стандартын технологи, аргачилалаар явуулж байна.

Түүнчлэн 2011 оноос эхлэн 1,529 газарт урьдчилсан хөрсний мониторингийг таван жил тутам хийж,

цөлжилтийн нөлөөнд үнэлгээ хийж байна. Урьдчилсан мониторингийг хөрсний морфологийн бичлэг, чийгшил, гумусын давхрага, рН, давсны хуримтлал, хөрсний доройтол, гадарга дээрхи элсний хуримтлал, түүний гүн, бүтэц, нягтрал ба тархалт зэрэг 11 үзүүлэлтээр хийж байна.

ЦУОШГ хөрсний чанарын жилийн тайлан илтгэлийг бэлтгэж цахим орчинд байршуулан олон нийтийн хүртээл болгодог. Зүүн Азийн хүчиллэг тунадасны мониторингийн сүлжээний зохион байгуулсан олон улсын хөрсний чанарыг шалгах арга хэмжээнд Монголын мэрэгжилтнүүд оролцож байна.

Тулгарч байгаа саад бэрхшээлүүд нь Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторид хөрсний дүн шинжилгээ хийх хүний нөөц болон тоног төхөөрөмж дутагдалтай, мөн олон улсын аргачилал, стандартыг хангалттай мөрдөхгүй байгаа явдал юм. Хөрсний хяналтыг таван жил тутам хийх давтамж нь хэвийн давтамж боловч химийн бохирдол байж болзошгүй газруудын хувьд хангалттай биш юм.

#### Дуу чимээ болон чичиргээ

ЦУОШГ эсвэл Байгаль орчин, аялал жуулчлалын яам хариуцан дуу чимээ болон чичиргээний мониторинг хийгдээгүй байна.

#### Цацраг идэвхжил

Цацрагийн мониторингийг Монгол улс 1972 оноос Оросын DP-5A төхөөрөмжийг ашиглан хийж ирсэн бөгөөд уг төхөөрөмжийг 2004 онд Финландын RDS-110 төхөөрөмжөөр шинэчлэн сольсон байна.

Улсын цацрагийн мониторингийн сүлжээн дээр 2017 оны байдлаар гамма туяа болон бета туяаны мониторингийг хөрс болон агаарт хийж байна. Мониторингийн сүлжээ нь 35 мониторингийн станц хамрах бөгөөд тэдгээрт өдөрт хоёр удаа цацрагийн хэмжээнд хяналт тавьж байна. Түүнээс гадна, 35 станцийн 26 нь агаарын салхиар тардаг бетагийн түвшинд 10 хоног тутам хяналт тавьдаг байна.

ЦУОШГ жил бүр цацрагийн суурь түвшингийн тайлан илтгэл боловсруулж, сар бүр дунджийг нь гарган Орчны цацрагийн мэдээллийн сангаар дамжуулан нийтэд хүргэж байна. Тэдгээр мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам тайлан илтгэлд ашиглаж, Цөмийн энергийн комиссын (<http://www.nea.gov.mn>) вэбсайтад байршуулдаг байна. Монголд мониторингийн шалгалт, баталгаажуулалт болон харьцуулалт хийх магадлан итгэмжлэгдсэн нэг лаборатор ажиллаж байна.

Цацрагын хяналтын сүлжээг сайжруулахын тул мониторингийн станцуудын тоог нэмэгдүүлэх, олон улсын стандарт болон сайн туршлагын дагуу онлайн мониторингийн системийг боловсруулан ашиглах шаардлагатай байна.

#### Биологийн олон янз байдал

Байгаль орчин, аялал жуулчлалын яам биологийн олон янз байдал ба тусгай хамгаалалттай газруудад мониторинг хийх үүрэгтэй. Тухайлбал, Монгол улсын ШУА-ын Биологийн хүрээлэн Яамтай гэрээ байгуулан, тусгай хамгаалалттай газар, устах аюултай болон экологийн чухал төрөл зүйлүүдийн талаар мэдээллээр хангахаар тохиролцсон байна. Экологи болон эдийн засгийн чухал ач холбогдол бүхий төрөл зүйлүүдийн талаар 1987 - 2010 онуудад дөрвөн жил тутам тогтмол судалгаа хийж ирсэн боловч санхүүжилтийн бэрхшээлээс болж 2014 оноос уг ажлыг зогсоожээ. Ер нь 2010 оноос хойш төрөл зүйлүүдийн тооллого хийгдээгүй байна. Шинжлэх ухааны академиас 2010 онд гурван өөр биомийн төрөл зүйлийн үнэлгээг хийжээ. Үүнд тал ба цөлийн төрөл зүйлүүд; уулын төрөл зүйлүүд болон ойн төрөл зүйлүүдийг хамруулсан (Бүлэг 11) байна. Тогтмол хийгдэж байгаа биологийн төрөл зүйлүүдийн тооллогын дүнг гол нь ан агнуурын квотыг тогтоох болон байгаль орчны нөхцөл байдлын тухай үндэсний тайланг бэлтгэхэд ашиглаж ирсэн байна. Аймаг, сумын түвшинд ажиллаж байгаа байгаль хамгаалагчид тодорхой асуулгуудад өөрсдийн ажиглалтын үндсэн дээр хариулж, тухайн газар дээр ажиллаж байгаа эрдэмтэдтэй хамтран ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамыг Шинжлэх ухааны академи голлон шинжлэх ухаанд төвлөрсөн мэдээллээр хангаж байна. Түүнчилэн, янз бүрийн үндэсний болон олон улсын байгуулагууд, ихэвчилэн



тодорхой төслүүд дээр ажиллаж байгаа эрдэм шинжилгээ болон байгаль хамгаалах байгууллагууд мөн тодорхой мэдээ, мэдээлэлээр хангаж байна. Санхүүжилт сайн төслүүд үндэслэлтэй мэдээ, мэдээлэл гаргаж (жишээ нь Говийн баавгайг хамгаалах) үндэсний болон олон улсын ач холбогдол бүхий тодорхой асуудлаар шийдвэр гаргах бололцоо олгож байгаа нь харагдаж байна. Хэдийгээр ШУА биологийн олон янз байдалд хяналт тавьж, үнэлгээний тайлан илтгэлийг тодорхой зөвлөмжийн хамт боловсруулан гаргах аргачилал болон техникийн чадавхитай байгаа ч гэсэн санхүүжилтийн хомсдолоос болж хяналтыг тогтмол хийж тайлагнах, мэдээлэх ажил зогсоод байна. Ерөнхийд нь авч үзвэл, нотолгоонд суурилсан бодлого боловсруулахад гол мэдээлэл болгон ашиглахад 2010 оны мэдээ, мэдээлэл хэтэрхий хуучирсан байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яам холбогдох байгаль орчны олон талт хэлэлцээрүүдийн дагуу тайлан илтгэл бэлтгэхэд шаардлагатай мэдээллийг эрдэм шинжилгээний холбогдох хүрээлэнгүүдээс авч байна.

Олон улсын түншүүдтэй хамтран ажиллаж, Улаан номын жагсаалтын хэд хэдэн үнэлгээ хийсэн байна. Анхны үнэлгээг 1987 онд гаргаж, 1997 онд шинэчилжээ. Үүнээс хойш хийгдсэн судалгааны ажлуудыг 2006-аас 2011 онуудад нийтэлжээ (Бүлэг 11). Үүнд тарвага, загас, хэвлээр явагч болон хоёр нутагтан амьтад, шувууг хамруулжээ. Тэдгээр судалгааны ажлууд нь аюулд нэрвэгдэж болзошгүй биологийн олон янз байдлын цар хүрээ, ач холбогдолын талаар чухал мэдээллийг агуулж, устах аюултай, эмзэг болон аюулд нэрвэгдэж болзошгүй төрөл зүйлүүдийг тодорхойлоход ач тустай юм.

Биологийн олон янз байдлын тухай 2015-2025 оны үндэсний хөтөлбөрт ердийн бус үржимхий төрөл зүйлүүдэд мониторинг хийх зорилт дэвшүүлсэн боловч өнөөдрийг хүртэл хэрэгжээгүй байна. Усны амьтдын талаар хааяа нэг үнэлгээг ихэвчилэн тодорхой төрлийн загасыг арилжааны зориулалтаар олборлох орон нутгийн байгууллагуудын хүсэлтээр (2-4 жил тутам хүсэлт ирдэг) хийдэг байна.

Холбогдох байгууллагууд биологийн олон янз байдлын мониторингод хувь нэмэр оруулахын зэрэгцээ өөр өөрсдийн мэдээллийн сантай байна. Байгаль орчны мэдээллийн сан олон нийтэд мэдээллийг ургамал, амьтад, улсын болон орон нутгийн хамгаалалтай газруудыг хамруулан хийхийн зэрэгцээ Даян дэлхийн байгаль хамгаалах сангийн зэрлэг ан амьтан, ургамалын мониторингийн хязгаарлагдмал хандалттай холбоосд нэвтрэх нууц үгийг бас өгдөг байна. Үндэсний Статистикийн газар (ҮСХ) ойн бүрхэц, мод бэлтгэлийн хэмжээ, агнахыг зөвшөөрсөн, ховордсон амьтадын тоо, “тусгай зориулалтын ан агнуур”, спортын загас агнуур, ахуйн зориулалтаар зэрлэг ан амьтаныг агнах дээд хязгаар зэрэг мэдээллийг өөрийн цахим хуудас болон статистикийн тайланд нийтлэн олон нийтийн хүртээл болгож байна.

Учирч байгаа саад бэрхшээл, сорилтуудад биологийн олон янз байдлын мониторингийн санхүүжилт хангалтгүй, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны зохицуулалтыг бүх шатанд сайжруулах, байгаа мониторингийн сүлжээнүүдийг бэхжүүлэх, бодлого боловсруулагчид болон олон нийтэд мэдээ, мэдээлэлүүдийн хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг асуудлуудыг дурьдаж болно.

### Ой

Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь ойд тавих хяналт мониторингийн асуудлыг хариуцдаг. Ойтой газруудад байнгын хяналт, мониторинг хийж түүний өөрчлөлт, ойн нөөц түүнд гарч байгаа өөрчлөлт, ойн ашиглалт, ойн түймэр, ойн нөхөн сэргээлт, ойн өмчлөл болон ойн зардлын тухай тайлан илтгэлийг ой хамгаалагчдын дотор явуулсан асуулга болон тогтмол тооллогын үндсэн дээр гаргаж байна. Асуулгын хяналтын жагсаалтыг аймгийн түвшинд ойн асуудал хариуцсан ажилтанд бичгэн хэлбэрээр хүргүүлдэг байна. Мэдээлэл нь Байгаль орчны мэдээллийн санд тухайн үзүүлэлтийн төрлөөс хамааран статистик болон газар зүйн орон зайн мэдээлэл хэлбэрээр орно.

Ойн анхны тооллогыг 1956 онд явуулсан бөгөөд дараагийн тооллого нь 1974-1975 онуудад хийгджээ. Сүүлчийн энэ тооллогыг ой модны үйлдвэрийг хөгжүүлэхийн тулд явуулсан байна. Ойн судалгаа ба хөгжлийн төвийг 2012 онд яамны дүн шинжилгээ, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулжээ. Германы Техникийн хамтын ажиллагааны байгууллагатай хамтран 2014-2016 онд Олон-зорилтот ойн үндэсний тооллогыг бэлтгэн явуулж (Бүлэг 13) үр дүнг монгол, англи хэлээр хэвлэн нийтэлжээ. Түүнээс гадна, цахим ойн атласын боловсруулан хэрэглэгчдийн янз бүрийн давхрагаас сонголт хийж, сонгосон мэдээллийг авах боломжтой байна. Мэдээллийн сан нь төв дээр байрлана. Байгаль орчны төлөв байдлын тухай үндэсний тайлан гаргахад уг мэдээллийг ашиглаж байна.

### *Шинжилгээний лаборатор*

ЦУОШГ-н харьяанд 22 байгаль орчин, хэмжил зүйн лаборатори байгаагийн нэг нь Улаанбаатар хотод, 21 аймаг бүрт нэг нэг лаборатори ажиллаж байна. Орон нутгийн 11 лаборатори (Архангай, Баянхонгор, Дархан-Уул, Дорнод, Орхон, Сэлэнгэ, Завхан, Увс, Ховд, Хөвсгөл, Өвөрхангай) 2011 оны байдлаар ажиллаж байжээ. Дараа нь 2012 онд орон нутгийн хяналт хяналтын цэгийг өргөтгөн 9 лаборатори (Баян-өлгий, Булган, Говь-алтай, Дундговь, Дорноговь, Өмнөговь, Хэнтий, Сүхбаатар, Төв аймагт), мөн нэг лабораторыг Говьсүмбэр аймагт шинээр байгуулсан байна.

Улаанбаатар дахь Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатороос орон нутгийн байгаль орчин, хэмжил зүйн лабораториудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тэдний ажилд жил бүр дотоод удирдлагаар хангадаг байна. Улаанбаатар дахь Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори 2009, 2012, 2015 онуудад устай холбоотой үзүүлэлтүүдийг тодорхойлох асуудлаар магадлан итгэмжлэл авсан байна. Аймгууд дахь найман лаборатори мөн устай холбоотой үзүүлэлтүүдийг (2008, 2010, 2015, 2016 онуудад тус бүр нэг, 2017 онд дөрөв) тодорхойлох магадлан итгэмжлэл авчээ. Агаарын чанараар долоон лаборатори (Улаанбаатар, Дорнод, Сэлэнгэ, Завхан, Увс, Хэнтий, Өвөрхангай) магадлан итгэмжлэл авсан байна.

#### **4.2 Байгаль орчин, тогтвортой хөгжлийн мэдээлэл**

##### *Байгууллагуудын мэдээллийн тайлан*

Байгаль орчны янз бүрийн мэдээлэлд хуулийн дагуу бие даасан дотоод хяналт байх шаардлагатай бөгөөд энэ талаар 2011 онд Бие даасан хяналтын тухай Засгийн газрын 311 тоот тогтоол мөн гарсан байна. Томоохон компаниуд өөрийн дотоод мониторинг хариуцсан нэгжүүдтэй, тэдгээрийн дотоод хяналтын тайлан илтгэлийн чанар нь бусад байгууллагын гаргасан тайлангаас сайн байгаа боловч жижиг болон дунд хэмжээний аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээлтэй байдаг байна. МХЕГ-н байцаагчид дотоод хяналтад тавигдах шаардлагуудын хэрэгжилтийг хянаж, үр дүнгүй дотоод хяналтын тайлан илтгэлд торгууль ноогдуулдаг байна.

##### *Статистик мэдээ*

Хоёр байгууллагын 2014 онд гарын үсэг зурсан Санамж бичгийн дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамны гаргаж өгсөн мэдээллийг ашиглан улсын албан ёсны статистик мэдээ боловсруулан гаргах ажлыг ҮСХ хариуцдаг байна. Улсын албан ёсны статистик мэдээг хариуцан гаргаж байх тухай хууль тогтоомж үйлчилж, тухайн хуулинд ТХЗ-уудыг оруулах тухай нэмэлт өөрчлөлт оруулаад одоо батлагдахыг хүлээж байгаа ажээ. Бүх статистик мэдээг олон улсын стандартын дагуу бэлтгэж, ҮСХ-ын вэб хуудсанд байршуулдаг. Одоогийн байдлаар байгаль орчны 24 үзүүлэлтийг ҮСХ-ын онлайн мэдээллийн санд оруулсан бөгөөд статистикийн аргачилал болон өгөгдөлүүдийн тайлбар олон нийтэд хүртээмжтэй байна. Түүнээс гадна, 2003 оноос 2015 он хүртэлх хугацаанд статистикийн жилийн эмхтгэлийг бэлтгэн гаргаж, байгаль орчны 10 багц мэдээллийг байгаль орчны 16 үзүүлэлтийг хамруулан хэвлэн гаргасан байна. Энэ нь жил бүр бэлтгэн хэвлэж байгаа жилийн эмхтгэлд байгаль орчны албан ёсны багц мэдээний тоог нэмэгдүүлэх үйл явц удааширалтай байгааг харуулж байна. Жилийн эмхтгэлийн бүх статистик мэдээллийг ҮСХ-ны цахим мэдээллийн санд оруулж байна.

ҮСХ дөнгөж саяханаас Байгаль орчны эдийн засгийн тооцооллын системийг хэрэгжүүлж эхлэн, одоогийн байдлаар материалын урсгал болон биет хангамжийн тооцооны системийг боловсруулж, эрчим хүчний хүснэгтийг ашиглаж байна. ҮСХ байгаль хамгаалалтын зардал болон байгаль орчны татварын тооцоог оруулах асуудлыг одоо авч үзэж байна. Нягтлан бодох бүртгэлийн ажлыг хараахан нийтлээгүй байна.

Байгаль орчны албан ёсны статистик мэдээллийг боловсруулах болон ашиглахад хэд хэдэн саад бэрхшээл сорилтууд тулгарч байна. Эдгээр нь:

- Байгаль орчин, аялал жуулчлалын яам байгаль орчны статистик мэдээллийг гаргах чадавхи хомс байгаа нь хэдийгээр мэдээлэл байгаа ч гэсэн боловсруулан гаргаж байгаа статистик мэдээний тоо өчүүхэн бага байгаагаас харагдаж байна;

- Ус болон хог хаягдлын бүртгэл тооцоог боловсруулаагүй байна ;
- Байгаль орчны эдийн засгийн тооцоололын системийг бүрэн хэрэгжүүлээгүй байна;
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас бэлтгэн ҮСХ-г хүргүүлж байгаа мэдээний чанар төдийдөн сайн биш, өөр хоорондоо авцалдахгүй зөрөөтэй байх тохиолдол гарч байна;
- Статистик мэдээ цуглуулахад ашиглаж байгаа маягт, асуулга болон байгаль орчны статистикийн үзүүлэлтүүдэд үнэлгээ хийх аргачлалыг сайжруулах асуудлыг УИХ-ын Байнгын хороонд хүргүүлэн батлуулах ажлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам хараахан хийж гүйцэтгээгүй байна.

Сүүлийн үед гарсан олон улсын бодлогын чухал баримт бичгүүдтэй уялдан Байгаль орчны статистик мэдээллийн эрэлт хэрэгцээ улам бүр өсөн нэмэгдсээр байна. Тухайлбал, ТХЗ-ууд, Парисын хэлэлцээр, Гамшгийн эрсдлийг 2015-2030 онд бууруулах Сендайн хамтар хүрээ зэргийг нэрлэж болно. Энэ бүхэн нь Байгаль орчны асуудлаарх олон талт гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргийн дагуу тайлан илтгэлд тавигдаж байгаа шаардлагууд болон үндэсний хэмжээний байгаль орчны төлөв байдлын тухай тайлан илтгэлийг боловсруулахад шаардлагатай юм. Гэвч, Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон ҮСХ-ны чадавхи (жишээ нь байгаль орчны стратегийн үнэлгээг хэрэгжүүлэх) хязгаарлагдмал, сул байна. Түүнээс гадна, мэдээний чанар хангалтгүй байгаа тул олон улсын стандарт болон сайн туршлагыг аль болох сайн ашиглах шаардлага тавигдаж байна. Түүнчлэн байгууллага хоорондын хамтын ажиллагаа төдийлөн сайн бус, Засгийн газрын байгууллагууд мэдээллийг харилцан ашиглах явдал хангалтгүй байна.

#### *Мэдээллийн сан*

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Байгаль орчны мэдээллийн төв одоогоор байгаль орчны 29 үндсэн мэдээллийн сантай байгаа бөгөөд тэдгээр нь тусгай цахим хуудсаар (<http://www.eic.mn>) дамжин нийтэд хүрч байна. Тухайлбал, газар; хөрс; ашигт малтмал; ус; ой; ургамал; ан амьтан; агаарын бохирдол; орчны цацраг; уур амьсгал; байгалийн гамшиг; аюултай, хортой химийн бодисууд; тусгай хамгаалалттай газрууд; эрх зүйн мэдээлэл; байгаль орчны нөлөөллийн үнэлгээ; байгаль орчны салбарын төслүүд ба бодлого; байгаль орчны статистик; байгаль орчны санхүүжилт; байгууллага ба хүний нөөц; ерөнхий мэдээлэл; амьжиргааны нөхөн олговор; байгальд учруулсан хохиролын барагдуулалт; геомэдээллийн сан; цөлжилт; байгаль орчны доройтол ба бохирдолт; байгальд ээлтэй технологи; бохирдсон газруудын бүртгэл; Даян дэлхийн байгаль хамгаалах сангийн цахим холбоосд нэвтрэх нууц үг (амьтан, өвс ургамал мониторинг); иргэдэд суурилсан менежмент ба хамгаалалт зэрэг мэдээлэл орж байна.

Мэдээллийн сан болон дэд сангууд нь бүтцийн хувьд ойлгомжтой, нэвтрэхэд харьцангуй хялбар байх ёстой. Гэтэл, хэрэглэгч шаардлагатай дэд санд нэвтрэн ороход байршуулсан мэдээллүүд нь холилдсон, олон тохиолдолд шаардлагатай мэдээ байхгүй байх тохиолдол олон байна. Түүнээс гадна, ус цаг уурын мэдээллийн цахим холбоосоос бусад тохиолдолд байгаль орчны мэдээллийн сангаас нийгмийн мэдээлэлд нэвтрэн эх сурвалж, хэлэлцүүлгийг өргөжүүлэх холбоос байхгүй байна Вэб хуудсанд хэдэн хүн нэвтэрсэн тооцоо байдаг ч нэг холбоосоос нөгөөд шилжин хэдэн хүн орж байгаа тоо байхгүй байна.

#### *Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд*

Байгаль орчны Статистикийг боловсруулах бүтэц (2013 оны) нь 492 үзүүлэлттэй бөгөөд харин Монголын хувьд одоогоор 187-г нь тодорхойлох боломжтой, үлдсэн 305 нь байхгүй байна. Тийм учраас цаашид байгаль орчны асуудлыг хяналтад авахад дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай шалгуур үзүүлэлтүүдийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

#### *ТХЗ-н шалгуур үзүүлэлтүүд болон мэдээлэл*

2017 оны дунд үеийн байдлаар авч үзвэл Тогтвортой хөгжлийн зорилтуудын шалгуур үзүүлэлтийн асуудлаарх Байгууллага хоорондын болон экспертүүдийн бүлгээс тодорхойлсон байгаль орчны холбоо бүхий 103 шалгуур үзүүлэлтээс Монгол улс 11 үзүүлэлтээр мэдээлэл гаргах боломжтой байна. Гэхдээ, Шатлал II-ын (онол үзэл баримтлалын хувьд тодорхой, олон улсын хэмжээнд тогтсон аргачилал болон стандарттай боловч улс орнууд мэдээлэл тогтмол боловсруулан гаргахгүй байгаа шалгуур

үзүүлэлтүүд), мөн Шатлал III -ын (олон улсын хэмжээнд тогтсон аргачилал, стандарт одоогоор байхгүй, гэвч аргачилал, стандартыг боловсруулах, шалгах ажил хийгдэж байгаа үзүүлэлтүүд) олон тооны үзүүлэлтүүд байгаа юм.

*Харилцан солилцож болох Байгаль орчны мэдээллийн системийн зарчмуудыг хэрэглэх*

Харилцан солилцож болох Байгаль орчны мэдээллийн системийн үзэл баримтлал нь Европоос<sup>1</sup> гаралтай бөгөөд байгаль орчны мэдээ, мэдээллийг цуглуулах, харилцан солилцох, ашиглалтыг сайжруулах зорилго агуулж, байгаль орчны суурь мэдлэгийг бэхжүүлэхэд чиглэсэн. Тийм учраас, энэхүү үзэл баримтлал нь Европын бус орнуудын хувьд хараахан системтэйгээр нэвтэрээгүй байна. Харилцан солилцож болох Байгаль орчны мэдээллийн систем нь өргөн утга агуулга бүхий гурван тулгууртай: агуулга бүтэц (контент): дэд бүтэц ба хамтын ажиллагаа; мэдээллийн менежментийн долоон “зарчимаас” бүрэлдэнэ. Монгол улсын хувьд байгаль орчны асуудлын хувьд дэд бүтэц болон хамтын ажиллагааг харьцангуй сайн гүйцэтгэж байгаа боловч “гадны” контент (мэдээний олдоц, мэдээний чанар) болон хамтын ажиллагааны хувьд төдийлөн сайн биш байна. Монгол улс мэдээллийн нэгдсэн сантай, энэ сан нь БОМ-ийн төвийн вэб хуудсаар дамжин байгаль орчны мэдээлэлд амархан нэвтрэх боломжийг олгож, мөн бусад байгууллагуудаас гаргаж байгаа найдвартай мэдээний багц болон мэдээлэлд нэвтрэх боломжтой байна. Энэ мэдээлэл нь олон зориулалтаар “ашиглах” боломжтой, олон “хэрэглэгчдэд” хүртээмжтэй бөгөөд мэдээллийн эх сурвалжид ойр удирдлагатай байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон ЦУОШГ орчин үеийн компьютер, мэдээллийн технологийн давуу талыг ашиглан суурь вэб хуудасны техникийн дэд бүтцийг хангаж байна. Сумаас аймагт, аймгаас үндэсний түвшинд ихэнх мэдээллийг одоо хүртэл цаасаар дамжуулж байгаа ажлыг сайжруулах шаардлагатай бөгөөд мөн өнөө үед мониторингийн сүлжээг (агаар, ус, цацраг) автоматжуулах өргөн боломж бололцоо байгаагийн зэрэгцээ мэдээллийг компьютерээр болон вэб технологийг ашиглаж хүлээн авах боломжтой юм. Эрх үүрэг, удирдамж, үйл ажиллагаа нь тодорхой байгаль орчны мэдээллийг гаргаж байгаа байгууллага, хүрээлэнгүүдийн хувьд хамтын ажиллагаа нь үр дүнтэй байгаа боловч энэхүү хамтын ажиллагааг Засгийн газрын бусад байгууллагуудтай, тухайлбал Үндэсний статистикийн газартай хамтын ажиллагаагаа сайжруулж болно. Эхний суурь ‘контент’-ийг зайлшгүй сайжруулах шаардлагатай бөгөөд энэ нь эцсийн бүлэгт хяналтын сүлжээний үр дүн, мэдээллийн чанар, тоо хэмжээнд (жишээ нь биологийн олон янз байдал) тулгуурлана. Харилцан солилцож болох Байгаль орчны мэдээллийн системийн үзэл баримтлал болон бүтцийг БОАЖЯ болон мониторингийн үүрэг хүлээдэг холбогдох бусад байгууллага, хүрээлэнгүүдийн үйл ажиллагааны удирдамж болгон ашиглах нь байгаль орчны мэдээллийг хоорондоо харилцан ашиглах ажлыг сайжруулах болно.

*Байгаль орчны тайлагнал, байгаль орчны мэдээг хэвлэн нийтлэх, шалгуур үзүүлэлтэд суурилсан үнэлгээний тайлан*

Байгаль орчны мэдээллийн илтгэл тайлан боловсруулах, хэвлэн нийтлэх асуудал хэд хэдэн гол шугамаар хийгддэг. Байгаль орчны тодорхой тооны статистик мэдээллийг Монголын статистикийн жилийн эмхтгэлд оруулан хэвлэдэг, түүнийг мөн ҮСХ-ын вэб хуудаснаас авч болно. Янз бүрийн сэдэвчилсэн мэдээ, мэдээллийг хоороноод янз бүрийн зайтайгаар мэдээлж байна. Тухайлбал, компьютерийн тухайн үеийн бодит мэдээлэл (агаарын чанар); нэг сарын завсарлагатайгаар (агаар, цацраг, ус); мөн жилийн зквасарлагатайгаар (агаар, цацраг туяа, ус, хөрс) болон дараа нь хэд хэдэн жилийн завсарлагатайгаар (хөрс, биологийн олон янз байдал, ойн тооллого) г.м. Жилийн тайлан мэдээг дараа нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хоёр жил тутам гаргадаг Байгаль орчны төлөв байдлын үндэсний тайлан илтгэлд ашиглаж байна. Зарим нэг гол мэдээг *eis.mn* вэб хуудас болон бусад порталд байршуулж нийтийн хүртээл болгож байгаа бөгөөд ЦУОШГ тэдгээрийг тогтмол шинэчилж байдаг. Байгаль орчны мэдээлэл болон статистик мэдээний гол ашиглагчид нь: бодлого боловсруулагчид; эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд болон иргэний нийгмийн байгууллагууд байна.

Байгаль орчны төлөв байдлын тухай анхны тайлан илтгэлийг 1997 онд гаргажээ. Одоо Байгаль орчин, аялал жуулчлалын яам уг тайлан илтгэлийг ЦУОШГ-ын мэдээллийг ашиглан хоёр жил тутам бэлтгэн,

<sup>1</sup> БДХМС нь ЕХ болон ЕЕА-н хамтын санаачилга бөгөөд Европын 39 орны байгаль орчны мэдээлэл, ажиглалтын сүлжээ юм. <https://www.eea.europa.eu/about-us/what/shared-environmental-information-system-1/shared-environmental-information-system>



хэвлэн нийтэлж байгаа бөгөөд түүнийг бодлого боловсруулах, шийдвэр гаргахад гол мэдээлэл болгон ашиглаж байна. Бүх тайлан илтгэлүүд 30 жилийн өөрчлөлтийн хандлагаар, 2015-2016 оныхоос бусад жилүүдэд хоёр жилийн хугацааг хамарч байна. Хоёр жил тутмын Байгаль орчны төлөв байдлын тухай анхны тайлан илтгэл нь тодорхой үзүүлэлтэд суурилсан үнэлгээ бөгөөд харин Хүчин зүйл, Дарамт, Нөхцөл байдал, Нөлөөлөл, Арга хэмжээ гэсэн бүтэцэд (DPSIR) тулгуурлаагүй байна. Тайлан илтгэлүүдэд техникийн бус ойлгоход хялбар хураангуйг оруулаагүй, зөвхөн ерөнхий зөвлөмж болон дүгнэлтийг тайлангийн эцэст тусгасан байдаг.

#### *Бусад мониторингийн системтэй холбогдох холбоос*

Бусад холбогдох яамд, агентлагууд болон хүрээлэнгүүдтэй байгаль орчны мэдээ, мэдээллийн харилцан солилцох систем байхгүй байна.

### **4.3 Хууль эрх зүй, бодлого болон бүтэц зохион байгуулалтын тогтолцоо**

#### *Хууль эрх зүйн тогтолцоо*

Байгаль хамгаалах тухай 1995 оны хуульд байгаль орчны мониторингийн тухай тодорхойлж, төрийн захиргааны төв байгууллагад (Байгаль орчин, аялал жуулчлалын яам) байгаль орчны мониторингийн сүлжээг байгуулан үйл ажиллагааг нь эрхлэн явуулах эрхийг олгожээ. Байгаль орчны мониторингийн сүлжээний хүрээнд гүйцэтгэх үйл ажиллагаанд дараах үйл ажиллагаа хамрагдана:

- Байгаль орчин болон бохирдолд гарч байгаа бодит, хими болон биологийн өөрчлөлтөд тогтмол ажиглалт, хэмжилт болон судалгаа хийх;
- Олон нийт, бизнес аж ахуйн нэгжүүд болон байгууллагуудад байгаль орчны талаар мэдээлэл хүргэх;
- Байгалийн гамшгийн үр дагавар хүний эрүүл мэнд болон байгаль орчинд үзүүлж сөрөг нөлөөнөөс сэргийлэх санал боловсруулах.

Байгаль хамгаалах тухай хуульд Байгаль орчин, аялал жуулчлалын яам байгаль орчны мэдээллийн сан буюу тогтолцоог гурван бүрэлдэхүүн хэсэгтэй байгуулахаар заасан: сум ба дүүргийн мэдээллийн сан; аймаг ба нийслэл хотын мэдээллийн сан; Улсын хэмжээний мэдээллийн сан. Хуульд, янз бүрийн оролцогдын (сумын засаг дарга нар, аймгийн засаг дарга нар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам) мэдээлэл бэлтгэх болон мэдээллийг хүргүүлэх хугацааны хувьд хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлж өгчээ.

Ус, цаг уур болон орчны мониторингийн тухай 1997 оны хууль нь уур амьсгал болон байгаль орчны үндэсний сүлжээтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулдаг. Үүнд, иргэд болон байгаль орчинд нөлөөлж болзошгүй цаг уур болон байгалийн нөхцөл байдлын талаар иргэдэд мэдээлж байх заалт орсон байна. Аймаг, нийслэл хот, сум, дүүргийн засаг дарга нар байгаль орчны аюултай болон ноцтой бохирдолын талаар иргэд, бизнес эрхлэгчид болон байгууллагуудыг мэдээлэлээр хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ажлыг хариуцана. Улсын цаг уур, орчны мониторингийн сүлжээнээс гадна, цаг агаар, байгаль орчны мэдээг хөдөө аж ахуй, тээвэр, эрчим хүч болон аялал жуулчлал зэрэг салбаруудын онцлог эрэлт шаардлагыг харгалзан зөвшөөрөл бүхий иргэд, аж ахуйн нэгжүүд болон байгууллагууд бас өгч болно. Хуульд Засгийн газар цаг агаар болон орчны мониторингийн сүлжээний мэдээллийг бүрэн утгаар нь ажил хэрэг болгон ашиглана гэж заасан.

Статистикийн тухай 1997 оны хуульд, Үндэсний статистикийн тогтолцооны ажлын цар хүрээ, үйл ажиллагаа болон зохицуулалтын асуудлыг тодорхойлоод, Үндэсний статистикийн газрын (хорооны) бүрэн эрх, үүрэг хариуцлага, эрх үүрэг болон ямар нэг хэмжээгээр албан ёсны статистик мэдээг бэлтгэн гаргах бусад арга хэмжээнүүд, тухайлбал хүн амын тооллого болон судалгааг зохион явуулахад тавигдах шаардлагууд, мөн албан ёсны статистик мэдээг бэлтгэн хэвлэн нийтлэх тухай зэрэг асуудлуудыг тусгасан байна. Энэхүү хуульд заасан статистикийн албан ёсны үзүүлэлтүүдийн жагсаалтад байгаль орчны дараах үзүүлэлтүүд оржээ: а) хөрс хамгаалал ба түүний эвдрэл; б) цэвэр усны нөөц, ус ашиглалт, бохирдол, цэвэршүүлэх ба бохир усыг цэвэрлэх; в) агаарын бохирдол; г) ойн хамгаалалт ба нөхөн сэргээлт; д) агнахыг хориглосон амьтдын тоо ба ан агнуур зэрэг болно.

Бие даасан дотоод мониторингийн үйл ажиллагааг Засгийн газрын 2011 оны 311 тоот тогтоолд нарийвчилан заасны дагуу зохицуулах ба тогтоолд эл ажлыг хариуцах зөвшөөрөл, лицензи бүхий хүнийг томилон ажилуулахаар заасан байна.



## Бодлогын тогтолцоо

Ус, цаг уур болон орчны мониторингийн 2015 хүртлэх хөтөлбөрийн (2002 оны Засгийн газрын тогтоол No. 182) зорилго нь ус цаг уур, орчны мониторингийн үндэсний сүлжээг сайжруулах, мэдээллийг сүлжээгээр дамжуулах болон хүлээн авах чадавхийг дээшлүүлэх, автомат мониторингийн системийн ашиглалтыг нэмэгдүүлэхэд оршиж байжээ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2003-2005 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг мөн батлан гаргажээ.


Цаг агаарт зориудаар нөлөөлөх арга хэмжээг 2015 он хүртэл авч хэрэгжүүлэх тухай 2007 оны Хөтөлбөрт (2007 оны Засгийн газрын тогтоол No. 96) хэмжилтийн үндэсний сүлжээг өргөтгөх асуудлыг мөн тусгасан байна.

Бусад орноос ялгаатай нь үндэсний байгаль орчны мониторингийн жилийн хөтөлбөр байдаггүй байна. Орчны мониторингийг жил жилийн төлөвлөгөөнд үндэслэн, Засгийн газрын баталсан Байгаль орчин, аялал жуулчлалын яамны жилийн төсвөөр дамжуулан санхүүжүүлж байна.

## Бүтэц зохион байгуулалтын тогтолцоо

Байгаль орчин, аялал жуулчлалын яам байгаль орчны мониторинг болон мэдээллийг бэлтгэх ажлыг хариуцана. Хариуцсан үүргээ хэрэгжүүлэхэд нь Байгаль орчин аялал жуулчлалын яаманд ЦУОШГ дэмжлэг үзүүлнэ. ЦУОШГ нь агаарын чанар; хүчиллэг тунадас; усны нөөц болон усны чанар; бохир ус; болон хөрсний бохирдолд тусгайлан мониторинг хийж дүнг тайлагнадаг байна. Зураг 4.1-д ЦУОШГ-н зохион байгуулалтын нарийвчилсан бүтцийг харуулав. ЦУОШГ нь мэдээг хадгалах болон мониторингийн цэгүүдээс мэдээг цаасан хэлбэрээр хүлээн авах үүрэгтэй. Мониторингийн стандартыг техникийн баримт бичигт тодорхойлж өгсөн байна. Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн нь ЦУОШГ-ын харьяанд ажилладаг. БОМТ нь энэхүү хүрээлэнгийн хэсэг юм.

Зураг 4.1: Цаг уур, орчны шинжилгээний газрын зохион байгуулалтын бүтэц



Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газар, 2017.

Тэмдэглэл: Ажиллагсадын тоог хаалтанд авч үзсэн. Ерөнхий захирлын зөвлөл нь ЦУОШГ-н хэлтсийн дарга нар болон Ус цаг уур, орчны хяналтын УБ дахь салбар, Ус цаг уур орчны мэдээлэл, шинжилгээний хүрээлэн, Төв лаборатори болон Авиацийн цаг агаарын төвийн захирлууд орж байна.

ҮСХ нь албан ёсны статистик мэдээ бэлтгэх үүрэгтэй. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн мэдээллийг байгаль орчны статистик мэдээлэл бэлтгэхэд ашиглаж байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон ҮСХ хоорондын харилцааг зохицуулж байгаа одоогийн хууль тогтоомжоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь ҮСХ-г байгаль орчны холбогдол бүхий мэдээллээр хангах үүрэг хүлээх ба 2014 онд гарын үсэг зурсан Санамж бичигт мэдээний чанарыг сайжруулах, байгаль орчны статистик мэдээний хамрах хүрээг өргөжүүлэх талаар заасан байна.

Байгаль орчны мэдээ, тоо мэдээлэл цуглуулах ажилд оролцдог бусад байгууллага, хүрээлэнгүүдэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, менежмент, Геодези, зураг зүйн газар, Улсын онцгой байдлын ерөнхий газар, усны сав газруудын захиргаа, тусгай хамгаалалттай газруудын захиргаа, аймаг, нийслэл хот, сум, дүүргүүдийн захиргаа, ой хамгаалагчид болон судалгаа шинжилгээний хүрээлэнгүүд хамрагдаж байна.

*Олон улсын хэлэлцээрүүд, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох оролцоо*

Монгол улс байгаль орчны хяналт, шалгалтын болон чанарын (усны чанарыг оролцуулан ) үнэлгээ баталгаажуулалт хийх чадавхийг бэхжүүлэх олон улсын төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдан ажиллаж байна.

#### **4.4 Үнэлгээ, дүгнэлт ба зөвлөмж**

*Үнэлгээ*

Байгаль орчны мониторингийн сүлжээ нь байгаль орчны үндсэн асуудлуудыг хамарсан боловч цаашид улам бэхжүүлэх, мөн мэдээлэл цуглуулах болон тайлагнах талаар зарим нэг шалгуур үзүүлэлтүүд байхгүй байгааг анхаарах хэрэгтэй байна. Тухайлбал, дуу чимээ болон чичиргээний мониторинг байхгүй байна. Ургамал, ан амьтаны төрөл зүйлүүдийн үнэлгээг 2010 онд хийсэн боловч төсөв мөнгө хомс байсан учир 2014 онд дахин хийгээгүй байна.

Байгаль орчны төлөв байдлын тайланг үндсэн үзүүлэлтүүдээр хоёр жил тутам гаргаж байна. Байгаль орчны төлөв байдлын тайланг бэлтгэхэд ашигласан мэдээллийг олж авах боломжтой, олон нийтэд нээлттэй байна. Харин Байгаль орчны төлөв байдлын тайлангийн өөр үндсэн хоёр тулгуур, тухайлбал агуулга (контент) ба хамтын ажиллагаанд хангалттай анхаарал хандуулаагүй байна. Агуулгын (контент) хувьд мэдээний чанар болон сумаас аймагт, аймгаас төвийн түвшинд мэдээлэл цуглуулах ажлыг сайжруулах шаардлагатай байна. Мөн байгаль орчны стратегийн нөлөөллийн үнэлгээг хэрэгжүүлэх, авах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх, болон Тогтвортой хөгжлийн зорилт 2030, Парисын хэлэлцээрийн болон Сендайн хамрах хүрээний мөрөөр авах арга хэмжээг үнэлэх дүгнэх чиглэлээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон ТББ хоорондын байгаль орчны статистик мэдээ бэлтгэх хамтын ажиллагааг нь бэхжүүлэх шаардлагатай байна.

*Дүгнэлт ба зөвлөмж*

Байгаль орчны мониторинг хийх нөөц бололцоо

Мониторингийн сүлжээг бэхжүүлэхийн тулд түүний хүний болон санхүүгийн нөөцийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Ялангуяа, 2010 оноос хойш ургамал, амьтаны төрөл зүйлийн үнэлгээг дахин хийгээгүй байгаа, түүнчлэн дуу чимээ, чичиргээний мониторинг байхгүй байна. ЦУОШГ-ын аймгууд дахь лаборторуудын чадавхи сул байгаагаас зарим нь гол үзүүлэлтүүдийн баталгаажилтийг орхигдуулж байна.

Зөвлөмж 4.1:

*Байгаль орчин, аялал жуулчлалын яам байгаль орчны мониторингийн одоогийн сүлжээг сайжруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Мэрэгшсэн хүний нөөц болон санхүүжилтийг нэмэгдүүлэх;*
- (b) *Ургамал, амьтаны төрөл зүйлийн үндэсний хэмжээний үнэлгээг сэргээн тогтмол хийж байх;*
- (c) *Дуу чимээ болон чичиргээний мониторинг хийх;*
- (d) *ЦУОШГ-ын аймгууд дахь лаборторуудыг дахин магадлан итгэмжлэх, шинэ тоног төхөөрөмжөөр хангах болон чадавхийг бэхжүүлэх замаар бэхжүүлэх.*

*Зөвлөмж 11.1-ийг үзэх.*

#### Мэдээ цуглуулах, хоорондоо солилцох

Сумаас аймагт, аймгаас төвд хүргүүлэх мэдээдэл цуглуулах, боловсруулах чадавхи хангалтгүй байна. Байгаль орчны үзүүлэлтүүд, статистик мэдээлэл боловсруулах ажилд олон улсын аргачлалууд, стандартууд болон шилдэг туршлагыг хангалттай нэвтрүүлээгүй байна.

#### Зөвлөмж 4.2:

*Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь Үндэсний статистикийн хороотой хамтран мэдээний чанарыг сайжруулах, мэдээ цуглуулах болон дутуу байгаа орхигдсон мэдээ, мэдээллийг нөхөх, шалгуур үзүүлэлтүүд боловсруулах ажлыг сайжруулахын тулд олон улсын аргачлал, стандартыг хэрэглэх шаардлагатай байна:*

- (a) *Байгууллага хоорондын хамтын ажиллагаа, улсын хэмжээнд янз бүрийн шатны байгууллагуудаар дамжуулан мэдээллийг харилцан солилцож ашиглах нөхцлийг сайжруулах;*
- (b) *Дутуу байгаа мэдээллийг нөхөхийн тулд шаардлагатай тэргүүлэх ач холбогдол бүхий мэдээний урсгал болон байгаль орчны шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох;*
- (c) *Сум, аймгийн түвшинд мэдээлэл цуглуулах болон мэдээний чанарын шалгалт хийх чадавхийг бий болгох,*
- (d) *Мэдээллийн санд оруулах илүү найдвартай, бодит мэдээлэл авахын тулд мэдээллийн технологи, Газар зүйн мэдээллийн системд суурилсан арга хэрэгсэл ашиглан байгалийн нөөцийн тооллыг байжруулах.*

#### Байгаль орчны төлөв байдлын тайлан

Байгаль орчин, аялал жуулчлалын яам хоёр жил тутам Байгаль орчны төлөв байдлын тайланг бэлтгэн гаргаж байна. Тайлан илтгэлүүд нь голдуу хоёр жилийн хугацааг (2015-2016 он ороогүй) хамарч, байгаль орчны төлөв байдлын үзүүлэлтүүдийн 30 жилийн өөрчлөлтийн хандлагыг тодорхойлж байна. Тайлан илтгэлүүд нь тодорхой үзүүлэлтэд тулгуурлаж, харин Хүчин зүйл, Дарамт, Нөхцөл байдал, Нөлөөлөл, Хариу арга хэмжээ (DPSIR) гэсэн бүтцэд тулгуурлаагүй байна. Тайлан илтгэлүүдэд техникийн бус энгийн хураангуйг оруулаагүй, зөвхөн ерөнхий зөвлөмж болон дүгнэлтийг тайлангийн эцэст тусгасан байна.

#### Зөвлөмж 4.3:

*Байгаль орчин, аялал жуулчлалын яам байгаль орчны төлөв байдлын тухай тайланг дараах зөвлөмжүүдийг анхааран сайжруулах хэрэгтэй:*

- (a) *Бодлогын хүрээнд тавигдаж байгаа шаардлагуудтай уялдуулах үүднээс Хүчин зүйл, Дарамт, Нөхцөл байдал, Нөлөөлөл, Хариу арга хэмжээ гэсэн (DPSIR) бүтцийг ашиглах;*
- (b) *Оролцогч талууд болон шийдвэр гаргагчдад илүү тодорхой мэдээлэл хүргэх үүднээс Байгаль орчны төлөв байдлын тайлан илтгэлд техникийн-бус энгийн товч хураангуйг оруулах.*

#### Байгаль орчны статистик

Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Үндэсний Статистикийн хорооны хувьд байгаль орчны сайн чанартай статистик мэдээлэл бэлтгэх туршлага, чадавхи дутагдаж байна. Байгаль орчны сайн чанартай статистик нь байгаль орчны үзүүлэлтүүдийг нэгтгэх, байгаль орчны тайлан илтгэлийг чанарын өндөр түвшинд боловсруулан гаргах, түүнчилэн байгаль орчны эдийн засгийн нягтлан бодох бүртгэлийн тогтолцоог хэрэгжүүлэх урьдчилсан нөхцлийг бүрдүүлдэг юм. Түүнчилэн, 2030 хүртлэх Тогтвортой хөгжлийн зорилт, зорилгуудын хэрэгжилтийг хангах болон дүгнэлт гаргахад мөн шаардлагатай юм. Олон улсын хамтын нийгэмлэг III түвшний аргачлал болон стандарт, үзүүлэлтүүдийн талаар зөвшилцөд хүрэхээр ажиллаж байгаа энэ үед Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон ТББ-ууд II түвшний үзүүлэлтүүдийн талаар зохих судалгааг хийж, цаашид мэдээлэл цуглуулах ажлыг сайжруулах талаар хамтран ажиллах хэрэгтэй байна. Үүнийг агаарт хаягдах ялгарал, ус, ой, хог хаягдал болон эрчим хүчний чиглэлээр байгаль орчны стратегийн үнэлгээг хэрэгжүүлэх ажилтай зэрэгцүүлэн гүйцэтгэх хэрэгтэй.

Зөвлөмж 4.4:

Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Үндэсний статистикийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:

- (a) Үндэсний болон олон улсын хэмжээнд тавигдаж байгаа шаардлагын дагуу байгаль орчны статистикийн тогтолцоог бэхжүүлэх үйл ажиллагааны зураглалыг боловсруулах;
- (b) Байгаль орчны үзүүлэлтүүд, ТХЗ-уудын байгаль орчинтой холбоотой үзүүлэлтүүд болон байгаль орчин-эдийн засгийн тооцоог нэгтгэн боловсруулахын тулд 2013 оны Байгаль орчны Статистик боловсруулах болон түүний Байгаль орчны статистикийн суурь багцын зарчмуудыг хэрэгжүүлэх;
- (c) Байгаль орчны тухай улсын тайлан илтгэл, ТХЗ-ууд болон Байгаль орчны эдийн засгийн тооцоог боловсруулах өөрсдийн ажиллагсадын чадавхийг бэхжүүлэх сургалтыг зохион байгуулах.

## Бүлэг 5

# МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО, БОЛОВСРОЛ

### 5.1 Байгаль орчны мэдээллийн хүртээмж

#### *Байгаль орчны мэдээллийн хамрах хүрээ*

Байгаль орчныг хамгаалах тухай 1995 оны хуульд 2008 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр байгаль орчны мэдээллийн хамрах хүрээг тодорхойлж, байгаль орчны мэдээлэл нь улсын мэдээллийн сангийн нэгэн хэсэг байхаар тогтоосон байна. Жагсаалтад байгаль орчны бараг бүх үзүүлэлтүүдийг хамруулсан, тухайлбал газар ба хөрс; газар шороо болон ашигт малтмал; ус ба рашаан; ой; ургамал; амьтан; агаар ба агаарын бохирдол; уур амьсгал. Түүнээс гадна, уг жагсаалтад тодорхой хүчин зүйлс буюу асуудлуудыг мөн оруулсан байна, тухайлбал: байгалийн гамшиг; аюултай болон хортой химийн бодис; хог хаягдал; тусгай хамгаалтай газрууд; байгаль орчны тухай хууль; байгаль орчны нөлөөллийн үнэлгээ; байгаль орчны бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт; байгаль орчны статистик ба тайлан илтгэлүүд; байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв болон өртөг зардал; байгаль орчны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд ба хүний нөөц; мэдээллийн сан болон байгаль орчны бусад мэдээллийг хамруулжээ. Үүний зэрэгцээ, байгаль орчны мэдээлэлд хамрахгүй, “байгаль орчны бусад мэдээлэл” ангилалд тусгагдаагүй боловч байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад ашиглаж байгаа эрчим хүч, дуу чимээ ба цацраг болон өртөг зардлын үр дүн болон эдийн засгийн бусад дүн шинжилгээ, төсөөлөл таамаглал зэрэг хүчин зүйлүүд, асуудлуудыг авч үзээгүй байна. Мөн, хүний эрүүл мэнд болон аюулгүй байдал, хүний амьдралын нөхцөл байдал, дурсгалт газрууд, байгууламжийн байдал зэрэг байгалийн янз бүрийн элементүүдийн нөлөөлд өртөж болзошгүй асуудлуудыг байгаль орчны мэдээллийн хамрах цар хүрээнд хамруулаагүй байна.

#### *Мэдээллийн идэвхитэй хандалт*

Байгаль орчны мэдээллийн идэвхитэй мэдээллийн хүртээмж гэдэг нь Засгийн газрын байгууллагуудын үүрэгт хамаарах олон нийтийн ашиг сонирхолын үүднээс цуглуулж, нийтэд түгээн тарааж байгаа мэдээллийг хэлнэ.

Байгаль орчны асуудлаархи олон нийтийн ухамсар ойлголтын түвшин болон байгаль орчны мэдээллийг хэр сонирхож байгаа талаар Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Засгийн газрын бусад байгууллага, төрийн бус байгууллагын оролцогсод ямар нэгэн судалгаа, үнэлгээ эсвэл дүгнэлт гаргаагүй байна.

#### Интернетээр авах мэдээллийн хүртээмж

Үндэсний хэмжээнд байгаль орчны мэдээллийг интернетээр шууд хандалтаар ороод авах боломжгүй, зөвхөн Яамны албан ёсны шийдвэрийн үндсэн дээр мэдээлэл олж авах боломжтой болно. Мэдээллийг нээлттэй болгохоос өмнө олон нийтэд шууд хүртээмжтэй болгосоноор аюулгүй байдал, эсвэл эрсдэл талаасаа ямар нэг асуудал дагуулж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам ([www.mne.mn](http://www.mne.mn)) вэб хуудсаараа яамны үйл ажиллагааны тухай мэдээлэл, зарим үед байгаль орчны талаархи Засгийн газрын бусад байгууллагуудын үйл ажиллагааны тухай мэдээллийг хүргэж байна. Вэб хуудсанд тавигдаж байгаа мэдээллийг Яамны хэвлэл мэдээллийн алба хариуцан бэлтгэдэг байна. Өдөрт 3,000- 4,000 хэрэглэгч вэб хуудсанд нэвтэрч байгаа бөгөөд хамгийн их хандалттай хэсэг нь лиценци болон зөвшөөрлийн хэсэг байна. Вэб хуудсыг нээж ажиллуулаад 10 жил болж байгаа, түүний холбох хэсгийг (интерфасе) 3-5 жил тутам шинэчилж байна. Нэгэнт вэб хуудасны контент болон үйлчилгээтэй холбоотой өнгөрсөн хугацааны статистик мэдээлэл байхгүй учир вэб хуудас хэрхэн хөгжиж өргөжиж ирсэнийг үнэлэх боломж байхгүй байна.



Байгаль орчны мэдээлэлд нэвтрэх гол платформ нь Байгаль орчны мэдээллийн төв бөгөөд одоогоор тус төвд байгаль орчны 29 гол мэдээллийн сан байгаа бөгөөд тэдгээрийг тусгайлсан вэб хуудсаар (<http://www.eic.mn>) дамжуулан олон нийтэд хандах боломжийг олгож байна (Бүлэг 4). Байгаль орчин, аялал жуулчлалын яам өөрийн вэб хуудсаар ойн менежмент, ойн аж ахуй, ус ба газрын зэрэг хэд хэдэн мэдээлэл нийтэд нээлттэй байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яам нийтэд нээлттэй байх мэдээлэл, төлбөргүй мэдээлэл болон төлбөртэй мэдээллийн жагсаалтыг батлах эрхтэй байна.

Байгаль орчинтой холбоо бүхий мэдээллийг өөрсдийн вэб хуудсаар хүргэж байгаа бусад байгууллагуудад: Цаг уур, байгаль орчны шинжилгээний газар (<http://namem.gov.mn>); Стандарт хэмжил зүйн газар ([www.masm.gov.mn](http://www.masm.gov.mn)); Үндэсний хууль эрх зүйн хүрээлэн (<http://legalinfo.mn>); Үндэсний статистикийн газар ([www.nso.mn](http://www.nso.mn) and [www.1212.mn](http://www.1212.mn)); Ашигт малтмал, газрын тосны газар (<http://edu.mgram.gov.mn>) орж байна. ЦУОШГ-ын Зайнаас тандан судлах үндэсний төвөөс байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээг олон нийтэд хүргэж байна (<http://icc.mn/index.php?content=58/>).

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг сурталчилахаад олон нийтийн оролцоог дайчлах болон хэрэглэгчийн хяналт, хариуцлага мэдлэгийг өндөржүүлэх үүднээс Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас (МХЕГ) (Бүлэг 1 ба 2) олон нийтэд санал бодлоо илэрхийлэх боломжийг олгож байна. МХЕГ хэд хэдэн шалгах-жагсаалтыг (санал авах маягт) боловсруулан гаргаж, түүнийг онлайнаар (<http://home.inspection.gov.mn>) бөглөх боломжтой болгосон байна. Нийт 14 шалгах-жагсаалтыг хүнсний бүтээгдэхүүн үйлчилгээ, эрүүл мэнд, хөдөлмөр ба нийгмийн хамгаалал, барилга ба цаг уурын салбарыг хамруулан гаргажээ.

Олон нийтийг байгаль орчны мэдээлэлээр хангах болон байгаль орчны асуудлаар олон нийтийн ойлголтыг гүнзгийрүүлэх чиглэлээр ажиллаж байгаа Засгийн газрын бусад байгууллагуудын үйл ажиллагааны одоогийн практик, баримталж байгаа дүрэм журам нь харилцан уялдаа, авцалдаа муутай байна. Тухайлбал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам өөрийн вэб хуудсанд 2016 оноос хойш олон нийтээс хүлээн авсан санал гомдол, тэдгээрт өгсөн хариу зэрэг ерөнхий мэдээлэлийг байршуулж байна.

Аймгийн түвшинд, мэдээллийг аймгийн захиргааны вэб хуудсаар хүргэдэг байна. Жишээ нь: Сэлэнгэ аймаг (<http://selenge.gov.mn/beta/64/all0>); Архангай аймаг (<http://arkhangai.gov.mn/>); Говь-Алтай аймаг (<http://govi-altai.gov.mn/>); Баян-өлгий аймаг (<http://www.bayan-olgi.gov.mn/>); Дархан аймаг (<http://darkhan.gov.mn/>); Дорнод аймаг (<http://www.dornod.gov.mn/>)) зэрэг вэб хуудсаар мэдээлэл түгээж байна. Олонхи аймгуудын засаг захиргааны вэб хуудсууд нь төстэй бүтэц, контенттэй бөгөөд байгаль орчны зарим нэг мэдээллийг байршуулсан байна. Гэхдээ, тийм мэдээллийг вэб хуудсанд тавьж байгаа давтамж нь удаан, дийлэнхи тохиолдолд холбоос нь ажиллахгүй эсвэл ямар ч холбогдолгүй мэдээлэл бүхий холбоост холбосон байна.

Орон нутгийн түвшинд (сум, баг), байгаль орчны тухай ерөнхий мэдээлэл, мөн ус болон агаарын чанар, ялангуяа хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх зэрэг ямар ч мэдээлэл байхгүй байна.

### Телевиз

Хэд хэдэн телевиз байгаль орчны тухай хөтөлбөрийг долоо хоног тутам, зарим үед илүү олон давтамжтай нэвтрүүлж байна. Телевизийн 9 дамжуулагчийн 42 сувгийн 11 нь байгаль орчин, аялал жуулчлалын тухай хөтөлбөрийг дамжуулж долоо хоногт нийт 33 цаг 30 минутын нэвтрүүлэг, суваг бүр дунджаар 15 минутаас 11 цагийн нэвтрүүлэг (2017 онд долоо хоногт 41 хөтөлбөрөөр бодож үзвэл) явуулж байна. Түүнээс гадна, ЭКО суваг байгаль орчны тухай хөтөлбөр явуулж байсан боловч саяханаас контент нь өөрчлөгдөж ийм хөтөлбөрийг оруулахгүй болсон байна. Байгаль орчны тухай хөтөлбөрийг ийнхүү хорогдуулах болсон нь тийм хөтөлбөрийг үзэх олон нийтийн сонирхол буурч, хөтөлбөрийн хамрах хүрээ болон чанартай холбоотой байж болох юм.

Байгаль орчны тухай болон байгаль орчинд санаа тавих асуудлаар олон нийтэд мэдээлэл хүргэхэд телевизийг хангалтгүй ашиглаж байна. Гэвч Монголын хаана ч гэсэн малчин өрхүүдэд сансарын холбоо ашиглан телевиз үзэх бүрэн боломжтой байгаа нөхцөлд телевиз нь хамгийн үр дүнтэй хэрэгсэл юм. Кабелийн телевиз хэрэглэгчдийн нийт тоо 2007 онд 89,689 байсан бол 2017 онд (гуравдугаар улиралд) 458,735 болж нэмэгдсэн байна. Орон нутгийн түвшинд телевизийн нэвтрүүлгийг уул уурхай, барилга буюу төлөвлөсөн бусад төслүүд байгаль орчинд хэрхэн нөлөөлөх талаар олон нийтийн хэлэлцүүлэг

хийх замаар малчдыг шийдвэр гаргахад татан оролцуулах боломж олгох нэвтрүүлгийг бэлтгэж дамжуулах ажлыг зохион байгуулахгүй байна.

### Бизнес эрхлэгчдээс байгаль орчны мэдээллийг түгээж байгаа байдал

Бизнесийн байгууллагуудын байгаль орчны мэдээллийг нийтэд идэвхитэй түгээн тараахад чиглэсэн ажлыг Засгийн газар хөхүүлэн дэмждэг байна. Монгол улс 2006 оноос Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгыг (ОҮИС) хэрэгжүүлж байна. Уул уурхайн компаниуд өөрсдийн үйл ажиллагаатай холбоо бүхий бүх статистик мэдээг вэб хуудсандаа байршуулах шаардлагатай бөгөөд тэдгээр мэдээллийг дараа нь ОҮИС-ын вэб хуудсанд байршуулна. ОҮИС-д нэгдэн орсоноор мэдээллийн хүртээмжийг сайжруулж, улмаар орон нутагт эрхэлж байгаа уурхайн үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналтыг бэхжүүлнэ. Уурхайн сөхөн сэргээлтээс байгаль орчныг хамгаалах тусгай санд орж байгаа орлогыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам ил тод мэдээлэхгүй байгаа нь мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангахад саад бэрхшээл учруулж байна (Шигтгээ 2.1). Бас нэг санаа зовоох асуудал бол уул уурхайн компаниуд тийм мэдээллийг өөрсдийн вэб хуудсанд тавих сонирхолгүй байдаг явдал юм. Гэхдээ, бизнесийн байгууллагуудаас байгаль орчны мэдээллийг нээлттэй болгож, идэвхитэй түгээхийг хөхиүлэн дэмжиж байгаа Засгийн газрын чармайлт дөнгөж эхлэлийн үедээ явж байгаа боловч уул уурхайгаас бусад салбарт эл байдал огт ажиглагдахгүй байна.

### Бусад

Засгийн газрын бус олон улсын нэлээд олон санаачилгууд байгаль орчны мэдээллийг өөрсдийн вэб хуудсанд тавьж байна: ([www.publishwhateoupay.org/members/mongolia/](http://www.publishwhateoupay.org/members/mongolia/))

### *Мэдээллийн идэвхигүй хандалт*

Байгаль орчны мэдээллийн идэвхигүй хандалт буюу хүртээмж гэдэг нь олон нийтийн зүгээс Засгийн газрын байгууллагуудаас мэдээлэл авахыг хүсэх эрх бөгөөд засгийн газрын байгууллагууд тэдгээр хүсэлтийн дагуу шаардлагатай мэдээлэл гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

Олон нийтийн зүгээс байгаль орчны холбогдол бүхий мэдээлэл олж авахтай холбоотой хоёр төрлийн хүсэлт байдгийн нэг нь байгаль орчны холбоотой мэдээлэл авах хүсэлт, харин нөгөөх нь өргөдөл, гомдол байдаг байна. Мэдээлэл авах хүсэлтийг Мэдээллийн ил тод байдал ба Мэдээлэл авах эрхийн тухай 2011 оны хуулиар зохицуулж байна. Захиргааны журмын тухай 2015 оны ерөнхий хуулиар өргөдөл болон гомдлын зохицуулж байна.

### Мэдээлэл авах хүсэлт

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай 2011 оны хуульд мэдээлэл олж авах талаар ерөнхий заалтууд байдаг, тухайлбал мэдээлэл авахыг хүсэх журам, мэдээлэлийг олгох, үйлчилгээний хөлс болон зарим нэг мэдээллийг гаргахыг хориглох зэрэг асуудал тусгагдсан байна. Хуульд заасны дагуу, иргэд олон нийт (иргэд, хуулийн этгээд) –ийн мэдээлэл авах тухай хүсэлтийг ажлын долоон өдөрт багтаан хариу өгөх бөгөөд хэрэв тухайн хүссэн мэдээллийг бэлтгэхэд илүү хугацаа шаардлагатай байвал дахин долоо хоногоор сунгаж болдог байна. Хүсэлт гаргасан мэдээлэл нь өөр байгууллагын эзэмшилд байгаа бол хүсэлтийг тухайн байгууллагад ажлын хоёр өдрийн дотор шилжүүлж, энэ тухай хүсэлт гаргагчид мэдэгдэнэ. Хуульд хүсэлтийн хариуг нэн даруй өгч, асуудлыг шуурхай шийдвэрлэнэ гэж заажээ.

### Гомдол

Иргэд болон хуулийн этгээд мэдээлэл авах хууль ёсны эрх нь зөрчигдсөн гэж үзвэл дээд шатны салбарын байгууллагад (Байгаль орчин, аялал жуулчлалын яам), эсвэл Монгол улсын Хүний эрхийн үндэсний комисст, эсвэл шүүхэд гомдол гаргаж болно. Дээд шатны байгууллагад гаргасан гомдлыг Төрийн албан хаагч болон төрийн байгууллагын эсрэг гаргасан иргэдийн гомдлыг шийдвэрлэх тухай 1995 оны хууль; 2015 оны Захиргааны ерөнхий хууль болон 2002 оны Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулиар зохицуулдаг байна. Шүүхэд гаргасан гомдлыг Захиргааны ерөнхий хууль болон Иргэний хуулийн дагуу хянан шийдвэрлэнэ.

Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд гаргасан өргөдөл гомдлыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу зохицуулна. Энэхүү хуулийн дагуу гомдлыг 30 өдрийн дотор шийдвэрлэнэ. Хэрэв нэмэлт мэдээлэл шаардлагатай бол гомдлын хариу өгөх хугацааг дахин 30 өдрөөр сунгаж болдог байна.

#### Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Байгаль орчин, аялал жуулчлалын яам хүлээн авсан гомдлын хариуг тухайн гомдлын шинж чанар болон гомдол гаргасан хэлбэрээс шалтгаалан бичгээр, амаар болон илүү нарийвчилсан тайлбар хэрэгтэй бол биечлэн уулзаж өгдөг байна. Олон нийтээс гаргаж байгаа өргөдөл, гомдлыг хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх үүднээс яамны үүдний хэсэгт нэвтрэх цэгийн хажууд тусгай хайрцаг байрлуулсан байна.

Олон нийтийн ирүүлсэн өргөдөл, гомдлыг Яамны бичиг хэргийн хэсэгт хадгална. Яаралтай анхаарал хандуулах өргөдөл, гомдлыг тусгайлан томилсон ажилтан хариуцах ба байгаль орчны талаар мэдээлэл авах хүсэлтийг ердийн журмаар бүртгэн, холбогдох газар, хэлтэст шилжүүлнэ.

Ноцтой гомдол мэдээлэл хүлээн авсан тохиолдолд тусгай журам үйлчилнэ. Энэ тохиолдолд санхүүгийн нөхөн олговор олгох механизм үйлчилж, хууль бус үйл ажиллагааны талаар мэдээлсэн иргэнд мөнгөн урамшуулал (ногдуулах торгуулын хувь хэлбэрээр) олгоно (Бүлэг 1). Хэрэв гомдол нь нэн ноцтой бол тусгай ажлын хэсгийг цагдаагийн байгууллага, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, бусад холбогдох яамд, орон нутгийн албан тушаалтнууд болон ТББ-н төлөөлөлийг оролцуулан байгуулан ажиллуулдаг байна. Ажлын хэсэг тухайн асуудал хууль зөрчсөн тогтсон 14 өдрийн дотор хянан үзнэ. Хэрэв тухайн асуудал ихээхэн ээдрээтэй асуудал байвал хянан шалгах хугацааг дахин 14 өдрөөр сунгаж болдог байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас гаргасан статистик мэдээгээр, 2016 оны дөрөвдүгээр улирлын байдлаар яамны нийт хүлээн авсан 308 өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 70 хувьтай байсан бол энэ хугацаанд ЦУОШГ-н хүлээн авсан 111 өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 98 хувьтай байжээ. Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон түүний харьяа байгууллагуудад 2017 оны эхний хоёр улирлын байдлаар иргэд, бизнесийн аж ахуйн нэгж, байгууллагуудаас 313 өргөдөл, гомдол ирсэн байна. Шийдвэрлэлт 85 хувьтай, 47 хүсэлтийг 2017 оны дунд үе гэхэд хянаж байгаа ажээ. Үүний зэрэгцээ, асуудлыг шийдвэрлэх 2, 7 болон 30 өдрийн тогтоосон хугацааг баримтлан зохих ёсоор шийдвэрлэсэн эсэх нь тодорхойгүй байна.

#### Бусад асуудал

Орон нутгаас (аймаг, сум) хүлээн авсан өргөдөл, гомдлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам тухайн аймгийн захиргаанд, тухайлбал аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газарт шилжүүлдэг байна. Тэдгээр хүсэлтэд 30 болон 14 өдрийн дотор хариу өгч шийдвэрлэх журамтай ажээ.

Түүнээс гадна, Байгаль орчин, аялал жуулчлалын яам байгаль орчныг янз бүрийн газар нутагт хэрхэн хамгаалах талаар иргэдээс санал хүсэлт хүлээж авдаг байна. Жишээ нь, 2016 онд уурхайн болон хайгуулын үйл ажиллагааны үед байгаль хамгаалах асуудлыг хэрхэн сайжруулах болон хулгайн мод бэлтгэлийн асуудлаар нэлээд олон санал хүлээн авсан байна.

#### *Мэдээлэл авахад тавих хязгаарлалт*

Мэдээллийн ил тод байдал ба Мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу, Монгол улс дараах үндэслэлээр мэдээлэл олж авахад хязгаарлалт тавьж байна:

- Онцгой нөхцөл байдалд (үндэсний аюулгүй байдал ба олон нийтийн ашиг сонирхол; сонгон шалгаруулалт эсвэл мэрэгжлийн хяналтын хянаж байгаа асуудлуудтай холбоотой асуудал; улсын нууц, байгууллага болон хувь хүний шалгагдаж байгаа, мөрдөн байцаалт болон яллах үйл ажиллагааны хяналтад байгаа хэргүүд; олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах явц болон үндэсний бусад хууль тогтоомжид заасан тэдгээртэй холбогдох бусад мэдээлэл);
- Оюуны өмчийг хамгаалах;
- Хувь хүний нууцыг хамгаалах;
- Байгууллага, бизнесийн нууцыг хамгаалах.

Үүний зэрэгцээ, Байгууллагын дотоод асуудлын тухай 1995 оны хуульд дараах мэдээллийг нууцлахыг зөвшөөрөөгүй байна:

- Олон нийтийн эрүүл мэнд болон байгаль орчинд нөлөөлөл бүхий байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, техник болон технологийн холбогдол бүхий мэдээлэл;
- Байгууллагын эзэмшилд байгаа олон нийтийн эрүүл мэнд болон байгаль орчинд аюултай байж болзошгүй бүх төрлийн хортой болон цацрагийн туяа бүхий бодисууд;
- Үндэсний хууль тогтоомжийн дагуу олон нийтэд нээлттэй болгох гэмт хэргийн мэдээлэл.

Гомдлын чанартай мэдээллийг хэн ч гаргаж болох бөгөөд ямар нэг хязгаарлалт байхгүй, өөрөөр хэлвэл хэн ч өргөдөл гаргаж болно. Хүлээн авсан өргөдлийг хэрхэн шийдвэрлэсэнд жил бүр хянаж үнэлгээ хийдэг.

### *Төлбөр*

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд мэдээлэл авахад тодорхой хэмжээний төлбөр төлөх тухай заасан байна. Төлбөрийн хэмжээг тухайн мэдээллийг бэлтгэн хүргүүлж байгаа байгууллагын удирдлага тогтоох ба төлбөрийн хэмжээ нь мэдээллийн хуулбар хийх болон шуудангийн зардлаас хэтрэхгүй байхаар заажээ. Хуульд мөн төлбөрийн хөнгөлдөлт үзүүлэх эсвэл төлбөрөөс чөлөөлөх асуудлыг Засгийн газрын зөвшөөрлөөр гүйцэтгэхээр заасан байдаг байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны тухайд бол байгаль орчны тухай мэдээлэл авахыг хүссэн албан ёсны хүсэлтийг хүлээн аваад тухайн мэдээлэл нь тайланд эсвэл нийтлэгдсэн материалд бэлэн байгаа бол үнэ төлбөргүй өгнө. Гэхдээ, байгаль орчны тодорхой мэдээлэл хүссэн (жишээ нь, хил дамнасан усны хагалбар г.м) хүсэлтийн хувьд Яам тухайн мэдээллийг бэлтгэн өгөх чадавхгүй, эсвэл тухайн хүсэлтийг биелүүлэх боломжгүй байж болно. ЦУОШГ-т олон жилийн агаарын чанарын талаар мэдээлэл авах хүсэлт ирүүлсэн бол тухайн хүсэлтийг төлбөртэй (хэмжээг өгөгдөл бүрийн тоогоор тогтооно) олгоно. Хэрэв хувь хүн эсвэл байгууллагын тухай мэдээлэл авахыг хүссэн бол тийм мэдээлэл нь нууцын зэрэглэлд хамаарах учир тийм мэдээллийг өгөх боломжгүй байдаг байна. Засгийн газрын бусад байгууллагуудын мэдээлэл олж авах төлбөр болон мөрдөх дүрэм журмын хувьд үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

### *Хэрэгжүүлэхэд тохиолдож байгаа саад бэрхшээл, сорилт*

Ерөнхийдөө байгаль орчны тухай мэдээлэлийн хүртээмжийг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн боловч тэдгээрийг хэрэгжүүлэх явдал Засгийн газрын байгууллагууд болон хувь хүний хувьд төдийлөн мөрдөгдөхгүй, саад бэрхшээл учирсаар байна. Олон нийтийн зүгээс мэдээлэл авахыг хүссэн хүсэлтийг хуульд заасны дагуу 2-7, 30 өдрийн дотор шуурхай хэрэгжүүлэх тодорхой бүтэц Засгийн газарт байхгүй байна. Олон нийтийн хувьд, мэдээлэл авах эрх болон үүнтэй холбогдсон хуулийн заалтууд, механизмын талаар мэдлэг хомс байна. Энэ нь 2012 оноос хойш холбогдох хууль тогтоомжид олон удаа өөрчлөлт орж ирсэнтэй холбоотой юм.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх нэгжийн хувьд төдийлөн шуурхай, хангалттай ажиллаж чадахгүй байна. Ялангуяа, иргэдийн хүсэлтийн шийдвэрлэж байгаад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Яамны хувьд энэ тухайд цогц хяналт тавьж чадахгүй байна, тухайлбал хүсэлт бүрт хариу өгсөн хугацааг хянахгүй байна (вэб хуудсанд хүсэлтийн хариуг хугацаанд нь өгсөн болон хугацаа хожигдуулсан байдлыг хувиар гаргасан ч чухам хэдий хугацаанд өгсөн, хэдэн өдрөөр хожимдуулсаныг тодорхой тэмдэглэхгүй байна).

Өөр нэг асуудал бол, байгаль орчны тухай, тухайлбал боловсруулаагүй, нэгтгэсэн, өөрчлөгдсөн тухай мэдээлэл цахим орчинд байхгүй байна.

## 5.2 Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоо

### *Байгаль орчны ТББ-ууд*

Бүртгэл мэдээллийн ерөнхий газарт бүртгэлтэй ТББ нийт 16,609 байгаагаас 487 нь байгаль орчны ТББ гэж бүртгүүлсэн байна (2017 оны 8 сарын байдлаар). Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэдээгээр бол байгаль орчны 100 орчим ТББ идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна.

Олон тооны “тамга цүнхэлсэн” ТББ буюу “хиймэл” ашгийн бус байгууллагуудыг нэг, хоёр хүн байгуулж, зөвхөн хандивлагчдаас мөнгө авах зорилго агуулдагаас биш тусгайлсан үйл ажиллагааны хөтөлбөргүй байна. Түүнчилэн, засгийн газарт ажиллаж байсан хүмүүс янз бүрийн ТББ байгуулах явдал ихээхэн түгээмэл байна.

Түүнээс гадна, Монголд олон улсын 90 ТББ ажиллаж байгаагийн 11 нь байгаль орчны чиглэлээр ажиллаж байна.

ТББ-уудыг 2015 оноос Улсын бүртгэл мэдээллийн газарт бүртгэж эхэлсэн байна. Үүнээс өмнө Хууль зүйн яаманд бүртгүүлсэн ТББ-ууд дахин бүртгүүлэхийн тулд нэмэлт мэдээлэл бас хүргүүлэх шаардлага тавигдсан, тэдгээр нэмэлт мэдээллийн олж авахад бэрхшээлтэй байсан зэрэг нь ТББ-уудад тодорхой саад бэрхшээл учруулж байжээ. Энэ бэрхшээл янз бүрийн ТББ-уудад, түүний дотор байгаль орчны ТББ –дад ч тохиолдож байсан байна. 2014 онд бүртгэлтэй байсан байгаль орчны 706 ТББ 2017 онд 487 болж буурсан нь нэг талаар зарим нэг ТББ үйл ажиллагаагаа зогсоосон байх талтай ч нөгөө талаар бодит амьдрал дээр дахин бүртгүүлэх ТББ гэж байгаагүйтэй холбоотой байж болно. Улсын бүртгэл мэдээллийн газар шинээр бүртгүүлэхэд 44,000 төгрөгийн (ойролцоогоор 20 доллар) төлбөр авдаг ба харин дахин бүртгүүлэхэд ямар нэг төлбөр авдаггүй байна.

Монголд олон тооны байгаль орчны ТББ-уудын холбоо, хөдөлгөөнүүд байна (Шигтгээ 5.1). Холбоо, хөдөлгөөн байгуулан ажилласанаар ТББ-ууд үйл ажиллагаагаа илүү зорилттой, үр дүнтэй явуулахад нь дэмжлэг болдог байна.

### **Шигтгээ 5.1: Байгаль орчны ТББ-уудын холбоод, хөдөлгөөнүүд, тэдгээрийн үйл ажиллагааны үр дүн**

Монгол улсад олон тооны ТББ-ын холбоод, хөдөлгөөнүүд ажиллаж байна. Зарим нэг ТББ хэд хэдэн холбоодын гишүүн байна.

Монголын байгаль орчны иргэний зөвлөл нь хууль, дүрэм журам, зохицуулалт, бодлогын төслийг боловсруулахад олон нийтийн оролцоог хангах зорилгоор анх байгуулагджээ. Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай нягт хамтран ажиллаж, байгаль орчны холбогдол бүхий хууль тогтоомжийн төслийн боловсруулахын тулд Яамны байгуулсан янз бүрийн ажлын хэсгүүдэд өөрийн төлөөллийг оролцуулдаг байна. Түүний гишүүнчлэлд 140 байгууллага хамрагдаж байна.

“Юу төлсөнөө нийтэл” эвсэл нь Монгол улсад 2006 онд байгуулагджээ. Эвсэл нь ОУИС –ыг үр дүнтэй хэрэгжүүлэх асуудалд анхаарал тавин ажиллаж, иргэд болон орон нутгийн түвшинд байгалийн баялагийн ашиглалт, хууль тогтоомжийн биелэлтийн асуудлаар хамтран ажиллаж байна. Эвсэл нь уул уурхайн бүх шатны үйлдвэрлэлийн ил тод байдалыг хангах болон байгалийн нөөц баялагтай холбогдсон хэлэлцүүлэгт олон нийтийн оролцоог хангах кампанит ажлыг удирдан зохион байгуулж байна. Эвсэлийн гишүүнчлэлд 29 байгууллага оролцож байна.

Монголын гол мөрөн, нууруудын нэгдсэн хөдөлгөөн нь гол мөрний сав газруудыг алтны уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөс хамгаалах 11 гол мөрний хөдөлгөөнийг нэгтгэжээ. Хөдөлгөөн нь 2009 оны Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг батлахад чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Ус хамгаалах талаар талаар идэвхитэй оролцож байгаа иргэний нийгмийн байгууллагын нэг жишээ бол Хатан Туулыг аврах Үндэсний хөлгөөн юм. Уг хөдөлгөөн нь Туул голын сав газарт ашигт малтмал ашиглах зөвшөөрлийг цуцлах шаардлагыг Засгийн газарт тавьж ажилладаг ба голын орчинд олборлолт явуулж ноцтой сөрөг үр дагавар дагуулж байгаа нь Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай 2009 оны хуулийн заалттай нийцэхгүй байгааг тэмдэглэж байна.



Байгаль орчны идэвхтэнүүдийг мөрдөн хавчих тохиолдлууд гарсаар байна. Засгийн газрын зүгээс иймэрхүү үзэгдлийг таслан зогсоох, ийм үйлдлийн мөрөөр шалгаж ямар нэг хууль бус үйлдлийг тогтоон зогсоох талаар ямар арга хэмжээ авдаг нь тодорхойгүй байна. Монголын Ирвэс хамгаалах сангийн зохицуулагчийн цогцосыг 2015 оны 11 дүгээр сард Хөвсгөл нуурын орчимд олсон ба үүнийг цагдаагийн газар усанд унаж амь насаа хөнөөсөн үйлдэл гэж тогтоосон боловч өмнөх хоёр жилийн хугацаанд зохицуулагчийн амь насанд халдах оролдого гурван ч удаа гарч байсан нь Тост ууланд (Говьд байдаг Алтайн нуруунд байдаг уул) тусгай хамгаалалттай газрын тухай хуулийг хэрэгжүүлэх гэсэн түүний хүчин чармайлт гаргаж байсны нь хариу үйлдэл байсан байна. Өөр нэг тохиолдол бол, Говь-алтай аймгийн орон нутгийн иргэдийн дөрвөн төлөөллийг Засгийн газрын ажлын хэсэгт уул уурхай сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа талаар мэдээлсэний нь төлөө уул уурхайн компани нэр төрийг нь гутаасан гэж 2013 онд шүүхэд өгч байсан байна.

Түүнээс гадна, байгаль орчны идэвхтэнүүдийг бизнесийн компаниуд шахан хавчихын зэрэгцээ Засгийн газрын зүгээс ч тэднийг хавчин мөрдөх тохиолдол гарч байсан байна. Үүний нэг тод жишээ бол, усны эх үсвэрийг уурхайн бохирдолоос хамгаалахаар тэмцсэн байгаль орчны идэвхтэнийг 2013 онд браивчилж, улмаар террорист үйл ажиллагааны ангилалаар шийтгэсэн байна. Бас нэг өөр жишээ бол, усан цахилгаан станцын төслийн байгаль орчны үнэлгээ нь хэр үндэслэлтэй, хангалттай хийгдсэн эсэхэд эргэлзээтэй байгаагаа илэрхийлсэний төлөө Оросын Холбооны улсын байгаль орчны идэвхтэнийг Монголоос албадан гаргаж байсан байна.

#### *Төлөвлөсөн төслүүдийн талаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоо*

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд (БОНУ) олон нийтийг оролцуулж байх тухай хууль тогтоомжид заасан (Бүлэг 2) байдаг. Гэвч төслүүдийн талаар шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоог хангах ажил хангалттай үр дүнтэй хэрэгжихгүй байна. Хууль тогтоомж нь Монгол улсын асар уудам газар нутагт оршин суугаа нүүдэлчин иргэдийн онцлогыг анхааран авч үзээгүй учир тухайн иргэдийн оршин суугаа нутагт хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төслүүдийн хэлэлцүүлэгт иргэдийн оролцоо хангалтгүй явж иржээ. Жишээ нь, төлөвлөж байгаа төслийн талаар (нарийвчилсэн БОНУ хийгдсэн тохиолдолд) 30 ажлын өдрийн хугацаанд хэлэлцүүлэгийг зохион байгуулахаар заасан нь, ялангуяа зуны улиралд нүүдэлчин малчин иргэд бэлчээр сэлгэн олон удаа нүүдэллэдэг учир хангалттай хугацаа биш юм. Багийн түвшинд ажиллаж байгаа орон нутгийн захиргаа болон төсөл хэрэгжих нутаг оронд ажиллаж байгаа ТББ-ууд олон нийтийн хэлэлцүүлгийг хэрхэн зохион байгуулах, иргэдийг хэрхэн татан оролцуулах талаар чадавхи дутагдалтай байна. Компаний олон нийттэй харилцах асуудал хариуцсан төлөөлөгчид ч хэлэлцүүлэгийг хэрхэн үр дүнтэй зохион байгуулах талаар шаардлагатай мэдлэг чадвар нь бас дутагдалтай байна.

Гар утасны хэрэглээ сүүлийн 10-аад жилд асар их нэмэгдэж, 2007 онд 1.1 сая дугаар хэрэглээнд байсан бол 2017 онд (гурвадугаар улиралд) 3.6 сая болж гурав дахин өссөн нь 100 иргэнд 120 гар утасны дугаар ногдож байна гэсэн үг юм. Гэвч, гар утасны сүлжээг болох гэж байгаа хэлэлцүүлэгийн талаар иргэдэд мэдээлэл хүргэхэд төдийлөн хангалттай ашиглахгүй байна. Түүнээс гадна, орон нутгийн телевизүүдийн сувгуудыг төлөвлөж байгаа төслүүд, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний дүнг иргэдэд хүргэх болон төлөвлөж байгаа төслүүдийн талаар шийдвэр гаргахад иргэд ямар эрхтэй, ямар журмаар оролцох талаар иргэдийн мэдлэг ойлголтыг бэхжүүлэх талаар мэдээллэлээр хангахад ашиглахгүй байна.

Тун цөөн тохиолдолд, олон нийт өөрсдөө зохион байгуулж нөхцөл байдлын талаар ашиг сонирхолоо илэрхийлэх боломж олдож байна (Шигтгээ 5.2).

#### **Шигтгээ 5.2: Тэмээчид өөрсдийн эрхээ хамгаалж байна**

Тэмээчдийн хоёр бүлэг 2012 онд Монголын хоёр ТББ-ын (Говийн хөрс болон Оюу толгойн хяналт) тусламжтайгаар Олон улсын санхүүгийн корпорацийн хөрөнгө оруулалтын үр дагаварт нэрвэгдсэн орон нутгийн иргэдийн маргааныг шийдвэрлэх үүрэг бүхий Өргөдөл гомдол барагдуулах Зөвлөх (Омбудстан)-д гомдол гаргасан байна. Малчид Оюу толгойн зэс-алт-мөнгөний уурхайн төсөл нь тэдний амьжиргаа, эрүүл мэнд, зан заншилд аюул занал учруулж байна гэж гомдол мэдүүлсэн байна.

Эл асуудлаар яриа хэлэлцээ дөрвөн жил (2012 оны 10 сараас 2017 оны 5 сар) Дэлхийн банкны Өргөдөл гомдол барагдуулах Зөвлөхийн зуучлалтайгаар үргэлжилсэн байна. Үүний үр дүнд Оюу толгой ХХК болон уурхайг хамтран өмчлөгч Засгийн газар 50 гаруй үүрэг хүлээхээр болсон байна.

Хариуцлага хүлээлгэх зөвлөл (АНУ-д байдаг ашгийн бус байгууллага) малчдыг дэмжиж, яриа хэлэлцээний бүхий л явцад малчдад хуулийн зөвлөгөө өгч, яриа хэлэлцээг хэрхэн явуулах сургалт зохион байгуулж байсан байна.

Хэрэгжилт нь хүлээгдсээр байгаа боловч байгуулсан хэлэлцээрийн хүрээнд малчид болон байгаль орчны хувьд ашигтай байх байх нэлээд хэдэн заалтууд орсон байна, тухайлбал: шинээр худаг гаргах, байгаа худгуудыг засаж засварлах; бэлчээрийн менежментийн төлөвлөгөө гаргах; уурхайн үйл ажиллагаанд тавих нөлөөллийн хяналтыг сайжруулах; нөхөн төлбөрийн багцыг хянан үзэх, илүү олон малчдийг хамруулах шалгуурыг өргөжүүлэх; малын тэжээл тариалах хөтөлбөрийг нэвтрүүлэх; малчдад үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах зэрэг асуудал орсон байна.

#### *Зөвшөөрөл олгоход олон нийтийн оролцоо*

Хууль тогтоомжид зөвшөөрөл олгох үйл явцад олон нийтийн оролцоог хангах заалт байхгүй (Бүлэг 2) байна.

#### *Байгаль орчны стратеги үнэлгээнд олон нийтийн оролцоо*

БОСҮ-нд олон нийтийн оролцоог хангах асуудлыг БОНУ-ний тухай 2012 оны хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2014 оны А-03 тоот тушаалаар зохицуулж байна. Гэвч, 2017 оны дунд үе гэхэд БОСҮ-г огт хийгээгүй учир олон нийтийн оролцоог хангах асуудлаар ямар нэг туршлагагүй байна (Бүлэг 1).

#### *Хууль боловсруулахад олон нийтийн оролцоо*

Байгаль орчин, аялал жуулчлалын яам Монголын Байгаль орчны Иргэний зөвлөлийн төлөөлөгчдийг хууль, журам болон бодлого боловсруулах ажлын хэсэгт оролцуулах замаар нягт хамтран ажиллаж байна. Зөвлөлийн хүрээнд ТББ-уудын хуулийн төсөл боловсруулахад хувь нэмэр оруулах оролцоог өргөжүүлэх зорилгоор Ногоон парламентыг байгуулжээ. Парламентийн байнгын хороодын хуралд Зөвлөл бас оролцож байна. Харин иргэний нийгмийн бүх байгууллага тус Зөвлөлд ордоггүй. Тэдгээр байгууллагууд (Байгаль хамгаалах Үндэсний Хоршоодын холбоо, Хэрэглэгчдийн бүлгүүд – ой, ус, малчид) өөрсдөө шууд холбоо тогтоон боловсруулж байгаа хуулийн төслийн ажлын хэсгүүдэд тухайн сэдвээс нь хамааран оролцож байна. Харин учирч байгаа саад бэрхшээл бол ТББ-уудын гаргасан санал, тайлбарууд хуулийн төсөлд тусгагдсан байсан ч Хууль зүйн яам болон парламентийн түвшинд ихэвчлэн янз бүрийн байдлаар хасаж байгаа явдал юм. Бас өөр нэг саад бэрхшээл бол ТББ-уудын хувьд хууль, зохицуулалтын төслүүдэд өндөр чанартай санал, тайлбар гаргах мэргэжлийн түвшин, мэдлэг дутагдаж байгаа явдал юм.

Хуулийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангах үүднээс 2015 оны Хууль тогтоомжийн тухай 2015 оны хуульд (2017 оны 1 дүгээр сард хүчин төгөлдөр болсон, 2017 оны 5 дугаар сард шинэчилсэн) шинэ хуулийн төсөл эсвэл шинэчлэх болон холбогдох дүрэм журмыг боловсруулахдаа вэб хуудсанд ажлын 15 өдөр байршуулан олон нийтийн хэлэлцүүлэг хийж байхаар заасан. Санал тайлбар бүхний хариуг хэлэлцүүлгийн сүүлийн өдрөөс хойш 30 өдрийн дотор вэб хуудсанд байршуулна. Хуульд, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа ТББ-ууд болон олон нийтийн бусад холбоодтой шинэ хуулийн төсөл эсвэл шинэчлэх төслийн талаар зөвлөлдөж байх шаардлагатай гэж бас заажээ. Хэлэлцүүлгийн хугацааг 15 өдрөөр тогтоож байгаа нь өргөн уудам нутагтай орны хувьд үр дүнтэй хэлэлцүүлэг явуулахад хэтэрхий богино хугацаа юм.

#### *Стандарт боловсруулахад олон нийтийн оролцоо*

Монгол улсын Стандарт, хэмжил зүйн газар шинэ стандартыг боловсруулахдаа тухайн стандартын төслийг вэб хуудсанд байршуулан олон нийтийн санал тайлбарыг авч байна ([www.masm.gov.mn](http://www.masm.gov.mn)).

#### *Генийн өөрчлөлттэй организмын талаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоо*

Үндэсний Био-аюулгүй байдлыг хангах хороог Байгаль орчин, аялал жуулчлалын сайд удирдаж, биологийн аюулгүй байдал болон ГӨО -той холбоотой үйл ажиллагааг Монгол улсад хянах үүрэг хүлээдэг (Бүлэг 7). Засгийн газрын төлөөллөөс гадна Хорооны бүрэлдэхүүнд шинжлэх ухааны байгууллагууд болон ТББ-уудын төлөөлөл оролцдог байна. Энэ бүхнээс гадна, генетикийн өөрчлөлтэй

организмын талаар мэдээлэх тухай шийдвэр гаргахад олон нийтийг оролцуулах талаар хуулийн ямар нэг заалт болон механизм байхгүй байна.

#### *Байгаль орчны сангуудийн ашиглалтад олон нийтийн оролцоо*

Байгаль орчны сангууд, тухайлбал Байгаль орчин, уур амьсгалын сангийн хөрөнгийг ашиглахтай холбогдсон асуудалд иргэд санал өгч болно (Бүлэг 3). Харин сангийн хөрөнгийг зарцуулахтай холбогдсон шийдвэрийг уг Сангийн ТУЗ (Байгаль орчин, аялал жуулчлалын сайд тэргүүлдэг) гаргадаг. ТУЗ-д ТББ-ууд болон хэрэглэгчдийн бүлгүүдийн холбоод орж байна.

#### *Байгаль орчны асуудлаар олон улсын түвшинд шийдвэр гаргахад олон нийтийн оролцоо*

Байгаль орчны талаархи олон улсын чуулган, хурлуудад ТББ-ын төлөөлөгчид үндэсний төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд бараг оролцдоггүй, тэдгээр хуралд Монгол улсын байр суурийг илэрхийлэх баримт бичгийг боловсруулахад тэдний оролцоо туйлын бага байна (Бүлэг 6). Оролцогч талууд болон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг олон улсын гэрээ хэлэлцээрт улс орны байр суурийг тусгах бэлтгэл ажилд оролцуулах талаар албан ёсны дагаж мөрдөх журам байхгүй байна (Бүлэг 7). ТББ-уудыг үндэсний тайлан илтгэл бэлтгэхэд оролцуулж байгаа тохиолдлууд байгаа ч гэсэн албан ёсны дүрэм журам байхгүй, бодит байдал дээр харилцан адилгүй байна.

#### *Байгаль орчныг хамгаалах олон нийтэд суурилсан арга барил*

Байгаль орчныг хамгаалахад иргэд, олон нийтэд суурилсан арга барил, хандлага Монголд сайжирч байна. Түүнээс гадна, ТББ-ууд, янз бүрийн хэрэглэгчдийн бүлгүүд болон хоршооллууд олон нийтийн оролцоог хангахад ихээхэн боломж болгож байна. Тэдгээрт ойн хэрэглэгчдийн бүлгүүд (Бүлэг 13); гамшгаас хамгаалах бүлгүүд (Бүлэг 14); уул уурхайн хоршооллууд (Бүлэг 1); малчдийн хоршооллоууд; тусгай хамгаалалтай газруудын иргэдэд түшиглэсэн захиргаа (Бүлэг 11) хамрагдаж байна. Хоршоолол болон хэрэглэгчдийн бүлгүүдийн үндэсний форумыг 2015 оноос, хоёр жил тутам зохион байгуулж байна. Хоёрдугаар форумын үеэр 800 орчим ТББ-ыг төлөөлсөн 1,000 шахам оролцогчид иргэд, олон нийтэд түшиглэсэн байгаль орчныг хамгаалах асуудлыг хэлэлцсэн байна.

### **5.3 Байгаль орчны асуудалд шүүхийн оролцоо**

Монгол улс эрүүгийн шүүх, иргэний шүүх болон захиргааны шүүх гэсэн гурван төрлийн шүүхийн тогтолцоотой. Байгаль орчны асуудлаар бие даасан шүүх байхгүй. Бусад байгууллагын хувьд, асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэхийн өмнө зохицуулах, тухайлбал байгаль орчны талаар гарсан гомдол хүсэлтийг шийвэрлэх тусгайлан томилогдсон хүн (омбудсман), байгууллага байхгүй байна.

Байгаль орчны захиргааны хэргийн хувьд, иргэн шууд шүүхэд хандах эсвэл байгаль орчны ТББ-ын төлөөлөлийг ашиглаж болно. Олон нийт, иргэд болон ТББ-ын төлөөлөл нь байгаль орчны холбогдол бүхий “байгаль орчны талаархи хуулийн заалтыг зөрчсөн” зэрэг байгаль орчны холбогдол бүхий асуудлаар гарсан шүүхийн бодит болон горимын шийдвэрээс татгалзан няцааж болно. Байгаль орчныг хамгаалах ТББ-ууд нь өөрсдийнхөө үүргийн дагуу байгаль орчинд учруулсан хохиролын асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй байна.

Байгаль орчны асуудлаарх шүүх процесс дөрвөн сар орчим үргэлжилдэг, эхний шат хоёр сар хүртэл, дараагийн хоёр, гуравдугаар шат тус бүр 30 өдөр үргэлжилдэг байна. Шүүхийн бүх шийдвэр олон нийтэд нээлттэй байдаг тул <http://new.shuukh.mn/> вэб хуудсанд орж танилцаж болно.

Иргэд болон ТББ-аас шүүхэд хандсан нөхцөлд Байгаль орчин, аялал жуулчлалын яамыг экспертиз хийлгэхээр ихэвчлэн урьж оролцуулдаг байна.

#### *Эрх зүйн туслалцаа*

Иргэд болон ТББ-н гишүүдэд байгаль орчны асуудлаар шүүхэд эрхээ хамгаалахад нь үзүүлэх эрх зүйн үнэ төлбөргүй туслалцаа (улсаас хангах) байхгүй байна. Байгаль орчны асуудлаар мэрэгшсэн 20 орчим өмгөөлөгч байна. Тэдгээр нь бүгд 2016 онд байгуулагдсан Монголын өмгөөлөлөгчдийн холбооны байгаль орчны салбарын гишүүд юм.

*Шүүгчдийн сургалт*

Байгаль орчны асуудлаар шүүгчдэд сургалт явуулдаггүй байна. Байгаль орчны асуудлаар тухайлан мэрэгшсэн шүүгч байхгүй байна.

*Зардал төлбөр*

Монгол улсад байгаль орчин төдийгүй ямарч асуудлаар шүүхэд хандаж хэрэг үүсгэхэд санхүүгийн зардал асар өндөр бөгөөд байгаль орчны асуудлаар иргэд шүүхэд хандах тэгш эрх, шудрага байдал хангагдаагүй байна.

Тэмдэгтийн хураамж нь Тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар зохицуулагдаж, иргэд олон нийт, ТББ-ууд тэмдэгтийн хураамж төлнө. Тэмдэгтийн хураамж харьцангуй өндөр байгаа нь иргэд болон ТББ-уудыг шүүхэд хандах эрмэлзлийг нь бууруулж байна.

Шүүхэд хэрэг үүсгэхэд ногдох төлбөрийн хэмжээ нь тухайн хэргийн нөхцөл байдлаас хамаарна. Шүүхэд хэрэг нээхэд төлөх төлбөрийн хэмжээ боломжийн хэмжээтэй (захиргааны шүүхэд хэрэг нээхэд 70,000 төгрөг, (ойролцоогоор 29 доллар)) байна. Хэргийг мөрдөн шалгахад шаардлагатай нотолгоо баримт цуглуулах зэрэг үйл ажиллагааны цар хүрээгээр төлбөрийн хэмжээ нэмэгдэх ба нэлээд тохиолдолд өртөг зардал байнга өсөн нэмэгдэж байгаагаас хамаарч хэргийг хаалгахад хүргэдэг байна. Захиргааны хэргийн 2016 оны ерөнхий хууль, мөн Захиргааны хэргийг шүүхээр шийдвэрлэх тухай хуулийн аль алинд шүүхтэй холбогдон гарсан зардлыг гэм буруутай тал бүрэн хариуцахыг заасан байдаг боловч шүүхийн эцсийн шийдвэр гарсаны дараа л эл асуудал шийдвэрлэгддэг байна. Шүүх ажиллагааны явцад нэхэмжлэгч нь бүх зардлыг хариуцан төлөх үүрэг хүлээдэг учир өндөр төлбөрийг төлөх чадвар, боломжгүй нөхцөлд хэргийг хаалгахад хүрдэг байна. Хандив цуглуулах ажил хийхгүй бол байгаль орчны асуудлаар шүүхэд хандсан олонхи хэргүүд өндөр төлбөрийн улмаас цуцлагдахад хүрч байна. Бас нэг нөлөөлж байгаа хүчин зүйл бол шүүх ажиллагааны сунжирсан урт хугацаа, давж заалдах шатыг оролцуулаад дөрвөн жил, түүнээс удаан хугацаагаар үргэлжлэх явдал гардаг байна.

Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай 2016 оны хуулинд шүүх ажиллагааны явцад хэрэв нэхэмжлэгч нь олон нийтийн эрх ашгийг хамгаалж байгаа бол шүүх ажиллагаатай холбогдсон төлбөрөөс чөлөөлөх тухай заалт байдаг байна. Энэ тохиолдолд төлбөрийг улсаас гаргаж, шүүхийн шийдвэр гарсаны дараа буруутай талаар нөхөн төлүүлдэг байна. Харин бодит байдал дээр хуулийн энэ заалт хэрэгжихгүй байгаа нь хөрөнгө санхүүгийн хүндрэлтэй холбоотой байна. Үүний зэрэгцээ, ялангуяа уул уурхайн үйл ажиллагаатай холбоо бүхий хэргүүдийн хувьд хүчирхэг компаниудын зүгээс үзүүлэх дарамт шахалттай холбоо бүхий авилга, хээл хахуулийн элемент мөн нөлөөлж байна.

#### **5.4 Байгаль орчны боловсрол болон тогтвортой хөгжлийн боловсролыг сургалтын хөтөлбөр боловсруулах явцтай уялдуулах нь**

Монголчуудын тавны хоёр нь (39.2 хувь) нь 21 наснаас залуу хүмүүс эзэлж байна. Монгол улс бараг бүх нийтээр анхан шатны болон ерөнхий боловсролын сургуульд хамрагддаг бөгөөд дунд сургуульд 86 хувь нь суралцдаг байна. Монгол улс нь газар зүйн хувьд өргөн уудам газар нутагтай, маш тархай бутархай суурьдаг тул боловсролын тогтолцоо нь хөдөөгийн хүүхдүүдийн сургуульд хамрагдах байдлаас ихээхэн хамааралтай байна.

Тогтвортой хөгжлийн боловсролыг сургалтын хөтөлбөртэй уялдуулах ажил сүүлийн жилүүдэд нэлээд сайжирч, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/458 тоот тушаалаар Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл баримтлалыг ерөнхий боловсролын сургуулийн үйл ажилагаа болон сургалтад тусгахаар шийдвэрлэсэн байна. Бүх сургуульд хэрэглэхийн тулд Тогтвортой хөгжлийн боловсролын асуудлыг дунд болон ахлах шатны боловсролын сургалтын хөтөлбөрийг (160 сургалтын хөтөлбөр) дахин хянаж боловсруулсан байна. Энэхүү Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл баримтлал боловсруулах ажил Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтран санхүүжүүлсэн Тогтвортой хөгжлийн боловсролын төслийн (Шигтгээ 5.3) хүрээнд амжилттай хэрэгжсэн байна.

Байгаль орчны боловсрол болон тогтвортой хөгжлийн боловсролын асуудлыг сургалтын хөтөлбөрт тусгахад учирч болох гол саад бэрхшээл, сорилтууд нь:

- Сургалтын шинэ хөтөлбөрийг улсын хэмжээний бүх сургуулиудад зохистойгоор нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх,



- “Тогтвортой хөгжлийн боловсрол, Байгаль орчныг хамгаалах, тогтвортой болон ногоон хөгжлийн тухай мэдлэг” сэдвээр багш нарыг сургах, боловсрол олгох ажлыг хийх,
- Залуу хүмүүсийн Байгаль орчин, тогтвортой хөгжлийн тухай мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн үр дүнтэй арга боловсруулах,
- БСШУСЯ, түүний харъяа байгууллагуудын бүх ажилтнуудын Тогтвортой хөгжлийн боловсролын тухай мэдлэг чадварыг хөгжүүлэх,
- Тогтвортой хөгжлийн боловсролын судалгаа шинжилгээ, бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай хангалттай санхүүжилтийг олгох.

### Шигтгээ 5.3: Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл

ТХБ төслийг хэрэгжүүлсэнээр (эхний үе шат, 2014 оны 12 сараас 2017 оны 12 сар) Монгол улс ТХБ-ыг албан болон албан бус боловсролын тогтолцоотой уялдуулах ажил эхэлжээ. Төслийн 2 дугаар шатыг (2018–2021) боловсруулах ажил хийгдэж байна.

Төслийн үндсэн зорилго нь ТХБ-ыг Монгол улсын сургуулийн системд тусгах, тогтвортой хөгжлийн хууль эрх зүйн болон бүтэц зохион байгуулалтын тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэх явдал байжээ. Төсөл нь нийт 628 сургуулийн сургалтын хөтөлбөрт ТХБ-ын асуудлыг тусгахын тулд албан боловсролын системийг шинэчлэхэд гол анхаарлаа хандуулжээ. Түүнчлэн, удирдлага болон олон нийтийн ТХБ, Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн тухай мэдлэг мэдээллийг сайжруулах, сонгон авсан зарим компаниуд болон байгууллагуудыг ISO 14001 стандартын дагуу сертификат авахад нь дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Төслийн эхний шатны үр дүнд ТХБ-ын асуудлаар БСШУ-ны сайдын хэд хэдэн тушаал гарч, тус яам болон БОАЖЯ-ны ажилтнуудад сургалтууд явуулан, багш нарын олон тооны сургалтууд зохион байгуулжээ. Мөн төслийн хүрээнд албан болон албан бус боловсролын системд зориулсан олон тооны сургалтын материал, гарын авлага боловсруулахад дэмжлэг үзүүлжээ.

БСШУЯ, БОАЖЯ, Боловсролын судалгааны хүрээлэн, Багш нарын мэргэжил дээшлүүлэх институт, МУИС, МУБИС зэрэг албан болон албан бус боловсролын голлох байгууллагуудын төлөөлөл төслийг хэрэгжүүлэх ажлын хэсэгт оролцож ажиллажээ. Төслийг БСШУЯ болон Швейцарийн хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага хамтран санхүүжүүлсэн. Төслийн менежментийг ГТХАГ, Uppsala их сургууль, Швейцарийн Их сургуулийн багш нарын боловсролын олон улсын хамтын ажиллагааны институт хамтран хийсэн байна.

#### Сургуулийн өмнөх боловсрол

Сургуулийн өмнөх боловсрол нь сайн дурын үндсэн дээр явагдана. Энэ шатны боловсролын гол зорилго нь балчир хүүхдүүдийн (нийт хүн амын 9.8 хувийг эзлэх 2-5 настай хүүхдүүд) тэднийг хамгаалах, санаа тавихад дэмжлэг үзүүлэх, тэдний насан туршийн боловсрол олоход нь дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн шаардлагатай арга барилыг хөгжүүлэхэд сургахад чиглэгдэнэ.

Сүүлийн 10 жилийн туршид, хүүхдийн цэцэрлэгийн тоо 2006 онд 742 байснаа 2016 онд 1,327 болж бараг 2 дахин нэмэгдсэн байна. Гэвч хамгийн том бэрхшээл бол хөдөөгийн, ялангуяа малчин өрхийн хүүхдийг сургуулийн өмнөх сургалталад хамруулах боломжийг олгох явдал байна. Зөврийн гэр цэцэрлэгийн хөтөлбөрийг малчин өрхийн хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдах, түүний чанарыг сайжруулахын тулд БСШУСЯ, НҮБ-ын ХС болон Даян дэлхийн боловсролын түншлэл ТББ-тай хамтран боловсруулсан байна. Үүний үр дүнд 2010-2015 оны хооронд дахин 64,571 хүүхэд хүүхдийн цэцэрлэгт хамрагдсан байна.

Байгаль орчны боловсрол болон тогтвортой хөгжлийн боловсролыг сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр болон бусад дадлагын хөтөлбөрт тусгах үйл явц эхний шатанд ихэнхдээ 4-5 насны хүүхдэд чиглэгдэж байна. Сургалтын хөтөлбөрүүд нь биднийг хүрээлэн буй байгалийг ашиглах, шинэ зүйлийг таньж мэдэж, туршиж мэдрэх, байгаль, ургамал, амьтныг хайрлах, хамгаалах, түүнээс таашаал авах, өдөр тутмын амьдралдаа дасан зохицоход суралцах зэрэг байгаль орчинтой холбоотой анхны элементүүдийг агуулна. Сургуулийн өмнөх боловсролд хог хаягдал болон бидний амьдралд цэвэр байгалийн ач холбогдолын тухай ойлголт, мэдлэгийг бий болгож энгийн туршилтууд хийх, ийм үйл ажиллагаанд томчуудыг оролцуулах явдал хамаарна. Хүүхдүүд сургалтандаа навч зэрэг байгалийн бүтээгдэхүүн, шагай зэрэг уламжлалт зүйлсийг ашиглах явдал чухал байдаг.

Улсын хэмжээгээр сургуулийн өмнөх боловсролд ТХБ-ын асуудалтай уялдуулахад амжилт гаргахын тулд цэцэрлэгийн багш болон бусад ажилтнуудын дунд ТХБ-ын асуудлаар өрсөлдөөн бий болгох



асуудал, ялангуяа сургуулийн өмнөх түвшинд арга хэмжээ зохион байгуулахад ТХБ-ын арга зүйг ашиглах сайн хөгжөөгүй байна.

### *Бага сургууль*

Бага сургуульд 6-10 насны хүүхдүүд (нийт хүн амын 9.6 хувь) хамрагдах 5 жилийн сургалтын сургууль хамрагддаг байна. Засгийн газрын зүгээс боловсролын системд оршиж байгаа томоохон саад бэрхшээлүүдийн нэг болох сургууль завсардах явдлыг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээнүүд авч байна. Нийтдээ 6-14 насны сургууль завардсан хүүхдийн тоо 2006 онд 12,373 байснаа 2014 онд 1,169 болж 10 дахин буурчээ. Энэ талаар олон улсын байгууллагууд ч гэсэн чухал тусламж үзүүлж байна. Жишээлбэл, Дэлхийн банкны 2.46 сая ам. долларын санхүүжилт бүхий Монгол орны хөдөөгийн эмзэг бүлгийн хүүхдүүдийн анхан шатны боловсролыг сайжруулах төсөл 2012-2017 онд Японы Хүүхэд хамгаалах байгууллагын Монгол дахь хөтөлбөрийн газар хэрэгжүүлж, сургууль завсардах хүүхдийн тоог бууруулах, хүүхдийн сургалтын үр дүнг сайжруулахад чухал хувь нэмэр оруулсан байна.

Анхан шатны боловсролын систем 2013 онд шинэчлэгдэж, үндсэн сургалтын хөтөлбөрүүдийн агуулга болон арга зүй шинэчлэгдсэн байна. Эдгээр сургалтын хөтөлбөр нь үндэсний соёл, уламжлалт зан заншлыг хүндэтгэн хүүхэд бүрийг сургах, хүүхдийн авъяас, сонирхолыг хөгжүүлэх, өөрийн үүрэг харицлагатай байх, сэтгэн бодох чадварыг бий болгох, насан туршийн боловсролын сайн арга барилыг хөгжүүлэх, хамтаараа ажиллаж амьдраад сургахад чиглэгдсэн байна. Шинэчилсэн сургалтын хөтөлбөр нь хүүхэд бүрийг тэдгээрийн хувь хүний зан чанар, арга барилыг хөгжүүлэх боломж олгох үндсэн зарчимд тулгуурласан байна. Үндсэн сургалтын хөтөлбөрийн ерөнхий зарчим (хүүхэд бүрийн ялгаатай байдлыг хүндэтгэх, хамтдаа суралцах, бие биендээ санаа, тавьж туслах г.м) нь ТХБ-ын элементүүдийг агуулна.

### *Дунд сургууль*

Дунд боловсрол нь албан ёсны 4 жилийн дунд ангийн боловсрол (11-14 насны хүүхэд хамрагдах) болон албан бус 3 жилийн ахлах ангийн боловсролын (15-17 насны хүүхэд хамрагдах) тогтолцооноос бүрддэг байна.

**Фото зураг 5.1: Уламжлалт материал (сур болон шагай) ашиглан хийн сампин**



### Дунд ангийн боловсрол

ТХБ-ын төслийн нэг хэсэг болж, БСШУСЯ дунд ангийн боловсролын суурь сургалтын хөтөлбөрийг боловсруулан 2015-2016 оны сургуулийн жилд зориулан 2015 оны 7 сард баталсан байна. Байгаль орчны болон ТХБ-ын асуудал энэхүү шинэ сургалтын хөтөлбөрт тусгагдсан байна. Жишээлбэл, байгалийн шинжлэх ухааны боловсролын зорилго нь амьдралын арга барилыг танин мэдэж, үргэлжлэн суралцах, байгальд ээлтэй байдлаар үйл ажиллагаа явуулах, байгаль хамгаалахад хувь нэмрээ оруулах мэдлэгтэй иргэдийг бэлтгэх явдал юм. Физик зэрэг хичээлүүд нь 8 дугаар ангийн сурагчдад эрчим хүч хэрэглэх, эрчим хүчний хэмнэлт, сэргээгдэх эрчим хүч зэрэг асуудлуудад сургана. Биологийн хичээл нь хүний үйл ажиллагааны хүнсний бүтээгдэхүүнд хэрхэн нөлөөлөх зэрэг асуудлыг хамарна. Химийн хичээл нь усны химийн бохирдол, шороо тоосоор бохирдох, бохирдлоос сэргийлэх арга замууд зэрэг орчны бохирдолтой холбоотой асуудлыг заана. Газар зүйн хичээл нь хүн ам зүйн өөрчлөлт (шилжилт хөдөлгөөн, хүний насжилт, ажилгүйдэл, хүйсийн асуудал зэрэг), уур амьсгалын өөрчлөлт, ус ашиглалт ба хэрэглээ, усны ба рашаан усны нөөц, байгаль хамгаалал, тогтвортой хөгжлийн байгаль орчны болон нийгмийн асуудал зэрэг зүйлийг үзнэ. Дизайны технологийн хичээл нь уламжлалт материалыг ашиглахад сургах, хог хаягдлыг эргүүлэн ашиглах тухай асуудлыг хамарна. Багш нарыг зохих ёсоор сургаж сургалтын шинэ хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх нь иргэдийн оюуны сэтгэхүйг өөрчилж тогтвортой хөгжлийн зарчмаар амьдралын замаа сонгоход нь зохих хувь нэмэр оруулах ёстой.

Шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажил эхлэлийн шатандаа байгаа тул түүний нөлөөллийн үр дүн хараахан гараагүй байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа гол саад бэрхшээл бол ТХБ-ын талаарх багш нарын мэдлэг, чадвар дутагдаж байгаа, өнөөгийн сургуулиудын дэд бүтэц болон санхүүгийн боломж хязгаарлагдмал байдал болж байна.

### Ахлах ангийн боловсрол

БСШУСЯ ахлах ангийн боловсролын суурь сургалтын хөтөлбөрийг ТХБ-ын төслийн дэмжлэгээр боловсруулан 2016-2017 оны сургуулийн жилд зориулан 2016 оны 6 сард баталсан байна.

### Улсын болон хувийн сургуулиудын хүчин чадал

Монгол улсад 2016 оны байдлаар нийт 778 сургууль, үүнээс 628 нь улсын сургууль байна. Хувийн сургуулиудын ихэнх нь Улаанбаатар хотод байрлаж байна. ТХБ-ын асуудлыг амьдрал дээр хэрэгжүүлэх болон нийт сургуулиудын өөрсдийн арга барилыг бий болоход улсын сургуулиудын чадавхи боломж хөрөнгө санхүүжилтийн хомсдол, шаардлагатай хүний нөөцийн боломжоос шалтгаалан ихээхэн бэрхшээлтэй тулгарч болзошгүй.

Улаанбаатар хотын нэгэн дунд сургуулийн захирлын хэлсэнээр, БО, ТХБ-ын асуудлыг сургалтанд тусгах асуудал 10 орчим жилийн өмнө эхэлж байсан боловч 2012 оноос нэлээд эрчимжсэн байна. Сурагчдад тулгардаг гол бэрхшээл нь онолын болон хийсвэр сэтгэлгээнээс бодит амьдралын асуудалд шилжүүлэх, жишээлбэл математикийн хичээл дээр А болон Б цэгийн хоорондын зайг тооцоолохын оронд сурагчид Монгол улсын нэг суурин газраас нөгөөд хүртэлх зайг тооцоолохыг сурагчид асуудаг. Мөн хэд хэдэн хичээлийг нэгтгэсэн нэгдсэн сургалтын арга барил улам бүр нэмэгдэж байна, жишээлбэл сурагчид ямар нэгэн мод 10 м өндөр ургахын тулд хэдий хэмжээний хугацаа шаардагдах, түүнчлэн түүний ялгаруулах хүчилтөрөгчийг хэрхэн тооцоолох талаар асуудаг. Түүнчлэн, 2013 оноос хойш олсон онолын мэдлэгийг амьдрал дээр хэрхэн ашигладагийг сурахын тулд сургалтын гадуурхи арга хэмжээ болох үйлдвэр аж ахуйн газруудад очиж үзэхийг сургалтад оруулж байна.

Өмнө дурьдсан улсын сургуульд эдгээр шинэ арга барилыг нэвтрүүлэхэд учирч байгаа гол саад бэрхшээл нь шаардлагатай техник хэрэгсэл сургуульд нь байдаггүй явдал ажээ. Сургуулиудын анги талбайн бодит хэрэгцээ одоо байгаагаас (1,080 сурагч байх ёстой байранд 3010 сурагч сурч байгаа) даруй 3 дахин илүү байгаагаас хэт олон хүүхэдтэй анги 3 ээлжээр хичээллэхэд хүрч байгаа аж. Мөн БО болон ТХБ-ыг сургалтад оруулахад шаардлагатай багш нарт зориулсан сургалт хягаарлагдмал байна. Сургуулиудын жилийн төсөв нь зөвхөн багш нарын цалин болон бусад үйлчилгээний зардалд л хүрэлцэж байна. Иймээс сургалтын гадуурхи арга хэмжээ зохион байгуулах, БО, ТХБ-ын асуудлаар багш нараа нэмэлт сургалтанд хамруулах хөрөнгө үлддэггүй байна. Тэр улсын сургуулийн 2016-2017 оны хичээлийн жилийн төсөв болох 1.7 тэрбум төгрөг (ойролцоогоор 700,000 ам.доллар)-т 2 сая орчим төгрөгийг (ойролцоогоор 816 ам.доллар) л багш нарын сургалтад зориулагдсан байна. Энэ байдал нь хувийн сургуулиуд дээр ТХБ-ыг зохион байгуулах, багш нарын ажил дээрх сургалт явуулах зардал хамаагүй өндөр байдаг байна (Шигтгээ 5.4).

**Шигтгээ 5.4: Хувийн сургууль дахь БО болон ТХБ-ын сургалт. Хобби сургуулийн жишээ.**

Хобби сургууль нь 1994 онд анх байгуулагдсан Англи-Монгол хэл дээр сургалтаа явуулдаг бага ангиас ахлах анги хүртэлх боловсрол олгодог хувийн сургууль юм. Уг сургууль 2016 оноос хойш Олон улсын бага сургуулийн хөтөлбөр болон Олон улсын дунд ангийн сургалтын хөтөлбөрийг баримталж “байгальд үйлчлэх” ерөнхий сэдвийн хүрээнд олон хичээлийн харилцан уялдааг хангасан сургалт явуулж байна.

Сургалтаа сургалтын үндсэн хөтөлбөр болон нэмэлт сургалтын хөтөлбөрийг хамарсан үйл ажиллагаа явуулдаг байна. Эдгээр нь 3 болон 4 дүгээр ангийн сурагчдад сургуулийн цэцэрлэгт өөрсдийн цэцгийг тарьж, арчлах үйл ажиллагаанд оролцуулдаг бол 5 дугаар ангид ургамал хамгаалах төсөлд оролцох, мөн дунд ангийн сурагчид хэрхэн үүрэг хариуцлага хүлээх, хүлээцтэй байх болон хөгжих тухай суралцдаг байна. Жишээлбэл, хариуцлагатай байхад суралцахын тулд 8 дугаар ангийн сурагчид шүүлтүүр болон усан дундуур никотиныг дамжуулж, усыг шар болон хүрэн өнгө оруулж, мөн толгой өвтгөх үнэрийг ялгаруулах туршилтууд хийж тамхинаас жигшихэд сургадаг байна. Мөн тэдэнд бусдадаа болон өндөр настанд санаа тавьж халамжлахад сургадаг байна. Есдүгээр ангийн сурагчид өөрсдийн хөгжлийн өсөлтийн явцыг үнэлэх, суурь мэдлэгээ тодорхойлох, зорилгоо тогтоох, үйл ажиллагаагаа хянаж үзэх, зорилгодоо хүрэхэд шаардлагатай үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх замаар өөрийгөө хөгжүүлэхэд сургадаг ажээ. Уламжлалт мэдлэгэд сургах үйл ажиллагааны хүрээнд ахлах ангийн сурагчид хичээлийн дараа 11 дүгээр ангийн эрэгтэй хүүхдүүд гэр хэрхэн барих, харин 12 дугаар ангийн эмэгтэй сурагчид уламжлалт хувцас хэрхэн оёх зэрэг нэмэлт сургалтын хөтөлбөрт хамрагддаг байна.

Хобби сургуульд бүх хичээлүүдийн хүрээнд байгаль орчин, тогтвортой хөгжилтэй холбоотой асуудалд суралцдаг, жишээлбэл биологийн хичээл дээр сурагчид байгаль орчны бохирдлын тухай, математикийн хичээл дээр усны хэрэглээгээ тооцоход суралцдаг байна. Мөн усны сэдвийн хүрээнд сурагчид бохир усны тухай, бохир усны хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөний талаар суралцдаг. Түүнчлэн сурагчид говь цөлийн усны гачаалын тухай, орон нутагт явахдаа усыг хэрхэн цэвэрлэх тухай, уул уурхайн үйл ажиллагаанаас бохирдсон ус амьтдад хэрхэн нөлөөлдөг тухай суралцдаг байна.

Хобби сургууль нь 2016-2017 оны хичээлийн жилд 800 хүүхдийн багтаамжтай ажиллаж, 796 сурагчийг нэг ээлжээр хичээлүүлж байна. Сургуулийн жилийн нийт төсөв 5.5 тэрбум төгрөг (2,235,000 ам доллар) байна. Тусгай санд 4.6 сая төгрөг (1,869 ам.доллар) жил тутам байгаль орчны болон тогтвортой хөгжлийн сургалтад зориулан төсөвлөдөг байна. Улсаас жил тутам 243 сая төгрөгийг (99,000 ам.доллар) дэмжлэг болгон олгодог байна. Багш нарын ажлын байран дахь сургалтын зардлыг сургуулийн төсвөөс гаргадаг байна.

Байгаль орчны болон тогтвортой хөгжлийн сургалтад учирдаг гол бэрхшээл нь энэ талын туршлага, багш нарын энэ талын гүнзгийрүүлсэн сургалт дутагдаж байгаа явдал юм.

**Байгаль орчны төрөлжсөн сургалттай сургуулиуд**

Байгаль орчны төрөлжсөн сургалттай ганц ахлах сургууль нь МУИС-ын дэргэд 2001 онд байгуулагдсан хувийн Экологийн лицей сургууль юм. Уг сургууль ахлах сургуулийн боловсролын 10-12 дугаар ангитай хичээллэж байна. Лицей нь ахлах сургуулийн боловсролын үндсэн хөтөлбөр болон МУИС болон тус лицейн багш нарын багтай хамтран боловсруулсан байгаль орчны салбарын 6 салбарыг хамарсан төрөлжсөн сургалтын хөтөлбөр гэсэн 2 сургалтын хөтөлбөрөөр сургалтаа явуулдаг байна. Лицей нь үндсэн ахлах сургуулийн сургалтын хөтөлбөртөө БСШУСЯ-ны боловсруулсан сурах бичгүүдийг ашигладаг бол төрөлжсөн сургалтандаа МУИС-ын өөрийнх боловсруулсан сурах бичиг ашиглаж байна. Уг сургуульд тус бүрт нь 20 орчим сурагч хамрагдах экологийн клуб, мөн ургамлын клуб ажилладаг байна. Лицей нь жил бүр шинэ сурагчдад зориулсан нэг өдрийн сургалтыг заавал зохион байгуулдаг байна. Ийм сургалтыг Байгаль орчны сургалтын төвөөс эко-аялал хэлбэрээр 2011 оноос хойш жил бүрийн намар зохион байгуулж иржээ. Ийм эко-аялалыг байгаль орчинтой холбоо бүхий 10 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэх үйл ажиллагааг байгаль дээр (ой, цэцэрлэгт хүрээлэн, хөдөө талд) зохион байгуулдаг байна.

**Мэргэжлийн сургалт**

Мэргэжлийн сургалтанд дунд сургууль төгсөгчид хамрагдана. Сүүлийн 10 гаруй жилд мэргэжлийн сургалтад хамрагдах сонирхол бараг 3 дахин нэмэгдэж 2016 оны байдлаар 19,500 оюутан хамрагдаж байна. Техникийн мэргэжлийн боловсролын төв 2017 оны байдлаар 91 ажиллаж байгаагаас 38 нь улсын төсвөөс, 53 нь хувийн болон хагас хувийн хөрөнгө оруулалтаар санхүүжиж байна.

Мэргэжлийн сургалтын хөтөлбөр нь хэрэгцээ шаардлагадаа тулгуурладаг байна. Тухайлбал



хэрэгцээ шаардлагаас хамааран уул уурхай, цахилгаан, замын болон барилгын ажилчин бэлтгэхээс хамааран холбогдох их сургууль болон тухайн ажилчдыг төгссөнийх нь дараа ажиллуулах компаний мэргэжилтнүүд хамтран боловсруулдаг байна. Улсын төсвөөс санхүүждэг Засгийн газрын байгууллага болох Мэргэжлийн боловсролын бодлогын хэрэгжлтийн газар нь мөн сургалтын хөтөлбөр боловсруулахад оролцож, багш нарын заах арга зүйн асуудалд оролцдог байна.

Мэргэжлийн сургалтын хөтөлбөрт байгаль орчин, тогтвортой хөгжлийн боловсролын асуудлыг тусгайлан тусгаж өгөөгүй байна. Гэвч янз бүрийн хичээлүүдэд байгаль орчин болон хөгжлийн асуудлыг тухайн салбаруыг ногооруулах асуудалтай уялдуулан тусгах оролдлого хийгдэж байна. Жишээлбэл, барилгын салбарын сургалтын хөтөлбөрт барилгын дулаан алдалдалтын талын 36 цагийн сургалт туссан бөгөөд оюутнууд барилгын дотоод дулаалгад хонины ноос зэрэг органик материалаар орлуулахад суралцаж байна.

Ерөнхийдөө мэргэжлийн сургалтын хөтөлбөр боловсруулахад хэрэгцээнд тулгуурласан, нээлттэй хаалганы бодлогын аргачлалтыг хэрэглэж байна. Жишээлбэл, байгаль орчны менежментийн асуудлыг боловсруулахдаа хэрэв оюутнууд сонирхсон тохиолдолд байгаль орчны менежментийн ISO 14000 болон чанарын менежментийн ISO 9000 стандартын асуудлыг авч үздэг байна.

Техникийн мэргэжлийн боловсролын төвүүдийн сургалтын хөтөлбөрийг 2016 оноос хойш Монгол улсын ТХЗ 2030 –гэй уялдуулж байна.

#### *Дээд боловсрол*

Дээд боловсролын байгууллагууд (Их дээд сургууль, коллеж) 2016 оны байдлаар 95 байгаагаас 90 нь Улаанбаатар хотод, бусад нь Архангай, Дархан, Говь алтай, Төв, Завхан аймгуудад байна. Эдгээрийн 17 нь улсын сургууль байна. Түүнчлэн гадаадын 4 их сургуулийн салбар Монгол улсад ажиллаж байна. Ерөнхийдөө их сургуулиудад экологи, байгаль орчны хамгааллын тусгай хөтөлбөр болон хичээл байна. Мөн бусад мэргэжлийн хөтөлбөрүүдэд байгаль хамгааллын асуудлаарх хичээл болон сонгон суралцах хөтөлбөр байна.

Их сургуулиуд бизнесийн болон эдийн засгийн сургалтын хөтөлбөртөө ногоон эдийн засгийн асуудлыг тусгаж эхэлсэн байна. Ялангуяа НҮБ-ПАЖЭ хөтөлбөр хэд хэдэн их сургуультай хамтран дээд боловсролын сургалтын хөтөлбөрт ногоон эдийн засгийн үзэл баримтлал, арга замыг тусгах талаар ажиллаж байна. Монгол улсын ХААИС, МУИС, Санхүү эдийн засгийн их сургууль, Худалдаа бизнесийн үндэсний их сургуулиудын оролцоотойгоор 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн ногоон эдийн засаг, загварчлал болон тогтвортой санхүүжилийн их сургуулийн шинэ хичээлүүдийг мэргэжил дээшлүүлэх шатны сургалтад ашиглахад бэлэн болгоод байгаа ажээ. Түүнчлэн Чех улсын Каритас байгууллага Монгол улсын ШУТИС-тай хамтран мэргэжил дээшлүүлэх сургалтын сонгон суралцах Ногоон барилгын курсын сургалтын хөтөлбөр боловсруулахаар хамтран ажиллаж байна.

#### Монгол улсын их сургууль (МУИС)

Монгол улсын их сургууль (МУИС) нь 2013 онд бүтцийн өөрчлөлт хийснээс хойш 5 үндсэн сургуультай ажиллаж байна. Шинжлэх ухааны сургууль нь МУИС-ийн нийт бүрэлдэхүүний 50 хувийг эзэлж 20,000 орчим оюутны 10,000 орчим нь энэ сургуульд сурч байна. Бусад нь Хууль зүйн сургууль, Бизнесийн сургууль, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль, Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль юм.

Биологийн салбар нь Шинжлэх ухааны сургуульд хамрагдаж 400 оюутантай, мөн газар зүйн салбартай. Эдгээр салбарууд нь экологи, байгаль хамгаалал ба биологийн олон янз байдал, физик газар зүй, дэлхий болон гариг судлал, зайнаас тандан судлал, газар зүйн мэдээллийн систем, молекулийн биологи, генетик болон биотехнологи, химийн био материал зэрэг байгаль орчинтой холбоо бүхий хичээл ордог байна.

Байгаль орчинтой холбоотой өөр нэг салбар нь Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуульд хамрах Байгаль орчны шинжлэх ухаан болон химийн инженерчлэлийн салбар юм. Энэ салбарт байгаль орчны шинжлэх ухаан, байгаль орчны үнэлгээ, цаг уур, ус судлал, хөрсний шинжлэх ухаан, хэрэглээний хими, химийн инженерчлэл ба технологи, байгаль хамгаалах технологи, материалын шинжлэх ухаан, нано шинжлэх ухаан ба инженерчлэл, цөмийн инженерчлэл, биотехнологи, биоинженерчлэл, ой зэрэг хөтөлбөрөөр сургалт явуулдаг байна.

Мөн МУИС-ын мастерийн болон боловсролын докторын хөтөлбөрт экологи, байгаль хамгаалал, байгаль орчны ашиглалт болон үнэлгээ зэрэг байгаль орчны судалгааны хичээлүүд ордог байна. МУИС-ын профессорууд сургалтын сурах бичиг, гарын авлагыг өөрсдөө боловсруулдаг байна. Багш нарын ажлын байран дээрх сургалтыг Хөгжлийн төвөөс зохион байгуулдаг байна. Тогтвортой хөгжлийн асуудал багш нарын ажлын байран дээрх сургалтад ордоггүй байна.

Тогтвортой хөгжлийн асуудал сургалтын хөтөлбөрүүдэд тусгагдаж эхэлж байгаа боловч одоогоор бүрэн байдлаар тусгаж чадахгүй байна. МУИС-ын хүрээнд Тогтвортой хөгжлийн хүрээлэн хэдэн жилийн өмнө судалгааны төв байдлаар байгуулагдсан байна.

### Монгол улсын ХААИС

Монгол улсын ХААИС нь нийт 25 хөтөлбөр (мэргэжил)-тэйгөөс байгаль хамгаалах технологи, болон экологи гэсэн 2 хөтөлбөр нь байгаль орчинтой холбоотой байна. Сургуулийн 2,500 оюутнаас 370 нь жил бүр байгаль орчинтой холбоотой хөтөлбөрийг судалж байна. Түүнчлэн байгаль орчинтой холбоотой асуудлууд бусад мэргэжлийн хичээлүүдэд ч мөн тусгагдсан байдаг байна. Тус сургуулийн уриа нь “Тогтвортой хөгжлийн төлөөх хөдөө аж ахуй” аж.

### Монгол улсын Боловсролын их сургууль

Боловсролын их сургууль нь дунд сургуулийн багш нарыг бэлтгэнэ. Тус сургууль нь мөн дадлага олгох болон мэргэжил дээшлүүлэх сургалт явуулна. Тогтвортой хөгжлийн боловсролын хичээл багш нарын мастерийн түвшний сургалтын хөтөлбөрт 8 кредит цаг, харин оюутнуудын сургалтад 10 кредит цаг ордог байна. Тус сургууль нь “Багш нарын манлайлал нь хөгжлийн гол түлхүүр мөн” гэсэн уриатай байна.

### Худалдаа, бизнесийн үндэсний их сургууль

Худалдаа, бизнесийн үндэсний их сургууль нь 2017 онд МУИС-аас салж бие даасан их сургууль болжээ. Тус сургуулийн дэргэд саяхан Тогтвортой бүтээгдэхүүн болон худалдааны төв байгуулагдсан байна.

### Багш нарын сургалт

Багш нарын мэргэжлийг дээшлүүлэх институтийн багш нарын ажлын байран дээрх сургалт нь дунд сургууль, сургуулийн өмнөх байгууллага, насан туршийн боловсролын төвүүд, мэргэжлийн боловсролын сургуулийн багш нар, мөн сургуулийн удирдлага, дотуур байрны багш, номын санчид, нийгмийн ажилтнууд, цэцэрлэгийн багш нар зэрэг бусад ажилтнуудын мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

Багш нарын мэргэжлийг дээшлүүлэх институт нь байгаль орчин, тогтвортой хөгжлийн асуудлаар тусгай сургалт явуулдаггүй боловч бусад хичээлүүдэд ямар нэгэн байдлаар тусгагддаг байна. Багш нарын мэргэжлийг дээшлүүлэх институт нь анх байгуулагдсан 2012 оноос 2014 он хүртэл багш нарын сургалтын хөтөлбөр болон төлөвлөгөөг боловсруулжээ. Эдгээр хөтөлбөрийг 2015 онд ТХХ 2030 болон ТХЗ-уудтай уялдуулан шинэчилсэн байна. Мөн уг институт ажлын явцыг үнэлэхийн тулд шалгуур үзүүлэлтүүд боловсруулсан байна.

Багш нарын мэргэжлийг дээшлүүлэх институт нь 2014 оноос хойш Тогтвортой хөгжлийн боловсролын төслийн үйл ажиллагаанд оролцож эхэлжээ. Энэ нь багш нар, сургуулийн ажилтнуудын сургалтад ТХБ-ын үзэл баримтлалыг оруулах боломж олгосон байна. Мөн энэ төсөлд оролцох болсоноор тус институтэд сургалтын модуль, гарын авлага боловсруулах, ажилтнуудынхаа чадавхийг бэхжүүлэх боломжтой болсон байна.

Багш нарын мэргэжлийг дээшлүүлэх институтийн вэб хуудсанд (<http://teacher.itpd.mn>) ТХБ-ын хэд хэдэн модуль орсон байна. Эдгээр модульд, жишээлбэл химийн хичээл болон байгалийн шинжлэх ухааны хичээл заахдаа ТХБ-ын асуудлыг хэрхэн оруулахыг тусгасан байна. Багш нарын мэргэжлийг дээшлүүлэх институт нь вэб хуудсанд янз бүрийн түвшний сургалтын сайн туршлага, мөн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай материал зэрэг хэрэгтэй мэдээллийг агуулж байна.

Тогтвортой хөгжлийн талаарх гүнзгий мэдлэг мэдээллийг бий болгох асуудал нь Багш нарын



мэргэжлийг дээшлүүлэх институтээс өөрсдийн сургалтын хөтөлбөрт ТХБ-ын асуудлыг тусгахад тулгарч байгаа саад бэрхшээлүүдийн нэг болж байна. Өөр нэг бэрхшээлтэй асуудал бол багш нарын цалин хөлс бага байгаа нь багш нарт өөрийгөө хөгжүүлэх, ТХБ-ын асуудлын өөрсдийн сургалтандаа тусгахад хөшүүрэг болж чадахгүй байна.

#### ТХБ төслийн дэмжлэгээр хийсэн багш нарын сургалт

ТХБ төслийн дэмжлэгтэйгээр улсын хэмжээгээр нийт 24,000 гаруй багш нарт ТХБ-ын үндсэн зарчмууд, сургалтын үндсэн хөтөлбөрийн талаар сургалт явуулсан байна. Мөн сургалтын байгууллагуудын чадавхийг бий болгох, БСШУСЯ болон түүний хүрээлэнгүүдийн ажилтнуудад сургалтууд явуулсан байна.

Саяхны жишээ гэвэл сургуулиудын ажилтнуудын мэдлэг мэдээллийг сайжруулах, тэдний чадавхийг бий болгоход чиглэсэн семинарыг БСШУСЯ-аас 2017 оны 3 дугаар сард зохион байгуулсан байна. Сургууль болгоноос сургуулийн захирал, удирдлага, нийгмийн ажилтан болон байгалийн шинжлэх ухааны багш нар зэрэг 3 хүнийг гурван өдрийн сургалтад хамрагджээ. Нийтдээ 850 ажилтан хамрагдсан байна. Эдгээр семинарын үргэлжлэл болгож аймаг бүрт шаардлагатай байгаа үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан байна. Мөн 2017 оны 3 сард аймгуудын боловсролын газрын ажилтнуудын семинар зохион байгуулж нийт 260 хүнийг сургасан байна.

### **5.5 Байгаль орчин, тогтвортой хөгжлийн албан болон албан бус боловсрол**

#### *БОАЖЯ-ны үйл ажиллагаа*

БОАЖЯ нь байгаль хамгаалал, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн асуудлаарх албан бус боловсрол олгох үйл ажиллагаанд оролцож Даян дэлхийн байгаль хамгаалах сан (ДДБХС), НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага (НҮБ-ын БСШУБ), НҮБ-ПАЖЭ хөтөлбөр, ТХБ төсөл болон Даян дэлхийн ногоон өсөлтийн байгууллагатай хамтран ажиллаж байна. Тэдний үйл ажиллагааны гол чиглэл нь яамд болон аймгуудын улс төрчид, байгаль орчны салбарын мэргэжилтнүүд, хувийн салбарын төлөөлөлтэй ажиллах явдал юм.

БОАЖЯ нь БСШУСЯ болон бусад хамтран ажиллагч байгууллагуудтай (ДДБХС, НҮББСШУБ, олон улсын болон үндэсний ТББ г.м.) хамтран ТХБ-ын үндэсний хөтөлбөрийг боловсруулж, 2017 онд дуусгахаар төлөвлөж байна. Уг хөтөлбөр нь бусад яамд, агентлагийн төрийн албан хаагчид байгаль орчин, тогтвортой хөгжлийн асуудлаар явуулах сургалтыг хамрана. Түүнчлэн БОАЖЯ-ны санаачлагаар ТХБ-ын төслийн дэмжлэгтэйгээр сэтгүүлчдэд зориулсан ТХБ-ын сургалтын материалыг боловсруулж, 300 орчим сэтгүүлдэд ТХБ-ын сургалт явуулжээ. 2014-2016 онуудад БОУАС-ийн санхүүжилтийн 40.85 хувийг байгаль орчны сургалтад зориулагдсан байна (Хүснэгт 3.14).

#### *Насан туршийн боловсролын үндэсний төвийн хөтөлбөр*

Насан туршийн сургалт, албан бус боловсролын асуудал 1997 оны Албан бус боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (Засгийн газрын 1997 оны 116 дугаар Тогтоол) болон 2002 оны Зайны боловсролын үндэсний хөтөлбөр (Засгийн газрын 2002 оны 14 дугаар Тогтоол)-ын хүрээнд явагдаж байна. Насан туршийн боловсролын үндэсний төв (өмнө нь Албан бус болон Зайны сургалтын үндэсний төв нэртэй байсан) нь БСШУСЯ-ны харьяанд орон нутагт үйл ажиллагаа явуулдаг насан туршийн боловсрол олгох 374 төвтэй хамтран ажиллаж үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохицуулах үүрэгтэй байна. Тус төв нь албан бус боловсролын сургалтын материалууд боловсруулж арга зүйн дэмжлэг үзүүлдэг байна. Үндэсний төвийн хэрэгжүүлдэг хөтөлбөрүүд нь амьдрах арга барил, байгаль орчны боловсрол, ТХБ болон эрүүл мэндийн боловсролын асуудлыг хамарч байна. Хүүхдүүдийн амьдрах аюулгүй орчныг бүрдүүлэх асуудлыг насан туршийн болон албан бус сургалтын хөтөлбөрийн гэр бүлийн боловсролын хэсэгтэй уялдуулан авч үздэг байна.

#### *Эко-сургуулиуд*

Монголын сургуулиуд нь ISO 14001 стандартад суурилсан олон улсын эко-сургуулийн хөтөлбөрт оролцож байна. Эко-сургуулиуд нь албан болон албан бус боловсролын хоорондын холбох гүүр болдог байна.

Швейцарийн хөгжлийн агентлаг (ШХА) цөлжилттэй тэмцэх төслийн дэмжлэгтэйгээр 2008 оноос эхлэн эко-сургуулиудыг байгуулах, үйл ажиллагааг явуулж эхэлсэн байна. Мөн БСШУСЯ болон БОАЖЯ-тай хамтран хэрэгжүүлсэн ШХА-ийн ТХБ-ын төслийн дэмжлэгийг 2015 оноос авч эхэлсэн байна. Эко-сургуулийн олон улсын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч үндэсний байгууллага нь Байгаль орчны мэдээлэл, сургалтын төв (БОСМТ) ТББ юм.

Эко-сургуулийн хөтөлбөрт 2017 оны дунд үеийн байдлаар 252 сургууль хамрагдаж байгаа нь Монгол улс дахь нийт улсын сургуулийн 40 хувь болоод байна. Мөн Улаанбаатар болон 11 аймаг дахь өөр 55 сургууль БОСМТ-ээс ТХБ төслийн хүрээнд зохион байгуулсан сургалтанд хамрагдаж Эко-сургуулийн хөтөлбөрт хамрагдахаар ажиллаж байна.

**Фото зураг 5.2: Сэлэнгэ аймгийн Баянгол сумын сургуулийн сурагчдын ажлыг дэлгэн харуулсан байдал**



Эко-сургуулийн хөтөлбөрт хамрагдахын тулд хэд хэдэн бүрэлдэхүүн хэсэг болон үе шатыг дамжих бөгөөд эдгээр нь тухайн сургууль нь 2 жилийн хугацаанд хүрэл болон мөнгөн шагналын болзол хангах, *Ногоон тугны* шагналд тодорхойлогдох явдал байдаг. Монголын хөтөлбөрт хамрагдаж байгаа ихэнх сургуулиуд хүрэл шагналын болзолыг хангаад байгаа ажээ. Шигтгээ 5.5 –д Сэлэнгэ аймгийн Баянгол сумын сумын сургуулийн жишээг үзүүлж, эко-сургуулийн хөтөлбөрт хамрагдахын тул гаргасан хүчин чармайлт, олсон ололт амжилтыг тайлбарлажээ.

*Байгаль орчны боловсролын төвийн үйл ажиллагаа*

МУИС-ын дэргэд ажиллах Байгаль орчны боловсролын төв нь сургуулийн өмнөх боловсролын байгууллага, бага болон дунд сургууль, дээд сургуулиудын оюутан сурагчид болон олон нийтэд байгаль хамгаалах сургалтыг явуулдаг байна.

Тус төвд жилд дунджаар 3,000 хүүхэд айлчилдаг бөгөөд тэдний 60 хувь нь бага болон дунд сургуулийн сурагчид, 30 хувь цэцэрлэгийн жаалууд, 10 хувь нь их дээд сургууль болон олон нийтийн төлөөлөл байдаг байна. Цэцэрлэгийн жаалууд амьтны музей, хүлэмж болон цэцэрлэгийг үзэж сонирхдог байна. Бага сургуулийн 1 болон 2 дугаар ангийн сурагчид мөн ижил хөтөлбөртэй байдаг. Харин 3

дугаар ангийн сурагчид зарим нэмэлт зүйл үзэж сонирхдог ажээ. Тус төв нийт 40 орчим хөтөлбөр, үйл ажиллагаатай тул түүнээс сонгож өөрсдийн сонирхлоос хамааран айлчилж байгаа багууд үндсэн хөтөлбөр дээр юу нэмж үзэж танилцах боломжтой. Төвийн ажилтнууд хөтөлбөр, үйл ажиллагаагаа өөрсдөө боловсруулж холбогдох гарын авлага материалаа бэлтгэдэг байна. Үндэсний болон олон улсын хамтран ажиллагч байгууллагуудын дэмжлэгтэйгээр 2012 оноос хойш зарим үйл ажиллагааг боловсруулжээ. Тус төв мөн байгаль орчинтой холбоотой зарим сургалтын хөтөлбөр боловсруулж зохион байгуулж байна. Жишээлбэл, 2012 онд ШХА-ийн бичил уурхайн төслийн дэмжлэгтэйгээр тус төв МУИС-ын ажилтнуудтай хамтран орон нутгийн удирдлага болон уул уурхайн компаниудын ажилтнуудад сургалт зохион байгуулсан байна. Байгаль орчны асуудалд илүү анхаарал хандуулах өнөөгийн шаардлагатай уялдуулан тогтвортой хөгжлийг дэмжих, түүний тухай мэдээллийг түгээх ажлыг сайжруулахын тулд тус төв өөрийн үйл ажиллагааг өргөжүүлэхээр төлөвлөж байна.

## 5.6 Хууль эрх зүй, бодлого болон бүтэц зохион байгуулалтын тогтолцоо

### *Хууль эрх зүй*

#### Мэдээллийн хүртээмж, олон нийтийн оролцоо

Мэдээллийн хүртээмжийн асуудлыг 2011 оны Мэдээллийн ил тод байдал ба Мэдээлэл авах эрхийн тухай хууль, 1995 оны Байгууллагуудын нууцлалын тухай хууль, 1995 оны Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 2011 оны нэмэлт өөрчлөлт оруулсан хууль, 2015 оны Захиргааны ерөнхий хууль, 1995 оны Төрийн албан хаагчид болон төрийн байгууллагын эсрэг гаргасан гомдлыг барагдуулах тухай хууль болон 2002 оны Иргэний хуулиар зохицуулж байна.

#### **Шигтгээ 5.5: Сэлэнгэ аймгийн Баянгол сумын сургууль: Эко-сургуулийн хөтөлбөрт хамрагдсанаар олсон ололт амжилт**

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын сургууль эко-сургуулийн хөтөлбөрт 2013 оноос эхлэн хамрагдаж, 2017 онд хүрэл шагнал хүртсэн байна. Энэхүү хүрэл шагнал хүртэхийн тулд тухайн сургууль Эко-сургуулийн шаардлагын Үе шат 1 (Эко-Хороо байгуулах), Үе шат 2 (байгаль орчны тойм гаргах), Үе шат 3 (Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах)-ийн шаардлагыг биелүүлсэн байх ёстой байдаг байна. Цаашид Ногоон тугийн болзолыг хангахын тулд мөн хэд хэдэн үе шатыг, тухайлбал Үе шат 4 (мониторинг, үнэлгээ хийх), Үе шат 5 (сургалтын хөтөлбөртэй уялдуулах), Үе шат 6 (бусад мэдээлэх, тэднийг оролцуулах), Үе шат 7 (Эко-код нэвтрүүлэх) хэрэгжүүлэх шаардлагатай байгаа ажээ.

Тус сургууль 2012 оноос хойш мод тарьж (2017 онд 350 мод) сургуулийн орчмын байгаль орчныг сайжруулах ажлыг хийж байна. Сурагчид 8 хүлэмжинд цэцэг болон үрслүүлэг суулгаж, дараа нь сургуулийн гадаа тариалж байна. Сургууль нь малчдын 140 хүүхдийг хүлээн авах дотуур байраа шинэжилж 8 нарны хавтан суурилуулсан байна. Сургууль мөн хүүхдүүдийн эцэг эх болон орон нутгийн байгууллагуудыг хүүхдүүдтэй хамт янз бүрийн үйл ажиллагаанд оролцуулж, гар урлалын зүйл хийх, элдэв уралдаан тэмцээн, сургуулийн орчныг сайжруулах болон уул уурхайн газрын нөхөн сэргээх ажилд татан оролцуулдаг байна. Сургууль мөн багш нарынхаа ажлын төлөвлөгөөг ТХЗ-уудтай холбоотой уялдуулах талаар ажиллаж байна.

Сургуулийн нийт 72 багш, үүний бүтэн цагаар ажилладаг 32 багшийг сумын удирдлагуудтай хамтран ТХБ-ын сургалтад хамруулжээ. Сургуулийн 910 сурагчийн 5 нь сургуулийн Эко-хорооны гишүүнээр ажилладаг байна.

Шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааг 2015 оны Захиргааны ерөнхий хууль, 2015 оны Хууль тогтоомжийн тухай хууль, 2012 оны БОНҮ-ний тухай хуулиар зохицуулж байна. ТББ-уудыг байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд итгэмжлэн оролцуулахтай холбогдсон хэд хэдэн хуулийн заалтууд байна.

Шүүх ажиллагааны хүртээмжийн асуудлыг 2002 оны Иргэний хууль, 2015 оны Захиргааны ерөнхий хууль, 2016 оны Захиргааны асуудлыг шүүхээр шийдвэрлэх тухай хууль болон 2002 оны Эрүүгийн хууль болон бусад эрх зүйн актаар зохицуулдаг байна.

Харин Засгийн газрын байгууллагууд болон бусад байгууллагуудын зүгээс хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явдал бэрхшээлтэй хэвээр байна. Олон нийтийн оролцооны тухай зарим асуудлаар тусгайлсан механизмуудыг боловсруулсан (БОНҮ болон СБОУ-нд олон нийтийн оролцоо) боловч бусад асуудлаар тийм механизм байхгүй байна (жишээ нь байгаль орчны асуудлаархи олон улсын яриа

хэлэлцээнд үндэсний байр суурийг бэлтгэх ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах).

#### Байгаль орчны боловсрол, тогтвортой хөгжлийн боловсрол

Хэд хэдэн хуулиар боловсролын салбарын асуудлыг зохицуулж байгаа бөгөөд эдгээрийн ихэнх нь 2002 онд гарч нэмэлт өөрчлөлт хийх ажил өнөөдөр хүртэл үргэлжилж байна. Эдгээрт 2002 оны Боловсролын тухай хууль, 2008 оны Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, 2002 оны Бага дунд боловсролын тухай хууль, 2009 оны Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, 2002 оны Дээд боловсролын тухай хуулиуд орж байна. Байгаль хамгаалах тухай 1995 оны хуульд байгаль орчны боловсрол, ялангуяа байгаль орчны боловсролын үйл ажиллагааны санхүүжилтад Засгийн газрын үүргийн тухай асуудлыг тусгаж өгчээ.

ТХБ-ын хууль эрх зүйн үндэс нь БСШУС-ын сайдын 2015 оны 11 сарын 13-ны өдрийн “Ерөнхий боловсролын сургуулиудын сургалт, үйл ажиллагаанд ТХБ-ын үзэл баримтлалыг тусган хэрэгжүүлэх ажлын хамрах хүрээ, үндсэн шаардлагын тухай” А/458 дугаар Тушаал юм. Энэхүү тушаалаар ТХБ нь боловсролын салбарын үндсэн гол зарчим байх бөгөөд ТХБ-ын асуудлыг албан боловсролын үйл ажиллагаанд оролцох байгаа бүхий л байгууллагууд хэрэгжүүлэх үүрэгтэй гэдгийг зааж өчээ. Өөр хууль эрх зүйн баримт бичиг нь бага боловсролын үндсэн сургалтын хөтөлбөр, түүнчлэн дунд сургуулийн боловсролын үндсэн хөтөлбөрийг тус тус баталсан БСШУС-ын сайдын тушаалууд (2015 оны 7 сарын 10-ны өдрийн А/302 тоот, мөн 2016 оны 7 сарын А/275 тоот ) хамрагдана.

#### *Бодлогын тогтолцоо*

#### Мэдээллийн хүртээмж, олон нийтийн оролцоо

Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д тогтвортой хөгжлийн Зорилго 2.4: “Тогтвортой хөгжлийн засаглал”-ын асуудлыг тусгасан байна. Энэхүү баримт бичиг болон үндэсний стартегийн бусад баримт бичгүүдэд олон нийтийн оролцоо, ил тод байдал, хариуцлага болон иргэдэд тулгуурласан байгалийн нөөц баялагийн менежментийн талаар тодорхой тусгажээ. Гэхдээ тэдгээр стратегийн баримт бичгүүдэд шалгуур үзүүлэлт байхгүй байгаа нь ямар дэвшилд хүрч байгааг хэмжих боломжийг хязгаарлаж байна.

#### Байгаль орчны боловсрол, тогтвортой хөгжлийн боловсрол

Байгаль орчны боловсролын асуудал Засгийн газрын баталсан Олон нийтийн экологийн боловсролын үндэсний хөтөлбөрт (ЗГ-ын 1997 оны 255 дугаар Тогтоол) тусгалаа олсон. Энэ үеэс хойш Албан бус боловсролын хөгжлийн үндэсний хөтөлбөр, Зайны сургалтын үндэсний хөтөлбөр, Төрөөс боловсролын талаар 2014-2024 онуудад баримтлах бодлого (УИХ-ын 2015 оны 2015 оны 12 дугаар Тогтоол) зэрэг бодлогын баримт бичгийг батлан гаргажээ.

Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 баримт бичигт (2016) боловсролын системийг сайжруулахад чиглэсэн асуудал, арга хэмжээ тусгагдсан. Ногоон хөгжлийн бодлогод (2014) ногоон хөгжлийг эрчимжүүлэхэд боловсрол, шинжлэх ухаан, технологи чухал үүрэгтэйг заасан байна. Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд бодлогын Стратегийн зорилт 5: “ТХБ-оор дамжуулан нөөцийн үр ашиг, хэмнэлттэй соёл, байгальд ээлтэй амьдралын хэвшил, байгаль хамгаалах, эх оронч уламжлалт соёлыг хэвшүүлэх” –ийг хэрэгжүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээг төлөвлөсөн байна. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх 8 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр заасны ихэнхийг БОАЖЯ-ны манлайлалтайгаар БСШУСЯ-тай хамтран хэрэгжүүлэх ажээ. Төлөвлөсөн 7 арга хэмжээний 6 –г нь олон улсын байгууллагуудын санхүүгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

#### *Энэхүү бүлэгтэй холбоотой ТХЗ-ууд, зорилго*

ТХЗ –ийн Зорилт 4.7 болон 12.8 –ийн Монгол улс дахь хэрэгжлтийн өнөөгийн байдлыг Шигтгээ 5.6 –д харуулав.





**Шигтгээ 5.6: Тогтвортой хөгжлийн 2030  
он хүртэлх хөтөлбөрийн Зорилт 4.7 болон 12.8**



**Зорилго 4: Бүх нийтийг хамруулсан, тэгш чанартай боловсролыг баталгаажуулах, насан туршийн сургалтын боломжийг дэмжих**

**Зорилт 4.7: 2030 он гэхэд тогтвортой хөгжлийн боловсрол болон тогтвортой амьдралын хэвшил, хүний эрх, хүйсийн тэгш байдал, энхийг сахих соёлыг дэмжих, дүр зоргоор авирлахын эсрэг боловсрол олгох замаар тогтвортой хөгжлийг дэмжихэд шаардлагатай мэдлэг чадварыг дэлхийн бүх иргэдийн соёлын бүх хэлбэрийг хүндэтгэсэн байдлаар бүх хүмүүст олгох явдлыг баталгаажуулах.**

**Зорилго 12: Тогтвортой хэрэглээ болон бүтээгдэхүүний бүх хэлбэрийг баталгаажуулах**

**Зорилт 12.8: 2030 он гэхэд Байгальтай зохицсон тогтвортой хөгжил болон амьдралын хэвшлийн тухай холбогдох мэдээ, мэдээлэлийг бүх хүмүүст олгох явдлыг баталгаажуулах**

Зорилт 4.7 болон Зорилт 12.8 нь даян дэлхийн шалгуур үзүүлэлтүүдээр (шалгуур үзүүлэлт 4.7.1 болон 12.8.1) хэмжигдэж, (i) дэлхийн иргэдийн боловсрол, (ii) хүйсийн тэгш байдал, хүний эрх, уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол зэрэг асуудлыг хамарсан ТХБ-ийг үнэлж, бүх түвшний (a) боловсролын талаарх үндэсний бодлого, (b) сургалтын хөтөлбөр, (c) багш нарын боловсрол болон (d) оюутнуудын үнэлгээ зэргийг тооцож гаргана.

Дэлхийн иргэдийн боловсролтой уялдуулж 2016 онд НҮБ-ын БШУСБ<sup>1</sup> - оос Монгол улсыг оролцуулсан дэлхийн 10 орны сургалтын хөтөлбөрийн гарын авлагад дэлхийн боловсролын үзэл баримтлал хэрхэн тусгагдсаныг харьцуулан дүн шинжилгээ хийсэн байна. Энэхүү үнэлгээгээр дэлхийн иргэдийн боловсрол болон холбогдох үзэл баримтлал Монгол улсын иргэний боловсролын хөтөлбөрт тусгагдаагүй байна. Монгол улсын иргэний боловсролын хөтөлбөр нь хоёр үндсэн бүлэгт хуваагдаж байна: Монголын уламжлал ба соёлын өв, ба өнөө үеийн иргэний боловсрол. Энэхүү илтгэлд дурьдсанаар иргэний болон иргэдийн боловсролын тогтолцоогоор дамжуулан идэвхтэй оролцох явдал олон нийтийн бүлэг, орон нутаг болон үндэсний түвшинд чухал хэвээр байна.

ТХБ-ын асуудлаар Монгол улс нь Зорилт 4.7 болон Зорилт 12.8 –ийг 2030 оны үе гэхэд бүрэн хэрэгжүүлэх, ТХБ-ыг үндэсний боловсролын бодлоготой уялдуулах орчныг бий болгожээ. Энэ талаар ТХБ-ын төсөлтэй хамтран шаардлагатай арга хэмжээ авч байна. Нөгөөтэйгүүр ТХБ-ын асуудлыг багш нарын боловсрол болон оюутнуудын үнэлгээнд тусгах талаар ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна. ТХБ-ын төслийг хэрэгжүүлсэн туршлага дээр үндэслэн БСШУСЯ нь БОАЖЯ-тай хамтран ТХБ-ын асуудлыг багш нарын боловсрол болон оюутнуудын үнэлгээнд тусгах талаар тодорхой бодит арга хэмжээ авах хэрэгтэй байна. ТХБ-ын дунд болон урт хугацааны санхүүжилтад хувийн салбарыг татан оруулж, засгийн газар болон олон улсын байгууллагын дэмжлэгт нэмэлт байдлаар ТХБ-ын санхүүгийн эх үүсвэрийг бэхжүүлэх үр ашигтай механизмыг бий болгох хэрэгтэй байна.

*Мэдээллийн хүртээмж, олон нийтийн оролцоог хангах бүтэц зохион байгуулалтын тогтолцоо*

Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Байгаль орчны мэдээллийн хүртээмжийн асуудлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам хариуцаж байна. Яамны вэб хуудасны агуулгыг бэлтгэх ажлыг дөрвөн хүний бүрэлдэхүүний Хэвлэл мэдээллийн алба хариуцаж байгаа ба тэдгээр дөрвөн хүний нэг нь нэгжийн дарга, хоёр нь сэтгүүлч, нэг нь зурагчин бөгөөд техникийн талын асуудлыг нь хоёр хүн ажилладаг Мэдээллийн технологийн нэгж хариуцаж байна. Түүнээс гадна, хэвлэл мэдээллийн нэгж нь байгаль орчны “халуун” сэдвээр (байгаль орчны салбар дахь хууль бус үйлдлүүд, эдийн засгийн салбаруудын байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөлөл г.м) мэдээллийг үндэсний хэмжээний болон орон нутгийн сонин хэвлэлүүдэд бэлтгэн өгч улмаар гол гол сонинуудад нийтлүүлж байна. Хэвлэл мэдээллийн алба нь мөн мэдээ мэдээллийг баталгаажуулан олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр нэвтрүүлэхэд бэлтгэж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд мэдээллийн хүртээмж болон шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог хангах асуудлыг тухайлан хариуцсан нэгж байхгүй байна. Тэдгээр асуудлыг яамны янз бүрийн газар, хэлтэсүүдэд тараан хариуцуулсан байна. Салбарын яамдтай холбогдсон хүсэлтийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь холбогдох яамдад нь дамжуулан хүргүүлдэг байна.

Байгаль орчны мэдээллийн төв

Байгаль орчны мэдээллийн төв нь байгаль орчны маш олон тооны мэдээллийн менежментийг хариуцдаг учир олон нийтэд мэдээлэл хүргэх нэн чухал механизм юм. Уг төв 1995 оны Байгаль орчныг хамгаалах



тухай хуулийн 2008 оны нэмэлт өөрчлөлтийн дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь байгаль орчны мэдээллийн асуудлыг хариуцсан Засгийн газрын агентлагыг байгуулах үүрэг хүлээсний дагуу байгуулагдсан байна. Төвийн хариуцах үүрэгт мэдээллийн сангаас мэдээлэл авах нөхцлийг бүрэлдүүлэх асуудал орж байна. Одоогийн байдлаар, ЦУОШГ-ын харьяанд байдаг Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн Байгаль орчны мэдээллийн төвийн үүргийг гүйцэтгэж байна. 2016 онд Байгаль орчны мэдээллийн төвийн статусыг бууруулан хүрээлэнгийн дотор байгаль орчны мэдээллийн хэлтэс болгосон боловч дийлэнхи хэрэглэгчид Байгаль орчны мэдээллийн төв гэж нэрлэсээр байна. Шуудхан хэлэхэд, Байгаль орчны мэдээллийн төвийн өнөөгийн бүтэц зохион байгуулалт нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны өмнөөс үйл ажиллагаа явуулах, боломж олгохгүй, түүнчлэн Байгаль орчныг хамгаалах тухай шинэчилсэн хуулийн заалтад нийцэхгүй байгаа юм.

#### Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв нь БОАЖЯ-ны дэргэд 2011 онд анх байгуулагдаж цэнгэг ус болон байгаль хамгаалах талаар судалгааны ажил явуулж, байгаль орчны боловсролыг олон нийтэд хүргэх үйл ажиллагаа явуулж байна. Төв нийт 25 ажилтантай.

#### Салбарын яамд

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ) 2016 оноос хойш өөрийн вэб хуудсан дээрээ иргэдийн санал хүсэлт, гомдлыг барагдуулсан тухай ехөнхий мэдээлэл тавьсанаас өөр салбарын яамд олон нийтээс гарсан хүсэлт хүсэлтийг хэрхэн барагдуулдаг тухай нарийвчилсан мэдээлэл байхгүй байна. УУХҮЯ 2016 онд иргэдээс нийт 279 хүсэлт, гомдол хүлээн авч 91 хувьд (65 санал, гомдол), харин түүний харьяа Багайлийн нөөц, газрын тосны газар 96 хувьд (214 санал, гомдол) нь хариу өгч барагдуулжээ. Ирсэн гомдлын тоо нь хүсэлтийн тооноос хавьгүй өндөр байна.

#### Бусад оролцогсод

Монголын өмгөөлөгчдийн холбооны байгаль орчны салбар нь 2016 онд байгуулагдсан, сайн дурын үндсэн дээр ажилладаг 20 гишүүнтэй байна. Энэ салбар нь байгаль орчны холбогдол бүхий хууль тогтоомжийг шүүхийн шатанд өмгөөлөх ажлыг хийж байна.

Байгаль орчны сэтгүүлчдийн клуб нь Хэвлэлийн хүрээлэнгийн дор 2009 онд байгаль орчны асуудлаар мэдээлэл сурвалжлагын чанарыг сайжруулах зорилготой байгуулагдсан, байгаль орчны чиглэлээр мэрэгшсэн эсвэл сонирхолтой бөгөөд байгаль орчин болон уул уурхайн асуудлаар сурвалжлага бэлтгэдэг сэтгүүлчдийн бүлэг юм. .

*Байгаль орчны боловсрол (БОБ), Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ)-ын бүтэц зохион байгуулалтын тогтолцоо*

БСШУСЯ нь улс орны боловсролын тогтолцоог хариуцсан Засгийн газрын үндсэн гол байгууллага юм. Тус яам үндсэндээ сургуулийн өмнөх боловсролоос авахуулаад насанд хүрэгчдийн боловсролын асуудал хүртэлх төрөөс санхүүждэг бүх шатны боловсролын хэлбэрийг хариуцан ажиллана. Яамны үүрэгт сургалтын хөтөлбөр болон бүх сурах бичгийг баталж хэвлэх асуудал багтана. БСШУСЯ нь бүх нийтийн боловсролын салбарт хамрагддаг бүх ажилтнуудын ажлын байран дээрх сургалтын асуудлыг зохицуулж, сургалт явуулдаг байна. БОБ, ТХБ-ын асуудлыг хариуцсан тусгай ажилтан яамны бүтцэд байхгүй боловч уг асуудлыг бүх шатны боловсролын байгууллагын холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэдэг байна.

БСШУСЯ ны дэргэдэх Насан туршийн боловсролын үндэсний төв нь аймаг, суман дахь салбаруудаараа дамжуулан насан туршийн сургалт болон албан бус боловсролын асуудлыг хянаж ажилладаг байна.

БСШУСЯ ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төв нь олон улсын стагдартын дагуу өөрсдийн боловсруулсан шалгуур үзүүлэлтүүд болон арга зүйд үндэслэн боловсролын чанарт үнэлгээ өгөх үүрэгтэй байна.

БСШУСЯ ны дэргэдэх Боловсролын судалгааны хүрээлэн нь сургалтын хөтөлбөр, гарын авлага сурах бичиг, сургалтын материал боловсруулж БСШУСЯ –аар батлуулахад бэлтгэдэг байна.

БСШУСЯ ны дэргэдэх Багш нарын мэргэжлийн хөгжлийн хүрээлэн нь сургуулийн өмнөх боловсролын байгууллага, бага, дунд сургуулийн багш нар, захирал бусад удирдах ажилтнуудыг тасралтгүй хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг байна. Хүрээлэнд нийт 70 хүн ажиллаж байгаагаас 40 нь 5 төрлийн сургалтын хэлтсүүдэд, харин үлдсэн 30 нь захиргааны хэсэгт ажиллаж байна. Хүрээлэн 2016 оноос хойш НҮБ-ын БШУСБ-ийн Нөөцийн хувиарлалт, сургалтын төв (RDTCs) болон Ази-Номхон далайн бүсийн Сургалтын чанарын мониторингийн сүлжээ (NEQMAP) –ийн гишүүнээр ажиллаж байна.

Хөдөлмөрийн яамны Мэргэжлийн боловсролын газар 50 гаруй жилийн турш мэргэжлийн сургалтын асуудлыг зохион байгуулж байна. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох улсын төсвөөс санхүүждэг Мэргэжлийн боловсролын бодлогын хэрэгжилтийн газар нь 91 мэргэжлийн сургуульд хийгдэх мэргэжлийн сургалтын асуудалд хяналт тавих үүрэгтэйгээр 2016 оны 11 сард байгуулагджээ. Хөдөлмөрийн яамны дэргэд ажиллах Мэргэжлийн боловсролын бодлогын хэрэгжилтийн газар нь яамнаасаа үндсэн чиглэл авч яамны холбогдох газруудтай нягт хамтран ажилладаг байна. Уг газар 6 хүнтэй ажиллаж тэдгээр нь сургууль, багш нарын арга барилыг хөгжүүлэх, статистик мэдээлэл бэлтгэх, сургуулиудын орчин, нийгмийн түншлэлийг хөхүүлэн дэмжих зэрэг асуудлыг анхааран ажилладаг байна. Мэргэжлийн боловсролын бодлогын хэрэгжилтийн газар нь мэргэжлийн сургалтад оролцож байгаа багш нарын сургалтын хөтөлбөр болон арга зүйг боловсруулах ажилд оролцдог байна.

БОАЖЯ-ны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар нв ТХБ-ын асуудлыг мөн хариуцан ажилладаг байна.

БСШУСЯ-наас 1957 онд байгуулсан Байгаль орчны боловсролын төв нь 1998 оноос хойш МУИС-ын удирдлага доор ажиллаж иржээ. Энэ нь Монгол улсад сургуулийн өмнөх болон дунд сургуулийн сурагчдад байгаль орчин, байгаль хамгаалах тухай мэдлэг мэдээллийг дээшлүүлэхэд чиглэсэн зохион байгуулалттай арга хэмжээнүүдийг явуулдаг өвөрмөц төв юм. Тус төв 5 ажилтантай. Төвийн төсвийн 50 хувийг МУИС гаргаж, үлдсэн хувийг багш нар нь өөрсдөө хөрөнгө босгох янз бүрийн арга хэмжээ (олон нийтэд зориулсан сургалт хийх, эко-аялал зохион байгуулах, төсөл боловсруулах, тэтгэмжийн хөтөлбөрт оролцох г.м) зохион байгуулж бүрдүүлдэг байна.

Аймаг бүрийн боловсролын газрууд нь Засгийн газрын албан болон албан бус боловсролын талаарх бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг. Эдгээр газрууд аймгийн цэцэрлэг, бага, дунд сургууль байгуулах, удирдлагаар хангах, зохион байгуулах ( мөн санхүүжүүлэх) ажлыг хариуцан гүйцэтгэж байна.

Жишээлбэл, Сэлэнгэ аймгийн Боловсрол соёлын газрын 10 ажилтан нь 32 сургууль, 42 улсын хүүхдийн цэцэрлэг, тэдгээрт хамрагдах 27,000 гаруй сурагчдыг хариуцан ажилладаг. Байгаль орчны боловсрол, ТХБ-ын асуудал харицсан тусгай ажилтан байхгүй. Ажилтнууд нь хими биологи, мөн физик, газар зүйн хичээлийг ТХБ-ыг олгох хэрэгсэл болгон авч үздэг. Тус аймагт БОБ, ТХБ-ыг хэрэгжүүлэхэд зориулсан тусгай төсөв байхгүй боловч Сэлэнгэ аймаг нь холбогдох арга хэмжээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэртэй байдаг байна. Тус газар мөн эко-сургуулийн хөтөлбөрт хамрагдахыг дэмжиж ажилладаг. Тухайн газар болон сургуулийн багш, ажилнуудад тулгарч байгаа гол саад бэрхшээл нь БОБ, ТХБ-ын хөтөлбөрийн агуулга, арга зүйн талаар мэдлэгийг бий болгох асуудал юм. Иймд БОБ болон ТХБ-ыг хэрэгжүүлэхэд шаарлагатай санхүүжилтийг олгох явдал нэн тэргүүний ач холбогдолтой асуудал болж байна.

## **5.7 Олон улсын гэрээ хэлэлцээр болон үйл явцад оролцох оролцоо**

*Мэдээллийн хүртээмж болон шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох болон Байгаль орчны асуудлаархи шүүхийн ажиллагаанд оролцох (Архусын Конвенци)*

Мэдээллийн хүртээмж болон шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох болон Байгаль орчны асуудлаархи шүүхийн ажиллагаанд оролцох тухай Архусын Конвенцид нэгдэх сонирхолоо Монгол улс 2011 онд илэрхийлсэн байна. Ингээд 2012 оны 4 дүгээр сард Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын

газрын урилгаар уг Конвенцид нэгдэн орсон талуудын хурлын дарга тэргүүтэй Конвенцид нэгдэн орсон зарим орны төлөөллийн бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид Монгол улсад айлчилжээ. Айлчлалын дараа Конвенцийн нарийн бичгийн дарга нарын газар болон Монгол улсын Засгийн газар хамтран ажиллаж байсан боловч 2017 оны дунд үеэр, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Конвенцид нэгдэн орох зохих нөхцөл Монгол улсад бүрдээгүй байгаа учир уг асуудлыг Монгол улсын Засгийн газар одоогоор авч үзэх боломжгүй байгааг мэдэгджээ.

#### *Нэгдсэн үндэстний байгууллагын Хүний эрхийн зөвлөл*

Хүний эрх ба байгаль орчны асуудлын НҮБ-ын тусгай төлөөлөгчид 2017 оны 9 дүгээр сард Хүний эрхийн Зөвлөлд танилцуулах илтгэл боловсруулах зорилгоор Монголд айлчилжээ. Айлчлалын дараа бэлтгэсэн илтгэлд байгаль орчныг хамгаалах асуудалд хүний эрхийг хэрхэн хүндэтгэж байгаа асуудлын сайн практик үйл ажиллагаа болон тулгарч байгаа саад бэрхшээлийн талаар тэмдэглэсэн байна. Урьдчилсан гаргасан дүгнэлтэд, оршиж байгаа асуудлуудын ерөнхий байдал, хууль тогтоомжийг сайжруулах шаардлага байгааг цохон тэмдэглэж, хууль тогтоомжийн заалтуудыг амьдралд хэрэгжүүлэх, хуулийг хэрхэн мөрдөж байгаа болон хэрэгжилтэд нь хяналт тавих шаардлагатайг тэмдэглэжээ. Цаашид сайжруулах дараах зөвлөмжийг мөн өгсөн байна:

- Төлөвлөж байгаа уул уурхайн төслүүдийн талаархи хэлэлцүүлэгт орон нутгийн иргэдийн оролцоог хангах үүднээс холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулж хуульд заасан хугацааг сунгах;
- Уул уурхайн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа, иргэний нийгмийн үр бүтээлтэй оролцоог хангах, тэдний үйл ажиллагааны ирээдүйн төлөв болон санал бодлыг нь шинэчилсэн хуульд анхаарах;
- Засгийн газар байгаль орчны талаарах мэдээлэл болон гомдлыг барагдуулах үндсэн холбоо барих, зохицуулах эрх үүрэг бүхий тусгай хүнийг (омбудсман) томилох;
- Монгол улс Аархусын конвенцид нэгдэн орох;
- Монгол улсын Хүний эрхийн үндэсний комиссын боловсруулсан хүний эрхийг хамгаалагчдийн тухай хуулийн төслийг батлах.

#### *Боловсрол*

Монгол улс НҮБ-ын ТХБ-ын арван жилийн (2005-2014) ажилд оролцож, улмаар Даян дэлхийн ТХБ-ын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг түүний дараагийн шатны арга хэмжээнүүдэд мөн оролцож иржээ.

Монгол улс Ногоон эдийн засгийн төлөөх үйл ажиллагааны түншлэл (PAGE) –ийн нэг оролцогч тал юм. Энэ хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байгаа арга хэмжээний хүрээнд сургууль, цэцэрлэгийн байшинг ногооруулах ажил хамрагдана. Жишээлбэл, тус түншлэл Улаанбаатар хотын 122 дугаар дунд сургуулийн өргөтгөлд зориулж өндөр үр ашигтай байшингийн стандартыг хэрхэн баримтлахыг олон нийтэд харуулахын тулд сургуулийн ногоон байшингийн загвар боловсруулахад Засгийн газарт дэмжлэг үзүүлсэн байна.

### **5.8. Үнэлгээ, дүгнэлт ба зөвлөмж**

#### *Үнэлгээ*

Сүүлийн арваад жилд байгаль орчны талаархи мэдээллийн хүртээмж болон байгаль орчны асуудалд иргэдийн оролцоонд нэлээд өөрчлөлт гарчээ. Хэдийгээр чадавхи, хөрөнгө нөөцийн хувьд саад бэрхшээл байсаар байгаа ч Байгаль орчин, аялал жуулчлалын яам энэ өөрчлөлтийг манлайлан удирдаж байна. Салбарын яамдын хувьд гэвэл байгаль орчны мэдээллийг хүртээмжтэй болгох, байгаль орчны асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах талаар тусгайлсан журам боловсруулах шаардлагатай байна. Цаашид, хуримтлуулсан туршлагадаа тулгуурлан одоогийн хүчин төгөлдөр байгаа хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах замаар байгаль орчны мэдээллийн хүртээмж болон олон нийтийн оролцоог үр дүнтэй болгох явдал гол зорилт болж байна. Шийдвэрлэвэл зохих бас нэг үндсэн чухал асуудал бол хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мөн хуулийн заалтуудыг дагаж мөрдүүлэхэд оролцогч бүх талуудын, ялангуяа орон нутгийн түвшинд ажиллаж байгаа Засгийн газрын эрх мэдэлтнүүдийн чадавхи хангалтгүй байгаа явдал юм.

Монгол улс ТХБ-ыг ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөртэй уялдуулах асуудлыг санаачлан ажиллаж байгаа нь ихээхэн сайн үйл ажиллагаа юм. Улсын хэмжээний бүх шатны сургуульд сургалтын шинэ хөтөлбөрийг тогтвортойгоор зохих журмаар нь хэрэгжүүлэх явдал одоо чухал болж байна. Энэ талаарх илэрхий сайн ололт амжилт бол эко-сургуулийн санаачлага, БОБ, ТХБ-ын амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлж байгаа Байгаль орчны сургалтын төвийн ажиллагаа юм. Тулгарч байгаа хамгийн бэрхшээлтэй асуудал бол ТХБ-ын төслийг хэрэгжээд дууссаны дараа ТХБ-ын үйл ажиллагааг улс орон даяар өргөжүүлэн хөгжүүлэх, багш нарын сургалт явуулах, Засгийн газрын ажилтнуудын ТХБ-ын талаарх чадавхийг бий болгохын тулд улсын төслөөс тодорхой санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох асуудал болж байна. ТХБ-ыг амжилттай хэрэгжүүлэх, ТХЗ-ын Зорилт 4.7 болон 12.8 -д хүрэх чухал урьдчилсан шаардлага бол Засгийн газрын зүгээс ТХБ-ыг албан болон албан бус боловсролтой уялдуулах явдлыг дэмжихэд чиглэсэн Засгийн газар энэхүү үүргээ хэрэгжүүлэх явдал чухал.

*Дүгнэлт, зөвлөмж*

#### Байгаль орчны мэдээллийн хүртээмж

Ерөнхийд авч үзвэл байгаль орчны мэдээлэл олон нийтэд хүртээмжтэй байх асуудлыг зохицуулах хууль эрх зүйн орчин байна. Гэсэн хэдий ч Засгийн газар болон олон нийтийн аль аль нь түүнийг хангалттай хэрэгжүүлэх явдал асуудалтай хэвээр байна. Олон нийтийн зүгээс тавьж байгаа хүсэлтийг хугацаанд нь шуурхай, үр дүнтэй шийдвэрлэх бүтцийг бий болгоход Засгийн газрын хөрөнгө нөөц дутагдаж байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас бусад Засгийн газрын байгууллагуудын байгаль орчны мэдээллийг олон нийтэд хүргэх одоогийн үйл ажиллагаа, дүрэм журам нь харилцан уялдаагүй байна. Олон нийтийн хувьд байгаль орчны тухай мэдээллийг олж авах эрх, мөн байгууллагуудын хууль тогтоомжийн дагуу энэ талаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх одоогийн механизмын талаар мэдлэг дутагдалтай байна. Энэ бүхэн нь ялангуяа 2012 оноос хойш хууль болон дүрэм журамд асар олон нэмэлт өөрчлөлт орсонтой бас холбоотой байна.

Бизнесийн байгууллагууд, тухайлбал Олворлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хүрээнд байгаль орчны талаархи мэдээллийг нээлттэй болгох, идэвхитэй түгээхийг хөхиүлэн дэмжих талаар Засгийн газар зарим нэг хүчин чармайлт гаргасан байна. Гэхдээ тэдгээр хүчин чармайлт нь дөнгөж эхлэлийн төдий байгаагаас гадна уул уурхайгаас бусад салбарт төдийлөн харагдахгүй байна.

#### Зөвлөмж 5.1:

*Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Мэдээллийн ил тод байдал ба Мэдээлэл авах эрхийн тухай 2011 оны хуулийг хэрэгжүүлэн мөрдөх;*
- (b) *Салбарын яамдын зүгээс байгаль орчны мэдээллийг идэвхитэй түгээх асуудлыг хөхиүлэн дэмжих;*
- (c) *Хуулиар баталгаажсан эрх, байгаль орчны тухай мэдээлэл авах журам ба мэдээлэл авах одоогийн механизмын талаархи олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, чадавхийг нь хөгжүүлэх сурталчилгааны ажлыг өрнүүлэх.*

#### Байгаль орчны мэдээллийн төв

Байгаль орчны олон тооны мэдээллийн менежментийг хариуцдаг Байгаль орчны мэдээллийн төв нь олон нийтэд мэдээлэл хүргэх нэн чухал механизм юм. Одоогийн байдлаар, ЦУОШГ-ын харьяанд ажиллаж байгаа Ус цаг уур, орчны мэдээлэл, судалгааны хүрээлэн байгаль орчны мэдээллийн төвийн ажлыг гүйцэтгэж байна. Мэдээллийн төвийн статусыг 2016 онд бууруулж, уг хүрээлэнгийн Байгаль орчны мэдээллийн сангийн хэлтэс болгожээ. Шуудхан хэлэхэд, Байгаль орчны Мэдээллийн төв нь Яамны шууд харьяалалд ажиллахгүй байгаа одоогийн энэ зохицуулалт нь нэмэлт өөрчлөлт оруулсан 1995 оны Байгаль орчны хамгаалалтын тухай хуультай нийцэхгүй байна.

#### Зөвлөмж 5.2:

*БОАЖЯ дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) Байгаль орчин, аялал жуулчлалын яам Байгаль орчны мэдээллийн төвийн үйл ажиллагаа, ажилд хяналт тавих ажлыг удирдаж, тус төвийн статус, бүтцийг өндөржүүлээ, өөрийн байранд байршуулах замаар байгаль орчны мэдээллийг “нэг цонхны” иж бүрэн онлайн порталд шилжүүлж олон нийтэд хүртээмжийг нь өргөжүүлэх;
- (b) Мэдээллийн баталгаа, чанарын шалгалтын тогтолцоог бий болгох замаар Байгаль орчны мэдээллийн төвд байгаа мэдээллийн чанарыг хангах.

Зөвлөмж 2.6-г үзнэ үү.

#### Олон нийтийн оролцоо

Монгол улс байгаль орчны асуудлаар шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоог хангах эрх зүйн орчинг бүрэлдүүлэх, практик үйл ажиллагаанд нэвтрүүлэн хэрэгжүүлэх талаар амжилттай ажиллаж байна. Энэ чиглэлд БОНУ, БОСҮ-д олон нийтийн оролцоог хангах албан ёсны журам бий болгож, 2015 онд Хууль тогтоомжийн тухай хууль баталсан байна.

Гэхдээ олон нийтийн үр дүнтэй оролцоог хангах тухайд олон тооны саад бэрхшээл байсаар байна. Тухайлбал, төлөвлөсөн төслүүдийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулах хугацаа ажлын 30 өдөр, хуулийн төсөл болон холбогдох журмын талаар олон нийтийн санал авах хугацааг 15 өдрөөр тогтоосон нь хангалттай хугацаа биш бөгөөд өргөн уудам нутагт тархан амьдардаг хөдөөгийн нүүдлийн аж ахуй эрхэлж байгаа иргэдэд хүрч ажиллах зэрэг суудлыг харгалзан үзээгүй байна. Бас нэг том бэрхшээл бол орон нутгийн (багийн түвшинд) захиргаа болон орон нутгийн ТББ-ууд иргэдийг хэрхэн хэлэлцүүлэгт оролцуулах талаарх чадавхи, мэдлэг мэдээлэл дутагдаж байна. Компаниудын олон нийттэй харилцах асуудал хариуцсан төлөөлөл нь хэлэлцүүлэгийг хэрхэн үр дүнтэй хөтлөн явуулахад шаардлагатай мэдлэг, ур чадвар мөн хангалтгүй байна. Гар утас болон орон нутгийн телевизийг олон нийтийн хэлэлцүүлгийн талаар мэдээлэл түгээх механизм болгон ашиглах явдал дутагдалтай байна.

Хууль тогтоомж болон бодлого боловсруулахад Байгаль орчин, аялал жуулчлалын яам Монголын Байгаль орчны иргэний Зөвлөлийн төлөөлөлийг хууль, дүрэм журам болон бодлого боловсруулах ажлын хэсэгт оруулах замаар нягт хамтран ажиллаж байна. Гэхдээ, Монголын байгаль орчны иргэний зөвлөлд иргэний нийгмийн бүх байгууллага хамрагдахгүй байна. Яамны зүгээс ажлын хэсгүүд, тэдгээрийн хурал болон тэдний ажлын үр дүнгийн талаар өөрийн вэб хуудсаар мэдээлэл өгдөггүй байна.

ТББ-ын төлөөлөлийг олон улсын байгаль орчны форум, хуралуудад оролцох үндэсний төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд бараг оролцуулдаггүй, тэдгээр олон улсын хурал зөвлөлгөөнд Монгол улсын байр суурийг илэрхийлэх материал бэлтгэх ажилд оролцуулахгүй байна.

#### Зөвлөмж 5.3:

*БОАЖЯ дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) Төлөвлөж байгаа төслүүдийн олон нийтийн хэлэлцүүлэг хийх, хуулийн төслүүдээр иргэдийн саналыг авах хугацааг сунгах талаар холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал дэвшүүлэх;
- (b) Төлөвлөж байгаа төслүүдийн талаар олон нийтийн хэлэлцүүлэгийг удирдан хөтлөх орон нутгийн захиргаа болон бизнесийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх;
- (c) Байгаль орчны мэдээлэл болон олон нийтийн оролцоог идэвхижүүлэхэд гар утас зэрэг холбоо мэдээллийн технологийн хэрэгсэлүүдийг илүү ашиглахыг хөхиүлэн дэмжих;
- (d) Монголын байгаль орчны иргэдийн зөвлөлд ордоггүй ТББ-уудын зүгээс хууль тогтоомж, бодлого боловсруулах ажилд оролцох боломжийг нээж өгөх үүднээс хууль тогтоомж, дүрэм журам боловсруулах ажлын хэсгүүдэд шууд оролцуулах;
- (e) Байгаль орчны асуудлаархи ТББ-уудын чадавхи, тайлагнах байдлыг сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх;
- (f) Байгаль орчны асуудлаархи олон улсын хурлуудад оролцох үндэсний төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд ТББ-н төлөөллийг оролцуулах боломжийг өргөжүүлэх.



### Байгаль орчны идэвхтнүүдэд учирч буй дарамт, шахалт

Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг идэвхтэнүүдийг байгаль орчныг хамгаалах ажил явуулсаных нь хувьд дарамт учруулах, хавчин гадуурхах явдал одоо ч гэсэн гарсаар байна. Засгийн газрын зүгээс эл үзэгдлийг гаргуулахгүй байх талаар ямар арга хэмжээ авдаг нь тодорхойгүй, тийм үйлдлийг халхлан хамгаалаад байна уу гэсэн сэжиглэлийг арилгахын тулд зохих ёсоор мөрдөн шалгах шаардлагатай байна. Түүнээс гадна, бизнесийн компаниуд байгаль хамгаалах идэвхитэн иргэдийг хяхан хавчиж байгаагийн зэрэгцээ Засгийн газрын зүгээс ч ийм үйлдэл гаргаж байгаа тохиолдлууд гарч байна.

#### Зөвлөмж 5.4:

*Байгаль орчныг хамгаалагч идэвхитэн иргэдийг хяхан хавчих үзэгдлээс сэргийлэх талаар Засгийн газар арга хэмжээ авах шаардлагатай.*

### Шүүхийн үйл ажиллагаанд оролцох

Олон нийтийн болон ТББ-н гишүүдээс шүүхэд хандах явдал хязгаарлагдмал байгаа нь тэд хөрөнгө хомс, мэдлэг дутагдаж байгаатай нь холбоотой байна. Байгаль орчны асуудлаар дагнан мэрэгшсэн шүүх байхгүй. Олон нийт болон ТББ шүүхэд хандахаас өмнө, тухайлбал тухайн асуудал хариуцсан тусгай ажилтан (омбудсмэн) –аар дамжуулан гомдол барагдуулахаар хандах байгууллага Монголд байхгүй байна. Байгаль орчны асуудлаар шүүгч нарт зориулан ямар нэг сургалт явуулахгүй байна.

#### Зөвлөмж 5.5:

*Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Захиргааны шүүхийн шийдвэрийн тухай 2016 оны хуулийн дагуу тогтоосон Тэмдэгтийн хураамжаас нийтийн ашиг сонирхолын талаар шүүхэд гаргасан нэхэмжлэлийг чөлөөлөх заалтыг хэрэгжүүлэх;*
- (b) *Байгаль орчны асуудлаар шүүгчдэд тогтмол сургалт зохион явуулах.*

### Аархусын конвенци

Байгаль орчны Мэдээлэл, Олон нийтийн оролцооны хүртээмж, шийдвэр гаргах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо болон Байгаль орчны асуудлаарх шүүхийн ажиллагаанд оролцох тухай конвенцид (Аархусын конвенци) нэгдэн орох албан ёсны сонирхолоо Монгол улс 2011 онд илэрхийлсэн байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэдэгдсэнээр 2017 оны дунд үе гэхэд Монгол улсын Засгийн газар эл асуудлыг авч үзээгүй байна. Тэгвэл Конвенцийн үндсэн зорилго нь ил тод, оролцоотой шийдвэр гаргах үйл явцыг тогтоох улс орнууды хүчин чармайлтад тусалж, улмаар хүчирхэг эдийн засагтай, тогтвортой байгаль орчин, нийгмийг цогцлон бүрэлдүүлэх явдал юм. Цаашилбал, ардчилсан тогтолцоог бэхжүүлэх, ард иргэд болон Засгийн газрын хоорондын харилцан итгэлцэл, хүндэтгэлийг гүнзгийрүүлэх замаар байгаль орчны асуудлаар шийдвэр гаргах үйл явцыг сайжруулахад Монгол улсад ихээхэн дэмжлэг үзүүлэх болно. Түүгээр ч үл барам, Конвенцийн зарчмуудыг хэрэгжүүлсэнээр Монгол улс бусад улс оронд, мөн өөрийн худалдаа, хөгжлийн түншүүд, гадаадын хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагуудад үр дүнтэй засаглал болон ардчилалын үйл хэргийн төлөө тууштай байгаагаар илэрхийлэх чухал илэрхийлэл, дохио болно.

#### Зөвлөмж 5.6:

*Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Конвенцид нэгдэн орох чиглэлээр Аархусын конвенцийн нарийн бичгийн дарга нарын газраас зөвлөх үйлчилгээ болон чадавхийг бэхжүүлэх тусламж авахаар хандах;*
- (b) *Конвенцийг хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавхийг газар дээр нь бүрэлдүүлсэний дараа Аархусын Конвенцид нэгдэх асуудлыг авч үзэх.*



## ***ХЭСЭГ II***

### ***ДОТООД, ГАДААД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УЯЛДАА***



## Бүлэг 6

# ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ ХЭЛЭЛЦЭЭР, ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

### 6.1 Байгаль орчин, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн асуудлаарх олон улсын хамтын ажиллагааны ерөнхий тэргүүлэх асуудлууд

Монгол улсын байгаль орчны бодлогын маш чухал хэсэг нь олон улс, бүс нутаг болон хоёр талын хамтын ажиллагаа юм. Монгол улс олон улсын хамтын нийгэмлэгийн тогтвортой хөгжил, байгаль орчин болон ногоон хөгжлийн ахиц дэвшлийг дагаж, тэдгээртэй идэвхтэй хамтран ажиллаж байна.

Монгол улс байгаль орчны холбогдол бүхий олон улсын бараг бүх гэрээ, хэлэлцээрүүдийг батламжилж, Мянганы хөгжлийн ихэнх зорилтуудыг хэрэгжүүлэхэд олсон ололт амжилтаа бүртгүүлсэн (Бүлэг 1) байна. 1994-1998 оны хооронд боловсруулсан Монгол улсын 21 дүгээр зууны Үйл ажиллагааны хөтөлбөр (МҮХ 21) нь тогтвортой хөгжлийн зарчмуудад нийцсэн анхны цогц баримт бичиг байжээ.

Монгол улсын тогтвортой хөгжлийн алсын хараа 2030 (ТХХ 2030) стратегийг 2016 онд баталсанаар олон улсын тогтвортой хөгжлийн зорилгуудыг Монголын бодлого, хууль тогтоомж, хөтөлбөрийн үйл ажиллагааны тулгуур цэг гэж үзэж байгааг дахин харуулж, Тогтвортой Хөгжлийн Зорилгуудыг (ТГЗ) хэрэгжүүлэхийн төлөө хөгжлийн бүхий л хүчин чармайлтыг төвлөрүүлэх эрмэлзэл дүүрэн байгаа нь Монгол улсыг ТХЗ-уудыг хүлээн авч байгаа дэлхийн анхдагч орнуудын нэг болгосон байна. ТХХ 2030-д 2016-2030 онд хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий тогтвортой хөгжлийн зорилтууд болон хүний хөгжил, нийтийн оролцоотой өсөлтийг хангахад төвлөрсөн ТХЗ-уудыг бүрэн хамруулсан багц зорилтуудыг тодорхойлжээ (Бүлэг 1). ТХЗ-г хэрэгжүүлэхэд чиглэсэн олон улсын хамтын ажиллагаанд идэвхитэй оролцох нь ТХХ 2030-н нэг гол зорилт бөгөөд энэ нь Монгол улс олон улсын хамтын ажиллагааны үйл ажиллагаандаа баримтлах чиглэл болж байна.

Монгол улс гадаад улс орон болон байгууллагуудтай үр дүнтэй нягт хамтран ажиллаж байна. ТХХ 2030 –д Монгол улс олон улс, бүс нутаг болон хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд улс орны хувьд нэн тэргүүний ач холбогдол бүхий асуудлууд болон зорилтуудад илүү анхаарал хандуулж, тэдгээрийн заримынх нь үйл ажиллагааны чиглэл, замын зураглалыг гаргасан байна.

Монгол улс 2014 онд байгаль орчны тогтвортой хөгжлийн замаар ирээдүй хойч үедээ урт удаан хугацаанд байгаль орчны тогтвортой хөгжлийн үр шимийг хүртэх үндэс суурийг тавихад чиглэсэн ногоон хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан бүх иргэдийн оролцоог хангасан Ногоон Хөгжлийн бодлогыг баталжээ. ТХХ 2030 болон Ногоон Хөгжлийн Бодлого нь харилцан шүтэлцээтэй баримт бичгүүд юм. ТХХ 2030-ийн үндсэн зорилгуудын нэг нь экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан, ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийн тэргүүлэх 30 орны эгнээнд орох явдал юм.

Монгол улсын хувьд, гадаад тусламж дэмжлэг болон улсын төсвийн санхүүгийн нөөцийн ашиглалтын үр өгөөжийг улам бүр нэмэгдүүлэх үндэс суурь болох бүтэц зохион байгуулалт, сайтар боловсруулсан хөгжлийн бодлогын төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлсэн байна (Бүлэг 1). ТХХ 2030 нь бүх шатны төлөвлөлтийн явцын стратегийн үндсэн баримт бичиг юм. Хөгжлийн бодлогын төлөвлөлтийн тухай 2015 оны хуульд бодлого болон төсвийн төлөвлөлтийн зарчмууд, мөн Үндэсний хөгжлийн хөтөлбөрүүдийг улсын төсөв болон улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж байхаар заасан байна. Өнөөдрийн байдлаар, байгаль орчин, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн асуудлуудыг улсын төсөвтэй холбож, улсын төсөвт тусгасан нь харагдахгүй байгаа (Бүлэг 3) бөгөөд хэрэгжүүлж байгаа дийлэнхи төсөл, арга хэмжээг хандивлагчдийн тусламжтайгаар үргэлжлүүлэн санхүүжүүлсээр байна.

Монгол улсыг дэмжин тусалж байгаа хоёр талын болон олон талын хандивлагчдийн тоо өсөн нэмэгдсээр байгаа нь Монгол улс дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэхийн тулд стратегийн түншлэлийг бүх шатанд тогтоох чадавхи, хүсэл эрмэлзэлтэй байгааг харуулахын зэрэгцээ Байгаль орчин, аялал жуулчлалын



ям нь хандивлагчидтай хамтын ажиллагааг өргөжүүлэн зохицуулах чадвартай байгаагийн илэрхийлэл юм.

## 6.2 Дэлхийн болон бүс нутгийн гэрээ хэлэлцээрүүд

### *Оролцоо, тайлагнал, арга хэмжээ*

Монгол улс 1990-ээд оноос хойш байгаль орчны асуудлаарх ихэнх гэрээ хэлэлцээрт нэгдэн орж, сүүлийн үеийн Мөнгөн усны Минаматагийн конвенци зэрэг байгаль орчны тухай гэрээ хэлэлцээрийг батламжилсан байна.

Байгаль орчны гэрээ хэлэлцээрүүдийн шийдвэр гаргах байгууллагуудын бүх хуралдаануудад наад зах нь нэг, зарим хуралдаануудад хэд хэдэн хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчийг оролцуулж иржээ. Техникийн чанартай байнга болдог хурлуудад оролцож байгаа төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийн мэрэгжилтэн эрдэмтэн судлаач оролцож байна. Үндэсний ТББ-н төлөөлөл төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд хааяа нэг орж байгаа боловч олон улсын хурлуудад Монголын байр суурийг танилцуулах баримт бичгийг боловсруулан бэлтгэх ажилд тэдний оролцоо байхгүй байна.

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци /САЙТИС-ын конвенци/, Аюултай хог хаягдал болон тэдгээрийг хил дамнуулан зайлуулах тухай Конвенцээс (Basel) бусад гэрээ хэлэлцээрийн хувьд Монгол улс олон улсын хэмжээнд хүлээсэн тайлагнах үүргээ мөрдөн ажиллаж байна. Харин САЙТИС -ын конвенцийн хувьд, хоёр жил тутмын тайлан илтгэлийг зөвхөн 2003-2004 болон 2015-2016 онд бэлтгэн хүргүүлсэн ба жил бүр бэлтгэн хүргүүлэх Базелийн конвенцийн хувьд 2001, 2005, 2014, 2015, 2016 онуудад таван удаа л тайлангаа хүргүүлсэн байна.

Хэдийгээр Монгол улс олон улсын тавцанд идэвхитэй ажиллаж, олон улсын хэлэлцээрийг хэрэгжүүлэх асуудлыг байгаль орчны үндэсний бодлогынхоо төвд тавьж анхаарч байдаг ч тэдгээр хэлэлцээрүүдийн дагуу авах арга хэмжээ, бүх үйл ажиллагаа болон тэдгээрийн хүрээнд боловсруулсан төслүүдийг хэрэгжүүлэхэд зарим саад бэрхшээл тулгарч байгаа нь тэдгээрийн үндэсний зохицуулагчид байнга өөрчлөгдөж байгаатай холбоотой юм. Үүний нотолгоо бол эдгээр зохицуулагчдын хооронд санал зөрөх явдал бараг хэвийн үзэгдэл болж, энэ талаар олон улсын хэлэлцээрийн Нарийн бичгийн дарга нарын газарт зарим гэрээ хэлэлцээрийн зохицуулагчид мэдэгдсэн байна. Ер нь хэт олон үндэсний зохицуулагчтай байх нь эргээд хэлэлцээр явуулж ирсэн түүхээс эхлээд хэрэгжүүлсэн үйл ажиллагаатай холбогдсон мэдээлэл алга болох зэрэг бэрхшээл тулгарч болзошгүй юм. Гэрээ хэлэлцээрүүдийн хэрэгжүүлэх асуудлыг, тухайлбал САЙТИС болон Базелийн конвенцийг нэг хүн хариуцаж, илүү олон тодорхой арга хэмжээнүүдийг тогтмол хэрэгжүүлэх үед энэ бэрхшээл улам илэрхий харагдаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам өөрийн вэб хуудсаар дамжуулан Монгол улсын нэгдэн орсон олон улсын хэлэлцээрүүд болон тэдгээрийн хэрэгжилтийн явц, зарим нэг тайлан илтгэлийг нийтийн хүртээл болгож байна.

*Биологийн олон янз байдал болон байгалийн нөөц баялагын тогтвортой ашиглалт, хамгаалалт*

Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенци /Рамсарын конвенци/

Монгол улс ы Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенци / Рамсарын конвенци/-д 1998 онд нэгдэн оржээ.

Монгол улс хүйтэн бүсийн намгархаг газраас эхлээд ультра-олиготрофик нуурууд, давст нуур, гол мөрний сав газрууд дахь хүчтэй үер болдог тал газар зэрэг асар ялгаатай харилцан адилгүй намгархаг газрын амьтадаар баялаг боловч Монгол улс ус намгархаг газруудад дөнгөж 1980-аад оны эцсээр анхаарал хандуулж эхэлсэн байна. Үүний гол шалтгаан нь тэр үеийг хүртэл намгархаг газрын нөөц баялагын ашиглалт төдийлөн их байгаагүйтэй холбоотой ажээ. Үүний зэрэгцээ, Их нууруудын хотгор дахь Бөөн цагаан нуур, Орог нуур, Таацын нуур, Адгийн цагаан нуур, Улаан нуурын усны түвшинд ихээхэн өөрчлөлт гарч эхэлсэнээр намгархаг газар ширгэж алга болох үйл явцыг зогсоох талаар арга хэмжээ авахад хүргэсэн байна.

Эдийн засаг хөгжиж, хүн ам хурдацтай өсч байгаа нөхцөлд намгархаг газрын нөөцийг хэвийн байдлаар хадгалах асуудал боломжгүй болж ирэхэд эрдэм шинжилгээ болон техникийн үнэлгээ, судалгааны ажлыг эхлүүлсэн байна. Ус зүйн үнэлгээ болон гүний усны чанарын шинжилгээ, биологийн олон янз байдал, үерийн усны урсац болон тэдгээрийн өөрчлөлт зэрэг цогц судалгааг 95 гол мөрөн, 14 нуурыг хамруулан хийсэн байна. Тухайлбал, 122 гол мөрөнд намгархаг газрын морфологи, гидрологи, өвс ургамал, амьтаны мониторинг хийсэн байна. Тэдгээр судалгаа шинжилгээний үр дүнд улс орны намгархаг газрыг гол, нуур, цэвэр усны намгархаг газар, давстай намгархаг газар зэргээр ангилан тогтоох бааз суурийг тавьж, Олон улсын ач холбогдол бүхий намгархаг газар гэдгийг товлон тогтоосон байна (Рамсарын газрууд).

Монгол улс Рамсарын конвенцид нэгдэх үйл явц үргэлжилж байх явцад 1977 онд Монгол Дагуурыг Рамсарын газар гэж тогтоосон байна. Нэг жилийн дараа, өөр гурван газрыг Рамсарын газарт оруулсан нь Өгий нуур, Тэрхийн цагаан нуур болон Их нууруудын хотгор байжээ.

Монгол Дагуурын нуур болон намгархаг газрыг Тусгай хамгаалалтай газрын тухай 1994 оны хуулийн дагуу тусгай хамгаалалтад авчээ. Монгол Дагуур нь Дагуурын олон улсын хамгаалалтай газрын нэг хэсэг бөгөөд Дагуурын экосистемийг хамгаалах тухай гурван талт хэлэлцээрт Монгол, Хятад, Орос улсууд 1994 онд гарын үсэг зурсан байна. Гурван талт энэхүү хэлэлцээрийг байгуулсан нь гурван улсын газар нутгийн хэсгүүдийг хамран үргэлжлэн тогтсон Дагуурын ус намгархаг газар, тал газрын нүүдлийн шувууд, тарвага зэрэг амьтдыг хамгаалах, биологийн олон янз байдал, экосистемд хяналт тавихад нэн чухал ач холбогдолтой болсон байна.

Намгархаг газрыг хамгаалах тухай бие даасан хууль Монголд байхгүй ч намгархаг газрыг хамгаалахтай холбогдсон заалтууд хэд хэдэн хуульд тусгагдсан байна, тухайлбал: Байгаль хамгаалах тухай 1995 оны хууль, Тусгай хамгаалалттай газрын тухай 1994 оны хууль (Бүлэг 11), Хилийн бүсийн тухай 1997 оны хууль (Бүлэг 11), Ан амьтаны тухай 2012 оны хууль (Бүлэг 11), 2012 оны Ан агнуурын тухай хууль, 2012 оны Ойн тухай хууль (бүлэг 13) болон Усны тухай 2012 оны хууль (Бүлэг 1) зэрэг хуулийг дурьдаж болно. Тэдгээрээс гадна, намгархаг газар болон усны шувууны зарим төрөл зүйлийг хамгаалах үүднээс 1997 оны Улаан номонд зарим төрөл зүйлс, тухайлбал, *Pelecanus crispus*, *Cygnus columbi anus bewickii*, *C. cygnus*, *Egretta alba*, *Platalea leucorodia*, *Lutra lutra* and *Castor fiber* зэрэг амьтдыг тусгайлан оруулж, Ан агнуурын тухай хуулийн дагуу хамгаалалтад авчээ. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны намгархаг газрын тухай хууль боловсруулах ажил одоогоор эхлэлийн шатанд явж байна.

Конвенцийг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс конвенцийн Үндэсний хороог 1998 онд байгуулж, 2001, 2010 онуудад бүрэлдэхүүнд нь зарим нэг зохицуулалтын өөрчлөлт оруулсан байна. Одоогийн байдлаар Үндэсний хороо нь удирдах зөвлөлийн хэлбэртэй байгаа бөгөөд бүрэлдэхүүнд нь Шувуу судлалын холбооны Ерөнхийлөгч тэргүүлж, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, ШУА-ын ус ба нуур, хүлэрт намгархаг газрын мэрэгжилтэнүүд, биологчид, мөн гол мөрний сав газрын 21 захиргааны төлөөлөл орж байна. Хороо нь жилд нэг удаа хуралдаж, Конвенцийн хэрэгжилтэд зөвлөлгөө өгөх чухал үүрэг гүйцэтгэж, хорооны хэд хэдэн гишүүн Рамсарын газрын холбогдол бүхий олон улсын хурлуудад оролцож байна.

Айраг нуур, Хар ус нуурыг 1999 онд Рамсарын газарт авсан бөгөөд 2004 онд одоогийн хүчин төгөлдөр байгаа жагсаалтыг дараах газруудыг оруулсанаар эцэслэсэн байна: Ачит нуур болон эргэн тойрны намгархаг газар, Буйр нуур болон эргэн тойрны намгархаг газар, Ганга нуур ба эргэн тойрны намгархаг газар, Увс нуур ба эргэн тойрны намгархаг газар, мөн Хөх-Хүйтэн голын хөндий дэх нуурууд оржээ. Рамсарын 11 газар нь нийт 1,439,530 га талбайг хамарч байна (Хүснэгт 11.5). Эдгээр газар нь Монголын нийт 70 газар ордог, нийт нутаг дэвсгэрийн 5 хувийг эзэлдэг Ач холбогдол бүхий шувууд болон биологийн олон янз байдал бүхий газрын (ИВА) жагсаалтад хамрагддаг байна.

Монгол улсын тусгай хамгаалалттай газруудын тухай хуулиар тусгай хамгаалалтын нөхцөл, статусыг тодорхойлсон заалтад дүн шинжилгээ хийж үзэхэд Рамсарын газруудын хамгаалалтын түвшин хуулийн заалтаас ихээхэн ялгаатай байна. Хуулинд тусгай хамгаалалттай газрыг төрийн болон орон нутгийн гэсэн хоёр ангилалд хуваан авч үзсэн байдаг. Түүнчилэн улсын тусгай хамгаалалттай газрыг Дархан цаазат тусгай хамгаалалттай газрууд, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Байгалийн нөөц газар, Түүхийн дурсгалт газар гэсэн дөрвөн дэд ангилалд хуваасан байдаг (Бүлэг 11). Хүснэгт 11.5 –д Тусгай хамгаалалттай газрын тухай хуулийн дагуу Рамсарын ямар газрууд бүрэн болон хэсэгчилсэн хамгаалалтад хамрагдаж байгааг харуулав.

Рамсарын бүх газар бүхэлдээ эсвэл тодорхой хэсэг нь улсын хамгаалалттай газрын сүлжээнд орсон байна. Бодит байдал дээр Монголын асар уудам газар нутагт говь, цөл, заримдаг цөл, хүйтэн хуурай бүсийн ой ихээхэн газар нутгийг хамарч байгаа бөгөөд тэдгээр нь бүхэлдээ ямар нэгэн аюулд нэрвэгдэх нөхцөлд хамрагдаагүй, тэдгээр газруудын заримд нь хамгаалалттай газрын албан ёсны хэлбэрийн шинж чанарыг агуулахгүй байна. Ганга нуур, Буйр нуур, Ачит нуур, Тэрхийн цагаан нуур менежментийн төлөвлөгөө байхгүй байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яам 2017 оны сүүлчээр тэдгээр менежментийн төлөвлөгөөг боловсруулахаар зорьж байна. Одоогийн байдлаар, тэдгээр газруудын статусын талаар цогц мэдээлэл байхгүй, менежментийн үйл ажиллагааны хэрэгжилт дутагдалтай байна.

Рамсарын газар гэж тодорхойлсон намгархаг газрын ангилал, менежмент болон энэ талаархи олон нийтийн ойлголт ухамсарыг дээшлүүлэх үйл ажиллагаа 1990-ээд оны эхэн үеэс хойш харьцангуй дээшилж байна. Рамсарын газарт орж байгаа боловч тусгай хамгаалалттай газар гэсэн статуст хамрагдахгүй байсан газруудыг тусгай хамгаалалтад оруулсанаар тусгай хамгаалалттай газрын хамрах хүрээ тэлж байна. Их нууруудын хотгорын Хөх нуур, Орог нуурыг Их Богдын Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд хамруулсан байна.

Олон улсын байгууллагын тусламжтайгаар нүүдлийн шувуудын талаар судалгаа шинжилгээ, хяналтын ажлыг хийсэн байна. Нүүдлийн шувуудын судалгаа шинжилгээ, хяналтын олон улсын хамтын ажиллагаа ихээхэн өргөжиж байна. Цагаан хүзүүт тогоруу, хун галуу зэрэг нүүдлийн шувуудыг хамгаалах, намгархаг газрын экосистемийн мониторинг хийх зэрэг хил дамнасан үйл ажиллагааг Олон улсын тогоруу судлалын сан, АНУ геологийн судалгаа, АНУ-н ойн алба, НҮБ-н Зүүн хойд Азийн байгаль орчны хөтөлбөр дэмжиж иржээ.

Рамсарын конвенцийг хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий асуудалд Рамсарын газруудын статуст үнэлгээ хийх, цаашид хэрхэн хамгаалах болон менежментийн талаар зөвлөмж өгөх; 2018 он гэхэд Хөвсгөл нуурыг Рамсарын газарт оруулах (Монголын цэнгэг усны нөөц гэж үздэг); Хурх Хүйтэний хөндийг орон нутгийн хамгаалалттай газрын статустай болгож, иргэдэд түшиглэсэн байгалийн нөөц газрын менежментийн загвар болгох; Рамсарын газруудад тавих хяналтын ажлыг сайжруулах, эдгээр газруудад мониторинг хийх механизмыг боловсруулах; 2018 он гэхэд Рамсарын газруудын олон нийтэд хүртээмжтэй үндэсний мэдээллийн сантай болох; нүүдлийн шувуудын судалгаа, намгархаг газар болон усны зохистой хэрэглээний сургалт зэрэг арга хэмжээгээр дамжуулан олон улсын харилцан зохицуулалтыг сайжруулах; тусгай хамгаалалт бүхий газрын сүлжээний гадна орших Рамсарын газруудын санхүүжилтийн механизмыг сайжруулах зэрэг асуудлыг хамруулан авч үзэж болно.

#### Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцид /САЙТИС-ын конвенци/ Монгол улс 1996 онд нэгдэн оржээ. Монголд конвенцийн Хавсралт I-д орсон 11 төрөл зүйлийн шувуу, зургаан төрөл зүйлийн хөхтөн амьтан, мөн Хавсралт II –ийн жагсаалтад орсон нэг төрөл зүйлийн шавьж, хоёр төрөл зүйлийн загас, нэг төрөл зүйлийн хоёр нутагтан, 52 төрөл зүйлийн шувуу, нэг төрөл зүйлийн хөхтөн амьтан, найман төрөл зүйлийн ургамал тус тус байдаг байна.

САЙТИС-ын конвенцийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс нь Устах аюулд орсон амьтан, ургамлын төрөл зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай 2002 оны хууль, дагалдах журам, Ан амьтаны тухай 2012 оны хууль, Байгалийн ургамалын тухай 1995 оны хууль болж байна. Устах аюулд орсон амьтан, ургамалын төрөл зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай 2002 оны хууль нь САЙТИС-ын конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж, Конвенцийн Хавсралтуудад орсон ан амьтан, ургамлын олон улсын худалдаанд болон холбогдох иргэд, аж ахуйн нэгжүүдэд зөвшөөрөл олгож байна. Монгол улсын тусгай хамгаалалтад авсан болон нэн ховордсон эсвэл устах аюулд орсон амьтдын жагсаалтад орсон 67 амьтаны төрөл зүйлийн 26 нь САЙТИС-ын конвенцийн Хавсралт I, эсвэл II-ийнн жагсаалтад орсон байна. Монголын хууль тогтоомжийн дагуу хамгаалалтад авсан 133 өвс ургамлын 8 нь Хавсралтад II-ийн жагсаалтад оржээ.

Эдгээр асуудлаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар ерөнхий удирдлагын үүргийг гүйцэтгэдэг бол ШУА-н Биологийн хүрээлэн эрдэм шинжилгээний ажлыг хариуцдаг байна. Конвенцийн хавсралтуудын жагсаалтад орсон ургамал, амьтны экспорт, импортын зөвшөөрөл авах хүсэлтээ БОАЖЯ-ны дээрх газарт ирүүлж лиценци эсвэл

сертификат авна. Тус яам 1996 - 2013 оны хооронд 800 орчим экспортын болон дамжуулан экспортлох зөвшөөрлийг 85 төрөл зүйлийн амьтан, 15,000 төрөл зүйлийн ургамлын бүтээгдэхүүнд олгож нийт 146 улсад экспортлох зөвшөөрөл олгосон байна.

САЙТИС-ын конвенцийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах Устах аюулд орсон төрөл зүйлийг хамгаалах Монголын комиссыг байгуулж, дараа нь 2009 онд хүрээг нь өргөтгөн Амьтан, ургамалыг хамгаалах Үндэсний хороо болж өргөжжээ.

САЙТИС-ын худалдааны тухай жил бүрийн тайлан мэдээг тогтмол гарган хүргүүлж байна. Харин 2002-2003 болон 2015-2016 оныг эс оролцуулбал, Конвенцийг хэрэгжүүлэх эрх зүй, зохицуулалт, захиргааны авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай хоёр жил тутмын тайланг гаргаж хүргүүлээгүй байна. 2017 оны 10 дугаар сарын 31-нээс эхлэн хууль бус ангийн тухай тайланг өмнөх жилийг хамруулан жил бүр гаргаж байх болсон байна.

Хэдийгээр Конвенцид олон улсад худалдаалах аль ч төрөл зүйлийн хувьд ямар нэг квот тавиагүй боловч Монгол улс худалдааны менежментийг сайжруулах зорилгоор зарим нэг төрөл зүйлд квот тогтоодог байна. Тухайлбал 2001 болон 2002 онд саарал чоно, цоохор ирвэс, аргал хонь, мөн 2010 болон 2011 онд шонхор шувуунд квот тогтоож өгсөн байна.

2005 онд Шонхор шувууны худалдаа болон Талуудын бага хурлын Conf.12.8 (Rev. CoP13) тогтоолын хэрэгжилт, мөн САЙТИС-ын Амьтаны асуудал эрхэлсэн хорооны 21 дүгээр хуралдааны зөвлөмжөөр (Женев, 2005 оны 5 дугаар сар) есөн Улс оронд “яаралтай анхаарах” төрөл зүйлийн ангилал, 26 улс оронд “анхаарах шаарлагатай байж болох” ангилал гаргасан байна. Монгол улс 2006 онд гаргасан яаралтай анхаарах тухай мэдэгдэл хүлээн авсан орны тоонд орж байгаа учир шонхор шувууны экспортод олгож байгаа зөвшөөрлийг цуцлах шаардлагатай болсон байна. Мэдэгдлийг хүлээн авсны дараагийн жилүүдэд Монгол улс шонхорыг хамгаалах, тоо толгойг нэмэгдүүлэх талаар хэд хэдэн арга хэмжээ авч хэрэгжүүлсэний үр дүнд энэ төрөл зүйлийн тоо нэлээд нэмэгдсэн учир Амьтны асуудал эрхэлсэн Хорооноос Монгол улсыг дараагийн жилд нь 300 шонхор экспортлохыг зөвшөөрсөн байна. Тэр жилдээ Монгол улс шонхорыг 2011-2012 онд экспортлох квот тогтоож, Кувейт, Катар, Саудын Араб улсад 203 шонхор экспортлох хэлэлцээр байгуулжээ.

Хил хамгаалах ерөнхий газар болон Гаалийн ерөнхий газрын тайланд дурьдсанаар нэлээд олон төрөл зүйлийн амьтан барьж, хууль бусаар улсын хилээр гаргаж байгаа хэрэгт бор баавгай (paws, gallbladder), саарал чоно (арьс, хэл), цоохор ирвэс, тарвага, үнэг (арьс), нарсны самар, говийн зарим амьтан (*Saposhnikovia divaricate*) орсон байна.

Зэрлэг ан амьтдыг хамгаалах нийгэмлэг, Чимээгүй тал байгууллагаас Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн төслийн үр дүнд 2006 онд, зэрлэг амьтны мах, эмийн бүтээгдэхүүний олон улсын худалдаа өссөөр байна гэсэн дүгнэлт гаргажээ. Мөн зэрлэг ан амьтны эд эрхтэнг эмийн зориулалтаар худалдаалах явдал ч өсч байгааг тэмдэглэн байна.

Устах нэн аюултай төрөл зүйлийг хамгаалах арга хэмжээг авч байна. Улсын тусгай хамгаалалтын газарт 2017 оны байдлаар, нийт 27,953,449.98 га (нийт газар нутгийн 17.87 хувь) талбайг авчээ. Хамгаалалтад авсан газар нутагт цоохор ирвэс, хулан, халиун буга, аргаль хонь, янгир ямаа болон хууль бусаар агнаж байгаа олон төрлийн зэрлэг амьтан тархан нутаглаж байна.

Сүүлийн хориод жилд, тодорхой төрөл зүйлүүдийг хамгаалах хэд хэдэн хөтөлбөр, тухайлбал: халиун буга хамгаалах Үндэсний хөтөлбөр (2000), Аргаль хамгаалах Үндэсний хөтөлбөр (2012), Цоохор ирвэс хамгаалах Үндэсний хөтөлбөр (2005), Идлэг шонхор хамгаалах үндэсний хөтөлбөр (2003), Халиун буга хамгаалах Үндэсний хөтөлбөр (2009), Говийн баавгай мазаалай хамгаалах үндэсний хөтөлбөр (2013) баталжээ. Харин тэдгээр хөтөлбөрүүдийн үр дүнгийн талаархи найдвартай, тогтмол мэдээлэл хангалтгүй байна. Мониторингийн асуудал томоохон бэрхшээл хэвээр байна. Мөн олон нийтэд хүргэх мэдээлэл хангалтгүй байна. Шийдвэр гаргах болон цаашид арга хэмжээ авахад шаардлагатай САЙТИС-ын төрөл зүйлүүдийн нөхцөл байдал, олгож байгаа зөвшөөрөл, сертификат болон хууль бус хулгайн антай холбогдсон үндэсний цогц мэдээллийн бааз суурь хангалтгүй байна.

САЙТИС-ын конвенциор хүлээсэн үүргийг биелүүлэх үүднээс хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн хувьд Монгол улс олон тооны идэвхитэй түншүүд болон байгууллагуудын дэмжлэг тусламжийг авч байна. Энэ бүхэн нь хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь ихээхэн тус нэмэр болж байна (Шигтгээ 6.1).



**Шигтгээ 6.1: САЙТИС-ын Хавсралт I –ийн жагсаалтад орсон устах аюултай төрөл зүйлүүдийг хамгаалах талаархи олон улсын хамтын ажиллагааны зарим жишээ**

Тахь буюу Пержвальскийн адуу бол дэлхийд байгаа адууны долоон төрөл зүйлийн нэг зүйл юм. Түүнийг 1960-аад оноос устаж үгүй болсон зэрлэг амьтны ангилалд оруулсан байдаг. Энэ төрөл зүйлийг Монголд эргэн нутагшуулах, сэргээн үржүүлэхэд Монгол улсад үзүүлсэн олон улс орон, олон улсын байгууллагуудын дэмжлэг туслалцаа чухал ач холбогдолтой байсан байна. Тухайлбал Голланд улс, Голландын Прежевалскийн адууг хамгаалах сан, Вагенингений их сургууль (Недерланд), Токио, Азабу, Цукуба, Окаяма, Ракуио, Гакуений их сургуулиуд (Япон), Сенкенбергийн Байгалийн музей (Герман), Лондонгийн зоологийн нийгэмлэг (Англи), Кибелла планетийн нийгэмлэг (Франц), Миннесота Зоопарк болон Смитсоны хүрээлэн (АНУ)-г дурьдаж болно. Энэ бол дэлхийн байгаль хамгаалах үйлсийн олон улсын амжилттай хамтын ажиллагааны сайн жишээ юм. Одоо нийт тахийн сүргийн тоо 300 гаруйд хүрсэн ба САЙТИС-ын Хавсралт I жагсаалтад устах аюултай амьтны ангилалаар орсон байна.

Хэдийгээр 1972 оноос цоохор ирвэсийг агнахыг хориглосон боловч түүний тоо толгой буурсаар байна. Дэлхийн байгаль хамгаалах сан (ДБХС) 1997 онд цоохор ирвэсийг хамгаалах ажлыг дэмжих зорилгоор Монголд төсөл хэрэгжүүлж эхлэн, Түргэн болон Цагаан шувуутын тусгай хамгаалалттай газрын Цоохор ирвэсийн менежментийн төлөвлөгөө боловсруулан ажиллажээ. ДБХС -гийн төсөл хэрэгжүүлж байгаа газарт 1997 - 2002 оны хооронд цоохор ирвэсийн тоо толгой өсч, Түргэнд 29 байсанаа 48, Цагаан шувуутад 4 байснаа 18 болж өсчээ. Тэдгээр газарт ирвэсийн тоо толгой тогтворжин нэмэгдсэн байна. Хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд орон нутгийн иргэдийн зүгээс бүрэн тусламж дэмжлэг үзүүлж байсан байна.

САЙТИС-ийн конвенцийн хэрэгжилтийг хангахад нэн тэргүүнд анхаарах шаардлагатай асуудлуудад хууль хэрэгжүүлэх байгууллагын чадавхийг сайжруулах, Монголын байгалийн үнэт зүйлийг хамгаалахын ач холбогдолын тухай мэдээлэл түгээх замаар олон нийтийн хууль бус ан агналттай тэмцэх ажилд оролцох оролцоог хангах механизмыг бэхжүүлэх, хууль бус ан агнахтай тэмцэх арга хэмжээ авах, тухайн газрын хүний нөөцийн, техникийн болон санхүүгийн бэрхшээлүүдийг даван туулах арга хэмжээнүүдийг авах зэрэг асуудал орж байна.

Нүүдлийн төрөл зүйлүүдийг хамгаалах тухай конвенци

Монгол улс 1999 онд Нүүдлийн төрөл зүйлүүдийг хамгаалах тухай конвенцийг (Боннын конвенци) батламжилжээ. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Уур амьсгалын өөрчлөлт ба Олон улсын гадаад харилцааны газраас гадна Монгол улсын ШУА-ийн Биологийн хүрээлэн, Монголын Улсын их сургууль, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Цоохор ирвэс хамгаалах нийгэмлэг зэрэг байгууллагууд нүүдлийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагаанд оролцож байна. Нүүдлийн төрөл зүйлийн судалгаанд Австри, Герман, Япон, АНУ-ын олон улсын мэрэгжилтнүүд хамтран ажиллаж иржээ.

Нүүдлийн төрөл зүйлийг хамгаалахад Монголын газар нутаг ихээхэн үүрэг гүйцэтгэж байна. Конвенцийн Хавсралт 1 болон Хавсралт 2 жагсаалтад орсон олон тооны төрөл зүйл жилийн турш, эсвэл тодорхой хугацааг Монголын нутагт өнгөрүүлж байна. Цоохор ирвэс, хавтгай тэмээ, Сибирийн тогоруу зэрэг 21 амьтад Конвенцийн Хавсралт 1-д ордог бол, Хавсралт 2-д 171 төрөл зүйл ордог байна.

Боннын Конвенцийн хүрээнд Монгол улс гурван Санамж бичигт гарын үсэг зурсан байна. Тухайлбал Сибирийн тогоруу хамгаалах асуудлаар 2004 онд, махчин шувуудын (Бүргэд, харцага г.м) асуудлаар 2008 онд, Бөхөн гөрөөсөөр 2010 онд гарын үсэг зуржээ. Монгол улс нүүдлийн төрөл зүйлийг хамгаалах талаар Аргаль угалзаар 2012 онд; идлэг шонхороор 200 онд; Цоохор ирвэсээр 2005 онд; бөхөнгөөр 2007 онд; Тул загасны асуудлаар 2007 онд; загас үржүүлэх, хамгаалах тухай 2008 онд зэрэг хэд хэдэн үндэсний хөтөлбөр батлан хэрэгжүүлж байна.

Үндэсний хэмжээний эдгээр тодорхой хөтөлбөрүүдээс гадна, Монгол улс бие даасан хэд хэдэн хууль баталсан байна, тухайлбал: амьтны аймгийн тухай (2012), байгалийн ургамлын тухай (1995), тусгай хамгаалалттай газрын тухай (1994), нүүдлийн төрөл зүйлүүдийг хамгаалах гол хууль болох агнахыг хориглох тухай хуулийг тус тус баталжээ. Ховор болон устах аюултай төрөл зүйлүүдийг хамгаалах тухай үйл ажиллагааны төлөвлөгөөг (Засгийн газрын 2011 оны 277 тоот тогтоол) тэдгээрийн хамгаалалтыг сайжруулах, ховор зэрлэг амьтадыг хамгаалах зорилгоор 2011 онд баталсан байна.



2000 онд Боннын конвенцийн хүрээнд Үндэсний хороо болон Шинжлэх ухааны Зөвлөлийг тухайн үеийн Байгаль орчны яам байгуулж, түүний гишүүдийг 2010 онд шинэчилэн өөрчилсөн байна. Энэ хоёр байгууллагын хэрэгжүүлсэн ажил, Конвенцийг хэрэгжүүлэхэд гүйцэтгэсэн үүрэг ролийн нь талаар хангалттай мэдээлэл байхгүй байна.

Монгол улс Конвенци болон гарын үсэг зурсан гурван санамж бичгийн хүрээнд хүлээсэн үүргийн дагуу 1999 болон 2011 онд тайлан гаргаж хүргүүлжээ. Харин түүнээс хойш Монгол улс тайлангаа тогтмол гаргаж хүргүүлээгүй байна. НҮБХХ болон Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар Монголын үндэсний тайланг бэлтгэх болон хэвлэхэд дэмжлэг үзүүлж иржээ.

Тахь нутагшуулах, хамгаалах талаар хүчин чармайлт гаргаж, зохих амжилтад хүрсэн ч нүүдлийн төрөл зүйлийн хамгаалалтын талаар зарим нэг анхаарах асуудал байсаар байна. Тухайлбал, тэдгээртэй холбогдсон асуудлыг төлөвлөх, зөвшөөрөл олгох, уул уурхай, мал аж ахуй, дэд бүтэц зэрэг эдийн засгийн үйл ажиллагаанд төдийлөн анхаарч тусгахгүй байна. Монгол шиг өргөн уудам газар нутагтай, ан агнах бүс тогтоогоогүй орны хувьд хууль бус ан агнах асуудал ихээхэн аюул, эрсдэл дагуулж байгаагаас гадна хяналтын цогц тогтолцоогүй учир хууль бус ан агнуур ямар хэмжээний нөлөө үзүүлж байгаад өгөх хариу байхгүй байна.

Арваад жилийн идэвхитэй үйл ажиллагааны дараа 2011 оноос авч хэрэгжүүлж ирсэн эрх зүй, зохицуулалт, төсөлд суурилсан Боннын конвенцийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн эрч далайц суларч байна. Монгол улс өмнө нь Конвенцид нэгдэн орсон Талуудын хурал зөвлөлгөөний үеэр Конвенцийн Хавсралтуудад төрөл зүйлүүдийг нэмж оруулах талаар асуудал тавьж байсан боловч одоогоор тэр бүхнийг баталгаажуулаагүй байна.

Боннын конвенцид нэгдэн орсон Талуудын хурлаас Нүүдлийн төрөл зүйлүүдийн тухай Стратегийн 2015-2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2014 онд баталжээ. Үүний дараа Биологийн олон янз байдлын тухай конвенцийн 2011-2020 оны Стратеги төлөвлөгөөг мөн баталж, түүнд мөн Айчигийн биологийн олон янз байдлын зорилтуудыг хамруулсан байна. Одоо таван зорилго болон үүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтуудыг холбогдох бодлого, төлөвлөлтийн хэрэгсэлд нэгтгэн оруулах хэрэгтэй байна. Нүүдлийн төрөл зүйлийн 2015-2023 оны Стратегийн төлөвлөгөөний зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих баримт бичгүүдэд бүрэн тусгаагүй байна.

#### *Дэлхийн Соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенци*

Монгол улс Дэлхийн Соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенцид 1990 онд нэгдэн орсон. Одоогийн байдлаар ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисс Гадаад харилцааны яамны харьяанд үйл ажиллагаагаа явуулж байна. Дэлхийн өвийн жагсаалтад таван өмчийг бүртгүүлсэн ба тэдгээрийн гурав нь соёлын ангилалд, хоёр нь байгалийн өвийн ангилалд орж байна. Увс нуурын ай сав газрыг 2003 онд, Дагуурын бүс нутгийг 2017 онд бүртгүүлсэн байна.

#### Увс нуурын ай сав

Увс нуурын ай сав газар нь (1,068,853 га) Төв Азийн бүс нутгийн хамгийн хойд хэсэгт оршдог. Сав газар нь Монгол, Оросын Холбооны улсын Тувагийн бүгд найрамдах улсын газар нутагт оршино. Увс нуурын ай сав газар нь Азийн цээжинд орших үндэстэн дамнасан Дэлхийн өв сан юм. Сав газар нь газар нутгийн хувьд Монголын баруун хойд хэсэг, Оросын холбооны улсын нэг Тувагийн Бүгд найрамдах улсын өмнөд хилийн бүсийн газрыг хамардаг. Энэ газар нь тус газар орших Увс нуураар нэрлэгдэнэ. Увс нуур нь хэмжээний хувьд том, гүехэн, давсархаг нуур бөгөөд нүүдлийн шувууд, усны шувууд болон далай тэнгисийн шувуудын амьдрах чухал газар юм. Үндэстэн дамнасан Дэлхийн өв Увс нуурын савыг аль аль улсад албан ёсны улсын мэдлийн газар гэж хамгаалж байна. Энэ газар нь арван хоёр тусгай хамгаалалттай газрыг хамарсан Евроазийн биомассын гол төлөөлөл юм. Тал газрын экосистем нь янз бүрийн төрлийн шувуудаар баялаг, ховордсон чичүүл, алаг даага, өрнийн эрэн хүрэнний нутаг юм. Уулархаг нутагт нь дэлхийд устах аюулд орсон цоохор ирвэс, аргаль угалз болон Азийн янгир ямааны амьдардаг нэн чухал газар юм.

Уг сав газар нь зөвхөн олон улсын хил дамнасан, экосистемийг хамгаалах хамтын ажиллагааны онцгой жишээ төдийгүй Засгийн газар, шинжлэх ухаан болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны тод жишээ юм. Холбогдох яамны түвшинд болон тусгай хамгаалалттай газруудын захиргааны хооронд байгуулсан хэд хэдэн хоёр талын хэлэлцээрийн дагуу хамтын ажиллагаа хөгжүүлж,

хамтарсан менежментийн төлөвлөгөөтэй ажилладаг байна. Хил хамгааллын ажилтнууд хилийн хоёр талд байнга хамгаалж байдаг. Увс нуурын сав газрыг хамгаалах Монгол-Оросын Холбооны улсын хамтарсан менежментийн төлөвлөгөөг хоёр тал хамтран хэрэгжүүлдэг байна. Увс нуурын сав газрын менежмент болон хамгаалалтыг зохих түвшинд хэрэгжүүлэхэд тохиолдож байгаа саад бэрхшээл, сорилт бол санхүүжилтийн найдвартай, урьдчилан тооцоолж болох эх үүсвэр атал энэ нь хандивлагчдаас хамааралтай байна.

#### Дагуурын байгалийн өв

Дагуурын байгалийг Дэлхийн өвийн жагсаалтад оруулсан нь Монгол болон Оросын Холбооны улсын хамтарсан санаачилгын үр дүн юм. Энэ газар нутаг нь хоёр орны болон Бүгд найрамдах Хятад ард улсын хамтын ажиллагааны олон жилийн түүхтэй холбоотой бөгөөд 1994 онд Хятад-Монгол-Оросын Дагуурын Олон улсын улсын Хамгаалалтын газрыг байгуулсан байна.

Монгол болон Оросын Холбооны улсын дунд орших Дагуурын байгалийн өв нь хил дамнасан Дэлхийн өв сангийн нэг бөгөөд дөрвөн бүрэлдэхүүн хэсэгтэй. Дагуурын тал нутгийн экосистем нь 1 сая хавтгай дөрвөлжин километр талбайг эзлэх ба Монголын зүүн нутгаас Оросын Сибирь тийш үргэлжилж Хятадын Зүүн хойд хэсэгт хүрнэ. Нийт 912,624 га газрыг эзлэж, Дагуурын хойд хэсэгт хэд хэдэн тусгай хамгаалалтын газартай Дагуурын тал хэсгийн эко бүс нь тайгаас говь хүртэл үргэлжилж, янз бүрийн экосистем хамрагддаг байна. Энэ өв санд Дагуурын Улсын Байгалийн шим мандлын нөөц газрын үндэсний хэмжээнд тогтоосон цөм болон завсрын бүс орж байна. Үүнд Жерений холбооны байгалийн хамгаалах газар (Оросын Холбооны улс), түүнчилэн Монгол Дагуурын тусгай хамгаалалттай газрын цөм болон завсрын бүс, бас Угтамын байгалийн хамгаалалтын газар (Монгол улс) хамрагдаж байна. Энэ өвийн дийлэнхи хэсэг нь Дэлхийн өв сангийн завсрын бүсийн 307,317 га газраар хүрээлэгдсэн, Рамсарын газрууд болон ЮНЕСКО-ийн шим мандлын хамагалттай газартай давхцаж байна (Монгол дахь Монгол Дагуур болон Оросын Холбооны улсын Торрэй нуур).

#### Урьдчилсан жагсаалт

ЮНЕСКО-ийн урьдчилсан жагсаалтад оруулахаар Монгол улс 12 өвийг өргөн бариад байгаагийн хоёр нь байгалийн өвийн ангилалд хамаарч байна. Эдгээрт Монголын их говийн говь цөлийн байгаль (2014) ба Монголын говь дахь үлэг гүрвэлийн чулуужсан үлдэгдлийг хадгалах газар (2014) орж байна.

#### Байгаль нуурын өв

Дэлхийн өвийн хорооноос (WHC) Монгол улсын Усан цахилгаан станц, далан барих төлөвлөгөө нь Оросын Холбооны улс дахь Байгаль нуурын өвд нөлөөлж магадгүй тул анхааралтай ажиглаж байна. Дэлхийн өвийн хорооны 2013 онд хуралдсан 37 дугаар чуулганаас Монгол улсын Орхон гол дээр барихаар төлөвлөж байгаа далан нь Байгаль нуурт нөлөөлөх магадлалтай тул сэтгэл ихэд зовниж байгааг цохон тэмдэглээд, оролцогч талууд болох Оросын холбооны улс болон Монголоос “тэрхүү төлөвлөгөөний одоогийн байдал болон магадлал өндөртэй нөлөөллийн эрсдэлийг хэрхэн дүгнэсэн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаар мэдээлэл” өгөхийг хүссэн байна. Байгаль хамгаалах олон улсын холбооны Байгаль орчны үнэлгээний тухай Дэлхийн өвийн Зөвлөх ноот бичгийн дагуу Ертөнцийн гайхамшигт үнэ цэнийг бүрэн үнэлж, тийм газарт хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа тэдгээр төслийн болзошгүй нөлөөллийн иж бүрэн үнэлгээг хийхээс нааш Орхон болон Сэлэнгэ гол дээр далан барихгүй байхыг Монгол улсад хүсэлт болгосон шийдвэрийг Дэлхийн өвийн хорооноос 2014, 2015 болон 2016 онуудад гаргаж, тэдгээр төслүүдийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний хувийг Дэлхийн өвд хүргүүлэхийг тэдгээр шийдвэрт заасан байна.

**Фото зураг 6: Орхоны хөндий**

Монголын хариуцлагатай албан тушаалтнууд дүрэм, журмыг хүндэтгэн, Дэлхийн өвийн хорооны дээрх далантай холбоотой бүх шийдвэрийг дагаж мөрдөх ёстой бөгөөд Монголын Засгийн газар тэдгээр гол дээр нэг далан барихаар шийдвэрлэсэн тухай мэдээлэлийг уг Хороонд ирүүлсэн байна.

Хүн ба шим мандал хөтөлбөр

Монгол улс, ЮНЕСКО хоёрын олон жилийн харилцаа нь ЮНЕСКО-гийн Засгийн газар хоорондын Хүн ба шим мандал (МАВ) хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд болон холбогдох бүсийн сүлжээ болох Зүүн Азийн шим мандлын дархан цаазат газрын сүлжээний хүрээнд хэрэгжүүлж байгаа ажлаас нь харагдаж байна. Монголын үндэсний Хүн ба шим мандал хөтөлбөрийн хороог Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай газрын асуудал хариуцсан газрын дарга тэргүүлдэг байна. Монголд шим мандалын зургаан дархан цаазат газар байна (Хүснэгт 11.4).

УсОлон улсын усыг навигацийн бус зориулалтаар ашиглах тухай конвенц

Монгол улс Олон улсын усан сувгыг навигацийн бус зориулалтаар ашиглах тухай конвенцид нэгдэн ороогүй, гэхдээ уг конвенцид нэгдэн орох асуудлыг судалж байгаа талаар Гадаад харилцааны яам мэдэгдсэн.

Хил дамнасан ус болон олон улсад хамаарах нууруудыг хамгаалах, ашиглах тухай конвенци

Хил дамнасан ус болон олон улсад хамаарах нууруудыг хамгаалах, ашиглах тухай конвенцийн талуудын 2009, 2012, 2015 оны хурлуудад Монгол улс ажиглагчаар оролцсон ба Конвенцийн хүрээнд

зохион байгуулсан бусад олон хурал болон үйл ажиллагаанд нь оролцож иржээ. Дагуурын Олон улсын тусгай хамгаалалттай газар нь ЕЭЗК-ын САВ газрын байгууллагуудын олон улсын сүлжээ (ECE-INBO) болон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох дэлхийн сүлжээний нэг хэсэг юм.

### *Озоны үе давхаргыг хамгаалах*

#### Озоны үе давхрагыг хамгаалах тухай конвенци

Озоны үе давхрагыг хамгаалах тухай конвенци (Венийн конвенци) болон Озон задалдаг бодисын тухай Монреалийн протоколд (Монреалийн протокол) нэгдэн орсон бөгөөд үүнд 1996 оны Лондон, Копенгагийн нэмэлт өөрчлөлтүүд мөн хамрагдана. Монгол улс Монреалийн нэмэлт өөрчлөлт, Бээжингийн нэмэлт өөрчлөлтийг 2002, 2008 онуудад батламжилсан байна. Хамгийн сүүлийн 2016 оны ус-фторт-нүүрстөрөгчийг (HFCs) зохицуулах бодисын жагсаалтад нэмж оруулсан Кигалийн нэмэлт өөрчлөлтийг хараахан батламжлаагүй байгаа боловч түүнийг 2018 онд батламжлах төлөвтэй байна.

Монгол улс 1999 онд Озоны үе давхрагыг хамгаалах тухай Венийн конвенцийг хэрэгжүүлэх үндэсний хороо байгуулжээ (тухайн үеийн Байгаль орчны яамны сайдын 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 53 дугаар тушаал). Уг хороо нь Монреалийн протоколийг хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг зохицуулах үүрэгтэй. Үндэсний хороог яамны байгаль орчны асуудал хариуцсан газрын дарга тэргүүлэх ба бүрэлдэхүүнд нь Гаалийн ерөнхий газар болон холбогдох яамд, ТББ, судалгааны байгууллагуудын төлөөлөл оролцдог байна.

Үндэсний хорооны бүрэлдэхүүнд 2016 онд өөрчлөлт оруулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А-107 тоот тушаалаар баталжээ. Одоо Үндэсний хороо нь холбогдох яамд болон агентлагийн төлөөлөл 20 гишүүнтэй, тухайлбал: Озоны асуудал хариуцсан үндэсний алба, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эрүүл мэндийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрчим хүчний яам, Онцгой байдлын ерөнхий газар, Гадаад харилцааны яам, Үндэсний статистикийн хороо, Стандарт, хэмжил зүйн газар, Гаалийн ерөнхий газар, Мэрэгжлийн хяналтын ерөнхий газар, Хүнс, хөдөө аж ахуй болон хөнгөн үйлдвэрийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Монголын халаалт, агааржуулалт, сэрүүцүүлэг, хөргөгчийн нийгэмлэг болон Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн нийгэмлэг орж байна.

Монголын Үндэсний Озоны алба \УОА\ нь байгаль орчны асуудал хариуцсан яаманд 1996 оны 12 дугаар сард 1996 оны Засгийн газрын 129 дугаар тогтоолоор баталсан “Озоны үе давхрагыг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн дагуу конвенцийн олон талт сангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн бүтэц зохион байгуулалтын чадавхийг бэхжүүлэх төслийн хүрээнд анх байгуулагдсан байна. УОА нь Монреалийн протоколийг хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулахын зэрэгцээ бусад үүрэг хүлээдэг, тухайлбал: i) ОСНБ-н хэрэглээ, импорт, экспортод хяналт тавих, мэдээлэл, ii) олон улсын байгууллага болон бүсийн нэгжүүдтэй үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, iii) ОСНБ-н нөлөөллийн талаархи олон нийтийн ойлголт мэдээллийг сайжруулах санаачилгуудыг хэрэгжүүлэх, iv) ОСНБ болон тоног төхөөрөмжийн жилийн импортын квотын талаар Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд санал хүргүүлнэ. ОСНБ болон тоног төхөөрөмжийн импорт\экспортын тусгай зөвшөөрөлд яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга болон УОА-н дарга нар гарын үсэг зурдаг байна.

УОА нь озоны давхаргад нөлөөлдөг бодис (ОСНБ) ашигладаг төхөөрөмж болон үйлчилгээг нь хариуцдаг хувийн хэвшлийн байгууллагууд, компаниудтай нягт хамтран ажиллаж, Гаалийн ерөнхий газар (ОСНБ болон ОСНБ-уудад суурилсан төхөөрөмжүүдийн импорт ба экспортод хяналт тавих үүрэгтэй), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ) (ОСНБ болон бусад химийн бодисын хэрэглээнд хяналт шалгалт тавих үүрэгтэй), Монгол улсын шинжлэх ухаан, технологийн их сургууль (ОСНБ-тай харилцах техникийн мэрэгжилтнүүдийг бэлтгэдэг), Монголын хөргөгчдийн нийгэмлэг болон HCFC–н менежментийн төлөвлөгөөний дагуу байгуулагдсан “Мастер Чадамж” үндэсний сургалтын төвтэй бас хамтран ажиллаж байна. УОА нь мөн Барилга, хот байгуулалтын яам, Эрчим хүчний яамтай нягт харилцан ажиллаж байна.

Озоны тухай олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу бүтэц зохион байгуулалт үүргийн хувьд, Гаалийн ерөнхий газар нь ОСНБ болон тэдгээр хийг ажилладаг тоног төхөөрөмжүүдийн импорт, экспортод хяналт тавих үүрэг хүлээдэг бол Мэргэжлийн хяналтын газар ОСНБ болон химийн бусад бодисуудын ашиглалтад хяналт шалгалт хийх үүрэг хүлээдэг байна.



Озон задалдаг бодисыг хэрэглээнээс гаргах Менежментийн төлөвлөгөө (ТЗМТ)-ний хэрэгжилтийг хангах чадавхийг бэхжүүлэх үүднээс Төслийн менежментийн албыг (ТМН) ҮОА-г 2011 онд байгуулж, одоогийн байдлаар ҮОА-ны гурван гишүүн дээр хоёр ажилтан нэмэгдэн ажиллаж байна. ҮОА нь жилийн ажлын төлөвлөгөө боловсруулах, ОСНБ-тай холбогдсон зохицуулалтыг мөрдүүлэх, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд мониторинг хийх, хэрэгжилтийн явцын талаар тайлан, илтгэл бэлтгэх зэрэг асуудлаар ТМН-тэй нягт хамтран ажиллаж байна.

Монгол улс урьд нь ОСНБ-г хөргөгч, сэрүүцүүлэгийн төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээнд голлон ашиглаж байв. Хөлдөөгч бодисын менежментийн төлөвлөгөө (RMP) болон ТЗМТ-г ХФК болон бусад ОСНБ-н хэрэглээг зогсоох төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлсэнээс хойш 1998, 2010 онуудад Монгол улс ХФК-ны хэрэглээг Монреалийн протоколийн графикийн дагуу амжилттай зогсоож чадсан байна.

Монгол улс ус-фторт-нүүрстөрөгчийг (НСFC) үйлдвэрлэдэггүй боловч тэдгээрийг импортлон хөөсөнцөр хавтангийн үйлдвэрлэл ба үйлчилгээний салбарт хэрэглэж байна. Монголын ТЗМТ –г Монреалын протоколийг хэрэгжүүлэх Олон талт Сангийн Гүйцэтгэх хороо 2011 онд баталсан байна. Уг төлөвлөгөө нь НСFC-ийн хэрэглээг 2009 болон 2010 оны хэрэглээний суурь түвшин 1.31 тоннтой харьцуулахад 2020 оны 1 дүгээр сарын 1 гэхэд 35 хувиар бууруулахыг зорьж байна. ТЗМТ-г Японы Засгийн газар болон НҮББОХ-ийн 366,000 долларын хөрөнгийн тусламжтайгаар хэрэгжүүлж байна. 2016 онд Гүйцэтгэх хороо уг төлөвлөгөөний эхний шатны гуравдахь хэсгийг баталжээ.

Монгол улс 2001 оноос озоны үе давхрагад сөрөг нөлөө үзүүлэх бодисыг үйл ажиллагаандаа ашиглах лиценци олгох ба импорт, экспортод квот тогтоож ирсэн ба үүнийг НСFC-д мөн мөрдөж болох юм. 2013 оноос, лиценци олгоходоо гол нь НСFC –д мониторинг хийх арга гэж үзэж, импортлогчид хүсэлт гаргасан хэмжээний ОСНБ-д зөвшөөрөл олгодог байсан байна. Хэрэглээний суурь үзүүлэлт (үндэсний хэрэглээний зорилт) –ийг нэвтрүүлсэний дараа 2013 оноос хойш тодорхой квотын түвшинг тогтоож өгсөн байна. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд жил бүр тушаал гаргаж, дараа жилийн ОСНБ-н квотыг тогтоож байна. Засгийн газрын хувьд Гүйцэтгэх хороотой тохиролцсоны дагуу НСFC-н 2017 оны ОСНБ-н импортын квотыг 0.77 тонноор тогтоосон байна. Монгол улс ОСНБ болон НСFC –д суурилсан төхөөрөмжүүдийн импортод хяналт тавьж байна.

Озоны тухай олон улсын хэлэлцээрийг хэрэгжүүлж ирсэн 20 жилийн хугацаанд Монгол улс мэдэгдэхүйц ахиц гаргажээ. Монгол улс 1995 оноос хойш Озоны үе давхрагыг хамгаалах эрх зүйн цогц бүтцийг бий болгожээ, тухайлбал, 1995 оны Агаарын тухай хууль (дараа нь 2012 оны Агаарын тухай шинэ хуулиар сольсон) болон 1995 оны химийн хортой бодисоос хамгаалах тухай хууль (дараа 2006 оны Аюултай болон хортой химийн бодисын тухай хуулиар сольсон)-ийг мөрдөж байна. Эдгээр хуульд ОСНБ-г зохицуулах (НСFC-г оролцуулан) тухай заалтууд орсон байна. Тэдгээр алхамуудын дараа, ОСНБ-н импорт, худалдаа ба хэрэглээний лиценз олгох журмын тухай 1999 оны Засгийн газрын 104 тоот тогтоол гарч, мөн тэр жилдээ “Озоны үе давхрагыг хамгаалах тухай Үндэсний хөтөлбөрийг” Засгийн газрын 129 тоот тогтоолоор батлан гаргажээ. Хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх холбогдох журмуудыг баталж, заримыг нь шинэчилсэн байна. Тэдгээрийн жишээ бол 2013 оноос үйлдвэрлэж байсан НСFC-22-суурилсан XPS хөөсөнцөр хавтанг шинээр үйлдвэрлэхийг хориглосон ба үүнд зарим НСFC, тухайлбал НСFC-141b-ыг 2014 онд шинэчилсэн Аюултай болон хортой химийн бодисыг хориглох буюу хатуу хязгаарлах жагсаалтад нэмж оруулсан явдал юм. Түүнээс гадна, НС-290, НСFC-32, R-152a болон R-477-д суурилсан төхөөрөмжүүдийн хэрэглээг дэмжих үүднээс худалдааны татвараас чөлөөлөх санхүүгийн урамшуулал олгох болсон нь ихээхэн чухал арга хэмжээ болжээ.

Хэдийгээр 2012 онд Агаарын тухай шинэчилсэн хууль болон салбарын яамдын хэмжээнд мөрдөх журмуудыг баталсан, тухайлбал 2001 оны Лиценцийн тухай хуулийг баталж (Аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль гэж бас нэрлэдэг) энэхүү хуулийн дагуу ОСНБ болон түүнд суурилсан төхөөрөмжүүдийн импорт, худалдаа ба хэрэглээг эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд заавал лиценз авах тухай заасан боловч озоны үе давхрагын тухай бие даасан хуулийн хувьд 1999 оноос хойш ямар нэг өөрчлөлт оруулаагүй явж иржээ.

Эрх зүйн хүрээнд ийм дэвшилттэй талууд олон байгаагийн зэрэгцээ Монгол улс Хятадтай ОСНБ-н худалдаанд хил дээр тавих хяналт шалгалтыг зохион байгуулах талаар хүчин чармайлт гаргаж, түүнчилэн лиценз/квотын хуулийн заалтуудыг практик дээр хэрэгжүүлэн мөрдөх, техникийн болон гаалийн ажилтнуудын сургалт, иргэдийн ухамсар ойлголтыг бэхжүүлэх ажил зохион байгуулах, ҮОА болон ТХН-ын үйл ажиллагааг тогтворжуулах зэрэг олон тооны арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. ТЗМТ-ний бэлтгэлийн нэг хэсэг болгон НСFC-ийн судалгааг 2008 оны 12 дугаар сараас 2009 оны 5



дугаар сард HCFC импорт ба хэрэглээ Монголд яг ямар байгаа цогц зургийг гаргах зорилгоор хийснийг цохон тэмдэглүүштэй юм. RMP Refrigerant Management Plan. TPMP Terminal Phase-Out Management Plan.

Энэ бүх үйл ажиллагаа нь Монгол улсад Хөргөгч бодисын менежментийн төлөвлөгөө (RMP), улмаар Терминалыг халах менежментийн төлөвлөгөө (TRMP)-г амжилттай хэрэгжүүлэх, CFC-н хэрэглээг амжилттай хориглоход чухал үүрэг гүйцэтгэжээ. ТЗМТ -ийн хувьд баталсан төлөвлөгөөний дагуу амжилттай хэрэгжиж байна. Засгийн газраас, ОСНБ болох HCFC-ийн хэрэглээ 2015 онд 0.64 тонн байсныг мэдээлсэн нь Монголын суурь үзүүлэлтээс 54 хувь доогуур байгаа юм. Иймд Монгол улс Монреалийн протоколийн төлөвлөсөн зорилт болох HCFC-ийн хэрэглээг 2015 он гэхэд 10 хувь бууруулах зорилтыг биелүүлсэн байна. Түүнчлэн Монгол улс HCFC-ийн импорт/экспортын лиценци, квотын системийг чанд мөрдөж, XPS-д шилжих ажлыг амжилттай гүйцэтгэж, HCFC-ийн хэрэглээг бүрэн хяналтанд авсан байна.

HCFC-ийн хэрэглээг 2020 он гэхэд 35 хувь бууруулах зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол улс ажлын одоогийн энэ эрч далайцыг бууруулахгүй, дэвшүүлсэн зорилтоо бодлого болон төслийн түвшинд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Ойрын ирээдүйд, ногоон худалдан авалт болон ногоон барилга байгууламжийн санаачилга илүү хүчтэй тавигдах төлөвтэй байна. Кигалийн нэмэлт өөрчлөлтийн бэлтгэл ажлын хүрээнд гааль болон техник ажилтнуудын сургалтын асуудалд илүү их хүчин чармайлтыг гаргах шаардлага тавигдах болно.

*Аюултай хог хаягдал ба химийн бодис*

Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай конвенци

Монгол улс Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай конвенцид (Basel конвенци) 1997 онд нэгдэн оржээ.

Аюултай хог хаягдалыг импортлох, дамжуулах болон экспортлохыг хориглох тухай 2000 оны хууль нь Вазелийн конвенцийн суурь заалтуудыг хамруулж, аюултай хог хаягдлын тодорхойлолтод тэсэрч дэлбэрэх, шатамхай шингэн ба хатуу биет, шатамхай болон цацраг идэвхт бодис, мөн хөрс, агаар, усанд нөлөөлөх болон шатах хий үүсгэгч хортой бодисууд, исэлдүүлэгч, идэмхий болон органик хэт ислийн бодисуудыг хамруулсан байна. Хуульд аюултай хаягдалын асуудлаар байгаль орчны байгууллагуудын эрх үүрэг, аюултай хог хаягдлын нарийвчилсан тодорхойлолт зэргийг бүрэн дүүрэн тусгаагүй байна. Монгол улс өөрийн хууль тогтоомж болон журмуудад аюултай хаягдлын тодорхойлолтыг нарийвчилан заагаагүй байна.

Аюултай хаягдлыг импортлох, дамжуулан тээвэрлэх, экспортлохыг хориглох тухай хууль нь тэдгээрийг хэрэглэх, хадгалах, түр хугацаанд байршуулах эсвэл устгахыг мөн хориглодог байна. Хог хаягдлыг дахин ашиглах, эсвэл бүрэн устгах хоёрын хоорондын ялгааг бүрэн тодорхойлоогүй байна. Уг хуульд аюултай хог хаягдлыг экспортлоход аюултай хог хаягдлын асуудлыг хариуцдаг байгаль орчны газраас экспортын лиценз авах шаардлагатайг заажээ.

Монгол улс хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор 2003 онд Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлын тухай хуулийг баталж, дараа нь 2012 онд Хог хаягдлын менежментийн тухай хууль, 2017 онд шинэчилсэн Хог хаягдлын тухай хууль багтагдан гарсан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар нь Базелийн конвенцийн Үндэсний гол хэрэгжүүлэгч байгууллага юм. Уг конвенцтэй холбоотой асуудлыг ганц хүн хариуцаж, аюултай хог хаягдлыг цуглуулах, зайлуулах, тээвэрлэх, дахин боловсруулах болон хадгалах зөвшөөрөл олгодог байна.

Аюултай хог хаягдлын менежментийн асуудал Монгол улсад ихээхэн бэрхшээлтэй асуудал болж байна. Хамгийн гол саад бэрхшээл, сорилт бол хаягдлыг ялгах, зайлуулах болон боловсруулах зохих арга хэрэгсэл байхгүй байгаа явдал юм. Хаягдлыг цэвэршүүлэх байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэлийг 2009 онд боловсруулсан боловч тухайн төслийг одоогоор хэрэгжүүлээгүй байна. Эмнэлгийн хаягдалаас бусад хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй менежмент хийж, зайлуулах нөхцөл Монголд байхгүй байна. Аюултай хог хаягдлын асуудал 2012 оноос хойш улам бүр нэмэгдэж байгаа нь аюултай хог хаягдлын нэлээд хэсгийг Өмнөд Солонгост экспортлохыг зогсоонтой холбоотой. Хятад улс нутаг дэвсгэр дээгүүрээ аюултай хаягдлыг тээвэрлэхийг 2012 онд хориглосон

бол Оросын Холбооны улсын хувьд үүнээс өмнө аюултай хаягдлын транзит тээвэрлэлтийг хориглосон юм. Энэ нөхцөлд Монголын аюултай хаягдлын экспорт бүр зогссон байна.

Монголд аюултай хог хаягдлын үндэсний тооллого явуулахгүй байна. Тооллого хийх туршилтын төслийг 2009 онд хэрэгжүүлсэн боловч түүний мөрөөр цаашид арга хэмжээ авч үргэлжлүүлээгүй зогсоожээ. Базелийн конвенцийн нарийн бичгийн дарга нарын газарт Монгол улс аюултай хог хаягдлын тухай ерөнхий мэдээлэл болон хил дамжуулан тээвэрлэх жилийн тайлан илтгэлийг тогтмол хүргүүлдэггүй байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яам аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх асуудалд хяналт тавьдаг боловч мэдээллийн санд үүнтэй холбогдсон мэдээллийг оруулахгүй байна.

Хог хаягдлын менежмент Монголд ерөнхийдөө эхлэлийн шатанд явж байна. Холбогдох хууль тогтоомжийг батлан гаргасан ч тэдгээрийн хэрэгжилт томоохон саад бэрхшээлтэй тулгарч байгаа бөгөөд хог хаягдлын менежментийн дэд бүтэц сул хөгжсөн, ер нь хаягдлын нөхцөл байдал хүнд байна. Нэгэнт хоёр хөрш орон нь аюултай хог хаягдлыг өөрсдийн нутгаар дамжуулан тээвэрлэхийг хориглосон нөхцөлд Монгол улс аюултай хог хаягдлын асуудлыг өөрөө шийдвэрлэх хэрэгтэй болж байна. Монгол улсын Тогтвортой хөгжлийн алсын хараа 2030-д хог хаягдлын менежментийн чанарыг сайжруулах асуудал тэргүүлэх зорилтуудын нэг болж тавигдсан учир ойрын ирээдүйд тодорхой дэвшил гарна гэсэн хүлээлттэй байна.

Эцэст нь тэмдэглэхэд, Монгол улс хог хаягдлын үр дүнтэй менежмент болон холбогдох дэд бүтцийг бий болгох, хог хаягдалд тавих мониторинг, хяналт шалгалтын тогтолцоо, тайлагнан мэдээлэх тогтолцоог бэхжүүлэх, холбогдох байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх зэрэг шаардлагатай тулгарч байна. Хил дамжуулан тээвэрлэх асуудлаархи Базелийн конвенцийн цахим системийг хөгжүүлэх нь эл асуудлыг хариуцаж байгаа газруудын хүчин чармайлтад ихээхэн дэмжлэг болох талтай юм.

#### Олон улсын худалдаанд зарим химийн аюултай бодис болон пестицидийн талаар урьдчилан мэдээлж, зөвшилцөх зарчмын тухай конвенци

Монгол улс олон улсын худалдаанд зарим тодорхой химийн аюултай бодис болон хортон шавьжны устгалын бодис пестицидийн талаар урьдчилан мэдээлж, зөвшилцөх журмын тухай конвенцийг (Роттердамын Конвенци) 2001 онд батламжилсан байна. БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар нь Үндэсний зохицуулагч байгууллага юм. Химийн бодисын менежментийн Үндэсний Зөвлөл нь үйлдвэрийн химийн бодис болон пестицидийн асуудлыг хариуцах Үндэсний байгууллага юм.

Монгол улс Конвенцийн Хавсралт 3-ийн жагсаалтад орсон 29 химийн бодисыг импортлох асуудлыг үл зөвшилцөх тухай болон Зөвшилцлийн талаар урьдчилан мэдээлэх асуудлыг судлаж үзэх тухай шийдвэрээ Конвенцид хүргүүлсэн байна. Тэдгээр шийдвэрийг 2007 оны Засгийн газрын 95 дугаар тогтоолоор хүчин төгөлдөр болгож, Монголд хориглосон химийн бодисын жагсаалтад өөрчлөлт оруулсан байна.

Монгол улс 2004 оноос хойш, 18 тохиолдлын хэд хэдэн химийн бодисын импортын талаар мэдээлэл хүргүүлээгүй нь Роттердамын конвенцийн 10 дугаар зүйлийг дагаж мөрдөхгүй байгаа хэрэг юм. Энэхүү Зүйлд Талууд конвенцийн Хавсралт 1-ийн жагсаалтад орсон химийн бодисыг импортлохоор гаргасан шийдвэрийн талаар конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт урьдчилан мэдэгдэж байх үүрэг хүлээсэн юм.

#### Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Конвенци

Удаан задардаг органик бохирдуулагчийн (POP) тухай конвенцийг Монгол улс 2004 онд батламжлан, түүнийг хэрэгжүүлэх Үндэсний төлөвлөгөө (ҮХТ)-г 2006 онд баталсан байна. БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар эл асуудлыг хариуцаж байна. Тайлан илтгэл бэлтгэн хүргүүлэх үүргээ Монгол улс биелүүлж байна.

ҮХТ-ний хүрээнд нэлээд ажлыг хийж гүйцэтгэжээ. Тухайлбал, Удаан задардаг органик бохирдуулагчтай холбоотой үйл ажиллагааны хууль тогтоомж болон зохицуулалтын журмууд, сурталчилан таниулах ажлууд болон сургалт зохион байгуулах, лаборатори байгуулах зэрэг ажлыг хийжээ. Удаан задардаг органик бохирдуулагчийн урьдчилсан тооллогыг 2005 болон 2006 онуудад НҮБ-ын ҮХБ болон Даян дэлхийн байгаль хамгаалах сангийн тусламжтайгаар хэрэгжсэн төслийн хүрээнд хийсэн байна.

Тооллогыг POP-д хамаарах хортон шавьжны устгалын бодис, PCBs, давхар исэл/фураны тооцоо, тэдгээрийн болзошгүй эх үүсвэрийг хамруулжээ.

Уг конвенцийн хавсралтад эхлээд 12 төрлийн удаан задардаг органик бохирдуулагчийг оруулсан байдаг. Стокольмийн конвенцийн Талуудын 4 болон 5 дугаар бага хурлаас 9 бодисыг 2009 онд, дахин нэг бодисийг 2011 онд тус тус конвенцийн Хавсралтад нэмж оруулсан. Монгол улс Даян дэлхийн байгаль хамгаалах сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокольмийн конвенцийг хэрэгжүүлэх Үндэсний хэрэгжилтийн төлөвлөгөөг дүгнэх, шинэчлэх” төслийн хүрээнд 2012 онд хортон шавьжны устгалын бодис, үйлдвэрийн химийн бодисууд, фуран болон РСВ-ний үндэсний тооллогыг хийсэн байна. Тооллогын үр дүн, үнэлгээний үндсэн дээр ҮХТ-г шинэчлэн боловсруулж, 2014 оны Засгийн газрын 341 дугаар тогтоолоор баталжээ. Шинэчилсэн ҮХТ-т 5 зорилтыг дэвшүүлж, 11 үйл ажиллагааны дагуу 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр зааснаас 35 хувь нь хаягдлын менежментийг сайжруулах, 19 хувь нь агаар, 10 хувь нь хөрсний бохирдолыг бууруулах заалт байна.

Стокльмийн конвенцийн хавсралтын “эхний удаан задардаг бохирдуулагч бодисийн” жагсаалтын хувьд Стокольмийн конвенцээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн түвшин ямар түвшинд байгааг ҮХТ-аар хянаж байна. Мөн шинээр жагсаалтад нэмж орсон бодисуудын Монгол дахь байдлыг хянаж, Монгол улс тэдгээр шинээр жагсаалтад орсон бодисуудыг нэгдмэл байдлаар хэрхэн шийдвэрлэхээр төлөвлөж байгаа мэдээлэлээр хангаж байдаг. Ерөнхийд нь авч үзвэл, ҮХТ-ийг шинэчлэх болсон зорилго нь удаан задардаг бохирдуулагч бодисийн хор уршгаас байгаль орчин, хүний эрүүл мэндийг хамгаалахад оршиж байна (Бүлэг 10).

Монгол улс олон улсын хамтын нийгэмлэгийн дэмжлэг туслалцааны үр шимийг хүртэж байна, тухайлбал удаан задардаг бохирдуулагч бодисийн чиглэлээр НҮБҮХБ, НҮББОХ болон ДБҮ-тэй хамтран ажиллаж байна. Монгол улс 2014-2015 онд PBDE-ийн менежмент ба бууруулах тухай 2013 онд батлагдсан “Дэд бүсийн үйл ажиллагааны төлөвлөгөөний” (Ази) хэрэгжилтэд оролцож байгаа таван орны нэг нь Монгол улс бөгөөд төслийг НҮББХ, ДБҮ дэмжиж, Ази номхон далайн чадавхи бэхжүүлэх болон технологи шилжүүлэх төв (SCRCAP), Ази номхон далайн бүсийн Базелийн конвенцийн бүсийн төвтэй (БКБТ, Бээжин, Хятад) түншлэн ажиллаж байна. Төсөл нь хог хаягдлын дахин боловсруулах салбарт PBDE-ийн бохирдолын төлөв байдлыг, PBDE-ийн үзүүлэх эрсдлийг бууруулах, бүсийн бохирдолын хяналтын стратегийн санал болон үндэсний бүтцийг Азид бий болгох зорилготой. ҮХТ-ийн үйл ажиллагаа болон арга хэмжээ нь хоёр үе шаттай (Бүлэг 10) хэрэгжих явц үргэлжилж байна.

#### Мөнгөн усны тухай Минаматагийн конвенци

Минаматагийн мөнгөн усны тухай конвенцийг Монгол улс 2015 онд батламжилжээ. БОАЖЯ-ны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар хариуцаж байна.

Монголд 2006 онд химийн бодисын менежментийн хэд хэдэн эрх зүй болон үйл ажиллагааны арга хэмжээг хэрэгжүүлжээ, тухайлбал химийн бодисын менежментэд үндсэн шинэчлэл хийж төвлөрсөн лабораторийг байгуулан, Аюултай хортой химийн бодисын тухай хуулийг баталжээ. Бүрэн хориглосон болон хатуу хязгааралт бүхий бодисын шинэчилсэн жагсаалтад мөнгөн ус болон цианидыг оруулсан байна. Байгаль орчин, эрүүл мэндийн асуудалд хариуцсан яамд, Онцгой байдлын ерөнхий газар (2009 оны хамтарсан 28\40\29 тоот тушаал) Аюултай болон хортой химийн бодисыг хадгалах, тээвэрлэх, устгах журмыг 2009 онд баталж, түүнийг 2012 онд мөн хамтарсан тушаалаар (2012 оны хамтарсан А-50\378\565 тоот тушаал) шинэчилжээ. Хууль бусаар онц хортой мөнгөн усыг уул уурхай олборлолт болон боловсруулах үйл ажиллагаанд ашиглах болсон нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдэх болсоноос Аюултай хортой химийн бодисын бодлогын зохицуулалтын Үндэсний Зөвлөл дээр энэ асуудлаар өргөн хүрээтэй хэлэлцүүлэгийг эхлүүлсэн байна.

Мөнгөн ус, цианит натри Дархан уул аймгийн Хонгор суманд алдагдсан хэрэг 2007 онд гарчээ. Энэ нь химийн менежментийн асуудалтай холбоотой байгуулагуудын үйл ажиллагааны талаарх хандлагыг хэд дахин нэмэгдүүлсэн байна. Хордсон газрыг тогтоох шалгалтын хоёр кампанит ажлыг 2007 болон 2008 онд явуулсан байна. Энэ бүх шалгалтын дүнд, 53 гектар газар, арваад худаг мөнгөн ус, цианидаар бохирдсон нь тогтоогдсон ба мөнгөн ус хэрэглэдэг 145 нунтаглах тээрмийг хаасан байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яам Цагдаагийн ерөнхий газартай хамтран хууль бусаар химийн бодис ашиглаж байгаа болон хадгалж байгаа талаар иргэдээс урамшуулалтай мэдээлэл авах ажлыг зохион байгуулсаны дүнд 17 кг мөнгөн усыг илрүүлэн хураасан байна. Түүнээс гадна, аюултай болон хортой

бодисыг булах, устгах дөрвөн газар байгуулж, 10 аймгийн 38 сумын нутгийн 231 газарт бохирдсон 128,444 хавтгай дөрвөлжин метр талбайг хоргүйжүүлсэн байна.

“Химийн бодисын хатуу менежментийг нэвтрүүлэх замаар хүний эрүүл мэнд болон байгаль мөнгөн усны нөлөөллийг бууруулах” төслийг НҮБ-ын ҮХБ болон ДБҮ-ний дэмжлэгтэйгээр 2013-аас 2015 оны хооронд хэрэгжүүлжээ. Төсөлд БОАЖЯ, Эрүүл мэндийн яам болон хувийн хэвшлийн Миреко компани оролцсон байна. Төслийн зорилго нь мөнгөн ус агуулсан хаягдлын хатуу менежментийн үндэсний хэмжээний удирдамж боловсруулах болон өмнө ажиллаж байсан уурхайгаас улбаатай мөнгөн усаар бохирдсон халуун цэгүүдийг туршилтын шугамаар эрүүлжүүлэх ажлыг гүйцэтгэхэд оршиж байсан байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэдээгээр мөнгөн ус агуулсан халуун цэгүүдийн зураглалыг гаргасан боловч энэ нь олон нийтэд нээлттэй бус байна.

Саяханы тооцоогоор антропоморфеник мөнгөн усны ялгарал Монголд 6,906 кг байгаа ажээ. Даян дэлхийн байгаль хамгаалах сангаас 2017 онд хоёр нэн чухал төслийг баталжээ. Монголд хэрэгжүүлэх Минаматагийн конвенцийн гүнзгийрүүлсэн анхны үнэлгээний төсөл нь бодлого боловсруулах, стратегийн шийдвэр гаргах ажиллагааг дэмжих зорилготой бөгөөд хэрэгжүүлэгч агентлаг нь НҮБ-ын ҮХБ байх юм. Бичил болон жижиг уурхайгаас алт олборлох Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах төсөл нь тэдгээр үйл ажиллагаанаас үүсэж байгаа мөнгөн усны ялгаралын асуудлыг шийдвэрлэх замын зураглалыг гаргахад шийдвэрлэх ач холбогдолтой бөгөөд түүний хэрэгжүүлэгч байгууллага нь НҮБ-ын БОХ байна. Монголд мөнгөн усны ялгаралыг үүсгэж байгаа гол салбарууд нь алтны бичил болон жижиг уурхай, түүнчлэн нүүрс шатаалт, өнгөт металын үйлдвэрлэл юм. Энэ Төлөвлөгөөг боловсруулах гол саад бэрхшээлтэй асуудал нь зорилгодоо хүрэхийн тулд авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон арга хэмжээг сонгон авах явдал байгаа бөгөөд учир нь тэдгээр уурхайн олонхи нь хууль бус шинжтэй байгаатай холбоотой маргаантай асуудлууд гарч байгаа явдал юм.

Минаматагийн конвенцийн хүрээнд үйл ажиллагаа явуулсанаар Монгол улс ойрын ирээдүйд хүлээсэн үүргээ биелүүлж, ахиц дэвшилд хүрэх нь эргэлзээгүй бөгөөд харин даван туулах ёстой нэг асуудал бол мөнгөн усыг цуглуулан авч цэвэршүүлэх байгууламжгүй байгаа явдал юм.

#### Олон улсын химийн бодисын менежментийн талаар баримтлах стратегийн арга зам

Улсын хэмжээний химийн бодисын менежментийн тухай асуудлыг 2008 онд шийдвэрлэж, Олон улсын химийн бодисын менежментийн стратегийн арга замыг (SAICM) Монголд нэвтрүүлэх зарчмуудыг тодорхойлон БОАЖЯ-ны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрыг Үндэсний зохицуулагчаар томилсон байна. НҮБ-ын ҮХБ-ын SAICM-н Яаралтай эхлэлийн хөтөлбөрийн итгэмжлэлийн сангийн санхүүжилтээр Швейцари улсын дэмжлэгтэйгээр “Химийн бодис болон Хаягдлын менежментийн Үндэсний нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд Засаглал, болон иргэний нийгэмийн оролцоо, түншлэлийг бэхжүүлэх” төслийг 2007 онд хэрэгжүүлсэн нь SAICM-г Монголд хэрэгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр болсон байна.

Олон улсын Химийн бодисыг тэмдэгжүүлэх, шошголох болон ангилах асуудлыг жигдрүүлэх дэлхийн системийн (GHS) дагуу Монгол улс 2009 оны үндэсний ангилах болон шошголох стандартыг шинэчилсэн байна. Монгол улс химийн бодисын менежментийн олон улсын хөгжилтэй хөл нийлүүлэхийг зорьж байгаа боловч хууль тогтоомжийг мөрдөн хэрэгжүүлэх, олон нийтийн ойлголт ухамсарыг дээшлүүлэх, химийн бодистой харилцаж байгаа төрийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, лабораторийн тоног төхөөрөмжийн дутагдалтай байдлыг давах туулах, бохирдсон газрыг эрүүлжүүлэх ажлыг улс даяар хэрэгжүүлэхэд саад бэрхшээлтэй тулгарч байна.

Химийн аюултай бодисыг цэвэршүүлэх байгууламж Монгол улсад одоогоор байхгүй байна. Хөдөө аж ахуй болон уул уурхайн салбар дахь химийн бодисын хэрэглээнээс байгаль орчныг хамгаалах бодлого, практик үйл ажиллагааг хараахан боловсруулан гаргаагүй байна.

*Энэ хэсэгт хамааралтай Тогтвортой хөгжлийн зорилт ба зорилго*

ТХЗ-ын Зорилт 11.4-ийн хэрэгжилтийн байдал Монголд ямар байгааг 6.2-д харуулав.





### Шигтгээ 6.2: Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх хөтөлбөрийн Зорилт 11.4

#### **Зорилго 11: Хот, суурин газрын иргэдийн оролцоог хангасан, аюулгүй, эрсдэлгүй, тогтвортой байдлыг хангах**

#### **Зорилт 11.4: Дэлхийн соёл, байгалийн үнэт өвийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах хүчин чармайлтыг бэхжүүлэх**

Монгол улс ЮНЕСКО-гийн соёлын салбарын долоон конвенцийн тавыг нь соёрхон батламжилсан нь олон янзын соёлыг дэлгэрүүлэх, биет болон биет бус өвийг хамгаалан дэлгэрүүлэх, хөдлөх өвийн хориотой наймаатай тэмцэх хүсэл эрмэлзэл дүүрэн байгаагийн нь илэрхийлэл юм. Үүний үндэсний илэрхийлэл болсон соёлын болон байгалийн өв сангийн талаархи иргэдийн мэдлэг мэдээлэл өндөр байна. 2017 онд Дагуурын ТХГ-ыг хоёрдох байгалийн өмчөөр товлон тогтоосон нь чухал амжилт юм.

Монголын Тогтвортой хөгжлийн алсын хараа 2030-д дэвшүүлсэн тэргүүлэх зорилтуудад Монгол улсыг нүүдэлчдийн соёл, аялал жуулчлалын олон улсын маршрут болгох, байгаль болон соёлын өвийн газрууд, үзэсгэлэнгүүдийн дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, Монгол улсын аялал жуулчлалын өвөрмөц дүр төрхийг бий болгох, эко-жуулчлалын бүсүүдийг байгуулах, байгаль орчин болон эрүүл мэндийн шаардлагыг хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, 2030 он гэхэд гадаадаас ирэх жуулчдийн тоог хоёр саяд хүргэх зорилтуудыг дэвшүүлээд байна. Түүнчлэн, Монгол улс өөрийн цогц стратегийн хүрээнд байгалийн онгон төрх, биологийн олон янз байдлыг хадгалах, экосистемийн тогтвортой үйлчилгээг хангах эрмэлзэл төгс байна.

Дэлхийн өвийн жагсаалтад орсон байгаль, соёлын бүх өвийн газрууд байгалийн өвөөр саяхан тогтоогоод байгаа Дагуурын газраас бусад бүх газрууд менежментийн төлөвлөгөөтэй, тэдгээрийг хэрэгжүүлэх ажил хийгдэж байна. Дэвшүүлсэн энэ зорилтыг хэрэгжүүлэх байгуулагууд нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам болон Байгаль орчин, аялал жуулчлалын яам юм.

Монголын хувьд тулгарч байгаа гол саад бэрхшээл нь эдийн засгийн өсөлт болон соёл, байгалийн өвийг хамгаалах асуудлын тэнцвэрийг хангах явдал болж байна. Соёлын өвийг үр дүнтэй хайрлан хамгаалахын тулд соёлын өвтэй холбогдон гарч байгаа хулгай, хулгайгаар хил давуулах, дээрэмдэх, урлагын зүйлийг хууль бусаар наймаалцах зэрэг өсөн нэмэгдэж байгаа гэмт хэргийн шинжтэй үзэгдэлтэй тэмцэж, дотоодын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлыг дунд хугацааны төлөвтэй уялдуулах шаардлагатай байна.

Холбогдох яамд ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисстой хамтран дээр дурдсан гэмт хэрэгтэй тэмцэх төлөвлөгөөг боловсруулан баталж, тэдгээр өв бүхий газруудын менежментийг зохих түвшинд хангахад чиглэсэн дөрвөн жилийн төсвийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх асуудлыг авч үзэхийг зөвлөж байна.

### **6.3 Байгаль орчин, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн талаарх хоёр талын хамтын ажиллагаа**

2011 оны шинэчилсэн Гадаад бодлогын үзэл баримтлалд (2011оны УИХ-ын 10 дугаар тогтоол 10) хоёр талын хамтын ажиллагааны цогц зарчмуудыг тодорхойлж өгчээ. Монгол улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл нь Оросын Холбооны улс болон Бүгд Найрамдах Хятад ард улстай найрсаг харилцаатай байх юм. Хоёрдугаарт, Өрнө, Дорнын хөгжингүй орнуудтай, тухайлбал АНУ, Япон, Герман зэрэг оронтой ойр доно харилцаа хөгжүүлэх явдал юм. Үүний зэрэгцээ, Монгол улс Энэтхэг, Бүгд Найрамдах Солонгос, Тайланд, Сингапур, Турк, Дани, Недерланд, Финланд, Австри, Швед, Швейцарь зэрэг орнуудтай найрсаг харилцаа хөгжүүлэхийг эрмэлзэж, тэдгээр улсуудтай тогтоосон эдийн засаг болон бусад харилцаа хамтын ажиллагааны түвшинг дээшлүүлэхийн төлөө ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам 2016 оны байдлаар 170 гаруй хоёр талын хэлэлцээр, санамж бичиг, хамтарсан хөтөлбөр болон санаачилгыг 30 гаруй оронтой байгуулсаны 20 нь засгийн газар хоорондын баримт бичиг байна. Хамтын ажиллагаанд голлон анхаарч ирсэн асуудлуудад байгаль хамгаалал, ус, ойн салбарууд байна. Монгол улсын хамгийн идэвхитэй хоёр талын хамтын ажиллагаа хөгжүүлж байгаа орнуудад Бүгд Найрамдах Солонгос улс (34 хамтарсан төсөл), Оросын Холбооны улс (28 хамтарсан төсөл), Япон, Бүгд Найрамдах Хятад Ард улс, Герман, Голланд, Арабын Нэгдсэн Эмират улс орж байна.

#### *Оросын Холбооны улстай тогтоосон хоёр талын хамтын ажиллагаа*

Монгол, Оросын Холбооны Улсын хооронд Байгаль орчин, хил дамнасан ус, ойн түймрээс хамгаалах зэрэг асуудлаар 3 хоёр-талын баримт бичигт гарын үсэг зурсан байна.



### Байгаль хамгаалал

Анхны хэлэлцээрт 1994 онд гарын үсэг зурсан бөгөөд уг хэлэлцээр нь байгаль орчны өргөн хүрээтэй асуудлыг хамарсан, тухайлбал, хил дамнасан агаарын бохирдол, хил дамнасан гол мөрөн, ашигт малтмалын нөөц, эрчим хүч ба газрын доорхи ус, хөрс болон газрын нөөц баялаг, цөлжилт, зэрлэг амьтан ба ургамал, тусгай хамгаалалттай газар, мониторинг ба үнэлгээ; уур амьсгалын өөрчлөлт ба озоны үе давхрага; цацраг туяа; байгаль орчинд ээлтэй технологи; байгаль орчны боловсрол ба ажилтнуудын сургалт зэрэг асуудлыг хамарч байна.

Байгаль хамгаалах Монгол-Оросын хамтарсан комиссыг 1994 оны хэлэлцээрийн дагуу байгуулж, 2017 оны дунд үе гэхэд нийт 6 удаа хуралдсан байна. Хамтарсан Комисс байгуулсан нь хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэх чухал платформ болж, тухайлбал Комиссын үйл ажиллагааны хүрээнд хил дамнасан хамгаалалттай газруудын асуудалд тэргүүлэх ач холбогдол өгч уг асуудлыг хэлэлцэж ирсэн байна.

Комиссын хурлуудаар хэлэлцэж нэгдсэн зөвшилцөлд хүрсэн асуудлуудын нэг бол Истоки Амурын газрыг хил дамнасан хамгаалалттай газруудын нэг гэж тогтоосон явдал юм. Түүнчилэн, хил дамжин амьдарч байгаа устах аюултай болон ховордож байгаа зэрлэг амьтдыг хамгаалах зорилгоор уг Комиссоос хамтарсан ажлын хэсгийг Монгол, Оросын хил дамнан амьдардаг аргалыг хамгаалах төлөвлөгөө боловсруулах зорилгоор байгуулсан байна. Комисс засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулж, хил дамнасан тусгай хамгаалалттай газрыг Хөвсгөл-Түнхэн ба Сиилхэмийн бүс нутгийг хамруулан байгуулах шийдвэр гаргажээ. Мөн хил дамнан амьдардаг нүүдлийн зэрлэг амьтад, ялангуяа аргал болон цоохор ирвэст мониторинг хяналт шалгалт хийж байх асуудлаар хоёр талын судлаачид, мэргэжилтнүүдийн семинар зохион байгуулахаар шийдвэрлэсэн байна.

### Хил дамнасан ус

Монгол, Оросын Засгийн газрууд хил дамнасан усны нөөцийг эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр хамтран хамгаалах, ашиглах талаар 1995 онд тохиролцсон байна. Хоёр талын хамтын ажиллагааг дараах салбаруудад хөгжүүлэхээр тохиролцжээ: i) хил дамнасан усны нөөцийг оновчтой ашиглах, хамгаалах, бохирдохын эсрэг тэмцэх, усны нөөцийн үр өгөөжтэй менежмент нэвтрүүлэх, ii) ус, гидрохими, гидробиологи, усны суваг, усны нөөц болон чанарын судалгаа хийх, iii) үер зэрэг сөрөг үр дагавраас сэргийлэх үүднээс гидрологийн мэдээлэл болон цаг агаарын урьдчилсан мэдээллийг харилцан солилцох, iv) хил дамнасан усны төлөв байдлын талаар судалгаа, үнэлгээ хийх, v) хил дамнасан усыг бохирдолоос хамгаалах, тэдгээрийн чанарт шалгалт хийх; хил дамнасан усны загас, болон бусад усны амьтдын чөлөөтэй нүүдэл хөдөлгөөнийг хангах зэрэг болно.

Хил дамнасан усны тухай хэлэлцээрийн хүрээнд Талууд хэд хэдэн хамтарсан үүрэг, тухайлбал: хил дамнасан усыг хамгаалах, ашиглах “сав газрын нэгдсэн үзэл баримтлал” боловсруулах, хил дамнасан усны нөхцөл байдалд хяналт тавих хөтөлбөр хэрэгжүүлэх, хил дамнасан зарим усны нөөцийн хоёр талын хуваарилалтын хэмжээг тогтоох ба усны менежмент, хамгаалалтын талаар авч байгаа арга хэмжээний тухай мэдээллийг харилцан солилцох зэрэг хүлээсэн байна.

Хэлэлцээрийн нэг хэсэг болох бүтэц зохион байгуулалтын механизм болох “Бүрэн эрхт институт” байгуулсан ба институтын хурлыг жил бүр зохион байгуулж (тогтмол бус хийгдэхгүй байгаа) хоёр талын төлөөлөгчид хуваан ашиглаж байгаа усны нөөцийн нөхцөл байдлын талаар хэлэлцэх үүрэгтэй ажээ. Гэхдээ энэхүү бүрэн эрхт механизмын ажлын хамрах хүрээ хязгаарлагдмал, тухайлбал хүлээх үүрэг болон хариуцлагыг хэт ерөнхий тодорхойлсон, шийдвэр гаргах эсвэл бодлого боловсруулан гаргах эрхгүй байна. Хил дамнасан институцийн механизмыг өргөжүүлэх үүднээс 1995 оны хэлэлцээрт зохих өөрчлөлт оруулах, орчин үед тавигдаж байгаа зорилго, зорилтуудтай уялдуулан шинэчлэх шаардлагатай байна, тухайлбал: байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хил дамнасан усны асуудалтай уялдуулан хийх, хил дамнасан усанд ямар нэг байдлаар нөлөөлж болзошгүй, хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа үйл ажиллагааны талаар харилцан мэдээлэл солилцох, бие биедээ мэдээлж байх, мэдээллийн хүртээмж, болон шийдвэр гаргах, аливаа маргааныг шийдвэрлэн зохицуулах механизмын ажиллагаанд иргэдийн оролцоог хангах шаардлагатай байна.

НУБ-ын ХХ-ДБХС-ийн “Байгаль нуурын сав газрын хил дамнасан экосистемийн байгалийн нөөц баялагийн менежмент” нэртэй төслийг Оросын холбооны улсын Байгалийн нөөц баялаг ба Байгаль орчны яам, Монголын Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран 2011-2015 онд хэрэгжүүлсэн

байна. Төслийн зорилго нь Байгаль болон Хөвсгөл нуурын сав газрын нөөцийн нэгдсэн удирдлагын менежментийг тогтоох, эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулан экосистемийн тэнцвэр, усны чанар доройтох аюулаас сэргийлэхэд оршиж байжээ. Төслийн дүгнэлтэд 1995 оны хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэх нь зүйтэй гэдгийг тэмдэглэж, хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг болох олон улсын өнөөгийн норм, стандартад тулгуурласан хил дамнасан байгалийн нөөц баялагын хамтарсан менежментийн механизмыг байгуулах асуудлыг тусгасан байна. Гэвч, 1995 оны хэлэлцээрийг шинэчлэх асуудал одоогоор хэрэгжээгүй байна.

### Ойн түймэр

Хил дамнасан ойн түймэрээс хамгаалах асуудал Монгол, Орос улсын хооронд 2014 онд гарын үсэг зурсан гуравдахь хэлэлцээрээр зохицуулагдаж байна. Хэлэлцээрийн зорилго нь хил орчмын газруудад ойн болон тал хээрийн түймрээс сэргийлэх, гарсан түймрийг унтраах ажлыг сайжруулах, түймрийн хор хөнөөлийг бууруулах, харилцан бие биедээ туслах, ойн болон талын түймэр унтраах туршлагаа харилцан солилцоход оршиж байна.

Монгол болон Оросын холбооны улс ой болон тал хээрийн түймрээс хамгаалах хамтын бүсийг хоёр талын хилийн заагаас аль аль талдаа 10 км зурвасыг хамруулан тогтоосон байна.

Ойн салбарын хамтын ажиллагааны хувьд Монгол-Оросын Байгаль хамгаалах хамтарсан комиссын хүрээнд хэлэлцүүлэн, холбогдох шийдвэр гаргаж байна. Мэдээлэл солилцох схем ажиллаж, хил дамнасан ойн түмэр гарсан нөхцөлд түймэртэй тэмцэх онцгой байдлын ажиллагсад хоёр талын хилээр чөлөөтэй нэвтрэх асуудлаар зөвшилцөлд хүрчээ.

### *Бүгд Найрамдах Хятад ард улстай тогтоосон хоёр талын хамтын ажиллагаа*

Хоёр орны хамтын ажиллагаа албан ёсоор 1989 оноос хойш хөгжиж, хил дамнасан гол мөрөн, нууруудад тогтмол хяналт тавих, шар шороон шуурга болон цөлжилттэй тэмцэх, хил дамнасан зэрлэг амьтдыг хамгаалах, байгаль орчны боловсрол мэдлэгийг хөхиүлэн дэмжих, байгаль орчны асуудлаархи олон нийтийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, байгаль орчны менежментийн чадавхийг бэхжүүлэх асуудалд гол анхаарал хандуулж байна.

Хоёр орны хооронд 1989-2016 онд хэд хэдэн хэлэлцээр, протокол, гэрээ хэлцэл байгуулан гаррын үсэг зурсан ба тэдгээр нь байгаль орчныг хамгаалах ерөнхий асуудал, ой болон өвс бэлчээрийг түймэрээс хамгаалах, усны хамгаалалт ба ашиглалтын асуудлыг тусгасан байна.

Хоёр талын хамтын ажиллагааны гол асуудал нь хил дамнасан устай холбогдсон асуудал байна. Хил дамнасан усны хамгаалалт ба ашиглалтын тухай Засгийн газар хоорондын 1994 оны хэлэлцээрийн хүрээнд холбогдох Хамтарсан комиссын хурал 1998 онд хуралдаж, тодорхой ажлуудыг тусгасан замын зураглалыг баталжээ.

Хамтарсан комиссын ажлын хүрээнд, мэргэжилтнүүдийн баг хэд хэдэн салбарт ихээхэн ажил хийсэн байна, тухайлбал: хил дамнасан усны судалгаа; усны чанарт хяналт тавих, мэдээлэл солилцох; усны чанарын стандарт, үзүүлэлтүүд ба аналитик аргачилал; үерээс сэрэмжлэх, гамшгийг бууруулах ба онцгой нөхцөлд хамтран ажиллах; усны нөөцийн оновчтой хэрэглээ, хамгаалалт; онцгой нөхцөлд хамтран авах арга хэмжээг тодруулан тодорхойлох, усны нөөцийг хамгаалах болон тогтвортой ашиглалт; хил дамнасан усыг бохирдуулж болох эх үүсвэрүүдийг тодорхойлох; урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг судлах; сөрөг үр дагаврыг бууруулах арга хэмжээнүүдийг төлөвлөх, хил орчмын усны асуудлаархи харилцааг өргөжүүлэх асуудлууд орж байна. 2014 оны Санамж бичгийн хүрээнд Буйр нуур болон эргэн тойрны орчинд хамтарсан топограф ба хэмжилтийг тогтоох талаар хоёр тал үүрэг хүлээсэн байна.

### хоёр талын хамтын ажиллагаа

“Гуравдахь хөрш”-ийн орнуудтай хамтын ажиллагааг сүүлийн 20 жилд амжилттай хэрэгжүүлж байна. Ногоон хөгжлийн асуудлаар Япон болон Бүгд найрамдах Солонгос улстай түлхүү хамтран ажиллаж байна.

Японтой хөгжүүлж байгаа хамтын ажиллагаа нь хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах, байгальд

ээлтэй технологийг нэвтрүүлэх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн хэрэглээг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сааруулах болон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах зэрэг асуудлаар томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд төвлөрч байна. Хоёр орон мөн шар шороон шуургатай тэмцэх, хүлэмжийн хийг бууруулах арга хэмжээний үр дүнг хэмжих, тайлагнах чадавхийг бэхжүүлэх, ногоон хөгжлийн төлөвлөлтийн асуудлаар мөн хамтран ажиллаж байна.

Монгол болон Бүгд найрамдах Солонгос улсын хамтын ажиллагааны нэг гол салбар нь ногоон хөгжлийн асуудал бөгөөд ялангуяа 2010 оноос хойш Ногоон өсөлтийн Солонгосын түншлэлийн хүрээнд идэвхитэй хөгжиж байна, тухайлбал: шинэ болон эрчим хүчний хэмнэлттэй технологи болон ногоон ажлын байртай холбогдол бүхий асуудлууд орж байна. Хоёр орны хамтын ажиллагаа мөн цөлжилт болон шар шороон шуургатай тэмцэх, хот суурин газруудад ус болон ариун цэврийн байгууламжуудыг барих, тусгай хамгаалалттай газруудын менежмент, чадавхийг бэхжүүлэх, мөнгөн усны бохирдолын үр дагаварыг арилгах, уул уурхайн нөхөн сэргээлтийн тухай зэрэг асуудлуудаар мөн хамтран ажиллаж байна.

Европын холбоо (ЕХ)-Монголын хамтын ажиллагааны хэлэлцээрт 1996 онд гарын үсэг зурсанаар Монгол болон Европын холбооны хамтын ажиллагаа ихээхэн дэвшилд хүрч, Монголын гадаад бодлогод чухал байр эзлэх “туравдахь хөршийн” нэг нь болсон. Түншлэл ба Хамтын ажиллагааны хэлэлцээрт 2013 онд гарын үсэг зурсанаар ЕХ-Монголын харилцааг өргөжүүлэх эрх зүйн үндэс тавигджээ. Энэхүү хэлэлцээр нь улс төрийн яриа, худалдаа, хөгжлийн тусламж, хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил, эрчим хүч, уур амьсгалын өөрчлөлт, судалгаа болон инноваци, боловсрол, соёлын салбарын хамтын ажиллагааны асуудлыг хамарч байгаа юм.

ЕХ-ны гишүүн улс орнууд болон бусад орнууд байгаль орчинтой холбоо бүхий төслүүдийг хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд дэмжиж иржээ (Шигтгээ 6.3).

**Шигтгээ 6.3: Эрчим хүчний хэмнэлт болон цэвэр усны бүх нийтийн хүртээмжийн асуудлаарх хоёр талын хамтын ажиллагааны жишээ**

Монгол улсын нүүрсээр галладаг цахилгаан станцууд, ялангуяа өвлийн улиралд агаарын бохирдолын ноцтой эх үүсвэр болж байна. Германы санхүүжилтэй “цахилгаан түгээлтийн сүлжээнд суурилсан эрчим хүчний хангамжийн үрдүнтэй схем” төслийг (3.9 сая евро) Монголын хэмнэлттэй эрчим хүчний стартеги боловсруулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор хэрэгжүүлж, цахилгаан түгээлтийн бүх сүлжээнд дүн шинжилгээ хийж, эрчим хүчийг хэмнэх хөшүүрэг болох цахилгааны зохистой тариф тогтоох талаар зөвлөх зорилго агуулсан байна. Швейцарын санхүүгийн нэмэлт дэмжлэгтэйгээр (3.8 сая евро), эрчим хүчний менежерүүд болон аудиторруудад сургалт зохион байгуулжээ. Энэ хамтын ажиллагаа нь сонгон авсан барилгуудын эрчим хүчийг хэмнэх асуудалд анхаарал төвлөрүүлсэн байна. Байгаль орчинд илүү ээлтэй, тасралтгүй, аюулгүй цахилгаан болон дулаанаар хангахын тулд Албан ёсны Хөгжлийн Тусламжийн (ODA) зээлээр Дарханы цахилгаан станц (10.5 сая евро) болон Улаанбаатарын 4 дүгээр цахилгаан станцын (8.5 сая евро) шинэчлэлийг хийжээ.

Чех улсын санхүүжилтээр Хөвсгөл аймгийн Мөрөн хотын усан хангамжийн системийг сайжруулах төслийг хэрэгжүүлжээ. Үүний зорилго нь аюулгүйн стандартыг сайжруулах, өсөн нэмэгдэж байгаа хүн амын хэрэгцээг хангаж чадах дэд бүтцийг байгуулахад оршиж байсан. Төслийн хүрээнд усан хангамжийн сүлжээнд засвар үйлчилгээ хийх, автомат ус шахуургыг байршуулах, ус түгээлт болон бохир усны байгууламжид хяналт тавих асуудлууд хамрагджээ. Усны шинэ эх үүсвэрийн хайгуул мөн хийгдсэн байна. Чехийн Засгийн газрын 845,000 еврогийн тусламжтай энэхүү санаачилга нь Монгол улсын үндэсний хөгжлийн зорилттой нийцэж байна. Монгол улс одоо 2030 он гэхэд Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 90 хувьд хүргэж, хүн амын 60 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох зорилт дэвшүүлээд байна.

*Энэ хэсэгт холбогдол бүхий Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтууд*

ТХЗ-ын Зорилт 6.5-ийн талаар Монголын улсын төлөв байдлыг Шигтгээ 6.4-д харуулав.



#### Шигтгээ 6.4: Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх хөтөлбөрийн Зорилт 6.5

##### Зорилго 6: Баталгаат үндны ус, ариун цэврийн байгууламжаар бүх нийтийг хангах Зорилт 6.5: 2030 оны үе гэхэд усны нөөцийн нэгдсэн менежментийг бүх түвшинд хэрэгжүүлэх, шаардлагатай хил дамнасан хамтын ажиллагааг хөгжүүлэх

Зорилт 6.5 нь хил дамнасан усны салбарын хамтын ажиллагаа болон бусад асуудлуудад анхаарал хандуулсан. Энэхүү зорилтын дэлхий нийтийн хоёр шалгуур үзүүлэлтийн нэг нь үйл ажиллагааны менежмент бүхий хил дамнасан усны сав газрын эзлэх хувь хэмжээ (6.5.2) юм. Монгол улс 2017 оны сүүлийн байдлаар энэ 6.5.2 шалгуур үзүүлэлтийн талаарх илтгэлээ НҮБ-ын Эдийн засгийн Европын комисс болон ЮНЕСКО-д гаргаж өгөөгүй байна.

Монгол улс хоёр хөрш улс Оросын Холбооны улс ба Бүгд Найрамдах Хятад ард улстай хил дамнасан усны асуудлаар хэлэлцээр байгуулж гарын үсэг зурсан байна. Оросын холбооны улстай байгуулсан 1995 оны хэлэлцээр нь хоёр улсын хил дамнасан гол мөрөн, горхи, нуур болон бусад гадаргын ус, түүнчилэн гүний усны асуудлыг хамарчээ. БНХАУ-тай 1994 онд байгуулсан хэлэлцээр нь Халх гол, Хэрлэн гол, Буйр нуур болон Булган гол, түүнчилэн хилийн зааг дээрхи гол, горхины асуудлыг хамруулсан боловч гүний усны асуудлаар огт дурсаагүй байна.

Монгол улсын хил дээр, Оростой хил дамнасан 212 гол, 10 нуур; Монгол Хятадын хооронд 37 гол, 12 нуур байдаг байна.

Хүчин төгөлдөр байгаа одоогийн хэлэлцээрүүдэд усны чанар, байгаль орчныг хамгаалах, эрүүл мэндийн асуудалд хандуулсан анхаарал нь харилцан адилгүй янз бүрийн түвшинд байна. Оросын холбооны улстай байгуулсан хэлэлцээрт хил дамнасан усны менежментийн асуудлаар илүү тодорхой арга хэмжээнүүдийг тусгасанаар хил дамнасан усыг бохирдолоос хамгаалах, зохистой хэрэглээг нэвтрүүлэх асуудлаар хоёр орны хамтын ажиллагааг тодорхойлсон бол Хятад улстай байгуулсан хэлэлцээр нь судалгаа, хяналтын асуудалд илүү анхаарал хандуулсан байна.

Эдгээр хүчин төгөлдөр хэлэлцээрүүдийг хэрэгжүүлсэнээр аль аль тал нь үр шимийг нь хүртэх учраас тэдгээр хэлэлцээрүүдийг боловсронгуй болгон сайжруулах замаар Монгол, түүний хоёр хөрш хил дамнасан усны асуудлаар илүү эрчимтэй хамтын ажиллагаа хөгжүүлэх боломж байгаа тул тэдгээр хэлэлцээрүүдийг эргэн хянаж, жишээ нь усны урсацын горимын шалгуурыг тодорхойлох, харилцан, зөвлөлдөх ажлыг сайжруулах, Усны нэгдсэн менежментийн үндсэн зармуудыг хэлэлцээрт тусган оруулж болох юм.

Усны нэгдсэн менежмент болон хил дамнасан усны хамтын ажиллагааг бэхжүүлэх үүднээс Хил дамнасан усны урсац болон олон улсын Нууруудыг хамгаалах, ашиглах тухай Конвенци, мөн Олон улсын усыг навигацын бус зориулалтаар ашиглах хуулийн тухай Конвенцид нэгдэн орох асуудлыг Монгол улс авч үзэж болох юм.

#### **6.4 Байгаль орчин, тогтвортой хөгжил болон ногоон эдийн засгийн үйл ажиллагаатай холбоо бүхий заавал дагаж мөрдөх шаардлагагүй үйл ажиллагааны оролцоо**

*НҮБ-ын Ази, Номхон далайн Эдийн засаг, нийгмийн комисс (ESCAP)*

НҮБ-ын Ази, номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (АНДЭНК)-ын үйл ажиллагаанд Монгол улс байнга идэвхитэй оролцон ажиллаж иржээ.

Монгол улс нь АНДЭНК-ын Зүүн Хойд Азийн бүсийн салбарын Зүүн хойд Азийн байгаль орчны хамтын ажиллагааны хөтөлбөрийн (NEASPEC) идэвхитэй гишүүн юм. Энэхүү Хөтөлбөрийн хүрээнд, ялангуяа “Байгаль орчны тогтвортой байдлыг бэхжүүлэх” хөтөлбөрийн дагуу хөтөлбөрийн таван салбарын, тухайлбал хил дамнасан агаарын бохирдол, байгаль хамгаалал, тэнгис далайн хамгаалалтай газрууд, нүүрсхүчлийн ялгарал багатай хотууд, цөлжилт ба газрын доройтол зэрэг асуудлуудын үйл ажиллагааны хэрэгжилтэд Монгол улс идэвхитэй оролцож, өөрийн хувь нэмрээ оруулж байна.

Монгол улс нэлээд олон салбарт, тухайлбал Монгол улсын хотуудын ногоон үйлдвэрлэлийн эрчим хүч-усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх, Байгаль орчин-Эдийн засгийн нягтлан бодох бүртгэлийн системийг нэвтрүүлэх, баялагийн нэгдсэн менежментийг хотуудад хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг үндэсний болон орон нутгийн түвшинд зонхилох чиг хандлага болгох асуудлаар АНДЭНК-н дэмжлэг тусламжийг авсан юм.

Монголын Тогтвортой байдлын төлөв (ТБТ - SOM) судалгааг АНДЭНК-оос 2017 оны байдлаар Монголд явуулжээ. Монгол нь ТБТ-г хэрэгжүүлсэн анхны орон юм. ТБТ нь АНДЭНК-оос гишүүн орнуудынхаа хувьд Тогтвортой хөгжлийн зорилгууд 2030 – г нэгдмэл хүчин чармайлтаар хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа юм. ТБТ нь Монголын 2017 оны байдлыг ТХЗ-уудын бүх үзүүлэлтэд суурь үзүүлэлт болгон авсан байна. Тухайлбал ТХЗ-уудын хэрэгжилтийн явц болон салбарын тэргүүлэх зорилтууд, олон улсын гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргийн хэрэгжилт зэргийг хамруулж байна. Мөн байгаль орчин, нийгэм, эдийн засгийн ТХЗ-тай холбогдох асуудлуудаар үндэсний алсын харааг салбар бүрээр, үндэсний болон орон нутгийн түвшингийн бодлогын нэгдмэл байдал, байгалийн нөөц баялагын үнэлгээ, нийгэм эдийн засгийн хөгжлийн тодорхой салбаруудын чадавхи зэргээр зураглал гаргах юм. ТБТ болон Байгаль орчны үйл ажиллагааны тайлан илтгэлийг ТХЗ-уудыг хэрэгжүүлэхэд нь Монгол улсад үндсэн чиглэл, баримжаа болох “Монгол улсын олон улсын хэмжээнд тохиролцон хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх арга зам” сэдэвт баримт бичиг боловсруулахад ашиглахаар төлөвлөсөн байна.

*Тогтвортой хэрэглээ ба бүтээгдэхүүний тухай хөтөлбөрийн үйлдвэрлэлийн арван жилийн чиглэл*

Хэдийгээр Монгол улс 2016-2030 онуудад хэрэгжүүлэх ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө Тогтвортой хэрэглээ ба бүтээгдэхүүний асуудлыг өөрийн тэргүүлэх зэргийн стратегийн зорилт гэж тодорхойлсон боловч тогтвортой хэрэглээ болон бүтээгдэхүүний хөтөлбөрийн арван жилийн зарчмыг хариуцах үндэсний зохицуулагчийг одоогоор товлон томилоогүй байна. Төлөвлөгөө нь “ашигт малтмалын салбарт нөөцийг үр өгөөжтэй ашиглах, хаягдал багатай технологи нэвтрүүлэхийг хөхиүлэн дэмжих” замаар Монгол улсыг нөөц баялагийн үр өгөөжтэй ашиглалтын түвшингээр бүсийн түвшинд хүргэх зорилготой юм.

Европын Холбооны санхүүжилт бүхий SWITCH-Ази хөтөлбөрөөр дамжуулан НҮБ-ын БОХ нь Монгол улсад нөөц баялагийн үр өгөөжтэй, хариуцлагатай тогтвортой хэрэглээ, бүтээгдэхүүнийг өөрийн эдийн засгийн хөгжлийн зорилтод нийцүүлэн, нөөц баялагын үр өгөөжтэй, тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн бодлого болон тавих хяналтын чадавхийг бэхжүүлэхийг дэмжиж байгаа юм.

*Ногоон эдийн засгийн үйл ажиллагааны түншлэл (НЭЗҮАТ - ПАЖЭ)*

Монгол улс 2013 онд НЭЗҮАТ -д нэгдэн орсон анхны улс бөгөөд ногоон эдийн засгийн бодлогыг амжилттай хэрэгжүүлэхийг зорьж байгаа ажээ. Монгол улсын хөгжлийн үндэс суурь ногоон хөгжил байх зорилго бүхий Монгол улсын Ногоон хөгжлийн бодлогыг 2014 оны 6 дугаар сард баталсан байна. Ногоон хөгжлийн бодлогод 2030 он хүртэлх зорилго, зорилтуудыг тодорхойлон, дэвшүүлсэн зорилгуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлжээ (Бүлэг 1).

НЭЗҮАТ нь Монгол улс ногоон эдийн засгийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлсэн байна. Ногоон эдийн засгийн анхны тайлан илтгэлийг орон нутгийн, үндэсний болон олон улсын гол түншүүдтэй зөвлөлдөн боловсруулж, 2014 онд хэвлэн гаргасан нь Монгол улсын ногоон хөгжлийн цаашдын ажилд чухал хувь нэмэр болсон байна. НЭЗҮАТ-ийн эхний шатны хүрээнд ногоон ажлын байрны зураглалыг 2013 оны эцсээр гаргажээ.

*Энэ хэсэгт холбогдол бүхий Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтууд*

ТХЗ-ын Зорилт 12.1-ийн хэрэгжилтийн явц Монгол улсад ямар байгааг Шигтгээ 6.5-д үзүүлэв.





### Шигтгээ 6.5: Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх хөтөлбөрийн Зорилт 12.1

Зорилго 12: Хариуцлагатай хэрэглээг дэмжих

Зорилт 12.1 Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэлийн хэв маягийн 10 жилийн үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх, бүх улс орон хөгжингүй орнууд тэргүүлэн, хөгжиж байгаа орнуудын хөгжил болон чадавхийг анхааралдаа авч арга хэмжээ авах,

Зорилт 12.1-тэй хамгийн их хамаарал бүхий асуудлуудыг 2014 оны Ногоон хөгжлийн бодлого болон 2016-2030 онд хэрэгжүүлэх Ногоон Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх 2016 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодорхойлсон байна.

Одоогийн байдлаар зөвшилцсөн дэлхийн шалгуур үзүүлэлт (12.1.1) нь тогтвортой хэрэглээ ба бүтээгдэхүүний үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө бүхий орнуудад хамааралтай юм.

Монгол улс хэдийгээр тогтвортой хэрэглээ, бүтээгдэхүүний байдлын бие даасан төлөвлөгөө байхгүй ч гэсэн ногоон хөгжлийн бодлого болон түүний үйл ажиллагааны төлөвлөгөөнд тогтвортой хэрэглээ, бүтээгдэхүүний байдлын хөтөлбөрийг холбогдох үзүүлэлтүүдийн нь хамт хэрэгжүүлэх тодорхой заалтуудыг тусган оруулжээ.

## 6.5 Хууль эрх зүй, бодлого, бүтэц зохион байгуулалтын тогтолцоо

### *Хууль эрх зүйн тогтолцоо*

Монгол улсын нэгдэн орж батламжилсан олон улсын хэлэлцээрийн заалт нь Монголын бусад хууль тогтоомжтэй зөрчилдвөл олон улсын хэлэлцээрийн заалтыг баримтлана.

Олон улсын гэрээ хэлэлцээрийн тухай 1993 онд баталсан хууль нь олон улсын хуульд нийцүүлэн, бичгэн хэлбэрээр байгуулсан олон талт олон улсын хэлэлцээрүүдэд мөн үйлчилнэ. Хууль нь олон улсын хэлэлцээрийг бэлтгэх үйл явц, нэгдэн орох, батламжлах явцыг зохицуулж байна.

### *Бодлогын тогтолцоо*

Монгол улсын олон улсын хамтын ажиллагаа нь 2011 онд батлагдсан Гадаад бодлоын үзэл баримтлал болон цогц зарчмуудад сайтар тодорхойлсон бодлогын дагуу явагдана.

Тогтвортой хөгжлийн алсын хараа 2030 баримт бичигт бүх салбарын болон салбар хоорондын стратегийг тодорхойлжээ (Бүлэг 1). Салбарын бодлогууд, тэдгээрийн зорилго, зорилтуудыг ТХХ 2030-д нийцүүлэн тодорхойлж байна. Тогтвортой хөгжил, байгаль орчны тэргүүлэх асуудлыг ТХХ 2030-д тодорхой тусган оруулсан ба ногоон хөгжлийн тэргүүлэх асуудлуудыг Ногоон хөгжлийн Бодлогод тусган оруулсан. Энэхүү хоёр баримт бичиг аль аль нь байгаль орчны асуудлаар олон улсын хамтын ажиллагаанд тэргүүлэх ач холбогдол өгсөн байна. ТХХ 2030 болон Ногоон хөгжлийн бодлогыг баталсаны дараа Засгийн газар салбаруудын одоогийн стратеги, хууль тогтоомж болон зохицуулалтын зарим шаардлагатай заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулна гэсэн хүлээлттэй байна.

ТХХ 2030-д тодорхойлсон бодлогын асуудлуудыг хэрэгжүүлэх тодорхой төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг баталсаны дотор байгаль орчны олон асуудлын төлөвлөгөө, хөтөлбөрүүд орж байна, тухайлбал: Ховор болон устах аюулд орсон төрөл зүйлүүдийг хамгаалах үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө, Удаан задарлаг органик бохирдуулагч бодисын тухай үндэсний төлөвлөгөө, Озоны үе давхаргыг хамгаалах үндэсний хөтөлбөр болон нүүдлийн төрөл зүйлүүдийг хамгаалах хэд хэдэн үндэсний хөтөлбөрүүд орж байна.

### *Бүтэц зохион байгуулалтын тогтолцоо*

Байгаль орчны олон улсын хамтын ажиллагаа бараг бүгд Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд төвлөрч байна. Дэлхийн байгаль орчны хэлэлцээрүүдийг тус яамны Хүрээлэн буй орчин ба байгалийн нөөцийн менежментийн газар, Уур амьсгалын өөрчлөлт ба олон улсын харилцааны газар, Газрын менежмент ба усны бодлого, зохицуулалтын газар, мөн Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар гэсэн дөрвөн газрын хэдхэн ажилтан хариуцаж байна.

Базелийн конвенци болон САЙТЭС-ийн хувьд ганц ажилтан конвенцийн бүх асуудлыг хариуцаж байгаа

нь үнэхээр хангалтгүй юм. БОАЖЯ-гаас зарим нэг тайлан илтгэлийг, тухайлбал Базелийн конвенци болон САЙТЭС-ийн хувьд бэлтгэн хүргүүлэхэд ажиллаж байгаа баг хүрэлцэхгүй байна.

Олон улсын, бүс нутгийн болон хоёр талын хамтын ажиллагааны тухайд Гадаад харилцааны яам салбарын яамдын ажилд ихээхэн тусламж дэмжлэг үзүүлэхээс гадна олон улсын хэлэлцээрт нэгдэн орох, тэдгээр хэлэлцээрийн үндэсний хууль тогтоомжтой хэр нийцэж байгаа байдал болон Монгол улсын хүлээх үүрэг хариуцлага зэрэгт дүн шинжилгээ хийн дүгнэлт гаргадаг байна.

Олон улсын, бүсийн болон хоёр талын байгаль орчны хамтын ажиллагааг хөгжүүлэхэд БОАЖЯ-ны Уур амьсгалын өөрчлөлт, олон улсын хамтын ажиллагааны газар бүр эхнээс нь хариуцан ажиллаж байна. Одоогийн Уур амьсгалын өөрчлөлт ба Олон улсын харилцааны газрын үндсэн үүрэг нь уур амьсгалын өөрчлөлтэй холбоо бүхий бодлого, стратеги, хөтөлбөрүүдийг боловсруулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах; салбар хоорондын бодлогын уялдааг хангах; байгаль орчны салбарын олон улсын хамтын ажиллагааны бодлогыг хэрэгжүүлэх, уялдуулан зохицуулах; олон улсын төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн гадаад эх үүсвэрийг дайчлах; Монгол улсын нэгдэн орж батламжилсан гэрээ конвенцийг хэрэгжүүлэх, хандивлагчдийн дэмжлэгтэй олон улсын төслүүдийн хэрэгжилтэд хяналт тавихад оршиж байна.

Олон улсын хэлэлцээрүүдийн хэрэгжилтэд хяналт тавих, салбарын яамд, засаг захиргааны янз бүрийн түвшин, зарим тохиолдолд ТББ, эрдэм шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг хангах зорилго бүхий салбар хоорондын хороог байгуулсан байна. Рамсар, САЙТЭС болон Венийн конвенцийг энд нэрлэж болно.

## 6.6 Олон улсын техникийн дэмжлэг, туслалцаа

Байгаль орчин, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн бодлогыг боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэхэд Монгол улсад олон тооны хандивлагчид (Бүлэг 3), НҮБ-ын системийн байгууллагууд гол үүрэг гүйцэтгэж иржээ.

Монгол улсын Тогтвортой хөгжлийн алсын хараа 2030 хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол улсад зориулсан НҮБ-н Хөгжлийн тусламжийн хамрах хүрээ (UNDAF), 2017-2021 оны үйл ажиллагааны нэгдсэн хөтөлбөрийг боловсруулан ажиллаж байна.

Байгаль орчин, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн чиглэлээр Монгол улсад үзүүлэх техник туслалцааны гол түнш нь НҮБХХ бөгөөд 2007-2017 онд хэд хэдэн төслийн хэрэгжүүлэхэд уг хөтөлбөрөөр дамжин 32 сая еврог зарцуулсан байна.

БОАЖЯ болон олон улсын хандивлагчдийн дэмжлэг тусламжтайгаар 1991-2017 оны хугацаанд нийт 83 төслийг хэрэгжүүлжээ. БОАЖЯ-ны оролцоотойгоор 2017 оны байдлаар 34 төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээр төслүүд нь: байгалийн баялагийн тогтвортой менежмент, ус, ой, ногоон хөгжил, ногоон эдийн засаг, био аюулгүй байдалын болон аюултай, хортой химийн бодисын зохицуулалтын бодлого, уур амьсгалын өөрчлөлт болон дасан зохицох (Бүлэг 3) зэрэг салбарт голлон төвлөрч байна. БОАЖЯ-нд хэрэгжиж байгаа төслүүдийн тухай мэдээллийн нэгдсэн санд хандивлагч улс орнууд, бусад байгууллагууд: Австри, Канад, Дани, Герман (GIZ, KfW), Япон, Кувейт, Голланд, Норвеги, Швед, Арабын нэгдсэн Эмират, Англи, АНУ, Олон улсын Умардын сан, ТАСИС, ФАО, ДБОУ, НҮБХХ, НҮББХ, Азийн хөгжлийн банк болон Дэлхийн банкны төсөл хөтөлбөрийн тухай мэдээллийг оруулсан байна. Байгаль орчны асуудал хариуцсан байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр хэд хэдэн төсөл хэрэгжүүлжээ.

Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон Европын Сэргээн босголт, хөгжлийн банк агаарын бохирдолын асуудлыг шийдэх болон усны менежментийг сайжруулах зорилгоор сэргээгдэх эрчим хүчний дэд бүтцэд зээл олгож байна.

Усан хангамж болон хотын бусад дэд бүтэц, үйлчилгээний салбарт 1990-ээд оноос хандивлагчид дэмжлэг тусламж үзүүлж байгаа бөгөөд энэ дэмжлэг сүүлийн жилүүдэд өргөжин тэлсээр байна. Эдгээр салбарын гол хандивлагчид нь Дэлхийн банк (Улаанбаатар хотын үйлчилгээ, дулаалга), Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг (хотын ерөнхий төлөвлөгөө, хатуу хог хаягдлын менежмент, УБ-ын гэр хорооллын тохижилт), Германы хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага (гэр хорооллын тохижилт, цахилгааны хэмнэлттай орон сууц), НҮБХХ (хотын засаглал), АНУ-ын Олон улсын

хөгжлийн агентлаг (орон сууц) зэрэг юм.

Бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх гол түнш нь АХБ юм. Түншлэлийн 2017-2020 оны стратеги нь Монголын хөгжлийн гол саад бэрхшээл, сорилтуудыг даван туулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор хөрөнгө оруулалтыг дэмжих, бодлогын шинэчлэл, чадавхийг бэхжүүлэх, хүртээмжтэй өсөлтийг хангахад чиглэгдэж байна. Тэдгээр зорилтуудыг хэрэгжүүлэх үүднээс АХБ өөрийн үйл ажиллагааг стратегийг гурван тулгуурт үндэслэн явуулж байна. Эдгээр нь: (i) эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангах, (ii) эдийн засгийг төрөлжүүлэх дэд бүтцийг хөгжүүлэх, (iii) байгаль орчны тогтвортой байдлыг бэхжүүлэх явдал байна.

Монголын байгаль орчин, тогтвортой хөгжлийн талаарх чармайлыг олон улсын ТББ-ууд, тухайлбал Даян Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь салбар ихээхэн тусламж үзүүлж байна. Уг байгууллага Монголд хэрэгжүүлж байгаа 100 гаруй төсөлд мэргэжлийн дэмжлэг үзүүлж, биологийн олон янз байдлыг хамгаалах болон цэцэрлэгжүүлэх, устах аюултай зэрлэг амьтны хамгаалал, байгалийн нөөц баялагийн зохистой менежмент, биологийн олон янз байдлын талаархи мэдлэг, ойлголтыг гүнзгийрүүлэх, усны үнэлгээ, тусгай хамгаалалтай газрын үр дүнтэй менежментийн асуудлуудаар техникийн туслалцаа үзүүлж иржээ.

Хандивлагчдийн үйл ажиллагаа, хөрөнгийн зохицуулалтыг Сангийн яам хариуцаж байна. Харин хандивлагчдын шууд оролцоотой хэрэгжүүлж байгаа уур амьсгалын өөрчлөлттэй холбоо бүхий байгаль орчны хамгаалалт, ногоон хөгжлийн стратеги, бодлогын хувилбаруудыг боловсруулах зэрэг асуудлыг БОАЖЯ-ны Уур амьсгалын өөрчлөлт, олон улсын хамтын ажиллагааны газар хариуцаж байна.

Хэдийгээр байгаль орчныг хамгаалах, тогтвортой хөгжил ба ногоон хөгжлийн бодлогыг цаашид хөгжүүлэхэд хандивлагчдын оруулж байгаа хөрөнгө нэн чухал үүрэг гүйцэтгэх боловч Монгол улс ихээхэн хөрөнгө оруулалт шаардагдах дэд бүтцийг янз бүрийн салбарт, тухайлбал хог хаягдал, эрүүл ахуй болон химийн бодис г.м салбарт цаашид хөгжүүлэх шаардлагатай байна. Ойрын ирээдүйд Монгол улсын санхүүгийн эрэлт хэрэгцээ одоогийн дотоод, гадаадын хөрөнгийн эх үүсвэрээс ихээхэн хэмжээгээр давах төлөвтэй байна.

## **6.7 Үнэлгээ, дүгнэлт ба зөвлөмж**

### *Үнэлгээ*

ТХЗ-уудыг хэрэгжүүлэхэд тэргүүн эгнээд явж, хөгжлийн бодлогыг ногооруулах болон Байгаль орчны салбарын олон талт гэрээ хэлэлцээрүүдэд оролцох хүсэл тэмүүлэл нь Монгол улсад байгаль орчныг хамгаалах үйлсийн хөтөлгөч хүч болж байна. Байгаль орчны салбарын олон талт гэрээ хэлэлцээр, тухайлбал Мөнгөн усны Минаматагийн Конвенцийг саяхан шуурхай батламжилсан явдал нь Засгийн газар байгаль орчны асуудлаар олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож байгаагийн илрэл юм. Байгаль орчны салбарын олон талт гэрээ хэлэлцээрүүдэд хамрагдаагүй улс орнуудын хөгжил дэвшил илүү хязгаарлагдмал явж ирсэн байдаг. Энэ нь, тухайлбал мэдээлэл олж авах болон байгаль орчны талаархи асуудлуудад олон нийтийн оролцоог хангах чухал хэрэгсэл болдог.

Олон улсын хэмжээнд хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх болон дагаж мөрдөх асуудал бэрхшээлтэй хэвээр байсаар байгаа нь ямар нэг хэмжээгээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хүний нөөц, түүний чадавхи болон санхүүгийн боломж хангалтгүй байгаатай холбоотой байна. Монгол улс техникийн ур чадвар болон санхүүгийн хөрөнгө нөөцийн хувьд олон улсын хандивлагчдаас ихээхэн хамааралтай байна. Олон улсын хэлэлцээр болон олон улсын хэмжээнд хүлээсэн үүргээ үр ашигтай биелүүлэхийн тулд Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон байгаль орчны асуудалд оролцдог байгууллагуудын чадавхи, санхүүгийн нөөц боломжийг Байгаль орчны салбарын олон талт гэрээ хэлэлцээрийн дагуу гишүүний хувьд хүлээсэн үүрэгтэй дүйцэх хэмжээнд хүргэж бэхжүүлэх шаардлагатай байна.

Байгаль орчны салбарын хоёр талын хамтын ажиллагаа нь Монгол улсын гадаад бодлогын үр дүнтэй гол чиглүүлэгч нь болж байна. Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг сайжруулах болон байгаль орчны өмнө тулгарч байгаа саад бэрхшээл, сорилтуудыг шийдвэрлэхийн тулд техникийн болон санхүүгийн дэмжлэгийг авахын тулд Монгол улс стратегийн түншлэлийг бусад улс орнуудтай, ялангуяа өөрийн хөрш болон бүс нутгийн орнуудтай амжилттай хөгжүүлж байна.

Дүгнэлт ба зөвлөмжЧадахи, нөөц бололцоо, үр дүнтэй харилцаа холбооны тухай

Олон улсын гэрээ хэлэлцээр болон олон улсын хэмжээнд хүлээсэн үүргээ үр дүнтэй биелүүлэхийн тулд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны чадавхи, санхүүгийн нөөц боломжийг Байгаль орчны салбарын олон талт гэрээ хэлэлцээрийн гишүүний хувьд хүлээсэн үүрэгтэй дүйцэх хэмжээнд бэхжүүлэх шаардлагатай байна. Хүлээсэн үүрэг, бодлогоор дэвшүүлсэн зорилт, зорилгуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө санхүүгийн нөөцийн байдалд үнэлгээ хийх явдал хангалтгүй байна.

Байгаль орчны салбарын олон талт гэрээ хэлэлцээр болон Монгол улсын холбогдох албаны хүмүүсийн харилцаа холбооны шуурхай байдлыг хангах үүднээс Байгаль орчны салбарын олон талт гэрээ хэлэлцээрийн Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлж байгаа гол гол асуудлын тухай тайлан мэдээлэл нь байнга шинэчлэгдсэн байх шаардлагатай. Түүнчлэн, эдгээр гэрээ хэлэлцээрийн өмнө хүлээсэн үүргээ ямар нэг саадгүй хэрэгжүүлэх үүрэг бүхий ажилтнуудын боломж нөөц нь хангалтгүй байна.

Зөвлөмж 6.1:

*Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Байгаль орчны салбарын олон талт гэрээ хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх ажлыг хариуцаж байгаа газар, нэгжүүдийн захиргааны болон техникийн чадавхи, санхүүгийн хэрэгцээ шаардлагад гүнзгий дүн шинжилгээ хийх;*
- (b) *Энэ дүн шинжилгээн дээр үндэслэн Байгаль орчны салбарын олон талт гэрээ хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх ажлыг хариуцаж байгаа газар, нэгжүүдийн захиргааны болон техникийн чадавхи, санхүүгийн хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах;*
- (c) *Асуудал хариуцсан Үндэсний зохицуулагдыг шинээр томилох тухай бүр холбогдох Байгаль орчны салбарын олон талт гэрээ хэлэлцээрүүдэд зохих журмын дагуу нэн даруй мэдэгдэж байх;*
- (d) *Байгаль орчны салбарын олон талт гэрээ хэлэлцээрийн асуудал хариуцсан ажилтнуудын тоог нэмэгдүүлж холбогдох гэрээ хэлэлцээрийн үйл ажиллагааг идэвхижүүлэх болон тайлагнах багийг бэхжүүлэх.*

Монгол улс хараахан нэгдэн ороогүй байгаа Байгаль орчны салбарын олон талт гэрээ хэлэлцээрүүдэд оролцох оролцоо

Монгол улс Байгаль орчны салбарын олон талт гэрээ хэлэлцээрүүдэд нэгдэн орсон нь байгаль орчны асуудлаар бодлого боловсруулах, үйл ажиллагаа хэрэгжүүлэх, илүү үр дүнд хүрэхэд ихээхэн түлхэц болно. Монгол улс дэлхийн хэмжээнд хэрэгжиж байгаа гол гол Байгаль орчны салбарын олон талт гэрээ хэлэлцээрүүдэд нэгдэн орсон байна. Хэдий тийм боловч, байгаль орчныг хамгаалах илүү цогц бүтцийг бий болгож, амжилтад хүрэхэд ихээхэн дэм болох Байгаль орчны салбарын зарим олон талт гэрээ хэлэлцээрүүдийг цаашид батламжлах асуудал үлдэж байна. Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд, Монреалийн протоколд оруулсан Кигалийн нэмэлт өөрчлөлтийг батламжлах нь озоны давхрагыг хамгаалах үндэсний хүчин чармайлтыг урагшлуулахад нэн чухал юм.

Монгол улс одоогоор хил дамнасан усны хамтын ажиллагааны тухай олон улсын хоёр конвенцид нэгдэн ороогүй байгаа, тухайлбал, Хил дамнасан урсгал ус болон олон улсын нууруудыг хамгаалах, ашиглах тухай 1992 оны конвенци, Олон улсын навигацын бус усны урсгалыг ашиглах хуулийн тухай 1997 оны Конвенци байна. Тэдгээр конвенцид нэгдэн орсоноор олон улсын усны тухай хуулийн зарчмууд болон заалтуудыг дагаж мөрдөх эрмэлзэлтэй байгаагийн нь илэрхийлэл болох юм. Дээрх 1992 оны конвенцид нэгдэн орох нь энэхүү конвенцийн бүтэцийн байгууллагуудын платформын үр шимийг хүртэх боломж олгоно.

Зөвлөмж 6.2:

*Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Озон задалдаг бодисын тухай 1987 оны Монреалийн протоколын 2016 оны Кигалийн нэмэлт өөрчлөлтийг батламжлах, шаардлагатай хяналтын механизмыг хэрэгжүүлэх;*

- (b) Хил дамнасан урсгал ус болон олон улсын нуурыг хамгаалах, ашиглах тухай 1992 оны конвенци болон Олон улсын навигацын бус усны урсгалыг ашиглах хуулийн тухай 1997 оны Конвенцид нэгдэн орох асуудлыг авч үзэх, мөн шаардлагатай өртөг зардал болон үр дүнг хүртэх боломжийн талаар дүн шинжилгээ хийх.

#### Рамсарын газруудын менежментийн төлөвлөгөө

Монгол улс нэгдэн орсон олон улсын хэлэлцэрүүдийн дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийн төлөө ихээхэн хүчин чармайлт гаргаж байгаа хэдий ч Олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газар, ялангуяа усны шувуудын тухай конвенцийг хэрэгжүүлэх талаар хийх зүйл байсаар байна.

Рамсарын газрыг товлон тогтоосноор тодорхой үүрэг хүлээж, байгалийн энэ үнэт зүйлийн менежментийн шаардлага өндөр байх тул ялангуяа тэдгээрийг хамгаалах асуудлыг чухалчлан байнга мониторинг хяналт тавих шаардлагатай байдаг. Монгол улсад байгаа Рамсарын бүх газруудыг хамарсан менежментийн төлөвлөгөө байхгүй байна.

#### Зөвлөмж 6.3:

*Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь Ганга нуур, Буйр нуур, Ачит нуур болон Тэрхийн цагаан нуурын Рамсарын газрын менежментийн төлөвлөгөөг батлах хэрэгтэй байна.*



## Бүлэг 7

# РИОГИЙН КОНВЕНЦҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ

### 7.1 Биологийн олон янз байдлын тухай конвенци

Монгол улс Биологийн олон янз байдлын тухай конвенцид (БОЯК) 1992 онд нэгдэн орсоноор конвенцийг хүчин төгөлдөр болгоход хувь нэмэр оруулсан 30 дахь орон болсон юм.

*Хууль эрх зүй, бодлого, бүтэц зохион байгуулалтын тогтолцоо*

#### Хууль эрх зүйн тогтолцоо

Монгол улсад Биологийн олон янз байдлын тухай конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өргөн хүрээтэй багц хууль тогтоомж батлан хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2012 оны Ойн тухай хууль, 2012 оны Амьтны аймгийн тухай хууль, 1995 оны Байгаль хамгаалах тухай хууль, 2012 оны Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль, 2012 оны Байгалийн нөөц баялаг ашигласны төлбөрийн тухай хууль, 1999 оны Ургамлын үрийн төрөл зүйл болон таримал ургамлын тухай хууль, 2016 оны Үр тарианы үйлдвэрлэлийн тухай хууль, 1995 оны Байгалийн ургамлын нөмрөгийн тухай хууль, 2012 оны хөрсийг хамгаалах, цөлжилтэй тэмцэх тухай хууль ( Бүлэг 1, 11, 12) зэрэг гол хуулиуд үйлчилж байна.

#### Бодлогын тогтолцоо

Монгол улс Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны анхны үндэсний төлөвлөгөөг 1996 онд баталжээ (1996 оны Засгийн газрын 163 дугаар Тогтоол). Уг төлөвлөгөөнд биологийн олон янз байдлын тухай судалгаа шинжилгээ, хамгаалалт, зохистой ашиглалт, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зэрэг 21 зорилт, 87 үйл ажиллагаа орсон байна. Түүний хэрэгжилтийн байдалд 2002 болон 2010 онуудад үнэлгээ хийжээ. Эхний үнэлгээгээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны уялдаа, зохицуулалт муу байна гэсэн дүгнэлт гарсаны дагуу төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих хороо байгуулж, Засгийн газар шаардлагатай хөрөнгийг гаргасан байна. Хоёрдох үнэлгээгээр 2010 он гэхэд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжсэн буюу хэрэгжихэд бэлэн болсон ажлын хувь 96 байсан байна.

Биологийн олон янз байдлын Айчигийн зорилтуудыг 2010 онд Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Талуудын 10 дугаар Бага хурлаас баталж, Талуудыг конвенцийн 2011-2020 оны стратеги төлөвлөгөөний зорилтуудыг Үндэсний биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган шинэчлэх зөвлөмж гаргасны дагуу Монгол улсын 2015-2025 онд хэрэгжүүлэх Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (Засгийн газрын 2015 оны 325 дугаар Тогтоол)-ийг 2015 онд баталсан байна. Хөтөлбөрийг БОАЖЯ-ны хэд хэдэн газрууд, Хууль зүйн яам, Монгол Улсын их сургууль, Швейцарийн хөгжил хамтын ажиллагааны агентлаг, Даян дэлхийн байгаль хамгаалах сан болон НҮББОХ хамтран боловсруулсан байна.

Биологийн олон янз байдлын Үндэсний хөтөлбөр нь Биологийн олон янз байдлын тухай конвенцийг хэрэгжүүлэх гол баримт бичиг бөгөөд конвенцийн 2011-2020 оны стратеги зорилтууд болон Биологийн олон янз байдлын Айчигийн Зорилтуудтай бүрэн нийцэж байгаа юм. Биологийн олон янз байдлын 1996 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөнд хийсэн үнэлгээ болон стратегийн анхны баримт бичгийг баталсанаас хойшхи хугацааны нийгэм эдийн засгийн өөрчлөлтийн байгаль орчинд үзүүлсэн нөлөөг бүрэн харгалзан үзэж боловсруулжээ.

Биологийн олон янз байдлын Үндэсний хөтөлбөр нь биологийн олон янз байдлыг хамгаалах бодлогыг ядуурлыг бууруулах бодлого болон бусад холбогдох үндэсний болон салбарын төлөвлөгөөтэй нийцүүлэх үүднээс дараах дөрвөн стратегид төвлөрч байна (Бүлэг 11): мэдлэг мэдээлийг дээшлүүлэх; шинжлэх ухаанд суурилсан бодлого; биологийн олон янз байдлын ухаалаг ашиглалт; бодлого болон эрх зүйн орчныг сайжруулах. Эдгээр стратегид тулгуурлан Айчигийн Зорилтуудын хэрэгжилтийн үнэлгээг 14 зорилго, 29 зорилт болон 74 бүтээгдэхүүн, үр дүнгийн дагуу хийхээр төлөвлөжээ. Эхний үнэлгээг 2020

онд, эцсийн үнэлгээг 2025 онд хийхээр төсөөлж байна. Хэрэгжилтийн явцын тайлан илтгэлийг гурван жил тутам парламентад, таван жил тутам Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт тус тус хүргүүлнэ. Үйл ажиллагааны төлөвлөгөөг БОАЖЯ-ны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газраас яамны бусад газар хэлтсийн оролцоотойгоор Биологийн олон янз байдлын Санхүүжилтын санаачилгын (BIOFIN) –н хүрээнд Дэлхийн байгаль хамгаалах сан (GEF), НҮБХХ, Германы санхүүжилтээр 2017 оны дунд үеийн байдлаар боловсруулаад байна.

Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 –д дэвшүүлсэн зорилтуудын нэг нь байгалийн ногоон байгууламж болон биологийн олон янз байдлыг хамгаалах, экосистемийн тогтвортой үйлчилгээг хангах явдал юм. ТХЗ-д нийт газар нутгийн 25 хувийг 2020 он гэхэд тусгай хамгаалалтад авах, 2025 онд үүнийг 27 хувьд хүргэх, улмаар 2030 он гэхэд 30 хувьд хүргэх зорилт дэвшүүлж (Бүлэг 11), 2020 он гэхэд ойгоор бүрхэгдсэн талбайг 8.5 хувь, 2025 он гэхэд 8.7 хувь, 2030 он гэхэд 9 хувьд хүргэн нэмэгдүүлэхээр заажээ (Бүлэг 13).

Биологийн олон янз байдлын Үндэсний хөтөлбөрт 2015-2025 онд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн зорилгуудыг багц бодлогын баримт бичгүүдээр дамжуулан хэрэгжүүлнэ. Үүнд холбогдол бүхий сүүлийн үеийн баримт бичгүүд нь: 2014 оны Ногоон хөгжлийн бодлого, 2011 оны Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр, 2010 оны Цөлжилттэй тэмцэх Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр, 2010 оны үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 1997 оны Төрөөс экологийн талаар баримтлах бодлого, 1998 оны Тусгай хамгаалалттай газруудын Үндэсний хөтөлбөр, 2011 оны ховор болон устах аюултай төрөл зүйлүүдийг хамгаалах Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр, 2008 оны загас хамгаалал, үржүүлгийн үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр, 2005 оны Ногоон Хүрэм Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр (Бүлэг 1, 13), 2015 оны Төрөөс ойн талаар баримтлах бодлого (Бүлэг 1, 13), 2010 оны Монгол мал үндэсний хөтөлбөр (Бүлэг 1), 2009 оны Малчдын талаар баримтлах Засгийн газрын бодлого (Бүлэг 1), 2015 оны Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, 2014 оны Төрөөс ашигт малтмалын талаар баримтлах бодлого зэрэг байна.

#### Бүтэц зохион байгуулалтын тогтолцоо

Одоогийн байдлаар БОАЖЯ-ны Уур амьсгалын өөрчлөлт, Олон улсын хамтын ажиллагааны газар Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Үндэсний зохицуулагчаар ажиллаж байна. Харин, Биологийн олон янз байдлын тухай конвенцийн төвтэй харьцах нэр дэвшүүлсэн газар нь Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн менежментийн газар, конвенцийн Шинжлэх ухаан, техник, технологийн талаар зөвлөх туслах байгууллагын Үндэсний зохицуулагч нь Монгол улсын их сургуулийн Урлаг, шинжлэх ухааны сургууль (энэ нь мөн Дэлхийн таксонномийн санаачилгын үндэсний зохицуулагч) байна. Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар нь 2011 он хүртэл уг конвенцийн Үндэсний зохицуулагч байжээ. Ийнхүү байн байн өөрчлөгдөж байгаа нь гол нь яамны дотоод зохион байгуулалтын өөрчлөлтэй холбоотой байна. Гэхдээ энэ өөрчлөлт нь Уур амьсгалын өөрчлөлт, Олон улсын хамтын ажиллагааны газрын биологийн олон янз байдлын талаарх үйл ажиллагаатай хамааралгүй юм. Яамны бусад газрууд мөн Биологийн олон янз байдлын тухай конвенцийн хэрэгжилтэд оролцож байна. Тусгай хамгаалалттай газрын удирдлагын газар нь Хамгаалалттай газруудын хөтөлбөрийн (PoWPA) Үндэсний зохицуулагч бөгөөд Монгол улсын их сургуулийн Ботаникийн салбар нь Дэлхийн ургамал хамгаалалын стратегийн үндэсний зохицуулагч байна.

Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Талуудын бага хурлуудад голдуу Үндэсний зохицуулагч нар оролцдог ба зарим үед ТББ-ын төлөөлөлийг оролцуулдаг байна

Үндэсний зохицуулагчид яриа хэлэлцээнд баримтлах байр сууриа техникийн газартай зөвлөж, Талуудын бага хурлын шийдвэрийн талаар эргээд мэдээлдэг байна.

#### *Хэрэгжилт*

Монгол улс тусгай хамгаалалтай газар нутгийн хэмжээгээ байнга нэмэгдүүлсээр иржээ. Улсын хэмжээний тусгай хамгаалалтай газар нутгийн (ТХГ) хэмжээ 2012 оны байдлаар 27 сая гаруй га талбай (бүх газар нутгийн 17.4 хувь эзлэж байсан) эзэлж байна. Энэ хэмжээ 2017 он гэхэд 17.87 хувьд хүрч нэмэгдсэн нь 2020 он гэхэд 17 хувьд хүргэх Айчигийн Зорилт 11-г хэрэгжүүлээд байгаа хэрэг юм. ТХГ нь 2017 онд 12.4 сая га талбай бүхий тулсын тусгай хамгаалалтай 20 газар (нийт газар нутгийн 7.93 хувь), 11.9 сая га талбай бүхий Үндэсний 32 цэцэрлэг (7.6 хувь), 3.5 сая га талбай бүхий 36 Байгалийн нөөц газар (2.26 хувь), 128,962.78 га талбай бүхий 14 Байгалийн дурсгалт газар (0.08 хувь) байна.

Тэдгээр тусгай хамгаалалтай газруудын үр дүнтэй байнгын менежментийн асуудал, ялангуяа байгалийн нөөц баялагаас хамааралтай аймгийн захиргаадын хувьд ихээхэн саад бэрхшээл, сорилт болж байна. Хамтарсан менежментийн арга зам, менежментийн эрхийг ТББ, аж ахуйн нэгжүүд болон орон нутгийг иргэдэд гэрээний үндсэн дээр тодорхой нөхцөлтэйгээр шилжүүлэх ажил эхлээд байна. Одоогийн байдлаар тусгай хамгаалалттай гурван газрын менежментийг ТББ хариуцаж байна (Бүлэг 11). Гэхдээ ТХГ-ын иргэдэд тулгуурласан менежментийн эрх зүйн зохих орчин байхгүй байна (Бүлэг 1 ба 11). Тусгай хамгаалалтай газрын тухай 1994 оны хуулийг шинэчлэх ажил одоо хийгдэж байна.

Айчигийн Зорилт 15 нь Монголын хувьд чухал ач холбогдолтой бөгөөд энэ нь 2020 он гэхэд доройтолд орсон экосистемийн наад зах нь 15 хувийг сэргээх зорилт юм. Биологийн олон янз байдлын 2015-2025 онд хэрэгжүүлэх Үндэсний хөтөлбөрийн дагуу, 2013 оны байдлаар уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй доройтолд орсон 24,000 га талбайн 10,000 га-д нь (41.65 хувь) техникийн, мөн 6,000 гаруй га-д (27.5 хувь) нь биологийн нөхөн сэргээлт хийсэн байна.

Монгол дахь Даян дэлхийн байгаль хамгаалах сангийн хөтөлбөрийн газар одоогоор голуудын урсац бүрэлдэх эхийн зураглалыг гаргахаар ажиллаж байгаа бөгөөд энэхүү зураглалд хамрагдсан талбайд уул уурхайн үйл ажиллагааг хориглох тул энэ нь аймгуудын захиргаануудад уул уурхайн үйл ажиллагааг хориглосон газруудын тухай мэдээлэл тодорхой болох ашиг тустай тул холбогдох газруудад уул уурхайн үйл ажиллагаанаас шалтгаалах гол мөрний эх газруудын бохирдолоос сэргийлэх, орон нутгийн төрөл зүйлүүдэд үзүүлэх нөлөөлөлөөс сэргийлэх боломжтой болно.

#### *Тайлагнах болон хэлэлцээрийн хүрээний үйл ажиллагаа болон механизмуудад оролцох оролцоо*

Монгол улс үндэсний тайлангаа Биологийн олон янз байдлын тухай конвенцид 1998, 2003, 2006, 2009, 2014 онуудад хүргүүлсэн байна. Тайлан илтгэлийг биологийн олон янз байдлыг хамгаалахад оролцогч талууд, тухайлбал салбарын яамд, судалгаа шинжилгээний байгууллагууд, ТББ-ууд хамтран бэлтгэсэн байна. Ялангуяа Монгол улс дахь Даян дэлхийн байгаль хамгаалах сангийн (WWF) хөтөлбөрийн газар Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай тайлан илтгэл болон стратегийн баримт бичгүүдийг боловсруулахад нягт хамтран ажиллаж иржээ. Хүлээсэн үүргийн хэрэгжилтийн байдлын талаар тайлан илтгэл бэлтгэхэд Дэлхийн байгаль хамгаалах сан (GEF) болон НҮББОХ санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Монгол улс Биологийн олон янз байдлын тухай конвенцийн үйл ажиллагаа болон механизмд оролцож байгаагийн үр дүнд Биологийн олон янз байдлын үндэсний стратеги болон Үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, Биологийн олон янз байдлын 2015-2025 онд хэрэгжүүлэх Үндэсний хөтөлбөрөө гаргаж, тайлан илтгэлүүдээ тогтмол гарган хүргүүлж байна. Биологийн олон янз байдлын конвенцид оролцогч Талуудын 2004 оны Тусгай хамгаалалттай нутгийн арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд баталсан Үйл ажиллагааны төлөвлөгөөг конвенцид албан ёсоор хараахан хүргүүлээгүй байна. Монгол улс биологийн аюулгүй байдлыг хангах Биоаюулгүй байдлын хүрээний үйл ажиллагаанд, ялангуяа бүсийн түвшингийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцож байна.

#### *Хэрэгжилтийг дэмжих мэдээлэл ба тооллого*

Биологийн олон янз байдлын Үндэсний хөтөлбөрт 2015-2025 онуудад хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн зорилгуудын нэг нь холбогдох салбаруудын төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт тавих үүднээс биологийн олон янз байдлын холбогдол бүхий үзүүлэлтүүдийг үндэсний үнэлгээний тогтолцоонд оруулж байх явдал юм.

Төрөл зүйлийг хамгаалахтай холбоотой болон төрөл зүйлийн тооллоготой холбоотой мэдээллийг тэр бүр тогтмол шинэчилж чадахгүй байгаа тул төрөл зүйлийн тооллого хийхэд мониторинг болон найдвартай мэдээллийн санг байгуулах явдал гол хэрэгцээ шаардлагын нэг гэдгийг тодорхойлсон байна. Монгол улс унаган төрөл зүйлийн тооллого хийж байгаа боловч унаган, нутагшмал бус төрөл зүйлийн талаархи мэдээлэл туйлын хангалтгүй байна (Бүлэг 11). Биологийн олон янз байдлын Үндэсний хөтөлбөрт 2018 он гэхэд нутагшмал бус амьтан болон ургамлын төрөл зүйлийн мэдээллийн санг бий болгон бүртгэх ба үржимтгий төрөл зүйлүүдийн тархалтыг хязгаарлах үүднээс хяналтын бүтэц болон эрх зүйн орчныг сайжруулахаар заажээ.

*Олон улсын техникийн тусламж*

Биологийн олон янз байдлын тухай конвенцид нэгдэн орсоноос хойшхи 25 шахам жилийн хугацаанд түүний үйл ажиллагааны хүрээнд гол гол олон улсын байгууллагууд болон хандивлагчдийн техникийн төслүүд, санхүүгийн тусламжийн үр шимийг хүртсээр иржээ. Биологийн олон янз байдлын тухай конвенцийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд нь Монгол улсын хувьд олон улсын хамтын нийгэмлэгийн дэмжлэг нэн чухал юм. Дэмжлэгийг эрх зүй болон стратегийн бодлогын баримт бичиг боловсруулах, бүтэц зохион байгуулалтын чадавхийг бэхжүүлэх болон тайлан илтгэл бэлтгэх зэрэгт авч байна. Олон тооны техник туслалцааны төслүүдийг хэрэгжүүлсээр байна, тухайлбал, энд ТББ-уудын идэвхитэй оролцоог хангах төслийг нэрлэж болно.

Одоогоор хэрэгжиж байгаа төслүүдэд Германы техникийн хамтын ажилагааны байгууллагын дэмжлэгтэй BIOFIN, НҮБХХ-ийн Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах төсөл; НҮБХХ-н тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц баялагын менежментийн сүлжээ төсөл; АХБ-ны техникийн тусламжийн Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл, Японы Засгийн газрын тусламжийн Орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулах болон ойн генетик нөөцийг хамгаалах Ойн тогтвортой менежментийн төсөл; Германы техникийн хамтын ажилагааны байгууллагын Уур амьсгалын өөрчлөлт II: Биологийн олон янз байдал болон ойн экосистемийн дасан зохицох зэрэг төсөл орж байна.

«Монгол улсын тусгай хамгаалалттай газруудын нөөц баялагын удирдлагатай сүлжээ» төслийг Дэлхийн байгаль хамгаалах сан болон НҮБХХ, түүнчилэн Герман (KfW, GIZ) болон Даян дэлхийн байгаль хамгаалах сангийн салбарын санхүүгийн дэмжлэгтэйгээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам хэрэгжүүлж байна. Төслийг хэрэгжүүлэх хугацаа нь 2013-2018 он, нийт өртөг нь 6,253,091 ам. доллар байна. Энэхүү төсөл нь хязгаарлагдмал хамгаалалттай нутгийн эрх зүйн орчныг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Төсөл нь хязгаарлагдмал хамгаалалттай нутгийн гурван зорилтыг хүрээнд менежментийн шинэ бүтцийг бий болгох, зарим тохиолдолд одоогийн бүтцийг бэхжүүлэхийг зорьж байна. Төслийн хүрээнд эдгээр асуудлын урт хугацааны стратеги, менежментийн төлөвлөгөө, бизнесийн төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлж байна. Харин, хязгаарлагдмал хамгаалалттай нутгийн гурван зорилтыг хэрэгжүүлэх боломжид санхүүжилтийн тогтвортой байдлыг хангахад бодит бэрхшээл байгааг цохон тэмдэглэсэн байна.

*Монгол улсын хүртэх тодорхой үр шим, учирч байгаа саад бэрхшээл*

Сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд Монгол улс БОЯБ-ын Конвенцийг хэрэгжүүлэх биологийн олон янз байдлын стратеги төлөвлөгөө, багц хууль тогтоомж болон бодлогын баримт бичгүүдийг боловсруулан гаргажээ. Энэ бүхний гол үр дүн бол нийт газар нутгийн 17.87 хувийг улсын тусгай хамгаалалтад аваад байгаа явдал бөгөөд цаашид ТХГ-ын эзлэх талбайг 2030 он гэхэд 30 хувьд хүргэх, мөн орон нутгийн иргэдэд тулгуурласан менежментийг сайжруулах төсөл хэрэгжүүлэх замаар ТХГ-уудын менежментийг сайжруулахыг зорьж байна. Гол саад бэрхшээл нь ТХГ-уудын үр дүнтэй, тогтвортой менежментийг нэвтрүүлэх асуудал, тэдгээрийн санхүүжилт, ТХГ-уудын бүтцийн сүлжээг сайжруулах, хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах асуудал болоод байна.

Монголд нутагшсан унаган төрөл зүйлүүдийн тоо өсөж байгаа нааштай хандлага гарч байна. Монгол улс Байгаль хамгаалах олон улсын холбооны Улаан жагсаалтын үнэлгээ, Монголд нутагшмал бүх нугаламтаны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэвлүүлсэн байна. Гэвч Монголын төрөл зүйлүүдийн нэгдсэн мэдээллийн сан найдвар муутай байна.

Биологийн олон янз байдлын тухай конвенцийг хэрэгжүүлэхэд тохиолдож байгаа гол саад бэрхшээл нь бүтэц зохион байгуулалт, техникийн болон санхүүгийн чадавхийн асуудал байсаар байна. Биологийн олон янз байдлын тухай конвенцийн хэрэгжилтэд оролцогч байгууллагуудын нь харилцан уялдаа холбоогүй, түүгээр ч үл барам Конвенцийн хэрэгжилтэд үндэсний зохицуулагч нь шууд оролцохгүй байгаа нь Риогийн бусад хоёр конвенцтэй харьцуулахад өөр байна. Биологийн олон янз байдлын асуудалд ТББ-уудын идэвхтэй хамтран оролцож байгаа боловч БОАЖЯ-нд бүтэц зохион байгуулалтын зохих чадавхийг бий болгох асуудалд анхаарах шаардлагатай байна.

Түүнээс гадна, Биологийн олон янз байдлын тухай конвенцийн хэрэгжилтэд байнга нөлөөлж байгаа саад бэрхшээлтэй асуудал бол экосистемийн үйлчилгээний дарамт болон Монголын биологийн олон янз байдлын асуудал нь олон салбарыг дамнан оршиж байгаа явдал юм, тухайлбал уур амьсгалын



өөрчлөлт, цөлжилт, мал маллагаанд гарч байгаа өөрчлөлтөөс үүдэлтэй малын бүтцийн өөрчлөлт, хөдөө аж ахуйн практик үйл ажиллагаа болон мал маллагааны тогтвортой бус байдал, гол мөрний эхээр уул уурхайн үйлдвэрлэл нэмэгдэж байгаагаас улбаатай бохирдлын асуудлыг дурьдаж болно.

## **7.2 Биологийн олон янз байдлын тухай Конвенцийн Био аюулгүй байдлын Картагений протокол**

Монгол улс 2000 оны Картагений протокольд 2003 онд нэгдсэн бол Хариуцлага хүлээх болон нөхөн төлбөрийн тухай Нагояа-Куала Лампурын нэмэлт протоколийг 2013 онд батламжилжээ.

*Хууль эрх зүй, бодлого, бүтэц зохион байгуулалтын орчин*

Монгол улс Генетикийн өөрчлөлтэй организмын тухай хуулийг 2007 онд баталсан нь үндэсний биоаюулгүй байдлын эрх зүйн орчин бүрдүүлсэн байна. Хуульд генетикийн өөрчлөлтэй организмыг бүртгэх болон хяналт тавих журам, түүний хил дамнасан хөдөлгөөнд эрсдлийн үнэлгээ хийх, хилийн боомтын шалгах цэгүүдийн асуудлыг хамруулсан байна. Мөн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл болон хэрэглээний асуудлыг хамруулжээ. Генетикийн өөрчлөлтэй организм болон түүний бүтээгдэхүүний менежментийн асуудлыг 2012 оны Хүнсний тухай хууль, 2012 оны Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, 2010 онд Парламентийн баталсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрөөр зохицуулж байна.

Биологийн аюулгүй байдлын тухай үйл ажиллагааны тусгайлсан төлөвлөгөө байхгүй байна. Биоаюулгүй байдлын тухай үйл ажиллагааны төлөвлөгөөг 2015 оноос өмнө боловсруулсан боловч тэр нь батлагдаагүй одоогоор байна. Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр боловсруулахдаа түүний 5 ба 6 дугаар зорилтуудад Картагений протоколтой холбогдол бүхий асуудлуудыг тусгажээ. Гэхдээ уг хөтөлбөрийн тэдгээр хоёр заалт нь биоаюулгүй байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөг орлож чадахгүй юм.

Монгол улс биоаюулгүй байдлын үндэсний хороог 2008 онд байгуулан, түүний хариуцах асуудал болон бүрэлдэхүүнийг БОАЖЯ-ны сайдын 2010 оны А-27 тушаалаар баталж, дараа нь 2013 онд шинэчилсэн байна. Хороо нь биоаюулгүй байдал, Монгол дахь био аюулгүй байдал болон генетикийн өөрчлөлтэй организмын байдалд хяналт тавьж, жилд дөрвөн удаа, шаардлагатай үед түүнээс олон удаа хуралдана. Хороог БОАЖЯ-ны сайд тэргүүлж, бүрэлдэхүүнд нь байгаль орчин, эрүүл мэнд, гадаад харилцаа, боловсрол шинжлэх ухааны яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Халдварт өвчний үндэсний төв, Зооноз өвчний үндэсний төв, Эрүүл мэндийн үндэсний төв, Хүнсний аюулгүй байдлын зөвлөл, шинжлэх ухааны байгууллагууд болон ТББ-уудын төлөөлөл орж байна. Хорооны үйл ажиллагаанд техникийн дэмжлэг үзүүлэх Нарийн бичгийн дарга ажиллаж байна.

Картагений протоколийн Үндэсний зохицуулагч нь БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар бөгөөд конвенцийн Талуудын бага хурлуудад Биоаюулгүй байдлын хорооны Нарийн бичгийн даргын газар тогтмол оролцож байна.

Картагений протоколыг хэрэгжүүлэх бүтэц ажиллаж, холбогдох байгууллагууд, судалгаа шинжилгээний байгууллагууд болон ТББ-н хамтын ажиллагааг зохицуулж байна. Монголын холбогдох хууль тогтоомж нь Картагений протоколийг хэрэгжүүлэхэд нийцтэй боловч Нагояа-Куала Лампурын нэмэлт протоколийн заалтуудын дагуу нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Учир нь генетикийн өөрчлөлтэй организмын нөлөөлөлөөр био аюулгүй байдалд учирсан хохиролыг барагдуулах хуулийн болон захиргааны арга хэмжээний механизм одоогоор байхгүй байна. Био аюулгүй байдлын үндэсний хороо хууль боловсруулах ажлыг хийж, эл ажилдаа олон улсын техникийн болон санхүүгийн тусламж авах асуудлыг тавихаар төлөвлөж байна.



## Фото зураг 7.1: Мал бэлчээрлэлт

*Хэрэгжилт*

Картагений протоколийг хэрэгжүүлэх ажилд Монгол улс зохих дэвшил гаргаж байна. Генетикийн өөрчлөлтэй организмыг илрүүлэх шинжилгээ хийх дөрвөн стандарт бүхий нарийвчилсан аргачлал ашиглаж байна. 2016 оны байдлаар гурван аж ахуйн байгууллагад зөвшөөрөл олгожээ.

Олон тооны сургалтыг холбогдох байгууллагуудын эрсдлийн үнэлгээг чадавхижуулах, оюутнууд болон иргэдийн мэдлэг, мэдээллийг сайжруулах ажлыг телевиз болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр сурталчилан зохион байгуулж байна. Генетикийн өөрчлөлтэй организмд хяналт тавих, шалгалт хийх удирдамжийг байцаагчид, гаалийн ажилтнууд, лабораторуудад зориулан бэлтгэсэн байна.

Молекулийн биологи болон генетикийн инженерийн суурь судалгааг хийж байна. Молекулын биологийн лабораторийг ШУА-н Ерөнхий ба сорилын биологийн хүрээлэнд байгуулж, генетикийн өөрчлөлттэй организмыг илрүүлэх, эрсдлийн үнэлгээ хийх техникийн болон хүний нөөцөөр зохих түвшинд хангахаар ажиллаж байна. Генетикийн өөрчлөлтэй организмыг илрүүлэх чадавхи 2012 он гэхэд нэлээд сайжирч, лаборатори нь Биоаюулгүй байдлын үндэсний хороотой хамтран ажиллаж байна.

Генетикийн өөрчлөлтэй организмын гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг шошголох ажлын судалгаагаар олон улсын болон үндэсний хууль тогтоомжийг зохих ёсоор мөрдөхгүй байна гэсэн дүгнэлт гарсан тул энэ чиглэлийн үйл ажиллагаа болон чадавхийг нь бэхжүүлэх шаардлагатай байна. Картагений протоколийн хэрэгжилтийн байдлын тухай тайлан илтгэлийг 2016 онд Биоаюулгүй байдлыг үндэсний хорооны хүсэлтээр боловсруулж, уг тайланд тодорхой саналуудыг тусгасан байна.

Генетикийн өөрчлөлтэй организмыг хил дамнуулан санаатайгаар тээвэрлэх, байгальд шингээх хүсэлт хэзээ ч хүлээн авч байгаагүй, генетикийн өөрчлөлтэй организмыг хууль бусаар хил дамнуулан Монголоос эсвэл Монголд тээвэрлэхтэй холбогдсон тохиолдол гарч байгаагүй байна. Монгол улс

Протоколийн оролцогч бус Талтай генетикийн өөрчлөлтэй организмыг хил дамнуулан тээвэрлэх асуудлаар хоёр талын, бүс нутгийн, эсвэл олон талт хэлэлцээр байгуулаагүй, мөн Оролцогч бус Талтай импорт, экспортын хэлэлцээр байгуулаагүй байна.

Картагений протоколийг хэрэгжүүлэлтэд Монгол улс идэвхитэй оролцож, хүний нөөцийн хувьд маш их дутагдалтай \зөвхөн хоёр хүн ажиллаж байгаа\ байгаа ч гэсэн биоаюулгүй байдлаар ихээхэн ажил гүйцэтгээд байна. Картагений протоколийг дагаж мөрдөх, хэрэгжүүлэхэд олон улсын санхүүгийн тусламж нэн чухал байна.

Монгол улс үндэсний биоаюулгүй байдлын үндэсний бүтцийг бий болгож үйл ажиллагааг нь эхлүүлэхийн тулд хэд хэдэн төсөл хэрэгжүүлж, олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд техникийн болон санхүүгийн тусламж дэмжлэг авч иржээ.

Био аюулгүй байдлын үндэсний хороо 2016 оны 12 дугаар сард Европын Холбооны Хими биологи, радиологи, цөмийн төвийн санаачилга төсөл 53 –д албан ёсоор оролцохыг зөвшөөрсөн байна. Энэ төсөл нь биоаюулгүй байдлын асуудлаар Төв Азийн орнуудад мэргэжлийн сургалт зохион байгуулж байна.

#### *Тайлагнах болон хэлэлцээрийн хүрээний үйл ажиллагаа болон механизмуудад оролцох оролцоо*

Картагений протокольд нэгдэн орсоноос хойш Монгол улс 2011, 2015 онуудад үндэсний тайлан илтгэлийг бэлтгэн хүргүүлжээ.

Монгол улс бүс нутгийн санаачилгуудад, тухайлбал Олон нийтийн мэдлэг мэдээллийг сайжруулах Ази-Номхон далайн сүлжээ, генетикийн өөрчлөлтэй организмын тухай боловсрол болон оролцоо (Ази-Номхон далайн РАЕР сүлжээ) төслүүдэд оролцож, олон тооны семинар сургалтаар дамжуулан генетикийн өөрчлөлтэй организмын талаарх мэдээлэл, туршлага солилцохыг хөхиүлэн дэмжиж иржээ.

Чадавхийг бэхжүүлэх, сайн туршлагыг харилцан солилцох зорилгоор байгуулагдсан Азийн биоаюулгүй байдлын нэг гэр бүл гэдэг 2016 онд байгуулагдсан бүсийн санаачилгад Монгол улс оролцож байна. Уг санаачилга нь 2016-2020 онд хэрэгжүүлэх үндэсний замын зураглалыг хэрэгжүүлэхдээ бүс нутгийн орнуудад зориулан дөрвөн тэргүүлэх чиглэлд (Био аюулгүй байдлын үндэсний бүтэц ба Картагений протокол; бүсийн хэмжээний сүлжээнд нэгдэх; РАЕР болон Биоаюулгүй байдлын төвийн үйл ажиллагаанд үр дүнтэй оролцох чадавхийг бэхжүүлэх) анхаарал төвлөрүүлж байна. Монгол улс нь 2018-2020 онуудад хэрэгжих Азийн биоаюулгүй байдлын Гэр бүл санаачилгын тэргүүлэх орон байх болно.

Генетикийн өөрчлөлтэй организмыг хэрэглэх хандлага улам бүр нэмэгдэж байгаа, бас эрх зүй, бүтэц зохион байгуулалт болон менежментийн тогтолцоо нь зохих түвшинд хүрч чадаагүй байгаа бүсийн хувьд энэхүү санаачилга нь туйлын чухал учир холбогдолтой юм.

#### *Хэрэгжүүлэхэд учирч байгаа саад бэрхшээлүүд*

Тусгарч байгаа саад бэрхшээлд генетикийн өөрчлөлтэй организм болон түүний гаралтай бүтээгдэхүүнд эрсдлийн үнэлгээ, мониторинг хийх асуудал орж байна. Генетикийн өөрчлөлтэй организм болон түүний гаралтай бүтээгдэхүүнийг бүртгэх үндэсний мэдээллийн сан байхгүй байна. Био аюулгүй байдлын асуудлаар ажиллах хүний нөөц нэн хязгаарлагдмал байгаа нь хэрэгжилтийг цаашид урагшлуулахад томоохон бэрхшээл болж байна.

Картагений протоколийг дагаж мөрдөх хорооны зүгээс Монгол улс ямар нэг журам зөрчсөн мэдэгдэл авч байгаагүй ажээ.

### **7.3 Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Генетикийн нөөцийг ашиглах, түүний үр ашгийг шудрага, тэгш хуваалцах тухай Нагояагийн протокол**

Монгол улс 2010 оны Генетикийн нөөцийг ашиглах, түүний үр ашгийг шудрага, тэгш хуваалцах тухай Нагояагийн протоколд 2014 онд нэгдэн оржээ. Генетикийн нөөцийг ашиглах, түүний үр ашгийг шудрага, тэгш хуваарилах тухай Нагояагийн протоколийн үндэсний зохицуулагч нь БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар байна. Тус яамны Ногоон хөгжил, төлөвлөлтийн газар хууль боловсруулах ажлын явцыг уялдуулан зохицуулж байна. Генетикийн нөөцийг ашиглах, үр ашгийг

хуваарилах асуудлыг хариуцах эрх бүхий байгууллагыг Монгол улс товлон томилох хэрэгтэй байна.

Биологийн олон янз байдлын Үндэсний үйл ажиллагааны 1996 оны төлөвлөгөөнд генетикийн нөөцийг ашиглах, түүнээс гарах үр ашгийг шудрага, тэгш хуваарилах тухай заалтыг тусгаагүй байна. Генетикийн нөөцийн ашиглах, үр ашгийг шудрага, тэгш хуваарилах тухай олон нийтийн мэдлэг хангалтгүй, генетикийн нөөцийг үнэлээгүй, генетикийн нөөцийг ашиглах тухай хууль тогтоомж дутагдалтай байсан тул 2014 онд генетикийн нөөцийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулсан байна.

Ногоон хөгжлийн 2014 оны бодлогын Стратегийн зорилт 2-т “Байгаль орчны тогтвортой хөгжил нь байгалийн нөөцийг үр өгөөжтэй ашиглан, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, үр шимийг урт хугацаанд хүртэх боломжийг байгаль орчны хамгаалалт, нөхөн сэргээх үйл ажиллагааг эрчимжүүлэх, байгаль орчны бохирдол, доройтолыг бууруулахыг зорилт болгон дэвшүүлж” нөөцийг хүртэх, түүнээс гарах үр ашиг, генетикийн санг бүртгэх, үнэлгээ хийх болон бусад холбогдох уламжлалт мэдлэгд тулгуурласан шаардлагатай зохицуулалтын бүтцийг бий болгох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэж заасан байна.

Айчигийн Зорилт 16-г хэрэгжүүлэх үүднээс Монгол улс Биологийн олон янз байдлын 2015-2025 оны хөтөлбөрийн хүрээнд генетикийн нөөцийг ашиглах, түүнээс гарах үр ашгийг шудрага, тэгш хуваарилах тухай эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилго дэвшүүлж, энэ зорилгыг хэрэгжүүлэх дараах гурван зорилтыг дэвшүүлжээ:

- Монголын малын генофонд, нутагшсан төрөл зүйлүүд, үр тариа болон тэдгээрийн зэрлэгээр байгальд оршиж байгаа төрөл зүйлүүдийг бүртгэлжүүлэн хамгаалах;
- Генетикийн нөөц болон генетикийн өөрчлөлтэй организмуудыг бүртгэлжүүлэн, генетикийн нөөцийн банк байгуулах;
- Генетикийн нөөцийг ашиглах, түүнээс гарах үр ашгийг шудрага тэгш хуваарилах эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Биологийн олон янз байдлын 2015-2025 оны үндэсний хөтөлбөрт зааснаар, 2017 онд генетикийн нөөцийн хууль тогтоомжийн техник эдийн засгийн үндэслэл болон хууль эрх зүй үндэслэлийн судалгааг хийхээр төлөвлөжээ. Монгол улс 2020 он гэхэд генетикийн нөөцийн үр өгөөжийг шудрага тэгш хуваарилах болон холбогдох уламжлалт мэдлэгийн тухай хуулийг батлахаар төлөвлөж байна. Мөн 2020 он гэхэд судалгаа шинжилгээний аргачлал болон үнэлгээний техникийг боловсруулж, генийн сан, уламжлалт мэдлэгийг цуглуулан боловсруулах, бүтээгдэхүүний тогтвортой ашиглалтын холбогдох дүрэм журмыг батлана гэсэн хүлээлттэй байна. Монгол улс 2025 он гэхэд ботаникийн цэцэрлэгт 100 хувь нутагшсан ургамлын үртэй болох, зэрлэг амьтны аймгийн үрийн эс болон эмбриог бүртгэлжүүлэн, генийн банканд хадгалах зорилт дэвшүүлсэн байна.

Нагояагийн протоколийн хүрээнд хүлээх үүрэгтэй холбогдсон хуулийн төслийг 2017 оны дунд үе гэхэд боловсруулаад байна. Төсөл бэлтгэх ажлыг Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар ажлын хэсгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд БОАЖЯ-ны бусад газруудын төлөөлөл, мөн Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Оюуны өмчийн газар, Тагнуулын төв газар, шинжлэх ухааны болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл оролцож байна.

Генетикийн нөөц ямар ч хяналтгүйгээр Монголоос гарч байгааг зогсоохын тулд Монгол улс Нагояагийн протоколийн хэрэгжилтийг аль болох эрт эхлүүлэх сонирхолтой байна. Гэвч зохих эрх зүйн орчныг бүрдүүлэхээс гадна Нагояагийн протоколийг хэрэгжүүлэх гол сорилт нь шаардлагатай санхүүжилт, чадавхийг бэхжүүлэх, бүтэц зохион байгуулалтын үр дүнтэй орчныг бүрдүүлэхэд бэрхшээл тулгарч байна. Шинжлэх ухаан, судалгаа шинжилгээний асуудал ч бас бэрхшээлтэй тулгарч байгаа нь Монголын генетикийн нөөцийн судалгаа зөвхөн эхлэлийн шатанд явж, генетикийн нөөцийн суурь мэдээлэл ч байхгүй байгаатай холбоотой. Монгол улс нь НҮБХХ, Даян дэлхийн байгаль орчны сангийн 2016-2019 онд хэрэгжүүлэх “Нагояагийн Протоколыг хэрэгжүүлэх хүний нөөц, эрх зүй, бүтэц зохион байгуулалтын орчныг бэхжүүлэх” төслийн үр шимийг хүртэгч орнуудын нэг юм.

*Энэ хэсэгт холбогдол бүхий Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтууд*

ТХЗ-ын Зорилт 15.6-ийн Монгол улс дахь хэрэгжилтийн байдлыг Шигтгээ 7.1-д үзүүлэв.





### Шигтгээ 7.1: Тогтвортой хөгжлийн 2030 хүртэлх хөтөлбөр ийн Зорилт 15.6

**Зорилго 15: Хуурай газрын экосистемийг хамгаалах, ойн тогтвортой менежментийг дэмжих, цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг зогсоож, эргээн сэргээх, биологийн олон янз байдлын алдагдлыг зогсоох**

**Зорилт 15.6: Генетикийн нөөцийг олон улсын хэмжээнд тохиролцсоны дагуу ашиглах, түүнээс гарах үр ашгийг шудрага тэгш хуваарилах.**

Дэлхийн хэмжээнд Зорилт 15.6-ийн хэрэгжилтийг “шалгуур үзүүлэлт 15.6.1: үр ашгийг шудрага тэгш хуваарилах хууль тогтоомж, захиргаа болон бодлогын бүтцийг баталсан орнуудын тоо”-ээр хэмждэг.

Нагояагийн протоколд нэгдэн орсоноор олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбогдсон хуулийн төслийг Монгол улс одоо бэлтгэж байна. Биологийн олон янз байдлын 2015-2025 онд хэрэгжүүлэх Үндэсний хөтөлбөрт холбогдох зарим заалтуудыг тусгасан байна. Гол саад бэрхшээл бол дүрэм журмын ээдрээтэй байдал, оролцогч талуудын ялгаатай байдал зэргээс үүдэж зохих чадавхитай, үр дүнтэй удирдлагын бүтцийг бий болгох асуудал болж байна. Хэрэгжилтэд хяналт, мониторинг хийх, чадавхийг бэхжүүлэхэд Монголд дэмжлэг үзүүлэх нь үндэсний болон орон нутгийн түвшний удирдах хүмүүс, орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулахад анхаарч, тэдний зүгээс Нагояагийн протоколийг хэрэгжүүлэхэд илүү үр дүнтэй оролцох оролцоог хангах боломж олгох болно.

#### 7.4 Ган, цөлжилттөд ихээр өртөж байгаа улс орнууд, ялангуяа Африк дахь Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенци (НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенци)

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийг (ЦТК) Монгол улс 1996 онд батламжилжээ.

*Хууль эрх зүй, бодлого, бүтэц зохион байгуулалтын тогтолцоо*

Хууль, эрх зүйн тогтолцоо

НҮБ-ын ЦТК-ийг дагаж мөрдөхөд нэн хамааралтай хууль тогтоомжууд нь 2012 оны Хөрс хамгаалал ба цөлжилтээс сэргийлэх тухай хууль, 2016 оны Ойн тухай хууль юм. Үр тарианы үйлдвэрлэлийн тухай 2016 оны хуульд хөрсний чанарт таван жил тутам шалгалт хийж байхаар заасан байна. Тариаланчид шаардлагатай бол хөрсийг сайжруулах арга хэмжээ авах үүрэг хүлээдэг байна. Засгийн газраас тариаланчдад төлбөрийн хөнгөлттэй нөхцлөөр бордоо олгож, бордоо болон хортон шавьжтай тэмцэх бодисыг импортын гаалийн татвараас чөлөөлжээ. Мөн хортон шавьжтай тэмцэхэд хэрэглэх бодисын хэрэглээ, тээвэрлэлтийн талаар сургалтыг тариаланчдад зориулан явуулж байна. Хуульд мөн био бордоо ашиглалтыг нэмэгдүүлэх заалт байгаа ч гэсэн энэ талаар ямар нэг тодорхой арга хэмжээ аваагүй байна.

Бодлогын тогтолцоо

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцод нэгдэн орсон Тал болохын хувьд Монгол улс Цөлжилттэй тэмцэх анхны Үндэсний төлөвлөгөөг 1996 онд боловсруулсан байна. Конвенцийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх үүднээс 10 жилийн (2008-2018) стратеги төлөвлөгөөг баталсаны дараа Монгол улс өөрийн 10 жилийн үндэсний стратеги төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан 2010-2020 онд цөлжилттэй тэмцэх Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөрийг 2010 онд Засгийн газрын 90 дугаар тогтоолоор баталжээ.

Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн зорилго нь ЦТК-ийг үндэсний түвшинд хэрэгжүүлэхэд оршиж байна. Дэвшүүлж байгаа гол зорилго нь Монголд цөлжилтөөс сэргийлэх, тэмцэх, улмаар цөлжилтэд өртсөн газрыг эргүүлэн сэргээх замаар байгаль орчны тогтвортой байдлыг хангах, хөдөөгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, дэлхийн ач холбогдол бүхий байгаль орчны үйлчилгээг бэхжүүлэхэд оршиж байна. Үүний зэрэгцээ аймгийн түвшинд дэд хөтөлбөрийг боловсруулан гаргаж, улсын төсвөөс санхүүжүүлж, түүний хүрээнд иргэдийн мэдлэг мэдээллийг гүнзгийрүүлэх, сургалт зохион явуулах зэрэг арга хэмжээг тусгажээ.

Хөтөлбөрийн зорилт, бүрэлдэхүүн хэсгүүд нь ЦТК-ийн 10 жилийн стратегитэй бүрэн нийцэж байна. Хэрэгжилтийн эхний үе шат 2010-2015 оныг хамарч байна. Энэ хугацаанд авч хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дараах арга хэмжээнүүд орж байна:

- Цөлжилтийн асуудлыг сургуулиудын хичээлийн хөтөлбөрт тусгах, Цөлжилт, гантай тэмцэх Дэлхийн өдрийг тэмдэглэх зэргээр олон нийтийн ойлголт, мэдлэг мэдээллийг гүнзгийрүүлэх, сурталчилах зэрэг арга хэмжээнүүд;
- Бодлого болон хууль эрх зүйн орчныг бий болгох (2012 онд Хөрсийг хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль батлагдсан, хөрсний доройтол болон цөлжилтийн байдлыг тодорхойлох харилцан уялдаатай шалгуур үзүүлэлтийн аргачилалыг боловсруулсан, орон нутгийн болон аймгийн түвшинд цөлжилттэй тэмцэх дэд хөтөлбөр болон дунд хугацааны төлөвлөгөөг 14 аймагт боловсруулан гаргасан байна);
- Цөлжилтийн мониторингийн 1,529 цэг бүхий анхны мониторингийн сүлжээг байгуулсан;
- Шинжлэх ухаан, технологи, мэдлэг олгох (олон улсын эрдэм шинжилгээний хурал, арга хэмжээг зохион байгуулж, Монголын цөлжилтийн байдлын атласыг хэвлэн гаргасан, цөлжилтийн хандлагад судалгаа хийж, зураглалыг тогтмол гаргаж ирсэн, хөрс, газар болон цөлжилтийн цахим мэдээллийн сантай болсон);
- Чадавхийг бэхжүүлсэн;
- Орон нутгийн түвшинд тодорхой арга хэмжээг санхүүлэн хэрэгжүүлсэн (мод тарих, ойжуулах болон нөхөн сэргээх төслүүд) байна.

Цөлжилтийн байдалд 2012 оны эцсээр үнэлгээ хийж хөтөлбөрийн эхний шатны арга хэмжээний хэрэгжилт 93 хувьтай байна гэж дүгнэжээ. Хэдийгээр зохих арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа ч 2006-2015 оны үнэлгээ, дүн шинжилгээний мэдээллээс харахад цөлжилтөд өртсөн газар нутгийн хувь 2006 онд 72 хувь байснаа 2010 онд 77.8 хувь болж нэмэгдсэн бол харин 2015 онд бага зэрэг буурч 76.8 болсон байна (Хүснэгт 12.2). Бусад салбарын бодлогод цөлжилт, газрын доройтол, гангийн асуудлыг нэгдмэл байдлаар тусган оруулах асуудал хангалтгүй байна.

ТХЗ 2030-д цөлжилтийн асуудлыг мөн тусгаж, цөлжилтийн 2014 оны суурь үзүүлэлт 78.2 хувь байгааг 2030 он гэхэд 60 хувь болгон бууруулах зорилтыг Монгол улс дэвшүүлсэн байна. ТХЗ-ын хүрээнд холбогдох салбаруудын хувьд хөдөө аж ахуйн салбарт сүргийн бүтэц болон малын тоог зохих түвшинд хадгалах, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, малын ашиг шимийн бүтээмжийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг тусгасан байна. Газар тариалангийн хувьд, хөрсний үржил шимийг сайжруулах, газрын доройтлыг бууруулах, агро-техник болон усжуулалтын эдийн засгийн ашигтай, үр өгөөж өндөр тэргүүлэх технологийг нэвтэрүүлэх замаар хөрсний эвдрэлийг засах, эрчимжсэн газар тариаланг хөгжүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлжээ.

#### Бүтэц зохион байгуулалтын орчин

ЦТК-ийн Үндэсний зохицуулагч нь БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар байна. Конвенцид оролцогч Талуудын бага хурал болон түүний Шинжлэх ухаан, технологийн талаар зөвлөх туслах байгууллагын хуралдаануудад үндэсний зохицуулагч тогтмол оролцож иржээ.

БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар, Газрын менежмент ба усны бодлого, зохицуулалтын газар, ойн бодлого, зохицуулалтын газар; Уур амьсгалын өөрчлөлт, олон улсын хамтын ажиллагааны газар зэрэг хэд хэдэн газрууд цөлжилт, газрын доройтол, ган (ЦГДГ) болон болон хөрс хамгаалах асуудлаар ажиллаж байна.

Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөрт Цөлжилтэй тэмцэх үндэсний хороо нь цөлжилтэй тэмцэх зорилтын хэрэгжилтийг зохицуулах үүрэг хүлээнэ гэж тодорхойлсон байна. Үндэсний хороог 2000 онд өөр өөр салбарын оролцогсдын бүрэлдэхүүнтэйгээр байгуулжээ. Хөрс хамгаалах болон цөлжилтөөс сэргийлэх тухай 2012 оны хуулиар Хорооны эрх үүргийг өргөтгөж, цөлжилтийн асуудлыг шийдвэрлэхэд оролцдог салбаруудын үйл ажиллагааны уялдаа холбоо болон хамтын ажиллагаанд хяналт тавина гэж заажээ. Гэтэл, 2015 оны 12 дугаар сард Хороог татан буулгаж, (2015 оны Засгийн газрын 501 тоот тогтоол), эрхэлж байсан ажлыг нь БОАЖЯ-нд шилжүүлжээ. Цөлжилт болон түүнтэй холбоотой бусад асуудлыг зохицуулах яамны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготойгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 7 дугаар сарын А\198 тоот тушаалаар Удирдах зөвлөлийг салбарын яамд, эрдэм шинжилгээний байгууллагуудын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө болон ЦТК-ын хэрэгжилтийг хангах үйл ажиллагаанд дэд хөтөлбөрийн хүрээнд аймаг, сумын засаг дарга нарыг цөлжилтэй тэмцэх ажиллагаанд 2012 оноос татан оролцуулж байна.



*Тайлагнал болон хэлэлцээрийн хүрээний үйл ажиллагаа, механизмд оролцох оролцоо*

Конвенцид нэгдэн орсоноос хойш Монгол улс өөрийн тайлан илтгэлийг бэлтгэн 2000, 2002, 2006, 2010, 2012, 2014 онуудад хүргүүлсэн байна. Дараагийн тайлан илтгэлийг 2018 онд хүргүүлэх ёстой (2016 онд заавал тайлан гаргах үүрэггүй байсан).

Конвенцийн хүрээнд бүс нутгийн үйл ажиллагаанд Монгол улс идэвхитэй оролцож байна. ЦТК-ийн 2011 онд болсон Талуудын 10 дугаар бага хурлын үеэр 2011 онд байгуулагдсан Зүүн хойд Азийн цөлжилт, газрын доройтол болон гангын сүлжээ (DLDD-MEAN)-нд нэгдсэн нь ихээхэн чухал алхам болсон байна. Энэхүү сүлжээ нь Хятад, Монгол, БНСУ-ын Засгийн газруудын төлөөлөгчид, шинжлэх ухааны байгууллагууд, олон улсын байгууллагууд, иргэний нийгэмийн төлөөлөлд цөлжилт, шороон болон элсэн шуургатай тэмцэх чадавхийг бэхжүүлэх, сайн туршлагаа харилцан солилцох боломжийг олгосон байна. Сүлжээний хурлыг 2013 онд Улаанбаатар хотод зохион байгуулжээ.

Цөлжилтэй тэмцэх, гангын нөлөөллийг бууруулах чадавхийг бэхжүүлэх бүсийн сэдэвчилсэн хөтөлбөрийн сүлжээг (TPN5) 2003 онд Улаанбаатарт нээжээ. Уг сүлжээг хариуцагчаар Монгол улсыг томилсон байна. Бүсийн сүлжээний зорилго нь үндэсний зохицуулалтын механизм, бүсийн дэд хөтөлбөрүүд болон энэхүү сүлжээний бүсийн бүтцийн байгууллагуудаар дамжуулан бүх оролцогч талуудад хүрч ажиллах явдал юм.

ЦТК-ийн Үндэсний зохицуулагч нь Даян дэлхийн байгаль хамгаалах сангийн бүсийн хурлууд болон ЦТК-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн системийн үнэлгээний (PRAIS) тухай хэлэлцдэг холбогдох хурлуудад оролцож байна. Монгол улс ЦТК-ын Азийн Үндэсний зохицуулагч нарын бүсийн дөрөвдүгээр хурлыг 2001 онд зохион байгуулжээ.

Монгол улс Боннын Сорилт санаачлагад 2017 оны 5 дугаар сард нэгдэн оржээ. Боннын Сорилт нь 2020 он гэхэд дэлхий дахины хэмжээнд утсан ой, доройтсон 150 сая га талбайг нөхөн сэргээх, 2030 он гэхэд энэ хэмжээг 350 сая га-д хүргэх зорилго бүхий дэлхийн санаачилга юм. Боннын Сорилт нь Риогийн гурван конвенцид дэвшүүлсэн зорилтууд, тухайлбал Биологийн төрөл зүйлийг хамгаалах конвенцийн Айчигийн Зорилт 15, УАӨСК –ын РЭДД+ хөтөлбөрийн зорилгын хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн байна. Бонны Сорилтын 2017 оны 5 дугаар сард зохион байгуулсан Азийн арга хэмжээний үеэр Монгол улс 2020 он гэхэд ойгоор бүрхэгдсэн 0.6 сая га талбайг сэргээх амлалт авсанаар 150 сая га талбайг нөхөн сэргээх улс орнуудын амлалтыг хэрэгжүүлэх боломжтой гэдгийг зарлан тунхагласан орнуудын нэг болсон юм. Бонны Сорилт нь бүс нутгийн орнуудад ойжуулах технологи, нөхөн сэргээх төлөвлөлтийн талаар сайн туршлагыг харилцан солилцох нэмэлт боломжийг олгож байна.

ЦГДГ-гийн бүсийн санаачилгуудад оролцсоноор чадавхи бэхжүүлэх болон мэдлэг туршлагаа бүс нутгийн орнуудтай хуваалцах боломжийг Монгол улсад олгосон байна.

*Хэрэгжилтийг дэмжих мэдээлэл, тооллого*

Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөрт орсон нэг арга хэмжээ нь нийт газар нутгийг хамарсан үндэсний хяналтын сүлжээг байгуулж, цөлжилтөд өртсөн болон ноцтой нэрвэгдсэн газруудын ЦГДГ-гийн цаашдын хандлагад үнэлгээ хийх асуудал юм. Анхны мониторингийн сүлжээ одоо 1,529 мониторингийн цэгээс бүрдэж, тэдгээрийн 2 нь урт хугацааны мониторингийн цэг байна. Байгаль орчны мэдээллийн санд цөлжилт, газар болон хөрсний доройтлын байдлын мэдээллийг хамруулан оруулж, энэ мэдээлэл [www.eic.mn](http://www.eic.mn) вэбсайтад тавигдсан байна.

*Олон улсын техникийн туслалцаа*

Конвенцийг хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа Монгол улс техникийн тусламж дэмжлэг авч байна. Тухайлбал, PRAIS –н сургалт болон цөлжилтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх төслүүдийг Ази-Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс болон НҮБХХ –ийн тусламжтайгаар хэрэгжүүлсэн байна. Монгол улс мөн хандивлагчдийн зүгээс дэмжлэг тусламж авч байна. Хэд хэдэн төсөл малчдад чиглэж, бэлчээрийн менежмент, цөлжилтээс сэргийлэх арга хэмжээг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Эдгээрээс хамгийн ач холбогдолтой төслүүдэд Швейцарын засгийн газрын дэмжлэгтэй цөлжилтийг хэрхэн даван туулах төсөл, НҮБХХ болон Нидерландын засгийн газрын дэмжлэгтэй Цөлжилтэй тэмцэх газрын тогтвортой менежмент төсөл; БНСУ-ын Засгийн газрын дэмжлэгтэй Ногоон хүрэм төсөл; Швейцарын засгийн газрын дэмжлэгтэй Ногоон алт төслийг нэрлэж болно.

*Монгол улсын хүрсэн тодорхой амжилт, саад бэрхшээл*

ЦТК-д нэгдэн орсоноор Монголын хүртсэн гол ололт бол уг конвенцийн 10 стратегид бүрэн нийцсэн Цөлжилтэй тэмцэх үндэсний үйл ажиллагааны 2010-2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байгаа явдал юм. ЦГДГ-гийн асуудлыг шийдвэрлэх стратегийн зохих бүтэцтэй болсоноор олон улсын байгууллагууд болон хандивлагч орнуудын техникийн тусламжийн төслүүд хэрэгжүүлэх боломжтой болсон байна. Газрын доройтолд мониторинг хийх сүлжээтэй болсон нь ямар нэг хэмжээгээр ЦТК-д нэгдэн орсоны үр дүн юм.

Уур амьсгалын өөрчлөлтийн хувьд цөлжилт болон газрын доройтлыг түүний байгалийн гол хүчин зүйл гэж үздэг бол Монгол улсын хувьд улс орны эдийн засагт ихээхэн нөлөөтэй хүний үйл ажиллагаа (тухайлбал мал аж ахуй, газар тариалан, уул уурхай) нь цөлжилтийг эрчимжүүлэхэд тодорхой нөлөөлж байгаа учир салбар хоорондын зохицуулалт, харилцан уялдаатай нэгдмэл бодлого хэрэгжүүлэх, иргэдийн ухамсарыг дээшлүүлэх нь Конвенцийн хэрэгжилтийг сайжруулахад чухал үүрэгтэй юм. Цөлжилтэй тэмцэх Үндэсний хороо 2015 оны сүүлч хүртэл тогтмол хуралдаж, үр дүнтэй үйл ажиллагаа явуулж байсан нь бодлогын зохицуулалтад нэн чухал үүрэгтэй байсан учир тус хороог татан буулгасан нь харамсалтай юм. Монгол улсын хэмжээнд байгаль орчны хувьд тохиолдож байгаа нэн ноцтой асуудал болох газрын доройтолтой тэмцэх санхүүгийн эх үүсвэрийг үндэсний болон орон нутгийн түвшинд босгох нь томоохон саад бэрхшээл сорилт болж байна.

**7.5 Уур амьсгалын өөрчлөлтийн НҮБ-ын суурь конвенци (УАӨСК)**

Монгол улс Уур амьсгалын өөрчлөлтийн НҮБ-ын суурь конвенцид 1993 онд нэгдэн орсоноор түүний Хавсралт 1-д ороогүй Тал болж, 1997 оны Киотогийн протокольд 1999 онд нэгджээ. Харин Киотогийн протоколийн Дохагийн нэмэлт өөрчлөлтийг хараахан батламжлаагүй байна. Монгол улс Парисын хэлэлцээрийг 2012 оны 9 дүгээр сард батламжилсан юм.

*Уур амьсгалын өөрчлөлтийн эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх одоогийн болон цаашдын нөлөөлөл*

Монгол улсын далайд гарцгүй газар зүйн байршил, агаарын температур нь эрс тэс, өндөр хэлбэлзэл, жилийн дундаж температур нь  $-8^{\circ}\text{C}$ -ээс  $+6^{\circ}\text{C}$  -ын (зуны дундаж температур  $10^{\circ}\text{C}$ - $26^{\circ}\text{C}$ , өвлийн дундаж температур  $-15^{\circ}\text{C}$ -аас  $-30^{\circ}\text{C}$ ) хооронд хэлбэлздэг, жилийн нийт хур тундас нь Говийн бүсэд 50 мм, нутгийн хойд уулархаг нутагт 400 мм ордог нь Монголыг уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд илүү өртөмтгий, эмзэг байдалд оруулдаг байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн талаар 2009 болон 2014 онуудад хийсэн үнэлгээгээр Монголын экосистем ихээхэн эмзэг, эдийн засаг нь мал аж ахуйгаас хамааралтай, хур борооны хэмжээнээс шууд хамааралтай газар тариалантай, хүн ам нь хурдацтай нэмэгдэж байгаа, уламжлалт нүүдлийн ахуйтай боловч хотжилтын хандлага давамгайлж байгаа зэрэг олон хүчин зүйл нь Монгол улсыг уур амьсгалын өөрчлөлтөд маш эмзэг, өртөмтгий болгож байна гэсэн дүгнэлт хийсэн байна. Өндөр уулсын цас, мөсөн голууд хайлж, гадаргын усны хомсдол, хөрсний болон бэлчээрийн доройтол зэрэг нь мал аж ахуй, газар тариалангаас хамааралтай хөдөөгийн иргэдийн хувьд уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их өртөхөд хүргэж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох явдал Монголын хувьд нэн чухлаар тавигдаж байна.

**Фото зураг 7.2: Хатуу хучилтгүй шороон зам**

Монголын уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний 2014 онд хэвлэгдсэн хоёрдахь тайлангаас үзвэл 1940-2014 оны хоорондох хугацааны цаг агаарын 48 станцуудын мэдээгээр авсан газрын гадарга орчмын температур  $2.1^{\circ}\text{C}$  –аар нэмэгдсэн байна. Температурын өсөлт уулархаг бүсэд эрчимтэй явагдаж байна. Сүүлийн 74 жилийн хамгийн халуун 10 жил нь 1997 оноос хойшхи хугацаанд тохиолдсон байна. (Зураг 7.1).

Хур тундасын хэмжээ ихэнх нутагт жилд 0.1-2.0 мм –р буурч (Зураг 7.2) байна. Унах хур тундасны байдал улирлаар ихээхэн ялгаатай өөрчлөгдөж байна, тухайлбал өвөлд орох хур тундасын хэмжээ аажмаар нэмэгдэж, харин зун орох хур тундас бага зэрэг буурч байна.

Хуурайшилтийг илэрхийлэх индексийн хэмжээ мөн буурч байна. Парисын хэлэлцээрт оруулсан Үндэсний зорилтот хувь нэмэр (INDC) баримт бичигт ашигласан уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн өөрчлөлтийн хувилбаруудаар агаарын температур 2016-2035 оны хооронд  $2.2^{\circ}\text{C}$ -ээр нэмэгдэж, хур тундасын хэмжээ буурах төлөвтэй байна. Уур амьсгалын урьдчилсан төсөөлөлөөр энэ хандлага дунд хугацаанд улам бүр эрчимжиж, ган, зудын үзэгдэл улам бүр давтамжтай болж, байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нь улам ноцтой болох хандлагатай байна.


Уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний 2014 оны хоёрдугаар тайлан илтгэлд мөн уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их эмзэг салбаруудыг тодорхойлсон байна, Эдгээр нь мал аж ахуй, газар тариалан, хүний эрүүл мэнд, ус, ой, бэлчээр, хөрс зэрэг салбар байна. Уур амьсгалын өөрчлөлтийн одоо ба цаашдын өөрчлөлтийн нөлөөлөлийн эдгээр нарийвчилсан үнэлгээний дүнг Монгол улсын ын 2015 онд Парисын хэлэлцээрт оруулсан Үндэсний зорилтот хувь нэмрийн (INDC) баримт бичигт тусган оруулсан байна (Хүснэгт 7.1).

Үндэсний хэмжээнд хохиролын тооцоог бүрэн гаргаагүй, бодлогын гол баримт бичгүүдэд энэ талаар тусгаагүй байна.

*Нэг хүнд ноогдох хүлэмжийн хийн ялгарал*


Дэлхийн банкны мэдээгээр, 2013 онд Монгол улсад нэг хүнд 13.50 тонн CO<sub>2</sub> –ийн ялгарал ноогдож, нэг хүнд ногдох CO<sub>2</sub> хэмжээгээр дэлхийн хамжээнд арван ес дэхь байранд орж байгаа нь (Зураг 7.3) дэлхийн дунджаас (4.90 тонн) хоёр дахин өндөр байна. 2014 онд Монгол тавин дөрөв дэхь байранд орсон ба нэг хүнд ногдох CO<sub>2</sub> ялгарал 7.12 mt болж буурсан байна.

**Зураг 7.1: Монголын нутаг дэвсгэр дээрхи 1961-1990 оны агаарын температурын олон жилийн өөрчлөлтийн явц, 1940-2015, °C**



Эх сурвалж: Уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний хоёрдугаар тайлан илтгэл, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, 2014

**Зураг 7.2: Монголын нутаг дэвсгэрт жилд ордог нийт хур тундасны хэмжээний өөрчлөлт (1961- 1990) , 1940-2015, mm**



Эх сурвалж: Монголын Уур амьсгалын өөрчлөлтийн хоёрдох үнэлгээний тайлан, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, 2014.

Тэмдэглэл: 48 цаг агаарын станцын дундаж.

## Хүснэгт 7.1: Одоо болон ирээдүйн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн хураангуй


Салбар	Одоогийн нөлөөлөл	Ирээдүйн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ
Бэлчээр, хөрс	<ul style="list-style-type: none"> <li>- Ажиглалтын мэдэгээр сүүлийн 40 жилд бэлчээрийн бүтээгдэхүүн 20-30 хувь буурсан,</li> <li>-Бэлчээрийн 70 орчим хувь ямар нэг байдлаар өөрчлөгдсөн,</li> <li>- Бэлчээрийн өвс ургамлын бүрэлдэхүүн өөрчлөгдөж, экосистемийн бүсүүд өөрчлөгдсөн, ганд тэвчээртэй өвс ургамал зонхилох болсон</li> <li>-хөрсний үржил шим, чанар доройтсон</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>-Экосистемийн үнэлгээний Century загвараар газар дээрхи био масс, бэлчээрийн нийт бүтээгдэхүүн, биомасс одоогийнхоос 10-40 хувиар буурна,</li> <li>-хөрсний органик нүүрстөрөгч 2050 он гэхэд ой болон тал нутагт 6.3-9.5 хувиар буурна.</li> </ul>
Ойн экосистем	<ul style="list-style-type: none"> <li>-Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ 1999-2012 онд 4.1 хувиар буурсан,</li> <li>-Ойн түймрийн давтамж нэмэгдсэн, 1999-2012 онд түймэрт нэрвэгдсэн газрын хэмжээ 13.3 хувиар нэмэгдсэн,</li> <li>-Хуурайшилт, ган ойн биомассын хуримтлалд сөргөөр нөлөөлж, биомассын жилийн хуримтлалын өсөлт удааширсан,</li> <li>-Ойн хортон шавьжны тархалтын талбай нэмэгдэх хандлагатай байна</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>-2050 он гэхэд, ойн хорт шавьжинд өртөх талбан хэмжээ одоогийнхоос 1.4-13 дахин нэмэгдэнэ,</li> <li>-2030 он гэхэд ямар нэг тодорхой арга хэмжээ аваагүй нөхцөлд ойн түймрийн хамрах талбайн хэмжээ 512,000 га-д хүрнэ</li> <li>-Өндөр уул, ой тал бүхий газрын хэмжээ 70-80, 8-41 хувиар тус тус буурна</li> <li>-цэвдэгт хөрс хайлах явц үргэлжилж, өндөр уулын ойн дээд хил уулын орой өөд шилжинэ.</li> </ul>
Усны нөөц, мөсөн гол, цэвдэг	<ul style="list-style-type: none"> <li>-Гадаргын усны горим өөрчлөгдөж, нуурын эзлэх тайлбайн хэмжээ бууран, жижиг нуур, булаг, шанд, зарим гол ширгэж байна,</li> <li>-Сүүлийн 70-аад жилд мөсөн голууд хайлж, хэмжээ 27.8 хувиар буурсан,</li> <li>-мөсөн гол хайлж байгаатай уялдан тэндээс эх авч байгаа голуудын мөсны зузаан 40 орчим см-ээр нэмэгдэж, мөстэй байх хугацаа 10-20 өдрөөр уртасаж, усны температур нь буурч байна,</li> <li>-Голын мөсөн бүрхүүлийн хугацаа 20 өдрөөр уртасаж, зузаан нь 35 см нэмэгдэж, мөсөн голоос эх аваагүй голуудын усны температур 2 градусаар нэмэгдсэн байна</li> <li>-гүний усны түвшин буурах хандлагатай байна</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>-4 сараас 10 сарын хоорондох усны дундаж температур 2080 оны үе гэхэд 3.1-4.2 градусаар нэмэгдэнэ,</li> <li>-Голын усны урсац 2080 оны үе гэхэд 8-13 мм хурдсаж, ууршилт хэд дахин нэмэгдэнэ,</li> <li>-мөсөн голын хайлах үзэгдэл 1982-2010 онтой харьцуулахад 67 хувиар өснө,</li> <li>-Газрын 10 болон 15 м гүний температур нутгийн хойд хэсгийн мөсөн талбай бүхий бүсэд нэмэгдэнэ.</li> </ul>
Байгалийн гамшиг	<ul style="list-style-type: none"> <li>-байгалийн гамшигийн давтамжийг сүүлийн хорин жилийн байдлыг харьцуулж үзвэл, эхний 10 жилд 75 удаа гамшигт үзэгдэл гарч байсан бол дараагийн арван жилд хоёр дахин нэмэгджээ,</li> <li>- хүчтэй аадар бороо, гэнэтийн үер, хүчтэй салхи, цахилгаан, мөндөр зэрэг гамшигт үзэгдэл олонтоо тохиолдох болж, эдийн засагт асар их хохирол учруулах болсон,</li> <li>-Ган, зудын давтамж нэмэгдэж, 2002\2003 оны өвлийн зуд, 2009\2010 оны зудын уршгаар ДНБ 6 хувь буурсан,</li> <li>-Нийт газрын 77.8 хувь доройтол, цөлжилтэд өртсөн байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Агаар мандалд явагддаг аюултай үзэгдэл 2050 он гэхэд өнөөгийн түвшинээс 23-60 хувь өснө,</li> <li>-ган, зудын уршгаас болж малын хорогдол 2050 он гэхэд 9.4 хувиар өсөх ба энэ нь 1981-2000 оныхоос 2.1 хувиар өндөр байна,</li> <li>-Газрын доройтол ба цөлжилт нэмэгдэхийн хэрээр ууршилт өсөж, хур борооны хэмжээ буурна</li> </ul>
Мал аж ахуй	<ul style="list-style-type: none"> <li>-Өнөөгийн байдлаар малын хорогдол жилд 2 хувьтай байгаа нь 1991-2011 оны үеэс 0.25 хувиар нэмэгджээ,</li> <li>-малын амьдын жин буурч байна</li> <li>-бэлчээрийн био массын хэмжээ буурч, хэт халуун өдрийн тоо нэмэгдэж байгаа нь малын бэлчээрлэлтийн нөхцлийг хшндруулж байна.</li> <li>-ямааны ноолуур, хонины ноос хөөрөх хугацаа 5-10 өдрөөр урагшилсан байна</li> <li>-Сүүлийн жилүүдэд малын 26 шинэ өвчин гарч, 8 өвчлөлт дахин гарч, 6 өвчин тархсан гэж бүртгэгджээ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>-ган, зудын нөлөөлөлөөр малын хорогдол 2020 он гэхэд 8.2 хувь, 2050 он гэхэд 9.4 хувь болно.</li> <li>-Өвөл орох цасны хэмжээ 40-50 хувиар нэмэгдэх нь бэлчээрийн хүрэлцээ хомсдож, малын жинд сөрөг нөлөөлнө</li> <li>-Малын жин буурсантай уялдан нийт мах бэлгэл 2050 он гэхэд 5.4 хувиар буурна</li> <li>-жижиг нуур болон шандууд ширгэж, хуурайшилт хүчтэй нэмэгдсэнээр бэлчээрийн усан хангамж хүндэрнэ.</li> </ul>
Газар тариалан	<ul style="list-style-type: none"> <li>- Хэт халалт (26°C –аас давсан) үр тарианы ургалтын явцад нөлөөлж ургац буурахад хүргэж байна.</li> <li>-Сүүлийн 70 жилд тариалангийн талбайн хуурайшилт эрчимтэй явагдаж байна. Талбайн 1 м гүний чийгийн хэмжээ ойролцоогоор 30 хувь буураад байна</li> <li>- хөрсний дулаан хангалт нэмэгдэж байгаа ч хуурайшилд нөлөөлж, ургац буурч байна</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>-DSSAT загвараар хийсэн судалгаагаар нэг га-гаас авах үр тарианы ургац 2030 он гэхэд 13 хувиар буурна</li> </ul>
Эрүүл мэнд	<ul style="list-style-type: none"> <li>-Зүрх судасны өвчин сүүлийн 31 жилд өсөж байна. \ Бумаажав, 2010\</li> <li>-30°C-аас давсан халуун өдрийн тоо нэмэгдсэнээр Улаанбаатарт зүрх судасны өвчин нэмэгдсээр байна</li> <li>-Байгалийн гамшигт нэрвэгдэх иргэдийн тоо өсөх хандлагатай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>-Халуун салхи, хэт халалт үргэлжлэх нь зүрх судасны өвчин үргэлжлэн өсөхөд нөлөөлнө</li> <li>-халдвар дамжуулагч бактериуд нэмэгдсэнээр халдарт өвчний өвчлөл өснө</li> </ul>



Дэд бүтэц	Сүүлийн 20 жилд цаг агаарын онцгой байдал, гамшигт үзэгдлийн давтамж өсөж, тэдгээрийн хамрах хүрээ ихээхэн нэмэгдэж байна	Хүчтэй бороо, үер зам, гүүр болон байшин, барилгыг эвдэн, ашиглалтын хугацааг богинсгоно -Их цас болон хөлдөлтийн улмаас цахилгаан дамжуулах шугамын эвдрэл нэмэгдэнэ -Усны горим өөрчлөгдсөнөөр үерийн хамгаалалт, усан байгууламжуудийн хэвийн ажиллагаа алдагдана
-----------	---	--

Эх сурвалж: Монголын Үндэсний зорилтот хувь нэмэрэ баримт бичиг, INDC, 2015.

**Зураг 7.3: Нэг хүнд ноогдох нүүрсхүчлийн хийн ялгарал, 1960-2014, сая тонн**



Эх сурвалж: Дэлхийн банк, 2017.

#### Хүлэмжийн хийн ялгарал эдийн засгийн салбараар

БОАЖЯ-наас 2017 онд бэлтгэсэн Хүлэмжийн хийн ялгарал (ХХЯ)-ийн инвенторийн дүнгээс харвал (Хүснэгт 7.2, Зураг 7.4), Монгол улсын ХХЯ-ийн нийт хэмжээ 2014 онд 34,530.08 Гг CO<sub>2</sub>-экв. байгаа нь 2013 онтой харьцуулахад 1990 оноос хойш 57.07 хувиар, харин 2013 онтой харьцуулахад 5.49 хувиар өссөн байна. 2013-2014 оны хооронд эрчим хүчний салбараас (2.78 хувиар буурсан) бусад салбарт ХХ-ийн ялгарал (үйлдвэрлэлийн явц, бүтээгдэхүүний хэрэглээ 37.74 хувиар, хөдөө аж ахуйн салбар 15.05 хувиар, хог хаягдал 6.25 хувиар) өссөн байна. Газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлт, ойн (ГАГАӨӨ) салбарт 2014 онд -24,451.93 Гг CO<sub>2</sub>-экв. шингэсэн нь 1990 оноос хойш 6.2 хувь өссөн үзүүлэлт болж байна.

**Хүснэгт 7.2: ХХ-н ялгарал, салбараар, 1990, 2013, 2014, Гг CO<sub>2</sub>- экв**

Салбар	1990	2013	2014	1990-2014 оны өөрчлөлт (%)
Эрчим хүч	11,091.14	17,762.10	17,267.79	55.69
Үйлдвэрлэл	218.66	238.20	328.06	50.03
Хөдөө аж ахуй	10,585.30	14,538.80	16,726.98	58.02
Хог хаягдал	88.40	195.10	207.26	134.44
<b>Нийт (ГАГАӨӨ-г тооцоогүй)</b>	<b>21,283.51</b>	<b>-24,547.70</b>	<b>34,530.08</b>	<b>57.07</b>
ГАГАӨӨ	-23,024.18	8,186.60	-24,451.93	6.2
<b>Нийт (ГАГАӨӨ-г тооцсон)</b>	<b>-1,040.67</b>	<b>32,734.20</b>	<b>10,078.15</b>	<b>-1,067.85</b>


Эх сурвалж: Хүлэмжийн хийн ялгаралын тооллого, БОАЖЯ, 2017.

Хамгийн их хүлэмжийн хий ялгаруулж байгаа салбар нь эрчим хүчний салбар (нийт ялгаралын 50 хувь, 2014) (Зураг 7.5), байгаа бөгөөд дийлэнхи нь эрчим хүчний үйлдвэрлэлийн дэд салбараас ялгарч байна (эрчим хүчний салбарын нийт ялгаралын 55.87 хувь). Эрчим хүчний салбарын 2014 оны нийт ялгарал 1990-2014 оны хооронд 55.69 хувиар, харин 2013 онтой харьцуулахад 2.78 хувиар буурсан байна. Эрчим хүчний салбарын ялгаралын хэлбэлзэл нь эдийн засгийн хандлага, эрчим хүч хангамжийн бүтэц, уур амьсгалын нөхцөлөөс хамаарч байгаа бөгөөд ХХ-ийн ялгаралыг нэмэгдүүлж байгаа гол хүчин зүйл

нь эрчим хүчний эрэлт хэрэгцээ, Монголын цахилгаан, дулааны үйлдвэрлэл чулуун нүүрснээс өндөр хамааралтай байгаатай холбоотой байна.


Эрчим хүчний үйлдвэрлэл нь чулуун нүүрсээр галладаг цахилгаан, дулааны станцуудад тулгуурлаж, Монголын удаан хугацаанд үргэлжлэх хүйтэн өвлийн нөхцөлд цахилгаан, халуун ус болон дулаан үйлдвэрлэж байна. Цахилгаан эрчим хүчний 90 орчим хувийг ДЦС-ууд үйлдвэрлэж байна. Одоогийн байдлаар 150кВ-аас 12.0 кВ хүчин чадалтай 13 усан цахилгаан станц ажиллаж байна. Түүнчлэн, цахилгаан ба дулааныг төвийн эрчим хүчний сүлжээнд холбогдоогүй дизель генераторууд, бие даасан нарны PV систем, бага хэмжээний нар-салхины хосолсон станцууд, мөн дулааны станцууд ажиллаж байна.

**Зураг 7.4: Хүлэмжийн хийн нийт ялгарал, шингээлт, салбараар, 1990-2014, 1990=100**



Эх үүсвэр: Хүлэмжийн хийн ялгаралын тооллого, БОАЖЯ, 2017.

**Зураг 7.5: Хүлэмжийн хийн ялгарал, салбараар, 2014, Gg CO<sub>2</sub>- экв**



Эх сурвалж: Хүлэмжийн хийн ялгаралын тооллого, БОАЖЯ, 2017.

Орон сууц болон үйлчилгээний салбарт эрчим хүч хэмнэлтийн түвшин доогуур байна. ХХЯ-ыг бууруулах тэргүүлэх чиглэл нь эрчим хүчний хэмнэлтийг сайжруулах болон нүүрсийг эрчим хүчний цэвэр эх үүсвэрээр солих явдал гэж тодорхойлсон байна.

Улаанбаатар хотын төвийн хэсэг болон дүүрэг, хороодод эрчим хүчний хэмнэлттэй аргаар тоногдсон барилга тун цөөн байгаа ба эрчим хүчнийг халаалтанд их хэрэглэж байгаа нь ашиглаж байгаа технологи болон хүмүүсийн дадал заншил, ухамсартай холбоотой байна. Аймгийн төвүүдийн улсын албан байгууллагуудын барилгуудад хэрэглэж байгаа дулаанаар хангах уурын зуухнуудын хувьд эрчим хүчний хэмнэлт маш доогуур байна. Суурьшлын бүсүүд болон хөдөөд нүүрс, мод хатаасан аргалыг халаалтын зорилгоор зууханд галлан хэрэглэж байна.

Хөдөө аж ахуйн салбар нь ХХ ялгаралын хоёрдахь том эх үүсвэр болж, 2014 онд ХХ ялгаралын 48.44 хувийг гаргасан байна. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөөр байгаа нь ялгаралыг нэмэгдэхэд хүргэж байгаа бөгөөд 1990-2014 онд ялгарал 58.02 хувиар өссөн буюу 2013 онтой харьцуулахад 15.05 хувиар өссөн байна.

Үйлдвэрлэлийн явц ба бүтээгдэхүүний хэрэглээний салбар 2014 онд ялгаралын 0.95 хувийг эзлэж, 1990 оноос хойш 50.03 хувиар өссөн байна. Тус салбарын ялгарал 2013 онтой (31.73 хувь) харьцуулахад хамгийн хурдацтай өсөж байгаагаас ашигт малтмалын үйлдвэрлэл \цемент, шохойн үйлдвэрлэл\ энэ салбарын ялгаралын 68.86 хувийг 2014 онд эзлэж, барилгын салбарын эрэлт хэрэгцээ нэмэгдсэнтэй холбоотой.

Хэдийгээр хог хаягдлын салбар 2014 онд ний ХХЯ-ын 0.34 хувийг эзлэж байсан ч энэ салбарын ялгарал 1990 оноос хойш (134.44 хувь), хамгийн хурдацтай өсөн, ХХ-ийн ялгаралын нэг эх үүсвэр болж, 2013 онтой харьцуулахад 6.25 хувиар өссөн нь сүүлийн арваад жилийн эдийн засгийн өсөлт, хот суурин газрын хүн ам өсөн нэмэгдэж байгаатай холбоотой юм.

ХХ-ийн 2017 оны ялгаралын тооллогоор, ГАГАӨО-н салбар 2014 онд 24,451.93 Gg CO<sub>2</sub>-экв. шингээж байсан нь 2013 онтой харьцуулахад 0,39 хувиар буурсан ч 1990-2014 оны хооронд 6.20 өссөн байна.

ХХ-ийн 2017 оны инвенторын тооцоогоор, (Хүснэгт 7.3) 2014 онд ХХ-ын нийт ялгаралын 46.46 хувийг нүүрсхүчлийн хий- CO<sub>2</sub> эзэлж байсан байна. 1990-2014 онд CO<sub>2</sub>-ийн нийт ялгарал 56 хувиар нэмэгдсэн нь эрчим хүчний салбарын ялгарал нэмэгдсэнтэй (81.92 хувь) холбоотой байна. Монголд CO<sub>2</sub> ялгарал өсөн нэмэгдэж байгаа нь нүүрсний шаталттай холбоотой бөгөөд үүний дараа аж үйлдвэрлэл болон барилгын салбар орж байна. Харин энэ хоёр салбарын CO<sub>2</sub> ялгарал 1990-2004 онд 8.65 хувиар буурчээ.

### Хүснэгт 7.3: Үндсэн хүлэмжийн хийнүүдийн ялгаралт, 1990, 2014, Gg CO<sub>2</sub>-экв

Үндсэн хүлэмжийн хийнүүд	1990 онтой харьцуулсан өөрчлөлт (%)		
	1990	2014	
CO <sub>2</sub>	10,927.61	16,004.13	646.46
CH <sub>4</sub>	6,905.40	11,388.9	64.93
N <sub>2</sub> O	4,150.49	7,040.58	69.63
HFCs	...	96.43	...
<b>Нийт</b>	<b>21,983.51</b>	<b>34,530.08</b>	<b>57.07</b>

Эх сурвалж: Хүлэмжийн хийн ялгаралын тооллого, БОАЖЯ, 2017.

Метан (CH<sub>4</sub>) хий нь ялгаралын хоёрдахь эх үүсвэр болж, 2014 оны ялгаралын 32.89 хувийг эзлэж байна. Энэ нь гол нь хөдөө аж ахуй болон мал аж ахуйгаас, мөн хатуу хог хаягдлын цэгүүдээс үүдэлтэй байна. Метаны ялгарал 1990-2014 он хооронд 64.93 хувиар нэмэгджээ.

Хөдөө аж ахуйн үйл ажиллагаа N<sub>2</sub>O-ийн ялгаралд ихээхэн нөлөөлж, 2014 онд ялгаралын 20.42 хувь байсан нь 1990 онтой харьцуулахад 69.63 хувиар өссөн байна. Ус-фторт нүүрстөрөч (HFCs) –ийн хувьд үүнтэй холбогдсон мэдээлэл зөвхөн 2012 оноос хойш байгаа бөгөөд 2014 онд 0.28 хувийн өсөлттэй байсан байна.

Шууд бус хүлэмжийн хийн ялгарал 1990 оноос хойш буурч, NO<sub>x</sub>-ийн хувьд 97.75 хувь, нүүрс төрөгчийн хий 97.58 хувиар буурсан байна (Хүснэгт 7.4).

**Хүснэгт 7.4: Шууд бус хүлэмжийн хийнүүдийн ялгаралт, 1990, 2014, Gg CO<sub>2</sub>-экв.**

Үндсэн хүлэмжийн хийнүүд	1990 оной харьцуулсан өөрчлөлт (%)	
	1990	2014
NOx	1.78	0.04
CO	63.63	1.54

Эх сурвалж: Хүлэмжийн хийн ялгаралын тооллого, БОАЖЯ, 2017.

2013 оны тооцоогоор, өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэглээ болон бусад хэд хэдэн салбарын хэрэглээтэй уялдан ХХ-ийн ялгарал аажмаар нэмэгдэх төлөвтэй байна. Цаашдын өөрчлөлтийн хандлага, 2020 он гэхэд ХХ-ийн ялгарал 2006 оны түвшингээс 2.1 хувиар, 2030 он гэхэд 3.2 хувиар нэмэгдэх төлөвтэй байна. Эрчим хүч, хөдөө аж ахуй, хог хаягдлын салбараас үүдэлтэй ялгарал өсөн нэмэгдэх төлөвтэй байгаагийн зэрэгцээ ГАГАӨО–н шингээлт буурч болзошгүй байна.

*Хууль эрх зүйн тогтолцоо*

УАӨСК-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин нь олон тооны хууль тогтоомжоос бүрдэж байна. Тухайлбал, 2001 оны Эрчим хүчний тухай хууль, 2007 оны Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль болон 2015 оны нэмэлт өөрчлөлт оруулсан хууль, 2015 оны Эрчим хүч хэмнэх тухай хууль болон 2012 оны Агаарын тухай хууль байна.

Монгол улсын Ерөнхийлөгч 2014 оны 9 дүгээр сард уур амьсгалын өөрчлөлтийн талаар 121 тоот зарлиг гаргажээ. Уг зарлиг Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт болон уур амьсгалын өөрчлөлтэй холбогдох бусад бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилго агуулсан байна. Зарлиг нь дасан зохицох арга хэмжээ, цэвэр эрчим хүчний технологи нэвтрүүлэх, байгалийн нөөц баялагын үр өгөөжтэй ашиглах, сэргээгдэх эрчим хүч, олон улсын яриа хэлэлцээнд оролцох, олон улсын санхүүгийн механизмд оролцох зэрэг асуудлыг хөндсөн байна.

Монгол улсын Засгийн газар 2010 оны 8 дугаар сард хөдөө орон нутаг, говь цөлд тусгай хуралдааныг хийж, уур амьсгалын өөрчлөлт Монголд хэрхэн нөлөөлж байгаа, ялангуяа эрчимтэй явагдаж байгаа цөлжилт, гамшигт үзэгдэл Монголын уламжлалт амьжиргаанд үзүүлж байгаа нөлөөлөл зэргийг тусгасан Тунхаглалыг гаргасан байна. Тунхаглалаар дамжуулан, Монгол улсын Засгийн газар хөгжиж байгаа далайд гарцгүй, эмзэг, цөлжилтэд хурдацтай өртөж байгаа байдалд УАӨСК-д оролцогч талуудын бага хурлыг анхаарлыг хандуулж, уур амьсгалд ээлтэй технологи нэвтрүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зохих арга хэмжээ авах, хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах уян хатан бодлого, шийдвэр батлахыг уриалсан байна. Үүний дараа Канкунд болсон УАӨСК-д оролцогч талуудын бага хурлаас Уур амьсгалын ногоон Сан байгуулах шийдвэр гаргаж, Канкуны Дасан зохицох асуудлаар бичиг баримт баталсан байна.

*Бодлогын тогтолцоо*Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний Хөтөлбөр

Уур амьсгалын үйл ажиллагааны үндэсний анхны хөтөлбөрийг 2000 онд Парламент баталж, дараа нь уг хөтөлбөрийг 2011 онд шинэчилэн баталсан (Парламентийн 2011 оны 2 дугаар тогтоол) байна. Уг хөтөлбөрийг 2021 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн эхний шатанд хэрэгжүүлэх төлөвлөгөөг Засгийн газар (2011 оны Засгийн газрын тогтоол №317) баталж, 2011-2016 онд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлжээ.

УАӨСК-ийг Монголд хэрэгжүүлэх Үндэсний одоогийн хөтөлбөрт стратегийн дараах гурван зорилт дэвшүүлсэн байна:

- Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай эрх зүй, бүтэц зохион байгуулалтын орчныг бүрдүүлэх;
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхийг бэхжүүлэх замаар байгаль орчны тогтвортой байдлыг хангах, нийгэм эдийн засгийн эмзэг байдал, эрсдлийг бууруулах;
- Байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх, эрчим хүчний үр өгөөж, үр дүнг сайжруулах замаар хүлэмжийн хийн ялгаралыг бууруулж, бага нүүрстөрөгчтэй эдийн засагтай болох.

Үндэсний хөтөлбөрт Монгол улсын эдийн засгийн гол салбаруудад хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах болон дасан зохицох арга хэмжээнүүдийг тусгасан байна. Төлөвлөгөөний дагуу, эхний шатанд эрх зүй, бүтэц зохион байгуулалтын орчинг бүрдүүлж, чадавхийг нь бэхжүүлэх зорилт дэвшүүлжээ. Хөтөлбөрийн хоёрдугаар шатанд (2017-2021) дасан зохицох болон ХХ-ийн ялгаралтыг бууруулах бодит үйл ажиллагаа явуулахаар тусгажээ.

Эхний шатны төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийсэн байна. Эхний шатанд хэрэгжүүлсэн гол арга хэмжээнүүдэд: уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг аймгуудын түвшинд хэрэгжүүлж, хэд хэдэн аймаг уур амьсгалын үйл ажиллагааны орон нутгийн төлөвлөгөө боловсруулсан; Гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталсан; 2015 оны Эрчим хүчний тухай хуулийн нэмэлт өөрчлөлт ба Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль; Гол мөрний сав газарт гамшгийн эрсдлийг бууруулах Экосистемд суурилсан Дасан зохицох үйл ажиллагааны төлөвлөгөө; ойжуулах, ойн нөхөн сэргээлтийг өргөжүүлэх үйл ажиллагаа; ойн тооллого явуулах; уур амьсгалын өөрчлөлтийн Монголын хоёрдугаар үнэлгээний тайланг бэлтгэх асуудлууд орж байна.

Хөтөлбөрийн хоёрдугаар шатанд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2017 оны дунд үе гэхэд, боловсруулан эдгээр үйл ажиллагааг Монгол улсын Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд оруулах Үндэсний зорилтот хувь нэмэр баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай хэрхэн уялдуулах, нийцүүлэх асуудлыг авч үзэж байна.

#### Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд оруулах Үндэсний зорилтот хувь нэмэр (ҮЗХН -INDC)

Монгол улс Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд оруулах Үндэсний зорилтот хувь нэмэр (ҮЗХН -INDC) –ийн баримт бичгээ 2015 оны 9 дүгээр сарын 24-нд конвенцийн газарт хүлээлгэн өгсөнөөр энэхүү баримт бичиг нь Монгол улсын зүгээс үүрэг хүлээн хувь нэмрээ оруулах анхны алхам болсон юм. Энэхүү баримт бичигт ХХЯ-г бууруулах талаар хүлээх үүргээс гадна дасан зохицох арга хэмжээний асуудлыг мөн тусгажээ. Уг баримт бичгийг Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал хариуцсан Тусгай элчийн зохицуулалт доор Байгаль орчин ногоон хөгжлийн яамны Байгаль орчин уур амьсгалын сангийн дэргэдэх Уур амьсгалын өөрчлөлтийн төсөл хэрэгжүүлэгч нэгж, Даян дэлхийн байгаль хамгаалах сан, НҮББОХ, Германы техникийн хамтын ажиллагааны газрын санхүүгийн тусламжтайгаар гүйцэтгэсэн байна. Баримт бичиг боловсруулах түр ажлын хэсэг байгуулж, техникийн түвшинд холбогдох салбарын яамдын төлөөлөлийг татан оролцуулжээ. Техникийн ажлаас гадна Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын зөвлөл дээр иргэний нийгмийн төлөөлөлийг оролцуулан баримт бичгийг хэлэлцсэн байна.

Үндэсний зорилтот хувь нэмэр (INDC)-д заасны дагуу, 2030 он гэхэд ХХ-ийн нийт ялгаралыг бууруулах дэлхийн хүчин чармайлтад Монгол улс хувь нэмэр оруулахын тулд Хүснэгт 7.5-д тодорхойлсон эрчим хүч, үйлдвэр, хөдөө аж ахуй, тээврийн салбарт олон улсын дэмжлэг, дотоодын хүчин чармайлтаар ХХЯ-ийг бууруулахад чиглэсэн үндэсний хэмжээний бодлогын болон бусад практик арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр заасан байна (Хүснэгт 7.5-д бодлого, арга хэмжээг үзүүлэв).

Үндэсний зорилтот хувь нэмэр баримт бичигт мөн эрчим хүч, тээвэр, хөдөө аж ахуй, хог хаягдал, аж үйлдвэрийн салбарт ХХЯ-г бууруулах нэмэлт арга хэмжээ авахаар заажээ.

Тодорхойлсон нийт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэнээр 2030 он гэхэд нийт хүлэмжийн хийн ялгаралтыг ГАГАӨО-ын салбарыг тооцолгүйгээр 7.3 сая тонн CO<sub>2</sub>-экв. буюу 14 хувиар бууруулах үүрэг хүлээхээр заажээ (Хүснэгт 7.6).

ҮЗХН-г заасан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах нь 2010 оны Үндэсний хоёрдугаар илтгэлд тодорхойлсон ХХ-ийн ялгаралын ирээдүйн хандлагын төсөөлөлд суурилсан байна. Харин хөдөө аж ахуйн салбарын ялгаралын бууралтыг шаардлагатай мэдээлэл байхгүй тул тооцож ҮЗХН-д тусгаагүй байна.

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудал Монголд ихээхэн хамааралтайг харгалзан дасан зохицох асуудалд зориулсан нэмэлт хэсгийг ҮЗХН-д оруулсан байна. Энэ хэсэгт уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлийг даван туулах, дасан зохицох чадавхийг бэхжүүлэх, экосистем болон нийгэм-эдийн засгийн салбарын тэсвэрлэх байдлыг бэхжүүлэх алсын харааг тусгажээ. Дасан зохицох зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжүүлэлт, чадавхи, технологийн хэрэгцээ шаардлагыг мөн хамтад нь тодорхойлсон байна.



## Хүснэгт 7.5: ҮЗХН баримт бичигт тодорхойлсон ХХЯ-г бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүд

Салбар	Арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хөрөнгө оруулалтын хэрэгцээ (сая ам.доллар)	Бодлогын баримт бичиг
Эрчим хүч (цахилгаан, дулаан)	Нийт эрчим хүчний үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 2014 онд 7.62 хувь байсан хэмжээнээс 2020 он гэхэд 20 хувь, 2030 оны үе гэхэд 30 хувиар нэмэгдүүлнэ.	675 MW хүчин чадал бүхий том хэмжээний УЦС байгуулах	1,350	Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлого, 2015 Ногоон хөгжлийн бодлого, 2014
		354 MW хүчин чадал бүхий СЦС байгуулах	584	
		145 MW хүчин чадал бүхий НЦС байгуулах	573	
	Эрчим хүчний дамжуулалтын алдагдал 2014 онд 13.7% байсныг 2020 онд 10.8%, 2030 оны үед 7.8% болгон бууруулах			
	Барилгын дулаан алдагдалтыг 2014 оны түвшинтэй харьцуулбал 2020 оны үед 20%, 2030 үед 40% -иар бууруулна.	УБ хотын өнөөгийн 18,184 айлын угсармал орон сууцны дулаан хадгалах байдлыг сайжруулна.	90	
	ДЦС-уудын үйл ажиллагааг сайжруулах замаар тэдгээрийн цахилгааны дотоод хэрэглээг 2014 онд 14.4% байсныг 2020 оны үед 11.2%, 2030 оны үед 9.4% болгож бууруулна.	Нүүрсээр ажилладаг станцуудын үр өгөөжийг сайжруулах	900	
Нүүрсийг өндөр даралтаар шатаах зэрэг дэвшилтэт технологийг 2030 оны үе гэхэд эрчим хүчний үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.				
Эрчим хүч (Тээвэр)	Хатуу хучилттай замын сүлжээг өртгөтгөж 2016 онд 8000 км байсныг 2021 оны үед 11000 км-т хүргэнэ.			УАӨҮХ, 2011, Нийтийн тээврийн хэрэгслийн хөрөнгө оруулалтынн хөтөлбөр, 2015, Үндэсний хувьд ашигтай ХХЯ-ыг бууруулах арга хэмжээ (NAMA), 2010, Дунд хугацааны хөгжлийн шинэ хөтөлбөр, 2010
	УБ хотын замын сүлжээг сайжруулж, замын түгжрэлийг 2023 оны үе гэхэд 30-40 хувиар бууруулна.			
	Гибрид хөдөлгүүртэй хувийн тээврийн хэрэгслийн эзлэх хувь 2014 онд 6.3% байсныг 2030 оны үед 13% -д хүргэж нэмэгдүүлнэ.			
	УБ хот болон аймгийн төвүүд татварын болон БО-ны төлбөрийн системийг сайжруулж, автомашиныг шингэн түлшнээс LPG түлшинд шилжүүлэх			
	Тээврийн хэрэгслийн стандартыг мөрдөх механизмийг хэрэгжүүлэх			

Үйлдвэр	Үйлдвэрийн технологийг шинэчлэх, шинэ үйлдвэрт хуурай технологи нэвтрүүлж цементийн үйлдвэрлэлийн ХХЯ-г бууруулна.			УАӨҮХ, 2011, Үндэсний хувьд ашигтай ХХЯ-ыг бууруулах арга хэмжээ (NAMA), 2010, Барилгын материалын хөтөлбөр, 2012 (ЗГ-ын 2012 оны Тогтоол 171)
Хөдөө аж ахуй	Бэлчээрийн даацтай уялдуулан мал тоо толгойг зохицуулах			Монгол мал үндэсний хөтөлбөр, 2010

Эх үүсвэр: Монгол улсын ҮЗХН, 2015.

### Хүснэгт 7.6: Хүлэмжийн хийн ялгаралын хэвийн нөхцөлтэй харьцуулсан бууралт, са тонн CO<sub>2</sub>-экв.

Салбар	2015	2020	2025	2030
Эрчим хүч (цахилгаан, дулаан)	0.04	1.150	2.59	4.88
Эрчим хүч - Тээвэр	0	0.297	0.97	1.76
Үйлдвэр				0.7
<b>Нийт</b>				<b>7.34</b>

Эх сурвалж: INDC, Монгол, 2015.

ҮЗХН-д тооцоолсоноор, хөдөө аж ахуй, ойн, усны нөөцийн салбаруудад дасан зохицох бодлого, арга хэмжээг хэрэгжүүлсэн, экосистемийн нүүрстөрөгчийн шингээх чадавхийг бэхжүүлсэнээр Монгол улсын хэмжээгээр эрчим хүчний салбараас ялгарч байгаа ХХ-ийн ялгаралын бараг тэн хагасыг шингээж чадах юм (Хүснэгт 7.7).

ҮЗХН-ийн ХХЯ-г бууруулах хэсэгт заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалтын урьдчилсан тооцоогоор 3.5 тэрбум доллар шаардагдана гэж үзжээ. Дасан зохицох болон технологи, чадавхийг бэхжүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд 3.4 тэрбум долларын хөрөнгө шаардлагатай байгаа тооцоо гаргажээ. Монгол улс тэдгээр арга хэмжээнүүдийн ихэнхийг олон улсын болон хандивлагч түнш байгууллагуудын эх үүсвэрээр санхүүжүүлэх төлөвлөгөөтэй байна. Тухайлбал: Уур амьсгалын ногоон сан, хамтарсан кредит олгох механизм, улсын төсөв болон Засгийн газрын бусад тусгай сангаас эх үүсвэрийг олохоор төлөвлөж байна.

Хэдийгээр Монгол улс олон улсын санхүү, техникийн тусламжийн механизмтай сайн харилцаатай явж ирсэн ч олон улсын санхүүжилтээс хэт хамааралтай байдлаас гарах, улсын төсвөөс санхүүжилтийн тодорхой хэсгийг гаргадаг болох талаар хүчин чармайлт гаргахгүй байна.

Монгол улсын ҮЗХН баримт бичиг нь “бодлого ба арга хэмжээ” гэсэн арга барилд суурилсан нь салбаруудын шаардлагатай мэдээлэл хомс, хөгжлийн нөхцөл байдал тодорхойгүй, зарим нэг тоон үзүүлэлттэй зорилтуудын хувьд ихээхэн эрсдэлтэй байгаатай холбоотой юм. Монгол улс ҮЗХН-д дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжих боломжтой гэж үзэж байна. Учир нь энэхүү баримт бичиг нь 2014 оны Ногоон хөгжлийн бодлогын улс төрийн эрмэлзэлд суурилсан бөгөөд уур амьсгалын үйл ажиллагааг бусад салбарын бодлогуудтай нийцүүлэн нэгтгэх замаар хүлээсэн үүргээ биелүүлэх боломжтой юм. Эхлээд ХХ ялгаралыг бууруулах зорилтыг нэлээд өндөр, дэврүүн авч үзэж байсан боловч илүү бодитоор авч үзэх аргыг сонгон авсан нь ҮЗХН олон улсын яриа хэлэлцээнээс ямар үр дүн гарах нь тодорхойгүй байсантай холбоотой. Сонгон авсан зорилтын түвшингийн талаар оролцогч талуудын санал нэг байгаагүй, зарим нь хувь хэмжээг өсгөхийн төлөө байхад зарим нь ХХ ялгаралыг 14 хувиар бууруулах чадвар байгаа эсэхэд эргэлзэж байсан.

ҮЗХН –ийн хэрэгжилтэд хийх мониторингийг дэвшүүлсэн зорилтуудын нэгдмэл байдлыг хэрхэн хангасан байдалд үнэлгээ хийх замаар хийх төлөвлөгөөтэй байна. Одоогийн байдлаар нэгдмэл мониторингийн механизм, бүтцийг харахан тогтоогүй байна. Хэрэгжүүлэх замын зураглалыг бэлтгэж

байгаа ба уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөрийн хоёрдугаар үе шатанд эцэслэн цэгцлэх төлөвлөгөөтэй байна. Төлөвлөж байгаа арга хэмжээнүүд нь одоогийн хүчин төгөлдөр байгаа хууль тогтоомжуудад болон хөгжлийн стратеги, салбаруудын төлөвлөгөөнд тусгагдсан учир салбар бүр бодлогын хүрээнд хүлээсэн үүрэг хариуцлагын дагуу хэрэгжүүлэх болно. Хэдийгээр шаардлагатай оролцоог нааштай хангаж чадах боловч хяналтын нэгдсэн журам шаардлагатай байгаа бөгөөд нэгэнт салбарын яамдад уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг гардан хариуцдаг нэгж, хүн байхгүй байгааг анхааралдаа авах нь зүйтэй юм. Ялангуяа Парисын хэлэлцээрийн заалтын дагуу тайлан илтгэл бэлтгэх болон зорилтуудыг тогтмол эргэн харж байх үүрэг хүлээж байгаа нөхцөлд мониторингийн дагаж мөрдөх нэгдсэн журамтай байх нь зохистой юм. 2017 оны 6 дугаар сард, энэ асуудлаар дэмжлэг хүссэн төслийн үзэл баримтлалыг Уур амьсгалын ногоон сан баталсанаар Монгол улс Парисын хэлэлцээрийн дагуу байгуулсан Чадавхи бэхжүүлэх ил тод байдлын санаачилгад хандах эхний орнуудын нэг болж байна.

### Хүснэгт 7.7: ҮЗХН баримт бичигт тодорхойлсон Дасан зохицох шаардлага, зорилт

Салбар	Дасан зохицох зорилго	Дасан зохицох зорилт	Чадавхи бэхжүүлэх шаардлага	Технологийн шаардлага	Санхүүгийн шаардлага (сая доллар)
Мал аж ахуй, бэлчээр	Тогтвортой бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх	--бэлчээрийн доройтлын хувь хэмжээг бууруулах -зэрлэг амьтаныг оролцуулан малын тоо толгойг бэлчээрийн даацтай нийцүүлэн зохицуулах	Бэлчээр ашиглалтын зохицуулалттай болох -бэлчээр ашиглалтын татвартай болох -бэлчээрийг зохистой ашиглах, хяналт тавих, хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	- малын хорогдлоос сэрэмжүүлэх үүднээс ган, зудын эрт сэрэмжлүүлэх системийг байгуулах -малын чанар, үүлдэр угсааг сайжруулах -малын эрүүл мэндийн менежментийг сайжруулах \ гоц халдварт болон халдварт өвчин\	46
Газар тариалан	Тариалангийн талбайг өргөжүүлэх, хөрсний усны алдагдлыг бууруулах, хөрсний нүүрстөрөгчийн ялгаралыг бууруулах	-хоосон уриншийг 30 хувиар бууруулах -сэлгээн тариалах системийг нэвтрүүлэх (3-5 таримлаар 3-4 удаа) -усалгаатай талбайг 2-2.5 дахин нэмэгдүүлэх	-хөрснийг хамгаалах зохицуулалтыг бий болгох \хөрсний бүтэц, шим, чийлэг\	-газрыг хагалахгүй тариалах технологийг түгээх -олон янзын үр тариаг сэлгүүлэн тариалах - усны хэрэглээг 2-2.5 дахин бууруулах усыг дулаар цацах үр ашигтай усалтын хэлбэрийг нэвтрүүлэх	150
Усны нөөц	Усны хангамж нөөцийг хадгалахын тулд салаа урсацууд, тэдгээрийн голын экосистемийг хамгаалах	2030 он гэхэд газар нутгийн 30 хувийг тусгай хамгаалалтад хамруулах ба тогтвортой санхүүгийн механизм нэвтрүүлэх	Усны нөөцийн нэгдсэн менежментийн систем нэвтрүүлэх -эрх зүй, бодлогын арга хэмжээ, үр дүнтэй менежментийг хэрэгжүүлэх замаар олон талт оролцлгч талуудын харицааг уялдуулан зохицуулах -техникийн асуудлуудыг хариуцах хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх	Экосистемд суурилсан технологийг нэвтрүүлэх -гидрологийн мониторинг, үер болдог газруудын усыг ширгэж байгаа нууруудад усны урсацыг өөрчлөн хүргүүлэх ба дахин ойжуулах замаар экосистемийн үйлчилгээг дэмжих	5
	-Мөсөн голын хайлсан ус хуримтлуулах сан байгуулж, тариаланд ашиглах -гол, горхины урсацыг зохицуулах	-Усан сангуудыг гол болон нууруудад байгуулах, усыг олон зориулалтаар ашиглах систем барих	-голын урсацыг зохицуулах гидрологийн хяналт, судалгаа шинжилгээний ажлыг өргөжүүлэх -усан сан барих, хуурай бүсүүдэд усны нөөцийг нэмэгдүүлэх усны урсацыг өөрчлөх байгууламж барих		1,800
	Ус хэмнэх болон усыг цэвэршүүлэн дахин ашиглах технологийг нэвтрүүлэх	Улаанбаатар хотын тогтвортой усны хамгамжийн шийдлийг олох ба Говийн үйлдвэр, уурхайн усны хангамжийг шийдэх	- судалгаа явуулж усны тогтвортой хангамжийг хангах үүднээс ус ууршилтаас сэргийлэх битүү системтэй болох	Ус хэмнэх болон цэвэршүүлэх шинэ технологийг нэвтрүүлэх	605

Ойн нөөц	Сэргээн ойжуулах ажлын үр дүнг сайжруулах	2030 он гэхэд ойгоор бүрхмэл талбайн хэмжээг сэргээн ойжуулах замаар 9 хувиар нэмэгдүүлэх	-мод тарих, үрслүүлэх шинэ технологийг нэвтэрүүлж ойн бүлгүүдийн чадавхийг бэхжүүлэх	-үр суулгах технологийг нэвтэрүүлэх	11
	-ойн доройтлын хувь хэмжээг бууруулах	Хүний нөлөөлөл, түймэр, шавьж, өвчний улмаас учирч байгаа ойн доройтолыг бууруулах	-ойн түмэр, хортон шавьжтай тэмцэх бүрэн тоноглогдсон станцуудыг байгуулах, чадавхийг бэхжүүлэх	-ойн түмэртэй тэмцэхэд нисэх онгоцыг ашиглах -хортон шавьжтай тэмцэх биологийн технологийг нэвтэрүүлэх	13
	-ойн менежментийн үр дүнг сайжруулах	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, өндөр бүтээмжтэй, зохих бүтэц, бүрэлдэхүүнтэй ойтой болох	-Ой цэвэрлэх төнөг төхөөрөмж, машинуудаар хангах -ойн менежментийн практик ажиллагааны сургалтыг зохион байгуулах	Ой цэвэрлэх технологийн үр дүнг сайжруулах	7
Байгалийн гамшгийн менежмент	Байгалийн гамшгаас хамгаалах эрт мэдээлэх болон сэрэмжүүлэх системийг сайжруулах	Байгалийн гамшгийн эрт сэрэмжлүүлэх системийг бэхжүүлэх	-эрт илрүүлэх болон урьдчилан мэдээлэх систем нэвтрүүлэх - орон нутгийн түвшинд гамшгийн эрсдлийн үнэлгээ хийх	-супер компьютерийн чадавхийг бэхжүүлэх замаар цаг агаарын урьдчилсан мэдээний чанарыг сайжруулах -бүх нутаг дэвсгэрийг хамрах Допплерийн радарийн сүлжээг бий болгох	65.4

Эх сурвалж: INDC, Монгол, 2015.

#### Бодлогын бусад баримт бичиг

ТХЗ-н гурван чиглэлийн нэг нь уур амьсгалын өөрчлөлтийн тухай асуудал юм. Энэ хүрээнд, Засгийн газар ХХЯ-ыг бууруулах болон дасан зохицох асуудлын аль алийг нь хэрэгжүүлэх зорилт дэвшүүлсэн байна. 2010 оны суурь мэдээллийг ашиглан, Монгол улс 2020 он гэхэд ХХ-ийн ялгаралыг 2 хувиар, 2025 он гэхэд 7 хувиар, 2030 он гэхэд 14 хувиар бууруулахыг зорьж байна. Энэ зорилт нь Монголын ҮЗХН –д тусгасан бодлого, арга хэмжээнүүдтэй нийцэж байгаа юм. 2020 он гэхэд, Монгол улс уур амьсгалын өөрчлөлтийг давж гарах стратеги боловсруулан хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд үүнд гамшгийн эрсдлийн менежментийг бэхжүүлэх, ажиглалт, мониторингийн чадавхийг бэхжүүлэх, өргөжүүлэх, байгалийн аюултай үзэгдэл болон болзошгүй гамшгийг эрт илрүүлэх болон сэрэмжлүүлэх системийг байгуулах, уур амьсгалын өөрчлөлтийг давж гарах мэдлэг чадвар, боловсролыг иргэдэд олгох арга хэмжээнүүдийг тусгажээ. 2025 он гэхэд хэрэгжүүлэх арга хэмжээнд, уур амьсгалын өөрчлөлтийг давж гарах туршилтын төслүүд хэрэгжүүлэх, сайн туршлагаудын төслүүд болон гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах үндэсний хэмжээний үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах зэрэг арга хэмжээнүүдийг хамруулсан байна. 2030 он гэхэд, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, газрын доройтол гамшгаас учрах хохирлыг бууруулахыг зорьж байна.

Хэдийгээр дасан зохицох асуудлыг уур амьсгалын өөрчлөлтийн тухай гол баримт бичигт тусгасан ч одоогоор ямар нэг стратеги, үндэсний дасан зохицох төлөвлөгөөг гарган баглаагүй байна. 2014 онд, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам АХБ-тай хамтран “Монголд бэлчээрийн тогтвортой байдлыг хангах: уур амьсгал болон байгаль орчны өөрчлөлтөд дасан зохицох” баримт бичгийг хэвлэн нийтэлсэн. Үүнд дасан зохицох стратеги болон практикийг орон нутгийн нөхцөл байдалд нийцүүлэн тодорхойлсон байна.

#### *Энэ хэсэгт хааралтай тогтвортой хөгжлийн зорилго, зорилтууд*

ТХЗ-ын Зорилт 13.2 болон 13.3 –ын хэрэгжилтийн байдал Монгол улсад ямар байгааг Шигтгээ 7.2-д харуулав.



## Шигтгээ 7.2: Тогтвортой хөгжлийн 2030 хүртэлх хөтөлбөрийн Зорилт 13.2 болон 13.3

### Зорилго 13: Уур амьсгалын өөрчлөлтийн үр дагаврыг багасгах

#### Зорилт 13.2: Уур амьсгалын өөрчлөлтийн арга хэмжээг үндэсний бодлого, стратеги, төлөвлөлтөд тусгах

Стратегийн гол баримт бичиг болох 2016 оны Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 болон 2014 оны Ногоон хөгжлийн бодлого зэрэг баримт бичгүүдэд уур амьсгалын өөрчлөлтийн арга хэмжээнүүдийг тусган оруулж, салбаруудын бодлогод уур амьсгалын өөрчлөлтийг онцлон оруулсан байна. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр болон Монголын хүлээх үүрэг нь мөн энэ чиглэлийг зорьж байгаа юм. 2017 оны 8 дугаар сард өргөн барьсан Хоёр жил тутмын шинэчилсэн тайлан илтгэлд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн үр дүнг танилцуулсан байна. Зорилго 13.2-ыг дагаж мөрдөхийн тулд Монгол улс дасан зохицох үндэсний төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй байна.

#### Зорилт 13.3: Боловсрол, мэдлэг мэдээлэл түгээх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, нөлөөлөлийг бууруулах ба эрт сэрэмжлүүлэхэд чиглэсэн бүтэц зохион байгуулалтын чадавхи

УАӨУХ-ийн эхний үе шатанд (2011-2016) уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн хөгжлийг бүх шатны сургуулийн хичээлийн хөтөлбөрт оруулахыг зорьж байна. Германы техникийн хамтын ажиллагааны байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд хичээлийн хөтөлбөрийг шинэчлэх, багш нарт зориулсан уур амьсгалын өөрчлөлтийн тухай сургалтыг явуулсан байна.

ТХҮБ 2030 –ийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхийг бэхжүүлэх, байгалийн гамшгийн эрдлээс сэрэмжлэх чадварыг бэхжүүлэх замаар энэхүү зорилтыг амжилттай биелүүлнэ. Түүнчлэн, УАӨУХ–д уур амьсгалын өөрчлөлтийн мониторингийн сүлжээг өргөжүүлэх, технологийн шинэчлэл хийх, судалгаа, хэмжилт, үнэлгээний ажлын цар хүрээг өргөтгөх ба чадавхийг бэхжүүлэхийг стратегийн зорилт болгон дэвшүүлсэн байна. БОАЖЯ-аас орон нутаг, аймгийн түвшинд эл асуудлаар иргэдийн мэдлэгийг гүнзгийрүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

### *Бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо*

#### Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал хариуцсан Тусгай элч

2008 оноос Монгол улс Ерөнхий сайдын томилсон Тусгай элчүүдийг ажиллуулж иржээ. Одоогийн Тусгай элч нь УАӨСК болон Уур амьсгалын ногоон сангийн үндэсний зохицуулагчийн үүргийг гүйцэтгэж байна.

#### Уур амьсгалын өөрчлөлтийн талаар төвийн түвшинд хүлээх үүрэг, хариуцлага

Цаг уур, орчны хяналт шинжилгээний газар нь 2008-2010 он хүртэл уур амьсгалын өөрчлөлтэй холбоотой асуудлуудыг хариуцаж, УАӨСК-ийн хэрэгжилтийг хариуцаж байв. Тухайлбал, ХХЯ-ын тооллого болон судалгаа, шинжилгээ, үнэлгээний ажил явуулж иржээ.

Уур амьсгалын өөрчлөлтийн 2011 оны Үндэсний хөтөлбөрөөр Үндэсний уур амьсгалын Хороо нь Засгийн газрын уур амьсгалын холбогдол бүхий асуудал болон Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцахаар заасан байна. Уур амьсгалын үндэсний хороог БОАЖЯ-ны сайд тэргүүлэх ба уур амьсгалын өөрчлөлттэй холбогдсон үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, салбар хоорондын ажлын уялдааг зохицуулах, төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн үнэлгээ, оролцогч талуудыг хяналт, удирдамжаар хангах үүрэгтэй байжээ. Тус Хороог төрийн захиргааны байгууллагуудын өөрчлөлт зохион байгуулалтын хүрээнд 2015 оны 12 дугаар сард татан буулгаж үүрэг хариуцлагыг нь Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яаманд шилжүүлсэн байна. Одоогоор Монгол улсад уур амьсгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах товлосон албан ёсны тогтвортой бүтэц байхгүй байна.

Уур амьсгалын Үндэсний Хорооны үйл ажиллагааг 2011 оны 2 дугаар сарын Сайдын А-23 тоот тушаалаар байгуулагдсан (дараа нь 2013 оны 1 дүгээр сарын сайдын А-11 тоот тушаалаар шинэчилсэн) Уур амьсгалын өөрчлөлтийн зохицуулах алба дэмжин ажиллаж байсан боловч 2015 оны төрийн захиргааны байгууллагуудын өөрчлөн шинэчлэлтийн хүрээнд уг албыг 2015 оны 1 дүгээр сард татан буулгажээ. Ажиллагсадын заримыг нь шинэхэн байгуулагдсан Байгаль орчин, уур амьсгалын сангийн дэргэд Уур амьсгалын өөрчлөлтийн төсөл хэрэгжүүлэх нэгжид (Сайдын 2015 оны 2 дугаар сарын



А/118 тоот тушаалаар байгуулагдсан) шилжүүлэн ажиллуулж, заримыг нь БОАЖЯ-ны Уур амьсгалын өөрчлөлт ба олон улсын харилцааны газарт шилжүүлсэн байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн төсөл хэрэгжүүлэх нэгж нь одоогоор Монгол улсад уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг дотоод болон гадаадад хариуцаж байгаа цорын ганц нэгж юм УӨТХН нь уур амьсгалын өөрчлөлтийн Тусгай элчид дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээж байна.

БОАЖЯ-ны Уур амьсгалын өөрчлөлт ба олон улсын хамтын ажиллагааны газар нь УАӨСК-ын хэрэгжилтэд хяналт тавьж, конвенцийн Талуудын бага хурлуудад оролцон, хамтын ажиллагааны зохицуулалтыг хариуцан, техник туслалцааны төслүүд боловсруулахад идэвхитэй оролцож байна.

#### УАӨСК-ын хурлуудад оролцож байгаа байдал

Конвенцийн Талуудын бага хурлуудад оролцож байгаа үндэсний төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд конвенцийн үндэсний зохицуулагч болон яамны Уур амьсгалын өөрчлөлт, олон улсын хамтын ажиллагааны газрын ажилтанг тогтмол оролцуулж ирсэн байна. Зарим тохиолдолд том хэмжээний төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй оролцож, бүрэлдэхүүнд нь Засгийн газар, орон нутгийн засаг захиргааны болон хувийн хэвшлийн төлөөлөл оролцож байжээ. Салбар байгууллагуудын хуралд зөвхөн үндэсний зохицуулагч оролцож байна. Монгол улс нь УАӨСК-ын Дасан зохицох хорооны гишүүнээр 2012-2017 онд ажилласан ба Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал хариуцсан усгай элчээр өмнө нь ажиллаж байсан хүн гишүүнээр хувь хүний хувьд үргэлжлүүлэн ажиллаж байна.

Оролцогч талууд эсвэл иргэний нийгмийн төлөөллийг олон улсын яриа хэлэлцээнд оруулцуулан улс орынхоо байр суурийг илэрхийлэх тухай тусгайлсан албан ёсны дүрэм журам байхгүй. Уур амьсгалын өөрчлөлтийн аливаа яриа хэлэлцээний талаар гадаад харилцааны сайдад мэдэгддэг ба харин тус яаманд нь эл асуудлыг товлон хариуцдаг ажилтан байхгүй, тэдний хувьд “77-ийн бүлгийн” гишүүний хувьд сайд нарын түвшний бүсийн зөвлөлдөх уулзалтад оролцож иржээ.

#### Байгаль орчин, Уур амьсгалын сан

Өмнө нь ажиллаж байсан Байгаль хамгаалах санг 2016 оны сүүлчээр Байгаль орчин, уур амьсгалын сан болгон Сайдын тушаалаар өөрчлөн зохион байгуулсан байна. Сангийн зорилго нь уур амьсгалын өөрчлөлт, байгаль хамгаалах төслүүдийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхийн тулд дотоодод болон гадаадын эх үүсвэрээс хөрөнгө босгоход оршино. 2014-2016 онд босгосон хөрөнгийн дийлэнхийг байгаль орчны боловсрол (40.8 хувь), усны менежмент (31.1 хувь), ховор болон устах аюултай биологийн төрөл зүйлүүдийг хамгаалах (12.7 хувь), болон цөлжилтэй тэмцэхэд (5.9 хувь) зарцуулсан байна (Хүснэгт 3.14). Уур амьсгалын өөрчлөлтийн арга хэмжээнд хөрөнгө зараагүй байна.

#### *Конвенцийн хэрэгжилт, дагаж мөрдөх асуудал*

Монгол улс УАӨСК-ийн санал үл нийлэх процедурын ямар нэг зөрчлийн асуудалд орж байгаагүй байна.

Монгол улс Киотогийн протоколийн хоёдахь хугацааг тодорхойлж, Киото протоколийн Хавсралт 1 –д орсон орнуудад шинэ үүрэг ноогдуулсан Дохагийн нэмэлт өөрчлөлтийг батламжлаагүй байна. Конвенцийн Хавсралт 1-д ордоггүй Талын хувьд энэхүү нэмэлтийг батламжлах нь Монгол улсын хувьд Протоколийн хэрэгжилтийг дэмжиж байгаагийн нь илэрхийлэл болох юм.

#### Дасан зохицох хүчин чармайлт

ҮЗХН баримт бичигт дасан зохицох талаар авах арга хэмжээнүүдийн талаар тусгасан байна. Тэдгээр арга хэмжээний ихэнх нь байгаль орчны мониторингийг сайжруулах, холбогдох мэдээлэл цуглуулах, байгалийн нөөц баялагын менежментийн сайжруулах зэрэг үйл ажиллагааг хамарч байна.

#### Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах

ҮЗХН баримт бичигт 2030 он гэхэд ХХЯ-г 14 хувиар бууруулах зорилтыг дэвшүүлсэн боловч хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа арга хэмжээнүүдийг эцэслэн шийдвэрлээгүй байна. УАӨҮХ-ийн хэрэгжилтийн хоёрдугаар үе шатыг ҮЗХН баримт бичгээр хүлээх үүргийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн

боловсруулж байна. Энэхүү УАӨҮХ-ийн хэрэгжилтийн хоёрдугаар үе шатанд ХХЯ-г бууруулах тодорхой арга хэмжээнүүдийг оруулна гэсэн хүлээлттэй байна. Сэргээгдэр эрчим хүчнийг хөгжүүлэх талаар хийж буй ажил, олсон амжилтын талаарх мэдээллийг Шигтгээ 7.3-д үзүүлэв.

### Шигтгээ 7.3: Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх боломж, ололт амжилт

Стратегийн гол баримт бичиг болох 2016 оны Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 болон 2005 оны сэргээгдэх эрчим хүчийг 2005-2020 онд хөгжүүлэх хөтөлбөр, 2015 оны Эрчим хүчний талаар төрөөс баримтлах 2015-2030 оны бодлого, 2014 оны Ногоон хөгжлийн бодлого болон 2015 оны ҮЗХН баримт бичигт Монгол улс 2020 он гэхэд нийт эрчим хүчний хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх жинг 20 хувиар, 2025 он гэхэд 25 хувиар, 2030 он гэхэд 30 хувиар нэмэгдүүлэх зорилт тавьсан байна.

2016 оны байдлаар Монгол улсын эрчим хүч үйлдвэрлэлийн дөнгөж 7 хувийг сэргээгдэх эрчим хүч эзлэж, эрчим хүчний гол эх үүсвэр нь нүүрс байсаар байна. ХХЯ-г 2030 он гэхэд 14 хувиар бууруулах зорилтыг биелүүлэх нь сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа арга хэмжээнүүдийн хэрэгжилтээс ихээхэн хамаарна.

Монгол улсын сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвийн мэдээгээр, сэргээгдэх эрчим хүчний боломж нь 2.6 TW гэж тооцоолсон байна. Салхи болон нарны эх үүсвэр нийлээд жилд 15,000 TWh цахилгаан үйлдвэрлэх боломжтой байгаа нь сэргээгдэх эрчим хүчний боломж нь хэрэглээний эрэлтээс хавьгүй өндөр байгааг харуулж байна. Олон улсын сэргээгдэх эрчим хүчний байгууллагын (IRENA) 2016 оны үнэлгээгээр сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх нь Монголын хувьд стратегийн чухал ач холбогдолтой, Монгол улсыг цэвэр эрчим хүч үйлдвэрлэгч болон экспортлогч орон болгох боломж байна гэсэн дүгнэлт гаргасан боловч энэ боломжийг ашиглахад ихээхэн саад бэрхшээл тулгарсаар байна. Тэр их нөөц бололцоог ашиглаж, эх орондоо болон бүс нутагт ашиг шимийг нь хүртэхийн тулд зах зээл болон хөгжлийн саад бэрхшээлийг таван туулах шаардлагатай тулгарч байгаа юм.

Эрчим хүчний талаар бодлого, стратегийн багц баримт бичгүүдийг баглан гаргасан байна. Тухайлбал: 2001 оны Эрчим хүчний хууль, 2007 оны Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль (2015 онд шинэчлэгдсэн), 2015 оны Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлого, 2015 оны Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль. Шинчилсэн хууль тогтоомж нь төр-хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, зах зээлд онилсон эрчим хүч үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг зорьж байна.

Монгол улсад 2013 оны 7 дугаар сард 52 MW-ийн Салхитын салхин станцыг барьж ашиглалтад оруулсанаар Монголын сэргээгдэх хүчний үйлдвэрийн эхлэлийг тавьсан юм. Сэргэлэнгийн 10 MW нарны эрчим хүчний станц 2017 оны 1 дүгээр сар ажиллаж эхэлжээ. Мөн 52 MW цахилгаан үйлдвэрлэх хүчин чадалтай салхины эрчим хүчний станц Сайншандад 2017 онд ашиглалтад орохоор төлөвлөгдөж байна. Цэцийгийн 15 MW хүчин чадалтай салхин станцыг говийн бүсэд барихаар төлөвлөж байна. Өөр хэд хэдэн станцуудыг барих ажил янз бүрийн хэрэгжилтийн шатанд явж байна.

315 MW хүчин чадалтай Эгийн голын усан цахилгаан станцын ТЭЗҮ болон байгаль орчны үнэлгээ хийгдсэн байна. ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн хорооны зүгээс уг төслийн байгаль орчинд үзүүлэх хил дамнасан нөлөөлөлтэй холбогдуулан санаа зовж байгаа илэрхийлсэн хүсэлтэд Монголын Засгийн газар хариу өгөхөөр төлөвлөж байна. Мөн Сэлэнгэ, Орхон голууд дээр барихаар төлөвлөж байгаа Шүрэнгийн усан цахилгаан станцуудын хувьд ч ийм асуудал тавигдаад байна (Бүлэг 6).

*Хэлэлцээрийн хүрээнд тайлан мэдээ бэлтгэх, үйл ажиллагаа, механизмуудад оролцох оролцоо*

#### Тайлан мэдээ гаргах

Монгол улс УАӨСК –ийн хэрэгжилтийн тухай анхны тайлан илтгэлийг 2001 онд, хоёрдугаар тайланг 2010 онд тус тус хүргүүлжээ. НҮББОХ болон Даян дэлхийн байгаль хамгаалах сангийн дэмжлэгтэйгээр 2017 оны дундуур гуравдахь тайланг мөн бэлтгэн хүргүүлжээ. Монгол улс нь конвенцийн Хавсралт 1-д ордоггүй Тал болохын хувьд хоёр жил тутам шинэчилсэн тайлан илтгэл хүргүүлэх үүргийн дагуу эхний тайланг 2014 оны 12 дугаар бэлтгэн хүргүүлэх ёстой байсан боловч 2017 оны 8 дугаар сард л хүргүүлсэн байна.

Тайлан хүргүүлэх хугацааг хойшилсон шалтгаан нь санхүүгийн эх үүсвэр олоход бэрхшээлтэй байсан, 2016 оны сонгуулийн дараа бүтэц зохион байгуулалтын орчин өөрчлөгдсөнтэй холбоотой гэж үзэж байна. Дараагийн тайлан илтгэлүүд бэлтгэх үүрэг БОУАС-гийн дэргэдэх УАӨ-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжид ноогдож байгаа юм. Төслийн удирдах зөвлөлийг БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар толгойлуулан байгуулж, зөвлөлд яамны хэд хэдэн газар, уул уурхай, эрчим хүч, сангийн яам, Улаанбаатар хотын захиргааны төлөөлөл, түүнчилэн Биологийн олон янз байдал болон Цөлжилттэй тэмцэх конвенцийн Үндэсний зохицуулагчид орсон байна.

Үндэсний хувьд зохистой ХХЯ-ыг бууруулах үйл ажиллагаа (НАМА)

Монгол улс ХХЯ-г цаашид эрчимтэй бууруулах тухай Копенганы зөвшилцөлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжиж байгаагийн илэрхийлэл болгож Үндэсний хувьд зохистой ХХЯ-ыг бууруулах үйл ажиллагаа (НАМА)-ны хүрээнд 22 саналын жагсаалтыг 2010 оны 1 дүгээр сард УАӨСК-д хүргүүлсэн байна. Эдгээр арга хэмжээ нь эрчим хүч, аж үйлдвэр, барилга, тээвэр, хөдөө аж ахуй, ойн салбаруудад төвлөрсөн байна. 2015 оны ҮЗХН –ний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ нь нь ерөнхийдөө НАМА-тай нийцэж байгаа бөгөөд ялангуяа тээвэр, аж үйлдвэрийн салбарын арга хэмжээнүүд илүү нийцэж байна.

Уур амьсгалын ногоон сан

Уур амьсгалын ногоон сантай Монгол идэвхитэй хамтран ажиллаж байна. УАӨСК-ийн дэргэд байгуулсан энэхүү санхүүгийн механизмын хөгжиж байгаа орнуудын уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх хүчин чармайлтыг дэмжих үүрэг Парисын хэлэлцээрийн дагуу өргөжиж байна. Монгол улс БОАЖЯ, БОУАС-ийн дэргэдэх УАӨ-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжийг УАНС-гийн Үндэсний эрх бүхий байгууллага (NDA) буюу Үндэсний зохицуулагчаар тохоон томилжээ. УАНС-ын анхны бүсийн семинар 2015 онд болж, тус сантай хамтран ажиллах үндэсний бэлэн байдлыг хангах болон тэргүүлэх зорилтуудын талаар санал солилцсон байна. Тэргүүлэх чиглэлээр тодорхойлсон салбаруудын хамрах хүрээ нэлээд өргөн цар хүрээтэй байна. Тухайлбал, цахилгаан, дулааны хангамж, аж үйлдвэр, тээвэр, хог хаягдал, ГАГАӨО болон хотын агаарын бохирдол, дасан зохицох, ус, хөдөө аж ахуй, гамшгийн эрсдэлийг бууруулах, ой зэрэг асуудлыг тэргүүлэх чиглэлээр тодорхойлжээ.

Монгол улсад 2016 онд УАНС-аас шууд санхүүжилт авах боломжоо баталгаажуулж Хас банкаар дамжуулан анхны дунд зэргийн эрсдэл бүхий жижиг хэмжээний төслүүдэд санхүүжилт авсан байна. Сангаас шууд санхүүжилт авах боломжоо нэмэгдэхийн тулд өөр хоёр хувийн хэвшлийн байгууллага онлайн баталгаажилтын системийн дансыг нээгээд байна. Үндэсний зохицуулагч, үндэсний шууд санхүүжилт авах итгэмжлэгдсэн байгууллага болон УАНС-ийн төлөөлөгчдийн хоорондын олон удаагийн уулзалт хэлэлцүүлгүүд явагдсаар байна.

Монгол улс УАНС-д хандан тус сангаар хэрэгжих төслийн санал боловсруулахад дэмжлэг авах талаар гурван хүсэлт тавиад байгаагаас хоёр төсөл нь 2017 оны дунд үед УАНС –аар батлагдаад байна.

НҮБХХ Хөдөөгийн иргэдийн Дасан зохицох чадавхи, эрсдлийн менежментийг сайжруулах төслийн санхүүжилтийн саналыг бэлтгэхэд Монголд дэмжлэг үзүүлж байна. Төслийн зорилго нь уур амьсгалын өөрчлөлтөд мал аж ахуйн салбарын дасан зохицох, эрсдэлийг даван туулах чадавхийг бэхжүүлэхэд оршиж байна. Олоогийн байдлаар УАНС-д тавих хэдэн хэдэн төслийн санал бэлтгэж, хянан үзэж байгаа ажээ.

Цэвэр хөгжлийн механизм

Монгол улс 2017 оны дунд үеийн байдлаар Киотогийн протоколын Цэвэр хөгжлийн механизм (ЦХМ)-ийн дөрвөн төслийг бүртгүүлээд байна (Хүснэгт 7.8). өөр хэд хэдэн төсөл баталгаажилтийн шатанд яваа бөгөөд өөр бусад зарим ЦХМ-ийн төсөл боловсруулж байна.

**Хүснэгт 7.8: Цэвэр хөгжлийн механизмийн төслүүд**

Нэр	Бүртгэгдсэн он	Хэрэгжүүлэгч орон	Хамрах салбар	Ялгаралын бууралт (хүлээгдэж байгаа Тонн СО <sub>2</sub> жил )
Монголын төвлөрсөн бус дулааны станцуудыг шинэчлэх	2006	Монгол	Эрчим хүчний бүтээмжийг сайжруулах	11,904
Тайширын усан цахилгаан станц	2007	Монгол Япон	Сэргээгдэх эрчим хүч	29,600
Дөргөний усан цахилгаан станцын төсөл	2007	Монгол Япон	Сэргээгдэх эрчим хүч	30,400
Салхитын салхин цахилгаан станц	2012	Монгол Швед	Сэргээгдэх эрчим хүч	178,778

Эх сурвалж: <http://cdm.unfccc.int> ба БОАЖЯ, 2017 оны 9 дүгээр сар

Хамтарсан кредит олгох механизм

Монгол улс болон Япон улсын Засгийн газрууд “Нүүрстөрөгч багатай хөгжлийн түншлэл” хоёр талын хэлэлцээрт 2013 онд гарын үсэг зурж, Хамтарсан кредит олгох механизмыг (ХКОМ) байгуулсан байна. Энэ нь Японы хувьд ийм зорилгоор байгуулсан анхны түншлэл юм. ХЗОМ-ийн төслүүд нь нүүрстөрөгчийн бага ялгаралтай технологи, бүтээгдэхүүнийг дэмжих зорилготой бөгөөд арилжаалахгүй байх нөхцөлтэй ХХЯ-ын кредитийг Монгол, Япон улсын ХХЯ-ийг бууруулах хүчин чармайлтад ашиглах юм. Механизмыг хэрэгжүүлэх Хамтарсан хороо байгуулж, Монголын талаас холбогдох яамдын төлөөлөл болон Эрчим хүчний зохицуулах хороо, Улаанбаатар хотын захирагчийн албаны төлөөлөл оролцож байна. Уур амьсгалын өөрчлөлтийн төсөл хэрэгжүүлэх нэгж хамтарсан хорооны НБД-ын үүргийг Монголын талаас хариуцан гүйцэтгэж байна. 2017 оны 6 дугаар сарын байдлаар, Монголын тал ХКОМ –д хоёр төсөл бүртгүүлэн, 2 аргачилалыг баталж, 6 төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна (Хүснэгт 7.9).

НҮБ-ын Хөгжиж байгаа орнуудад Ойгүйжилт, ойн доройтлоос шалтгаалсан ХХЯ-г бууруулах хөтөлбөр (НҮБ-РЭДД)

Монгол улс НҮБ-ын Хөгжиж байгаа орнуудад Ойгүйжилт, ойн доройтлоос шалтгаалсан ХХЯ-г бууруулах хөтөлбөр (НҮБ-РЭДД) (UN-REDD) хөтөлбөрийн түншлэлд 2011 оны 6 дугаар сард нэгдсэнээр томоохон хэмжээний хуурай ой бүхий анхны орон болж, РЭДД+ хөтөлбөрийн бэлэн байдлыг хангах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Бэлэн байдлын замын зураглалыг 2014 онд боловсруулжээ.

**Хүснэгт 7.9: Хамтарсан кредит олгох механизмийн төслүүд**

Төрөл	Төслийн нэр	Бүртгүүлсэн/баталсан огноо	Ялгарлын хүлээгдэж байгаа бууралт (тонн CO <sub>2</sub> /жил)
Бүртгэгдсэн төсөл	УБ хотын 118 дугаар сургуульд өндөр бүтээмжтэй дулааны халаагуур тавих төсөл	2015.06.30	92 tCO <sub>2</sub> /жил
Бүртгэгдсэн төсөл	Бор нуур суманд төвлөрсөн халаалтаар хангах өндөр бүтээмжтэй дулааны халаагуур тавих төсөл	2015.06.30	206 tCO <sub>2</sub> /жил
Аргачилал батлагдсан	Монголын цахилгаан түгээх сүлжээнд эрчим хүч хэмнэх шугам тавих	2014.02.20	
Аргачилал батлагдсан	Халуун усны хангамжийн системд өндөр бүтээмжтэй дулааны халаагуур тавих төсөл	2015.01.28	
ТЭЗҮ	Дарханы уул аймгийн цементийн үйлдвэрт эрчим хүч хэмнэх төсөл		7,800 tCO <sub>2</sub> /жил
ТЭЗҮ	Говь алтай аймгийн Тайшир суманд тогтвортой цахилгаанаар хангах 10МВ нарны эрчим хүч үйлдвэрлэх төсөл		17,537 tCO <sub>2</sub> /жил
ТЭЗҮ	Улаанбаатарын цахилгаан станцийн дулааны алдагдлыг бууруулах, ус, агаар цэвэршүүлэлтийг сайжруулах төсөл		3,000 tCO <sub>2</sub> /жил
ТЭЗҮ	Улаанбаатарын дулааны цахилгааны станцын дулааны алдагдлыг бууруулах төсөл		1,723 tCO <sub>2</sub> /жил (CHP-3&CHP24)
ТЭЗҮ	Улаанбаатарт биомасс, нүүрсний хольц бүхий түлш ашиглах халаагуурыг дулаан түгээх системд ашиглах төсөл		3,760 tCO <sub>2</sub> /жил

Эх сурвалж : <http://www.jcm-mongolia.com>, 2017 оны 9 дүгээр сар.

НҮБ-РЭДД хөтөлбөрийг 2016-2018 онуудад хэрэгжүүлэх Монгол улсын Үндэсний хөтөлбөрийг 2015 онд НҮБХХ-н дэмжлэгтэйгээр баталсан байна. Хөтөлбөрийн зорилго нь Үндэсний РЭДД+ стратегийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг туслалцаа үзүүлэх явдал юм. УАӨСК-ийн Варшавын Зарчим баримт бичигт дэвшүүлсэн шаардлагуудыг хангасан нөхцөлд РЭДД+ -ийн үр дүнд үндэслэсэн төлбөр авах боломж бүрдэх юм. Монголын НҮБ-РЭДД үндэсний хөтөлбөр нь ойн мониторингийн үндэсний системийг хөгжүүлэх, мониторингийг хэмжилттэй хослуулах, тайлагнах болон баталгаажуулах ажлыг

дэмжинэ. Энэ хүрээнд 2014-2016 онд Германы техникийн хамтын ажиллагааны дэмжлэгтэйгээр РЭДД+ ойн тоологыг явуулах төслийг хэрэгжүүлсэн байна (Бүлэг 13). Төслийн зорилго нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр ойн ургалтын талаархи найдвартай мэдээлэл бэлтгэх явдал байсан байна. РЭДД+ үндэсний стратегийг одоогоор Үндэсний стратегийн сүүлийн үеийн баримт бичгүүдтэй нийцүүлэн боловсруулж байгаа бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөө болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг мөн хамруулна гэсэн хүлээлттэй байна.

#### ҮЗХН-ийн Түншлэл

Монгол улс ҮЗХН түншлэлийн гишүүн орон юм. Энэхүү түншлэл нь НҮБ-ын УАӨСК-ийн Талуудын 22 дугаар бага хурлаас улс орнуудын ҮЗХН-д дэвшүүлсэн үүргээ биелүүлэхэд нь туслах, санхүүгийн болоод техникийн дэмжлэг үзүүлэх зоригоор байгуулагдсан санаачлага юм.

#### Технологийн эрэлт хэрэгцээний үнэлгээ

Монгол бол Технологийн эрэлт хэрэгцээний үнэлгээний төсөлд нэгдэн орсон 14 орны нэг юм. Даян дэлхийн байгаль хамгаалах сан болон НҮББОХ-ийн дэмжлэг, Азийн Технологийн институтийн Бүсийн төвийн оролцоотойгоор 2013 онд БОАЖЯ ХХ-ийн ялгаралыг бууруулах болон дасан зохицох зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай Технологийн эрэлт хэрэгцээний үнэлгээний цогц илтгэлийг боловсруулсан байна. ХХ-ийн ялгаралыг бууруулах арга хэмжээг эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний салбарууд, барилга орон сууц, худалдаа үйлчилгээний дэд салбарт хэрэгжүүлэх ёстой гэж үзсэн байна. Дасан зохицох тухайд, тэргүүлэх чиглэлд газар тариалан, мал аж ахуйн салбарыг улс орын эдийн засагт чухал үүрэгтэй, уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн эмзэг салбар гэж тодорхойлжээ.

#### *Эх мэдээлэл ба тооллого, инвентори*

Монгол улс уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний хоёр дэлгэрэнгүй тайлан илтгэл бэлтгэн гаргасан байна. Эхний илтгэлийг 2009 онд, дараагийн илтгэлийг 2014 онд гаргажээ. ХХЯ-ийн инвентори, тооллогыг боловсруулж УАӨСК-д гаргасан тайлан хоёр удаагийн илтгэлд тусгаж 2001 ба 2010 онд тус конвенцид хүргүүлсэн байна.

Даян дэлхийн байгаль хамгаалах сан болон НҮББОХ-ийн дэмжлэгтэйгээр шинэчилсэн ХХЯ-н тооллогыг ГАГАӨО-ын салбарыг хамруулан 2017 дунд үе гэхэд хийж дуусган УАӨСК-д гаргах 2 жил тутмын тодотгосон тайлан илтгэлд оруулжээ.

#### *Олон улсын техникийн туслалцаа дэмжлэг*

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар Монгол улс холбогдох олон улсын байгууллагууд болон хандивлагчдаас өргөн цар хүрээтэй дэмжлэг тусламж авч ирсэн байна. Монгол улс нь Парисын хэлэлцээрийн дагуу байгуулагдсан Ил тод байдлын чадавхийг бэхжүүлэх (СВИТ) –д хандсан анхны орнуудын нэг юм. Даян дэлхийн байгаль хамгаалах санд 2016 оны 9 дүгээр сард оруулсан анхны санхүүжилтийн санал болох “Үндэсний дасан зохицох төлөвлөгөөг боловсруулах үйл явцад ахиц гаргах чадавхийг бэхжүүлэх” төслийн санал нь Монголын үндэсний дасан зохицох төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд туслах зорилгод нийцэж байна.

#### *Хүрсэн тодорхой үр дүн ба саад бэрхшээл*

УАӨСК-д нэгдэн орсон дүнд Монгол улс нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар стратегийн цогц төлөвлөлт хийх, эрэлт хэрэгцээний үнэлгээнүүдийг боловсруулсан байна. Ийнхүү холбогдох тайлан илтгэлүүдийг бэлтгэн хүргүүлж, зарим техникийн тусламжийг авсанаар өнөөдөр Монгол улс уур амьсгалын холбогдолтой 25 жилийн эх мэдээллийн сантай болсон байна. Гэвч эх мэдээллийн олдоц болон ХХЯ-н тооллогын тухайд зарим нэг бэрхшээлтэй тулгарсаар байна.

Түүнчлэн Монгол улс ЦХМ, ХКОМ, УАНС зэрэг механизмаар дамжуулан олон улсын хамтын нийгэмлэгийн техникийн болон санхүүгийн дэмжлэг тусламж авч, үр өгөөжийг нь хүртэж байна.

Тодорхой саад бэрхшээл тулгарсаар байгаа нь ихэнхдээ бүтэц зохион байгуулалтын орчинтой холбоотой байгаа бөгөөд энэ нь үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад сөрөг үр дагавар дагуулж байна. Одоогийн байдлаар, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар техникийн болоод мэргэжилтний



түвшний тогтвортой бүтэц, уур амьсгалын асуудлаарх бодлогын зохицуулалтын нэгж байхгүй байна. Энэ байдал нь бодлогын зохицуулалт, мониторингийн нэмэлт саад бэрхшээлийг бий болгож, цаашид энэ нь улам илүү бэрхшээл учруулах болно.

## 7.6 Риогийн конвенцуудын хэрэгжилтийн харилцан уялдаа

Риогийн гурван конвенцийн хэрэгжилтийн харилцан уялдааг хангах ажил ихэвчлэн эдгээр конвенцуудын Үндэсний зохицуулагч нарын хоорондын албан бус харилцаанд дээр үндэслэн явагдаж байна.

Конвенцүүдийн холбогдох 3 үндсэн стратегийн хөтөлбөрүүд нь Конвенцүүдийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд хангах гол чиглэл удирдамж болон шууд болон шууд бус замаар Конвенцүүдийн хамрах үйл ажиллагаанд хувь нэмэр болж байна.

Хэдийгээр зохицуулалтын албан бус бүтэцтэй байгаа ч гэсэн гурван конвенцийн үндэсний зохицуулагчид зохицуулалтын механзмын хэсэг болон ажиллаж чадаж байна. Тухайлбал эдгээр зохицуулагчид УАӨСК-д хүргүүлэх хоёр жил тутмын тодотгосон тайлан илтгэл бэлтгэх зорилгоор байгуулсан төслийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна. Мөн эдгээр гурван үндэсний зохицуулагчид Монгол-Японы ХКОМ-ийн хамтарсан хорооны ажилд оролцдог байна.

## 7.7 Үнэлгээ, дүгнэлт ба зөвлөмж

### *Үнэлгээ*

Риогийн конвенцүүдэд нэгдэн орсон нь сүүлийн бараг 25 жилд Монгол улсын байгаль орчны бодлогод шууд нөлөөлж иржээ. Монгол улс конвенцуудын заалтын дагуу бүх гурван асуудлаар үндэсний хөтөлбөр батлан хэрэгжүүлж байна. Риогийн конвенцүүдэд нэгдэн орсон үр дүн нь зөвхөн байгаль орчны бодлогоор хязгаарлагдахгүй. Биологийн олон янз байдал, цөлжилт, уур амьсгалын өөрчлөлттэй холбогдсон сорилт, саад бэрхшээл болон олон улсын хэмжээнд хүлээсэн үүргийн талаар үндэсний хөгжлийн стратеги, тухайлбал ТХБ 2030-д тусгасан байна. Риогийн конвенцүүдийг хэрэгжүүлэхэд бүтэц зохион байгуулалтын болон санхүүгийн чадавхи гол асуудал болж байна. Зохих стратегийн төлөвлөгөөтэй байх нь олон улсын хамтын нийгэмлэгээс техникийн болон санхүүгийн тусламж дэмжлэг авах боломжийг бүрдүүлнэ, гэхдээ Риогийн конвенцүүдэд заасан бүх гурван асуудлыг хэрэгжүүлэхэд асар их зүйлийг хийх шаардлагатай. Бүтэц зохион байгуулалтын хувьд тогтвортой ажиллах боломж бүрдээгүй, мөн бодлогын уялдаа холбоог хангахад нэн чухал үүрэгтэй байсан Цөлжилттэй тэмцэх үндэсний хороо болон Уур амьсгалын өөрчлөлтийн зохицуулах албыг 2015 оны 12 дугаар сард татан буулгасан байна.

### *Дүгнэлт ба зөвлөмж*

#### Биологийн олон янз байдлын тухай конвенци

Монгол улс Биологийн олон янз байдлын тухай конвенцийг хэрэгжүүлэх талаар хүчин чармайлт гарган ажиллаж байна. Биологийн олон янз байдлын 2015-2025 оны хөтөлбөр нь одоогийн байдлаар бодлогын гол баримт бичиг болж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон заалтуудыг хууль тогтоомжуудад болон бодлогын баримт бичгүүдэд тусгасан байна. Ерөнхийдөө энэхүү конвенцийг хэрэгжүүлэхэд одоо дутагдаж байгаа бүтэц зохион байгуулалт, техникийн болон санхүүгийн чадавхи бэрхшээлтэй хэвээр байна. Түүнээс гадна, хэрэгжилтэд нөлөөж байгаа өөр нэг хүчин зүйл бол салбар хоорондын асуудалтай холбоо бүхий экосистемийн үйлчилгээний дарамт, биологийн олон янз байдалд учирч байгаа аюул юм. Биологийн олон янз байдлын салбарт ТББ-н хамтын ажиллагаа сайн байна.

#### Зөвлөмж 7.1:

*Биологийн олон янз байдлын тухай конвенци болон Айчигийн Биологийн олон янз байдлын зорилтуудыг дагаж мөрдөх үүднээс Байгаль орчин, аялал жуулчлалын яам Биологийн олон янз байдлын Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэн, конвенцийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцож байгаа бүх талуудын уялдаа холбоог хангах механизм шаардлагатай байна.*

Картагений болон Нагояагийн протокол

Картагений протоколийг хэрэгжүүлэх эрх зүй болон бүтэц зохион байгуулалтын орчин ерөнхийдөө зохих хэмжээнд байгаа боловч Нагояа-Куала Лампурин нэмэлт протоколийн заалтыг хэрэгжүүлэх үүднээс хууль тогтоомжид өөрчлөлт, нэмэлт оруулах шаардлагатай байгаа бөгөөд мөн санхүү болон хүний нөөц асар их хязгаарлагдмал байна.

Монгол улс Нагояагийн протоколийн Хүртээмж ба Ашиг хуваах асуудлыг хариуцах Эрх бүхий Үндэсний байгууллагыг одоогоор томилоогүй байна. Нагояагийн протоколийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн заалтуудыг хэрэгжүүлэхэд оролцож байгаа яамд болон оролцогч талуудын үйл ажиллагааг одоо Байгаль орчин, аялал жуулчлалын яам уялдуулан зохицуулж байна. Түүнээс гадна, Монгол улс одоогоор орон нутгийн иргэдийг оролцуулсан зохицуулалтын үр дүнтэй эрх зүйн болон бүтэц зохион байгуулалтыг бий болгоогүй байна. Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030 –ийн Зорилго 15.6-ийг (олон улсын хэмжээнд зөвшилцсөний дагуу байгалийн баялаг ашигласны үр шимийг шудрага бөгөөд тэгш хуваарилах ба тэдгээр баялаг нь зохих ёсоор хүртээмжтэй байх явдлыг хөхүүлэн дэмжих) хэрэгжүүлэхийн тулд эрх зүйн болон бүтэц зохион байгуулалтын орчныг бий болгох нь Монгол улсын хувьд хамгийн чухлаар тавигдаж байна.

Зөвлөмж 7.2:

*Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Өөрчилсөн амьд органзмаас үүдэлтэй биологийн олон янз байдалд учирч байгаа хохиролыг арилгах арга хэмжээ авах болон Картагений протоколын Хүлээх хариуцлага ба нөхөн төлбөрийн тухай Нагояа-Куала Лампурин нэмэлт протоколийг хэрэгжүүлэх үүднээс биологийн аюулгүй байдлын тухай хууль тогтоомжид өөрчлөлт оруулах;*
- (b) *Нагояагийн протоколийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль тогтоомжийг батлах;*
- (c) *Нагояагийн хүлээх хариуцлага ба нөхөн төлбөрийн тухай нэмэлт протоколийн үндэсний эрх бүхий байгууллагыг томилж, протоколийг хэрэгжүүлэхэд оролцох байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах үр дүнтэй механизмийг бий болгох.*

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенци

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенци тухайд, Монгол улсын Цөлжилттэй тэмцэх Үндэсний 2010-2020 онд хэрэгжих хөтөлбөр нь Конвенцийн 10 жилийн стратеги болон стратегийн зорилтын хүрээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай нийцэж байна. Стратегийн бодлогын баримт бичиг нь олон улсын гол тодорхойлолтуудтай нийцэж байгаа нь цөлжилттэй тэмцэхэд нь техникийн болон санхүүгийн дэмжлэг авах нөхцлийг Монголд бүрдүүлж байна. Гэхдээ, 2015 оны сүүлчийн үнэлгээгээр Монгол улсын нийт газар нутгийн 76.8 хувь цөлжилт болон газрын доройтолд өртсөнөөс үзэхэд асуудлын цар хүрээ нь илүү их хүчин чармайлт шаардаж байна.

Зөвлөмж 7.3:

*Байгаль орчин, аялал жуулчлалын яам дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино::*

- (a) *НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн 10 жилийн стратегийг Цөлжилттэй тэмцэх Үндэсний Хөтөлбөрийн хоёрдугаар үе шатыг хэрэгжүүлэх чиглэл болгон үргэлжлүүлж, Газрын доройтол, цөлжилт, гангийн асуудлыг цаашид салбарын бодлогод тусган өргөжүүлэх;*
- (b) *Конвенцийн 2018 оноос хойшхи хугацаанд хэрэгжүүлэх стратегийн талаар явагдаж байгаа хэлэлцээрт идэвхитэй оролцох хэрэгтэй бөгөөд энэ нь ирээдүйн бодлогын төлөвлөлтийг боловсруулахад шаардлагатай;*
- (c) *НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн хүрээнд явагдаж байгаа үйл ажиллагаанд цаашид үргэлжлүүлэн оролцох, тухайлбал бүс нутгийн түвшинд харилцан туршилага солилцох, олон улсын байгууллагууд болон бусад улс орнуудтай техникийн болон санхүүгийн нэмэлт дэмжлэг олж авахын тулд тэдгээртэй түншлэл тогтоох боломжийг эрэлхийлэх.*

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенци (НҮБ-ын УАӨСК)

Засгийн газар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлэх талаар хүчин чармайлттай ажиллаж, ХХЯ-ыг бууруулахын ач холбогдолыг ойлгож байна. 2011-2021 онд хэрэгжүүлэх Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр нь бодлогын

зохистой баримт бичиг боловч үндэсний дасан зохицох төлөвлөгөөг хараахан батлаагүй байна. Энэхүү төлөвлөгөөг боловсруулах нь ТХЗ-ийн Зорилго 13.2 -ыг \уур амьсгалын өөрчлөлтийн арга хэмжээнүүдийг үндэсний бодлого, стратеги болон төлөвлөлтөд тусгах\ хэрэгжүүлэх чухал нөхцөл юм.

Парисын хэлэлцээрийг соёрхон баталсан эхний орнуудын нэг нь Монгол улс юм. 2015 оны ҮЗХН баримт бичигт тодорхойлсоноор, эрчим хүч, аж үйлдвэр, хөдөө аж ахуй болон тээврийн салбарт тодорхой арга хэмжээ хэрэгжүүлсэнээр ХХЯ-ийг бууруулахад чиглэсэн дотоодын хүчин чармайлтыг дэмжихэд олон улсын тусламж чухал үүрэгтэй байна. Арга хэмжээнүүдийн үр дүнд ХХЯ-г жил бүр бууруулах замаар 2030 он гэхэд 7.3 сая тонн CO<sub>2</sub>-экв буюу арга хэмжээ аваагүй нөхцөлтэй харьцуулбал 14 хувиар бууруулах боломж бүрдэнэ. Энэ тооцоонд ГАГАӨО-н салбарыг оруулж тооцоогүй байна.

Монгол улс ХХЯ-ыг бууруулах болон уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн эмзэг салбаруудын дасан зохицох зорилтыг хэрэгжүүлэхэд учирч байгаа гол саад бэрхшээл нь шаардлагатай санхүүгийн нөөц болон чадварлаг зохистой бүтэц зохион байгуулалтын орчин болж байна. Монгол улс олон улсын хамтын нийгэмлэгийн техникийн болон санхүүгийн дэмжлэгийн дүнд ихээхэн амжилтад хүрч ЦХМ, ХКОМ болон УАНС-гийн мехазмуудад амжилттай оролцох боломжтой болсон байна. Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөрийн хоёрдугаар үе шатны төлөвлөгөөг 2015 оны ҮЗХН баримт бичгийн үзэл санааны дагуу боловсруулж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлууд нь үр дүнтэй бүтэц зохион байгуулалтын уялдааны механизмын бодлогын зохицуулалтаас ихээхэн хамааралтай боловч Монгол улсад одоогоор ийм орчин байхгүй байна. ХХЯ-д мониторинг хийх чадавхи болон ноу-хауг бэхжүүлэх шаардлагатай байна. Хүний болон бүтэц зохион байгуулалтын чадавхийг бэхжүүлэх нь ТХЗ-ын Зорилго 13.3 (уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, нөлөөлөлийг бууруулах болон эртнээс сэрэмжлүүлэх талаархи мэдлэг боловсролыг сайжруулах, мэдээлэл түгээх, хүний болон бүтцийн орчны чадавхийг дээшлүүлэх) -ыг Монгол улсад хэрэгжүүлэхэд нь ихээхэн дэмжлэг болно.

#### Зөвлөмж 7.4:

*Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Үндэсний дасан зохицох төлөвлөгөө болон Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хоёрдугаар үе шатны төлөвлөгөөг Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар олон улсын хэмжээнд оруулах хувь нэмэр болон ҮЗХН-ын стратеги, үүрэг хариуцлагатай нийцүүлэн боловсруулж батлах;*
- (b) *Уур амьсгалын бодлогын асуудалд хамаарал бүхий салбарын яамдын үйл ажиллагааг зохицуулах бие даасан техникийн болон чадварлаг бүтэц бүхий байнгын нэгжийг байгуулах;*
- (c) *Хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцлийг баталгаажуулах болон чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах замаар олон улсын санхүүгийн хөрөнгө нөөцөөс хамааралтай байгаа байдлыг бууруулах арга хэмжээ авах.*

#### Конвенцүүдийн хэрэгжилтийн харилцан уялдаа

Риогийн конвенциудын хэрэгжилтийн уялдааг хангахад чиглэсэн тусгайлсан механизм буюу нэгдмэл бүтэц байхгүй байна. Гэсэн ч гурван конвенцийг уялдаа холбоотой хэрэгжүүлэхэд шууд буюу шууд бусаар нөлөөлөх үндэсний бодлого үйлчилж байна.

#### Зөвлөмж 7.5:

*БОАЖЯ Риогийн конвенци бүрийн эрх зүй болон бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхдээ Риогийн конвенциудын харилцан уялдааны асуудлыг цаашид ч анхааралдаа авч ажиллах нь зүйтэй юм.*



### ***ХЭСЭГ III***

***БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛЫГ ХОЛБОГДОХ  
САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БОДЛОГОД  
ТУСГАХ НЬ***





## Бүлэг 8


### АГААР ХАМГААЛАЛ

#### 8.1 Хот, хөдөөгийн агаарын чанар

Монгол Улсад агаарын чанарын мониторинг, хяналт шинжилгээг сүүлийн 30 жилд хийж ирсэн боловч хэмжилт тогтмолжоогүй, шалгуур үзүүлэлтийн тоо хязгаарлагдмал, мэдээ мэдээлэл хомс зэргээс шалтгаалан зөвхөн 2008-2016 оны хяналт ажиглалтын мэдээгээр хамгийн урт хугацааны дүн шинжилгээ хийх боломжтой байна. Энэ хугацаанд хүхэрлэг хий ( $\text{SO}_2$ ), азотын давхар исэл ( $\text{NO}_2$ ) зэрэг хоёр бохирдуулагчийн хяналт шинжилгээг 10 хяналтын цэгт тогтмол хийж иржээ.

Хяналт ажиглалтын хугацаанд янз бүрийн цэгүүдэд хийсэн хэмжилтээр хүхэрлэг хий ( $\text{SO}_2$ )-н жилийн дундаж агууламж  $20 \mu\text{g}$ -аас доош байсан нь ДЭМБ-ын Агаарын чанарын удирдамжид тусгасан 24 цагийн хамгийн их зөвшөөрөгдсөн хэмжээ болон Үндэсний жилийн хүлцэх агууламжтай дүйцэж байна (Зураг 8.1). Азотын давхар исэл ( $\text{NO}_2$ )-ийн агууламж нь Эрдэнэтээс бусад хотод үндэсний MNS 4585:2007 стандартаар тогтоосон жилийн хүлцэх агууламж  $40 \mu\text{g}/\text{m}^3$ , ДЭМБ-ын Агаарын чанарын удирдамжид зөвшөөрөгдсөн хэмжээнээс ялимгүй доогуур байна (Зураг 8.2).

Зураг 8.1:  $\text{SO}_2$ -ийн жилийн дундаж агууламж, сонгосон хотуудаар, 2008-2016 он,  $\mu\text{g}/\text{m}^3$



Эх сурвалж: Байгаль орчны статистик, EP-8.1 Агаарын чанарын төлөв байдлын илтгэлүүд (<http://www.eic.mn>)


Эрдэнэт нь Монголын гурав дахь том хот, дэлхийн хамгийн том зэсийн уурхайнуудын нэг гэдгээрээ танигдсан байна. Тээврийн хэрэгсэл, замын хөдөлгөөн нь азотын давхар ислийн томоохон эх үүсвэр болох хандлагатай. Уул уурхайн салбарт хүхрийн ислийг зэсийн олборлолт, баяжуулалтад ашигладагийн улмаас Эрдэнэт хотод хүхэрлэг хийн нягтшилт өндөр байх магадлалтай хэдий ч хүхэрлэг хийн өндөр хэмжээний агууламжийн тухай нотлох мэдээ мэдээлэл байхгүй байна.

Улаанбаатар хотод хүхэрлэг хий, азотын давхар ислийн хүлцэх агууламжийн хэмжээ хэтэрсэн байдал ажиглагдаж байна (Зураг 8.3). Азотын давхар ислийн жилийн хамгийн дээд хэмжээ болох  $168 \mu\text{g}/\text{m}^3$ -ийг 2013 онд замын хөдөлгөөн бүхий УБ-2 автомат хэмжилтийн цэг дээр бүртгэсэн байна.

Хүчиллэг тундасыг хянах Зүүн Азийн сүлжээний (ХТХЗАС) хүрээнд Монголд 2001 оноос хүчиллэг тунадасанд хяналт тавьж эхэлжээ. Монголд хүчиллэг тундасны хэмжилт ажиглалтыг Улаанбаатар хот, Тэрэлжид байрлах хоёр хяналтын цэг дээр хийж байна. Хүчиллэг тундасыг хянах Зүүн Азийн сүлжээний 2015 оны жилийн тайлангаас үзвэл хяналтын хоёр цэгийн ажиглалтаар  $\text{SO}_2$ ,  $\text{NO}_x$ -ийн агаар дахь ялгаруулалтын улмаас хур тундасан дахь рН-ийн жилийн дундаж хэмжээ нэмэгдсэн тохиолдол


илрээгүй байна (Хүснэгт 8.1). Мониторингийн хяналтыг зөвхөн  $\text{Ca}^{2+}$ ,  $\text{Mg}^{2+}$ ,  $\text{K}^+$ ,  $\text{Na}^+$ ,  $\text{NH}_4^+$ ,  $\text{Cl}^-$ ,  $\text{NO}_3^-$ ,  $\text{SO}_4^{2-}$  зэрэг анион, катионы агууламжийг шүүлтүүрийн багц ашиглан хийж ирсэн байна.

Зураг 8.2:  $\text{NO}_2$ -ийн жилийн дундаж агууламж, сонгосон хотуудаар, 2008-2016 он,  $\mu\text{g}/\text{m}^3$



Эх сурвалж: Байгаль орчны статистик, EP-8.1 Агаарын чанарын төлөв байдлын илтгэлүүд (<http://www.eic.mn>)

Зураг 8.3: Улаанбаатар хотын  $\text{SO}_2$ ,  $\text{NO}_2$ -ийн жилийн дундаж агууламж, 1990-2016 он,  $\mu\text{g}/\text{m}^3$



Эх сурвалж: БОАЖЯ, 2017 он.

Хүснэгт 8.1: Хур тунадас дахь жилийн дундаж рН-ийн жиллэсэн үзүүлэлт, 2001-2015 он

	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Улаанбаатар	6.19	6.38	5.72	6.46	5.99	6.45	6.26	6.28	6.11	5.88	5.44	5.88	5.98	.	6.42
Тэрэлж	6.04	5.75	5.40	5.78	5.26	5.16	5.22	5.43	6.22	5.61	5.26	5.74	4.91	.	5.50


Эх сурвалж: Зүүн Азийн бүс нутгийн хүчиллэг тундасны тайлан илтгэл, Хүчиллэг тундасыг хянах Зүүн Азийн сүлжээ, 2015 он.

Тайлбар: 2014 оны мэдээлэл байхгүй.

Монгол Улс, ялангуяа Улаанбаатарын агаарын бохирдлын гол эх үүсвэр болж буй агаар дахь тоосонцорын агууламжийн мэдээлэл зөвхөн 2009 оноос хойш байгаа боловч 2009-2016 онд  $\text{PM}_{10}$  том ширхэглэгт тоосонцорын хяналтыг Улаанбаатарт тогтмол нэг цэгт хийгээгүй байна.

PM<sub>10</sub> том ширхэглэгт тоосонцорыг 2015 оноос хойш 12 мониторингийн болон дээж авах цэгт хянаж байгаа бол PM<sub>2.5</sub> нарийн ширхэглэгт тоосонцорыг тэдгээрийн зөвхөн 3 нь хянадаг байна. PM<sub>10</sub> том ширхэглэгт тоосонцорын жилийн дундаж агууламжийг Монгол дахь 6 хяналтын цэг болон дээж авах цэгийн 2014-2016 оны тасралтгүй хэмжилтээр хийсэн дүнг Зураг 8.4-т харуулав. PM<sub>10</sub> том ширхэглэгт тоосонцорын жилийн дундаж агууламж Улаанбаатар хотод маш өндөр, ялангуяа УБ-5 автомат хяналтын цэгийн орчинд агууламж нь 200  $\mu\text{m}^3$ -ээс буухгүй байгааг зургаас харж болно. УБ-5 автомат хяналтын цэг нь Сүхбаатар дүүрэгт, хотын төвд байрладаг. Тоосонцорын өндөр агууламжийг гэр хороололд түүхий нүүрс ихээр түлж байгаатай холбон үздэг байна.

Зураг 8.4: PM<sub>10</sub>-ийн жилийн дундаж агууламж, 2014-2016 он,  $\mu\text{m}^3$



Эх сурвалж: ЦУОШГ, 2017 он.

Агаарын бохирдлын үндэсний MNS 4585:2007 стандартын дагуу PM10-ийн 24 цагийн хүлцэх агууламжийг 100  $\mu\text{m}^3$ -ээр тогтоосон нь ДЭМБ-ын удирдамжаар тогтоосон хэмжээнээс нэг дахин илүү байна. PM<sub>10</sub> -ийн жилийн дундажийн хүлцэх хэмжээ 50  $\mu\text{m}^3$  байдаг бол ДЭМБ-ын зөвлөмж болгодог хүлцэх хэмжээ 20  $\mu\text{m}^3$  байна.

Монгол Улсын нийт 3.1 сая хүн амын тэн хагас орчим нь амьдардаг<sup>1</sup>, нэг хавтгай дөрвөлжин километр 306.5 хүн ноогддог, их хэмжээний бохирдолтой нийслэл хот болон өргөн уудам нутагт нэг хавтгай дөрвөлжин километр 0.4-2.6 хүн ноогддог хөдөө орон нутгийн хооронд агаарын чанарын ихээхэн ялгаа байх ёстой хэмээн үздэг. Гэвч Улаанбаатараас гадна хөдөө орон нутагт PM<sub>10</sub> тоосонцорын нягтшилт өндөр байна. Жишээ нь Баянхонгор, Ховдод 2014, 2015 онд жилийн агууламж 120-245  $\mu\text{m}^3$  байсан боловч хяналтыг 2016 онд үргэлжлэн хийгээгүй байна. Мөн Дархан хотод 2009 онд жилийн дундаж агууламж 174  $\mu\text{g}/\text{m}^3$ , 30 минут тутамд хэмжсэн хэмжилтийн хамгийн өндөр утга нь 2,470  $\mu\text{g}/\text{m}^3$  байв. Улаанбаатар хотод орон сууц, байшингийн халаалтад нүүрс түлдэг, гурван том дулааны цахилгаан станц ажилладаг, аж үйлдвэр, барилга ихээхэн эрхэлдэг, 339.626 тээврийн хэрэгсэл ашигладаг зэрэг нь агаарын бохирдлын гол эх үүсвэр хэмээн үзэж байгаа боловч бусад аймгуудын мэдээ мэдээлэл байхгүй байгаа нь бохирдуулагч тодорхой бодисын өндөр агууламжийн талаар хангалттай баримт цуглуулах боломжгүй байна.

Байгаль орчны төлөв байдлын 2008-2010 оны илтгэлд Улаанбаатар хотод PM<sub>10</sub> тоосонцорын жилийн дундаж агууламж 2009 онд 150  $\mu\text{g}/\text{m}^3$ -д хүрсэн, өдрийн хамгийн өндөр дундаж агууламж 2009 оны 12 дугаар сард 1,548  $\mu\text{g}/\text{m}^3$  ажиглагдсаныг УБ-5 хяналтын цэгт тэмдэглэсэн байна. Түүнчлэн зуны улиралд том ширхэглэгт тоосонцорын бохирдол байгаа нь ажиглагдсан байна. Хавар, зуны улиралд уур амьсгал, хөрсний хуурайшилт, салхи шуурга, барилга, замын ажил, ялангуяа замын тоосны улмаас тоосонцорын агуулга үлэмж нэмэгдэж байгааг илтгэлд тэмдэглэжээ. Тус илтгэлд бусад аймаг дахь PM<sub>10</sub>

<sup>1</sup> Нийт хүн ам 2016 онд 3,119,935; Улаанбаатар хотын хүн ам 1,440,447 байжээ. Эх үүсвэр: УСХ.

тоосонцорын агууламжийн мэдээллийг тусгасан байна. Тухайлбал 2009 онд Сүхбаатарт тоосонцорын жилийн дундаж агууламж  $39 \mu\text{g}/\text{m}^3$ , Дарханд  $174 \mu\text{g}/\text{m}^3$  байсан, 30 минут тутамд хэмжсэн хамгийн өндөр дундаж хэмжээ  $2,470 \mu\text{g}/\text{m}^3$  Дарханд тэмдэглэгджээ. Архангай, Орхон, Өвөрхангай аймгуудын төвд жингийн аргачлалыг ашиглан хэмжилт хийсэн байна. Тоосонцорын жилийн дундаж агууламж 2009 онд  $45\text{--}136 \mu\text{g}/\text{m}^3$ , 2010 онд  $51\text{--}95 \mu\text{g}/\text{m}^3$  байв. Энэ мэдээллийг байгаль орчны албан ёсны статистикийн вэб хуудсанд байршуулаагүй байна. Олон аймагт авсан агаарын чанарын хэмжилтийн дүнд үндэслэн Дархан-Уул, Ховд, Хөвсгөл, Орхон аймгийн төвүүдийн агаарын бохирдол бусдаас илүү өндөр байгааг илтгэлд онцолжээ. Түүнчлэн говийн бүсийн Говь-Алтай, Дорноговь, Өмнөговь аймгуудын төвийн агаарын бохирдол үлэмж нэмэгдсэн, зарим тохиолдолд хүлцэх агууламжаас хэтэрснийг илтгэлд тэмдэглэсэн байна.

2015 оны Зүүн Ази дахь агаарын бохирдлын төлөв байдлын дүгнэлтэд<sup>2</sup> Монголын баруун хойноос зүүн өмнөд, Монголын Алтайн нурууны өмнөд хэсгээс Хятадын хойд хэсэг, Монголын өмнөд хилээс БНХАУ-ын Өвөр Монголын Бадайн Жаран говь, Тэнгэрийн говь, Муу усны говь хүртэлх өргөн уудам бүс нутгийг тоосонцор үүсгэх өндөр магадлалтай бүс хэмээн хүлээн зөвшөөрсөн ( $> 500$  тонн/км<sup>2</sup>/жил) байна. Говьд тоос, шороон шуурганы үзэгдлийн жилийн бодит давтамж 19.8/газар, элсэн шуурганы үзэгдлийн давтамж 31.7/газар байна. 2010 оны жилийн нийт тоосны уналын хэмжээ 371.8 сая тонн болсон байна.

PM<sub>2.5</sub> нарийн ширхэглэгт тоосонцорт 2011 онд зөвхөн Улаанбаатар дахь замын хөдөлгөөний УБ-02 хяналтын нэг цэгт хийж эхэлсэн байна. Хяналт шинжилгээг 2011-2016 онд тасралтгүй хийжээ. ЦУОШГ-ын 2 хэмжилтийн цэгт 2014 онд мониторинг хийсэн бол УБ хотын Агаарын бохирдлыг бууруулах газар 2015-2016 онуудад PM<sub>2.5</sub>-ийн хэмжилт хийжээ. PM<sub>10</sub>, PM<sub>2.5</sub> тоосонцорын жилийн агууламжийг нэг цэгт хянасан мэдээ мэдээлэл хязгаарлагдмал боловч энэ хоёр бохирдуулагчийн тооцоолсон харьцаа 0.5 байна. Мөн 2017 оны 5, 6 дугаар сард өдрийн тоосонцорын агууламжийн энэ харьцаа үлэмж буурч, 0.1 болжээ. Хятадын Ус, цаг уурын шинжлэх ухааны академийн мэдээгээр энэ харьцаа хойд Хятадад 0.7 байгаа бол Европын холбоонд PM<sub>2.5</sub>/PM<sub>10</sub> ялгаруулалтын харьцаа 0.5-аас 0.8 хооронд байна. Том ширхэглэгт PM<sub>10</sub> тоосонцорын агууламжид байгалийн эх үүсвэр (тухайлбал говийн тоос, элс) хэрхэн нөлөөлж байгаад дүн шинжилгээ хийгээгүй байна.

Агаарын чанарын байнгын хяналт шинжилгээнд агаар дахь тоос шорооны (PM) дүн шинжилгээ ордоггүй байна. Ийм дүн шинжилгээ хийх нь хүнд метал болон поли-аромат нүүрсустөрөгчийн сацуу талст эд эсийг бүрдүүлэг гол элементүүд болох Al, Si, K, Ca, Fe зэрэг бодисыг илрүүлэхэд хувь нэмэртэй. Нүүрсний шаталт нь PM<sub>2.5</sub> нарийн ширхэглэгт тоосонцорын агууламжийн гол эх үүсвэр болж, PM<sub>2.5</sub> нийт агууламжийн 35-92 хувийг бүрдүүлж байгааг 2008-2009 онд Дэлхийн банкнаас хэрэгжүүлсэн Агаарын үнэлгээ ба эрүүл мэндийн нөлөөллийн суурь судалгаа<sup>3</sup> харуулсан байна. Мөн хөрсний хэсгүүд нь PM<sub>10-2.5</sub> тоосонцорын агууламжийн 70-90 хувийг эзэлдэг байна. Улаанбаатар хотын агаарын тоосонцорын судалгаанаас<sup>4</sup> үзвэл бохирдуулагчийн бүтэц, эх үүсвэр, эх үүсвэрийн байршил нь адил үр дүнг харуулсан байна. Улаанбаатар хотын агаарын бохирдуулагчийн нягтшилтад PM<sub>10</sub>, PM<sub>2.5</sub> тоосонцор нь талст эд эсийг (элс, тоос) бүрдүүлэгч гол элемент бөгөөд том ширхэглэгт PM<sub>10</sub> тоосонцорын гол эх үүсвэр болж байна. Агаарын нарийн ширхэглэгт PM<sub>2.5</sub> тоосонцорын гол эх үүсвэр нь нүүрсний шаталт болохыг тогтоосон байна.


Тропосферын давхарга дахь озоны хяналт шинжилгээг Улаанбаатар хот дахь агаарын чанарын хяналтын 7 цэгт хийж байна. Эдгээр 7 цэгийн 3 нь үндэсний сүлжээнд, 4 нь Улаанбаатар хотын захиргаанд харьяалагддаг. Улаанбаатар хотын захиргаанд харьяалагддаг 4 хяналтын цэгийн хэмжилт зөвхөн 2015 онд эхэлсэн, бүх хэмжилт нь хүлцэх агууламж үндэсний стандартаас доош, ДЭМБ-ын зөвлөмжтэй (8 цагийн дундаж  $100 \mu\text{m}^3$ ) нийцэж байгааг харуулж байна (Зураг 8.5). Улаанбаатар хотод NO<sub>2</sub>-ийн агууламж өндөр байгаатай холбогдон хотын орчинд тропосферын озон бий болох магадлалтай хэмээн үздэг (Зураг 8.3).

<sup>2</sup> Үнэлгээг Зүүн Азийн Хүчиллэг тунадасны мониторингийн сүлжээний Шинжлэх ухааны талаар зөвлөгөө өгөх хорооны -Номхон Судалгааны зохицуулалтын асуудлаархи ажлын хэсэг хийжээ. Эх үүсвэр: Агаарын мониторинг болон эрүүл мэндийн нөлөөллийн Суурь илтгэлийн мэдээллийн дүн шинжилгээний загварчлал.

<sup>3</sup> Source apportionment by receptor modelling from AMHIB data analysis.

<sup>4</sup> Perry K. Davy, Gerelmaa Gunchin, Andreas Markwitz, William J. Trompeter, Bernard J. Barry, Dagva Shagjamba and Sereeter Lodoysamba, "Air particulate matter pollution in Ulaanbaatar, Mongolia: determination of composition, source contributions and source locations", *Atmospheric Pollution Research*, vol. 2, No. 2 (April 2011), p. 126-137.



Зураг 8.5: Улаанбаатар хотын  $O_3$  –ийн жилийн дундаж агууламж, 2011-2016 он,  $\mu/m^3$ 

Эх сурвалж: Байгаль орчны статистик, EP-8.1 Агаарын чанарын төлөв байдлын илтгэлүүд://www.eic.mn)

Фото зураг 8.1: Гуравдугаар Дулааны цахилгаан станц (ДЦС-3)



Монгол орны агаар дахь  $CO$ -ийн хүлцэх агууламж нь ДЭМБ-ын удирдамжийн зөвшөөрөгдсөн хэмжээтэй нийцэж байгаа хэдий ч хэмжилтийг миллиграммаар бус микрограммаар хийж байгаа нь мэдээ мэдээллийн зөрчил үүсгэн харьцуулсан дүн шинжилгээ хийхэд хүндрэл учруулж байна. Нүүрсийг цахилгаан үйлдвэрлэл, ахуйн хэрэглээнд их хэмжээгээр ашигладаг, замын хөдөлгөөн нэмэгдсэн боловч  $CO$ -гийн агууламжийн талаарх 2009-2016 оны мэдээнээс үзвэл хүлцэх агууламж зөвшөөрөгдсөн хэмжээнд байна. Байгаль орчны төлөв байдлын 2002 оны тайлангаас үзвэл өвлийн

улиралд Улаанбаатар хотын гурван дулааны цахилгаан станц цагт 6.76 кг СО агаарт ялгаруулдаг, агаар мандал дахь СО-гийн агууламж зөвшөөрөгдсөн хэмжээнээс 2-4 дахин илүү байв. Энэ хугацааны мэдээ мэдээлэл байхгүй болно.

Байгаа мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзвэл хот суурины агаар дахь PM<sub>10</sub> тоосонцорын өндөр агууламжид анхаарал хандуулахыг шаардаж байна. Хөдөө орон нутагт PM<sub>10</sub> тоосонцорын хэмжилт огт хийдэггүй. Том ширхэглэгт тоосонцорын бүтэц нь бас нэг чухал асуудал бөгөөд үүнд говийн тоос болон хөрсний элэгдлийн тоосны нөлөөллийг тооцох шаардлагатай тулгарч байна. Тоос, шороо салхиар хол тээгдэн, газар эсвэл усанд буудаг. Газар усанд буусан эдгээр тоос шорооны химийн найрлагаас шалтгаалан нуур, гол горхины хүчлийн агууламж ихсэх, ус, том голуудын сав газрын тэжээлийн тэнцвэр өөрчлөгдөх, хөрсний тэжээллэг чанар алдагдах, эмзэг ой болон ургамалд хор хохирол учруулах, экологийн тогтолцооны олон янз байдалд сөргөөр нөлөөлөх, хүчиллэг бороо тунадас орох зэрэг олон төрлийн өөрчлөлт гарч болно. Агаар бохирдуулахаас гадна тоос нь үрийг далдлах замаар ургамлын ургацыг бууруулах, ургамлын гадаргууг нимгэлэх, фотосинтезийн ажиллагааг бууруулах, хөрсний элэгдлийг нэмэгдүүлэх зэргээр ХАА-д ихээхэн сөрөг үр дагавартай. Тоосны шууд бус сөрөг нөлөөлөлд тээврийн зам дарагдах, гол горхины усны чанар өөрчлөгдөх зэрэг орно.

Агаар дахь тоосонцорын агууламж хүний эрүүл мэндэд ноцтой эрсдэл дагуулна. Эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь тоосонцорын хэмжээнээс шууд хамаарна. Бүтцээс эс шалтгаалан 10  $\mu\text{m}$ -ээс том хэмжээтэй тоосонцор амьсгалын замаар дамждаггүй, ийм зөвхөн ил эрхтэнд нөлөөлөх, нүд, арьсны харшил, конъюнктивит үүсгэх, нүд халдварт эмзэг болох зэрэг сөрөг үр дагавартай. Амьсгалын замаар дамжих 10  $\mu\text{m}$ -ээс бага хэмжээтэй нарийн ширхэгт тоосонцор нь хамар, ам, амьсгалын дээд замын хэсэгт хуримтлагдан багтраа, уушигны хатгаа, харшилт ринит, силикоз зэрэг амьсгалын замын өвчин үүсгэдэг. Түүнчлэн нарийн ширхэглэгт тоосонцор нь амьсгалын доод замд нэвтэрч, цусанд орсон нөхцөлд дотоод бүх эрхтэнд нөлөөлөх, зүрх судасны өвчний эх үүсвэр болох магадлалтай.

## 8.2 Ялгаруулалтын түвшний өөрчлөлтийн хандлага

Агаар дахь тоосонцорын ялгаралын анхны шинжилгээг Улаанбаатар хотод анх 2007 онд хийсэн байна. Шинжилгээний илтгэлд PM<sub>10</sub> –ийн ялгаруулалтын 32.8 хувийг цахилгаан станцууд, 22.6 хувийг гэр хорооллын ахуйн эх үүсвэрүүд эзэлж байна гэж үзсэн бол Дэлхийн банкнаас 2009 онд зохион байгуулсан “Улаанбаатар хотын агаарын бохирдол-өнөөгийн байдлын суурь үнэлгээ болон авах арга хэмжээний тухай” хэлэлцүүлгийн илтгэлд шинжилгээний дүнд засвар оруулан, PM<sub>10</sub> –ийн ялгаруулалтын 40.6 хувь нь гэр хороололд, 15.6 хувь нь цахилгаан станцуудад ноогдоно гэж тэмдэглэжээ. Мөн 2011 оны 12 дугаар сард Дэлхийн банкнаас зохион байгуулсан “Улаанбаатар хотын агаарын чанарын дүн шинжилгээ-хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах нь” хэлэлцүүлгийн илтгэлд эл дүгнэлтийг мөн шинэчлэн, бохирдуулагч ялгаруулдаг хоёр эх үүсвэрийг бараг тэнцүү, гэр хорооллын ялгаруулалтыг 38 хувь, цахилгаан станцуудын ялгаруулалтыг 36.8 хувиар тогтоосон байна.

Гэвч эдгээр үзүүлэлтийг эс харгалзан Агаар, орчны бохирдлыг 2017-2025 онд бууруулах үндэсний хөтөлбөрт (ЗГ-ын 2017 оны 98 дугаар тогтоол) Улаанбаатар хотын агаарын бохирдлын судалгаа нь: (1) гэр хорооллын ахуйн хэрэглээний зуух болон ААН-үүдийн 3,200 орчим дулааны халаагуурууд агаарын бохирдлын 80 хувь, (2) 400,000 гаруй тээврийн хэрэгсэл 10 хувь, (3) дулааны цахилгаан станцууд, үнсний сангийн утаа, тоос 5-6 хувь, (4) зам, ил хог хаягдал 5-4 хувийг бүрдүүлдэг гэж тусгасан боловч хөтөлбөрт энэ мэдээллийн эх сурвалжийг дурьдаагүй байна.

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын (ЖАЙКА) хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд цахилгаан станцуудын ялгаруулалтыг анх удаа хэмжиж, дулааны халаагууруудын хэмжилт бүртгэл 2010-2012 онд үлэмж сайжирсан байна. 2010 онд ялгаруулалтын шинэ инвентори хийж, 2010 оныг суурь үзүүлэлт болгон авсан байна. Энэхүү инвенторийг 2011 онд шинэчлэх, ялгаруулалтын инвенторийн системийг боловсронгуй болгох, гарын авлага боловсруулах ажлыг ЖАЙКА-гийн өөр нэг төслөөр хэрэгжүүлсэн байна. Энэхүү төслийн хоёр дахь шатанд ялгаруулалтын инвенторийг цаашид шинэчлэх ажлыг хийж, 2016 оны жилийн тайланд 2010-2016 оны ялгаруулалтын мэдээ мэдээллийг оруулсан байна.

Ялгаруулалтын инвентори нь зөвхөн Улаанбаатар хот болон ялгаруулалтын сонгосон эх үүсвэрүүдийг хамаарч байгаагийн хувьд улсын хэмжээнд агаар бохирдуулагчийн ялгаруулалт, бохирдуулагч гол эх үүсвэрүүдийг тогтоох арга хэрэгсэл болохгүй байна. Ялгаралтын инвенторид дараах салбаруудыг хамруулсан байна:

- Дулааны цахилгаан станцууд, тэдгээрийн үнсний сангуудын ялгаруулалт;
- Дулааны халаагуур болон дотоод эргэлттэй усны халаагуурын станцуудын шаталтын ялгаруулалт;
- Ахуйн хэрэглээний ялгаруулалт, ердийн болон сайжруулсан зуухны ялгаруулалт;
- Тээврийн хэрэгслийн ялгаруулалт, хатуу хучлагатай болон шороон зам, замын гадаргуунаас үүсч буй хөрсний тоосжилтыг тусгайлан тооцсон байна.

Ялгаруулалтын инвенторид аж үйлдвэрийн эх үүсвэрүүд, замаас бусад гадаргуугийн хөрсний тоосны ялгаруулалт, мөн удаан задардаг органик бодис, хүнд метал зэргийг оруулаагүй байна.

Зураг 8.6, 8.7-д 2016 оны байдлаар нийт SO<sub>2</sub>-ийн ялгаруулалтад цахилгаан станцууд зонхилох хувь нэмэр оруулж байгааг (71.1 хувь), NOx-ийн ялгаруулалтад 72.7 хувь эзэлж байгааг харуулжээ.

Өмнөх инвенторийн дүнгээс ялгаатай нь 2016 оны байдлаар цахилгаан станцууд PM<sub>10</sub>-ийн 73.2 хувийг ялгаруулж, бохирдуулагчийн гол эх үүсвэр болсон байна (Зураг 8.8). Инвенторид PM<sub>2.5</sub>-ийн ялгаруулалтын үзүүлэлтийг тусгаагүй, зөвхөн нийт тоосонцорын хэмжээг тооцож, Дулааны цахилгаан станцуудын ялгаруулалт 69.25 хувийг эзэлж, 2016 оны байдлаар зонхилох бохирдуулагч болсон байна.

Тээврийн хэрэгсэл нь 2016 оны байдлаар CO ялгаруулагч гол эх үүсвэр (41.6 хувь) байсан бол цахилгаан станцууд 16.9 хувь, шаталтын зуухнууд 12.3 хувь, айл өрхүүдийн ялгаруулалт 29.2 хувьтай байжээ (Зураг 8.9).

Хүлэмжийн хийн ялгаруулалтын хамгийн сүүлийн инвенторийн (2014) дүнгээс үзвэл 1990-2014 онд CO-ийн ялгаруулалт 63.63-аас 1.54 Gg болтол буурсан байна. 2014 оны CO-ийн ялгаруулалтыг 1990 оныхтой харьцуулвал 95.78 хувиар буурчээ.

#### *Хүлэмжийн хий*


Хүлэмжийн хийн (XX) инвенторид эрчим хүч, аж үйлдвэрийн үйлдвэрлэл болон бүтээгдэхүүний ашиглалт, ХАА, хог хаягдлыг Монгол дахь хүлэмжийн хий ялгаруулдаг гол эх үүсвэрүүд, харин Газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлт болон ойн (ГАГАӨО) салбарыг хүлэмжийн хийн шингээгч хэмээн үзсэн байна.

Монгол дахь XX-н нийт ялгаруулалтын зонхилох 50.01 хувь нь 2014 оны байдлаар эрчим хүчний салбарт ноогдож байсан бол удаах байрыг 48.44 хувиар ХАА-н салбар эзэлж байжээ (Зураг 7.5). 2014 онд Монгол дахь XX-ийн нийт ялгаруулалтын 0.95 хувийг аж үйлдвэрийн үйлдвэрлэл болон бүтээгдэхүүний ашиглалтын салбар гаргаж, харин хог хаягдлын салбар багахан хэмжээг ялгаруулсан байна. XX-н ялгаруулалт 1990-2014 оны хооронд 57.07 хувиар нэмэгдэж, 12,546.57 Gg CO<sub>2</sub>-экв. болжээ (Хүснэгт 7.2).

#### *Озон задлагч бодис*


Монгол Улс 2016 онд 8.18 тонн озон задлагч бодис импортлосон нь бүгд ус-хлор-фторт нүүрстөрөгчийн (НСFC) бүлгийн хөргөгчийн R22 шингэн байсан байна. Импортын саад бэрхшээлээс шалтгаалан нийт зөвшөөрөгдсөн хэмжээ 17.5 тонны 50 хувьтай тэнцэх хэмжээний бодисыг импортлосон байна. Жилийн зөвшөөрөгдсөн хэмжээ нь БОАЖ-ын сайдын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А-429 тоот тушаалаар тогтоосон 1.4 тонн озон задлах потенциалтай дүйцэж байна. 2012 оноос хойш озон задлагч бодисын хэрэглээ 75 орчим хувиар огцом буурчээ (Зураг 8.10).

**Зураг 8.6: SO<sub>2</sub>-ийн ялгаруулалт, салбараар, Улаанбаатар хот, 2010-2016 он, тонн**




Эх сурвалж: Ялгаруулалтын бүртгэл судалгааны тайлан, 2016 он.

**Зураг 8.7: NOx-ийн ялгаруулалт, салбараар, Улаанбаатар хот, 2010-2016 он, тонн**




Эх сурвалж: Ялгаруулалтын бүртгэл судалгааны тайлан, 2016 он.

**Зураг 8.8: PM<sub>10</sub>-ийн ялгаруулалт, салбараар, Улаанбаатар хот, 2010-2016 он, тонн**




Эх сурвалж: Ялгаруулалтын бүртгэл судалгааны тайлан, 2016 он.

**Зураг 8.9: CO-ийн ялгаруулалт, салбараар, Улаанбаатар хот, 2010-2016 он, тонн**



Эх сурвалж: Ялгаруулалтын бүртгэл судалгааны тайлан, 2016 он.

**Зураг 8.10: Озон задлагч бодисын хэрэглээ, 2012-2016 он, тонн**

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2017 он.

### 8.3 Агаарын хяналт шинжилгээний сүлжээний ажиллагаа болон дутуу зүйлс

Монгол Улсад агаарын чанарын мониторинг, хяналт шинжилгээний ажлыг 1977 онд Улаанбаатар хотод хяналтын хоёр цэг байгуулсанаар эхэлж байжээ. 1970-аад оны сүүлч гэхэд Монголд агаарын хяналтын 6 цэгт дээжийн идэвхгүй шинжилгээгээр зөвхөн хоёр үзүүлэлтээр ( $\text{SO}_2$ ,  $\text{NO}_2$ ) чанарын хяналтыг хийдэг байсан бол дараах 10 жилд хяналтын сүлжээг 12 цэгээр нэмэгдүүлжээ. 1990-ээд онд Улаанбаатарт хяналтын хоёр, Дарханд нэг цэгийг нэмж байрлуулсан байна. Байгаль орчны албан ёсны статистикийн мэдээгээр (<http://www.eic.mn>) 2004 оноос хойш сүлжээнд нийт 35 цэг хамрагдах болсон байна. Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн ашиглаж байсан агаарын чанарын хяналтын автомат 4 станцыг Улаанбаатар хотын захиргааны агаарын чанарын хяналтын хэлтэст 2009 онд хандивласан (хэмжигчийг 2013 онд шинэчилсэн) байна. Мөн Францын засгийн газрын дэмжлэгтэйгээр таван суурин, нэг хөдөлгөөнт станцыг 2010 онд авч, Японы ЖАЙКА байгууллагын төслийн хүрээнд нэг автомат станцыг Улаанбаатар хотод 2015 онд суурилуулжээ.

Улаанбаатар хотод байрладаг 11 автомат станцын 6 нь ЦУОШГ хариуцдаг бол 5 нь Улаанбаатар хотын харьяанд ажиллаж байна (Хүснэгт 8.2). Хөдөө орон нутагт, ихэвчлэн аймгийн төвд байрлах бүсийн хяналтын цэгүүд дээр агаарын чанарыг дээжийн идэвхгүй шинжилгээгээр хязгаарлагдмал тооны шалгуур үзүүлэлтээр хийж байна. Агаарын дээжинд дараа нь химийн дүн шинжилгээ хийдэг байна.

Гэвч мониторинг хийсэн хязгаарлагдмал тооны үзүүлэлтүүдийг ангилалынх нь дагуу зохистойгоор харьцуулж үздэггүй байна. Жишээлбэл, озоныг уг нь хоёрдогч бохирдуулагч бодис байдлаар суурь станцуудад голдуу хэмжих ёстой боловч хот суурин газар тодорхойлж байна.

Мөн агаарын чанар муудахад гэр хорооллын ахуйн хэрэглээнээс үүдэлтэй гэсэн нийтлэг ойлголт байдаг боловч гэр хороололд автомат ажиллагаатай 4 станцууд 2009 оноос, 1 станц 2017 оноос ажиллаж  $\text{PM}_{10}$ ,  $\text{PM}_{2.5}$  тоосонцорыг хэмжиж байна.

Байгаа мэдээ мэдээлэл нь агаарын чанарын хяналт тогтмолжоогүй,  $\text{NO}_x$ ,  $\text{SO}_2$ -ийн дээжийн идэвхгүй шинжилгээг эс тооцвол нэг шалгуур үзүүлэлтээр нэг станцад урт хугацаанд хэмжилт хийсэн тохиолдол нэн ховор байна. Иймд агаарын чанарын төлөв байдал, өөрчлөлтийг ойлгох, агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааны үр бүтээмжид үнэлгээ дүгнэлт хийхэд нэлээд хүндрэлтэй юм. Үүгээр үл барам тодорхой бүсэд бохирдуулагчийн агууламж өндөр тэмдэглэгдсэн нөхцөлд хяналт шинжилгээг тасласан тохиолдол хүртэл байна. Улс даяар  $\text{NO}_x$ ,  $\text{SO}_2$ -ийн байнгын хяналтыг хийж байгаа ба үүнд хүлцэх агууламжаас доош агууламжтай бүсийг мөн хамруулдаг. Нөгөө талаар байгаа мэдээ мэдээллийг боловсронгуй болгох, загварчлалын арга хэрэглэх үйл ажиллагаа хэрэгжихгүй байна.



## Хүснэгт 8.2: Улаанбаатар хотын агаарын чанарын мониторингийн сүлжээ, 2017

Станц	Байрлалын онцлог	Бохирдуулагч						Хэмжилтийн хэлбэр	Байгуулагдсан он
		SO <sub>2</sub>	NO <sub>x</sub>	CO	PM <sub>10</sub>	PM <sub>2.5</sub>	O <sub>3</sub>		
<b>ЦУОШГ-ын харьяа</b>									
УБ01	Аж үйлдвэр		√		√		√	идэвхгүй дээж	1977
УБ02	Замын хажууд	√	√		√			автомат	1978
УБ03	Гэр хороолол		√					Химийн анализ	1985
УБ04	Хотын бүс		√		√		√	идэвхгүй дээж	1996
УБ05	Хотын бүс		√		√		√	идэвхгүй дээж	2009
УБ06	Хотын бүс	√						Химийн анализ	2009
УБ07	Үйлдвэрийн бүс		√		√			идэвхгүй дээж	2009
УБ08	Суурь станц	√		√	√		√	идэвхгүй дээж	2010
УБ09	Гэр хороолол		√					Химийн анализ	2010
УБ11	Гэр хороолол		√					Химийн анализ	2011
<b>УБ хотын Агаарын бохирдлыг бууруулах газрын харьяа</b>									
Нисэх		√	√		√	√		идэвхгүй дээж	2009
Баян хошуу		√			√			идэвхгүй дээж	2017
Толгойт		√	√		√	√		идэвхгүй дээж	2009
Зурагт		√	√		√	√		идэвхгүй дээж	2009
Амгалан		√	√		√	√		идэвхгүй дээж	2009

Эх үүсвэр: ЦУОШГ, 2017

Азийн уур амьсгал, цэвэр агаар санаачлагаас гаргасан “Ази дахь агаарын чанарын мониторингийг сайжруулах нь” илтгэлд, Азийн хөгжлийн банк Монгол Улсыг агаарын чанарын мэдээ мэдээлэл цуглуулах, боловсруулахад Чанарын баталгаа/Чанарын шалгалт (QA/QC) аргачлалыг ашигладаг Азийн 17 улсын тоонд оруулсан хэдий ч энэ аргачлалыг ашигладаг давтамжийн үзүүлэлтээр жагсаалтын сүүлд орсон байна. Сайн, бодит мэдээ мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг хангах замаар агаарын чанарын талаарх мэдээ мэдээллийн улмаас ташаа ойлголтод хүрэх явдлыг бууруулахад энэ Чанарын баталгаа/Чанарын шалгалтын аргачлалыг хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

PM<sub>10</sub> тоосонцорын агууламжийн дийлэнхийг хөрсний жижиг хэсэг, харин PM<sub>2.5</sub> тоосонцорын зонхилох хувийг нүүрс шаталтын бодисууд бүрдүүлдэг хэмээн үзэж байгааг харгалзан агаарын чанарын мониторинг хийх, олон нийтэд мэдээлэх, бодлого боловсруулахад дээрх хоёр асуудалд илүү анхаарал төвлөрүүлэх явдал дутагдаж байна.

#### 8.4 Агаарын чанарт нөлөөлөгч хүчин зүйлс

##### *Хөдөө аж ахуй*

Монголын хөдөө аж ахуйн (ХАА) салбарт хөдөө орон нутгийн мал аж ахуй (МАА) зонхилж байна. Нүүдлийн уламжлалт МАА нь агаарын чанарт төдийлөн нөлөөгүй, харин шар шороон шуурга болон уур амьсгалын хатуу ширүүн нөхцөл МАА-д ихээхэн сөрөг нөлөөтэй байдаг байна. Жишээ нь 2009-2010 оны онцгой хүйтэн өвөл зудын улмаас улсын нийт малын 22 хувь хорогдсон байна. Засгийн газар малчдыг их хэмжээний хохирлоос хамгаалах зорилгоор малын индексжүүлсэн даатгалыг Дэлхийн банкны тусламжтайгаар нэвтрүүлсэн байна.

Энэхүү даатгалын системийн дагуу малчид бага хэмжээний (малын хорогдлын түвшин 6 хүртэл хувь) хохиролыг малчид өөрсдөө даах, дунд түвшний хохиролыг (малын хорогдлын түвшин 6-30 хувь) даатгалын компани, харин маш их хэмжээний (малын хорогдлын түвшин 30-аас дээш хувь) хохиролыг Засгийн газар тус тус хариуцахаар тооцжээ. Энэ бол уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээний тус улсад хэрэгжүүлж буй сайн жишээ юм.

### *Эрчим хүч*

Монгол улсад дийлэнхи цахилгаан эрчим хүчийг нүүрс шатаадаг дулааны цахилгаан станцууд үйлдвэрлэдэг нь улсын эдийн засгийг нүүрснээс ихээхэн хамааралтай болгож байна. Дулааны 7 цахилгаан станцын нийлбэр хүчин чадал нь 915 орчим МВт, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс 60 орчим МВт үйлдвэрлэж байна.

Бохирдуулагч бодисын ялгаралтын инвенторийн 2016 оны тайлан илтгэлд дурьдсанаас үзвэл Улаанбаатар хотын 3 ДЦС агаарын чанарт нөлөөлж, SO<sub>2</sub>, NO<sub>x</sub>, PM<sub>10</sub>-ийн ялгаралтын 70 гаруй хувийг эзэлдэг байна. ДЦС-уудын ялгаруулалтыг тогтмол хянадаггүй, нүүрс шатаадаг томоохон станцуудад тогтоосон ялгаруулалтын үндэсний стандарт байхгүй байна. Агаарын тухай 2012 оны хууль, Агаар бохирдуулсны төлбөрийн тухай 2010 оны хуулиар зөвшөөрөл олгох механизм, томоохон суурин эх үүсвэрүүд ялгаруулсан бохирдуулагч бодисын килограмм тутамд (Хүснэгт 3.1) төлбөр төлөх хариуцлагыг зохицуулсан боловч ялгаруулалтын мониторинг тогтмол хийхгүй байгаа нөхцөлд энэ тогтолцоо хэрхэн ажиллах нь тодорхой бус байна. Ийм байдлыг ашиглан ялгаруулагч зарим гол эх үүсвэрүүд, тухайлбал дулааны цахилгаан станцууд агаар бохирдуулсны төлбөр төлөхөөс татгалзах тохиолдол гарч байжээ (Бүлэг 3).

Засгийн газраас цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийг төрөлжүүлэх, 2020 он гэхэд сэргээгдэх эрчим хүчийг ихээхэн нэмэгдүүлж, нийт эрчим хүч үйлдвэрлэлийн 20-25 хувьд хүргэхээр хүчин чармайлт гаргаж байгаа боловч 2017 оны байдлаар сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл зөвхөн 7 хувийг эзэлж байна. Сэргээгдэх эрчим хүчний тухай 2007 оны хуулиар сэргээгдэх эрчим хүчний сан байгуулсан. Сэргээгдэх эрчим хүчний 2005 оны үндэсний хөтөлбөрийн (2005-2020 онд хэрэгжих) дагуу Тайширын усан цахилгаан станцыг байгуулсан боловч усны хомсдлоос шалтгаалан бүрэн хүчин чадлаар ажиллахгүй байна. Засгийн газраас хөдөөгийн бүх малчин өрхийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрээр хангах “100,000 нарны гэр” үндэсний хөтөлбөрийг 1999-2010 онд хэрэгжүүлсний үр дүнд 20-75 ваттын хүчин чадалтай 100,000 бага оврын нарны цахилгаан үүсгүүрийг хөдөө орон нутгийн айл өрх, малчдад нийлүүлсэн нь монголын нүүдэлчин айл өрхийн 70 хувь ногоон эрчим хүч ашиглах боломжоор хангажээ. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд салхины эрчим хүч үйлдвэрлэлийг оновчтой дэмжих тариф тогтоосон нь Салхитын салхины эрчим хүчний үйлдвэрийг 2013 оны 6 дугаар сард ашиглалтад оруулахад ихээхэн түлхэц болсон байна. Засгийн газар нэг МВт-ийн эрчим хүчийг 95 ам.доллараар худалдан авах гэрээг Монголын Цэвэр эрчим хүч- анхны салхины эрчим хүчний компанитай байгуулжээ. Салхитын салхины эрчим хүчний үйлдвэр нь нийт 50 МВт цахилгаан үйлдвэрлэх хүчин чадалтай 31 үүсгүүртэй. Одоо 100 МВ-ын хүчин чадалтай Орхоны усан цахилгаан станцыг байгуулах асуудал хүлээгдэж байна.

АНУ-ын Сэргээгдэх эрчим хүчний үндэсний лабораторийн тооцоогоор Монгол Улс нь сэргээгдэх эрчим хүчний ихээхэн, тухайлбал 2.6 ТВт-ын потенциалтай. Говийн бүсийг жилд 300 гаруй нарлаг өдөртэй, салхины өндөр нөөц бололцоотой, агаарын чийгшилт бага, хүйтэн сэрүүн цаг агаартай тул нарны болон салхины эрчим хүчний үйлдвэрүүд байгуулахад ихээхэн тохиромжтой, Монголын баруун, хойд бүсийн Эг, Сэлэнгэ, Завхан, Ховд голуудын сав газрыг усны цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлийн ихээхэн нөөц боломжтой хэмээн тодорхойлсон байна.

### *Уул уурхайн олборлолт*

Монгол Улс нь ашигт малтмалын ихээхэн нөөцтэй учир уул уурхайн салбар улсын эдийн засгийн хамгийн чухал салбар болдог. Дэлхийн банкны үзүүлэлтээр зэс, алт, уран, мөнгө, нүүрс нь ДНБ-ний 20-30 хувь, жилийн экспортын 89 хувийг тус тус бүрдүүлж байна. Монгол Улсад дэлхийн нүүрсний илрүүлсэн нийт нөөцийн 10 хувь болох 162 тэрбум тонн ноогддог бөгөөд 2011 оны байдлаар 17 нүүрсний томоохон уурхай ажиллаж байна. Нүүрсний уурхайнууд нь олборлосон килограмм нүүрс тутамд агаар бохирдуулсны төлбөр 1 төгрөг төлөх үүрэгтэй, харин уул уурхайн бусад үйл ажиллагаанаас төлбөр авдаггүй байна. Ашигт малтмалын олборлолтын янз бүрийн үе шатанд, ялангуяа хууль бусаар бичил уурхай эрхлэгчид химийн хорт бодис ашиглах тохиолдол гардаг бөгөөд алслагдсан уурхайнууд руу хатуу хучлагатай зам тавигдаагүй байгаа нь хөрсний элэгдлийн гол эх үүсвэр болж байна.

### *Аж үйлдвэр*

Монгол дахь бохирдуулагчдын ялгаруулалтын бүртгэл судалгаанд аж үйлдвэрийн салбарыг хамруулаагүй, аж үйлдвэрийн ялгаруулалтыг тогтоох бохирдуулагчийн мэдээ мэдээлэл, шилжилтийн бүртгэл байхгүй байна.

Фото зураг 8.2: Малчин айлын нарны цахилгааны эх үүсвэр



Агаарын чанарт аж үйлдвэрийн үзүүлж буй сөрөг нөлөөг Дэлхийн банкны Цэвэр агаар төслийн хүрээнд хийсэн зарим судалгаагаар тогтоохыг оролдож, барилгын талбайд их хэмжээний тоос үүсч байгааг харгалзан барилгын үйлдвэрлэлийг агаар бохирдуулагч гол салбар хэмээн дүгнэжээ.

Барилгын бэлтгэл ажлын хүрээнд тоосго, цементийн үйлдвэрлэл эрхлэх шаардлагатай байдаг бөгөөд Улаанбаатар хотод эдгээр материалын хэрэгцээ өндөр байдаг байна. Дээрх хоёр салбар нь элс, шохой олборлох зорилгоор хөрс хуулдаг, дизель хөдөлгүүртэй техник хэрэгсэл ашигладаг, тоосго шатаахад түлш (голдуу нүүрс) ашигладаг, бэлэн бүтээгдэхүүнийг хотын янз бүрийн цэгт тээвэрлэдэг зэргээр агаарын бохирдолд ихээхэн нөлөө үзүүлдэг байна. Нүүрс шатаахад үүссэн үнс, талбайн тоосжилт, хотоос 10 км-ийн зайд ил талбайд элс олборлох зэрэг үйл ажиллагаа явуулж байгаа нь бохирдлын хоёрдагч эх үүсвэр болдог байна.

Арьс ширний үйлдвэрлэл, боловсруулалт агаарын бохирдлын бас нэг томоохон эх үүсвэр юм. Агаар бохирдуулсны төлбөрийн тухай 2010 оны хуульд органик уусгагч үйлдвэрлэгч, импортлогчдод төлбөр төлөхөөр тогтоосон байна.

#### *Тээвэр*

Тээврийн салбар нь  $SO_2$ -ийн нийт ялгаруулалтын 2.2 хувь,  $NO_x$ -ийн нийт ялгаруулалтын 21.5 хувь,  $PM_{10}$ -ийн 1.1 хувь,  $CO$ -гийн 43.6 хувийг тус тус бүрдүүлдгийг 2016 оны бохирдуулагчдын ялгаруулалтын инвенторийн тайлан илтгэлд тэмдэглэсэн байна.  $SO_2$  болон  $PM_{10}$ -ийн ялгаруулалтад уг салбарын эзлэх хувь бага боловч  $NO_x$ , ялангуяа  $CO$ -гийн ялгаруулалтад өндөр хувийг эзэлж байна. Энэхүү тооцоонд зөвхөн авто тээврийн замыг хамруулсан бөгөөд замын тоосжилт нь  $PM_{10}$ -ийн нийт ялгаруулалтын 10.4 хувийг бүрдүүлж байгааг тусад нь тооцоолжээ. ХХЯ-ийн инвенторид тээврийн салбарыг хамруулаагүй байна. Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хуулиар тээврийн хэрэгсэл эзэмшигчид километр тутамд ялгаруулсан  $CO_2$ -ийн ялгаруулалтаар жилийн төлбөр төлөх үүрэг хүлээлгэжээ. Жилийн төлбөр нь ёс төдий, 0.75 – 3.90 ам. доллартай тэнцдэг байна.

#### *Орон сууц*



Өнгөрсөн 20 жилийн хугацаанд Монгол Улс эрчимтэй хотжин хөгжжээ. Байгалийн гамшигт удаа дараа нэрвэгдсэн малчид 2000 оноос эхлэн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах, хамгийн гол нь ажлын боломж эрэлхийлэн нийслэл хот, бусад хот сууринд олноор шилжжээ. Үндэсний статистикийн мэдээгээр нийслэлийн хүн ам 2016 онд 1,440,447 хүрч улсын нийт хүн амын 46 хувийг эзэлж байна. Хүн амын хот сууринд шилжин ирэгсдийг зохих дэд бүтцээр хангаж чадаагүй, Улаанбаатар хотын нийт хүн амын 61 хувь буюу 736,000 оршин суудаг гэр хороололд амьдардаг тооцоо байна. Гэр хороололд ус, цахилгаан, халаалт, хог хаягдлыг цуглуулах байгууламжийн хүртээмж муу, оршин суугчид гэр, эсвэл дулаалга муутай, албан бусаар барьсан байшинд амьдарч байна.

Маш хүйтэн өвлийн улиралд нүүрс, шатах бусад материалын хэрэглээ эрчимтэй нэмэгдэж, ихэнх айл өрх ердийн зуух ашиглаж байгаагийн улмаас агаарын чанарт үлэмж сөрөг нөлөө үзүүлж байна. Гэвч агаарын бохирдолд гэр хорооллын оруулж буй хувь нэмрийн талаарх мэдээ мэдээлэл өөр хоорондоо зөрчилтэй, шаардлага хангахгүй байна. Жишээ нь агаар бохирдуулагчийн инвенторын илтгэлд гэр хорооллыг агаар бохирдуулагч гол эх үүсвэр гэж дурьдсан бол 2016 оны илтгэлд гэр хороололд  $SO_2$ -ийн ялгаруулалтын 2.24 хувь,  $NO_x$ -ийн ялгаруулалтын 3.54 хувь,  $PM_{10}$ -ийн 10.3 хувь,  $CO$ -гийн 28.3 хувийг эзэлж байна гэжээ. Гэр хороололд байршилтай мониторингийн цэгүүд зөвхөн  $SO_2$ ,  $NO_x$ -ийн хэмжилт хийдгийг өмнө тэмдэглэсэн.  $PM_{2.5}$  тоосонцорт ЦУОШГ-ын харьяа гэр хороололд байрлах ганцхан станц хэмжилт хийж байна.

Монгол Улсын Засгийн газар, олон улсын хандивлагчид гэр хороололд олон тооны төсөл хэрэгжүүлж, цэвэр түлш, сайжруулсан зуухаар хангасан бөгөөд одоо ч ийм үйл ажиллагааг үргэлжлүүлж байна. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо 2017 оны улсын төсвийн санхүүжилтийг гэр хорооллын айл өрхийг найдвартай цахилгаанаар хангах, шөнийн цахилгаан хэрэглээний төлбөрийг тэглэх (Бүлэг 3), өрхүүдийг экологид ээлтэй зуухаар хангах, шахмал түлшний хангамжийг нэмэгдүүлэхэд зарцуулах арга хэмжээнд зарцуулах арга хэмжээ авч байна.

## 8.5 Хууль эрх зүй, бодлого, бүтэц зохион байгуулалтын тогтолцоо

### *Хууль эрх зүйн тогтолцоо*

Агаарын тухай 2012 онд шинэчилсэн хууль нь агаарыг хамгаалах, бохирдлоос сэргийлэх, бууруулах, хянах үйл ажиллагааг зохицуулах үндсэн хууль эрх зүйн механизм юм. Хуульд төрийн захиргааны байгууллагууд, компаниуд, ААН, иргэдийн эрх үүргийг тодорхойлж өгчээ. Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааны зарчмыг тусгай бүлэгт авч үзсэн байна. Энд тодорхойлсон 7 үйл ажиллагааны дөрөв нь гэр хороололд чиглэгдсэн, хоёр нь хөдөө орон нутагт таатай нөхцөл бий болгох замаар хот суурины бохирдлыг бууруулах, сэргийлэхтэй холбоотой, нэг нь агаарын бохирдолтой тэмцэхэд чиглэгдсэн инновацийг дэмжих зорилготой байна. Дулаалгыг сайжруулах, сайжруулсан зуух, яндангийн шүүлтүүр, экологид илүү ээлтэй түлш ашиглах, цахилгааны шугамд холбогдох, сэргээгдэх эрчим хүч ашиглах зэргээр агаар хамгаалах үйл ажиллагаанд оролцож байгаа айл өрхийг урамшуулах асуудлыг хуульд тусгажээ. Жишээ нь шөнийн цахилгааны төлбөрийг бууруулах шийдвэр нь Агаарын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн шаардлагыг хангасан (дулаалга, цахилгааны 2 фазтай тоолуур г.м.) айл өрхөд үйлчлэхээр заасан байна. Хуульд бохирдуулагч гол суурин эх үүсвэрүүдэд ялгаруулалтын хяналт мониторинг хийх төхөөрөмж суурилуулах, ялгаруулалтын стандартыг зөрчвөл торгууль ноогдуулахаар заасан байна. Ялгаруулалтын стандартыг зөрчсөн байгууламжид ноогдуулах дээд торгууль нь сарын цалингийн доод хэмжээг 9 дахин нэмэгдүүлж тооцохоор тогтоосон нь үр өгөөж, ашиг муутай байна. “Бохирдуулагч гол суурин эх үүсвэр” хэмээн нэрлэгдэж байгаа байгууламжуудад жилд 100 тонн гаруй төрөл бүрийн бохирдуулагч бодис, эсвэл 5 тонн гаруй аюултай бохирдуулагч бодис ялгаруулж байгаа эх үүсвэрүүдийг хамруулдаг байна.

Агаар бохирдуулсны төлбөрийн тухай 2010 оны хуульд (2012 онд шинэчлэн найруулсан) нүүрс олборлогчид, органик уусгагч ашиглагчид, үйлдвэрлэгчид, импортлогчид, тээврийн хэрэгсэл эзэмшигчид, гол суурин эх үүсвэр болон агаар бохирдуулагч бусад эх үүсвэрээс төлбөр авахаар тусгасан байна. Хуульд ялгаруулалтын стандартыг зөрчсөн заалтыг боловсронгуй болгон, гол суурин эх үүсвэрийн ялгаруулалт нь стандартаас хэтэрсэн (хуулиар тогтоосон мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн) тохиолдолд байгаль орчны байцаагч хохирлыг арилгах арга хэмжээ авах, хохирлын үнийг гурав нугалсантай тэнцэх нөхөн төлбөрийг бохирдуулагчид ноогдуулах, нөхөн төлбөр хийгдсэн эсэхийг хянах, хохирлыг бүрэн арилгахаар заасан байна. Энэхүү заалт нь Агаарын тухай хуулийнхаас илүү хатуу шаардлагатай боловч агаарын бохирдлоос үүссэн “хохирлыг арилгах, сэргээх”, хохирлын

үнэ, хэмжээг тогтоох зэргээс шалтгаалан хэрэгжүүлэхэд нэлээд бэрхшээлтэй тулгардаг байна. Хуулиар бохирдуулагч бодисыг агаарт ялгаруулсаны төлбөрийн хэмжээг нэг килограмм бохирдуулагч бодист 10-30 төгрөг байхаар тогтоожээ. Тээврийн хэрэгслийн жилийн CO<sub>2</sub> ялгаруулалтын төлбөр нь километр тутмын CO<sub>2</sub> ялгаруулалтын хэмжээнээс хамааран 1800-2500 төгрөг, 120 гр/км болон түүнээс доош CO<sub>2</sub> ялгаруулдаг тээврийн хэрэгсэл, комбайн болон тракторыг төлбөрөөс чөлөөлөхөөр заажээ. Үндэсний аюулгүй байдал, олон нийтийн ашиг сонирхлын үүднээс зарим эрчим хүч, түүхий нүүрс үйлдвэрлэгчдийг төлбөрөөс чөлөөлөх буюу хөнгөлөлт үзүүлдэг байна.

Ахуйн хэрэглээний халаалт, дулааны цахилгаан станц, уурын болон усан халаалтын зуух, хог хаягдал шатаах зуух, крематорийн агаарын бохирдуулагч ялгаруулах зөвшөөрөгдсөн дээд хэмжээг үндэсний MNS5457:2005, MNS5919:2008, MNS6298:20, MNS6342:2012, MNS5606-1:2006 стандартуудаар зохицуулж байна. Эрх зүйн тогтолцоонд дүн шинжилгээ хийхэд хууль тогтоомжид эдгээр стандартыг огт дурьдаагүй учир стандартуудыг заавал даган мөрдөх ёстой эсэх нь тодорхойгүй байна.

#### *Бодлогын тогтолцоо*

Агаар хамгаалах хөтөлбөр (ЗГ-ын 1999 оны 82 дугаар тогтоол), түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 1999 онд боловсруулж, тэдгээрийг дагалдан олон тооны судалгаа, төсөл, бодлогын баримт бичиг гарсан байна.

#### Хөгжлийн бодлогын үндсэн баримт бичгүүдэд агаарын бохирдлын асуудал туссан байдал

Сүүлийн жилүүдэд гарсан хөгжлийн бүх үндсэн баримт бичиг, тухайлбал 2014 оны Ногоон хөгжлийн бодлого, 2015 оны Монгол улсын зорилтот хувь нэмэр баримт бичиг, 2016 оны Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны мөрийн хөтөлбөр, 2016 оны Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, 2017 оны 2017-2025 онд Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр зэрэгт агаарын бохирдлын асуудлыг тусгасан байна.

Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт нүүрс үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлэх, байгаль орчны хяналт мониторингийг сайжруулах, ялангуяа байгальд сөрөг нөлөөтэй аж үйлдвэрийн үйлдвэрлэлд анхаарал хандуулах, байгаль орчин, уур амьсгалын сан байгуулах, бохирдлыг бууруулах үйл ажиллагааг тусгажээ. Байгаль орчныг хамгаалах, бохирдлоос сэргийлэх, хяналт тавих ерөнхий үйл ажиллагаанаас гадна уг цогц баримт бичигт байгаль орчинтой холбоотой зорилтуудыг салбарын бодлогод тусгах, тогтвортой, ногоон эдийн засаг, сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашиг, тогтвортой болон байгальд ээлтэй тээврийг сурталчлах, байгаль орчны боловсролыг сайжруулах, байгаль орчны талаарх олон нийтийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх олон талт арга хэмжээг онцолсон байна.

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх үзэл баримтлалын 2016-2020 онд хэрэгжүүлэх нэгдүгээр үе шатанд хотын төлөвлөлт, орчныг сайжруулах, харин 2 дахь зорилгын хүрээнд Улаанбаатар хотын агаарын бохирдлыг арилгахаар төлөвлөжээ. Энэхүү баримт бичгийн цар хүрээг харгалзвал дээрх зоримог зорилтыг хэрхэн хэрэгжүүлэх нарийн асуудлыг тусгаагүй нь ойлгомжтой. Үзэл баримтлалын хэрэгжилтийн түвшинг тогтоох шалгуур үзүүлэлтийн жагсаалт, тухайлбал байгаль орчны төлөв байдлын индексийг Засгийн газар баталсан байна. 2030 он хүртэлх Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг баталсан УИХ-ын тогтоолд УИХ, Засгийн газрын баталсан үндэсний, салбаруудын болон салбар хоорондын бодлого нь Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай зохицож, нийцэж байгаа эсэхэд хяналт үнэлгээ хийх, шаардлагатай бол бодлогыг шинэчлэн боловсруулах үүргийг Засгийн газарт ноогдуулсан байна.

Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад оруулах үндэсний хувь нэмрийн зорилгын хүрээнд Монгол Улс “Үндэсний зорилтот хувь нэмэр” баримт бичгийг 2015 онд боловсруулж, түүнд агаарын бохирдлыг бууруулах асуудлыг тусгасан байна. Баримт бичигт үр ашиг сайтай сайжруулсан зуухаар айл өрхүүдийг хангах замаар түлш ашиглалтыг багасгах, автобусны түргэн үйлчилгээний системийг хөгжүүлэх, Улаанбаатар хотын нийтийн тээврийн тогтолцоог сайжруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхээр заажээ. Түүнчлэн 2014 онд нийт эрчим хүч үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь 7.62 байсныг 2020 онд 20 хувь, 2030 онд 30 хувьд хүртэл нэмэгдүүлэх, цахилгаан дамжуулалтын алдагдлыг багасгах, барилга байгууламжийн дулааны алдагдлыг 2014 оны түвшингөөс 2020 он гэхэд 20, 2030 он гэхэд 30 хувиар бууруулах, дулааны цахилгаан станцын үр ашгийг нэмэгдүүлэх, эрчим хүч үйлдвэрлэлд хэт өндөр даралтын нүүрс шатаах дэвшилтэт технологи нэвтрүүлэх зэргээр 2030 он



гэхэд станцын дотоод эрчим хүч ашиглалтыг бууруулах асуудлыг баримт бичигт заажээ. Тээврийн салбарын хувьд хатуу хучилттай замын сүлжээг нэмэгдүүлж, тээврийн үйл ажиллагаанаас ялгарах тоос шорооны хэмжээг багасгахаар төлөвлөжээ. Аж үйлдвэрийн салбарын хувьд цемент үйлдвэрлэлд хуурай технологи нэвтрүүлэх, шинэчлэх замаар ялгаруулалтыг бууруулахаар төлөвлөжээ.

Ногоон хөгжлийн 2014 оны бодлогод агаарын чанарыг сайжруулах өнөөгийн бодлогыг боловсронгуй болгох асуудлыг чухалчлан, улсын байгаль орчны асуудлуудыг шийдвэрлэх, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад Монгол Улс ногоон хөгжлийн стратеги боловсруулах шаардлагатайг чухалчлан тэмдэглэсэн байна.

#### *Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр*



Агаарын чанарыг сайжруулах асуудлаарх хамгийн сүүлд боловсруулсан нэлээд цогц, дэлгэрэнгүй бодлогын баримт бичиг бол 2017 онд баталсан Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр юм. Хөтөлбөрийг 2017-2025 онуудад 2017-2019 оны богино, 2020-2025 оны дунд хугацааны хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Хөтөлбөрт 5 салбарт хэрэгжүүлэх 60 үйл ажиллагааг тусгажээ. Энэ хөтөлбөр нь агаар, орчны бохирдлыг бууруулах зорилготой хэдий ч агаарын бохирдолд голлон төвлөрч, 50 гаруй үйл ажиллагаа нь агаарын бохирдлыг бууруулахад чиглэгдсэн байна. Эдгээр үйл ажиллагааны дийлэнх нь (20 гаруй) нийслэл хотын агаарын бохирдлыг бууруулах, гэр хороололд экологид ээлтэй халаалт болон бусад арга хэмжээ хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна. Тээвэр, барилга, үйлдвэрлэлийн бусад салбарын сөрөг нөлөөг бууруулахад 10 орчим үйл ажиллагаа чиглэгджээ. Бусад үйл ажиллагаа нь стратегийн болон эрх зүйн тогтолцоог сайжруулах, агаарын чанарт хяналт мониторинг хийх, олон нийтийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх зорилготой байна.

Хөтөлбөрт Улаанбаатар хот дахь бохирдуулагч эх үүсвэрүүдэд хийсэн агаарын бохирдлын судалгааны дүн, тухайлбал гэр хорооллын ахуйн хэрэглээний зуух болон ААН-үүдийн 3,200 орчим халаалтын зуух агаарын бохирдлын 80 хувь, 400,000 гаруй тээврийн хэрэгсэл 10 хувь, дулааны цахилгаан станцууд, үнсний хаягдлын сангийн утаа, тоос шороо 5-6 хувь, зам, ил хог хаягдал 5-4 хувийг бүрдүүлдэг гэсэн үзүүлэлтийг суурь болгон ашигласан байна. Хөтөлбөрт дээрх үзүүлэлтийн талаар дэлгэрэнгүй тайлбарлаагүй боловч дулааны цахилгаан станцуудын ялгаруулалт, байгалийн бусад эх үүсвэрүүдийн нөлөөг огт тооцоогүй нь илт байна.

Мэдээ мэдээллийн чанар, эрх зүйн тогтолцоог сайжруулах шаардлагыг хөтөлбөрт хүлээн зөвшөөрсөн байна. Агаарын чанарыг сайжруулах чиглэлээр олон төсөл хэрэгжүүлж, Засгийн газраас тодорхой арга хэмжээ авсан боловч үр дүнгийн системтэй үнэлгээ хийхгүй байна.

#### *Энэхүү бүлэгтэй холбоотой Тогтвортой хөгжлийн зорилт, зорилгууд*

2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн Зорилт 3.9 болон 11.6 –ын биелэлтийг Шигтгээ 8.1-д харуулав.

	<b>Шигтгээ 8.1: Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх хөтөлбөр: Зорилт 3.9 болон 11.6</b>	
<p><u>Зорилго 3. Нийт хүн амыг насан турш эрүүл, сайн сайхан амьдрах нөхцөлөөр хангах</u>  <u>Зорилт 3.9: Химийн хорт бодис, агаар, ус, хөрсний бохирдол, хордуулалтаас үүдэлтэй үхэл, өвчлөлийн тоог 2030 он гэхэд үлэмж бууруулах.</u></p>		
<p>Зорилтын шалгуур үзүүлэлт 3.9.1-ийг (ахуйн болон орчны агаарын бохирдлоос үүдэлтэй нас баралтын түвшин) Монголд хэрэгжүүлэхийн тулд аргачлал болон мэдээллийн эх сурвалжийг тодорхойлох шаардлагатай юм. 2016 оны ДЭМБ-ын “Орчны агаарын бохирдол: хамрал болон өвчлөлтийн дэлхийн үнэлгээ” илтгэлд <math>PM_{2.5}</math> тоосонцорт өртсөн Монгол улсын хүн амын загварчилсан тооцоо, орчны агаарын бохирдлоос үүдэлтэй нас баралтын тоог гаргасан байна. Илтгэлд Монголын хот суурины хүн амын өндөр өртөлтийг <math>51 \mu/m^3</math> гэж тооцсон. Монголд 2012 онд үүний улмаас 100,000 хүн тутамд 40 хүн, нийт 1,123 хүн цаг бусаар нас баржээ. Илтгэлд Монгол Улсыг Номхон далайн баруун бүсийн бага, дунд орлоготой улсуудын бүлэгт хамруулж, энэ бүлгийн улсуудтай харьцуулвал орчны <math>PM_{2.5}</math> тоосонцорын дундаж <math>54 \mu/m^3</math> өртөлтөөс Монголын хот суурины хүн амын өртөлт ялимгүй доогуур байна. Нөгөө талаар Монголын хүн амын тоог авч үзвэл цаг бусаар нас барсан хүний тоо нь бүлгийн дундаж 1102-оос бага зэрэг дээгүүр байна. Хамгийн нийтлэг өвчин нь зүрхний шигдээс байна.</p>		

Агаарын бохирдол эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаатай холбоотой олон судалгааг Монголд хийжээ. Тухайлбал НҮБХС-ийн “Монгол дахь хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлж буй сөрөг нөлөөг шийдвэрлэх” (2016 он), Дэлхийн банкны “ Улаанбаатар хотын агаарын чанарын дүн шинжилгээ- Агаарын бохирдлын түвшин ба чанар эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл” илтгэл (2009 он), ДЭМБ-ын Монгол Улсын орчны эрүүл мэндийн төлөв байдал (2016 он) зэрэг олон баримт бичгийг дурьдаж болно.

НҮБХС-ийн судалгаа нь агаарын бохирдол нь хүүхдэд ихээхэн нөлөөтэй, хүүхэд уушигны хатгаа өвчнөөр нас барах, насан туршийн эрүүл мэнд болон амьдралд нөлөөлөх уушигны өвчний эх үүсвэр болж байгааг харуулжээ. Судалгаанд дотоод орчны агаарын бохирдол эрүүл мэндэд илүү нөлөө үзүүлж байгааг хүлээн зөвшөөрч, цаашид агаарын бохирдолтой холбоотой хүүхдийн өвчлөлийг бууруулахын тулд хүүхдийн орших үндсэн гурван орчин, тухайлбал төрөхөөс өмнөх, гэр бүл болон сургуулийн дотоод орчны агаарын бохирдлыг бууруулахад анхаарахыг тэмдэглэжээ.

Дэлхийн банкны тооцоогоор 2008 онд агаарын бохирдлоос учирсан эрүүл мэндийн хохирол нь Улаанбаатар хотын ДНБ-ний 18.8-27.9 хувь, улсын ДНБ 8.8-13.1 хувьтай тэнцсэн байна. Эрүүл мэндэд үлэмж сөрөг нөлөө үзүүлж байгаа тооцоо гарч байгаа боловч үүнд дотоод орчны агаарын бохирдлын нөлөө хамрагдаагүй болохыг анхаарах хэрэгтэй.

Монгол Улс дэлхийн хамгийн их нүүрсний нөөцтэй орнуудын нэг, нүүрсний хэрэглээнээс ихээхэн хамааралтай хэдий ч эрчим хүчийг төрөлжүүлэх хүчин чармайлт гаргаж байна. Цаашид нийт хүн амыг хямд, найдвартай, тогтвортой, орчин үеийн эрчим хүчээр хангахын тулд (*Зорилт 7: нийт хүн амыг хямд, найдвартай, тогтвортой, орчин үеийн эрчим хүчээр хангах*) Монгол Улс нь дэлхийн эрчим хүчний үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулах шаардлагатай байна.

#### **Зорилго 11. Хот, суурин газруудын тэгш, хүртээмжтэй, аюулгүй, тогтвортой хөгжлийг дэмжих.**

#### **Зорилт 11.6: 2030 он гэхэд хотуудын байгаль орчинд үзүүлэх нэг хүн тутмын сөрөг нөлөөллийг бууруулах, агаарын чанар, хотын болон бусад хог хаягдлын менежментэд онцгой анхаарал хандуулах.**

Зорилт 11.6-ийн хэрэгжилтийг түүний шалгуур үзүүлэлт 11.6.2 (хот суурингийн хүн амтай харьцуулсан  $PM_{2.5}$ ,  $PM_{10}$  тоосонцорын жилийн бодит түвшин) болон бусад шалгуур үзүүлэлтээр тооцоолдог.

Улаанбаатар хотын агаарын бохирдол нь Монгол Улсын хамгийн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллыг сайжруулсан зуух болон түлшээр хангах, цахилгаан халаагуур ашиглахыг дэмжиж цахилгааны шөнийн тарифыг багасгах, зуух болон халаагуур үйлдвэрлэгч, импортлогч ААН-д дэмжлэг үзүүлэх, хямд орон сууц барих, хотыг ногооруулах зэрэг олон үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Улаанбаатар хотын  $PM_{10}$  тоосонцорын жилийн агууламж (Зураг 8.4) буурсан үзүүлэлттэй байгаа хэдий ч хяналт тогтмолжоогүй, мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ хийгээгүйн улмаас хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг тооцоход хүндрэлтэй байна.  $PM_{10}$  тоосонцорыг Улаанбаатар дахь агаарын чанарын хяналтын автомат 6 станцаар, харин  $PM_{2.5}$  тоосонцорыг ЦУОШГ-ын харьяа зөвхөн ганц станцаар хянаж байна. Мөн  $PM_{10}$ ,  $PM_{2.5}$  тоосонцорыг Улаанбаатар хотын харьяа автомат 5 автомат станцаар (Хүснэгт 8.2) хянадаг байна.

Үйл ажиллагааны дийлэнх нь гэр хорооллын агаарын бохирдлыг бууруулахад чиглэгдэж байгаа боловч гэр хороололд байршилтай станцууд тоосонцорын хяналт хийх боломжгүй, зөвхөн идэвхгүй дээж авах ажиллагаатай байна. Агаарын чанарын байнгын үнэлгээнд элс, тоос, ялангуяа  $PM_{10}$  тоосонцорын нөлөөг тооцдоггүй байна. Нийт 900 МВт-ын хүчин чадалтай Улаанбаатар хотын дулааны 3 цахилгаан станц 2016 онд 4.9 сая тонн нүүрс ашиглаж, 2016 оны Ялгаруулалтын инвенториоор 21,328 тонн  $PM_{10}$  тоосонцор ялгаруулсан байхад үүнд зохих анхаарал хандуулдаггүй, хяналт тогтмолжоогүй байна. Шинжлэх ухааны баримт, найдвартай мэдээлэлд суурилсан зорилтот үйл ажиллагааг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг нотлох хяналт мониторингийг тогтмолжуулаагүй тохиолдолд Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах асуудал нэлээд сорилт бэрхшээлтэй тулгарч болзошгүй байна

#### *Бүтэц зохион байгуулалтын тогтолцоо*

Монгол Улсын Засгийн газар Уур амьсгалын өөрчлөлт болон Агаар хамгааллын үндэсний хөтөлбөрүүдийг батлан, тэдгээрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Засгийн газар нь агаарын бохирдлыг бууруулахад шаардлагатай төсвийг төсөвлөх, Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг боловсруулах, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар УИХ-д тайлагнах үүрэгтэй байна. Агаарын тухай хуульд зааснаар Засгийн газар нь агаарын чанарыг сайжруулах бүсэд цахилгаан түгээх, дамжуулах сүлжээг өргөжүүлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх, гэр хорооллын агаарын чанарыг сайжруулах бүсэд байгаа айл өрхийн дулааны алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх талаар хуульд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлж буй иргэд, ААН, байгууллагыг урамшуулах арга хэмжээ авах үүрэгтэй ажээ. Мөн нийслэл хотод хүн амын хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэхийн тулд бусад бүс,

орон нутагт амьжиргааны илүү таатай нөхцөл бий болгох зорилгоор дэд бүтцийн зохистой төлөвлөгөө боловсруулах үүрэгтэй.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хувьд БОАЖЯ нь агаарын чанарын асуудал, эрх зүй болон бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг зохицуулах, агаарын чанарын хяналт мониторингийг зохион байгуулах, стандарт аргачлалыг боловсруулах, агаарын мэдээллийн санг бүрдүүлэх, гол суурин эх үүсвэрүүдэд зөвшөөрөл олгох үүрэгтэй. БОАЖЯ-нд агаар хамгааллын асуудал эрхэлсэн тусгай газар байхгүй байна.

Цаг уур, орчны шинжилгээний газар нь (ЦУОШГ) Агаарын тухай хуульд дурьдсан мэргэжлийн байгууллагын хувьд агаарын чанарын хяналт мониторинг, тайлан гаргах, агаарт ялгаруулж байгаа бохирдуулагчдын ялгаруулалтын үндэсний инвентори хийх, агаар хамгаалахтай холбоотой үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, олон улсын гэрээгээр озоны давхрагыг хамгаалах үүргийн биелэлтийг хангах зэрэг үүрэгтэй.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь (МХЕГ) хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцана.

Үйл ажиллагаагаа 2011 оноос эхлэн явуулж буй Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны (Бүлэг 1) бүрэлдэхүүнд яамд, МХЕГ, зарим аймгийн засаг дарга нар зэрэг төр засгийн төлөөлөл орж байна.

Монголын засаг захиргааны хуваарилалтын дагуу аймаг, сумдын байгаль хамгааллын үүрэг бүхий нэгжүүд (Бүлэг 1) аймаг, сумын эрх зүй болон бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, ялгаруулалтын бүртгэл судалгааг хөтлөх, олон нийтийг агаарын чанарын мэдээ мэдээллээр хангах, дүүрэг, айл өрхөд экологид ээлтэй халаалтын хэрэгсэлийг нэвтрүүлэх (цахилгаан, хий, халаалтын бусад технологи), агаарын чанарыг сайжруулах бүсэд амьдарч буй бага орлоготой өрхүүдийг байр, байшингийн дулаалгын материал, сайжруулсан зуух, цэвэр түлш, хагас коксжсон нүүрс, шингэн хийгээр хангах үйл ажиллагааг хариуцдаг байна.

Улаанбаатар хотын захиргааны Байгаль, орчныг хамгааллын газарт агаарын чанарын хэлтсийг 2006 онд анх байгуулж, түүнийг 2009 оны 2 дугаар сард Улаанбаатар хотын Агаарын бохирдлыг бууруулах газар болгон өргөжүүлсэн байна.

#### *Эдийн засаг, санхүү, мэдээллийн үйл ажиллагаа*

Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хуулиар тогтоосон агаар бохирдуулсны төлбөр нь ёс төдий (Бүлэг 3) бага хэмжээтэй боловч сүүлийн жилүүдэд Монголд агаар хамгаалах үйл ажиллагаанд ихээхэн хөрөнгө оруулалт хийж, олон улсын тусламжийг татаж чадсан байна. БОАЖЯ-ны мэдээгээр 2011-2015 онд агаарын бохирдлыг бууруулахад Засгийн газар 37 сая ам.доллар, олон улсын хандивлагч нараас нэмэлт 47 сая доллар зарцуулжээ.

#### *Цэвэр агаар сан*

Агаарын тухай 2010 онд батлагдсан хуулийн дагуу Цэвэр агаар санг 2011 оны 1 дүгээр сард анх байгуулжээ. Сангийн шугамаар 1,1000 өрхийг сайжруулсан түлш, 70,000-80,000 өрхийг түлш хэмнэх сайжруулсан зуухаар хангах, Улаанбаатар хотын ногоон бүсийг 1,700 га-гаар өргөжүүлэх, Туул, Сэлбэ, Улиастай голуудын хөндийд ногоон бүс байгуулах, Улаанбаатар хотын жижиг цэцэрлэгт хүрээлэнгүүдийг 2300 га-гаар өргөжүүлэх, гэр хорооллын 33,000 айл өрх хийн түлш ашиглахад дэмжлэг үзүүлэх, тээврийн хэрэгслийн бохирдуулагчийг багасгах, 60 гаруй жижиг, дунд дулааны халаагуурын зуухны технологийн шинэчлэлийг хийх, агаарын бохирдлыг бууруулахын ач холбогдлын талаарх олон нийтийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх зэрэг үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн байна. Сангийн үйл ажиллагааг 2015 оны 11 дүгээр сард зогсоосон (Бүлэг 3) байна.

Агаар, орчны бохирдлыг бууруулах 2017 оны үндэсний хөтөлбөрт агаарын бохирдолтой тэмцэх сан байгуулах, агаарын бохирдлыг бууруулах зорилго бүхий бүх төсөв, нөөцийг нэгтгэх, цогц менежмент, удирдлагыг бүрдүүлэхээр заажээ.

### *Үнэ, тариф*

Цахилгааны тоолууртай гэр хорооллын иргэдэд 2017 оноос эхлэн оройн 9-өөс өглөөний 6 цаг хүртэл шөнийн тэглэх тусгай тариф үйлчлэх болсон байна. Нүүрс түлж агаар бохирдуулдаг зуухаас татгалзаж цахилгаан халаагуур ашиглахыг урамшуулах зорилготой энэ үйлчилгээг өвлийн улиралд (1-3 сар) үзүүлж байна (Бүлэг 3).

### *Агаарын чанарын индекс*

Улаанбаатар хотод агаарын чанарын индексийг (АЧИ) цахим хэлбэрээр хэд хэдэн эх сурвалжаас авч болох хэдий ч үзүүлэлтүүд нь өөр хоорондоо зөрүүтэй байна.

Агаар дахь бохирдуулагчийн (зөвхөн SO<sub>2</sub>, NOx) жилийн дундаж агууламжийн мэдээллийг нийслэл хот, аймгийн төвийн байдлаар Үндэсний Статистикийн хорооны цахим хуудсанд байршуулсан боловч үзүүлэлтийг µg бус мг-аар гаргаж байна (<http://www.1212.mn/statHtml/start.jsp>).

Байгаль орчны мэдээллийн төвийн цахим порталд (<http://www.eic.mn>) мэдээ мэдээллийн хүртээмжээс шалтгаалан SO<sub>2</sub>, NO<sub>2</sub>, PM<sub>10</sub>, PM<sub>2.5</sub>-ийн агууламжийг бохирдуулагчийн хамгийн өндөр агууламжийг давтах хэлбэрээр тооцолж ердийн агаарын чанарын индексэд үндэслэн өмнөх жил, сар, өдрийн дундаж агууламжийг станц тус бүрээр гаргаж байна.

ЦУОШГ-ын <http://www.tsag-agaar.mn> цахим хуудсанд цаг агаарын урьдчилсан мэдээ болон өдрийн, сарын, жилийн агаарын чанарын мэдээг илүү олон үзүүлэлтээр (SO<sub>2</sub>, NO<sub>2</sub>, CO, O<sub>3</sub>, PM<sub>10</sub>, PM<sub>2.5</sub>) гаргаж, зөвхөн Улаанбаатар дахь агаарын чанарыг өөр индекстэй (<http://agaar.mn/index>) холбон харуулж байна. Энэ холбоосыг зөөврийн цахим хэрэгслээр ашиглах боломжтой.

Агаарын чанарын гурав дахь индексийг Улаанбаатар хотын агаарын чанарын цахим хуудсанд (<http://www.ub-air.info/ub-air/en/>) байршуулж, хяналт мониторингийн мэдээ мэдээллийг нийслэл хотын Агаарын чанарын газраас гаргасан мэдээг харуулж байна. Үзүүлэлтүүд хоорондоо зөрүүтэй хэдий ч агаарын чанарын индексийн өнгөт тэмдэглэгээ MNS 4585:2016 үндэсний стандартын дагуу хийгдсэн байна. Мэдээ мэдээллийг <http://agaar.mn/index> дахь үзүүлэлттэй харьцуулах боломжгүй, учир нь цагийн дундаж үзүүлэлтийг бүх хотын хэмжээнд гаргадаг бол өмнөх нь агаарын чанарын индексийг хяналтын станц, цэг бүрээр гаргадаг байна. Мөн <http://www.ub-air.info> цахим хуудсын мэдээлэл агаарын чанарын хасах индекстэй байгаад зарим тодруулга, тайлбар хийх шаардлагатай байна.

Монгол улсын агаарын чанарын MNS 4585:2016 стандартын дагуу агаарын чанарын индексийг  $АЧИ = (BBA / XXX) * 100$  аргачлалаар тооцоолдог байна. Үүнд АЧИ нь агаарын чанарын индекс, BBA нь бохирдуулагчийн агаар дахь агууламж, XXX нь агаарын чанарын стандартаар агаар дахь бохирдуулагчийн зөвшөөрөгдсөн хэмжээ болно. Тооцоолсон бохирдуулагчийн дээд агууламжийг АЧИ гэж үзнэ. Монголд PM<sub>10</sub>-ийн өндөр агууламж бохирдлын гол асуудал болж байгаагаа бөгөөд 24 цагийн хугацаанд PM<sub>10</sub>-ийн агууламжийн дээд хэмжээг 100 µg/m<sup>3</sup>-аар тогтоосон байдаг тул өмнөх тэгшитгэлд байгаа XXX нь 100 –аас дээш байгааг харгалзан ихэнх тохиолдолд АЧИ нь PM<sub>10</sub>-ийн бодит агууламжтай дүйцнэ. Монгол улсын АЧИ-ийн ангилалаар энэхүү индекс 0-50 бол цэвэр, 50-100 бүл хэвийн, 101-250 бол бага дэргийн бохирдолтой, 251-400 бол дунд зэргийн бохирдолтой, 401-500 бол өндөр бохирдолтой гэж ангилж байна. Гэвч энэ ангилал нь буруу ойлголт төрүүлж болзошгүй, тухайлбал PM<sub>10</sub> нь 250 µg/m<sup>3</sup> байсан үед АЧИ нь 250 гэж үзэж, агаар бага бохирдолтой байсан гэж ойлгоход хүргэнэ.

Агаарын чанарын өөр индексийг Монгол улс дахь АНУ-ын ЭСЯ-ны интернэт хуудсанд <http://aqicn.org/city/ulaanbaatar/us-embassy/> байршуулсан байна. Цахим хуудсанд агаарын чанарын урьдчилсан мэдээнээс гадна “*StateAir.mn хуудсанд байршуулсан мэдээ мэдээлэл бүрэн баталгаажсаагүй, алдаатай, засварлагдаж, өөрчлөгдөж болзошгүй, мэдээ мэдээлэл ямарч тохиолдолд албан бус болно*” гэсэн тайлбартай байдаг. Агаарын чанарын энэ индексийг АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлаг зөвхөн PM<sub>2.5</sub>-ийн нягтшилтад суурилан боловсруулдаг байна.

Олон янзын мэдээ мэдээлэл, индекс, тооцоолох аргачлал нь олон нийтийг төөрөгдөлд оруулахын зэрэгцээ албан ёсны мэдээ мэдээллийн чанарт итгэл алдахад хүргэх аюултай. Агаарын чанар муудсан нөхцөлд хүн амд мэдээлэл хүргэх, сонор сэрэмжийг нь дээшлүүлэх хэрэгслийн хувьд Монголд АЧИ-ийг зөвхөн Улаанбаатар хотын хэмжээнд ашиглах боломжтой. Зөвхөн Улаанбаатар хотын агаарын чанарын хяналтын автомат станцууд цаг үеийн бодит мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх чадвартай байна.



## 8.6 Олон улсын гэрээ хэлэлцээр, үйл ажиллагаанд оролцох оролцоо

Хил дамнансан удаан хугацааны агаарын бохирдлын тухай Конвенцийн хүрээнд агаар бохирдуулагчийн алсын зайн тархалтад хяналт тавих, үнэлгээ хийх хамтын ажиллагааны хөтөлбөрийг (ЕМЕР) Европт хэрэгжүүлсэн туршлагад үндэслэн Хүчиллэг тунадасанд хяналт мониторинг хийх Зүүн Азийн сүлжээг (ХТХМХЗАС) байгаль орчны тогтвортой байдлыг хангах, Зүүн Азийн бүсийн хүний эрүүл мэндийг хамгаалах хүчин чармайлтыг дэмжих зорилгоор байгуулжээ. ХТХМХЗАС нь зүүн Ази дахь хүчиллэг тунадасны төлөв байдлын талаар нэгдсэн ойлголтод хүрэх, орон нутаг, улс орон, бүсийн түвшинд шийдвэр гаргахад ашигтай зөвлөмж гаргах, гишүүн орнуудын хооронд хүчиллэг тунадастай холбоотой асуудлаар хамтын ажиллагаа хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой. Монгол Улс нь ХТХМХЗАС-нд оролцогч 17 гишүүн орны нэг бөгөөд нойтон, хуурай тунадасанд (хур тунадас болон агаар дахь бохирдуулагчийн агууламж) хяналт хэмжилт хийх хоёр станц ажиллаж байна. Өнөөгийн байдлаар Улаанбаатар дахь зөвхөн нэг станц хуурай тунадасын мэдээг сүлжээнд нийлүүлж байна. Агаар дахь агууламжийг хянах Тэрэлжийн алслагдсан станц 2012 оноос хойш ажиллаагүй байна.

Монгол Улс Озоны давхрагыг хамгаалах Венийн конвенцийн Монреалийн протоколыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцдог (Бүлэг 6). Монгол Улс озон задлагч бодис үйлдвэрлэдэггүй, протоколын дагуу HCFC-ээс бусад бодисын ашиглалтыг хориглосон байна. HCFC төрлийн бодисыг аажмаар хориглох, 2015 он гэхэд ашиглалтыг 10 хувиар, 2020 он гэхэд 35 хувиар, 2025 он гэхэд 67.5 хувиар бууруулан улмаар 2030 гэхэд 100 хувь хориглохоор төлөвлөжээ. Озон задлагч бодисын импортыг Засгийн газрын 1999 оны 129 дүгээр тогтоолын хүрээнд зөвшөөрөл олгох замаар зохицуулж байна.

Монгол Улс НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенци, Киотогийн протокол, Парисын гэрээнд нэгдсэн (Бүлэг 7) улс. Монгол Улсын үндэсний зорилгот хувь нэмэр баримт бичигт 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгаруулалтыг 14 хувиар бууруулах зорилт дэвшүүлсэн байна. Энэхүү зорилтыг биелүүлэх явцад агаарын бохирдлыг бууруулах дараах дам үр ашиг гарна:

- Зуухны үр ашгийг дээшлүүлэх замаар айл өрхийн түлшний ашиглалтыг бууруулах;
- Улаанбаатар хотын нийтийн тээврийн системийг сайжруулах;
- Хатуу хучлагатай замын үндэсний сүлжээг өргөжүүлэх;
- Хосолмол хөдөлгүүртэй хувийн автомашины эзлэх хувь 2014 онд 6.5 байсныг 2030 онд 13 хувь болтол өсгөх;
- Улаанбаатар хот, аймгийн төвүүдэд автомашины шингэн түлшнээс шингэрүүлсэн хий ашиглахад шилжих;
- Барилга байгууламжийн дулааны алдагдлыг 2014 оны түвшнээс 2020 он гэхэд 20 хувь, 2030 он гэхэд 40 хувиар бууруулах болно.

Монгол Улс мөн Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенцид нэгдсэн (Бүлэг 6). Түүнийг хэрэгжүүлэх 2014 онд шинэчилсэн Үндэсний төлөвлөгөөнд (ЗГ-ын 2014 оны 341 дүгээр тогтоол) хог хаягдлыг ил шатаах, эмнэлгийн хог хаягдлыг устгах, нүүрс шатаадаг дулааны цахилгаан станц, дулааны халаалтын зуух, гэр ахуйн зуухнаас ялгарч буй диоксин, фураны хэмжээг багасгах багц үйл ажиллагааг тусгасан байна. Төлөвлөгөөнд 2020 он гэхэд диоксин, фуран, хар тугалгын зөвшөөрөгдсөн хэмжээг дулааны болон цахилгаан станцуудын хаягдал хийн стандартад нэмж оруулахаар тусгасан байна.

## 8.7 Үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж

### Үнэлгээ

Мэдээ мэдээлэл цуглуулах, боловсруулах, түгээх үйл ажиллагааны зохицуулалттай холбоотой нэлээд дутагдалтай байдал оршиж байгаа бөгөөд 2012 оны Агаарын тухай хуулиар энэ үйл ажиллагааг яамны удирдлага доор ажиллах мэргэжлийн алба хариуцахаар заасан байна. Энэ үүрэг болон бохирдуулагч бодисын агаарт ялгаруулалтын үндэсний инвентори, судалгаа хийх ажлыг Цаг уур, орчны шинжилгээний газар гүйцэтгэж байна. Хуулиар ЦУОШГ нь агаарын чанарын хяналтыг стандартын дагуу явуулах гэрчилгээ авах, мэдээний чанар, шалгалтын процедурыг хэрэгжүүлэх үүрэг ноогдуулаагүй байна.

Агаар хамгаалал нь Монгол Улсын хувьд нэн чухал асуудал учир түүнийг захиргааны дээд байгууллагууд хариуцаж, харин шинжлэх ухаан, мэргэжлийн болон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо хязгаарлагдмал байна. Төр засгийн бодлого нийслэл хотод илүү төвлөрч, бусад бүсийн агаарын чанар



муудаж байгааг төдийлөн анхаарахгүй байгаа нь мэдээ мэдээлэл хомс байгаатай холбоотой байх боломжтой. Агаарын бохирдолд цахилгаан станцууд, гэр хороолол, шороо тоосны үзүүлж буй нөлөөг зохих ёсоор тооцохгүй байна. Бохирдуулагч гол эх үүсвэрүүдийн ялгаруулалтыг тогтмол хянадаггүй, дотоод хяналтыг зохион байгуулдаггүй, гэр хороололд автомат, байнгын хяналтын станцууд байхгүй, агаарын чанарын мэдээг шороон шуурганы хяналт мониторингийн мэдээтэй харьцуулан дүгнэлт хийдэггүй, тоосонцорын агууламжид тогтмол дүн шинжилгээ хийх ажил төлөвшөөгүй байна.

Засгийн газар гэр хороололд олон тооны төсөл хэрэгжүүлж, цэвэр түлш, сайжруулсан зуухаар хангах, байгаль орчинтой холбоотой зорилтуудыг биелүүлэхийн тулд ядуу оршин суугчдад урамшуулал олгох, бусад дэмжлэг үзүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Агаар хамгаалах үйл ажиллагаанд төр засаг, олон нийт ихээхэн анхаарал хандуулж, их хэмжээний хөрөнгө зарцуулсан боловч эрх зүйн тогтолцоо нь “бохирдуулагч нь хариуцлага хүлээх зарчим”-ыг тодорхой дүрэм журам, төлбөр торгууль, ажиллагааны механизмаар баталгаажуулаагүй байна.

#### Дүгнэлт, зөвлөмж

##### Агаарын чанарын мониторинг

Монгол Улс нь агаарын чанарын мониторингийн 35 станц, цэг бүхий агаарын чанарын хяналт мониторингийн томоохон сүлжээтэй боловч зөвхөн 6 нь автомат ажиллагаатай, тэдгээр нь бүгд Улаанбаатар хотод байрлаж байна. Хяналтын бусад цэгүүд голдуу SO<sub>2</sub>, NOx-ийг дээжийн идэвхгүй шинжилгээгээр хянах чадвартай байна. Агаарын бохирдлыг бууруулахад их хэмжээний хөрөнгө зарцуулсан, агаарын бохирдлоос үүдэлтэй эрүүл мэндийн зардлын тооцооноос үзвэл агаарын чанарын хяналт мониторингийн өнөөгийн систем нь бодлогыг боловсронгуй болгох, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг тооцооход зохих дэмжлэг үзүүлж чадахгүй байна. Цаашид хотуудын байгаль орчинд үзүүлэх хүн хүчин зүйлийн сөрөг нөлөөллийг бууруулахын тулд (ТХЗ-уудын Зорилго 11.6) агаарын чанарт онцгой анхаарал хандуулах, агаар бохирдуулагчдын агууламж, ялгаруулалтын талаар найдвартай, нарийвчлал өндөртэй, байнгын, харьцуулах боломжтой мэдээ мэдээлэл цуглуулах ажлыг боловсронгуй болгох нь зүйтэй юм.

#### Зөвлөмж 8.1:

*Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Агаарын чанарын хяналт, мониторингийн техник төхөөрөмжийг илүү бүтээмжтэй, зардал багатай техникээр аажмаар шинэчлэн сүлжээний үйл ажиллагааг боловсронгуй болгох, адил нөхцөлтэй газар орны агаарын чанарын загварчлал гаргах;*
- (b) *Нарийн ширхэглэгт PM2.5 тоосонцор нь хүний эрүүл мэндэд илүү сөрөг нөлөөтэй, PM10 тоосонцортой харьцуулвал тоос, элснээс хамаарал багатайг харгалзан PM2.5 тоосонцорын хяналтад анхаарал төвлөрүүлэх;*
- (c) *Аж үйлдвэр, нүүрсний хэрэглээний нөлөө багатай газарт мониторингийн суурь станцуудыг байгуулж, агаарын бохирдолд байгалийн үзүүлж буй нөлөөг тодорхойлох.*

#### Шороо тоосны мэдээ, мэдээлэл

Монгол Улс, ялангуяа Улаанбаатар хотод тоосонцорыг агаарын гол бохирдуулагч хэмээн үздэг боловч тоосонцорын агууламж, эх үүсвэрийн талаарх шинжлэх ухааны мэдлэг хомс байна. Говь, цөлөөс гаралтай шороон шуурга нь (голдуу шар элсний) тоосонцорын өндөр агууламжийг бий болгодог, шуурганы үеэр Монгол, хойд Хятадын нутагт агаар дахь тоосонцорын дундаж агууламж 1,000 µg/m<sup>3</sup>-ээс давж байгааг хэмжилтийн мэдээлэл харуулж байна.

#### Зөвлөмж 8.2:

*ЦУОШГ нь олон улсын холбогдох байгууллагуудтай хамтран агаар дахь тоосонцорын агуулгад тогтмол дүн шинжилгээ хийх арга туршилагыг нэвтрүүлэх, тоосонцорын агуулга, тухайлбал хүнд метал, поли-аромат нүүрс-устөрөгчийн талаарх мэдээ мэдээллийг тогтмол гаргах, тоосонцорт элс, тоосны үзүүлэх нөлөөлд үнэлгээ хийх шаардлагатай.*

#### Зөвлөмж 8.3:

*БОАЖЯ нь шороон шуурганаас үүдэлтэй тоосонцорын жилийн дундаж агууламжийн тооцоонд оруулахгүй байгаа түүний өндөр агууламжийг тодорхойлох аргачлалыг боловсруулан гаргах шаардлагатай.*

### Агаарын бохирдолын голлох суурин эх үүсвэрүүд

Агаарын тухай 2012 онд шинэчилсэн хуульд бохирдуулагч гол эх үүсвэрүүдийн агаар дахь ялгаралтад хяналт мониторинг хийх тоног төхөөрөмж суурилуулах, ялгаруулалтын стандартыг зөрчсөн нөхцөлд торгууль ноогдуулахаар заасан байна. Гэвч торгууль нь нэн бага учир агаар дахь ялгаруулалтад хяналт мониторинг хийх тоног төхөөрөмж суурилуулах хөшүүрэг болохгүй байна. Цахилгаан станц болон дулааны халаалтын зуухнуудын бохирдуулагч бодис ялгаруулалтын нарийн бодит мэдээ мэдээллийг зөвхөн ЖАЙКА-гийн тусламжаар хэрэгжүүлж буй төслийн хүрээнд хийсэн хэмжилт шинжилгээний мэдээнээс авч, зохистой шийдвэр гаргах, ялгаруулалтын инвенторийн тооцоонд ашиглах боломжтой байна. Төслийн хүрээнд 2010-2012 онд зохион байгуулсан сургалтад байгаль орчны байгууллагуудын 4 мэргэжилтэн, цахилгаан станцын 5 техникийн ажилтныг хамруулсан байна.

#### Зөвлөмж 8.4:

*Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Бохирдуулагч гол эх үүсвэрүүдийн ялгаруулалтад тогтмол хяналт тавих, бохирдуулагч гол эх үүсвэрүүдийн ялгаруулалтын стандартыг зөрчсөн нөхцөлд тэдгээрийн үйл ажиллагааг хязгаарлах, түр хугацаагаар зогсоох тухай Агаарын тухай хуулийн заалтуудын хэрэгжилтийг хангах;*
- (b) *Ялгаруулалтын стандартыг зөрчсөний торгуулийг үр дүнтэй, нөлөөтэй болгох.*

### Агаарын чанарын индекс

Монгол улсын агаарын чанарын стандарт MNS 4585:2016 –д АЧИ-ийг тооцох аргачлалыг тодорхойлж өгсөн. Гэвч энэ АЧИ-ийг тооцох аргачлал нь ихэнх тохиолдолд АЧИ –ийн утга нь агаар дахь  $PM_{10}$  тоосонцорын бодит агуулгатай дүйцэж байгаа тул зарим талаар буруу ташаа ойлголт төрөхөд хүргэж байна.

#### Зөвлөмж 8.5:

*Засгийн газар нь АЧИ-ийг тодорхойлох аргачлалыг өөрчлөх шаардлагатай.*

### Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

Агаар бохирдуулсны төлбөрийн тухай 2010 оны хуульд ялгаруулалтын стандартыг зөрчиж буй гол эх үүсвэрүүдэд ноогдуулах торгуулийг учруулсан хохирлын хэмжээг харгалзан тогтоохоор заасан байна. Агаарын бохирдлоос үүдсэн хамгийн том хохирол бол хүний эрүүл мэндийн хохирол бөгөөд хохирлыг аливаа эх үүсвэр бохирдуулагчийн ялгаруулалтаа хэтрүүлсэнтэй шууд уялдуулах, нөгөө талаар эрүүл мэндийн хохирлыг байгаль орчны уламжлалт аргаар нөхөх, хохирлын мөнгөн хэмжээг тодорхойлох боломжгүй юм. Агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөл, нас баралтыг үлэмж хорогдуулахын тулд ТХЗ-ын Зорилго 3.9 -ын хүрээнд хүн амын агаарын бохирдолд өртөж байгаа байдал, түүний үр дагаврыг тооцох механизм боловсруулах шаардлагатай байна.

#### Зөвлөмж 8.6:

*Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг зохистой хэрэгжүүлэхийн тулд Засгийн газар хүн амын агаарын бохирдолд өртөж байгаа байдлыг тооцох нарийвчилсан аргачлалыг батлах, агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллийн эдийн засгийн өртөг зардлын тооцоог гаргах, ялгаруулалтыг хэтрүүлснээс үүссэн хохирлын хэмжээг ялгаруулалтын хугацаа, бохирдуулагч хорт бодисын агууламж, хэтрүүлсэн хэмжээ зэргийг тооцон гаргах аргачлал батлан хэрэгжүүлэх нь зүйтэй.*

### Бохирдуулагч бодисын улсын хэмжээний ялгарлын тухай эх мэдээ, мэдээлэл

Агаарын тухай 2012 онд шинэчилсэн хуулиар агаар дахь бохирдуулагч бодисын ялгаруулалтын үндэсний инвентори хийх асуудлыг Цаг уур, орчны шинжилгээний газарт хариуцуулсан боловч бохирдуулагч бодисын улсын хэмжээний ялгарлын тухай эх мэдээ, мэдээлэл байхгүй байна. Байгаа мэдээлэл нь зөвхөн Улаанбаатар хотод хамааралтайн зэрэгцээ ялгаруулалтын эх үүсвэрийн ангилал нь олон улсын нийтлэг ангилалтай нийцэхгүй байна.

Зөвлөмж 8.7:

ЦУОШГ нь бохирдуулагч бодисын ялгарлын үндэсний хэмжээний инвентори, тооллогыг хийх, тогтмол шинэчлэх чадавхийг хөгжүүлэх, үүнд Европын агаарын бохирдуулагчийн алсын зайн тархалтад хяналт тавих, үнэлгээ хийх хамтын ажиллагааны хөтөлбөрийн Агаар бохирдуулагчийн ялгаруулалтын инвенторын гарын авлагыг ашиглах, НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенци, түүнтэй холбоотой гэрээ, бусад баримт бичиг, холбогдох шийдвэрүүдийн хүрээнд боловсруулсан ХХЯ-ын инвенторийн арга зүйтэй Монгол улсын ангилал, ялгаруулалтын эх үүсвэрийн мэдээллийг нийцүүлэх арга хэмжээ авах нь зүйтэй.

## Бүлэг 9

### УСНЫ МЕНЕЖМЕНТ

#### 9.1 Усны нөөц

Монгол Улс нь усны нөөц хомс орон юм. Үүний гол шалтгаан нь тус улс Төв Азийн өндөрлөгт байрладаг, хуурай газрын эрс тэс уур амьсгалтай, хур тунадас бага, ууршилт нэн өндөр, ихэнх гол мөрний урсац хилээс гадагш чиглэсэн байдаг явдал юм. Жилд орох хур тунадас нь гадаргуугийн болон газрын доорхи усны гол тэжээл болно. Нийт усны нөөц, урсацын 70 орчим хувь нь улсын нийт нутаг дэвсгэрийн 30 хүртэл хувийг эзлэх Монгол Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулсын сав газар бүрэлдэн бий болдог байна. Монгол улсын усны жилийн нийт нөөцийг 565 тэрбум шоо дөрвөлжин метр гэж тогтоосон байна (Хүснэгт 9.1). Энэхүү усны нийт нөөцийн 88.5 хувь нь нууруудад, 3.4 хувь нь мөсөн голуудад, 6.1 хувь нь голуудын системд, 1.91 хувь нь газрын доорхи усанд хуримтлагдаж байдаг байна.

Хүснэгт 9.1: Усны нөөц, тэрбум м<sup>3</sup>

	Хэмжээ	Эзлэх хувь
Нуурууд, үүнээс:	500.00	88.53
давстай	90.00	
цэнгэг	410.00	
Голууд	34.60	6.13
Мөсөн голууд	19.40	3.43
Газрын гүний ус	10.80	1.91
<b>Нийт</b>	<b>564.80</b>	<b>100.00</b>

Эх үүсвэр: БОАЖЯ, 2017

Монгол Улсын газар нутаг усны гурван ай сав газарт хуваагддаг (Хүснэгт 9.2). Эдгээрээс Төв Азийн хуурай газрын гадагш урсацгүй усны ай сав хамгийн том нь бөгөөд түүнд их нууруудын хотгор, Увс, Хар-Ус, Хар болон Хяргас нуурууд ордог.

Хүснэгт 9.2: Усны нөөцийн усны сав газрын хуваарилалт

	Усны нөөц (км <sup>3</sup> )	Сгв газрын талбайн эзлэх хувь (%)
Хойд мөсөн далайн ай сав	16.90	20.50
Номхон далайн ай сав	13.90	11.50
Төв Азийн гадагш урсацгүй ай сав	3.80	68.00
<b>Нийт</b>	<b>34.60</b>	<b>100.00</b>

Эх үүсвэр: БОАЖЯ, 2017

Монгол орны гол, горхийн нийт урт нь ойролцоогоор 67,000 км. 2016 оны байдлаар нийт 5,585 гол горхийн 263 нь, 11,420 булаг шандын 774 нь ширгэсэн, 106-г нөхөн сэргээсэн, 2214 нуур цөөрөмөөс 346 нь ширгэж, 31-ийг сэргээсэн байна (хүснэгт 9.3).

Хүснэгт 9.3: Гадаргын ус, 2003, 2007, 2011, 2013-2016 он

	Гол, горхи		Булаг, шанд		Нуур, цөөрөм	
	Нийт	хатсан	Нийт	хатсан	Нийт	хатсан
2003	5,230	703	9,058	1481	4,193	760
2007	5,121	831	9,340	2096	2,820	1039
2011	6,681	586	10,557	1587	2,694	417
2013	6,131	394	11,061	1009	2,988	341
2014	5,800	387	10,809	1091	2,738	399
2015	6,122	328	11,667	1102	3,233	495
2016	5,585	263	11,420	774	2,214	346

Эх үүсвэр: БОАЖЯ, 2017

### Фото зураг 9.1: Сэлэнгэ аймгийн газрын гадаргын байдал



Монгол орны гол мөрний 60 орчим хувь нь ОХУ, БНХАУ-ын нутаг руу урсаж, үлдсэн 40 хувь нь говийн нууруудад цутгадаг байна. Улсын усны нөөц нутаг дэвсгэрт тэгш бус хуваарилалттай (хойд хэсэгт хангалттай, өмнөд хэсэгт усны нөөц туйлын хомс), голуудын урсац төдийлөн тогтвортой бус.

Усны горим улирлын болон бүсийн ихээхэн ялгаатай, ялангуяа Төв Азийн хуурай гадагш урсацгүй усны ай сав газарт энэ байдал тодорхой харагдана. Энэ нь өвлийн хүйтэн улиралд гол мөрөн хагас жилээр хөлдөж урсац багасах буюу зогсох, хур тунадасын хэмжээ хойноос урагшлах тусам багасах, говь нутгийн хуурайшилтын улмаас усны ууршилт эрчимтэй явагдах, буюу хөрсөнд шингэж, хуурайшилт нэмэгдэж байгаатай холбоотой юм. Гадаргуугийн усны нөөц, гол мөрний сүлжээ Сэлэнгэ, Хөвсгөл, Булган, Архангай, Төв, Хэнтий аймгуудад бусдаас харьцангуй илүү, Говь-Алтай, Өвөрхангай, Баянхонгор аймгийнх хомс байна.

#### *Гадаргын ус*

Гадаргын усны нөөцийн дийлэнх хувь нь Сибирийн болон Алс Дорнодын томоохон голын эхэнд төвлөрч Хойд мөсөн далай болон Номхон далайд цутгадаг. Хамгийн том голуудад Хэрлэн (1,213 км), Орхон (1,124 км), Сэлэнгэ (1,095 км), Туул (898 км), Завхан (808 км) голууд орно (Хүснэгт 9.4). Сэлэнгэ мөрний сав газар нь Монголын хамгийн том голын сав газар юм.

Монгол улсын баруун, баруун өмнөд нутгийн голууд өндөр уулсаас эх авч, уулын нууруудын дундах сав газраар урсан, ихэвчлэн далайд хүрэлгүй, нууруудад цутгадаг байна.

Монголын бүх голууд жилд дунджаар 140-180 хоногоор хөлдөж, 80-120 см мөсөн бүрхүүл тогтон, нам дор газарт 4 дүгээр сард, харин уулархаг бүсэд 5 дугаар сарын дунд хүртэл мөс хайлдаггүй учир Монгол Улс газрын доорхи уснаас ихээхэн хамааралтай, тус улсын эдийн засагт чухал ач холбогдолтой юм.

#### Мөсөн гол, цэвдэг

Монгол орны 41 уулсын бүсэд 659 км<sup>2</sup> талбай бүхий 262 мөсөн гол байдаг бөгөөд 2016 оны байдлаар эдгээр мөстлийн усны нийт нөөц нь 19.40 тэрбум м<sup>3</sup> байжээ. Мөн 1999 онд мөстлийн усны нийт нөөцийг 63 тэрбум м<sup>3</sup> хэмээн тооцжээ.

Цэвдэг нь Монгол орны хойд хэсгээр тархсан байдаг.



Нуур, цөөрөм

Дөрөвдөгчийн эхэн үед Монгол нутгийн дийлэнх хэсэг нь далай байсан бөгөөд хожим нь хэд хэдэн том сав газарт хуваагдсан нь өнөөгийн нуурууд юм. Хамгийн том нуур нь баруун хойд нутгийн Их нууруудын хотгорын Увс, Хар, Хяргас нуурууд ба тэдний гүн нь хэдэн метрээс хэтэрдэггүй. Буйр, Хөх нуур нутгийн зүүн хэсэгт оршино. Хангайн нурууны хойд талд орших Хөвсгөл нуур нь Хангайн нурууны хойд хэсгийн тевтоны үеийн хотгорыг эзлэн тогтсон.

Монгол орон 1000 гаруй тогтмол, олон тооны түр зуурын нууртайгаас зургаан том нуурын гадаргын талбай 500 км<sup>2</sup> давдаг. 2003 оны тооллогоор нийт 4,000 гаруй нуур цөөрөм бүртгэгдсэн бол 2016 оны байдлаар 2,214 болж цөөрчээ.

Газрын доорхи ус

Монгол орны жилийн ашиглах боломжтой усны нөөцийг 10 тэрбум м<sup>3</sup> гэж тооцдог нь жилийн сэргээгдэх гүний усны нийт 23.644 тэрбум м<sup>3</sup> нөөцийн 42.34 хувийг сэргээгдэх, ашиглагдахуйц гүний усны нөөц эзэлдэг байна.

**Хүснэгт 9.4: Томоохон голууд**

	Сав газар (km <sup>2</sup> )	Голын урт (km)	Сав газрын түвшин (m)	Голын сүлжээний нийт урт (km)
Хойд мөсөн далайн сав газар				
Сэлэнгэ	282,154	1,095	1,500	107,693
Идэр	22,420	465	1,780	22,230
Дэлгэрмөрөн	18,671	440	1,921	8,002
Эг	38,354	510	1,624	13,551
Орхон	131,106	1,124	1,300	85,870
Туул	48,909	898	1,300	11,047
Хараа	14,400	352	1,272	5,359
Ерөө	10,905	388	1,320	5,735
Шишхэд	19,933	341	2,200	11,354
Номхон далайн сав газар				
Хэрлэн	107,040	1,213	1,071	11,793
Онон	27,998	570	1,090	12,756
Улз	37,391	496	720	19,187
Халхгол	7,440	264	720	26,448
Төв Азийн хуурай газрын усны сав газар				
Завхан	68,738	808	2,040	25,204
Туй	8,404	243	2,100	4,461
Онги	16,028	435	1,650	5,274
Байдраг	18,226	310	2,191	..
Таац	6,701	200	1,760	1,599
Ховд	58,514	596	2,700	35,799
Тэс	21,027	426	1,682	5,084
Хануй	32,821	196	1,860	6,660
Хархираа	1,298	70	2,020	571
Түргэн	1,136	94	1,720	1,103
Үенч	3,215	132	1,780	421
Бодонч	6,068	167	1,425	3,917
Булган	9,853	268	2,180	6,713

Эх сурвалж: Байгаль орчин, ногоон хөгжлийн яам: Усны нэгдсэн менежментийн үнэлгээний үндэсний тайлан, Улаанбаатар хот, 2012 он.

## 9.2 Усны чанар

### Усны чанарын ангилал

Монгол Улсын усны MNS 4586-1998 стандартын дагуу усны шалгуур, шинжилгээг 27 үзүүлэлтээр гаргадаг. Гадаргын усны чанарыг температур, хатуулаг, булингар зэрэг физикийн үзүүлэлт; тэжээл, эрдэс, метал, хүчил төрөгч, органик бодис, болон янз бүрийн бохирдуулагч зэрэг химийн үзүүлэлт; бактери, замгийн агууламж зэрэг биологийн үзүүлэлтээр тодорхойлдог байна.

Монгол орны усны чанарын экологийн төлөв байдлыг тогтоох зорилгоор гадаргын усны ангиллыг 2006 онд нэвтрүүлсэн байна. Уг ангилалд усны чанарыг зургаан хэсэгт ангилдаг. Усны чанарын индекс (УЧИ) нь усны ерөнхий төлөв байдлыг, нэн цэвэрээс ( $УЧИ \leq 0.3$ ) маш бохир ( $УЧИ \geq 6.0$ ) хүртэл индексээр тогтоодог (Хүснэгт 9.5) байна. Ангиллыг гаргахдаа 53 хүчин зүйлийн дүн шинжилгээнд суурилж, ангиллыг гадаргын, газрын доорхи, ундны усанд тус тус хэрэглэдэг.

**Хүснэгт 9.5: Усны чанарын индекс**

Усны чанар	Ангилал	Индекс	Өнгийн тэмдэглэгээ
1	Нэн цэвэр	$0 \leq 0.3$	Тод цэнхэр
2	Цэвэр	0.31–0.89	Гүн цэнхэр
3	Бага бохирдолтой	0.90–2.49	Шар
4	Бохирдолтой	2.50–3.99	Улбар шар
5	Бохир	4.00–5.99	Ногоон
6	Маш бохир	$\geq 6.0$	Саарал

Эх сурвалж: БОАЖЯ, 2017 он.

Сүүлийн үеийн судалгаагаар хотын бохир ус цэвэрлэх байгууламж, аж үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагаас гарах хаягдал ус, төрийн эзэмшлийн болон хувийн цэвэрлэх байгууламжаас гарах дутуу цэвэршүүлсэн хаягдал усыг нийтийн татуургад нийлүүлэх, аж үйлдвэрийн болон ахуйн шингэн хаягдал зэрэг нь байгалийн усны нөөцийг бохирдуулагч гол эх үүсвэр болж байна. Иймд цэвэрлэх байгууламжийн хэвийн үйл ажиллагааг хангах, орчин үеийн техник технологи нэвтрүүлэх, тэдгээрт үзлэг засвар тогтмол хийх нь байгаль орчны бохирдлыг бууруулах, ариун цэврийн нөхцөлийг сайжруулахад нэн чухал юм. Ус бохирдуулагч гол бодисуудыг Хүснэгт 9.6 -д харуулав.

**Хүснэгт 9.6: Ус бохирдуулагч, эх үүсвэрээр**

Ус бохирдуулагч	Жишээ	Ахуйн	Аж үйлдвэр
Биологид уусах органик бохирдуулагч	Хүнсний хаягдал	√	√
Удаан задардаг органик бохирдуулагч	Дестицид, уусгагч, поливинил хлорид, Эм, эм зүйн бодис, зүйлс, гормон	√	√
Тэжээл	Азот, фосфор	√	√
Хүнд метал	As, Cd, Co, Cr, Cu, Hg, Mn, Ni, Pb, Sn, Tl		√
Хатуу хаягдал, зүйлс	Пластик, цаас, лааз, жийргэвч, бэлгэвч, хиймэл үс	√	√
Хатуу эд	Элс, тунадас, шавар, коллоид	√	√
Өвчин тээгч	Бактери, нян	√	
Тос	Тос, мазут, өөх	√	√
Давс	Сод, хлорид, сульфат		√

Эх сурвалж: Байгаль орчин, ногоон хөгжлийн яам: Усны нэгдсэн менежментийн үнэлгээний үндэсний тайлан, Улаанбаатар хот, 2012 он.

### Ундны ус

Ундны усны чанарыг үндэсний MNS 0900:2005 стандартаар тогтоодог байна. 2013 оны байдлаар 100 гаруй сумын ус нь ундны усны стандартын чанарыг хангахгүй, 60 хувь нь хатуу бодисын агууламж хэт

өндөр, 40 хувь нь хэт хатуулаг байжээ.

### *Газрын доорхи ус*

Газрын доорхи усны чанарыг MNS 4586-1998 стандартын дагуу тогтоодог боловч гүний усыг ашиглах зориулалтаас нь шалтгаалан ундны усны стандарт, мал усалгааны стандарт, тариалангийн усалгааны стандартыг ашиглаж болно.


### *Байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл*

Ерөнхийдөө гадаргын усны чанарыг сайнаас маш сайн гэж үзэх үндэслэлтэй. Урсгал ус нь эрдэс гэжээлийн агуулга багатай, бага тцмпературтай байх нь урсгал усан дахь биологийн бүтээгдэхүүн, органик бодисын хуримтлалыг хязгаарладаг байна. Голын чөлөөтэй урсгал, усны амьтдын байгалийн тархалт нь усны биологийн өвөрцөц олон янз байдал, байгалийн өвөрмөц нөхцөлийг бүрдүүлэн, уур амьсгалын энэхүү онцлог нөхцөлд дасан зохицсон амьтан ургамлын төрлийг бий болгодог байна. Гүний усыг хүний ундны усанд ашиглаж болох хэдий ч баруун болон өмнөд бүсийн усны олон давхрагын ус эрдэсжилт, сульфатын агуулга өндөртэй байдаг. Энэ үзүүлэлт нь хүний үйл ажиллагаатай холбоогүй, гүний усны сэргээлтийн давтамж, хөрс чулууны бүтцээс шалтгаалдаг байна.

### *Усны эх булаг, ундаргыг хамгаалах*

Усны эх булгийг хамгаалах зорилгоор усны ундарга орчмын олон бүсэд газар ашиглалт болон эдийн засгийн үйл ажиллагааг хязгаарлах арга хэмжээг авч байна. Түүнлэн гол мөрний дагуу ус хамгаалах бүсийг тогтоож, “онолын хувьд” голын гольдригоос 5 метрийн бүсэд хүний ямарваа нэгэн үйл ажиллагаа, нөлөөлөл оруулахгүй, мал бэлчээхгүй байхаар заасан байна. 2016 оны байдлаар голын ундаргын нийт талбайн 44.5 хувийг улсын хамгаалалтад авч, нийт 2,299 булаг шандыг хамгаалалтад хамруулсан байна (Зураг 9.1).

**Зураг 9.1: Хамгаалалттай булаг шандын тоо, 2006-2016 он**



Эх сурвалж: БОАЖЯ, 2017 он.

## **9.3 Усны хэрэгцээ**

Усны хэрэгцээг 2013 онд үнэлж, 2015, 2021 оны хэрэгцээг улсын хөгжлийн гурван хувилбараар (бага, дунд, өндөр), өнөөгийн төр засгийн бодлого, стратегийн баримт бичгүүдтэй уялдуулан урьдчилан тооцоолон гаргасан (Хүснэгт 9.7) байна. Эдгээр хувилбараар тооцолсон 2015, 2021 оны усны хэрэгцээ нь 2010 оны усны нөөцийн ашиглалтаас өндөр байна. Өнөөгийн хэрэглээний дийлэнх хувийг гүний усаар хангаж байгааг харгалзан гадаргын ус ашиглалтыг сайжруулах замаар ус хангамжийг нэмэгдүүлэх боломжтой юм.

**Хүснэгт 9.7: Усны хэрэгцээний урьдчилсан тооцоог улсын хөгжлийн гурван хувилбараар гаргасан байдал, сая м<sup>3</sup>**

Салбар	Дэд салбар	2010	Төсөөлөл					
			2015			2021		
			Бага	Дунд	Өндөр	Бага	Дунд	Өндөр
Дотоод	Хот	51.9	66.4	70.9	78.6	67.2	72.9	81.8
	Хөдөө	3.2	4.1	4.0	4.0	5.9	6.0	6.0
ХАА	МАА	76.9	90.2	94.9	109.4	103.1	108.6	117.3
	Усжуулалт	98.7	125.0	169.8	203.2	165.5	260.8	360.0
Аж үйлдвэр	Уул уурхай	41.5	52.5	81.1	103.5	61.8	111.1	187.8
	Хүнд үйлдвэрлэл	1.3	1.6	1.8	2.3	2.0	2.7	4.7
	Үйлдвэрлэл	3.6	4.4	5.1	6.6	5.6	7.6	13.5
	Барилга	1.2	1.6	2.0	2.4	2.1	3.2	4.5
Эрчим хүч	Цахилгаан станц	33.4	37.8	44.7	54.3	43.9	63.5	97.3
Хот суурин	Худалдааны үйлчилгээ	3.9	4.8	5.6	7.7	6.3	8.7	17.2
	Олон нийтийн үйлчилгээ	5.5	5.8	5.9	6.7	6.0	6.5	8.5
	Ногоон бүсүүд	2.5	2.6	2.6	2.7	2.7	2.9	3.0
Аялал жуулчлал		0.8	1.2	1.4	1.6	2.7	3.4	4.0
Зам, тээвэр		2.7	3.2	3.6	4.1	4.1	4.5	5.0
<b>Нийлбэр, бүгд</b>		<b>327.1</b>	<b>401.2</b>	<b>493.4</b>	<b>587.1</b>	<b>478.9</b>	<b>662.4</b>	<b>910.6</b>

Эх сурвалж: Монгол Улсын Усны цогцолбор менежментийн төлөвлөгөө, 2013 он.

#### 9.4 Усны мониторингийн сүлжээний үйл ажиллагаа, дутагдалтай тал

##### *Гадаргын усны мониторинг*

Цаг уур, орчны шинжилгээний газар (ЦУОШГ), түүний харьяа Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн (УЦУОСМХ), аймгийн ус, цаг уур болон байгаль орчны газрууд, ЦУОШГ-ын аймаг дахь лабораториуд, цаг уур, орчны шинжилгээний төв лаборатори, усны сав газрын захиргаад гадаргын усны чанарын хяналт мониторингийг хариуцаж байна. Гүний усны хяналт мониторингийг БОАЖЯ, УЦУОСМХ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ), ШУТИС, ус хангамж болон уул уурхайн хувийн компаниуд холбогдох чиглэлээрээ хариуцан ажиллаж байна.

Гадаргын усны хяналт мониторингийг УЦУОСМХ –ийн харьяа 191 ус судлалын ажиглалтын цэгүүд 94 гол, 18 нуур дээр хийж байна. Ус судлалын үндэсний сүлжээнд гүний усны горимыг хянах 24 цэг, гидробиологийн дээжийн шинжилгээний 74 ажиглалтын цэг, усны чанар, химийн бодисын агууламжийн хяналтын 142 цэг хамрагдан, үндсэн катион, анион, ууссан хатуу бодис, рН, O<sub>2</sub>, биохимийн шинжилгээ, зарим металын ул мөрийн шинжилгээг хийдэг байна.

##### *Газрын доорхи усны мониторинг*

Газрын доорхи усны мониторингийг БОАЖЯ, УЦУОСМХ, ШУТИС зэрэг байгууллагуудад хийж, үүн дээр уул уурхайн хувийн компаниудын хийх мониторингийн цэгүүд нэмэгдэж байна.

Мониторингийн цэгүүд нь гүний усны зөвшөөрөгдсөн 287 усны цооног, үүнээс 25 нь ундны, бусад нь аж үйлдвэр, уул уурхайн зориулалтынх байна. Хяналтын 250 худаг (цооног) байгаагаас 15 нь автомажсан, мэдээллийг байнга дамжуулдаг, Эдгээрээс 10-г нь уул уурхайн компаниуд, 3-г Улаанбаатарын ундны усны цооногт, 2-ыг стратегийн орд газарт ажиллуулж байна. Бусад гар ажиллагаатай ба ундны усны шинжилгээг сард нэг, аж үйлдвэрийн зориулалтын усны шинжилгээг улиралд нэг удаа авдаг байна. Янз бүрийн байгууллагын харьяанд байгуулагдсан цэвдэгийн хяналт шинжилгээний 100 гаруй цооног бий.

Газрын доорхи усны горим, шинэ нөөцийг ашиглах талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хяналт тогтоох цэгүүд цөөн байгааг харгалзан газрын доорхи усны мониторингийг ихээхэн бэхжүүлэх шаардлагатай байна.

Аймгуудад хаягдал усны гарц дээр хяналт хийх 40 цэгийг ус цэвэрлэх 20 байгууламжид байгуулсан, Улаанбаатарт бохир ус цэвэрлэх 7 байгууламжийн оролт, гарц дээр хяналт хийх нийт 15 цэгийг (7 нь гарцын хяналт хийх) байгуулсан байна.

## 9.5 Ус ашиглалтын менежмент

Монгол улсын усны жилийн ашиглалтыг дундажаар 500 сая м<sup>3</sup> байна гэж тогтоожээ. Ашигласан усны хэмжээг 2012 он хүртэл тооцон гаргасан байна.

Усны тухай 2012 онд шинэчилсэн хуулийг хэрэгжүүлж эхэлснээр усны ашиглалт, хэрэглээг холбогдох байгууллага, хэрэглэгчдийн хооронд байгуулдаг албан ёсны гэрээний үндсэн дээр бүртгэдэг болжээ (Хүснэгт 9.8). 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудтай 97 гэрээ (Хүснэгт 9.9) байгуулсан бол 2016 онд 481 болтол өсч, уул уурхайн салбарт байгуулсан гэрээний тоо мөн хугацаанд бараг нэг дахин нэмэгдсэн байна. Ашигласан усны хэмжээг усны тоолуур, эсвэл “чөлөөт” хэмжилтээр хийж болох ба чөлөөт хэмжилт нь тоолуур ашигласнаас илүү өндөр өртөгтэй байдаг байна. 2012 онд усны 19 тоолуур байрлуулсан бол 2016 онд 188 болсон нь бараг 10 дахин өсчээ.

**Хүснэгт 9.8: Усны хэрэглээ, дүгнэлт, усны тоолуур, 2012-2016 он**

	2012	2013	2014	2015	2016
Ашигласан, хэрэглэсэн ус, сая м <sup>3</sup>	41.2	71.6	96.9	172.3	168
Дүгнэлтийн тоо	97	131	153	523	481
Усны тоолуурын тоо	19	31	55	155	188

Эх сурвалж: БОАЖЯ, 2017 он.

Тайлбар: Ус ашиглуулах дүгнэлт нь эрх бүхий байгууллага, хэрэглэгчийн хооронд байгуулсан албан ёсны баримт бичиг болно.

**Хүснэгт 9.9: Ус ашиглах дүгнэлт гаргуулсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, 2012-2016 он**

	2012	2013	2014	2015	2016
<b>Бүгд, үүнээс</b>	<b>97</b>	<b>131</b>	<b>153</b>	<b>523</b>	<b>481</b>
Хүнсний үйлдвэрлэл	3	2	1	24	20
Хөнгөн үйлдвэрлэл	-	-	2	20	44
Хүнд үйлдвэрлэл	-	-	-	1	1
Барилга, барилгын материалын үйлдвэрлэл	4	6	6	60	43
Эрчим хүч	4	5	10	21	26
Уул уурхай, үүнээс					
Олборлолт, боловсруулалт	83	108	110	153	157
Хайгуул, өрөмдлөгө	-	-	-	69	76
Тариалан	1	-	-	29	12
Усны хангамж	2	10	19	26	31
Нийгмийн үйлчилгээ	-	-	-	55	33
Аялал, рашаан сувилал					
Жуулчны болон амралтын бааз	-	-	-	61	35
Рашаан сувилал, амралт	-	-	5	4	3

Эх сурвалж: БОАЖЯ, 2017 он.

Ус ашиглалтын мэдээгээр 2012 онд нийт 41.2 сая м<sup>3</sup> ашигласан бол 2016 онд 168 сая м<sup>3</sup> хүрчээ. (Хүснэгт 9.10), 2013-2016 онд хэрэглэсэн нийт усны 95.5 хувийг газрын доорхи усны нөөцөөс гарсан гэж тооцсон байна.




Хүснэгт 9.10: Ус ашиглалтын хэмжээ, 2012-2016 он, сая м<sup>3</sup>

	2012	2013	2014	2015	2016
Бүгд	41.2	71.6	96.9	172.3	168
Гадаргын ус	..	3.9	4.4	7.1	6.4
Гүний ус	..	67.6	92.5	165.2	161.6

Эх сурвалж: БОАЖЯ, 2017 он.

Ашигласан нийт усны 39 хувийг аж үйлдвэр (дулааны цахилгаан станцууд, хөнгөн үйлдвэрлэл, барилга), 24 хувийг МАА, 18 хувийг усжуулалт, 18 хувийг ундны болон ахуйн хэрэглээ, 1 хувийг бусад (аялал жуулчлал, ногоон хөгжил, зам) зориулалтаар ашигласан байна (Зураг 9.2).

Зураг 9.2: Ус ашиглалт салбараар, хувиар



Эх сурвалж: БОАЖЯ, 2017 он.

Гүний ус нь усны гол нөөц бөгөөд нийгмийн, эдийн засгийн үндсэндээ бүх салбаруудын үйл ажиллагаа гүний усны хүртээмжээс шалтгаалж байна. Гадаргын усгүй бүсэд мал усалгаанд худгийн ус, ХАА-д гүний усыг усжуулалт болон усны дутагдлыг нөхөх зорилгоор, аж үйлдвэр, уул уурхайн салбарт бүтээгдэхүүний боловсруулалтын зорилгоор ашиглаж байна. Гүний усны чанарыг баталгаажуулах нь ундны усыг ашиглах нэг чухал нөхцөл юм. Хүн амын 99 хувь унданд гүний ус хэрэглэж, зөвхөн нэг орчим хувь гадаргын усыг хэрэглэдэг байна.

#### Хөдөө аж ахуй (ХАА)

Монгол улсын хувьд ХАА нь (мал аж ахуй, усжуулалт) хамгийн их ус ашигладаг салбар юм. ХАА-д усжуулалтын зорилгоор газрын далан ихэвчлэн ашигладаг, тухайлбал улсад хамгийн өндөр Хаяагийн усжуулалтын системийн газрын далан 36 метр ба хиймэл нуурын усны багтаамж 3.9 сая м<sup>3</sup> байна. Гадаргын болон гүний усыг усжуулалтад ашиглахад бороожуулах, дуслын арга, технологийг өргөнөөр хэрэглэдэг байна.

#### Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн ус ашиглалтыг өргөн хэрэглээний бараа, хүнсний бүтээгдэхүүн, хүнд үйлдвэрлэл, уул уурхай, барилга болон барилгын материалын үйлдвэрлэл зэрэг салбаруудаар ангилж болно. Эдгээр салбарын усны нөөц ашиглалтын бодит мэдээ мэдээлэл байхгүй боловч үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний хэмжээг үндэслэн тооцоож болох юм. Жишээ нь өргөн хэрэглээний бараа, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ, тоог үндэслэн ашигласан усны хэмжээг тогтоосон тооцоогоор тус салбар нь жилд 0.8 сая м<sup>3</sup>, Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байрладаг үйлдвэрлэлийн нэгжүүд жилд 0.25-0.3 сая м<sup>3</sup> ус ашигладаг байна.

Арьс ширний үйлдвэрлэл 2010 онд 0.1 сая м<sup>3</sup>, ноос ноолуурын үйлдвэрлэл 0.3 сая м<sup>3</sup> ус ашигласан ба арьс шир, ноос ноолуурын боловсруулалтад 30 гаруй химийн бодис ашигладаг нь усыг ноцтой бохирдуулах нэг шалтгаан болж байна. Улаанбаатар хотын арьс шир, ноос ноолуурын үйлдвэрүүд төв ус хангамжийн системийн усыг ашиглан, хаягдал усыг Харгиа, эсвэл төв цэвэрлэх байгууламжуудад нийлүүлж байна. МХЕГ-ын хяналт шинжилгээний мэдээгээр ноос ноолуур боловсруулах зарим үйлдвэрт үйлдвэрлэлийн хаягдал усыг цэвэрлэх бичил төхөөрөмжүүдийг ашиглаж байна.

**Фото зураг 9.2: Төв аймгийн Заамар сумын Хайлааст багт ус зөөж яваа эрэгтэй хүүхэд**



Хими, биологийн аргаар өдөрт 13,000 м<sup>3</sup> хаягдал ус цэвэрлэх хүчин чадалтай Харгиа ус цэвэрлэх байгууламжийг 1972 онд Зөвлөлтийн технологиор барьжээ. Сүүлийн үед тус байгууламж нь өдөрт 7,000-8,000 м<sup>3</sup> хаягдал ус хүлээн авч байгаа боловч цэвэрлэгээний техникийн болон үйл ажиллагааны элэгдэлд орсны улмаас зарим тохиолдолд хаягдал усыг шууд төв цэвэрлэх байгууламжид нийлүүлж, Туул гол, гүний ус, хөрсний бохирдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна. Харгиа ус цэвэрлэх байгууламжийг 2009 онд төрийн хөрөнгөөр шинэчилсэн байна.

### Эрчим хүч

Усны цахигаан эрчим хүч үйлдвэрлэлийн потенциалыг 5,700 МВ/цаг гэж тооцоолсон ажээ. Дулааны цахилгаан станцууд усыг хөргөлтийн системд, усан цахилгаан станцууд цахилгаан үйлдвэрлэлийн зорилгоор ашигладгийн хувьд эрчим хүчний салбар маш их хэмжээний усыг ашигладаг. Дулааны цахилгаан станцууд 2010 оны байдлаар 30 сая м<sup>3</sup>, усан цахилгаан станцууд 1 тэрбум м<sup>3</sup> ус ашиглажээ. Монголд усан цахилгаан станцууд, тухайлбал Дөргөн, Тайширын станцууд, зарим сумдад бичил станцууд ажиллан цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж байгаагийн дийлэнх нь баруун бүсэд байрладаг, 100 КВ-аас 300 МВ-ын төлөвлөгдсөн хүчин чадалтай. Өвлийн улиралд ихэнх гол мөрөн, далангууд хөлддөг нь усан цахилгаан станцуудын ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг байна.

### Ахуйн хэрэглээ

#### Ундны усны хангамж

Ундны усны хэрэглээний дийлэнх хувийг гүний усаар хангадаг. Ундны усны чанар үндсэндээ сайн, өнөөгийн хангамжийн системийн чадавхи хангалттай байна. Гэвч зарим аймаг, сумдын усны чанар ундны усны чанарын стандартыг хангахгүй, төвлөрсөн хангамжийн систем ихээхэн хуучирч, түүнийг яаралтай шинэчлэх шаардлагатай болсон байна. Хотын хүн ам, эдийн засгийн түргэн өсөлт нь усны хэрэгцээг байнга нэмэгдүүлж, энэ нь усны шинэ дэд бүтэц бий болгохыг шаардаж байна.

Хот, хөдөөд ундны усны нөөц болон хангамж ялгаатай байна. Ундны усыг гүний усаар хангадаг, том хотууд, аймгийн төвүүд, зарим том сумдууд ус хангамжийн төвлөрсөн системтэй байдаг байна. Хотын захын гэр хороолол, сумын төв, хөдөө орон нутагт төвлөрсөн систем байхгүй, усыг зөөж ахуйн хэрэглээг хангаж байна ( Шигтгээ 9.1).

#### Шигтгээ 9.1: Ус нөөцлөх: жендерийн асуудал

Ус нөөцлөх асуудлаар монголд хийсэн судалгаагаар Улаанбаатар хотод ус нөөцлөх, зөөх бүх төрлийн ажиллагааны дийлэнх хувийг эрчүүд, ялангуяа тээврийн хэрэгсэл болон ердийн хөсөг ашиглан зөөхөд зонхилж байна. Өөрөөр хэлбэл эрчүүд, хөвгүүд дугуй, мотоцикл, машин ашиглан ус зөөх ажлыг хийх магадлалтай, зөөврийн ус хэрэглэдэг хотын өрхүүдийн 70 орчимд машинаар ус зөөх ажлыг эрчүүд, ердийн хөсөг ашиглан ус зөөх ажлыг 100 хувь эрчүүд хийдэг байна. Хөдөө орон нутагт тээврийн хэрэгслээр, голдуу мотоциклоор зөөх ажлын 48 хувь, гараар зөөх ажлын 25 хувийг эрчүүд гүйцэтгэдэг тооцоо байна.

Монголд эрчүүд ус зөөх ажилд оролцож байгаа нь жендерийн эрх тэгш байдлыг сайн хангаж байгаагийн илрэл юм. Учир нь зарим улсад эрчүүд ус зөөхийг эр хүнийг гутаасан ажил хэмээн үздэг. Эмэгтэйчүүд харин хэзээ, хэдий хэмжээний ус хэрэгтэй байгааг тогтоодог болох нь судалгаагаар харагдав. Гэвч жендерийн энэ эрх тэгш байдал нь усны менежментийн орон нутгийн, бүсийн шийдвэр гаргах явцад эмэгтэйчүүдийн оролцоог хангах хөшүүрэг болдоггүй байна.

Эх сурвалж: Р.Хоукинс, Ж.Сигэр, Жендер болон Монгол дахь усны асуудал, Мэргэжлийн газар зүйч 62 (1), 16-31, 2010 он; Дэлхийн жендерийн болон байгаль орчны тойм, НҮББОХ, 2016 он.

Улаанбаатар хотын ус хангамжийг хотын Ус сувгийн удирдах газар хариуцаж, түүний мэдэлд төвлөрсөн системийн усны 4 эх булаг, ус дамжуулах насосны 6 станц, гүний 175 худаг, 320 дамжуулах цэг, төвлөрсөн бус усан хангамжийн 305 цэг, 59 ус тээвэрлэх автомашин, 586 км ус дамжуулах хоолой, 147.7 км ус зайлуулах хоолой, гэр хорооллын 172 км ус хангамжийн шугам харьяалагддаг байна. Энэ сүлжээ нь нийслэлийн 1.3 сая хүн амыг ундны ус болон 4500 аж үйлдвэрлэлийн нэгжийг усаар хангадаг байна. Бүх 21 аймгийн төв, зарим хотууд ус хангамж, зайлуулах төвлөрсөн системтэй, тэдгээрийг аймгийн хот тохижуулалтын олон нийтийн байгууллага хариуцдаг байна. Төвлөрсөн системийн бус усны цэгүүд нь хот, суурингийн гэр хороололд жижиг байшинд байрлаж, цахилгаан насос бүхий худаг, усны зөөврийн машинаар үйлчилгээ үзүүлдэг.



Усны өдөр тутмын хэрэглээ

Хотын орон сууцанд амьдарч байгаа иргэдийн өдрийн усны хэрэглээг хүн тутамд 200-350 литр гэж тооцдог бол 2016 оны байдлаар нэг оршин суугчийн өдрийн хэрэглээ 150 литр байжээ (Хүснэгт 9.11). Гэр хорооллын болон хөдөө орон нутгийн оршин суугчдын өдрийн усны хэрэглээ дунджаар 5-10 литр байгаа нь ДЭМБ-гаас тогтоосон доод хэмжээний тэн хагаст ч хүрэхгүй байна. 2012 он гэхэд орон сууц нийтийн үйлчилгээний байгууллагуудын 49.2 хувь, ус хангамж, ус зайлуулах байгууллагууд бараг 100 хувь усны тоолуураар хангагдсан байв.

**Хүснэгт 9.11: Улаанбаатар хотын усны хэрэглээ, 2012-2016 он**

Усны хэрэглээ	2012	2013	2014	2015	2016
Орон сууцны иргэдийн өдрийн усны хэрэглээ, литр	200	189.7	167.8	156.3	150
Усны цэгээс ус авдаг гэр хорооллын иргэдийн өдрийн усны хэрэглээ, литр	8.3	8.9	7.7	8.1	8.1
Ус тээвэрлэх машинаас ус авдаг гэр хорооллын иргэдийн өдрийн усны хэрэглээ, литр	7	7.7	7.4	7.9	7.3
Тооцоогүй усны хэмжээ (хувиар)	19.2	17.4	14.1	13.9	..

Эх сурвалж: УСУГ, 2016 он.

Ус хангамжийн хүрэлцээ, эрүүл ахуй ба Мянганы хөгжлийн зорилтууд

Өнгөрсөн 10-15 жилийн хугацаанд ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг дээшлүүлэх талаар Засгийн газраас тууштай арга хэмжээ авч зохих ахиц дэвшил гарч байна. Гэвч ус хангамж, эрүүл ахуйн нөхцөл, хүртээмжийн талаар албан ёсны мэдээ мэдээлэл, МХЗ-уудтай холбоотой мэдээллийн хооронд ихээхэн зөрчилтэй, эх сурвалж тодорхойгүй байна.

НҮБ-ын МХЗ-уудын мэдээллийн сан, сайжруулсан ундны усны хүртээмжийг дээшлүүлэх тухай 7.8 дугаар шалгуур үзүүлэлтийн дагуу 1990-2015 онд усны хүртээмж 9 хувиар буюу 1990 онд 53 хувь байснаас 2015 онд 64 хувь болж өссөн байна (Хүснэгт 9.12). Усны хүртээмжийн өсөлтийн ихэнх нь хөдөө орон нутагт (168 хувиар) гарсан бол хот сууринд 14 хувиар буурсан сонин үзүүлэлт гарчээ. Мөн сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг дээшлүүлэх тухай 7.9 дүгээр шалгуур үзүүлэлтээр мөн хугацаанд 30.4 хувиар буюу 1990 оны 46 хувиас 2015 онд 60 хувь болтол өссөн, үүнээс хот сууринд 1.5, хөдөөд 104.7 хувиар тус тус өссөн байна.

Монголд хүлээн зөвшөөрсөн МХЗ-уудын эрүүл ахуйн шаардлага хангасан аюулгүй ундны усны эх үүсвэрт хамрагдаагүй хүн амыг бууруулах зорилгын хүрээнд 2015 онд 40 хувь болгох зорилго дэвшүүлсэн энэ үзүүлэлт 1990 онд 45 хувь байсан бол 2010 онд 27.41 хувь болж, 39 хувиар буурсан, байна. Мөн Монголд хүлээн зөвшөөрсөн үндэсний МХЗ-уудын сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амыг бууруулах зорилгын хүрээнд 2015 онд 46 хувь болгох зорилготой байснаас энэ үзүүлэлт 1990 оны 77.40 хувь байсан бол 2010 онд 76.80 хувь болж, 0.8 хувиар буурчээ, Үндэсний МХЗ-уудын 2015 оны үзүүлэлтийн албан ёсны мэдээлэл байхгүй байна.

2013 оны Усны нэгдсэн менежментийн төлөвлөгөөнөөс үзвэл 2010 онд хот суурины 86.7 хувь хамгаалалттай усны эх үүсвэрээс хангагдаж байсан бол хөдөө орон нутгийн зөвхөн 43.5 хувь хамрагдаж байжээ (Хүснэгт 9.13). Эрүүл ахуйн байгууламжийн хувьд 2010 онд хот суурины хүн амын 37.7 хувь нь ариун цэврийн зохих шаардлагыг хангасан, 30.2 хувь төвийн хангамжийн сүлжээнд холбогдсон байв. Хөдөө орон нутгийн хувьд ариун цэврийн байгууламжийн талаарх мэдээлэл байхгүй, тооцоогоор 5 доош хувьтай байна.

Ус сувгийн удирдах газрын мэдээгээр Улаанбаатар хотын эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангагдсан хүн амын эзлэх хувь 2005 онд 94.5 хувь байсан бол 2015 онд 95.2 хувь болж нэмэгдсэн байна.

Хаягдал усны цэвэрлэгээ

Жилд дунджаар 200 сая м<sup>3</sup> хаягдал усыг нийтийн татуургаар дамжуулдаг байна. Цэвэршүүлээгүй хаягдал усыг байгальд шууд асгаж, гадаргын болон гүний усыг бохирдуулах тохиолдол олонтоо гардаг

байна. Цэвэршүүлсэн хаягдал усны хэмжээ 2012 оны 60 сая м<sup>3</sup> (30 хувь) байсан бол 2014 онд 88 сая м<sup>3</sup> (44 хувь) болж өсчээ (Зураг 9.3).

### Хүснэгт 9.12: Устай холбоотой МХЗ-уудын үзүүлэлт, 1990, 2000, 2010, 2015 он, хувиар

	1990	2000	2010	2015	Зорилго 2015
Усны талаарх дэлхийн МХЗ-ууд <sup>1)</sup>					
<b>7.8 Ундны усны сайжруулсан эх үүсвэр ашиглаж буй хувь, нийт *</b>	<b>53</b>	<b>56</b>	<b>63</b>	<b>64</b>	
Сайжруулсан ундны усны эх үүсвэр ашиглаж буй хувь, хотод	77	74	69	66	
Сайжруулсан ундны усны эх үүсвэр ашиглаж буй хувь, хөдөөд	22	32	50	59	
<b>7.9 Сайжруулсан ариун цэврийн байгууламж ашиглаж буй хувь, нийт **</b>	<b>46</b>	<b>48</b>	<b>57</b>	<b>60</b>	
Сайжруулсан ариун цэврийн байгууламж ашиглаж буй хувь, хотод	65	65	66	66	
Сайжруулсан ариун цэврийн байгууламж ашиглаж буй хувь, хөдөөд	21	26	37	43	
Усны талаарх монголын үндэсний МХЗ-ууд <sup>2)</sup>					
<b>Аюулгүй ундны усны эх үүсвэрт хамрагдаагүй хүн амын хувь</b>	<b>45.00</b>	<b>33.81</b>	<b>27.41</b>		<b>40.00</b>
<b>Сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын хувь</b>	<b>77.40</b>	<b>77.00</b>	<b>76.80</b>		<b>60.00</b>

Эх сурвалж: 1) НҮБ-ын статистикийн газар. МХЗ-уудын үзүүлэлтүүд (<http://mdgs.un.org/unsd/mdg/default.aspx>). 2017 оны 8 дугаар сар. 2) МХЗ-уудыг хэрэгжүүлэх нь, үндэсний 5 дугаар тайлан илтгэл, 2013 он.

Тайлбар: \* Ундны усны эх үүсвэрээр төвийн шугам, олон нийтийн усны хоолой, цооног, хамгаалалттай худаг, булаг шанд, борооны ус болон савласан ус хэрэглэж буй хүн амын хувь.

\*\* Усны татуураг бүхий бие засах газар, агааржуулагч бүхий сайжруулсан жорлон, бие засах газрыг бусад өрхүүдтэй хамтран эзэмшдэггүй хүн амын хувь.


### Хүснэгт 9.13: Ундны аюулгүй ус, ариун цэврийн сайжруулсан байгууламж 2010 оны байдлаар, хувиар

	Хувь
<b>Хот сууринд</b>	
Хамгаалалттай эх үүсвэрээр хангасан	86.7
Хувийн хангамжтай	32.9
Сайжруулсан ариун цэврийн нөхцөлтэй	37.7
Төвийн шугамд хувийн холболттой	30.2
<b>Хөдөө орон нутагт</b>	
Хамгаалалттай эх үүсвэрээр хангасан	43.5
Сайжруулсан ариун цэврийн нөхцөлтэй	< 5

Эх сурвалж: Усны нэгдсэн менежментийн төлөвлөгөө, 2013 он.

Томоохон хот суурин, зарим аймаг, сумдын төвийн хаягдал ус цэвэрлэх байгууламжуудыг (ХУЦБ) ХТОНБ-ууд хариуцдаг байна. Ус хангамж, зайлуулах сүлжээний дийлэнхийг 1960-1990 оны үед байгуулсан учир одоо ихээхэн хуучирсан, найдвартай ажиллагааг хангахад бэрхшээлтэй болсон байна. 2015 оны байдлаар нийт 125 хаягдал ус цэвэрлэх байгууламж байснаас 51 нь бүрэн ажиллагаатай, 27 нь хагас ажиллагаатай, 47 нь зогссон байна. Цэвэрлэх байгууламжуудын ихэнх нь төв бүсэд төвлөрсөн, аж үйлдвэр болон ахуйн хаягдал усыг цэвэрлэх зорилготой, хаягдал усанд шинжилгээ хийх өөрийн лабораторигүй, дээжийн шинжилгээг МХЕГ-аас зохион байгуулдаг байна.



Зураг 9.3: Цэвэрлэсэн хаягдал ус, 2012-2016 он, сая м<sup>3</sup>

Эх сурвалж: БОАЖЯ, 2017 он.

Аж үйлдвэрийн цэвэрлэх байгууламжуудад агааржуулах, тунгаах, хлоржуулах зэрэг механик болон биологийн хосломол технологийг голдуу ашиглаж, цэвэршүүлсэн усыг хотын төв цэвэрлэх байгууламжид нийлүүлдэг. Хотуудын цэвэрлэх байгууламжуудын хүчин чадал нь зарим нь өдөрт хэдэн зуун шоо метр цэвэрлэх жижиг хэмжээтэй бол Дархан хотын цэвэрлэх байгууламж 16,000 м<sup>3</sup>, хамгийн том нь Улаанбаатарын 160,000 м<sup>3</sup> хүчин чадалтай цэвэрлэх байгууламж байна. Аймгийн ХУЦБ-ууд өдөрт дунджаар 1,000-5,000 м<sup>3</sup> бохир ус цэвэрлэх хүчин чадалтай байна.

Санхүүгийн нөөц бололцооноос шалтгаалан ХУЦБ-уудад засвар үйлчилгээ, шинэчлэл хийх ажил удааширч, аж үйлдвэр, аймгийн төвүүдийн хаягдал ус зайлуулах сүлжээ муудаж, байгальд цэвэршүүлсэн ус нийлүүлэх хэмжээ мөн багасч байна. Хөдөө, алслагдсан орон нутагт ХУЦБ-уудын үйл ажиллагааг хангах мэргэжлийн байгууллага, боловсон хүчин байхгүйн улмаас зарим цэвэрлэх байгууламжууд ажиллахгүй байна.

Лаг шавар зайлуулах, цэвэрлэх стандарт 2017 оны байдлаар Монгол улсад байхгүй байна. Бодит байдал дээр хаягдал ус цэвэршүүлсний дараа бага хэмжээний лаг шавар үлдвэл түүнийг хатааж зориулалтын талбайд булаах аргаар шийдвэрлэдэг, харин их хэмжээний шавар гарвал хүчилтөрөгчгүй орчинд эсэлдүүлэх аргаар цэвэршүүлдэг байна.

#### Аялал жуулчлал

Аялал жуулчлал нь улсын эдийн засагт чухал үүрэгтэй. Ялангуяа жуулчны баазууд ус хангамж, хаягдал усны асуудлыг олон улсын стандартад аль болохоор нийцүүлэн шийдвэрлэх шаардлагатай байна. Байршлаас хамааран ус хангамж, хаягдал ус зайлуулах жижиг оврын төхөөрөмж ашиглахыг санал болгодог байна. УННМ-ийн төлөвлөгөөнд ус хангамж, хаягдал ус зайлуулах жижиг оврын төхөөрөмжийг аялал жуулчлалын зорилгоор ашиглахыг тусгаагүй байна.

#### Үер

Монголд нийтдээ 100 гаруй км далан, 84.2 км усны суваг байна. 2010 оны байдлаар 42 км үерээс хамгаалах бетон далан, 56 км голын хамгаалах далан, 9.8 км газрын далан, 3.5 км чулуугаар доторлосон далан, үерийн болон авто замын борооны ус хуримтлуулах 6 агууламж (9,800-10,300 м<sup>3</sup> багтаамжтай 3, 200-250 м<sup>3</sup> багтаамжтай 3) байна. Гүний ус хуримтлуулах 18 усан сан, ус зайлуулах 70 км газар доорх хоолой ажиллаж байна. Улаанбаатар хотын үерээс хамгаалах дэд бүтэц маш муудсан, төлөвлөгөөгүй суурьшилт, ялангуяа гэр хорооллууд үерээс хамгаалах ямарваа нэгэн нөхцөлийг хангахгүйгээр тэлж байна (Бүлэг 14).

## 9.6 Усны сав газрын менежмент

Усны тухай 2012 онд шинэчилсэн хууль нь усны нөөцийн нэгдсэн менежментийн (УННМ) зарчимд суурилж, голын сав газрын менежментийн асуудлыг тусгасан байна. УННМ-ийн зарчмыг Монголд усны нөөцийн ашиглалтын төлөвлөгөөг сайжруулах, зохицуулалтыг хангах зорилгоор нэвтрүүлж, хуулийн дагуу усны нөөцийн нэгдсэн менежментийн үндэсний болон усны сав газар бүрийн төлөвлөгөө боловсруулахаар заажээ. Монгол 29 голын сав газартай (Хавсралт IV, Газрын зураг 2).

Усны нөөцийн менежментийг хэрэгжүүлэх усны сав газрын захиргаа, усны сав газрын зөвлөл гэх хоёр байгууллагыг байгуулснаар УННМ-ийн зарчмыг нэвтрүүлж эхэлжээ. 2013 онд усны сав газрын 25 захиргааг анх байгуулан, дараа нь татан буулгаж, нийлүүлснээр 2017 оны байдлаар 21 захиргаа ажиллаж байна. Усны сав газрын захиргаа нь усны нөөцийг бохирдол, хомсдлоос хамгаалах, үр ашигтай ашиглах, орчныг сэргээх, орон нутаг болон салбар хоорондын зохицуулалтыг хийх, усны сав газрын УННМ-ийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх үүрэгтэй ажиллаж байна.

Усны сав газрын менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор сав газрын зөвлөлийг байгуулжээ. Усны сав газрын зөвлөл нь 31-45 гишүүнийн бүрэлдэхүүнтэй, түүний гуравны нэг нь төрийн захиргаа, УИХ болон иргэдийн төлөөлөгчдийн хурал, гуравны нэг нь ТББ, орон нутгийн байгууллага, гуравны нэг нь ус хэрэглэгчид, тухайлбал аж үйлдвэр, ХАА-н салбарын төлөөллөөс бүрдсэн ТББ юм.

2017 оны дунд үеийн байдлаар 17 усны сав газрын менежментийн төлөвлөгөө батлагдан, 6 төлөвлөгөө боловсруулалтын шатандаа, 8 захиргааны төлөвлөгөө боловсруулалтын эхний шатандаа явж байна.

УННМ-ийг нэвтрүүлэх талаар тодорхой амжилтад хүрсэн боловч олон саад бэрхшээлтэй тулгарч байна. Усны олон сав газарт зөвлөл байгуулсан хэдий ч санхүүжилтээс шалтгаалан үйл ажиллагаа явуулдаггүй, нэгдсэн менежмент хийхэд сав газарт ойн талбай багасах (Туул голын сав газар), малыг их хэмжээгээр бэлчээх зэрэг хүчин зүйл сөргөөр нөлөөлдөг байна. Цаашид гүний усны нэмэгдэл эх үүсвэрүүдийг ашиглах, гүний усны хяналт мониторингийн зохистой сүлжээ бий болгох, үйл ажиллагаа нь доголдсон ус цэвэрлэх байгууламжуудын тоог хорогдуулах, усны сав газрын ажилтнуудын мэргэжлийн сургалт зэрэг чухал асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй.

## 9.7 Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, түүнтэй дасан зохицох

Урьдчилсан төсөөллөөр уур амьсгалын өөрчлөлт нь агаарын температурын өсөлт, цас мөс, мөсөн голын хайлалт, усны хомсдол, цөлжилтийг үүсгэнэ хэмээн үзэж байна. Газар зүйн байршлын хувьд Монгол улс нь уур амьсгалын өөрчлөлтөд ихээхэн эмзэг, 1940-өөс 2008 оны хооронд жилийн дундаж температур цельсийн 2.1 градусаар өссөн, гангийн улмаас олон зуун нуур, гол горхи ширгэсэн, 1992-2002 онд өндөр уулсын цасан бүрхүүл 30 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Дасан зохицох арга хэмжээг усны салбарын хэтийн зорилгын хувьд 2015 оны Монгол Улсын зорилтот хувь нэмэр баримт бичигт усны эх бүрэлдэх газрын талбайг улсын тусгай хамгаалалтад авах замаар нэмэгдүүлэх, голын сав газарт УННМ-ийг бэхжүүлэхээр тусгажээ (Бүлэг 7). Дасан зохицох зарим бодит арга хэмжээнд цас, мөсөн бүрхүүлийн хайлсан усыг хуримтлуулах усан сан байгуулах, гол горхийн урсацыг зохицуулах, ус хэмнэх болон цэвэрлэх технологийг нэвтрүүлэх, дуслын усалгааны технологийг усжуулалттай газар тариаланд нэвтрүүлэхийг заасан байна.

## 9.8 Хууль, эрх зүй, бодлого, бүтэц зохион байгуулалтын тогтолцоо

### *Хууль эрх зүйн тогтолцоо*

Усны нөөцийн ашиглалтыг зохицуулах гол баримт бичиг бол 1995 онд анх батлан, 2012 онд шинэчилсэн Усны тухай хууль юм. Уг хуульд усны нөөцийн ангилал, нөөцийн хэмнэлттэй менежмент, ус ашиглах зөвшөөрөл олгох журам, ус ашиглах болон олборлох харилцаа, нэмэлт хуулиар усны сав газар, усны сав газрын менежментийн төлөвлөгөөг боловсруулах удирдамж, сав газрын захиргаа болон зөвлөл байгуулахыг зохицуулсан байна (Бүлэг 1).

2012 оны Усны тухай, 2011 оны Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулиар ус хангамж болон ариутгах татуурга ашиглалтын төлбөр (Бүлэг 3), ус бохирдуулсаны

төлбөрийг 2012 оны Усны тухай, Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хуулиар тус тус зохицуулж байна. Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх нэмэлт хуулийг одоо боловсруулан батлах хэрэгтэй (Бүлэг 3).

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай 2009 оны хуулиар усны урсац бүрэлдэх эх газарт хайгууль, олборлолтын тусгай зөвшөөрөл олгохыг хоригложээ.

#### Бодлогын тогтолцоо

Үндэсний стратеги, хөтөлбөрүүдэд ус хангамж, ариун цэврийн салбар, УННМ-ийн талаар олон чухал зорилго дэвшүүлсэн боловч тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх, үүрэг хариуцлага болон санхүүгийн стратегийг нарийвчлан тодорхойлоогүй байна.

#### Усны үндэсний хөтөлбөр

Усны 2010 оны үндэсний хөтөлбөрийг (УИХ-ын 2010 оны 24 дүгээр тогтоол) 2010-2015 оны эрчимтэй хөгжлийн, 2016-2021 оны тогтвортой хөгжлийн гэсэн хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Хөтөлбөрийн стратегийн зорилгод усны нөөцийн менежментийг эрчимжүүлэх, түүний үр дүнг дээшлүүлэх, нөөцийн ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх, усны нөөц болон менежмент хийх байгууллагуудын эрх зүйн орчинг сайжруулахаар тусгажээ. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт мониторинг, үнэлгээгээр 2015 оны төлөвлөгөөт арга хэмжээний биелэлт 68 хувьтай, хэрэгжилтийн ерөнхий байдал 2015 оны байдлаар 40 хувьтай байна гэж дүгнэжээ.

#### УННМ-ийн үндэсний төлөвлөгөө

УННМ-ийн үндэсний төлөвлөгөө нь (ЗГ-ын 2013 оны 389 дүгээр тогтоол) усны нөөцийн менежментийг зохицуулах гол баримт бичиг бөгөөд түүнд үйл ажиллагааны дараах таван гол зорилгыг тодорхойлсон байна:

- Хүн амыг ундны аюулгүй усаар хангах;
- ХАА-н салбарыг шаардлагатай усаар хангах;
- Аж үйлдвэр, уул уурхайн салбарыг шаардлагатай усаар хангах;
- Байгаль орчны тэнцвэрийг хадгалж, усны нөөцийг хамгаалах;
- Усны зохистой менежмент, салбар хоорондын зохицуулалт, хяналт мониторинг, олон нийтийн оролцоог сайжруулах.

Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнд тодорхой аймаг, сум, хэрэгжүүлэх байгууллага, хугацаа, санхүүжилтийн эх үүсвэрийг зааж өгсөн байна.

#### Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 -д устай холбоотой дараах зорилтуудыг тодорхойлжээ:

- 2020 он гэхэд борооны болон гадаргын усыг хуримтлуулах үндэсний түвшний хоёроос доошгүй том усан сан, далан барих;
- 2025 он гэхэд Хэрлэн, Орхон, Сэлэнгэ зэрэг том голуудын усыг нөөцлөх цогц төслүүдийг хэрэгжүүлэх, гадаргын усыг хуримтлуулах сангийн тоог нэмэгдүүлэх;
- 2030 он гэхэд усны нөөц, гол горхи, усны урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах;
- 2030 он гэхэд нутаг дэвсгэрийн 30 хувийн дунд масштабын гидрологийн газрын зургийг боловсруулах;
- 2030 он гэхэд хүн амын 90 хувь ундны аюулгүй усаар хангагдсан, 60 хувь ариун цэвэр, эрүүл ахуйн сайжруулсан байгууламж ашиглах нөхцөлийг хангах.

#### Бусад

Бодлогын бусад баримт бичигт 2008 оны Ундны аюулгүй усаар хангах үндэсний хөтөлбөр (ЗГ-ын 2008 оны 84 дүгээр тогтоол), 2012 оны Хатан Туул үндэсний хөтөлбөр (ЗГ-ын 2012 оны 203 дугаар тогтоол) орно (Бүлэг 1).

## Энэхүү бүлэгтэй холбоотой Тогтвортой хөгжлийн зорилт, зорилгууд

2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн Зорилго 6 -ын Монгол улс дахь хэрэгжилтийн байдлыг Шигтгээ 9.2-т харуулав.



**Шигтгээ 9.2: Тогтвортой хөгжлийн 2030 хүртэлх хөтөлбөрийн Зорилго 6 -ын зарим Зорилтууд**

**Зорилго 6: Нийт хүн амыг усны нөөцийн тогтвортой менежмент, хүртээмж, ариун цэврийн байгууламжаар хангах.**

Монгол Улс УННМ-ийг амжилттай хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд тус улсын хувьд ТХЗ-ын 6 дугаар зорилт нэн чухал ач холбогдолтой юм. Өнөөдөр Монгол улсад усны нөөцийн менежментийн эрх зүйн болон бодлогын тогтолцоо бүрдсэн, байгууллагуудын зохион байгуулалтын бүтэц бий болсон боловч байгууллага хоорондын хамтын ажиллагаа сул, хөрөнгө оруулалт дутмаг зэргийг шийдвэрлэн практик дээр үр ашигтай хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

**Зорилт 6.1: 2030 он гэхэд нийт хүн амыг аюулгүй, хямд үндны усаар тэгш хангах.**

НУБ-ын МХЗ-уудын мэдээллийн сангийн мэдээнээс үзвэл 2015 оны байдлаар хүн амын 64 хувь нь ундны найдвартай усны эх үүсвэрээр хангагдсан ч хот хөдөөгийн хооронд ихээхэн ялгаа оршоор байна (Хүснэгт 9.12). ТХЗ-ын зорилт 6.1 нь бүрэн хэрэгжээгүй, Монголын 2030 он хүртэлх ТХАХ-нд энэ зорилгыг тусгаж 2030 он гэхэд хүн амын 90 хувийг ундны аюулгүй усаар хангахаар заажээ. Энэ зорилгыг улам нарийвчлан, хот хөдөө, бүсүүд хоорондын ялгааг арилгах хэрэгтэй.

Зорилт 6.2: 2030 он гэхэд бүх нийтээр ариун цэвэр, эрүүл ахуйн зохистой, тэгш үйлчилгээнд хамрагдах, ил бие засах явдлыг зогсоох, ингэхдээ эмэгтэйчүүд, охид, эмзэг бүлгийн хүмүүсийн шаардлага хэрэгцээнд онцгой анхаарал хандуулах.

НУБ-ын МХЗ-уудын мэдээллийн сангийн мэдээнээс үзвэл 2015 оны байдлаар хүн амын 60 хувь нь ариун цэврийн сайжруулсан байгууламж ашиглаж байна (Хүснэгт 9.12). 2010 оны байдлаар хот суурины хүн амын 37.7 хувь нь ариун цэврийн зохих нөхцөлөөр хангагдсан, харин хөдөө орон нутагт ийм нөхцөлөөр хангагдсан хүн амын хувь 5 хүрэхгүй байгааг 2013 оны усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөнд тэмдэглэсэн (Хүснэгт 9.13) байна.

Монгол улсад нийт хүн амын 10-15 хувь нь ил бие засч, зарим (ЖМР) мэдээгээр ийм хүн амын хувь ядуу орон нутагт 26-д хүрч байна.

2030 он хүртэлх ТХАХ-нд 2030 он гэхэд хүн амын 60 хувь ариун цэвэр, эрүүл ахуйн сайжруулсан байгууламж ашиглах нөхцөлийг хангах зорилго дэвшүүрт. Ил бие засах явдлыг зогсоох талаар ямарваа нэгэн зорилт дэвшүүлээгүй, Монгол Улсын стратегийн баримт бичгүүдэд охид эмэгтэйчүүд, эмзэг бүлгийнхний тусгай хэрэгцээний асуудлыг тусгаагүй байна.

**Зорилт 6.3: 2030 он гэхэд дэлхий дахинд усны бохирдлыг багасгах, гол усанд бохир ус цуглахыг зогсоох, химийн хорт бодис болон материал усанд цуглах явдлыг багасгах, цэвэрлээгүй бохир усны хувийг тэн хагасаар бууруулах, бохир усыг эргэлтэд оруулах, дахин аюулгүй ашиглах замаар усны чанарыг дээшлүүлэх.**

УНЦМ-ийн Үндэсний төлөвлөгөөний нэг гол зорилго бол цэвэршүүлээгүй хаягдал усны хэмжээг багасгахад оршиж байгаа хэдий ч усны хэмжээг нарийвчлан тогтоогоогүй, ариутгах татуургын сүлжээг шинэчлэх, өргөжүүлэх, цэвэрлэх байгууламжуудыг шинэчлэн хамрах бүсийг өргөжүүлэх арга хэмжээг тусгасан байна.

Хотын дэд бүтэц, тухайлбал хог хаягдлыг цуглуулах, устгах, усны хангамж болон ариутгах татуургын үйлчилгээ, хаягдал усыг цэвэрлэх зэрэгт оруулсан хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл тун хомс байна. Хаягдал усыг цэвэршүүлэх дэд бүтэцд хангалттай хөрөнгө оруулсан нөхцөлд хаягдал усны хэмжээг багасгах зорилгыг хэрэгжүүлэх боломжтой.

**Зорилт 6.5: 2030 он гэхэд усны нөөцийн нэгдсэн менежментийг, шаардлагатай тохиолдолд хил дамнансан хамтын ажиллагаагаар бүх түвшинд хэрэгжүүлэх.**

2017 оны дунд үе гэхэд 29 усны сав газрын 17-гийн менежментийн төлөвлөгөөг баталсан, УННМ-ийг хэрэгжүүлэхэд зохих амжилт гаргасан хэдий ч сорилт бэрхшээл оршоор байна. Усны сав газрын захиргаа, зөвлөлүүд нь УННМ-ийг төлөвлөх, хэрэгжүүлэх хангалттай эрх мэдэлтэй боловч үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх мэдлэг туршлага, мэргэжлийн боловсон хүчин дутмаг байна.

Зорилт 6.5-ийн хил дамнансан усны асуудлыг шигтгээ 6.4-д тусгасан болно.

*Бүтэц зохион байгуулалтын тогтолцоо*

Усны аж ахуйн яам 1938-1986 онуудад усны салбарын бодлогыг хариуцаж байсан бөгөөд 1990-ээд оны эхээр усны салбарыг хувьчилжээ. Усны аж ахуйн хувийн компанийг анх 1991 онд байгуулсан байна. 1990-ээд онд усны нөөцийн менежментийг Байгаль орчны яам, Хүнс, ХАА-н яам (ХАА-н салбарын усны хангамж), БХБЯ (хотын ус хангамж болон хаягдал ус), ЭМЯ (усны эрүүл ахуй), Эрчим хүчний яам (усны эрчим хүч), БХЯ, Мэргэжлийн хяналтын газар (хяналт) зэрэг 7 яам, байгууллага хариуцдаг

байжээ. Төрөөс усны талаар баримтлах бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх зорилгоор анхны Усны үндэсний хороог 1999 онд байгуулжээ.

2012 онд засгийн газрын бүтэцэд орсон өөрчлөлтийг даган усны салбарын бүтэц, зохион байгуулалт ихээхэн шинэчлэгдэн, усны нөөцийн асуудлыг БОАЖЯ-ны хоёр хэлтэс бүхий Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газар хариуцах болжээ (Зураг 1.2). Усны нөөцийн хэлтэс нь гүний усны нөөцийг хамгаалах, сэргээх, судалгаа хийх, гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх, усны хяналт мониторингийн үндэсний сүлжээг өргөжүүлэх, УННМ-ийг хэрэгжүүлэх, Голын сав газрын удирдлагын хэлтэс нь 29 сав газрыг хариуцаж, сав газрын 21 захиргааны үйл ажиллагааг зохицуулах үүрэгтэй байна.

Усны сав газрын захиргаад ус хангамжийн төв байгууллагууд, ус ашиглагчид, өдөрт  $100 \text{ м}^3$  –аас дээш ус ашигладаг ААН-үүдэд ус ашиглалтын зөвшөөрөл, өдөрт  $50 \text{ м}^3$  –аас дээш хаягдал ус гаргадаг ААН-үүдэд хаягдал ус нийлүүлэх зөвшөөрөл олгох үүрэгтэй (Хүснэгт 2.1). Усны сав газрын зөвлөлүүд усны нөөцийн төлөвлөлт, хэрэгжүүлэлт, ус ашиглалт болон бохирдуулалтад хяналт тавихад олон нийтийн оролцоог хангах, ус ашиглалтын зөвшөөрлийг цуцлах санал гаргах, усны сав газрын захиргаанд менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд зөвлөмж гаргах үүрэгтэй байна.

Байгаль орчны болон усны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, сахин мөрдөх үйл ажиллагааг МХЕГ хариуцаж, МХЕГ-ын байцаагчид усны нөөцийн ашиглалтад хяналт тавьж байна.

Аймгуудын байгаль орчны асуудал эрхэлсэн нэгжүүд (байгаль орчин, аялал жуулчлалын газар, хэлтэс) Усны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, аймаг нийслэл хотын усны мэдээллийн санг бүрдүүлэх, усны сав газрын захиргаанаас өдөрт  $50 \text{ м}^3$ - $100 \text{ м}^3$  ус ашигладаг хэрэглэгчтэй байгуулсан ус ашиглалтын гэрээг батлах үүрэгтэй.

Аймгийн ИТХ нь засаг дарга, усны сав газрын захиргааны менежментийн төлөвлөгөө, хөтөлбөрийг батлах, аймаг сумын түвшинд усны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцана. Сумын засаг дарга нь өдөрт  $50 \text{ м}^3$  –аас доош ус хэрэглэх усны зөвшөөрлийг олгодог байна.

Аймаг, сумын захиргаа нь тухайн орон нутгийн үерийн хамгаалалтын асуудлыг хариуцана.

Төрийн өмчит “Монгол Ус” компани нь салбарын яамдаас тогтоосон усны бодлогыг хэрэгжүүлэх, гүний усны нөөцөд хяналт мониторинг хийх, улсын төсвийн хөрөнгөөр Улаанбаатар хотод усны нөөц, хаягдал ус цэвэрлэх дэд бүтцийн барилга, менежментийн үйл ажиллагаанд удирдлага хяналт тавих үүрэгтэй ажээ.

Улаанбаатар хотын УСУГ нь ус хангамж, ариутгах татуургын дэд бүтцийг хариуцан, нийслэлийн 1.3 сая хүн ам, аж үйлдвэрийн болон бусад 4,500 ААН-ийг усаар хангадаг. Төвлөрсөн ус хангамжаас гадна УСУГ нь гэр хорооллын оршин суугчдыг төвийн ус хангамжийн сүлжээнд холбогдсон ус түгээх 550 цэгүүд болон ус тээвэрлэх машинаар үйлчилж байна.

Аймгийн төв, бусад хотуудад ус хангамжийг хот тохижуулалтын байгууллагууд хариуцана.

“Усны барилга байгууламж” компани үерийн хамгаалалтын ажлыг хариуцдаг.

*Зохицуулалтын болон эдийн засгийн арга хэрэгсэл*

#### Зөвшөөрөл олгох, БОНУ

Ус хэрэглэгч, ус ашиглагч өөрийн статусаас үл хамааран төрийн байгууллагаас ус ашиглах зөвшөөрөл авах үүрэгтэй. Өдөрт ашиглах усны хэмжээнээс хамааран усны зөвшөөрлийг янз бүрийн байгууллагууд олгоно (Хүснэгт 2.1). Ус ашиглах зөвшөөрлийг 10 жилийн хугацаагаар олгож, 5 жилээр сунгана. Өдөрт  $100 \text{ м}^3$  –аас дээш хэмжээний ус ашиглах зөвшөөрөл хүсэгч нь БОНУ хийлгэсэн байх шаардлагатай ажээ.

#### Усны үйлчигээний төлбөр

Ус хэрэглэгч, ашиглагчид усны үйлчилгээний төлбөрийг ус хангамжийн байгууллагуудад төлнө. Усны тоолууртай хэрэглэгчид ашигласан усны бодит хэмжээнээр үйлчилгээний төлбөрийг төлж байна.



### Ус ашигласны төлбөр

Усны тухай 2012 онд шинэчилсэн хуульд усыг ашиглах зориулалтаас хамааран иргэд, хуулийн этгээдийг ус хэрэглэгч, ус ашиглагч гэж ангилжээ. Ус хэрэглэгч гэж усыг ундны, ахуйн, мал усалгаа, ХАА зэрэг худалдааны бус зорилгоор хэрэглэгч иргэд, харин бизнесийн нэгж байгууллагыг, ус болон усны орчныг орлого олох зориулалтаар ашиглах аж үйлдвэр, үйлчилгээний салбарыг ус ашиглагчид гэж заагласан байна.

Ус ашиглагчид ус ашигласны төлбөр төлж, харин ус хэрэглэгчдийг ийм төлбөрөөс чөлөөлж, зөвхөн усны тээвэрлэлт, хуваарилалтын үйлчилгээний төлбөр төлнө. Усны төлбөрийг усны сав газрын усны экологийн болон эдийн засгийн үнэлэмжийн хувиар тооцон тогтоодог байна. Туул голын сав газарт гадаргын болон газрын доорх усны үнэлэмж хамгийн өндөр байна. Аймгийн захиргаа усны төлбөрийн хэмжээг тогтоож, орлого нь орон нутгийн захиргааны төсөвт төвлөрдөг ба орлогын 35 хувийг ус хамгаалал, менежментэд зарцуулах ёстой боловч бодит амьдралд тэр бүр хэрэгждэггүй (Бүлэг 3) байна.

### Ус бохирдуулсны төлбөр

Ус бохирдуулсны төлбөрийн тухай 2012 оны хуульд бохирдуулсны төлбөрийн асуудлыг тусгажээ. Харин уг хуулийг хэрэгжүүлэх нэмэлт хуулийг боловсруулах, батлах явдал хүлээгдэж байна (Бүлэг 3).

### *Хоёр талын гэрээ хэлэлцээр, оролцоо*

Монгол Улсад хил дамнансан 243 усны эх үүсвэр байгаа ба хил дамнансан эх үүсвэрийг ашиглах, хамгаалах талаар хоёр хэлэлцээр (Бүлэг 6) байгуулжээ. Хил орчмын усыг ашиглах, хамгаалах тухай хэлэлцээрийг ОХУ-тай 1995 онд, БНХАУ-тай 1994 онд тус тус байгуулжээ. Одоогоор, гурван талын хамтын ажиллагааны ямарваа нэгэн хэлбэр байхгүй байна.

## **9.9 Үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж**

### *Үнэлгээ*

Засгийн газар усны менежментийн тэргүүлэх чиглэлүүдийг 2010 оны Усны үндэсний хөтөлбөр, 2030 он хүртэлх Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тусгаж, эрх зүй, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгон өргөжүүлэх ажлыг чухалчлан, зорилтот хөтөлбөр, янз бүрийн төслийг хэрэгжүүлж байна. 2016 он гэхэд усны урсац бүрэлдэх газрын 44.5 хувийг улсын хамгаалалтад авч, усны сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглохыг 2009 онд хуульчилсан нь томоохон амжилт юм.

Эрх зүй, зохицуулалтын хууль тогтоомж, хөтөлбөрүүд гарсан боловч усны нөөцийн менежментийн асуудал нь хамгийн бэрхшээлтэй, ялангуяа уур амьсгал, нийгэм, эдийн засгийн үр дагаврын хувьд асуудал хэвээр байна.

Монгол улсад УННМ-ийн зарчмыг усны менежментийн тогтолцоог шинэчлэх гол чиглэл хэмээн үзэж байгаа боловч УННМ-ийг хэрэгжүүлэх, усны бүх сав газарт энэ менежментийн төлөвлөгөөг нэвтрүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хэрэгжүүлэх зохион байгуулалтын бүтцийг бэхжүүлэх, усны сав газрын зөвлөлүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх, сав газрын удирдлага менежментэд олон нийтийн оролцооны боломжийг нэмэгдүүлэх зэрэг ажил дутагдаж байна.

Усны бохирдлын гол эх үүсвэр нь хотын болон аж үйлдвэрийн цэвэрлэх байгууламжууд, төрийн болон хувийн ариун цэврийн байгууламжуудаас нийлүүлж буй дутуу цэвэршүүлсэн хаягдал ус бөгөөд цэвэрлэх байгууламжуудын ажлын зохистой горимыг хангах, орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх, засвар үйлчилгээг тогтмол хийх нь байгаль орчны бохирдлыг багасгах, ариун цэврийн нөхцөлийг сайжруулахад нэн чухал ач холбогдолтой байна.

### *Дүгнэлт, зөвлөмж*

### Усны хангамж, ариун цэвэр, хаягдал ус цэвэрлэх дэд бүтэц

Засгийн газар усан хангамж, ариун цэврийн нөхцлийг сайжруулах талаар сүүлийн 10-15 жилийн

хугацаанд ихээхэн амжилтад хүрчээ. ТХЗ болон Монгол улсын ТХЗ 2030-д усны хангамж болон эрүүл ахуйн шаардлагыг хангах үндэсний хэмжээний шинэ зорилтууд дэвшүүлэн ажиллаж байна. ТХЗ-ийн хэрэгжилт, усны хангамж, эрүүл ахуйн шаардлага хангах талаар авч байгаа арга хэмжээний тухай албан ёсны эх мэдээлэл өөр өөр эх үүсвэрийн хувьд ихээхэн зөрүүтэй байна. Тодорхой байгаа, дутагдалтай байгаа асуудлууд бол хот хөдөөгийн усны хангамж, эрүүл ахуйн асуудал ихээхэн ялгаатай, хязгаарлагдмал айл өрх төв суурин газрын ус зайлуулах төвлөрсөн системд холбогдсон, хөдөөгийн иргэдийн маш бага хувь (5 хувиас бага) нь ариун цэврийн байгууламж ашиглаж байгаа явдал байна. Ил задгай бие засах явдал одоо хүртэл оршиж, хөдөө орон нутгийн ядуу хэсгийн ил задгай бие засч байгаа байдал 26 хувиас дэгүүр байна. Иймд Монгол улсын хувьд ТХЗ-ын Зорилго 6.1 болон 6.2 –ийг хэрэгжүүлэхийн тулд нэмэлт хүчин чармайлт гаргах хэрэгтэй байна.

2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн зорилго 6.3-г (2030 он гэхэд бохирдол, хаягдал усны хэмжээг тэн хагасаар багасгах, аюултай химийн бодис, материалын нийлүүлэлтийг бууруулах, усыг эргэлтэд оруулах, аюулгүй дахин ашиглах замаар усны чанарыг дэлхий дахинд сайжруулах) хэрэгжүүлэх нь усны чанарыг хамгаалахад хаягдал ус хамгийн тулгамдсан асуудал болсон Монгол Улсын хувьд чухал ач холбогдолтой. Цэвэрлэх байгууламжуудын өнөөгийн техникийн байдал, хүчин чадлыг харгалзан ус цэвэршүүлэх чанар, бүтээмжийг сайжруулах, ялангуяа хөдөө, алслагдсан орон нутгийн цэвэрлэх байгууламжуудыг сайжруулах шаардлагатай байна.

#### Зөвлөмж 9.1:

*Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Ус хангамж, ариун цэврийн болон бохир ус зайлуулах татуургын асуудлыг хөдөө орон нутагт төвлөрөн шийдвэрлэх,*
- (b) *Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх арга хэмжээ авах.*

#### Газрын доорхи ус болон газаргын усны хэрэглээ

Монгол Улсад ашиглаж буй нийт усны 95 хувийг газрын доорх усны нөөцөөс хангаж байгаа бол түүний нөөц нь нийт усны нөөцийн зөвхөн 1.91 хувийг эзэлдэг байна. Гадаргын усны нөөц улсын нутаг дэвсгэрт тэгш бус хуваарилагдсан, түүний ашиглалт хязгаарлагдмал, ашиглалтыг нэмэгдүүлэх цогцолбор дэд бүтэц байхгүй байна.

#### Зөвлөмж 9.2:

*БОАЖЯ нь БХБЯ, төр засгийн бусад байгууллагуудтай хамтран дараах арга хэмжээг авч хэрэгжүүлвэл зохино:*

- (a) *Төрөл бүрийн зориулалтаар газрын гүний ус ашиглалтаас гадаргын ус ашиглалтад шилжих мөрийн хөтөлбөр боловсруулах;*
- (b) *Усны нөөцийг хуримтлуулах, бүх салбарыг усаар хангах дэд бүтцийг хөгжүүлэх, санхүүжүүлэх үйл ажиллагааг хангах,*
- (c) *Хот суурин газар болон говийн зарим бүсэд уст давхаргын усыг сэргээх схемийг боловсруулж, хэрэгжүүлэх асуудлыг авч үзэх.*

#### Газрын доорхи усны мониторинг

Монголд усны нөөцийн менежментийн хяналт мониторинг, ялангуяа газрын доорхи усны мониторингийг цаашид боловсронгуй болгох нь чухал ач холбогдолтой. Монгол улсад хяналтын 193 худаг, цооног байгаагаас 28 нь автоматжсан, мэдээллийг тогтмол дамжуулдаг байна.

#### Зөвлөмж 9.3:

*БОАЖЯ нь газрын доорхи усны чанар, хэрэглээг сайжруулахын тулд түүний хяналт, мониторингийн худаг, цооногийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлвэл зохино.*

#### Усны сав газрын менежмент, мэдээллийн сан

Монгол улсын 29 усны сав газарт усны сав газрын 21 захиргаа байгуулан ажиллаж байна. Тэдгээр нь сав газрын УННМ-ийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд салбар хоорондын зохицуулалт

хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, ус ашиглалтын хяналт тогтоох зэрэг өргөн үүрэгтэй. Гэвч эдгээр захиргаа нь үүргээ биелүүлэх практик мэдлэг туршлага дутмаг, 2030 он хүртэлх ТХХ-ийн Зорилго 6.5-ыг (2030 он гэхэд усны нөөцийн цогц менежментийг, шаардлагатай тохиолдолд хил дамнасан хамтын ажиллагаагаар бүх түвшинд хэрэгжүүлэх) хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд усны сав газрын боловсон хүчний сургалт, мэргэжлийн хөгжлийг хангах явдал хамгийн чухал асуудал болж байна.

Зөвлөмж 9.4:

*БОАЖЯ нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлвэл зохино:*

- (a) Усны сав газрын захиргааны ажиллагсдын усны нөөцийн менежментийн сургалт, мэргэжлийн хөгжлийг хангах;*
- (b) Голын сав газрын менежмент, УННМ-ийг хэрэгжүүлэхэд мэдлэг, туршлага хуримтлуулсан олон улсын байгууллага, бусад улсын засгийн газраас тусламж эрэлхийлэх, туршлагыг судлах.*
- (c) Усны тухай мэдээллийн зөрөөтэй байдлыг арилгах, мэдээний чанар, байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох талаар анхаарах,*
- (d) Үндэсний хэмжээний мэдээллийн сан, усны сав газруудын мэдээллийн дэд сангуудыг байгуулж, удирдлагаар хангах.*

## Бүлэг 10

# ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

### 10.1 Хог хаягдлын менежментийн төлөв байдал, чиг хандлага

#### *Хотын хатуу хог хаягдал*

Монгол Улсын хотын хатуу хог хаягдлын (XXXX) хэмжээг Улаанбаатар хотын Захиргааны мэдээллийг үндэслэн тооцоолсон дүнгээс үзэхэд Улаанбаатар хотын нэг иргэн жилд дунджаар 360 кг ахуйн хог хаягдал бий болгож байна. Энэ нь нэг хүнд жилд дунджаар 200 кг ахуйн хог хаягдал ногдож байсан 1996-2010 онтой харьцуулахад огцом өсчээ. Үүнийг гудамж талбайн цэвэрлэгээгээр (ойролцоогоор өдөрт 300 тонн) гаргаж байгаа хог хаягдалтай нийлүүлж тооцвол жилдээ нэг хүн дунджаар 440 кг хотын хатуу хог хаягдал үүсгэж байна.

Улаанбаатар хотын хог хаягдлын талаарх мэдээлэлд хог хаягдлыг цуглуулах үйлчилгээ эрхэлдэг компаниудын бусад салбар компаниудаасаа (хуулийн этгээдүүд) өдөрт дунджаар 1,400 тонн хог хаягдал цуглуулж байгааг мөн хамруулж үзсэн болно. Олон улсын жишгээр бол хотын худалдаа арилжааны хог хаягдалд дэлгүүр, ресторан, албан байгууллагууд болон хотын бусад дэд бүтцээс бий болгож буй хог хаягдлыг мөн хамруулдаг. Монголын хувьд харин энэ байдал өөр байна. Энэ ангилалд XXXX-тай төстэй үйлдвэрлэлийн хог хаягдлыг (хүнс, ундааны үйлдвэрлэл, нэхмэл, арьс шир, үслэг эдлэлийн үйлдвэрлэл зэргээс үүссэн хог хаягдал гэх мэт) оруулж тооцож байгаа бөгөөд эдгээрийг уг нь аж үйлдвэрлэлийн (эсвэл үйлдвэрлэлийн) хог хаягдал гэж тусад нь тайлагнах ёстой. Тиймээс энэ ангиллын хог хаягдлыг XXXX-ын тооцооноос салгаж үйлдвэрлэлийн хог хаягдлыг тусад нь тооцоолоход ашигласан болно. Улаанбаатар хотын бий болгож буй ахуйн, худалдаа арилжааны болон үйлдвэрлэлийн хог хаягдлын хувь хэмжээ жилд нийтдээ нэг сая тонноос давж байна.

Энэхүү сүүлийн үеийн мэдээлэл нь Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын (ЖАЙКА) судлаачдын 2010 оны хог хаягдлын мэдээлэлд үндэслэн гаргасан тооцооллоос ялгаатай байна. ЖАЙКА-ийн судлаачид гэр хорооллын хог хаягдлын хувь хэмжээ өвлийн саруудад нүүрс түлж эхлэхээр илүү их хэмжээгээр өснө хэмээн тооцоолсон байна. Шинэчлэн хийсэн тооцооллоос үзэхэд өвлийн улиралд гэр хорооллынхон хог хаягдлаа түлж хэрэглэх иохиолдол их байдаг тул өвөл, зуны улиралд гэр хорооллоос гарах хог хаягдлын хэмжээ ойролцоо байна. Харин ч эсрэгээрээ 2013-2014 оны сар тутмын мэдээллийг задлан шинжлэхэд зуны саруудад худалдаа наймаа, үйлчилгээ, барилгын үйл ажиллагаа ихээр нэмэгддэг учир хог хаягдлын хэмжээ хамгийн дээд цэгтээ хүрч байжээ.

Хөдөө орон нутагт амьдардаг айл өрхүүд маш бага хэмжээний хог хаягдал гаргадаг. Илүү их эрх чөлөөтэй уламжлалт нүүдлийн аж амьдралын хэв маягаас харахад харин ч хог хаягдалгүй амьжиргааны дадал ажиглагдаж байна. Гэсэн хэдий ч хот орчмын нүүдэлчдийн төвлөрөл нь хог хаягдлыг цуглуулах, зайлуулах зэрэг дэд бүтцийн хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

Хог хаягдлын талаарх үндэсний статистик мэдээлэл нь зөвхөн цуглуулсан хог хаягдлын мэдээлэлд суурилж байна. XXXX өсөн нэмэгдэх хандлагатай байгаа нь хотын хог хаягдал цуглуулах үйлчилгээний чадавхийг нэмэгдүүлэх, мэдээ тайлангийн чанарыг сайжруулах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ эрхэлдэг компаниудын сонирхолыг дээшлүүлэхийн тулд үйлчилгээнийх нь санхүүжилтийг баталгаажуулах шаардлагатай бөгөөд хүн амын амьдралын түвшин сайжрахын хирээр хог хаягдлын хэмжээ нэмэгдэхийг тооцоолох хэрэгтэй юм.

1996-2001 оны мэдээллийг шоо метрээр тооцсон бөгөөд 2006-2007 онд ашиглалтанд оруулсан гурван том хогийн цэг дээр гүүрэн жин суурилуулсан боловч 2002-2004 оны тоон мэдээлэл байхгүй байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны (БОАЖЯ) тоо баримтыг нягтлан үзэж, тооцооллыг шинэчилсэн (орлуулан тооцох аргыг ашигласан) бөгөөд олон улсын стандартад нийцүүлэхийн тулд зарим зохицуулалтын өөрчлөлтийг хийсэн (Хүснэгт 10.1) болно. Эдгээр тоо мэдээлэл нь 2005 оноос эхлэн тооцох боломжтой боловч зөвхөн 2012 оны мэдээлэл нь арай илүү баримжаатай байгаа нь Монгол Улсын хог хаягдлын менежментийн бодит байдлыг илэрхийлж чадах байж магадгүй юм. Тоо

мэдээллийн үнэн зөвийг нягтлах үйл явц хангалтгүйгээс шалтгаалж байгаа тоо мэдээлэл нь ихээхэн эргэлзээтэй байна. Үүнээс гадна хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ эрхэлдэг компаниуд нь үйлчлүүлэгчдээс хураамж авахын зэрэгцээ цуглуулж тээвэрлэсэн хог хаягдлын хэмжээ, хогийн цэг хүртэлх явсан км-ийг үндэслэн хотын захиргаанаас татаас авч байна. Хог хаягдлын цэгийн диспетчерүүд нь тээвэрлэлтийн тоо бүрээс хогийн цэг рүү нэвтрэх үеийн хураамж авдаггүй бөгөөд хүлээн авсан хог хаягдлын тоо хэмжээг үндэслэн татаас авдаг. Ийм хэлбэрийн татаасууд нь хог хаягдлын тоо хэмжээг ихэсгэх, илүү хол тээвэрлэснээр нэмэлт санхүүжилт авах нөхцөлийг бий болгох талтай.

### Хүснэгт 10.1: Хотын хатуу хог хаягдлын цуглуулалт, 2005-2016, тонн/жил

	Монгол Улс				Улаанбаатар			
	Нийт	Орон сууц	Гэр хороолол	Зам талбай, бусад	Нийт	Орон сууц	Гэр хороолол	Зам талбай, бусад
2005	41	12	19	10	.	.	.	.
2006	557,832	86,563	418,428	52,841	.	.	.	.
2007	8,996	2,584	5,914	498	.	.	.	.
2008	347,081	131,630	186,186	29,266	226,310	103,907	111,814	10,590
2009	554,211	177,806	288,319	88,086	263,424	119,580	121,500	22,344
2010	774,029	236,052	426,481	111,496	241,873	107,803	125,921	8,149
2011	899,323	274,450	503,075	121,798	440,556	180,778	251,625	8,153
2012	1,258,501	290,048	718,747	249,706	484,255	166,975	265,981	51,299
2013	1,815,356	414,013	1,027,616	373,727	771,547	300,610	439,910	31,028
2014	1,441,655	342,606	840,170	258,879	581,535	169,493	306,038	106,004
2015	1,608,909	359,332	1,026,600	222,978	614,859	148,169	370,645	96,045
2016	1,710,909	361,395	1,113,331	236,182	684,000	146,300	402,400	135,300

Эх үүсвэр: Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2017.

Хэд хэдэн судалгаагаар тодорхойлсон Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын бүтцийг Хүснэгт 10.2-д үзүүлэв. Хүснэгтэд үзүүлсэн мэдээллүүд нь олон өөр аргаар, өөр өөр хугацаанд наргасан байсан учир үр дүн нь ч нилээд ялгаатай байна. 2004, 2007 оны тооцоог хогийн сав контейнерт цугларсан хог хаягдлын хэмжээ, гэр хорооллын үнсний хаягдлын хэмжээг тооцох замаар үнэлэмжийг тооцоолсон байна. Эдгээр нь хотын дүүргүүдийн түвшин дэх хог хаягдлын талаарх мэдээлэл юм. Айл өрхийн түвшинд гарч буй хог хаягдлын бүтцийг 2016 онд судлаач Дэлгэрмаа, Мацүмото нар хоёр долоо хоногийн туршид 18 өрх дээр судалсан байна. Түүвэрлэлтийг өрхөд суурилж хийсэн учир хүнсний хог хаягдал өрхийн түвшинд нилээд өндөр хувь хэмжээтэй гарсан байна. Худалдаа арилжааны болон гудамжны хог хаягдал, үнсний хаягдлын тооцоог энэ судалгаанд оруулаагүй ажээ. 2016 онд хийсэн Хогийн цэгт хаягдаж буй хог хаягдлын бүтцийг Батбилэг нарын судлаачдын судалгаа болон ЭкоПаркийн техник эдийн засгийн үндэслэлийг гаргах судалгааны мэдээллээс үзэх боломжтой. Эдгээр нь төмрийн төрлийн хог хаягдалд бага зэргийн ялгаатай байсан ч зэрэгцүүлж болохуйц үр дүнг гаргасан бөгөөд ЭкоПаркийн судалгаагаар хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулж ашиглахтай холбоотой мэдээллийг мөн тусгасан байна.

### Хүснэгт 10.2: Хотын хатуу хог хаягдлын бүтэц, хувиар

Хог хаягдлын төрөл	Арендал 2004		ЖАЙКА, 2007		Дэлгэрмаа, Мацүмото 2016	Батбилэг нарын 2016	ЭкоПарк, 2016
	Зун	Өвөл	Зун	Өвөл	Жил	Жил	Жил
Хог хаягдлын төрөл	36	23	34	13	74	26	26
Хүнсний хаягдал	22	14	15	8	3	7	5
Хуванцар	22	13	19	5	3	13	9
Цаас	9	-	11	5	4	3	3
Шил	7	-	4	2	0	1	10
Төмөр	4	1	5	2	-	1	1
Даавуу	-	49	-	60	-	8	6
Үнс	-	-	13	5	15	41	40

Эх үүсвэрүүд: НУББОХ(UNEP)/ДНМС(GRID)-Арендал 2004, ЖАЙКА 2007, Дэлгэрмаа, Мацүмото 2016, Батбилэг нарын 2016, ЭкоПаркийн ТЭЗҮ судалгаа 2016.



Хог хаягдлын бүтцийн талаархи мэдээллийг зэрэгцүүлэх бололцоотой хогны төрлөөр нь Улаанбаатар хотын хог хаягдлын өнөөгийн байдалтай уялдуулан дахин тооцоолж үзэв. Барилгын хог хаягдал нь ХХХХ-ын 1-2 хувиас ч бага хувийг эзэлж байсан учир 2016 онд хийсэн Батбилэг нарын судалгаа болон ЭкоПаркийн судалгаанаас хасагдсан байна.

#### Хог хаягдлыг цуглуулах

Монгол Улсад хатуу хог хаягдлыг тогтмол цуглуулах үйлчилгээ нь хот суурин газарт төвлөрч байна. Хот суурингийн хог хаягдлын 70 хувь, хөдөөгийн хог хаягдлын 40 орчим хувийг цуглуулж авч чадаж байгаа гэсэн мэдээ байдаг. Улаанбаатар хотын хог хаягдлын цуглуулалт 90-95 орчим хувьтай байна.

Хог хаягдлыг цуглуулах үйлчилгээг хотын өмчит болон хувийн өмчийн компаниуд гэрээгээр гүйцэтгэж байна. Ерөнхийдөө, хотын хэд хэдэн аж ахуйн нэгж, компаниуд хотдоо үйлчилж байна. 2015 он гэхэд Улаанбаатар хотод хог хаягдал цуглуулах үйлчилгээний 23 аж ахуйн нэгж/компани, 250 гаруй тээврийн хэрэгсэлтэйгээр үйл ажиллагаа явуулж байжээ. Улсын хэмжээнд 2015 онд ХХХХ-ыг цуглуулах нийт 773 тээврийн хэрэгсэлтэй байжээ. Хог хаягдлын чиглэлээр үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжийн тоо ийм олон байгаа нь хог хаягдлын удирдан зохион байгуулах үйлчилгээ хөгжлийнхөө эхэн үед байна гэсэн үг юм. Орчин үеийн хог хаягдлын менежментээр бол нэг хот нэг чадварлаг сайн компаниар үйлчлүүлэхэд л хангалттай байдаг.

Хотын хатуу хог хаягдлыг цуглуулах тогтолцоо нь суурьшлын төрлөөр ялгаатай байгаа бөгөөд автоматаар өргөх зориулалттай хогийн савнууд бараг байдаггүйгээс гар ажиллагаатай, цаг хугацаа ихээр шаардаж байна. Өндөр барилга байгууламжуудад хог хаягдлаа цуглуулах тоноглол, бункерүүд байдаг ч тэдгээрийг ихэвчлэн гараар ухаж суллаж байна. Гэр хороолол, бага оврын барилга байгууламжийн хог хаягдлыг тээврийн хэрэгсэлээр тогтоосон цэгүүдээс болон гэр хорооллын дундуур аажуухан явж цуглуулж байна. Эдгээр машинууд нь дуу хөгжим хангинуулан дохио өгч хүмүүс хог хаягдлаа авчирч өгөхийг анхааруулан явж байдаг. Үүний оронд, хог хаягдлыг цуглуулан тээвэрлэх машин ирэхээс өмнө хүмүүс хог хаягдлаа орхих тогтоосон цэг гаргаж, тухайлбал, задгай талбай, ханаар хашсан талбай зэрэгт, хогийн том сав (4-5 м<sup>3</sup>), аль эсвэл хэд хэдэн багавтар савнууд байрлуулж хог хаягдлаа хуримтлуулж байвал илүү үр дүнтэй байж болох юм.

Улаанбаатар хотын хог цуглуулан зөөвөрлөх тээврийн нэг хэрэгсэл өдөрт 100 орчим хэсэгт (үйлчлүүлэгч) хүрч үйлчилдэг байна. Харьцуулж үзбэл, Европын ХХХХ цуглуулах компаниуд өдөрт 1,000 орчим цэгт хүрч үйлчилж байна. Хэдийгээр энэ тогтолцоо нь Европын хувьд нэг их үр дүнтэй тогтолцоо биш ч Монгол Улсын хог хаягдлыг цуглуулах үйлчилгээнд авч хэрэгжүүлүүштэй зүйл юм. Тусгай зориулалтын тээврийн хэрэгсэлүүдийг өөр өөр эх үүсвэрээр олж авсан ихэвчлэн хуучирсан, сэлбэг хэрэгсэл дутмаг, ялангуяа гидро өргөлтийн системийг засварлах сэлбэг хүрэлцээгүй байна. Үүнээс гадна Монголд хог хаягдлын сав үйлдвэрлэгч байдаггүй, гэтэл энд хогийн сав олноор үйлдвэрлэх бизнесийн орон зай хэрэгцээ их байна.

Монголд ХХХХ-ыг цуглуулан тээвэрлэхэд зориулан 5-6 тонны багтаамж бүхий тусгай зориулалтын ачааны машинаас эхлээд стандарт хэрэглээний ачааны машин хүртэл маш олон төрлийн тээврийн хэрэгсэлийг ашиглаж байна (Зураг 10.1).


Гэр хорооллын иргэд өвлийн улиралд хэрэглэж байгаа түлээ түлшнийхээ үнсийг 200 орчим литрийн багтаамжтай саванд хуримтлуулж, улмаар хог зөөвөрлөх машинд хогийг юулж хотын хогийн цэг рүү илгээдэг байна. Зуны улиралд хоол хүнсээ бэлтгэх үйл ажиллагаанаас үүсэх үнсээ шууд л ХХХХ-тай нийлүүлэн хаяж байна. 2007 оны ЖАЙКА-ийн судалгаанд өвлийн улиралд гэр хорооллын нэг хүнд өдөрт дунджаар 0,63 кг үнс ногдохоор тооцоолсон боловч энэ нь нотлогдоогүй байдаг.

#### Хог хаягдлыг устгах

ХХХХ-ыг орон сууцны хорооллуудын ойролцоо байрладаг хогийн цэгүүд дээр хаяж байна. Эдгээр цэгүүд нь эхэндээ санамсаргүй байдлаар хүмүүс хогоо хаяж эхэлсэн газрууд байдаг бөгөөд хожим нь хот, дүүргийн захиргаанаас албан ёсны хогийн цэг болгон бүртгэж авсан нь олонх байдаг байна. Албан ёсоор бүртгэгдсэн болон албажин бүртгэгдээгүй хог хаягдлын цэг, талбайн хэмжээний талаарх мэдээлэл 2005 оноос хойш бий болсон байдаг. Монгол Улсад одоогоор 3,500-4,500 га талбайг хамарсан албан ёсоор бүртгэгдсэн 400 орчим хогийн цэг байна. Албажаагүй буюу хууль бус хог хаягдлын цэгийн тоог тооцоолоход хүндрэлтэй боловч сүүлийн 10 жилд (2006-2016) 500,000 га талбайг хамарсан 4,000

гаруй хогийн цэгийг цэвэрлэж, 1,1 сая тонн орчим хог хаягдлыг албан бүртгэлтэй хогийн цэг рүү зөөн тээвэрлэсэн байна.

**Зураг 10.1: Хог хаягдал цуглуулан зөөвөрлөх тээврийн хэрэгсэлийн тоо, 2001-2015**



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, 2017.

Хог хаягдлын цэгүүдэд хотын, үйлдвэрлэлийн болон аюултай хог хаягдлыг хамтад нь хаяж байна. Хог хаягдлын цэгүүд дээр хаягдсан цогтой үнс нурамнаас болж байнга гал түймэр гарч байгаа бөгөөд энэ нь нөгөө талаар хуримтлагдсан хог хаягдлыг багасгахад ашиглагдаж ирсэн практик юм. Хог хаягдлын тухай 2012 оны хуулиар ил задгай хог шатаахыг ерөнхийд нь хориглон журамласан бөгөөд Хог хаягдлын тухай 2017 оны хуулиар хогийн цэгүүд дээр хог хаягдлыг шатаахыг хориглосон байна. Ингэснээр хог хаягдлын цэгүүд дээр гарах гал түймрийг бууруулах болно хэмээн Байгаль орчин, аялал жуулчлалын яам найдаж байна.

Олон улсын стандартад нийцэхэд ойртсон хог хаягдлын цэг нь Улаанбаатар хотоос баруун хойш 5 орчим км-т байрлах Нарангийн Энгэрийн Хогийн цэг юм. Энэ хогийн цэгийг 2004 онд ЖАЙКА-ийн төслийн хүрээнд байгуулсан байна. Улаанбаатар хотын өөр хоёр томоохон хогийн цэг бол Морингийн Даваа болон Цагаан Давааны Хогийн цэгүүд юм. Эдгээр гурван хогийн цэгүүдэд авто гүүрэн жин суурилуулсан бөгөөд тэдгээрт нийслэл хотын зургаан дүүргээс өдөрт дунджаар 3,200 тонн хог хаягдал хүлээж авч байна. Улаанбаатар хотын дээрх гурван хогийн цэг дээр цуглуулсан хог хаягдлын талаархи олдсон мэдээллээ Хүснэгт 10.3 –д үзүүлээ. Улаанбаатар хотын бусад гурван дүүрэг тус бүртээ хогийн цэгтэй байна.

**Хүснэгт 10.3: Улаанбаатар хотын гурван том хогийн цэгийн хог хаягдлын мэдээлэл, 2013-2014, тонн/жил**

Хогийн цэг	2013	2014	2015	2016
Нарангийн Энгэр	591,991	557,962	455,427	429,262
Морингийн Даваа	105,608	152,920	157,198	163,845
Цагаан Даваа	401,796	380,596	356,533	395,285

Эх үүсвэр: Суурь судалгааны тайлан, Байгаль орчны нөөцийн менежментийн сан, Япон Улс, 2015.

Тэмдэглэл: өөр мэдээлэл олдоогүй

Монголд хотын хог хаягдлыг дахин боловсруулах ажил олон улсын стандартаар бол эхний шатанд явж байна. Дахин боловсруулалтыг төмөр, хуванцар, цаас, картон зэрэг үнэ хүрч болзошгүй хог хаягдалд түлхүү анхаарч байгаа бөгөөд зарим хог хаягдлыг дахин боловсруулах дотоодын хүчин чадал хязгаарлагдмал байна. Ангилан ялгалт хийсэн хог хаягдлын дийлэнхийг Хятад руу экспортолж байна.

**Фото зураг 10.1: Улаанбаатар хотын хог хаясан цэг (албан бус)**

Хог хаягдлыг ангилан ялгалт хийж хаях дадлыг эх үүсгүүр дээр нь бий болгох талаар нилээд оролдлого хийж байна. Гэхдээ хүмүүс ангилан ялгасан хог хаягдлаа хаягдал авах цэгүүдэд тушаах боломжтой. Тиймээс Европд нилээд түгээмэл байдаг хог хаягдлаа ангилан ялгаж хаядаг сайн дурын тогтолцоо нь хаягдал худалдан авдаг цэгүүдтэй өрсөлдөх боломж муутай байдагтай адил Монгол Улсад ч энэ нь үр дүн муутай байна. Үүнээс гадна, хог хаягдал түүгчдэд чиглэсэн сайн дурын үндсэн дээр хогийг ангилан ялгах тогтолцоог бий болгосноор зарим талаараа хогийн эх үүсгүүр дээр хогоо ангилан ялгаж хаяж сурахад сөргөөр нөлөөлж байна.

Дахин боловсруулах хог хаягдлыг ангилан ялгаж байгаа байдлыг Монгол Улсад хэд хэдэн түвшинд



авч үзэж болох юм. Нэгдүгээрт, айл өрхүүд дахин боловсруулж ашиглах боломжтой хог хаягдлаа ангилан ялгаж хаягдал хүлээн авах цэгт өгч борлуулж байна, мөн орон сууцны хогийн бункерүүдээр хог түүгчид явж цуглуулж байна. Хоёрдугаарт, хог түүгчид энд тэндээс түүж, хаягдал хүлээн авах цэгт өгч борлуулж байна. Эцэст нь хог түүгчид хогийн цэг дээрээс дахин боловсруулж ашиглах боломжтой хаягдлыг түүж байна. Улаанбаатарт ойролцоогоор 200 гаруй тогтмол хог түүгчид байгаа бөгөөд тэд өдөрт дунджаар 10 тонн орчим дахин боловсруулах хаягдлыг цуглуулж байна.

БНСУ-ын дэмжлэгтэйгээр 2014 онд Нарангийн Энгэрийн хогийн цэг дээр хог ангилан ялгах үйлдвэрийг байгуулжээ. Тус үйлдвэр нь орон сууцны хорооллуудаас өдөрт 50-70 тонн ахуйн холимог хог хаягдал хүлээн авч боловсруулдаг байна. Хангалттай дулаалгагүйгээс шалтгаалан өвлийн саруудад тус үйлдвэр ажиллах боломжгүй бөгөөд өнөөгийн байдлаар жилдээ 20,000 орчим тонн хог хаягдал хүлээн авч боловсруулж байна. Орон нутгийн зах зээлийн хязгаарлагдмал байдлаас болж хаягдал түлш үйлдвэрлэх анхны төлөвлөгөөнөөс татгалзаж одоогоор үйлдвэр нь хуванцар, цаас, шил зэргийг ангилан ялгаж байна. Тус үйлдвэр нь 33 ажилчинтай бөгөөд нэг ээлжээр үйл ажиллагаа явуулж байна. Ангилан ялгасан хог хаягдал нь үйлдвэрийн зардлыг нөхөх боломжгүй тул энэхүү хог ангилан ялгах үйлдвэр нь байнга Нийслэлийн Захиргааны татаас авч байна. Санхүүгийн хувьд үйлдвэр нь алдагдалтай ажиллаж, үйл ажиллагаагаа орон нутгийн засаг захиргааны татаас дээр явуулж байна.

Бүхий л бараа бүтээгдэхүүнээ импортоор авдаг учир Монгол Улсад ангилан ялгасан хог хаягдлаа дахин боловсруулах хүчин чадлаа нэмэгдүүлэх нь туйлын чухал юм. Дахин боловсруулалтын хүчин чадлаа бэхжүүлэхэд тулгарч буй томоохон саад бол ангилан ялгасан хаягдлыг экспортлох явдал бөгөөд түүнтэй дотоодын аж ахуйн нэгжүүд өрсөлдөх хэрэгтэй болж байна. 2015 онд гэхэд Улаанбаатар хотын зургаан үйлдвэрт 87,600 тонн төмрийн хаягдал, гурван үйлдвэрт 200,000 тонн хөнгөн цагааны хайлш, таван үйлдвэрт 120,000 тонн хуванцар, дөрвөн үйлдвэрт 1,000 тонн цаас, хоёр үйлдвэрт хаягдал дугуй, ашигласан түлшийг дахин боловсруулж, мөн блокны үйлдвэр, шилэн хаягдал боловсруулах үйлдвэрүүд ажиллаж байна.

Тусгайлан ангилан ялгасан хог хаягдал болон дахин боловсруулсан хог хаягдлын талаарх мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам тусад нь авч байна (Хүснэгт 10.4). Ийм хог хаягдал нь эх үүсгүүр дээрээ ангилагдаж ердийн хог тээвэрлэлтийн мэдээлэлд хамрагддаггүй, мөн хогийн цэг дээрх ангилан ялгах боловсруулалтад ч ордоггүй учир цуглуулж тээвэрлэсэн болон устгасан хог хаягдлын талаарх ерөнхий мэдээлэлд бас тусахгүй байна.

#### Хүснэгт 10.4: Тусгайлан ангилсан, дахин боловсруулсан хог хаягдал, 2008-2016, тонн/жил

	цаас		шил		Хөнгөн цагаан		төмөр		хуванцар	
	Ангилан ялгасан	Дахин боловсруулсан	Ангилан ялгасан	Дахин боловсруулсан	Ангилан ялгасан	Дахин боловсруулсан	Ангилан ялгасан	Дахин боловсруулсан	Ангилан ялгасан	Дахин боловсруулсан
2008	855	...	136	...	64	...	476,307	...	532	356
2009	20,598	9	4,131	1	923	7	2,544	732	20,539	77
2010	43,282	40	6,053	102	103	5	1,206	779	15,196	317
2011	32,429	31	17,355	66	1,388	1,317	9,948	7,264	23,081	12,743
2012	9,432	727	3,734	710	131	17	301,845	300,617	5,223	2,939
2013	168,849	22	55,187	4,111	3,875	2,271	30,494	1,120	177,394	4,132
2014	91,340	21	66,653	34	984	56	134,084	1,371	17,802	318
2015	136,526	18	41,309	1,395	1,687	59	116,414	932	121,536	861
2016	127,292	15,029	51,974	1,709	5,371	31	141,341	120,848	93,076	49,084

Эх үүсвэр: Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2017.

ЭкоПарк хог хаягдлын менежментийн цогцолборыг Улаанбаатар хотод Нарангийн Энгэр болон Цагаан Давааны хогийн цэгт байгуулахаар төлөвлөж байна. Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийн үндэсний холбоо, Улаанбаатар хотын Засаг даргын Тамгын газар хамтран хог хаягдлыг дахин боловсруулахад чиглэсэн ЭкоПаркийг хөгжүүлэх ажлыг эхлүүлж 2017 оны 5-р сард санхүүжилтын асуудлыг нь баталгаажуулсан байна.


#### Үйлдвэрлэлийн хог хаягдал

Боловсруулах үйлдвэрлэлийн салбар нь 2016 оны байдлаар Монгол Улсын ДНБ-ний дөнгөж 7,25

хувийг үйлдвэрлэж байсан бол хөдөө аж ахуйн салбар 11.68 хувийг нь, уул уурхайн салбар 20.09 хувийг нь үйлдвэрлэж байжээ. Боловсруулах үйлдвэрлэлийн гол салбарууд нь хүнсний бүтээгдэхүүн болон ундааны үйлдвэрлэл, нэхмэлийн үйлдвэрлэл, хувцас, арьс шир, үслэг эдлэлийн үйлдвэрлэл, кокс болон цэвэршүүлсэн газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, энгийн металл болон металл бус эрдэсийн бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл зэрэг юм. Хүнсний бүтээгдэхүүн, ундаа, нэхмэл эдлэл, хувцас, арьс, үслэг эдлэлийн үйлдвэрлэлээс гардаг хог хаягдал нь хотын хог хаягдалтай төстэй бөгөөд хотын хогийн цэгүүд дээр хаягддаг. Харин кокс, цэвэршүүлсэн газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, энгийн металл болон металл бус эрдэсийн бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс үүссэн хаягдлыг аж ахуйн нэгжүүдийн өөрсдийнх нь тогтоосон цэгт, эсвэл нутаг дэвсгэрийн ойролцоох зориулалтын хогийн цэгүүдэд хаяж байна. Эдгээр хогийн цэгүүд дээр хуримтлагдсан хог хаягдлын талаарх мэдээлэл олдохгүй байна.

Аж ахуйн нэгжүүдийн цуглуулсан үйлдвэрлэлийн хог хаягдлын талаарх ерөнхий мэдээллийг Байгаль орчны мэдээллийн төвийн мэдээллийн сангаас авч болно (Зураг 10.2). Аж ахуйн нэгжүүд өөрийн тээврийн хэрэгслээр, аль эсвэл хотын гэрээлэн гүйцэтгэх үйлчилгээний журмын дагуу хог хаягдлыг цуглуулан тээвэрлэж байна. Үйлдвэрлэлийн хог хаягдлын төрлийн талаар нарийвчилсан мэдээлэл олдохгүй байна.

**Зураг 10.2: Аж ахуйн нэгжүүдийн цуглуулсан үйлдвэрлэлийн хог хаягдал, 2006-2016, сая тонн/жил**



Эх үүсвэр: Байгаль орчны мэдээллийн төв, 2017.

#### Эрчим хүчний салбарын хог хаягдал

Монгол Улсад эрчим хүчний 90 гаруй хувийг нүүрсээр үйлдвэрлэж байна. Нүүрс шатааж эрчим хүч үйлдвэрлэдэг цахилгаан станцууд нийт шатаасан нүүрснийхээ 10-30 хувийг үнс болгон гаргаж байгаа нь энэ салбарын гол хаягдал болж байна. Үнсийг хаягдлын сандаа хурааж лаг зуурмаг болгон тээвэрлэж байна. Монгол Улсад энэхүү хаягдал үнсний санг Оросын стандартын дагуу анх байгуулжээ.

Улаанбаатар хотын цахилгаан, дулааны хэрэгцээг Дулаан, цахилгааны гурван станц (ДЦС-2: 21.5 МВт, ДЦС-3: 198МВт, ДЦС-4: 700 МВт) хангаж байна. Дөрөв дэх станц (ДЦС-5 450MW) баригдаж байгаа бөгөөд энэ нь ДЦС-3-г орлох юм. Бага оврын дулаан, цахилгааны станцууд Дархан хотод 48 МВт, Чойбалсанд 36 МВт, Эрдэнэтэд 28.8 МВт, Даланзадгадад 6 МВт тус тус ажиллаж байна.

ДЦС бүр өөрийн гэсэн хаягдал үнсний сантай. Үнсний сан нь ДЦС-аас алсхан хэдэн км-ын зайтай байгуулагдсан байдаг. Монгол Улс нь жилд дунджаар 600,000 тонн эрчим хүчний үйлдвэрлэлийн тунамал болон дэгдэмхий үнс ялгаруулж байгаа гэсэн тооцоо байна. Үүний 300,000 орчим тонн-ыг нь зөвхөн ДЦС-4 гаргаж байна.

Жилд ялгаруулж буй хаягдал үнсний хэмжээ, түүнээс хэдий хэр нь үнсний санд хуримтлагдаж байгаа талаарх мэдээлэл байхгүй байна. Улаанбаатар хот дахь үнсний сангуудын нөхцөл байдлыг үзвэл:



(1) ДЦС-2 үнсний сан нь бүрэн хүчин чадалдаа тулсан, цаашид удаан хугацаанд үнс хуримтлуулах боломжгүй; (2) ДЦС-3 үнсний сан нь 1.5 сая м<sup>3</sup> хүчин чадалтай бөгөөд 2024 он хүртэл үнсний хаягдал хүлээн авах боломжтой; (3) ДЦС-4 нь дөрөвдэх үнсний сангаа байгуулж байгаа боловч энэ нь бага хүчин чадалтай, ердөө хоёрхон жилийн хэрэгцээг хангах боломжтой ажээ. ДЦС-4-ийн өмнө ашиглаж байсан гуравдахь үнсний сан нь 6 жилийн хуримтлалыг даах хүчин чадалтай байжээ. ДЦС-4 нь үнсийг замын барилгын материал болгон ашиглах мөн халаалтын зуухны дотор талд галд тэсвэртэй материал болгон ашиглах боломжийг судалж байна.

*Барилга барих, буулгаж нураахад гарах хог хаягдал*

Монгол Улсад, ялангуяа Улаанбаатар хотод барилгын салбар эрчимтэй хөгжиж байна. Шинэ барилгаас гадна Улаанбаатар хотын захиргаа нь эртний хуучин барилгуудыг буулгахаар төлөвлөж байна. Барилгын хог хаягдал нь Монгол Улсын нийт хатуу хог хаягдлын 20-25 хувийг бүрдүүлдэг байна.

Барилгын хог хаягдлын дийлэнх хувийг хууль бус замаар хаяж байна. Барилгын компаниудад хог хаягдалынхаа төрөл, бүтцийг бүртгэх, хаягдлаа ангилан ялгах тогтсон системгүй байна. Үүний зэрэгцээ хогийн цэгүүд дээр буулгаж байгаа барилгын хог хаягдлын хэмжээ улам нэмэгдсээр байна (Хүснэгт 10.5).

**Хүснэгт 10.5: Барилгын хог хаягдал, 2006-2016, тонн/жил**

	Монгол Улс	Улаанбаатар
2006	33,113	.
2007	.	.
2008	2,314	.
2009	48,236	11,306
2010	38,637	7,455
2011	98,072	15,150
2012	77,943	.
2013	182,249	92,831
2014	93,508	.
2015	133,107	87,467
2016	119,187	80,800

*Эх үүсвэр:* Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2017.

“Монгол Улсад ногоон, эрчим хүчний хэмнэлттэй барилгын салбарт дэмжлэг үзүүлэх нь” төсөл болон “Монгол Улсын барилгын салбарын нөөцийн ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх, барилгын материалыг орлуулан шинэчлэх замаар байгальд ээлтэй бүтээгдэхүүн гаргахыг дэмжих” төсөл зэрэг нь Европын Холбооны санхүүжилтээр хэрэгжиж буй SWITCH-Ази хөтөлбөрийн нэг хэсэг юм. Эхний төслийн хүрээнд 2012-2016 онд байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн болохыг нь баталгаажуулах, дулааны станцаас гарч буй дэгдэмхий үнсийг дахин боловсруулж барилгын материал болгон ашиглах боломжийг судлахад түлхүү анхаарч байгаа юм. Барилгын материалын үйлдвэрлэл эрхэлдэг 15 орчим компани үнс ашиглах технологийг турших саналаа ирүүлжээ. Хоёр дахь төсөл нь 2020 он хүртэл хэрэгжих дөрвөн жилийн төсөл бөгөөд хог хаягдлын өртөгийн сүлжээг тооцож барилгын дизайнаас эхлэн нураах хүртэлх бүхий л үйл ажиллагааг ногоон болгох зорилготой юм. Төслийн хүрээнд хаягдлыг дахин боловсруулж барилгын материал болгон ашиглах, тэдгээрийн дизайн, маркетингийн стратеги, чанарыг баталгаажуулах, итгэлцлийг бий болгохын тулд хаягжуулах схемийг ашиглана. Мөн Монгол Улсын Засгийн газар, томоохон үл хөдлөх хөрөнгө эзэмшигчид болон барилгын компаниудтай хамтран ажиллахын зэрэгцээ барилга барих, нураах үед ялгарах хог хаягдлыг багасгахад чиглэсэн шинэ дүрэм журмыг боловсруулахыг дэмжих зорилготой юм.

*Уул уурхайн үйл ажиллагаа болон олборлолтын үеийн хог хаягдал*

Уул уурхай нь Монгол Улсын эдийн засгийн голлох салбаруудын нэг юм. 2016 онд уул уурхайн салбар тус улсын ДНБ-ний 20.09 хувийг үйлдвэрлэжээ. Монгол Улсад 400 гаруй томоохон компаниуд уул уурхайн үйл ажиллагаа явуулж байна. Уул уурхайн үйл ажиллагаа нь ихэвчлэн ил уурхайд явагдаж байгаагаас их хэмжээний хөрс/газрыг ухан сэндийлж ашигт малтмал олборлож байна. Хүдрээс металлыг олборлохдоо флотаци хийж урсгаж ялгаруулах аргыг голдуу хэрэглэдэг учир их хэмжээний

хаягдал үүсгэж байна. Түүнчлэн уул уурхайн үйл ажиллагааны нэг онцлог хэлбэр бол хувиараа ашигт малтмал олборлох болон бичил уурхайн үйл ажиллагаа юм. Хэдийгээр уул уурхайн томоохон төслүүдтэй харьцуулахад эдгээр бичил уурхайчдын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөө нь бага боловч тэдгээрийг журамд оруулж зохицуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавихад амаргүй ажээ.

Алтны уурхайнууд харьцангуй богино хугацаанд үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр уурхайнууд нь нөхөн сэргээлтийг батлагдсан төлөвлөгөөнийхөө дагуу хийж тухайн газар нутгийг олборлолтын өмнөх онгон байдалд нь оруулж хүлээлгэн өгөх журамтай. Өөрсдийн бий болгосон овоолгоо хөрсөөр хучиж ургамал, мод бут тарих зэргээр нөхөн сэргээлтийг хийж байна.

Бүх уурхайнууд үйл ажиллагаанаас нь үүдэн гарах байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлд хяналт тавихын тулд байгаль орчны менежментийн жилийн төлөвлөгөө боловсруулж ажиллах үүрэг хүлээдэг (Бүлэг 2). Үүндээ хог хаягдлын менежментийн тухай мэдээллийг тусгах ёстой. Уул уурхайн салбар дахь хог хаягдлын менежмент, газрын нөхөн сэргээлтийн талаарх мэдээлэл олдоц муутай байна. Шигтгээ 10.1-д уул уурхайн салбарын хог хаягдлын менежментийн зарим жишээг үзүүлэв.

Бичил уурхайн үйл ажиллагаанаас үзүүлж буй байгаль орчны нөлөөллийн талаарх мэдээлэл тун бүрхэг байна. Байгаль орчны төлөв байдлын тухай 2007 оны тайланд 120 гаруй газарт хууль бусаар алт олборлох үйл ажиллагаа явагдаж байгаа тухай тэмдэглэжээ. Эдгээр хууль бус үйл ажиллагааны уршгаар 203,500 шоо метр хаягдал овоолго бий болж, 53.5 га газар нутгийг мөнгөн усаар бохирдуулсан байна.

#### Шигтгээ 10.1: Уул уурхайн салбарын хог хаягдлын менежмент

Эрдэнэт үйлдвэр нь Ази тивийн хамгийн том зэс-молибдений уурхай юм. Энэ үйлдвэр 1978 онд үйл ажиллагаагаа эхэлжээ. Одоогоор тус үйлдвэр жилд 26 сая тонн зэсийн хүдэр боловсруулж, 530,000 тонн зэсийн баяжмал, 4,500 тонн молибдений баяжмал үйлдвэрлэж байна. Жил бүр газрын гүнээс ухаж гаргасан 10-12 сая тонн хүдрийн хөрс шороог одоо байгаа овоолго дээрээ нэмж байна. Хүдэр боловсруулах үйл ажиллагаанаас үүсэх хаягдлыг үйлдвэрийн хаягдал хуримтлуулах далан руу түрж оруулдаг бөгөөд энэ нь 2006 он гэхэд аль хэдий нь 400 сая тонн хаягдал, 15 сая шоо метр ус агуулж байжээ. Хаягдлын далангийн цөөрөм дүүрэхэд үйлдвэрийн хаягдал 1 тэрбум тонн болох бөгөөд энэ нь дэлхий дээр өнөөгийн байгаа үйлдвэрийн хаягдлын хамгийн том цөөрмүүдийн нэг болох ажээ. Тус үйлдвэр нь 2007 оноос хойш 3 дугаар чулуун овоолгын хэсэг буюу ил уурхайн хэсэгт нөхөн сэргээлт хийж эхэлсэн бөгөөд одоогоор нийт 18 га талбайд 15 мянга гаруй мод, бут сөөг тарьсан ажээ.

Шарын голын нүүрсний орд нь 1965 онд үйл ажиллагаагаа эхэлсэн ил уурхай юм. Тус уурхай нь 580 га талбайг эзэлдэг бөгөөд нэг ил уурхай, нэг томоохон болон хэд хэдэн бага оврын хаягдал чулуулгийн овоолготой, жилдээ 800,000 орчим тонн нүүрс олборлож байна. Хаягдал чулуулгийн жилийн үйлдвэрлэл 4,5 сая шоо метр байна. Хог хаягдлыг ил уурхайн ойр орчимд овоолдог ажээ. Хаягдал чулуулгийн овоолго нь 210 сая шоо метр талбайг бүрхэж байна.

Багануурын нүүрсний уурхай нь 1,700 га талбайг хамардаг. 1978-2001 оны хооронд ойролцоогоор 162 сая шоо метр хаягдал чулуулгийг уурхайгаас гаргажээ. Тэдгээрийн 103 сая шоо метрийг нь уурхайн ашиглалт дууссан хэсэгт булж, 59 сая шоо метр орчмыг нь уурхайгаас гаргаж овоолсон байна. 1995 онд хийсэн Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний зөвлөмжийн дагуу 2000 онд хаягдал чулуулгийн овоолгыг нөхөн сэргээх ажлыг эхлүүлжээ. Хаягдал чулуулгийн овоолгуудын нөхөн сэргээлтийн хэсгийг налуу болгож өвс ургамалжуулах замаар хийж байна. 2001 он гэхэд ойролцоогоор хаягдал чулуулгийн 61 га талбайг налуу болгож, түүний 46 га орчимд нь ургамал тариалжээ.

Бороогийн алтны уурхай нь 2004 оноос 2006 оны хооронд үйл ажиллагаа явуулж жилдээ 2.5 сая тонн хүдэр боловсруулжээ. Тус уурхай нь газрын нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлж байсан бөгөөд 2010 он гэхэд 264 га талбайд нөхөн сэргээлтийн ажил хийсэн байна.

Оюу Толгойн уурхай нь 2013 онд зэсийн баяжмал үйлдвэрлэж эхэлсэн шинэхэн үйлдвэр юм. Тус уурхай нь өдөрт 70,000 тонн хүдэр боловсруулдаг бөгөөд бүрэн хүчин чадлаараа ажилласнаар 2021 он гэхэд өдөрт 140,000 тонн хүдэр боловсруулахаар төлөвлөж байна. Хаягдал чулуулгийн овоолгыг нуруулдах буюу хүчил үүсгэж болзошгүй хэсгийг нь ялган нүхэнд булшлах зэргээр ажиллаж байна. Тус үйлдвэр нь уурхайн барилгын ажлын явцад хог хаягдлыг аюулгүй зайлуулах зорилгоор Хог хаягдлын менежментийн асуудал хариуцсан түр төвийг байгуулан ажиллуулж байгаа бөгөөд үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэхээр энэ нь Хог хаягдлын менежментийн төв болж ажиллах юм. Хог хаягдлын менежментийн төвийн үйл ажиллагааг Элемент ХХК хариуцан гүйцэтгэж байгаа бөгөөд шатаах зуух, хог хаягдал булшлах (ландфилл) болон хаягдал түр хадгалах агуулах зэрэг ажиллаж байна. Оюу Толгойн уурхайн Биологийн нөхөн сэргээлтийн журмын дагуу Газрын эвдрэлийн хяналтын болон нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна.

*Хөдөө аж ахуйн хог хаягдал*

Хөдөө аж ахуйн салбар нь уул уурхайн салбарын дараа ордог Монгол Улсын ДНБ-ний үйлдвэрлэлд дорвитой хувь нэмэр оруулдаг хоёр дахь том салбар юм. 2016 онд хөдөө аж ахуйн салбар ДНБ-ний 11.68 хувийг үйлдвэрлэж байна. ХАА-н салбараас гарах хог хаягдлын дийлэнхийг мал аж ахуйн салбарынх эзэлдэг бөгөөд үүнийг том асуудал биш хэмээн үздэг байна. Социалист нийгмийн үед байсан томоохон аж ахуйнууд хөдөө аж ахуйн салбарын хог хаягдлын гол эх үүсгэгч болж байсан бөгөөд эдгээр нь нийгэм солигдож газар тариалангийн салбар хөгжихийн хирээр алга болжээ. Орчин үеийн шинэ шинэ фермүүд хог хаягдлын асуудлаа зохих ёсоор анхаарах болж, тухайлбал, Улаанбаатар хотын тахиа үржүүлэх аж ахуйнууд тахианы ялгадсыг хүчилтөрөгчгүй орчинд боловсруулж, дулааны эрчим хүчийг үйлдвэрлэж, боловсруулсан ялгадасыг бордоо болгон ашиглаж байна. Хөдөө орон нутагт малын өтөг бууцыг бордоо болгон ашигладаг уламжлалтай бөгөөд мөн малын аргал хөрзөнг ахуйн түлш болгон ашиглаж байна.

Хөдөө аж ахуйн хаягдлын талаарх статистик мэдээлэл байхгүй байна.

*Аюултай хог хаягдал*

Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл хязгаарлагдмал байна. Аюултай хог хаягдлын менежментийн тухай хууль болон бусад эрхийн актууд батлагдан гарсан хэдий ч энэ нь сайн хэрэгждэггүй бөгөөд үүний уршгаар аюултай хог хаягдлыг хоргүйжүүлэх, устгах асуудал бэрхшээлтэй хэвээр байна.

Монгол улсын аюултай хог хаягдлын өнөөгийн гол эх үүсгүүр нь арьс шир боловсруулах үйлдвэрээс гарч байгаа хог хаягдал, боловсруулалтын үеийн хаягдал, түүхий шатах тослох материалын хэрэглээ, алтны хүдэр боловсруулах явцад ялгарч буй цианид, мөнгөн усны агууламжтай хөрс зэрэг юм. Үүний зэрэгцээ, химийн бодис, хүчил ихээр ялгаруулдаг авто машины аккумуляторын хаягдал ч мөн асуудал дагуулж байна. Аюултай хог хаягдлын хэмжээ, төрлүүдийн талаарх мэдээллийг тогтмол цуглуулахгүй байна. БОАЖЯ-наас Улаанбаатар хотод 2009 онд явуулсан судалгааны Аюултай хог хаягдлын тооллогын урьдчилсан дүнг дараах 10.6 дугаар хүснэгтэд үзүүлэв.

**Хүснэгт 10.6: Улаанбаатар хотын аюултай хог хаягдал, 2009, тонн**

Боловсруулах/устгах арга	Аюултай хог хаягдал
Шатаасан	7,994
Дахин боловсруулах	1,354
Булшлах/Ландфил	998
Физик-химийн боловсруулалт	455
<b>Нийт</b>	<b>10,801</b>

Эх үүсвэр: Байгаль орчны мэдээллийн төв, 2017.

Эдгээр тоон мэдээллээс үндэслэн тооцооход улсын хэмжээнд жилд 27,000-54,000 тонн аюултай хог хаягдал бий болж байна.

Хаягдал тос зэрэг зах зээлийн үнэ цэнэ бүхий аюултай хаягдлыг дотооддоо ашиглан түлш гаргаж авах, мөн дахин боловсруулж ашиглах, цэвэршүүлэх зорилгоор экспортод гаргаж болох юм. 2012 он хүртэл буюу өмнө нь аюултай хог хаягдлын дийлэнх хэсгийг өөр орнууд руу, ялангуяа Өмнөд Солонгос руу экспортолж байсан бөгөөд 2012 оноос эхлэн энэ асуудал нилээд хурцдаж эхэлжээ. 2012 онд ОХУ, БНХАУ зэрэг нь аюултай хог хаягдлыг дамжуулан тээвэрлэхэд хориг тавьсан нь Монгол Улс экспортоо хязгаарлахаас аргагүйд хүрсэн байна. Химийн хог хаягдлыг дахин боловсруулах эсвэл цэвэршүүлэх, хоргүйжүүлэн ашиглах талаарх үндэсний чадавхи сул учир аюултай хог хаягдлын дийлэнх хэсэг нь Улаанбаатар хотын Хогийн цэгүүдэд хаягдаж байна.

БОАЖЯ-ны мэдээлснээр 2007 онд 20,000 гаруй тонн химийн бодис бүхий бүтээгдэхүүн импортолж, 134 аж ахуйн нэгж химийн бодис бүхий бүтээгдэхүүн импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл авчээ. Хилийн хяналт сулаас химийн бодисын хууль бус импорт сүүлийн жилүүдэд өссөн байна. Химийн бодис хууль бусаар хадгалж байсан агуулахыг Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий

газраас илрүүлэн тогтоож, химийн бодисыг хураан авчээ. Тооллогын үеэр сургуулиуд дээр болон баталгаат бус газруудад аюултай хог хаягдал хадгалагдаж байсныг илрүүлэн тогтоож улмаар ОБЕГ-ын агуулах руу шилжүүлэн байршуулсан байна.

Уул уурхайн салбарын алт олборлолт дахь мөнгөн ус, натрийн цианидын ашиглалтыг шалгах зорилготой улсын хэмжээний 2 удаагийн үзлэг шалгалтыг 2007-2008 онд явуулжээ. Эдгээр үзлэг шалгалтаар нийт 53 га газар нутаг, хэдэн арван худаг мөнгөн ус, цианидаар бохирдож, 10 аймгийн 120 гаруй газарт 200,000 тонн лаг болон хог хаягдал хуримтлагдсаныг илрүүлсэн байна. Эдгээр үзлэгүүдийн явцад мөнгөн ус ашиглаж байсан 145 буталгааны тээрэм хаагдсан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь Цагдаагийн ерөнхий газартай хамтран 17 кг мөнгөн усыг илрүүлэн хурааж, саармагжуулахаар ОБЕГ-т хүлээлгэн өгчээ. БОАЖЯ, ОБЕГ нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран 2008-2009 онд химийн бодисын алдагдал, бохирдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж, хамгийн их бохирдолтой дөрвөн газарт аюултай хог хаягдлыг цуглуулах цэгийг байгуулжээ. Эдгээр цэгүүдэд өнөөгийн байдлаар 197,687 тонн саармагжуулсан лаг хуримтлагдсан байна. Засгийн газраас аюултай хог хаягдлыг саармагжуулахад зориулан 3.7 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

Аюултай хог хаягдлыг хоргүйжүүлэх цэвэрлэх байгууламжийг барих техник, эдийн засгийн үндэслэлийг гаргах судалгааг 2009 онд хийсэн байна. Энэхүү судалгаанд шатаах байгууламж, физик-химийн боловсруулалт хийх байгууламж, шингэн хаягдлыг хатаах/өтгөрүүлэх, булшлах, эмнэлгийн хог хаягдлыг ариутган хоргүйжүүлэх, шинжилгээний лабораторийг байгуулах зэрэг асуудлууд орохоор төлөвлөгдсөн юм. Гэсэн ч аюултай хог хаягдлыг хоргүйжүүлэх, цэвэрлэх байгууламжийг байгуулахад шаардагдах хөрөнгө оруулалтын талаар ямар нэгэн шийдвэр гаргаагүй байна.

#### *Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал*

Эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлын менежментэд нилээд өөрчлөлт гарч байгаа бөгөөд энэ нь Улаанбаатар хотод нэлээд ахицтай, харин бусад бүс нутгуудад д хоцрогдонгуй байна.

Эмнэлэг бүр хог хаягдлаа зайлуулах асуудлаа ганцаарчлан шийдэж байсан хуучин арга барилаа Улаанбаатар хот халж эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулан халдваргүйжүүлэх нэгдсэн байгууламжийг Улаанбаатар хотноо байгуулжээ. 2011 оноос хойш энэхүү Эмнэлгийн хог хаягдлыг халдваргүйжүүлэх байгууламжийг Элемент ХХК хариуцан ажиллуулж байгаа бөгөөд энэ нь Улаанбаатар хотоос зайдуу орших Нарангийн Энгэрийн хогийн цэгийн орчим байрлаж байна. Тус байгууламж нь Улаанбаатар хот, Эрүүл мэндийн яам, Элемент ХХК зэрэг байгууллагуудын төр-хувийн хэвшлийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Хэдийгээр гэрээг таван жилийн хугацаатай байгуулсан ч уг гэрээний хугацаа автоматаар сунгагдаж байх тухай заалт оржээ.

Элемент ХХК нь нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй улсын болоод хувийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх бүх төрлийн эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг тогтмол цуглуулж, автоклавт халдваргүйжүүлсний дараа энэхүү хаягдлыг Нарангийн Энгэрийн Хогийн цэгт хүргэж байна. Уг байгууламж нь биологийн хаягдлыг халдваргүйжүүлэх тусгай тоноглолтой хоёр автоклавтай, нэг нь 2,800 кг/цаг хүчин чадалтай зүү, тариур шовх үзүүртэй хэрэгсэлийг халдваргүйжүүлэх автоклав юм. Элемент ХХК-ийн боловсруулсан эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын талаарх мэдээллийг Хүснэгт 10.7-д үзүүлэв. Эдгээр тоо мэдээлэл нь 2005 онд хийсэн Улаанбаатар хотын эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын талаарх урьдчилсан тооцоололд өдөрт 781 кг буюу жилд 285 тонн байна гэж үзсэнээс харьцангуй өндөр байгаа юм.

#### **Хүснэгт 10.7: Эрүүл мэндийн байгууллагын халдваргүйжүүлсэн хог хаягдал, Улаанбаатар хот, 2011-2016, тонн/жил**

2011	2012	2013	2014	2015	2016
589	.	750	796	863	945

*Эх үүсвэр:* Элемент ХХК, 2017.

Улаанбаатар хотын эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлын менежментийн байгууламжаас гадна Элемент ХХК нь Увс аймагт ижил төстэй байгууламж ажиллуулж байгаа бөгөөд улмаар Улаанбаатар хотын Налайх дүүргийн эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах техник,



эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан байна. 2017 оны 8-р сарын байдлаар Налайх дүүргийн эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах шинэ байгууламжийн талаар ямар нэгэн шийдвэр гараагүй байлаа.

**Фото зураг 10.2: Эмнэлгийн байгууллагын хог хаягдлыг Улаанбаатар хотын гадна орших Эмнэлгийн хог хаягдлын төв цэвэрлэх байгууламжид хүргэхээр тээвэрлэж яваа автомашин**



Монгол Улсын бусад бүс нутгийн эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн талаарх нарийвчилсан мэдээлэл байхгүй байна. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментэд үнэлгээ хийх судалгааг 2006-2007 онд явуулжээ. Эрүүл мэндийн байгууллагуудын 90 орчим хувь нь хог хаягдлаа бага багаар нь шатаах, агаарын ямар ч шүүлтүүргүй бага оврын зууханд шатаах, гадаа ил задгай шатаах замаар устгаж байжээ. 2011 он гэхэд аймгуудын нэгдсэн эмнэлэгийн 33 хувь, сумдын эмнэлгийн 41 хувь нь хог хаягдлаа шатаалтын бус технологиор халдваргүйжүүлэх горимд шилжсэн байна. Халдваргүйжүүлсэн хог хаягдлыг орон нутгийн хог хаягдлын цэг рүү илгээдэг болжээ. Биологийн хаягдлаа эмнэлэгийн ойролцоох нүхэнд булж булшилж байна.

2009-2011 онд олон улсын байгууллагуудаас, тухайлбал, ДЭМБ-аас 9 аймгийн 28 сумын эмнэлгийг, Мянганы сорилын сангаас 10 аймгийн 35 сумын эмнэлгийг, Азийн хөгжлийн банкнаас 5 аймгийн 90 сумын эмнэлгийг тус тус өндөр даралттай уурын автоклаваар хангаж ажилтнуудыг нь сургалтанд хамруулж дэмжлэг үзүүлжээ. Энэхүү тусламжийн нийт өртөг нь 1 сая ам.доллар болсон байна.

Үүнээс гадна Дархан, Эрдэнэтийн эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох зорилгоор 2009 онд Улаанбаатар хотын төв эмнэлэг дээр суурилуулан ашиглагдаж байгаа эмнэлэгийн хог хаягдлыг халдваргүйжүүлэх байгууламжтай ижил төстэй тоног төхөөрөмжийг худалдан авахад зориулж 90,000 америк доллартай тэнцэх хөрөнгийг улсын төсвөөс хуваарилсан байна. Мөн 2011 онд Ховд аймгийн төвийн нэгдсэн эмнэлэг болон алслагдсан гурван сумын эмнэлгүүд дээр эмнэлэгийн хог хаягдлын менежментийг сайжруулахад зориулж 60,000 америк доллартай тэнцэх хөрөнгийг улсын төсөвт тусгажээ.

АХБ-ны санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй Эрүүл мэндийн салбарын хөгжлийн 5 дахь шатны төсөл нь 2012 онд үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд 2018 онд хэрэгжиж дуусна. Уг төсөл нь Дархан, Эрдэнэт хотын болон бусад зургаан аймгийн нэгдсэн эмнэлэгт хог хаягдлыг түр агуулах байгууламж барих; 21 эмнэлгийг хог хаягдлын менежментийн тоног төхөөрөмжөөр хангах; эмнэлгийн хог хаягдлын менежментийн тогтолцоог сайжруулах, тус улсын боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх зэрэг зорилтуудыг тусгажээ. 2017 оны 3-р сарын байдлаар Эрүүл мэндийн яам нийт найман нэгдсэн



эмнэлгийн хоёрт нь эмнэлгийн хог хаягдлыг түр хадгалах байгууламж барих барилгын ажлын гэрээ байгуулжээ. Гэхдээ тухайн эмнэлгүүдийн засварын ажил удааширч байгаагаас шалтгаалан эмнэлгийн хог хаягдлын менежментийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх, угсрах ажил хараахан эхлээгүй байна. Дээрх төсөл нь эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн талаарх хууль эрх зүйн болон засаглалын тогтолцоог сайжруулахад дэмжлэг үзүүлж нилээд ахиц гаргасан байна. Өнөөгийн хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа холбогдох бодлогын баримт бичгүүдийг хянан үзсэний үндсэн дээр төслийн зөвлөхүүд одоо мөрдөж буй хууль, тогтоомжоо сайтар хэрэгжүүлэх шаардлагатай хэмээн дүгнэжээ.

#### *Цацраг идэвхит хог хаягдал*

Монгол Улс нь цөмийн бус орон, атомын цахилгаан станцгүй, цөмийн судалгаа шинжилгээ хийх реактор ч байхгүй. Цацрагийн эх үүсгүүр ба цацраг идэвхит бодисыг анагаах ухаан (цацраг туяаны эмчилгээ, оношлогоо), мал эмнэлэг, геологи, уул уурхай, шинжлэх ухаан, судалгаа шинжилгээ, боловсролын салбар зэрэгт ашигладаг. Цацраг идэвхит бодисын хаягдлын хэмжээ бага, ихэнхдээ ашиглагдсан эх үүсгүүрээс гарч байна. Эдгээр нь Изотопын төвд хадгалагддаг (Шигтгээ 10.2).

Стронци-90 (Sr-90)-ээр бохирдсон газар Улаанбаатар хотноо 1993 онд илэрсэн байдаг. Тухайн газрыг ариутган цэвэрлэж, хөрсийг нь хуулан зайлуулжээ. Хаягдал хөрсийг тусгайлан зориулж бэлтгэсэн 6 давхар бүрхүүлтэй 93-ын бөмбөлөгт битүүмжилж Изотопын төвд хадгалжээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь цацраг идэвхит хаягдлын менежментийг сайжруулах шаардлагатайг хүлээн зөвшөөрч байна. Ашиглагдаад битүүмжлэгдсэн эх үүсгүүрийг дахин экспортлоход тавигдах шаардлагууд хуульчлагдаагүй тул хэрэгжих боломжгүй байна. Цацраг идэвхит хаягдлын менежментийн талаарх үндэсний хөтөлбөр байхгүй. Үүнээс гадна өнөөгийн байгаа цацраг идэвхит хаягдлыг хадгалах хүчин чадал нь ирээдүйн хэрэгцээнд хангалтгүй юм.

#### **Шигтгээ 10.2: Изотопын төв**

Изотопын төв нь Цөмийн энергийн газрын харъяанд 1982 онд байгуулагджээ. Изотопын төв нь Улаанбаатараас зайдуу 25 орчим км-т байрладаг. Төвийн үйл ажиллагаа нь цацрагийн үүсгүүр, цацраг идэвхит материал, цацраг идэвхит хаягдлыг төвлөрүүлэх, тээвэрлэх, устгахад чиглэгддэг. Изотопын төв нь хоёр хадгалах байгууламжтай. Эхний хадгалах байгууламж нь цацрагийн идэвхижил багатай хаягдал, ашиглагдан битүүмжлэгдсэн үүсгүүрийг хадгалахад зориулсан 12 агуулахын худагтай. Хоёр дахь хадгалах байгууламж нь зургаан худагтай. Энэ нь өндөр идэвхижилтэй, удаан хугацаатай цацраг идэвхит хатуу бодис агуулсан Co-60, Cs-137, Pu-Be, Ra-226 зэрэг бодисыг хадгалах зориулалттай.

Изотопын төв нь Монгол дахь цацраг идэвхит үүсгүүрийг улс дотроо тээвэрлэх үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал, ашигласан үүсгүүрийг хэрэглэгчээс нь авч Изотопын төвийн ург хугацаагаар хадгалах байгууламжид тээвэрлэн хүргэнэ. Цацраг идэвхит бодисын тээвэрлэлт нь Монгол Улсад ноцтой асуудал биш юм. Бүх цацрагийн үүсгүүрийг импортоор авч байна.

Изотопын төв нь стандартын агааржуулах тоног төхөөрөмж үгүй учир ашиглагдаад битүүмжлэгдсэн үүсгүүр болон цацраг идэвхит хог хаягдлыг агааржуулах хүчин чадал дутагдалтай байна.

Төрийн өмчийн үйлдвэр болох Мон-Атом ХХК нь 2020 он гэхэд анхны атомын цахилгаан станц барих, цөмийн түлшний үйлдвэрлэлийг байгуулахаар төлөвлөж байна. Хэдийгээр эдгээр төлөвлөгөө нь эхний шатандаа явж байгаа боловч цацраг идэвхит хог хаягдлын менежмент, зохицуулалтыг сайжруулах үндэсний чадавхийг Монгол Улсад бий болгох шаардлагатайг илэрхийлж байна.

#### *Удаан задардаг органик бохирдуулагчийн хаягдал*

#### Пестицид

Монгол Улс анх 1958 оноос мал аж ахуйн салбарт пестицидийг хэрэглэж эхэлжээ. Төрөл бүрийн хэлбэрээр гексахлорцикликесан (НСН) -ийг ЗХУ-аас 1985 он хүртэл импортолж байжээ. НСН-ийг малын эктопаразит (ectoparasites) хортон шавьж устгах бодис, малын хашаа хороог хортон шавьжаас ариутгах зориулалтаар ашиглаж байжээ. 1990 онд Байгаль орчин болон Хүнс, хөдөө аж ахуйн яамдын

хамтарсан тушаалаар 12 хувийн НСН-ийг хэрэглэхийг хориглосон нь Монгол Улсад пестицидийн хэрэглээнд хориг тавьсан анхны тохиолдол болсон байна. Гэсэн хэдий ч зарим сумдад 2000 он хүртэл НСН-ийг хэрэглэсээр байжээ.

НСН-ээс гадна 1969-2003 онд Гексахлорбензол (Hexachlorobenzene), Хлордан (Chlordane), Альдрин (Aldrin), Дильдрин (Dieldrin), Гептахлор (Heptachlore) зэрэг бусад пестицидийг хэрэглэж байжээ.

Даян дэлхийн байгаль орчны сан (ДДБАС)/НҮБ-ын Үйлдвэрлэлийн хөгжлийн байгууллагаас (НҮБ-ын ҮХБ) хэрэгжүүлсэн «Удаан задардаг органик бохирдуулагчийг (УЗОБ) илрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх төсөл» –ийн хүрээнд УЗОБ-ыг бүртгэлжүүлэх тооллогыг хийжээ. 1958-2003 онд ургамлыг хортон шавьжаас хамгаалах зорилгоор Альдрин, Хлордан, Дильдрин, Гексахлорбензолыг бага хэмжээгээр хэрэглэж байсан байна. Энэхүү бүртгэлжүүлэх тооллогын явцад 5 орчим тонн НСН Ховд аймгийн Ховд суманд, 10 гаруй тонн ТМТД-80 (tetramethylthiuram disulfide -тетраметилтиур десульфад) Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд, 108.3 литр (2.5 хувийн) Гинмикс (Chinmix) Улаанбаатар төмөр замын гаалийн баталгаат талбайд тус тус хадгалагдаж байжээ. Эдгээр бүх бодисууд шаардлага хангаагүй нөхцөлд хадгалагдаж байсан байна. 1980-аад оны үед төрөл бүрийн пестицидүүдийг (нэр болон хэмжээ нь тодорхойгүй) Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн Амгалан хавьд булж булшилсан байна.

Хэрэглээнээс хасагдсан химийн бодис, пестицидийн үлдэгдлийн 2014 онд явуулсан тооллогоор 21 аймгийн 139 сумын 297 аж ахуйн нэгжийн байранд нийт 369 тонн, 69,000 л хэрэглээнээс хасагдсан химийн бодис, пестицид хадгалагдаж байсныг илрүүлжээ. Эдгээр зүйлүүдийн 55.6 орчим хувь нь ажлын байранд, 25.4 хувь нь шаардлага хангаагүй агуулахад, 2.6 хувь нь ил задгай хадгалагдаж байжээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь 2020 он гэхэд бүх аймаг, суманд хүрч полихлорт бифенил (РСВ), бусад пестицидээр бохирдсон газар нутгийг илрүүлэх нарийвчилсан судалгаа хийхээр төлөвлөж байна. Хэрэглээнээс хасагдсан пестицидийн үлдэгдлийг бүрэн устгах ажлыг 2024 он гэхэд хийж дуусгах бөгөөд 2030 он гэхэд бохирдсон нийт нутаг дэвсгэрийг цэвэрлэн ариутгахаар төлөвлөж байна.

#### Полихлорт бифенилүүд (ПХБ)

ПХБ-ийн урьдчилсан тооллогыг 2005 онд хийж, улмаар тусгаарлагч тостой цахилгаан тоног төхөөрөмжийг хамруулан 2009 оноос эхлэн нарийвчилсан тооллогыг явуулж байна. Өнөөгийн байдлаар Монгол Улс ПХБ-ыг бууруулах үйл ажиллагаагаа зөвхөн тусгаарлагч тостой цахилгаан тоног төхөөрөмжийг хамруулах замаар тун хязгаарлагдмал хүрээнд явуулж байна.

2005-2006 оны тооллогоор трансформатор 2595.4 тонн, тормоз 2472.7 тонн, конденсатор 7.5 тонн, бусад төрлийнх 442.7 тонн гэх зэрэг нийт 5,518.3 тонн ПХБ-ын агууламжтай тоног төхөөрөмж бүртгэгджээ. Ихэнх шингэн бодисыг эрчим хүчний салбарт хэрэглэж байна. Газар зүйн байршлаар нь авч үзвэл дээрх төрлийн тоног төхөөрөмжийн 97 хувь нь төвийн бүсэд байгаа аж. Бүртгэгдсэн нийт тоног төхөөрөмжийн 8 орчим хувь нь 50 ppm-ээс илүү ПХБ-ийн агууламжтай байжээ. Төрлөөр нь авч үзвэл, 188 трансформатор, 66 тормоз, тосны 2 хаягдал банк/сав байсан бөгөөд тэдгээрийн нийт жин нь 663.6 тонн бөгөөд тосных нь жин 207.1 тонн байна.

“ПХБ-ын тосны агууламжтай тоног төхөөрөмжийг шатаалгүйгээр хоргүйжүүлэх технологи - Байгаль орчинд ээлтэй ПХБ-ийн менежмент ба устгалын чадавхийг бэхжүүлэх” төсөл нь НҮБ-ын ҮХБ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр 2013 оноос үйл ажиллагаагаа эхэлжээ. ПХВ-ын агууламжтай тос, тоног төхөөрөмжийн хоргүйжүүлтийг CDP (битүү горимоор тасралтгүй урсгаж гаргах) технологийг ашиглан гүйцэтгэж байна. Эдүгээ хүртэл 800 тонн ПХБ-ийн агууламжтай тоног төхөөрөмжийг CDP технологиор хоргүйжүүлэн цэвэрлэсэн бөгөөд үүнийг 1,000 тоннд хүргэх зорилтод дөхөж байгаа юм. 2020 он гэхэд 50 ppm-ээс илүү ПХБ-ийн агууламжтай тостой тоног төхөөрөмжийг 2020 он гэхэд бүрэн хоргүйжүүлэх зорилт тавьж байна.

#### *Онцлог хог хаягдлын урсгал*

Монгол Улсад онцлог хог хаягдлын урсгалын талаарх менежментийн төлөвлөгөө, стратеги байхгүй байна. Эко-Паркийн ТЭЗҮ-ийг боловсруулах судалгааны явцад хийсэн онцлог хог хаягдлын урсгалын талаарх дүн шинжилгээний мэдээллийг менежментийн төлөвлөгөө гаргах суурь болгон ашиглаж болох юм.

Үндэсний статистикийн хороо, Байгаль орчны мэдээллийн төвийн аль алины гаргаж байгаа мэдээлэл нь өнөөгийн Монгол Улсад бий болж буй дахин боловсруулахаар ангилан ялгалт хийсэн болон дахин боловсруулсан хог хаягдлын тоо хэмжээний мэдээллээс маш ихээр зөрүүтэй байна. Дахин боловсруулах хог хаягдлын дийлэнх хэсгийг БНХАУ, БНСУ-руу экспортолж байна.

#### Органик хог хаягдал

Органик хог хаягдалд гал тогоо болон цэцэрлэгт хүрээлэнгээс гарах хог хаягдлыг хамруулах бөгөөд Улаанбаатар хотод жилдээ ийм төрлийн 350,000 тонн хог хаягдал гарч байна. Органик хог хаягдлыг багасгах талаар Монгол Улсад одоогоор тусгайлсан хөтөлбөр үгүй бөгөөд органик хог хаягдлыг шууд хогийн цэгрүү хүргэдэг ажээ.

#### Хаягдал яс

Монгол Улсад 2014 онд гэхэд нийт 9 сая толгой малыг нядалж, үүнээс 77,000 орчим тонн хаягдал яс гарчээ. Тус улсын хүн амын бараг тал хувь нь төвлөрдөг Улаанбаатар хотод гэхэд нядалгааны улмаас 38,500 тонн хаягдал яс гарч байна. Хог хаягдлын бүтцийн шинжилгээнээс үзэхэд 7,124 тонн орчим хаягдал яс Улаанбаатар хотын Хогийн цэгүүдэд хаягдсан байна.

#### Батерей болон аккумуляторын хаягдал

Автомашинны аккумулятор, гар утас, компьютерын батерей, ахуйн хэрэглээний зай гэх мэт хаягдал жилдээ 1,851 орчим тоннд хүрч байна.

#### Хаягдал дугуй

Монгол Улсад ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн тоо хэмжээг үндэслэн тооцвол хаягдал дугуйны хэмжээ жилдээ 15,359 тонн болж байна.

#### Электрон болон цахилгаан хэрэгслийн хаягдал

Телевизор, хөргөгч, угаалгын машин, компьютер, цахилгаан халаагуур, ус халаагч зуухнууд, гар утас гэх мэт хэрэгслийн хаягдал энэ бүлэгт хамаарна. Эдгээр хэрэгслийг ашиглаж байгаа айл өрхийн тоо, эдгээр хэрэгслийн ашиглалтын хугацаа зэргийг харгалзан хийсэн тооцоогоор жилд дунджаар 6,287 тонн электрон болон цахилгаан хэрэгслийн хаягдал гарч байна.

#### Хаягдал шил болон шилэн лонх сав

Шил, шилэн савны импорт, дотоодын ундааны үйлдвэрлэл, шилэн саванд савласан хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хоосон шилэн сав суулга, бусад шилэн бүтээгдэхүүн эдлэл зэргийг харгалзан тооцоолоход жилд дунджаар 33,773 тонн хаягдал шил хаягдаж байна. Улаанбаатар хотын Хогийн цэгүүдийн мэдээллийг үндэслэн хог хаягдлын бүтцийг судалж үзэхэд хаягдал шилний хэмжээ 31,818 тонн байна. Үндэсний статистикийн хорооны мэдээллээс харахад дунджаар 50,000 тонн хаягдал шилийг ангилан ялгасан бөгөөд тэдгээрийн дөнгөж 1,500 тонныг нь эх орондоо дахин боловсруулсан байна.

#### Хаягдал хуванцар

Эко-Паркийн тооцоогоор жилд дунджаар 15,000 тонн хаягдал хуванцар гаргаж байгаагийн 7,929 тонн нь Улаанбаатар хотод байна. Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр илүү их буюу жилд дунджаар 120,000 тонн хуванцар хаягдал гарч байна. Эко-Паркийн тооцоонд үйлдвэрүүдийн хуванцар баглааны мэдээлэл хамрагдаагүй байгаа юм. Хаягдал хуванцарын хэрэглээний эрэлт хэрэгцээнээс шалтгаалан дахин боловсруулсан хаягдал хуванцарын хэмжээ нь 300 тонноос 4,000 тонн хүртэл хэлбэлзэж байна. Жилд дунджаар 7,000 тонн хаягдал хуванцарыг экспортолж байна.

#### Хаягдал төмөр

Зэвэрдэг, зэвэрдэггүй төмрийн хаягдлыг дахин боловсруулах хоёр хувилбар байна. Төмрийн хаягдал ихэнхдээ үүсгүүр дээрээ ангилан ялгагдаж төмрийн үйлдвэрүүд рүү шууд илгээгддэг учир ХХХХ-т

хамаардаггүй. Хоёр дахь хувилбар нь төмрийн хаягдал ХХХХ-ийн хэлбэрээр Улаанбаатар хотын Хогийн цэгүүдэд хүргэгддэг бөгөөд тэндээс авсан мэдээллээс үзэхэд жилд дунджаар 136,000 тонн зэвэрдэг, зэвэрдэггүй төмрийн хаягдал хогийн цэгүүдэд хүргэгддэг байна.

Үндэсний статистикийн хорооны мэдээллээс харахад дунджаар 130,000 тонн хаягдал төмрийг тусад нь цуглуулж, ангилан ялгасан байгаа бөгөөд тэдгээрийн 120 тонныг нь эх орондоо дахин боловсруулж байна.

#### Хаягдал цаас

Цаасан сав баглаа боодлын талаарх мэдээлэл хомс учир хаягдал цаасны тооцоог хийхэд төвөгтэй юм. Улаанбаатар хотын Хогийн цэгүүдэд жилд дунджаар 80,000 тонн хаягдал цаас хүргэгдэж байна. 2015-2016 онд дунджаар 130,000 тонн хаягдал цаасыг тусад нь цуглуулжээ. Монгол Улсад хаягдал цаасыг дахин боловсруулах хүчин чадал тун тааруу бөгөөд жилд дунджаар дөнгөж 20 тонныг дахин боловсруулж байна.

#### Хөдөлгүүрийн хаягдал тос

Монгол Улс нь 2014 онд 981 тонн хөдөлгүүрийн тос импортлосон байна. Үүн дээр үндэслэн тооцооход жилд дунджаар 700 тонн хөдөлгүүрийн хаягдал тос гарч байна. Албан ёсны мэдээллээс харахад Улаанбаатар хотын хогийн цэгүүдэд жилд дунджаар 489 тонн хөдөлгүүрийн хаягдал тос хүргэгджээ.

#### Хэрэглээнээс гарсан тээврийн хэрэгслийн хаягдал

Хэрэглээнээс гарсан тээврийн хэрэгслийг сэргээн ашиглах талаарх үндэсний хөтөлбөр байхгүй байна. Хэрэглээнээс гарсан тээврийн хэрэгслийг задалж ашиглах туршилтын төслийг 2014 онд Улаанбаатар хотод Солонгосын олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас боловсруулсан хэдий ч уг төсөл бүрэн хэмжээгээрээ хэрэгжээгүй байна. Хэрэглээнээс гарсан тээврийн хэрэгслийн асуудал Монгол Улсын хувьд нэн тэргүүлэх чухал асуудал биш бололтой.

### **10.2 Хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх**

Монгол Улс нь аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглосон. Түүнчлэн хөрш улс болох БНХАУ, ОХУ ч төстэй хоригийг баталжээ. Тиймээс Монгол Улсын аюултай хог хаягдлын экспорт БНХАУ, БНСУ руу онцгой зарим нөхцөлд хийсэн экспортоор хязгаарлагдаж байна.

2005-2006 онд БНСУ улс руу 3,000 тонн хар тугалганы хүчилтэй баттерейн хаягдал экспортлосон тухай цорын ганц тохиолдол бүртгэгджээ. Энэхүү тээвэрлэлтийг Базелийн Конвенцийн шаардлагуудын дагуу гүйцэтгэж БНСУ болон БНХАУ-ын зөвшөөрөлтэйгээр хийжээ.

Дахин боловсруулах хог хаягдал нь тус улсаас гол төлөв БНХАУ руу экспортлогдож байгаа боловч дахин боловсруулах хаягдлын тоо хэмжээ, төрлийн талаарх тодорхой мэдээлэл байхгүй байна.

### **10.3 Хог хаягдлын хор нөлөө**

Байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх хог хаягдал болон хог хаягдлын цэгүүдээс үүсэх хор нөлөөний талаарх цогц судалгаа хийгдээгүй байна. Гэсэн хэдий ч, ямар ч хяналтгүй хогийн цэгүүд дэх хотын хог хаягдал, үйлдвэр аж ахуйн газруудад хадгалагдаж буй аюултай хог хаягдал, уул уурхайн үйл ажиллагаанаас үүссэн хаягдал чулуулгийн овоолго, бохирдлын сан цөөрөм зэрэг Монгол улсын байгаль орчинд ноцтой нөлөө үзүүж байгаа гурван төрлийн хог хаягдал байна. Ийм нөлөөллийн талаар зөвхөн хэсэгчилсэн мэдээлэл байгаа бөгөөд байгаль орчин, хүний эрүүл мэндэд учруулж буй хохирол нөлөөллийг бүрэн хэмжээгээр нь судалсан судалгаа одоохондоо алга байна.

#### *Агаар*

Монгол орны хот суурин газрын агаарын чанарт ихэвчлэн хотуудтай ойролцоо орших хог хаягдлын цэгүүдэд гарах түймрийн хор нөлөө их байна. Монголд үүсч байгаа диоксин, фураны бохирдлын 50 орчим хувь нь хог хаягдал ил задгай шатааснаас үүдэлтэй гэж үздэг. Хөдөө орон нутгийн агаарын чанар нь уул уурхайн үйл ажиллагаанаас үүссэн хаягдал чулуулгийн овоолгоос гарах тоос шорооны

хор нөлөөнд автаж байна. Хаягдал чулуулгийн овоолго ихээр хуримтлагдсанаас салхины улмаас эргэн тойронд нь үргэлжид шороо тоос босч байна.

Уурхайн зохисгүй үйл ажиллагаанаас үүссэн хаягдал усны цөөрмийн ууршилтаар химийн бодисын агууламжтай тоос босч агаарт хүнд металлын бохирдол үүсгэж байна. Улаанбаатар хотын хувьд цахилгаан станцын үнс нурам салхиар агаарт дэгдэж агаарын чанарт нь хор уршиг хүргэж байна.

#### *Ус*

Хотын хог хаягдлын цэгүүдэд хүрээлэн буй орчноо бохирдуулахаас сэргийлсэн тусгаарлах хаалт байхгүй байна. Хэдийгээр Монгол Улс нь хуурай уур амьсгалтай ч хог хаягдлаас үүсэх чийг хөрсөнд нэвчин газрын доорхи усыг бохирдуулж болзошгүй юм.

Түүнчлэн уул уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй хаягдлын сан цөөрөм нь бохирдуулагч бодисын даланг үүсгэж орон нутгийн гол горхинд хүнд металлын агууламж нэвчин бохирдуулах эрсдэл үүсгэж байна.

ДЦС-4 дээр хоёр ч удаа буюу 2000, 2008 онд үнсний сангийн далан сэтэрч үнсний лаг урсч ойр орчмын газрыг бохирдуулсан тохиолдол гарчээ (2000 онд Туул голруу орсон байдаг). Үүнээс хойш үнсний санг норгох, цасаар хучих замаар хамгаалж ирсэн хэдий ч хуурай улирлаар салхи, шуургаар үнс дэгдэн хийсч байгаагаас сэргийлэх, түүнээс үүсэх байгаль, орчны нөлөөллийг бууруулахын тулд хуримтлагдсан үнсн нуруу руу ус цацаж байнга норгож чийглэх арга хэмжээ авч байгаа аж.

#### *Хөрс, газар, газрын гадаргын байдал*

Томоохон ил уурхайн үйл ажиллагааны явцад ихээхэн хэмжээний хөрс хуулагдаж, хүдрийн боловсруулалтын явцад хаягдал ус лагийн цөөрөм үүсч улмаар хөрс, газар, газрын унаган төрх байдалд хор нөлөө үзүүлж байна. Эдгээр үйл ажиллагааны уршгаар газрын унаган төрх алдагдаж хөрсний үржил шимийг үгүй хийж байна. Тус улсын Засгийн газар энэхүү эрсдэлийг мэдрэхийн хирээр уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж компаниудыг тухайн газар нутгаа олборлолтын өмнөх байдалд оруулж нөхөн сэргээж байх талаар шаардлага тавьж тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Хот суурин газрын ойролцоо байрлах хотын Хогийн цэгүүд нь ойр тойрныхоо газар нутаг, орчинд сөрөг нөлөө үзүүлж байна. Хогийн цэгийн хог хаягдал шатах, газрын гадаргуу нь унаган төрхөө алдаж доройтох, улмаар хог хаягдал хийсч тархан орчин тойрноо бохирдуулах зэргээр газар, газрын унаган төрхөд эрсдэл учруулж байна.

Химийн бодис, аюултай хог хаягдлыг зүй зохисгүй хадгалах, бичил уурхайнууд мөнгөн ус ашиглах зэргээс орон нутгийн хөрсний бохирдол үүсч байна.

#### *Биологийн олон янз байдал болон экосистем*

Хотын болон үйлдвэрлэлийн хог хаягдлын менежментийг тухайн нутаг орчиндоо (хязгаарлагдмал орчинд) явцуу хийж байгаагаас биологийн олон янз байдал болон экосистемд бүхэлд нь дорвитой нөлөө үзүүлэхгүй байна. Уул уурхайн хуримтлагдсан хог хаягдлаас болж тухайн газар нутгийн экосистем, орон нутгийн биологийн олон янз байдалд хор нөлөө учрах боловч энэ нь чухамдаа уул уурхайн үйл ажиллагааны үр дагавар юм.

#### *Хүний эрүүл мэнд*

Хүн амын хамгийн аюулд ороод байгаа хэсэг нь хог хаягдлын цэг дээр хог түүдэг хүмүүс юм. Тэд хог хаягдлын шаталтаас гарах утаа тортог, илжирч муудсан хог хаягдлын үнэр танар, магадгүй хог ухаж байхдаа бэртэж гэмтэх гээд олон аюултай эрсдэл дунд байна. Улаанбаатарын ойролцоох Хогийн цэгүүд дээр тогтмол хог түүж амьдардаг 200 гаруй хүн байгаа гэсэн тооцоо байна. Хүний эрүүл мэндэд үзүүлэх хог хаягдлын хор нөлөөний талаар тодорхой мэдээлэл байхгүй байна.



## 10.4 Хууль эрх зүй, бодлого, бүтэц зохион байгуулалтын тогтолцоо

### *Хууль эрх зүйн тогтолцоо*

#### Хог хаягдлын менежментийн хууль тогтоомж

Монгол Улс нь хог хаягдлын менежментийн хууль эрх зүй, зохицуулалттай орон юм.

Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай 2004 оны 7-р сараас хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн хууль нь хог хаягдлын менежментийн талаарх анхны хууль эрх зүйн баримт бичиг байжээ. Энэ хуулийн зорилго нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хор нөлөөллийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, устгах болон түүхий эдийн эх үүсвэр болгон дахин ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Энэхүү хуулийг хожим нь Хог хаягдлын менежментийн тухай хууль болгон 2012 онд өөрчилсөн байна. 2012 оны хуулиар хог хаягдлын менежментийн асуудлыг илүү нарийвчлан хог хаягдлыг багасгах, эргүүлэн ашиглах, дахин боловсруулах (3R) зарчмыг журамласан байна. Улмаар 2012 оны хуулийг дахин шинэчлэн Хог хаягдлын тухай шинэ хуулийг 2017 оны 5-р сарын 19-нд баталжээ.

Хог хаягдал гэж өмчлөгч эзэн нь дахин ашиглах боломжгүй хэмээн үзсэн эд зүйл, материалыг хэлнэ. Аюултай хог хаягдлыг Базелийн конвенцийн дагуу тодорхойлж байна.

2017 оны Хуулиар Монгол Улс дахь хог хаягдлын менежментийн шинэ үзэл баримтлалыг гаргаж баталжээ. Үүгээр аюултай хог хаягдлын менежментийн асуудлууд, тулгарч буй саад бэрхшээл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж өгсөн байна. Хог хаягдлын менежментийн эдийн засаг, санхүүжилтийн асуудлыг ч мөн оруулсан бөгөөд түүнчлэн хог хаягдлаас олж болох эдийн засгийн үр өгөөжийг ч авч үзжээ. Энэ талаар Хог хаягдлын менежментийн тухай 2012 оны хуулинд байснаас илүү олон заалтыг нэмж оруулсан байна. Жишээлбэл, нэг өрхөд ногдох хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоохдоо өрх бүрт хавтгайруулан жигд тогтоогоогүй харин илүү шударга байх үүднээс тухайн өрхөд амьдарч буй хүмүүсийн тоог харгалзан тогтоосон байна. Мөн хог хаягдлын менежментийн зөрчлийн талаар мэдээлсэн хувь хүн, байгууллагын урамшуулалыг (жишээ нь, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас ногдуулсан торгуулийн 15 хувьтай тэнцэх урамшууллыг мэдээлэгчид олгоно) хуульчилж өгсөн. Энэхүү хуулинд байгаль орчинд ээлтэй хэрэглээний соёлыг бий болгох, хог хаягдлыг багасгах дадлыг эзэмшүүлэх, ангилан ялгах, дахин боловсруулах талаарх олон нийтийн боловсрол, мэдлэг мэдээллийг түгээхийг чухалчилжээ. Мөн хог хаягдлын талаарх боловсролыг журамлаж өгсөн байна. Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн зөрчлийн хариуцлагыг ч мөн хуульчилжээ.

Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэхийг хориглох, экспортлох тухай 2000 оны хууль нь Базелийн конвенцийн зарчмыг Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд оруулж өгчээ. Энэ хуулийн нөхцөл, үзэл санааг 2012 онд батлагдсан Хог хаягдлын менежментийн тухай хуулинд оруулсан учир 2000 оны хууль хүчингүй болгосон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 135 тоот тогтоолоор батлагдсан Аюултай хог хаягдлыг цуглуулах, савлах, түр байршуулах, аюулгүй болгох, хадгалах, устгах тухай журмаар засгийн газрын шийдвэр гартал орон нутгийн засаг захиргаа нь аюултай хог хаягдлыг хаях цэгийг байгаль орчны болон эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн дүгнэлтийг үндэслэн тогтоох эрхийг олгожээ. Тэгэхдээ аюултай хог хаягдлыг олон улсын стандартын дагуу хадгалж, савласан байх ёстой. Мөн аюултай хог хаягдлын хариуцлагыг үйлдвэрлэгч нь хариуцахыг үүрэг болгож журамлаж өгсөн байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын Хог хаягдал булах, устгах зориулалтын байгууламж, төвлөрсөн цэгийн төрөл, тэдгээрт тавигдах шаардлага, хог хаягдал булах, устгах үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны тухай 404 тоот тушаалаар хог хаягдлын цэгийн төрөл, байршлын шаардлага, хог хаягдлын цэгийн үйл ажиллагааны журам, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлаа зайлуулах үйл ажиллагааг журамлаж өгсөн байна. Энэхүү журамд хогийн цэгүүдэд хүлээн авч байгаа хог хаягдлын хэмжээг бүртгэж байхыг журамлажээ.

Аюултай хог хаягдлын төлбөрийг тооцох тухай 2006 онд гарсан аргачлалд бохирдуулагч нь төлөх зарчмыг баримтлах, улмаар аюултай хог хаягдлыг ердийн хог хаягдлаас ангилан ялгах, хог хаягдлын үүсгүүрийг бүртгэж байхыг зааж өгсөн.

Хог хаягдлын норматив тогтоох тухай 2007 оны аргачлалаар иргэд, айл өрх, аж ахуйн нэгж, бүтээгдэхүүн бүрийн дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг тооцох, мөн хог хаягдлын бүтэц, тээврийн зардлыг тооцоолох зорилт тавьсан байна.

Аюултай хог хаягдлын бүртгэл, тайлангийн тооллого явуулах тухай 2009 оны журам нь аюултай хог хаягдлаас үүсэх эрсдлээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж, хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдлыг дахин боловсруулах, хог хаягдлыг бүртгэх тайлагнах, хог хаягдлын цэгийг нөхөн сэргээх ажлыг зохицуулах чиглэлээр төсөл хэрэгжүүлэхийг зорьжээ.

Монгол Улсын Их Хурлаас 2010 оны 1 дүгээр сараас эхлэн ахуйн болон сав баглаа боодлын зориулалтаар 0.025 мм-ээс нимгэн нийлэг хальсан уут импортлох болон ашиглах, улмаар зарим нийлэг хальсан уутны хэрэглээ болон импортыг хориглосон байна.

Аюултай хог хаягдлын ангиллын тухай 2015 оны 264 тоот тогтоолоор уул уурхай, хөдөө аж ахуй болон бусад салбаруудаас гаргаж байгаа аюултай хог хаягдлын ангиллыг тодорхойлж баталж өгсөн байна. Үүнийг Европын Холбооны хог хаягдлын ангиллын системийг үндэслэн гаргажээ.

#### Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын тухай хууль тогтоомж

Яамдын сайд нарын 2011 оны 305/320 тоот хамтарсан тушаалаар эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, түр хадгалах, тээвэрлэх, эмнэлгийн хог хаягдлыг халдваргүйжүүлэх талаарх журмыг баталсан байна.

Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги, Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах талаар 2009-2013 онд авч хэрэгжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2009 оны 293 тоот тушаалаар баталжээ.

Эрүүл мэндийн сайдын 2010 оны 165 тоот тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудын халдвараас урьдчилан сэргийлэх, хянах стандартын доод түвшинг баталж, хог хаягдлын сав баглаа боодлын өнгө, хаягны стандартыг тогтоож өгсөн байна.

Эрүүл мэндийн сайдын 2011 оны 93 тоот тушаалаар эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг халдваргүйжүүлэх, тээвэрлэх зардлын тооцоог зохицуулж өгсөн. Энэ нь эмнэлгийн төсөвт хог хаягдлын менежментийн зардлыг оруулах боломж олгосон байна. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хог хаягдлын менежментийн зардлын тооцоог хийхдээ нэг ор хоногт ногдох хог хаягдлын тоо хэмжээ болон амбулаториор бий болж буй хог хаягдлын тооцоон дээр үндэслэж байна.

Эрүүл мэндийн сайдын 2011 оны 179 тоот тушаалаар орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлыг хадгалах байгууламж, сум, сум дундын эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлыг хадгалах байгууламжийн талаарх журмыг баталж, мөн эхэс булшлах нүх барих, ашиглах журам, аймаг, сум, сум дундын эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлын менежментийн ээлтэй орчинг бүрдүүлүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмжийн жагсаалт, нэр төрлийг баталжээ.

Эрүүл мэндийн сайдын 2011 оны 380 тоот тушаалаар нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлын нэгдсэн цэгийг байгуулах, ажиллуулах ерөнхий зааврыг баталжээ.

#### Химийн бодисын тухай хууль тогтоомж

Монгол Улс нь Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуулийг 1995 онд баталсан нь химийн бодисын зохицуулалтын тухай анхны хууль эрхийн баримт бичиг болсон байна. Энэ хуулийг 2006 онд Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулиар өөрчилжээ. 2006 оны хууль нь химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, Монгол Улсын хилээр дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Байгаль орчны болон Эрүүл мэндийн сайдын 2008 оны 04/04 тоот хамтарсан тушаалаар Хортой болон аюултай химийн бодисын ангиллыг баталсан бөгөөд энэ нь НҮБ-аас баталсан Химийн бодисын ангилал, хаягжуулалтын дэлхийн нэгдсэн системийг үндэслэн боловсруулагджээ. Хориглох болон хязгаартайгаар ашиглах Хорт болон аюултай химийн бодисын жагсаалтыг Монгол Улсын Засгийн газар

1997 онд баталсан байна. Энэхүү жагсаалтыг 2007 онд шинэчилсэн бөгөөд үүгээр 83 төрлийн химийн бодист хориг тавьж, 28 төрлийн химийн бодисыг хязгаартайгаар ашиглахыг журамлажээ. 2008, 2010, 2011, 2012 онд тус жагсаалтад шинээр хэд хэдэн химийн бодисууд нэмэгдсэн бөгөөд одоогоор 126 төрлийн химийн бодисыг хэрэглэхийг хориглосон бөгөөд 31 төрлийн химийн бодисыг хязгаартайгаар ашиглахыг журамласан байна.

Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх үйл ажиллагааг Байгаль орчны сайд, Гадаад харилцааны сайдын 2009 оны 334/104 тоот “Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх үйл ажиллагааны журмын тухай” хамтарсан тушаалаар журамлажээ. Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагааг Байгаль орчны болон Эрүүл мэндийн сайдын 2007 оны 151/126/52 тоот “Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын тухай” хамтарсан тушаалаар журамласан байна.

“Химийн хорт болон аюултай бодисын эрсдлийн үнэлгээ хийх журам”-ыг Байгаль орчны болон Эрүүл мэндийн сайд, ОБЕГ-ын дарга нарын 2012 оны А-50/378/565 тоот хамтарсан тушаалаар баталжээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн болон Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан 2009 оны 63/67/87 тоот “Пестицидийг химийн бордоо, шавьж устгал, рестораны, эрүүл ахуй, халдваргүйжүүлэлтэд турших, ашиглах журмын тухай” тушаалаар ургамлын хамгаалалт, мал эмнэлгийн зориулалтаар пестицид, бодисын туршилт, ашиглалтыг журамласан байна.

УЗОБ-тай холбоотой үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн анхны баримт бичгийг Байгаль орчин, Эрүүл мэндийн сайд нарын 2012 оны 17/16 тоот “Полихлорт бифенилүүд (ПХБ)-ийг бүртгэх, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, устгах, импортлох, экспортлох болон хил дамнасан хөдөлгөөний зохицуулах журам”-ын тухай хамтарсан тушаалаар гаргажээ.

#### Цацраг идэвхит хаягдлын тухай хууль тогтоомж

Монгол Улсад цацраг идэвхит хог хаягдлын талаар тусгайлсан хууль тогтоомж байхгүй бөгөөд энэ нь 2009 оны Цөмийн энергийн тухай хууль болон цөмийн болон цацраг идэвхит үүсгүүрүүдийн тухай бусад ерөнхий хууль тогтоомжийн хүрээнд зохицуулагдаж байна.

#### *Бодлогын хүрээ*

#### Хог хаягдлыг бууруулах 1999 оны үндэсний хөтөлбөр

Засгийн газрын 1999 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан 1999-2010 онд хэрэгжүүлэх “Хог хаягдлыг бууруулах тухай” Үндэсний хөтөлбөрийн үндсэн зорилго нь хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хог хаягдлыг хүрээлэн буй орчинд халгүйгээр зайлуулах, ялган боловсруулах замаар түүний хэмжээг бууруулах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог өргөжүүлэхэд оршиж байна. Хөтөлбөрийн энэхүү үндсэн зорилгын хүрээнд дараах асуудал хамаарч байна. Үүнд:

- Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, ялган ангилах, боловсруулах, дахин ашиглах, устгах үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
- Хаягдлын эх үүсвэр, хэмжээ, бүтэц, шинж чанарын байдлыг тогтоож, хог хаягдлын цэгийг оновчтойгоор байршуулах;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нутгийн захиргааны байгууллага, иргэн, бүх хэвшлийн аж ахуйн нэгжийг өргөнөөр татан оролцуулж, тэдэнд дэмжлэг үзүүлэх арга механизмыг тогтоож хэвшүүлэх;
- Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, техник технологийн шинэчлэлт хийх;
- Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж буй хогийн цэгүүдийг дарж устган байгалийн нөхөн сэргээлт хийх замаар тэдгээрийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ялзмагжуулан цэвэршүүлэх байгууламж болгон өөрчлөх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх;
- Аюултай хог хаягдлыг тусгайлан цуглуулж цэвэршүүлэх, хоргүйжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Хог хаягдлыг эргүүлэн ашиглах, дахин боловсруулах замаар хог хаягдлын хэмжээг багасгах арга хэмжээ авах

Хог хаягдлын менежментийн талаарх үндсэн зорилгоо энэхүү хөтөлбөрийн хүрээнд маш зөв тодорхойлсон хэдий ч хэрэгжилт хангалтгүй байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа шаардагдах ажил болон хөрөнгө оруулалтын хэрэгцээг дутуу тодорхойлсон байна. Энэ хөтөлбөрийн биелэлт чамлалттай байгаа хэдий ч хөтөлбөрийн үндсэн зорилгоо олон улсын тусламж дэмжлэгийг түлхүү авах, Монгол Улсын хог хаягдлын менежментийн тогтолцоонд нэн шаардлагатай байгаа тээвэрлэлтийн хэрэгцээг хангахад чиглүүлсэн нь ач холбогдолтой болжээ.

#### Хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах 2014-2022 онд хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөр

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 298 тоот тогтоолоор батлагдсан 2014-2022 онд хэрэгжүүлэх Хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр нь Монгол Улсын Хог хаягдлын менежментэд нэн тэргүүнд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор батлагдсан байна. Тус хөтөлбөр нь хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хугацаа, санхүүжүүлэх эх үүсвэр, хүрэх зорилтууд, тэдгээрийг хянаж үнэлэх шалгуур бүхий Үйл ажиллагааны төлөвлөгөөтэйгөөр батлагджээ.

Хөтөлбөрийн үндсэн зорилго нь нөөцийн үр ашигтай, хэмнэлттэй хэрэглээ, технологийг дэмжин хаягдлыг бууруулж, байгаль орчинд хал багатайгаар зайлуулах, хүн амд амьдрах орчны эрүүл ахуйн мэдлэг, зөв дадлыг олгох замаар хатуу хог хаягдлын зохистой менежментийг төлөвшүүлж, цэвэр эрүүл орчин бүрдүүлэхэд оршиж байна. Хөтөлбөрийн энэхүү үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьсан байна. Үүнд:

- Хог хаягдлын эрх зүйн орчин, менежментийг боловсронгуй болгох;
- Үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, нөөц, түүхий эдийн зарцуулалтыг багасгах, хэмнэх замаар хог хаягдлыг бууруулах болон хаягдалгүй дэвшилтэт технологийг дэмжих, үйлдвэрлэлийн хог хаягдлын зохистой менежмент, хяналтын тогтолцоог бүрдүүлэх;
- Аюултай хог хаягдлын менежментийг сайжруулж байгаль орчинд хал багатайгаар зайлуулах чадавхийг бүрдүүлж, аюултай хаягдал хуримтлагдахаас сэргийлэх;
- Хүн амд ногоон хэрэглээний соёл, хог хаягдлыг ангилан ялгах, амьдрах орчны эрүүл ахуйн зөв дадлыг төлөвшүүлэх замаар амьдралын тав тухтай орчин бүрдүүлэх;
- Хог хаягдлыг дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, эрчим хүч үйлдвэрлэх зэргээр хог хаягдлын хэмжээг бууруулах.

Хөтөлбөрийг хоёр үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Нэгдүгээр үе шатанд (2014-2017 он) Хог хаягдлыг бууруулах эрх зүй, зохион байгуулалтын орчныг боловсронгуй болгож, менежментийг сайжруулах, дэд бүтцийн болон санхүүгийн чадавхийг бэхжүүлэх, хог хаягдлыг бууруулах үйл ажиллагаанд иргэд, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэхэд чиглэсэн цогц бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Эдгээр зорилтуудын зарим хэсэг нь л биелэгдсэн байна. 2017 онд шинээр батлагдсан Хог хаягдлын тухай хууль гарснаар хог хаягдлын асуудлыг илүү өргөн хүрээнд авч үзэж эхэлсэн төдийгүй ялангуяа эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент, дэд бүтэц аажмаар сайжирч байгаа боловч хог хаягдалд хандах дадал хандлагад өөрчлөлт гарахгүй байна. Хоёрдугаар үе шатанд (2018-2022) хог хаягдлаас үүдэлтэй орчны доройтлыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлж, ногоон хэрэглээний соёл, нийгмийн хариуцлагын ойлголтыг төлөвшүүлж, хог хаягдлын зохистой менежментийн тогтолцоо бий болж цэвэр эрүүл орчинг бүрдүүлэх зорилт тавьжээ.

Үндэсний стратегиар тодорхойлогдсон бүх бүрэлдэхүүн хэсгүүд нь энэхүү хөтөлбөрт тусгагдаагүй байна. Хөтөлбөрт үйл ажиллагааны зорилго, зорилтын талаар олон асуудал орсон хэдий ч тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой зөвлөмж алга байна, түүнчлэн зорилтдоо хүрэх боломжит ямар хувилбарууд байж болох, аль нь илүү давуу талтай болох, шаардагдах төсөв хөрөнгө зэрэг асуудлууд тусаагүй байна. Энэхүү хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд өнөөгийн нөхцөл байдалд нухацтай дүн шинжилгээ хийж, улмаар хог хаягдлын менежментийг сайжруулахад шаардагдах арга хэмжээний төсөв зардлыг нягтлан тооцоолох шаардлагатай.

Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн Олон улсын байгаль орчны технологийн төв, Азийн Технологийн институт, Ази, номхон далайн бүсийн Экспертүүдийн төв зэрэг байгууллагуудын судлаачид хамтран Монгол Улсын Хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг 2017 онд шинээр боловсруулжээ. Одоогоор энэхүү стратеги нь албан ёсоор батлагдаагүй байна.



Тус стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөнд дараах стратегийн зорилтуудыг тусгасан байна. Үүнд:

- Хог хаягдлын тогтвортой менежментийг бүрдүүлэхийн тулд хуулийн хэрэгжилтийг сайжруулах хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох;
- Хог хаягдлыг эргүүлэн ашиглах, дахин боловсруулахыг хөхиүлэн дэмжих эдийн засгийн урамшууллыг ашиглах замаар хог хаягдлыг 30 хувиар бууруулах;
- Аюултай хог хаягдлын цогц менежментийг бий болгох;
- Хог хаягдлыг ангилан ялгах дадлыг бий болгоход чиглэсэн олон нийтийн боловсролыг дээшлүүлэх замаар хог хаягдлыг эх үүсгүүр дээр нь багасгах;
- Хог хаягдлыг устгах байгаль орчинд ээлтэй технологид шилжих замаар хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах;
- Үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахын тулд хог хаягдлын менежментийн тогтвортой зохион байгуулалт, санхүүгийн тогтолцоог бий болгох.

Энэхүү стратегийн зорилтуудыг бүрэн хэрэгжүүлснээр Монгол Улсад хог хаягдлын менежментийг дорвитой сайжруулж, шинэ түвшинд хүргэх болно. Гэхдээ зорилго нэг бүрийг болон үйл ажиллагаа нэг бүрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв санхүүгийн тооцоо хийгдээгүй байна.

#### Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол Улс нь Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын Конвенцийг хэрэгжүүлэх талаарх Үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрөө 2006, 2014 онд тус тус баталсан бөгөөд одоогоор дахин шинэчилсэн хувилбарыг боловсруулж байна. Засгийн газрын 2014 оны 341 тоот тогтоолоор батлагдсан “Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай” үндэсний хөтөлбөрт дараах зорилго, зорилтыг тавьжээ:

- УЗОБ химийн бодисын тухай хууль тогтоомжиндоо нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэглэж байгаа ангилал, стандарт, жишиг үнэ тарифыг өөрчлөх аль эсвэл шинээр тогтоох замаар УЗОБ-той холбоотой үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчныг сайжруулах;
- УЗОБ агуулсан бүтээгдэхүүний хаягдлыг цуглуулах, дахин боловсруулах, байгаль орчинд ээлтэй аргаар устгах зохистой менежментийг бий болгох, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, үйлдвэрийн шинээр бий болж буй химийн бодисыг судлах зэргээр УЗОБ-ийн байгаль орчинд ялгарах ялгарлыг бууруулах, улмаар хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг багасгах
- Эх үүсгүүрээс зориудын бусаар үүсдэг УЗОБ-ийн ялгарлыг бууруулах; ихэвчлэн хог хаягдлыг ил задгай шатаах болон эмнэлгийн хог хаягдалыг шатаах зуухнаас ялгардаг диоксин, фураныг багасгах; цахилгаан станц, халаалтын бойлуур, айл өрхийн зуухнаас ялгарах диоксин ба фураныг багасгахад чиглэсэн боломжит хамгийн сайн арга (BAT) болон хүрээлэн буй орчинд ээлтэй сайн практикийг (БЕР) нэвтрүүлэх;
- УЗОБ-пестицидээр бохирдсон газрыг олж тогтоон, цэвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- УЗОБ агуулсан тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүний хэрэглээг зогсоох, бохирдлыг хоргүйжүүлэх, устгах замаар 2020 он гэхэд Монгол Улс нь “Полихлор бифенилгүй орон” болох зэрэг зорилт тавьжээ.

УЗОБ-ийн тухай үндэсний хөтөлбөрийн зорилтыг дараах 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Нэгдүгээр үе шатанд (2014-2020 он) Хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг сайжруулах, хог хаягдал, аюултай хог хаягдал, ялангуяа УЗОБ агуулсан хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй аргаар цуглуулах, дахин боловсруулах, устгах менежментийг бий болгох, УЗОБ бодисуудыг тодорхойлох лабораторийн чадавхийг бүрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Хоёрдугаар үе шатанд (2020-2040 он) УЗОБ агуулсан бараа бүтээгдэхүүний хэрэглээг зогсоох, нөөц хаягдлыг устгах, бохирдсон газруудыг хоргүйжүүлэх, ийм бохирдлын үүсэлтийг бууруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилт тавьжээ.

#### Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах 2009-2013 онд хэрэгжүүлэх стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө

Энэхүү баримт бичгийн гол зорилго нь эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, ангилах, тээвэрлэх, боловсруулах, устгах оновчтой тогтолцоог бүрдүүлэхэд оршино. Мөн эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг халдваргүйжүүлэх, хог хаягдлыг шатаахаас татгалзах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх нь уг стратегийн тэргүүлэх зорилт болж байна. Олон улсын хандивлагчдын санхүүгийн тусламжтайгаар хэрэгжүүлж байгаа төслүүдийг ч мөн уялдуулан зохицуулах хэрэгцээ



шаардлагатайг энэхүү стратегиар хүлээн зөвшөөрч байгаа аж.

Энэхүү стратегийн зорилтууд нь эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн салбар хоорондын зохицуулах механизмыг бүрдүүлж, удирдлага, зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгоход чиглэж байна. Түүнчлэн, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн эрх зүйн зохистой орчинг бүрдүүлэх, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн санхүүжилтийн тогтвортой механизмыг бий болгож, улмаар эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн санхүүжилтийг нэмэгдүүлэхийг зорьж байна. Мөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүх шатлалд хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах асуудлыг цогцоор шийдвэрлэх дэд бүтцийг бий болгох зорилт тавьжээ. Улмаар эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн чиглэлээр хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх нь чухал болохыг тэмдэглэжээ. Эцэст нь эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн хяналт үнэлгээг сайжруулахыг зорьж байна. Энэхүү стратегийг хэрэгжүүлэхэд нийт 3029 сая төгрөгийн санхүүжилтыг төлөвлөсөн байна.

Тус стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг 2013 оны 4 дүгээр сард ЭМЯ-ны Удирдагын зөвлөлийн хурлаар үнэлэн хэлэлцсэн байна. Нийслэл Улаанбаатар хотын болон 19 аймгийн Эрүүл мэндийн газрууд стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тайлангаа танилцуулжээ. Удирдлагын Зөвлөлийн хурлаар стратегийн үндсэн зорилтууд биелэгдсэн хэмээн дүгнэж, улмаар стратегийн хэрэгжилт сайжирч, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментэд эерэг нөлөө үзүүлсэн боловч цаашид анхаарал хандуулах шаардлагатай асуудлууд байгааг тэмдэглэжээ.

Энэхүү Стратегийг хэрэгжүүлж эхэлснээс хойш эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментэд мэдэгдэхүйц ололт амжилт гарсныг Улаанбаатар хотын жишээ үзүүлж байна. Улаанбаатар хотноо нэвтрүүлсэн эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн тогтолцоо нь хэрэгжүүлэх боломжтой сайн шийдэл болсон хэдий ч Монгол Улсын бусад бүс нутаг дэвсгэрүүдэд өргөжин тэлээгүй байна.

#### 2016 он. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030 баримт бичгийн Байгаль орчны тогтвортой хөгжил хэсгийн Хоёрдугаар зорилтод “Хот суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж, хүрээлэн байгаа орчны чанар, хог хаягдлын менежментийг сайжруулна” хэмээн тусгажээ. Хэдийгээр энэхүү зорилтод хог хаягдлын менежментийн асуудлыг маш өргөн хүрээнд хамруулж тусгасан ч гүйцэтгэлийг үнэлэх “дахин боловсруулсан хог хаягдлын тоо хэмжээ” гэсэн ганцхан шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна. Дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээг 2020 он гэхэд 20 хувиар, 2025 он гэхэд 25 хувиар, 2030 он гэхэд 30 хувиар нэмэгдүүлэх зорилт тавьжээ.

#### 2014 он. Ногоон хөгжлийн бодлого

Ногоон хөгжлийн бодлогын Нэгдүгээр стратегийн зорилтод “Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлнэ” хэмээн тодорхойлсон байна. Хог хаягдлын менежментийг тус бодлогын 3.1.8-д заасан “Эрдэс баялгийн салбарт нөөцийг үр ашигтай, хаягдалгүй ашиглах технологи бүхий үйлдвэрлэлийг дэмжих” арга хэмжээг хэрэгжүүлэх замаар сайжруулахаар томъёолжээ. Түүнчлэн, Гуравдугаар Стратегийн зорилтын “Ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлж, байгаль хамгаалал, хүний хөгжил, цэвэр технологийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” хүрээнд бодлогын 3.6.4-д “Үр ашигтай, хэмнэлттэй технологийг дэмжих, хүн амд амьдрах орчны эрүүл ахуйн мэдлэг, зөв дадлыг олгох замаар хаягдлыг бууруулах зохистой менежментийг төлөвшүүлж, хог хаягдлыг боловсруулж дахин ашиглах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгальд булж зайлуулах хаягдлын хэмжээг 2020 онд 20 хувь, 2030 онд 40 хувь бууруулах” гэсэн арга хэмжээний жагсаалтыг тусгасан байна.

Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явц үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтүүдэд хог хаягдалтай холбоотой ганц үзүүлэлтийг оруулсан байна. Энэ нь “Хог хаягдлын дахин боловсруулалтыг суурь он болох 2013 оноос хойш 2020 он гэхэд 20 хувьд, 2030 он гэхэд 40 хувьд хүргэх” зорилт юм. ХХХХ-ын ангилан ялгалтын түвшин өнөөгийн байдлаар 20 орчим хувьтай байгаагийн дийлэнх нь экспортод гарч байна. Хог хаягдлын дахин боловсруулалтын чадамжаа нэмэгдүүлэхэд ихээхэн хөрөнгө оруулалт шаардагдана.

2008 он. Химийн бодисын менежментийн тухай үндэсний тайлан

2008 онд гарсан Химийн бодисын менежментийн тухай үндэсний тайланд хэрэглээнээс гарсан химийн бодис, аюултай хог хаягдлыг хадгалах, устгах, боловсруулах асуудлыг үндэсний хэмжээнд шийдвэрлэвэл зохих эн тэргүүний асуудал болгох ёстой хэдий ч Засгийн газарт ийм чадавхи сул байна хэмээн тодорхойлсон байна. Түүнчлэн химийн бодис, хог хаягдлын тухай хангалттай мэдээлэл байхгүй байгааг ч тэмдэглэжээ.

*Энэхүү бүлэгтэй холбоотой Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтууд*

2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн Зорилтууд: 3.9, 11.6, 12.4, 12.5 – ын талаарх мэдээллийг доорх Шигтгээ 10.3-т үзүүлэв.

*Бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо*

Хог хаягдлыг эргүүлэн ашиглах, хоргүйжүүлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах үйл ажиллагааг дэмжихэд зориулсан эдийн засгийн урамшууллыг тогтоох болон шаардагдах төсвийг батлах эрхийг Монгол Улсын Их Хурал эдэлж байна. Энэ нь 2017 оны Хог хаягдлын тухай хуулинд туссан шинэ зүйл бөгөөд Монгол Улсад хог хаягдлын менежментийг цаашид хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулах болно.



Шигтгээ 10.3: Тогтвортой хөгжлийн 2030 хүртэлх хөтөлбөрийн Зорилт 3.9, 11.6, 12.4, 12.5

**Зорилго 3: Нийт хүн амыг эрүүл, сайн сайхан амьдрах нөхцөлөөр хангах**

**Зорилт 3.9:** 2030 он гэхэд химийн хорт бодис, агаар, ус, хөрсний бохирдол, хордуулалтаас үүдэлтэй үхэл, өвчлөлийн тоог үлэмж бууруулах.

Дэлхий нийтээрээ зөвшилцөлд хүрсэн шалгуур үзүүлэлт 3.9.3 нь санамсаргүй хордолтоос үүдэлтэй нас баралтын түвшин юм. Монгол Улсад хордолтоос үүдэлтэй нас баралтын түвшин, ДЭМБ-ын мэдээлснээр 2015 онд 100,000 хүн амд 2.2 хүн ногдож байна. Энэ нь 100,000 хүн амд ногдох нас баралтын түвшин 3.8 байсан 2012 оныхтой харьцуулахад буурсан үзүүлэлт. Гэсэн хэдий ч, ДЭМБ-ын ангилалд хамаарах Номхон далайн баруун бүсийн улс орнуудын дунд энэхүү үзүүлэлтээрээ Монгол Улс нь хамгийн өндөрт орж байна. Энэ бүс нутагт 2015 онд 100,000 хүн амд ногдох хордолтоос үүдэлтэй нас баралтын дундаж түвшин 1.4 байна. Энэ үзүүлэлтийн дэлхийн дундаж нь 2015 онд 100,000 хүн амд 1.5 ногдож байв.

Пестицид, керосин, гэр ахуйн химийн бодис, нүүрстөрөгчийн дан исэл нь бага, дунд орлоготой орнуудад санамсаргүй байдлаар хордох нийтлэг шалтгаан болдог. Монгол Улс нь химийн бодис импортлох, ашиглахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь санамсаргүй хордолтын нэг шалтгаан болдог. Санамсаргүй хордолтоос үүдсэн нас баралтыг бууруулахын тулд Монгол Улс нь химийн бодис импортлох, ашиглахтай холбоотой эрх зүйн зохицуулалтаа нухацтай хэрэгжүүлэх хэрэгтэй.

**Зорилго 11: Хот, суурин газруудын тэгш, хүртээмжтэй, аюулгүй, тогтвортой хөгжлийг дэмжих**

**Зорилт 11.6:** 2030 он гэхэд хогүүдэн байгаль орчинд үзүүлэх нэг хүн тутмын сөрөг нөлөөллийг бууруулах, агаарын чанар, хотын болон бусад хог хаягдлын менежментэд онцгой анхаарал хандуулах

Дэлхий нийтээрээ зөвшилцөлд хүрсэн шалгуур үзүүлэлт 11.6.1-ийг тогтмол цуглуулж байгаа хот суурин газрын хатуу хог хаягдлын хувь хэмжээ болон хот суурингийн нийт гаргаж байгаа хатуу хог хаягдлаас бүрэн цэвэрлэгдсэн хэсгийн хувь хэмжээ зэргийг хот хотоор гаргаж тооцно. Хог хаягдлыг тогтмол цуглуулах, зайлуулах талаарх хууль тогтоомжийг Монгол Улс батлан хэрэгжүүлж ирсэн боловч хог хаягдлын устгал дорвитой журамлагдаагүй, булж булшлах ландшафтийн техникийн стандарт боловсруулагдаагүй байна. Ийм үйл ажиллагаа зохистой хэмжээнд явагдаж байгаа ганц газар бол Нарангийн Энгэрийн Хогийн цэг бөгөөд энд 2014 онд гэхэд Улаанбаатар хотын нийт хог хаягдлын 50 орчим хувь буюу 557962 тонн хог хаягдлыг хүлээн авсан байдаг. Тус улсын хот суурингийн хүн амын гуравны хоёр нь Улаанбаатар хотноо амьдардаг бөгөөд, тус улсын нийт ХХХХ-ын 90 гаруй хувийг энд бий болгож байна. Монгол Улсын хэмжээнд бий болж буй ХХХХ-ын 70 орчим хувийг тогтмол цуглуулж, 30 орчим хувийг зохистой хэмжээнд нь устгаж байгаа тооцоо байна.

2009-2013 оны хооронд 101 улсын хотуудаас авсан тоо мэдээллээс харахад дэлхийн хот суурин газрын хүн амын 65 хувь нь хотын хог хаягдлыг цуглуулах үйлчилгээ авчжээ. Европ, Хойд Америк, Австрали тивийн нийт хүн амын 95 гаруй хувь нь ийм үйлчилгээ авч байгаа бөгөөд хотын цуглуулсан бүх хог хаягдлыг зохих ёсоор нь устгалд оруулж байна. Монгол Улс нь хог хаягдлын талаарх тогтвортой хөгжлийн зорилт 11.6-д хүрэхийн тулд хот суурин газрын хатуу хог хаягдлыг цуглуулах, эцсийн устгал хийх үйл ажиллагаагаар сайжруулах хэрэгтэй.

Зорилго 12: Хариуцлагатай, тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийг дэмжих

Зорилт 12.4: 2020 он гэхэд олон улсын хэмжээнд тохиролцсны дагуу хиймийн бодис болон хаягдлыг ашиглалтын бүх хугацаанд байгаль орчинд ээлтэй менежментээр хангах, тэдгээрийн хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор агаар, ус, хөрсөнд хаях явдлыг үлэмж багасгах

Дэлхий нийтээрээ зөвшилцөлд хүрсэн шалгуур үзүүлэлтүүдэд 12.4.1 (аюултай хог хаягдал болон бусад химийн бодисын тухай олон улсын олон талт байгаль орчны гэрээ хэлэлцээрт холбогдох гэрээний дагуу шаардлагатай мэдээллийг хуваалцах амлалт, үүрэг хариуцлагаа хүлээн зөвшөөрч нэгдэн орсон улс орны тоо) болон 12.4.2 (нэг хүнд ногдох аюултай хог хаягдлын тоо хэмжээ, боловсруулан хоргүйжүүлсэн аюултай хог хаягдлын хувь хэмжээ, боловсруулалтын төрлөөр) зэрэг орно.

Монгол Улс нь хог хаягдал, химийн бодисын менежментийн талаарх чухал конвенцүүдэд нэгдэн орсон бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай конвенцийг идэвхитэй хэрэгжүүлж байгаа бөгөөд Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худаалахад хэрэглэх, урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай конвенци, Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортолох тухай конвенцийг хэрэгжүүлэхэд илүү идэвхи гаргах шаардлагатай байна. Тус улс нь 2007 онд мөнгөн ус импортлох, ашиглахыг хориглосон байсан ч Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцийг Монгол Улс 2015 онд соёрхон баталсан байна.

Нэг хүнд ногдох аюултай хог хаягдлын хэмжээ нь тухайн улсын үйлдвэрлэлийн төрөл, хэмжээ, хүн амын тооноос хамаарна. Тухайлбал, Европын Холбооны энэхүү үзүүлэлт дундаж хэмжээнд буюу 2014 онд нэг хүнд 150 кг ногдож байгаа бол Эстонид 7500 кг, Малтад бараг тэглэсэн байх жишээтэй. Уул уурхайн үйл ажиллагааг ихээхэн явуулдаг улс орнуудад нэг хүнд ногдох аюултай хог хаягдлын хэмжээ өндөр байна. (Тухайлбал, нэг хүнд Сербид 1900 кг, Болгарт 1800кг тус тус ногдож байна). Аюултай хог хаягдлын бараг тал хувийг (49,0 хувь) буюу нэг хүнд ногдох 73кг-тай тэнцэх хэмжээний аюултай хог хаягдлыг ЕХ-28 аргаар булж булшилсан байна. Нийт аюултай хог хаягдлын 6 орчим хувийг (нэг хүнд 9 кг ногдох) эрчим хүч сэргээн ашиглалгүйгээр, 7.4 хувийг (нэг хүнд 11 кг ногдох) нь эрчим хүч сэргээн ашиглах замаар чандарлажээ. Европын Холбооны ялгаруулсан аюултай хог хаягдлын гуравны нэгээс илүү хувийг (37.5 хувь) 2014 онд нөхөн сэргээж (дахин боловсруулах, орлуулах замаар) ашигласан байна. Энэ нь нэг хүнд 56 кг ногдох хэмжээнийх юм.

Дунд орлоготой орнуудад нэг хүнд ногдох аюултай хог хаягдлын хэмжээ 1996-2000 онд 17 кг байсан бол 2006-2011 онд 42кг болж нэмэгдсэн байна. Харин өндөр орлоготой орнууд буюу ЭЗХАХБ-ын бус орнуудын нэг хүнд ногдох аюултай хог хаягдлын хэмжээ 2006-2011 онд 981кг байжээ. Энэ үед бага орлоготой орнуудын ялгаруулсан нэг хүнд ногдох аюултай хог хаягдлын хэмжээ 7 кг байжээ.

Монгол Улсад аюултай хог хаягдлын талаарх бодитой тоо мэдээлэл байхгүй байгаа тул нэг хүнд ногдох аюултай хог хаягдлын тоо хэмжээ, боловсруулж хоргүйжүүлсэн аюултай хог хаягдлын хувь хэмжээг тооцох боломжгүй юм. Монгол Улсын хүн ам цөөн, уул уурхайн салбар ихээхэн хөгжсөн зэрэг нөхцөлийг бодолцвол нэг хүнд ногдох аюултай хог хаягдлын хэмжээ дэлхийн дунджаас хол давж мэдэх юм. Аюултай хог хаягдлын талаарх тоо мэдээлэл дутмаг байгааг бодолцон Тогтвортой хөгжлийн 12.4 дүгээр зорилтын хэрэгжилтийг хянахын тулд Монгол Улс нь аюултай хог хаягдлын талаар тайлагнах механизмыг дорвитой сайжруулах хэрэгтэй.

**Зорилт 12.5: 2030 он гэхэд хаягдлыг багасгах, эргэлтэд оруулах, дахин ашиглах замаар хаягдлын хэмжээг ихээхэн бууруулах**

Дэлхий нийтээрээ зөвшилцөлд хүрсэн шалгуур үзүүлэлт 12.5.1 нь дахин боловсруулсан хог хаягдлын тоо хэмжээ юм. Хог хаягдлыг багасгах тухай зүйлийг 2012 оны хатуу хог хаягдлын менежментийн хууль тогтоомжид оруулж журамласан. 2017 оны Хог хаягдлын тухай хуулиар хог хаягдал боловсруулах, эргүүлэн ашиглах, дахин боловсруулах, нөхөн сэргээх, устгахтай холбоотой үйл ажиллагаа явуулахыг дэмжихэд чиглэсэн эдийн засгийн урамшууллыг бий болгох эрхийг УИХ эдэлж байна.

Энэ зорилтын гүйцэтгэлийг 2014-2022 онд хэрэгжүүлэх Хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах тухай үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтээс тооцож болох юм. Энэхүү хөтөлбөрт ХХХХ-ын дахин боловсруулалтын түвшин 2013 онд 4.4 хувь (төмөр ороогүй) байсан бөгөөд 2018 он гэхэд 10 хувьд, 2022 онд 22 хувьд хүргэх зорилт тавьжээ. ЖАЙКА-ийн судалгаагаар 2015 онд ХХХХ-ын дахин боловсруулалтын түвшин 11 хувь байсан хэмээн тооцоолсон байна. Гэхдээ тоо мэдээллийн чанар, бүтэц сул учир бодитой дүгнэлт гаргах боломжгүй юм. Үйлдвэрийн хог хаягдлын дахин боловсруулалтын талаарх мэдээлэл олдохгүй байхгүй. Тиймээс Монгол Улс нь Тогтвортой хөгжлийн Зорилт 12.5-ын хэрэгжилтийг хянах боломжгүй учир аюултай хог хаягдлын талаар тайлагнах механизмаа боловсронгуй болгох шаардлагатай.

Маш олон орны онцлог шинж байдал, тоо мэдээллээс хамааралтай учир хог хаягдлын дахин боловсруулалтын талаар дэлхийн дундаж үзүүлэлтийг тодорхойлох боломжгүй юм. Жишээлбэл, Европын Холбооны орнууд ХХХХ-ынхаа 29 хувийг 2015 он дахин боловсруулж байжээ. ХХХХ-ынхаа 60 гаруй хувийг дахин боловсруулдаг буюу дахин боловсруулалтын түвшин хамгийн өндөртэй орнуудад Австри, Герман, Сингапур зэрэг орнууд орж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь хог хаягдлын менежментийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах, энэхүү бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг хангах, аюултай хог хаягдлыг тээвэрлэхэд шаардагдах дагалдах бичиг, бүртгэлийн маягтыг батлах, хог хаягдлын менежментийн үйл ажиллагааны талаарх улсын мэдээллийн нэгдсэн санг байгуулах үүрэг хүлээж байна. Мөн яам нь 2012 оны Хог хаягдлын менежментийн тухай хуулинд ороогүй шинэ зүйл болох үйлдвэрлэгчийн хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлнэ.

Тус яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын ганцхан мэргэжилтэн

хог хаягдлын менежментийн асуудлыг хариуцан ажиллаж байна. Тэрээр яамныхаа бусад газрын мэргэжилтнүүд болон орон нутгийн захиргааны холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран өдөр тутмынхаа үйл ажиллагааг явуулж байна.

Хог хаягдлын менежментийн тухай 2012 оны хуулиар яам бүр өөрийн харъяа байгууллагуудынхаа хог хаягдлын менежментийн стандарт, дүрэм журмыг боловсруулах тогтолцоог нэвтрүүлсэн байна. Эрүүл мэндийн яам нь Улаанбаатар хотын захиргаа болон хувийн компани болох Элемент ХХК-тай гурвалсан гэрээ байгуулж зохицуулалт, стандартаа сайжруулж уламжилж ирсэн ажлын арга барилаа өөрчилж чаджээ. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь уул уурхайн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдал, тэдгээрийг сэргээн ашиглах талаарх журмыг боловсруулан гаргаж хэрэгжүүлж байна. Бусад яамдууд нь хог хаягдлын менежментийг сайжруулах талаар болон стандарт, дүрэм журам боловсруулан хэрэгжүүлэх талаар бодитой үр дүнд хүрээгүй байна. 2017 оны Хог хаягдлын тухай хуулиар Сангийн яам нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран хог хаягдлын менежментийн санхүүжилтийн төлөвлөгөө боловсруулах үүргийг шинээр зүйлчилсэн байна. Энэ нь Монгол Улсын хог хаягдлын менежментэд хөрөнгө татах таатай орчинг бий болгож болзошгүй юм.

Орон нутгийн хог хаягдлын менежментийг аймаг, сумдын захиргаа, Улаанбаатарын хотын хог хаягдлын менежментийг Нийслэл, дүүргийн захиргаа хариуцан хэрэгжүүлж байна. Аймгийн захиргаад нь өөрийн орон нутгийнхаа хог хаягдлын менежментийн хөтөлбөрийг хариуцах бөгөөд сумдынхаа үйл ажиллагаанд хяналт тавьж байх үүрэгтэй. Сум, дүүргийн Засаг дарга нар нь хог хаягдлын менежментийн үйлчилгээг шууд өөрсдийн хүчээр аль эсвэл хувийн компаниудтай гэрээ байгуулж гүйцэтгүүлэх бөгөөд олон нийтийн гудамж талбайн цэвэрлэгээ, хогийн сав түгээн байршуулах, хог хаягдлын менежментийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, иргэдийн санаачлагыг дэмжих зэрэг ажлыг зохион байгуулж байна. Хотын хог хаягдлын цуглуулалт дээшилж байгаа, хог хаягдлын хураамжийг цуглуулахад өөрчлөлт гарч байгаа зэрэг нь хог хаягдлын үйлчилгээнд анхаарал хандуулж, үйлчилгээний чанар сайжирч байгааг харуулж байна.

Цөмийн энергийн комисс нь улсын хэмжээнд цацраг идэвхит ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, судалгаа хөгжүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэгтэй. МХЕГ нь цацрагийн эх үүсвэрийг ашиглах лиценз олгож байна. Цацраг илэвхит эрдэсийг ашиглахтай холбоотой лицензийг Эрдэсийн нөөц, газрын тосны газар олгоно.

“МонАтом” ХХК нь 2009 онд төрийн өмчит компани хэлбэрээр үүсгэн байгуулагджээ. Компани нь уран болон бусад төрлийн цацраг идэвхит ашигт малтмалын хайгуул хийх, Монгол Улсын нутаг дэвсгэрт ураны тандан судалгааг стандартын өндөр түвшинд хийж, хайгуулын ажлыг гүйцэтгэж нөөцийг тогтоох, дангаар болон бусад талуудтай хамтран ураны хайгуул, олборлолт хийх, ураны тандан судалгаануудын мэдээллийн санг байгуулан ажиллуулж байна.

Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийн үндэсний холбоо нь 2005 онд хог хаягдлыг дахин боловсруулах бизнес эрхлэгчдийн ашиг сонирхлыг хамгаалах, хог хаягдлын менежментийг хөгжүүлэх болон хог хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжих зорилготой байгуулагджээ. Холбоо нь хог хаягдлыг ангилан ялгах, тээвэрлэх, дахин боловсруулах, экспортлох үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү холбоо нь хог хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагаа явуулдаг 8 компани, 100 гаруй аж ахуйн нэгж, 21 аймгийн 20000 орчим хоёрдогч түүхий эд цуглуулагчид, 5 аймаг дахь хог хаягдал цуглуулах цэгийг хамаарч байна.

#### Улс, аймаг, сумдын түвшин дэх хог хаягдлын менежментийн асуудлыг хариуцсан байгууллагуудын ажлын зохицуулалт

Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ) нь бусад салбарын яамдтайгаа хамтран тухайн салбарын онцлогт тохирсон хог хаягдлын менежментийн журам зохицуулалт, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж байна. Эрүүл мэндийн яам болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь салбартаа хог хаягдлын менежментийн стратеги, журам хэрэгжүүлэхдээ хамгийн сайн, тэргүүнд нь явж байна. Хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар БОАЖЯ нь нийслэл хотын захирагч, аймгуудын засаг дарга нартай хамтран ажиллаж байна. Хотын захирагч, аймгуудын засаг дарга нарын хамтын ажиллагаа тун сайн, байнга уулзалт хийж байгаа талаар БОАЖЯ мэдээлж байсан хэдий ч Улаанбаатар хотын захиргаа яамнаас илүү их дэмжлэг авахыг хүсч байгаагаа илэрхийлж байсан.



Хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах, гудамж талбайг цэвэрлэх, олон нийтийн газруудын цэвэрлэгээ зэрэг хатуу хог хаягдлын менежментийн үүргийн дийлэнхийг хотын захиргаа хүлээж байна. Аймгийн түвшинд аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын хэлтэс болон бусад байгууллагууд хог хаягдлын менежментийн үйл ажиллагаанд оролцож байна.

Улаанбаатар хотын захиргаа нь бодлого, төсөв санхүүжилтийг тодорхойлж хог хаягдлын менежментийн асуудлаарх хотын хэмжээний үйл ажиллагааг дүүргүүдийн хооронд зохицуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж байна. Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс (өмнө нь Хотын хог хаягдлын менежментийн хэлтэс гэсэн нэртэй байсан) нь хатуу хог хаягдлыг цуглуулах, устгах үйл ажиллагааг шууд удирдан явуулж байна. Энэ хэлтэс нь төрийн өмчит аж ахуйн нэгж болох Улаанбаатар хотын Тохижилт үйлчилгээний компани (ТҮК)-ийг гэрээлж хог хаягдлыг булж булшлах, нийтийн эзэмшил, суурьшлын бүсүүдийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг явуулж байна.

2007 он хүртэл Хотын хог хаягдлын менежментийн хэлтэс нь Улаанбаатар хотын хатуу хог хаягдлыг цуглуулах, устгах ажлыг шууд удирдаж байжээ. Хог хаягдлын менежментийн асуудалд хотын удирдлагын оролцоог аль олох багасгах, улмаар менежментийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор 2017 он хог хаягдлын менежментийн талаарх шинэ журмыг боловсруулж батлан нэвтрүүлсэн байна. Өнөөгийн институцийн тогтолцооны дагуу дүүрэг бүр нутаг дэвсгэрийнхээ айл өрх, аж ахуйн нэгж, олон нийтийн эзэмшлээс бусад байршлаас хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх асуудлыг хариуцаж байна. Дүүргүүдийн хог хаягдлын удирдлагын хэлтэс нь хогны хураамжийг (хотын зөвлөлийн шийдвэрийн дагуу) цуглуулах, гэрээгээр хог хаягдал цуглуулах үйлчилгээ үзүүлдэг хувийн аж ахуй болон тээврийн компаниас (Улаанбаатар ТҮК) үйлчилгээ авч гүйцэтгэлд нь хяналт тавих, гудамж талбайг цэвэрлэх үйлчилгээ үзүүлэх ажлыг тус тус хариуцаж байна.

*Зохицуулалт, эдийн засаг, санхүү, мэдээллийн арга хэмжээ*

#### Зөвшөөрөл

Хог хаягдлын үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг төвлөрсөн бусаар олгож байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгож байна. Хог хаягдлын цэгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг даргын түвшинд олгож байна. Мөн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх зөвшөөрлийг сум, дүүргээс өгч байна. Гэхдээ эдгээр зөвшөөрлийн талаарх нэгдсэн мэдээллийн сан байхгүй байна. Хог хаягдлын талаарх мэдээллийг Байгаль орчны мэдээллийн төв, Үндэсний статистикийн хорооны цахим хуудаснаас харах боломжгүй байна.

Засгийн газраас химийн бодисын зохицуулалттай хяналтыг бий болгох зорилгоор засгийн газрын агентлагуудын химийн бодис импортлох, экспортлох журмыг баталсан. 2007 оноос өмнө орон нутгийн захиргаад аюултай болон хортой химийн бодис болон бусад химийн бодисыг импортлох зөвшөөрлийг өгдөг байсан бөгөөд энэ нь химийн бодисыг хяналт, зохицуулалтгүй импортлох, заримдаа аюултай болон химийн хортой химийн бодисыг гаалиар энгийн нэрээр оруулж ирэх нөхцөлийг бүрдүүлж байжээ. Ийм учраас Монгол Улсын Засгийн газраас чанд зохицуулалт хийж журамласан байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь бүх төрлийн химийн бодисыг импортлох зөвшөөрлийг олгох болсон нь дээрх асуудлыг шийдвэрлэх боломж олгожээ. Тус яам нь 2016 онд 170 аж ахуйн нэгжид аюултай химийн бодис импортлох зөвшөөрлийг олгосон байна.

#### Татвар, хураамж

Хог хаягдлын хураамж болон сум/дүүрэг, аймгийн захиргаанаас олгодог татаас нь Монгол Улсад хог хаягдлын менежментийн үйлчилгээ үзүүлэх санхүүгийн эх үүсвэр болж байна.

Орон сууцны хорооллын айл өрх бүр сар бүр 2000 төгрөгийн хог хаягдлын хураамж төлж байна. Хураамжийг Орон сууц нийтийн аж ахуйг удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүд, аль эсвэл Сууц өмчлөгчдийн холбоод хурааж 6 хувийг нь үйлчилгээнийхээ зардалд суутган авч үлдэгдлийг сум, дүүргийн холбогдох дансанд шилжүүлж байна. Орон сууцны айл өрхүүдийн хог хаягдлын хураамжийн төлөлт 90 хувьтай байгаа бөгөөд 2014 онд энэ нь 2,2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Гэр хорооллын хог хаягдлын хураамжийг цахилгааны тоолуураар, тухайн өрх хэдэн ам бүлтэйг үл



хамааран тогтоож байна. 2011 оны 7-р сараас хойш нэг өрх 2700 төгрөгийн хог хаягдлын сарын хураамжийг эрчим хүч ашигласныхтайгаа хамт төлдөг бөгөөд улмаар цахилгаан түгээх компани нь үйлчилгээндээ 27 хувийг нь суутган авч үлдэгдлийг нь сум/дүүргийн холбогдох дансанд шилжүүлж байна. Гэр хороололд, 2011 оны 6-р сар хүртэлх хугацаанд хог хаягдлын хураамжийг хог хаягдлыг цуглуулдаг тээврийн хэрэгслийн жолооч нар цуглуулдаг байсан бөгөөд энэ үед хог хаягдлын хураамжийн төлөлт дөнгөж 30 орчим хувьтай байжээ. Хог хаягдлын хураамж цуглуулах тогтолцоог өөрчилснөөс хойш хураамжийн төлөлт 60 хувь хүртэл өссөн байна. 2010, 2011 онуудад жилд дунджаар 3 тэрбум төгрөгний хогны хураамжийг цуглуулсан бөгөөд энэ нь 2012 онд ч өссөн бөгөөд, улмаар 2014 он гэхэд 6 тэрбум төгрөгт хүртэл өсчээ.

Бизнес эрхлэгчдийн хувьд өөрийн үйл ажиллагаанаасаа үүсэх хатуу хог хаягдлаа зайлуулах асуудлаар өөрсдөө хог хаягдал цуглуулах компаниудтай шууд гэрээ байгуулж, үйлчилгээ авч байна. Хог хаягдлын хураамжийг аж ахуйн нэгжийн бүртгэлийн мэдээлэл дээр үндэслэн дүүргийн татварын алба авч байна. Хог хаягдлын хураамжийг аж ахуйн нэгж бүрийн бизнесийн төрөл, хэмжээ, бусад холцогдох үзүүлэлтүүдийг нь харгалзан тогтоож байна. 2013, 2014 оны орлого хураалтын дүн шинжилгээнээс харахад гэрээт үйлчилгээ авч байгаа аж ахуйн нэгжүүдийн бараг 90 хувь нь үйлчилгээнийхээ төлбөрийг төлсөн байгаа бөгөөд энэ нь нийт бизнес эрхлэгчдийн 60 хувийг бүрдүүлж байна. Аж ахуйн нэгжүүдээс хураасан хог хаягдлын үйлчилгээний хураамж 2014 онд 6 тэрбум төгрөг болжээ. 2011 оноос өмнө буюу хог хаягдлын хураамжийг цуглуулах тогтолцоонд өөрчлөлт оруулахаас өмнө энэхүү хог хаягдлын хураамж төлөлт дөнгөж 20 хувьтай байжээ.

Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн үйл ажиллагааны зардал нь 2014 онд 23 тэрбум болжээ. Энэ нь 8.6 тэрбум төгрөг байсан 2013 онтой харьцуулахад огцом өссөн байна. Энэхүү өсөлт нь хог хаягдлыг тээвэрлэх, нийтийн гудамж, талбайг цэвэрлэхэд зориулсан санхүүжилтийг нэмэгдүүлсэнтэй холбоотой. Эдгээр үйл ажиллагаа нь хог хаягдлыг тээвэрлэх үйлчилгээг сайжруулах, хууль бусаар хог хаяхаас сэргийлэх, Улаанбаатар хотын ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулахад чиглэгджээ.

Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэхэд зориулж өгдөг татаас нь Улаанбаатар хотын хог цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжүүдийн жилийн төсвийн 30 орчим хувийг бүрдүүлж байна. Татаасын хэмжээг тогтоохдоо цуглуулж тээвэрлэсэн хог хаягдлын хэмжээ, хогийн цэг хүртэлх зайг харгалзаж байна. Хог хаягдлын цэгүүдийн үйл ажиллагааг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байгаа бөгөөд хог хаягдлын цэгийг тохижуулах, хог хаягдлыг булж булшлах зардал гэх мэт хог хаягдлын урсгалаас олж болох төлбөр хураамжийн механизм одоогоор байхгүй байна. Хог хаягдлын цэгт олгож байгаа татаасын хэмжээг хүлээн авч байгаа нэг тонн хог хаягдал тутамд 2080 төгрөг байхаар тооцон олгож байгаа бөгөөд энэ нь 2006 оноос хойш өөрчлөгдөөгүй байна.

### **10.5 Олон улсын гэрээ хэлэлцээр, арга хэмжээнд оролцох оролцоо**

Монгол Улс нь Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн Конвенцийг 1996 онд соёрхон баталсан байна. Базелийн конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт жил бүр үндэсний хэрэгжилтийн тайлангаа гаргаж өгөх ёстой бөгөөд тус улс нь 2001, 2005, 2014, 2015, 2016 онд тайлангаа хүргүүлсэн бөгөөд тэдгээр нь зөвхөн хэсэгчилсэн мэдээллийг агуулсан байна.

Монгол Улс нь Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худаалахад хэрэглэх, урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын Конвенцийг 2001 онд соёрхон баталсан байна. Монгол Улс нь химийн хорт бодис, пестицид импортлох талаар 2010 онд Конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт 29 удаа хандан зөвшилцөж тус Конвенцийн заалтыг идэвхитэй хэрэгжүүлж байжээ. Гэсэн хэдий ч, Монгол Улс нь 2004-2016 оны хооронд хийсэн 18 удаагийн импортынхаа талаар Роттердамын Конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт мэдээлж зөвшилцөөгүй байна (Бүлэг 6).

Удаан задардаг органик бохирдуулагчийн (УЗОБ) тухай Стокгольмын конвенцийг Монгол Улс 2004 онд соёрхон баталсан. Үндэсний тайлангаа дөрвөн жил тутамд Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлэх журамтай. Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь Үндэснийхээ хоёр болон гуравдугаар тайланг Стокгольмын конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлсэн байна (Бүлэг 6). Үндэсний гуравдугаар илтгэлийг НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллагын тусламжтайгаар бэлтгэжээ.

Монгол Улс нь Мөнгөн усны тухай Минаматагийн Конвенцид 2015 онд нэгдэн оржээ. 2007 оноос

хойш Монгол Улсын Засгийн газар мөнгөн ус импортлох, ашиглахыг хуулиар хориглож, энэ хууль тогтоомжоо идэвхитэй хэрэгжүүлж байна (Бүлэг 6).

Монгол Улс нь Ашигласан түлшний болон Цацраг идэвхит хаягдлын менежментийн аюулгүй байдлын тухай Хамтарсан Конвенцид нэгдэн ороогүй байна.

## 10.6 Үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж

### *Үнэлгээ*

Хотоо цэвэрлэдэг байсан арга барил, хотын захад замбараагүй хогоо хаядаг байсан зуршлаа өөрчилж зохион байгуулалттай, төлөвлөгөөтэйгөөр хог хаягдлыг цуглуулдаг, тогтоосон цэгүүдэд буулгадаг болгох зэргээр Монгол Улсын хог хаягдлын менежмент өөрчлөгдөж байна. Хог хаягдлын менежментийн журам зохицуулалт дэгтэй болж, хууль эрх зүйн үндэс нь ч алхам алхмаар бэхжиж байна. Гэсэн хэдий ч хог хаягдлын талаарх үндэсний стратегийн зорилго, зорилтууд нь үндэсний түвшинд тодорхойлогдсон боловч хэрэгжилт нь аймаг сумын түвшинд хийгдэж байгаа нь тус стратегийн хэрэгжилтэд эрсдэл учруулж байна. Ингэснээр орон нутгийн хатуу хог хаягдлын менежмент сайжирч аймаг, сумдын удирдлагын ашиг сонирхолд нийцэж байгаа хэдий ч үйлдвэрлэлийн хог хаягдлын менежментэд ахиц гарахгүй байна.

### *Дүгнэлт, зөвлөмж*

#### Хог хаягдлын менежментийн байгууллагуудын чадавхи

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хог хаягдлын менежментийг удирдах өнөөгийн чадавхи хязгаарлагдмал байгаа бөгөөд хог хаягдлын менежментийг үндэсний хэмжээнд хангах боломж сул байна. Хог хаягдлын менежментийн тухай хуулийн заалтыг бүрэн хэрэгжүүлэх, бусад яамдын хог хаягдлын менежментийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг зохицуулах зорилгоор БОАЖЯ-ны бүтцэд Хог хаягдлын менежментийн газрыг оруулан байгуулах замаар үүргээ хэрэгжүүлж болох юм. Өөр нэг хувилбар бол яамны хог хаягдлын менежментийн мэргэжилтэнд техникийн туслалцаа үзүүлэх, яам, аймаг, сумдын удирдлага, үйлдвэр аж ахуйн газруудад мэргэжлийн мэдлэг түгээх, хог хаягдлын менежментэд олон улсын тусламж авах асуудлыг зохицуулах зэрэг үүрэг бүхий Хог хаягдлын менежментийн агентлагийг байгуулах явдал байж болно.

#### Зөвлөмж 10.1

*Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь хог хаягдлын менежментийг сайжруулах гол хөтөч, мэдлэг мэдээллийн төв болохуйц Хог хаягдлын менежментийн асуудал хариуцсан газар, аль эсвэл агентлаг байгуулж, хог хаягдлын менежментийн чадавхиа бэхжүүлэх хэрэгтэй.*

#### Стратегийн баримт бичиг

Сүүлийн арван жилд хог хаягдлын менежментийн тэргүүлэх чиглэл нь хотын хатуу хог хаягдлын менежмент болон эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах явдал байжээ. Нэн хэрэгцээ, шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулснаар энэхүү үр дүнд хүрсэн байна. Гэсэн хэдий ч үйлдвэрлэл, уул уурхай, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хог хаягдал, ялангуяа аюултай хог хаягдлын менежментийг өөрчлөн сайжруулахын тулд бусад яамдтай нягт хамтран ажиллах шаардлага байна. Хог хаягдлын талаарх салбарын стратеги, хог хаягдлын менежментийн салбарын төлөвлөгөө харахан үгүй байна.

#### Зөвлөмж 10.2:

*Засгийн газар нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохионо. Үүнд:*

- (a) *Бүх салбарын яамдууд хог хаягдлын менежментийн стратегиа боловсруулж хэрэгжүүлэх;*
- (b) *Хог хаягдлын менежментийн үндэсний шинэ стратегийг баталж, энэхүү стратегийг хэрэгжүүлэх санхүүжилтийн төлөвлөгөө боловсруулах,*
- (c) *Хотуудын эргэн тойронд том хэмжээний хог хаягдал дарах цэг байгуулах зэрэг хог хаягдлын зохистой бус системээс зайлхийхийн тулд Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хот суурингийн төвшинд хэрэгжүүлэх,.*

### Хог хаягдлын мэдээлэл

Хог хаягдлын талаарх болон хог хаягдлын менежменттэй холбоотой тоон мэдээлэл нь үр дүнтэй шийдвэр гаргахад ихээхэн чухал юм. Тус улс хэдийгээр хог хаягдлын талаарх мэдээллийг 10 гаруй жилийн турш цуглуулж байгаа ч чанар нь сайнгүй байна. Монгол Улс нь Европын Холбооноос баталсан Хог хаягдлын ангиллаас Аюултай хог хаягдлын жагсаалтыг гаргаж баталсан боловч мөрдөж хэвшээгүй байна. Бусад төрлийн хог хаягдлын менежменттэй холбоотой тоо баримт байгаа боловч үндэсний хэмжээнд нэгтгэгдээгүй (жишээ нь, уул уурхайн нөхөн сэргээлт хийсэн газар нутаг, уул уурхайн болон эрчим хүчний салбарын хаягдлын сан, гэх мэт) байна. Хог хаягдлын менежментийн талаарх тоо мэдээлэл дутагдалтай байгаа нь төсөл боловсруулах, олон нийтэд мэдээлэл түгээх боломжийг хязгаарлаж байна. Түүнчлэн хог хаягдлын салбарт бий болсон ололт амжилтыг ч мэдээлэх боломжгүй байна. Үүнээс гадна нийтэлж буй тоо мэдээллээ нягтлан хянаж шалгадаггүйгээс бодит нөхцөл байдлыг үнэн зөвөөр илэрхийлэхгүй байна. Үндэсний статистикийн хороотой нягт хамтран ажиллаж хог хаягдлын талаарх мэдээллийг жил бүрийн статистикийн эмхтгэлд оруулах ажил хязгаарлагдмал байна.

Хог хаягдал, химийн бодисын талаарх мэдээллийн чанар муу байгаагаас Монгол Улс нь хотын болон бусад төрлийн хог хаягдлын менежментийн асуудлаарх Тогтвортой хөгжлийн зорилтын Зорилго 11.6 (2030 он гэхэд хотуудын байгаль орчинд үзүүлэх нэг хүн тутмын сөрөг нөлөөллийг бууруулах, агаарын чанар, хотын болон бусад хог хаягдлын менежментэд онцгой анхаарал хандуулах) болон химийн бодис болон бусад бүх төрлийн хог хаягдлын байгаль орчинд ээлтэй менежментийн асуудлаарх Зорилго 12.4 (2020 он гэхэд олон улсын хэмжээнд тохиролцсоны дагуу хиймийн бодис болон хаягдлыг ашиглалтын бүх хугацаанд нь байгаль орчинд ээлтэй менежментээр хангах, тэдгээрийн хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор агаар, ус, хөрсөнд хаях явдлыг үлэмж багасгах)-ын хэрэгжилтийг тус тус үнэлэхэд бэрхшээл учруулж байна.

Хог хаягдлын менежментийн тухай 2017 оны хуулиар хог хаягдлын талаарх мэдээллийн санг байгуулан хэрэгжүүлэх, хог хаягдал үйлдвэрлэгчдэд чиглэсэн хог хаягдлаа тодорхойлж бүртгэх, хог хаягдал болон аюултай хог хаягдлын ангилал зэрэг асуудлаар сургалт явуулахыг журамлаж өгсөн байна.

#### Зөвлөмж 10.3:

*Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь Байгаль орчны мэдээллийн төв болон Үндэсний статистикийн хороогоор дамжуулан хог хаягдлын асуудлаар үндэсний мэдээллийн санг байгуулан хэрэгжүүлэх, тоон мэдээллийн үнэн зөвд хяналт тавих журмыг нэвтрүүлэх, хог хаягдлын менежментийн талаарх мэдээллийг жил бүрийн статистикийн эмтгэлд оруулж нийтлүүлж байх хэрэгтэй.*

### Цацраг идэвхт хог хаягдал

Цацраг идэвхит хаягдлын асуудал нь Монгол Улсын нэн тэргүүний анхаарах асуудал биш байгаа боловч цацраг идэвхит хог хаягдлын менежментийг найдвартай удирдан зохицуулах хууль эрх зүйн суурь үндэс, стратегийн баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөгөө байхгүй байна. Монгол Улс нь Ашигласан түлшний болон Цацраг идэвхит хаягдлын менежментийн аюулгүй байдлын тухай Хамтарсан Конвенцид нэгдэн ороогүй байгаа бөгөөд энэ конвенцуудаар цацраг идэвхит хог хаягдлын менежментийн аюулгүй байдлын талаар эрх зүйн үндсэн механизмыг тогтоож өгсөн байдаг. Энэхүү конвенцид нэгдэн орсноор Монгол Улс нь олон улсын хамтын ажиллагаанаас ашиг тус хүртэх, улмаар цацраг идэвхит хог хаягдлын менежментийг олон улсын жишигт хүргэх боломжтой болно.

#### Зөвлөмж 10.4:

*Цөмийн энергийн комисс нь БОАЖЯ-тай хамтран дараах асуудалд анхаарал хандуулбал зохино:*

- (a) *Ашигласан түлшний болон Цацраг идэвхит хаягдлын менежментийн аюулгүй байдлын тухай Хамтарсан Конвенцид нэгдэн орох асуудлыг авч үзэх;*
- (b) *Цацраг идэвхит хаягдлын менежментийн талаарх тусгайлсан стратеги, төлөвлөгөө, хууль тогтоомжийг боловсруулах.*

### Хог хаягдлын дахин боловсруулалт

Хотын хог хаягдлаас дахин боловсруулах хог хаягдлыг ангилан ялгах үйл ажиллагааг хог хаягдлыг худалдан авах цэгээр дамжуулан сайн зохион байгуулж байна. Гэхдээ Монгол Улсын хог хаягдал дахин боловсруулах чадавхи боломж дутмагаас дийлэнх нь экспортод гарч байна. Энэхүү нөхцөл байдал

нь хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийн үндэсний холбооноос төлөвлөж буй ЕсоПаркийг хөгжүүлснээр өөрчлөгдөх боломжтой. Хог хаягдлыг дахин боловсруулах үндэснийхээ хүчин чадлыг нэмэгдүүлэх нь хог хаягдлыг багасгах, ногоон ажлын байр бий болгох, байгалийн нөөцийг тогтвортой ашиглахад эерэг нөлөө үзүүлнэ.

Зөвлөмж 10.5:

*Монгол Улсын Засгийн газар нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Сангийн ямаараа дамжуулан нь ЭкоПаркийг орчин үеийн хог хаягдлын менежментийн төв болгон хөгжүүлэхийг дэмжих нь зүйтэй.*





## Бүлэг 11

# БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ, ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР

### 11.1 Биологийн төрөл зүйл, экосистемийн өнөөгийн нөхцөл байдал, чиг хандлага

Монгол орны газрын гадаргын төрх байдал болон байгаль орчны онгон дагшин байдлыг хадгалан үлдэхэд түүний өргөн газар уудам нутаг (1,564,116 км<sup>2</sup>), хөдөө нутагт хүн ам сийрэг суурьшсан байдал (1 км<sup>2</sup>-д ойролцоогоор 0.6 хүн), байгаль орчинд нөлөө багатай газар ашиглалтын хэлбэр нь тааламжтай нөхцөл бүрдүүлж иржээ. Мөн байгалийн экосистемд үзүүлэх хүний нөлөөг хязгаарлах өөр хүчин зүйлс нь томоохон хот суурин, үйлдвэрлэлийн бүс, гол замын сүлжээнээс алс оршдог нь нөлөөлж байна. Зам, дэд бүтцийн сүлжээ, хот, тосгон суурин газрын эзлэх талбай нь 2015 оны байдлаар улсын нийт нутаг дэвсгэрийн зөвхөн 0.8 хувийг эзэлж байна (Зураг 12.1).

#### *Биологийн төрөл зүйлийн олон янз байдал*

Монгол улсад 2017 оны байдлаар, ургамлын аймагт 108 овог, 680 төрлийн гуурст ургамлын 3,160 зүйл, дэд зүйл, тэдгээрийн дотор 120 унаган (эндемик), 4,900 завсрын унаган (суб-эндемик) төрөл зүйлс багтаж байна. Цаашлаад хөвдийн 580 зүйл, хаг ургамлын 1,033 зүйл, замгийн 2,003 зүйл ба дэд зүйлүүд, мөөгийн 574 зүйл байна. Монгол орны ой 140 зүйлийн мод, сөөг агуулж, ой бүрдүүлэгч гол зүйлүүд нь Монголын зонхилох модны төрөл болох шинэс (*Larix sibirica*), нарс (*Pinus silvestris*), хуш, гацуур, жодоо, хус, улиас, улиангар, арчил, бургас байна. Монгол орны амьтны аймаг хөхтөн амьтны 138 зүйл, загасны 75 зүйл, хэвлээр явагчдын 21 зүйл, хоёр нутагтны 6 зүйл, шувууны 500 зүйл, шавжны 13,000 гаруй зүйл, нялцгай биетний 30 зүйл байдаг байна.

#### *Ховордсон төрөл зүйлс*

Байгаль Хамгаалах Олон Улсын Холбооны Ховордсон төрөл зүйлийн улаан жагсаалтаар (2017-1) Монгол орноос зөвхөн нэг зүйл ургамалыг дэлхийн хэмжээнд Ховордож болзошгүй (ХБо), есөн зүйлийг Мэдээлэл дутмаг (МД), 187 зүйлийг Анхааралд орохооргүй (АО) гэж тодорхойлсон байна. Монгол орны амьтны аймгийн 41 зүйлийг (11 зүйлийн хөхтөн, 25 зүйлийн шувуу, 2 зүйлийн загас, 3 зүйлийн сээр нуруугүй амьтан) дэлхийн хэмжээнд ховордсон, 4 зүйлийг Устаж байгаа (УБ), 12 зүйлийг Устаж болзошгүй (УБо), 25 зүйлийг Эмзэг (ЭМ) гэж үзжээ. Түүнчлэн амьтны аймгийн 28 зүйлийг ХБо, 8 зүйлийг МД, 509 зүйлийг АО гэж тодорхойлсон байна.

Монгол Улс 2006-2011 онд амьтан ургамлын улаан номынхоо гурав дахь хэвлэлийг боловсруулж, анх удаагаа Байгаль хамгаалах олон улсын холбооны (IUCN) шалгууруудыг бүсийн хэмжээнд хэрэглэсэн байна. Үнэлгээнд хамрагдсан 148 гуурст ургамлын зүйлийн 110 нь (74 гаруй хувь нь) 2011 онд бүсийн хэмжээнд ховордсон зүйл гэж тодорхойлогдсон, үүнээс 16 зүйлийг УБ, 39 зүйлийг УБо, 55 зүйлийг Э гэсэн ангилалд хамруулжээ. Загасны 48 зүйлийн (унаган 64 зүйлээс) хамгааллын төлөв байдлыг үнэлж, загасны 11 зүйлийг 2006 онд Монгол оронд ховордсон гэж үзсэний дотор нэг зүйл болох шивир хилэмийг (*Acipenser baerii*) УБ, Говийн эрээлж (*Barbatula dgebuadzei*), Зүүнгарын мөрөг (*Leuciscus dzungaricus*), цагаан загас (*Coregonus pidschian*), Хар мөрний хадран (*Thymallus grubei*), Хөвсгөлийн хадран (*Thymallus nigrescens*), тул (*Hucho taimen*) зэрэг зургаан зүйлийг УБо, түүнчлэн 4 зүйлийг ЭМ гэж ангилжээ. Үнэлгээнд хамрагдсан унаган 24 зүйлийн хэвлээр явагч, хоёр нутагтнаас 2 зүйлийн хэвлээр явагч: Говийн нүцгэн бах хонин гүрвэл (*Cyrtopodion elongatum*) ба загалмайт могой (*Vipera ursini*), 4 зүйлийн хоёр нутагтан: хятад хүрэн мэлхий (*Rana chensinensis*), япон ойн мэлхий (*Hyla japonica*), шивирийн гүлмэр (*Salamandrella keyserlingii*), Певцовын бах (*Bufo pewzowi*) зэргийг 2006 онд бүс нутагт ховордсон гэж үзэн ЭМ ангилалд хамааруулсан байна. Мөн хэвлээр явагчдын таван зүйлийг ХБо, нэг зүйлийг МД, 12 зүйлийг УО гэж ангилжээ.

Шувуудын 476 зүйлд 2011 онд үнэлгээ хийснээс 20 зүйлийг бүсийн хэмжээнд ховордсон гэж үзсэн. Хоёр зүйлийг: Далматын хотон (*Pelecanus crispus*) ба шивирийн тогорууг (*Grus leucogeranus*) УБ

ангилалд, Цагаан толгой ямаан сүүлт (*Oxyura leucocephala*), үлдэг цахлай (*Larus relictus*), бор бүргэд (*Aquila clanga*), усны нөмрөг бүргэд (*Haliaeetus leucoryphus*), могойч загалай (*Circaetus gallicus*), хурагч бор (*Paradoxornis heudei*) зэрэг зургаан зүйлийг УБо гэсэн ангилалд хамруулжээ. Шувууны 12 зүйлийг ЭМ гэж ангилсан, тэдгээр нь: одой галуу (*Anser erythropus*), Байгалын нугас (*Anas Formosa*), ундар шумбуур (*Aythya nyroca*), ёл (*Gypaetus barbatus*), дорнын хан бүргэд (*Aquila heliaca*), идлэг шонхор (*Falco cherrug*), цэн тогоруу (*Grus vipio*), юүдэнт тогоруу (*Grus monacha*), Азийн цууцил (*Limnodromus semipalmatus*), тоодог (*Otis tarda*), жороо тоодог (*Chlamydotis undulate*), монгол хуланжороо (*Podoces hendersoni*) байна. Түүнчлэн шувууны 16 зүйлийг ХБо гэж үзжээ. Монгол орны нийт шувуудын 90 хувийг УО гэж ангилалд орж байна.

Унаган 128 зүйлийн амьтнаас 21 зүйл (16.4 хувь), тэдгээрийн дотор унаган туурайт амьтдын зүйлийн 79 хувь, махчин амьтдын зүйлийн 12 хувь, мэрэгч амьтдын зүйлийн 12 хувийг 2006 оны мэдээгээр Монгол оронд ховордсон гэж үзсэн байна. Эдгээрт бүсийн хэмжээнд УБ гэж ангилагдсан хөхтөн амьтны 3 зүйл: мазаалай (*Ursus arctos gobiensis*), тахь (*Equus ferus przewalskii*), халиун буга (*Cervus elaphus*) багтсан байна. Бусад 14 зүйлийг УБо гэж ангилсан бол үүнд: ирвэс (*Uncia uncia*), хулан (*Equus hemionus*), хавтгай (*Camelus bactrianus ferus*), аргаль (*Ovis ammon*), цагаан зээр (*Procapra gutturosa*), бөхөн (*Saiga tatarica mongolica*), хүдэр (*Moschus moschiferus*), хандгай (*Alces alces*), халиу (*Castor fiber*), тарвага (*Marmota sibirica*), Алаг шарын жирх (*Spermophilus alashanicus*), бага алаг даага (*Allactaga elater*), алаг даага (*Stylodipus sungorus*), сухайн харх (*Meriones tamariscinus*) орж байна. Мөн хар сүүлт (*Gazella subgutturosa*), цаа буга (*Rangifer tarandus*), соотон алагдай (*Euchoreutes naso*), булга (*Martes zibellina*) гэсэн 4 зүйлийг ЭМ гэж ангилж, саарал чоно (*Canis lupus*), шилүүс (*Lynx lynx*), янгир ямаа (*Capra sibirica*), зэрлэг гахай (*Sus scrofa*) гэсэн найман зүйлийг ХБо гэж үзжээ. Зөвхөн цөөвөр чоно (*Cuon alpinus*) л Бүс нутгийн хувьд устсан (УС) байна. Хөхтөн амьтны бүх зүйлийн 37 хувь (ихэвчлэн жижиг амьтад) МД ангилалд орж байгаа тул эрчимтэй судалгаа хийх, хамгааллын үнэн төлөв байдлыг нь тогтоох шаардлагатай байна.

#### *Байгалийн ховордсон болон түгээмэл амьтдын тоо толгойн өөрчлөлт*

Баян бүрдийн экосистемд амин чухал бургас, бутны зарим зүйл 2006 - 2010 оны хооронд бүсийн хэмжээнд устаж, зарим ургамлын зүйл амьдрах орчин нь алдагдсаны уршгаар тархалтын талбай нь багассан байна.

21-р зууны эхэн үеэс олон загас, хоёр нутагтны тархалтын хүрээ хумигджээ. Мөлхөгчдийн тухайд тоо толгойн бууралтын талаар мэдээ баримт байхгүй байна.

Шувуудын зүйлүүдийн популяцийн 2000-2010 оны чиг хандлагын хамгийн сүүлийн үеийн үнэлгээ Шувуудын амьдрал олон улсын ТББ-ын байгууллагын технологиор 2011 онд хийгдэж, шувууны 476 зүйл буюу 64.9 хувийн нь популяц тогтвортой, 4 хувьд нь популяц бууралттай, зүйлүүдийн ердөө л 0.1 хувьд өсөлт ажиглагдсан бөгөөд шувуудын зүйлүүдийн 31 хувьд нь өөрчлөлтийн чиг хандлага тодорхойгүй байна гэж үзжээ.

Бүсийн хэмжээнд УБ гэж ангилсан хөхтөний гурван зүйлийн популяцийн чиг хандлага өөр өөр байна: мазаалайн популяц нэн хязгаарлагдмал боловч тогтвортой (1980 онд 20-25 мазаалай, 2010 онд 22-31, 2014 онд 28, 2016 онд 30 толгой болсон), амжилттай дахин нутагшуулсан тахийн популяц 2014 онд 387 хүрсэн ба аажмаар нэмэгдэж байна гэж үздэг. Халиун бугын популяц сүүлийн гучин жилд ихээхэн хэлбэлзэлтэй: 1986 онд 130,000 байснаа 1990-ээд оны эхээр 200,000 хүрсэн боловч дараа нь хурдтай буурч (гол нь хулгайн ан) 2004 он гэхэд 8,000-10,000 болсон ч 2010 оны үндэсний тооллогоор 16,800 хүрсэн байна.

#### Монголд ховордсон гэж 2006 онд ангилагдсан хөхтөний зүйлүүд

Хавтгайн (дэлхий нийтийн төлөв байдал нь УБ) популяц нь 1985 онд 650 байснаа 2004 онд 350 болж буурчээ (хоёрхон жилийн дотор 46 хувь буурсан). Жил бүр 25 - 30 хавтгайг хууль бусаар агнадаг гэсэн тооцоо байгаа бөгөөд энэ байдлаараа үргэлжилбэл байгаа багахан популяц нь улмаар ховордож, мөхөх аюулд хүрч болзошгүй байна.

Бөхөнгийн популяц (дэлхий нийтийн төлөв байдал нь УБ) цаг агаарын таатай нөхцөл, хамгаалах арга хэмжээний үр дүнд эхэндээ нэмэгдэж, 1978 онд 300 тоо толгойтой байснаа 1993 онд 1,400, 1998 онд 3,000, 2000 онд 5,200-5,300 хүрсэн байна. Харин 2000-2002 онд зуд ойр ойрхон болсоноос популяц нь 80 гаруй хувиар цөөрч 2002 онд 1,020 болж, цаашид хулгайн ангийн улмаас 2004 онд 750 болжээ.

Дараа нь дахин сэргэж, 2008 онд 3,200, 2010 онд 8,000 хүрчээ. Гэвч 2016 оны төгсгөлөөр малаас халдварласан хонины цэцэг өвчинөөр бөхөн өвчилж, тоо толгой нь бараг 50 хувиар буурч бараг гамшгийн хэмжээнд хүрч 2,000-3,000 болтлоо цөөрсөн тул эдүгээ бүсийн хэмжээнд УБ төлөв байдалд шилжих үндэслэлтэй болоод байна. Гэхдээ одоогийн 2017 оны бөхөнгийн популяцийн тоо толгойн мэдээ хараахан мэдэгдэхгүй байна.

Ирвэсийн (дэлхий нийтийн төлөв байдал нь УБо) популяцийн тооцоо 1990 онд 1,000, 2000 онд 500-1,000, 2009 онд 809 болжээ.

Хүдрийн (дэлхий нийтийн төлөв байдал нь ЭМ) популяц үргэлжлэн цөөрч, 1970 онд 60,000-80,000 байсан бол 1986 онд 44,000 болж, 2010 онд ердөө 7,400 болтол буурснаар сүүлийн 30 жилд 83 хувиар цөөрөөд байгаа ажээ.

Монгол дахь хулангийн популяц нь (дэлхий нийтийн төлөв байдал нь ХБо) дэлхий даяар үлдсэн хулангийн популяцуудаас хамгийн том популяц бөгөөд тоо толгой 1990-ээд оны дундуур 39,500-42,500 байсан бол 2002 онд 17,172, 2009 онд 14,051 болон буурчээ.

Аргалийн (дэлхий нийтийн төлөв байдал нь ХБо) популяц 1985 онд 60,000 толгой байсан бол 2001 он гэхэд 13,000-15,000 орчим болж, хорин жилд 75 хувиар буурсан байна. Улсын хэмжээний Байгаль орчны төлөв байдлын албан ёсны тайлан илтгэлд аргалийн популяц 2002 онд ердөө 3,059 байсан бол 2009 онд ойролцоогоор 18,140 болсон байна. Амьжиргааны зорилгоор аргаль агнахыг 1953 оноос хориглосон хэдий ч гадаадын жуулчдад аргаль агнах зөвшөөрөл олгосоор байгаагийн зэрэгцээ хулгайн ан нь аргалийн тоо хорогдох ноцтой хүчин зүйл болсон хэвээр байна.

Цагаан зээрийн популяцийн (дэлхий нийтийн төлөв байдал нь УО) тоо толгой жилээс жилд 400,000 - 2,700,000-ын хооронд хэлбэлзэж ирсэн бөгөөд ингэж тоо толгой хэлбэлзэх нь хахир өвөл, нэн халдвартай малын шүлхий өвчний байнгын дэгдэлтээс (жишээ нь 2005, 2010 онд) шалтгаалж байна. Одоогоор цагаан зээрийн тоо толгой нэг сая орчим байна.

Хандгайн популяцийн (дэлхий нийтийн төлөв байдал нь УО) тоо толгой 2002 онд 40,000 байсан нь 2008-2010 онд 7,800 болтол буюу 80 хувиар буурсан байна.

Монголд хар сүүлтийн дэлхийн хамгийн том популяц байдаг (дэлхий нийтийн төлөв байдал нь ЭМ), тоо толгой 1990-ээд оны үед 60,000 байсан ба 2009 он гэхэд 11,978 болж бууран, цаашид ч хулгайн ангийн нөлөөгөөр буурсаар байна.

#### *Харь инвазив зүйл*

Өнөөгийн төсвийн хомсдлын улмаас одоогоор харь инвазив зүйлийн судалгаа хийгдээгүйгээс ямар ч мэдээлэл байхгүй байна. Зарим нутагт америк булга (*Neovison vison*) болон шувуудын зарим зүйлд аюул учруулж байж болзошгүй, мөн Говийн бүсэд моджуулах, уул уурхайн нөхөн сэргээлтийн зорилгоор унаган бус инвазив ургамлын зүйлүүдийг (жишээ нь зарим мод, загийн зүйлүүд) Хятадаас импортолж байна.

#### *Ургамалжилтын бүс, бүслүүр*

Ургамалжилтын зургаан үндсэн бүс, бүслүүрийг ялган тогтоожээ. Үүнд: өндөр уулын ургамалжилтын бүс (нийт нутгийн 3.6 хувь), уулын тайгын бүс (4.5 хувь), уулын ойт хээрийн бүс (15.2 хувь), хээрийн бүс (34.2 хувь), хагас цөлийн бүс (23.4 хувь), цөлийн бүс (19.1 хувь) орно.

Монгол орны нутаг дэвсгэрийг физик газар зүй, хөрс, уур амьсгалын үндсэн дээр ургамалжилтын 16 бүсэд хувааж байна. Хангайн нурууны ойт хээр, Монгол Алтайн нурууны хээр, Хэнтийн нурууны тайга, Дагуурын уулсын ойт хээрийн ургамал бүрхэвчийн бүрэлдэхүүн бусад бүсийг бодоход ургамлын зүйлүүдээр харьцангуй баян юм. (Хүснэгт 11.1). Сэрүүн бүсийн ой, цөл, тагийн нутагт ургамалжилтад онцлог орчин нөхцөлтэй боловч зүйлүүдийн олон янз байдлын хувьд төдийлөн баялаг бус атлаа нэн ховор унаган зүйлүүдийг агуулж байгаа ч тухайн орчин нөхцлийг хадгалан эс хамгаалбаас мөхөж мэдэх юм.

### Хүснэгт 11.1: Ургамалжилтын бүсүүд дэх ургамлын аймгийн биологийн олон янз байдал

Ургамлын бүс нутаг	Эзлэх хувь	Ургамлын зүйлийн тоо
Хөвсгөлийн улсын тайга	4.96	885
Хэнтийн уулсын тайга	3.05	977
Хангайн уулсын ойт хээр	17.59	1,214
Дагуурын уулсын ойт хээр	6.60	946
Ховдын уулсын тал хээр	1.98	657
Монгол Алтайн уулсын тал хээр	7.02	1,020
Хангайн уулсын тал хээр	0.87	465
Дундад халхын тал хээр	11.54	509
Дорнод Монголын тал хээр	3.94	539
Их нууруудын хотгорын цөлийн хээр	6.11	666
Нууруудын хөндийн цөлийн хээр	3.18	346
Говь-алтайн уулсын цөлийн хээр	5.02	710
Өмнөд говийн цөлийн хээр	9.35	327
Алашаагийн говь	6.43	183
Адтай дамнасан говь	5.92	326
Зүүн гарын говь	1.62	483

Эх сурвалж: Биологийн олон янз байдлын тухай конвенцийн хэрэгжилтийн Үндэсний 4 дэх илтгэл, 2009.

#### Экосистем болон эко-бүсүүд

Монгол орон харьцангуй бохирдоогүй байгаль орчин бүхий газар нутагтай, тухайлбал тагийн бүс нь өрнөд хийгээд төв Монголын уулархаг нутагт оршиж, мөн өргөн уудам шилмүүст ой, тал хээр, говь, цөлийн орчин, цэнгэг ба давст ус бүхий нутгуудтай. Эдгээр орчин нутаг дэлхий даяар чухал ач холбогдолтой биологийн олон зүйлийн амьдрах орчин болдог агаад тэдгээрийн зарим нь бусад улс оронд бөөнөөрөө устаж, ховордож байна. Жишээлбэл Дагуурын тал хээр дэлхийн хамгийн бага хөндөгдсөн экосистем бөгөөд хээрийн бэлчээрээс хамааралтай том туурайтан амьтан, шувуудын популяцийг оршоодог агаад тэдгээр зүйлийн зарим нь дэлхийн бусад нутагт нэгэнт мөхөөд байгаа ажээ.

Монгол орны газрын болон усны биомд нийт 19 экосистемийг (15 матриц, 4 нөхөөс экосистем) ялгаж болно: өндөр уулын биомд хээрийн экосистемийн 4 хэлбэр (тагийн тундра, тагийн нуга, өндөр уулын хээр, тагийн хормойн ой), ойн биом 2 экосистем (сэрүүн бүсийн шилмүүст ой, сэрүүн бүсийн ойн өвөр хормойн холимог ой, хээрийн экосистемийн 4 хэлбэр (нугын хээр, хурайвтар хээр, хуурай хээр, цөлөрхөг хээр), цөлийн экосистемийн 3 хэлбэр (хагас цөл, жинхэнэ цөл, хэт хуурай цөл), усны хоёр экосистем (нуур, гол ба голын сав хөндий), 4 жижиг боловч олон хэсэг талбайг хамарсан алаг цоог экосистем (ширгэдэг голууд, хаалттай хонхор, хужирт эргүүд, элсэн манхан, мөнх цас мөсөн гол). Хүний үйл ажиллагаагаар бүтсэн хорь дахь экосистем нь үйлдвэржсэн хийгээд хотожсон бүсүүд, тариалан бүхий газар болно. Хээрийн 4 экосистем нь Монгол орны ландшафтад зонхилдог, өргөн тархсан, үндсэн экосистемүүд юм. Экосистемийн төрөл хэлбэр тус бүр нь улс орны 10 гаруй хувийг эзэлдэг ба дөрвүүлээ хамтдаа Монгол орны нийт нутгийн тэн хагасыг эзэлж байна.

Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (WWF) 2010 онд биологийн олон янз байдлын хамгаалалтад дутагдаж байгаа асуудлын иж бүрэн дүн шинжилгээ, үнэлгээ хийхдээ үндэсний байгаль хамгаалал, бүсийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөг сайтар тусгах үүднээс өргөн хүрээтэй эко-бүс нутгийн аргачлалыг хэрэглэсэн (Хавсралт IV, Газрын зураг 3) байна. Монгол дахь Дэлхийн Байгаль Хамгаалах Сангийн салбар ургамалжилтын 16 жижиг бүсийг 4 том эко-бүс нутагт нэгтгэн авч үзсэн, үүнд: Алтай-Соён (Монгол орны 23.1 хувь), Хангай (16.4%), Дагуурын тал хээр (28.2%), Төв Азийн Говь (32.3%), эдгээрийн тус бүр нь Дэлхийн Байгаль Хамгаалах Сангийн тодорхойлсон жижиг эко-бүс нутгуудыг багтааж байна.

Алтай-Соёны эко бүс нутаг нь зургаан жижиг эко-бүс нутгаас бүрдэнэ: Алтайн уулын ой, ойт хээр, Алтайн тагийн нуга, тундра, Их Нууруудын Хотгорын цөлөрхөг хээр, Соёны тагийн нуга, тундра, Соёны уулын шилмүүст ой, Соёны уул хоорондын хээр – эдгээр нь нийлээд Монгол орны байгалийн 19 экосистемийн 17-г агуулж байна. Энэхүү эко-бүс нутаг биологийн олон янз байдал баялаг, шинэс,



нарсан ойн зурвас нь хөндөгдөөгүй онгон дагшин гэж үздэг. Энэ бүс нутагт хүдэр, янгир, аргаль, ирвэс, хар сүүлт, хотон, Монгол бөхөн гэхчилэн чухал ач холбогдолтой ховор зүйлүүд амьдардаг. Энэхүү экосистемийн 14 хувь нь 2010 он гэхэд улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээнд багтсан боловч хэсэг бусгаар орсон байна.

Хангайн эко-бүс нутаг улс орны төв хэсэгт оршдог ба гурван жижиг эко-бүс нутгийг багтааж байна, үүнд: Хангайн нуруун дахь хоёр (Хангайн нурууны тагийн нуга, Хангайн шилмүүст ой), Орхон-Сэлэнгийн сав дахь ойт хээр. Энэхүү эко-бүс нутаг биологийн төрөл зүйлээр баялаг бөгөөд Монголын 15 матриц эко-системийг багтаадаг. Шилмүүст ой нь голчлон нарс байх ба Хангайн нурууны араар ургадаг, харин өвөрт нь хээрийн ургамалтай. Энэхүү экосистемийн 7.9 хувь нь 2010 он гэхэд улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээнд орсон байна.

Дагуурын хээр талын эко-бүс нутаг Монгол орны дорнод хэсэгт нийт нутаг дэвсгэрийн 28.2 хувийг эзлэн үргэлжилж, гурван жижиг эко-бүс нутгаас бүрдэнэ, үүнд: Дорнод Байгалийн шилмүүст ой, Дагуурын ойт хээр, Монгол-Манжуурын хээр нутаг – эдгээр нь хамтдаа Монголд тодорхойлсон бүх экосистемийг агуулдаг. Тус бүс нутгийн нилээд хэсэг нь тэгш тал, эсвэл дов толгод бүхий ландшафттай, зөвхөн умард хэсгээрээ уултай. Нам газрын нуур, намаг нь шувууны олон зүйл, тэдгээрийн дотор тогорууны зургаан зүйлийн (тухайлбал цэн тогоруу) амьдрах орчин болж өгөх ба өргөн уудам тал нутгийн зонхилох зүйл нь тоодог, цагаан зээр, тарвага байна. Дагуурын эко-бүс нутгийн 9.6 хувь нь 2010 онд тусгай хамгаалалттай газрын сүлжээнд хамрагдсан.

Төв Азийн Говийн эко-бүс нутаг Монгол орны өмнөд хэсэгт орших ба дөрвөн жижиг эко-бүс нутгаас бүрддэг байна, үүнд: Алаг Шарын тэгш өндөрлөгийн хагас цөл, Дорнод Говийн цөлөрхөг хээр, Говийн нуурын хөндийн цөлөрхөг хээр, Зүүнгарын савын хагас цөл багтана. Энэ бүс нутагт бүхэлд нь цөлийн экосистемийн төрөл хэлбэрүүд давамгайлна. Ургамалжилт нь хээрийн ургамлын зүйлүүд, нам өвс, ганд тэсвэртэй сөөг, өргөгдсөн нам газар, баян бүрд, голын дагуу ургах загийн ой, ургамлын олон унаган зүйл, нэн ховордсон олон зүйлээс бүрдэнэ. Амьтны аймаг нь мазаалай, хулан, хавтгай, хар сүүлт, цагаан зээр, түүнчлэн Төв Азийн унаган мөлхөгчдийн зүйл болох хавтгай сүүлт хонин гүрвэл (*Teratoscincus przewalskii*), говийн нүцгэн хуруут хонин гүрвэл (*Cyrtopodion elongatus*), тэмээн сүүл могой (*Eryx tataricus*) зэргийг агуулдаг. Энэхүү эко-бүс нутгийн умард хэсгийн уулс ирвэс, аргаль, янгирын нутаг болдог. Энэ эко-бүс нутаг улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээнд хамрагдсан хувь өндөртэй (2010 оны байдлаар 21.4 хувь), үүнд нь хангалттай хэмжээ бүхий сайтар боловсруулах дархан цаазтай газрууд багтсан бөгөөд хамгааллын хамгийн өндөр стандарт, горим сахигддаг байна.

#### Эко-бүс нутгуудад тулгарч буй гол эрсдлүүд

Алтай-Соёны эко-бүс нутагт тулгардаг гол эрсдлүүд нь бэлчээр талхлагдал, биологийн нөөцийн хэт ашиглалт (мод бэлтгэл, ан) юм. Хангайн эко-бүс нутаг Монгол Улсын бусад бүсийг бодвол илүү нягт хүн ам суурьшсан байдаг. Сүүлийн 20-30 жилд хөдөөгийн олон иргэд хөдөө аж ахуйн давуу боломж, хотжилт, дэд бүтцийг даган энд суурьшсанаас бэлчээрийн даац хэтрэх, ойн түймэр, хууль бус мод бэлтгэл, гар бичил уурхай зэрэг хүчин зүйлс биологийн олон янз байдалд дарамт учруулах болсон байна. Дагуурын тал хээрийн эко-бүс нутаг, түүний биологийн олон янз байдалд тохиолдох гол эрсдэл нь уур амьсгалын өөрчлөлт, бэлчээр талхлагдал, ялангуяа ямааны тоо толгой хэт өссөний улмаас бэлчээрийн доройтол, хэтийдсэн ан гөрөө, загасчлал, уул уурхай, газрын тос олборлолт, тэдгээртэй холбогдсон дэд бүтцийн хөгжил юм.

Төв Азийн Говийн эко-бүс нутгийн хувьд гол аюул эрсдэл нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр улам хомсдож буй усны нөөц, гэтэл усны үүсвэрүүд нь нутгийн хийгээд нүүдлийн амьтад онд ороход амин чухал үүрэгтэй бөгөөд хүн ам, баян бүрд дэх малын хэт төвлөрлийн улмаас усны төлөө өрсөлдөөн тэмцэлд хүрч болзошгүй юм. Түүнчлэн бэлчээрийн даац хэтрэх, ямааны тоо толгой нэмэгдсэний уршгаар цөлжих, механикжсан тээврийн хэрэгслийн хяналтгүй хэрэглээ гэх зэрэг аюул эрсдэл нь амьтдын амьдрах орчныг доройтуулах төдийгүй дэд бүтцийн эрэлтийг нэмэгдүүлж, амьтдын амьдрах нутаг хуваагдах, популяцууд тусгаарлагдах байдалд хүргэнэ.

#### Үнэлгээ

Монгол орны хүн ам сийрэг тархсан өргөн уудам уул, хээр, говь нутаг нь дэлхий даяар чухал ач холбогдолтой зэрлэг амьтдын амьдрах орчин, хөхтөн амьтдын (ялангуяа туурайтны зүйлүүд) популяцуудыг одоо ч агуулж байдаг атал сүүлийн гучин жилд хөхтөний гол зүйлүүд эрс цөөрчээ.



Ингэснээр дэлхийн даяар мөхөх аюул нүүрлэсэн хөхтөний зүйлүүд болох бөхөн, тарвага, түүнчлэн дэлхий нийтийн төлөв байдал нь хамгаалан үлдэх боломжтой гэж байсан боловч ховордсон халиун буга, аргаль хонь зэрэг зүйлүүдийн популяцид нэн сөрөг нөлөөлж байна. Монгол орны дөрвөн эко-бүс нутаг тус бүрийн байгалийн бараг бүх экосистемийн бүрэн бүтэн байдал эдүгээ аюулд өртөж байгаа нь байгалийн хүчин зүйл (уур амьсгалын өөрчлөлт гэх мэт), мөн хүний нөлөөтэй дарамт, тухайлбал бэлчээрийн даац хэтрэх, биологийн нөөцийг хэт ашиглах, уул уурхайн үйл ажиллагаа өргөжих, түүнийг дагасан дэд бүтцийн хөгжил зэргээс улбаалж байна.

## 11.2 Биологийн олон янз байдлын хяналт мониторингийн сүлжээ, саад бэрхшээлтэй асуудлууд

Байгаль орчны хяналтын тогтолцоо аль 1977 онд байгуулагдсан боловч биологийн олон янз байдал, байгаль хамгаалал, зэрлэг амьтан, ургамлын төрөл зүйлийн мэдээлэл бүрдүүлэхийг хууль тогтоомжоор үүрэг болгодоггүй байв. Байгаль орчныг хариуцсан алба 1987 онд байгуулагдсанаас хойш тогтмол (дөрвөн жил тутам) үндэсний хэмжээний тандан судалгаа, ургамал амьтны тооллого зохион байгуулж, өөр өөр биом дахь (хээр, цөл, уул, ой) зэрлэг амьтдын зүйлүүдийн популяцийн хэмжээг тогтоох, үүндээ эдийн засгийн (аргаль, янгир гэх мэт) буюу байгаль орчны (цагаан зээр гэх мэт) ач холбогдолтой зүйлүүдийг онцлон хамруулдаг болжээ. Хамгийн сүүлчийн улсын хэмжээний үнэлгээ 2010 онд хийгдсэн боловч 2012 оноос хойш төсвийн хомсдлын улмаас 2014 онд хийгдээгүй байна. Мөн ийм шалтгаанаар харь инвазив зүйлийн судалгаа хийгдээгүй тул мэдээлэл олдохгүй байна.

Ургамлын зүйлүүд, амьтдын зүйлүүд, тэдгээрийн популяцийн мэдээллийг шинжлэх ухааны хээрийн судалгаануудаас авдаг байна. Тэдгээр судалгааг үндэсний ба олон улсын шинжлэх ухааны байгууллага (жишээ нь, МУИС, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Биологийн Хүрээлэн, УБИС) эрдэм шинжилгээ, байгаль хамгааллын байгууллагууд (жишээ нь Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Ирвэсийн Сан), бие даасан судлаачид, байгаль орчны ТТБ (жишээ нь, Монголын Байгаль Орчныг Хамгаалах Нийгэмлэг, Монголын Байгалийн Шинжлэх Ухаан, Байгаль Хамгааллын Төв, Монголын Шувуу Судлалын Нийгэмлэг), олон улсын байгаль орчны байгууллагуудын (Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг, Байгаль хамгаалаалал ҮУ ТББ, Дэлхийн байгаль хамгаалах сан зэрэг) төсөлд тулгуурлан зохион байгуулдаг ба мөн улсын тусгай хамгаалалттай газар, аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газрын байгаль хамгаалагчдын өдөр тутам ажиглалтын мэдээллийг ч ашигладаг боловч хээрийн судалгаанд орчин цагийн тоног төхөөрөмж хомс, хяналт ажиглалтын дэвшилтэт арга техникийг хэрэгжүүлэх ур чадвар, туршлага дутмаг байна.

Өөр өөр статистик мэдээ, албан тайлан, бодлогын баримт бичгүүд найдваргүй, эсвэл хуучирсан мэдээлэлтэй байдаг тул ургамлын зүйлүүдийн тооны олдсон өгөгдлийг болгоомжтой тайлбарлах шаардлагатай байна. Хээрийн судалгаа, байгалийн тооллогын явцад шинэ зүйлүүд тэмдэглэгдсээр байдаг. Жишээлбэл, 1989 онд гуурст ургамлын 2,443 зүйл, дэд зүйлүүдийг тодорхойлсон ба 2015 онд энэ тоо 3,127 (сүүлийн хэдэн жилд гэхэд л Монголд гуурст ургамлын 292 “шинэ” зүйл, дэд зүйлүүдийг тэмдэглэсэн) болтол нэмэгдсэн. Улаан ном, Монголын ургамлын талаарх үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийн нэгдсэн судалгаа боловсруулсан мэргэжилтнүүд Монгол Улсын Ургамлын мэдээллийн сан боловсруулахад оролцсон байна.

### Үнэлгээ

Биологийн олон янз байдлын мониторинг, хяналт ажиглалт тогтмол хийх чадавхи санхүүжилт, тоног төхөөрөмж, боловсон хүчний хомсдлын шалтгаанаар ноцтой доголдож байна.

## 11.3 Тусгай хамгаалалттай газруудын хөгжил, удирдлагын чиг хандлага

Монгол Улс тусгай хамгаалалттай газар байгуулах эртний уламжлалтай, бүр 13-р зуунд Чингис хаан гурван дагшин хайрханыг онголсон байдаг. Халх Журамд (1709) Богд Хан, Хан Хэнтий, Хөгнөхон, Түвхэнхан зэрэг 16 ууланд ан хийх, мод авах, тариалан эрхлэхийг хориглосон байдаг. Тэртээ 13-р зуунаас хойш хамгаалагдаж ирсэн гурван газрын нэг Богд Хан уул (Улаанбаатарын ойролцоо) 1778 онд дархан цаазтай болж, төрийн хамгаалалтад орсноор мод бэлтгэх, ан гөрөө хийхийг хориглосон байна (мөн Отгонтэнгэр, Булган ууланд 1818 онд үүнтэй адил хамгаалалтын горим тогтоосон байдаг).

Тусгай хамгаалалттай газрын тогтолцоо

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай 1994 оны хууль дөрвөн төрлийн тусгай хамгаалалттай газрыг тодорхойлсон, үүнд: дархан цаазтай газар, байгалийн цогцолбор газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар гэж заасан байна. Дурсгалт газар нь Түүх соёлын дурсгалт газар, байгалийн дурсгалт газрыг багтаана. Тусгай хамгаалалттай газрын тогтолцоонд мөн орон нутгийн тусгай хамгаалалттай газар багтдаг байна.

Тусгай хамгаалалттай газрын хөгжил

Улсын тусгай хамгаалалттай газрын тогтолцооны хөгжил эхэндээ удаан явцтай байжээ. Богд Хан уулын (анх 1778 онд 41,651 га газарт байгуулагдсан) дархан цаазат байдлыг 1957 онд баталж, хоёр харьцангуй бага хэмжээтэй байгалийн нөөц газрыг нэмснээр тусгай хамгаалалттай газрын нийт талбай 66,400 га (Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 0.6 хувь) болжээ. Дараа нь 1965 онд есөн тусгай хамгаалалттай газартай болж, нийт 236,200 га (0.15 хувь) хамарсан байна. Цаашлаад 1976 онд Их Говийн Дархан цаазат газрыг байгуулснаар тусгай хамгаалалттай газрын нийт талбай 5,547,900 га (улсын нийт нутаг дэвсгэрийн 3.52 хувь) хүрчээ.

Тусгай хамгаалалттай газрын талбай эрс хурдтай нэмэгдэх болсон нь 1990-ээд оны үеэс бөгөөд тэр үед байгаль орчныг хамгаалах нь Засгийн Газрын эн тэргүүлэх чиглэл болж иржээ. Засгийн Газар 1992 оны Рио-де-Жанейрогийн бага хурлын мөрөөр тусгай хамгаалалттай газрыг нийт нутаг дэвсгэрийн 30 хувьд хүргэх зоригтой зорилго тавьсан юм. Тиймээс 1992 онд томоохон талбай бүхий 7 тусгай хамгаалалттай газрыг (6 нь дархан цаазат, нэг нь байгалийн цогцолбор газар) бий болгож, 1993 онд дахин 12 тусгай хамгаалалттай газрыг (дөрөв нь дархан цаазат, тав нь байгалийн цогцолбор газар, гурав нь байгалийн нөөц газар) байгуулав. Үүний үр дүнд Монгол Улс 1993 онд нийт 12,629,800 га хамарсан 26 тусгай хамгаалалттай газартай болсон нь нийт нутаг дэвсгэрийн 8.01 хувь болсон байлаа. Тусгай хамгаалалттай газрын талбай 2000 онд 21,731,500 га (13.8 хувь) хүрэх үест улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээ тэлэх явц удааширсан боловч орон нутгийн тусгай хамгаалалттай газрын талбай хурдацтай тэлснээр энэхүү бууралтыг тэнцвэржүүлсэн гэж үзэж болно. Улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээ 2012 онд 99 тусгай хамгаалалттай газраас бүрдэж, нийтдээ 27,207,800 га (17.4 хувь) талбай хамарч, цаашдаа 2017 онд улсын хоёр шинэ тусгай хамгаалалттай газраар өргөжин тэлсэн байна.

Улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээ 2017 оны байдлаар нийт 12,411,057.44 га (улсын нийт нутгийн 7.93 хувь) талбай бүхий 20 дархан цаазтай газар, 11,884,605.59 га (7.6 хувь) талбай хамарсан 32 байгалийн цогцолбор газар, 3,528,824.17 га (2.26 хувь) талбай хамарсан 36 байгалийн нөөц газар, 128,962.78 га (0.08 хувь) хамарсан 14 дурсгалт газрыг багтааж байна. Энэхүү сүлжээ нь нийт 27,953,449.98 га (улсын нийт нутгийн 17.87 хувь) газрыг хамарч байна. Үүний зэрэгцээ орчны бүсүүд хийгээд орон нутгийн захиргааны тодорхойлсон орон нутгийн чанартай тусгай хамгаалалттай газрууд бий. Ийнхүү улсын тусгай хамгаалалттай газрууд (Хавсралт IV, Газрын зураг 4, Хүснэгт 11.2) нийт 279,534 км<sup>2</sup> газар нутгийг хамарч байгаа нь зарим улсын нутаг дэвсгэрээс их байна.

**Хүснэгт 11.2: Улсын ба орон нутгийн тусгай хамгаалалттай газрууд, 2017**

Тусгай хамгаалалттай газрын ангилал	Тоо	Нийт талбай (га)	Эзлэх хувь (%)
Улсын тусгай хамгаалалттай газар	102	27,953,449.98	17.87
дархан цаазтай газар,	20	12,411,057.44	7.93
байгалийн цогцолбор газар,	32	11,884,605.59	7.60
байгалийн нөөц газар,	36	3,528,824.17	2.26
дурсгалт газар	14	128,962.78	0.08
Орон нутгийн тусгай хамгаалалттай газар	1,108	18,837,459.73	12.04
<b>Нийт</b>	<b>1,210</b>	<b>46,790,909.73</b>	<b>29.91</b>

Эх сурвалж: БОАЖЯ, өөрийн тооцоо

Гэхдээ улсын тусгай хамгаалалттай газрын талбайн тухай мэдээ, мэдээлэл тэр бүр найдвартай бус байна. Хамгийн сүүлийн үеийн газар зүйн мэдээллийн системийн үнэлгээнээс үзэхэд албан ёсны статистик нь нийт бодит талбайг дутуу тооцоолсон байдаг. Түүнчлэн улсын тусгай хамгаалалттай газар, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хооронд статистикийн давхцал ажиглагддаг (2009 онд

газар нутгийн давхцал нийтдээ 929,202 га байсан нь тухайн үеийн орон нутгийн тусгай хамгаалалттай газрын сүлжээний 6 хувьтай тэнцэж байв). Орон нутгийн тусгай хамгаалалттай газруудыг (жишээ нь, Баянхонгор аймгийн тусгай хамгаалалттай газрын 222,820 га талбай 2007 онд Богд Хан уулын байгалийн цогцолбор газарт багтсан) улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээнд нэгтгэж үзэхэд энэ мэт давхцалуудыг хялбархан тайлбарлаж болох ч орон нутгийн статистикт тэмдэглэгдсээр байна.

Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрын тухай мэдээ нь 2017 онд Монгол Улсад 46.79 саяас доошгүй га талбайтай (улс орны нийт нутгийн 29.91 хувь) 1,210-аас доошгүй тусгай хамгаалалттай газартайг илтгэж байна.

#### Улсын тусгай хамгаалалттай газрын тогтолцоо

Дархан цаазтай газрууд (Олон Улсын Байгаль Хамгаалах Холбооны тусгай хамгаалалттай газрын удирдлагын ангиллаар Ia, Ib ангилалд хамаарна) нь байгалийн унаган төлөв, экологийн үйл явц нь онцгой сайн хадгалагдсан, хүний нөлөөлөл, ашиглалтыг хатуу хязгаарласан онгон дагшин нутаг юм. Дархан цаазтай газрын үйл ажиллагааны бүсчлэлд зөвхөн идэвхгүй хамгаалалтын арга хэмжээ, байгалийн унаган төрхөд нөлөөлөхгүй судалгаа шинжилгээ хийхийг зөвшөөрсөн “онгон (цөм) бүс” багтдаг. Хоёр дахь бүс нь “хамгаалалтын бүс” агаад зарим нэг идэвхтэй хамгаалалтын арга хэмжээ (жишээ нь, байгалийн гамшгаас үүдэлтэй хохирлыг нөхөх) хэрэгжүүлэхийг зөвшөөрдөг. Гурав дахь нь “хязгаарлалтын бүс” бөгөөд хамгаалалтын өргөн хүрээний арга хэмжээ авах (жишээ нь, хөрс, ургамал бүрхэвчийг нөхөн сэргээх, ойн арчилгаа, цэвэрлэгээ хийх), орон нутгийн оршин суугчид арилжааны бус зорилгоор эмийн ургамал түүх, модон бус ойн бүтээгдэхүүн ашиглах, сүсэг бишрэлийн зан үйл үйлдэх, аялал жуулчлал явуулахыг зөвшөөрдөг. Энэ гурван бүсийн алинд ч уул уурхай, мод бэлтгэл, ан агнуур, барилга барихыг хориглодог. Дархан цаазтай газар тус бүр өөрийн захиргаатай байх ёстой, захиргааг нь дархан цаазтай газруудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үүсгэн байгуулна. Дархан цаазтай газрыг тойрсон “орчны бүсийг” бас тогтоодог ба тэнд нь орон нутгийн засаг дарга нар дархан цаазтай газрын захиргаа, орчны бүсийн зөвлөлтэй хамтран орчны бүсийн удирдлагын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хэмжээний хувьд дархан цаазтай газруудын маш цөөн нь 100,000 га-аас бага нутагтай, жишээлбэл анхны дархан цаазат газруудын нэг болох Хасагт Хайрхан уул 1965 онд байгуулагдаж, 27,448 га газар эзэлдэг. Зарим дархан цаазтай газар 1 саяас дээш га талбай эзэлдэг, тухайлбал Их Говийн дархан газар 1975 онд байгуулагдсан бөгөөд 5,311,730 га (газар зүйн мэдээллийн системийн хэмжсэнээр 5,565,642 га) эзэлдэг нь Швейцар Улсын нутгаас ч их бөгөөд Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 3.4 хувьтай тэнцэнэ.

Байгалийн цогцолборт газрууд нь (Олон Улсын Байгаль Хамгаалах Холбооны тусгай хамгаалалттай газрын удирдлагын ангилал II) байгалийн нөхцөл нь сайтар хадгалагдсан, түүх, соёл, шинжлэх ухаан, боловсролын үнэ цэнтэй газар нутаг юм. Байгалийн цогцолборт газар нь дархан цаазтай газрын адил бүсчлэгдэхдээ зөвхөн судалгаа шинжилгээ, хамгааллын арга хэмжээг зөвшөөрдөг “онцгой (цөм) бүс”, судалгаа шинжилгээ, хамгааллын арга хэмжээний сацуу аялал жуулчлал, загасчлалыг зөвшөөрдөг “аялал жуулчлалын бүс”, дээрх үйл ажиллагааны зэрэгцээ мал аж ахйн, аялал жуулчлалын дэд бүтэц, барилгын (байгалийн цогцолборт газрын захиргааны зөвшөөрлөөр) үйл ажиллагааг зөвшөөрдөг “хязгаарлалтын бүсээс” бүрдэнэ. Эдгээр бүсийн алинд ч уул уурхай, мод бэлтгэл, ан агнуурыг хориглоно. Байгалийн цогцолборт газарт нь дархан цаазтай газрын адил захиргааны албатай, орчны бүсийн удирдлагын төлөвлөгөөтэй байх шаардлагатай. Ганц ялгаатай зүйл нь байгалийн цогцолборт газрын орчны бүсийг байгалийн цогцолборт газрын гадуур нь, эсвэл зарим хэсгээр нь хязгаарлалтын бүстэй давхцуулж байгуулж болдог оршино.

Байгалийн цогцолборт газрууд хэмжээгээрээ янз бүр байх ба тэдгээрийн гуравны нэг нь л 100,000 га хүрэхгүй газартай, харин зарим нь сая шахам, саяас дээш га талбайтай байна. Хамгийн том байгалийн цогцолборт газар Говь Гурван Сайхан уул 2,697,170.84 га (Монголын нийт нутаг дэвсгэрийн 1.72 хувь) талбай хамарч байна.

Байгалийн тодорхой онцлог чанар, нөөцийг хадгалах зорилгоор байгалийн нөөц газруудыг байгуулдаг. Байгалийн нөөц газрыг таван төрөлд хуваадаг байна, үүнд: экосистемийн (байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах зорилго бүхий *байгалийн иж бүрдлийн нөөц газар*); биологийн (ховор ховордсон ургамал, амьтныг хамгаалах, тэдгээрийн нөхөн үржих нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий *биологийн нөөц газар*); палеонтологийн (эртний амьтан, ургамлын ховор олдворыг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий *байгалийн түүхэн олдворын нөөц газар*); геологийн (газрын өвөрмөц тогтоц,

илэрц, тэдгээрийн бүтцийг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий *геологийн нөөц газар*); усны (мөрөн, гол, усны эх үүсвэрийг хамгаалах зорилго бүхий усны нөөц газар). Байгалийн нөөц газарт зөвхөн уламжлалт аж ахуйн үйл ажиллагааг зөвшөөрдөг, чингэхдээ гол үнэт зүйлд хохирол учруулахгүй байхыг шаардана. Тийм ч учраас Монгол Улсын байгалийн нөөц газар нь Олон Улсын Байгаль Хамгаалах Холбооны Ia (дархан цаазтай байгалийн нөөц) ангилалд таардаггүй ч цар хэмжээнийхээ хувьд, мөн нутгийн уугуул оршин суугчдад нөөц ашиглахыг зөвшөөрдгөөрөө Олон Улсын Байгаль Хамгаалах Холбооны Ib (онгон байгаль бүхий нутаг) ангилалтай төстэй. Уул уурхай, ан агнуур, барилгыг эрс хориглодог.

Байгалийн нөөц газруудад захиргааны албатай байх шаардлага тавигддаггүй, тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг дарга байгалийн нөөцийн хамгааллыг зохион байгуулах үүрэгтэй. Байгалийн нөөц газрыг бүсчлэн хуваадаггүй, гэхдээ шаардлагатай гэж үзвэл сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, хорооны иргэд нийтийн хурлаар гадаад орчны бүсийг тогтоож болно.

Байгалийн нөөц газрууд харьцангуй хатуу хамгаалалтын горимтой хэдий ч талбай нь нилээн том, найман байгалийн нөөц газрын талбай 100,000 га-аас дээш, жишээлбэл 2016 оны 4 сард байгуулсан Тост-Тосон Бумбын нурууны байгалийн нөөц газар 743,057.93 га талбайтай байна.

Дурсгалт газар (Олон Улсын Байгаль Хамгаалах Холбооны тусгай хамгаалалттай газрын удирдлагын ангилал III) судалгаа шинжилгээ, үзвэр үзүүлэнгийн зорилгоор байгуулдаг. Байгалийн дурсгалт газрууд ландшафтын өвөрмөц тогтоц, хэлбэржилтийг (хүрхрээ, байц, цав, хад чулуу, баян бүрд, элсэн манхан) хадгалж хамгаалдаг, түүх соёлын дурсгалт газар нь эртний хүний сууц, агуйн зураг, хадны зураг, бичээс, түүхэн хөшөө, булш, балгас, уламжлалт зан үйлтэй холбоотой уул, шүтэгдэж ирсэн газар нутгийг хамгаалдаг. Дурсгалт газарт хязгаарлагдмал хэмжээнд үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөх ба чингэхдээ дурсгалт газрын гол үнэт зүйлсийг эвдэх, хохирол учруулахгүй шаардлага тавина. Дурсгалт газар нь байгалийн нөөц газрын адил бүсчлэн хуваагддаггүй, захиргааны албатай байхыг шаарддаггүй, удирдлагыг холбогдох орон нутгийн аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргаанд даалгадаг. Мөн гаднахи орчны бүсийн асуудлыг байгалийн нөөц газрынхтай адилаар зохицуулна.

Талбай, хэмжээний тухайд 1,000 га-аас бага талбайтай дурсгалт газар хоёр л байна. Хамгийн том дурсгалт газар нь 31,277.21 га талбай бүхий Даян Дээрхийн агуй юм.

#### Орон нутгийн тусгай хамгаалалттай газар

Улсын тусгай хамгаалалттай газрын тогтолцооны зэрэгцээ орон нутгийн тусгай хамгаалалттай газрын сүлжээ ажиллаж байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд аймаг, нийслэл, сум, дүүрэг харьяаллынхаа тодорхой талбайг орон нутгийн тусгай хамгаалалттай газар болгон зарлаж болохыг заагаад аймаг, сумдын иргэдийн төлөөлөгчдийн хурлуудад орон нутгийн тусгай хамгаалалттай газрууд байгуулан, хил хязгаарыг нь тогтоож, зохих хамгааллын горимыг нь тодорхойлох эрх олгосон байдаг.

Тусгай хамгаалалттай газрын энэхүү нэмэлт сүлжээ хэрэгтэй болсон нь Монгол Улсын байгалийн нөхцөл, амьтны аймгийн олон төрөл зүйлийн амьдрахад шаардлагатай өргөн уудам нүүдлийн зам, бэлчээрийг хадгалан хамгаалж, популяци хоорондын генийн солилцоог хангах хэрэгцээгээр тайлбарлагдана. Үүний сацуу тусгай хамгаалалттай газрын гадна үлдсэн нутгуудад орон нутгийн оршин суугчид, хагас нүүдэлчин хийгээд нүүдэлчин малчин хүн ам хамтран амьдарч, нөөцийг өргөнөөр ашигладаг, чингэхдээ тогтвортой арга хэлбэрээр ашиглах эрмэлзэлтэй байдаг байна.

Улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээ экологийн ач холбогдолтой бүх нутгийг хамарч чадахгүй тул биологийн хамгаалалтыг орон нутгийн хүн амын нийгэм, эдийн тогтвортой хамгааллын тогтолцоо бий болгохын тулд байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг улсын тусгай хамгаалалттай газрын хил хязгаараас хавьгүй өргөн хүрээнд хэрэгжүүлэх, үүндээ хөдөөгийн хүн ам оршин сууж, ашигладаг газар нутгийг хамрах шаардлагатай байдаг, ингэснээр тэдгээр газар нутгийн тогтвортой удирдлагыг хангах арга хэрэгсэл бүхий оролцогч, сонирхлын бүлгүүдтэй болдог байна.

Орон нутгийн тусгай хамгаалалттай газруудыг байгуулах зорилго нь экосистемийн тогворжилтыг хангах, байгаль, түүх, соёлын үнэ цэн бүхий газар нутаг дахь газрын тогтвортой ашиглалтыг дэмжихэд оршино. Хамгааллын гол зоригдлоос нь үүдэн орон нутгийн тусгай хамгаалалттай газруудыг ой, зэрлэг амьтан, ургамал, усны нөөц газар, байгалийн ба түүхийн өв нөөц газар гэж ангилдаг. Шаардлагатай бол орон нутгийн тусгай хамгаалалттай газруудыг хамгааллын ба хязгаарлагдмал ашиглалтын бүсүүдэд



хувааж болно. Орон нутгийн тусгай хамгаалалттай газарт тогтоох хамгааллын горим нь Олон Улсын Байгаль Хамгаалах Холбооны тусгай хамгаалалттай газрын удирдлагын ангилал Ib (орон нутгийн хүн ам хамгаалалтын зорилго зорилтод нийцтэй арга хэлбэрээр нөөцийг ашиглаж болох том хэмжээний онгон газар нутаг), мөн ангилал VI-тай (соёлын үнэт зүйл, байгалийн нөөцийн удирдлагын уламжлалт тогтолцоо бүхий экосистем, амьтдын амьдрах орчныг багтаасан өргөн уудам хамгаалагдсан газар нутаг) төстэй байх магадлалтай, энэ хоёрын аль аль нь орон нутгийн олон нийтэд түшиглэсэн байгалийн нөөцийн удирдлагад суурилах ба энэ нь Монгол орны уламжлалд нийцтэй бөгөөд Биологийн олон янз байдлын тухай конвенцийн дэмждэг арга хэлбэр юм.

Орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг орон нутгийн захиргаа зөвхөн түр хугацаагаар тогтоох ба арван жилээс хэтрэхгүй хугацаатай байна. Гэхдээ хамгааллын хугацаа дуусаха үед сунгаж болно. Тиймээс орон нутгийн тусгай хамгаалалттай газрын тоо байнга хэлбэлзэж байдаг. Цаашлаад, орон нутаг ба төвийн хооронд мэдээллийн урсгал хөшүүн удаан явах тул Уул Уурхай Хүнд Үйлдвэрийн Яам орон нутгийн тусгай хамгаалалттай газарт уул уурхайн зөвшөөрөл олгочихсон тохиолдлууд гардаг байна.

Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын сүлжээний хөгжил эхэндээ удаан явцтай байсан боловч 1988, 1999 онуудад жилд 15 шинэ орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг тогтоож байжээ. Харин 2000 оноос эхлээд жилд зарлах орон нутгийн тусгай хамгаалалттай газрын тоо нэмэгдсэн байна (жишээлбэл 2000 онд 119, 2007 онд 180 орон нутгийн тусгай хамгаалалттай газар тогтоосон). Харин улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээ байгуулах явц эрс удааширсан билээ. Ийнхүү одоогийн орон нутгийн тусгай хамгаалалттай газрын дийлэнх нь 2000 оны 1 сарын 1-ээс хойш бий болсон байна. Түүнчлэн 2013, 2016 онд орон нутгийн тусгай хамгаалалттай газрын тоо эрчимтэй нэмэгдсэн (2013 онд 125, 2014 онд 374, 2015 онд 576, 2016 онд 348) байна. Ийнхүү орон нутгийн тусгай хамгаалалттай газрын тоо эрс нэмэгдэнд тухайн тогтолцоог шүүмжлэх, тухайн газар нутаг хамгаалалтын чухал ач холбогдолтой болохыг нотлох байгалийн тооллого, үнэлгээг нухацтай хийх боломжтой эсэхэд эргэлзэх хандлага гардаг байна. Энэчлэн ийм олон орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг тогтоох албан ёсны журмуудыг гүйцэтгэх боломжид эргэлзэж байв. Ийнхүү шүүмжилснээр зарим орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг байгуулсан сэдэл нь байгаль орчин биш, үржил шимтэй бэлчээр нутгийг бусад орон нутгийн хүмүүсээс харамласан, эсвэл уул уурхайн компаниудаас тухайн газрын тусгай хамгаалалтаас гаргасны төлбөр төлүүлэх гэх мэт сэдэлтэй байж болзошгүй гэж сэжиглэж байв.

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 1 га-аас 100,000 га байгаа ч орон нутгийн 40 тусгай хамгаалалттай газар үүнээс их талбайтай бөгөөд нийлээд бүх орон нутгийн тусгай хамгаалалттай газрын нийлбэрээс илүү юм. Орчин цагийн үндэсний хэмжээний цахим мэдээллийн системгүйн уршгаар олдож байгаа статистик мэдээлэл нь орон нутгийн тусгай хамгаалалттай газрын тоо, талбайн талаар нарийвчилсан өгөгдлөөр хангаж чадахгүй байна. Учир нь орон нутгийн тусгай хамгаалалттай газар тогтоосон ба хугацаа дууссан, сунгасан байдлын мэдээллийн төв рүү тэр бүр шуурхай дамжуулахгүй байна. Тийм учраас Байгаль орчны Мэдээллийн Төв болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хоёр зэрэгцээ мэдээллийн сан бий болж, тэдгээрийн нэг нь мэдэгдэж байгаа бүх орон нутгийн тусгай хамгаалалттай газрын мэдээтэй (хамгааллын эрх зүйн байдал, хил хязгаар нь тодорхойгүй газрууд бас хамрагдсан), нөгөө нь эрх зүйн байдал, хил хязгаар нь батлагдсан орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын тухай мэдээтэй байна. Жишээлэхэд, Монгол Улс 2015 онд нийт 57.9 сая га талбай (нийт нутгийн 37.1 хувь) бүхий 2,362 орон нутгийн тусгай хамгаалалттай газартай (аймгийн 919, сумын 443) байсан. Гэтэл орон нутгийн 978 тусгай хамгаалалттай газрын эрх зүйн байдал тодорхойгүй, 681 тусгай хамгаалалттай газрын хил хязгаар тодорхойгүй байлаа. Эдгээрээс шалтгаалаад, хоёр дахь мэдээллийн сан нь батлагдсан учраас маргаангүй 17.7 сая га (нийт нутгийн 11.36 хувь) талбай бүхий 1,103 орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг хамарч байна.

Орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын томоохон нь Баянхонгор аймаг дахь Хангайн бүсийн тусгай хамгаалалттай газар (989,126 га); “Өвөрхангай аймгийн улсын хил дагуухи өмнөд сумдыг хамарсан тусгай хамгаалалттай газар (863,271 га); Сүхбаатар аймаг дахь Зогол Хан Уулын тусгай хамгаалалттай газар (530,942 га) юм. Зарим аймаг нутаг дэвсгэрийнхээ ихээхэн хэсгийг хамарсан өргөн уудам нутгийг тусгай хамгаалалттай газрын бүрэлдэхүүнд оруулахаар шийдвэрлэсэн байна. 2017 онд хамгийн томоохон талбайг орон нутгийн тусгай хамгаалалтад оруулсан, тусгай хамгаалалттай газар аймгийн нутаг дэвсгэрийн нь ихээхэн хэсгийг эзэлдэг таван аймгийн тусгай хамгаалалттай газрын нийлбэр талбай 13 сая га (Хүснэгт 11.3) буюу улсын нийт нутгийн 8.25 хувийг эзэлж байна. БОАЖЯ-ны мэдээллээр орон нутгийн тусгай хамгаалалттай газрын сүлжээнд 2016 онд 1108 тусгай хамгаалалттай газар (тодорхойгүйг нь хасаад), 18,837,459.75 га (улсын нийт нутгийн 12.04 хувь) талбай хамрагдаж байжээ.



**Хүснэгт 11.3: Хамгийн том талбай бүхий тусгай хамгаалалттай газар бүхий аймгууд, 2017**

Аймаг	Тоо	Талбай (га)	Аймгийн нутагт эзлэх хувь (%)
Өмнөговь	69	3,976,878.65	24.05
Сүхбаатар	78	2,637,860.74	32.06
Говь-Алтай	117	2,471,075.35	17.47
Дундговь	99	1,1997,248.28	26.74
Хэнтий	350	1,850,253.21	22.47
<b>Нийт</b>	<b>713</b>	<b>12,933,316.23</b>	

Эх сурвалж: БОАЖЯ, 2017.

*Орчны бүс*

Тусгай хамгаалалттай газруудыг хүрээлсэн орчны бүсүүдийг орон нутгийн захиргаа тогтооно. Орчны бүс нь тусгай хамгаалалттай газарт тусах бодитой болон болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах, арилгах, урьдчилан сэргийлэх, түүнчлэн байгаль хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн хүн амын амьжиргааг хангах үүрэгтэй. Орон нутгийн засаг дарга нар эдгээр орчны бүсийн хамгааллын удирдлагын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх асуудлыг хариуцна. Ийнхүү орон нутгаас тодорхойлж, удирдаж зохицуулдаг орчны бүсүүдийн тусгай хамгаалалттай газрын бие даасан “BZ” ангилал гэж үзэх боломжтой. Гэвч орчны бүсүүд албан статистик мэдээ болон мэдээллийн сангийн анхаарлын гадна үлддэг тул тэдгээрийн талаар бараг мэдээлэлгүй байна. Улсын зарим тусгай хамгаалалттай газрын (жишээлбэл Дорнод Монгол, Их Говийн ДЦГ-ын А, Б хэсэг, Хан Хэнтий, Хасагт Хайрхан уул, Монгол-Дагуур, Нөмрөг, Увс нуурын сав газар гэсэн долоон дархан цаазтай газар; Алтай Таван Богд, Говь Гурван Сайхан, Горхи-Тэрэлж, Хустай нуруу, Хар Ус Нуурын зэрэг таван байгалийн цогцолборт газар) орчны бүсийг БОАЖЯ албан ёсоор баталсан байна. Бүх дархан цаазтай газрын орчны бүс нийтдээ 15 сая га тайлбайтай байна. Гэтэл эдгээр орчны бүс орон нутгийн тусгай хамгаалалттай газрууд, байгалийн цогцолборт газруудын хязгаарлалтын бүсүүдтэй ямар хэмжээнд давхцаж байгаа нь тодорхойгүй байна.

*Байгалийн онгон дагшин газрууд*

Дагшин газарт байгалийн ач холбогдолтой (уул, нуур, төгөл гэх мэт), соёлын ач холбогдолтой (сүм, буган чулуу, хадны зураг бүхий газар, эртний булш, хиргисүүр бүхий газар гэх мэт) газрууд багтана. 2009 он гэхэд 21 аймаг, нийслэлд 47 байгалийн дагшин газар байсны гурав нь Ерөнхийлөгчийн зарлигаар үндэсний түвшинд тодорхойлогдсон, 34 нь аймаг, нийслэлийн түвшинд, 10 нь зэргэлдээ аймгууд хамтран тодорхойлсон байна. Хамгийн олон дагшин газар бүхий хоёр аймаг нь Хөвсгөл, Өвөрхангай юм (тус бүр дөрвөн дагшин газартай). Нийтдээ 16 байгалийн дагшин газар улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээний хамгаалалттай бүсэд, найм нь орон нутгийн тусгай хамгаалалттай газруудад оршиж байна. Дагшин газрууд нь ихэвчлэн бага хэмжээний талбайтай, хил хязгаарыг нь тэр бүр албан ёсоор тогтоодоггүй тул 47 байгалийн дагшин газрын талбайн хэмжээг Хүснэгт 11.2-т тусгаагүй болно.

*Менежмент*Менежментийн төлөвлөгөө

Улсын тусгай хамгаалалттай газрын удирдлага мцнежментийн төлөвлөгөө боловсруулахад хуулиар тодорхойлсон шаардлага байдаггүй ч БОАЖЯ улсын бүх тусгай хамгаалалттай газрыг удирдлагын төлөвлөгөөгөө боловсруулан, сайдаар батлуулан ажиллахыг шаардаж байгаа бөгөөд төлөвлөгөөний төслийг буцаах эрхтэй, жишээлбэл орон нутгийн сонирхогч талуудтай зөвлөлдөөгүй бол төслийг буцааж болно.

Эхэндээ төлөвлөх үйл явц төдийлөн амжилттай бус, тусгай хамгаалалттай газрын цөөн нь л шаардлага хангасан удирдлагын төлөвлөгөөтэй байсны эхнийх нь Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрын 1998 онд батлуулсан төлөвлөгөө, дараагийнх нь 2001 онд батлуулсан Нөмрөгийн дархан цаазтай газрын, дараагийнх нь Хустай нурууны байгалийн цогцолборт газрын 2002 оны төлөвлөгөө, Хар Ус Нуурын байгалийн цогцолборт газрын 2002/2006 оны төлөвлөгөө байх агаад харин Хан Хангий, Говь Гурван Сайхан, Дорнод Монголын тусгай хамгаалалттай газар, Увс нуурын савын дархан цаазтай газрын төлөвлөгөөнүүдийг яам буцаасан байна. Хожим нь олон улсын дэмжлэгтэй төслүүдийн хүрээнд тусгай хамгаалалттай газрын менежерүүдэд зориулж удирдлагын төлөвлөлтийн сургалт олонтаа зохион байгуулж, тусгай хамгаалалттай газрын төлөвлөлтийг дэмжих арга хэмжээ авсан байна. Зарим

удирдлагын төлөвлөгөөг олон улсын байгууллагын тусламжтай боловсруулсны дотор Хөвсгөл, Хар Ус Нуурийн байгалийн цогцолборт газруудын төлөвлөгөөг Дэлхийн Байгаль Хамгаалах Сан, Дорнод Монголын дархан цаазтай газар, Монгол-Дагуурын дархан цаазтай газрын төлөвлөгөөг Дэлхийн Байгаль Хамгаалах Сан, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн хамтарсан төслийн хүрээнд боловсруулжээ.

2010 он гэхэд ердөө л долоон дархан цаазтай газар (Богд Хан Уул, Дорнод Монгол, Их Говь, Хан Хэнтий, Монгол-Дагуур, Нөмрөг, Увс Нуурын Савын дархан цаазтай газрууд), арван байгалийн цогцолборт газар (Алтай Таван Богд, Дарьганга, Говь Гурван Сайхан, Горхи-Тэрэлж, Хустай нуруу, Хангай нуруу, Хан Хөхий-Хяргас нуур, Хорго Тэрхийн Цагаан нуур, Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрууд) шаардлага хангасан удирдлагын төлөвлөгөөтэй болсон байв (мөн Нагалхаан байгалийн нөөц газар). Улсын олон тусгай хамгаалалттай газрын удирдлагын төлөвлөгөө 2010 оноос хойш гарсан ба зарим нь олон улсын байгууллагын туслалцаатай боловсруулжээ. Түүнчлэн Хавтгар орон нутгийн тусгай хамгаалалттай газрын удирдлагын төлөвлөгөөг 2007 онд “Байгаль хамгаалал, байгалийн нөөцийн тогтвортой удирдлага” төслийн хүрээнд Германы Олон Улсын Хөгжлийн байгууллагын тусламжтай боловсруулсан байна.

#### Тусгай хамгаалалттай газрын захиргааны тогтолцоо

Дархан цаазтай газар, байгалийн цогцолборт газруудыг тусгай хамгаалалттай газрын 33 захиргаа удирдаж, тус бүр нь нэг буюу түүнээс дээш тусгай хамгаалалттай газрыг хариуцдаг (түүнчлэн Тахийг дахин нутагшуулах эрдэм шинжилгээний төвд тусгай хамгаалалттай газрын статус олгосон) бол байгалийн нөөц газар, байгалийн дурсгалт газруудыг аймаг, сумын захиргаад удирддаг байна.

Хууль тогтоомжийн дагуу тусгай хамгаалалттай газрын удирдлагыг гэрээний үндсэн дээр ТББ-аар гүйцэтгүүлэх боломжтой, жишээлбэл Хустай нурууны байгалийн цогцолборт газрын удирдлагыг Монголын Байгаль Орчныг Хамгааллын Нийгэмлэг (1993-2003), орон нутгийн Хустай нурууны байгалийн цогцолборт газрын итгэмжлэгчтэй (2003 оноос) байгуулсан гэрээг дурдаж болно. Байгалийн нөөц газар, дурсгалт газар, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хувьд ч аймгийн ИТХ ба ТББ, эсвэл малчдын бүлгүүдийн хооронд гэрээ олонтаа байгуулагддаг, тухайлбал Аргаль Судалгааны Төв ба Монголын Байгаль Орчныг Хамгаалах Эвсэл Их Нарт байгалийн нөөц газрыг хамтарч, Гулзат ТББ Увс аймгийн Гулзат орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг, Хавтгар Ширээ ТББ Хэнтий аймгийн Хавтгар орон нутгийн тусгай хамгаалалттай газрын удирдлагыг хариуцаж байна.

*Тусгай хамгаалалттай газрын сүлжээний экосистем, зүйлийн хамгаалалттай холбоотой орхигдол, дутагдалтай тал*

Монголын улсын тусгай хамгаалалттай газрын тогтолцоон дахь орхигдлын нарийвчилсан шинжилгээний үр дүнгийн тайланг 2010 онд Монгол дахь Дэлхийн Байгаль Хамгаалах Сан нийтэлжээ. Уг тайланд Дэлхийн Байгаль Хамгаалах Сан, Байгаль хамгаалал болон бусад байгууллагын 2007-2009 онд байгаль орчны асуудал эрхэлсэн яамтай хамтран хэрэгжүүлсэн судалгааны төслүүдийн үр дүнг нэгтгэсэн байна. Тэдгээр судалгааг MAVA сан, Нидерланд дахь Дэлхийн Байгаль Орчны Сан, Даян Дэлхийн Байгаль Орчны Сан (GEF) зэрэг байгууллагуудаас санхүүжилттэй гурван төслийн хүрээнд хэрэгжүүлсэн байна.

Дээрхи дүн шинжилгээнээс үзэхэд 2010 онд улсын тусгай хамгаалалттай газрын тогтолцоо цар хэмжээгээрээ ч, хамрах бүрдлээрээ ч, экологийн хувьд ч хангалтгүй, 19 байгалийн экосистемээс 7 экосистем дутуу хамрагдсан байжээ. Эдийн засгийн хэрэглээнд тохиромжгүй экосистемүүдийг сайн хамгаалсан улсын тусгай хамгаалалттай газрууд мөнх цас, мөсөн голоор бүрхэгдсэн нутгийн 79.39 хувь, хэт хуурай цөлийн экосистемийн 74.18 хувь, тагийн тундрын 40.73 хувийг багтаасан байна. Эдгээр экосистем нь Монгол орны хувьд нийтлэг биш бөгөөд улсын нийт нутаг дэвсгэрийн 4.64 хувийг л хамарч байна. Ойн ургамалжилт бүхий гурван экосистем (хамтдаа улсын нийт нутаг дэвсгэрийн 7.52 хувийг бүрхдэг) харьцангуй сайн хамгаалагдсаны дотор улсын тусгай хамгаалалттай газрууд сэрүүн бүсийн шилмүүст ойн 31.42 хувь, тагийн хормойн ойн 15.62 хувь, сэрүүн бүсийн ойн эмжээр холимог ойн экосистемийн 9.96 хувийг багтаасан байна. Гэтэл хээрийн дөрвөн экосистем тусгай хамгаалалттай газарт хамгийн бага багтсан (нугын хээрийн 7.62 хувь, хуурайвтар хээрийн 5.39 хувь, хуурай хээрийн 4.24 хувь, цөлөрхөг хээрийн экосистемийн 6.59 хувь) атал эдгээр экосистем нь Монгол орны хувьд хамгийн түгээмэл бөгөөд улсын нутаг дэвсгэрийн 55.42 хувийг эзэлдэг байна.

Нийт 19 экосистемийн тухайд дөрвөн эко-бүс нутаг тус бүрт, тодорхой эко-бүс нутгийн гол зэрлэг амьтдын зүйлийн потенциал амьдрах орчны орхигдлын шинжилгээ хийсэн байна. Улсын тусгай

хамгаалалттай газрууд дахь экосистемийн хамралтын зохисгүй харьцаа тэмдэглэгдсэний дотор Хангайн эко-бүс нутгийн ой хамгийн бага хамгаалагдсан байна. улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээ 2010 онд эко-бүс нутгуудыг хамарсан байдал нь Хангайн эко-бүс нутгийн 7.9 хувь, Дагуурын хээр талын 9.6 хувь, Алтай-Соёны 14 хувь, Төв Азийн Говийн эко-бүс нутгийн 21.4 хувь байна.

Энэхүү тайлангийн үр дүн нь тусгай хамгаалалттай газрын сүлжээг цаашид өргөтгөх, боловсронгуй болгоход амин чухал ач холбогдолтой юм. Гэхдээ улсын тусгай хамгаалалттай газруудын сүлжээ өөр өөр бүс нутаг, байгалийн өөр өөр экосистемд үзүүлж буй хамгаалалтын түвшинд нь үнэлгээ хийхэд байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд (аялал жуулчлалын дэд бүтэц, байнгын суурин барилга хөгжүүлэхийг зөвшөөрдөг) “түвшин IV” гэсэн өндөр үзүүлэлт, байгалийн нөөц газар, байгалийн дурсгалт газарт (аялал жуулчлал мэт үйл ажиллагааг хориглодог). “түвшин V” гэсэн нам үзүүлэлт оноосноороо арга зүйн алдаа гаргасан гэж үзэж болно. Үүний улмаас нутаг дэвсгэрийн хамралт, экосистемийн хамгааллын түвшнүүдэд хамаарах эдгээр шинжилгээ, статистик, үр дүнгүүд нь эргэлзээтэй болсон байна.

Гэхдээ л Монгол орны тусгай хамгаалалттай газрын дийлэнх хэсэг өргөн уудам нутаг дэвсгэр хамарч байгаа мэт боловч хамгийн өндөр түвшний хамгааллыг тэрхүү их хэмжээний талбайн өчүүхэн хэсэгт хүртээж байна. Цаашлаад, уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхлэхийг тусгай хамгаалалттай газрын сүлжээний ихээхэн хэсэгт (жишээлбэл байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын хязгаарлалтын бүсүүдэд) зөвшөөрсөн нь зэрлэг амьтдын амьдрах орчинд тусах дарамтыг нэмэгдүүлж байна. Иймд ихэнх тохиолдолд тусгай хамгаалалттай газруудын одоогийн бүсчлэл нь үнэт биологийн олон янз байдлыг хангалттай хамгаалахгүй байна.

#### *Тусгай хамгаалалттай газрын сүлжээг өргөжүүлэх төлөвлөгөө*

Монгол Улс 1992 онд нийт нутаг дэвсгэрийнхээ 30 хувийг улсын тусгай хамгаалалтад авах зорилго дэвшүүлж, 1996 онд Биологийн олон янз байдлыг хамгаалах үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө, 1998 оны Тусгай хамгаалалттай газрыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт энэхүү зорилгыг тусгасан боловч тодорхой хугацаа тавиагүй байна. Үндэсний түвшний МХЗ-д (УИХ-ын 2005 оны Тогтоол №25) тогтоохдоо Монгол Улс 2015 он гэхэд нийт нутаг дэвсгэрийнхээ 30 хувийг тусгай хамгаалалттай газрын сүлжээнд хамруулах, 15 хувь нь орон нутгийн тусгай хамгаалалттай газрын сүлжээнд хамрагдахаар тусгасан. Газрын менежментийн 2003 оны Мастер төлөвлөгөөнд (2003 оны ЗГ-ын Тогтоол № 264) 24.2 сая га нутгийг тусгай хамгаалалттай газрын сүлжээнд хамруулах, 75 газар нутгийг улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээнд багтаахаар тусгасан байна.

Засгийн Газар тусгай хамгаалалттай газрын сүлжээг өргөтгөх төлөвлөгөөг Биологийн олон янз байдлын тухай Конвенцийн хэрэгжилтэд оруулж байгаа хувь нэмэр гэж үздэг. БОАЖЯ-ны сүүлийн үеийн олон баримт бичиг, нийтлэлүүдэд 2030 оныг МХЗ дахь 30 хувийн үзүүлэлтэд хүрэх сүүлчийн хугацаа болгон дурдсан байдаг. Гайхууштай нь, энэ хүсэл зориг нь харин Үндэсний Биологийн олон янз байдлын 2015-2025 оны хөтөлбөрөөс алга болсон байна. Түүний оронд 2025 он хүртэл экосистем тус бүрийн 30-аас доошгүй хувийг өргөжүүлсэн тусгай хамгаалалттай газрын сүлжээнд багтаахаар тусгасан байна. Үнэндээ нутаг дэвсгэрийн 30 хувь гэдэг нь 46.9 сая га бөгөөд улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээ нь орон нутгийн тусгай хамгаалалттай газруудтай хамт 2017 он гэхэд бараг 46.8 сая га-г хамраад байгаа тул үндэсний МХЗ бараг биелээд байна (Хүснэгт 11.2).

Түүнчлэн Улсын Байгаль орчны 2015-2016 оны илтгэлд тусгай хамгаалалттай газрын сүлжээг өргөжүүлэх төлөвлөгөөний гурван үеийг тодорхойлсон байна. Үүнд: Нэгдүгээр шатанд 24,754,228 га талбай хамарсан 90 тусгай хамгаалалттай газар (2016-2020), Хоёрдугаар шатанд 9,519,045 га талбай бүхий 47 тусгай хамгаалалттай газар (2021-2025), Гуравдугаар шатанд 8,952,356 га талбай бүхий 78 тусгай хамгаалалттай газар нутгийг бий болгохоор төлөвлөжээ (2026-2030). Энэ нь одоогийн тусгай хамгаалалттай газрын сүлжээг (27,953,450 га-г хамарсан 102 тусгай хамгаалалттай газар нутаг улсын нийт нутаг дэвсгэрийн 17.87 хувийг эзэлдэг) 43,223,829 га-аар өргөжүүлж 215 тусгай хамгаалалттай газрыг шинээр байгуулна гэсэн үг. Ийм зоригтой төлөвлөгөөг хэрэгжүүлбэл 2030 он гэхэд тусгай хамгаалалттай газрын сүлжээ нийт 71,177,279 га талбай буюу улсын нийт нутаг дэвсгэрийн 45.50 хувийг бүрхсэн 317 тусгай хамгаалалттай газрыг багтаахаар байна.

Тун саяхан 2016 онд Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлалд “байгалийн ландшафт, биологийн олон янз байдлыг хамгаалах, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хангах” тухай зарлаад үүний тулд дараах хугацааг тогтоожээ. Үүнд: Нэгдүгээр шатанд (2016-2020) тусгай хамгаалалттай газрын талбайг 25 хувь хүртэл ихэсгэх; хоёрдугаар шатанд (2021-2025) 27 хувь хүртэл, гуравдугаар

шатанд улсын нутаг дэвсгэрийн 30 хувьд хүргэх (2026-2030). Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлалд тусгай хамгаалалттай газрыг дурдахдаа улсын ба орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг ойлгож байгаа ч яг зорилго нь улсын тусгай хамгаалалттай газруудын сүлжээг 2030 он хүртэл 30 хувь болтол өргөжүүлэхэд оршиж байна. Учир нь 2017 оны байдлаар улсын нийт нутаг дэвсгэрийн 29.91 хувь нь улсын ба орон нутгийн тусгай хамгаалалттай газруудад нэгэнт хамрагдсан тул үүнээс өөрөөр ойлгох аргагүй байна.

#### Үнэлгээ

Монгол Улс 1990-ээд оны эхнээс тусгай хамгаалалттай газрын сүлжээг далайцтай хөгжүүлж, засаг захиргааны өөр өөр түвшнүүдэд (төвийн, бүсийн, орон нутгийн) тусгай хамгаалалттай газруудыг байгуулж, 2017 он гэхэд уг сүлжээ нь бараг 47 сая га буюу улсын нийт нутгийн 30 шахам хувийг эзэлсэн байна. Түүнчлэн ТББ ба орон нутгийн олон нийтэд түшиглэсэн тусгай хамгаалалттай газрын менежментийг хэрэгжүүлсэн нь нийт сүлжээг удирдах төрийн зардлыг хэмнэсэн зэрэг олон давуу талтайг дурдууштай. Гэтэл дэлхийд чухал ач холбогдолтой зэрлэг амьтдын олон зүйлийн амьдрах орчин, нүүдлийн замын 70 хувь нь хамгаалалтын гадна орхигдож, тэдгээрийг тусгай хамгаалалтад багтаахаар төлөвлөөгүй байна.

Менежментийн төлөвлөгөө нь одоогийн хууль тогтоомжоор хангалттай зохицуулагдаагүй, уг сүлжээний сул хэсэг хэвээр үлдэж байна. Удирдлагыг хариуцуулах байдал нь ч түвэгтэй, дархан цаазтай газар ба байгалийн цогцолборт газруудыг шууд төр удирддаг, эсвэл ТББ, малчдын бүлгүүдтэй гэрээлдэг, харин улсын байгалийн нөөц газар ба байгалийн дурсгалт газар, тэдгээрийн орон нутгийн захиргаадаас тогтоосон орчны бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын удирдлагыг бүсийн ба орон нутгийн захиргаад өөрийн зардлаар зохион байгуулдаг байна.

Монгол Улс тусгай хамгаалалттай газрын сүлжээгээ тасралтгүй өргөтгөсөөр улсын нийт нутаг дэвсгэрийн 29.91 хүргээд байна. Гэвч тусгай хамгаалалттай газрын сүлжээ нь биологийн олон янз байдлын найдвартай хамгаалал болж чадахгүйн зэрэгцээ чухал экосистемүүдийг орхигдуулсан байна. Цаашлаад зарим тусгай хамгаалалттай газрын хувьд одоогийн бүсчлэл нь зарим чухал байгалийн амьтны амьдрах орчныг дорвитой хамгаалж чадахгүй байна.

#### 11.4 Олон улсын статустай тусгай хамгаалалттай газрууд

##### Биосферийн нөөц газрын дэлхийн сүлжээ

Зургаан газар нутгийг НҮБ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллага болон Биосферийн Хөтөлбөрийн хүрээнд биосферийн нөөц газар гэж зарласан нь биологийн олон янз байдлын хамгааллыг биосферийн нөөц тус бүрийн цөм ба орчны бүс, эргэн тойрны эмжээр бүсэд тогтвортой хөгжил, байгалийн нөөцийн ашиглалттай нийцүүлэн баталгаажуулах зорилготой юм (Хүснэгт 11.4). Биосферийн нөөц газрын МаВ тэмдэглээ нь тухайн газар нутагт үндэсний хууль тогтоомжоор олгосон хамгааллаас өөр нэмэлт хамгааллын статус олгодоггүй байна. Тиймд цөм бүсийн хамгаалалтын эрх зүйн байдал нь биосферийн нөөц газрын статус хүсэх урьдач нөхцөл болно. Ийм шаардлага тавигддаг тул зургаан биосферийн нөөц газрыг дархан цаазтай газрыг түшиглэж байгуулсан байна. Нийтдээ зургаан биосферийн нөөц газрын талбай 16,078,072 га, үүнд нь хамгааллын хамгийн хатуу горим бүхий 2,064,505 га багтдаг бөгөөд нийт талбай нь Монгол орны нутаг дэвсгэрийн 10.28 хувийг эзэлж байна.

#### Хүснэгт 11.4: Биосферийн нөөц газар

Нөөц газар	Байгуулагдсан он	Талбай (га)	Цөм бүс (га)
Их говь	1990	5,300,000	985,000
Богд хаан уул	1996	67,300	41,651
Ус нуурын сав газар	1997	771,700	366,080
Хустайн нуруу	2002	778,000	50,000
Дорнод Монгол	2005	8,429,072	570,374
Монгол дагуур	2007	732,000	51,400
<b>Нийт</b>		<b>16,078,072</b>	

Эх сурвалж: UNESCO, 2017.

Тайлбар: Увс нуурын сав нутаг нь 1998 оноос бас Рамсарын бүс болж, 2003 онд Дэлхийн өвийн бүртгэлд орсон. Монгол-Дагуурын тусгай хамгаалалттай газар нь бас Дагуурын олон улсын тусгай хамгаалалттай газрын нэг хэсэг юм.



*Дэлхийн өв газар*

Одоогоор таван газар нутгийг Дэлхийн соёл, байгалийн өвийг хамгаалах тухай конвенцийн хүрээнд НҮБ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллагын Дэлхийн Өвийн Бүртгэлд оруулсан байна. Тэдгээрт багтах Увс нуурын сав газар (2003 онд бүртгэгдсэн) болон Дагуурын бүс нутаг нь (2017) Оросын Холбооны Улстай хамтарсан хил дамнан Дэлхий өв газар юм. Увс нуурын сав газрын долоон бүрэлдэхүүн хэсэг нь Монголд, таван бүрэлдэхүүн хэсэг нь Орос Улсад байдаг, нийт нутаг дэвсгэр нь 898,064 га (810,234 га буюу 91.2 хувь нь Монголд, 87,830 га буюу 9.8 хувь нь Орос), нэмэлт орчны бүсүүд нь (зөвхөн Оросын талд) 170,790 га байна. Монголын хэсэг нь бас ЮНЕСКО-ын МаВ биосферийн нөөц газрын статустай бөгөөд Монгол-Оросын хил дамнан хамтын тусгай хамгаалалттай газарт багтдаг. Дагуурын бүс нутгийн гурван бүрэлдэхүүн хэсэг нь Монголд, хоёр нь Орос орших ба нийт нутаг дэвсгэр нь 912,624 га (633,541 буюу 69.4 хувь нь Монголд, 279,023 га буюу 30.6 хувь нь Орос), нэмэлт орчны бүс нь 307,317 га юм. Монголын талд Монгол-Дагуурын дархан цаазтай газар, Угтам байгалийн нөөц газар багтдаг.

Монгол улсын 12 газар нутаг урьдчилсан жагсаалтад бүртгэгдсэний дотор Дэлхийн Өвийн байгалийн гэх ангиллын дагуу гурван газар, “холимог” буюу байгалийн ба соёлын өв газар гэдэг ангилалаар нэг газар нутаг бүртгэгджээ. Дээрх гурван газар нутгийн нэг болох Монголын Их Говийн Цөлийн ландшафт (2014 оноос урьдчилсан жагсаалтад байгаа) нь Их Говийн дархан цаазтай газрын А ба Б хэсэг, Бага Говийн дархан цаазтай газрын Б хэсгийг (хамтдаа 6.2 сая шахам га) хамарч байна. Дорнод Монголын Тал хээр нь (2014) Дорнод Монголын дархан цаазтай газар, Тосон Хулстайн байгалийн цогцолборт газар, Баянцагааны тал хээрийн биосферийн нөөц газар, Яхь нуурын биосферийн нөөц газрыг багтаадаг. Монгол Алтайн өндөрлөг нь (2014 онд холимог ангиллаар бүртгэгдсэн) Алтай Таван Богдын байгалийн цогцолборт газар, Сийлхэм Хархираа уулын байгалийн цогцолборт газрын А ба Б хэсгийг хамарч байна. Бас хүсэлт гаргасан бас нэг байгалийн газар нутаг бол “Монгол Говийн Цэрдийн галбын үлэг гүрвэлийн өлгий нутаг” бөгөөд 13 жижиг хэсгээс бүрдэнэ.

*Рамсарын газрын сүлжээ*

Одоогоор Монгол орны 11 газар нутгийг Олон Улсын Ач холбогдолтой ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай Рамсарын конвенцийн хүрээнд Рамсарын бүртгэлд багтсан Олон улсын ач холбогдолтой ус, намгархаг газар болгон тодорхойлжээ (Хүснэгт 11.5). Эдгээр 11 Рамсарын бүс нийтдээ 1,439,530 га талбай эзэлж байна. Эдгээрийн тодорхой хэсэг нь улсын ба орон нутгийн тусгай хамгаалалттай газрын сүлжээнд багтаж хамгаалагддаг.

**Хүснэгт 11.5: Рамсарын газар**

Рамсарын газар, бүс	Он	Хамрах нутаг (га)	ТХН-ын сүлжээний хамрах байдал
Өгий нуур	1997		Хэсэгчлэн (Монгол дагуурын ДЦГ, 4 ОНТХГ)
Тэрхийн цагаан нуурын Үндэсний парк	1998	210,000	Хэсэгчлэн (ОНТХГ)
Нууруудын хөндий	1998	2,510	Бүрэн хамрагдсан (Хорго, Тэрхийн цагаан нуур ҮП)
Айраг нуур	1998		Хэсэгчлэн (2 ОНТХГ)
Хар ус нуухын үндэсний парк	1999	45,600	Хэсэгчлэн (Хяргас нуурын ҮП)
Ачит нуур, түүний эргэн тойрны ус намгархаг газар	1999	45,600	Хэсэгчлэн (ХАр ус нуурын ҮП)
Буйр нуур, түүний эргэн тойрны ус намгархаг газар	2004	321,360	Хэсэгчлэн (Дэвэлийн арал ҮП)
Ганга нуур, түүний эргэн тойрны ус намгархаг газар	2004	73,730	Хэсэгчлэн (2 ОНТХГ)
Ачит нуур, түүний эргэн тойрны ус намгархаг газар	2004	104,000	Хэсэгчлэн (Дарьгангын ҮП)
Хурх-хүйтний голын сав	2004	3,280	Хэсэгчлэн (ОНТХГ)
Увс нуур, түүний эргэн тойрны ус намгархаг газар	2004	42,940	Хэсэгчлэн (Увс нуурын ДЦГ, Тэсийн гол ҮП)
<b>Нийт</b>		<b>1,439,530</b>	

*Эх сурвалж:* Рамсарын Конвенц, 2017; BirdLife Asia. Эдийн засгийн хөгжлийн зэрэгцээ байгалийн амьдрах орчин болсон чухал бүс нутгуудыг хамгаалах. 2009.

*Тайлбар:* Монгол Дагуурын дархан цаазтай газар нь бас биосферийн нөөц газар МаВ бөгөөд Хятад, Оростой хамтарсан гурван талын хил дамнан тусгай хамгаалалттай газар юм. Увс нуур нь бас биосферийн нөөц газар МаВ бөгөөд Оростой хамтарсан хил дамнан тусгай хамгаалалттай газар юм.



*Шувуудын амьдрах биологийн янз байдлын хувьд чухал бүс нутгууд*

Монголын 21 аймгийн 18-д нь 2017 онд шувуудын амьдрах орчин болсон 70 чухал бүс нутгийг тодорхойлсны бараг тэн хагас нь Дорнод (10), Завхан (8), Ховд (7), Хөвсгөл (7) гэсэн дөрвөн аймаг ноогдож байна. Эдгээр бүх 70 бүс нутаг 8,358,313 га (улсын нийт нутгийн 5.3 хувь) талбай хамарч байна. BirdLife Asia байгууллага, Дэлхийн Банкны судалснаар 69 бүс нь дэлхийн хэмжээнд аюул нүүрлэсэн шувуудын зүйлүүдийг хамгаалахад чухал ач холбогдолтой, долоод нь хязгаарлагдмал нутагтай шувууны зүйлүүд амьдардаг байна. Шувуудын амьдрах орчин чухал бүс нутгийн сүлжээний 70 орчим хувь нь (5,858,813 га) улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хүрээнд хамгаалагддаг бол 6.2 хувь нь (519,341 га) орон нутгийн тусгай хамгаалалттай газруудад хамаарч байна. Үлдсэн 23.8 хувь нь (1,980,159 га) тусгай хамгаалалттай газрын сүлжээнд ороогүй байна. Эдгээр үлдсэн газар нутгийн зарим нь Рамсарын бүс, Дэлхий өв газар, биосферийн нөөц газруудад багтсан байна.

*Үнэлгээ*

Монгол Улс Рамсарын газар, бүсүүдийг тодорхойлох, олон улсын хэмжээнд байгалийн өв газруудаа хүлээн зөвшөөрүүлэх чиглэлд идэвхтэй ажиллаж иржээ.

**11.5 Биологийн зүйл, экосистемд учрах дарамт**

Бэлчээрийн эрэлт нэмэгдсэн, эрдэсийн нөөц баялаг олборлох (тусгай зөвшөөрөлтэй болон гар уурхайн аль аль нь) салбар хурдацтай хөгжсөн энэ цаг үед газар нутаг хумигдах нь биологийн олон янз байдалд илэрхий дарамт, аюул занал учруулж байна. Үр дагавар нь бэлчээр, зэрлэг амьтдын амьдрах орчин доройтох, тусгай хамгаалалттай газар, тэдгээрийн сүлжээг өргөжүүлэх горимтой холбоотой мөргөлдөөн үүсч болзошгүй.

Уул уурхай (тусгай зөвшөөрөлтэй болон гар уурхайн аль аль нь) бас ноцтой нэг аюул занал бөгөөд усны хэрэглээ нь нэмэгдсээр, дагалдах дэд бүтэц нь ч биологийн олон янз байдалд сөрөг нөлөө үзүүлнэ. Шугамын дэд бүтэц буюу авто зам, төмөр зам барихад нүүдлийн туурайтан амьтад, жишээ нь хулан, хар сүүлтийн амьдрах орчин хуваагдана. Хашаалсан төмөр зам хилийн торон шугамтай адил нөлөөлж, зэрлэг амьтдын популяцийг хагацуулан хувааж, нүүдэлд нь саад учруулж байна. Замын сүлжээ хөгжсөнөөр алслагдсан бүс нутагт дарамт нэмэгдэж, аялал жуулчлал, ан гөрөө, хулгайн анчид хүрэхэд хялбар болно. Нөгөөтэйгүүр хатуу хучилттай замгүйгээс (ялангуяа өрнөд ба дорнод бүсүүдэд) замаас хяналтгүй гарч сэлгүүцэж зэрлэг амьтдыг үргээх, олон салаа зам үүсгэх зэрэг хор уршигтай. Механикжсан тээврийн хэрэгслээр бэлчээр дундуур туучин олон салаа шинэ замууд үүсгэдэг Монголд л байдаг энэ хорт үзэгдлийн гайгаар 1991-2001 онд 300,000 га бэлчээр доройтож утсан байна.

Бас нэг ноцтой аюул занал нь малын тоо толгой эрчимтэй өсөж, сүргийн бүтэц алдагдсанаар бэлчээрийн даац хэтэрч талхлагдсаны улмаас амьтдын байгалийн амьдрах орчин их хэмжээгээр доройтож, алдагдах явдал юм. Монгол Улсын малын тоо 2015 онд 56.0 сая толгой (24.9 сая толгой хонь, 23.6 сая ямаа, 3.8 сая үхэр, 3.3 сая адуу, 0.4 сая тэмээ) байжээ. Үүнд ямааны эзлэх хувь өндөр байгаа нь (42.1 хувь) Монгол орны уламжлал биш, харин ямааны ноолуурын бүтээгдэхүүний эрэлт өссөнтэй холбоотой бөгөөд ямаа бусад малыг бодвол олон төрлийн ургамал иддэгийн дээр үндсээр нь гэмтээж иддэг төдийгүй хурц туурайгаараа хөрсний дээд давхаргыг гэмтээж, хөрсний эвдрэл, цөлжилтийг эрчимжүүлдэг тул тал хээрийн экосистемд сөрөг нөлөөлж байна.

Уур амьсгалын өөрчлөлт цөлжилт, амьдрах орчны доройтолд хүргэж, туурайтан, мэрэгч, шувууны популяцид хөнөөлтэй ой хээрийн түймрийн давтамжийг нэмэгдүүлэн Монгол орны биологийн олон янз байдалд ноцтой занал учруулж нутгийн болон нүүдлийн зэрлэг амьтад амин чухал усны хомсдол үүсэхэд хүргэн орон нутгийн хүн ба малтай усны төлөө өрсөлдөх тэмцэлд түлхэж байна. Зэрлэг амьтны популяц мөн гантай зуны дараа тохиолддог хатуу өвөл, зуд, тэжээлийн хомсдлын нөлөөлөлд өртөж байна. Зуд нь дотроо хэт хүйтэн (-50°C хүртэл) харын зуд, хэт их цастай цагаан зуд, хүйтэн үе нь сунжирсан хүйтэн зуд, бороо, эсвэл хайлсан цас нь мөстөж, өвсийг бүрхдэг төмөр зуд буюу мөсөн зуд, мал сүргийг хүчтэй салхинд өртүүлдэг шуурган зуд, эдгээрийн хоёроос доошгүй нь хосолсноор хавсарсан зуд гэсэн төрөл хэлбэрүүдтэй байна. Зудын үр дагавар нь амьтад олноороо хүнс тэжээлгүй өлсөж, байгалийн амьтны болон малын тоо толгой эрс хорогддог. Зуд арав орчим жилийн давтамжтай байсан боловч сүүлийн үед давтамж нь нэмэгдэж, сүүлийн гучин жилд дөрвөн жил хүрэхгүй хугацаанд давтагддаг болжээ. Түүнчлэн жил дараалан зуд болох тохиолдол байдаг байна. Тухайлбал 1999-2002 оны зудын улмаас нийт 11 сая толгой мал хорогдсон, 2009/2010 оны зуднаар 8 сая мал хорогдсон (нийт

малын 17 хувь), 2015/2016 оны зуданд 1.1 сая мал хорогджээ. Харин зудны нөлөөгөөр зэрлэг амьтад хэрхэн хорогдсон талаар өгөгдөл мэдээ, тооцоо аль нь ч байхгүй байна.

Цөл, элсэн манханы экосистем нийт нутаг дэвсгэрийн 20.7 хувийг эзэлдэг, үлдсэн 66.56 хувь нь хээрийн экосистемд (өндөр уулын хээрийг оролцуулаад) хамрагддаг улс орны хувьд цөлжилт бас нэг аюул занал билээ. Хур тунадас багассан нь ховор ба устах аюул нүүрлэсэн ургамлын зүйлүүд, ургамалжилтын нөхөн сэргэлтэд сөрөг нөлөөтэй, мал, зэрлэг туурайтны (махчин хөхтөн, шувуудын ан болдог) тэжээлийн нөөцийг бууруулж байна. Гадаргын уст цэгүүд ширгэж, мөнх цас, мөсөн голууд хайлж, намаг хатаж байгаагаас хоёр нутагтан зүйлүүдийн амьдрах орчин устаж байна.

Эрчим хүчний байгууламж, дэд бүтэц хөгжих нь биологийн олон янз байдалд томоохон аюул учруулахгүй байна. Гэхдээ одоо байгаа жижиг далан, усан цахилгаан станцууд загасны зүйлүүдийн урсгал сөрөх нүүдлийг саатуулах, харин салхин цахилгаан станцын сэнснүүд шувуудын популяц дахь хорогдлыг өсгөж болзошгүй.

Ан агнуурыг харьцангуй сайн зохицуулж байгаа хэдий ч тодорхой зүйлүүдийг агнах зөвшөөрөл, агнах тоог тогтоохдоо популяцийн чиг хандлагын талаар мэдээ, мэдээлэлгүй зөвшөөрөл олгож байгаад анхаарах шаардлагатай. Популяциудын хамгийн сүүлчийн үнэлгээ 2010 онд хийгдсэн байдаг. Тиймээс “тусгай зорилготой ан” (албан ёсны нийтэлсэн статистик) гэгчид зориулж гаргасан ховор амьтдын тоон өгөгдөл нь энэхүү тайланд тусгахад ач холбогдол багатайн дээр агнаж болох тоо нь зүйлийн тогтвортой менежментэд нийцдэг эсэхэд үнэлгээ хийх боломжгүй байна. Ер нь зэрлэг амьтад бодитой аюул занал учруулдаг нь амьжиргааны зорилготой ч, өндөр ашигтай худалдааны зорилготой ч хулгайн ан, мөн хавтгай, ирвэс, бөхөн зэрэг устах аюул нүүрлэсэн зүйлүүдийг агнах явдал юм.

Хууль бус мод бэлтгэл, модны худалдаа (тухайлбал түлээ) асуудал дагуулсаар байгаа ч сүүлийн үед орон нутгийн олон нийтэд түшиглэсэн аргачлал (ой ашиглагчдын бүлэгтэй гэрээлэх, тусгай зөвшөөрөл олгох) хэрэглэх болсноор буурч байгаа юм. Хувийн хэрэглээ, орон нутагт худалдах зорилгоор хүнсний, эмийн, анхилам үнэртний зүйлийн ургамал зэрэг модон бус ойн бүтээгдэхүүн түүх нь одоохондоо үндэсний хэмжээний аюул занал болоогүй ч зарим бүс нутагт зарим тодорхой зүйлүүдийг хэт ихээр түүх тохиолдол гарч болзошгүй.

Ихэвчлэн хууль бус алт олборлолт бүхий нутгуудын гол, хөрсний ус, хөрс исэлжиж байгаа ба зохицуулалтгүй мал аж ахуй, малын сэг зэм гадаргын усыг ихээр бохирдуулж байгаа явдлаас акватик системүүд, ялангуяа жижиг нуурууд замагшиж байна. Гол, нууруудын усны бохирдол загас, хоёр нутагтан, мөлхөгчдийн популяцид аюул учруулж байна. Хөдөө аж ахуй, бэлчээрийн менежментэд шавьж, мэрэгчийн хор хэрэглэх нь шувууны популяцид сөргөөр нөлөөлдөг. Байгалийн амьтдын амьдрах орчинд мал нэвтрэх нь ихсэж, малын халдварт өвчин халдахад хүргэж байгаагийн жишээ нь бөхөнгийн популяц хонины тахалд нэрвэгдсэн явдал билээ. Харь инвазив зүйлүүд, генийн өөрчлөлттэй организмуудын нөлөөлөл судлагдаагүй боловч одоохондоо төдийлөн мэдэгдэхүйц нөлөөгүй байна.

Аялал жуулчлал одоохондоо аюул занал учруулаагүй, статистикийн мэдээгээр 2007-2016 онд улсын тусгай хамгаалалттай газруудад аялагчдын тоо 2009 онд 156,510 байснаас 2015 онд 331,583 болсон (дотоодын аялагчид 274,075 буюу 82.7 хувь, гадаадын жуулчид 57,508 буюу 17.3 хувь) байна. Аялал жуулчлалын зам хамгийн алдартай, хүрч очиход хялбар цөөн тусгай хамгаалалттай газруудад чиглэж байдаг ч цөм бүс рүү халдан орох нь ховор байна. Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Хустай нурууны байгалийн цогцолборт газар, Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрууд жуулчдаар дүүрэн байхад бусад тусгай хамгаалалттай газар эл хуль хэвээр байна. Улам бүр нэмэгдэх хатуу хог, муу ус, бас жуулчдын хязгаарлагдмал хэрэглээний дэд бүтэц нь ландшафтдад сөрөг нөлөө үзүүлж байна.

**Фото зураг 11.1: Нумидийн тогоруу***Үнэлгээ*

Монголын байгаль, цаг агаарын нөхцөл нь байгалийн амьтан ургамлын зүйлүүд жил бүр онд орж амьд үлдэхэд нь хангалттай сорилт, бэрхшээл учруулдаг. Эрчимжиж байгаа уур амьсгалын өөрчлөлт нь цөлжилт, зуд гэх зэрэг сөрөг үзэгдлүүдийн цар хүрээ, давтамжийг нэмэгдүүлж байгаа нөхцөлд экосистемийн төрөл зүйл бүхэн тэсэн гарах чадвартай биш юм. Гэхдээ биологийн олон янз байдалд нүүрлэх дийлэнх аюул занал нь хүний нөлөөтэй дарамт, арилжааны болон амьжиргааны зорилготой төрөл бүрийн үйл ажиллагаа (ялангуяа уул уурхай, мал аж ахуй), амралт чөлөөт цагийн зугаа цэнгэл амралтын үйл ажиллагаа (аялал жуулчлал, агнуур), тэр тусмаа хууль бус үйл ажиллагаанаас (хууль бус мод бэлтгэл, гар уурхай, хулгайн ан) үүдэлтэй байна.

**11.6 Эрх зүй, бодлого, бүтэц зохион байгуулалтын тогтолцоо***Хууль эрх зүйн тогтолцоо*

Монгол орон биологийн олон янз байдлыг хамгаалах эрх зүйн орчин бий болгож боловсруулж ирсэн эртний уламжлалтай, 1206 онд Чингис хааны Их Засаг хуульд ан агнуурын эрх зүй, арга ажиллагаа, зэрлэг амьтад, тахилгат газрын хамгааллын харилцааг тодорхой тусгасан байдаг. Засгийн Газар 1972 онд Байгалийн нөөцийг зохистой ашиглах, байгаль орчныг хамгаалах тогтоол гаргаж, 1975 онд Дархан цаазтай газрын журмыг баталсан байна. Социалист гэгдэх цаг үед бүх газар, ой, ус төрийн өмч байсан тул 1975 онд Их Говийн дархан цаазтай газрын А ба Б хэсгийг (5.3 сая га талбай бүхий) байгуулахад нэн дөхөмтэй байжээ.

Тусгай хамгаалалттай газрын тухай 1994 онд гарсан хуульд улсын тусгай хамгаалалттай газрын дөрвөн төрөл хэлбэрийг тодорхойлж, аймаг, сумын удирдлагууд орон нутгийн тусгай хамгаалалттай газар



байгуулах, завсрын бүсийг тодорхойлох эрх зүйн үндсийг бий болгож өгчээ. Тусгай хамгаалалттай газрын тухай хууль дархан цаазтай газар, байгалийн цогцолборт газрыг дотоод үйл ажиллагааны бүсчлэлийг тогтоож, тусгай хамгаалалттай газрын төрөл хэлбэр тус бүрт хамгаалалтын горимыг тодорхойлж өгсөн байна.

Байгаль Орчныг хамгаалах тухай 1995 оны хууль (2012 онд нилээн нэмэлт өөрчлөлт хийгдсэн) байгалийн нөөц, түүний хамгаалалтын ерөнхий удирдамжийг тодорхойлсон. Энэ хуулийн хүрээнд газар, газар дорхи нөөц, ой, ус, амьтад, ургамал, бусад байгалийн нөөц төрийн хамгаалалтад байна. Энэ хуулиар орон нутгийн засаг захиргаад орон нутгийн тусгай хамгаалалттай газруудыг байгуулах эрхийг баталгаажуулсан. Энэ хуульд 2012 онд оруулсан нэмэлт өөрчлөлт, тухайлбал байгалийн нөөцийн хамтарсан удирдлага, түүний дотор орон нутгийн олон нийтэд түшиглэсэн байгалийн нөөцийн удирдлага, малчдын бүлгүүдэд байгалийн нөөцийг тогтвортой ашиглах, байгаль хамгаалах арга хэмжээний үр шимийг хүртэх зэрэг эрх олгосон байна. Энэхүү хуулийн дагуу байгаль орчны судалгаа шинжилгээг төр, орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, төрийн захиргааны байгууллага, засаг дарга нарын хүсэлтээр зөвшөөрөл бүхий холбогдох байгууллага хэрэгжүүлэх, харин иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд өөрсдийн зардлаар судалгаа шинжилгээ хийхийг дэмждэг. Гэхдээ эдгээр заалт хэрэгжихэд ихээхэн сорилт бэрхшээл тулгарч байна.

Газрын тухай хууль 2002 онд шинэчлэгдэж, “тусгай хэрэгцээний газар” гэгч газрын тусгай төрөл ангиллыг бий болгож, түүнийг улсын өмчид байх, хувьд өмчлүүлэхгүй байхаар заажээ. Тусгай хамгаалалттай газар нь дээрх “тусгай хэрэгцээний газрын” дэд ангилал болно. Энэ хуулиар газар ашиглалтын төлөвлөгөө батлах эрх зүйн шаардлагыг тогтоосон. Түүнчлэн газар боловсруулагч, ашиглагчдаас газрын шинж байдал, чанарын доройтлоос урьдчилан сэргийлэх, ой, ховор, нэн ховордсон амьтан, ургамал, түүх, соёлын дурсгал бүхий газрыг хамгаалан хадгалах арга хэмжээ авах үүргийг тогтоожээ.

Байгалийн ургамлын тухай хууль 1995 онд гарсан ба зэрлэг ургамлын (ойн ба таримлаас бусад) хамгаалал, зохистой хэрэглээ, нөхөн сэргээлтийг зохицуулдаг. Энэ хуулиар ургамлын зүйлүүдийг “нэн ховор”, “ховор”, “элбэг” гэж ангилсан нь ховордсон байдал, хамгааллын статус, нөхөн сэргээх үйл ажиллагаанд үндэслэж, хавсралтаар мөхөх аюул нүүрлэсэн “нэн ховор” зүйлүүдийн бүртгэлийг оруулж, тэдгээр зүйлүүдийг хуулийн хамгаалалтад авсан байна. Түүнчлэн байгаль орчны болон экологийн тэнцвэрийг хадгалахад ач холбогдолтой газар нутгуудыг (хот, тосгон, бусад суурин газар; гол, горхи, нуур цөөрмийн эргээс 2 км-ийн доторхи газар, нэн ховор амьтдын нутаг, баян бүрд, ургамлын бүрхэвч доройтсон газар, элсний нүүдлээс хамгаалах ач холбогдолтой газар, хөрсний эвдрэлээс хамгаалах зурвас) тодорхойлж, тэнд ургамлын аливаа зүйлийг ашиглахыг хориглосон байна. Харь инвазив зүйлүүдийн талаар заалтууд орсон хэдий ч төсвийн хомсдлын нөхцөлд харь зүйлүүдийн талаар судалгаа шинжилгээ хийгдэхгүй байгаа тул шаардлагатай мэдээ, мэдээлэл үгүйлэгдсэн хэвээр байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль 2012 онд батлагдсан ба ойн нөөц, зэрлэг ургамал, амьтад (Бүлэг 3) зэрэг байгалийн нөөц ашигласны төлбөр хураамжийн асуудлыг зохицуулж байна.

Тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн тухай 1997 оны хууль тусгай хамгаалалттай газрын орчны бүсийг тогтоох эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Орчны бүс байгуулах нь дархан цаазтай газар, байгалийн цогцолборт газрын хувьд зайлшгүй шаардлага, байгалийн нөөц газар, байгалийн дурсгалт газрын хувьд сайн дураар байгуулж болно, харин орон нутгийн тусгай хамгаалалттай газрын тухайд энэ хууль зохицуулсан заалт тусгаагүй байна. Хуульд орчны бүс байгуулах сайтар боловсруулсан шалгуурууд тусгагдсаны дотор 1994 оны Тусгай хамгаалалттай газрын тухай хуульд байгаагүй экологи, нийгэм эдийн засгийн шалгууруудыг тогтоосон байна. Амьтны аймгийг хамгаалах тухайд экологийн шалгуурын дагуу орчны бүсүүд нэн ховор ба ховор амьтны зүйлүүдийн байгалийн орчныг хамгаалан хадгалах төдийгүй, бас тэдгээрийн бэлчээр, нүүдлийн зам, тухайн үед тухайн газарт тухайн амьтад байхгүй байлаа ч боломжит тархалтын нутгийг нь хамгаалахаар тусгасан нь онцлог юм.

Түүнчлэн Тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн тухай 1997 оны хууль орчны бүсийн удирдлагад орон нутгийн олон нийтийн оролцоог бэхжүүлж, сайн дурын зөвлөх эрхтэй “орчны бүсийн зөвлөл” байгуулах эрх зүйн орчноор хангаж, орон нутгийн засаг дарга, тусгай хамгаалалттай газрын захиргаатай хамтран орчны бүсийн удирдлагын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох эрх олгосон байна. Мөн удирдлагын төлөвлөгөөнд заавал багтах агуулгыг тодорхойлж өгчээ. Бас орчны бүсийн удирдлагад зориулж орчны бүсийн сан байгуулах, тухайлбал төслийн орлогын тодорхой хэсэг, орчны

бүсийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үйлчилгээний орлого, жишээлбэл аялал жуулчлалын хураамж, орон нутгийн оршин суугчдын амьжиргааг дэмжих мэтийн энэхүү санг ашигласан эх үүсвэрүүдээр бүрдүүлэх эрх зүйн орчин бий болгож өгсөн. Тэрчлэн, орчны бүсэд явагдах ашгийн үйл ажиллагаанууд, тухайлбал арилжааны мод бэлтгэл, ан агнуур, ангийн отог байгуулах, эрдэс баялгийн хайгуул, олборлолт, усан сан, далан байгуулах зэрэг үйл ажиллагаанд байгаль орчны нөлөөллийн дэлгэрэнгүй үнэлгээ хийх шаардлагыг тусгасан байна. Энэ хуулийн хүрээнд орчны бүсэд төлөвлөсөн үйл ажиллагаанд тэдгээр журмыг шаардахгүй тул аялал жуулчлалын дэд бүтэц, орон сууцны барилга зэргийг болзошгүй хор нөлөөтэй ашгийн үйл ажиллагааны жагсаалтад оруулаагүй байна.

Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай 2002 оны хуулиар зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн хэрэгжилтийг хариуцсан хоёр тусгай байгууллагыг бий болгосон. Удирдан зохицуулах зөвлөл (байгаль орчин, аж үйлдвэр, худалдаа, хүнс, хөдөө аж ахуй хариуцсан төв засгийн газрын төлөөлөл; гааль, мэргэжлийн хяналтыг хариуцсан төрйн захиргааны байгууллагын төлөөлөл; байгаль орчны ТББ-ын төлөөлөл бүхий) нь конвенцийн хэрэгжилтийг хариуцаж, экспорт, импортын тусгай зөвшөөрөл олгох эрх эдэлнэ. Шинжлэх ухааны зөвлөл нь үнэлгээ хийх, удирдан зохицуулах зөвлөлдөө зөвлөмж өгөх үүрэгтэй.

Эрдэс баялгийн тухай 2006 оны хууль том хэмжээний олборлолт, уул уурхайн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохицуулж, тусгай хэрэгцээний газар нутагт (улсын ба орон нутгийн тусгай хамгаалалттай газрууд хамаарна) эдгээр үйл ажиллагааг хориглодог. Гэхдээ энэ хуулийн одоогийн заалтууд нь тусгай зөвшөөрөл олгох явцад олон нийттэй зөвлөлдөх ажиллагааг сулруулж, ялангуяа нөлөөлөлд нь өртөж болзошгүй хүн амын саналыг авах шаардлагыг хасаж, санал авах хугацааг 30 хоногоор хязгаарлаж, энэ хугацаа дууссаны дараа тусгай зөвшөөрөл аяндаа хүчин төгөлдөр болох нөхцлийг бүрдүүлсэн байдаг. Тэр тусмаа БОАЖЯ уул уурхайн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг баталдаг комиссын бүрэлдэхүүнд ордог бөгөөд энэ шатанд байгаль орчны нөлөөллийн үнэлгээний үр дүнг танилцуулах боломж хомс юм (Бүлэг 1). Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хил хязгаарыг тодорхой үзүүлсэн зураглал тэр бүр байхгүй тул БОАЖЯ олборлолтын бүс нь тусгай хамгаалалттай газартай давхцах тохиолдолд арга хэмжээ авах боломжийг алдагдуулж байна.

Амьтны тухай 2012 оны хууль амьтдыг хамгаалах, зохицуулах, сэргээн нутагшуулах, эзэмших, үржүүлэх, зэрлэг амьтдыг ашиглах асуудлыг зохицуулах, мөн агнах, хавх хаж тавих, ангийн улирал, зөвшөөрөл олгох, экспортлохтой холбоотой харилцааг зохицуулж байна. Уг хуульд амьтныг хамгаалахад чиглэсэн 11 үйл ажиллагааг тодорхойлж, үүнтэй холбоотой үүрэг хариуцлагыг төр, иргэн, орон нутгийн аж ахуйн нэгжүүдэд ногдуулсан байна. Энэхүү хуулиар амьтдын зүйлийг “нэн ховор” ба “ховор” гэж ангилаад, нэн ховор 32 зүйлийн жагсаалтыг оруулсны дотор 22 хөхтөн, 8 шувуу, 2 загасны зүйл багтсан байна. Амьтны тухай 2000 оны хуультай харьцуулахад энэ жагсаалтад багтсан хөхтний зүйлийн тоог эрс нэмэгдсэн, өмнөх хуульд 12 зүйлийг оруулсан байв. Мөн энэ хуулиар ховор зүйлийн амьтдын агнуурын асуудлыг зохицуулсан байна. Уг хуульд харь инвазив зүйлийн тухай заалт тусгагдсан хэдий ч төсвийн хомсдлын нөхцөлд энэ талаар судалгаа хийгдээгүй тул өгөгдөл мэдээлэл үгүйлэгдэж байна.

Тусгай хамгаалалттай газрын тухай хууль, Орчны бүсийн тухай хуулийг дагаж гарсан ба тэдгээрийн хэрэгжилтийг дэмжих олон журам гарчээ. Жишээлбэл, тусгай хамгаалалттай газрууд дахь аялал жуулчлалыг зохицуулах журам (1996/2002), тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн зөвлөлийн тухай (1998), газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай (2000), тусгай хамгаалалттай газар дахь усны нөөц, эрдэст усыг ашиглах тухай (2000), тусгай хамгаалалттай газарт газар ашиглах зөвшөөрөл олгох тухай (2001), тусгай хамгаалалттай газар дахь үйлчилгээний хураамжийн тухай (2002), тусгай хамгаалалттай газар дахь ойн аж ахуйн үйл ажиллагааны тухай (2003), Орон нутгийн олон нийтийн удирдлагатай тусгай хамгаалалттай газрын тухай (2011) журмууд гарсан. 2013 онд Тусгай хамгаалалттай газрын удирдлагын төлөвлөгөө боловсруулах арга зүй, удирдамж, Тусгай хамгаалалттай газрын бизнес төлөвлөгөө боловсруулах удирдамжийг баталсан байна.

#### Тусгай хамгаалалттай газрын тухай хууль тогтоомжийн тойм

Тусгай хамгаалалттай газрын тухай 1994 оны хуульд олон учир дутагдалтай, хоорондоо зөрчилдсөн заалтууд олон байсан байна. Жишээлбэл, улсын хийгээд орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг тодорхойлох шалгуурыг тогтоогоогүй, удирдлагын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх шаардлага тавиагүй, төлөвлөгөөний маягт, бүтэц агуулгын талаар удирдамж, зохицуулалт өгөөгүй, ийм чухал баримт бичгийг боловсруулах, батлах журмыг тодорхойлоогүй байна. Цаашлаад, тусгай хамгаалалттай



газар ба орчны бүсийн удирдлагын төлөвлөгөөний заалтуудыг газар ашиглалтын төлөвлөгөөнд тусгахыг шаардаагүй атал Газрын тухай 2002 оны хуульд газар ашиглалтын төлөвлөгөө боловсруулах шаардлага тавигдсан байдаг. Тусгай хамгаалалттай газруудын хил хязгаарууд, дотоод бүсүүдийн хил хязгаар дээр тодорхой тэмдэглэл тавьж хамгааллын горимуудыг зааглах шаардлага тавиагүй байна. Тусгай хамгаалалттай газрын захиргааны удирдлагын бүтцийг тодорхойлоогүй, гэтэл дархан цаазтай газар ба байгалийн цогцолборт газарт ийм захиргаа байгуулах шаардлага тавигдсан байдаг. Түүнчлэн тусгай хамгаалалттай газрын удирдлагатай холбоотой асуудлаар шийдвэр гаргах эрх мэдлийг төрийн захиргааны төв байгууллага буюу БОАЖЯ-д оногдуулсан атлаа байгалийн нөөц газар ба дурсгалт газрын удирдлагын үүргийг бүсийн ба орон нутгийн удирдлагад (засаг дарга нарт) оногдуулсан байна. Уг хууль аль шатны эрх баригчид тусгай хамгаалалттай газрыг хамгаалалтаас гаргах эрх мэдэлтэй болохыг заагаагүй бөгөөд хамгаалалтаас гаргаж болох эсэхийг тодорхойлоогүй байна. Цаашлаад, уг хууль тусгай хамгаалалттай газрын сүлжээнд албан ёсоор оруулахаар хэлэлцэж байгаа газарт хайгуулын хийгээд уурхайн тусгай зөвшөөрөл олгоход хориг тавих асуудлыг тусгаагүй байна.

Орчны бүсийн тухай хуулийн зөрчилдөөнтэй тал нь засаг дарга нар хуулийн дагуу орчны бүсийн удирдлагын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн тул байгалийн цогцолборт газрын тухайд (орчны бүс нь байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүстэй давхцаж болдог) ийнхүү орон нутагт боловсруулсан төлөвлөгөө нь (хэдийгээр тусгай хамгаалалттай газрын захиргаатай хамтарч боловсруулах боловч) байгалийн цогцолборт газрын зарим хэсгийн удирдлагын төлөвлөгөөнд багтах, орон нутгийн удирдлага өөрийн зардлаар хэрэгжүүлэхээр байна.

Энэ мэт олон орхигдол, дутагдал, зөрчил байгаа учраас Тусгай хамгаалалттай газрын тухай хууль, Орчны бүсийн тухай хуулийг засаж өөрчлөх ажил явагдаж байна. Энэ үйл ажиллагаа арав гаруй жил үргэлжилж, эхний нэмэлт өөрчлөлтийг 2006 онд санал болгож, 2007 онд Олон Улсын Байгаль Хамгаалах Холбоо хянан үзсэний үр дүнд Яам шинэ хянан зассан шинэ хувилбарыг бэлдэхээр болж, дээрх хоёр хуулийг нэгтгэхээр шийдвэрлэсэн байна.

#### Үнэлгээ

Биологийн олон янз байдлын хамгаалах тухай хууль тогтоомж ерөнхийдөө олон талыг хамарсан, олон улсын жишигт нийцэж байна. Байгалийн ургамлын тухай 1995 оны хууль, Амьтны тухай 2012 оны хууль нь биологийн зүйлүүдийг хамгаалахад тусгай боловч амьтан, ургамлын зүйлийг “нэн ховор”, “ховор”, “элбэг” гэх мэтээр ангилдаг уламжлалаасаа салаагүй, тэр нь Олон Улсын Байгаль Хамгаалах Холбооны Улаан номны ангилал, шалгууруудтай тохирохгүй байна. Эрдэс баялгийн тухай хуульд орон нутгийн олон нийттэй зохих ёсоор зөвлөлдөх, БОАЖЯ-аас зохицуулалт хийх асуудлыг орхигдуулсан байна. Тусгай хамгаалалттай газрын тухай 1994 оны хууль олон орхигдол, дутагдалтай бөгөөд улсын ба орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг тодорхойлох, удирдлагын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх харилцааг зохих түвшинд зохицуулаагүй байна. Биологийн олон янз байдлыг хамгаалах, тусгай хамгаалалттай газрыг байгуулах, удирдах үүрэг бүхий төвийн, бүсийн ба орон нутгийн удирдлагуудын харилцаа, үүрэг хариуцлага тодорхойгүй байна. Цаашлаад, улс орны ихээхэн хэмжээний нутаг дэвсгэрийг нэгэнт багтаасан бөгөөд цаашид өргөжиж байгаа тусгай хамгаалалттай газрын сүлжээний удирдлагын төлөвлөгөө боловсруулах ажлыг 2002 оны Газрын тухай хуульд тусгагдсан газар ашиглалтын орон зайн төлөвлөгөөтэй уялдуулаагүй байна.

#### *Бодлогын тогтолцоо*

#### Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (1996)

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрт 17 зорилтыг тодорхойлж, холбогдох үйл ажиллагаануудыг заажээ. Нийт 17 зорилтын 3 нь биологийн олон янз байдлын хамгаалалттай шууд холбоотой байна, үүнд: бүх экосистемийг төлөөлсөн, устах аюул нүүрлэсэн биологийн зүйлүүдийг хамгаалсан иж бүрэн тусгай хамгаалалттай газрын сүлжээ байгуулах, энэ талаар Хятад, Оросын Холбооны Улстай хамтран ажиллах, ан ба загачлалд хяналт тавих, биологийн зүйлүүдийн хамгаалал, генийн нөөцийг хадгалах чиглэлээр удирдлагыг боловсронгуй болгох зэрэг зорилтууд тусгагдсан. Нэг зорилт нь биологийн олон янз байдал, нүүрлэх аюул заналын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн, бас нэг зорилт нь биологийн олон янз байдлын үндэсний хэмжээний мэдээлэл, хяналт шинжилгээний тогтолцоо бүрдүүлэхэд чиглэсэн байна. 2010 онд хийсэн үнэлгээний дүгнэлтэд “зорилтын 96 хувь нь биелсэн тул бүрэн хэрэгжсэн гэж үзнэ” гэсэн боловч энэ хөтөлбөрийн хэд хэдэн зорилт нь 2015-2025 оны Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрт дахиад ороод ирсэн байна.

### Тусгай хамгаалалттай газрын үндэсний хөтөлбөр (1998)

Тусгай хамгаалалттай газрын үндэсний хөтөлбөр нь (Биологийн олон янз байдлын тухай конвенцийн (CBD) Тусгай хамгаалалттай газрын талаарх үйл ажиллагааны хөтөлбөртэй холбоотой) экологийн төлөөлөл бүхий тусгай хамгаалалттай газрын сүлжээ бий болгох, үүндээ 2015 он гэхэд Монгол орны 30 хувийг хамруулах, тусгай хамгаалалттай газрын удирдлагын үр дүнтэй байдлыг сайжруулах асуудал тусгагдсан байна. Түүнчлэн тусгай хамгаалалттай газар, тэдгээрийн орчны бүсийн хамгааллыг орон нутгийн төлөвлөлт, хамгаалалтын үйл ажиллагаанд тусгах зорилт дэвшүүлжээ. Мөн тусгай хамгаалалттай газрын судалгаа шинжилгээний үр дүн, мэдээ, мэдээллийг нэгдсэн санд хуримтлуулах; улсын тусгай хамгаалалттай газрын мониторинг хяналт шинжилгээний сүлжээ бий болгох; тусгай хамгаалалттай газрын удирдлагын төлөвлөгөө боловсруулах шаардлага, хэрэгжилтэд орон нутгийн олон нийтийг оролцуулах тухай заасан. Засгийн Газар 1999 онд Тусгай хамгаалалттай газар нутгийн 1998-2005 оны хэрэгжилтийн үйл ажиллагааны төлөвлөгөө баталсан байна.

### Биологийн олон янз байдлын 2015-2025 онуудад хэрэгжих үндэсний хөтөлбөр

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр нь Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Биологийн олон янз байдлын стратеги төлөвлөгөө 2011-2020, Аичигийн Биологийн олон янз байдлын зорилтуудын (2014 онд талуудын 12-р бага хурлаар баталсан)-дтай уялдуулан боловсруулж, дөрвөн стратегийн хүрээнд 14 зорилтыг тодорхойлжээ (холбогдох арга хэмжээ, 74 үр дүн бүхий). Үүнд:

- Стратеги 1: Биологийн олон янз байдлын хамгаалах талаар мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, шийдвэр гаргагчид болон олон нийтийн дунд тогтвортой эзэмшүүлэх;
- Стратеги 2: Биологийн нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах талаар шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Стратеги 3: Биологийн олон янз байдлыг тогтвортой ашиглах;
- Стратеги 4: байгаль орчныг хамгаалах, биологийн олон янз байдлыг ашиглах, экологийн үйлчилгээнд чиглэсэн эрх зүй, бодлогын орчныг боловсронгуй болгох.

Хөтөлбөрийн 14 зорилгын гурав нь биологийн олон янз байдлыг хамгаалахад шууд холбогдож байна. Зорилго 4 нь амьтан, ургамлын устах аюул нүүрлэсэн зүйлүүдийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэхтэй холбоотой. Хөтөлбөрт тусгай хамгаалалттай газрын сүлжээг 30 хувь хүртэл өргөтгөх асуудлыг давтан тусгаагүй байна. Түүний оронд, Зорилго 5 нь “гол экосистемүүдийн наанадаж 30 хувь, бүх уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг экосистемүүдийг” үндэсний тусгай хамгаалалттай газрын сүлжээнд хамруулах, удирдлагыг зохицуулалтыг сайжруулахад чиглэсэн байна. Зорилго 7 нь ойн бүхэвчийг 2025 он гэхэд 9 хувь хүргэх, үүний тулд ойн менежментийг боловсронгуй болгох, ингэснээрээ биологийн олон янз байдлыг хамгаалахаар тусгасан байна.

Зорилго 9 нь бэлчээр талхлагдал, доройтлыг бууруулах, урьдчилан сэргийлэх (энэ нь зэрлэг амьтдын амьдрах орчинд ноцтой нөлөөлдөг), Зорилго 10 нь байгаль орчны нөлөөллийн дэлгэрэнгүй үнэлгээ хийх, ингэснээр биологийн олон янз байдалд ач холбогдол бүхий газрыг уул уурхай, хөдөө аж ахуйн хэрэглээнээс чөлөөлөх, хамгаалалтад авахаар тусгажээ. Зорилго 8 нь ангийн нөөцийн удирдлагыг орон нутгийн нөхөрлөл, хувийн аж ахуйн нэгжүүдэд шилжүүлэх, ангийн болон байгалийн ургамлын экскортод гаалийн татвар ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх тухай байна. Зорилго 2 нь Үндэсний Байгаль орчны мэдээллийн сангийн агуулга, хүртээмжийг сайжруулах замаар биологийн олон янз байдлын дэд мэдээллийн сан байгуулахаар тусгажээ (Биологийн олон янз байдлыг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөний Үйл ажиллагаа 3.2.5-тай төстэй).

Хөтөлбөрийн дунд хугацааны хэрэгжилтийг 2020 онд хангахаар төлөвлөсөн байна. Гэхдээ одоо байгаа санхүүжилтийн хэмжээ Хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэхэд хүрэхгүй байж мэдэх талаар ихээхэн зовнил байдаг. Тооцоолсноор, Хөтөлбөр хэрэгжүүлэхэд (2017 – 2021 онд) 123.9 саяам. Доллар шаардлагатай (үүний 64 хувь нь ойн бүрхэвчийг нэмэгдүүлэх, тусгай хамгаалалттай газрын сүлжээг өргөжүүлэх, хөрс, усны нөөцийн бохирдлоос урьдчилан сэргийлэх гэсэн гурван гол зорилтыг хангахад шаардлагатай), харин улсын төстөөс 40.4 сая ам. доллар шаардлагатай байгаа бөгөөд долоон байгууллага төлөвлөсөн 26 төсөлд 38.4 сая ам.полларыг хандивлах төлөвтэй байна. Тиймээс Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн хомсдол зөвхөн 2017-2021 онуудад 45.2 сая ам.доллар байхаар байна.

## Бусад

Аргаль хонь, халиун буга, идлэг шонхор, ирвэс, бөхөн, тул, мазаалайг хамгаалах гэхчилэн ховор ба устгах аюул нүүрлэсэн амьтан, ургамлын зүйлүүдийг хамгаалахад чиглэгдсэн үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөнүүд батлагдан хэрэгжиж байна.


## Үнэлгээ

Биологийн олон янз байдлыг хамгаалан хадгалах бодлогын орчин багц шинжтэй бөгөөд Биологийн олон янз байдлын тухай конвенцийн заалтууд, дэлхий дахинаа батлагдсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх Монгол Улсын хүсэл эрмэлзийг тусгасан олон стратегийн баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс бүрдэж байна. Гэхдээ амьдралд хэрэгжих явцад санхүүгийн хомсдол саад болдог тул эдгээр баримт бичиг хэрэгжих үндэслэл төгс биш, ялангуяа одоогийн чадавхийг тооцолгүй олон зоригтой санаачилгуудын урт жагсаалт агуулсан стратегийн баримт бичгүүд бий болж, тэдгээрийн зарим нь сайтар гаргалгаатай мөрөөдлийн жагсаалт мэт төсөөлөгдөнө. Биологийн олон янз байдлын 1996 оны Үндэсний хөтөлбөрийн хэд хэдэн чухал зорилт 2017 он хүртэл биелээгүй хэвээр байна.

Тиймээс биологийн зүйлүүдийн популяц хурдацтай доройтож, экосистемд нүүрлэх дарамт, аюул занал нэмэгдэж байгаа нөхцөлд одоогийн Биологийн олон янз байдлын 2015-2025 онуудад хэрэгжих хөтөлбөрийн хоёр зорилгыг дорвитой хэрэгжүүлэх нь Монгол Улсын хувьд практик ач холбогдолтой байх билээ. Эдгээр нь: Зорилго 4 нь ховор ба устгах аюулд өртсөн амьтан, ургамлын зүйлүүдийг хамгаалах үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх; Зорилго 5 нь гол экосистемүүдийг үндэсний тусгай хамгаалалттай газрын сүлжээнд багтаахад чиглэгдсэн байна.

*Энэхүү бүлэгтэй холбоотой Тогтвортой Хөгжлийн Зорилт, Зорилгууд*

ТХЗ-ын Зорилго 15-ын Монгол улсын одоогийн хүрсэн түвшин, төлөв байдлыг Шигтгээ 11.1-д үзүүлэв.



**Шигтгээ 11.1: Тогтвортой хөгжлийн 2030 хүртэлх хөтөлбөрийн Зорилго 15-ын зарим Зорилтууд**

**Зорилго 15. Хуурай газрын экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглалтыг дэмжих, ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх, цөлжилттэй тэмцэх, газрын доройтол, биологийн олон янз байдлын алдагдлыг тавин хувиар зогсоох, нөхөн сэргээх**

Ерөнхийдөө Зорилт 15.1 ба 15.5, тэдгээрийн холбогдох шалгуур үзүүлэлтүүдийн дагуу Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн хүрээнд зохих үйл ажиллагаа хэрэгжүүлж байна (Хөтөлбөрийн Зорилго 5 нь экосистемүүдийг тусгай хамгаалалттай газрын сүлжээнд шаардлагатай түвшинд хамруулах тухай, Зорилго 4 нь ховор ба ховордсон амьтан ургамлын зүйлүүдийг хамгаалах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх тухай). Гэхдээ, ТХЗ 15-ыг хэрэгжүүлэх, Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр 2015-2025-ын түүнтэй уялдаатай зорилгуудыг хэрэгжүүлэх нь санхүүгийн болон хүний нөөцийн чадавхийн хомсдлын шалтгаанаар бэрхшээлтэй байна. Монгол Улс гадаадын санхүү, техникийн туслалцаагүйгээр Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ТХЗ-15-ын төлөвлөгөөт үзүүлэлтүүдийг хангах боломжгүй байна.

**Зорилт 15.1: Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу 2020 он хүртэл хуурай газрын цэнгэг усны экосистем, тэдгээрийн үйлчилгээ, тухайлбал ой, намаг, уул, хуурай бүсийн хамгаалалт, нөхөн сэргээлт, тогтвортой ашиглалтыг хангах.**

Хуурай газрын болон цэнгэг усны биологийн олон янз байдалд чухал ач холбогдолтой газар нутгийн эзлэх хувийг Монгол орны 19 байгалийн экосистем бүрээр тооцоолж, үнэлгээ хийсэн байна (шалгуур үзүүлэлт 15.1.2). эдгээрийн харьцаа нь 2010 онд (шалгуур үзүүлэлтийн утгын буурах дарааллаар): мөнх цас, мөсөн гол 79.39, нуур 79.02, хэт хуурай цөл 74.18, тагийн тундра 40.73, тагийн нуга 34.80, сэрүүн бүсийн шилмүүст ой 31.42, жинхэнэ тундра 27.25, ширгэдэг гол, саарь 26.67, тагийн бэлийн ой 15.62, олон наст гол, голын хөндий 13.94, хагас цөл 13.91, элсэн манхан 13.08, өндөр уулын хээр 11.14, сэрүүн бүсийн өвөр холимог ой 9.96, битүү хотгор, хужирт эрэг 9.03, нуга хээр 7.62, цөлөрхөг хээр 6.59, хуурайвтар хээр 5.39, хуурай хээр 4.24 байна. Ийнхүү сүүлийн дөрвөн хээрийн экосистем хамтдаа улс орны 55.42 хувийг эзэлдэг, Монгол оронд хамгийн түгээмэл атал 2010 оны байдлаар тусгай хамгаалалттай газрын сүлжээнд хамгийн бага хамрагдсан байна. Гэхдээ Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр 2015-2020-ийн дагуу бүх экосистемийн төлөөллийг тусгай хамгаалалттай газрын тогтолцоонд багтаах Зорилго 5-ын хүрээнд хэрэгжүүлэх шаардлага хэвээр үлдэж байна.

**Зорилт 15.4: 2030 он хүртэл уулын экосистем, түүний биологийн олон янз байдлын хамгааллыг хангаж, тогтвортой хөгжилд шаардлагатай үр шимийг нь дээшлүүлэх**

Монгол орон далайн түвшнээс өндөр өргөгдсөн (дунджаар 1,580 м), уул нурууд нутгийн ихээхэн хэсгийг хамардаг. Уулын биологийн олон янз байдалд чухал ач холбогдолтой бүс нутгуудыг тодорхойлсон үнэлгээ огт хийгдээгүй тул шалгуур үзүүлэлт 15.4.1-ийг (уулын биологийн олон янз байдалд чухал ач холбогдолтой газруудыг тусгай хамгаалалттай газрын сүлжээнд хамруулсан байдал) тооцох боломжгүй байна. Уулын экосистемийн дийлэнх хэсэг, тухайлбал тагийн бэлийн ой, өндөр уулын хээр, сэрүүн бүсийн өвөр холимог ой 2010 оны байдлаар тусгай хамгаалалттай газруудын гадна орхигдсон хэвээр үлдсэн тул тусгай хамгаалалттай газрын сүлжээг өргөжүүлэх төлөвлөгөөндөө үүнийг анхаарах шаардлагатай. Түүнчлэн, Монгол Алтай, Говь-Алтай зэрэг Монгол орны өрнөдөд чиглэсэн нурууд хээр, цөлөрхөг хээрийн экосистемийг агуулдаг бөгөөд уулын ховордсон биологийн зүйлүүдийн амьдрах чухал орчин байдаг.

Уулын ногоон бүрхэвчийн индексийн утга (Шалгуур үзүүлэлт 15.4.2) Монгол Алтай ба Говь-Алтайн нуруудад илүү ойгүйжсэн, Алтайн нурууны өрнөд зах сэжүүр, Хангай, Хэнтийн нурууныхаас ихээхэн ялгаатай байх нь ойлгомжтой юм. Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн Зорилт 7 нь ойн бүрхэвчийг 2025 он хүртэл 9 хувь хүртэл нэмэгдүүлэх тухай заасан тул энэ нь улс орны уулын ногоон бүрхэвчийн индексд нөлөөлнө гэж үзжээ.

**Зорилт 15.5: Байгалийн амьдрах орчны доройтлыг сааруулах яаралтай бөгөөд дорвитой арга хэмжээ авах, биологийн олон янз байдлын алдагдлыг зогсоох, 2020 он хүртэл ховордсон зүйлүүдийг хамгаалж, мөхөж устхаас урьдчилан сэргийлэх**

Биологийн зүйлүүд дэх мөхөж устгах эрсдлийн өөрчлөлтийг нэгтгэсэн Олон Улсын Байгаль Хамгаалах Холбоо (ОУБХХ)-ны Улаан номын индексийг (шалгуур үзүүлэлт 15.5.1) Монголын хувьд тооцоолох боломжгүй байна. Тус улсад ОУБХХ-ын арга зүйн дагуу үнэлгээг зөвхөн 2006 онд хөхтөн, загас, мөлхөгч, хоёр нутагтанд, 2011 онд шувуу ба нэн ховор ургамлын зүйлүүдэд хийгдсэн ба дээрх индексийг тооцоолоход тухайн бүлэг дэх бүх зүйлүүдийн хувьд наанадаж хоёр удаа үнэлгээ хийсэн байх шаардлагатай байдаг. Тиймээс Улаан номын индексийг тооцоход ОУБХХ-ын шалгуурын дагуу үндэсний улаан номын дараагийн редакцийг гаргах хэрэгтэй байна.

Ихэнх биологийн зүйлийн одоогийн төлөв байдал судалгаа шинжилгээний ажил зогсож, 2010 он хүртэл үндэсний хэмжээнд тогтмол явагдаж байсан зэрлэг амьтдын тооллого хийгдэхээ больсны улмаас асуудал тодорхойгүй болоод байна. Гэхдээ ямар зүйлүүдэд яаралтай онц анхаарал хандуулах шаардлагатай нь илэрхий ойлгомжтой юм.

Олон Улсын Байгаль Хамгаалах Холбооны дэлхий даяар хийсэн үнэлгээгээр Монголын унаган 41 амьтны зүйлийг (11 хөхтөн, 25 шувуу, 2 загас, 3 сээр нуруугүй амьтны зүйлүүд) 2017 онд дэлхий даяар устах аюулд нүүрлэсэн гэж үзсэн байна. Улаан номын сүүлийн редакцид 110 гуурст ургамал, 11 загас, 2 мөлхөгч, 4 хоёр нутагтан, 20 шувуу, 21 хөхтөн амьтны зүйлүүдийг Монголд бүсийн хэмжээнд аюулд өртсөн гэж үзсэн. Тиймээс юуны өмнө эдгээр зүйлүүдэд хэрийн эрдэм шинжилгээний судалгаа, биологийн олон янз байдлын хяналт шинжилгээг чиглүүлж, Улаан номд шинэчилсэн мэдээлэл оруулах, биологийн зүйлүүдийг хамгаалах үндэсний хөтөлбөрүүд боловсруулахад туслах хэрэгтэй байна.

**Зорилт 15.7: Хулгайн ан, хамгаалагдсан ургамал, амьтны зүйлүүдийг хууль бусаар хил давуулан худалдаалах явдлыг энцэ болгох чиглэлээр яаралтай арга хэмжээ авах, зэрлэг ургамал амьтны бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийг нь хазаарлах**

Байгалийн ургамал, амьтдын одоогийн популяцийн хэмжээний мэдээ мэдээлэл хомс байгаа тул шалгуур үзүүлэлт 15.7.1-ийг (хулгайгаар агнагдсан, хууль бусаар хил даван наймаалагдсан байгалийн амьтны эзлэх хувь) тооцоолох боломжгүй байна. Хэдий тийм боловч Монгол Улсын Засгийн Газар байгалийн амьтны бүтээгдэхүүний хууль бус нийлүүлэлтийг цаашлан бууруулах, хууль тогтоомжийг чангатгах замаар хулгайн анг таслан зогсоох, ялангуяа байгаль хамгаалагчдын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх, орчин үеийн холбоо, навигацийн тоног төхөөрөмж, туулах чадвартай механикжсан тээврийн хэрэгслээр хангах боломж бий. Цаашлаад, хилийн боомтууд дээр гаалийн хяналтыг сайжруулснаар байгалийн амьтан, ургамлын хууль бус худалдааг улмаар багасгаж болно.

**Зорилт 15.8: 2020 он хүртэл хуурай газрын ба усны экосистемд харь инвазив биологийн зүйлүүд нэвтрүүлэхээ урьдчилан сэргийлэх, тэдгээрийн нөлөөллийг дорвитой бууруулах, гол нөлөөтэй харь зүйлүүдэд хяналт тавих буюу устгах арга хэмжээ хэрэгжүүлэх**

Шалгуур үзүүлэлт 15.8.1-ийн (харь инвазив биологийн зүйлээс урьдчилан сэргийлэх, хянахад чиглэсэн үндэсний хууль баталж, хангалттай санхүүжилт хуваарилсан улсуудын эзлэх хувь) чиглэлээр Монгол Улс хэд хэдэн хууль тогтоомж баталсан; харь биологийн зүйлийн тухай заалтууд 1995 оны Ургамлын тухай хууль, 2012 оны Амьтны тухай хуульд орсон байдаг. Харин тэдгээрийн хэрэгжилт харь биологийн зүйлийн импортын суваг, тархалтын тухай мэдээлэлгүй, мөн судалгаа шинжилгээ явуулах төсвийн хомсдлын шалтгаанаар удаашралттай байна. Тиймээс шалгуур үзүүлэлт 15.8.1 хэрэгжээгүй байна.

**Зорилт 15.9: 2020 он хүртэл экосистем, биологийн олон янз байдлын үнэт зүйлсийг үндэсний болон орон нутгийн төлөвлөлт, хөгжлийн үйл явц, ядуурлыг бууруулах стратеги, сангуудад тусгах**

Шалгуур үзүүлэлт 15.9.1 нь Биологийн олон янз байдлын 2011-2020 оны Стратеги төлөвлөгөөний Личигийн Биологийн олон янз байдлын Зорилт 2-ын дагуу үндэсний зорилтот үзүүлэлтийг хэрэгжүүлэх чиглэлд ахиц гарсан. Байгаль орчны стратеги үнэлгээний механизм амьдралд хэрэглэдэггүй тул тусгай хамгаалалттай газрын удирдлагын төлөвлөгөөг орон нутгийн газар ашиглалтын төлөвлөгөөтэй уялдуулах механизм байхгүй байна (Бүлэг 1).

**Зорилт 15.а: Биологийн олон янз байдал, экосистемийг хамгаалах, тогтвортой ашиглахад шаардлагатай бүх санхүүгийн эх үүсвэрийг дайчилж, дорвитой нэмэгдүүлэх**

Дэлхий нийтээрээ санал нийлсэн Шалгуур үзүүлэлт 15.а.1 нь биологийн олон янз байдал, экосистемийг хамгаалах, тогтвортой ашиглахад шаардлагатай Хөгжлийн албан ёсны тусламж, төрийн зардлыг тусгасан байна. Гэтэл Монгол улсын биологийн олон янз байдал, экосистемийг хамгаалах, тогтвортой ашиглалтыг хангахад шаардлагатай төрийн санхүүжилт сүүлийн үед багассан нь 2015-2020 оны Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг сааруулж болзошгүй. Тиймээс олон улсын санхүүгийн дэмжлэгийг дайчлах гарцаагүй шаардлагатай байна.

**Зорилт 15.с: Хулгайн ан, дархан цаазтай биологийн зүйлүүдийг хууль бусаар хил давуулан худалдаалахтай тэмцэхэд дэлхий нийтийн дэмжлэгийг нэмэгдүүлэх, тухайлбал орон нутгийн хүн амын тогтвортой амьжиргааны чадавхийг бэхжүүлэх**

Зорилт 15.с-ийн явцыг дэлхий нийтээр зөвшөөрсөн Шалгуур үзүүлэлт 15.с.1-ээр (хулгайгаар агнасан, хууль бусаар хил давуулсан байгалийн ургамал, амьтны эзлэх хувь) хэмжигдэх ба мөн Зорилго 15.7-ийн хүрээнд үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг шаардана. Монгол Улс орон нутгийн хүн амын тогтвортой амьжиргаагаа залгуулах чадавхийг бэхжүүлэх талаар ихээхэн ахиц дэвшил гаргасан, чингэхдээ орон нутгийн олон нийтэд түшиглэсэн тусгай хамгаалалттай газрын удирдлага, ойн менежментийн аргачлалыг хэрэгжүүлсэн нь хулгайн ан, мод бэлтгэл зэрэг хууль бус үйл ажиллагааг дорвитой бууруулах шаардлагатай.

*Бүтэц зохион байгуулалтын тогтолцоо*

Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам

БОАЖЯ нь байгаль орчин, байгаль хамгаалал, ногоон хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага юм. Яамны үүрэгт тусгай хамгаалалттай газрын удирдлага, ус, ойн нөөц, ангнуурыг зохицуулах, биологийн олон янз байдлыг хамгаалах, хяналт шинжилгээ хийх болон бусад олон ажил үүрэг хамаардаг. Тус яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар болон Тусгай



хамгаалалттай газрын удирдлагын газар нь биологийн олон янз байдал, тусгай хамгаалалттай газрын удирдлагыг зохион байгуулах чиг үүрэгтэй.

Тусгай хамгаалалттай газрын удирдлагын газар нь нийт тусгай хамгаалалттай газрын сүлжээний удирдлага, зохицуулалтыг хариуцдаг. Тус газар 2017 онд орон тооны долоон ажилтантай, үүнд газрын дарга, хоёр ахлах ажилтан (нэг нь тусгай хамгаалалттай газрын удирдлагаар, нөгөө нь газар ашиглалтаар), дөрвөн ажилтны нэг нь тусгай хамгаалалттай газрын бүсчлэл, орчны бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын удирдлага зохицуулалтыг хариуцсан; нэг нь аялал жуулчлал, сургалт, ухуулга сурталчилгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан; нэг нь судалгаа шинжилгээ, мэдээ мэдээлэл хариуцсан; дөрөв дэх ажилтан нь олон улсын хамтын ажиллагаа, эрх зүйн асуудлыг хариуцаж байна.

Тусгай хамгаалалттай газрын удирдлагын газар нь тусгай хамгаалалттай газрын төлөвлөлт, удирдлагын талаар бодлого, эрх зүй, техникийн удирдамжаар хангах, бүс нутгийн 33 тусгай хамгаалалттай газрын захиргааны үйл ажиллагааг хянан зохицуулдаг. Тэдгээр захиргаад нь улсын нэг буюу хэд хэдэн тусгай хамгаалалттай газрыг (дархан цаазтай газар, байгалийн цогцолборт газар) удирдан зохицуулах үүрэгтэй. Бүсийн тусгай хамгаалалттай газрууд нь бүгд зохион байгуулалтын нийтлэг бүтэцтэй, тусгай хамгаалалттай газрын дарга, захиргааны мэргэжилтнүүд, байгаль хамгаалагчид, техникийн бус туслах ажилтнуудтай байдаг. Тусгай хамгаалалттай газрын хариуцлагатай ажилтнууды тоо нь тухайн газар нутгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээ, газар нутгийн онцлогоос шалтгаалдаг. Тусгай хамгаалалттай 33 газрын ажилтнуудын нийт тоо (ТББ-ын удирддаг гурван захиргааг оруулаад) 2017 онд 607 ажилтан (үүнд 337 байгаль хамгаалагч багтана) байгаа бол 2013-2014 онд 625 байжээ. Байгаль хамгаалагчид нь эргүүл, ажиглалт хийх хууль сахиулах, байгалийн ажиглалтаа тэмдэглэх үүрэгтэй. Засгийн Газрын 2009 оны 87-р тогтоолын дагуу хамгаалах талбай нь тухайн нутгийн топографаас хамаарах ба нэг байгаль хамгаалагчид ногдох эргүүлийн тойрог нь уулархаг нутагт 40,000 га, өндөр ууланд 50,000 га, говь нутагт 200,000 га байна.

Тусгай хамгаалалттай газрын удирдлагын газар ба 33 тусгай хамгаалалттай газрын захиргааны хүний нөөцийн хийгээд техникийн чадавхи маш хязгаарлагдмал юм. Одоогийн нөхцөл байдалд 52 тусгай хамгаалалттай газрын удирдлагад нэмэлт 80 байгаль хамгаалагч хэрэгтэй гэсэн тооцоо байна. Гэтэл залуу, бие бялдар сайтай байгаль хамгаалагчид байгаль хамгаалах салбарын ажлаас гарсаар байна.

Төсвийн хүндрэл улсын санхүүжилттэй тусгай хамгаалалттай газрын захиргаадад түгээмэл бөгөөд аялал жуулчлалын гол нутгууд гэж үздэг тусгай хамгаалалттай газрын захиргаад ч нэвтрэх хураамжийн орлогоо хадгалж, ашиглаж чадахгүй байна. Тэр тусмаа БОАЖЯ-ны төсөв сүүлийн жилүүдэд буурч 2017 оны төсөв нь төгрөгөөр тооцоход 2011 оны төсвийн дөнгөж 52 хувьтай тэнцэж байна (ам. долларт шилжүүлбэл 30.4 хувь л болно). Тусгай хамгаалалттай газрын сүлжээний зардал ердөө 3 хувь бөгөөд дийлэнх хэсэг (80-90 хувь) нь ажилтнуудын цалин, урсгал зардалд зарцуулагдаж, газар дээр байгаль хамгаалах үйл ажиллагаанд маш бага зардал үлддэг байна. Байгаль орчныг хамгаалах сангаас (Бүлэг 3, Байгаль орчин, уур амьсгалын сан) биологийн олон янз байдлыг хамгаалах үндэсний олон хөтөлбөрт олгодог санхүүжилт багассан, жишээлбэл тусгай хамгаалалттай газарт хуваарилдаг 2016 оны санхүүжилт 2014 оны санхүүжилтийн 69.4 хувь, байгалийн ургамал хамгаалах санхүүжилт 14.4 хувь, ховор, нэн ховор биологийн зүйлийн хамгаалалтын санхүүжилт 58.7 хувь байна (Хүснэгт 3.14).

Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн бүтэцэд биологийн олон янз байдл, тусгай хамгаалалттай газрын мэдээллийн сан бүхий Байгаль орчны мэдээллийн төв ажиллаж байна.

#### Бусад яамд

Барилга хот байгуулалтын яам нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраараа дамжуулан газар ашиглалтын төлөвлөлтийг хянан зохицуулдаг байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хөдөө аж ахуйн хөгжил, бэлчээр, мал аж ахуйн асуудлыг хариуцана.

Уул уурхай хүнд үйлдвэрийн яам эрдэс баялаг олборлолт, тусгай зөвшөөрлийн асуудлыг эрхэлдэг байна.



### Орон нутгийн түвшинд

Аймаг сумдын засаг дарга нар улсын байгалийн нөөц газар, дурсгалт газар, орон нутгийн тусгай хамгаалалттай газар, тэдгээрийн орчны бүсийн удирдлага зохицуулалтыг хариуцана. Бусад чухал оролцогчид нь орон нутгийн олон нийт, олон нийтэд түшиглэсэн байгууллагууд, үндэсний ба орон нутгийн 500 гаруй ТББ-ууд байна.

Байгалийн нөөц газар, дурсгалт газрууд нь улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээнд багтдаг атал тэдгээрийн удирдлагыг улсын төсвөөс санхүүжүүлдэггүй. Аймаг, сумын төсөв улсын санхүүжилттэй тусгай хамгаалалттай газрын захиргаа шиг чадавхи бүхий удирдлагын бүтэц байгуулж ажиллуулах, мэргэжилтэй ажилтан хангалттай тоогоор авч ажиллуулахад хүрэлцэхгүй, байгаль хамгаалах идэвхтэй үйл ажиллагаа явуулахад маш хангалтгүй байдаг байна. Тиймээс орон нутгийн тусгай хамгаалалттай газар, орчны бүсүүдийн удирдлагыг гэрээлэх, орон нутгийн олон нийтийн байгууллага, малчдын бүлэг, байгаль орчны ТББ-уудад (эдгээр нь гадаад санхүүжилтээс хамааралтай байх нь их) шилжүүлэх болдог. Үүний улмаас орон нутгийн тусгай хамгаалалттай газруудыг байгаль хамгааллын үр нөлөө багатай, зөвхөн газрын зурагт л харагддаг цаасан дээрх байгууллага гэж шүүмжлэх нь их байна. Түүнчлэн цөөн тохиолдлоос бусдад эдгээр тусгай хамгаалалттай газар дархан цаазтай газар, байгалийн цогцолборт газраас (ялангуяа Рамсарын бүс нутаг, шувуудын амьдрах орчны чухал бүс нутаг, ЮНЕСКО-ийн биосферийн нөөц газар, Дэлхийн өв газар зэрэг олон улсын статустай газрууд) хавьгүй бага анхаарагдаж, дэмжигддэг атал одоогийн улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээнд дутуу багтсан экосистем, биологийн төрөл зүйлүүдийн нутгийг хамарсан байдаг.

### Үнэлгээ

Одоогийн бүтэц зохион байгуулалт, төв, аймаг, сумдын захиргаадын үүрэг хариуцлагын хуваарилалт, хүний нөөц, техник, үйл ажиллагаа, санхүүгийн чадавхи нь бодлогын баримт бичигт тусгасан чиг үүрэгтэй харьцуулахад хангалтгүй байна. Тиймээс биологийн олон янз байдлыг хамгаалах зорилтыг биелүүлэхэд ихээхэн саад бэрхшээл тохиолдох эрсдэл илэрхий байна. Үүнийг батлах жишээ нь БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар улсын тусгай хамгаалалттай газрыг хариуцсан долоохон ажилтантай, 24 сая га газарт эргүүл, харуул, хууль сахиулах ажил хариуцсан 337 байгаль хамгаалагч ажиллаж байгаа нь туйлын хангалтгүй юм. Сүүлийн үед төсөв танасан нь БОАЖЯ-ны чадавхи, тусгай хамгаалалттай газрын удирдлагын хээрийн ажил, биологийн олон янз байдлыг хамгаалах арга хэмжээ, үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлэх чадавхид сөргөөр нөлөөлсөн байна.

### *Зохицуулалт, эдийн засаг, мэдээллийн үйл ажиллагаа*

Тусгай хамгаалалттай газрын тухай 1994 оны хууль дархан цаазтай газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, байгалийн дурсгалт газрын хязгаарлалтын бүсэд Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд газар ашиглах харилцааг зохицуулж, 5 жилээс хэтрэхгүй газар ашиглалтын гэрээ хийх эрх зүйн орчноор хангадаг. Газар ашиглалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагаа явуулахад төлбөр хураамжтай. Энэхүү хууль учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, тусгай хамгаалалттай газрын журмыг зөрчсөний торгууль (эрдэм шинжилгээний үйл ажиллагаанаас учирсан хохирол бас багтана) ногдуулж, торгуулийн хэмжээ нь зөрчлийн төрөл хэлбэр, тусгай хамгаалалттай газрын ангилал, хохирлын цар хэмжээ, зөрчигч нь хуулийн этгээд, байгууллага, аж ахуйн нэгж үү гэдгээс хамаарна.

Байгаль орчныг хамгаалах тухай 1995 оны хууль байгалийн нөөц ашигласны төлбөр хураамж авах, зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлж ашигласны, мөн хог, хаягдал, бохирдуулагч бодис хаясны нөхөн төлбөр авах эрх зүйн орчныг бүрдүүлжээ. Энэхүү хуулиар байгаль орчныг хамгаалах сан байгуулж (Бүлэг 3), байгаль орчин бохирдуулсны болон сөрөг нөлөөллийн төлбөр хураамж, улсын тусгай хамгаалалттай газарт аялах, жуулчлах тусгай зөвшөөрлийн хураамж, хандив, бусад үүсвэрийг төвлөрүүлэхээр заасан. Эдгээр санг экологийн боловсрол, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд хуваарилж болно. Түүнчлэн байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж зөрчсөний торгуулийг тодорхойлж өгчээ.

Байгалийн ургамлын тухай 1995 оны хууль ургамал ашиглалтыг зохицуулж, хууль зөрчсөн тохиолдолд ногдуулах торгуулийн түвшнийг тогтоосон, харин ургамал ашигласны төлбөрийг 2012 оны Байгалийн нөөцийн төлбөрийн тухай хуулиар зохицуулж байна.

Амьтны тухай 2012 оны хууль амьтны зүйл ашигласны төлбөр авах эрх зүйн үндсийг бүрдүүлж, зөрчлийн торгуулийг тодорхойлсон байдаг. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай 2002 оны хуулиар уг хуулийг зөрчсөний торгуулийг тодорхойлж, хууль зөрчсөнийг илрүүлсэн, мэдээлсэн иргэдэд олгох эдийн засгийн урамшилд торгуулийн 20 хувийг олгохоор тусгажээ.

Цахим хандалттай Монголын статистик мэдээллийн үйлчилгээ, Статистикийн 2015 оны эмхэтгэл нь ойн газар, ургацын хэмжээ, ангах, “тусгай зориулалттай ангийн” зориулалтаар барих ховор амьтны зөвшөөрсөн тоо, спорт загасчлал, ахуйн зорилгоор агнаж болох дээд тоо хязгаарын талаар хязгаарлагдмал мэдээлэл агуулж байна.

Хүчин төгөлдөр хууль тогтоомжийн дагуу байгаль орчны мэдээлэл нь сум, аймаг, нийслэлийн мэдээллийн сан, төрийн төв мэдээллийн санд байх ба ой, амьтад, ургамал зэрэгтэй холбоотой тайлан, мэдээлэл, ялангуяа төрийн санхүүжүүлсэн судалгаа шинжилгээний тайлан мэдээллийг (ийм тохиолдолд төлбөргүй хэрэглүүлэх ёстой) агуулна. БОАЖЯ мэдээллийн сангуудын нийцлийг хангах үүрэгтэй.

Байгаль орчны мэдээллий төвийн мэдээллийн сан 39 сэдэвчилсэн мэдээллийн сан, тухайлбал ой, ургамлын аймаг, амьтны аймаг, улсын ба орон нутгийн тусгай хамгаалалттай газрын мэдээллийн санд олон нийтийн хандалтыг зөвшөөрдөг. Дэлхийн Байгаль Хамгаалах Сангийн (WWF) зэрлэг амьтан, ургамлын аймгийн мэдээллийн санд нэвтрэхэд хэрэглэгчийн бүртгэл шаарддаг байна.

#### Ургамал, амьтны Улаан ном

Монголын Улаан ном гурван удаа нийтлэгдсэн, эхнийх нь 1987 онд, дараагийнх нь 1997 онд гарч ховор, устах аюул нүүрлэсэн ургамал, амьтдын зүйлсийг оруулдаг. Улаан номд орсон 100 ургамлын зүйлийн дийлэнх нь Монголын унаган зүйлүүд байна.

Гурав дахь хэвлэлийн үнэлгээ нь Олон улсын байгаль хамгаалах холбооны 2001 оны Улаан ном дахь ангилал, шалгуурын Хувилбар 3.1-ийн дагуу хийгдсэн ба Монгол улсын биологийн зүйлүүдийн хамгааллын төлөв байдлыг дэлхийн бусад бүс нутгийнхтай анх удаагаа харьцуулжээ. Лондоны Амьтан судлалын нийгэмлэгтэй хамтарч Улаан номын хэд хэдэн ботийг хэвлэсэн байна. Ботиуд нь 2006 онд Хөхтөн амьтны Улаан ном, Загас болон мөлхөгчдийн Улаан ном; 2011 онд Шувуудын Улаан ном гарч, тэдгээр нь тухайн жилд нь нийтэлсэн Хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөний тойм дагалдаж байжээ.

Ургамлын Улаан номын гурав дахь хэвлэлийн эхний хэсэг 2011 онд нийтлэгдсэн ба 148 найман ургамлын зүйл, тэдгээрийн дотор нэн ховорт ангилагдсан 131 зүйлийг багтааж, хавсралтад БОАЖЯ-ны хүсэлтээр 1995 оны Байгалийн ургамлын тухай хууль, 1997 оны Улаан номд орсон 82 зүйлийн (75 нь аль аль баримт бичигт орсон) жагсаалтыг оруулж, эдгээр зүйлийг хамгаалах удирдлага зохицуулалт боловсруулахыг дэмжихийг зорьжээ. Гуравдугаар хэвлэлийн хоёр дахь хэсэг чухал ач холбогдолтой “ховор” ургамлуудын төлөв байдлыг тусгах ёстой байсан ч санхүүгийн хүндрэлийн улмаас боловсруулан, хэвлүүлж чадаагүй ажээ.

#### Үнэлгээ

Биологийн олон янз байдлын мэдээллийн удирдлагын системийг цаашид сайжруулах, ялангуяа яамд, газар, байгууллагуудын хооронд, мөн засаг захиргааны өөр өөр түвшний байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох харилцаа холбоог боловсронгуй болгох шаардлагатай байна. Монгол Улс Олон улсын байгаль хамгаалах холбооны аргачлалаар бүх унаган сээр нуруутан амьтны Улаан ном боловсруулж чадсан нь томоохон амжилт юм. Гэхдээ Монголын Ургамлын Улаан номын хоёр дахь хэсгийг боловсруулах ажил судалгаа шинжилгээ хийгдээгүй, санхүүгийн дэмжлэг олдоогүй учраас хэрэгжээгүй байгааг анхаарууштай.

### **11.7 Олон улсын гэрээ хэлэлцээр, үйл ажиллагаанд оролцох оролцоо**

#### *Олон улсын гэрээ, хэлцэл*

Монгол Улс 1990 онд нэгдэн орсон Дэлхийн Соёлын ба байгалийн өвийг хамгаалах тухай Конвенцийн хүрээнд таван газрыг ЮНЕСКО-ийн Дэлхийн өвд бүртгүүлсний гурав нь соёлын, хоёр нь байгалийн өв байна.

Монгол Улс ЮНЕСКО-ийн Хүн ба Биосфер хөтөлбөрт оролцож, биологийн олон янз байдлыг хамгаалах, байгалийн нөөцийн тогтвортой хэрэглээний нийцтэй байдлыг хангахаар ажиллаж байна. Монгол Улс Зүүн Азийн Биосферийн Нөөцийн Сүлжээний идэвхтэй гишүүн бөгөөд Хүн ба Биосфер хөтөлбөрийн сүлжээд өөрийн сүлжээнжр дамжуулан хувь нэмрээ (16,078,072 га газар буюу улсын нийт нутаг дэвсгэрийн 10.28 хувьтай тэнцэх газар) оруулж байна (Хүснэгт 11.4).

Монгол Улс 1993 оноос Биологийн олон янз байдлын конвенцид нэгджээ (Бүлэг 7). Энэхүү конвенцийг үндэсний түвшинд хэрэгжүүлэх чиглэлээр хэд хэдэн стратеги үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулсан. Монгол Улс 1998-2014 онд Биологийн олон янз байдлын конвенцийн хэрэгжилтийн талаар үндэсний таван тайлн илтгэл боловсруулан конвенцид хүргүүлсэн байна. Монгол Улс 2000 оноос Биологийн аюулгүй байдлын тухай Картагений Протокол, Генийн нөөц, тэдгээрийг ашигласны үр шимийг шударга, эрх тэгш хүртэх тухай Нагояагийн Протоколд 2014 онд нэгдсэн байна.

Тус улс 1996 онд Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай конвенцид (Бүлэг 6) нэгдэж, жил бүрийн тайлангаа тасралтгүй хүргүүлж байна. Эхний жилүүдэд хэрэгжилт нь хязгаарлагдмал байсан байна, тухайлбал хил дээрх хяналтыг хааяа л хийдэг байсан. Монгол дахь Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF) Байгалийн биологийн зүйлүүдийг танин тодорхойлох удирдамж бэлтгэсний зэрэгцээ Байгалийн амьтдыг хамгаалах нийгэмлэг 2017 онд Конвенцийг хэрэгжүүлэх талаар гаалийн ажилтнуудад чиглэсэн шинэ төсөл эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Монгол 1998 онд Ус намгархаг газрын тухай Рамсарын конвенцид нэгдэж, 1997 - 2004 онд 11 Рамсарын бүс нутгийг тодорхойлж, тэдгээрт нийт 1,439,530 га газрыг хамруулжээ (Хүснэгт 11.5). Одоогоор эдгээр Рамсарын газрын зөвхөн зарим хэсэг нь тусгай хамгаалалттай газрын үндэсний сүлжээнд багтсан байна.

Монгол Улс 1999 оноос Нүүдлийн биологийн зүйлүүдийн тухай конвенцийн оролцогч тал болж, уг конвенцийн Төв Азийн хөхтөн амьтдыг хамгаалах санаачилгын гишүүн болжээ. 2004 онд Цагаан тогорууг (*Leucogeranus leucogeranus*) хамгаалах арга хэмжээний тухай санамж бичиг, 2008 онд Африк, Еврази дахь Агнуурын нүүдлийн шувуудыг хамгаалах тухай санамж бичиг, 2010 оноос Бөхөн хамгаалах, сэргээн нутагшуулах, тогтвортой ашиглалтыг хангах тухай санамж бичигт гарын үсэг зурсан байна (Бүлэг 6).

#### *Хоёр талын гэрээ, хэлэлцээр*

Монгол Улсын Байгаль орчны яам, БНХАУ-ын Байгаль хамгаалах төрийн захиргааны байгууллагатай 2000 онд хил дамнан нүүдэллэдэг хавтгай тэмээ хамгаалах санамж бичигт гарын үсэг зуржээ.

Онон Балжийн байгалийн цогцолборт газар, ОХУ-ын Сохондины байгалийн нөөц газар 2014 онд хил дамнан хамтын ажиллагааны тухай засгийн газар хоорондын гэрээ байгуулсан байна. Монголын хэд хэдэн тусгай хамгаалалттай газар бусад улсын тусгай хамгаалалттай газруудтай хоёр талын хамтын ажиллагаанд оролцож байна. Жишээлбэл, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар АНУ-ын Мөсөн голын Үндэсний цэцэрлэгтэй; Хөвсгөлийн байгалийн цогцолборт газар АНУ-ын Ёсемитийн Үндэсний цэцэрлэгтэй; Их Нарт байгалийн цогцолборт газар АНУ-ын Анза-Борргогийн цөлийн муж-улсын цэцэрлэгтэй; мөн Хан Хэнтий дархан цаазтай газар Солонгос улсын Сеораксаны Үндэсний цэцэрлэгтэй хамтран ажиллаж байна. Отгонтэнгэрийн байгалийн цогцолборт газар 2017 онд АНУ-ын Деналийн Үндэсний цэцэрлэгтэй хамтын ажиллагаа тогтоохоор төлөвлөж байна.

Монголын тусгай хамгаалалттай газрууд Япон, Хятад улсуудтай хээрийн судалгааны ажилтан солилцох сургалтын хөтөлбөрт оролцож байна.

#### *Хил дамнансан экологийн сүлжээ*

Монгол Улс хөрш улсуудтай хил дамнансан тусгай хамгаалалттай газрууд байгуулан хамтран ажиллаж байна.

Хятад, Монгол, Орос улсын гурван талын хил дамнансан тусгай хамгаалалттай газар болох “Дагуурын олон улсын тусгай хамгаалалттай газрыг” 1994 онд байгуулж, түүнд Монгол-Дагуурын дархан цаазтай газар (Монголын Дорнод аймаг), Дагуурын Улсын байгалийн нөөц газар, Цасучейн Ой, Зээрийн

хавцалийн байгалийн амьтны нутаг (Оросын Чита муж), Хөлөн нуурын (Далай нуур) Үндэсний биосферийн нөөц газар (Өвөр Монголд) хамаарч байна.

Хоёр улсын тусгай хамгаалалттай газар (Монгол, Орос) болох Увс нуурийн сав газар 2011 онд байгуулагдсан ба үүнд Увс нуурын дархан цаазтай газар (Увс аймаг), Увс нуурын хотгорын улсын байгалийн биосферийн нөөц газар (Тува Улс) хамрагдсан байна.

БОАЖЯ 2017-2019 онд дахин гурван хил дамнасан тусгай хамгаалалттай газар (жишээ нь, Хөвсгөлийн байгалийн цогцолборт газр ба Буриадын Түнхиний байгалийн цогцолборт газар) байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

#### *Олон улсын төслүүд*

Австрали, Нидерландын Засгийн Газар, Тахь Хамгаалах Нидерландын Сан хамтран 1993-1997 онд энэ ховор, бараг устсан биологийн зүйлийг эргүүлэн нутагшуулах, Хустайн нуруунд дасан зохицуулах хоёр чиглэлээр хоёр төсөл хэрэгжүүлжээ (Шигтгээ 11.2).

ХБНГУ-ын Засгийн Газар 1994-1998 онд Дорнод Монголын хээр талын биологийн олон янз байдлыг хамгаалах, тогтвортой ашиглах төсөл, дархан цаазтай 3 газрын удирдлагын төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай судалгаа, мэдээ мэдээлэл цуглуулах ажлыг дэмжсэн. ХБНГУ-ын Засгийн Газар 1995-1998 онд дархан цаазтай газрын чадавхийг бэхжүүлэх, тэдгээртэй залгаа нутгийн байгаль орчныг хамгаалах, тогтвортой хөгжүүлэх үйл ажиллагаанд анхаарч ажилласнаар Германы Олон улсын техникийн хамтын ажиллагааны байгууллагын (GTZ) санхүүжилттэй Байгаль орчныг хамгаалах, орчны бүсийг хөгжүүлэх төслийн II шатыг (У21 сая ам.доллар) хэрэгжүүлэх замыг нээв. Мөн GTZ байгууллага 2009-2011 онд уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлд өртсөн Хангай Хэнтийн ой, хээрийн бүсийн биологийн олон янз байдлыг хамгаалахад чиглэсэн Уур амьсгалын өөрчлөлт ба ойн биологийн олон янз байдлын хөтөлбөрийг (8.5 сая ам.доллар) хэрэгжүүлсэн байна.

АНУ Олон улсын хөгжлийн агентлаг (USAID), АНУ-ын Дотоод Хэргийн Департамент болон Биологийн олон янз байдлын төлөө түншлэл 1998-2001 онд Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрыг өргөжүүлэх хөтөлбөрийн хүрээнд техникийн туслалцаа үзүүлжээ.

Монгол дахь Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF) Монголын Биологийн олон янз байдлыг хамгаалах төсөл хэрэгжүүлсний үр дүнд Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын удирдлагын төлөвлөгөө гарсан байна. Байгаль орчны яам, Дэлхийн байгаль хамгаалах сан 1993-1999 онд шинээр байгалийн цогцолборт газрууд (Горхи-Тэрэлж, Говь Гурван Сайхан, Хорго-Тэрхийн Цагаан Нуур, Хангай нуруу, Хар Ус Нуур), байгуулах санал боловсруулсаныг Засгийн Газар, УИХ баталсан байна. Дэлхийн байгаль хамгаалах сан 1997-2002 онд Хар Ус Нуурын байгалийн цогцолборт газрын удирдлагын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх; 1998-2002 онд Шарга Манхан байгалийн цогцолборт газарт бөхөн хамгаалах, удирдлагын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлжээ. Дэлхийн байгаль хамгаалах сан н, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтарч 1998-2003 онд Дорнод Монгол, Монгол-Дагуурын дархан цаазтай газрын удирдлагын төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлсэн байна.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр 2004-2011 онд Алтай Соёны эко-бүс нутгийн уулархаг ландшафтын биологийн олон янз байдлыг олон нийтэд түшиглэн хамгаалах төсөл (Даян дэлхийн байгаль орчны сан (GEF), Нидерланд Улс, 4.8 сая ам.доллар), Их Говийн дархан цаазтай газрын экосистемийг хавтгайн жишээн дээр хамгаалах төсөл (GEF), 1.5 сая ам.доллар) хэрэгжүүлжээ.

Байгаль хамгаалал (TNC) байгууллага 2006 оноос хойш Дорнодын хялганат хээрийг хамгаалах, гол оролцогч талуудтай хамтран төлөвлөгөө боловсруулах, Хустай Нурууны байгалийн цогцолборт газар, Их Нарт байгалийн нөөц газрын олон нийтэд суурилсан удирдлагыг хөгжүүлэх чиглэлд ажиллаж байна.

Байгалийн амьтан ургамал хамгаалах нийгэмлэгийн (WCS) Дагуурын хээрийн ландшафт, эн тэргүүний экосистемүүд дэх тогтвортой хамгааллын аргачлал төслийг хэрэгжүүлэн (2009-2014, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг 1.2 сая ам.доллар) олон нийтэд суурилсан бэлчээр хамгаалал, байгалийн амьтан ургамлын зохицуулалтын төлөвлөгөө, хяналт шинжилгээ, хууль сахиулах, Хавтгарын орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг дэмжих үйл ажиллагаа явуулжээ.



Тусгай хамгаалалттай газрын сүлжээний одоогийн сул тал, орхигдлын талаарх иж бүрэн тайлан илтгэл 2010 онд Амьд гаригт зориулсан тусгай хамгаалалттай газрууд төсөл, Монгол, Оросын Алтай-Соёны эко-бүс нутгийн хил дамнасан бүс дэх аргаль, ирвэсийг урт хугацаагаар хамгаалах (Нидерланд дахь WWF байгууллага санхүүжүүлсэн) төсөл, Биологийн Олон Янз Байдлын Төвийн Тусгай хамгаалалттай газрыг хөтөлбөр хэрэгжүүлэхэд чиглэсэн улс орны үйл ажиллагааг дэмжих (Даян Дэлхийн Байгаль Орчны Сан, НҮБ санхүүжүүлсэн) төслийн хүрээнд нийтлэгдсэн байна. Илтгэлд 2007-2009 онд Байгаль хамгаалал байгууллага (Монгол-Дагуурын эко-бүс нутагт), Даян Дэлхийн Байгаль Орчны Сан (Хангай, Говийн эко-бүс нутагт), Монгол дахь Дэлхийн Байгаль Орчны Сан (Алтай Соёны эко-бүс нутагт) хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүнг нэгтгэн дүгнэсэн байна.

Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн 2010-2015 онд хэрэгжүүлсэн Монгол орны тусгай хамгаалалттай газрын сүлжээг бэхжүүлэх төслийн (4.3 сая ам.доллар) хүрээнд тусгай хамгаалалттай газрын удирдлагын төлөвлөгөө боловсруулах арга зүй, удирдамжийг хянан шинэчлэн, тусгай хамгаалалттай газрын бизнес төлөвлөгөө боловсруулах удирдамж боловсруулж, хоёр байршилд (Орхоны хөндийн байгалийн цогцолборт газар, Их Нартын байгалийн нөөц газар) туршин хэрэгжүүлэн БОАЖЯ-аар албан ёсоор 2013 онд батлуулсан байна. Энэ хоёр арга зүй одоо байгаа удирдлагын төлөвлөгөөнүүдийг шинэчлэхэд үйлчилж байгаа бөгөөд 289 тусгай хамгаалалттай газрын менежерүүдийг дээрх хоёр арга зүйд сургасан байна.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн 2013-2018 онд хэрэгжүүлж байгаа Монголын тусгай хамгаалалттай газрын зохицуулалттай нөөцийн сүлжээ төлсөл (1.5 сая ам.доллар) дутуу хамрагдсан хуурай газрын экосистемүүдийг багтаасан олон нийтэд түшиглэсэн байгаль хамгааллын газар нутгийн сүлжээгээр улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээг нөхөх, өргөтгөх зорилгоор орон нутгийн тусгай хамгаалалттай газруудад чиглэн хэрэгжиж байна. Туршин хэрэгжүүлэх газрууд нь Гулзатын орон нутгийн тусгай хамгаалалттай газар, Хавтгарын орон нутгийн тусгай хамгаалалттай газар, Тосон Хулстайн байгалийн цогцолборт газрын орчны бүс юм.

АХБ Монгол Улстай түншлэх 2017-2020 оны стратегийг эхлүүлсний хүрээнд Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрыг дэмжих төсөл (“Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт амьжиргааг сайжруулах, тогтвортой аялал жуулчлалын цогц хөгжил”, 2016-2019 он, 3.0 сая ам.доллар) хэрэгжүүлж, мөн 38.0 сая ам.долларын зээлээр “Тогтвортой аялал жуулчлалын хөгжил” төслийг 2019-2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Хөвсгөл бол Монгол орны хамгийн том цэнгэг нуур агаад Монголын цэнгэг усны 70 хувийг агуулдаг. Мөн хил дамнасан ач холбогдолтой, Сэлэнгэ мөрнөөр дамжин Байгал нууртай холбогддог. Урьд нь байгалийн цогцолборт газарт аялагчид цөөн ирдэг, 2010 онд 11,000 хүн ирж байсан бол нэгэнт засмал зам тавигдсанаар 2014 онд 60,000 хүн ирдэг болж, 60 гаруй жуулчны бааз байгуулагдаж, бохир усны болон аялал жуулчлалын дэд бүтэцгүйн улмаас тус нутгийн байгалийн үнэ цэнд занал учруулж эхэлсэн байна. Дээрх төсөл амьжиргаа, аялал жуулчлал, хаягдлын менежмент, газар ашиглалтын төлөвлөгөөний чиглэлийг багтаасан цогц аргачлал хэрэгжүүлэх зорилт тавьсан бөгөөд Монголын бусад тусгай хамгаалалттай газруудад загвар болж өгөхөөр төлөвлөжээ.

Герман улсын KfW Хөгжлийн Банк 2015 онд анхныхаа томоохон биологийн олон янз байдлыг хамгаалах “Биологийн олон янз байдал ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” нэртэй 15.3 сая еврогийн төсөв бүхий төсөл нь тусгай хамгаалалттай газрын захиргаадын чадавхийг бэхжүүлэх, удирдлагын үр ашгийг дээшлүүлэх, орчны бүс дэх орон нутгийн олон нийттэй хамтын ажиллагаа төлөвшүүлэхэд чиглэсэн байна. Төслийн эхний шатанд (сонгосон 11 тусгай хамгаалалттай газрын захиргаанд тоног төхөөрөмж, дэд бүтэц, унаа, дүрэмт хувцас хүргэхийн зэрэгцээ) оролцооны үйл ажиллагаагаар тусгай хамгаалалттай газрууд, тэдгээрийн орчны бүсийн удирдлагын төлөвлөгөө боловсруулахад тусалж, үр дүнд нь эрдэм шинжилгээний салбарын оролцоотой боловсруулсан жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө гарсан байна. Төслийн 2018 оноос эхлэх дараагийн шатанд өмнө нь хамрагдаж байгаагүй тусгай хамгаалалттай газрын захиргаадын удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх (удирдлагын төлөвлөгөөтэй байх нь 200 саяас 1.5 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламж авах хүсэлт гаргах урьдач нөхцөл байсан), тусгай хамгаалалттай газрын өгөгдлийн менежментийн систем байгуулахад дэмжих юм.



**Шигтгээ 11.2: Олон улсын хамтын ажиллагааны үлгэр жишээ Хустайн нурууны байгалийн цогцолборт газар**

Хустай нуруу нь анхандаа 1993 онд тахийг (*Equus ferus ssp. przewalskii*) хамгаалах зорилготой байгалийн нөөц газар болж байгуулагдсан бөгөөд тахь нь тухайн үед Олон Улсын Байгаль Хамгаалах Холбооны (IUCN) ангилалд байгальд устсан гэж орсон байв. Тахь Хамгаалах Сан, Монголын Байгаль Орчныг Хамгаалах Нийгэмлэг 1992-2000 онд Европоос 84 тахийг анх авчирч нутагшуулж эхэлжээ. Энэхүү ховор биологийн зүйлийг дахин нутагшуулах хоёр төслийг Австрали, Нидерландын Засгийн Газрууд дэмжин хэрэгжүүлжээ. Нидерландын Засгийн Газар түүнчлэн тус байгалийн цогцолборт газрын экосистемийг хамгаалах, удирдлагын чадавхийг бэхжүүлэх, орчны бүсэд тогтвортой амьжиргаа хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжсэн байна. Хустайн нурууны судалгаа шинжилгээний хөтөлбөрүүд Япон Улсын Киотогийн Их Сургууль, Токиогийн Их Сургууль, Нидерландын Вагенингений Их Сургууль зэрэг гадаадын байгууллагуудтай түншлэн ажиллаж байна.

Тахийг амжилттай дахин нутагшуулсан хийгээд биологийн олон янз байдлыг хамгаалах, эрдэм шинжилгээ судалгааны ажлын амжилтыг 1998 онд дүгнэж, Хустайн нурууг байгалийн цогцолборт газар (50,600 га талбайтай, орчны бүс нь 350,000 га) болгосон төдийгүй 2002 онд ЮНЕСКО биосферийн нөөц газар (378,000 га нэмэлт орчны бүстэй) нэр дэвшүүлсэн байна. Хустайн нуруу ТББ-тай (Монголын Байгаль Орчныг Хамгаалах Нийгэмлэг 1993-2003 онд, орон нутгийн Хустайн нурууны байгалийн цогцолборт газрын нөхөрлөл 2003 оноос) гэрээгээр удирдуулсан анхны тусгай хамгаалалттай газар бөгөөд шаардлага хангасан удирдлагын төлөвлөгөө бүхий (2002 оноос) анхны тусгай хамгаалалттай газар болсон байна.

Хустайн нурууны байгалийн цогцолборт газрын нөхөрлөл нь эрдэм шинжилгээний зөвлөл (Монголын их дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн төлөөлөл бүхий биологичид, ургамал судлалчид, экологичид, малын эмч нар) бүхий Монголын цорын ганц ТББ бөгөөд тус байгалийн цогцолборт газрын удирдлага, судалгаа шинжилгээ, сургалтын үйл ажиллагааг зөвлөн зохицуулдаг байна. Тус байгууллага 60 орчим ажилтантай, түүний дотор байгаль хамгаалах нэгж (13 байгаль хамгаалагчтай) нь байгалийн цогцолборт газрын талбайд өдөр тутам эргүүл хийж, байгалийн амьтдын популяцийг ажигладаг; сургалт, судалгаа шинжилгээний нэгжтэй (биологич, мэдээллийн менежер, эко-сайн дурынхны зохицуулагчтай).

Хустайн нурууны байгалийн цогцолборт газрын нөхөрлөл байгаль хамгаалах хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор эко-аялал жуулчлалын хөтөлбөрүүд, олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагаа, нүүдэлчдийн аж амьдралыг танилцуулах, жуулчдыг орчны бүсийн өрхүүдээр зочлуулах зэрэг ажил зохион байгуулдаг. Тус байгууллага орон нутгийн хүн амыг байгаль хамгаалах, судалгаа шинжилгээний үйл ажиллагаанд оролцуулж, уламжлалт мал аж ахуйгаас өөр амьжиргааны боломжуудаар хангаж ажиллаж байна. Уг ТББ Алтанбулаг суманд бяслагны үйлдвэр байгуулж бүтээгдэхүүний нь тодорхой хэсгийг тус байгууллага худалдан авч, орон нутгийн малчдын бүлгүүдийн бусад бүтээгдэхүүний хамт байгалийн цогцолборт газрын зочдод борлуулдаг байна. Энэ бүхний үрээр байгалийн цогцолборт газар өөрийгөө санхүүжүүлдэг болсон ба удирдлагад нь төсвийн татаас шаарлагагүй байдаг.

**Үнэлгээ**

Монгол Улс биологийн олон янз байдлыг хамгаалах үйл ажиллагаагаа бусад улс орнуудтай уялдуулахдаа байгаль орчны даян дэлхийн олон талт гэрээ хэлэлцээр, бүсийн, хоёр талын хийгээд олон талын хамтын ажиллагааны түвшинд ажиллаж, үүний хүрээнд хил дамнасан тусгай хамгаалалттай газруудыг байгуулж байна. Хөрш улс гүрэнтэй хамтарсан ажиллагаа нь хил дамнасан экосистем, нүүдлийн биологийн зүйлүүдийн хамгаалал, хил дамнасан тусгай хамгаалалттай газрын сүлжээг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Тус улс дэлхий нийтийн баталсан үйл ажиллагааны хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хувь нэмэр оруулж, олон улсын хамтын ажиллагааны сүлжээнүүдэд идэвхтэй оролцон ажиллаж байна. Эдгээрийн үрээр Монгол Улс найдвартай, үнэн сэтгэлээсээ, чармайлт бүхий, зарим тохиолдолд өөрийн хязгаарлагдмал чадавхиас давж ажиллах чадвартай түнш гэдгээ харуулсан. Иймд азаар дэлхий нийтийн нийтлэг ашиг сонирхлын дагуу ажиллах хүрээнд олон улс, байгууллага Монгол Улсын байгаль хамгаалах үйлсэд дэмжлэг үзүүлж, үр ашигтай санхүүжилт хийж байна. Дэлхий дахинд чухал ач холбогдол бүхий Монгол орны ландшафт, экосистем, ургамал амьтны аймгийн гоо үзэсгэлэн, арвин баялгийг анхаарч сайн хөрөнгө оруулалт хийвэл одоо ба ирээдүйд өндөр ашиг олох болно.

Фото зураг 11.2: Хустайн нурууны БЦГ-т бэлчээрлэж буй тахь



### 11.8 Үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж

#### Үнэлгээ

Монгол Улс унаган байгалийн экосистемийг хадгалж чадсан, Зүүн Азид байгалийн биологийн зүйлүүдийн сүүлчийн орших газар нутаг болсон хэвээр байна. Энэ нь хүн ам сийрэг суурьшсан өргөн уудам нутаг дэвсгэртэйн ач төдийгүй олон зуун жилээр байгальтайгаа зохицон амьдарч, байгалийн нөөцийг тогтвортой аргаар ашиглаж ирсэн Монголын ард түмний соёл, ёс зүйн илрэл болж байна.

Гэвч сүүлийн гучаад жилд Монгол Улсад биологийн зүйлүүд эрчимтэй хорогдож, дэлхий даяар ховордсон зүйлүүд ч, бусад бүс нутагт элбэг боловч сүүлийн үед ховордож байгаа зүйлүүд ч аюулд өртөж байна. Үүний зэрэгцээ Монгол орны бүх дөрвөн эко-бүс нутгийн бараг бүх байгалийн экосистемийн бүрэн бүтэн байдал эрсдэлд орж байгаа нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойн дээр нэн ялангуяа хүний үйл ажиллагааны нөлөөтэй дарамтаас улбаалж байна.

Одоогийн хууль тогтоомж, бүтэц зохион байгуулалтын орчин, тусгай хамгаалалттай газрын сүлжээ биологийн олон янз байдлын хамгааллыг үр нөлөөтэй зохион байгуулж чадахгүй байгаа тул нэмэлт арга хэмжээнүүдийг яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Дэлхий даяар зөвшөөрсөн ГХЗ-ын хүрээнд удирдамж болгон авч хэрэгжүүлж болох хэд хэдэн зорилгыг дэвшүүлсэн (Зорилго 15.1, 15.4, 15.5, 11.4) байна. Цаашлаад, Монгол Улс Биологийн олон янз байдлын тухай конвенцийн нэг тал болохын хувьд Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Биологийн олон янз байдлын төлөө стратеги төлөвлөгөөг (2011–2020) хэрэгжүүлэх, Аичигийн зорилтуудыг биелүүлэхийн төлөө сэтгэл зориг гарган ажиллаж, тэдгээрийг Биологийн олон янз байдлыг хамгаалах Үндэсний Хөтөлбөр 2015-2025-д тусган хэрэгжүүлж байна.



Дүгнэлт, зөвлөмжБиологийн олон янз байдлын мониторинг, эх мэдээллийн хүрэлцээ

Биологийн олон янз байдлын мэдээллийг тогтмол цуглуулдаггүй, бас шинэчлэхгүй байгаа нь биологийн олон янз байдлын хяналт шинжилгээ, мэдээллийн иж бүрэн тогтолцоо байхгүй байгаагай холбоотой байна. Санхүүжилт хомсдсон нь үндэсний хэмжээний биологийн олон янз байдлын судалгаа шинжилгээний ажил зогсоход хүргэжээ. Бага зэрэг эх мэдээ, мэдээлэл байгаа нь албан тушаалтан, байгууллага, эрдэм шинжилгээний хүрээлэн, байгаль орчны байгууллагуудын хооронд тарамджээ. Мэдээлэл эзэмшигчид, засаг захиргааны түвшнүүдийн хооронд харилцаа холбоо, мэдээлэл солилцоо үгүйлэгдэж байна.

Биологийн олон янз байдлын талаар найдвартай, шинэ мэдээлэлгүйн улмаас судалгааны ажил давхардаж, үндэсний, бүсийн, орон нутгийн бодлого, биологийн төрөл зүйлийн хамгааллын үйл ажиллагааны төлөвлөгөө, тусгай хамгаалалттай газрын удирдлагын төлөвлөгөө, агнуурын зөвшөөрөх тоо тогтоох ажил цалгардаж байна. Биологийн олон янз байдлын талаарх найдвартай, шинэ мэдээлэл хомс байгаа нь ТХЗ-ын Зорилго 15.5-ыг хэрэгжүүлэх, байгалийн орчны доройтлыг бууруулах яаралтай, дорвитой арга хэмжээ авах, биологийн олон янз байдлын доройтлыг зогсоох, 2020 оноос өмнө ховордсон биологийн зүйлийг устахаас хамгаалж, урьдчилан сэргийлэхэд саад бэрхшээл учруулж байна

Зөвлөмж II.1:

*Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамтай хамтран үндэсний хэмжээний мониторинг хяналт шинжилгээ, судалгааны хөтөлбөр, тухайлбал эрсдэлд учирсан экосистем, ховордсон ургамал амьтны зүйлүүдэд чиглэсэн ажлыг дэмжих;*
- (b) *Улаан номыг шинэчилж, Ургамлын Улаан номын хоёр дахь хэсгийг боловсруулж гүйцээх;*
- (c) *ҮСХ, Монгол улсын ШУА, МУИС болон бусад байгууллагуудтай хамтран биологийн олон янз байдлын үр бүтээлтэй мэдээллийн тогтолцоо бүрдүүлэх, үүний тулд мэдээлэл авах, хадгалах, сэргээх, боловсруулах, мэдээллийн багцыг нийцүүлэх зэрэгт орчин цагийн цахим арга хэрэгсэлийг хэрэглэж, биологийн олон янз байдлын мониторинг хяналт шинжилгээ, судалгааны төрийн санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнг цуглуулах, хадгалах, түгээх, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд оролцогч бүх талуудад энэхүү мэдээллийн системийг нээлтэй, хүртээмжтэй болгох (хандалтын болон өгөгдөлтэй харьцах түвшний ялгаатайгаар), түүнчлэн зорилтот хөтөлбөрөөр дамжуулан ШУА болон их сургуулиудын тэтгэвэртээ гарсан эрдэмтдийн тусламжтайгаар үндсэн мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг дэмжих,*
- (d) *Биологийн олон янз байдлын тухай мета-мэдээллийн санг бий болгож, удирдлагаар хангах.*

Ховор болон ховордсон төрөл зүйл

Биологийн олон зүйлийн популяци цөөрөх, байгалийн амьдрах орчин нь алдагдах, доройтох үйл явц аюултай хурдаар эрчимжиж байна. Одоогийн хэрэгжүүлж байгаа хамгааллын арга хэмжээний цар хүрээ ховор, ховордсон амьтан, ургамлын зүйлүүдэд чиглэж байгаа нь дээрх үйл явцыг сааруулах, ТХЗ-ын Зорилго 15.5-ыг биелүүлэхэд хангалтгүй байна. Байгалийн амьтад, дэлхий нийтэд чухал ач холбогдол бүхий биологийн зүйлүүдийн нүүдлийн замын дийлэнх хэсэг нь тусгай хамгаалалттай газруудын гадна, улс орны нутаг дэвсгэрийн 70 хувь болох хамгаалагдах ороогүй газар нутагт үлдсэн байна.

Зөвлөмж II.2:

*Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Ховор, ховордсон биологийн зүйлүүдийг хамгаалах үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрүүдэд үр нөлөөний үнэлгээ хийх, шаардлагатай бол өөрчлөлт, тодотгол оруулах;*
- (b) *Яаралтай илүү хамгаалалт шаардлагатай ховордсон бусад биологийн зүйлүүдийг тодорхойлох, тэдгээрийг хамгаалах үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгтэй.*

Хамгаалалттай газар нутгийн бүсчлэл

Монгол Улс 1990-ээд оны эхэн үеэс тусгай хамгаалалттай газрын үндэсний сүлжээ бий болгож, 2017 он гэхэд нийт нутаг дэвсгэрийн бараг 30 хувийг хамруулжээ. Гэтэл тусгай хамгаалалттай газрын сүлжээ нь биологийн олон янз байдлын үнэ цэнийг хангалттай хамгаалж чадахгүй байгаа нь зарим экосистем дутуу хамрагдсантай холбоотой байна. Түүнчлэн зарим тусгай хамгаалалттай газрын одоогийн бүслэлийн аргачлал чухал ач холбогдолтой байгалийн амьтдын амьдрах орчныг зохих хэмжээнд хамгаалах нөхцөл бүрдүүлж чадахгүй байна. Эдгээр саад бэрхшээлийг шийдэх нь Монгол Улс ТХЗ-ын Зорилго 15.1 (2020 хүртэл хуурай газрын болон цэвэр усны экосистем, тэдгээрийн үйлчилгээ, тухайлбал ой, ус намгархаг газар, уул, хуурайшилттай газрын экосистемийн үйлчилгээг олон улсын гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргийн дагуу хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах) болон 15.4-ийг (2030 он хүртэл уулын экосистем, түүний биологийн олон янз байдлыг хамгаалах, үүгээрээ тогтвортой хөгжилд үзүүлэх үр шимийг нь дээшлүүлэх) хэрэгжүүлэхэд чухал шаардлагатай байна.

Зөвлөмж 11.3:

*Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Өнөөгийн ДЦГ болон ҮП-ын дотоод бүсчлэлийг байгаль хамгалах үр өгөөжийг нь сайжруулахын, ялангуяа үндсэн гол, онцгой ач холбогдол бүхий амьтад, ховор, ховордсон төрөл зүйлийн нүүдлийн замыг хамгаалахын тулд дахин үнэлэх,*
- (b) *Хамгаалалттай нутгийн бүсчлэлийн хянан үзэж, газар зүйн мэдээллийн системийн технологи ашиглан бүсчлэлийн шинэ зураг боловсруулан ТХН-ын захиргаад, олон нийтийн хүртээл болгох, түүнтэй уялдуулан ТХН-ын менежментийн төлөвлөгөөг боловсронгуй болгох,*
- (c) *Тусгай хамгаалалттай газрын сүлжээг өргөтгөж, гол экосистем болон уулын биологийн олон янз байдлалд чухал ач холбогдол бүхий газруудын наанадаж 30 хувийг нь хамруулах;*
- (d) *Тусгай хамгаалалттай нутгийг сонгох, түүний сүлжээг өртгөхдөө орон зайн төлөвлөлтийн арга хэрэгсэл ашиглах явдлыг нэвтрүүлэх хэрэгтэй.*

Биологийн олон янз байдлыг хамгаалах чадавхи

Биологийн олон янз байдлын хяналт шинжилгээ, үр нөлөөтэй удирдлага, биологийн олон янз байдлыг хамгаалах арга хэмжээг газар дээр нь хэрэгжүүлэхэд одоогийн хүний нөөцийн болон техникийн, үйл ажиллагааны чадавхи хүрэлцэхгүй байна. Тусгай хамгаалалттай газрын сүлжээг өргөжүүлэхээр төлөвлөж байгаа, тэдгээрт аялал жуулчлалын дарамт нэмэгдэж байгаа нөхцөлд чадавхи бэхжүүлэх нь яаралтай чухал зорилт болж байна. Эс тэгвэл биологийн олон янз байдал, тусгай хамгаалалттай газартай холбоотой төрийн бодлого, стратеги, ТХЗ-ын Зорилго 15.1, 15.4, 15.5 –ийг хэрэгжих боломжгүй болно.

Зөвлөмж 11.4:

*Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамтай хамтран төрийн байгууллагууд, эрдэм шинжилгээний хүрээлэн, тусгай хамгаалалттай газрын захиргааны хүний нөөцийн болон техникийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино, чингэхдээ:*

- (a) *Зэрлэг амьтдын тоо толгойн тооллого хийх, орчин үеийн технологи хэрэглэх асуудлаар холбогдох мэргэжлийн сургалтууд зохион байгуулах,*
- (b) *Биологийн олон янз байдлын хяналт шинжилгээний орчин үеийн тоног төхөөрөмж, хээрийн судалгааны тоног төхөөрөмж, дүрэмт хувцас, туулах чадвар сайтай болон тусгай зориулалтын механикжсан тээврийн хэрэгслээр хангах;*
- (c) *Чадвартай мэргэжлийн ажилтнууд, их сургууль төгсөгчид, залуу судлаачид, байгаль хамгаалагчдыг биологийн олон янз байдлыг хамгаалах салбарт хөдөлмөр эрхлэх сонирхол төрүүлэхүйц төсөв хөрөнгө, ажилтнуудын цалин хөлсийг нэмэгдүүлэх хэрэгтэй.*

Тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөө

Шинжлэх ухааны судалгаа, байгаль орчны тооллогод суурилсан тусгай хамгаалалттай газрын удирдлагын төлөвлөгөө нь үндсэн гол биологийн төрөл зүйл, экосистемд тулгарч буй эрсдлийг тодорхойлох, судлах, байгаль орчныг хамгааллын зорилтыг тодорхойлох, аюул, дарамтын эсрэг зохистой хамгаалах арга хэмжээ сонгон хэрэгжүүлэхэд юугаар ч сольшгүй арга хэрэгсэл болдог. Санхүүгийн нөөц хомс, хязгаарлагдмал нөхцөлд урт хугацааны төлөвлөлт нь хамгийн яаралтай

удирдлагын асуудлыг эн тэргүүнд эрэмбэлэх, эдийн засгийн үр ашигтай байгаль хамгааллын жилийн төлөвлөгөө, мөн уялдах бизнес төлөвлөгөө боловсруулах, санхүүжилт босгох стратеги, кампанит ажил зохион байгуулахад чухал шаардлагатай. Тусгай хамгаалалттай газрын удирдлагын төлөвлөгөө нь төсвийн хуваарилалт хүсэх, үндэсний болон орон нутгийн санхүүгийн үүсвэрүүд, олон улсын хамтын нийгэмлэг, бодит хандивлагчдаас санхүүгийн дэмжлэг эрэлхийлэхэд чухал үндэслэл болж өгнө. Тусгай хамгаалалттай газрын удирдлагын төлөвлөгөө боловсруулах нь ТХЗ-ын Зорилго 15.1, 15.4, 15.5-ын хэрэгжилтэд хувь нэмэр оруулах чухал арга хэрэгсэл болно.

#### Зөвлөмж II.5:

*Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам олон улсын холбогдох туршлагыг ашиглан, тусгай хамгаалалттай газруудын менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан сайжруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.*

#### Тусгай хамгаалалттай газрын бодлогын тогтолцоо, санхүүжилт

Тулгарч байгаа саад бэрхшээл, дутагдалтай тал, санхүүгийн хомсдолтой байдлыг үндэслэн Тусгай хамгаалалттай газрын тухай 1994 оны хууль, мөн Тусгай хамгаалалттай газрын завсрын бүсийн тухай 1997 оны хуулиудыг шинэчлэн өөрчлөлт хийх ажил одоо хийгдэж байна. Энэ хууль шинэчлэх үйл явц хэдэн арван жил үргэлжилж байгаа бөгөөд сүүлийн энэ хоёр хуулийг нэгтгэх тухай яригдаж эхлээд байна. Түүнчлэн, ТХН-ын 1998 оны үндэсний хөтөлбөрийг өөрчлөн шинэ хөтөлбөр боловсруулах ажил хийгдэх хэрэгтэй болж байна. Энэхүү шинэ хөтөлбөр нь бусад олон асуудлын зэрэгцээ хамгаалалттай газрын улсын сүлжээг тэлэх, ТХН-ын менежментийг сайжруулахад илүү анхаарах ёстой.

Санхүүгийн бэрхшээл төсвөөс санхүүждэг бүх хамгаалалтын захиргаадад түгээмэл байгаа бөгөөд ТХН-д нэвтрэх төлбөрийг өөртөө үлдээж ашиглаж чадахгүй байна. ТХН-ын удирдлага менежмент хийхэд газрын төлбөр төлөх тухай эрх зүйн үндэслэл байхгүй. Зарим ҮП-ын хувьд машин тэрэг болон жуулчдын тээврийн хэрэгслийн үзүүлэх нөлөөлөл илэрхий нэмэгдэж байна.

#### Зөвлөмж II.6:

*Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Тусгай хамгаалалттай газрын тухай 1994 оны хуулийг шинэчлэх ажлыг эцэслэж БОАЖЯ-д газар ашиглалтын зөвшөөрлийг давхардуулан олгодог асуудлыг шийдвэрлэх боломж олгох, шинэчилсэн хуулийг батлуулах арга хэмжээ авах,*
- (b) *Тусгай хамгаалалттай нутгийг өргөтгөх, түүний менежментийн болон санхүүгийн чадавхийг сайжруулах хэтийн төсөөллийг үндэслэн ТХН-ын шинэ хөтөлбөрийг эцэслэн боловсруулж батлах,*
- (c) *ДЦГ болон ҮП-уудын менежментийн чадавхийг сайжруулахын тулд эдгээр газарт нэвтрэх төлбөрийг нэмэгдүүлж, түүнийг хураасан ТХГ-дад нь буцаан олгох асуудлыг авч үзэх,*
- (d) *ТХН-т үйл ажиллагаа явуулж байгаа аялал жуулчлалын байгууллагуудад газар ашигласны төлбөр ноогдуулж түүнийг ДЦГ болон ҮП-уудын менежментийн чадавхийг сайжруулахад ашиглах асуудлыг шийдвэрлэх,*
- (e) *ТХГ-ын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аялал жуулчлалын байгууллагууд ДЦГ болон ҮП-уудад хувийн бизнес эрхлэх эрх эдэлж байгаагийн хувьд өөрийн нийт орлогын тодорхой хувийг ТХН-уудад төлж байх асуудлыг шийдвэрлэх,*
- (f) *Хөвсгөл, Горхи-Тэрэлж зэрэг ҮП-ууд аялал жуулчлалын байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаа явуулж байгаа ТХН-ийн бүсэд үзүүлэх авто машины үзүүлэх нөлөөлөл, амьтдыг үргээж цочоох байдлыг бууруулахын тулд өөрийн тээврийн хэрэгсэлээр байнга хангах арга хэмжээ авах.*





## Бүлэг 12


### ГАЗРЫН МЕНЕЖМЕНТ

#### 12.1 Өнөөгийн байдал

Монгол Улсын нийт нутаг дэвсгэр 156.412 сая га, дэлхийд газар нутгийн хэмжээгээр 18-д, далайд гарцгүй орнуудаас 2 дугаарт орно. Нутгийн хойд хэсэг ойгоор бүрхэгдсэн уул нурууд, өмнөд хэсэг говь цөл, цөлийн хээр хосолсон болон хээр тал нутаг, баруун бүсэд Алтай, Хангайн нуруу, зүүн хэсэг нь өргөн уудам тал болон нам дор газар нутаг зонхилно.

Газрын тухай 2002 онд шинэчилсэн хуулиар Монгол Улсын газрыг 6 үндсэн ангилалд хувааж, 2015 онд эдгээр ангилал тус бүрийн эзлэх тайлбайн хэмжээг тогтоосон байна. Эдгээр нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар (нийт нутаг дэвсгэрийн 73.5 хувь); хот, тосгон, бусад суурин газар (0.5 хувь); зам, шугам сүлжээний газар (0.3 хувь); ойн сан бүхий газар (9.2 хувь) (Бүлэг 13); усны сан бүхий газар (0.4 хувь) (Бүлэг 9); тусгай хэрэгцээний газар (16.1 хувь) гэж 6 ангилжээ (Зураг 12.1). Тусгай хэрэгцээний газарт тусгай хамгаалалттай газар (Бүлэг 11), улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар, шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг уурын төлөв байдлын байнгын ажиглалт, мониторингийн талбай зэрэг олон дэд ангиллын газар хамаардаг байна.

Зураг 12.1: Газрын ангилал, 2016 оны байдал



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2017 он.

Тайлбар: ХАА-н газар ангилалд бэлчээр 99 хувийг эзэлдэг.

#### Хот байгуулалт

Монголд хотжуулалт 1950-иад онд эхэлж байх үед нийт хүн амын зөвхөн 20 орчим хувь хот сууринд оршин сууж байжээ. Хотын хүн ам 1987 онд нийт хүн амын 54.0 хувийг эзэлж 1.053 сая байсан бол 2015 онд хүн амын 68.8 хувьтай тэнцэж 2.096 сая болтол өссөн байна. Хотын хүн амын жилийн дундаж өсөлт 1987-2015 оны хооронд 2.40 хувьтай байсан нь хөдөө орон нутгийн хүн амын өсөлт 0.24-тэй харьцуулбал 10 дахин илүү байна. Монголчууд амьдралын уламжлалт нүүдэлчин хэв маягаас татгалзан хот сууринд шилжиж, нүүдэлчин болон хөдөө орон нутгийн хүн ам дагамгайлж байсан түүхийн уламжлал өөрчлөгдөн, өнөөгийн Монгол нь хүн амын гуравны хоёр нь хот сууринд амьдардаг хотжисон улс болжээ. Үүнийг даган хот, тосгон, бусад суурин газар, хотын барилгын талбай, аж үйлдвэр, уул уурхайн талбай, хотын нийтийн эдэлбэр газар нь 1997 онд 523,600 га байсан бол 2015 онд 716,900 га болтол тэлсэн байна (Хүснэгт 12.1).

Нийслэл Улаанбаатар хот нь улсын хотжилтад тэргүүлэх үүрэг гүйцэтгэж, нийт хүн амын 46 хувь, хот суурины оршин суугчдын 67 хувь Улаанбаатарт амьдарч байна. Улаанбаатарын хүн амын 60 гаруй

хувь нь ус хангамжийн хоолой, ариун цэвэр, засмал зам, олон нийтийн тээврийн үйлчилгээ зэрэг орчин үеийн дэд бүтэц сул хөгжсөн хотын захын гэр хороололд амьдарч байна. Нийслэл хотын төлөвлөгөөгүй тэлэлт, хөдөөгөөс хот руу шилжин суурьших хурдацтай хөдөлгөөн нь ажилгүйдэл, замын түгжрэл, агаар хөрсний бохирдол, гэр хорооллын тэлэлт зэрэг олон сорилт бэрхшээлийг бий болгож байна.

**Хүснэгт 12.1: Газрын ангилалуудын эзлэх талбай, 1997-2015 он, сая га**

Он	ХАА-н газар	Хот, суурины газар	Зам, шугам сүлжээний газар	Ойн сан бүхий газар	Усны сан бүхий газар	Тусгай хэрэгцээний газар
1997	128.89	0.52	0.20	17.85	1.68	7.27
1998	129.13	0.38	0.33	17.85	1.67	7.06
1999	130.36	0.40	0.33	18.29	1.67	5.37
2000	130.54	0.42	0.34	18.29	1.67	5.16
2001	130.17	0.42	0.37	18.63	1.67	5.15
2002	130.17	0.43	0.36	18.63	1.67	5.15
2003	115.58	0.43	0.35	14.67	0.94	24.43
2004	115.46	0.44	0.35	14.69	0.97	24.50
2005	115.23	0.47	0.36	14.75	0.97	24.64
2006	116.04	0.49	0.36	14.30	0.67	24.56
2007	116.99	0.51	0.37	14.23	0.67	24.65
2008	115.82	0.53	0.37	14.23	0.67	24.79
2009	115.59	0.54	0.38	14.32	0.67	24.92
2010	115.53	0.62	0.41	14.30	0.68	24.88
2011	115.49	0.67	0.43	14.26	0.69	24.88
2012	115.40	0.70	0.44	14.26	0.69	24.93
2013	115.36	0.70	0.44	14.30	0.69	24.93
2014	115.01	0.71	0.45	14.32	0.69	25.23
2015	114.98	0.72	0.46	14.33	0.69	25.23
2016	114.93	0.75	0.47	14.33	0.69	25.23


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2016 он.

Тайлбар: Нийт нутаг дэвсгэр 156.41 сая га.

#### Хөдөө аж ахуйн үйл ажиллагаа

ХАА, бэлчээр, хадлан, газар тариалан, жимс жимсгэнэ тариалах газар, ХАА-н барилга байгууламж, ХАА-н бусад үйлдвэрлэлийн зориулалтын газар нь улсын нийт газар нутгийн 70 гаруй хувийг эзэлж байна. ХАА-н газар 1987 онд нийт нутаг дэвсгэрийн 79.8 хувийг эзэлж ойролцоогоор 124.889 сая га байсан бол 2015 онд 73.5 хувийг эзэлж, 114.983 сая га болж буурчээ (Зураг 12.2). Их хэмжээний газрыг улсын тусгай хамгаалалтад авсаны улмаас 2002 -2003 оны хооронд ХАА-н газар 14.590 сая га-гаар огцом буурсан байна.

**Зураг 12.2: ХАА-н газар, бэлчээр, малын тоо, 1987-2016 он**



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2017 он.

Бэлчээр, мал аж ахуй

Бэлчээрийн газар нь 2016 оны байдлаар ХАА-н нийт эдэлбэр газрын 97.7 хувийг эзэлж байна. Монгол орны хувьд бэлчээрийн газар гэсэн нэр томъёог бэлчээрийн мал аж ахуйд ашиглах, хадлан тэжээл хадах зорилгын үүднээс өргөн хэрэглэдэг боловч энэ газрыг өвст хээр газар (rangeland) гэж зөвөөр тайлбарлууштай бөгөөд учир нь энд унаган өвс ургамал ургаж, олон төрлийн бэлчээрийн амьтад, махчин амьтад, ховордсон шувууд зэрэг зэрлэг амьтдын амьдрах орчин болдог юм.


Бэлчээрийн газар 1987 онд 123.554 сая га байснаа 2015 он гэхэд 9.16 хувиар хорогдож 112.7 сая га болсон байна. Харин энэ хугацаанд малын тоо толгой 1987 онд 22.741 сая байснаас 2016 он гэхэд 61.549 сая толгой болж 2.7 дахин өсчээ (Зураг 12.2). Малын тоо толгой өссөн нь малын нягтралыг нэмэгдүүлж, 1987 онд нэг га-д 18 толгой мал ноогдож байсан бол 2016 онд 54 толгой болж өсчээ. Энэ нь бэлчээрт учруулах дарамтыг нэмэгдүүлж байна. Монголд мал сүргийн бэлчээрлэлтийг хязгаарладаггүй нь бэлчээрийн даацын асуудлыг улам хүндрүүлж байна. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газраас (ГХГЗЗГ) хийсэн үнэлгээгээр бэлчээрийн даац 30 гаруй хувиар хэтэрсэн байна. 2015 оны сүүлийн байдлаар бэлчээрийн нийт газрын 63 орчим хувьд даац нь ноцтой хэтэрсэн байна.

Малын тоо толгой өсөхийн сацуу бүтцэд ихээхэн өөрчлөлт гарч, сүүлийн жилүүдэд ноолуурын зах зээлийн хэрэгцээ, үнэ өсч байгаатай холбогдуулан малчид ямаа үржүүлэхэд илүү анхаарах болсон байна. Ямааны тоо толгойн нийт мал сүрэгт эзлэх хувь 1987 онд 19.3 хувь байснаа 2015 онд 42.1 хувь болтол өссөн бол бусад мал, үхэр, хонь, адуу, тэмээний тоо толгойн эзлэх хувь буурсан байна. Ямаа нь зөвхөн өвсний иш навч төдийгүй өвсний үндсийг иддэг нь бусад малтай харьцуулвал бэлчээр байгаль орчинд хавьгүй илүү хохирол учруулдаг байна.

Газар тариалан, үр тарианы үйлдвэрлэл

ХАА-н эдэлбэр газарт тариалангийн газар нэг хүрэхгүй хувийг эзэлдэг. Тариалангийн газар 1987 онд 1,334 сая га байсан бол 2016 онд 1,067 сая га болтол буурсан (Зураг 12.3). Тариалангийн энэ газрын бага хэсгийг үр тарианы үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байна. 1980-аад оны сүүлч, 1990-ээд оны эхээр тариалангийн газрын тэн хагасаас илүүг үр тарианы үйлдвэрлэлд ашиглаж байсан бол тэр үеэс хойш нийт тариалангийн газарт эдэлбэр газрын эзлэх хувь буурч, 1994-2008 онд маш бага, тухайлбал 2000 онд хамгийн бага 18 хувьд хүрч байжээ. Энэ хугацаанд тариалангийн газрын ихэнхийг ашиглахгүй атаршуулж орхисон байсан тул Засгийн газраас үр тарианы үйлдвэрлэлийг сэргээх зорилгоор 2008 онд Атрын аян-III үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлжээ (Засгийн газрын 2008 оны 70 дугаар тогтоол).

**Зураг 12.3: Тариалангийн болон эдэлбэр газар, 1987-2016 он, мянган га**



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2017 он

Хуурай уур амьсгалтай, өвөл урт удаан үргэлжилдэг нь таримлын ургац боловсролтын хугацааг хойд бүсэд 80-100 хоног, өмнөд бүсэд 120-140 өдрөөр хязгаарлаж, ургац боловсролтын тохиромжгүй

нөхцөлийг бий болгодог байна. Улаанбуудай, арвай, овьёос, хөх тариа, сагаг зэрэг амуу тариа нь тариалангийн хамгийн гол төрлүүд ба дараа нь төмс, хүнсний ногоо орно. 2016 онд 377,800 га-д амуу тариа, 15,000 га-д төмс, 9,050 га-д хүнсний ногоо тарьжээ. Мөн 29,900 га-д малын тэжээл тариалсан байна. Атрын аян-III үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Монгол улсын ХАА салбар дотоодын хэрэгцээг хангахуйц үр тариа, төмс хурааж байна. Хүнсний ногооны 60 гаруй хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна.

Уур амьсгалын өвөрмөц нөхцөл, хур тунадас бага унадаг нь хүйтэн, хуурай нөхцөлд тэсвэртэй ургамал тариалах, газар тариаланд усжуулалтын систем нэвтрүүлэхийг шаарддаг. Усжуулалтыг хур тунадас ургац боловсроход хангалттай бус нөхцөлд голдуу нэмэлт хэлбэрээр ашигладаг. Монголын усжуулалттай талбай 1990 оны байдлаар 91,000 га байснаас 90 гаруй хувийг нь гадаргын усаар усжуулдаг байжээ. Усжуулалттай талбай 1998 онд 5,000 га болтол буурч, 2010 онд 37,000 га (нийт тариалангийн газрын 10 орчим хувь) болтол дахин өсчээ. Өнөөгийн байдлаар ихэнх ургацыг усжуулалтгүй нөхцөлд ургуулдаг тул ургацын хэмжээ цаг агаарын нөхцөлөөс ихээхэн хамаардаг байна.

Монголд хаврын газар хагалалт хүчтэй салхитай үетэй давхацдаг бөгөөд тариалангийн ихэнх талбай ойн зурвас зэрэг салхины бусад хамгаалалт байхгүй. Говьд салхины дундаж хурд 3-4 метр секунд, түүнээс илүү байдаг нь хөрсний чийгийг үлэмж хорогдуулах, элэгдлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болдог байна. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд газар тариалангийн эдэлбэр газрын га бүрээс дунджаар 35-50 тонн хөрс алдагдсан тооцоо гаргасан байна. Монгол улсын эдэлбэр газрын тэн хагас нь ямарваа нэгэн хэмжээгээр доройтсон байна. Шинээр тариалангийн зориулалтаар хагалж буй газар нь ихэвчлэн бэлчээр ба энэ газрын дийлэнх хувь нь ач холбогдол багатай, байгалийн хувьд газар тариаланд ашиглахад тохиромжгүй юм.

### *Ой*

Ойн сан бүхий газар 2016 оны байдлаар улсын нийт нутаг дэвсгэрийн 11.8 хувьд 18.45 сая га талбайг эзэлж байна. Үүнээс зөвхөн 12.28 сая га талбай буюу нийт нутгийн 7.85 хувь нь жинхэнэ ойгоор бүрхэгдсэн талбай юм (Зураг 12.4). Ойн болон ойн бус үйл ажиллагаа, хэт бэлчээрлэлт, дараалсан ойн түймэр, хортон шавьжинд эдэгдсэнээс болоод ашиглах боломжгүй болсон ойн талбай 5.63 сая га байна.

Монголын ойг хойд нутгийн ой хээрийн бүсийн шилмүүст, арктикийн болон уулын бүсийн ой (нийт ойн талбайн 75 хувь), өмнөд нутгийн цөл, цөл хээрийн бүсийн заган (ойн нийт талбайн 25 хувь) гэж үндсэн 2 төрлөөр ангилж болно (Хавсралт 4, Газрын зураг 8). Хойт хэсгийн хуурай ой нийт ой бүхий талбайн 84.7 хувийг эзэлнэ. Ойн бүх нөөц улсын мэдэлд байна.

Ой хомсдох, ойгүйжих явц нь голдуу цэвэрлэгээний огтлолт, түлээний модны бэлтгэл, түймэр болон хортон шавьжинд идэгдэхтэй холбоотой байна. Статистикийн хорооны мэдээгээр жил тутмын зөвшөөрөлтэй мод бэлтгэлийн хэмжээ 1999-2015 оны хооронд 0.625 сая шоо метр байна. Үүний зэрэгцээ жил тутам 1 сая үоо метр шургааг болон түээний модыг хууль бусаар огтолж байгаа нь зөвшөөрөлтэй мод бэлтгэлээс бараг 2 дахин илүү байна. Монголд зөвшөөрөлгүй мод бэлтгэлийг амьжиргааны үндсэн хэрэгцээг хангах, амьжиргааг дээшлүүлэх, худалдан борлуулах зэрэг гурван гол зориулалтаар хийдэг байна. Жилд дунджаар 0.5 сая га ой ойн түймэрт өртдөг бол 0.6 сая га ой хорт шавьжны улмаас сүйтэж байна

### *Тээвэр*

Монгол Улс нийт 49,200 км урт замын сүлжээтэй, үүнээс 12,700 км нь улсын, 36,500 км нь орон нутгийн мэдлийн зам байна. Улсын мэдлийн зам нь Улаанбаатар хотыг аймгуудын төвтэй холбодог. Сүүлийн жилүүдэд хатуу хучилттай олон зам тавигдаж байгаа хэдий ч авто тээрийн хэрэгслийн хөдөлгөөн шороон замаас хамааралтай хэвээр байна. Авто замын 90 гаруй хувь нь шороон, 10 хүрэхгүй хувь нь хатуу болон хайрган хучлагатай байна. Замын сүлжээ нь 2009 оны байдлаар зөвхөн 2,680 км хатуу хучилттай, 2,100 км хайрган, 1,730 км сайжруулсан шороон замтай байсан бол 2013, 2014 онуудад 2,656 км хатуу хучлагатай зам тавьснаар хатуу хучлагатай замын нийт урт 5,300 км болтол нэмэгджээ. Хатуу хучлагатай замын урт 2016 онд 7,500 км болтол нэмэгджээ.



**Фото зураг 12.1: Хатуу хучилтгүй шороон зам**

Улсын мэдлийн гол 12,700 км замын дагуу дунджаар 164 метрийн өргөн шороон зурвас байгуулсны улмаас 3 сая гаруй га газар доройтолд орсон байна. Харьцангуй бага ачаалалтай үлдсэн 36,500 км зам нь улсын мэдлийн замтай адил хэмжээнд газрыг доройтуулах хандлагатай байна. Төлөвлөж буй Монголыг дайран өнгөрөх хурдны замын дагуу дунджаар 788 метрийн өргөн зурвас (замын хөдөлгөөний 225 эгнээтэй тэнцэх) газрын доройтолд нөлөөлөх болно. Үүнээс үзэхэд энэхүү транс-Монголын 20 метр өргөн хатуу хучилттай хурдны зам нь зөвхөн 6,000 га газрыг эзэлж байгаа бол түүний нөлөөгөөр доройтолд өргөх газрын талбай 236.700 га болох төлөвтэй байна.

Туулах өндөр чадвартай машинууд газрын хөрсийг нягтруулж, чийг, тэжээлийг шингээх, хадгалах газрын чадавхид хохирол учруулж байна. Гадаргын усны урсацын хэмжээ, хурд нь нэмэгдэж байгаа нь усны эх үүсвэрүүд дээр хөрсний элэгдэл хүчтэй явагдахад хшргэж байна. Аяаны автомашины зам гарсанаас болж эвдэрсэн газрын ургамлын бүрхэвч шороон замыг ашиглахыг бүрмөсөн зогсоосноос хойш 10-15 жилийн хугацаанд хөрс бүрэн сэргэдэг байна. Ийм том зурвас талбайд ургамлын хомсдол, хөрсний элэгдэл, доройтол үүсч байгаа нь өнөөгийн цөлжилтийн аюулыг улам даамжруулж байна. Монголд авто зам нь одоогийн байгаа машин тэрэгний шаардлагатай хэмжээнээс 4 дахин илүү байгаа тооцоо гарсан бөгөөд энэ нь 0.7 сая га газрын доройтолд нөлөөлж байна.

*Уул уурхай*

Монгол Улс нь ашигт малтмалын баялаг нөөц, нүүрс, зэс, алт, модибден, тугалга, диц, хөнгөн цагаан, цагаан тугалга зэрэг томоохон ордуудтай. Уул уурхай нь үйлвэрлэлийн хамгийн том салбар бөгөөд эдийн засгийн гол хөшүүрэг юм. Уул уурхай, олборлолт нь 2016 онд ДНБ-ний 20.1 хувийг бүрдүүлж, Монголын нийт экспортын 70.86 хувийг ашигт малтмалын бүтээгдэхүүн эзэлж байна.

Өмнө говийн бүсэд орших Оюу толгойн зэс, Таван толгойн нүүрсний уурхайнууд уул уурхайн хамгийн том төслүүд юм. Уул уурхайн бас нэг томоохон аж ахуйн нэгж нь Эрдэнэтийн уулын баяжуулах



үйлдвэр юм. 2013 оны байдлаар 1,753 компанийн эзэмшлийн, 17.5 сая га талбайг хамарсан уул уурхайн 3,285 тусгай зөвшөөрөл байснаас гадна улс даяар бичил болон хувийн жижиг олон уурхай (БХЖУ) үйл ажиллагаа явуул байна. БХЖУ-уудын дийлэнх буюу 80-90 хувь нь алт, бусад нь нүүрс, жоншны олборлолт эрхэлдэг, хаагдсан том уурхайнуудын талбайг голдуу ашигладаг байна.

Хөгжиж буй уул уурхайн салбар нь Монголын орны байгаль орчин, тухайлбал бэлчээрийн доройтол, ус, хөрсний бохирдол, зэрлэг амьтан, ургамлын амьдрах орчинд шинэ дарамт, бэрхшээл учруулж байна. Том эрэл хайгуул, уурхайн үйл ажиллагаа ихээхэн хохирол учруулж болох хэдий ч БХЖУ-уудад химийн бодисыг аливаа хяналтгүйгээр ашиглаж байгаа нь байгаль орчинд мөн хохирол учруулж байна. Уул уурхайтай холбоотой байгаль орчны хамгийн ноцтой асуудлууд нь хаягдлын нэвчилтээс гарсан хяналтгүй химийн хаягдал, хаагдсан уурхайн дутуу, хангалтгүй нөхөн сэргээлт юм. Нүүрс, алтны уурхайн үйл ажиллагаанаас 100,000 га газар доройтсон гэсэн тооцоо байна. Уул уурхайн ажиллагаанаас доройтсон газрын багахан хэсгийг нөхөн сэргээж байна.

#### *Хог хаягдлын менежмент*

Бүх төрлийн хог хаягдлын мэдээллийг тооцож, хотын бүсэд гаргаж буй хот суурины хатуу хаягдлын (ХСХХ) хэмжээг Улаанбаатар хотын захиргаанаас өгсөн мэдээлэлд үндэслэн тооцоолов. Улаанбаатар хотын иргэн бүр жилд ахуйн 360 кг хог хаягдал гаргадаг нь энэ тооцооноос харагдаж байна. Монгол улсад 2016 онд 1.7 сая тонн ХСХХ цуглуулснаас 40 хувь нь Улаанбаатар хотод ноогдож байна. Тооцоогоор Монгол улсад жилд 27,000-54,000 орчим тонн аюултай хог хаягдал үүсч байна.

#### **Фото зураг 12.2: Уул уурхайн үйл ажиллагаанаас үүссэн газрын эвдрэл**



Одоогоор Монголд хатуу хог хаягдлын зохистой менежментийн практик туршлага хомс байна. Монгол улсад 125,000 га орчим талбай бүхий хог хаягдлын 400 орчим төвлөрсөн цэг бий. Хог хаягдлыг устгах тогтолцоо нь шаардлага хангахгүй байгаагаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд ноцтой асуудал үүсгэдэг байна. Өнөөгийн байдлаар ахуйн, үйлдвэрлэлийн, барилгын болон бусад төрлийн хог

хаягдлыг хот, суурины захад байрлах хог хаягдал устгах газарт хөрсөн дээр ил асгаж байгаа нь хөрсний бохирдол, газрын доройтлыг үүсгэж байна. Жишээ нь Улаанбаатар хотын ойролцоо хог хаягдал устгах зөвхөн 2 цэг, задгай хэд хэдэн талбай байна.

### Хөрсний доройтол

Хөрс, ургамлын бүрхэвчинд салхины үзүүлж буй сөрөг нөлөөлөл нь газрын доройтлын нэг гол хүчин зүйл болдог байна. Нийт нутаг дэвсгэрийн 60 гаруй хувь нь салхины элэгдэлд өртдөг (Хавсралт IV, Газрын зураг 5). Говь цөлийн бүс, Их нууруудын хотгор, нууруудын хөндийд салхины элэгдлийн түвшин хамгийн өндөр байдаг байна. Баруун хуурайн хотгор, Өмнө Алтайн говь, Улаан нуур, Мандал овоогийн нутагт ургамлын бүрхэвч хомс, газрын гадаргуу тэгш, салхи хаах саад тотгоргүйн улмаас салхины нөлөөллөөр хөрсний элэгдэл хамгийн ноцтой, энэ нутагт салхины нөлөөллөөр га тутмаас 165.7 тонн хөрсний алдагдал учирсан тооцоо гарсан байна. Монголын хээр тал, говь хээр нутаг, тухайлбал Дорнодын тал, Замын Үүд, Сайншандын бүсүүд салхины нөлөөллийн элэгдэлд дунд зэрэг өртсөн нутагт ордог бол уулын бүсүүд салхины нөлөөлөл бага, хөрсний салхины элэгдэлгүй бүсэд хамаарагддаг. Их нууруудын хотгорын баруун хэсэг, Хар ус нуур болон Буянт голын сав газрын орчимд салхины нөлөөллийн хөрсний элэгдэл буурсан байна.

Монголд усны нөлөөллөөр хөрс элэгдэх явдал газрын доройтолд бага сөрөг нөлөөтэй байдаг байна. Нийт нутаг дэвсгэрийн 9 орчим хувь нь усны нөлөөллийн хөрсний элэгдэлд өртдөг гэж үздэг (Хавсралт IV, Газрын зураг 6). Жилд усны нөлөөллөөр 300-400 тонн хөрс алдагддаг гэсэн тооцоо байна. Усны нөлөөллийн хөрсний элэгдлийн эрч нь ургамлын бүрхэвч, гадаргын налуу өнцөг, хөрсний бүтэц, хур тунадасын ууршилт зэргээс шалтгаалан Их нууруудын хотгор, нууруудын хөндий, нам өндөртэй уул, хотгор бүхий говийн зүүн бүсэд усны нөлөөллийн хөрсний элэгдэл бага байна. Энэ бүсүүд усны нөлөөллийн хөрсний элэгдэлтэй нийт талбайн 92 хувийг эзэлдэг. Уулын болон уулын бэлийн бүс нутагт усны нөлөөллийн хөрсний элэгдэл хамгийн их, тухайлбал Монгол Алтай, Говь Алтай, Говийн уулсын бэл, Хангай, Хан Хөхийн нурууны өмнөд хэсэгт их байна. Энэ бүсүүд усны нөлөөллийн хөрсний элэгдэлтэй нийт талбайн 4 хувийг эзэлдэг. Өргөн нуга, том голуудын сав газар бүхий Монголын нутаг дэвсгэрийн төв хэсэгт усны нөлөөллийн хөрсний элэгдэл дунд хэмжээнд байгаа ба харин хур тунадас ихэссэн, ургамлын бүрхэвч багассанаас болж Монголын хойд нутгийн усны нөлөөллийн хөрсний элэгдэл нэмэгдсэн байна.

## 12.2 Газрын доройтлоос учирч буй саад бэрхшээл

Газрын доройтол нь Монгол Улсын байгаль орчны хамгийн ноцтой асуудлуудын нэг юм. Газрын доройтол нь газрын эдийн засгийн болон биологийн бүтээмж, газрын үржил шим буурах, алдагдахад хүргэж байна. Монгол улсад газрын доройтлын талаар сүүлийн үед хийсэн үнэлгээнээс үзвэл 2015 оны байдлаар нийт нутаг дэвсгэрийн 76.8 хувь ямарваа нэгэн хэмжээгээр доройтсон, үүнээс 24.1 хувь бага, 29.8 хувь дунд, 16.8 хувь хүчтэй, 6.1 хувь нэн хүчтэй зэрэглэлд доройтсон болохыг тогтоожээ (Хүснэгт 12.2). Хүчтэй болон нэн хүчтэй доройтсон зэрэглэлд Увс нуурын сав газрын хуурай, говь хээрийн бүс, Их нууруудын хотгор, Дундговь, Дорноговь аймгууд хамрагдаж байна (Хавсралт IV, Газрын зураг 7).

Хүснэгт 12.2: Газрын доройтол, 2006, 2010, 2015 он, нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь

Он	Сул доройтсон	Дунд зэрэг доройтсон	Хүчтэй доройтсон	Маш хүчтэй доройтсон	Нийт нутагт эзлэх хувь, %
2006	23.0	26.0	18.0	5.0	72.0
2010	35.3	25.9	6.7	9.9	77.8
2015	24.1	29.8	6.1	6.1	76.8

Эх сурвалж: Монгол Улсын Цөлжилтийн атлас, 2015 он.

### Ой болон ойн дагавар бүтээгдэхүүн

Мод, түлшний модны жилийн борлуулалтын нийт өртөг 200 тэрбум төгрөгт хүрч байгаагаас тал хувь нь зөвшөөрөлгүй мод бэлтгэлийн борлуулалтад ноогдож байна. Ойн дагавар бүтээгдэхүүний жилийн борлуулалтын нийт өртөг бараг 16.5 тэрбум төгрөг байгаагаас 90 хувь нь зөвшөөрөлгүй үйл ажиллагаанд ноогдож байна.

Ой бүхий газрын доройтол нь мод бэлтгэл, ойн дагавар бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ буурах гол шалтгаан болж байна. Гэвч мод бэлтгэл, ойн дагавар бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ буурахад ойн газрын доройтлын үзүүлсэн сөрөг нөлөөллийн судалгаа үнэлгээ Монголд хийгдээгүй байна.

#### *Биологийн олон янз байдал болон экосистем*

Мал маллагааны үйл ажиллагаа уламжлалт 4-улирлын арга хэлбэрээс өнөөгийн 2-улирлын хэлбэрт шилжиж байгаагаас бэлчээр дахин сэргэх хугацаа улам богиносч байна. Энэ өөрчлөлт нь малын тоо толгой өссөн, сүргийн бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотой байна. Ийнхүү мал маллагааны арга хэлбэр өөрчлөгдөж, газар болон бэлчээрийн нөөцийг хэт ихээр ашиглаж байгаа, мөн түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл эрс нэмэгдэж байгаагаас амьтан, ургамлын оршин тогтнох бүс нутаг хумигдах, нөөц нь багасахад хүргэж улмаар олон тооны амьтан, ургамал ховордсон ангилалд хамрагдахад нөлөөлсөн гол хүчин зүйл болж байна.

#### *Хөрс*

Газрын доройтол нь хөрсний органик бодисын агууламж, үр шимийг буурахад хүргэж байна. Бэлчээрийн даац хэтэрсэн, доройтолд орсны улмаас хөрсний үржил шим буурч, хөрсний химийн бодисын агууламж өөрчлөгдөж байна. Монгол улсын бэлчээрийн даацыг хэтрүүлсэн газрыг бэлчээрийн бус газартай харьцуулвал хөрсний органик бодисын агууламж 30-50 хувь, солигдмол кальцийн агууламж 40-60 хувь бага байна. Газрын доройтол нь мөн хөрсний усны физик нөхцөлд нөлөөлж, хөрсний гадаргуугын температур нэмэгдэх, чийгшилт буурахад хүргэж байна. Түүнчлэн мал сүргийн хөрсний өнгөн хэсэгт үзүүлж буй сөрөг нөлөөллийн улмаас өнгөн хөрс нягтарч, улам хатуу болж байна. Монголд хөрсний доройтлын асуудлаар ямарваа нэгэн судалгаа үнэлгээ хомс байна.

#### *Ургамал*

Ургамал бүрхэвчийг ургамлын нормчилсон зөрүүгийн индекс (NDVI) ашиглан тооцож болно. Монголд NDVI-ийн үнэлгээ бүсээр ялгаатай, тухайлбал говийн бүсэд 0.05-0.18, хээр, ой хээрийн бүсэд 0.2-0.35, ой хээр, ойн бүсэд 0.4-0.5-ийн үнэлгээтэй байна. Өнгөрсөн арван жилд Монгол Дагуурын хээр тал, зүүн говийн хөндий, өмнөд говийн хээр тал, Хангайн нурууны бүсийн ургамлын бүрхэвч сайжирч, эдгээр бүсийн NDVI-ийн утга нэмэгдсэн байна. Харин Монгол Алтайн нуруу, Их нууруудын хотгор, Хөвсгөлийн уулсын баруун хэсэг, Орхон Сэлэнгэ голуудын сав газар, төв халхын өндөрлөг, өмнөд говь, Даригангын бүс нутагт ургамлын бүрхэвч үргэлжлэн буурах хандлагатай байна. Мөн ХАА-н бүс хойд зүгт тэлж байгаагаас зүүн Монголын тал хээрийн бүс өргөжиж ойт хээрийн бүс хойд хэсэгт төвлөрөхөд хүргэж байна. Монголд өндөр уулс, ой хээрийн бүсийн талбай багасч, харин хээр тал, говь хээрийн бүс өргөжих хандлагатай байгаа ажээ.

#### *Агрономын бүтээгдэхүүн*

Газрын доройтлын сөрөг шууд нөлөөлөл нь газар ашиглагчдад газар тариалангийн бүтээгдэхүүний бууралтаар мэдрэгдэж байна. Газрын доройтлын үр дүнд ургамлын үндэсний зохистой гүн буурах, ургамлын тэжээллэг чанар болон хөрсний органик нүүрс төрөгч алдагдах, ургамлын усны агууламж багасах, тариалан, эдэлбэр газар багасах, үрийн нөөцөд хохирол учрах зэрэг зарчмын олон өөрчлөлт газар тариалангийн бүтээгдэхүүн буурахад хүргэж байна.

Монголын нийт бэлчээрийн 90 орчим хувь нь газрын доройтол болон цөлжилтөд ихээхэн эмзэг юм. Бэлчээрийн бүтээгдэхүүн говь цөл болон ойн бүсэд аль алинд нь 1997-2008 онуудад өвөл, отрын бэлчээр нутагт үлэмж буурсан бол мал иддэггүй ургамлын төрөл нэмэгдсэн, отрын бэлчээрийн ус багассаны улмаас зуны бэлчээрийн үржил шим, бүтээгдэхүүн ялимгүй өссөн байна<sup>1</sup>. Тухайлбал 2008 оны говь нутгийн өвлийн нийт бэлчээрийн хэмжээ 1997 оныхтой харьцуулвал 78.8 хувиар буурсан, говь хээрийн бэлчээрийн малын тэжээлийн ургац 1997 онд дунджаар га-д 544.6 кг байсан бол 2008 онд 20 хувиар буурч га тутмын ургац 443.1 кг болсон байна.

<sup>1</sup> Sheehy, D.P. and D. Damiran. Assessment of Mongolian rangeland condition and trend (1997-2009). Final report for the World Bank and the Netherlands-Mongolia Trust Fund for Environmental Reform (NEMO), 2012.



Фото зураг 12.3: Давсжсан газар



#### *Усны нөөц*

Газрын доройтол нь гол, нууруудын ус бүрэлдэхэд нөхцөлд нөлөөлнө. Хур тунадас, үерээр хөрсний гэжээл, үнэт бичил биетүүд хөрсний элэгдлээр гол, нуурт хуримтлагдаж, ингэж гол, нууранд хөрс хуримтлагдах нь усны сав газрын ус хадгалах чадварыг бууруулдаг байна. Монголын Хомын талын баруун хэсэгт бор хөрс бүхий элсэрхэг говийн томоохон газрыг тариалангийн зориулалтаар ашиглаж эхэлсэн бөгөөд энэ талбайд ургац авах боломжтой гэж үзэж байжээ. Гэвч энэ үйл ажиллагааны дүнд үр шимтэй хөрс салхины нөлөөллөөр элэгдэж, зарим хэсэг нь давсжин эвдэрч, улмаар говийн газрын гүний давслаг усны эргэлтийг бууруулсан байна. Түүнчлэн газрын доройтол нь голын усны түвшин нэмэгдэхэд нөлөөлж, үерийн аюул, эрсдлийг нэмэгдүүлж болзошгүй.

#### *Орон нутгийн иргэдийн хөгжил, амьжиргаа*

Монгол Улс нь дэлхийн хамгийн хүн амын нягтрал багатай улсын нэг боловч доройтсон газар нутагт амьдарч байгаа хүн амын эзлэх хувь өндөр байна. Газрын доройтол нь орон нутгийн хүн амд олон талаар нөлөөлж байна. Орлого, ажлаа алдаснаас хүн амын амьжиргааны бодит түвшинг буурсан, газрын бүтээгдэхүүний үр бүтээмж багассаныг нөхөх зорилгоор үйлдвэрлэл, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд боловсрол, нийгмийн үйл ажиллагаанд зарцуулах цагийг ашиглах зэрэг шууд нөлөө үзүүлэхийн зэрэгцээ, орон нутгийн эдийн засгийн болон нийгмийн төлөв байдлыг доройтуулах, доройтсон газартай харьцаж байгаагаас учрах эрүүл мэндийн эрсдэл зэрэг шууд бус нөлөө гарч байна. Газрын үйлдвэрлэлийн бүтээмж багасах нь орон нутгийн оршин суугчдын орлогын эх үүсвэрийг хязгаарлан, ядууралд хүргэж, хот сууринд шилжих хөдөлгөөнийг нэмэгдүүлнэ. Салхины нөлөөллийн элэгдэл нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэйн зэрэгцээ тээврийн байгууламжуудад хохирол учруулдаг. Говь, хээрийн бүсэд элсэнд дарагдсан, элсний нүүдлээс хохирсон 145 суурин байна. 1960 онтой харьцуулвал тоос, шороон шуургатай өдрийн тоо 3-4 дахин нэмэгдэж, говь болон Их нууруудын хотгорт 61-127 өдөр болтол өсчээ.



### 12.3 Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл ба дасан зохицол

Уур амьсгалын өөрчлөлт нь 1940-2014 оны хугацаанд Монгол орны жилийн дундаж температур Цельсийн 2.1 градусаар нэмэгдэхэд хүргэж, сүүлийн жилүүдэд энэ үйл явц түргэсэх хандлагатай байна. Өнгөрсөн 70 жилийн хамгийн халуун зунтай 10 жил нь 1997 оноос хойш тохиожээ. Температур өсөхийн сацуу Монголын өмнөд, төв бүсийн хур тунадасын жилийн хэмжээ ялимгүй буурсан байна. Хур тунадасын улирлын горим өөрчлөгдөн өвлийн хур тунадасын хэмжээ нэмэгдэн, харин зуны борооны хэмжээ багасч байна. Зуны хур тунадасын хувьд зөөлөн, үргэлжилсэн, нутаг дэвсгэрийн ихэнхийг хамарсан зүс борооны давтамж буурч, харин хүчтэй, усархаг аадар бороо зурваслан орох нь ихэсчээ. Температурын огцом өсөлт, дулааны улирлын хур тунадас багассаны улмаас говьд хуурайшилт 3-10 хувь, ой хээр, өндөр уулын бүсэд 10-15 хувиар тус тус өсчээ.

#### *Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл*

Өнгөрсөн 20 жилийн уур амьсгалын өөрчлөлтийн улмаас бэлчээрийн нийт ургацын хэмжээ 5-13 хувиар буурсан нь улсын зүүн бүсийн төв, баруун хэсгийн 1961-1990 оны жилийн дунджаас илүү байна. Бэлчээрийн биомасс буурсан, халуун салхи нэмэгдсэн нь малд халууны дарамт учруулан, улмаар бэлчээрт хангалттай тарга авахгүй байгаагаас бие нь давжаарч жижгэрч байна.

Уур амьсгалын өөрчлөлт газар тариаланд сөргөөр нөлөөлж байна. Газар тариалан Монголд өндөр эрдэлтэй, цаг агаараас шалтгаалан ургацын хэмжээ 50 хүртэл хувиар хэлбэлзэх, заримдаа ургацыг бүрмөсөн алдах магадлалтай байдаг. Газар тариаланд уур амьсгалын үзүүлж буй нөлөөлөл хүнс болон малын тэжээлийн усалгаагүй газар тариалангийн салбарт хамгийн тод илэрч, усалгаагүй газар тариалан улам тогтворгүй болж байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан усалгаагүй газрын ургац 10-15 хувь хорогдох магадлалтай. Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан улаан буудайн үйлдвэрлэл 2030 он гэхэд 15 хувиар буурч болзошгүй байна. Цаг агаарын нөхцөл байдал эрчимтэй хуурайшиж байгаа нь ой, хээрийн түймэр, ойн хортон шавьжны өргөн тархалтын давтамжийг нэмэгдүүлж байна. Үүний улмаас жил тутам ойн талбай 0.46 хувиар хорогдож, ойн нөөц ихээхэн доройтож байна.

#### *Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохуй*

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зарим арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэлж байна, жишээлбэл улсын төсвөөс жилд 1.0 сая орчим ам.долларыг бэлчээрийн хортон шавьж, мэрэгчийг устгах шинжлэх ухааны үндэслэлтэй, байгальд ээлтэй үйл ажиллагааг эрчимжүүлэхэд зарцуулж байна. Бэлчээр, хөрсний хяналт мониторингийн тогтолцоог бүрдүүлжээ. Тариалангийн нийт талбай 2015 оны байдлаар 750,000 га, үүнээс 450,000 га нь дахин сэргээсэн атаржсан тариалангийн талбай байна.

Үндэсний зорилтот хувь нэмэр 2015 оны баримт бичигт дасан зохицох алсын харааны чиглэлүүдийг тодорхойлж бэлчээрийн менежментийг сайжруулах замаар экологийн тогтолцооны тэнцвэртэй байдлыг хадгалах, эрчимжсэн МАА-г хөгжүүлэх; тариалангийн ургамлын төрлийн дунд болон удаан хугацааны сэлгэн тариалах хуваарь гаргах, цас, борооны усыг хуримтлуулах зэрэг ус хэмнэх технологийг нэвтрүүлэх, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх, хөрсний чийг алдах нөхцөлийг бууруулах замаар улсын нийт хэрэгцээг хангах газар тариалангийн салбарыг бий болгох; ойн доройтлыг бууруулах, ойг сэргээх, ойн тогтвортой менежментийн стратегийг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна.

### 12.4 Хууль эрх зүй, бодлого, бүтэц зохион байгуулалтын тогтолцоо

#### *Хууль эрх зүйн тогтолцоо*

Газрын тухай хуулийг УИХ 1994 онд анх баталж, уг хуулийг 2002 онд шинэчлэн найруулан 2003 оноос мөрдөж эхэлжээ. Газрын тухай хуулиар газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулдаг. Хуульд газрын нөөцийн менежментийн үндсэн зарчмууд, газар өмчлөх, эзэмших зэрэг газар ашиглах хэлбэр, эрхийг тодорхойлсон байна.

Шинэчлэн найруулсан 2002 оны Газрын тухай хуульд газрыг 6 ангилалд хуваасан ба эдгээр ангилалд хамаарал бүхий газрын тусгай ашиглалтыг зохицуулах хэд хэдэн хуулийг баталсан байна. 1994 оны

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар тусгай хамгаалалттай газрын төрөл, дэглэмийг; 1997 оны Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулиар тусгай хамгаалалттай газар нутагт орчны бүсийг тогтоох, орчны бүсэд үйл ажиллагаа явуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан (Бүлэг 11) байна. Ойн тухай 2012 оны хуулиар ой хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглах, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан (Бүлэг 13). Тариалангийн тухай 2016 оны хуулиар тариалан эрхлэх, тариалангийн газрыг зүй зохистой ашиглах, хөрсийг хамгаалах харилцааг зохицуулж байна.

Газрын төлбөрийн тухай 1997 оны хуулиар газар ашигласны төлбөрийн харилцааг зохицуулдаг. Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар төлбөрийн хэмжээ, газар ашигласны жилийн төлбөрийн дээд, доод хэмжээг тогтоожээ (Бүлэг 3).

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай 2002 оны хуулиар өмчлүүлэх газрын хэмжээ, болзол, шаардлага, журам, нөхцөлийг зохицуулсан байдаг. Кадастрын зураглал, газрын кадастрын тухай 1999 оны хуулиар кадастрын зураглал үйлдэх, газрын кадастр эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Монгол Улс хөрс хамгаалах, газрын доройтолтой тэмцэх тусгай хуультай. Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай 2012 оны хууль нь бэлчээрийн даац хэтрэх, цөлжилтийн улмаас хөрс доройтох, хөрсний үр шим буурахаас сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх, ХАА, уул уурхай, зам, хот байгуулалтын эрчимтэй хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс цөлжилт үүсэхээс сэргийлэх зорилготой (Бүлэг 1) байна.

Бэлчээрийн тухай хуулийг боловсруулах ажил 2011 онд эхэлсэн боловч өнөөг хүртэл төслийн шатандаа хэвээр байна. Хуулиар илүү боловсронгуй, зохицуулалттай бэлчээрийн төлөвлөлт, менежментийн тогтолцоог бүрдүүлэх зорилт тавьж байна.

#### *Бодлогын тогтолцоо*

#### 2016 оны Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 (Бүлэг 1) 2016 онд батлагдаж 2030 он гэхэд цөлжилттэй газар нутгийн хэмжээг бууруулах, тухайлбал 2014 онд 78.2 хувь байсан суурь үзүүлэлтийг 60 хувь болтол бууруулах, тусгай хамгаалалттай газар нутгийн талбайг нийт нутаг дэвсгэрийн 30 хувь, ойн талбайг 9.0 хувь болтол нэмэгдүүлэх чухал зорилгыг дэвшүүлсэн байна.

#### 2014 оны Ногоон хөгжлийн бодлого, 2016 оны Ногоон хөгжлийн бодлогыг 2016-2030 онуудад хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Ногоон хөгжлийн бодлого нь эдийн засгийн түргэн өсөлт, уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд байгаль орчинд үзүүлэх хүний үйл ажиллагааны нөлөөг бууруулах, багасгах замаар цөлжилт, газрын доройтол, гангийн нөлөөллийг бууруулах зорилготой ажээ. Уг бодлогод аж үйлдвэрийн үйл ажиллагаанаас доройтсон, бохирдсон, эвдэрсэн газрын 70-аас доошгүй хувийг сэргээхэд чиглэсэн хүчин чармайлтыг дэмжих, сэргээсэн газрыг эдийн засгийн янз бүрийн зориулалтаар ашиглах зорилгыг дэвшүүлсэн байна.

Ногоон хөгжлийн бодлогыг 2016-2030 онуудад хэрэгжүүлэх 2016 онд баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2030 он гэхэд хүрэх дараах үр дүн, үзүүлэлтийг тусгасан байна:

- Доройтсон, эвдэрсэн, элэгдсэн газрын 70-аас доошгүй хувийг нөхөн сэргээх;
- Сум бүрийн нийт бэлчээрийн 10 хүртэл хувийг сэлгэн ашиглах горимд оруулах, отрын бүс болгон нөхөн сэргээх, хадгалах;
- Атаршсан тариалангийн талбайн 450,000 га газрыг нөхөн сэргээж, тариаланд ашиглах;
- Тариалангийн усалгаатай талбайн хэмжээг 100,000 га-д хүргэх;
- Доройтсон, цөлжсөн 1,000 га-гаас доошгүй газар талбайд ойн бүс байгуулах;
- Ойн нөөцийн доройтлыг зогсоох замаар ойн талбайг 1.9 сая га-гаар нэмэгдүүлэх.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт газрын бодлоготой холбоотой дараах зорилго тусгагджээ:

- Газрын бодлогын ерөнхий тогтолцоог бүрдүүлж, газар ашиглалт, өмчлөл, эзэмшлийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах;
- Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, бэлчээрийн доройтол, цөлжилтийг бууруулах, экологид ээлтэй, дэвшилтэт аргыг хэрэглэн хортон шавьж, мэрэгчтэй тэмцэх үйл ажиллагаанд малчдын оролцоог нэмэгдүүлэх;
- Ургамал хамгаалах цогц арга хэмжээг боловсруулах, тариалангийн талбайг хөрсний элэгдэл, доройтлоос сэргийлэх, тэг элдэншүүлэлтийн технологийг ажмаар нэвтрүүлэх, таримлын төрлийн сэлгэн тариалах болон хөрсний үржил шимийг сайжруулах арга хэмжээ авах;
- Усжуулалтын шинэ системүүдийг байгуулах, хуучныг шинэчлэх, усалгааны дэвшилтэт техник технологи нэвтрүүлэхийг дэмжих;
- Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах бодлого баримтлах, уулуурхайн хайгуул, олборлолтын үйл ажиллагааны улмаас доройтсон газар талбайг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх.

2010-2020 онд хэрэгжүүлэх Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр

Цөлжилттэй тэмцэх 2010-2020 онд хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн (ЗГ-ын 2010 оны 90 дүгээр тогтоол) гол зорилго нь цөлжилттэй тэмцэх, цөлжилтийг сааруулах, газрын доройтлоос урьдчилан сэргийлэх замаар байгаль орчны тэнцвэрт байдлыг хангаж, цөлжилтөд өртсөн нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, дэлхийн ач холбогдол бүхий байгаль орчны үйлчилгээ үзүүлэхэд оршиж байна. Дээрх зорилгыг биелүүлэхийн тулд дараах тэргүүлэх чиглэл, ач холбогдол бүхий арга хэмжээг тодорхойлжээ:

- Бүтэц зохион байгуулалтын чадавхийг бэхжүүлэх: Хөрс хамгаалах, Цөлжилттэй тэмцэх үндэсний хорооны (ХХЦГҮХ) бүтцийг боловсронгуй болгох; цөлжилтийг сааруулах засгийн газрын бодлого, зорилго, үйл ажиллагааг үр бүтээлтэй хэрэгжүүлэх; улсын болон орон нутгийн төсөв, тусгай сангаас шаардлагатай санхүүгийн нөөцийг бүрдүүлэх; чадавхийг бэхжүүлэх;
- Хууль эрх зүй, бодлогын тогтолцоог бэхжүүлэх: Цөлжилттэй тэмцэх, цөлжилтийг сааруулах, сэргийлэх зохистой, үр өгөөжтэй эрх зүйн болон бодлогын тогтолцоог бүрдүүлэх;
- Шинжлэх ухаан, технологи, мэдлэгийг сайжруулах: Газрын доройтол, цөлжилтийн үнэлгээ хийх хяналт мониторингийн цогц сүлжээ байгуулах; цөлжилтийн үндэсний цогц мэдээллийн сан байгуулах; газрын доройтол, цөлжилтийг сааруулах технологи, арга замын тухай мэдээллийн сан байгуулах;
- Мэдээлэл сурталчилгаа, оролцоог нэмэгдүүлэх, боловсролыг дэмжих: Хүүхэд залуучуудын байгаль орчин, цөлжилтийн талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлэх; цөлжилт үүсэх шалтгаан, үр дагаврын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн мэдээллийг түгээх; бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдыг шинжлэх ухаанд суурилсан мэдээллээр хангах.
- Хэрэгжүүлэх шатанд авах тодорхой арга хэмжээг эрчимжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх: Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх практик үйл ажиллагааг эрчимжүүлэх, байгаль орчныг хадгалах, байгалийн нөөцийн ашиглалтын менежментийг бэхжүүлэх; байгалийн нөөцийн тогтвортой менежментийн төлөвлөгөөг боловсруулах; доройтсон газрын нөхөн сэргээлтэд газар ашиглагчдын оролцоог нэмэгдүүлэх.

*Энэхүү бүлэгтэй холбоотой Тогтвортой хөгжлийн зорилт, зорилгууд*

Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030 -ийн Зорилт 15.3 –ын биелэлтийн явцыг шигтгээ 12.1-т харуулав.



## Шигтгээ 12.1: Тогтвортой хөгжлийн 2030

он хүртэлх хөтөлбөр: Зорилт 15.3

Зорилго 15: Хуурай газрын экологийн системийг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах, ойн нөөцийн тогтвортой байдлыг хангах, цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах, биологийн олон янз байдлыг мөхөж устахаас сэргийлэх

Зорилт 15.3: 2030 он гэхэд цөлжилттэй тэмцэх, цөлжилт, ган, үерийн улмаас доройтсон газар, хөрсийг нөхөн сэргээх, дэлхийд газрын доройтлыг зогсоох нөхцөлийг бүрдүүлэх

Монголд газрын доройтлын талаар сүүлийн үед хийсэн үнэлгээнээс үзвэл 2015 оны байдлаар нийт нутаг дэвсгэрийн 76.8 хувь ямарваа нэгэн хэмжээгээр доройтсон, үүнээс 24.1 хувь нь бага, 29.8 хувь нь дунд, 16.8 хувь хүчтэй, 6.1 хувь нь нэн хүчтэй зэрэглэлд доройтсон болохыг тогтоосон байна (Хүснэгт 12.2). Монгол Улс нь ТХЗ-уудын Зорилго 15.3 –ийн хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт 15.3.1 (2030 он гэхэд доройтсон газрын 70-аас доошгүй хувийг нөхөн сэргээх, цөлжилттэй газрын нийт нутаг дэвсгэрт эзлэх хувийг 60 хувь болтол бууруулах) –ээр үнэлнэ.

Монгол Улс нь газрын доройтолтой тэмцэх эрх зүй, бодлого, бүтэц зохион байгуулалтын тогтолцоо, механизмыг бүрдүүлсэн байна. Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай 2012 оны хуулиар цөлжилтөөс үүсэх хөрсний эвдрэлээс сэргийлэх, хөрсний үржил шимийг хамгаалах, хөрсний элэгдлээс сэргийлэх үйл ажиллагааг тодорхойлсон байна. 2010-2020 онд хэрэгжүүлэх Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрт цөлжилттэй тэмцэх тэргүүлэх чиглэл, холбогдох үйл ажиллагааг тодорхойлжээ. БОАЖЯ-нд газрын доройтол, цөлжилтийн байдалд хяналт мониторинг хийх сүлжээ байна. Гэвч хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд санхүүгийн нөөц, технологи, чадавхийн хязгаарлагдмал байдал, холбогдох салбаруулын зохицуулалт сул байгаа нь саад бэрхшээл учруулж байна.

Зорилт 15.3-г хэрэгжүүлэхэд Монгол Улс нь дотоодын болон олон улсын санхүүгийн нөөцийг дайчлах, газрын доройтолтой тэмцэх чадавхийг бэхжүүлэхийн сацуу бусад улс орон, олон улсын байгууллагын тэргүүний мэдлэг, газрын тогтвортой менежментийн практик ажиллагааны туршлагыг судлан нэвтрүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн газрын доройтлын хяналт мониторингийн үндэсний сүлжээг сайжруулах, газрын доройтлын саармаг гурван үзүүлэлтийг (ГДСҮ) нэвтрүүлэх (газрын бүрхэвч, газрын бүрхэвчийн өөрчлөлт; газрын бүтээгдэхүүн; гадаргын болон газрын доорх нүүрс хүчлийн агууламж) шаардлагатай.

*Бүтэц зохион байгуулалтын тогтолцоо*

Газрын харилцааны асуудлыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (ГХГЗЗГ) хариуцаж байна. Газрын тухай 2002 онд шинэчилсэн хууль, газрын шинэчлэлийн үйл ажиллагаатай холбогдуулан ГХГЗЗГ-ыг (хуучин нэрээр) Газрын хэрэг эрхлэх газар, Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар, Геодези, зураг зүйн газрыг нэгтгэн уг газрыг байгуулсан байна. 2006 онд Улсын эрхийн бүртгэлийн албыг ГХГЗЗГ-аас тусгаарласан. ГХГЗЗГ нь 2000-2004 онд Ерөнхий сайдын харьяанд, 2004 оноос хойш БХБЯ-ны харьяанд үйл ажиллагаагаа явуулж байна. Тус газар нь Улаанбаатар хот, 21 аймагт нутгийн захиргааны байгууллагуудтай, сум бүрт газрын харилцаа хариуцсан 1 даамал ажиллаж байна.

ГЗБГЗЗГ нь газрын асуудал, тухайлбал газрын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, геодези, зураг зүй, газар зохион байгуулалт, газрын кадастр, кадастрын хэмжилт, зураглал, хаягжилт, бүртгэл, газрын менежментийн төлөвлөлт, газрын мэдээ мэдээллийн үндэсний систем, газрын сансрын мэдээ мэдээллийн дэд бүтцийг бүрдүүлэх, иргэдийг газрын талаарх мэдээ мэдээллээр хангах үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг юм.

ХХААХҮЯ нь бэлчээр, газар тариалангийн удирдлага менежментийг, БОАЖЯ нь тусгай хамгаалалттай газар, ой, усны нөөцийн менежментийг, УУХҮЯ нь уул уурхайн кадастрын асуудлыг тус тус хариуцдаг байна (Бүлэг 2). Зам тээврийн яам нь зам, ялангуяа хатуу хучлагатай замын уртыг нэмэгдүүлэх асуудлыг хариуцдаг. Эдгээр яамдын хооронд газрын менежментийг зохицуулах, газрын доройтлоос сэргийлэх үйл ажиллагааны албан ёсны механизм бүрдээгүй байна.

Монгол улсад 1,500 хянах цэг бүхий газрын доройтол, цөлжилтөд хяналт мониторинг хийх сүлжээ бий. БОАЖЯ-ны харьяа ЦУОШГ нь газрын доройтол, цөлжилтийн хяналт мониторинг хийж байна.

*Зохицуулалтын болон эдийн засгийн арга хэмжээ*

Зөвхөн Монгол Улсын иргэн, ААН газрыг урт хугацаагаар эзэмших эрхтэй. Газар эзэмших нь газар өмчлөхөөс ялгаатай, газрыг тодорхой зорилгоор ашиглахаар түр хугацаагаар түрээслүүлж байгаатай адил. Улаанбаатар хотод гэр бүлд 0.07 хүртэл, Дархан, Эрдэнэт хотод 0.5 хүртэл, аймаг, сумын төв, сууринд 0.35 хүртэл га газрыг өмчлүүлдэг байна.

Иргэнд өмчлүүлэх газрын үнийг Засгийн газар газрын суурь үнэ, газрын үнэлгээний аргачлалыг үндэслэн тогтоодог байна. Хот, суурин газарт газрын төлбөр нь газрын үнийн 0.01-ээс 1 хувь, тусгай хамгаалалттай газарт төлбөр 3 хүртэл хувь байж болно. Жилийн төлбөрийн хэмжээ м<sup>2</sup> тутамд 44 төгрөгөөс (\$0.02) 440 төгрөг (\$0.18) байна (Бүлэг 3). Малчдыг бэлчээр болон хадлангийн газар ашигласны жилийн төлбөрөөс чөлөөлж байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай 1994 оны хуулиар дархан цаазат газар, байгалийн цогцолбор газарт газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, элс, хайрга чулуу авах, байгалийн дагалт баялаг, эмийн, хүнсний болон техникийн зориулалттай ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, хөрс, ус, агаар бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулах зэргийг хориглоно.

## 12.5 Олон улсын гэрээ хэлэлцээр, үйл ажиллагаанд оролцох оролцоо

### *Цөлжилттэй тэмцэх тухай конвенци*

Монгол Улс нь Ган цөлжилтөд ноцтой нэрвэгдэж буй орнуудын болон ялангуяа африк тивийн цөлжилттэй тэмцэх тухай конвенцид (НҮБ-ын ЦТК) 1996 онд нэгдэн оржээ. Энэ үеэс хойш гишүүн орнуудын бага хурал, конвенцийн хэрэгжилтийг дүгнэх хорооны хуралдаан, холбогдох бусад хурал уулзалтад тогтмол оролцож иржээ.

НҮББОХ, НҮБХХ, Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн зөвлөлийн тусламжтайгаар Монгол Улс Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг анх 1996 онд боловсруулж (ЗГ-ын 1996 оны 169 дүгээр тогтоол), 2003 онд уг хөтөлбөрийг шинэчилжээ (ЗГ-ын 2003 оны 141 дүгээр тогтоол). НҮБ-ын ЦТК-д 2010 онд хүргүүлсэн Монголын үндэсний дөрөв дахь тайлан илтгэлд санхүүгийн хязгаарлагдмал нөөц, мэдлэг мэдээлэл, технологийн нөөц бололцоо дутмаг, холбогдох салбар хоорондын зохицуулалт сул, чадавхи хязгаарлагдмал зэрэг шалтгааны улмаас цөлжилттэй тэмцэх анхны үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хүлээгдсэн үр дүнд хүрээгүйг онцлон тэмдэглэсэн байна. 2010-2020 онд хэрэгжих Цөлжилттэй тэмцэх өнөөгийн үндэсний хөтөлбөрийг (ЗГ-ын 2010 оны 90 дүгээр тогтоол) НҮБ-ын ЦТК-ийн гишүүн орнуудын 9 дүгээр бага хурлаас гаргасан стратегид суурилан боловсруулсан байна.

### *Цөлжилт, газрын доройтол, гантай тэмцэх Зүүн-хойд Азийн сүлжээ*

БНСУ, БНХАУ, Монгол Улс Цөлжилт, газрын доройтол, гантай тэмцэх Зүүн-хойд Азийн сүлжээг 2011 онд Зүүн-хойд Азийн ойн сүлжээг өргөжүүлэх замаар байгуулжээ. Уг сүлжээ нь: (i) цөлжилт, тоос болон шороон шуургатай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх; (ii) цөлжилт, газрын доройтлоос сэргийлэхэд хувь нэмэр оруулах, ойн бусад асуудлаар хамтран ажиллах; (iii) ойн болон газрын тогтвортой менежментэд хувь нэмэр оруулах зэрэг үйл ажиллагааг явуулж байна.

Удирдах хорооны хуралдаан, форум, ажлын зөвлөлгөөнийг жилд тогтмол зохион байгуулж байна. Монгол Улс бүх хурал уулзалтад идэвхтэй оролцож, уг сүлжээний хурлыг Улаанбаатарт 2 удаа зохион байгуулжээ. “Хятадын Эрээн хот, Монголын Замын-Үүд хотын бүсэд тоос, шороон шуургаанаас сэргийлэх, сурталчилан таниулах хамтарсан төсөл”-ийг 2012-2016 оны хооронд хэрэгжүүлжээ.

## 12.6 Үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж

### *Үнэлгээ*

Монголын хуурай газрын дийлэнх хувийг бэлчээр эзэлж, тусгай хэрэглээний газар, ойн сан бүхий газар тодорхой хувийг эзэлж байна. Сүүлийн жилүүдэд бэлчээр нутаг, ойн сан болон усны сан бүхий газрын хэмжээ багасч, харин тусгай хэрэгцээний газар үлэмж хэмжээгээр нэмэгджээ. Энэ нь экологийн хувьд эмзэг олон газрыг тусгай хамгаалалтад авсантай холбоотой. Хотжилт, зам тавих үйл ажиллагаа эрчимжиж байгаагийн зэрэгцээ хот байгуулалт, зам тавихад ашиглах газрын хэмжээ нэмэгдэж байна.

Газрын нөөцтэй холбоотой байгаль орчны хамгийн чухал, тулгамдсан асуудал бол газрын доройтол болон цөлжилт юм. Газрын доройтлын дийлэнх нь бэлчээр нутаг, дараа нь ойн сан бүхий газар болон тариалангийн газарт ноогдож байна. Бэлчээрийн доройтолд уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагаа хоёулаа нөлөөлж байна. Бэлчээрийн даацыг хэтрүүлэх, уул уурхай, олон салаа зам,



хотжилт нь хүний үйл ажиллагааны гол нөлөө юм. Ойн нөөцөд хууль бус мод бэлтгэл, ойн түймэр, хортон шавьж зэрэг нь сөрөг нөлөө үзүүлдэг. Эдэлбэр газрын доройтол нь тариалангийн газрыг ашиглахгүй орхисноос ихэвчлэн үүсдэг. Газрын доройтол нь хөрс, усны нөөцөд сөргөөр нөлөөлөх, газрын бүтээгдэхүүн багасах, улмаар орон нутгийн хүн амын хөгжил, амьжиргаанд нөлөөлж байна. Гэвч Монгол улсад өнөөг хүртэл газрын доройтлын эдгээр сөрөг үр дагаварт системчилсэн үнэлгээ хийгээгүй байна.

Монгол Улс нь 2030 он гэхэд нийт доройтсон газрын 70-аас доошгүй хувийг нөхөн сэргээх, цөлжилттэй газрын нийт нутаг дэвсгэрт эзлэх хувийг 60 хүртэл бууруулах зоримог зорилтуудыг дэвшүүлсэн байна. Эдгээр нь 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн Зорилго 15.3 (2030 он гэхэд цөлжилттэй тэмцэх, цөлжилт, ган, үерийн улмаас доройтсон газар, хөрсийг нөхөн сэргээх, дэлхийд газрын доройтлыг зогсоох нөхцөлийг бүрдүүлэх)-ын хүрээнд оруулах үндэсний зорилтот хувь нэмрийн илэрхийлэл болно.

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийг 2012 онд, 2010-2020 онд хэрэгжүүлэх Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2010 онд баталсан нь Монгол Улс нь газрын доройтол, цөлжилттэй тэмцэх эрх зүйн болон бодлогын тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээний илрэл юм. Гэвч бодлогын эдгээр баримт бичгийн бодит хэрэгжилт нь санхүүгийн хязгаарлагдмал нөөц, байгууллагуудын зохицуулалт хангалтгүй байгаагаас нэлээд саад бэрхшээлтэй тулгарч байна.

*Дүгнэлт, зөвлөмж*

#### Хууль эрх зүйн орчин, төлөвлөлт

Монгол Улсын газрын нөөцийн менежментийн эрх зүйн тогтолцоо нь түүний суурь болох 2002 онд шинэчилсэн Газрын тухай хууль, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх асуудалд төвлөрсөн 2012 оны Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулинд суурилж байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай 1994 оны хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай 1997 оны хуулиар тусгай хэрэгцээний газрын харилцааг, Ойн тухай 2012 оны хуулиар ойн сан бүхий газрын харилцааг, Тариалангийн тухай 2016 оны хуулиар ХАА-н газрыг тариалан эрхлэхэд ашиглах харилцааг тус тус зохицуулж байна. Гэвч бэлчээрийн ашиглалтыг зохицуулах хууль өнөөг болтол батлагдаагүй, олон жил төслийн шатандаа явж байна. Бэлчээр нь улсын нийт нутаг дэвсгэрийн 70 гаруй хувийг эзэлдэг, газрын доройтлын дийлэнх нь бэлчээртэй холбоотойг анхааран үзвэл Бэлчээрийн тухай хуулийг хэлэлцэн батлах нь нэн чухал ач холбогдолтой юм. Ийм хууль нь бэлчээрийн менежментийг сайжруулах, тогтвортой байдлыг хангахад чухал үүрэгтэй. Нөгөө талаар саяхан батлагдсан хуулиуд, тухайлбал Тариалангийн тухай хуулийг хэрэгжүүлэх нэмэлт хууль тогтоомжууд гараагүйн улмаас хуулиудын бодит хэрэгжилт саарч байна.

#### Зөвлөмж 12.1:

*Засгийн газраас дараах арга хэмжээг хэрэгжүүлвэл зохино:*

- (a) *Бэлчээрийн тухай хуулийг эцэслэн боловсруулж батлах арга хэмжээ авах;*
- (b) *Газартай холбоотой хуулиуд, ялангуяа саяхан батлагдсан Тариалангийн тухай хуулийг хэрэгжүүлэх нэмэлт хууль, журмын багцыг дахин боловсруулах,*
- (c) *Засгийн газрын байгууллагууд, засаг захиргааны өөр өөр түвшингийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхийн тулд газрын менежментийн төлөвлөгөө боловсруулах механизмыг сайжруулах,*
- (d) *Гэр хорооллыг дахин төлөвлөж шинэчлэн оршин суугчдад нь төвлөрсөн усан хангамж, ариун цэврийн байгууламжууд, хатуу хучилттай зам, нийтийн тээврийн үйлчилгээнд хамрагдах боломжоор хангах,*
- (e) *Гэр хорооллын төлөвлөгдөөгүй тэлэхээс урьдчилан ёргийлэх арга хэмжээ авах.*

#### Зохицуулалт болон хамтын ажиллагаа

1990-ээд оны эхнээс газрын нөөцийн менежментийн бүтэц зохион байгуулалтын тогтолцоо боловсронгуй болсоор иржээ. БХБЯ-ны харьяа ГЗБГЗЗГ нь газрын харилцаатай холбоотой дийлэнх асуудлыг хариуцдаг боловч газрын төлөвлөлт, менежментийн асуудлыг хэд хэдэн яамд хариуцаж байгаа тул тэдэнтэй хамтран ажиллах, үйл ажиллагаагаа зохицуулах хийх шаардлагатай байна. ХХААХҮЯ нь

ХАА-н газар, бэлчээр, газар тариалангийн удирдлага менежментийг, БОАЖЯ нь тусгай хамгаалалттай газар, ой, усны нөөцийн менежементийг, УУХҮЯ нь уул уурхайн тусгай зөвшөөрөл олгох, кадастрын асуудлыг, Зам тээврийн яам нь зам, ялангуяа хатуу хучлагатай замын уртыг нэмэгдүүлэх асуудлыг тус тус хариуцдаг. Эдгээр яамд болон холбогдох бусад байгууллагуудын хооронд газрын менежментийн хамтын ажиллагаа, зохицуулалтын механизм бүрдээгүй байна.

Зөвлөмж 12.2:

*Засгийн газар нь үр бүтээмжтэй хамтын ажиллагаа, практик үйл ажиллагааг хангахын тулд холбогдох яамд, агентлагуудын хооронд газрын менежментийн ерөнхий зохицуулалтын механизмыг бүрдүүлэх шаардлагатай. Үүнд:*

- (a) *Бэлчээр болон тариалангийн газрын тогтвортой менежмент;*
- (b) *Ойн сан, усны сан бүхий газар, тусгай хэрэгцээний газрыг хамгаалах;*
- (c) *Уул уурхай болон хатуу хучилтгүй шороон зам ашиглалтаас үүдсэн газрын доройтлыг бууруулах, уурхайн үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг дэмжих,*
- (d) *Газрын бүрхэвч мэдээ, мэдээлийн санг байнга шинэжилж, үйл ажиллагааг нь хэрэгжүүлэхийн тулд газар бүрхэвчийн CORINE зэрэг олон улсын стандартыг хэрэглэх.*

*Зөвлөмж 1.4(f) харна уу.*

Нөөц бололцоо, олон улсын хамтын ажиллагаа

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх зонвенцийн гишүүн улсын хувьд Монгол Улс нь Цөлжилттэй тэмцэх үндэсний анхны хөтөлбөрийг 1996 онд боловсруулж, 2003 онд уг хөтөлбөрийг шинэчлэн, одоо 2010-2020 онуудад хэрэгжих Цөлжилттэй тэмцэх хоёр дахь үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Гэвч санхүүгийн хязгаарлагдмал нөөц, мэдлэг мэдээлэл, технологийн нөөц бололцоо дутмаг, холбогдох салбар хоорондын зохицуулалт сул, чадавхи хязгаарлагдмал зэрэг шалтгааны улмаас цөлжилттэй тэмцэх анхны үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт зохих түвшинд хүрээгүй байна.

Бүс нутгийн хувьд Монгол Улс нь БНСУ, БНХАУ-тай хамтран Цөлжилт, газрын доройтол, гантай тэмцэх Зүүн-хойд Азийн сүлжээг байгуулан, газрын доройтолтой холбоотой бүх уулзалт хурал, хамтарсан төслүүдэд оролцож, Зүүн хойд Азийн газрын доройтлыг бууруулах зорилтыг биелүүлэхэд хувь нэмэр оруулж байна.

Зөвлөмж 12.3:

*Засгийн газраас дараах арга хэмжээг хэрэгжүүлвэл зохино:*

- (a) *Цөлжилттэй тэмцэх 2010-2020 оныг хамарсан хоёр дахь үндэсний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд дотоодын болон олон улсын санхүүгийн нөөцийг дайчлан, чадавхийг хөгжүүлэх арга хэмжээ авах;*
- (b) *Түни орнууд, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, газрын тогтвортой менежментийн талаарх тэдний тэргүүний туршилага, практик технологийг судлах, ашиглах.*

Газрын доройтлыг саармагжуулах шалгуур үзүүлэлтүүд

Монгол улсад газрын доройтол, цөлжилтийн хяналт мониторингийн 1,500 цэг ажиллаж байна. БОАЖЯ-ны харьяа ЦУОШГ нь газрын доройтол, цөлжилтийн хяналт мониторинг хийдэг. Газрын доройтлыг саармагжуулах гурван шалгуур үзүүлэлтийн (ГДСҮ) (газрын бүрхэвч болон газрын бүрхэвчийн өөрчлөлт; газрын бүтээгдэхүүн: газрын гадаргын дээрх болон доорх нүүрс хүчлийн агууламж) мэдээ мэдээллийг Монголд одоогоор цуглуулахгүй байна. ТХЗ-уудын Зорилго 15.3-ыг хэрэгжүүлэх үндэсний хүчин чармайлтад хяналт мониторинг хийх, тайлагнах үйл ажиллагааг сайжруулахад эдгээр гурван үзүүлэлтээр мэдээ мэдээлэл боловсруулах чадавхийг бий болгох нь чухал ач холбогдолтой байна.

Зөвлөмж 12.4:

*БОАЖЯ нь Үндэсний статистикийн хороотой хамтран газрын доройтлыг саармагжуулах гурван үзүүлэлтийн мэдээ мэдээллийг цуглуулах ажлыг санаачлах шаардлагатай.*

Мэдээ, мэдээлэл

Холбогдох яам, газруудын хооронд газрын нэгдсэн менежментийн механизмын зохицуулалт байхгүй байгаагийн зэрэгцээ газар, газар ашиглалттай холбоотой нэгтгэсэн мэдээллийн сан байхгүй байгаа нь

анхаарах асуудал болж байна. Газрын мэдээллийн үндэсний системийг ажиллуулж, газартай холбоотой мэдээ мэдээллээр Засгийн газрын байгууллагууд болон олон нийтийг хангах үндсэн үүргийг ГХГЗЗГ гүйцэтгэж байна. Гэвч Бодлого боловсруулах, шийдвэр гаргах явцад газартай холбоотой мэдээллийг зохистойгоор ашиглахын тулд газар, газар ашиглалтын мэдээллийн санд янз бүрийн түвшний Засгийн газрын байгууллагуудын оруулах мэдээлэл чухал шаардлагатай.

Зөвлөмж 12.5:

*ГХГЗЗГ нь ХХААХҮЯ болон ҮСХ-той хамтран газар, газар ашиглалтын мэдээллийн санг байгуулах, түүнд холбогдох байгууллагуудаас бэлтгэсэн таримал болон хадлан бэлчээрийн ургамлын ургац, бүтээгдэхүүний тухай мэдээллийг хамруулах, мэдээллийн чанар, уялдаа, урсгал, тасралтгүй байдлыг хангах шаардлагатай.*



## Бүлэг 13

## ОЙ БОЛОН БАЙГАЛЬ ОРЧИН

## 13.1 Өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт

## Ойн төлөв байдал

## Ангилал

Монгол Улсад “ойн сан бүхий газар” гэдэгт ойтой болон ойгүй газар, ойн ургалтад шаадлагатай эргэн тойрны орчныг хамруулан ойлгоно. Ойн сангийн газарт ой бүхий газар, таримал ой, бут сөөг, мод бэлтгэсэн, ой, хээрийн түймэр, хөнөөлт шавьж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, ойн цоорхой, түүнчлэн ойн захаас гадагш 100 метр газар, тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газрын эзлэх талбай хамаарна. Ойгоор бүрхэгдээгүй газарт хээр тал, нам дор намгархуу бүс, газар тариалангийн талбай хамрагдана. Иймд, ойн тухай 2012 онд шинэчилсэн хуулиар “ойн сангийн газар” гэдэг ойлголтод ойгоор бүрхэгдсэн газар гэж үзэхээс илүүтэйгээр газар ашиглалтын хэлбэр гэж үзэн ойгоор бүрхэгдээгүй газрыг мөн хамааруулан авч үзсэн байна.

2016 оны байдлаар 18.45 сая га газрыг ойн сангийн газар гэж тодорхойлсон нь нийт нутаг дэвсгэрийн 11.8 хувийг эзэлж байна. Энд 17.91 сая га нь ойн талбай бөгөөд үүнээс ойн сангийн газрын 66 хувь, нийт нутаг дэвсгэрийн 7.85 хувийг эзлэх 12.28 сая га нь ойгоор бүрхэгдсэн газар байна. Ойгоор бүрхэгдээгүй, эсвэл нөөц нь доройтсон 5.63 сая га ойн талбай байна. Ойн нөөц доройтсон талбайд ойн болон ойтой холбоотой янз бүрийн үйл ажиллагаа, тухайлбал даац хэтэрсэн, мод бэлтгэл болон түлшний модыг хэтрүүлэн ашигласан, олон удаагийн ойн түймэр, хортон шавьж болон өвчлөлд өртсөн зэргээс ой доройтсон, устсан газрыг хамруулна (Зураг 13.1). Эдгээр талбайг нөхөн сэргээхээр төлөвлөж байна. Ойн бүрхэвчгүй талбайд (0.54 сая га) ойн сангийн газарт хамаарах өндөр уулсын нуруу, хяр, ургамал, хад асагтай газар, цагаан энгэр, мод үржүүлгийн газар багтана.

Зураг 13.1: Ойн сангийн газар, түүний ангилал, 2016 он



Эх сурвалж: Ойн судалгаа, хөгжлийн төв, БОАЖЯ, 2017 он.



Нийт газар нутгийн 10 хүрэхгүй хувь нь ойгоор бүрхэгдсэн учир НҮБ-ын Хүнс, ХАА-н байгууллагын (ХХААБ) тодорхойлолтоор Монгол Улс нь ойн бүрхэвч багатай улсад тооцогддог. Гэвч цөөн хүн амтай (3.12 сая хүнтэй), өргөн уудам газар нутагтай, хүн амын нягтралын хувьд дэлхийд хамгийн бага нягтралтай улс (2 хүн/км<sup>2</sup>) тул Монгол орныг нэг хүнд ноогдох ойн талбайн харьцаа нь 4.09 га/хүн байгаа нь дэлхийн дундаж 0.54 га/хүн үзүүлэлтээс хавьгүй өндөр байгааг үндэслэн ойн бүрхэвч багатай улсын жагсаалтад оруулдаггүй байна.

### Тархалт

Ой мод нь улсын хойд, төв бүсэд ихэвчэн тархаж, Сибирийн их тайгын хуурай ой болон төв Азийн говь хээр хоорондын шилжилтийн бүс болдог байна. Улсын хойд хэсгийн ой нь дэлхийн хуурай ойн өмнөд хязгаар юм.

Монголын ойг хойд хэсгийн шилмүүст болон навчит ой, өмнөд хэсгийн заган ой гэж хоёр төрөлд ангилна (Хавсралт IV. Газрын зураг 8). Хойд хэсгийн хуурай ой нийт ойн талбайн 84.8 хувийг эзэлдэг ба шинэс (*Larix sibirica*), хуш (*Pinus sibirica*), нарс (*Pinus sylvestris*), гацуур (*Picea obovata*), жодоо (*Abies sibirica*) зэрэг шилмүүст, хус (*Betula platyphylla*), улиангар (*Populus tremula*), тоорой (*Populus diversifolia*) зэрэг навчит модноос бүрддэг байна. Өмнөдийн заган ой нь нийт ойн талбайн 15.3 хувийг эзэлж, заг (*Haloxylon ammodendron*) голдуу ургадгийн зэрэгцээ сухай (*Tamarix spp*), жигд (*Caragana*) мөн ургадаг байна. Заг нь монголын говь, говь хээрийн онцлог ургамал бөгөөд экологийн, соёлын, эдийн засгийн чухал ач холбогдолтой. Ой нь газрын элэгдэл, цөлжилтөөс хамгаалах, малын тэжээл болон түлшний модоор хангах зэрэг олон үүрэгтэй.

### Бүтэц болон насжилт

Ой нь 140 гаруй зүйлийн мод, сөөгөөс бүрдэнэ. Шинэс мод нь эзэлдэг талбай (62.5 хувь) болон нөөцийн (78.6 хувь) хувьд зонхилдог байна.

Шилмүүст модны дундаж наслалт 133 жил, навчит модных 46 жил байна. Ойн насжилтын байдлын хувьд саяхан хийсэн үндэсний ойн олон зорилгот тооллогын дүнгээр Монголын ойн дийлэнх хэсэг өндөр насжилттай, үүнээс 74.07 хувь өндөр болон хэт өндөр, 14.16 хувь насжсан, 11.29 хувь дундаж, 0.48 хувь нь залуу насжилттай гэж тогтоожээ. Заган ойн хувьд 34.95 хувь хэт өндөр, 51.82 хувь өндөр, 11.55 хувь нь насжсан, 1.28 хувь дундаж, 0.4 хувь нь залуу насжилттай байна. Үүнээс шалтгаалан ойн үйлдвэрлэл багасахын зэрэгцээ түймэр, хортон шавьжийн хөнөөлд өртөх магадлал нэмэгдэн, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвар муудаж, улмаар ойн доройтол, ой устахад хүргэж байна.

Монголын ойн модны нөөц 1.24 тэрбум м<sup>3</sup> тэнцэх ба үүнээс шинэс 78.54 хувь, хуш 9.39 хувь, нарс 4.99 хувь, гацуур 0.22 хувь, жодоо 0.02 хувь, навчит мод 6.70 хувь, заг 0.14 хувийг тус тус эзэлдэг (Хүснэгт 13.1) байна. Шилмүүст ойн нэг га тутмын нөөц 1.14 м<sup>3</sup>/га, навчит ойн нөөц 0.98 м<sup>3</sup>/га байгаа бөгөөд жилийн нөөцийн дундаж өсөлт 1.036 тэрбум м<sup>3</sup> байна.

**Хүснэгт 13.1: Ойн модны зүйл төрөл, 1997, 2007, 2008, 2010, 2012, 2014, 2016 он, сая м<sup>3</sup>**

Модны төрөл								ЭЗЛЭХ ХУВЬ
	1997	2007	2008	2010	2012	2014	2016	2016 он (%)
Шинэс	1,017.10	1,033.00	1,074.90	1,058.50	1,035.10	977.10	978.10	78.54
Хуш	163.50	150.50	129.80	126.80	120.80	116.10	116.90	9.39
Нарс	90.50	97.10	86.70	66.70	63.70	61.80	62.10	4.99
Гацуур	3.60	3.40	4.30	3.60	3.60	2.90	2.80	0.22
Жодоо	0.38	0.30	0.30	0.20	0.20	0.20	0.20	0.02
Навчит мод (хус, улиангар, тоорой, хайлаас)	86.25	93.50	97.80	92.20	91.90	83.17	83.45	6.70
Заг	1.40	1.40	1.50	1.50	1.80	1.80	1.80	0.14
Сухай					0.01	0.03	0.03	0.00
<b>Нийт</b>	<b>1,362.73</b>	<b>1,379.20</b>	<b>1,395.30</b>	<b>1,349.50</b>	<b>1,317.10</b>	<b>1,243.07</b>	<b>1,245.35</b>	<b>100.00</b>

Эх сурвалж: БОАЖЯ, 2017 он.

### Захиргааны бүсүүд

Ойн тухай 2012 онд шинэчилсэн хуулийн Зүйл 5.1 -ээр ойн санг ашиглалт, нөөцийн менежментийн хэлбэрээр хамгаалалтын бүсийн ой, ашиглалтын бүсийн ой гэж захиргааны хоёр ангилалд хамааруулсан байна. 2016 оны байдлаар нийт ойн сангийн газрын 79.5 хувийг хамгаалалтын бүсийн ой, 20.5 хувийг ашиглалтын бүсийн ой эзэлж байна.

#### Хамгаалалтын бүсийн ой

Хамгаалалтын бүсийн ойд цармын бүслүүрийн ой, тусгай хамгаалалттай газрын болон сургалт, судалгааны зориулалттай ой, ногоон бүс, хориотой зурвасын ой, заган ой, баянбүрдийн ой, 100 га хүртэлх хэмжээний төгөл ой, бут, сөөг, 30 градусаас илүү налуу газрын ой хамаарна. Түүнчлэн усны сав газар, гол нууруудын орчмын ой, хот, суурин, зам, төмөр замын орчмын ойг хамгаалалтад авдаг. Хамгаалалтын бүсийн ойд зам, гүүр барих, ус, эрчим хүч, холбооны шугам татах болон түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг дэмжихэд чиглэгдсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт баялгийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглодог байна. Ойн тухай 2012 онд шинэчилсэн хуульд тусгай хамгаалалттай газар нутаг дахь ойн хамгаалалтын дэглэмийг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулахаар заажээ. Дархан цаазат газар, байгалийн нөөц болон дурсгалт газарт ойг түлшний мод бэлтгэх, мод бэлтгэлээс бусад ойн дагалт бүтээгдэхүүн ашиглах зэрэг зөвхөн амьжиргааны зорилгоор хязгаарлагдмал байдлаар ашиглахыг зөвшөөрдөг байна.

#### Ашиглалтын бүсийн ой

2014-2016 онд хийсэн Монголын Олон зорилгот үндэсний ойн тооллогын дүнгээс үзвэл нийт ойн сангийн 20.5 хувь буюу 1.9 сая га ойн талбайг үйлдвэрлэлийн зорилгоор ашиглахаар төлөвлөснөөс 1.5 сая га-г албан ёсны бүртгэлтэй 915 ойн нөхөрлөлтэй гэрээ байгуулан, 0.4 сая га-г хувийн ААН-тэй концессийн 76 гэрээ байгуулах журмаар ашиглахаар төлөвлөжээ. Үлдсэн 4.4 сая га ойн талбайг хамгаалалтад албан ёсоор аваагүй, ашиглах хэлбэрийг тогтоогоогүй байна.

#### *Тусгай хамгаалалттай газар нутаг дахь ой*

2000 оны мэдээ баримтаас үзвэл нийт ойн сангийн 17.3 хувь нь улсын тусгай хамгаалалттай бүсийн тогтолцоонд хамрагдаж байснаас 67.2 хувь нь ДЦГ, 32.1 хувь нь ҮП, 0.7 хувь нь байгалийн нөөц газарт харьяалагдаж байв. 2000 оны байдлаар заган ойн 34.2 хувийг улсын тусгай хамгаалалттай бүсэд хамруулжээ.

Тусгай хамгаалалттай газарт хамаарах ойн сангийн эзлэх хувийн талаар сүүлийн үеийн үндэсний болон орон нутгийн мэдээ мэдээлэл байхгүй байна. 2017 оны байдлаар улсын тусгай хамгаалалттай газрын системд нийт 27,953,449.98 га газар (улсын нутаг дэвсгэрийн 17.87 хувь) хамрагдаж байв (Бүлэг 11).


2014-2016 онд хийсэн Монголын Олон зорилгот үндэсний ойн тооллого, ЕЭЗК-ын тооцоогоор өнөөгийн байдлаар тусгай хамгаалалттай газарт шилмүүст, навчит, заган ойн 3.1 сая га талбай байгаа нь ойн бүрхэвчтэй нийт газрын 25 орчим хувь, улсын нийт нутаг дэвсгэрийн 1.98 хувийг эзэлж байна.

#### *Ойг нөхөн сэргээх, ойжуулах үйл ажиллагаа*

Ойг нөхөн сэргээх үйл ажиллагааг Монгол улсад 1968 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлжээ. Хөхөн сэргээсэн ойн талбай 1970-аад онд жил тутам 50 га байсан бол 1980-1984 онд 1,000-2,000 га, 1990-1994 онд 4,000-5,000 га болж өссөн байна. 2000 оноос эхлэн жил тутам 8,000-9,000 га ойн талбайг, 1980-2016 онд нийт 201,145 га талбайг нөхөн сэргээжээ (Зураг 13.2).

Ойн нөхөн сэргээх үйл ажиллагаанд мод бэлтгэсэн болон ойн түймэрт сүйтсэн талбайд мод тарих, ойн зурвас байгуулах, ойн байгалийн нөхөн үржихүйг дэмжих, тарьц, суулгац бойжуулах, мод үржүүлэг зэрэг үйл ажиллагаа хамрагдана. Тарьц, суулгац ашиглан нөхөн сэргээх үйл ажиллагааг хавар, намрын улиралд хийдэг ба нөхөн сэргээлтэд 2-3 настай суулгац ашиглаж байна.

Зураг 13.2: Ойн нөхөн сэргээсэн талбай, 1980-2016 он, га



Эх сурвалж: 2015-2016 оны Байгаль орчны төлөв байдал, БОАЖЯ, 2017 он.

Ойн нөхөн сэргээлтийн үр дүн ихээхэн доогуур байна. Дэлхийн банкнаас 2006 онд хийсэн “Монгол Улсын модны хангамж: хууль ёсны болон хууль бус эдийн засаг” судалгаагаар улсын төв, хойд бүсийн мод үржүүлгийн 19 байршилд үнэлгээ хийж, суулгацын бодит бойжилт зөвхөн 12 хувьтай байгааг тогтоосон байна. Хатуу ширүүн уур амьсгалаас гадна мал бэлчих, ойн түймэр, мод тарих ажиллагааны чанар зэрэг олон хүчин зүйл мод бойжилтын бодит үр дүнд сөрөг нөлөөлж байна. Мод үржүүлгийн амьдралын хувийг мод тарьсны дараа суулгацыг услах, талбайд хашаа барих, уулын хойд энгэрийг сонгох зэрэг аргачлалаар нэмэгдүүлж болно.

Ойг нөхөн сэргээх үйл ажиллагааг “Ногоон хүрэм” (ЗГ-ын 2005 оны 44 дүгээр тогтоол) хэмээх том хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлжээ. Хөтөлбөр нь ногоон бүс байгуулах, мод, бут сөөг, эмийн ургамлын ногоон зурвас байгуулах замаар улсын өмнөд хэсгийн хөрсний элэгдлийг бууруулах, цөлжилтийг сааруулах зорилготой байв. Хөтөлбөрийн 1 дүгээр үе шатыг 2005-2015 онд, 2 дугаар үе шатыг 2016-2025, 3 дугаар үе шатыг 2025-2035 онд тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Нэгдүгээр үе шатанд нийт 5,302 га ойн талбайг нөхөн сэргээжээ (Хүснэгт 13.2).

**Хүснэгт 13.2: Ногоон хүрэм хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ойн нөхөн сэргээх үйл ажиллагаа, 2005-2017 он, га**

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	Нийт
Улсын төсвөөр нөхөн сэргээсэн талбай	307	409	260	265	132.4	106	160	356	106	100	100	50	50	2,401.4
Гадаадын хөрөнгө оруулалтаар нөхөн сэргээсэн талбай, Үүнээс:														
Ногоон Ази ТББ	-	10	-	6	39	47	95	56	-	-	-	-	-	253.00
Монгол-Солонгосын Ногоон хүрэм төсөл	-	-	-	150	100	100	110	200	300	430	500	600	-	2,490.00
Ротари клуб	60	42	40	5	-	-	-	-	-	-	-	-	-	147.00
Бусад санхүүжилтээр нөхөн сэргээсэн талбай		11	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	11.00
<b>Нийт талбайн хэмжээ</b>	<b>367</b>	<b>472</b>	<b>300</b>	<b>426</b>	<b>271.4</b>	<b>253</b>	<b>365</b>	<b>612</b>	<b>406</b>	<b>530</b>	<b>600</b>	<b>650</b>	<b>50</b>	<b>5,302.40</b>

Эх сурвалж: Ойн судалгаа, хөгжлийн төв, БОАЖЯ, 2017 он.

**Фото зураг 13.1: Салхины элэгдлээс хамгаалж тарьсан мод***Ойн дагалт баялаг, бүтээгдэхүүн*

Ойн дагалт баялаг, бүтээгдэхүүнд (ОДББ) самар, мөөг, жимс жимсгэнэ, эмийн болон үнэртэн ургамал ордог бөгөөд орон нутгийн хүн амын ахуйн хэрэглээ, орлогын чухал эх үүсвэр болдог байна. ОДББ-нд мөн зэрлэг амьтны арьс, эмийн зорилгоор ашиглах бугын эвэр, ангийн мах орно (Хүснэгт 13.3).

**Хүснэгт 13.3: Ойн дагалт баялгийн төрөл, ашиглалт**

Төрөл	Баялаг, бүтээгдэхүүн	Ашиглалт
Ургамлын ОДББ	Хадлан	Малын тэжээл
	Самар, мөөг	Хувийн хэрэглээ, худалдан борлуулах
	Хүнсний ургамал (жимс, жимсгэнэ, эмийн ургамал, булцуу, ногоо)	Хувийн хэрэглээ
	Эмийн ургамал	Хувийн хэрэглээ, худалдан борлуулах
Амьтны ОДББ	Үнэртэн ургамал	Шашны зан үйл (зөвшөөрөл авна)
	Арьс (булга, чоно, үнэг, шилүүс)	Худалдан борлуулах
	Бугын эвэр	Эмийн зорилгоор, БНХАУ, БНСУ-д экспортлох
	Тарваганы тос	Эмчилгээний зорилгоор
	Ангийн мах	Хувийн хэрэглээ

Эх сурвалж: ЕЭЗК, 2017 он.

### 13.2 Ойд учирч буй дарамт, нөлөө

#### *Ойн түймэр*

Монгол орны ойн санд ойн түймэр маш их хэмжээний хохирол учруулдаг. Монгол дахь түймрийн талаар НҮБ-ын ХХААБ-аас хийсэн судалгаанаас үзвэл өнгөрсөн 35 жилийн хугацаанд нийт 4,609




удаагийн ойн болон хээрийн түймэр бүртгэгдсэнээс 1980-2014 онд жилд дунджаар 34,3770 га, нийт 12 сая га ой түймэрт сүйтсэн байна (Зураг 13.3). Түймэрт өртсөн ойн талбай удаан нөхөн сэргэдэг. Түймрийн дараа шилмүүст ойн оронд хус, улиангар болон чанар муутай шилмүүст мод голдуу ургадаг байна.

Ойн түймэр цас хайлсны дараахан, ойн хөрс ихээр хуурайшдаг 3 дугаар сараас 6 дугаар сарын дунд үеийн хооронд ихэвчлэн гардаг байна. Нарны идэвхтэй цацрагийн улмаас хөрсний дээд хэсгийн чийг богино хугацаанд алдагдаж, ойн хөрс их хуурайшиж түймэр гарах нөхцөлийг бүрдүүлдэг. Монгол орны хаврын түймрийн 90 гаруй хувь нь хүний болгоомжгүй үйлдэл болон санаатайгаар түймэр тавьснаас гардаг байна. Болгоомжгүй үйлдэлд бугын эвэр цуглуулж байгаа хүмүүс хаврын хүйтэн улиралд гал асаах, алслагдсан ойн бүсэд автомашины яндангаас оч үсрэхээс түймэр гарахыг (нэн ховор) хамруулж байна. Мөн сүүлийн үед дотоодын аялал жуулчлал, амралт зугаалгыг хөгжүүлэхийг дэмжиж байгаатай холбогдон ойд аялж, зугаалж байгаа хүмүүс хот суурингийн орчимд гал тавих тохиолдол өсч байна. Сүүлийн жилүүдэд санаатайгаар түймэр тавих явдал мэдэгдэхүйцээр нэмэгджээ. Түймэр тавих нь өнөөгийн зохицуулалтын систем, мод бэлтгэлийн үйл ажиллагаанд нэлээд хориг тогтоож, зөвхөн унанги мод бэлтгэхийг зөвшөөрдөг болсонтой холбоотой байна. Иймэрхүү хориг нь сөрөг үр дагавартай, унанги мод бэлтгэлийн зөвшөөрөл авахын тулд хүмүүс санаатай гэмт хэргийн үйлдэл, түймэр тавихад хүргэж байна.

Хамгийн олон ойн түймэр 1997 онд гарсан байна (Зураг 13.3). 1996-1998 оны өвөл, хаврын улиралд улсын ихэнх нутгаар цас бага орж, ихээхэн хуурайшилттай байжээ. 1996, 1997 онд хоёр жил дараалан Монголд том хэмжээний ойн түймрүүд гарч улсын нэлээд ойн талбайг сүйтгэсэн байна. 1996 онд 2.3 сая га ойн талбай түймэрт өртсөн бол 1997 онд 2.71 сая га талбай сүйтсэн байна.

**Зураг 13.3: 1980-2014 онд түймэрт сүйтсэн ойн талбай, сая га**



Эх сурвалж: БОАЖЯ, 2017 он.

#### *Хортон шавьж*


Ойн түймэр, мод бэлтгэл, цэвдэгт хөрс хайлах зэрэг уур амьсгалын болон бусад хүчин зүйлээс шалтгаалан ойн модны чанар доройтож, хөнөөлт шавьжинд өртөх нөхцөлийг нэмэгдүүлж байна. 1980-2012 онд нийт 9.9 сая га ойн талбай хөнөөлт шавьжинд өртсөн нь нэг жилд нэг га талбайд 301 мэрэгч, шавьж ноогдож байв (Зураг 13.4). Сүүлийн үед хөнөөлт шавьжийн дэгдэлт 10-12 жил тутамд илүү далайцтай тохиолдож байсан боловч гангийн нөхцөл дэгдэлтийн давтамжийн хугацаа богиносоход хүргэж байгаа ажээ. Монголын ойд сибирийн хүр эрвээхэй (*Dendrolimus sibiricus*), өрөөсгөл хүр эрвээхэй (*Lymantria dispar*), яковсоны төөлүүрч эрвээхэй (*Erannis jacobsoni*) хамгийн их тархсан байна. Ойн хөнөөлт шавьж мод сүйтгэхийн сацуу орон нутгийн хүн амын эрүүл мэнд, ялангуяа ойн бүсэд амьдардаг хүүхдүүдэд харшил үүсгэх зэргээр сөрөг нөлөөлж байна.

Засгийн газраас шавьжны дэгдэлтэд хяналт тавих тууштай арга хэмжээ авч байгаа хэдий ч өргөн уудам нутаг, мэргэжлийн боловсон хүчний болон шаардлагатай тоног төхөөрөмжийн хомсдол, санхүүгийн



дутагдал, хоцрогдсон менежемент, зохицуулалт, хуучирсан тоног төхөөрөмж зэрэг нь үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэл учруулдаг байна. Жишээ нь 2001 онд доод тал нь 400,000 га ойн талбайд арчилгаа хийх шаардлагатай тооцоо гарсан боловч олгосон санхүүжилт нь зөвхөн 10,000 га-д арчилгаа хийхэд хүрэлцсэн байна.

**Зураг 13.4: Хортон шавьжинд өртсөн ойн талбай, 1980-2012 он, сая га**



Эх сурвалж: БОАЖЯ, 2017 он.

Шавьжны тархалтад хяналт тавих нь байгалийн тогтолцоо, мөн тархалтын зарим талбай нь орон нутгийн хүн амын оршин суудаг газрын орчинд байгаагаас хүндрэл учруулдаг байна. Хотын захын бүсүүдэд хяналтын үйл ажиллагааг цацсан химийн бодисууд суурингууд газруудад нөлөөлөхгүй байх нөхцөлийг ханган хэрэгжүүлдэг байна.

Хүчтэй салхи, хэт хүйтэн цаг агаар, ойн шавьжны амьдралын онцлог мөчлөг нь хяналтын стратеги, үйл ажиллагааг улам хүндрүүлж байна. Химийн бодисын сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах үүднээс Засгийн газраас байгальд ээлтэй технологи, органик ургамалд суурилсан бүтээгдэхүүн, биологийн арга хэрэгслийг ашиглах хүчин чармайлт гаргаж байна.

#### *Хүний үйл ажиллагаа*

Ойн санд сөрөг нөлөө үзүүлж буй олон тооны хүчин зүйл бий. Ойн сангийн багахан хэсгийг дэд бүтцийг хөгжүүлэх, зам, цахилгааны болон холбооны шугам тавих зорилгоор цэвэрлэж байна. Сүүлийн жилүүдэд уул уурхай, ялангуяа бичил уурхайн үйл ажиллагаа өргөжсөн нь ойн зарим талбай хорогдоход хүргэжээ.

Ойн бүсэд мал бэлчээх нь ойн талбай, ялангуяа ургамлын нөхөн ургалтад хамгийн ноцтой сөрөг нөлөө үзүүлж байна хэмээн дүгнэж болох талтай. 1990 онд мал хувьчилснаас хойш малын тоо толгой үлэмж өссөн. Сүүлийн 30 жилд малын тоо толгой тогтвортой өсч, 1986 онд 22.6 сая байсан бол 2000 онд 30 сая, 2012 онд 40 сая, 2014 онд 50 гаруй сая, хамгийн сүүлийн 2016 оны тооллогоор 61.5 сая болтол өсөв. Малын огцом өсөлт, мал залуу суулгацыг идэж байгаа нь ойн ургамлын нөхөн ургалтад мэдээж нөлөө үзүүлж байна. Малын сөрөг нөлөөлөл, тухайлбал ямар төрлийн мал, ямар төрлийн ойд хэрхэн нөлөөлж байгаа асуудалд төвлөрсөн судалгаа хийгдээгүй учир ойн талбайд мал бэлчээж байгаагийн статистик мэдээлэл байхгүй, эдийн засгийн хохирлыг үнэлэх боломжгүй байна.

#### *Хүчиллэг бороо*

Хүчиллэг борооны ойн санд үзүүлсэн нөлөөний талаар мэдээ мэдээлэл байхгүй байна. 2000-аад оны эхээр ой хариуцдаг байгууллагууд хүчиллэг борооны асуудлыг өргөн хүрээнд хэлэлцсэн байсан байна. Монгол Улс хүчиллэг тунадасанд хяналт мониторинг хийх Зүүн Азийн сүлжээний (ХТХМХЗАС) үйл ажиллагаанд оролцож, сүлжээний хүрээнд усан дахь металын хорт агууламж, хүхэр болон азотын ислийг хэмжих тоног төхөөрөмж суурилуулжээ. Гэвч энэ үйл ажиллагааны хүрээнд хяналт хэмжилтийн

тусгай судалгаа хийгдээгүй учир Монголын ойн санд хүчиллэг борооны үзүүлсэн нөлөөнд дүгнэлт хийх боломжгүй байна.

**Фото зураг 13.2: Ой дахь мал бэлчээрлэлт**



*Мод бэлтгэл, хууль бус мод бэлтгэл*


Монгол Улсыг аж үйлдвэржүүлэх ерөнхий бодлогын хүрээнд 1960-аад оноос ойн санг эдийн засгийн зорилгоор ашиглаж эхэлжээ. Барилгын материал, гэр, тавилга, эмээл зэрэг гэр ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх мод боловсруулах үйлдвэрүүдийг байгуулжээ. Мөн модыг БНХАУ руу экспортолж байв. Ойн аж үйлдвэр нь 1960-1990 онд төвлөрсөн эдийн засагтай улсын чухал салбар болж, ДНБ-ний 6 хувийг бүрдүүлж байжээ.

Мод бэлтгэх, боловсруулах бүх байгууллагуудыг 1990-ээд оны эхээр хувьчилсан боловч хувьчилсан байгууллагууд нь хөрөнгө санхүү, мэргэжлийн боловсон хүчин, менежментийн туршлага чадварын дутагдал, дотоод болон олон улсын заах зээлд гаргах бүтээгдэхүүн чанарын стандарт хангаагүйн улмаас бүрэн хүчин чадлаар ажиллах боломжгүй байжээ. Хувьчлагдсаны дараа тэдгээрийн зарим нь дампуурч хаагдсан байна. Үүний дүнд жилийн мод бэлтгэлийн хэмжээ 1980-аад онд 1.8 сая м<sup>3</sup> байсан бол 2002 онд 620,000 м<sup>3</sup> орчим болтол буурсан байна. Ойн сангийн газар талбай тууштай хорогдож байгааг сааруулах зорилгоор засгийн газар жилийн мод бэлтгэлийн хэмжээг багасгасан нь мод бэлтгэлийн үйл ажиллагаанд мөн нөлөөлсөн байна. Ойн зарим талбайг хамгаалалттай газарт хамруулсан нь сүүлийн 20-иод жилд ойг эдийн засгийн зорилгоор ашиглах явдлыг үлэмж бууруулсан байна.

Статистикийн зарим мэдээнээс үзвэл 1980-2003 онд нийт 29.2 сая м<sup>3</sup> мод, 1980-2014 онд нийт 37.496 сая м<sup>3</sup>, үүнээс жилд дунджаар 1,040 сая м<sup>3</sup> мод бэлтгэсэн байна (Зураг 13.5). Гэвч 1980-1990, 1991-2000 онд мод бэлтгэлийн хэмжээ өөр байсныг харгалзан үзвэл жилийн дундаж үзүүлэлтийг ерөнхий байдлаар гаргах үндэслэл муутай байна. Мод бэлтгэлийн жилийн дундаж хэмжээ 1980-1990 онд 1.924 сая м<sup>3</sup> байв. Мөн 1990-ээд оноос мод бэлтгэлийн хэмжээ үлэмж багасгасан нь ойн доройтолтой холбогдуулан засгийн газар мод бэлтгэлийн хэмжээг бууруулах бодлого хэрэгжүүлсэнтэй холбоотой

юм. Мод бэлтгэлийн жилийн дундаж хэмжээ 1991-2000 онд 0.701 сая м<sup>3</sup>, 2001-2014 онд 0.665 сая м<sup>3</sup> байжээ.

**Зураг 13.5: Мод бэлтгэл, 1980-2014 он, сая м<sup>3</sup>**



Эх сурвалж: Үндэсний статисткийн хороо, 2017 он.

Монгол Улсын ойн нөөцийн менежментийн гол тулгамдсан асуудал нь хууль бус мод бэлтгэл хэвээр байна. 2003 онд Дэлхийн банкнаас гаргасан “Монголын ойн салбарын дүгнэлт” илтгэлд мод бэлтгэл, түлээний модны жилийн дотоод нийт хэрэглээг 0.965 - 3.0 сая м<sup>3</sup> хооронд хэлбэлзэж байна гэж тооцолсон байна. Жилд дунджаар 0.663 сая м<sup>3</sup> мод бэлтгэдэг гэж үзвэл жилд 0.301 сая м<sup>3</sup>-ээс 2.336 сая м<sup>3</sup> модыг хууль бусаар бэлтгэдэг тооцоо гарч байна. Сүүлийн жилүүдэд барилгын салбар үлэмж өргөжсөн, хүн ам өссөн, газрыг хувьчилсан, хотруу шилжих хөдөлгөөн идэвхжсэнтэй холбогдон модны хэрэгцээ, хэрэглээ нэмэгдсэнийг харгалзан дээрх тоо бодит байдлаас доогуур байж болзошгүй юм.

Жилийн мод бэлтгэл буурч байгаагаас хот, хөдөөгийн хүн ам түлээний модны хомсдолд орж байна. Түлээний мод нь нийт мод бэлтгэлийн 65 орчим хувийг эзэлдэг ба улсын ихэнх бүсэд цахилгаан болон нүүрс хангамж хүрэлцээгүйн учир түлээний мод нь гэр байшингаа дулаанаар хангах болон хоол хүнсээ бэлтгэх цорын ганц эх үүсвэр болдог байна. Мөн банз модоор хашаа, байшин барьдаг. Хувийн хэрэглээний сацуу олон хүн нэмэгдэл орлого олох зорилгоор мод зардаг байна. Зарим хүмүүс бүлэг байгуулан модыг зохион байгуулалттай борлуулдаг ба хууль бус мод бэлтгэл хүмүүсийн орлогын гол эх үүсвэр болсоор байна. Зарим хүмүүс улсын мод боловсруулах үйлдвэрүүдэд ажиллаж байсны хувьд мод бэлтгэлийн ажлын тодорхой мэдлэг чадвартай. Хуучин тогтолцоо нурж, хот суурины мод боловсруулах үйлдвэрүүд хаагдсанаар орон нутгийн оршин суугчид хуулийн хүрээнд орлого олох ажлын боломжоо алдсан байна. Засгийн газраас мод бэлтгэлээс өөр орлого олох хувилбарыг санал болгоогүй байна. Гэвч дээр дурьдсан мод бэлтгэх бүлгүүдийн мод бэлтгэлийн хэмжээ нь “мэргэжлийн” хууль бус мод бэлтгэгчдээс хавьгүй бага байна. Дэлхийн банкны илтгэлд “мэргэжлийн” хууль бус мод бэлтгэгч гэж мод бэлтгэх зөвшөөрөлтэй боловч зөвшөөрсөн хэмжээнээс хавьгүй илүү мод бэлтгэдэг компаниудыг тодорхойлсон байдаг.

Байгаль орчны хуулиудын нийт зөрчилд хууль бус мод бэлтгэл нь давтамж, цар хүрээний хувьд хамгийн ноцтой хэвээр байна. Хууль бус мод бэлтгэлийн нийт зөрчил 2009-2016 онд 1134 тохиолдол бүртгэгдсэн нь байгаль орчны хуулиудын хүрээнд гарсан зөрчлөөс хамгийн олон гарчээ (Зураг 2.5). Тухайлбал 2012 онд 262, 2013 онд 246 зөрчил бүртгэгдсэн байна.

Засгийн газар хуулиудын хэрэгжилтийг сайжруулах замаар хууль бус мод бэлтгэлийн асуудлыг шийдвэрлэхийг оролдож байгаа боловч хууль бус мод бэлтгэлийг таслан зогсооход хүн хүч болон санхүүгийн нөөц дутагдаж байна. Нэг ойн хамгаалагчид 100,000 га ойн талбайн хамгаалалт, арчилгаа ноогддог учир ой дахь хууль бус үйл ажиллагаанд үр бүтээмжтэй хяналт тавих үндсэндээ боломжгүй юм. Ойн нөхөрлөлүүд байгуулсан нь тухайн нөхөрлөлийн хариуцсан ойн бүсэд хууль бус мод бэлтгэлийг зогсоох үр дүнтэй арга хэмжээ болж байна.



### 13.3 Ойн үйл ажиллагааны учруулж байгаа дарамт, нөлөөлөл

Монгол Улсад ойтой холбоотой үйл ажиллагааны ойн сан, биологийн олон янз байдал, хөрс, эрүүл мэнд, орон нутгийн иргэдийн амьжиргаанд үзүүлсэн нөлөөллийн талаар судалгаа огт хийгдээгүй байна.

#### *Төлөвлөлтгүй мод бэлтгэл*

НҮБ-ын Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах хөтөлбөрийн (НҮБ-РЭДД) урьдчилсан үнэлгээгээр Монгол дахь ойн сангийн өөрчлөлт, доройтлын хамгийн гол хүчин зүйл нь ойн түймэр, дараа нь хөнөөлт шавьж, мод бэлтгэл хэмээн тогтоосон байна. Төлөвлөлтгүй мод бэлтгэлийн дүнд 2004-2014 онд жилд дунджаар 34,000 га газрын ойн доройтол бий болжээ. Төлөвлөлтгүй мод бэлтгэлийн сөрөг нөлөөлөлд чанаргүй мод бэлтгэл, бэлтгэлийн дараах менежментийн доголдолтой үйл ажиллагаа улам нэрмээс болж байна. ААН-үүд түймэр болон хөнөөлт шавьжны хохирлын үр дагаврыг багасгах, мал бэлчээх болон нэмэлт мод бэлтгэх боломжийг багасгах талаар зохистой арга хэмжээ авахгүй байна.

#### *Биологийн олон янз байдал болон экосистем*

Мод бэлтгэлийн үйл ажиллагааг зохистой менежментээр хангахгүй байгаа нь хөрсний элэгдэл, амьтан, ургамлын орчин алдагдахад хүргэж, улмаар Монгол Улсын хязгаарлагдмал хэдий ч маш үнэ цэнэтэй ойн нөөцөд аюул учруулж байна. Ой устах ерөнхий үйл явц нь биологийн олон янз байдал болон экосистемд сөрөг нөлөө үзүүлж байна. Төлөвлөлтгүй мод бэлтгэл нь байгаль орчны тэнцвэрт байдал өөрчлөгдөх, зэрлэг амьтан ургамлын зүйл төрөлд аюул учруулна. Иймд урьдчилан сэргийлэх арга хэмжээ болгон Ойн тухай хуулиар ойг их хэмжээгээр огтлохыг хориглосон байна. Гэвч ойтой холбоотой үйл ажиллагааны биологийн олон янз байдал болон экологийн тогтолцоонд үзүүлсэн сөрөг нөлөөлөлд үнэлгээ хийх статистикийн мэдээлэл, судалгаа байхгүй байна.

#### *Хөрс*

Мод бэлтгэлийн явцад мод унахад ойн ургамлын бүрхэвчинд шууд нөлөөлж, ихэнх тохиолдолд хөрсний элэгдлийн урьдчилсан нөхцөлийг бүрдүүлдэг байна. Ойг нөхөн сэргээхэд газар хагалах технологийг ашиглаж байгаа нь хөрсөнд сөрөг нөлөө үзүүлж, цэвдгийг ил гаргаж улмаар цэвдэг хайлахад хүргэдэг. Ойн үйл ажиллагаанаас үүдэн хөрсөнд ямар өөрчлөлт орж байгаад дүгнэлт хийхэд бэрхшээлтэй. Гэвч ойтой холбоотой үйл ажиллагааны цар хүрээ хязгаарлагдмал байгаа тул нөлөө нь ч мөн бага талбайг хамаардаг. Суурь бодитой мэдээ мэдээлэл байхгүйн улмаас дүгнэлт хийх боломжгүй байна.

#### *Орон нутгийн иргэдийн хөгжил, амьжиргаа*

Монголын хүн амын 40 орчим хувь хөдөө орон нутагт амьдардаг. Ойн бүсэд амьдардаг хүмүүсийн хувьд ой нь амьжиргааны орлогын чухал эх үүсвэр, амьжиргааны хэрэглээ, түлээ, ажлын байраар хангадаг. Ойн бүс нь аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжийг олгож байна.

### 13.4 Ойн менежментийн төрлүүд

Монголын бүх ойн сан төрийн өмч юм. Ойн тухай 2012 онд шинэчилсэн хуулиар ойн менежментийг төр засаг, орон нутгийн захиргаа болон ойн нөхөрлөл, хувийн хэвшлийн ААН-үүд хэрэгжүүлж болно. Төр нийт ойн сангийн 80 орчим хувьд нь менежмент хийж байна.

#### *Орон нутгийн иргэдийн ойн менежмент*

1990 он хүртэл ойн аж үйлдвэр эрчимтэй хөгжиж, өргөжин, ойн салбар ДНБ-ний 6 хувийг бүрдүүлж байжээ. 1990-ээд онд нийгмийн тогтолцоо өөрчлөгдсөнтэй холбогдон улсын өмчит мод боловсруулах үйлдвэрүүдийг хувьчилж жижиг аж ахуйн нэгжүүд болгосон боловч тэдгээрийн ихэнх нь хөрөнгө санхүү, мэргэжлийн боловсон хүчний хомсдлоос болж нэн удахгүй хаагдсан байна. Түүнчлэн модон бүтээгдэхүүний дотоодын зах зээл үлэмж хумигдаж, үүнээс үүдэн хууль бус мод бэлтгэл ихээхэн нэмэгдсэн байна. Нийгмийн тогтолцоо өөрчлөгдсөний улмаас эдийн засгийн ерөнхий байдал хүндэрч, ажилгүйдэл огцом өссөн нь нөхцөлийг улам даамжруулсан байна. Үүнтэй холбогдуулан төр засгийн менежментийн гол бодлого нь ойн санг ашиглах бус, харин хамгаалах, хадгалахад чиглэгдэх болж энэхүү бодлогын хүрээнд нийт нутаг дэвсгэрийн 30 хувийг тусгай хамгаалалттай газарт хамруулахаар

засгийн газар шийдвэрлэсэн (Бүлэг 11) байна. Гол зорилго нь биологийн олон янз байдал, ойн санг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, эдийн засгийн зорилгоор мод бэлтгэхийг бууруулахад оршиж байв. Ойжуулах, ойг нөхөн сэргээх хөтөлбөр, үйл ажиллагаа өргөжиж байна.

Гэвч хууль бус мод бэлтгэлд хяналт тавих төрийн дээрээс доошоо чиглэгдсэн, хууль сахиулах босоо тогтолцоо нь төрөөс хангалттай боловсон хүчин, тоног төхөөрөмжийн хангалтыг санхүүжүүлэх боломжгүй байдлаас үүдэн үрөгөөж багатай байгаа нь удалгүй харагджээ. Иймд асуудлыг шийдвэрлэхийн тулд Засгийн газар орон нутгийн ард иргэдийг ойн менежмент, ялангуяа ойг хамгаалах, нөхөн сэргээх ажиллагаанд татан оролцуулж байна. Орон нутгийн иргэдийг татан оролцуулахад ойн нөөц, тухайлбал мод, түлээний мод, ойн дагалт баялаг амьжиргааны гол эх үүсвэр нь болдог, ойгоос хамааралтай ард иргэдэд түшиглэх бодлого баримталжээ. Ийм иргэд ойн нөөцийг тогтвортой ашиглах, гадны хүмүүс ойн нөөцийг хууль бусаар ашиглахаас хамгаалах илүү сонирхолтой байдаг байна. Энэхүү хандлага нь ойн тухай хууль тогтоомжийг шинэчлэн, орон нутгийн ард иргэдэд ой ашиглах урт хугацааны эрх олгохыг шаардсан. 1995 оны ойн тухай хуулийг 1998 онд шинэчилж, ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь ойн менежментийн төлөвлөгөөний дагуу эзэмшлийнхээ ойг хамгаалах, энэ хуульд заасан үндэслэл журмын дагуу мод, дагалт баялгийг ашиглах, ойд арчилгаа, цэвэрлэгээ явуулах, нөхөн сэргээх арга хэмжээг авахаар зохицуулсан байна. Бодлого, хууль тогтоомжид орсон энэ өөрчлөлтийн дагуу орон нутгийн хүмүүс ойн нөхөрлөл (ОН) байгуулж эхэлжээ. Ойн нөхөрлөлийн үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж, 2017 оны байдлаар ойн сангийн нийт газрын 18.7 хувь нь ойн нөхөрлөлийн харъяанд шилжээд байна (Шигтгээ 13.1).

#### *Ойн концесс*

Ойн тухай 1995 оны хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт, Засгийн газрын 2009 оны 227 дугаар тогтоол нь ойн хувийн концессийн гэрээ байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн байна. 2016 оны байдлаар хувийн хэвшлийн 90 ААН-үүд нийт ойн сангийн 4.7 хувьтай тэнцэх 681.400 га ойн талбайг концессийн гэрээгээр эзэмшиж байна. Концессийн гэрээний нөхцөл, хугацаа нь ойн нөхөрлөлийнхтэй адил, анхлан нэг жилээр байгуулж, 10 жил тутам сунган нийт 60 жилээр байгуулна. Хувийн хэвшлийн концессийн гэрээний гол зорилго нь ажлын байр, орлогын эх үүсвэр бий болгох замаар орон нутгийн ард иргэдийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэхэд оршиж байна.

#### *Ойн мэргэжлийн байгууллагууд*

Дээр дурьдсан ААН-үүдээс гадна БОАЖ-ын сайдын 2003 оны А-223 тоот тушаалын хавсралтын дагуу БОАЖЯ-наас хувийн компани, байгууллагуудад “ойн мэргэжлийн байгууллага” гэрчилгээ, зөвшөөрөл олгох болсон байна. Эдгээр байгууллагууд нь гэрээний үндсэн дээр ойн тооллого хийх, ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, хөнөөлт шавьжны судалгаа, хяналт хийх, ойг цэвэрлэх, сийрэгжүүлэх болон ойжуулах, үйлдвэрлэлийн зорилгоор мод бэлтгэх үйл ажиллагаа эрхэлдэг. 2016 оны байдлаар 814 хувийн хэвшлийн байгууллагад ойн мэргэжлийн байгууллагын гэрчилгээ олгосон боловч эдгээр хувийн компаниуд нэлээд бэрхшээлтэй тулгарч байна.

Хуулийн дагуу ойн мэргэжлийн байгууллага бүр нэгээс доошгүй ойн мэргэжилтэн, бэлтгэгдсэн зохих тооны ажилтнууд, бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэлтэй байх үүрэгтэй боловч улирлын чанартай ажлаас шалтгаалан тэдгээр нь орчин үеийн технологи, техник хэрэгсэлд хөрөнгө бүрэн оруулах боломжгүй, техник хэрэгслийг бие биенээс түрээслэх хэлбэрээр үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Зарим компаниуд олон жил мэргэжлийн үйл ажиллагаа хийгээгүй хэдий ч тусгай гэрчилгээг хадгалж, зөвхөн цаасан дээр бүртгэлтэй байна. Мөн зарим ОН-үүд мод бэлтгэлийн үйл ажиллагаа явуулах эрх авах зорилгоор өөрсдийгөө ойн мэргэжлийн байгууллага хэмээн нэрлэдэг байна.

Ойн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаа, тэдний ажлын чанарт яам, орон нутгийн захиргаанаас байнгын хяналт үнэлгээ хийдэггүй бөгөөд цаашид ойн мэргэжлийн байгууллагын гэрчилгээг зөвхөн ажлыг чанарын шаардлагын дагуу гүйцэтгэх чадвартай, зохих техник хэрэгслээр хангагдсан компаниудад олгох үүднээс үйл ажиллагааны үнэлгээг тогмолжуулах хэрэгтэй байна. Нөгөө талаар ойн мэргэжлийн компаниудын үйл ажиллагаанд үнэлгээ хийхийн тулд тэдний чадавхийг дээшлүүлэх сургалтууд зохион байгуулбал зохино. Мөн нийт 814 ойн мэргэжлийн байгууллага байгаа нь нийт ойн сангийн газарт хэрэгжүүлэх үйл ажиллагаатай харьцуулвал хэтэрхий олон байна.



## Шигтгээ 13.1: Ойн нөхөрлөл

Баг, хорооны иргэний төлөөлөгчдийн хурлын саналыг үндэслэн сум, дүүргийн иргэний төлөөлөгчдийн хурлаас Ойн нөхөрлөлд (ОН) концессийн эрх олгоно (Ойн тухай хуулийн 2012 оны шинэчилсэн найруулга). Концессийн гэрээг анхлан нэг жилээр байгуулж, зохих бэлтгэл ажил хангагдсаны дараа нийт 60 жилийн хугацаагаар байгуулан, 10 жил тутам шинэчлэнэ. Гэвч гэрээ эзэмшигчдийн аюулгүй байдал, гэрээний эрх зүйн баталгаа тодорхой бус байна. Зөвхөн уул уурхайн концесс бүрэн баталгаажсан байдаг. Ойн тухай болон холбогдох бусад хуулиудад гэрээнд тусгасан ойн талбайн эрх давхардахгүй байх явдлаас сэргийлэх асуудлыг тодорхой тусгаагүй учир ойн нөхөрлөлд концессоор олгосон ойн талбайг бусдад давхардуулан олгох тохиолдол гарч байна.

ОН-ийн боловсруулсан өөрийн эзэмшлийн ойн талбайн ойн менежментийн төлөвлөгөөг орон нутгийн иргэний төлөөлөгчдийн хурал батална. ОН нь төлөвлөгөөний биелэлтийг жил тутам тайлагнах үүрэгтэй. Ойн мэргэжилтнүүд (төрийн байгууллага болон хувийн хэвшлийн) ойн менежментийн төлөвлөгөө боловсруулахад ойн нөхөрлөлд тусламж үзүүлэхийг 2015 оноос хуульчилсан. Ойн мэргэжилтний төлбөр өндөр байгаагаас зарим ойн нөхөрлөл төлбөр хийх чадваргүй байдаг. Сүүлийн үед хандивын сангуудаас хэрэгжүүлсэн төслүүд нь ОН-ийн ойн менежментийн төлөвлөгөөг хялбарчлах талаар нааштай арга хэмжээ, аргачлалыг нэвтрүүлсэн нь орон нутгийн иргэдийн үйл ажиллагаанд эергээр нөлөөлж байна. Гэрээгээр эзэмшиж буй ойн талбайд ОДББ-н ашиглахыг зөвшөөрөх боловч мод бэлтгэх, түлээний мод авахад тусгай зөвшөөрөл шаардлагатай байдаг байна.

2017 оны байдлаар нийт 1281 ойн нөхөрлөлд 6742 айл өрх хамрагдаж, орон нутгийн захиргаатай байгуулсан гэрээний дагуу 3.345 сая га ойн талбайг эзэмшиж байна. Энэ нь улсын нийт ойн сангийн газрын 18.7 хувь юм. ОН-үүдийг байгуулснаас хойш тэдний эзэмшлийн ойн талбайд түймэр гарах нь үлэмж багасчээ. ОН-үүд ойн менежментийн үйл ажиллагааг санаачилж, ойн ААН-үүдийг байгуулж байна. Ойн нөхөрлөлүүдийн ойн менежмент богино хугацаанд маш үр дүнтэй хэрэгжиж, орон нутгийн ард иргэдэд ч эзэмшигчийн сэтгэлгээ төлөвшиж байна. Гэвч эрх зүй, зохицуулалтын тогтолцоо нь үйл ажиллагааг хязгаарласан хэвээр байна. Тухайлбал ОН-ийн гишүүдийн ой хамгааллын талаар хүлээх үүрэг нь эдлэх эрх, ашгаас хэтэрсэн байна. ОН-үүдийн статус нь санхүүгийн зах зээлд нэвтрэх эрх олгохгүй байна. Иймд ОН-д суурилсан ойн тогтвортой менежмент, эдийн засаг болон экологийн үр ашгийн потенциалыг бүрэн тооцоогүй байна.

### 13.5 Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, түүнд дасан зохицохуй

#### Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө

Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн (ГТХАН) шугамаар Landsat хиймэл дагуулын мэдээллийг ашиглан 2011 онд хийсэн тооцоогоор 1999-2011 онд ойн бүрхэвчтэй талбай 4.1 хувиар буюу 533,100 га-гаар хорогдсон нь ойн алдагдлын эрчим нь 0.34 хувьтай байна гэсэн үг юм. 1999-2011 оны хугацаанд шилмүүст, навчит, заган ойн байгалийн талбай нийт 944,300 га-гаар буюу 7.5 хувиар, жилд 73,000 га буюу 0.62 хувиар хорогдсон бол бут сөөгийн талбай 409,300 га, таримал ойн талбай 2,050 га-гаар тус тус нэмэгджээ (Хүснэгт 13.4).

Ойн судалгаа, хөгжлийн төвийн ойн татварын бүртгэлийн мэдээнээс үзвэл 2011-2016 онд ойн бүрхэвчтэй талбай дахин 272900 га-гаар хорогджээ. Ойн бүрхэвчтэй талбай хорогдсоны сацуу ойн түймэр, хөнөөлт шавьжинд өртсөн ойн бүрхэвчгүй, доройтсон ойн талбай нэмэгдсэнийг ойн татварын бүртгэлийн мэдээ харуулж байна. Ойн талбай 1999-2011 онд хорогдож, харин ойн түймэрт өртсөн ойн талбай 768500 га-гаар, мод бэлтгэсэн ойн талбай 96900 га-гаар, хөнөөлт шавьшинд өртсөн талбай 95600 га-гаар нэмэгдсэн байна. 1999-2016 онд ойн нийт талбайд бут сөөгийн эзлэх талбай 368300 га буюу 87.08 хувиар өсчээ. Бут сөөгийн эрчимтэй тархац нь ойн цэвдэг хайлж, өнгөн хөрсний чийгшилт нэмэгдсэнтэй холбоотой. Ялангуяа агаарын температурын өндрийн өөрчлөлтийн инверс (урвуу хамаарал) ажиглагддаг нарийн хөндийд бут сөөгийн тархац эрчимтэй явагдаж байна.

#### Хүснэгт 13.4: Ойн талбайн өөрчлөлт, 1999, 2011, 2014, 2016 он, мянган га

Талбайн төрөл	1999	2011	2014	2016	1999-2011 оны өөрчлөлт (%)
Ойн бүрхэвчтэй талбай, үүнээс:	13,086.00	12,552.90	12,174.80	12,280.00	-4.07
Байгалийн ой	12,670.30	11,726.00	11,388.00	11,500.42	-7.45
Бут, сөөг	415.60	824.90	784.70	777.49	98.48
Таримал ой	0.05	2.10	2.10	2.10	4,100.00
Нөөц доройтсон ойн талбай, үүнээс:	3,951.30	5,124.70	5,603.00	5,631.08	29.70
Ил энгэр	2,900.40	3,476.70	3,469.30	3,495.34	19.87
Шатсан	417.80	1,186.30	1,713.90	1,708.27	183.94
Ойг огтолсон	193.70	124.10	108.60	106.12	-35.93

Ойжуулах талбай	438.80	221.30	163.70	173.96	-49.57
Нөхөн сэргээсэн	0.50	9.20	10.80	10.70	1,740.00
Хөнөөлт шавьжинд өртсөн	-	95.70	135.70	135.78	
Салхинд сүйтсэн	-	0.90	0.90	0.89	

Эх сурвалж: ГТХАН, 2011 он, Монголын хойд тайгын ойн мониторинг, “Монголын уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний 2 дахь илтгэл-2014”, 2014 он. БОАЖЯ-ны 2016 оны мэдээ мэдээлэл.

#### *Хүлэмжийн хийг бууруулах арга хэмжээ*

2015 оны Үндэсний зорилтот хувь нэмэр (ҮЗХН- INDC) баримт бичигт Монгол Улс нь эрчим хүч, аж үйлдвэр, ХАА, хог хаягдлын салбарт 2030 он хүртэл хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлжээ. ҮЗХН баримт бичигт ойн салбарын хүлэмжийн хийг бууруулах арга хэмжээг тусгаагүй байна. Бодлого, арга хэмжээг хэрэгжүүлсэнээр Газар, газар ашиглалт, ой (ГАӨО)-н салбарыг тооцоогүй байдлаар 2030 он гэхэд улсын хэмжээний хүлэмжийн хийн нийт ялгаруулалтыг 14 хувиар бууруулах зорилт дэвшүүлсэн байна.

Төрөөс ойн талаар баримтлах 2015 оны бодлогод ойн салбарын ХХ-ийг бууруулах үйл ажиллагаа, тухайлбал ой устах, ойн доройтлоос үүдэлтэй ХХ-ийн ялгаруулалтыг 2020 он гэхэд 2 хувиар, 2030 он гэхэд 5 хувиар бууруулах зорилгыг дэвшүүлсэн байдаг.

#### *Дасан зохицох арга хэмжээ*

Монголын агаарын дундаж температур 1940-2014 оны хооронд 2.07 цельсийн хэмээр нэмэгдсэн байна. Сүүлийн 70 жилд тохиолдсон хамгийн дулаан 10 жил нь 1997 оноос хойших хугацаанд тохиосон байна. Ойн салбарт дулаарлын үзүүлсэн гол нөлөөлөл нь ойн болон хээрийн түймрийн давтамж өссөн, хөнөөлт шавьж мэргэчийн дэгдэлт, цар хүрээ өргөжсөнөөр илэрч байна. Үүний улмаас ойн талбай жилд 0.46 хувиар хорогдож, ойн нөөц үлэмж багасчээ.

Монгол улсын ҮЗХН-т ойжуулах, ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх, ард иргэдэд суурилсан ойн менежментэд дэмжлэг үзүүлэх замаар ойн доройтлыг бууруулах, дасан зохицоход чиглэсэн арга хэмжээг тодорхойлсон байна.

Ойжуулах, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй ойн доройтлыг бууруулах, ойн зохион байгуулалт, бүтцийг сайжруулах, үйлдвэрлэлийн нөөцийг нэмэгдүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтөд ойн дасан зохицох чадварыг сайжруулж, ойн сангийн газрыг 2030 он гэхэд улсын нийт нутаг дэвсгэрийн 9 хувьд хүргэх зорилгыг ҮЗХН-т дэвшүүлсэн байна. Мөн ийм зорилтыг Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-д тусгасан байдаг. Нөхөн сэргээсэн ойн талбай 2000-2016 онд жилд дунджаар 7429 га-гаар нэмэгдэж, өнөөгийн байдлаар ойн бүрхэвчтэй талбай 12,280,042 га буюу нийт нутаг дэвсгэрийн 7,85 хувийг эзлэх болжээ. 2030 он гэхэд ойн нийт талбайг 9 хувьд хүргэх зорилгоо хэрэгжүүлсэн тохиолдолд ой 14,071,950 га талбайг эзлэх болно. Энэхүү ихээхэн давуу зорилгыг биелүүлэхийн тулд 2017-2030 оны 14 жилийн хугацаанд нийт 1,791,908 га, жилд 128,000 га талбайг ойжуулах шаардлагатай болно. Ойжуулах, нөхөн сэргээх үйл ажиллагаа нь ойн сангийн газрыг өсгөх цорын ганц хэлбэр бус, байгалийн нөхөн сэргээлтийг дэмжих бусад аргыг мөн хэрэгжүүлэх шаардлагатай. Гэвч ойн бүрхэвчтэй талбайг жилд 128,000 га-гаар өсгөх зорилго нь бодитой бус байж болох юм.

### **13.6 Хууль эрх зүй, бодлого, бүтэц зохион байгуулалтын тогтолцоо**

#### *Хууль эрх зүйн тогтолцоо*

Ойн тухай 1995 оны хууль Монгол орны ойг хамгаалах, ойн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үндсийг бүрдүүлдэг. Ойн бүх нөөц төрийн эзэмшилд байх бөгөөд төрөөс аймаг, сум, нийслэл хотын захиргаанд ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх эрхийг олгож болно. Иргэний төлөөлөгчдийн хурлууд нь иргэд, ААН, эдийн засгийн байгууллагуудад ойн нөөц болон ОДББ-ыг тодорхой хугацаанд гэрээ, зөвшөөрлийг үндэслэн ашиглах эрх олгож байна.

Ойн тухай 1995 оны хуулинд 2007 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр ойн менежментийн төвлөрсөн

удирдлагыг өөрчилж, аймаг, сумын засаг даргад орон нутгийн түвшинд ойн менежментийг хариуцуулсан байна. Орон нутгийн засаг захиргааны ачааллыг цаашид хөнгөвчлөх зорилгоор хуулиар ойн менежментийг олон нийт, хувийн хэвшлийнхэнд шилжүүлэх, ойн санг хувийн ААН, ОН-үүдэд гэрээгээр эзэмшүүлэх эрхээр хангасан. Ойн менежментийг ойн нөхөрлөлүүдэд шилжүүлснээр хууль бус мод бэлтгэлийг багасгах, ойн менежментийн албан ёсны төлөвлөгөө хэрэгжүүлж, зохицуулалтыг боловсронгуй болгох замаар ойн сангийн олон талбайн ерөнхий чанарыг сайжруулахаар төлөвлөжээ. Ойн цэвэрлэгээ, арчилгаа зэрэг ойн менежментийн үйл ажиллагааг системтэй хэрэгжүүлэх нь мод бэлтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх, ойн түймэр болон шавьжны хөнөөлийг бууруулахад зохих хувь нэмэр оруулна хэмээн үзэж байна.

Байгаль орчны хууль тогтоомжийг цогцоор нь шинэчлэх үйл ажиллагааны хүрээнд Ойн тухай хуулийг 2012 онд шинэчилжсэн нь (Бүлэг 1) бусад хуулиудтай зөрчилдөж байсан зүйл, заалтууд, давхардлыг арилгахад хувь нэмэр оруулсан байна. Мөн 2012 онд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд 1995 оны Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэсний төлбөрийн тухай болон янз бүрийн төлбөрийг зохицуулдаг бусад хэд хэдэн хуулийг нэгтгэжээ.

Энэхүү хуулиар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн нөөц ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг улсын төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулсан байна. Хуулиар бүх төрлийн мод болон түлээ бэлтгэх, ОДББ-н ашиглахад төлбөр төлөх, төлбөрийн хуримтлалын 85 хувийг байгаль орчныг хадгалах хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд ашиглахаар тусгасан байна (Хүснэгт 13.5).

#### **Хүснэгт 13.5: Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд зарцуулах төлбөрийн хувь хэмжээ, хувиар**

<b>Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого</b>	<b>%</b>
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	30
Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	50
Газрын нөөцийн төлбөрийн орлого	30
Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	85
Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	35

*Эх сурвалж:* Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012 он.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай 1994 оны хуулиар тусгай хамгаалалттай газар дахь ойтой холбоотой үйл ажиллагааг зохицуулж байна. Жишээ нь онцгой хамгаалалттай бүсэд зөвхөн ойн арчилгааны ажлыг хязгаарлагдмал талбайд хийхийг зөвшөөрдөг. Байгаль орчныг хамгаалах тухай 1995 оны хуулийг 2005 онд шинэчилж, хууль тогтоомжид заасан журмын дагуу иргэн, түүнчлэн ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн газартаа өөрийн хөрөнгөөр зориудаар тарьж ургуулсан ой модыг өмчилж болох заалтыг оруулсан байна.

Засгийн газрын 2009 оны 227 дугаар тогтоолоор ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх замаар ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, зохистой ашиглах ажлын үр өгөөжийг дээшлүүлэх, мөн тогтоолын хавсралтаар өмчлөх хүсэлт гаргах журам, гэрээ, өмчлөх ойн сангийн хэмжээг тогтоож өгчээ.

#### *Бодлогын тогтолцоо*

#### Ой, ойн бодлогын баримт бичиг

Монгол Улсад ойн салбарын урт хугацааны бодлого боловсруулах анхны оролдлогыг 1950-иад онд хийж, бодлого нь ойн бүтээгдэхүүний асуудалд төвлөрч байжээ. “Монголын ойн сангийн ашиглалтын удирдлагын ерөнхий чиглэл”-ийг ЗХУ-ын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар 1975 онд боловсруулж, эл баримт бичиг 1990 он хүртэл үйлчилж байжээ. Засгийн газрын бодлого нь 1950-1990 оны үед дотоодын хэрэгцээг хангахад ойн нөөцийг ашиглах, ЗХУ-д мод экспортлоход чиглэгдэж, бодлогын хүрээнд төрийн ойн ААН, ойн ажилчдын суурин, тосгодыг байгуулсан байна. Мод бэлтгэлийн хэмжээ, бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах, тосгон суурин байгуулахыг төрийн хатуу төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлдэг байв.

Гэвч төрийн 1950-1990 оны бодлогод ойн санг хадгалах, ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд бага, эсвэл огт анхаарал хандуулаагүй, ойн аж үйлдвэр нь технологи, аж үйлдвэрийн хэрэглээ, химийн бодисын хувьд экспортоос бүрэн хамааралтай, үндсэндээ төрийн санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулдаг байжээ. Мод бэлтгэлд ашиглаж байсан технологи, техник хэрэгслийн хангамж тогтмолжоогүй, ойг хавтгайруулан огтолж, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй нь ойн доройтлын үндсэн шалтгаан болсон байна.

Харин 1990-ээд он нь байгаль орчны хөгжилд үзүүлэх нөлөөллийг олон улсын хамтын нийгэмлэг ухамсарлаж эхэлсэн үе байв. Байгаль орчин, хөгжлийн асуудлаарх 1992 оны Риогийн бага хурлын дараа Монгол Улсын Засгийн газар Төрөөс экологийн талаар баримтлах бодлогыг (УИХ-ын 1997 оны 106 дугаар тогтоол) 1997 онд боловсруулсан нь ойн асуудалд ихээхэн нөлөөлжээ. Байгаль экологид нийцсэн хөгжлийг тодорхойлох зорилгоор Ойн үндэсний бодлогыг (ЗГ-ын 1998 оны 122 дугаар тогтоол) 1998 онд баталсан байна. Бодлогын үндсэн 7 зорилгын 3 нь ойн ашиглалт, олборлолт, 3 нь ойн хадгалалт хамгаалал, 1 нь нийгмийн халамжийн асуудалд чиглэгдэж байв. Ойн хамгаалал нь төр засгийн бодлогод илүү анхаарал татсан асуудал болжээ.

Ойн 1998 оны үндэсний бодлогыг 2001 онд шинэчлэн Ойн тухай үндэсний хөтөлбөрийг баталсан (ЗГ-ын 2001 оны 248 дугаар тогтоол) нь төрийн бодлого ойн ашиглалтаас илүү хамгаалах чиглэлд хандаж байгаагийн илрэл болов. Бодлогод ойн нөөцийн менежмент, ойн түймэр, хөнөөлт шавьжны хөнөөлөөс хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах, байгууллагуудын бүтцийг боловсронгуй болгох, мод бэлтгэл, боловсруулалтын чанарыг дээшлүүлэхэд түлхүү анхаарсан байна. Ойн сангийн доройтлыг бууруулах арга хэмжээний хүрээнд тусгай хамгаалалттай ойн талбайг нэмэгдүүлэх, жилийн мод бэлтгэлийн хэмжээг багасгахаар төлөвлөжээ. Энэ багц арга хэмжээ нь асуудлыг техникийн аргаар шийдвэрлэхэд чиглэгдэж, бүтэц зохион байгуулалт болон нийгмийн асуудалд бага анхаарал хандуулжээ.

Төрөөс 2030 он хүртэлх хугацаанд ойн талаар баримтлах шинэ бодлогыг 2015 оны 5 дугаар сард УИХ баталжээ (УИХ-ын 2015 оны 49 дүгээр тогтоол). Шинэ бодлогод улсын нийгэм-эдийн засгийн болон байгаль орчны асуудлыг ногоон хөгжлийн үндэсний бодлоготой нийцүүлэх, уялдуулах цогц хандлагыг баримтлан, ойн сангийн нөөцийн ашиглалт, хадгалалт болон нөхөн сэргээлтийн асуудлаар шийдвэр гаргах чиглэлийг тодорхойлсон байна. Ерөнхий зарчим, зорилт, зорилгын хувьд 2015 оны бодлого нь ойн сангийн нөөцийн тогтвортой ашиглалт, хадгалалт, нөхөн сэргээлтийн талаарх өмнөх бодлогын баримт бичгүүдийн чиглэлтэй нийцэж байна. Уг бодлогод тодорхойлсон 8 зорилгын 4 нь ойн сангийн хамгаалалт, бусад нь ойн сангийн засаглал, удирдлага, ойн тогтвортой менежмент, ашиглалт, ойн түймэр, хортон шавьж, өвчнөөс сэргийлэх чадавхийг бэхжүүлэх, “ойн нөөцийг ашиглагч, өмчлөгч нар нь ойн сангийн хамгаалал, тогтвортой менежмент”-ийг хариуцах зарчмыг нэвтрүүлэх асуудлыг тусгажээ.

Төрөөс 2030 он хүртэлх хугацаанд ойн талаар баримтлах шинэ бодлогод ойн сангийн менежментэд олон оролцогч талыг хамруулах, ойн сангийн сайн засаглалыг бий болгох, шинжлэх ухаан, баримтад суурилсан ойн менежментийг дэмжих зарчмыг илүү хүчтэй болгожээ. Бодлого, зорилгыг хэрэгжүүлэх явцад зарим шинэлэг хандлага гарсан байна. Тухайлбал бодлогод төрөөс мод бэлтгэхээр олгох зөвшөөрлийн тоог багасган, харин мод орлох бүтээгдэхүүнийг түлхүү ашиглахыг дэмжихийг илэрхийлсэн. Үүгээр үл барам аж үйлдвэрийн модны хэрэгцээг импортын эх үүсвэрээс хангах стратеги баримтлах, иргэдийн модны дотоод хэрэгцээг ойн сангийн цэвэрлэгээ, арчилгаа, сонгомол тарилтаас гарсан модоор хангахаар бодлогод тусгажээ.

Төрөөс 2030 он хүртэлх хугацаанд ойн талаар баримтлах бодлогод ХАА, ойн цогцолбор байгуулах, ойн сангийн дэд бүтцийг өргөжүүлэх, түргэн ургадаг зүйл төрлөөр ойг тарималжуулах, био болон шахмал түлш үйлдвэрлэх, 2020 он гэхэд олон улсын стандартад нийцсэн ойн мэргэжлийн байгууллагуудын үндэсний стандартыг боловсруулах, экологийн тогтолцооны үйлчилгээний төлбөрийн системийг баталгаажуулах үйл ажиллагааг онцолсон байна.

Төрөөс 2030 он хүртэлх хугацаанд ойн талаар баримтлах бодлогыг баталсантай холбогдуулан Засгийн газар 2016-2020 онд бодлогын зорилгыг хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг 2016 онд баталжээ. Бодлогыг хоёр үе шаттай хэрэгжүүлэх бөгөөд 2020 он гэхэд ойгоор бүрхэгдсэн талбайг 8.3 хувь, 2030 он гэхэд 9 хувьд хүргэх зорилгыг дэвшүүлжээ.



Ойн сантай холбоотой бодлогын бусад баримт бичиг

Засгийн газар Ногоон хүрэм үндэсний хөтөлбөрийг 2005 онд батлан (ЗГ-ын 2005 оны 44 дүгээр тогтоол) ба түүнийг өнөөг хүртэл хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн гол зорилго нь улсын өмнөд хэсгийн говь, хээрийн бүсийн цөлжилт, элсний нүүдлийг сааруулахын тулд ногоон бүс, ойн зурвас байгуулахад орших ба хөтөлбөрийг гурван үе шаттай, 1 дүгээр шатыг 2005-2015, 2 дугаар шатыг 2016-2025, 3 дугаар шатыг 2025-2035 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байдаг. Засгийн газар 1 дүгээр үе шатны хэрэгжилтэд үнэлгээ хийжээ. Яам болон орон нутгийн захиргаа хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төсөв санхүүгийн дэмжлэг үзүүлж ирсэн байна. Ногоон хүрэм хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор яаманд байгуулсан нэгжийг төсвийн хүндрэлээс шалтгаалан 2012 онд татан буулгасан бөгөөд өнөөгийн байдлаар энэ үүргийг яамны Ойн бодлого зохицуулалтын газар хариуцаж байна. Тарьсан модны бодит бойжилт нь арчилгаа хангалтгүй, хот суурингаас алслагдсан учир арчилгаа услалтыг тогтмол хийх боломжгүйн улмаас маш доогуур байна. Дараагийн шатанд тарьсан талбайн дагуу ХАА, ойн цогцолбор салбарыг хөгжүүлэх, ойн зурвасыг суурингуудыг ногооруулах хүчин чармайлттай уялдуулах боломжийг судлах бодлогыг Засгийн газар баримталж байна.

Ой цэвэрлэх 2014 оны үндэсний хөтөлбөрийн (ЗГ-ын 2014 оны 30 дугаар тогтоол) зорилго нь айл өрхийн ахуйн мод, түлээний хэрэгцээний зарим хэсгийг ойн цэвэрлэгээний ажлаас гаргахад оршиж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд ойг цэвэрлэх, унанги, үхмэл болон түймэр, шавьжинд өртсөн модыг устгах, ойг сийрэгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Энэ үйл ажиллагаа нь ойг түймэр, шавьжинд өртөхөөс хамгаалахад дэмжлэг үзүүлнэ хэмээн үзэж байна. Үндэсний хөтөлбөрт ойн цэвэрлэгээ, ойг сийрэгжүүлэх үйл ажиллагаанаас олсон нөөцийг үр ашигтай ашиглах бодлогыг тусгаагүй байна.

Ногоон эдийн засаг, Тогтвортой хөгжлийн үндэсний бодлогын баримт бичигт ойн сангийн асуудлыг тусгасан байдал

Ногоон хөгжлийн 2014 оны бодлогод ойн сантай холбоотой дараах зорилгыг тусгажээ:

- Ойг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлж нүүрстөрөгчийг шингээх ойн чадавхийг нэмэгдүүлэх, 2030 он гэхэд ойгоор бүрхэгдсэн талбайг улсын нийт нутаг дэвсгэрийн 9 хувьд хүргэх;
- Ойн сан, ойн дагалт баялаг, ан амьтан болон ургамлын нөөцийг хамгаалах, үр ашигтай ашиглах дэвшилтэт, ард иргэдэд суурилсан байгалийн нөөцийн менежментийг нэвтрүүлэх, санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх.

Ногоон хөгжлийн бодлогыг 2016-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2016 онд батлан, түүнд бодлогын зорилгуудыг биелүүлэх тодорхой арга хэмжээ, тухайлбал ойн инвентори тооллого хийх, ойжуулах болон ойн нөхөн сэргээх арга хэмжээг эрчимжүүлэх, мод үржүүлгийн өндөр бүтээмжтэй газруудыг байгуулах, айл өрхийн ахуйн хэрэглээ, барилга, зам, хашаанд мод ашиглахыг багасгах, ард иргэдэд суурилсан байгалийн нөөцийн менежментийн эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох зэргийг тусгажээ.

Монгол Улсын 2016 оны Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 баримт бичигт ойгоор бүрхэгдсэн талбайг 2020 он гэхэд улсын нийт нутаг дэвсгэрийн 8.5 хувь, 2025 он гэхэд 8.7 хувь, 2030 он гэхэд 9.0 хувьд хүргэх зорилгыг тодотгосон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт дараах 4 жилд ойн менежментийн талаар баримтлах бодлого, үйл ажиллагааг тодорхойлж өгсөн байна. Бодлогын 5 тулгуурын нэг болох Байгаль орчин, Ногоон хөгжлийн бодлогод ойн сан, ойн дагалт баялгийг тогтвортой ашиглах, экологид ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ойн нөхөн сэргээлт, ойн менежментийг боловсронгуй болгох, иргэд, ойн нөхөрлөл, ААН, байгууллагуудад ойжуулах арга хэмжээ хэрэгжүүлсний санхүүгийн урамшуулал олгох зэрэг ойн менежментийн гол чиглэлүүдийг тусгасан байна.

*Энэхүү бүлэгтэй холбоотой Тогтвортой хөгжлийн зорилт, зорилгууд*

ТХЗ 2030 хөтөлбөрийн Зорилт 15.2, 15.6 хэрэгжилтийн явцыг Шигтгээ 13.2-т харуулав.





**Шигтгээ 13.2: Тогтвортой хөгжлийн 2030  
он хүртэлх хөтөлбөр: Зорилт 15.2 болон 15.b**

**Зорилго 15. Хуурай газрын экологийн системийг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах, ойн нөөцийн тогтвортой байдлыг хангах, цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах, биологийн олон янз байдлыг мөхөж устахаас сэргийлэх.**

**Зорилт 15.2: 2020 он гэхэд бүх төрлийн ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх, ой устгахыг зогсоох, доройтсон ойг нөхөн сэргээх, дэлхий дахинд ойжуулах, ойг нөхөн сэргээх үйл ажиллагааг үлэмж нэмэгдүүлэх.**

Төрөөс ойн сангийн талаар баримтлах 2015 оны бодлогод ойн тогтвортой менежментийн 7 үндсэн сэдэвчилсэн чиглэлтэй нийцүүлэн бодлогын гол зарчмыг тодорхойлсон байна. Үүнд ойн сангий нөөцийг нэмэгдүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, ойн сангийн амьдрах чадвар, эрүүл байдлыг сайжруулах, үйлдвэрлэлийн нөөцийг нэмэгдүүлэх, ойн сангийн нөөцийн экологийн болон нийгэм, эдийн засгийн үүрэг ач холбогдлыг нэмэгдүүлэх, эрх зүй, бодлого, бүтэц зохион байгуулалтын тогтолцоог сайжруулах, “ойн сангийн сайн засаглал”-ыг бүрдүүлэх, ойн нөөцийн баримтад суурилсан, тогтвортой ашиглалтыг хангах, ойн түймэр, хортон шавьжны хөнөөлөөс сэргийлэх, мониторингийн чадавхийг бэхжүүлэх, “ашиглагчид нь ойн сангийн хадгалалтыг хариуцах” зарчмын нэвтрүүлэх чиглэлийг онцолсон байна.

Монгол Улс нь ойгоор бүрхэгдсэн талбайн өнөөгийн эзлэх 7.85 хувийг 2020 он гэхэд улсын нийт нутаг дэвсгэрийн 8.3 хувь, 2030 он гэхэд 9.0 хувьд хүргэх зоримог зорилтыг дэвшүүлсэн байна. Энэхүү зорилтыг ойн тогтвортой менежментийг нэвтрүүлэх, тухайлбал ойжуулах, ойг нөхөн сэргээх арга хэмжээг өргөжүүлэх замаар хэрэгжүүлнэ. Засгийн газраас ойжуулах, ойг нөхөн сэргээх арга хэмжээнд тэргүүлэх ач холбогдол өгч байгаа. 1980-2016 онд нийт 194.400 га талбайг ойжуулжээ.

Цөлжилт болон элсний нүүдлийг сааруулах зорилгоор говийн бүсэд ойн зурвас байгуулах үндэсний “Ногоон хүрэм” хөтөлбөрийг Засгийн газраас хэрэгжүүлж байгаа нь ойжуулах үйл ажиллагааны нэг хэсэг юм.

Засгийн газар олон улсын стандарттай нийцүүлэн ойн мэргэжлийн байгууллагуудад гэрчилгээ олгох үндэсний стандартыг 2020 он гэхэд боловсруулах зорилго тавьсан ба энэ стандартыг мөрдсөнөөр зөвхөн гэрчилгээ бүхий компани, байгууллагууд ойн нөөцийг ашиглах эрхтэй болно. Ойн тогтвортой менежментийн зөвлөлөөс ойн мэргэжлийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх сургалт зохион байгуулж, сургалтыг амжилттай дүүргэсэн байгууллагад улсын гэрчилгээ олгодог. Ойн тогтвортой менежментийн зөвлөл нь Ойн гэрчилгээг батламжлах хөтөлбөртэй (ОГБХ) нягт хамтран ажиллаж, хөтөлбөрийн хараат бус гуравдагч этгээдийн шаардлагыг хангахыг эрмэлзэж байна.

ТХЗ Зорилт 15.2-ын биелэлтийг дэлхийд хүлээн зөвшөөрсөн 15.2.1 шалгуур үзүүлэлт, ойн тогтвортой менежментийг боловсронгуй болгох явцыг дүгнэх зорилгоор Монгол Улс ойн тогтвортой менежментийн шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах шаардлагатай байна. 2014-2016 онд хийсэн Олон зорилтот үндэсний ойн тооллогын дүн, сургамж нь ойн тогтвортой менежментийн ирээдүйн бодлогын чиглэлийг тодорхойлох суурь болсон. Мөн ойн тогтвортой менежментийн гэрчилгээ олгох үндэсний системийг улам боловсронгуй болгож, олон улсын системтэй нийцүүлэх нь Монголын нөхцөл, ялангуяа ойн нөхөрлөлийн үйл ажиллагаанд эерэг нөлөөтэй.

**Зорилт 15.в. Ойн тогтвортой менежментийг санхүүжүүлэх, хөгжиж байгаа орнуудад ой хамгаалах болон ойжуулах ажлын дэвшилтэт менежмент нэвтрүүлэхэд чиглэсэн зохистой санал санаачлагаар хангахын тулд бүхий л эх үүсвэрээс хангалттай санхүүжилт босгох**

Шалгуур үзүүлэлт 15.b.1 нь биологийн олон янз байдал, экосистемийг хамгаалахад албан ёсны хөгжлийн тусламж болон улсын санхүүжилтийг зарцуулах тухай үзүүлэлт юм.

Жил тутам БОАЖЯ нь ойжуулах, ойг нөхөн сэргээх ажлын төсөв, төлөвлөгөөг баталдаг. Ойн менежментийн үйл ажиллагаанд 2015 онд нийт 5.656 тэрбум төгрөг төсөвлөсөн бол 2016 онд төсөв 2.828 тэрбум болтол буурсан нь улсын санхүүгийн хямрал, улсын дотоод нөхцөл байдалтай холбоотой. Ойжуулах, ойг нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулсан төсвийг хүснэгт 13.6-д харуулав.

Өнгөрсөн 10 жилд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого тууштай өссөн ба түүнийг байгаль орчны хамгаалал, байгалийн нөөцийн менежментийг санхүүжүүлэхэд зарцуулах ёстой. Гэвч БОАЖЯ-ны байгаль орчны санхүү, зардал сүүлийн жилүүдэд ихээхэн буурсан байна.

Хүснэгт 13.6: Ойжуулах, ойг нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулсан улсын төсөв, 2015-2016 он, тэрбум төгрөг

Үйл ажиллагаа	2015	2016
Нөхөн сэргээх	0.626	0.330 (440 га ойд )
Ойжуулах	0.200	0.100 (50 га ойд )
Тарьц үйлдвэрлэх	0.085	0.053
Ойн менежментийн төлөвлөгөө	0.302	0.218
Ойн түймрээс сэргийлэх	0.221	0.130
Шавьжнаас сэргийлэх	3.076	0.420
ОН-ийн чадавхийг бэхжүүлэх	0.08	0.220
Ойн арчилгаа, хууль бус мод бэлтгэлтэй	0.508	0.544
Бусад	3.634	0.813
<b>Нийт</b>	<b>5.656</b>	<b>2.828</b>

Эх сурвалж: БОАЖЯ, 2017 он

Засгийн газраас ойн сантай холбоотой үйл ажиллагааны санхүүжилтийг өсгөх арга хэмжээ авбал зохино. Ойн салбар нь албан бус ажлын байр бий болгох, ойн дагалт баялгаас орлого олох зэрэг олон хэлбэрээр орон нутгийн иргэдийн амьжиргаанд хувь нэмэр оруулдаг. Мөн орлогын эх үүсвэр болохын зэрэгцээ Монголын ойн сан нь усны урсацыг зохицуулах, хөрсийг тогтворжуулах, хөрсний үр шимийг хадгалах, уур амьсгалыг зөөлрүүлэх зэргээр ХАА-н салбарт ээргээр нөлөөлөх экосистемийн үйлчилгээ үзүүлдэг. Иймд ойн хамгаалал, менежментийн санхүүжилтийг зөвхөн ойн салбарт оруулж буй хөрөнгө оруулалт бус, улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулж буй чухал хувь нэмэр хэмээн өргөн утгаар ойлгох хэрэгтэй.

### *Бүтэц зохион байгуулалтын тогтолцоо*

#### Ой, ойн менежментийн асуудал хариуцсан улсын байгуулагууд

Ойн нөөцийн менежмент, ойн сантай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, жил тутмын мод бэлтгэлийн хэмжээг тооцох, мод бэлтгэлийн талбайг тогтоох, мод боловсруулах үйлдвэрлэлд хяналт мониторинг хийх, ойжуулах, ойг нөхөн сэргээх үйл ажиллагааг төлөвлөх үүрэг бүхий Ой, модны аж үйлдвэрийн яамыг 1972 онд байгуулсан байна. Модны аж үйлдвэрийн салбар 20,000 гаруй ажилтантай, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 18 хувь, ДНБ-ний 6 хувийг бүрдүүлж байсны хувьд ойн асуудлыг хариуцсан яам байгуулсан нь Засгийн газрын хариуцлагатай шийдвэр болсон байдаг. Бүх аймаг, нийслэл хотод ой хариуцсан, ангийн нэгж бүхий албад байсан ба мод бэлтгэл, боловсруулах үйлдвэрүүдийг шинэ яаманд харьяалуулсан. 1970 оноос ойн салбарт мэргэжлийн ойн мэргэжилтэн, инженерүүд ажиллаж эхэлжээ. 1987 онд ойн салбарт үндсэн өөрчлөлт хийж, засгийн газрын бүтцийн шинэчлэлээр мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэлийг Аж үйлдвэрийн яаманд, хожим нь 1992 онд Худалдааны яаманд шилжүүлсэн. Үүний зэрэгцээ ойг хамгаалах, нөхөн сэргээх, ойн нөөцийн менежментийн үүргийг 1987 онд байгуулсан Байгаль орчныг хамгаалах яамны Ойн хэлтэст шилжүүлсэн байна. 1990 онд яамыг бусад агентлагтай нэгтгэн Байгаль орчны хяналтын улсын хороо, 1992 онд хороог Байгаль орчны яам болгон шинэчилсэн. Ойн сантай холбоотой менежмент, захиргааны асуудлыг 2004 он хүртэл тус яамны ойн хэлтэс дангаар нь, зарим үед байгалийн бусад нөөцийг хамруулан хариуцаж байв.

Ойн хэлтсийг 2004 онд Байгаль орчин, ой, усны нөөцийн агентлаг болгон, ойн сангийн хадгалалтын бодлогын хэрэгжилт, нөхөн сэргээх, ойжуулах үйл ажиллагаа, ойн дагалт баялгийн ашиглалт зэрэг үүргийг хариуцуулсан байна. Энэхүү өөрчлөлт нь улс орны хөгжилд ойн сангийн асуудалд тэргүүлэх ач холбогдол өгөх Засгийн газрын чухал алхам болсон байна. Гэвч төсвийн хомсдлоос шалтгаалан агентлагийг 2010 онд татан буулгаж, ойн сангийн асуудлыг яамны бүтцэд дахин хамааруулжээ. Ойн бодлого зохицуулалтын газар нь 2017 оны байдлаар БОАЖЯ-ны бүтцийн есөн газрын нэг болон ажиллаж байна (Зураг 1.2).

Ойн бодлого зохицуулалтын газар нь ойн сангийн бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтийн ажлыг зохицуулах, техник, арга зүйн удирдамж, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, ойн сангийн менежментийг сайжруулах санал боловсруулах үндсэн үүрэгтэй байна. Түүнчлэн тус газар нь ойн тооллого, судалгааны ажлыг зохицуулах, ойжуулах, нөхөн сэргээх, хөнөөлт шавьж болон мэрэгчийн хяналт, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх, ойн арчилгаа, ойн тогтвортой менежмент, ойн бүтээгдэхүүн, “ойн засаглал”-ыг бэхжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

БОАЖЯ-ны шууд удирдлаган дор ажилладаг Ойн судалгаа, хөгжлийн төв УТҮГ нь ойн бүртгэл, судалгааг хариуцдаг.

Орон нутгийн түвшинд ойн нөөцийг хариуцдаг хэд хэдэн байгууллага байна. Ойн нөөцийн тооллогын дүнд үндэслэн жилийн мод бэлтгэлийн хэмжээг БОАЖЯ тогтоодог боловч мод бэлтгэлийн зөвшөөрлийг аймаг, сумын засаг дарга олгож байна.

#### *Бусад холбогдох байгууллагууд*

Ойн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг 1987-1990 онд Ойн хэлтэс, 1991-1996 онд Ой, ургамлын нөөцийн агентлаг, 1997-2003 онд Байгаль орчныг хамгаалах агентлагийн Ойн товчоо, Байгаль орчны яамны Байгалийн нөөцийн газар хариуцаж байсан ба 2003 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг (МХЕГ) байгуулснаар байгаль орчны болон ойн сангийн тухай хуулиудыг мөрдүүлэх асуудал энэхүү шинэ агентлагт шилжсэн байна (Бүлэг 2). МХЕГ-ын байгаль орчны байцаагчид бүх аймагт ажилладаг ба харин сумын түвшинд байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийг сумын засаг даргын томилсон байгаль орчны байцаагч, ой хамгаалагчид хариуцдаг.

Ойн түймэр гарсан тохиолдолд Онцгой байдлын ерөнхий газар өөрийн нөөцийг дайчлан ажилладаг. Улсын хэмжээнд онцгой байдлын нийт 3200 албан хаагч (аврагч, гал сөнөөгч) орон нутгийн онцгой байдлын газруудад ажиллаж байгаа ба тэднийг ойн түймэр унтрахад дайчилдаг байна.

*Ойн сангийн менежмент хариуцсан улсын хэмжээний болон орон нутгийн байгууллагууд хоорондын ажлын уялдаа*

Засгийн газрын олон түвшний байгууллагууд, тэдгээрийн ойтой холбоотой үүрэг хариуцлагыг Хүснэгт 13.7-д харуулав. БОАЖЯ нь аймгийн захиргааны нэгж болох байгаль орчин, аялал жуулчлалын хэлтсүүдийг техникийн болон арга зүйн удирдамжаар хангадаг бөгөөд аймгийн түвшний ойн нэгжүүдийн үйл ажиллагааны зардлыг аймгийн Засаг даргын байгаль орчны сангаас гаргадаг. Байгаль орчны санг байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдүүлдэг байна. 2000 оны Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хууль, Байгалийн нөөцийг нөхөн сэргээх тухай хууль (хүчин төгөлдөр бус), 2012 онд шинэчилсэн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.1 дэх хэсэгт заасан төлбөрийн орлогын хэсгийг (байгалийн ургамал, ус, рашаан, ой, амьтны нөөц, тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах) бүрдүүлэх, төсвийн зарлагад байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд төлөвлөх, зарцуулах, тайлагнах, хянах журмыг баталсан Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын дагуу олсон төсвийн орлогыг байгаль орчны хамгаалал, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд зарцуулдаг байна.

Жил тутам зарцуулах хувь хэмжээг хуулиар тогтооно. Мод, түлээ бэлтгэлийн төлбөрийн орлого нь байгаль орчныг хамгаалах нийт орлогын дийлэнх хувийг эзэлдэг (Хүснэгт 13.5).

Ойн үйлдвэрлэлийг (мод бэлтгэлийн технологийн асуудлыг оролцуулан) ХХААХҮЯ хариуцаж байна.


## Хүснэгт 13.7: Ойн менежментийн байгууллагуудын тогтолцоо

Түвшин	Засгийн газрын байгууллагууд	Үүрэг хариуцлага
Үндэсний	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Ойн нөөцийн менежментийг стратегийн чиглэл, бодлого, зарчмын удирдлагаар хангах, хууль тогтоомжийг боловсруулах, Аймгийн саналд үндэслэн жилийн мод бэлтгэлийн дээд хязгаарыг тогтоох, Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын хэлтэст ойн санг нөхөн сэргээх, үр болон тарьц бэлтгэх, ойн судалгаа, ойн түймэр болон шавьжны хяналт, хууль бус мод бэлтгэлийн хяналт, ойн нөхөрлөл, сум дундын ойн ангиудын чадавхийг дээшлүүлэх, Ойн судалгаа, хөгжлийн төвийн шугамаар үйл ажиллагаанд мониторинг хийх, Аймаг болон нийслэл хотын ойн менежментийн төлөвлөгөөг батлах, Талбайг тогтоож, ойн цэвэрлэгээний төсвийг сум дундын ойн ангид хуваарилах,
	Ойн судалгаа, хөгжлийн төв	Үндэсний ойн тооллого хийх Ойн судалгаа хийх Мод сөөгний үр шинжлэх, ойн сонгомол үрийн нөөц бүрдүүлэх, хадгалах Ойн мэдээллийн сан бий болгох Ойжуулах талбайг сонгох, зураг төсөл хийх, таримал ойг улсын ойн санд хүлээн авч, баталгаажуулах Ойн түймэр болон хууль бусаар мод бэлтгэсэнээс ойн санд учирсан хохирлыг тогтоох Ойн хөнөөлт шавж, өвчний голомтын судалгаа хийж дүгнэлт гаргах, хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажлын явцад хяналт, шинжилгээ, мэргэжлийн зөвлөлгөө өгөх Ойн төлөв байдалд үнэлгээ өгөх, ойн тооллого, бүртгэл, зохион байгуулалтын ажлын явцад хяналт шинжилгээ хийх Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний шинэ техник, технологи турших Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний норм, стандартыг боловсруулах, шинэчлэх судалгаа хийх, санал боловсруулах Ойн төлөв байдлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах
Аймаг	ИТХ	Ойг хамгаалах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх, мод үржүүлэх, ойн түймрээс сэргийлэх үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө, төсвийг батлах
	Засаг даргын тамгын газар	Ойжуулах, ойг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэх хувийн ААН-г шалгаруулах тендер явуулах, Мод бэлтгэлийн жилийн хэмжээг сумдад хуваарилах Ойн сангийн төлөв байдлын талаар БОАЖЯ-нд тайлагнах Жилийн мод бэлтгэлийн хэмжээний талаарх аймгийн саналыг БОАЖЯ-нд хүргүүлэх Сумдын ойн менежментийн төлөвлөгөөг батлах
	Байгаль орчин, аялал жуулчлалын хэлтэс (ойн нэгж)	Сумдын жилийн мод бэлтгэлийн саналыг цуглуулж аймгийн засаг даргад танилцуулах Сум дундын ойн нэгжүүдийг техникийн болон арга зүйн дэмжлэгээр хангах Сум дундын ойн нэгжүүдтэй гэрээ байгуулах БОАЖЯ болон аймгийн засаг даргад ажлаа тайлагнах
Сум	ИТХ, Засаг дарга	Ойг хамгаалах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх, мод үржүүлэх, ойн түймрээс сэргийлэх үйл ажиллагааны сумын төсвийг батлах, Жилийн мод бэлтгэлийн хэмжээг тооцоолох
	Сум дундын ойн анги	Мод бэлтгэх, ойг сийрэгжүүлэх талбайг тогтоох Ойн ААН, ОН-ийн ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтэд мониторинг хийх Ойн түймрээс сэргийлэх, түймэр унтрахад орон нутгийн иргэдийг дайчлах арга хэмжээ зохион байгуулах

Аймгийн түвшний ойн нэгжүүд нь аймгийн засаг дарга болон БОАЖЯ-нд харъяалагдана. Засгийн газрын 2012 оны 255 дугаар тогтоолоор сум дундын ойн ангиудыг байгуулжээ. Өнөөгийн байдлаар ой бүхий 6 аймагт сум дундын 36 нэгж ажиллаж байна. Аймгийн ойн нэгж нь сум дундын ойн ангиудыг техникийн удирдамжаар хангаж, сум дундын ойн ангиуд сумын засаг даргад харъяалагддаг (Зураг 13.6). Сум дундын ойн ангиуд ойн сангийн томоохон талбайг хариуцаж, ойн нөхөрлөл болон ойн мэргэжлийн байгууллагуудын ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт мониторинг хийдэг. Дээр дурьдсан Засгийн газрын тогтоол болон түүний хавсралт Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх

арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын дагуу зарим сум дундын ойн ангиуд 1 сая гаруй га ойн талбайг хариуцаж байна. НҮБ-ын ХХААБ, Германы ТХАН-ээс хийсэн үнэлгээнд эдгээр сум дундын нэгжүүд боловсон хүчнээр хангагдаагүй, ажилтнуудын мэргэжлийн шаардлагатай мэдлэг чадвар дутмаг, тэдний чадавхийг дээшлүүлэх сургалт тогтмолжоогүй, өдөр тутмын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай техник хэрэгсэлгүйг тэмдэглэсэн байна.

**Зураг 13.6: Ойн салбарын бүтэц, байгууллагууд**



*Эдийн засгийн болон мэдээллийн үйл ажиллагаа*

Засгийн газрын 2010 оны 59 дүгээр тогтоолоор ойн санд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, ойд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэх шинэ технологи нэвтрүүлэх, ойн нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлж буй хуулийн этгээдэд (иргэд, ААН, ОН, бусад байгууллага) санхүүгийн урамшуулал хүртээх асуудлыг зохицуулсан байна. Энэхүү санхүүгийн урамшууллыг ойн сангийн эрүүл байдал, нөөц, үйлдвэрлэл; ойн бүтээгдэхүүний боловсруулалтыг сайжруулах; байгаль орчны мэдлэг мэдээлэл болон боловсролыг дээшлүүлэх технологийг нэвтрүүлэх зэрэг гурван үндсэн үйл ажиллагаанд олгохоор заажээ<sup>1</sup>. Гэвч Засгийн газраас хэдий хэмжээний санхүүгийн урамшуулал олгосон талаар мэдээ мэдээлэл байхгүй байна.

Сүүлийн жилүүдэд орон нутгийн ард иргэд, хувийн хэвшлийнхнийг мод үржүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй татан оролцуулах арга хэмжээг Засгийн газраас авч, үүнд шууд болон шууд бус урамшууллын хэлбэрийг ашиглаж байна. Санхүүгийн урамшуулал нь газар өмчлөгчдийг мод үржүүлэхэд татан оролцуулах чухал хөшүүрэг юм. БОАЖ, Сангийн сайд нарын хамтран баталсан А-140/63 тоот журмаар (31.03.2015) иргэд, ОН, ААН, бусад байгууллагад мод үржүүлэх ажиллагааны урамшуулал олгох тогтолцоог тогтоожээ. Журмын гол зорилго нь дээрх хуулийн этгээдүүд өөрийн зардлаар сайн чанарын үр, тарьц бэлтгэсэн нөхцөлд мөнгөн урамшуулал олгоход оршиж байна.

Мөн хуулийн этгээд ойн түймрийн болон хөнөөлт шавьжны тархалтыг өөрийн зардлаар сэргийлсэн, тухайлбал түймрийн зурвас байгуулсан, ойн түймэр илрүүлсэн, унтраасан тохиолдолд мөнгөн урамшуулал олгохоор журамд заасан байна. Түүнчлэн ойн түймрийн давтамж багассан, ойн түймрийн хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, экологийн тогтолцоонд учруулсан хохирол буурсан нөхцөлд хуулийн этгээдүүдэд мөнгөн урамшуулал олгоно. Хөнөөлт шавьжтай тэмцэх үйл ажиллагааг өөрийн зардлаар хэрэгжүүлсэн, байгальд ээлтэй технологи, арга хэлбэрийг ашигласан хуулийн этгээдэд мөнгөн урамшуулал олгоно.

Ойг нөхөн сэргээх болон мод үржүүлэх үйл ажиллагааг улсад шаардлагатай хэмжээнээс давуулан

<sup>1</sup> 0.07 га газраа эзэмшиж байгаа иргэд (Монголд иргэн бүр зөвхөн гэр бүлийн зориулалтаар 0.07 га газар эзэмших эрхтэй байдаг).



хэрэгжүүлэхийн тулд 2012 онд шинэчилсэн Ойн тухай хуулиар иргэн өөрийн өмчлөлийн болон эзэмшлийн газартаа, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн газартаа өөрийн хөрөнгөөр зориудаар тарьж ургуулсан ой модыг өмчилж болохоор тусгасан байна. Энэ заалт нь иргэдийн өмчлөлийн сэтгэлгээг төлөвшүүлэх, тэдний мод үржүүлэх ажиллагааг урамшуулах инновацийн хандлага болсон хэдий ч түүний эрх зүйн үндэс нь тодорхойгүй байна. Ойн сан төрийн эзэмшилд байгаа тул таримал модноос бүрдсэн ойн нь мөн төрийн эзэмшилд байх ёстойг харгалзан тодотгол хийх шаардлагатай байна.

#### Ойн тооллого

Ойн сан болон ойн нөөцийн анхны үнэлгээг 1950-иад онд хийсэн байна. Ойн сангийн үндэсний анхны тооллогыг 1956-1958, хоёр дахь тооллогыг 1974-1975 онд тус тус хийжээ. Анхны тооллогын дүнг Монгол Улсын нарийвчилсан газрын зураг боловсруулах, ойн сангийн цогц мэдээллийн сан бүрдүүлэхэд ашиглаж, хоёр дахь тооллогоор нэг дахь тооллогын үнэлгээг шинэчлэсэн байна. Хоёр дахь тооллогын үнэлгээнд үндэслэн анхны “Монгол Улсын ойн сангийн нөөцийг ашиглах 1975-1990 оны мастер төлөвлөгөө”-г боловсруулсан байна. Мастер төлөвлөгөөний хүрээнд байгуулсан мод бэлтгэлийн 16 байгууллагын хэрэгцээнд зориулан 1976-1988 онд ашиглалтын бүсийн ойн мод бэлтгэлийн боломжит нөөцийг тогтоох үнэлгээг үргэлжлүүлэн хийжээ.

Ойн тухай шинэ хуулийн дагуу орон нутгийн ойн сангийн тооллогыг аймгийн түвшинд арван жил тутам 1990-ээд оноос эхлэн хийж иржээ. Татварын бүртгэл тооллогоор ойн сангийн талбай, хэмжээ, чанар, төлөв байдал, модны дундаж өндөр, диаметр, нас, нөхөн ургалт, мод бэлтгэлийн хэмжээ зэрэг ойн нөөцийн мэдээллийг цуглуулж, түүнийг ойн менежментийн төлөвлөлтийг боловсруулах суурь болгон ашиглаж байна.

#### Олон зорилтот үндэсний ойн тооллого (2014-2016 он)

Олон зорилтот үндэсний ойн тооллого (ОЗҮОТ) нь анхны улсын хэмжээний ойн тооллого бөгөөд түүнийг Ойн судалгаа, хөгжлийн төв, ойн болон судалгааны гол байгууллагууд, их сургууль, олон улсын байгууллагуудтай хамтран 2014-2016 онуудад зохион байгуулсан байна.

Олон зорилтот гэдэгт ойн сангийн олон шалгуур үзүүлэлт, функцийг Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй ХХ-ийн ялгаруулалтыг бууруулах хөтөлбөрийн (НҮБ-РЭДД) олон улсын мэдээ мэдээлэлд нийцүүлэн хэрэгжүүлэх ойлголтыг агуулж байна.

ОЗҮОТ-ын гол зорилго нь Монгол улсын ойн сангийн нөөцийн тухай бодит, нарийвчилсан мэдээ мэдээллийг гаргах, удирдамжууд боловсруулах, баримтад суурилсан ойн сангийн үндэсний бодлогыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, ойн төлөвлөлтийн үйл ажиллагааг сайжруулахад оршиж байв. Монгол Улсын ойн сангийн газар зүйн тархалт, хэмжээг орчин үеийн хяналтын арга хэлбэрийг ашигласан үнэлгээгээр гаргасан байна. ОЗҮОТ-ын үнэлгээг 4,211 дээж авах нэгжийн гүйцэтгэсэн 251890 мод, нөхөн сэргээсэн 166830 модны хэмжилт болон талбайн тооллогын мэдээ мэдээлэлд үндэслэн гаргажээ. ОЗҮОТ-оор Монгол Улсын ойн сан хөгширсөн, ашиглалт хангалтгүй, нөөц доройтсон байна гэсэн гол үнэлгээг гаргажээ.

#### Үндэсний мод тарих өдөр

Үндэсний мод тарих өдрийг иргэн бүрийг мод тарих хөдөлгөөнд идэвхтэй оролцохыг дэмжих зорилгоор 2010 онд санаачилжээ (Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг). Энэхүү санаачилгын хүрээнд ард иргэд 2012 онд 2.21 сая орчим мод, 2013 онд 1.17 сая мод, 2014 онд 1.43 сая мод тус тус тарьсан байна.

#### *Олон улсын гэрээ хэлэлцээр, үйл ажиллагаанд оролцох оролцоо*

Монгол Улс нь Биологийн олон янз байдлын тухай конвенци (Бүлэг 7), Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци (Бүлэг 6), Цөлжилттэй тэмцэх конвенцид (Бүлэг 7) нэгдэн орсон.

Монгол Улс НҮБ-ын ХХААБ-ын шугамаар боловсруулсан Дэлхийн ойн сангийн нөөцийн 2005, 2010, 2015 оны үнэлгээнд ойн сангийн нөөцийн тухай тайлан илтгэлүүдийг хүргүүлсэн байна.

Бүх төрлийн ойн сангийн менежмент, хадгалалт, тогтвортой хөгжлийг дэмжих, улс төрийн урт хугацааны оролцоог хангах зорилготой НҮБ-ын Ойн форумыг (НҮБОФ) 2000 онд байгуулсан цагаас хойш Монгол Улс түүнд нэгдэн, энэ үйл ажиллагаанд гол анхаарлаа хандуулж иржээ. Монгол Улс нь төрөөс ойн сангийн талаар баримтлах бодлого, ойн сангийн төлөв байдлын үнэлгээгээ НҮБ-ын бүх төрлийн ойн (заавал даган мөрдөх албагүй) баримт бичиг, ойн аргачлалын дагуу шинэчлэх боломжтой анхны орнуудын нэг байж болох юм. Туршилтын төсөл нь Монгол Улсын төрөөс ойн сангийн талаар баримтлах бодлогын сул талуудыг тогтоох, тэдгээрийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

### *Олон улсын төслүүд*

Ойн салбарт хандив үзүүлж байгаа гол орнууд нь Япон, Нидерланд, Герман, БНСУ, техникийн тусламж үзүүлж буй олон улсын байгууллагууд нь НҮБ-ын ХХААБ, НҮБХХ, ДБ, АХБ байна. Гадаадын тусламжийг 1990-ээд оны дунд үеэс ойг нөхөн сэргээх, ойн түймрээс сэргийлэх жижиг төслүүдээр эхлүүлж, тэдгээр төслүүдийн үр дүн нь техникийн хамтын ажиллагааны төслүүдийг боловсруулах бодит суурь болжээ. 2000-аад оны эхээр ойн түймрийн менежментийн төслүүдийг НҮБ-ын ХХААБ, Германы ТХАН-ээс хэрэгжүүлжээ. Тэдгээр төсөл хэрэгжсэнийг хойш гадаадын тусламж нь орон нутгийн ард иргэдэд суурилсан ойн менежментэд дэмжлэг үзүүлэх чиглэлтэй болсон байна.

## **13.7 Үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж**

### *Үнэлгээ*

Ойн аж үйлдвэр 1990 он хүртэл эрчимтэй хөгжиж, өргөжин, ойн салбар ДНБ-ний 6 хувийг бүрдүүлж байв. 1990-ээд онд тогтолцоо өөрчлөгдсөнтэй холбогдон улсын өмчит мод боловсруулах үйлдвэрүүдийг хувьчилсан боловч тэдгээр нь хөрөнгө санхүү, мэргэжлийн боловсон хүчний хомсдлоос болж нэн удалгүй ихэнх нь хаагдсан байна. Түүнчлэн модон бүтээгдэхүүний дотоодын зах зээл үлэмж буурч, үүнээс үүдэн хууль бус мод бэлтгэл ихээхэн нэмэгдсэн байна. Нийгмийн тогтолцоо өөрчлөгдсөний улмаас эдийн засгийн ерөнхий байдал хүндэрч, ажилгүйдэл огцом өссөн нь нөхцөл байдлыг улам даамжруулжээ. Үүнтэй холбогдуулан төр засгийн менежментийн гол бодлого нь ойн санг ашиглах бус, хамгаалахад чиглэгдэх болсон байна.

1990-ээд оноос эхлэн засгийн газар ойн нөөцийн менежментийн эрх зүй, бодлого, бүтэц зохион байгуулалтын цогц тогтолцоог бүрдүүлж иржээ. Төрөөс ойн сангийн талаар баримтлах 2015 оны бодлогоор гол зорилт зорилгыг тодорхойлсон байна. Эдгээр 8 зорилтын 4 нь ойг хамгаалах чиглэлтэй байгаа нь ойг хамгаалах асуудал улсад тэргүүлэх ач холбогдолтой байгааг харуулж байна. Энэ зорилтын хүрээнд мод бэлтгэлийн хэмжээг бууруулах, хамгаалалттай газар нутагт ойн аль болох олон талбайг хамруулах, ойг нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөжээ. Гэвч дээрх бодлогод ойн төлөв байдал, дотоодын мод бэлтгэл, ахуйн хэрэглээний түлээний модны асуудлууд орхигдсоныг Олон зорилтот үндэсний ойн тооллогын (2014-2016 он) дүн харуулсан байна. Тооллогын мөрөөр ойн менежментийн идэвхтэй үйл ажиллагааг тодорхой бодлоготой явуулах шаардлагатай болж байна.

Ойн бодлогын бас нэг тэргүүлэх чиглэл бол ойжуулах, ойг нөхөн сэргээх үйл ажиллагаа бөгөөд ойн салбарын төрийн санхүүжилтийн дийлэнхийг мод үржүүлэх болон хөнөөлт шавьжны хяналтад зарцуулж байна. Ногоон хүрэм хөтөлбөрийг төрөөс санхүүжүүлсэн нь ойжуулах ажилд төрийн ихээхэн санхүүжилтийг зарцуулсан тод жишээ юм. Гэвч ойжуулах, ойг нөхөн сэргээх үйл ажиллагааны бодит үр дүн, тарьсан модны бодит бойжилтын түвшинд нарийвчилсан үнэлгээ хийдэггүй, сургамжийг урт хугацааны бодлогод тусгадаггүй байна.

Монгол Улс ойн менежментэд олон нийтийн оролцоог хангахад ихээхэн дэвшил гарчээ. Энэ хандлагыг засгийн газраас баримталсан нь хууль бус мод бэлтгэл, ойн түймрийн хяналтыг сайжруулахтай холбоотой. Энэ бодлого нь орон нутгийн ард иргэдийг ойн менежментэд татан оролцуулах, ойн нөөц, тухайлбал мод, түлээний мод, ойн дагалт баялаг амьжиргааны гол эх үүсвэр нь болдог, ойгоос хамааралтай ард иргэд ойн нөөцийг тогтвортой ашиглах, гадны хүмүүс ойн нөөцийг хууль бусаар ашиглахаас хамгаалах илүү сонирхолд суурилсан байна.

Мөн 2015 онд төрөөс ойн талаар баримтлах бодлогыг батласнаар нааштай хөгжил дэвшил гарсан хэдий ч улсын ойн сангийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд ойн нөхөрлөлүүд гол үүрэгтэй болохыг баталгаажуулаагүй, орон нутгийн ард иргэдийн оролцоог ойн менежмент, нөөцийн ашиглалтад бус, голдуу ой хамгаалалтад чиглүүлдэг байна. Ойн нөхөрлөлийн эрх зүйн статус, үйл ажиллагааны аюулгүй

байдал, баталгаа тодорхой бус байгаа нь итгэл алдагдахад хүргэх, тэдний урт хугацааны оролцоог сааруулахад нөлөөлөх магадлалтай. Орон нутгийн ард иргэд өөрсдийн амьжиргааг сайжруулах бодит үр дүнг олж хараагүй нөхцөлд тэдний тогтвортой оролцоог цаашид хангах боломжгүй юм.

*Дүгнэлт, зөвлөмж*

#### Ойн тогтвортой менежмент

Саяхан нийтлэгдсэн Олон зорилтот үндэсний ойн тооллогын (2014-2016 он) дүн, сургамжууд тайлан нь 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн Зорилго 15.2 -той нийцүүлэн ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх ирээдүйн бодлогын чиглэлийг тодорхойлох суурь болсон байна. Монголын ойн сангийн дийлэнх нь насжилт өндөр байгааг Олон зорилтот үндэсний ойн тооллого харуулжээ. Өндөр насжилттай ойн үйлдвэрлэлийн чадамж бүтээмж сул, ойн түймэр, шавьжинд өртөх илүү магадлалтай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхгүй байдгийн улмаас ойн сан доройтож, улмаар ой устахад хүргэдэг. Ойн сангийн ерөнхий төлөв байдлыг сайжруулах, хөдөө орон нутагт ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн өндөр, хэт өндөр насжилттай ойд идэвхтэй менежментийг хэрэгжүүлэх ажил хоцрогдож байна. Монголд ойн тогтвортой менежментийн үндэсний шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулаагүй нь ТХЗ-ын Зорилго 15.2-ын биелэлтэд үнэлгээ хийх боломжийг алдагдуулж байна. Улсад гэрчилгээ олгох үндэсний тогтолцоог бүрдүүлж байгаа нь ойн тогтвортой менежментийг боловсронгуй болгох бас нэг арга хэмжээ юм.

#### Зөвлөмж 13.1:

*БОАЖЯ нь дараах арга хэмжээ хэрэгжүүлвэл зохино:*

- (a) *Олон зорилтот үндэсний ойн тооллогын (2014-2016 он) үр дүнд үндэслэн 2015 оны төрөөс ойн сангийн талаар баримтлах бодлогыг шинэчлэх, ойн нөөцийн тогтвортой менежмент, ашиглалтыг сайжруулах шаардлага, баримтад суурилсан бодлого боловсруулах үйл ажиллагааг хангах;*
- (b) *Ойн тогтвортой менежментийн үндэсний шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах;*
- (c) *Ойн тогтвортой менежментийн үндэсний гэрчилгээ, баталгаа олгох тогтолцоог бүрдүүлэх, түүнийг Ойн гэрчилгээ батламжлах хөтөлбөр (ОГБХ) зэрэг олон улсын баталгаажуулалтын системтэй ойртуулах.*

#### Ойн салбарын байгууллагууд

Монгол Улс нь ойн менежментийн эрх зүйн болон бодлогын цогц тогтолцоотой орон. Гэвч ойн бодлогын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх байгууллагуудын бүтэц, ялангуяа орон нутгийн түвшинд төдийлөн бэхжээгүй байна. Сум дундын ойн ангиудыг 2012 оноос байгуулж эхэлсэн нь менежментийн нэлээд үүргийг орон нутагт шилжүүлэх сайн санаачлага болсон хэдий ч эдгээр нэгжүүд нь өдөр тутмын үйл ажиллагаа явуулах шаардлагатай нөөц, техник хэрэгсэлгүй байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг бас нэг байгууллага бол ойн мэргэжлийн байгууллагууд юм. 2016 оны байдлаар 814 хувийн ААН-д ойн мэргэжлийн байгууллагын гэрчилгээ олгосон боловч тэдгээр нь бэлтгэгдсэн боловсон хүчин, техник төхөөрөмж, орчин үеийн технологийн боломжгүй зэрэг олон бэрхшээлтэй тулгарч байна. Ойн мэргэжлийн байгууллагуудын ажлын чанарт БОАЖЯ, орон нутгийн захиргаа тогтмол үнэлгээ хийдэггүй байна.

#### Зөвлөмж 13.2:

*Орон нутаг дахь ойн байгууллагуудыг бэхжүүлэхийн тулд БОАЖЯ нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Техник хэрэгслээр хангах, сургалт зохион байгуулах замаар сум дундын ойн нэгжүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэх;*
- (b) *Гэрчилгээ бүхий ойн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт мониторинг хийх, гэрчилгээг зөвхөн мэргэжлийн шаардлага хангасан байгууллагуудад олгох.*

#### Ойн оролцоотой менежмент

Монгол Улс ойн менежментэд олон нийтийн оролцоог хангахад ихээхэн дэвшил гаргасан байна. Гэвч ойн нөхөрлөлийн эрх зүйн статус тодорхой бус байна. ОН-үүдэд мод бэлтгэлийн зөвшөөрөл олгох

боломжгүйн улмаас зөвшөөрөл авахын тулд тэд хувийн ААН, ойн мэргэжлийн байгууллагуудтай түншлэл байгуулах шаардлагатай болдгийн зэрэгцээ эрх зүйн аливаа статусгүй учир санхүүжилтийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй байна.

Ойн тухай 2012 оны шинэчилсэн хуулиар ОН-д 60 жил хүртэлх концессийн эрх олгодог. ОН нь гэрээг сумын засаг даргатай байгуулдаг хэдий ч эрх эзэмшигчдийн аюулгүй байдал, гэрээний эрх зүйн статус нь баталгаагүй, тодорхой бус байна. Зөвхөн уул уурхайн концесс бүрэн баталгаатай. Ойн тухай хууль болон холбогдох бусад хуулиудад ойн сангийн талбайн эзэмшлийн давхардлаас сэргийлэх тодорхой заалт байхгүй байна. Иймд ойн нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлж байгаа ойн талбайг бусдад давхардуулан олгох явдал цөөнгүй гардаг байна.

#### Зөвлөмж 13.3:

*БОАЖЯ нь дараах асуудлыг анхааран хууль тогтоомжийг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулбал зохино. Үүнд:*

- (a) *Ойн нөхөрлөлийн статусыг албажуулж, хуулиар тэдэнд ойн нөөцийг тогтвортой ашиглах эрх олгох;*
- (b) *Ойн нөхөрлөлийн менежментэд байгаа ойн талбайд уул уурхай, газрын тосны тусгай зөвшөөрөл олгохгүй байхыг баталгаажуулах;*

#### Шийдвэр гаргахад шаардлагатай мэдээ, мэдээлэл

Ойн нөхөрлөлийн эзэмшилд байгаа ойн төлөв байдал сайжирч, ойн түймрийн тоо багасч байгааг сүүлийн үеийн статистик мэдээ, 2015-2016 оны Байгаль орчны төлөв байдлын илтгэл харуулж байна. Орон нутгийн ард иргэдэд өөрсдийн нөөцийг эзэмших ухамсар төлөвшиж байна. Гэвч ойн нөхөрлөлд ойн талбай эзэмшүүлэх нь ойн доройтол, ой устах, ойн дагалт баялаг, амьтан ургамлын нөөцийн менежмент, нүүрстөрөгчийн шингээлтийг дэмжих хэрхэн нөлөөлсөн талаар ямарваа нэгэн мэдээ мэдээлэл байхгүй байна. Ийм мэдээлэл нь олон нийтийн хамтын оролцоотой ойн менежментийг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй болно.

#### Зөвлөмж 13.4:

*БОАЖЯ нь ойн доройтол, ой устах явдлыг сааруулахын тулд ойн идэвхтэй менежмент, ойн нөхөрлөлд ой эзэмшүүлэхийн ач тус, нөлөөлөл, улмаар нүүрстөрөгчийн ялгаралтын багасгахад үзүүлэх хувь нэмэр, ойн доройтол болон ойн түймрийн бусад нөхцлийг бууруулахад чиглэсэн судалгааг орон зайн аргачлал ашиглан хийх.*

#### Био түлшний бүтээгдэхүүн болон орон нутгийн игэдийн амьжиргаа

Монголын байгалийн ойн санг арчлах, цэвэрлэх, сийрэгжүүлэх замаар ойн санг эрүүлжүүлэх, үржлийг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхийг нэмэгдүүлэх нэн шаардлагатай байна. Гэвч ойн цэвэрлэгээ, арчилгаанаас гарсан модыг үр ашигтай ашиглах, арчилгааны үйл ажиллагааны зардлыг босгох, орон нутгийн ард иргэдийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн бодлого байхгүй байна. Ойн төслүүд хэрэгжүүлэх явцад зарим шинэлэг арга хэлбэр, тухайлбал нөхөрлөлийн үйл ажиллагаатай холбоотой туршилтыг хийсэн байна.

#### Зөвлөмж 13.5:

*БОАЖЯ нь холбогдох бусад талуудтай хамтран дараах арга хэмжээ хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Ойн цэвэрлэгээ, арчилгаанаас гарсан модыг зомгол, шахмал нүүрс зэрэг биотүлш боловсруулах боломжийн талаар эдийн засгийн болон үр ашиг, тогтвортой байдлын судалгаа, шинжилгээ хийх;*
- (b) *Модны хаягдал, ойн цэвэрлэгээ, арчилгаанаас гарсан модыг ашиглан биотүлш үйлдвэрлэх цогц бодлого боловсруулах, мод шатаадаг цахилгаан станцууд, халаалтын зуухнуудыг сумын төвд байгуулан цахилгаан үйлдвэрлэх, шахмал түлшээр Улаанбаатар хотын зах зээлийг хангах;*
- (c) *Ногоон ажлын байр бий болгох, дотоодын модны хэрэгцээг тогтвортой хангах, дулаан болон ахуйн хэрэглээний модны хамгамжийг сайжруулах, орон нутгийн ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэхийн тулд ойн нөхөрлөлд суурилан ойн жижиг ААН байгуулах бодлого боловсруулах.*

### Санхүүжилт

Өнөөгийн байдлаар ойн салбарын төрийн санхүүжилтийн дийлэнх хувь мод үржүүлэг (ойжуулах болон нөхөн сэргээх), хөнөөлт шавьжны хяналтад зарцуулагдаж байна. Гэвч мод үржүүлгийн үйл ажиллагааны бодит үр дүн хангалтгүй байна. Хатуу ширүүн уур амьсгалын зэрэгцээ мал бэлчээх, ойн түймэр, үржүүлгийн ажлын чанар зэрэг хэд хэдэн хүчин зүйл үржүүлгийн ажлын үр дүнд нөлөөлж байна. Мод үржүүлгийн үр бүтээмжийг дээшлүүлэх арга замыг ойн бүрхэвчтэй талбайн эзлэх өнөөгийн байгаа 7.85 хувийг 2020 онд 8.3, 2030 онд 9.0 хувьд хүргэх Засгийн газраас дэвшүүлсэн зорилтын хүрээнд шийдвэрлэх боломжтой. Ойн салбарын өнөөгийн санхүүжилт ойн менежментийг улам боловсронгуй болгох, ойн салбарын орон нутгийн хүн амын амьжиргааг дээшлүүлэх нөөц боломжийг дайчлахад хангалтгүй байна. Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нэмэлт санхүүжилт дайчлах нь 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн Зорилго 15.6 –г биелүүлэх талаар Засгийн газраас авч буй арга хэмжээтэй нийцэх болно.

#### Зөвлөмж 13.6:

*Засгийн газар дараах арга хэмжээ хэрэгжүүлбэл зохино:*

- (a) Ойжуулах, ойг нөхөн сэргээх үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийн үнэлгээ, шинжилгээ хийх;*
- (b) Ойн менежментийг улам боловсронгуй болгох, ойн салбарын орон нутгийн хүн амын амьжиргааг дээшлүүлэх нөөц боломжийг дайчлах, ногоон ажлын байр бий болгох санхүүжилтийг нэмэгдүүлэх хүчин чармайлт гаргах.*



## Бүлэг 14

# БАЙГАЛИЙН БОЛОН ТЕХНОЛОГИ, ХҮНИЙ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ГАРАЛТАЙ ГАМШГИЙН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТ

### 14.1 Өнөөгийн төлөв байдал

Монгол Улсад тулгарч байгаа өнөөгийн гамшиг, гамшгийн эрсдлийн менежментийн (ГЭМ) байдлыг нийгэм, эдийн засаг, геофизикийн нийлмэл хүчин зүйлүүдээр тодорхойлж болно.

Монгол Улс нь далайд гарцгүй, газар нутаг болон геофизикийн хувьд олон янз нөхцөл байдалтай, температурын огцом хэлбэлзэлтэй улс юм. Нийт хүн амын 70 орчим хувь хот сууринд, үүнээс 1.2 сая буюу хүн амын 40 хувь нийслэл Улаанбаатар хотод амьдардаг. Мөн байгаль орчноос хамааралтай, нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг нэг сая орчим иргэд байна.

Уур амьсгал, цаг агаарын төлөв байдал болон эдийн засгийн уламжлалт бүтэц тогтворгүй болсноор гамшиг, ялангуяа цаг уур, усны үзэгдлийн үүдэлтэй гамшиг улсын нийгэм эдийн засгийн байдалд ихээхэн нөлөө үзүүлж байна. Аадар бороо, цас, хүчтэй салхи шуурга, элс шороон болон цасан шуурга, мөндөр, уруйн үер нь Монгол улсын иргэдийн амь нас, эд хөрөнгөд ихээхэн хохирол учруулдаг байна. Зуд, ган зэрэг цаг уурын гамшиг нь монголын нүүдэлчин малчин ард иргэдэд үлэмж хохирол учруулж байна. Зуд гэдэг нь хавар, өвлийн улиралд тохиолддог, хүйтний эрч эрс чангаран мал сүрэг бэлчих аргагүй болж, өвс тэжээлээр гачигдан зутарч, улмаар тарга хүч муутай мал олноор үхэж хорогддог цаг агаартай холбоо бүхий байгалийн гамшигт өвөрмөц үзэгдлийг тодорхойлсон Монголд хэрэглэдэг нэр томъёо юм. Хот суурин болон хөдөө орон нутагт тохиолддог ган, үер, тал хээрийн болон ойн түймэр, шуурга, ХАА-н хортон шавьж нь уур амьсгалын нөлөө, байгаль орчны өөрчлөгдөж буй төлөв байдал, эдийн засгийн хүндрэлийн хавсарсан гамшгийн дүр зураг юм. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан байгалийн гамшгийн давтамж, цар хүрээ улам өргөжих төлөв тодорхой байна.

Дээрх байгалийн гамшгууд нь улсын янз бүрийн бүсүүд, хүн амын давхрагад янз бүрийн үр дагавартай хэдий ч нэн аюултай, их хэмжээний хохирол учруулдаг гамшгийн тоо хэмжээ ойрын жилүүдэд буурах төлөвгүй байна. Мөн улсын газар нутаг, газар болон усны байгалийн нөөц нь ихээхэн эмзэг бөгөөд эрчимтэй доройтож, бүтгээгдэхүүн нь багасах зэрэг асуудал хурцаар тавигдах болсон байна.


Томоохон хот суурингийн барилга байгууламжууд хуучирч муудан, газар хөдлөлтөд тэсвэргүй болсон байна. Хотруу шилжих эрчимтэй хөдөлгөөн, Улаанбаатар хотын захын гэр хорооллын албан бус тэлэлт, өсөлтөөс хамааран гэр хороололд одоо хотын хүн амын 60 хувь амьдарч байна. Гэр хороолол нь шинэ, шийдвэрлэх боломжгүй эрсдэл бий болгохын зэрэгцээ хотын бодит орчинд нэмэлт дарамт учруулан, хотын дэд бүтцийг өргөжүүлэх ихээхэн шаардлагыг бий болгож байна. Бодит орчны хүнд, бэрхшээлтэй нөхцөл, эдийн засгийн түргэн хурдацтай өөрчлөлт, хотын болон худалдааны үйл ажиллагаа, хот хөдөөгийн хүн амын нийгмийн ялгаа зэрэг нь Монголын эрсдлийн хүчин зүйлийг улам нэмэгдүүлж байна.

Түүнчлэн хүмүүсийн амьжиргаа, улсын газар болон байгалийн нөөцөд нөлөөлөх “удаан хугацааны” нэмэлт эрсдлүүд бий болж байна. Сүүлийн үед эрчимтэй хөгжсөн уул уурхайн томоохон үйл ажиллагаанууд нь байгаль орчны эмзэг болон хуурайшилттай бүсүүдийн усны нөөцийг хомсдуулах аюул учруулж байгаа нь ноцтой асуудал болоод байна.

Хүний хүчин зүйлийн гаралтай болон байгалийн гамшиг 2000-2016 оны хооронд жил тутам 3,200 удаа тохиолдож, жилд 190 орчим хүн амь эрсдэж байжээ. Бүртгэгдсэн нийт гамшгийн 90 хувийг байшин барилга, ой, хээрийн түймэр эзэлж, үлдсэн 10 хувь нь байгалийн болон бусад гамшиг байна. Монгол дахь байгалийн, технологийн, хүний хүчин зүйлийн гаралтай гамшгийн тоо, давтамж, цар хүрээ, хохирол, үр дагаврын хэмжээ 2000-2016 оны хооронд өссөн байна (Зураг 14.1). Байгалийн,


технологийн холбоотой гамшигийн эдийн засгийн дундаж хохирол 2000-2016 онд жилд 76.0 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна (Зураг 14.2). Эдийн засгийн хохирлыг 2010 оны тогтмол үнээр тооцвол 534,796.4 сая төгрөг болсон нь ДНБ-ний 5.5 хувьтай тэнцэж байна.

**Зураг 14.1: Байгалийн болон технологийн гамшиг, холбогдох хүний эрсдлийн түвшин, 2000-2016.**



Эх сурвалж: Гамшиг судлалын хүрээлэн, 2017 он.

**Зураг 14.2: Байгалийн болон технологийн гамшигийн эдийн засгийн хохирол, 2000-2016, сая төгрөг**



Эх сурвалж: Гамшиг судлалын хүрээлэн, 2017 он.

#### Уур амьсгалын өөрчлөлт, түүний нөлөөлөл

Монгол Улсын жилийн дундаж агаарын температур 1940-2013 оны хооронд Цельсийн 2.07 градусаар өссөн нь дэлхийн дунджаас гурав дахин илүү байна. 1961 оноос хойш жилийн халуун өдрийн тоо 15-25 өдрөөр нэмэгдсэн, жилийн нийт хур тунадасны түвшин 9.4 хувиар буурсан, зунд адаар ширүүн борооны тоо нэмэгдэж, харин зөөлөн шиврээ борооны тоо багасчээ.


Цэвдгийн давхарга өөрчлөгдөж, олон тооны гол, горхи, булаг шанд, нуур, цөөрөм, баян бүрд ширгэж байна. Бэлчээрийн ургамлын нягт 2-3 дахин буурч, хээр тал нутгийн 78.2 хувь нь дунд зэргийн болон их хэмжээний цөлжилтөд өртөж, ургамлын ургацын хэмжээ нийт нутаг дэвсгэрт 20-30 хувиар буурсан байна.

Ган, зуд, аадар ширүүн бороо, шороон болон цасан шуурга, аянга, мөндөр, уруйн үер зэрэг байгаль, цаг агаарын гамшгийн тоо, төрөл, давтамж сүүлийн 20 жилд нэмэгдэж, нийгэм, эдийн засгийн алдагдал, хор хохирол өмнөх жилүүдтэй харьцуулбал өсч байна. Агаарын жилийн дундаж температур 2050 он гэхэд Цельсийн 2.1-3.0 градусаар нэмэгдэх төлөвтэй байна. Иймд хүний амь нас, эрүүл мэндэд учрах хохирол, малын алдагдал хорогдол, эд хөрөнгө болон байгаль орчны хохирол ирээдүйд өсөх магадлалтай байна.

### Байгалийн гамшиг

Байгалийн гамшиг нь хамгийн нийтлэг, хамгийн их хохирол учруулдаг (Зураг 14.3).

**Зураг 14.3: Байгалийн гамшиг, 2000-2014 он, тоо**



Эх сурвалж: Онцгой байдлын ерөнхий газар, 2017 он.

Тайлбар: Байгалийн гамшигт ой хээрийн түймэр, цасан болон шороон шуурга, зуд, аадар бороо, цасан уруй, газар хөдлөлтийг оруулав.

### Зуд

Зуд гэж гантай зуны дараа хүйтний эрч маш чангарсан, ширүүн салхитай цаг уурын олон талтай үзэгдэл юм. Гантай зунд мал тарга хүч авч чадахгүй, хатуу өвлийг давах чадвар муутай болдог байна. Зудад олон тооны мал хорогддог учир эдийн засгийн хямрал, хүнсний аюулгүй байдлын асуудал үүсгэж болзошгүй. Зудын хэд хэдэн төрөл, хэлбэр байдаг байна (Хүснэгт 14.1).

**Хүснэгт 14.1: Зудын төрөл**

Төрөл	Нөхцөл	Нөлөөлөл
Цагаан зуд	Бэлчээр зузаан цасанд дарагдах (хамгийн түгээмэл төрөл)	Их талбайг хамардаг; мал бэлчээрээс өвс олж идэх боломжгүй
Хар зуд	Өвөлд цас орохгүй, хүйтний эрч дунджаас байнга доогуур байна	Усны дутагдал үүсгэж, өвсний хомсдолтой хавсардаг
Төмөр зуд	Цас хайлж, хөлдсөнөөс бэлчээр мөсөн бүрхэвчтэй болдог	Мал бэлчээрлэх боломжгүй болдог
Туурайн зуд	Ган	Бэлчээрийг бүрэн сүйтгэдэг
Хавсарсан зуд	Дээрх нөхцөл байдал хавсарсан тохиолдол	Дээрх нөлөө хүндэрч, малд ихээхэн хүндрэл учруулдаг

Эх сурвалж: Гамшиг судлалын хүрээлэн, 2017 он.

2009-2010 онд тохиолдсон зуданд улсын нийт малын 25 хувь хорогдсон нь олон малчдын амьжиргаанд эрсдэл авчирч, хотруу шилжих хөдөлгөөнийг эрс нэмэгдүүлсэн байна. 2015-2016 оны хатуу өвөл монголын нийт малчдын 41 хувьд (225,788 хүн) ихээхэн сөрөг нөлөөлжээ. Эдгээрээс 100-аас доош толгой малтай 11,800 өрхөд хамгийн эмзэг туссан гэж үзсэн байна. Малчдад суурь үйлчилгээнд

хамрагдах боломжгүй болох, хүнсний аюулгүй байдал, амьжиргааны орлогоо алдах, сэтгэл зүйн дарамт зэрэг олон хүчин зүйлийн дарамт хохирол амссан байна. Монголын зудын бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөнөөс (2016 оны 4 дүгээр сар) үзвэл Монголын нийт 55.975 сая малын 858,153 толгой тэмээ, адуу, үхэр, хонь, ямаа цаг агаарын хатуу нөхцөл, 9,115 нь өвчнөөр хорогдсон байна. Түүнчлэн таримал ургацын хэмжээ буурсан нь ХАА-н салбарын нөхцөлийг улам хүндрүүлж, улсын хүнсний хангамжид нөлөөлж байна.

#### Газар хөдлөлт

Монгол Улс нь газар хөдлөлтийн идэвхтэй бүсэд оршдог бөгөөд нийт газар нутгийн 80 орчим хувь нь газар хөдлөлтийн идэвхтэй бүсэд хамрагддаг байна. Ялангуяа хүн амын хамгийн нягтшил ихтэй нийслэл хотын бүс газар хөдлөлтийн өндөр магадлалтай идэвхтэй бүсэд орж байна. Газар хөдлөлтийн давтамж 2005 он, ялангуяа 2009 оноос хойш идэвхжиж байна. Улаанбаатар хот нь 7 баллын (M7) газар хөдлөлт үүсгэх боломжтой 4 бүсээр хүрээлэгдсэн байна.

Засгийн газрын Газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийг бууруулах комиссийн 2000 онд хийсэн загварчлалын үнэлгээн дээр үндэслэн Улаанбаатар хотод 7 баллын газар хөдлөлт болвол барилга байгууламжийн 22-50 хувь, 60,000 оршин суугч өртөнө гэсэн тооцоог хийсэн байна. Хот эрчимтэй тэлж байгаа өнөөгийн нөхцөлд хохирлын хэмжээ хавьгүй өндөр байх магадлалтай. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд 3.5-аас 6 Рихтерийн баллын газар хөдлөлт жилд 45 удаагийн давтамжтай тохиолдож байжээ. 20 дугаар зуунд 8 баллаас илүү хүчтэй газар хөдлөлт 8 удаа бүртгэгдсэн байна. Нийслэл хотын барилга байгууламжийн 70 орчим хувь нь газар хөдлөлтөд тэсвэргүй, үүнд томоохон эмнэлгүүд, цахилгаан станцууд болон дэд бүтцийн бусад чухал объектууд орсон байна. Нөгөө талаар хүн ам нь газар хөдлөлтөөс хамгаалах суурь мэдлэг, газар хөдлөхөд амиа хамгаалах шаардлагатай урьдчилан сэргийлэх арга ажиллагааг эзэмшээгүй байна.

#### **Фото зураг 14.1: Өвөрхангай аймгийн Бүрд суманд тохиолдсон харын зуд**





## Үер

Монгол Улсын гамшгийн эрсдэлд хот суурины уруйн үер ихээхэн хохирол учруулдаг. Хот суурин, ялангуяа Улаанбаатар хотын хязгаарлагдмал газар, талбайн төлөөх өрсөлдөөн нь эрсдлийг улам нэмэгдүүлж байна. Туул голын үерийн сав газар, Богдхаан уулын Дархан цаазат газар ч үерийн аюултай тулгарч байна. Төлөвлөлтгүй суурин, ялангуяа хөдөөгөөс хотруу чиглэгдсэн шилжих хөдөлгөөний улмаас гэр хорооллууд тэлж байна. Хотын захын гэр хорооллууд үерийн усны замд байрлаж байгаа тул оршин суугчдыг гэнэтийн үерээс хамгаалах боломжгүй байна. Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын дэд бүтцийг 1966 оны үерийн дараа байгуулжээ. Улаанбаатар хотод тохиолдсон 1966 оны үер нь 1940-өөд оноос хойших хамгийн том үер юм. Улаанбаатар хотын үерээс хамгаалах системд зохих арчилгаа хийгээгүй учир хүчтэй бороо, хаврын цас хайлалтын усыг зайлуулах чадваргүй байна. Уруйн үерийн давтамж, учруулж буй хохирлын хэмжээ жил тутам нэмэгдэж байна. Жишээ нь 2009 оны 7 дугаар сарын 17, 21-ний өдрийн хүчтэй аадар борооны (30-60 минутанд 17-51.6 мм бороо орсон) улмаас 2,000 орчим айл өрхийг нүүлгэн шилжүүлж, нийт 2.7 тэрбум төгрөгийн (1.93 сая ам.доллар) хохирол учирчээ. Борооны шинж төлөвд өөрчлөлт орох төлөвтэй байгаа нь суурин газруудад, ялангуяа голын сайр газарт байгаа хот сууринд ихээхэн нөлөөлнө.

## Цасан болон шороон шуурга

Хүчтэй цасан шуурга нь Монгол дахь хамгийн аюултай гамшигт үзэгдэл бөгөөд шуурганы улмаас төөрсөн, алдсан малаа хайсан малчид шуурганд амиа алдах нь олонтаа тохиолддог. Хамгийн аюултай цасан шуурга 2011 онд болж, 1 дүгээр сард болсон шуурганд 12; 4 дүгээр сард болсон шуурганд дахин 11 хүн амиа алдсан байна. Хүчтэй салхи нь мод, цахилгаан болон утасны шугамыг гэмтээх, унагаах, байшин, гэрийг нураах аюул учруулдаг байна.

Монгол оронд тохиолддог шороон шуурганы 60 орчим хувь нь хаврын улиралд гардаг. Хүчтэй шороон болон шороон шуурга нь агаарын чанарт нөлөөлж, алсын харааг эрс бууруулдаг. Монгол улс болон хойд Хятадын говиос үүдэлтэй хуурай хөрсний нарийн ширхэгтэй тоос шороо агаарт дэгдэн салхиар зүүн зүгт зөөгдөн Солонгос, Япон, ОХУ-ын Алс Дорнод, зарим тохиолдолд бүр АНУ-ын зүүн эргийн агаарын чанарт нөлөөлөх нь бий. Энэ шороон болон элсэн шуурга нь хил дамнасан, зөвхөн Монголын төдийгүй бүс нутгийн байгаль орчин, эрүүл мэнд, аж үйлдвэр, амьжиргаа, хот суурины дэд бүтэц, ХАА-д нөлөөлсөн олон талт асуудал болж байна.

## **Фото зураг 14.2: Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг болсон мөстөл, 2017**






Ой, хээрийн түймэр

Монгол оронд жилд ой, хээрийн түймэр олонтоо гардаг. Улсын нутаг дэвсгэрийн 55.6 хувь нь ой, хээрийн түймэрт эмзэг ангилалд хамаардаг. Түймэр нь Монголын ойн экологийн тогтолцооны нөхөн ургалтад нөлөөлж байдаг байгалийн элемент боловч түймэр нь ихэнх тохиолдолд хүний үйл ажилагаанаас үүдэж, олон хүний амь хохироход хүргэдэг байна. Мэргэжлийн гал сөнөөгчдийг хувийн хамгаалах хэрэгсэл, техник төхөөрөмжөөр хангахгүй байгаа нь тэд ч амиа алдахад хүргэдэг. Ойн түймэр нь ойн доройтлын нэг гол шалтгаан болж (Зураг 13.3) биологийн бусад нөлөөллөөс хавьгүй илүү хохирол учруулдаг байна.

*Хүний хүчин зүйл, технологийн гаралтай гамшиг*

Монгол Улс хүний хүчин зүйл, технологийн гаралтай хэд хэдэн аюултай гамшигтай тулгарч байна. Тэдгээр нь хүний амь, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчин, нийгэм, эдийн засагт үлэмж хохирол учруулдаг байна (Зураг 14.4).

**Зураг 14.4: Хүний хүчин зүйл, технологийн гаралтай гамшигийн тоо, 2000-2014 он**



Эх сурвалж: Онцгой байдлын ерөнхий газар, 2017 он.

Тайлбар: Хүний хүчин зүйл, технологийн гаралтай гамшигт барилга байгууламжийн түймэр, аж үйлдвэрийн болон замын хөдөлгөөний осол, химийн болон цацраг идэвхт бодисын тархалт, хүний болон малын халдварт өвчнийг оруулсан.

Барилга байгууламжийн гал түймэр

Барилга байгууламжийн түймэр 2005-2015 онд 33,500 гаруй удаа гарсан байна (харьцуулбал, мөн хугацаанд нийт 2,132 ой, хээрийн түймэр бүртгэгджээ).

Химийн бодис алдагдах, аж үйлдвэрийн бусад осол

Химийн бодисын менежмент ерөнхийдөө сайжирсан боловч Монголд мэргэжлийн байгууллагууд, олон нийтийн мэдлэг туршлага хязгаарлагдмал байгаа нь нэлээд бэрхшээл учруулсан хэвээр байна. Химийн хорт бодисын аюул гамшигтай тэмцэх улсын хэмжээний чадвар, бэлтгэл туйлын дорой байгаа нь 2007 онд Дархан-Уул аймгийн Хонгор суманд химийн бодисын хордолтод олон хүн өртсөн тохиолдол харуулсан байна.

Мал, амьтны өвчин, гоц халдварт өвчин

Монгол улсын улсын малын тоо 2016 оны байдлаар 61 саяд хүрч, нян, бактерийн гаралтай мал, амьтны гоц халдварт өвчин эдийн засгийн үлэмж хохирол учруулах явдал гарсаар байна. Малын халдварт өвчин нь хүнд халдварлах боломжтой, хөдөөгийн айл өрхүүд түүхий махтай харьцаж байдгийн хувьд малын өвчин нийгмийн эрүүл мэндэд ноцтой аюул эрсдэлтэй. Шүлхий, галзуу, адууны болон тэмээний

томуу, шувуу, гахайн томуу, боом зэрэг өвчин хамгийн түгээмэл байна. Шүлхий байнга гарч, хонь, ямаа, тэмээ, үхэр зэрэг салаа туурайт малд хохирол учруулдаг. Шүлхий төл малын хорогдолд голдуу нөлөөлдөг бөгөөд цагаан зээр зэрэг зэрлэг амьтанд халдварласан нөхцөлд шүлхий өвчинд хяналт тогтооход нэлээд бэрхшээлтэй болдог байна. Иймд Монголд өргөн хүрээний хяналт судалгаа, сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

## 14.2 Гамшгийн эрсдлийн менежмент

### *Гамшгийн эрсдлийн үнэлгээ*

БСШСЯ сургууль, цэцэрлэгүүдийн барилга байгууламжийн ашиглалтын аюулгүй байдлын үнэлгээг 2012 онд хийж, 97 барилгыг шинэчлэх шаардлагатай, 120 барилга сургуулийн барилгын ашиглалтын стандартад нийцэхгүй байгааг тогтоосон байна.

ОБЕГ 2015, 2016 онд Улаанбаатар хотын Боловсролын газартай хамтран, Дэлхийн банкны “Монгол дахь гамшгийн эрсдлийг бууруулах чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд төрийн 55 сургууль, цэцэрлэгийн барилгын аюулгүй байдлын нарийвчилсан үнэлгээ хийжээ. Мөн Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотын үерийн гамшгаас хамгаалах газрын зургийг 2014 онд боловсруулжээ.

Түүнчлэн зарим дүүрэг, сумдын гамшгийн эрсдлийн үнэлгээг орон нутгийн эрсдлийн үнэлгээний аргачлалд үндэслэн хийсэн байна. ОБЕГ Монгол дахь Дэлхийн зөн байгууллагатай хамтран АНУ-ын ОУХАБ-ын санхүүжүүлсэн “Монголын баруун аймгуудын гамшгийн эрсдлийг бууруулах төсөл”-ийн хүрээнд баруун аймгуудын гурван сум, хоёр сургуулийн барилгын гамшгийн эрсдлийн үнэлгээг гаргажээ. Мөн НҮБХХ-өөс “Монголын орон нутгийн гамшгийн эрсдлийг бууруулах, чадавхийг бэхжүүлэх, менежмент, зохицуулалтыг сайжруулах төсөл”-ийг 2014-2016 онд хэрэгжүүлж, 5 аймгийн 11 сум, Улаанбаатар хотын 2 хороонд гамшгийн эрсдлийн үнэлгээг хийжээ.

### *Гамшгийн эрт зарлан мэдээлэх систем*

#### Өргөн нэвтрүүлэг

Монгол Улсын Засгийн газар айл өрхүүдийн 50-иас доошгүй хувийг хямд радио өргөн нэвтрүүлгийн сувагт холбох, алслагдсан бүсүүдийн айл өрхийн 40 хувийг радио өргөн нэвтрүүлгийн сүлжээнд холбох зорилгоор Үндэсний өргөн нэвтрүүлгийн 2011-2015 онуудад хэрэгжүүлэх хөтөлбөрийг 2011 онд хэрэгжүүлж эхэлсэн байна.

#### Газар хөдлөлтийн тухай шуурхай зарлан мэдээлэх систем

“Газар хөдлөлтийн зарлан мэдээлэх систем” төслийг 2012-2014 онд хэрэгжүүлжээ. Төслийн хүрээнд МХТ-ийн дэвшилтэт системийг ашиглан төр засаг ард иргэдийг газар хөдлөлт, үер зэрэг гамшгаас хамгаалах газар хөдлөлтийн гамшгаас сэрэмжлүүлэх, зарлан мэдээлэх системийг боловсруулсан байна (Шигтгээ 14.1).

### *Гамшгийн эрсдлийг бууруулах (ГЭБ), газар ашиглалтыг бүсчлэх арга хэрэгсэл*

Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх 2014 оны мастер төлөвлөгөө, хөгжлийн чиг хандлагад хотын газар ашиглалтын шинэ бүсчлэлийн системийг нэвтрүүлэхээр тусгасан байна. Шинэ системээр Улаанбаатар хотын бүх газар нутгийг хамаарч орон сууц, олон нийтийн, худалдааны, үйлдвэрлэлийн, ногоон байгууламж, холимог, инженерийн шугам сүлжээ, зам тээврийн болон тусгай зориулалтын 7 бүсэд хуваасан байна. Хотын бүсчлэл нь Улаанбаатарын хөгжлийг удирдах, хяналт тогтоох гол арга хэрэгсэл болох юм.

Газар ашиглалтын шинэ бүсчлэл нь Улаанбаатарын төлөвлөлтийн гол асуудлууд, тухайлбал i) Улаанбаатар хотын бүтэц, зохион байгуулалт, хилийн системчилсэн тогтолцоог бүрдүүлэх; ii) хотын төлөвлөлтгүй тэлэлтийг зогсоох; iii) нийтийн эзэвшлийн задгай талбайг хамгаалах; iv) бүсчлэлийн тусгай систем тогтоохгүйгээс газар ашиглалт, хөгжлийн стандартыг боловсруулах, мөрдүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг арилгах; v) түүх соёлын дурсгалыг хадгалах; vi) газар ашиглалт, хяналт, менежментийн тогтолцоог бүрдүүлэх зэрэг асуудлыг зохистой шийдвэрлэхэд ач холбогдолтой.

**Шигтгээ 14.1: Газар хөдлөлтийн гамшгаас Сэрэмжлүүлэн мэдээлэх систем**

“Газар хөдлөлтийн гамгаас сэрэмжлүүлэн мэдээлэх систем” төслийг 2012-2014 онд Засгийн газрын санхүүжилтээр ОБЕГ хэрэгжүүлжээ. БНСУ-ын КТ телехолбооны компани түншээр ажилласан байна. Төслийн эхний үе шатыг 2013 онд дуусган, түүний хүрээнд хяналтын төв, дуут дохиоллын 40 цамхаг, телевизийн 3, радиогийн 5 системийг байгуулсан байна. Газар хөдлөлтийн хяналтын хөдөлгөөнт төв, хяналтын мэдрүүрүүд, дуут дохиоллын 20 цамхаг нэмж байгуулах төслийн 2 дахь үе шатыг 2014 онд амжилттай хэрэгжүүлсэн. Энэ систем нь дамжуулагчийн мэдээллийг цуглуулж шинжилгээ хийж, гамшиг тохиолдох үед холбогдох бүх байгууллагыг радио, эсвэл утсан сүлжээг ашиглан гамшгийн аюулыг зарлан мэдээлнэ.

Аюул гамшгийн тухай зарлан мэдээлэх арга хэлбэрт дуут дохиоллын цамхаг, телевиз, радиогийн онцгой байдлын зарлан мэдээлэх суваг, үүрэн утасны операторуудын зарлан мэдээлэх систем хамрагдана. Гамшиг тохиолдсон үед эдгээр сувгаар аюулын дохиог ард иргэдэд 30 секундэд багтаан хүргэх боломжтой. Энэ систем нь Одон орон, геофизикийн судалгааны төв, Цаг уур, орчны шинжилгээний газраас гамшгийн мэдээллийг ОБЕГ-ын Хяналтын төвийн тусгай шугам, хяналтын механизмаар дамжуулан авч, гамшгийн аюулын дохиог дуут дохиоллын цамхаг, телевиз, радиогийн онцгой байдлын зарлан мэдээлэх суваг, үүрэн утасны операторуудын зарлан мэдээлэх системд дамжуулдаг байна.

*Эх сурвалж:* Монгол дахь Гамшгийн эрсдлийн менежментэд мэдээлэл, холбооны технологийн үүргийг нэмэгдүүлэх, цахим хэрэглээг бий болгох төсөл, АНДЭЗНЗ, 2016 он.

**14.3 Хууль, эрх зүй, бодлого, бүтэц зохион байгуулалтын тогтолцоо***Хууль, эрх зүйн тогтолцоо*

Гамшгаас хамгаалах тухай 2003 онд баталсан хуулиар (одоо хүчин төгөлдөр бус) гамшгаас сэргийлэх, авран туслах, үр дагаврыг арилгах үйл ажиллагааг зохицуулсан байна. Тус хуулинд дайн болон үйл олноор устгах зэвсгийн үр дагаврыг хамруулаагүй ажээ. Хуульд төр, орон нутгийн захиргаа, бусад байгууллага, иргэдийн эрх үүрэг, төр засаг, аймаг, нийслэл хот, сум, дүүрэг, баг, хорооны түвшин дахь гамшгаас хамгаалах байгууллагын бүтэц, удирдлагын тогтолцоо, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төсвийн эх үүсвэр зэргийг тодорхойлж өгсөн байна. Төрийн үйл ажиллагааг нэгдсэн төсвөөс санхүүлэх, орон нутгийн төсвийг аймаг, нийслэл хот, сум, дүүрэг, баг, хорооны түвшингийн үйл ажиллагаанд зарцуулахаар тусгажээ.

Гамшгаас хамгаалах тухай 2017 онд шинэчилсэн хуульд эмзэг байдал, олон талт гамшгийн эрсдлийн үнэлгээ хийхийн ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн байна. ОБЕГ-аас олгосон тусгай гэрчилгээ бүхий хуулийн этгээдүүд гамшгийн эрсдлийн үнэлгээ хийх эрхтэй бөгөөд ОБЕГ-аас энэ үйл ажиллагаанд хяналт тавина. Хуульд гамшгийн эрсдлийг бууруулах, сэргийлэх, хүмүүнлэгийн үйл ажиллагааны зохицуулалт, үр дагаврыг арилгах, сэргээн босгох чиглэлийн үйл ажиллагааг бэхжүүлэхээр зааж, олон улсын хамтын ажиллагаа, том хэмжээний гамшиг тохиолдсон үеийн гадаадын тусламжийг авах, зохицуулах үйл ажиллагааг тусгасан байна. 2017 онд шинэчилсэн хуульд гамшгийн менежментийн тогтолцоонд олон тооны нааштай өөрчлөлтийг оруулжээ. Үүнд:

- Монголын гамшгийн нэр томъёог олон улсын ГЭМ-ийн нэр томъёотой нийцүүлсэн;
- Гамшгаас сэргийлэх үйл ажиллагааны шат дарааллыг нэн тодорхой болгосон;
- ГЭБ үндэсний болон орон нутгийн тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн;
- Гамшгийн үеийн дотоодын болон олон улсын тусламжийн зохицуулалтыг онцолсон;
- ГЭБ үйл ажиллагаанд оролцох талууд, төр засгийн агентлагууд, ТББ, хувийн хэвшил, сайн дурынхан, иргэдийн үүрэг, хариуцлага, мандатыг нэн тодорхой болгосон;
- ГЭБ үйл ажиллагааны албан ёсны санхүүжилтийг төр засаг, орон нутгийн захиргааны байгууллагууд, хуулийн этгээдэд олгохыг хуулиар зохицуулсан.

Гамшгаас хамгаалах тухай 2017 онд шинэчилсэн хуулиар гамшгийн эрсдлийг бууруулах, төр, хувийн хэвшил, салбар хоорондын байгууллага, иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг хангах, бодлогын зөвлөмж гаргах үүрэг бүхий үндэсний болон орон нутгийн зөвлөлүүдийг байгуулжээ.

Аймаг, сумдын засаг дарга нар мэргэжлийн 50-60 хүний бүрэлдэхүүнтэй Гамшгаас хамгаалах алба байгуулах, тэднийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулахыг хуульд тусгасан. Хуульд гамшгийн эрсдлийн менежментийн үйл ажиллагаанд дахь иргэд, олон нийт, хувийн хэвшил, ТББ-уудын эрх үүрэг, оролцоог тодорхойлсон заалтыг нэмж оруулсан байна. 2017 онд шинэчилсэн хуульд Сендайн үйл ажиллагааны хүрээний тэргүүлэх 4 чиглэл, дэлхийн 7 зорилгыг тусгасан ба ГЭБ нь цаашдын хөгжилд нэн чухал болохыг онцолсон байна.

Хуулийн хэрэгжилтийг Гамшгийн эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ хийх журам (ЗГ-ын 2006 оны 176 дугаар тогтоол); Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх журам (ЗГ-ын 2011 оны 339 дүгээр тогтоол); Гамшгийн үед нөөц, хүч хэрэгсэл дайчлах, шилжин нүүлгэх журам (ЗГ-ын 2011 оны 340 дүгээр тогтоол); Галын аюулгүй байдлын үндсэн журам (ЗГ-ын 2016 оны 339 дүгээр тогтоол); Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам (ОБЕГ-ын даргын 2016 оны А/185 тоот тушаал); Улсын онцгой байдлын хорооны журам (ЗГ-ын 2017 оны 152 дугаар тогтоол); Гамшгаас хамгаалах мэргэжлийн тусгай ангийн журам (Шадар сайдын 2017 оны 75 тоот тушаал) зэрэг хууль тогтоомж, баримт бичгээр хангаж байна.

#### *Бодлогын тогтолцоо*

#### 2016 оны Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал- 2030

2016 оны Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал- 2030 баримт бичигт үндэсний тэргүүлэх чиглэлийг “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхийг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ” гэж тодорхойлжээ.

#### 2010 оны Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

2010 оны Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (УИХ-ын 2010 оны 48 дугаар Тогтоол) байгалийн болон хүний үйл ажиллагаа, технологийн аюул гамшгийн эрсдэлийн менежментэд онцгой анахаарал хандуулахыг зааж өгсөн байна.

#### 2011 оны Гамшгаас хамгаалах төрийн бодлого, хөтөлбөр

2011 оны Гамшгаас хамгаалах төрийн бодлого, хөтөлбөр нь (УИХ-ын 2011 оны 22 дугаар тогтоол) гамшгийн менежментийн тогтолцоог бэхжүүлэх зорилготой. Энэхүү бичиг баримт нь Гамшгаас хамгаалах төрийн бодлого, Гамшгаас хамгаалах чадавхийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрөөс бүрдэх гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний чухал стратеги юм.

Гамшгаас хамгаалах төрийн бодлогод дараах стратегийн зорилгуудыг тусгажээ:

- Гамшгийн менежментийн тогтолцоог бэхжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд улсын болон орон нутгийн захиргаа, агентлагууд, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийг идэвхтэй татан оролцуулахад дэмжлэг үзүүлэх;
- Байгалийн, хүний хүчин зүйлийн гаралтай, техникийн гамшгийн эрсдлийн үнэлгээг төрөл тус бүрээр гаргах, гамшигт эмзэг байдлыг бууруулах арга хэмжээг үндэсний түвшинд зохион байгуулах;
- Гамшгийн үеийн хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт, эрх зүй болон хууль тогтоомжийн орчинг сайжруулах, даатгалд хамруулах, гамшгийн хамгаалалтад төр засаг, хувийн хэвшлийн хувь нэмрийг нэмэгдүүлэх, гамшгийн нэр томъёог нийтээр хүлээн зөвшөөрөх, ойлгох явдлыг дэлгэрүүлэх;
- Болзошгүй аюул гамшгийн, аюулт үзэгдлийн үнэлгээ, урьдчилсан тооцоолоход дэвшилтэт технологи, аргачлалыг нэвтрүүлэх, мэдээллийг түгээх үр бүтээмжтэй, найдвартай механизм бүрдүүлэхийн тулд шуурхай сэрэмжлүүлэх, зарлан мэдээлэх системийг боловсронгуй болгох;
- Гамшгийн үр дагаврыг арилгах хүний болон техникийн нөөцийн чадавхийг бэхжүүлэх.

Гамшгаас хамгаалах чадавхийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрт дээрх стратегийн зорилгуудыг хоёр үе шаттайгаар 2011-2015, 2015-2020 онуудад хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээнүүдийг тусгажээ.

Засгийн газар 2012 онд Гамшгаас хамгаалах төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж (ЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоол), хэрэгжилтийг жил тутам дүгнэж байна.

#### 2015 оны Гамшгийн эрсдлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр

2015 оны Гамшгийн эрсдлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр нь (ЗГ-ын 2015 оны 303 дугаар тогтоол) 2015-2025 оныг хамаарч, Гамшгаас хамгаалах төрийн бодлогын хэрэгжилтийг хангах, үүнд орон нутаг, ард иргэд, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд, эмзэг бүлгийнхэн, бага орлоготой, ядуу хүмүүсийг хамгаалах чадавхийг бэхжүүлэх зорилго тавьжээ.

Хөтөлбөрийн гол зорилго нь орон нутаг, ард иргэдийг гамшгаас сэргийлэх үйл ажиллагаанд татан

оролцуулах, сургалт зохион байгуулах замаар тэдний мэдлэг чадвар, мэдээллийг дээшлүүлэх, амьдралын аюулгүй орчин, соёлыг бүрдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхийг бэхжүүлэхэд оршино. Хөтөлбөр нь:

- Гамшигийн эрсдлийг олон нийтийн оролцоотой бууруулах үйл ажиллагааны эрх зүйн орчин, тогтолцоог бүрдүүлэх;
- ГЭБ сургалт, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх ажлыг бүх түвшинд зохион байгуулах;
- Гамшигийн эрсдлийг олон нийтийн оролцоотой бууруулах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх;
- Уур амьсгал, ус, цаг агаарын гамшгаас сэргийлэх шуурхай сэрэмжлүүлэх, зарлан мэдээлэх системийг сайжруулах;
- Ард иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхийг бэхжүүлэх зэрэг стратегийн зорилгуудыг дэвшүүлсэн байна.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2016 онд батлан гаргажээ (Шадар сайдын 2016 оны 50 тоот тушаал).

#### 2011 оны Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (УАӨҮХ)

Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийг (УАӨҮХ) 2011 онд шинэчлэн 2011-2021 онуудад хэрэгжүүлж байна (УИХ-ын 2011 оны 2 дугаар тогтоол). Хөтөлбөрт уур амьсгалын системтэй ажиглалт, хяналт мониторинг хийх, уур амьсгалын өөрчлөлтийн хувилбаруудыг боловсруулах, эмзэг байдал болон эрсдлийн үнэлгээ хийх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох боломжит арга хэмжээ авах асуудлыг тусгажээ (Бүлэг 7).

#### Бодлогын бусад баримт бичиг

Бодлогын бусад баримт бичигт 2015 оны Гамшигийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө (ЗГ-ын 2015 оны 416 дугаар тогтоол); 2016 оны Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээ (УИХ-ын 2016 оны 34 дүгээр тогтоол); Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээг хэрэгжүүлэх 2016 оны төлөвлөгөө (ЗГ-ын 2016 оны 282 дугаар тогтоол); 2016 оны Гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээний нийтлэг журам (ЗГ-ын 2016 оны 97 дугаар тогтоол); 2016 оны Гамшигийн менежментийн сайн дурын оролцооны нийтлэг журам (шадар сайдын 2016 оны 34 дүгээр тушаал) орж байна.

#### Гамшигийн эрсдэлийг бууруулах 2015-2030 онд хэрэгжих стратегийн төсөл

ГЭБ 2015-2030 онуудад хэрэгжих стратегийн төсөл, мөн 2017-2020 онд ГЭБ дунд хугаацааны үндэсний төлөвлөгөөг 2015-2030 онд Гамшигийн эрсдлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээний тэргүүлэх 4 чиглэл, дэлхийн 7 зорилгод үндэслэн боловсруулсан байна. Баримт бичгүүдийг Засгийн газраар батлуулахаар 2017 оны 5 дугаар сард өргөн барьжээ.

#### *Гамшигийн эрсдэлийг бууруулах бодлогод уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг тусгасан байдал*


Дэлхийн хэмжээний 2015 онд баглагдсан гурван суурь баримт бичиг болох 2015-2030 онд Гамшигийн эрсдлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ, 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Парисын хэлэлцээр нь хоорондоо нягт уялдаатай, нийтлэг зорилго, үзүүлэлттэй баримт бичгүүд юм. Уур амьсгалын өөрчлөлт, гамшигийн эрсдлийг нэгтгэн шийдвэрлэх, тогтвортой хөгжлийг зөвхөн эрсдлийг бүрэн тооцсон нөхцөлд хангах боломжтой гэдэгт БОАЖЯ, ОБЕГ нэгдмэл ойлголт, байр суурьтай байна.

Гамшигийн эрсдлийн менежмент, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тогтвортой хөгжлийн харилцан уялдааны талаар тодорхой ойлголттой байгаа хэдий ч энэ харилцан уялдаа, байгууллага хоорондын зохицуулалтыг бодит байдалд хангах ажил зарим саад бэрхшээлтэй тулгарч байна. ГЭМ, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааг санхүүжүүлэхийн чухал ач холбогдлыг Засгийн газар мэдэрч, улсын чадавхийг бэхжүүлэхэд оруулах хөрөнгийг нэмэгдүүлэхээр тооцож байна. Хөрөнгө оруулалтыг төвлөрүүлэхээр төлөвлөж байгаа гол салбаруудад эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, ХАА, хот байгуулалт, онцгой байдал, гамшигийн үр дагаврыг арилгах, нөхөн сэргээх салбар орж байна.




## Энэхүү бүлэгтэй холбоотой Тогтвортой хөгжлийн зорилт, зорилгууд

2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн Зорилт 1.5, 11.5, 11.6 -ын хэрэгжилтийн явцыг Шигтгээ 14.2-г харуулав.



**1** ЯДУУРЛЫГ  
УСТГАХ

**Шигтгээ 14.2: Тогтвортой хөгжлийн 2030  
хүртэлх хөтөлбөрийн Зорилт 1.5, 11.5 болон 11.6**



**11** Залтэй хот,  
иргэдийн бодлогод  
дэмжих

**Зорилго 1. Ядуурлын бүх хэлбэрийг бүрэн устгах**  
**Зорилт 1.5: 2030 он гэхэд ядуу, эмзэг байдалд байгаа хүмүүсийн дархлааг бэхжүүлэх, уур амьсгалын холбоотой онцгой нөхцөл, эдийн засаг, нийгэм, байгаль орчны гамшиг, аюулд өртөх эмзэг байдлыг бууруулах.**

Энэ зорилтыг үнэлэх дэлхийд хүлээн зөвшөөрсөн шалгуур үзүүлэлтүүдэд гамшгийн улмаас 100,000 хүн тутамд ноогдох нас барсан, алга болсон, гамшигт өртсөн хүний тоо (шалгуур үзүүлэлт 1.5.1), дэлхийн ДНБ-тэй харьцуулсан эдийн засгийн бодит хохирол (шалгуур үзүүлэлт 1.5.2), гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний болон орон нутгийн стратегитай улсын тоо (шалгуур үзүүлэлт 1.5.2) орно.

Монгол Улсын Байгалийн болон хүний хүчин зүйлийн гаралтай гамшгийн мэдээллийн товхимлоос (2014, 2015 он) үзвэл байгалийн, хүний хүчин зүйлийн гаралтай гамшгийн улмаас дундаж нас баралт 2000-2015 онд жилд 186 байв. Нийт нас баралтын 51 гаруй хувь нь хүний хүчин зүйлийн гаралтай гамшиг, 31.7 хувь нь барилга байгууламжийн түймэрт ноогдож байна. Байгалийн, хүний хүчин зүйлийн гаралтай гамшгийн эдийн засгийн дундаж шууд хохирол 2000-2015 онд жилд 89.0 тэрбум төгрөг болж, ДНБ-ний 3 хувьтай тэнцэж байна.

Үндэсний түвшинд Гамшгаас хамгаалах төрийн бодлого, хөтөлбөрийг 2011 онд баталсан, Сендайн үйл ажиллагааны хүрээтэй нийцүүлэн 2015-2030 онд гамшгийн эрсдлийг бууруулах шинэ стратегийг боловсруулж байна.

Зорилго 1.5 -ыг биелүүлж, ядуу хүмүүсийн дархлаат байдлыг бэхжүүлэх, ГЭБ үйл ажиллагааг хөгжлийн стратегийн суурь болгохын тулд Засгийн газар нь дараах арга хэмжээ хэрэгжүүлвэл зохино:

- Гамшгийн эрсдэл, эмзэг байдал, чадавхи, гамшгийн шинж байдал, үзүүлэх нөлөөллийн (эрсдлийн дүр зургийг тогтоох) үнэлгээ хийх;
- Эрсдлийн мэдээллийн системийг байгуулах, холбогдох мэдээ мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ менежмент хийх, ашиглах, түгээхэд дэмжлэг үзүүлэх, Газар зүйн мэдээллийн систем (ГЗМС), мэдээлэл холбооны технологи, инновацийг ашиглах;
- Бизнес явуулж буй өөрийн байршилдаа орон нутгийн эрсдлийн үнэлгээ хийхийг урамшуулах, гамшгийн өртөлт, эмзэг эрсдэлтэй байдлыг нарийвчлан тогтоох;
- ГЭМ, хөгжлийн бодлого хоорондын уялдааг бэхжүүлэх арга хэмжээ авах;
- Үндэсний болон орон нутгийн түвшинд чадавхи, удирдлагыг бэхжүүлэх.

**Зорилго 11. Хот, суурин газруудын тэгш, хүртээмжтэй, аюулгүй, тогтвортой хөгжлийг дэмжих**  
**Зорилт 11.5. 2030 он гэхэд гамшиг, тухайлбал устай холбоотой гамшгийн улмаас нас барсан, хохирсон хүмүүсийн тоо, дэлхийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд үзүүлэх эдийн засгийн шууд хохирлыг ихээхэн бууруулах, ингэхдээ ядуу болон эмзэг байдалд байгаа хүмүүсийг хамгаалахад анхаарал хандуулах.**

Энэ зорилгыг үнэлэх дэлхийд хүлээн зөвшөөрсөн шалгуур үзүүлэлтүүдэд гамшгийн улмаас 100000 хүн тутамд нас барсан, алга болсон, гамшигт өртсөн хүний тоо (шалгуур үзүүлэлт 1.5.1), дэлхийн ДНБ-тэй харьцуулсан эдийн засгийн бодит хохирол, чухал дэд бүтцэд учруулсан хохирол, үндсэн үйлчилгээ тасалдсан тоо (шалгуур үзүүлэлт 1.5.2), гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний болон орон нутгийн стратегитай улсын тоо (шалгуур үзүүлэлт 1.5.2) хамаарна.

Монголд 2011 оны Гамшгаас хамгаалах төрийн бодлого, хөтөлбөр, 2015-2025 онд Гамшгийн эрсдлийг бууруулах 2015 оны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлсний дүнд ГЭМ үйл ажиллагаа нь гамшгийн улмаас учирч буй нас баралт, эдийн засгийн шууд хохирол буурах хандлагатай байна.

Энэ зорилгыг биелүүлэхийн тулд Засгийн газар нь дараах арга хэмжээ хэрэгжүүлвэл зохино:

- Орон нутгийн захиргаа орон нутгийн түвшинд гамшигийн эрсдлийн менежментийн асуудлаар иргэний нийгэм, орон нутгийн ард иргэдтэй хамтран ажиллах, зохицуулалт хийх эрх зүйн болон санхүүгийн тогтолцоог бүрдүүлэх;
- Төрийн, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт хийх шийдвэрт гамшигийн эрсдлийн арга хэмжээг тусгасны шууд болон шууд бус урамшууллыг тогтоох;
- Уян хатан байдлыг бэхжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг хангах;
- Гамшигийн үр дагаврыг арилгах, шуурхай нөхөн сэргээлтийн ажлын хангалттай санхүүжилтийг цаг алдалгүй олгох, бодит хохирлын хэмжээг бууруулах;
- Гамшигийн үр дагаврыг арилгах асуудлыг гамшгаас сэргийлэх төлөвлөгөөнд тусгахыг дэмжих, гамшигтай тэмцэх хүчин чармайлтыг хүний урт хугацааны хөгжлийн зорилттой уялдуулах;
- Ядуу хүмүүст гамшигийн дараах тусламж үзүүлэх механизмыг боловсруулах.

Зорилт 11.6. 2020 он гэхэд Гамшигийн эрсдлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээний гамшигийн эрсдлийн бүх түвшний менежментийг боловсруулан хэрэгжүүлэх, баталгаатай, нөөцийг үр ашигтай зарцуулдаг, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвартай, гамшигт тэсвэртэй байх цогц бодлого, төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлдэг хот, суурингуудын тоог ихээхэн нэмэгдүүлэх.

Энэ зорилтыг үнэлэх дэлхийд хүлээн зөвшөөрсөн шалгуур үзүүлэлтүүдэд 2015-2030 онд Гамшигийн эрсдлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээний дагуу гамшигийн эрсдлийг бууруулах үндэсний стратегийг батлан хэрэгжүүлж буй улсын тоо (шалгуур үзүүлэлт 11.b.1), үндэсний стратегийг үндэслэн орон нутгийн гамшигийн эрсдлийг бууруулах стратегийг батлан хэрэгжүүлж буй орон нутгийн захиргааны хувь (шалгуур үзүүлэлт 11.b.2) хамаарна.

1990-ээд оноос Монголд хөдөөгөөс хотруу чиглэсэн шилжилт хөдөлгөөн, хотжилт эрчимжив. Нэг үеийн өмнө монголын хүн амын дийлэнх нь нүүдэлчин малчид байсан бол өнөө хүн амын дийлэнх нь хот суурин, уул уурхайн төвүүдэд амьдарч байна. Хөдөөгөөс хотруу чиглэсэн шилжилт хөдөлгөөн нь төвлөрсөн эдийн засгаас зах зээлийн эдийн засагт хурдацтай шилжсэний дүнд хот сууринд эдийн засгийн ажил нөхцөл нэмэгдсэнтэй холбоотой. Гадаад руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн ч өсч байна. Түүнчлэн хөдөө орон нутагт мал маллаж амьдрах нөхцөл олон жилийн зуд, гангаас хүндэрсний улмаас хүмүүс хот сууринд шилжих нь эрс өссөн байна. Хот суурины эрчимтэй тэлэлт голдуу ямар ч төлөвлөлтгүй явагдаж байгаа нь хөгжлийн олон сорилт, тухайлбал үндсэн үйлчилгээний хүртээмж дорой, хотын захын дүүргүүдийн өвлийн улирлын агаарын өндөр бохирдол зэрэг бэрхшээлийг үүсгэж байна.

Зорилт 11.b.1 –ийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол улс Сендайн үйл ажиллагааны хүрээтэй уялдуулан 2015-2030 онуудад хэрэгжүүлэх Гамшигийн эрсдлийн бууруулах үндэсний шинэ стратеги боловсруулах ажлыг хийж байна.

Зорилт 11.b.2 –ийг хэрэгжүүлэх хүрээнд 2015 онд Монгол улсын гурван хот, Дархан, Улаанбаатар, Эрдэнэт нь НҮБ-ын ГЭБ газраас зохицуулдаг “Хотын дархлааг сайжруулах: Миний хот бэлэн байна” Дэлхийн кампанит хөдөлгөөнд албан ёсоор нэгдсэн. Эдгээр хотууд ГЭБ асуудлыг орон нутгийн хөгжлийн бодлого, хотын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, гамшигийн эрсдлийг бууруулах хөрөнгө оруулалтыг өсгөх талаар идэвхтэй ажиллаж байна. 2015-2030 оны ГЭБ үндэсний стратегийн төсөлд Дэлхийн кампанит хөдөлгөөнд нэгдсэн монголын хотуудын тоог нэмэгдүүлэхээр заасан байна.

Өнөөгийн байдлаар 116.2 үзүүлэлтийн талаар тодорхой мэдээ мэдээлэл байхгүйн улмаас Монгол Улс нь Зорилго 116-ийн биелэлтийг дүгнэх боломжгүй байна. Энэ үзүүлэлтийн суурь мэдээллийг орон нутгийн захиргаанд асуулт-хариултын судалгаа хийх хэлбэрээр бүрдүүлж болно.


Зорилт 11.6 -ыг биелүүлэхийн тулд Засгийн газар нь дараах арга хэмжээ хэрэгжүүлвэл зохино:

- Орон нутагт кампанит ажил зохион байгуулах, 2020 он гэхэд орон нутгийн хэмжээнд ГЭБ, ГЭМ, уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицох стратеги, төлөвлөгөөг боловсруулах ажлыг төлөвшүүлэх замаар Сендайн үйл ажиллагааны хүрээний талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх. Эдгээр стратеги, төлөвлөгөө нь орон нутгийн эрсдлийн нарийвчилсан үнэлгээ, гамшигт хяналт мониторинг хийх, эмзэг байдлыг тогтоох захиргааны чадавхид суурилсан байх ёстой;
- ГЭМ-ийн арга хэмжээг хэрэгжүүлэх нөөц зардлыг орон нутгийн захиргаанд хуваарилах;
- Орон нутгийн захиргаа, иргэний нийгэм, сайн дурын байгууллагууд, нутгийн ард иргэдэд суурилсан байгууллагуудын удирдлага, чадавхийг дээшлүүлэх;
- Орон нутгийн захиргаа хоорондын хамтын ажиллагаа, харилцан суралцах үйл ажиллагааг дэмжих.

### *Бүтэц зохион байгуулалтын тогтолцоо*

Монгол улсын гамшгаас хамгаалах бүтэц зохион байгуулалтын тогтолцоог Зураг 14.5-д харуулав.

## Зураг 14.5: Гамшгаас хамгаалах бүтэц зохион байгуулалтын тогтолцоо



Эх сурвалж: ОБЕГ, 2017 он.

Тайлбар: \* 2017 онд шинэчилсэн Гамшгаас хамгаалах тухай хуульд ГЭБ үндэсний хороо байгуулахаар тусгасан. Шаардлагатай нэмэлт хууль тогтоомж батлагдаагүйн улмаас 2017 оны дунд гэхэд тус хороо байгуулагдаагүй байв. \*\* Улс, аймаг, нийслэл хот, сум, дүүргийн түвшинд “гамшгаас хамгаалах алба” гэдэгт хуулиар тухайн түвшинд гамшгаас хамгаалах үүрэг хүлээсэн төрийн бүх нэгжийг хэлнэ.

Гамшгийн менежменттэй холбоотой асуудлыг улс төрийн хамгийн дээд түвшинд шийдвэрлэх байгууллага бол Үндэсний аюулгүй байдлын зөвлөл байна. Мөн Газар хөдлөлтийн үндэсний зөвлөлийг 2016 онд байгуулж, түүний ажлын төлөвлөгөөг Засгийн газар баталсан байна (ЗГ-ын 2016 оны 282 дугаар тогтоол).

#### Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ)

ОБЕГ-ыг Иргэний хамгаалалтын газар, Гал сөнөөх газар, Үндэсний нөөцийн газрыг нэгтгэн 2004 онд байгуулжээ. ОБЕГ нь Шадар сайдад шууд харьяалагддаг, гамшгаас хамгаалах, гамшгийн нөлөөллийг бууруулах, онцгой байдлын менежмент, бэлэн байдлыг хангах гол агентлаг юм. ОБЕГ нь ГЭБ бодлого боловсруулах, ард иргэдийг гамшгаас хамгаалах, уян хатан байдлыг бий болгох үүрэгтэй. ОБЕГ-ын үүргийг 2017 онд шинэчилсэн Гамшгаас хамгаалах тухай хууль, 2015 онд шинэчилсэн Галын аюулгүй байдлын тухай хууль, 2012 онд шинэчилсэн Ойн тухай хууль, 2007 оны Төрийн нөөцийн тухай хуулиар зохицуулдаг байна.

ОБЕГ-ын үйл ажиллагааны чадавхи сүүлийн 5 жилд бүх түвшинд сайжирчээ. Дотоодод сургалт явуулахын зэрэгцээ НҮБХХ, НҮБГЭБА, НҮБХХЗГ, ЖАЙКА, АХБ, ДБ, Азийн гамшгийн бэлэн байдлын төв зэрэг олон улсын байгууллагуудын санхүүгийн болон техникийн тусламжтайгаар хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх системчилсэн сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлжээ.

ОБЕГ-ын мэргэжлийн чадавхи, ялангуяа эрэн хайх, авран туслах ажиллагаа мөн сайжирсан. Хувийн хамгаалах хэрэгсэл, хорт материалтай харьцах багц, гал сөнөөх болон аврах хэрэгслийг НҮБ-ын төрөлжсөн агентлагууд болон хүмүүнлэгийн байгууллагуудаас хандивласан байна.

ОБЕГ-ын харьяа Гамшиг судлалын хүрээлэн нь Монгол орон даяар олон талт гамшигийн эрсдлийн үнэлгээ гаргах үүрэгтэй хэдий ч цөөн салбарын эрсдлийн үнэлгээг хийж байна.

ОБЕГ нь офицерын бүрэлдэхүүнийг оролцуулан (аврагч, гал сөнөөгч) 3,200 орчим ажилтантай, тэд нар орон нутгийн онцгой байдлын хэлтэс (сум, дүүрэг), онцгой байдлын газарт (аймаг, нийслэл хот) алба хашдаг. Гамшиг тохиолдсон үед ОБЕГ нь удирдлага, зохицуулалт, тусламжийн асуудлыг хариуцана. Ерөнхийдөө ОБЕГ нь гамшгаас хамгаалах мэргэжлийн бүрэлдэхүүн, мэргэжлийн аврагч дутагдалтай, аврах техник хэрэгсэл болон бусад байгууламжаар хангах шаардлагатай байна.

Байгууллага нь стандартчилсан, гамшигийн бүх төрлийг хамруулсан менежментийн арга барилыг баримталдаг. Улсын, орон нутгийн бүх түвшний янз бүрийн бүтцийн үйл ажиллагааг үр дүнтэй зохицуулах, нөөцийг хамгийн үр ашигтай зарцуулах нь байгууллагын тулгамдсан сорилт болж байна.

ОБЕГ нь онцгой байдлын менежментийн чадавхийг дээшлүүлэх, шуурхай зарлан мэдээлэх, сэрэмжлүүлэх техник хэрэгслийн баазыг бэхжүүлэх, гамшигийн мэдээллийн сан бий болгохоор ажиллаж байна.

#### Цаг уур, орчны шинжилгээний газар (ЦУОШГ)

ЦУОШГ нь байгалийн аюул гамшигийн үед богино, дунд болон урт хугацааны өмнөөс сэрэмжлүүлэх, олон нийтэд мэдээлэх, сэрэмжлүүлэг хүргэх үүрэгтэй байгууллага юм. ЦУОШГ нь гамшигийн тухай сэрэмжлүүлгийг аймгууд дахь өөрийн харьяаны газруудтайгаа хамтран хүргэх бөгөөд тэдгээр нь аймаг сумын удирдагуудад болзошгүй гамшигт үзэгдлийн тухай мэдээлдэг байна. Засгийн газрын 2015 оны 286 дугаар Тогтоолын дагуу ЦУОШГ-аас ОБЕГ-т хүргүүлсэн гамшигийн тухай сэрэмжлүүлэг мэдээг олон нийтэд тараана. Гамшигт үзэгдлийг урьдчилан тодорхойлохын тулд ЦУОШГ цаг уурын радарын систем ашиглаж байна. Энэхүү радарын систем нь бүхий л нутаг дэсгэрийг хамарч чадахгүй, зөвхөн Улаанбаатар хотын эргэн тойрны 200 км доторх үзэгдлийн урьдчилсан мэдээллийг өгөх боломжтой юм.

ЦУОШГ-ын дэргэдэх Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн үйл ажиллагаа нь судалгаа шинжилгээний ажилд төвлөрч, ОБЕГ болон бусад байгууллагуудад шаардлагатай цаг агаарын тухай хиймэл дагуулын мэдээллийг боловсруулж, зуд, ган, ой, хээрийн түймэр зэрэг байгалийн гамшигийн тухай мэдээллээр хангах үүрэгтэй байна.

Байгалийн гамшигийн тухай, ой хээрийн түймрийн тухай мэдээллийн санг тус хүрээлэнгийн Байгаль орчны мэдээллийн сангийн харьяанд ортлоо статус нь буурсан Байгаль орчны мэдээллийн төвийн вэб хуудсан ([http://eic.mn/index\\_disaster.php](http://eic.mn/index_disaster.php)) дээр тавьдаг байна.

#### Улсын онцгой комисс

Анх онцгой комиссыг Улсын байнгын онцгой комисс нэртэйгээр 1990 онд Сайд нарын зөвлөлийн дэргэд байгуулагдаж, үндэсний төлөвлөгөө боловсруулах, яам, орон нутгийн захиргаа хоорондын уялдааг зохицуулах, гамшигийн хор уршгийг арилгах ажлыг зохицуулах, аймаг, хотын сэргээн босголт болон нөхөн сэргээлтийн ажлыг удирдлагаар хангах зэрэг 4 үндсэн үүрэгтэй байжээ.

Улсын байнгын онцгой комиссыг хожим нь Улсын онцгой комисс (УОК) болгон, улсын хэмжээнд онцгой байдал үүссэн тохиолдолд улс төр, үйл ажиллагааны шийдвэр гаргах гол байгууллага болсон байна. УОК-ыг шадар сайд даргалж, тэрээр ОБЕГ, хүмүүнлэгийн байгууллагуудаас дэвшүүлсэн асуудлыг засгийн газарт мэдүүлэх үүрэгтэй байна. УОК нь санхүүжилт, нөөцийг зарцуулах зэрэг асуудлыг шийдвэрлэнэ.

УОК-т ХАА, эрчим хүч, байгаль орчин, эрүүл мэнд, гадаад харилцаа, боловсрол, барилга хот байгуулалт, тээвэр, сангийн яам, засгийн газрын хэвлэл мэдээллийн алба, МХЕГ, МТШХХГ, ЦЕГ, ЦЭГ, ЦУОШГ, СХЗГ, ХХЕГ, ГЕГ зэрэг агентлагуудын төлөөлөл ордог. ОБЕГ нь УОК-т гамшигийн ерөнхий менежмент, газар, агентлаг хоорондын төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг байна.

#### Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой байгууллагууд

2008 оноос хойш Монгол Улс нь Уур амьсгалын өөрчлөлтийг хариуцсан хэд хэдэн тусгай элчийг

томилон ажиллуулж байна. Улсын Уур амьсгалын хороо 2015 оны 12 дугаар сар хүртэл үйл ажиллагаа явуулж байжээ. Одоо БОАЖЯ-ны Уур амьсгалын өөрчлөлт, олон улсын хамтын ажиллагааны газар холбогдох бодлого болон НҮБ-ын УАӨСК-тай хамтран ажиллах асуудлыг хариуцан ажиллаж байна (Бүлэг 7).

#### Орон нутаг дахь үйл ажиллагаа

ОБЕГ нь гамшгийн менежментийг улсын хэмжээнд хариуцдаг байгууллага бөгөөд аймгууд өөрсдийн засаг захиргааны тодорхой үүрэгтэй. Бүх 21 аймагт ОБЕГ-ын харъяа онцгой байдлын газрууд гамшгаас сэргийлэх, сэргээн босгох, эмзэг байдал, эрсдлийг бууруулах, гамшиг, онцгой байдлын үнэлгээ хийх үүрэгтэй ажилладаг. Эдгээр газрууд улсын төсвөөс санхүүжиж, аймгийн засаг даргын тамгын газартай хамтран ажилладаг байна. Аймгийн засаг дарга нар аймагтаа онцгой байдлын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэгтэй байна.

#### *Ард иргэд, олон нийтийн оролцоо*

Газар хөдлөлт, үерийн аюул байнга тохиолддог газар нутагт сэрэмжлүүлэх, шуурхай зарлан мэдээлэл хүргэх уламжлалт тогтолцоо бий. Эрсдэлтэй бүсэд оршин суудаг хүмүүс өөрсдийн байгалийн мэдрэмжид үндэслэн гамшгийн сөрөг үр дагавраас сэргийлэх, гамшгийн бүсээс нүүх арга хэмжээг өөрсдөө авдаг байна.

Гамшгаас хамгаалах тухай 2017 онд шинэчилсэн хуульд иргэдийн оролцоог гол зарчим болгосон байна.

Ихэнх сум, дүүрэгт гамшгийн эрсдлийг бууруулах түншлэлийн зөвлөлүүд, гамшгаас сэргийлэх бүлгүүд байгуулах ажил явагдаж байна. Ийм бүлгийн гишүүд гамшгийн эрсдлийг бууруулах, өөрсдийн амьжиргаа, мал, тариаланг хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулалттайгаар хэрэгжүүлдэг. Эдгээр бүлгүүд нь орон нутгийн түвшинд шийдвэр гаргах, ялангуяа гамшгийн эрсдлийг бууруулах түншлэлийн зөвлөлийн ажилд идэвхтэй оролцдог байна. Гамшгийн эрсдлийг бууруулах түншлэлийн зөвлөл, гамшгаас сэргийлэх бүлгүүд байгуулах үйл ажиллагаанд НҮБХХ-өөс ОБЕГ-тай хамтран 2002-2011 онд хэрэгжүүлсэн “Монгол Улсын гамшгийн менежментийг бэхжүүлэх” төсөл дэмжлэг үзүүлжээ.

Зарим сумдад сумын засаг даргын тушаалаар гамшгаас хамгаалах сайн дурын бүлгүүдийг байгуулж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцуулж байна.

Саяхнаас улсын эдийн засгийн өсөлтийг хангах, гамшгийн шинж чанар өөрчлөгдөж байгааг харгалзан Монголд гамшгаас сэргийлэх, гамшгийн эрсдлийг бууруулах зорилготой төр, хувийн хэвшлийн шинэ түншлэлийг байгуулж эхэлсэн байна. ОБЕГ нь Монгол дахь гамшгийн эрсдлийг бууруулах Төр-Хувийн хэвшлийн түншлэлийн хөтөлбөрийг санаачлан, Гамшгийн эрсдлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээний хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар хоёр салбар хамтран ажиллахаар тохиролцсон. ОБЕГ, Монголын худалдаа, аж үйлдвэрийн үндэсний танхим хоорондын хамтын ажиллагааны гэрээнд шадар сайд гарын үсэг зурсан байна.

#### *Санхүүжилт*

Монгол дахь гамшгийн эрсдлийн менежментийн үйл ажиллагааг улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжиж буй олон улсын хөтөлбөр, төслүүдийн санхүүжилтээс санхүүжүүлдэг. ГЭБ үндэсний болон орон нутгийн стратеги, хэрэгжүүлэх төлөвлөгөөг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байна.

Төрийн нөөцийг ОБЕГ-ын төрийн нөөцийн газар зохицуулж, санхүүжилтийг эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, гамшгийн хор уршгийг арилгах зорилгоор хүнс, бараа, буудай, шатахуун, аж үйлдвэрийн болон хамгаалалтын материал хэрэгсэл нөөцлөхөд зарцуулдаг байна. Барааны төрөл бүр төсвийн тусгай санхүүжилттэй. Нөөцийг улс даяар стратегийн бодлогоор байршуулсан агуулахад хадгална. Аймаг, сумын захиргаанууд мөн нөөц бүрдүүлэх бөгөөд улс, аймаг, сумын түвшинд нөөцлөх бараа материалын төрөл, хэмжээг хуулиар тогтооно. Нөөцийг зөвхөн УОК-ын шийдвэрээр зарцуулах, нөөцийг борлуулах, үнэ төлбөргүй тараах, борлуулалтаас олсон орлогыг нөөцийг сэлгэх, шинэчлэхэд ашиглах, улсын төсөвт тушаахыг зэрэг ажлыг зохицуулна. Улсын нөөцийн нэмэлт санхүүжилтийг төсвийн хуваарилалт, тодотголоор олгож болно. Төсвийн үлдэгдлийг жилийн эцэст төрийн төсөвт эргүүлэн тушаадаг бөгөөд үлдэгдлийг буцааж эргүүлэн олгодоггүй байна.



Төрийн нөөцийг Сангийн яам хариуцдаг ба түүнийг байгалийн, технологийн гамшиг, хүний болон малын гоц халдварт өвчин зэрэг гэнэтийн олон янзын зорилгод зарцуулж байна. Жилийн нөөцийн тодорхой хэсгийг гамшиг, гоц халдварт өвчинтэй тэмцэхэд зарцуулахаар төлөвлөдөг.

Онцгой байдлын ноцтой байдал үүссэн (тухайлбал түймэр) нөхцөлд аймгаас гамшигт өртсөн ард иргэдэд яаралтай тусламж дэмжлэг үзүүлэн, дараа нь УОК-оор уламжлан Засгийн газрын болон төрийн нөөцөөс нөхөн хангалтыг авдаг байна.

Аймгууд засгийн газрын нөөцөөс олгосон нөөцийн ашиглалтын тайланг ОБЕГ-г хүргүүлэх үүрэгтэй. Гамшигийн тусламжийн дансаар олгосон санхүүжилтийн бүх тайланг ОБЕГ нэгтгэн, тайланг төрийн санд хүргүүлнэ. Төрийн нөөцийн төсвийн зарцуулалтын тайланг мөн ОБЕГ гаргана.

Бусад төрөлжсөн агентлагууд гамшигийн тусгай төсөвгүй, харин зарим яаманд гамшигийн бэлэн байдлын төсөв хувиарлагдаж, түүнийг гамшигийн хор уршгийг арилгах зорилгод ашиглах боломжтой. Гэвч энэ төсөв нь маш бага бөгөөд хор хохирлыг арилгах зорилгод ашиглахад хангалттай бус байдаг байна.

Ерөнхийдөө ГЭМ, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээний улсын төсөв үргэлж хангалтгүй байдаг байна. Монгол Улс нь ГЭМ, уур амьсгалын өөрчлөлтийн олон тооны төсөл, хөтөлбөрийг хоёр талын хэлэлцээрийн үндсэн дээр АНУ, Япон, БНСУ, Герман, Швейцар зэрэг хандивлагч улс, Дэлхийн банк, АХБ, ДБОБ, НҮБХХ, НҮББОХ зэрэг олон улсын байгууллагуудтай хэрэгжүүлж, Дасан зохицох сангийн шугамаар төслийн санхүүжилт (төслийг Монгол дахь НҮБХХ хэрэгжүүлж буй) авч байгаа боловч санхүүжилт хангалтгүй хэвээр байна.

#### *Олон улсын хамтын ажиллагаа*

Монгол Улс нь ГЭМ-ийн чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар идэвхтэй ажиллаж байна. ГЭМ-ийн олон тооны төслийг НҮБХХ, ДБ, АХБ, ЖАЙКА, Мерси корпус, Монголын улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран түншлэлийн журмаар боловсруулан амжилттай хэрэгжүүлжээ.

НҮБ-ын хүмүүнлэгийн агентлагууд, олон улсын ТББ-ууд ГЭБ хууль тогтоомж, бодлого, стратегийг боловсруулах, салбар болон ард иргэдэд суурилсан уян хатан байдлыг бэхжүүлэх, шуурхай зарлан мэдээлэх сэрэмжлүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд чиглэгдсэн Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ихээхэн дэмжлэг үзүүлж иржээ. Жил дараалан болсон зудын улсад учруулсан хохирлыг даван туулах, янз бүрийн газарт тохиолдсон үер, түймэр, ган, гоц халдварт өвчин зэрэг орон нутгийн гамшигийн үр дагаврыг арилгахад хүмүүнлэгийн түншүүдийн оруулсан хувь нэмрийг нийтээр талархан хүлээн авдаг байна. Гэвч ГЭБ үйл ажиллагааг дагах бус, урьдчилан сэргийлэх зарчимд шилжүүлэх шаардлагатай байна.

Монгол Улс НҮБ-ын ГЭБ газартай түншилж, хамтран ажиллаж байна. Тухайлбал Монгол Улс Сендайн үйл ажиллагааны хүрээний дэлхийн зорилгуудын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах НҮБ-ын ГЭБГ-ын ажлын бүлгийн ажилд оролцож, зохих хувь нэмэр оруулж байна. ГЭБ Азийн түншлэлийн 2017 оны уулзалтыг Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын ГЭБГ-ын Ази, Номхон далайн бүсийн газар хамтран Улаанбаатар хотноо зохион байгуулжээ. Монголын гурван хот НҮБ-ын ГЭБГ-ын зохицуулалтаар хэрэгждэг “Хотын дархлааг бэхжүүлэх” дэлхийн кампанит хөтөлбөрт нэгдэж, хотуудын удирдах бүрэлдэхүүн кампанит ажлыг хэрэгжүүлэх сургалтад хамрагдсан байна.

Мехико-д 2017 оны 5 дугаар сард болсон ГЭБ цын дэлхийн хөтөлбөрийн хурал дээр Монгол Улсын Шадар сайдыг ГЭБ үйлсэд оруулсан хувь нэмэр, амжилтыг үндэслэн ГЭБ Азийн тэргүүлэгчээр тодорхойлсон байна. Монголын Засгийн газар НҮБ-ын ГЭБГ-тай хамтран Азийн сайд нарын ГЭБ –ын бага хурлыг 2018 онд Улаанбаатарт зохион байгуулна. ОБЕГ, Монголын худалдаа, аж үйлдвэрийн үндэсний танхим нь НҮБ-ын ГЭБГ-ын Гамшигт уян хатан нийгмийн Хувийн хэвшлийн салбарын холбоо (ХХСХ) байгуулах сонирхлоо илэрхийлээд байна.

#### **14.4 Үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж**

##### *Үнэлгээ*

Монгол улсад тохиолдсон хүний хүчин зүйл, байгалийн гаралтай гамшиг, ган, зуд, ойн түймрээс сургамж авч, өнгөрсөн 10 жилд гамшигийн эрсдлийг бууруулах, менежментийг сайжруулахад ихээхэн

амжилт ахиц дэвшил гаргажээ. 2009-2010 оны зудаар авсан арга хэмжээ нь бэлэн байдал, харилцаа холбоо, хор уршгийг арилгахад нэлээд дутагдал байгааг илрүүлсэн нь ГЭБ асуудлыг үндэсний бодлого, тухайлбал уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тогтвортой хөгжлийн бодлогод тусгахад хүчтэй нөлөөлжээ.

Олон улсын суурь баримт бичиг болох 2015-2030 онд Гамшгийн эрсдлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ, 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Парисын хэлэлцээр нь үндэсний хөгжлийг хөтөлбөрийн хэрэгжилтийн хөшүүрэг болж байгаа талаар Засгийн газрын ажилтнууд бүрэн ойлголттой байна. Засгийн газраас ГЭБ, ГЭМ-ийн бодлого төлөвлөгөөг олон улсын байгууллагуудын тусламж, түншлэл, чадавхийг дээшлүүлэх үндэсний төслүүдийн үр дүнд түшиглэн эрчимтэй боловсруулж байна. Өнгөрсөн жилүүдэд хөгжлийн олон шийдвэрийг хүн ам болон дэд бүтцийн эмзэг байдлыг тооцохгүйгээр гаргаж байв. Зарим шийдвэр, тухайлбал барилга байгууламжийн төсөл, байршлыг сонгохдоо газар хөдлөлтийн эрсдлийг тооцоогүй, гамшигт өртөж болох бүсэд нийтийн дэд бүтэц, ажлын байр бий болгосноор ард иргэдийг ийм бүсэд шилжин амьдрах нөхцөлийг бүрдүүлж, түүнийг дэмжсэн шийдвэрүүд нь хөгжлийн бодлогод ихээхэн сөрөг нөлөөтэй байв. Засгийн газарт хэлэлцэгдэж буй хөгжлийн олон асуудлууд нь гамшгийн эрсдэлтэй байж болох талтай ч цаашид уян хатан байдлыг бэхжүүлэх боломжийг олгох болно. Гамшгийн эрсдлийн асуудлыг үндэсний хөгжлийн бодлого, үйл ажиллагаанд тусгах нь Монгол улсын гамшгийн уян хатан байдлыг бэхжүүлэхийн суурь байх ёстой.

Гамшгийн уян хатан байдлыг бэхжүүлэх чиглэлээр засгийн газар, хөгжлийн түншүүд, иргэний нийгмээс хэрэгжүүлэх боломжтой өргөн цар хүрээтэй арга хэмжээнүүд байна. Санхүүгийн нөөц туйлын хязгаарлагдмал байгаа нь нөөцийг стратеги, үнэ зардлын хувьд хамгийн зохистой хувилбараар ашиглахыг шаардаж байна.

Түүнчлэн гамшгийн гол эх үүсвэрт анхаарлаа төвлөрүүлэн, гамшгийн эрсдлийг бууруулах, гамшгийн дараах уян хатан нийгэм, ард иргэдийг төлөвшүүлэх асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй.

*Дүгнэлт, зөвлөмж*

Гамшгийн эрсдэлийн менежмент болон уур амьсгалын өөрчлөлтийн бодлогын тогтолцоо

Гамшгаас хамгаалах 2011 оны төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Одоо Засгийн газар Гамшгийн эрсдлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ, 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн холбогдох зорилгуудтай нийцсэн 2015-2030 оны гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний шинэ стратегийг боловсруулж байна. Орон нутгийн түвшинд Монгол улсын Дархан, Эрдэнэт, Улаанбаатар хотууд “Хотын дархлааг бэхжүүлэх” дэлхийн кампанит хөтөлбөрт нэгдсэн нь эдгээр хотууд ГЭБ асуудлыг орон нутгийн хөгжлийн бодлого, хотын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр идэвхтэй ажиллаж байгаагийн илрэл юм. Орон нутагтаа ГЭБ стратегийг батлан хэрэгжүүлж байгаа бусад засаг захиргааны байгууллагуудын талаар мэдээлэл байхгүй байна. Гамшгийн эрсдлийн менежмент, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тогтвортой хөгжил хоорондын харилцан уялдааг сайн ойлгож байгаа боловч бодит амьдралд энэ уялдаа холбоог хэрэгжүүлэх, байгууллагуудын хоорондын уялдаа, зохицуулалт бэрхшээлтэй тулгарч байна.

Зөвлөмж 14.1:

*Засгийн газар гамшгийн эрсдлийн менежмент, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тогтвортой хөгжлийн уялдаа холбоог хангах, үр бүтээмжийг дээшлүүлэх талаар дараах арга хэмжээ авбал зохино:*

- (a) *Үндэсний болон орон нутгийн ГЭМ-ийн стратегийн баримт бичгүүд нь тогтвортой хөгжлийн үндэсний хэмжээний өргөн хүрээний хөтөлбөрт тусгагдан, түүнтэй уялдаж байгааг баталгаажуулах;*
- (b) *Гамшгийн эрсдлийн менежмент, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг салбарын болон орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, төсөвт суулгах;*
- (c) *Гамшгийн эрсдлийн менежмент, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөөнүүдийг нэгтгэн ажлын төлөвлөгөө боловсруулах, уялдуулах боломжийг судлах.*

### Хотын дэд бүтэц

Монгол улсад 1990-ээд оноос хөдөөгөөс хотруу чиглэсэн шилжилт хөдөлгөөн, хотжилт эрчимжжээ. Хот суурины эрчимтэй тэлэлт ихэнхдээ ямар ч төлөвлөлтгүй явагдаж байгаа нь хөгжлийн олон саад бэрхшээл сорилт, тухайлбал үндсэн үйлчилгээний хүртээмжийг доройтуулах, хотын захын дүүргүүдийн өвлийн улирлын агаарын бохирдол нэмэгдэх зэрэг бэрхшээлийг үүсгэж байна. Хотын захын гэр хорооллын иргэд үерийн усны зам дээр амьдарч, уруйн үерээс хамгаалах ямар ч бололцоогүй байдлыг үүсгэж байна. Эдгээр бэрхшээлийг шийдвэрлэх нь 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн Зорилго 1.5, 11.5, 11.b -ыг биелүүлэхэд чухал ач холбогдолтой.

#### Зөвлөмж 14.2:

*Засгийн газар дараах арга хэмжээ хэрэгжүүлвэл зохино:*

- (a) *Хотын бүсийн дэд бүтцийн байгууламжуудын бүртгэл, эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ хийх;*
- (b) *Хотын дэд бүтцийг шинэчлэн байгуулах ажлыг дэмжлэг, удирдамжаар хангах;*
- (c) *Гамшигийн эрсдлийн менежмент, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг барилга байгуулалт, бүсчлэл болон холбогдох бусад хууль тогтоомжид тусгах.*

### Чадавхи, зохицуулалт

Бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаатай холбоотой ГЭМ-ийн олон саад, сорилт байсаар байна. Онцгой байдлын бэлэн байдал, хор уршгийг арилгах чадавхи төвийн буюу үндэсний түвшинд илүү хөгжсөн боловч ОБЕГ-т мэргэжлийн боловсон хүчин, техник хэрэгсэл дутмаг хэвээр байна. Орон нутагт олон улсын байгууллагууд, ТББ-ууд засаг захиргааны үйл ажиллагааг дэмжиж, гамшигт байнга өртөж байгаа бүсүүдэд техникийн туслалцаа, онцгой байдлын хор уршгийг арилгах арга хэмжээ хэрэгжүүлж байна.

Газар хөдлөлт, үерийн аюул байнга тохиолддог газар нутагт шуурхай зарлан мэдээлэх уламжлалт тогтолцоо бий. Эрсдэлтэй бүсэд оршин суудаг иргэд өөрсдийн байгалийн мэдрэмжид үндэслэн гамшигийн сөрөг үр дагавраас сэргийлэх, гамшигийн бүсээс нүүх арга хэмжээг өөрсдөө авдаг байна. Байгаа нөөц, санхүүжилтийг хамгийн үр бүтээмжтэй ашиглахын тулд ГЭМ-ийн бүх үйл ажиллагааг үндэсний, орон нутгийн түвшинд зохистой зохицуулалтаар хангах нь тулгамдсан асуудал болж байна.

#### Зөвлөмж 14.3:

*Засгийн газар гамшигийн бэлэн байдал, хор уршгийг арилгах, нөхөн сэргээх, сэргээн босголтын ажлыг сайжруулбал зохино. Үүний тулд:*

- (a) *Бүх төрлийн гамшигийн бэлэн байдлыг дээшлүүлэхийн тулд оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх, төлөвлөлтийг сайжруулах, сургалт зохион байгуулах;*
- (b) *Гамшигийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхийг дээшлүүлэхийн тулд үндэсний болон аймгийн түвшний төлөвлөгөө боловсруулах, үнэлэх, дууриалган үзүүлэх сургуулилт зохион байгуулах;*
- (c) *ОБЕГ-ын чадавхийг бэхжүүлэх (боловсон хүчин, техник хэрэгсэл);*
- (d) *Гамшигийн нөөцийн зохицуулалт, хяналт мониторингийг сайжруулах;*
- (e) *Гамшигийн дараа ядуу эмзэг бүлгийнхэнд тусламж үзүүлэх механизмийг бүрдүүлэх, урт хугацааны хөгжилд сөргөөр нөлөөлж болзошгүй гамшигтай тэмцэх албан бус үйл ажиллагааны механизм ашиглахыг хязгаарлах.*


### Гамшиг болон уур амьсгалын эрсдэлийн тухай ойлголт

Монголд засаг захиргааны бүх түвшний (төв, орон нутаг) дийлэнх байгууллагууд, мэргэжилтэн нар, ОБЕГ-ын харьяа Гамшиг судлалын хүрээлэн гамшиг, уур амьсгалын эрсдэл, ГЭМ-ийн өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагааны ач холбогдлын талаар тодорхой ойлголттой байна. Гэвч цөөн салбарт эрсдлийн үнэлгээ хийгдсэн ба тогтолцоог бүрэн хэмжээгээр ажиллуулахын тулд мэдээ мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, шуурхай зарлан мэдээлэх сэрэмжлүүлэх, мэдээллийн цогц менежментийг нэвтрүүлэх шаардлагатай.

Зөвлөмж 14.4:

Засгийн газар ГЭМ-д оролцож буй талуудын ГЭМ-ийн үзэл баримтлал, практик үйл ажиллагааны талаарх мэдлэг, ойлголтыг бэхжүүлэх арга хэмжээ авбал зохино. Үүний тулд:

- (a) Олон талт гамшигийн эрсдлийн үнэлгээг тогтмол хийх;
- (b) Олон талт гамгийн эрсдлийн үндэсний дүр зургийг боловсруулан тогтмол шинэчлэх, уур амьсгалын өөрчлөлтийн загварчлалын хувилбаруудыг үндэсний гамшигийн эрсдлийн төлөвлөлтөд тусгах;
- (c) Холбогдох байгууллагууд хоорондын зохицуулалт, мэдээ мэдээлэл цуглуулах, мэдээлэл солилцох механизм бүрдүүлэх;
- (d) ГЭМ-ийн үйл ажиллагаанд ард иргэдийг идэвхтэй татан оролцуулах, тэдний мэдлэг, боловсрол, чадвар чадавхийг дээшлүүлэх.





## Бүлэг 15

# ЭРҮҮЛ МЭНД, ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БАЙГАЛЬ ОРЧИН

### 15.1 Хүн амын эрүүл мэндийн төлөв байдал

#### *Хүн амын хөгжил*

Монгол Улсын хүн ам 1989 оны эцсийн байдлаар 2,043,954; 1997 оны байдлаар 2,307,484, 2007 оны байдлаар 2,620,446 болтол өсч 2016 оны эцсийн байдлаар 3,119,935 болсон байна. Хүн амын хувьсал нь хот, суурин газрын хүн ам өсөхөд шууд нөлөөлж, 1997 оны эцсийн байдлаар 1.215 сая (нийт хүн амын 52.7 хувь), 2016 оны эцсийн байдлаар 2.131 сая (68.3 хувь) болжээ. 2016 оны байдлаар хотын хүн амын 67 хувь Улаанбаатарт оршин сууж байна. Харин 2004 оны байдлаар хөдөө орон нутгийн хүн ам нэг сая хүрэхгүй болтлоо багасч (993,862), 2016 оны эцсийн байдлаар нэг саяас доош хэвээр (988,112) байна.

2016 оны байдлаар Монголын хүн амын 12.6 хувь нь баруун бүсэд, 18.7 хувь нь Хангайн бүсэд, 15.8 хувь нь төвийн бүсэд, 6.8 хувь нь зүүн бүсэд, 46.2 хувь нь Улаанбаатар хотод оршин сууж байна. Улаанбаатар хотод шилжин суурьшсан олон тооны иргэнийг хот багтаах боломжгүйн улмаас хотын захад гэр хорооллууд үүсч байна. Улаанбаатар хотын захын гэр хороололд дунджаар 3-5 ам бүлтэй 200,000 гаруй айл өрх эрүүл бус орчинд амьдарч байна. Ариун цэвэр, орчин, нийгмийн доройтсон нөхцөлд амьдарч буй хүмүүс өвчинд өртөх өндөр магадлалтай байна.

2016 оны эцсийн байдлаар эмэгтэйчүүд хүн амын 50.8 хувь, эрэгтэйчүүд 49.2 хувийг эзэлж байна. 1997 онд 5 хүртэлх насны хүүхэд 10.1 хувь, 5-14 насны хүүхэд залуучууд 26.3 хувийг эзэлж байсан бол 2016 онд 5 хүртэлх насны хүүхэд 12.6 хувь болтол нэмэгдэж, харин 5-14 насны хүүхэд залуучууд 17.4 хувь болж буурч, харин 1997 онд 15-64 насны хүмүүс 59.7 хувь байсан бол 2016 онд 66.2 болтол нэмэгджээ. 2016 оны эцсийн байдлаар 65-аас дээш насны хүмүүс хүн амын 3.8 хувийг эзэлж байна.

1997 онд 1,000 хүн тутамд 21.6 төрөлт ноогдож байсан бол 2007 онд 21.7, 2016 онд 25.9 болж өссөн байна. 2016 онд амьд төрөлтийн 54.3 хувийг 20-29 насны эмэгтэйчүүд эзэлж, 20-иос доош насны эмэгтэйчүүдийн амьд төрөлт 1997 онд 8.1 хувь байснаа 2007 онд 4.0 хувь болтол буурч, 2016 онд 5.4 болсон байна. 2016 онд төрөлтийн ерөнхий түвшин 95.3 хувь (1,000 төрөлтөд амьд төрөлтийн эзлэх хувь) байсан бол 1997 онд 79.2, 2007 онд 72.3 хувьтай байжээ.

Сүүлийн хоёр арван жилд Монголын хүн амын эрүүл мэндийн байдал сайжирчээ. 2016 онд төрсөн хүн дунджаар 69.6 жил амьдарна гэж тооцоолсоноос эмэгтэйчүүд 75.1, эрэгтэйчүүд 65.6 насална гэж тооцоолж байна (Шигтгээ 15.1). Дундаж наслалт 2000-2016 онд 7 жилээр уртасчээ (2000 онд 63.2, 2016 онд 70.82 жил). Хамгийн богино наслалт 2000 оноос хойш Дорнод аймаг (2000 онд 58, 2010 онд 63.9, 2017 онд 68.63 жил) болон Хөвсгөл аймагт (2000 онд 59, 2010 онд 63.6, 2016 онд 66 жил) бүртгэгдсэн байна.

#### *Эх, нярайн эндэгдэл*

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд ноогдох) 2010 онд 24.5, 2012 онд 18.7, 2016 онд 20.8 байжээ. 2015 оны байдлаар 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн гол шалтгаан нь төрөхөөс өмнөх үеийн нөхцөл, уургийн буруу өсөлт, хромосомын гажуудал болон амьсгалын замын өвчин байсан байна. Хүүхдийн эрүүл мэндийн байдал нь эцэг эхийн боловсрол, өрхийн орлого, дэд бүтцийн хөгжил, газар зүйн байрлалаас шалтгаалан ихээхэн ялгаатай байгааг 2015 оны “МХЗ-оос Тогтвортой хөгжилтийн зорилтуудад шилжих нь” үндэсний илтгэлд тэмдэглэжээ. Түүнчлэн ядууралд өртөх магадлалтай бүсүүдэд өрхийн орлого багасч, хүнсний хомсдолд ордог нь нярай, 5 хүртэлх насны хүүхэд тэжээлийн доройтолд орох шалтгаан болж байна.

**Шигтгээ 15.1: Дотор агаарын чанарын хүүхдийн эрүүл мэндэд үзүүлж буй нөлөө**

Хүүхдүүд нийт цагийн 90 гаруй хувийг гэр дотор өнгөрүүлдэг. Сургуулийн насны хүүхдийн агаарын бохирдолд өртөх нь сургууль явахад зарцуулдаг цаг, тээврийн хэрэгсэл, сургуулийн байршил, хоол идэх дэглэм журам болон сургуульд өнгөрүүлэх цагаас хамаарна. 2013 онд нас баралтад хамгийн их нөлөөлсөн гурван өвчин агаарын бохирдолтой шууд холбоотой байна.

Амьсгалын замын халдвар нь 5 хүртэлх насны хүүхдийн нас баралтын хоёр дахь үндсэн шалтгаан болж, нас баралтын 15 хувийг эзэлж байна. Гэрийн дотор хүүхдүүдийн агаарын бохирдолд өртөх явдлыг багасгах нь уушигны хатгаа, уушигны өвчний магадлалыг бууруулдаг учир сургуулийн насны хүүхдүүдийг агаарын бохирдлоос сэргийлэх нь хожим агаарын бохирдлоос үүдэлтэй өвчингүй байхад хувь нэмэр оруулна. Судалгаанд стратегийн гурван гол зорилгыг гэр, сургуульд цэвэр түлш ашиглах, вакцинжуулалт болон өрхийн эрүүл мэндийн үйлчилгээгээр уушигны хатгааны тохиолдлыг багасгах, тамхины утаа, тэжээлийн доройтол зэрэг өвчний эрсдлийн хүчин зүйлийг бууруулах гэж тодорхойлсон байна.

Шинжлэх ухааны баримт дүгнэлттэй хөгжлийн бодлогыг уялдуулах явдал сул, яам, бусад байгууллагууд хоорондын мэдээллийн зохицуулалт муу зэрэг агаарын бохирдлыг хянах, бууруулах ажилд нэлээд хүндрэл учирдаг.

Гэвч Засгийн газар Агаарын тухай 2012 оны хуулийг шинэчлэх, техник хэрэгслийн хэрэгцээг тогтоох, агаар бохирдуулагч эх үүсвэрийн ялгаруулалтын стандартыг тогтоох зэрэг нийслэл хотын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Эдгээр арга хэмжээг үр бүтээмжтэй хэрэгжүүлэхэд техник хэрэгсэл, техникийн мэдлэг туршлага, хүний нөөц, ялгаруулалтын хяналт мониторинг хийдэггүй, дотоод мониторинг төлөвшөөгүй, торгуулийн тогтолцоо сул зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Агаарын бохирдлын асуудлыг улсын хэмжээнд анхаарах, бохирдуулагчийн ялгаруулалтыг бууруулах, засгийн газар эрх зүй, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох, ард иргэд сайн арга практик ажиллагааг хэрэгжүүлэх, аж үйлдвэрийн салбар агаарын чанарыг хамгаалах, агаарыг цэвэршүүлэх (шүүлтүүр, техникийн арга хэлбэр) арга хэмжээг авах хэрэгтэй байна.

*Эх сурвалж:* Хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлж буй нөлөөг ухамсарлах, шийдвэрлэх нь, НҮБХС, 2016 он.

Нярайн (1 хүртэлх насны) 1,000 амьд төрөлт дахь эндэгдлийн түвшин 1990 онд 64.4 байсан түвшингөөс үлэмж буурч, 2000 онд 17.6, 2016 онд 16.8 болжээ. 2015 оны байдлаар 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 15.3 байсан бол баруун бүсэд хамгийн өндөр үзүүлэлттэй байв (1,000 амьд төрөлтөд 22).

2015 оны байдлаар нярайн (1 хүртэлх насны) хүүхдийн эндэгдлийн гол шалтгаан нь амьсгалын замын өвчин (хот сууринд 54.3 хувь, хөдөө орон нутагт 63.9 хувь), дараа нь халдварт өвчин болон вирусн халдварт өвчин (хот сууринд 12.6 хувь, хөдөө орон нутагт 7.9 хувь) болж байна. Амьсгалын замын өвчин мөн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн гол шалтгаан (хот сууринд 57.5 хувь, хөдөө орон нутагт 68.8 хувь) болж байна (Хүснэгт 15.1).

**Хүснэгт 15.1: 1 болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан, 2016 он, тоо, хувь**

Өвчний төрөл	Насны ангилал			
	0 – 1 настай		5 хүртэл настай	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
Амьсгалын замын өвчин	54.3	63.9	57.5	68.8
Хоол боловсруулах системийн өвчин	9.9	9.7	8.7	12.6
Төрөхөөс өмнөх үеийн нөхцөл	7.9	3.7	4.0	2.3
Гэмтэл, хордолт, гадны бусад	1.9	0.7	7.0	1.9
Халдварт, нянгийн өвчин	12.6	7.9	7.6	3.3
Арьсны өвчин	4.9	3.7	9.6	4.8

*Эх сурвалж:* Эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтийн товхимол, Эрүүл мэндийн хөгжлийн төв, 2015 он.

100,000 амьд төрөлт дахь эхийн эндэгдлийн харьцаа 2007 онд 89.6 байсан бол 2013 онд 42.6, 2016 онд 38.0 болтол буурчээ. 2016 онд 100,000 амьд төрөлт дэх эхийн эндэгдлийн харьцаа аймгийн түвшинд 56, харин Улаанбаатар хотод 41.8 байсан байна.

2015 онд нийт төрөлтийн 99.6 хувь мэргэжлийн эмчийн хяналтад болсон байна.

2016 онд жирэмсэн эмэгтэйчүүдийн 83.6 хувь нь жирэмсний хугацаанд 6-аас доошгүй удаа эмчийн үзлэгт хамрагдсан байна. Эдгээрээс 20-иос доош насны эхчүүд 5 хувийг эзэлж байгаа бол 35-аас доош насны эхчүүд 15.4 хувийг эзэлж байна. 2016 онд үр хөндөлтийн түвшин нөхөн үржихүйн чадвартай 1,000 эмэгтэй тутамд 21.5 байжээ (нийт 18,316 үр хөндөлт бүртгэгдсэн). Үр хөндөлтийн хувийг насны бүлгээр үзүүлвэл 20-иос доош насны эмэгтэйчүүд 5.0, 20-34 насны эмэгтэйчүүд 70.7 хувь, 35-аас дээш насных 24.3 хувийг эзэлж байна.

#### Нас баралтын шалтгаан

2016 онд нийт 16,181 нас баралт бүртгэгдсэнээс 40 хувь нь эмэгтэй, 60 хувь нь эрэгтэйчүүд байна.

2016 онд нас баралтын гол шалтгаан нь зүрх судасны системийн өвчин (33.3 хувь), хавдар (25.6 хувь) байв (Хүснэгт 15.2). Гэмтэл, санамсаргүйгээр хордох зэрэг гадна нөлөөллөөр нас барсан тохиолдол 15.0 хувийг эзэлж байна. 1990 оны байдлаар амьсгалын замын өвчин нас баралтын гол шалтгаан байсан (31.3 хувь) бол 2005 оны үед 4.5 хувиар буурч, 2005–2016 оны хооронд 3.4-4.5 хувийн хооронд хэлбэлзэж байжээ. 2014 онд 30-аас 70 насны өвчтөнүүдийн халдварт бус гол 4 өвчнөөр (ХБӨ) нас барах магадлал 32 хувь байв.

#### Хүснэгт 15.2: Нас баралтын гол шалтгаан, 1990, 1995, 2000, 2005, 2010-2016 он

	1990	1995	2000	2005	2010	2011	2012	2013	2014	2015	2016
<b>Бүх нас баралт, тоо</b>	16,401	16,184	15,472	15,469	17,276	17,127	16,923	16,192	16,495	16,374	16,181
үүнээс											
эмэгтэй	7,787	7,164	6,789	6,003	6,951	6,556	6,471	6,459	6,558	6,552	6,519
эрэгтэй	8,614	9,020	8,683	9,466	10,325	10,571	10,452	9,733	9,937	9,822	9,662
<b>Гол шалтгаан, хувь</b>											
Зүрх судасны өвчин	15.66	30.85	31.33	38.29	37.69	36.73	35.09	35.09	34.37	34.15	33.31
Цус, цус төлжүүлэх эрхтэн, дархлалын систем	0.80	0.34	0.24	0.14	0.16	0.08	0.14	0.12	0.13	0.16	-
Хорт хавдар	16.37	18.52	19.57	18.86	20.79	20.65	21.22	23.44	24.32	24.60	25.60
Гэмтэл, хордолт, гадны бусад нөлөө	4.83	8.69	11.74	18.26	16.14	18.26	18.88	17.22	16.72	15.65	15.02
Амьсгалын замын өвчин	31.32	15.79	8.83	4.52	4.34	3.88	3.78	3.40	3.55	3.74	4.32
Хоол боловсруулах замын өвчин	13.94	7.93	7.20	8.07	8.47	8.95	8.93	8.38	7.72	8.01	7.45
Шээсний замын өвчин	4.54	5.54	3.24	3.06	2.14	1.75	1.78	1.86	1.89	2.00	2.86
Төрөхийн өмнөх өвчин	2.35	2.65	2.28	2.00	1.65	1.46	1.22	1.06	1.27	1.63	1.52
Мэдрэлийн системийн өвчин	5.24	2.55	2.85	2.92	3.77	3.35	3.70	3.81	4.20	4.49	3.60
Мэдрэлийн системийн өвчин	3.99	1.78	1.61	1.51	1.84	1.63	1.88	1.78	1.91	1.87	2.04
	1990	1995	2000	2005	2010	2011	2012	2013	2014	2015	2016

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2017 он.

#### Өвчлөлийн гол хандлага

2016 онд 10,000 эрэгтэйчүүд тутмаас 2,102.1 нь, 10,000 эмэгтэйчүүд тутмаас 3,416.7 нь эмнэлэгт хэвтэж эмчлүүлжээ. 2016 онд эмнэлэгт хэвтэж эмчлүүлэгсдийн гол өвчлөлд амьсгалын замын өвчин (10,000 тохиолдолд 456.1 нь), зүрх судасны өвчин (10,000 тохиолдолд 399.3 нь), хоол боловсруулах замын өвчин (10,000 тохиолдолд 3221 нь), бөөр, шээсний замын өвчин (10,000 тохиолдолд 306.1 нь), мэдрэлийн системийн өвчин (10,000 тохиолдолд 197.7 нь) орж байна.

#### Халдварт бус өвчин (ХБӨ)

2015 онд ХБӨ-өөр нийт 16,181 нас баралт бүртгэгдсэнээс (нас баралтын 85.4 хувь) цусны эргэлтийн системийн өвчин (33.3 хувь), хавдар (25.6 хувь), гэмтэл, хордлого болон бусад гадны нөлөө (15 хувь), хоол боловсруулах системийн өвчин (7.4 хувь) болон амьсгалын замын өвчин (4.3 хувь) зонхилж байна.

2005-2016 онуудад бүх ХБӨ нэмэгдсэн байна. Амьсгалын замын өвчин хамгийн түгээмэл тохиолдож 2005 онд 10,000 хүн тутамд 829 өвчлөл гарсан бол 2016 онд 1,647.4 болтол нэмэгджээ. Амьсгалын замын өвчин 10,000 хүн ам тутамд хотод 1,623.3, хөдөөд 1,659.1 бүртгэгдсэн байна.

2016 оны байдлаар 10,000 хүн ам тутамд ноогдох нас баралтад хүргэсэн гол өвчинд амьсгалын замын өвчин (1,647.4), хоол боловсруулах замын өвчин (1,231.4), цусны эргэлтийн системийн өвчин (1,007.6), шээсний замын өвчин (807.6), гэмтэл, хордолт, гадны бусад нөлөөний өвчин (469.9) орж байна. Амьсгалын замын өвчинтэй холбоотой багтраа, харшил, шөрмөсөн чулуутай болбоотой өвчлөлтийн талаар мэдээлэл байхгүй байна.

1990 оноос хойш хорт хавдар нь хүн амын нас баралтын хоёр дахь гол шалтгаан болж, 2016 онд нийт нас баралтын 25.6 хувийг эзэлж байна. Эрэгтэйчүүдийн хорт хавдрын гол таван өвчинд элэгний хорт хавдар (42.2 хувь), ходоод (20.9 хувь), уушиг (11.9 хувь), улаан хоолой (5.7 хувь), нойр булчирхай (3.7 хувь), эмэгтэйчүүдийн хувьд элэг (36.9 хувь), умайн хүзүү (13.9 хувь), ходоод (10.5 хувь), хөх (7.1), улаан хоолой (5.6), өндгөвч (3.8) хувийг эзэлжээ.

ДЭМБ-ын дүгнэлтээр дэлхий дахинд хорт хавдрын 19 орчим хувь нь орчны нөхцлөөс үүдэлтэй байна. Жишээ нь нүүрс, биомассыг байрны дотор шатааснаас гаралтай дотор орчны агаарын бохирдол нь уушигны хорт хавдрын магадлалыг нэмэгдүүлдэг. Уушигны хорт хавдрын 14 хувь нь орчны агаарын бохирдол, 17 хувь нь гэрийн дотор агаарын бохирдол, 6.6 хувь нь ажлын байрны эрсдлээс гаралтай гэсэн тооцоо гаргажээ.

Монгол орны байгаль орчны бохирдол, ялангуяа агаарын бохирдол хот сууринд зөвшөөрөгдсөн хэмжээнээс дээгүүр байдаг (Бүлэг 8). Монгол орны байгалийн карциногены (агаар, хөрс, ус) талаар суурь мэдээлэл, мэдээллийн сан байхгүй, иймд байгалийн карциногены түвшинг зөвшөөрөгдсөн түвшин хүртэл бууруулах системтэй ажил хийдэггүй байна.

2016 онд ХБӨ-г эрт оношлох үзлэгийг 417,241 хүнд хийснээс 42.0 хувь нь эрэгтэй, 58.0 хувь нь эмэгтэйчүүд байв. Эрт оношлогооны дараах эмнэлгийн шинжилгээнлд нийт 76,969 хүн хамрагджээ. Эдгээрээс 9,605 хүн (2.3 хувь) артерийн даралт өндөртэй гэж оношлогдсон байна. Мөн энэ онд 392,233 хүн диабет өвчнийг эрт илрүүлэх оношлогоонд хамрагджээ. Мөн хавдраас сэргийлэх болон хяналтын ажил хийгдсэн байна. Энэ онд 73,706 эмэгтэй умайн хүзүүний хавдрын, 286,921 эмэгтэй хөхний хавдрын эрт илрүүлэх оношлогоонд хамрагджээ.

#### *Халдварт өвчин*

2016 онд нийт 29 төрлийн 69,663 халдварт өвчин бүртгэгджээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт халдварт өвчний 57.7 хувь Улаанбаатар хотод ноогдож байна. 2016 онд улсад бүртгэгдсэн нийт халдварт өвчний 62.0 хувийг амьсгалын замын, 21.5 хувийг бэлгийн замын (БЗДӨ), 13.0 хувийг дотоод эрхний, 0.7 хувийг амьтнаас хүнд нянгаар халдварладаг өвчин эзэлж байна.

2016 онд нийт 277 хүн халдварт өвчнөөр нас барсанаас, 132 нь улаан бурхан, 112 нь сүрьеэ, 15 нь тэмбүү, 8 нь ДОХ, 5 нь вируст шар, 2 нь тахал, 1 тохиолдол нь менингит өвчнөөр нас баржээ.

#### Амьсгалын замын халдварт өвчин

2016 онд амьсгалын замын өвчнөөр өвчилсөн 43,198 тохиолдол гарсанаас 70.1 хувь нь улаан бурхан, 15.8 хувь нь салхин цэцэг, 9.4 хувь нь сүрьеэ, 3.2 хувь нь улаан эсэргэнэ өвчнөөр өвдсөн байна. Үүнийг 2015 онтой харьцуулбал, 10,000 хүнд ноогдох сүрьеэгийн өвчлөл 1.2 тохиолдлоор буурсан бол улаан бурхан, салхин цэцэг, улаан эсэргэнэ, гахай хавдар зэрэг өвчнөөр 10,000 хүнд ноогдох тохиолдол 19.8, 3.3, 3.0, 0.3 –аар тус тус нэмэгдсэн байна.

Хатгалгаа нь голдуу бактери болон вирусны гаралтай уушигны халдвартай холбоотой өвчлөл юм. Ихэнх тохиолдолд 2 хүртэлх насны хүүхэд өвчилдөг байна. Шим тэжээлийн дутагдал, хэт олон хүн цугларсан газар болон агаар дахь утааны бохирдол нь энэхүү өвчин үүсэх гол эрсдэлийг бий болгоно. Түүнчлэн хэт хүйтэн цаг агаар өвчин үүсэх нэг шалтгаан болдог. Хөдөө орон нутгийн алслагдсан нутагт, ядуу өрхийн хүүхдүүд энэ өвчнөөр өвдөх өндөр эрсдэлтэй байна.

## Сүрьеэ

2016 оны байдлаар сүрьеэгийн өвчлөл өндөр хэвээр байгаа бөгөөд 10,000 хүн тутамд 13.2 байгаа нь нийгмийн эрүүл мэндэд ихээхэн аюул учруулж байна (Хүснэгт 15.3). Энэ өвчнөөр өвчлөх явдал Сэлэнгэ аймаг (10,000 хүн тутамд 18), Улаанбаатар хот (10,000 хүн тутамд 17.7), Дархан уул аймаг (10,000 хүн тутамд 17.4), Дорнод аймагт (10,000 хүн тутамд 15.6), Говьсүмбэр аймаг (10,000 хүн тутамд 15.1), Хэнтий аймаг (10,000 хүн тутамд 13.6)-г улсын дундаж хэмжээнээс дээгүүр байна.

2016 онд шинээр бүртгэгдсэн 4,045 сүрьеэгийн тохиолдлоос 2,469 нь Улаанбаатар хотод ноогдож байна (61 хувь). Шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдлын 63.6 хувь нь 15-44 насны бүлэгт ноогдсоноос 53.5 хувь нь эрэгтэй, 46.5 хувь нь эмэгтэйчүүд байв. Эдгээр шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн 2,131 тохиолдол нь уушигны сүрьеэ, үлдсэн 47.3 хувь нь уушигны хурц хэлбэрийн сүрьеэ байна. Энэ онд сүрьеэгийн оношлогоо 84.8 хувь, эмчилгээний үр дүн 80.64 хувь байна.

Улаанбаатар хотод эмэнд мэдрэг, олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн оношлогоо зурцаар батлагдсан хүмүүсийн гуравны нэгээс дээш хувьд оношлогдсон ба эмчилгээ амжилтгүй болсон байна. 2006-2012 оны хооронд эмэнд мэдрэг, олон эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвдсөн хүмүүсийн хувь 0-ээс 17 болтол өсчээ.

**Хүснэгт 15.3: Халдварт болон нянгаар дамждаг өвчний тохиолдол, 2007, 2011-2016 он, 10,000 хүн ам тутамд ноогдох**

	2007	2011	2012	2013	2014	2015	2016
Халдварт салмонелла	..	0.4	0.4	0.3	0.3	0.5	0.6
Шигелоз	..	7.6	7.4	7.0	7.9	9.2	9.3
Сүрьеэ	16.8	14.3	14.2	14.6	14.2	14.4	13.2
Бруцелёз	..	1.4	1.6	1.3	0.9	1.0	0.5
Салхин цэцэг	..	11.1	10.1	16.6	15.8	19.0	22.3
Улаан бурхан	..	0.0	0.0	0.0	0.0	79.2	99.0
Вируст шар	38.4	52.8	24.7	9.0	3.9	3.0	1.9
А	..	49.0	21.2	5.7	1.1	0.3	0.1
В	..	2.7	2.3	2.2	2.0	1.6	1.2
С	..	0.5	0.6	0.4	0.4	0.4	0.3
Гахайн хавдар	3.7	3.7	32.6	18.7	1.5	0.8	1.1
Тэмбүү	12.7	15.3	17.8	22.2	23.5	25.9	20.3
Гонкоккийн халдвар	17.5	18.6	19.2	17.2	15.5	16.8	14.3
Трихомониз	..	14.4	15.0	13.5	13.0	13.6	14.3

Эх сурвалж: Эрүүл мэндийн үзүүлэлтүүд, Эрүүл мэндийн хөгжлийн төв, 2016, 2017 он.

Улаан бурхан

Улаан бурхан өвчнөөс сэргийлэх тариа хийлгэсэн 1 настай хүүхдийн тоо 1991 оноос хойш өсчээ. 1991 онд улаан бурханаас сэргийлэх тариа хийлгэсэн 1 настай хүүхдийн хувь 82, 1997 онд 90.6 хувь, 2002 онд 98.5 хувь, 2015 онд 97.5 хувь болсон байна. Улаанбаатар хотын хүүхдүүдийн хувьд 2013 онд 94.5 хувь, 2014 онд 94.7 хувьтай байсан байна.

Улаан бурханы тохиолдол 2012, 2013, 2014 онд үндсэндээ бүртгэгдээгүй, 2013 онд 100,000 хүүхдэд өвчлөлийн түвшин 0.1 тохиолдол болсон (2 тохиолдол бүртгэгдсэн) байна. Харин 2015 оны 3 сараас эхлэн улаан бурханы дэлгэрэлт эхэлжээ. Энэ оны эхний 4 сард Эрүүл мэнд, спортын яамд энэ өвчний 105 тохиолдол гарсаныг мэдээлсэн байна. Эдгээрээс 59 тохиолдол нь лабораторын шинжилгээгээр баталгаажсан, 46 нь клиникийн түвшинд батлагдсан тохиолдол байна. Эдгээрийн 90 хувьд нь 8 сараас доош насны нярай өвчилсөн байна. Нийтдээ 2016 онд нийт 21 аймагт 30,273 улаан бурхан өвчнөөр өвдсөн тохиолдол бүртгэгджээ. Дэлхий нийтийн хэмжээгээр энэхүү үхлийн аюултай өвчнөөс урьдчилан сэргийлэх аюулгүй, үр дүн өндөртэй вакцин хүрэлцээтэй байгаа ч гэсэн 5-аас доош насны хүүхдийн үхлийн үндсэн шалтгаан нь улаан бурхан өвчин болсон хэвээр байна. Түүнчлэн судалгаанаас улаан бурханы вирус нь ихэнхдээ уушигны хатгаа буюу суулгах өвчин тусахад хүргэж энэ нь улаан бурхан өвчнөөр нас барсан хүүхдийн тоонд нөлөөлж байгаа нь харагдаж байна.



Вакцинжуулалтын түвшин маш өндөр, 96 хувьтай байгаа ч гэсэн 2015 оны улаан бурхан өвчний дэгдэлт нь иргэдийн тодорхой бүлгийн дунд дархлаажуулалтын завсар байгааг харуулсан байна. Одоогоор байгаа өвчний тархалтын дүн шинжилгээний дүнгээс харвал энэ өвчнөөр 18-30 насны хүмүүс болон улаан бурханы анхны вакцин хийлгэх хугацаа арай болоогүй 8 сараас бага настай нярай голдуу өвчилж байсан байна. Энэ нь иргэдийн дунд 1986-1998 оны хооронд төрсөн (одоо 18-30 настай) хүмүүс, мөн эхийн дархлааг өвлөөгүй дөнгөж төрсөн нярай нь улаан бурханы эсрэг вакцины дархлаа тогтоогүй бүлэгт орж байгааг харуулж байна. Энэ иргэдийн дархлааны завсрын бүлгийн хүмүүсийг хамгаалах гол арга нь энэ бүлгийн хүмүүсийг улаан бурханы эсрэг вакцинжуулан компанит ажлыг хийх хэрэгтэй байна. Иймд Засгийн газар энэ хоёр бүлгийн дархлааг бэхжүүлэхийн тулд улаан бурханы вакцинжуулалтыг зохистой хэрэгжүүлэх шаардлагыг харгалзан 18-30 насны бүлгийн хүмүүсийн нэмэлт вакцинжуулалтыг 2016 оны 5 дугаар сард зохион байгуулсан байна.

#### Ходоод гэдэсний халдвар

2016 онд ходоодны нийт 9,086 халдварын тохиолдол бүртгэгдсэнээс улаан суулга 61.3, цусан суулга 31.3 хувь, хоолны хордлого 4.7 хувь, салмонелла 2.0 хувь, суулга 0.2, А вируст шар өвчин 0.4 хувийг эзэлж байна. 2008 оны 5 дугаар сард Ентеровирус 71 ам гэмтэх өвчин Монголд дэгдэж, олон мянган хүүхэд айл өрх өртөж, нийт 3,210 тохиолдол бүртгэгдсэн байна. Ентеровирусийн халдвараар өвчилсөн хүмүүсийн 83 хувь нь 10 хүртэлх насны хүүхэд, 10 хувь нь 1 хүртэлх насны хүүхэд байв. Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн ажилтнууд, сайн дурынхан эрүүл ахуйг сайжруулах, энэ өвчнөөс сэргийлэх мэдлэгийг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулсан байна.

Булчин задлах тахал 1996 онд дэгдэж, 100 орчим хүнийг хамарсаныг нэн даруй хяналтад авсан бөгөөд түүнээс хойш дахин ийм өвчний тохиолдол бүртгэгдээгүй. Харин энэ тахал гарсан шалтгааныг хараахан тогтоож чадаагүй байна.

Уснаас үүдэлтэй гэдэсний хижиг өвчнөөр 1999 онд Дундговь аймгийн төвд 19 хүн өвчилсөн, мөн уснаас үүдэлтэй А вируст шар өвчнөөр 2000 онд Өвөрхангай аймагт 291 хүн өвчилсөн байна.

Уснаас үүдэлтэй халдварт өвчин мөн 2004 онд Ханхонгор суманд гарч, нийт 123 хүн цусан суулгаар өвчилсөн.

#### Вируст шар өвчин

2016 онд вируст шарын 566 тохиолдол бүртгэгдсэнээс В вируст шар 46.6 хувь, С вируст шар 18.2 хувь, А вируст шар 6.9 хувь, бусад вируст шар өвчин 28.3 хувийг эзэлж байжээ.

Шар өвчний бүх төрлийн 10,000 хүн тутмын тохиолдол 2007 онд 38.4 байсан бол 2011 оны 52.1 хүртэл өссөн нь 2005 оноос хойших хамгийн өндөр үзүүлэлт байв. 10,000 хүн тутам дахь шар өвчин 2014 онд 3.9, 2015 онд 3.0, 2016 онд 1.9 тохиолдол болтлоо буурсан байна.

Вакцинжуулалт болон нэг удаагийн тариагуур ашиглах болсон нь вируст шар өвчнийг бууруулахад хувь нэмэр оруулсан гэж үзэж байна.

#### Бэлгийн замаар дамжих халдвар

2016 онд бүртгэгдсэн нийт халдварт өвчний 21.5 хувийг бэлгийн замаар дамжих өвчин (БЗДӨ) эзэлж (14,964 тохиолдол) байгаагаас тэмбүү 41.4, заг хүйтэн 29.2, трихомонад 29.2, ДХДВ\ДОХ 0.2 хувийг тус тус эзэлж байна. 2016 оныг 2015 онтой харьцуулвал төрөлхийн тэмбүү өвчний 42 тохиолдол ажиглагдсанаас (2015 онд 52 тохиолдол бүртгэгдсэн) 25 нь Улаанбаатар хотод гарсан байна. Ингэж төрөлхийн тэмбүү өвчний тохиолдол буурсан нь жирэмсний үеийн хяналт сайжирсантай холбоотой байна. БЗДӨ 2016 онд хамгийн олон тохиолдол Баянхонгор (10,000 хүн тутамд 36.5 тохиолдол), Дорнод (34.7), Сүхбаатар (31.5), Хөвсгөл (26.5), Говь-Алтай (24.0), Төв (23.7), Говьсүмбэр (23.7), Дорноговь (21.3), Улаанбаатар хотод (22.2) ажиглагдсан байна. Трихомонад өвчний улмаас нас баралт Дорнод (60.7), Баянхонгор (53.3), Булган (17.5), Сүхбаатар (15.8) аймаг, мөн Улаанбаатар хотод (15.4) байсан нь улсын дундаж (14.3) болон аймгуудын дундажаас (13.3) дээгүүр байсан байна.

Монголд ДХДВ\ДОХ-н анхны тохиолдол 1992 онд бүртгэгдсэнээс хойш 2016 оны эцсийн байдлаар нийт ДХДВ\ДОХ-ын 225 тохиолдол бүртгэгдэн ба 2005 оноос хойш ДОХ-ын халдвар аажмаар өсч байна. 2005 онд ДОХ-ын 11 шинэ тохиолдол гарч байсан бол 2016 онд 26, 2014 онд хамгийн их 31

шинэ тохиолдол бүртгэгдсэн байна. 2014 онд ДОХ-ын халдвараар 5 хүн нас барсан нь мөн хамгийн дээд үзүүлэлт болжээ.

ДОХ-ын халдварын дийлэнх, 98 хувь нь бэлгийн замаар дамжсан байна. Одоогоор цус, эмнэлгийн үйлчилгээ, эхээс хүүхдэд дамжсан ДОХ-ын тохиолдол тэмдэглэгдээгүй.

#### Мал амьтнаас хүнд халдварладаг болон салхиар зөөгддөг өвчин

2016 онд халдварт өвчний 0.7 хувь нь мал амьтнаас хүнд халддаг өвчин байна.

Мэрэгч амьтны ажиглалтыг байнга хийдэг бөгөөд малчид мэрэгч амьтан тархаж байгаа талаар гомдол мэдүүлдэг. Мэрэгчид нь тахал, лептоспирозын халдварын эх үүсвэр болдог ба өвчин үүсгэгч мөчлөгт нөлөөлдөг байж болзошгүй юм.

#### Тахал

Монголын хэд хэдэн бүс тахлын голомттой боловч тахлаар өвчилсөн тохиолдол бага байгаа нь хүнд халдварлах явдал төдийлөн дэлгэрээгүйг харуулж байна. *Yersinia pestis*-ын халдвараар тахлаар өвчилсөн хүний тоо жилд 40 орчим байгаа ба дийлэнх нь хөдөөд тохиолддог. Хүмүүс тахлаар өвчилдөг гол эх үүсвэр нь тарвага (*Marmota sibirica*) агнаж, тарваганы мах иддэгт оршдог. Мөн хоёр төрлийн зурам (*Rhombomys opimus*), (*Meriones unguiculatus*) нь өвчний эх үүсвэр байж болох талтай. Ж.М.Риелм нар (Ж.М.Риелм, бусад, 2011 он)<sup>1</sup> *Yersinia pestis*-ын халдвар тээгч гол эх үүсвэр болох, тахлын бодит байдалд илүү анхаарал хандуулах шаардлагатайг тэмдэглэж байна. Хүн амын нягтрал багатай байдал нь хүмүүс тахлаар өвчлөх явдлыг хязгаарлаж байна.

#### Бурцелёз

Бурцелёз (*Brucella melitensis*) нь Монголын өвчтөнүүдийн цуснаас ялгарсан хамгийн түгээмэл бруселла байх талтай. Монголд хүнд бурцелёз халдварлах явдал малтай шууд харьцаж байгаа, малтай харьцах болон нядлах явцад шархаар дамжих, заримдаа сүүгээр дамжих тохиолдол гарч байна. 2003 оны Халдварт өвчний тархалт судалгаанаас<sup>2</sup> үзвэл 2001 оны байдлаар архаг бруцелёзын 8,000 орчим тохиолдол бүртгэгдсэн байв.

2016 онд 10,000 хүн тутамд бруцелёзын тохиолдол 0.5 байсан байна. Дорнод (11.6), Сүхбаатар (1.2), Архангай (0.9), Хэнтий (0.7) аймгуудад бруцелёзын тохиолдол улсын дундажаас дээгүүр байна.

#### Хачигаар дамждаг өвчин

Хачиг нь хачигт реккетсиоз, энцефалит, боррелиоз болон хижиг өвчний эх үүсвэр болдог байна.

2012 оны Монгол дахь малын хачигт өвчнийг илрүүлэх, халдварын судалгаанд<sup>3</sup> хоёр аймгийн мал сүрэгт хачигт өвчний өндөр тохиолдол байгааг тэмдэглэсэн байна. Хачигт өвчний тархалт бүсээс нэлээд шалтгаалж байна. Тухайлбал Хөвсгөл аймаг *A. phagocytophilum* (64 хувь), *A. ovis* (77 хувь); Хэнтий аймгийн мал реккетсиозын төрөлд (48 хувь) илүү өртөмтхий байна. Эдгээр өвчин үүсгэгчүүд нь мал болон хүний эрүүл мэндэд нөлөөлөх боломжтой.

#### Бусад

Туляремийн тохиолдол хаяа бүртгэгддэг. Монгол улсад үхэр, хонь, ямааны боом өвчин гарах тохиолдол бий. Хүний ходоодны боом болон арьсны харшлын тохиолдол хаяа гардаг.

Чоно, нохойд галзуу өвчний тохиолдол бий бөгөөд хүнд халдварлах магадлалтай.

Монгол Улс полиомелитээс чөлөөт улс болсныг ДЭМБ 2000 онд зарласан байна.

<sup>1</sup> Riehm, Julia M. et al. (2011). *Ersinia pestis* in Small Rodents, Mongolia. *Emerging Infectious Diseases* - Vol. 17, No. 7, July 2011.

<sup>2</sup> Ebright J.R. et al. (2003). *Emerging Infectious Diseases in Mongolia*. *Emerging Infectious Diseases*, volume 9, number 12 – December 2003.

<sup>3</sup> Sophia, P. et al. (2012). *Detection and Epidemiology of Tick-Borne Pathogens in Free-Ranging Livestock in Mongolia*. *Journal of Clinical and Experimental Pathology* S3:006.

## 15.2 Байгаль орчинтой холбоотой эрүүл мэндийн эрсдэл, нас баралт, өвчлөлд байгаль орчны хүчин зүйлийн нөлөө

### *Гадна, дотор орчны агаарын бохирдол*

Улаанбаатар хотын агаар дахь тоос, шорооны агууламжийн үнэлгээний судалгаагаар<sup>4</sup> 2012-2013 оны байдлаар хөрс, хог хаягдлын шатаалт, цахилгаан станц, жижиг оврын зуух, барилга байгууламж, замын ажлын тоос, тээврийн хэрэгсэл зэрэг бохирдуулагчийн гол эх үүсвэрүүд байгааг тодорхойлсон байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлын нэг гол эх үүсвэрийг нүүрс шатаалтын утаа болохыг тогтоожээ. Улаанбаатар хотын захиргаа сайжруулсан, утаа бага ялгаруулдаг зуух нэвтрүүлэх, ядуу айл өрхөд чанартай нүүрс олгох, 2012 онд 1,000 өрхөд цахилгаан халаагуурын систем суурилуулах, оройн 9-өөс өглөөний 6 цагийн хооронд цахилгааны ашиглалтын төлбөрийг тэглэх зэрэг арга хэмжээ хэрэгжүүлэн агаарын бохирдлыг бууруулахыг чармайж байна. Агаар бохирдуулагчийн агууламж 10-аас 4 дүгээр сарын хүйтний улиралд агаарын температур хасах 40 хэм хүрэхэд хамгийн өндөр байдаг.

Агаар бохирдуулагч  $PM_{2.5}$  тоосонцорын жилийн дундаж хэмжээ 70 г/м<sup>3</sup> байгаа нь Монгол улсын агаарын чанарын стандартаар тогтоож өгсөн 25 г/м<sup>3</sup>, ДЭМБ-ын зөвшөөрөгдсөн 10 г/м<sup>3</sup> үзүүлэлтээс ихээхэн дээгүүр байна. Агаарын бохирдол нь хүүхдийн уушигны хатгаа, насанд хүрсэн хүмүүсийн зүрх судасны өвчний гол шалтгаан болж байна (Шигтгээ 15.2). Хүүхэд ахуйдаа агаарын бохирдолд өртсөн тохиолдолд хожим нь архаг өвчний суурь болох магадлалтай.

Эрүүл мэндийн үйлчилгээнд агаарын бохирдлын үзүүлэх нөлөөллийн 2016 оны судалгаа<sup>5</sup> болон судалгааны зардлын тооцоо нь амьсгалын замын нийт өвчний 19.5 хувь, зүрх судасны өвчний 23.5 хувь нь агаарын бохирдлоос үүдэлтэй болохыг тогтоосон байна. Агаарын бохирдол нь эрүүл мэндийн үйлчилгээнд ихээхэн дарамт учруулж байна. 2010 оны тооцоогоор агаарын бохирдолтой холбоотой өвчний улмаас ажлын чадвараа түр алдсаны шууд бус зардал, эдийн засгийн хохирол нь амьсгалын замын өвчний хувьд 551.4 сая төгрөг, зүрх судасны өвчний хувьд 173.9 сая төгрөг байна.

Нас баралтын 2009 оны статистикт үндэслэн Улаанбаатар хотын агаарын бохирдлын үнэлгээ, түүнтэй холбоотой нас баралтын тооцоог<sup>6</sup> гаргахад 623 хүн агаарын бохирдлоос шалтгаалан нас барсан байв. Энэ нь хотын хэмжээний нийт 6,426 нас баралтын 9.7 хувь, улсын жилийн нийт 15,522 нас баралтын 4.0 хувийг эзэлж байна. Зүрх судасны өвчнөөр нас барсан Улаанбаатар хотын иргэдийн 29 хувь, уушигны өвчнөөр нас барсан хүмүүсийн 40 хувь нь гадна агаарын бохирдлоос үүдэлтэйг тооцоолжээ. Гэвч энэ тооцоо нь Улаанбаатар хотын агаарын бохирдлын нийгмийн эрүүл мэндэд учруулж буй бодит нөлөөллийг дутуу үнэлсэн гэж үзэх хэд хэдэн шалтгаан бий. Тухайлбал судалгаа нь зөвхөн дотор агаарын бохирдлыг харгалзсан, дүн шинжилгээг зөвхөн  $PM_{2.5}$  тоосонцорт үндэслэсэн, нас баралтын шалтгааныг зөвхөн 30-аас дээш насны хүмүүсийн дунд тогтоосон байна. Агаарын бохирдлын түвшин стандартаас хэтэрсэн нөхцөлд хүн амд мэдээлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах зарлан мэдээллийг радио, телевиз, гэрэлт дэлгэц зэрэг хэрэгслээр түгээж байна.

Тээвэр болон суурин эх үүсвэрийн агаарын бохирдол, Монгол улсын хүн амын эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөний талаар хийсэн судалгаа хомс байна .

### Ургамлын тоосонцор

Агаар дахь ургамлын тоосонцорын улирлын агууламж, тархалтын талаар мэдээлэл байхгүй байна.

### Дотор агаарын бохирдол

Дотор агаарын янз бүрийн бохирдуулагчийн (барилгын материал, хөгз) агаарын чанар, нийгмийн эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөний талаарх мэдээ мэдээлэл тун хомс. Дотор хатуу түлшийг халаалт болон хоол хүнсээ бэлтгэхэд ашиглах нь туйлын түгээмэл байгаа нь хатгаа, хорт хавдар, дутуу жинтэй

<sup>4</sup> Amgalan, N. et al. (2016). Valuation of elemental concentration of particulate matter in Ulaanbaatar, Mongolia. Open Journal of Air Pollution, 2016, 5, 160-169.

<sup>5</sup> Oyuntsetseg P. (2016). Impact of air pollution on health care services and its cost. International expert consultation on understanding and addressing the impact of air pollution on child health in Mongolia. Abstract book, Ulaanbaatar, Mongolia 25-26 January 2016.

<sup>6</sup> Allen, R. W. et al. (2013). An assessment of air pollution and its attributable mortality in Ulaanbaatar, Mongolia (2013). Air Quality Atmosphere and Health (2013) 6:137-150.

хүүхэд төрөх, багтраа зэрэг амьсгалын замын хурц өвчний эрсдлийг нэмэгдүүлж байна.

Дотор агаарын чанарын эрүүл мэндэд үзүүлж буй эрсдлийн талаар 2003-2004 онд хийсэн үнэлгээнээс<sup>7</sup> үзвэл хамрагдсан хүүхдүүдийн 19 хувь нь бронхит, 1.4 хувь нь багтраа, 77.8 хувь амьсгалын замын өвчний шинж тэмдэгтэй байв. Эдгээр өвчин гэр, байшинд амьдардаг хүүхдүүдийн дунд илүү тохиолдож байна. Нүүрс төрөгчийн дутуу исэл (СО) болон агаар дахь тоосонцорын (РМ) нягтшилт гэр, байшинд орон сууцнаас илүү байгаа бөгөөд СО, тоосонцорын нягтшилт болон хүүхдийн бронхитын хооронд шууд холбоо бий.

Сайжруулсан зуухны дотор агаарын чанарт үзүүлж буй нөлөөний судалгааг 2005 онд Улаанбаатар хотод хийж, 65 гэрийн доторх РМ, СО-гийн агууламжийг 24 цагаар хэмжсэн байна<sup>8</sup>. Янз бүрийн зуух ашиглаж байгаа байшингуудын дотор агаарын РМ, СО-гийн агууламж 24 цагийн Монголын стандартаас дээгүүр байсан ба ялангуяа РМ тоосонцорын агуулга маш өндөр байв. Дотор агаарын бохирдуулагчийн агууламж ДЭМБ-гаас зөвшөөрөгдсөн хэмжээнээс мөн илүү байна.

2016 онд Улаанбаатар хотод РМ<sub>2.5</sub> тоосонцор болон цусан дахь хар тугалгын түвшингийн талаар хийсэн судалгаагаар<sup>9</sup> гэрт амьдарч ердийн зуух ашигладаг 40-60 насны эмэгтэйчүүд орон сууцанд амьдардаг хүмүүсээс РМ<sub>2.5</sub> тоосонцорын илүү нягтшилтад өртөж байгааг тогтоожээ. РМ<sub>2.5</sub> тоосонцорын 127.8 мг/м<sup>3</sup> агууламж нь 24 цагийн дундаж нагууламжийн Монголын улсын стандарт болох 50 мг/м<sup>3</sup> –аас 2-3 дахин илүү байна.

Нүүрсний шаталтаар ажилладаг зуух, халаалтын бусад төхөөрөмжүүд нь дотор агаарын СО-гийн ялгаруулалтын гол эх үүсвэр юм. СО хий нь үнэргүй тул хүн түүнийг мэдэрдэггүй ба СО-гийн хордолт үхэлд хүргэж болзошгүй. СО-гийн хордолтын тохиолдол одоогоор бүртгэгдээгүй бөгөөд ямарваа нэгэн сэргийлэх арга хэмжээ авдаггүй байна.

Улаанбаатар дахь хүүхдийн хатгаа болон түүнийг бууруулах боломж судалгааг 2016 онд хийж, хатгааны эрсдлийн гол хүчин зүйлийг хүйтэн цаг агаар, тэжээлийн доройтол, төвлөрөл болон дотор агаарын утаа гэж тогтоожээ<sup>10</sup>. Утаанд агуулагдах нүүрстөрөгчийн дутуу исэл нь жирэмсэн эмэгтэйн уургийн цусны эргэлтийг бууруулдаг нь дутуу жинтэй хүүхэд төрөхөд нөлөөлдөг байна. Дутуу жинтэй хүүхдүүд хатгаа тусах өндөр эрсдэлтэй байдаг.

Сургууль болон эрүүл мэндийн үйлчилгээний байгууламжуудын дотор агаарын чанарт хяналт хийсэн, сэргийлэх арга хэмжээ авсан талаар мэдээ мэдээлэл байхгүй байна.

#### Тамхины утаа

Тамхины хэрэглээ нь дэлхийн ХБӨ эрсдлийн гол шалтгаан болж байгаагийн зэрэгцээ Монгол дахь нас баралтын тэргүүлэх шалтгаан болдог. 2013 оны байдлаар 15 –аас дээш настай нийт хүн амын 27.1 хувь тамхи татаж байна. Эрэгтэйчүүд (49.1 хувь) эмэгтэйчүүдээс (5.3 хувь) хавьгүй их тамхи татаж байна.

<sup>7</sup> Ministry of Health (2003-2004). Health risk assessment of indoor air quality. Ulaanbaatar-Mongolia 2003-2004 – MOG/HSE/4.3/001.

<sup>8</sup> Cowlin, S. C., Kaufmann, R.B., and Edwards, R. (2005). Impact of Improved Stoves on Indoor Air Quality in Ulaanbaatar, Mongolia. Energy Sector Management Assistance Program.

<sup>9</sup> Enkhbat, U. et al. (2016). Exposure to PM<sub>2.5</sub> and blood lead level in two populations in Ulaanbaatar, Mongolia. International Journal of Environmental Research and Public Health, 2016, 13, 214.

<sup>10</sup> Mullholand, K. (2016). Pneumonia in children in Ulaanbaatar and the potential for mitigation. International expert consultation on understanding and addressing the impact of air pollution on child health in Mongolia. Abstract book, Ulaanbaatar, Mongolia, 25-26 January 2016.

**Шигтгээ 15.2: Эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл ба суургуулиудын дотор агаарын чанар**

Сүүлийн жилүүдэд орчны болон дотор агаарын бохирдол Монгол улсын орчны эрүүл мэндийн нэн тулгамдсан асуудлын нэг болж байна. 2016 онд ЭМЯ болон Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв НҮБ-ын ХС –ийн санхүүжүүлсэн Эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл ба суургуулиудын дотор агаарын чанарын үнэлгээг хийсэн байна. Энэхүү судалгааг Улаанбаатар хотын агаарын бохирдлын түвшин хамгийн ноцтой байгаа Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн 3 сургууль дээр, мөн Хан уул дүүргийн агаарын бохирдолд өртөж байгаа 3 сургуульд хийжээ.

Сургуулийн хүүхдийн эрүүл мэндэд нөлөөлж байгаа орчин болон сургуулиудын байдлын эрсдлийг үнэлэхийн тулд ажиглалт, лабораторын шинжилгээ, агаарын чанар зэрэг 10 орчим үзүүлэлтийг ашигласан байна. Эдгээрээс анги тасалгааны байгалийн өдрийн гэрэлтүүлэг, цэвэрлэгээний чанар, давтамж болон бага ангийн хүүхдэд тусгай анги хувиарласан байдал гэсэн гуравхан үзүүлэлт л шаардлагыг хангаж байжээ. Нэг хүүхдэд ноогдох талбай, сандал ширээ нь хүүхдийн нас, биенд хэр тохиромжтой байдал, ангийн бичил уур амьсгал, дотор агаарын чанар зэрэг бусад үзүүлэлтүүд стандартыг хангахгүй байсан байжээ.

Энэхүү үнэлгээний гол дүгнэлтүүд нь:

Нэг ангид хэт олон хүүхэд сурч, боломжоосоо хэтэрсэн нөхцөлд ажиллаж байна. Нийт сургуулийн 38.8 хувьд нь нэг хүүхдэд ноогдох талбай 1.5 ам дөрвөлжин метр талбай ноогдох ёстой стандартаас 2.8 дахин бага байгаа бол үнэлгээ хийсэн нийт сургуулийн 22.2 хувьд нь нэг ангийн сурагчийн тоо байж болох хэмжээнээс хэтэрсэн байна.

Сургуулийн сандал, ширээ зэрэг тавилга үндэсний MNS 3213:198 стандартын шаардлагыг хангахгүй, хүүхдийн нас, биенд тохирохгүй хэт жижиг, нарийхан байна.

Анги тасалгааны температур, агаарын чийгшил зэрэг бичил уур амьсгалын үзүүлэлтүүд үндэсний эрүүл ахуйн стандартыг хангахгүй байна. Судалгаанд хамрагдсан анги тасалгааны агаарын температур байх ёстой норм хэмжээ (17–20°C)- нээс 2–3.6°C-аар хэтэрч байсан байна. Түүнчлэн эдгээр ангийн 40.3 хувьд нь өрөөний дундаж чийгшил байх ёстой хэмжээ (30–50%)-нээс доогуур байжээ.

Мөн сонгож хэмжилт хийсэн бүх ангид нүүрсхүчлийн хий CO<sub>2</sub> -ийн агууламж 3,148.9 µg/m<sup>3</sup> байсан нь батлагдсан стандартаас 1.6–1.8 дахин өндөр байсан байна. CO<sub>2</sub> -ийн агууламж өндөр байх нь агааржуулалт муу, ангид хэт олон сурагчтай, нэг хүүхдэд ноогдох талбай хангалтгүй байсан зэрэг бусад үзүүлэлттэй шууд хамааралтай байна.

Агаар дахь жижиг ширхэгтэй тоосонцор PM<sub>2.5</sub> –ийн агууламж агаарын чанарын үндэсний стандартаас 3.1–10.05 дахин өндөр байжээ. PM<sub>2.5</sub> –ийн агууламж Сүхбаатар, Сонгинохайрхан дүүрэг, мөн халаалтын зуух болон шигүү сууршсан гэр, байшингаас ялгардаг агаарын бохирдол хамгийн их байдаг гэр хорооллын сургуулиудаас авсан дээжинд хамгийн их хэмжээтэй байсан байна.

Энэхүү судалгааны ерөнхий үр дүн бол сурагчдын 20-70 хувийнх нь эрүүл мэнд болон сэтгэн бодох чадвар нь тэдний сурдаг сургуулийн орчин, эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл байдал болон бусад орчны нөхцлөөс шууд хамаардаг гэдгийг харуулж байна.

Эх үүсвэр: Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл ба суургуулиудын дотор агаарын чанарын үнэлгээ, 2017 он.

**Усны бохирдол болон ариун цэвэр**

Гүний ус бол ундны усны гол эх үүсвэр боловч зарим тосгон суурин, айл өрх гадаргын усыг ашиглаж байна. Ундны усыг ус дамжуулах хоолой, ус түгээх цэг болон усны машинаар түгээдэг. Ус түгээх цэгийн 43 хувь нь ус дамжуулах төв системтэй холбоотой, 42.9 хувь нь холбоогүй, 13.4 хувийг нь автомашинаар тээвэрлэн усаар хангадаг байна.

НҮБ-ын ТХЗ-ын мэдээллийн санд тусгаснаар 2010 онд Монгол улсын нийт хүн амын 63 хувь (хотын хүн амын 69, хөдөөгийн хүн амын 50 хувь) нь сайжруулсан ундны усны эх үүсвэрийг ашиглаж байна (Хүснэгт 9.12). 2005 онд нийт хүн амын 64 хувь (хотын хүн амын 66, хөдөөгийн хүн амын 59 хувь) нь сайжруулсан ундны усны эх үүсвэрийг ашиглаж байв. Энэ онд Монголын нийт хүн амын 40 хувь нь сайжруулсан ариун цэврийн байгууламж ашиглаж чадахгүй байна (Хүснэгт 9.12). Сайжруулсан ариун цэврийн байгууламж ашиглаж чадахгүй байгаа иргэдийн хувь 2015 онд хот суурин газарт 34 хувь, хөдөөд 57 хувь байна.

Энэ байдал бүс нутгаар ихээхэн ялгаатай байна. Ариун цэврийн байгууламж ашиглаж чадахгүй байх явдал баруун бүсэд хамгийн бага, 2010 оны байдлаар иргэдийн 35.2 хувь нь аюулгүй ундны ус



хэрэглэх боломжтой байна. Үүний зэрэгцээ 2010 онд баруун бүсэд амьдарч байгаа иргэдийн 95 хувь нь сайжруулсан ариун цэврийн байгууламж ашиглах боломжгүй байгаа бол энэ байдал Улаанбаатар хотын бүсэд 63 хувь байна.

Сургууль, дотуур байр, цэцэрлэгийн усны хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйг (УАЦЭА) сайжруулах зорилгоор Монгол дахь НҮБ-ын ХС-гийн газар УАЦЭА-ийн жижиг байгууламжийг контейнерт байгуулсан бөгөөд түүнийг барилга байшин, гэрт холбож болно. Контейнерт 30-60 сурагчдад үйлчлэх урсгал устай суултуур, бие засах цэг, угаагуур, усанд орон шүршүүрийг байрлуулсан байна. Ийм контейнерүүдийг 2014 оноос нэвтрүүлж эхлэн Хөвсгөл аймаг, Налайх дүүрэгт байрлуулсан байгууламжууд 1,400 орчим хүүхдэд үйлчилжээ. Сургуулиудад ийм байгууламж байгуулсан нь хүүхдийн эрүүл ахуй, зан харьцааг сайжруулах, эрүүл, хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэхэд хувь нэмэр оруулсан байна.

Ундны ус, ариун цэврийн байгууламж хангалтгүй, ундны усны чанар муу байгаа нь ходоодны халдвар үүсгэх гол эрсдлийг дагуулж байна. Улаан суулга, гэдэсний хижиг зэрэг ходоодны өвчин түгээмэл байна.

Рашаан булгийн орчимд бохирдол, чанарын доройтлоос хамгаалах ажил зохион байгуулж байна. Рашаан булгийн орчимд 50-100 метрийн тойрог ариун цэврийн хамгаалалтын бүсийг байгуулдаг. Тойргийн хэмжээг рашаан булгийн урсацыг харгалзан тогтоодог хэдий ч олон тохиолдолд бүсийг нарийвчлан тогтоогоогүйн улмаас энэ ажил хэрэгжихгүй, бохирдлын эх үүсвэр байсаар байна.

2004 оны 3 дугаар сараас 2006 оны 9 дүгээр сард Улаанбаатар болон 21 аймагт хэрэгжүүлсэн “Монголын эрүүл булаг шанд” төслөөр Улаанбаатар хотын орчмын болон төвийн бүсийн ихэнх рашаан булгийн эрүүл ахуйн байдал хангалтгүй байгааг тогтоосон байна. 2004 оны судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотын 28, орон унтгийн 99, нийт 127 булаг шандын ихэнх нь ямарч хамгаалалтгүй, орчин тохижоогүй байв. Төслийн хэрэгжилтийн явцад 2006 онд Улаанбаатар хот, 19 аймгийн 28 булаг шандыг хамгаалалтад авч тохижуулсан байна. “Монголын эрүүл булаг шанд”, “Булаг шандын усны чанарыг хамгаалъя” төслүүдийн хүрээнд 2004-2005 онд Улаанбаатар хот, Дархан-Уул аймагт сургалтууд зохион байгуулжээ. Сургалтуудын зорилго нь уснаас үүдэлтэй эрүүл мэндийн эрсдлээс сэргийлэх, ард иргэдийн хандлагыг өөрчлөх, өрхийн түвшинд ус цэвэршүүлэх зохих арга хэмжээ авах, булаг шанд болон ундны усны бусад эх үүсвэрийн хамгаалалт, тохижуулалтын талаарх оролцогчдын мэдлэг чадварыг дээшлүүлэхэд оршиж байв. Засгийн газар булаг шандыг хамгаалах ажлыг 2016 оноос зохион байгуулж, 2,299 булаг шандыг хамгаалалтад авсан байна (Зураг 9.1).

МХЕГ-аас 2012 онд ундны усны чанарын байдалд хийсэн 602 сорьцын шинжилгээ нь нийт сорьцын 1.5 хувьд нь шүвтрийн агууламж стандартаас дээгүүр, 10.1 хувьд нь нянгийн агууламж стандартаас дээгүүр, 4.8 хувьд нь Е.колийн агууламж стандартаас дээгүүр байгааг тогтоосон байна. 218 суманд хийсэн усны чанарын хяналт дээрх үзүүлэлтийг батлан, сорьцын 0.8 хувьд нь шүвтрийн агууламж зөвшөөрөгдсөн дээд хэмжээнээс (ЗДХ) дээгүүр, 19.6 хувьд нь нянгийн агууламж ЗДХ-ээс дээгүүр, 9.6 хувьд нь Е.колийн агуулга илэрсэн байна. Хяналтад хамрагдсан сумдын тоо аймаг тус бүрээр ялгаатай, 30-100 хувийн хамралттай байсан ба 2012 онд Хэнтийн 17 сум, Баянхонгорын 20 сумд ундны усны хяналт мониторинг хийгдээгүй байна. 2015 оны байдлаар нянгийн үзүүлэлтээр төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн 12.8 хувь, төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн 28.1 хувь ундны усны чанарын стандартыг хангахгүй байна.

Говь болон өмнөд бүсийн газрын доорхи гүний ус эрдсийн өндөр агууламжтай, хатуулаг чанар өндөр байдаг. 80 сумын ундны усны кальци, магни, хлор, хүхрийн ионы нягтшилт монголын холбогдох стандартаас давж байгаа нь бүсийн хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх магадлалтай.

2005 оны байдлаар усан дахь хүнцэлийн нягтшилт нийт сорьцын 10.3 хувьд зөвшөөрөгдсөн 0.01 мг/л стандартаас давж, хамгийн их 0.05 мг/л агууламж Төв аймагт бүртгэгдсэн байна.

МХЕГ-аас 2013 онд говийн аймгуудын 63 сумдын 142 худгаас авсан сорьцын судалгаагаар 19 сумын ус дахь мөнгөний нягтшилт Монголын стандартаас 12-81 дахин, 16 сумын ус дахь хүнцэл 1-6 дахин, сумын ус дахь хлор 2.6 дахин, 6 сумын ус дахь төмөр 27-728 дахин, 7 сумын ус дахь магни 17 дахин, тугалга 40 дахин илүү байгааг тогтоосон байна. Төмрийн ийм өндөр агууламж хүн амын эрүүл мэндэд нөлөөлнө.

Зарим газар усыг хотын болон төвлөрсөн ус хангамж, ус түгээх цэгээс бохир саванд авах, бохир, химийн бодис ялгаруулдаг, нян үүсгэх саванд хадгалж байна. “2010-2015 оны усны аюулгүй байдлын

төлөв байдал” илтгэлд тэмдэглэсэнээр айл өрхийн усны сорьцын 55.2 хувь нь нянгийн бохирдолтой, бохирдсон эх үүсвэрээр авсан, ихэнх өрхүүд ундны усыг зориулалтын бус саванд хадгалдаг, угаалга, ариутгал шаардлага хангахгүй байна. Уул уурхайн орчмын гадаргууны ус, ундны усанд тугалга илэрсэн байна. 2015 оны байгаль орчны эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийн судалгаа<sup>11</sup> нь усыг зориулалтын бус шатахууны, пластик саванд хадгалах нь тугалгын өндөр агууламж үүсгэж болохыг тэмдэглэжээ. Монгол улсын хүүхдийн нөхцөл байдлын 2014 оны дүн шинжилгээнд 2010 оны байдлаар ус авах ажлыг голуу эрэгтэйчүүд хийдэг хэдий ч эмэгтэйчүүдийн 31 хувь, 15-аас доош насны хүүхдийн 11 хувь мөн хийж байна. Бага насандаа хүнд ачааг байнга тээсэн нөхцөлд ар нурууны согог гэмтэлтэй болох магадлалтай.

Савласан рашаан, усны чанарын хяналтын мэдээ мэдээлэл байхгүй байна.

#### *Ахуйн хэрэгцээний ус*

#### Халуун усны газар, бассейн, халуун рашаан

Халуун усны газар, бассейн, халуун рашааны усны чанарын тухай дорвитой мэдээ мэдээлэл байхгүй байна.

Улаанбаатар хотын Мэргэжлийн хяналтын төв лаборатори 2017 оны 10 сард хотын 5 дүүрэг ажиллаж байгаа 13 байгууллагын 11 усан бассейн, 12 халуун, хүйтэн угаалгын газарт уснаас нь дээж авч шинжилжээ. Хлорын тунадас болон бичил организмын халдварыг MNS 6186:2010 стандартын микробиологийн шинжилгээний анализ, мөн бактерийн болон химийн анализийн MNS 7793-3:2008 стандартыг ашиглан шинжилсэн байна. Шинжилгээний дүнд хлорын агууламж нийт шинжилсэн дээжийн 56 хувьд зөвшөөрөгдөх хэмжээнээс доогуур байгааг харуулжээ. Мөн шинжилгээнд хамрагдсан халуун усны газруудын дээжний 65 хувьд нь олон тооны антибиотик эмэнд тэсвэртэй микро-органзмын халдвар байгааг тогтоосон байна.

#### Легионелозис сэргийлэх

Легионелозийн тохиолдол бүртгэгдээгүй байна. Түүнээс сэргийлэх арга хэмжээ авдаггүй хэдий ч Монголд халуун ус түгээх сүлжээ, агааржуулагч систем, халуун рашаан зэрэг легионеллагийн голомт байж болох талтай. Легионеллагийн судалгаа байхгүй тул энэ нь нийгмийн эрүүл мэндтэй холбоотой эсэх асуудлыг тогтооход бэрхшээлтэй.

#### *Цацраг*

Суурь цацрагийн хэмжилтийг цацраг хяналтын 39 станцад өдөрт 2 удаа хийж байна. Эрүүл мэндэд цацрагийн үзүүлсэн нөлөөний талаар мэдээ мэдээлэл байхгүй.

#### Эмнэлэгт цацраг ашиглаж буй байдал

Цацрагт өртсөн, сэргийлсэн, бүртгэгдсэн талаар мэдээ мэдээлэл байхгүй.

#### Цахилгаан соронзон орон, хэт ягаан туяаны цацраг

Цахилгаан соронзон оронд хэмжилт хийдэггүй, сургууль, эрүүл мэндийн төв зэрэг эмзэг байгууламжуудыг сэргийлэх тусгай арга хэмжээ авдаггүй байна.

Монголд хэт ягаан туяаны индекс 5, 6, 8 дугаар саруудад өндөр (6-7 дугаар түвшин), 7 дугаар сард маш өндөр 8 дугаар түвшинд хүрдэг байна. Эрүүл мэндэд хэт ягаан туяаны үзүүлсэн нөлөөний талаар мэдээ мэдээлэл байхгүй.

#### *Дуу, чимээ шуугиан*

Эрүүл мэндэд дуу, чимээ шуугиан, чичрэлтийн үзүүлсэн нөлөөний талаар мэдээ мэдээлэл байхгүй байна. Улаанбаатар хотын замын түгжрэл, уул уурхайн орчмын чимээ шуугианыг эс тооцвол хүн амын эрүүл мэндэд ихээхэн сөрөг нөлөөтэй нь илэрхий орчны энэ хүчин зүйлд анхаарал хандуулаагүй байна. Чимээний чанарын стандарт үйлчилж байна. Өдрийн 7-оос 22 цагт зөвшөөрөгдсөн хэмжээ 60 дБ, шөнийн 22-оос өглөөний 7 цагт зөвшөөрөгдсөн хэмжээ 45 дБ байна.

<sup>11</sup> Jadambaa, A. et al. (2015). The impact of the environment on health in Mongolia: a systematic review. Asia Pacific Journal of Public Health, vol. 27(1) 45-75.

### Химийн аюулгүй байдал

Чанаргүй архины метанолд хордсон хэд хэдэн тохиолдол бүртгэгдсэн байна. Метанолын хордлогоор 1 хүн нас барж, 4 хүн эмнэлэгт хүргэгдсэнээс шалтгаалан 2017 оны 1 дүгээр сард согтууруулах ундааны борлуулалтыг түр хугацаагаар хориглосон тохиолдол гарчээ.

### Хог хаягдал, бохирдсон хөрс

Хотын бүсийн хөрсний бохирдол нь гэр хорооллын ариун цэврийн байгууламж, жорлон, бохир уснаас гаралтай нянгаар ихэвчлэн бохирдож байгаа бол хөдөө орон нутгийн хөрс уул уурхайн хаягдлаас голдуу бохирддог байна. Боловсруулах үйлдвэрүүд, машин засвар, хог хаягдал цуглуулах цэгүүдийн орчин тугалга, хром, цайр зэрэг хүнд металын бохирдол өндөртэй байна.

МХЕГ орон сууцны бүсийн хөрсний бохирдлын үнэлгээг орон даяар 2014 онд хийжээ. Улаанбаатар хотын нянгийн бохирдол төрөл, байршлаас хамааран бага, багавтар бохирдолтой, харин аймгуудаас авсан нийт 120 сорьцын 27 хувь нянгийн ихээхэн бохирдолтой, 43 хувь нь бохирдолгүй болохыг үнэлгээгээр тогтоожээ. Улаанбаатарт хүнд металын 58 сорьцод хийсэн шинжилгээгээр тугалга, кадмий, мөнгөн усны агууламж Монгол орны хөрсний бохирдуулагчийн MNS 5850:2008 стандартын хэмжээнд байгааг тогтоосон байна.

Улаанбаатар хотын хөрсний металын бохирдлын 2010 оны үнэлгээ, мөн Монголын аж үйлдвэржсэн Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад хөрсний хүнд металын бохирдлын байдалд 2011 онд хийсэн судалгаагаар<sup>12</sup> pb, As, Cr, Hg, Cu, Ni, Zn, Mo зэрэг хүнд метал Монгол орны хөрс, ялангуяа аж үйлдвэржсэн хотуудын хөрсөнд илэрсэн байна.

Хүнд металын бохирдол нь арьс шир боловсруулах үйлдвэр, уул уурхай, зам тээврийн хөдөлгөөн, дулааны шугам сүлжээ зэрэг эх үүсвэрээс гаралтай байна.

Монголын бохирдсон хөрсийн байршил, ангиллын талаар мэдээллийн сан байхгүй.

### Удаан задардаг органик бохирдуулагч

Удаан задардаг органик бохирдуулагч пестицидыг Монголд огт үйлдвэрлэдэггүй боловч импортоор оруулдаг. 2004-2005 онд хийсэн урьдчилсан тооллогоор удаан задардаг органик бохирдуулагч пестицидын хэрэглээ бага байгааг тогтоосон хэдий ч тэдгээрийн зүй бус ашиглалт, хадгалалт, хугацаа нь дууссан пестицидын ашиглалт нь байгаль орчны бохирдол, полихлор бифенил (ПХБ) болон пестицидтэй харьцах нь хүн амын эрүүл мэндийн эрсдлийг нэмэгдүүлнэ.

НҮБ-ын АҮХБ 2013 онд Монголд 2300 тонн полихлор бифенил байгааг тооцоолсон байна. Жийргэвч тосыг цэвэршүүлэх, ПХБ-г аюулгүй болгох, нэг жил хагаст 1,000 тонныг цэвэрлэх үйлдвэрийг Монголд байгуулсан байна.

Улаанбаатар хот Яргайтын богино ам, Хөвсгөл аймгийн Тариалан сумын агаар, хөрсөн дахь удаан задардаг органик бохирдуулагчийн (ПХБ, ОСП) судалгааг 2011 онд хийж, сорьцоор ПХБ болон органохлорын пестицидийн агаар, хөрс дахь түвшинг тогтоожээ<sup>13</sup>. Эрсдлийн үнэлгээний аргачлалыг ашиглан агаар, хөрсний удаан задардаг органик бохирдуулагчийн бохирдлын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг тодорхойлсон байна. Агаар, хөрс дахь бохирдуулагчийн хэмжээ ЗДХ-нээс бага байна. Агаар, хөрс дахь УЗОБ-ийн хор уршгийн индекс нь хүний эрхтэн, системд хор учруулах түвшингээс 2-4 дахин бага байна.

### Аж үйлдвэрийн хаягдал

Арьс ширний үйлдвэрлэл хром зэрэг химийн бодисууд, их хэмжээний амьтны гаралтай бүтээгдэхүүнийг ашигладаг. Жамбаа нарын Монголд байгаль орчин хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгаа тухай

<sup>12</sup> Tserennyam, B. et al. (2010). Assessment of metals contamination of soils in Ulaanbaatar, Mongolia, Journal of Hazardous Materials, Volume 184, Issues 1-3, 15 December 2010, 872-876. Kosheleva, Natalia E. et al. (2011). Soil pollution with heavy metals in the industrial cities of Mongolia. Mongolian journal of biological sciences 2011 Vol.9(1-2):39-45.

<sup>13</sup> Mamontova, E. A. et al. (2011). Persistent organic pollutants (PCBs and OCP) in air and soil from Ulaanbaatar and the Lake Hovsgol region, Mongolia. Mongolian Journal of Chemistry, 12-38-2011 69-77.

2015 оны судалгаагаар эцэг эхчүүд ажлын байрандаа хромтой харьцаж байгаа нь хүүхдийн бага насны эрүүл мэндтэй холбоотой болохыг тогтоосон байна.

Үйлдвэр, арьс ширний үйлдвэрүүд, уул уурхайгаас гаргаж буй цэвэршүүлээгүй хаягдал ус Монголын голуудыг бохирдуулж байна. Аж үйлдвэрийн хог хаягдлын хэмжээ, агуулгын талаар мэдээ мэдээлэл байхгүй, хаягдлын байгаль орчин, агаар, хөрс, ус, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөний үнэлгээ хийгээгүй байна.

#### Эмнэлгийн хог хаягдал

Эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагуудын 90 гаруй хувь нь эмнэлгийн хаягдлыг шатаадаг боловч тэдгээрийн шатаах зуухууд нь эрүүл ахуйн шаардлагад нийцдэггүй, шүүлтүүргүй байна. Улаанбаатар хотод эмнэлгийн хог хаягдлыг төвлөрүүлэн цуглуулах, цэвэрлэх, устгах тогтолцоог 2009 онд нэвтрүүлжээ. 21 аймгийн 151 сумын эмнэлэгт эмнэлгийн хаягдлыг ариутгах жижиг оврын төхөөрөмжийг 2010-2013 онд янз бүрийн төслийн санхүүжилтээр нийлүүлжээ (Бүлэг 10).

Тус улсад эмнэлгийн материалд мөнгөн ус ашиглахаас татгалзах бодлого баримталж, Мөнгөн уснаас чөлөөт эмнэлэг санаачилгыг амжилттай хэрэгжүүлж байна. 2012 оны байдлаар 14 эмнэлэг мөнгөн ус хэрэглэхээ зогсоосныг мэдэгджээ. 2011 оны 1 дүгээр сараас мөнгөн устай халууны шил, сфигмоманотетр, шүдний амалгам борлуулахыг хориглосон байна.

Айл өрхийн эмнэлгийн хог хаягдлыг цуглуулах ажил хийгддэггүй байна.

#### *Байшин барилга, суурин газрууд*

#### Шөрөмсөн чулуу

Шөрөмсөн чулууг дулааны жийргэвч болон барилгын материал болгон цахилгаан станц, төмөрлөгийн үйлдвэр, барилгын салбарт 1961 оноос ашиглаж эхэлжээ. 1995-2010 онд нийт 35,484 тонн шөрөмсөн чулуу импортлосон байна. 1960, 1970, 1980-аад онд барилгын салбарт шөрөмсөн чулууны цементийг их ашигладаг байсан бөгөөд өнөө эдгээр барилгын дийлэнх нь засвар хийгдээгүйгээс ажилчид, хүн амыг шөрөмсөн чулуутай харьцахад хүргэж байна.

Шөрөмсөн чулууг тохиромжгүй нөхцөлд ашигласан, материал доройтож чулуу ил гарсан, барилга хуучирсан буюу нураасан үед хүнд нөлөө үзүүлдэг. Мөн гэр бүлийн гишүүд шөрөмсөн чулуутай харьцаж, хувцасанд шингэсэн нөхцөлд бусад хүмүүст мөн нөлөөлнө.

2016 оны “Орчны эрүүл мэндийн төлөв байдал” илтгэлд шөрөмсөн чулууны талаар зарим арга хэмжээ авч, тайлан илтгэл гаргажээ. Гэвч шөрөмсөн чулуутай холбоотой ажил зогсож холбогдох стандарт, журам, хяналтын системийг боловсруулах, өвчлөлийн бүртгэлийг хөтлөх зэрэг зорилгууд хэрэгжээгүй байна. Шөрөмсөн чулууны шинжилгээний лабораторийг Эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэд байгуулсан боловч ажиллагаагаа зогсоосон байна.

Өнөөгийн байдлаар шөрөмсөн чулууны нөлөөллийн стандарт, шөрөмсөн чулууны доройтол, барилгыг нураахын өмнө шөрөмсөн чулууны шинжилгээ хийх ажил огт хийдэггүй, шөрөмсөн чулуутай холбоотой өвчлөлд хяналт тавьдаггүй, бүртгэл хөтөлдөггүй байна. Сургууль, эмнэлгэг зэрэг олон нийтийн газар шөрөмсөн чулууны агууламж байгаа эсэхэд хяналт хийдэггүй байна.

Монголд месотелиомагийн судалгааг 2015 онд хийж, шөрөмсөн чулуунаас үүдэлтэй месотелиомагийн нэг тохиолдол бүртгэгдсэн байна. Шөрөмсөн чулуу ашиглаж байгаа учир цаашид түүнтэй холбоотой өвчлөл гарах магадлалтай.

#### Радон хий

Радон хий нь хүн амд уушигны хорт хавдар үүсгэх нөхцөл болдог бөгөөд тамхины утаа энэ нөхцөлийг улам даамжруулдаг. 1999-2005 онд жилийн хугацаанд радоны агууламжийг дотор (цемент, тоосго, модон байшин, гэрийн) болон гадны агаарт өвлийн улиралд (11, 12 дугаар сар) хэмжиж байжээ.

Монголд радоны жилийн хэмжээний талаар 2008 онд хийсэн судалгаанаас<sup>14</sup> үзвэл өвлийн улиралд гадна агаар дахь радоны агууламжийн хэмжээ  $18.7 (2.3/38.8) \text{ Bq/m}^3$ , дотор агаарынх  $26.0 (8.2/42.6) \text{ Bq/m}^3$  байв. Радоны агууламж цементэн барилгад  $41.9 \text{ Bq/m}^3$ , тоосгон барилгад  $36 \text{ Bq/m}^3$  байгаа нь модон барилгын агууламж  $19.1 \text{ Bq/m}^3$ , монгол гэрийн агууламж  $10.1 \text{ Bq/m}^3$ -аас дээгүүр байна. Монголын нэг хүнд ноогдох радоны жилийн хэмжээг  $0.8 (0.33/1.26) \text{ mSv/жил}$  гэж тооцжээ. Энэ агууламж нь жилд нэг хүнд ноогдох дээд нөлөөлөх хэмжээ  $2.5 \text{ mSv/жил}$ ээс бага байна.

### Хар тугалга

Хар тугалга агуулдаг бензиныг Монголд 2008 онд хориглосноос хойш зам тээврийн тугалгын нягтшилтад үзүүлэх нөлөө буурсан байна. Гэвч өвлийн улиралд халаалт болон хоол боловсруулахад нүүрс шатааж байгаа нь агаарт тугалга ялгаруулж, агаарын бохирдол нь хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг.

2014 хийсэн Улаанбаатар хотын хүүхдийн цусан дахь тугалганы түвшин болон холбогдох эрсдлийн хүчин зүйлийн үнэлгээ нь цусан дахь тугалганы түвшин 2005 онд  $16.5 \pm 9.5 \mu\text{g/dl}$  байсан хэмжээнээс  $5.3 \mu\text{g/dl}$  болтол буурсныг харуулав<sup>15</sup>. Түвшин буурсан нь 2008 онд тугалга агуулдаг бензиныг хориглосонтой холбоотой. Улаанбаатар хотын сургуулийн 153 хүүхдэд шинжилгээ хийхэд 69.3 хувийн цусан дахь тугалгын түвшин  $5 \mu\text{g/dl}$ -тай тэнцүү, эсвэл дээш байв. Хүүхдийн цусан дахь тугалгын түвшин  $10 \mu\text{g/dl}$ -аас доош байхад эрүүл мэндийн сөрөг нөлөө үүсэх боломжтой.

2016 онд Улаанбаатар хотод  $\text{PM}_{2.5}$  тоосонцор болон цусан дахь тугалгын түвшингийн талаар хийсэн судалгаагаар Улаанбаатарт амьдарч буй 40-60 насны эмэгтэйчүүдийн цусан дахь тугалгын түвшин  $3.1 \mu\text{g/dl}$  байгааг тогтоосон<sup>16</sup>. Гэрт амьдардаг, орон сууцанд амьдардаг эмэгтэйчүүдийн цусан дахь тугалгын түвшин төдийлөн их ялгаагүй байгаа нь тугалгын нягтшилт зөвхөн нүүрс шатааснаас болоогүй, олон эх үүсвэртэйг харуулжээ.

Монголын хүн ам тугалгын нягтшилаас хамааран эрүүл мэндийн сөрөг нөлөөнд өртөж болзошгүйг хэд хэдэн судалгаа харуулсан боловч тугалгын эх үүсвэрийн талаар, тухайлбал тоглоом, будаг дахь тугалга, ажлын байран дахь тугалгын агууламж, тоос, хөрсний тугалгын хүн амын эрүүл мэндэд үзүүлсэн нөлөөний талаар мэдээ мэдээлэл байхгүй байна.

### Хөгз

Хөгзтэй холбоотой харшлын шинж тэмдгийн бүртгэгдсэн мэдээ мэдээлэл байхгүй.

Монголын агаар нэн хуурай учир хөгз үүсэх нөхцөл хязгаарлагдмал боловч өрхийн дотоод нөхцөл, тухайлбал чийгшлийн зохих хяналт, агааржуулагчгүй байрны хоол боловсруулах болон халаалтын хэлбэрээс шалтгаалан хөгз үүсэхэд нөлөөлж болно.

### *Хөдөлмөрийн эрүүл мэнд болон аюулгүй байдал*

1990-2000 оны ажлын байрны өвчлөлийн хяналтаас үзвэл уушигны өвчин, химийн бодисын хордолт, мэдрэлийн өвчин хөдөлмөрлөлттэй холбоотой хамгийн түгээмэл гурван өвчин байв. Аж үйлдвэрийн хөгжил нь ажлын хортой байрны тоо, цар хүрээ, хорт нөхцөлд өртөх ажилчдын эмзэг байдлыг нэмэгдүүлжээ. Ажилчид ажлын байрандаа хүнцэл, хлор, цахиур шороо, шөрөмсөн чулуу, ароматик нүүрсустөрөгч зэрэгт өртөх эрсдэлтэй.

Ажлын байрнаас үүдэлтэй хорт хавдар цөөн тохиолдох боловч маш өндөр эрсдэлтэй ба энэ төрлийн хорт хавдраас боловсрол олгох, мэдээлэл түгээх, ажилчдыг хамгаалах хууль тогтоомжоор сэргийлэн хамгаалах боломжтой. Өнөөгийн байдлаар ажлын байраас үүдэлтэй хорт хавдарт хяналт мониторинг хийх тогтолцоогүй ба ажлын байрнаас үүдэлтэй хорт хавдрын (уушигны хорт хавдар, лейкоми,

<sup>14</sup> Batjargal, E., Bandisuren, M., and Battogtvor, E. (2008). Annual dose from radon in Mongolia. Proceedings of IRPA12: 12.

Congress of the International Radiation Protection Association: Strengthening Radiation Protection Worldwide - Highlights, Global Perspective and Future Trends-IAEA-19-24 October 2008- Argentina.

<sup>15</sup> Meredith L. Praamsma et al. (2016), Assessment of Blood Lead Levels and Associated Risk Factors Among Children in Ulaanbaatar, Mongolia, Central Asian Journal of Medical Sciences, 2016 Nov 2(2): 195-205.

<sup>16</sup> Enkhbat, U. et al. (2016). Exposure to  $\text{PM}_{2.5}$  and blood lead level in two populations in Ulaanbaatar, Mongolia. International journal of environmental Research and Public Health, 2016, 13, 214.



месотелиом) талаар найдвартай мэдээлэл байхгүй байна.

2012 оны НҮБ-ын ХС-гийн Хөдөлмөрийн хүчний судалгаанд 5-17 насны хүүхдийн 9.6 хувь хүүхдийн ажил хийж байгаагаас хөдөөд 17.8, хотод 2.8 хувьтай байна. Хүүхдүүд ХАА-н салбар, морины уралдаан, барилга, уул уурхайд ажилладаг ба барилга, уул уурхайн хорт нөхцөлд 15-17 насны хүүхдийн тэн хагас нь ажиллаж байна. Хөдөөд ажиллаж буй хүүхдийн 96 хувь нь ХАА-н салбарт байна. Ихэнх хүүхдүүд айлын мал хариулдаг ба ямарваа нэгэн албан ёсны гэрээ байгуулдаггүй байна.

Монгол дахь хүүхдийн ажил эрхлэлтийн талаарх ОУХБ-ын 2016 оны бодлогын танилцуулгад 2016 оны байдлаар 10,000 гаруй хүүхэд хурдан морь унахаар бүртгүүлснийг тэмдэглэжээ. 2012-2014 онд мориноос унасан 326 хүүхдэд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлсэн ба 18 хүүхэд амиа алджээ.

Хот сууринд хүүхдүүд голдуу барилгын салбарт ажиллаж байна. Хөвгүүд 15-18 насандаа ажил хийж эхэлдэг байна. Эдгээр хүүхдүүдтэй хөдөлмөрийн албан ёсны гэрээ байгуулдаггүй, тэдний бараг тэн хагас нь ажил дээрээ бэртдэг, олонх нь ажлын аюулгүйн зохих хэрэгсэлгүй байдаг.

Хүүхдүүд уул уурхайн салбарт хорт, бохирдсон, чимээ шуугиантай орчинд ажиллаж байна. Тэд аюулгүйн хэрэгслийг байнга хэрэглэдэггүй, олонх нь ажил дээрээ гэмтэл бэртэл авдаг байна.

#### *Уул уурхайн үйл ажиллагаа*

Уул уурхайтай холбоотой гол өвчлөл бол тоосноос үүдэлтэй амьсгалын замын өвчин болон химийн бодисын хордолт юм. Гол нөлөөлөл нь хот сууринтай ойр уурхайнууд, бичил уурхайд ашиглаж буй химийн бодисууд, ажлын хүнд нөхцөлд оршиж байна. Уул уурхайн хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөнд үнэлгээ хийгээгүй байна.

Эдийн засгийн тогтолцооны өөрчлөлт, цаг агаарын гамшиг нь улс даяар ядуурал, ажилгүйдлийг нэмэгдүүлсний улмаас зарим уурхайчид өөрсдийн амьжиргааг сайжруулах зорилгоор бичил, хувийн уурхай эрхэлдэг болсон. 2010 онд 100,000 гаруй хүн хувийн, бичил уурхай эрхэлж байв.

Алтыг хүдрээс ялгахад мөнгөн ус ашигладаг нь байгаль орчинд учруулж буй гол эрсдэл, хохирол юм. Мөнгөн устай хүдрийг мөнгөн ус уурштал халаадаг арга нь түүнийг байгальд, ус, хөрс, агаарт ялгаруулдаг тул хүний эрүүл мэндэд ихээхэн эрсдэл учруулдаг (Шигтгээ 15.3). Хүдрийг гэр, байшинд халаавал мөнгөн ус нь дотор агаарыг бохирдуулдаг. Мөнгөн ус нь маш хортой, хүний мэдрэлийн сиситемд нөлөөлдөг, цусанд чөлөөтэй нэвтэрдэг байна.

Засгийн газар мөнгөн ус ашиглахыг 2008 онд хориглосон байна.

Уул уурхайн үйл ажиллагаа болон нүүрсний шаталт нь байгальд хүнд металын агууламж нэмэгдэх гол шалтгаан юм. Монголын хойд, төвийн бүсийн газар, гадаргуу, хаягдал болон ундны усны хүнцэлийн түвшин өндөр байгааг сүүлийн үеийн судалгаа харуулсан.

#### **Шигтгээ 15.3: Алт олборлолтод ашиглаж буй мөнгөн усны хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө**

Эмэгтэй алт олборлогчдын бие махбодь дахь мөнгөн усны агууламжийг тогтоох байгаль орчин, халдварын судалгааг 2011 онд хийсэн байна. Судалгаагаар эмэгтэйчүүдийн бие махбодь нь мөнгөн усны хамгийн их агууламжтай байгааг тогтоожээ. Мөн зөвхөн эмэгтэй уурхайчид бус, бичил уурхайн орчинд амьдардаг уурхайн ажил хийдэггүй эмэгтэйчүүдийн мөнгөн усны нягтшилт өндөр байгааг илрүүлсэн байна. Алт олборлолтын явцад их хэмжээний мөнгөн ус, цианид байгальд алдагдсан химийн ноцтой гамшиг 2007 оны 4 дүгээр сард Хонгор суманд гарч байжээ.

Энэ байгаль орчны гамшиг нь орон нутгийн хүн амын эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байв. ДЭМБ-аас Борнуур сум, Жаргалан сумын Тал булаг багийн хүн амд хийсэн шинжилгээгээр мөнгөн усны шинж тэмдэг илэрсэн. Борнуур сум, Жаргалан сумын хүн ам мөнгөн усанд удаан хугацаанд өртөж байгаа нь тэдний эрүүл мэндэд ихээхэн хор хохирол учруулж байгаа ба мөнгөн устай шууд харьцаж байгаа хүмүүс илүү эрсдэлтэй тулгарч байна.

2015 онд хийсэн бичил уурхайн мөнгөн усны хордолтын үнэлгээ нь Борнуур сум, Жаргалан сумын талаар гарсан дүгнэлттэй нийцэж, эдгээр сумдын ард иргэдийн мэдрэлийн төв системийн өвчлөлд мөнгөн ус нөлөөлсөн болохыг тогтоосон байна

**Фото зураг 15.1: Уул уурхайн бүсийн замыг усалж байгаа нь, Төв аймгийн Заамар сум**

Монголын хойд бүсийн газар, гадаргуу, хаягдал болон ундны усны хүнцэлийн түвшин, түүний эх үүсгэрийг тогтоох судалгаанаас<sup>17</sup> үзвэл хүнцэлийн хамгийн их нягтшилт (2,820  $\mu\text{g}/\text{l}$  хүртэл) алтны уурхайн орчинд, дулааны цахилгаан станцын үнсний санд (1,170  $\mu\text{g}/\text{l}$  хүртэл) тогтоогдсон. Мөн ундны усны 54 сорьцоос 5 нь, голын усны 184 сорьцоос 16-д нь хүнцэлийн агууламжийн түвшин ДЭМБ-аас зөвшөөрөгдсөн дээд хэмжээ 10  $\mu\text{g}/\text{l}$ -ээс давж, зарим тохиолдолд агууламж 300  $\mu\text{g}/\text{l}$  болсон байв.

Тоос нь уул уурхайн үйл ажиллагаа, ялангуяа нүүрсний уурхайн сөрөг нөлөөлнө. Уул уурхайн бүсийн тоосны гол эх үүсвэр нь том даацын ачааны автомашины хөдөлгөөн болон уурхайн хаягдал юм. Компаниуд уурхайн дотоод болон орчны агаарын чанарын хяналт мониторинг хийж, бохирдол монголын үндэсний стандартаас хэтэрсэн нөхцөлд холбогдох байгууллага болон хүн амд мэдээлэх үүрэгтэй. Гэвч Таван толгойн уурхайн бүсэд зөвхөн нэг компани тоосны хяналтын мэдээг гаргаж байна.

Уул уурхайгаас үүдэлтэй тоос уурхайн орчимд, тээврийн замын дагуу амьдардаг малчдад ихээхэн нөлөөлдөг. Тоос нь орчны хүн ам, малчдын гэр бүл, малын эрүүл мэнд, бэлчээрийн чанарт сөрөг нөлөөтэй. Уул уурхайн ажиллагаатай холбогдон малчид харшилтай болох, ханиах, амьсгал хүндрэх зэрэг өвчинтэй болж байгааг мэдээлдэг хэдий ч энэ талаар шинжлэх ухааны тусгай судалгаа хийгдээгүй. Малчид бэлчээр хайж алсад оторлох шаардлагатай тулгарч байна.

“Монголын хариуцлагатай уул уурхай” илтгэлд дурьдсанаар иргэд уул уурхайн орон нутгийн усны нөөцөд (чанар болон хэмжээ) үзүүлж буй нөлөөг бүс бүрээр, уурхайн төрөл болон орон нутгийн усны нөөцөөс хамааран ялгаатай үнэлж байна. Малчдын хувьд уул уурхайн үйл ажиллагаа нь ундны усны чанарт сөргөөр нөлөөлж, мөнгөн ус, цианид зэрэг хорт бодис ус болон хүнсэнд агуулагдах шалтгаан болсон. Гэвч усны чанар, хэмжээнд уул уурхайн үзүүлж буй нөлөөг тодорхойлох шинжлэх ухааны судалгаа хийгдээгүй байна.

<sup>17</sup> Pfeiffer, M., Batbayar, G., and Hofmann, J. et al. (2015). Investigating arsenic (As) occurrence and sources in ground, surface, waste and drinking water in northern Mongolia. *Environmental Earth Sciences* 2 73: 649.

### 15.3 Хоол тэжээл болон хүнсний аюулгүй байдалтай холбоотой эрүүл мэндийн эрсдэл

#### *Хүнсний аюулгүй байдал*

Хүнсний 13 гол нэрийн бүтээгдэхүүний хэрэглээнд үндэслэн 2015 оны үндэсний хүнсний хэрэгцээ нь 176,500 тонн мах болон махан бүтээгдэхүүн, 132,500 тонн сүү, 176,500 тонн сүүн бүтээгдэхүүн, , 88,300 тонн гурил, 194,200 тонн гурилан бүтээгдэхүүн, 68,900 тонн будаа, 20,300 тонн сахар болон амтлагч, 123,600 тонн төмс, 176,500 тонн хүнсний ногоо, 79,600 тонн шош, 158,900 тонн жимс, жимсгэнэ, 16,700 тонн өндөг, 22,000 тонн ургамлын тос байсныг тооцоолсон байна. 2014 онтой харьцуулвал хүн амын жилийн хүнсний хэрэгцээ 200 тонноор (тос, өндөг, сахар), гурилан бүтээгдэхүүн 2,100 тонноор нэмэгдсэн байна. 2015 оны байдлаар дотоодын үйлдвэрлэл нь хүн амын мах, махан бүтээгдэхүүний жилийн хэрэгцээний 97.1 хувь, төмсний 90.6 хувь, гурил, гурилан бүтээгдэхүүний 91.3 хувь, хүнсний ногооны 62.7 хувийг хангах чадвартай байжээ.

Хүн тутмын сүүн бүтээгдэхүүний үндэсний дундаж калорийн хэрэглээ 2015 онд зуны улиралд 2,911.4 ккал, өвөл 2,722.8 ккал байсан нь сүүн бүтээгдэхүүний өдрийн калорийн зохистой хэмжээ, эмэгтэйчүүдийн 2,000 ккал, эрэгтэйчүүдийн 2,500 ккал-аас дээгүүр байна.

Монгол Улс өргөн уудам нутаг дэвсгэр, байгалийн үлэмж нөөцтэй, олон сая малтай, газар тариалангийн их хэмжээний газартай боловч уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй хөрсний үр шим бууралт, мал сүргийн бүтээмж багатай менежмент, байгалийн гамшгийн өндөр сөрөг нөлөө, эрсдэл зэргээс шалтгаалан ХАА, хүнс, байгалийн нөөцийн салбарууд ихээхэн саад бэрхшээлтэй тулгарч байна.

#### *Хоол тэжээл*

Тэжээлийн микро хоол тэжээлийн дутагдал оршсоор байна. Ердийн монгол хүний хүнсний гол бүтээгдэхүүнд мах, гурил давамгайлж, хүнсний ногоо, жимсний хэрэглээ бага. Хүнсэнд шаардлагатай витамин, эрдэс дутагдаж байгаа нь хөгжлийн ноцтой гажуудал, ялангуяа хүүхдэд үүсгэж байна. Монголын 5 хүртэлх насны хүүхдийн 41 хувь нь Д витамин дутагдалтай, энэ үзүүлэлт зүүн, баруун, уулархаг бүс, Улаанбаатарт илүү байна. ЭМЯ-ны мэдээнээс үзвэл хүүхдийн 20 хувь, жирэмсэн эмэгтэйчүүдийн 11.5 хувь нь цус багадалттай. Мөн 5 хүртэлх насны хүүхдийн төмрийн дутагдал маш өндөр, 21 хувьтай байна.

2013 оны байдлаар өсвөр үеийнхэний 12 хувь жингийн илүүдэлтэй, 2 хувь нь таргалсан байв. 2000-2010 онд жингийн доройтолтой хүүхдийн хувь 11.6-ээс 3.3 хувь, өсөлтийн сааралт 29.9-аас 15.3 хувь, тураал 7.1-ээс 1.6 хувь болтол тус тус буурсан байна. Гэвч 0-6 сартай хүүхдийн жингийн доройтол 2005 онд 6.9 хувь байсан бол 2010 онд 8.4 хувь болтол нэмэгдсэн байна. 2014 оны байдлаар бага жинтэй хүүхдийн төрөлт хот суурингаас (Улаанбаатарт 3.8 хувь) хөдөө орон нутагт илүү түгээмэл (ялангуяа баруун бүсэд 6.6 хувь) байна.

#### *Хүнсний баталгаатай байдал*

Хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, бэлэн хүнс, хүнсний бусад материалд хяналт, шалгалт хийдэг. Хориглосон, ашиглалтыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын анхны жагсаалтыг Засгийн газар 1997 онд гаргаж, түүнийг 2007 онд шинэчлэн, 2008, 2010, 2011, 2012 онд жагсаалтад шинэ бодисуудыг нэмж оруулсан байна. 2016 оны байдлаар Монголд 126 химийн бодисыг хориглосон, 31 химийн бодисыг хязгаарласан байна (Бүлэг 10). Химийн бодисыг ашиглахад зөвшөөрөл авна.

2015 оны байдлаар олон улсын байгууллагын шийдвэрээр чанарын менежментийн MNS ISO9001:2010 стандартын гэрчилгээтэй бизнесийн 14 байгууллага байв. Бизнесийн 3 байгууллага хүнсний аюулгүй байдлын менежментийн ISO 22000 стандартыг, нэг байгууллага гамшгийн дүн шинжилгээ, хяналтын үндсэн үзүүлэлтийн стандартыг нэвтрүүлсэн байна.

Компаниуд хүнсний баталгаатай байдал, эрүүл ахуйн дотоод хяналтыг хийх үүрэгтэй ба дотоод хяналтыг шалгалтаар дүгнэдэг байна. 2015 оны байдлаар МХЕГ нийт 29,869 зөрчил илрүүлснээс 3,151 нь дотоод хяналтын хэв журмын зөрчил байв. Зөрчлийг бууруулах, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор МХЕГ-аас байгууллагуудын бүрэлдэхүүнд сургалт явуулах, зөвлөмжөөр хангах ажлыг зохион байгуулдаг.

МХЕГ 2015 онд хүнстэй холбоотой 31,847 байгууламжид шалгалт хийж (6,897 ААН, 24,950 хувь хүн), 68 ААН, 66 хувь хүний үйл ажиллагааг зогсоосон байна. МХЕГ-аас 29,869 зөрчил илрүүлж 79.1 хувийг нь шийдвэрлэжээ. Нийт зөрчлөөс барилга байгууламжийн стандартын зөрчил 20 хувь, ариун цэвэр, эрүүл ахуйн стандартын зөрчил 19.1 хувь, хадгалалт, тээвэрлэлтийн зөрчил 13.2 хувь, түүхий эд, бэлтгэл, чанар, бэлэн бүтээгдэхүүний аюулгүй байдлын зөрчил 9.9 хувийг эзэлж байжээ. Зөрчлийг арилгах явц зөрчлийн төрлөөс шалтгаалан 77-84 хувь, дундаж 79 хувьтай байсан байна.

Зөрчлийг арилгаагүй нөхцөлд сануулга өгөх, торгох, үйл ажиллагааг нь зогсоох зэрэг арга хэмжээ авч байна. Хүнсний гэрчилгээ бүхий 65 шинжилгээний лабораторид микробиологи, химийн үзүүлэлтээр шинжилдэг байна.

#### *Хүнсний гаралтай өвчин*

2015 онд хүнсний гаралтай өвчний 6 удаагийн дэгдэлт гарч, нийт 311 хүн өвчилж, 33 хүнийг эмнэлэгт хэвтүүлсэн (нийт өвчтөний 10.6 хувь), барсан тохиолдол гараагүй (Хүснэгт 15.4). Хүнсний гаралтай өвчний дэгдэлтийн хор уршгийг нийт өвчлөгсдийн тоо, хордолтын шинж чанараар тогтоодог.

2015 оны байдлаар нянгийн гаралтай хоолны хордлогын тохиолдол өндөр байсан ба хөдөө орон нутагт нийт хордлогын дотор хоолны хордлого 2012 онд 12, 2013 онд 49, 2014 онд 57, 2015 онд 22 хувийг эзэлж байжээ (Хүснэгт 15.5).

#### *Эрүүл хооллолт*

ДЭМБ болон Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв хамтран 2012 онд хүнсний хүрэлцээний талаар (Монгол улсын Улаанбаатар хотын сургуулиудын хүнсний байдал: Хүнсний сурталчилгаа ба хүрэлцээ) төсөл хэрэгжүүлжээ. Төслийн үр дүн сургуулийн орчинд эрүүл бус хүнсний сурталчилгаа маш их байгааг тогтоожээ. Сонгон авсан 30 сургуулийн орчимд нийт 1,459 сурталчилгаа, нэрийн барааны хүнсний бүтээгдэхүүнийг харуулсан, 501 сурталчилгаа нэрийн бус бүтээгдэхүүний урамшууллыг харуулсан байгааг тогтоожээ. Хүүхдүүд сургуулийн эргэн тойронд сурталчилж байгаа эдгээр эрүүл бус хүнсний бүтээгдэхүүнийг худалдан авахад хүрдэг байна.

#### **Хүснэгт 15.4: Хүнсний гаралтай өвчний дэгдэлт: өвдсөн ба эмнэлэгт хэвтсэн хүний тоо, 2012-2015 он**

	2012	2013	2014	2015	2016
Хүнсний гаралтай өвчний дэгдэлт	3	5	11	6	12
Өвчилсөн хүмүүс	572	93	766	311	382
Эмнэлэгт хэвтсэн	5	1	244	33	127

*Эх сурвалж:* Хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтийн статистик, ҮСХ, 2015, 2016 он

#### **Хүснэгт 15.5: Нянгийн гаралтай хоолны хордлогын тохиолдлын тоо, 2012-2015 он**

	2012	2013	2014	2015	2016
<b>Нийт</b>	<b>719</b>	<b>238</b>	<b>548</b>	<b>482</b>	<b>430</b>
Хот суурин	633	121	235	375	366
Хөдөө	86	117	313	107	44

*Эх сурвалж:* Хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтийн статистик- 2015, ҮСХ

### **15.4 Уур амьсгалын өөрчлөлт болон хүний эрүүл мэнд**

#### *Өнөөгийн төлөв байдал*

Уур амьсгалын өөрчлөлтийн анхны үнэлгээний илтгэлийг 2009 онд нийтэлсэн ба 2009 оноос хойш уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, эмзэг байдал, холбогдох эрсдэлд үнэлгээ хийж байна. 2014 оны Уур амьсгалын өөрчлөлтийн хоёр дахь үнэлгээний илтгэлд судалгаа үнэлгээний ажлыг өргөжүүлэн, уур амьсгалын өөрчлөлтийн нийгэм, эдийн засаг, хүний эрүүл мэнд, амьжиргаанд үзүүлж буй нөлөөний



талаар бүлэг нэмж оруулсан байна.

2014 оны илтгэлд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрүүл мэндийн хэд хэдэн судалгааг нэгтгэн дүгнэж, уур амьсгалын өөрчлөлт, эрүүл мэндийн 2009 оны судалгаанд Улаанбаатар дахь хэт халуун өдрүүдийн тоо, зурх судасны өвчлөлийн хооронд уялдаа байгааг тэмдэглэжээ. Мөн сүрьеэ, хижиг, А вируст шар, улаан суулга, тахал, хачигт энцефалит зэрэг халдварт өвчин нь температур, хур тунадас зэрэг цаг агаарын үзүүлэлттэй холбоотой болохыг онцолсон байна. 2010-2012 онд уур амьсгалын өөрчлөлт, эрүүл мэндийн бас нэг судалгааг цаг агаарын дөрвөн өөр бүсэд хийжээ. Нян тээгчээс гаралтай өвчин нь мөн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой болохыг судалгаагаар тогтоосон байна. Хачиг, шумуулын үржилд уур амьсгалын дулаарал нөлөөлж, нян тээгчээр дамждаг өвчний тархалтыг нэмэгдүүлж байна.

2009-2010 оны өвлийн зуд нь түүхэнд хамгийн хахир, улсад ихээхэн хохирол учруулсан үзэгдэл болжээ (Бүлэг 14). Засгийн газар 15 аймагт гамшгийн нөхцөл зарласан байна. 2009-2010 оны зуднаар 8.5 сая толгой мал, улсын нийт малын 20-25 хувь нь хорогдож, 769,000 хүний амьдралд нөлөөлжээ. Зудад нэрвэгдсэн бүсэд 5-аас доош насны хүүхдийн эндэгдэл 35-40 хувиар нэмэгдсэн, жирэмсэн эмэгтэйчүүдийн тэжээлийн цочмог болон архаг дутагдал нэмэгдсэн, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж буурсан, хүнсний аюулгүй байдал орон даяар алдагдсан, малчид, тэдгээрийн гэр бүл амьжиргааны эх үүсвэрээ алдаж сэтгэл санааны гүн дарамтад орсон зэрэг ихээхэн сөрөг таагүй нөлөөлөл гарсан байна.

Цаг агаарын үзэгдлүүд нь амиа егүүтгэх, сэтгэлийн хямралд орох зэрэг нийгмийн болон сэтгэлийн нөлөөлөлтэй байдаг. Ган зудад нэрвэгдсэн малчид хот суурин, ялангуяа Улаанбаатар хотод олноор шилжин суурьшдаг. Монголд 1999-2002 онд гурван жил дараалан зуд тохиолдсоны улмаас мал ихээхэн хорогдож, малчин өрхүүдийн амьжиргааны түвшин буурч, аймгуудад ядуурал, ажилгүйдэл эрс нэмэгдсэн байна.

Ундны аюулгүй ус, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хүртээмж бага байгаа нь ядуу хүмүүсийн халдварт өвчний эрсдлийг нэмэгдүүлдэг. Алслагдсан орон нутагт эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж муу байгаа нь жирэмсэн эмэгтэйчүүд, төрсөн эхчүүд, хүүхэд, өндөр настай хүмүүсийн эрсдлийг нэмэгдүүлж байна.

Уур амьсгалын өөрчлөлт нь улирлын хүнсний аюулгүй байдлыг даамжруулах төлөвтэй байна. Зудын давтамж нь мал олноор хорогдох шалтгаан болж байна. Уур амьсгалын өөрчлөлт нь ХАА-н салбар (усжуулалт), бэлчээрийн чанарт нөлөөлж, усны эх үүсвэртэй газарт малын хэт төвлөрөл бий болгоход хүргэдэг байна.

#### *Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох*

2014 оны Уур амьсгалын өөрчлөлтийн хоёр дахь үнэлгээний илтгэлд ХАА, усны салбарт учирч байгаа сорилтуудыг онцолж, уламжлалт соёл, технологийн шинэчлэлийг уур амьсгалын өөрчлөлттэй уялдуулах шаардлагыг тэмдэглэжээ. Үүнд усны салбарт онцгой анхаарал хандуулах, ялангуяа усны нөөц багатай бүсийн хүн амын амьжиргааны асуудлыг зохистой шийдвэрлэхийг заасан байна.

### **15.5 Эрх зүй, бодлого, институтцийн тогтолцоо**

#### *Хууль, эрх зүйн тогтолцоо*

Эрүүл мэндийн тухай 2011 оны хууль нь төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, түүний үндсэн зарчим, эрүүл мэндийн системийн бүтэц, төр засгийн бүх шатны байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхойлж өгсөн байна.

Эрүүл ахуйн тухай 2016 онд шинэчилсэн хуулиар ус, агаар, хөрс, хог хаягдлын менежментийн эрүүл ахуйн шаардлагыг хангах, хяналт тавих үндэсний болон орон нутгийн бүх шатны удирдлагын үүрэг хариуцлагыг тодорхойлж өгчээ. Хуулиар хотын барилга, төлөвлөлтийн эрүүл ахуйн шаардлагыг нэвтрүүлжээ. Хуулиар мөн 50, түүнээс дээш ажилтантай ААН-үүд эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэнтэй байхаар зохицуулсан байна. Хуульд эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийж байхаар тусгасан байна. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг 2012 оны Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хуулийн (2016 онд шинэчилсэн) холбогдох заалтуудын дагуу (Бүлэг 2)



гүйцэтгэхээр заасан боловч эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх ажил эхлээгүй байна

Агаарын тухай 2012 онд шинэчилсэн хуулиар орчны агаарыг хамгаалах, бохирдлоос сэргийлэх, агаарт бохирдуулагч ялгаруулахыг бууруулах, хяналт тавих асуудлыг зохицуулжээ (Бүлэг 8). Хуульд агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөнөөс хүн амыг хамгаалах үүрэг хариуцлагыг тодорхойлон, хүн амыг агаарын чанар болон эрүүл мэндийн нөлөөний талаарх зөвлөмжөөр хангахыг заасан байна.

Тамхины хяналтын тухай 2005 оны хуулийг 2015 онд шинэчлэн найруулжээ. Хуулиар тамхины бүх бүтээгдэхүүнд эрүүл мэндтэй холбоотой анхааруулга тавих, анхааруулга нь тамхины савны 50-иас доошгүй хувийг эзэлсэн байхаар заасан. Олон нийтийн газар, нийтийн тээвэр, амралтын хүрээлэн, тоглоомын талбайд тамхи татахыг хориглосон байна.

Цөмийн энергийн тухай 2009 оны хуулиар цацрагаас хамгаалах, аюулгүй байдлыг хангах асуудлыг зохицуулж өгсөн байна.

Цацрагаас хамгаалах, аюулгүй байдлыг хангах тухай 2001 оны хуулиар эмнэлгийн ажилтан, өвчтөний аюулгүй байдлыг зохицуулсан. Хуулийн дагуу оношлогоо, цацрагийн эмчилгээний бүх тоног төхөөрөмжид тогтмол үзлэг, хяналт, чанарын баталгаа, тохируулга хийх үүрэгтэй.

Орчны чимээ шуугианыг Орон сууц, иргэний барилгын чимээний түвшний стандарт MNS 0012-1-009-1985, ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэнд, чимээ болон аюулгүй байдлын ерөнхий шаардлагын MNS 5002-2000 хоёр стандартаар зохицуулдаг.

Барилгын материалын үйлдвэрлэл, аюулгүй байдлыг 2016 онд шинэчилсэн Барилгын тухай хуулиар зохицуулдаг байна. Хуульд шөрөмсөн чулуу болон тугалгын агуулгатай будаг ашиглах асуудлыг тусгаагүй байна.

Хот байгуулалтын тухай 2008 оны хуульд хот байгуулалтын “эрүүл орчин” зарчмыг тодорхойлж, хотын бүсчлэлийн шаардлагыг тогтоож өгсөн байна.

Химийн хорт болон аюултай бодисын тухай 2006 оны хуулиар химийн хорт болон аюултай бодисын экспорт, импорт, хил дамнансан тээвэрлэлт, үйлдвэрлэл, хадгалалт, тээвэр, ашиглалт, устгал, хяналтыг зохицуулсан (Бүлэг 10). Байгаль орчин, Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан 2008 оны 04/04 тоот тушаалаар химийн хорт болон аюултай бодисын ангиллыг баталж өгсөн байна. Энэ ангиллыг НҮБ-ын Химийн бодисын ангилал, хаягжуулалтын нэгдсэн системд үндэслэн боловсруулжээ. Тугалганы агуулгатай будаг, тоглоом, импортын бүтээгдэхүүний асуудлыг зохицуулсан хууль тогтоомж байхгүй, тусгай үйл ажиллагаа хэрэгжээгүй байна.

2008 оны Хөдөлмөрийн юулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль нь ажлын байран дахь аюулгүй байдал, эрүүл ахуйг зохицуулдаг эрх зүйн үндсэн баримт бичиг юм. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай 1996 оны хуулийг 2016 онд шинэчилж, ажил хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарыг тогтоосон 138 дугаар конвенцийн дагуу ОУХБ-ын хорооноос 2015 онд гаргасан шийдвэрээр тогтоосон хязгаарлалтыг нэвтрүүлжээ. 15-аас доош насны хүүхэд ажил хөдөлмөр эрхлэхийг үл зөвшөөрөх ба хуулиар хүүхдийн ажлын цагт хязгаар тогтоож, илүү цагаар, баяр амралтын өдрүүдэд ажиллахыг хориглолсон. Хөдөлмөрийн сайдын 2016 оны 2 дугаар сарын А/36 тоот тушаалаар насанд хүрээгүй хүмүүсийн ажиллахыг хориглосон ажлын жагсаалтыг шинэчлэн, насанд хүрээгүй хүмүүс амь нас, эрүүл мэнд, ёс суртахуун, аюулгүй байдал, хөгжилд харш, аюултай бодистой холбоотой ажил хийхийг хоригложээ. Түүнчлэн 11 дүгээр сарын 1-нээс 5 дугаар сарын 1-ний хооронд хүүхдийг хурдан морины уралдаанд оролцохыг хориглосон боловч зуны улиралд 7 настай хүүхэд хүртэл хурдан морины уралдаанд оролцох боломжтой хэвээр байна.

#### *Бодлогын тогтолцоо*

#### Орчны эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр (2006–2015)

2005 оны Орчны эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр (ЗГ-ын 2005 оны 245 дугаар Тогтоол) нь орчны эрүүл мэндийн мониторинг, ажиглалт тандалт and болон үнэлгээний системийг сайжруулах, хүрээлэн буй орчны хүний эрүүл мэндэд нөлөөлөлх байдалд дүн шинжилгээ хийх, орчны хүчин зүйлийн хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах болон орчны эрүүл мэндийн боловсролыг асуудалд

голлон анхаарсан байна. Монгол улсын орчны эрүүл мэндийн ерөнхий байдлыг үндэслэн ДЭМБ болон ЭМЯ 2016 онд хөтөлбөрийн төгсгөлийн үнэлгээ хийж, эрх зүйн орчныг сайжруулах, Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ, салбар дундын хамтын ажиллагаа болон эрдэм шинжилгээ судалгааны чадавхийг сайжруулахын тулд олон тооны санал санаачлага гаргасныг тэмдэглэсэн байна.

#### Орчны эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр (2017–2020)

2005 оны Орчны эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр (ЗГ-ын 2017 оны 225 дугаар Тогтоол) –ийг 2017-2020 онуудад хэрэгжүүлэхээр боловсруулжээ. Хөтөлбөр нь Тогтвортой хөгжлийн 2030 оны хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд голлон анхаарсан байна. Хөтөлбөрийн зорилтууд нь:

- Агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах,
- Усны чанар, баталгаат байдлыг сайжруулах, хөрсний бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах,
- Эрүүл мэндийн ажиглалт, судалгаа шинжилгээний ажлыг сайжруулах,
- Амьсгалын замын өвчлөлээс сэргийлэх болон гамшгийн хүний эрүүл мэндэд учруулах нөлөөллийг шийдвэрлэх чадавхыг бэхжүүлэх;
- Эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлын менежментийг сайжруулах,
- Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндийн нөхцлийг сайжруулах,
- Химийн бодисын хүний эрүүл мэндэд учруулах нөлөөллийг судлах, бууруулах.

Эдгээр чиглэлийн үйл ажиллагаанаас гадна гадаад орчны хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийх талаар мэргэжилтнүүдийг сургах, уур амьсгалын өөрчлөлтөд эрүүл мэндийн салбарын дасан зохицох төрөл бүрийн арга хэмжээ авах, орчны эрүүл мэндийн статистикийг сайжруулах зэрэг олон арга хэмжээг төлөвлөсөн байна. Хөтөлбөрт 2018 болон 2020 гэхэд хүрсэн байх тодорхой тоон үзүүлэлт зорилтуудыг дэвшүүлжээ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, Эрүүл мэндийн сайд батлахаар төлөвлөж байна.

#### Бодлогын бусад баримт бичиг

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах 2001 оны бодлого нь (УИХ-ын 2001 оны 81 дүгээр тогтоол) нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, сайжруулах, хүний амьдрах, хөдөлмөрлөх таатай, эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх, төрийн эрүүл мэндийн үйлчилгээ давамгайлсан эрүүл мэндийн тогтолцоог сайжруулах зорилготой. Орчны эрүүл мэндийн талаарх бодлогод дараах асуудлуудыг онцолсон байна:

- Хот суурины агаарын бохирдлыг бууруулах, амьсгалын замын архаг болон хурц өвчлөлөөс сэргийлэх, шалтгаан болон үр дагаврыг бууруулах зорилгоор дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх;
- Ногоон бүсийг нэмэгдүүлэх;
- Хотын цэвэрлэх байгууламжуудын техникийн нөхцөлийг сайжруулах;
- Хотын хатуу хог хаягдлыг устгах технологийг сайжруулах замаар хөрсний бохирдлоос хамгаалах;
- Цацраг идэвхит болон аюултай бодис, эмнэлгийн хог хаягдлын аюулгүй устгалыг хангах;
- Хөдөлмөрийн ослыг бууруулах, ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах.

2005 оны Эрүүл мэндийн салбарын 2006-2015 онуудад хэрэгжих стратегийн мастер төлөвлөгөөг (ЗГ-ын 2005 оны 72 дугаар тогтоол) МХЗ-уудыг хэрэгжүүлэх зорилгоор боловсруулжээ. Агаарын бохирдол, хөдөө орон нутгийн нүүдлийн амьдралтай холбоотой хүнс, ундны усны аюулгүй байдал, хүний болон малын гаралтай хог хаягдлын устгал, Монголын өмнөд, зүүн бүсийн ундны усан дахь хүнцэлийн агуулга өндөр байгаа зэрэг асуудалд анхаарал хандуулах шаардлагатайг төлөвлөгөөнд онцолсон байна. Эрүүл мэндийн сайдын баталсан Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын 2012-2016 оны үндэсний төлөвлөгөө нь нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын төлөвлөлт, бэлэн байдал, сэргийлэх, эрт илрүүлэх, яаралтай хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг бэхжүүлэх зорилготой. Сүүлийн жилүүдэд Монголд шинэ халдварт өвчний дэгдэлт гарах тохиолдол нэмэгдэж байна.

Агаар, орчны бохирдлыг 2017-2025 онд бууруулах үндэсний хөтөлбөрийг аюулгүй, эрүүл орчныг бий болгох, хот төлөвлөлтийг сайжруулах замаар бохирдлын эх үүсвэрийг багасгах, төвлөрлийг бууруулах, дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, агаар, орчны бохирдлыг бууруулах замаар амьдралын таатай орчинг бүрдүүлэх зорилгоор 2017 онд баталсан (ЗГ-ын 98 дугаар тогтоол). Тус хөтөлбөрт эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтүүдийг тогтоож, байгаль орчин, эрүүл мэнд, эдийн засаг, эрчим хүчний стратегид бохирдлын үзүүлэх нөлөөг дэлхий дахины хандлагад нийцүүлэн тодорхойлжээ. Хөтөлбөр

нь хот байгуулалтын хамгийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх, төлөвлөлт дэд бүтцийг сайжруулах, хөдөө орон нутгийг хөгжүүлэх, төвлөрлийг багасгахад анхаарсан байна. Төлөвлөгөөнд тусгаагүй мэдээ мэдээллийг бүрдүүлэхийн тулд бохирдол, ялгаруулалтын эх үүсвэрүүдийн бүртгэлийг хөтлөх, дуу чимээ, цахилгаан соронзон орны дүн шинжилгээний ажлыг гүйцэтгэнэ. Энэ өргөн цар хүрээтэй хөтөлбөрийг сэдэвчилсэн бусад хөтөлбөр, засаг захиргааны үндэсний болон орон нутгийн бүх шатны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан, нягт хамтын ажиллагаа, зохицуулалтад үндэслэн хэрэгжүүлнэ.

Монгол улс 2006-2015 онд хэрэгжүүлэх орчны эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийг 2005 онд батлан хэрэгжүүлсэн (ЗГ-ын 2005 оны 245 дугаар тогтоол) байна. Хөтөлбөр нь орчны эрүүл мэндийн хяналт, шалгалт, үнэлгээний тогтолцоог сайжруулах, хүний эрүүл мэндэд орчны үзүүлж буй нөлөөнд дүн шинжилгээ хийх, байгаль орчны бохирдлыг бууруулах, орчны хүчин зүйлийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах, орчны эрүүл мэндийн боловсролыг сайжруулахад анхаарчээ. ДЭМБ, ЭМЯ-наас 2016 онд гаргасан Монгол Улсын орчны эрүүл мэндийн байдлын тухай илтгэлд (хөтөлбөрийн үнэлгээний тайлан) эрх зүйн орчин, орчны нөлөөллийн үнэлгээ, салбар хоорондын хамтын ажиллагаа, судалгааны ажлын чадавхийг сайжруулах олон санаачилгыг хэрэгжүүлснийг тэмдэглэсэн байна.

Ус, ариун цэвэр, бүх нийтийн амьдралын нөхцөлийг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлтийн усны нөөцөд үзүүлж буй сөрөг нөлөөг бууруулах, усны хүртээмжийг цаашид хадгалах зорилготой 2010 оны Усны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байна (Бүлэг 1, 9).

Австрали улс, ДЭМБ-ын усны чанарын түншлэлийн хүрээнд усны аюулгүй байдлын төлөвлөлтийн санаачилгыг 2 хот, хөдөөгийн 6 бүсэд 2012 оноос хэрэгжүүлж байна.

Хот суурин хурдацтай тэлж байгаагийн үр дагаврыг бууруулах зорилгоор 2012-2016 онд хэрэгжүүлэх Эрүүл хот, дүүрэг, сум, ажлын байр, сургууль –тай холбоотой үндэсний хөтөлбөрийг 2011 онд батлан хэрэгжүүлж (ЗГ-ын 2011 оны 359 дүгээр тогтоол), хотын төлөвлөлт, дэд бүтэц, эрүүл мэнд, орон сууц, тээврийн үйлчилгээ, ус хангамж, хог хаягдлын менежментэд хотын хүн амын түргэн өсөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, салбар хоорондын хамтын ажиллагаа, ард иргэдийн оролцоог бэхжүүлэх арга хэмжээ авчээ.

2015 оны “Хотжилт ба эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр нь (ЗГ-ын 2015 оны 4 дүгээр тогтоол) хүн амын эрүүл мэндэд хотжилтын үзүүлж буй сөрөг нөлөөг бууруулах, эрүүл аюулгүй амьдралын нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилготой байна.

2009 онд батлагдсан 2009-2016 онд хэрэгжих Хүнсний аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр (ЗГ-ын 2009 оны 32 дугаар тогтоол) хүнс, ХАА-н салбарт чиглэгдсэн, тэжээллэг, аюулгүй, хүртээмжтэй хүнсээр тогтвортой хангах, хүн амын эрүүл мэнд, хөдөлмөрийн өндөр чадавхийг бий болгох зорилготой. Мал сүргийн тогтвортой өсөлт, байгальд ээлтэй технологийг нэвтрүүлэх, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг сайжруулах, үнийг сүлжээг байгуулах, хүнсний бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын стандарт, хүнсний бүтээгдэхүүний зах зээлийг сайжруулах нь хөтөлбөрийн 4 тэргүүлэх чиглэл юм. Хөтөлбөрт аюулгүй, чанартай хүнсний үндэсний стандартыг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Эрүүл бус амьдралын хэв маягаас гаралтай өвчлөлөөс сэргийлэх, хянах 2014-2021 онд хэрэгжих хоёр дахь хөтөлбөр (ЗГ-ын 2014 оны 34 дүгээр тогтоол) нь улс дахь ХБӨ-ний тохиолдлоос сэргийлэх, бууруулах зорилготой байна.

Хорт хавдрын хяналтын 2007-2017 оны үндэсний хөтөлбөр нь хорт хавдраас сэргийлэх, эрт оношлох, эмчлэх үйл ажиллагааг сайжруулах зорилготой. Орчны болон ажлын байрны хүчин зүйлүүдийг тооцсон үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг санал болгосон ба тоон мэдээ мэдээлэл (хяналт мониторингийн мэдээлэл болон хорт хавдрын бүртгэл), менежментийн санхүүжилтийн асуудалд анхаарал хандуулсан. Хөтөлбөрт зөвлөмжийн багцыг оруулсан ба одоогоор хэрэгжилтийн тайлан гараагүй байна.

Дархлаажуулалтын үндэсний хөтөлбөрийг 1991 оноос хэрэгжүүлж, сүрьеэ, полиомелит, В вирус шар, дифтери, бүгшүүлдэг ханиад, татран өвчин, улаан бурханы вакциныг хийж байна. Улаан туурах өвчний вакциныг 2002 оноос нэвтрүүлжээ. 2015, 2016 оны вакцинжуулалтын дундаж үзүүлэлтийг хүснэгт 15.6-т харуулав.

**Хүснэгт 15.6: Хүүхдийн вакцинжуулалтын дундаж үзүүлэлт, 2015 он, хувь**

	Пента вакцин		Полио 3		А шар		DT	
	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
Аймаг	99.3	98.9	97.5	99.1	97.7	99.1	95.5	96.0
Улаанбаатар	98.4	98.4	97.5	97.9	97.5	97.8	91.5	95.5
Улсад	98.9	98.7	97.5	98.5	97.6	98.5	94.1	95.8

Эх сурвалж: Эрүүл мэндийн үзүүлэлтүүд, 2015 он, Эрүүл мэндийн хөгжлийн төв.

Эх, нярайн эрүүл мэндийн 2011-2015 оны үндэсний хөтөлбөр нь 100,000 амьд төрөлт тутам дахь эхийн эндэгдлийн түвшинг (ЭЭТ) 50 болтол бууруулах МХЗ-уудын зорилгыг биелүүлэхэд чухал хувь нэмэр оруулж, 2013 онд Монголын 100,000 амьд төрөлтөд ноогдох эхийн эндэгдлийн түвшин 42.3 болсноор уг зорилт биелэгдсэн байна.

Эх, нярайн эрүүл мэндийн 2017-2021 үндэсний хөтөлбөрийг (ЗГ-ын 2017 оны 78 дугаар тогтоол) хэрэгжүүлж, дараах асуудалд анхаарал хандуулж байна:

- Гэр бүлийн төлөвлөлтийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Эх, нярай, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний бүртгэл, хяналт шалгалт, үнэлгээг сайжруулах;
- Эх, нярай, нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалахад гэр бүлийн гишүүд, иргэдийн оролцоо, хариуцлагыг дээшлүүлэх.

Эмнэлгийн хог хаягдлын менежментийн 2009 оны стратеги болон 2009-2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөө нь эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлыг цуглуулах, ангилах, тээвэрлэх, цэвэрлэх, устгах тогтолцоог бүрдүүлэхэд чиглэгджээ (Бүлэг 10).

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн нөхцөлийг сайжруулах үндэсний хөтөлбөр (ЗГ-ын 2012 оны 122 дугаар тогтоол) нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, журам, дүрэм, технологийн дэглэмийг сайжруулах зорилготой.

#### Бодлогын бусад баримт бичгийн төслүүд

2017 оны Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд Орчны эрүүл мэндийн үндэсний шинэ хөтөлбөрийг боловсруулж байна. Шинэ хөтөлбөр нь 2006-2015 оны Орчны эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийн үргэлжлэл болно.

Уурхайн бүс дахь орон нутгийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, орон нутгийн эрүүл мэндийн салбарын чадавхийг дээшлүүлэх зорилго бүхий Уул уурхай, эрүүл мэндийн 2015-2020 оны стратегийн төслийг боловсруулж байна.

Улаан бурхан, улаан туурах өвчнийг устгах 2016-2020 үндэсний төлөвлөгөө, халдварт өвчний дэгдэлтээс хамгаалах, бэлэн байдлыг дээшлүүлэх үндэсний журмыг боловсруулж байна.

#### *Энэхүү бүлэгтэй холбоотой Тогтвортой хөгжлийн зорилт, зорилгууд*

Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн Зорилт 2.1, 3.1, 3.2, 3.3, 3.4, 3.9, 3.а, 8.8 –уудын биелэлтийн өнөөгийн байдал Монгол улсад ямар байгааг Шигтгээ 15.4-т харуулав.



**Шигтгээ 15.4: Тогтвортой хөгжлийн 2030  
он хүртэлх хөтөлбөрийн Зорилт 2.1, 3.1, 3.2, 3.3, 3.4, 3.9, 3.а болон 8.8**

**Зорилго 2. Өлсгөлөнг зогсоон, хүнсний аюулгүй байдлыг хангаж, тэжээллэг чанарыг нэмэгдүүлэн, хөдөө аж ахуйн тогтвортой өсөлтийг хөхиүлэн дэмжих**

**Зорилт 2.1. 2030 он гэхэд өлсгөлөнг зогсоож, бүх хүмүүс, ялангуяа ядуу болон эмзэг байдалд байгаа хүмүүс, бага насны хүүхдүүд аюулгүй, тэжээллэг, хүрэлцээтэй хүнсээр жилийн турш хангах байдлыг баталгаажуулна.**

Хүн амын амьдралын хэлбэр (малчид), байршил (хот суурин, хөдөө), цаг агаарын нөлөө (зуд) зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан хүн амын ихээхэн ялгаатай байдал нь Монгол улсад шийдвэрлэхэд хүндрэлтэй асуудал юм. Монголд хүн амын ядуурлын хувь 1995 онд 36.3 хувь байсан бол 2014 онд 21.6 хувь болтол буурсан боловч бүсүүд хоорондын ялгаа хэвээр байна. Тухайлбал баруун бүсийн хувьд 31.4 хувь байна. Хотын захын гэр хорооллын ядуу хүн амын асуудал хурцаар тавигдаж байна. Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-д ядуурлын түвшинг 2030 он гэхэд тэглэх зорилго дэвшүүлсэн.

Зудад олон мал хорогддог нь малчдын ядуурал, тэжээлийн хомсдлын гол шалтгаан болдог. Мал нь өрхийн хүнсний аюулгүй байдал, мах, сүү зэрэг хүнсний гол эх үүсвэр болж малчдын амьжиргаанд нэн чухал үүрэгтэй. Байгалийн нөөцийн менежмент, байгальд ээлтэй үйлдвэрлэлийн технологийг хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, нөлөөг бууруулах нь дээрх зорилгыг биелүүлэх үндсэн арга зам юм.

Дээрх зорилтын гол шалгуур үзүүлэлт бол тэжээлийн дутагдал (үзүүлэлт 2.1.1). 1992 онд жингийн дутагдалтай 5-аас доош насны хүүхдийн хувь 12.0 хувь байсан бол 2013 онд 1.6 хувь болтол буурчээ. 5-аас доош насны өсөлт нь саарсан хүүхдийн хувь 1992 онд 12.0 хувь, 2010 онд 15.9 хувь, 2013 онд 1.0 хувь байв. 5-аас доош насны тураалд орох шинжтэй хүүхдийн хувь 2000 онд 5.5 хувь байснаас 2010 онд 3 хувь, 2013 онд 10.8 хувь байв.

Хоёр дахь шалгуур үзүүлэлт нь Хүнсний аюулгүй байдлын түвшний (ХАБТ) аргачлалаар тогтоосон хүн амын хүнсний аюулгүй байдлын дээд, дунд түвшин болно (үзүүлэлт 2.1.2). ХАБТ нь хүнсний хүртээмжийг хувь хүн, айл өрхийн түвшинд тодорхойлдог ба түвшинг тусгай асуулт хариулт, дүн шинжилгээгээр тогтоодог. Монголд ХАБТ-ийн тодорхой мэдээ мэдээлэл байхгүй байна.

**Зорилго 3. Нийт хүн амыг насан турш эрүүл, сайн сайхан амьдрах нөхцөлөөр хангах.**

**Зорилт 3.1. 2030 он гэхэд дэлхийн хэмжээнд эхийн эндэгдлийн хувийг (ЭЭХ) 100,000 амьд төрөлтөд 70□ аас дээшгүй болгон бууруулах.**

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд Монгол Улс хүн амынхаа эрүүл мэндийг сайжруулахад тууштай дэвшил гаргасан боловч бүсүүдийн хооронд эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн нэлээд ялгаа оршсоор байна.

2004 оноос хойш Монголын ЭЭХ (үзүүлэлт 3.1.1) 100,000 хүн тутамд 100-аас доош нас баралттай байна. 100,000 хүн тутамд 50-иас доош нас баралттай байх МХЗ-уудын зорилгыг Монгол Улс 2013 онд 42.3 болгосон үзүүлэлтээр хангасан байна. 2015 оны байдлаар бүх бүсэд ЭЭХ 50 доош үзүүлэлттэй байснаас хамгийн их 28.7 үзүүлэлт (100,000 амьд төрөлт дахь эндэгдэл) төвийн бүсэд тэмдэглэгдсэн. Жирэмсний хүндрэлтэй эмэгтэйчүүдэд эмчилгээ хийсэн, алслагдсан бүсүүдийн эмэгтэйчүүдийг эмнэлгийн үйлчилгээнд хамруулсан нь дээрх үзүүлэлтийн бууралтад нөлөөлсөн байна. Гэвч 2015 оны байдлаар ЭЭХ нь аймаг тус бүрээр ялгаатай, 100,000 амьд төрөлт дахь үзүүлэлт 0-78.5 (Төв аймаг) хооронд хэлбэлзэв. Мөн улирлаас хамааран аймгийн дотор хэлбэлзэл ихтэй байна.

Монголын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-д ЭЭХ-г 2030 он гэхэд 100,000 хүн тутамд ноогдох нас баралтыг 15 –аас бага байлгах зорилго дэвшүүлсэн ба зорилгын биелэлтийг гурван үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Монголд эх, нярайн сэргийлэх боломжтой эндэгдлийн хүчин зүйлийг бууруулах зорилгоор нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, тэжээлийн доройтлыг бууруулах арга хэмжээ авахаар төлөвлөж байна. Гол бэрхшээл нь энэ зорилгыг аймгуудад жигд хэрэгжүүлэх, аймгуудын ялгааг арилгахад оршиж байна. 1991 оноос хойш мэргэжлийн эмчийн хяналтад төрсөн эхчүүд нийт төрөлтийн 99-100 хувийг эзэлж байна (үзүүлэлт 3.1.2).

Монгол Улсын Засгийн газар нийтээр бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах, гадны нөлөөтэй эхийн эндэгдлийг бууруулахад анхаарал хандуулах шардлагатайг 2013 оны МХЗ-уудын 5 дахь үндэсний илтгэлд онцолсон байна.



Зорилт 3.2. 2030 он гэхэд шинэ төрсөн болон 5 хүртэлх насны хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг зогсоох. Ингэхдээ улс орнууд 1000 амьд төрөлтөд шинэ төрсөн хүүхдийн эндэгдлийг 12-оос, 1000 амьд төрөлтөд 5-аас доош насны хүүхдийн эндэгдлийг 25-аас дээшгүй байлгах зорилт тавина.

Энэ зорилтын дэлхийд зөвшөөрөгдсөн хоёр үзүүлэлт нь 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (3.2.1), нярайн эндэгдлийн түвшин (3.2.2) болно.

1990-2010 онд Монголд 5 хүртэлх насны болон нярайн эндэгдлийн түвшин үлэмж буурсан.

2015 онд 1,000 амьд төрөлтөд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 18.0 байсан хэдий ч бүсүүдийн хооронд ихээхэн ялгаатай, жишээ нь 1,000 амьд төрөлтөд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл төвийн бүсэд 13.7 байхад баруун бүсэд 25.3 байна. Монголд энэ хүчин чармайлтыг цаашид үргэжлүүлэн, ялангуяа баруун бүсэд анхаарал хандуулан, Монголын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-д дэвшүүлсэн 2020 он гэхэд 1,000 амьд төрөлтөд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 15, 2030 он гэхэд 9 болгох зорилгыг хэрэгжүүлэх шаардлагатай.

2015 онд 1,000 амьд төрөлтөд нярайн эндэгдэл 15.3 байсан ба үүнээс эрэгтэй хүүхдийн эндэгдэл 58.6, эмэгтэй хүүхэд 41.4 хувийг эзэлж байжээ. Нярайн эндэгдлийн гол шалтгаан нь хот хөдөөд төрөлтийн дараах өвчлөл бөгөөд бүсүүдийн хооронд түвшин маш их ялгаатай. 2015 оны байдлаар 1,000 амьд төрөлтөд нярайн эндэгдэл төвийн бүсэд 11.2 байхад баруун бүсийнх 21.6 байна. Хангай, баруун бүс, 11 аймагт 1,000 амьд төрөлтөд нярайн эндэгдлийн түвшин 15.0-аас илүү байна (өмнөх МХЗ-уудын зорилго). Иймд бүс хоорондын ялгааг арилгах арга хэмжээ авах, 1,000 амьд төрөлтөд нярайн эндэгдлийн түвшинг 8 байхаар тогтоосон зорилгыг хэрэгжүүлэх хэрэгтэй.

2015 онд нийт 80,875 амьд төрөлт бүртгэгдсэн, үүнээс шинэ төрсөн хүүхдийн 4.4 хувь нь биенийн жин 2,5 килограммаас бага, 94.8 хувийг төрсний дараах нэг цагт хөхүүлсэн байна. 2015 онд 1,000 төрөлтөд амьгүй төрсөн хүүхэд 6.8 байв. 2015 онд төрөхийн дараах өвчлөлийн нийт 16,799 тохиолдол бүртгэгдсэн нь нийт амьд төрөлтийн 20.8 хувийг эзэлсэн.

2016 онд нярайн эндэгдлийн тал (54.8) хувь нь төрөхийн дараахан тохиолдсон ба 1,000 амьд төрөлтөд нярайн эндэгдлийн түвшин 9.2 байв (721 тохиолдол). Төрсний дараах эндэгдлийн 74.2 хувь (528 тохиолдол) нь эхний 0-6 өдөрт, 26.8 хувь нь (193 тохиолдол) төрснөөс дараах 7-28 өдөрт гарсан байна.

Зорилт 3.3. 2030 он гэхэд ДОХ, сүрьеэ, хумхаа, урьд нь анхаардаггүй байсан халуун орны өвчнийг зогсоох, шар, усаар дамждаг болон халдварт бусад өвчинтэй тэмцэх.

2015 оны байдлаар ДОХ-ын халдвартай хүмүүс нийт хүн амын 0.1 хүрэхгүй хувийг эзэлж байсан ба жирэмсэн эмэгтэйчүүд, 15-24 насны залуучуудын дунд 0.05 доош хувьтай байна. 1992 оноос хойш ДОХ-ын 199 тохиолдол бүртгэгдсэн, үүнээс 159 эрэгтэй, 39 эмэгтэй, 199 хүнээс 27 нь нас барсан байна.

2011 оноос хойш сүрьеэгийн тохиолдол 100,000 хүн тутамд 140 орчим байгаа (үзүүлэлт 3.3.2) ба 1990 оноос сүрьеэгээр нас барсан хүний тоо аажмаар буурч байна. Нас баралт 100,000 хүн тутамд 1990 онд 4.8, 2000 онд 3.1, 2010 онд 3.3, 2014 онд 2 байв.

Оношилгоо, эмчилгээний олон улсын стандартын хүрээнд илрүүлж, эмчилсэн сүрьеэгийн тохиолдлын хувь 1995 онд 62.5 байсан ба 2014 онд 80.7 болтол өссөн. 2013 оны МХЗ-уудын тав дахь үндэсний илтгэлд “ОЭТС-тэй өвчтөний эмчилгээгээ таслах, үр дүнгүй болох тохиолдол нэмэгдэж байгаа нь аймаг, сумын түвшингийн ОЭТС-ийн эмчилгээний хяналт сул, сүрьеэгийн байгууллагын боловсон хүчний хангамж, тогтвор суурьшил муу байгаагаас голлон шалтгаалж байна. Түүнчлэн сүрьеэгийн өвчлөл дорвитой буурахгүй байгаад сүрьеэгээр өвдөгсдийн өвчин нь дахин сэдэрх, өвчилсөн тохиолдолд эмчид үзүүлэхгүй байсаар хожуу оношлогдох, оношлогдох хүртлээ халдвараа бусдад тараах, эмчлэгдэж байгаа тохиолдолд эмчилгээгээ орхих, таслах, эмэнд тэсвэртэй сүрьеэтэй болох зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна” гэж тэмдэглэжээ.

Сүүлийн жилүүдэд хумхаа өвчний тохиолдол Монголд бүртгэгдээгүй байна (үзүүлэлт 3.3.3).

Монголд В вируст шар маш түгээмэл ба Монгол Улс нь В вируст шарын вакциныг 1 хүртэлх насны хүүхэд болон нярайд дархлаажуулалтын зорилгоор хийж эхэлсэн анхны орнуудыг нэг юм. Монголд В вируст шарын тохиолдол үлэмж буурсан ба 2015 оны байдлаар нийт вируст шарын дотор 54.1 хувийг эзэлсэн. 2011 оноос 10,000 хүн тутамд В вируст шарын тохиолдол (үзүүлэлт 3.3.4) 2 орчим, 2011 онд 2.7 байсан бол 2015 онд 1.6 болтол буурсан байна.

Монголын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-д урьдчилан сэргийлэх, эрт оношлох, эмчлэх замаар халдварт өвчний тархалтыг бууруулах зорилгыг дэвшүүлсэн. Энэ зорилгыг биелүүлэхэд вакцинжуулалт, эрүүл мэндийн үйлчилгээний чанар гол үүрэг гүйцэтгэнэ. 2030 он гэхэд 10,000 хүн тутам дахь шарын тохиолдлыг 2, сүрьеэгийн тохиолдлыг 13 болтол бууруулах зорилго дэвшүүлсэн.

**Зорилт. 3.4. 2030 он гэхэд урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон эмчилгээ, оюуны эрүүл мэнд болон амьжиргааг сайжруулах замаар халдварт бус өвчний нас баралтыг гуравны нэгээр бууруулах.**

Энэ зорилтын дэлхийд хүлээн зөвшөөрсөн хоёр үзүүлэлт нь зүрх судас, хорт хавдар, шижин, амьсгалын замын архаг өвчний нас баралтын түвшин (3.4.1), амиа егүүтгэх нас баралтын түвшин (3.4.2) юм.

2014 онд монголын нийт нас баралтын 79 хувийг ХБӨ эзэлснээс (19,000 нас баралт) зүрх судасны өвчин тэргүүлж 43 хувь, хорт хавдар 17 хувь, амьсгалын замын архаг өвчин 3 хувь, шижин 1 хувийг тус тус эзэлж байжээ. 2015 онд 10,000 хүн тутамд зүрх судасны өвчний түвшин 18.5 (2030 онд гэхэд 14 нас баралт болгох зорилго тавьсан), 100,000 хүн тутамд хорт хавдар 131.8 (2030 онд гэхэд 10,000 хүн тутамд 8 нас баралт болгох зорилго тавьсан), 100,000 хүн тутамд амьсгалын замын архаг өвчин 20.3, шижин 6.2 байсан байна.

2030 оны зоримог зорилгуудыг биелүүлэхийн тулд хүн амыг муу зуршлаас ангижруулж, амьдралын орчныг сайжруулахаар төлөвлөж байна. Хорт хавдраас сэргийлэх, хянах үйл ажиллагааг тогтмол хийдэг. 2015 онд хөх, умайн хүзүүний хорт хавдрыг эрт оношлох үзлэгт 72,851 эмэгтэйчүүд хамрагдсан нь хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн 69.5 хувь байна.

2014 оноос хойш Монголд Эрүүл бус амьдралын хэв маягаас үүдэлтэй өвчлөлөөс сэргийлэх, хянах хоёр дахь 2014-2021 оны хөтөлбөрийг хэрэгжүүлж (ЗГ-ын 2014 оны 34 дүгээр тогтоол) байгаа нь үзүүлэлтийн цаашдын хөгжлийг ажиглах зохистой арга хэрэгсэл байж болох талтай.

2015 онд нийт 479 хүн амиа егүүтгэснээс эрэгтэй 408, эмэгтэй 71 байна.

Зорилт 3.9. 2030 он гэхэд химийн хорт бодис, агаар, ус, хөрсний бохирдол, хордуулалтаас үүдэлтэй үхэл, өвчлөлийн тоог үлэмж бууруулах.

Хүн амын амьдралын чанарыг сайжруулах, амьдралын эрүүл орчин бүрдүүлэхэд олон үйл ажиллагаа хэрэгжүүлэх шаардлагатай байна. Усны нөөцийг хамгаалах, ундны усны хангамжийг сайжруулах, чанарыг сайжруулах, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжуудыг хөгжүүлэх нь тулгамдсан зорилго болж байна.

Мөн орчны агаарын бохирдлыг бууруулах, сургууль, эмнэлэг зэрэг олон нийтийн барилга байгууламжийн доторх агаарын бохирдлыг бууруулах шаардлагатай. Монголд дэлхийд зөвшөөрөгдсөн зорилго 3.9 үзүүлэлтүүдийг нэвтрүүлэх, уялдуулах системийг боловсруулах хэрэгтэй. Зорилго 3.9 холбоотой нэмэлт мэдээллийг Шигтгээ 8.1 болон 10.3 -д оруулсан болно.

**Зорилт 3.а. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Тамхинд хяналт тогтоох суурь Конвенцийн хэрэгжилтийг бүх улс оронд зохих ёсоор эрчимжүүлэх.**

2013 оны байдлаар 15, түүнээс дээш насны хүмүүсийн 27.1 хувь тамхи татаж байна (үзүүлэлт 3.а.1).

**Зорилго 8. Хүртгэмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих, нийт хүн амыг бүрэн, үр бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлт, зохистой ажлын байраар хангах.****Зорилт 8.8. Хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, бүх ажилчид, тухайлбал цагаач ажилчид, ялангуяа эмэгтэй цагаач ажилчид, түр ажил эрхэлж байгаа хүмүүсийн ажлын байрны аюулгүй, баталгаатай орчинг хангах.**

Монгол Улсын эдийн засаг уул уурхай, барилга, тээвэр, эрчим хүчний салбараас ихээхэн хамааралтай бөгөөд эдгээр салбарууд нь аж үйлдвэрийн осол, ажлын байрны өвчлөлийн дийлэнхийн шалтгаан болдог. Өрхийн, жижиг болон дунд ААН-үүд олширч байгаа өнөөгийн нөхцөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, журам, дүрэм, технологийн дэглэмийг мөрдөх нь чухал асуудал болсон. Ажлын байрны болон эрүүл мэндийн осол гэмтэл буурахгүй байгаа нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн стандартыг мөрдөхгүй байгаатай холбоотой. Жишээ нь 2005-2011 онд Монголд 661 хүн нас барж, ажлын байрны 1,321 өвчлөлийн тохиолдол шинээр бүртгэгдсэн ба 83,940.5 сая төгрөгийг аж үйлдвэрийн осол, ажлын байрны өвчлөлийн даатгал, тэтгэлэг, урамшуулалд зарцуулсан байна.

*Бүтэц зохион байгуулалтын тогтолцоо**Эрүүл мэндийн яам*

Нийт хүн амыг хүртгэмжтэй, хямд, чанартай эрүүл мэндийн үйлчилгээгээр хангах үүргийг ЭМЯ хүлээж, хүн амыг өвчлөлөөс сэргийлэх зорилгоор эрүүл, аюулгүй, гэжээллэг хүнсээр хангах зорилгыг хэрэгжүүлдэг. ЭМЯ нь эрүүл мэндийн бүх бодлого, үндэсний хөтөлбөр, стандартыг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэгтэй. Эрүүл мэндийн улсын агентлагууд, орон нутаг дахь эрүүл мэндийн байгууллагууд эрүүл мэндийн бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. 2017 онд яаманд орчны эрүүл мэндийн асуудлыг 3 ажилтан, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд 18 ажилтан хариуцаж байв. 2013 он хүртэл яамны нэг ажилтан уур амьсгалын өөрчлөлт, эрүүл мэндийн асуудлыг хариуцаж байсан ба 2013 оноос хойш ямарваа нэгэн үйл ажиллагаа явагдаагүй байна.

Шинэ өвчнийг хянах, хариу арга хэмжээ авах нэгж нь халдварт өвчний бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах, урьдчилан сэргийлэх, эрт оношлох замаар үндэсний тогтвортой тогтолцоог бүрдүүлэх, нийгмийн эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (НЭМҮТ)-ийг баримтад суурилсан бодлого боловсруулах, шийдвэр гаргахад техникийн удирдамжаар хангах, хүний нөөцийн чадавхийг сайжруулах, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор 1968 онд байгуулжээ. Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн нэртэй байсныг 2013 онд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв болгон, бүтэц зохион байгуулалт, үүргийг өргөжүүлсэн байна.

Шинэ бүтцийн хувьд нийгмийн эрүүл мэндийн судалгааг хариуцах гол үүргийн зэрэгцээ НЭМҮТ нь эрүүл мэндийн олон хөтөлбөрийн хэрэгжилт, эрүүл мэндийн үйл ажиллагааг улсын хэмжээнд сайжруулах олон талт үүрэг хүлээдэг. Төвийн үйл ажиллагаа нь байгаль орчин, хөдөлмөрийн эрүүл мэнд болон судалгаа, хордолтын судалгаа, тэжээлийн судалгаа, зан байдлын судалгаа зэрэг салбарыг хамаардаг.

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь эрүүл мэндийн бүх үзүүлэлтийг цуглууж, сар тутам шинжилж, жил тутмын товхимлыг боловсруулдаг. Сумдын өрхийн эмч нар үзүүлэлтийг аймгийн эрүүл мэндийн газарт хүргүүлдэг ба аймгаас сар бүрийн эхний өдөр нэгтгэсэн мэдээллийг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлдэг байна.

Халдварт өвчний үндэсний төв, ХБӨ-ний үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Эрүүл мэндийн үндэсний төвүүд чиглэл тус бүрээр үйл ажиллагаа явуулдаг. Хорт хавдрын бүртгэлийн төв алба Хавдар судлалын үндэсний төвд ажилладаг. Хавдар судлалын үндэсний төв нь дүүргийн эмнэлэг, аймгийн эрүүл мэндийн төвүүдээс хорт хавдрын өвчлөл, нас баралтын мэдээг цуглуулж байна.

Сүүлийн үеийн халдварт өвчний дэгдэлтүүд нь нийгмийн эрүүл мэндийн тогтолцооны сул талуудыг илчилснийг ДЭМБ-ын Монгол дахь газар тэмдэглэж байна. Олон улсын эрүүл мэндийн мониторингийн журмын дагуу боловсруулсан жил тутмын эрүүл мэндийн илтгэлүүд нь халдварт өвчний хяналт, эмчилгээний үндсэн чадавхи доод хэмжээнд байгааг харуулсан, олон улсын шаардлагыг биелүүлэхийн тулд орон нутгийн хяналт, эмчилгээний чадавхийг ихээхэн дээшлүүлэх хэрэгтэй байна. Халдварт өвчний хяналтын мэдээ мэдээллийг улсын хэмжээнд долоо хоног тутам шинжилдэг боловч орон нутгийн түвшинд эрсдлийн үнэлгээ хийх чадавхи хязгаарлагдмал байна.

#### Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)

ХХААХҮЯ нь мал аж ахуй, газар тариалан, хүнсний аюулгүй байдал, хөнгөн үйлдвэрлэлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, бордоо, пестицидийн баглаа боодол, аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Пестицид, химийн бодисыг ХАА-д ашиглах асуудлыг БОАЖЯ, ХХААХҮЯ, ЭМЯ хамтран зохицуулж байна (Бүлэг 1).

#### Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)

БОАЖЯ нь агаар, ус, ойн сан, хөрс, цөлжилт, байгаль хамгаалал, биологийн олон янз байдал, тусгай хамгаалалттай газар нутаг, хог хаягдал, байгаль орчны үнэлгээ зэрэг байгаль орчинтой холбоотой асуудлуудыг хариуцна.

#### Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ)

МХЕГ-ын эрүүл ахуй болон байгаль орчны байцаагчид (Бүлэг 1,2) байгаль орчин, эрүүл мэндийн хуулиудын дагуу тухайн чиглэлээр хяналт шалгалтыг гүйцэтгэдэг. МХЕГ нь усны эх үүсвэр, ундны ус түгээх цэгүүдийн шалгалт, хяналтыг хийдэг. Хүнсний аюулгүй байдлын хяналтын хувьд бүх шатанд, түүхий эдээс эхлэн бэлэн бүтээгдэхүүний хяналт шалгалтыг хийдэг. Мөн эмнэлгийн эрүүл ахуй, ариун цэвэр, хог хаягдлын менежментэд хяналт шалгалт хийдэг байна.

#### Улаанбаатар хотын захиргаа

Байгаль орчны бохирдуулагч хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөг бууруулах үүрэгтэйгээр Орчны эрүүл мэндийн хэлтсийг хотын захиргаанд 2000 онд байгуулжээ. Хэлтэс нь ус, агаарын чанар, ариун цэврийн байгууламжууд, хог хаягдлын менежментэд анхаарал хандуулж, эрүүл ахуй, эрүүл мэндийн үйл ажиллагаатай холбоотой зөвлөмж гарган, Улаанбаатар хот дахь байгаль орчны болон эрүүл мэндийн хүрээлэнгүүд, өрхийн эмч нар, сургуулиудтай хамтран ажилладаг.

### *Урьдчилан сэргийлэх арга хэмжээ*

Халдварт өвчний хяналтын тогтолцоо нь эрүүл мэндийн байгууллагуудаас авсан өвчлөлийн мэдээллийг системтэй бүртгэн Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлдэг. Орчин, амьдралын хэв маяг, хорт зуршил зэрэг эрүүл мэндийн сөрөг хүчин зүйлүүдээс үүдэлтэй өвчлөлөөс сэргийлэх хэд хэдэн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний өдрүүдийг (дэлхийн тамхигүй өдөр, шижин, багтраа ханиаднаас сэргийлэх өдөр г.м.) тэмдэглэдэг байна.

### *Орчны эрүүл мэндтэй холбоотой гэрээ хэлэлцээр*

Монгол Улс нь олон улсын хөдөлмөрийн байгууллагын (ОУХБ) 20 орчим конвенцид, үүний дотор орчны эрүүл мэндтэй холбоотой дараах конвенцид нэгдэн орсон байна:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл мэндийн конвенци, 1981 он (№ 155) (1998 оноос);
- Уул уурхайн аюулгүй байдал, эрүүл мэндийн конвенци, 1995 он (№ 176) (2015 оноос);
- Хөдөлмөрийн доод насны тухай конвенци, 1973 он (№ 138) (2002 оноос; доод насыг 15-аар тогтоосон);
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд, 1999 он (№ 182) (2001 оноос).

Монгол Улс ОУХБ-ын орчны эрүүл мэндийн дараах конвенцид одоогоор нэгдээгүй байна:

- Хөдөлмөрийн хяналт шалгалтын тухай конвенци, 1947 он (№ 81);
- Хөдөлмөрийн хяналт шалгалтын тухай конвенци (ХАА), 1969 он (№ 129);
- Цацрагаас хамгаалах тухай конвенци, 1960 он (№ 115);
- Ажлын байрны орчны тухай (агаарын бохирдол, чимээ шуугиан, чичрэлт) конвенци, 1977 он (№ 148);
- Хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл мэндийн конвенци, 1979 он (№ 152);
- Шөрөмсөн чулууны тухай конвенци, 1986 он (№ 162);
- Барилгын аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай конвенци, 1988 он (№ 167);
- Химийн бодисын конвенци, 1990 он (№ 170).

## **15.6 Үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж**

### *Үнэлгээ*

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд Монгол улсын хүн амын эрүүл мэндийн нөхцөл байдал сайжирсан нь вакцинжуулалт, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотой байна. Гэвч эрүүл мэндийн үзүүлэлтүүд нь бүс, аймгуудад ихээхэн ялгаатай, бүсээс шалтгаалан хүн амын амьжиргаа, орчин тэс өөр, эрүүл мэндэд олон янзаар нөлөөлж байна. Эрүүл мэндийн тэгш бус байдлыг бууруулахад алслагдсан бүсэд оршин суудаг хүмүүсийг эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах явдал чухал ач холбогдолтой юм. Гэвч хүний эрүүл мэнд нь орчин, тэжээл, нийгэм, боловсрол, хөдөлмөр эрхлэлт зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалдаг.

Эрүүл мэндийн хүчин зүйлийн бүртгэлийн мэдээллийн сан байгуулсан боловч түүнд багтраа ханиад, шөрөмсөн чулуутай холбоотой өвчлөл, легионелоз зэрэг өвчнийг хамруулаагүй, өвчлөлд орчны хүчин зүйлийн нөлөөг тодорхойлоогүй байна. Тугалга, нүүрстөрөгчийн дутуу исэл (СО)-ийн хордолт зэрэг орчны онцлог шинжилгээг хийдэггүй, хордолтын эх үүсвэрийг тогтоох, түүнийг арилгах үйл ажиллагаа зохион байгуулаагүй байна.

ЭМЯ-ны харьяа хэд хэдэн үндэсний судалгааны төвүүд олон чиглэлээр үйл ажиллагаа явуулж, тэдгээрийн шинжлэх ухааны ажил, мэдээллийн дүн шинжилгээ нь орчны эрүүл мэндийн асуудлуудыг тодорхойлох, зохистой хариу арга хэмжээ авахад Засгийн газарт бодит дэмжлэг болдог байна.

2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн бусад зорилт, зорилготой харьцуулдал Монгол Улс 3 дугаар зорилтыг хэрэгжүүлэх нөхцөл, үзүүлэлтийг бүрдүүлсэн, 2030 он хүртэлх үндэсний зорилгуудыг Монгол Улсын бодлогын суурь баримт бичиг Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-д тодорхойлсон байна.

Дүгнэлт, зөвлөмжОрчны эрүүл мэндийн үзүүлэлтүүд

Монголын хүн ам агаар, ус, орчны олон бохирдуулагчид ихээхэн өртөж байна. Химийн бодис, аюултай хог хаягдал, шөрмөсөн чулуу, хар тугалга, радон хий зэрэг аюултай бодисын мэдээллийн сан бүрдээгүй, тэдгээрийн ялгаруулалтын хэмжээ болон байршлыг тогтоогоогүй, цуглуулсан мэдээ мэдээллийг мэдээллийн санд оруулж хэвшээгүй байна. Иймд хүн ам бохирдуулагчид өртөж, тэдний эрүүл мэндэд нөлөөлж байгаа асуудлыг тогтоох боломжгүй, хүн амыг өртөлтөөс хамгаалах чадваргүй байна.

Зөвлөмж 15.1:

*ЭМЯ нь УСХ-той хамтран орчны эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг тодорхойлох, орчны эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг цуглуулах ажлыг зохион байгуулах, олон нийтэд хүртээмжтэй болгох.*

Орчны хүчин зүйлс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг судлах

Аюултай бодисууд (химийн бодисууд, аюултай хог хаягдал, шөрмөсөн чулуу, хар тугалга, радон хий зэрэг) болон тэдгээрийн ялгаралт, байрлалын тухай мэдээллийн сан бий болгоогүй, мэдээллийг цуглуулж мэдээллийн санд оруулахгүй байна. Иймд эдгээр бодисыг иргэд хэрхэн ашиглаж, тэр нь эрүүл мэндэд яаж нөлөөлж байгааг судлан тогтоогоогүй тул ийм үр дагавраас сэргийлэхэд хүдрэлтэй юм.

Зөвлөмж 15.2:

*ЭМЯ нь шинжлэх ухааны бусад байгууллагуудтай хамтран дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Орчны хүчин зүйлийн хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөг судлах;*
- (a) *Шөрмөсөн чулуу, хар тугалганы хордолт, легионелоз зэргээс үүдэлтэй өвчлөлийн бүртгэлийг хөтлөх;*
- (a) *Эдгээр өвчлөлийн эх үүсвэрийг тогтоон, арилгах зорилгоор нарийвчилсан шинжилгээ судалгаа хийх.*

Орчны эрүүл мэндийн нийтлэг стратеги боловсруулах шаардлага

Улсын хэмжээний бүс нутгуудын ялгаатай байдлыг Засгийн газар харгалзан орчны эрүүл мэндийн зорилгуудыг тодорхойлсон байна. Орчны эрүүл мэндийн олон хөтөлбөр байгаа боловч тэдгээрийн аймаг, орон нутгийн түвшин дахь хэрэгжилт, эцэслэсэн үнэлгээний мэдээ мэдээлэл байхгүй, олон төрлийн төлөвлөгөө, хөтөлбөрийн уялдаа тодорхой бус, орчны эрүүл мэндийн тэргүүлэх чиглэлүүд, суурь стратегийг тодорхойлоогүй байна. Түүнчлэн шөрмөсөн чулуу, дотор агаарын чанар, орчны дуу чимээ шуугиан зэрэг тодорхой сэдэв, чиглэлийн үйл ажиллагааны төлөвлөгөө байхгүй байна.

Орчны хүчин зүйлийн хүн амын эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөний талаар мэдлэг тун хязгаарлагдмал, агаарын бохирдлоос бусад, жишээ нь шөрмөсөн чулуу, орчны чимээ шуугиан, химийн бодис, хүний үйл ажиллагааны эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөг баримтжуулаагүй байна. Хүн амын эрүүл мэндэд нөлөөлж буй орчны гол хүчин зүйлүүдийг тогтоох, үйл ажиллагаа, тэргүүлэх чиглэлийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна.

Зөвлөмж 15.3:

*Засгийн газар дараах арга хэмжээг боловсруулан, хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Орчны эрүүл мэндийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн үнэлгээнд суурилан орчны эрүүл мэндийн суурь стратегийг боловсруулах;*
- (b) *Орчны эрүүл мэндийн суурь стратегид суурилсан сэдэвчилсэн үндэсний хөтөлбөрүүдийг боловсруулах;*
- (c) *Орчны эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөөг холбогдох бүх байгууллагуудтай хамтран засаг захиргааны бүх түвшинд боловсруулах.*

Усны аюулгүй байдал



Аюулгүй усны хүртээмж, ариун цэврийн нөхцөл нь хөдөө, алслагдсан орон нутагт тулгамдсан асуудал болж байна. Усны нөөцийг хамгаалах ажлыг тогтвортой хийж чадахгүй байгаа нь усны чанарыг хадгалах, усны бохирдлоос сэргийлэх гол арга хэмжээ юм. Усны аюулгүй байдлын зураглалыг гаргаж, ундны усны чанар, усны эх үүсвэр, ариун цэврийн дэд бүтцийн эрсдлийг тогтоосон байна. Усны чанар, эх үүсвэрийг хамгаалах, ус ашиглалтын төрийн цогц бодлого боловсруулах шаардлагатай байна.

Нийт халдварт өвчлөлийн 59.5 хувь нь сургууль болон сургуулийн өмнөх насны хүүхдэд тохиолдож байна. Сургууль, цэцэрлэг, ялангуяа алслагдсан бүсүүдэд аюулгүй ундны усны хангамж тулгамдсан асуудал болоод байна. Үндэсний болон олон улсын байгууллагууд орон нутагт олон арга хэмжээ зохион байгуулсан боловч бүх аймгийг хамруулж чадаагүй байна. 2012 оноос усны аюулгүй байдлын төлөвлөлтийн санаачилгыг Австрали, ДЭМБ-ын усны чанарын түншлэлийн хүрээнд хоёр хот, орон нутгийн 6 бүсэд хэрэгжүүлсэн боловч энэ үйл ажиллагааг Засгийн газрын мэдэлд оруулаагүй байна.

#### Зөвлөмж 15.4:

*ЭМЯ нь БОАЖЯ, БХБЯ-тай хамтран дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Усны аюулгүй байдлын төлөвлөлтийн санаачилгад үндэслэн Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх;*
- (b) *Сургууль, цэцэрлэгийн ундны аюулгүй усны хангамж, ариун цэврийн нөхцөлийг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх;*
- (c) *Усны бохирдлыг бууруулах бодлого, үйл ажиллагааг боловсруулах.*
- (d) *Ундны усыг давсгүйжүүлэх хөтөлбөрийг өмнөд бүсэд хэрэгжүүлэх.*

#### Хот төлөвлөлт, орчин болон эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ

Орчны дарамт нь олон хүчин зүйлээс бүрддэг бөгөөд түүний хуримтлагдсан нөлөө нь хүн амын эрүүл мэндэд ихээхэн сөрөг нөлөөтэй. Хүчин зүйл бүрийг тооцоход бэрхшээлтэй хэдий ч орчны эрүүл мэндийн асуудлыг хотын төлөвлөлт, хөгжилд тусгаснаар эрүүл орчныг бүрдүүлэх таатай нөхцөлийг бий болгоно. Эрүүл хотуудыг байгуулахад хотын төлөвлөлт, орчин, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ чухал үүрэгтэй боловч өнөөгийн байдлаар эдгээр хүчин зүйлийг зохистой ашиглахгүй байна.

Засгийн газар орчны болон эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээнд анхаарч саяхан эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг нэвтрүүлсэн нь хүн амыг орчны сөрөг нөлөө, нөхцөлөөс хамгаалах, эрүүл орчин бүрдүүлэхэд чухал алхам болжээ.

#### Зөвлөмж 15.5:

*Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Орчны болон эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг тогтмол хийж, дүгнэлтүүдийг ашиглах;*
- (b) *Орчны эрүүл мэндийн асуудлыг хотын төлөвлөлт, байгуулалтад тусгаж, эрүүл хотуудыг байгуулахад дэмжлэг үзүүлэх.*

#### Агаарын бохирдлын эрүүл мэндийн нөлөө

Агаарын бохирдол нь улсын хэмжээнд, ялангуяа Улаанбаатар хотод тулгамдсан асуудал болж, SO<sub>2</sub>, NO<sub>2</sub>-зэрэг бодисын жилийн агууламж ДЭМБ-гаас зөвшөөрөгдсөн хэмжээнээс дээгүүр байна. Аж үйлдвэрийн бохирдуулагчийн ялгаралтын хэмжээг тогтоож зохицуулах шаардлагатай байна. Дотор агаарын чанар нь эрүүл мэндийн чухал үзүүлэлт, ялангуяа цагийн дийлэнхийг дотор, гэр сургуульд өнгөрүүлдэг хүүхдүүдийн хувьд чухал ач холбогдолтой юм. 2016 оны НҮБХС-ийн илтгэлд дотор агаарын бохирдлын хүний эрүүл мэнд, ялангуяа хүүхдийн эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөг тэмдэглэсэн байна. Дотор агаарын чанарын судалгаа нь нүүрс шаталтаас үүдэлтэй бохирдуулагчид төвлөрсөн бөгөөд тугалга, уусгагч зэрэг бохирдуулагчийн талаар судалгаа хийгдээгүй байна. Бохирдуулагчийн эх үүсвэрийг арилгах талаар байгаль орчны судалгаа шинжилгээ хийгээгүй байна.

#### Зөвлөмж 15.6:

*Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Агаарт бохирдуулагч ялгаруулахыг хязгаарлах, хүн амыг гадна, дотор агаарын бохирдлоос хамгаалах үйл ажиллагаа хэрэгжүүлэх,*
- (b) *Агаар бохирдуулагчдын үндэсний стандартыг сайжруулах.*

Шөрмөсөн чулуу, хар тугалга

Монгол улсад шөрмөсөн чулууг одоо болтол ашигласаар байна. Шөрмөсөн чулууны хэрэглээг шийдвэрлэхтэй холбоотой зарим арга хэмжээг авч хэрэгжүүлсэн боловч энэ ажил зогсож, стандарт, дүрэм журам боловсруулах, хяналт тавих, бүртгэх зэрэг ажил хэрэгжихгүй байна. Одоогоор шөрмөсөн чулууг ашиглах талаар стандарт, барилгыг буулгахын өмнө түүнийг илрүүлэх бодлого байхгүй байна.

Хар тугалга бүхий бензин ашиглахыг 2008 онд хоригложээ. Гэвч өвлийн улиралд ахуйн хэрэгцээнд нүүрс түлэх үед хар тугалга агаарт гарсаар байна. Янз бүрийн эх үүсвэрээс, тухайлбал будаг, хүүхдийн тоглоом, ажлын байртай болбоотой хар тугалга, мөн тоос шороо, хөрсөн дэхь хар тугалганы тухай болон түүний хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөний тухай мэдээлэл байхгүй байна.

Шөрмөсөн чулуу болон хар тугалга агуулсан будаг ашиглах асуудлыг зохицуулсан хууль эрх зүйн баримт бичиг байхгүй байна. Хар тугалганы хордолтын талаарх сэрэмжүүлэг, тохиолдлуудын талаарх байгаль орчны судалгаа хийгдээгүй байна.

Зөвлөмж 15.7:

*Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Шөрмөсөн чулуу, хар тугалганы ашиглалт, хэрэглээний талаарх мэдээлэл цуглуулах;*
- (b) *Шөрмөсөн чулуу, түүний ашиглалтын талаар судалгаа хийх;*
- (c) *Шөрмөсөн чулуу, хар тугалганы агуулгатай будаг ашиглахыг хориглох хууль тогтоомж, арга хэмжээг боловсруулах;*
- (d) *Хүүхдийн хар тугалгад хордох явдлыг бууруулах арга хэмжээ авах;*
- (e) *Шөрмөсөн чулуу, хар тугалганы хог хаягдлын менежментийг боловсруулах.*

Уул уурхай болон эрүүл мэнд

Өнгөрсөн 20 жилд уул уурхайн үйл ажиллагаа идэвхжиж, байгаль орчин, ажилчид, хүн амын эрүүл мэнд, мал сүрэгт сөргөөр нөлөөлж байна. Уул уурхайн бүсэд амьдардаг хүн ам, малын эрүүл мэндэд агаар, хөрс, усны бохирдол ихээхэн нөлөөлж байгаа боловч эрүүл мэндэд чухам ямар хэмжээний нөлөөлөл байгааг тогтооход бэрхшээлтэй байна. ЭМЯ, БОАЖЯ, УУХҮЯ -аас ДЭМБ-тай хамтран уул уурхай, эрүүл мэндийн 2015-2020 оны стратегийн төслийг боловсруулсан боловч 2017 оны дунд үе гэхэд батлагдаагүй байна.

Зөвлөмж 15.8:

*Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Уул уурхай, эрүүл мэндийн стратегийн төслийг батлан хэрэгжүүлэх;*
- (b) *Уул уурхайн үйл ажиллагааны хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөний талаар цогц судалгаа хийх;*
- (c) *Бохирдуулагчийн ялгаруулалтыг бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэх.*

Химийн баталгаат байдал болон хөрсний бохирдол

Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хөрсний бохирдол нь цаашдаа хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх магадлалтай байна. Гэвч бохирдсон хөрс, түүний хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөний талаар судалгаа, мэдээлэл хомс байна. Үйлдвэр аж ахуйн газар, арьс шир боловсруулах үйлдвэр болон уул уурхайн цэвэрлээгүй бохир ус нь гол горхийг бохирдуулж байна. Гэвч үйлдвэрийн бохир усны агуулга, хэмжээний тухай мэдээлэл байхгүй, түүний байгаль орчин, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг судлаагүй байна.

Зөвлөмж 15.9:

*Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино:*

- (a) *Бохирдсон хөрсний мэдээллийн сан бүрдүүлэх;*
- (b) *Химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөний талаар судалгаа хийх (бохирдсон хөрс, аж үйлдвэрийн ялгаруулалт);*

- (с) Хүн амыг химийн бодисын эрсдлээс хамгаалах бодлого, арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлэх.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенцүүд

Монгол Улс нь ОУХБ-ын олон конвенцид, үүний дотор орчны эрүүл мэндийн конвенцид нэгдсэн боловч зарим конвенцид нэгдээгүй байна. Эдгээр конвенцид нэгдэх нь нийт ажилчдын аюулгүй хөдөлмөрлөх орчныг бүрдүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, 2030 он хүртэлхи Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн зорилго 8.8-г хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах болно.

Зөвлөмж 15.10:

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам нь ОУХБ-ын орчны эрүүл мэндийн дараах конвенциудад нэгдэх санаачилгыг гаргавал зохино:

- (a) Хөдөлмөрийн хяналт шалгалтын тухай конвенци, (ОУХБ 81);
- (b) Хөдөлмөрийн хяналт шалгалтын тухай конвенци (ХАА), 1969 он (ОУХБ 129);
- (c) Цацрагаас хамгаалах тухай конвенци, 1960 он (ОУХБ115);
- (d) Ажлын байрны орчны тухай (агаарын бохирдол, чимээ шуугиан, чичрэлт) конвенци, 1977 он (ОУХБ 148);
- (e) Хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл мэндийн конвенци, 1979 он (ОУХБ 152);
- (f) Шөрөмсөн чулууны тухай конвенци, 1986 он (ОУХБ 162);
- (g) Барилгын аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай конвенци, 1988 он (ОУХБ 167);
- (h) Химийн бодисын конвенци, 1990 он (ОУХБ 170).



## ***ХАВСРАЛТ***

***Хавсралт I: Монгол улсын нэгдэн орсон байгаль  
орчны олон талт гэрээ хэлэлцээр***

***Хавсралт II: Байгаль орчинтой холбоотой гол хууль,  
тогтоомжийн жагсаалт***

***Хавсралт III: Эх үүсвэр***

***Хавсралт IV: Газрын зураг***





## Хавсралт I

## МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН БАЙГАЛЬ ОРЧНЫ ОЛОН ТАЛТ ГЭРЭЭ ХЭЛЭЛЦЭЭР

		Монгол улс	
Он		Он	Төлөв
1958	(Женев) Эх газрын далайн доорхи хэсгийн тухай Женевийн конвенци		
1958	(Женев) Задгай далайн загасчлал болон амьд нөөцийг хамгаалах тухай конвенци		
1958	(Женев) Эх газрын тэнгис болон эргийн бүсийн тухай конвенци		
1958	(Женев) Задгай далай тэнгисийн тухай конвенци	1976	Нэ
1960	(Женев) Ажилчдыг цацрагийн ионжилтоос хамгаалах тухай конвенци (Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 115 дугаар конвенци)		
1961	(Парис) Ургамлын шинэ төрөл зүйлийг хамгаалах тухай олон улсын конвенци		
1963	(Вена) Цөмийн аюулаас иргэдийг хамгаалах тухай конвенци		
	1997 (Вена) 1963 оны Цөмийн аюулаас иргэдийг хамгаалах тухай конвенцид нэмэлт оруулах тухай протокол		
1968	(Лондон, Москва, Вашингтон) Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай гэрээ	1969	Бж
1969	(Брюссель) Задгай далайд газрын тосны бохирдол үүссэн тохиолдолд хөндлөнгөөс оролцох тухай конвенц		
1971	(Рамсар) Олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газар, ялангуяа усны шувуу олноор амьдардаг орчны тухай конвенц	1997	Нэ
1971	(Женев) Бензиний аюул гамшгаас хамгаалах тухай конвенци (Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 136 дугаар конвенци)		
1971	(Брюссель) Газрын тосны бохирдлоос учирсан хохирлыг нөхөн төлөх олон улсын сан байгуулах тухай конвенци		
	1992 Сангийн протокол		
1971	(Лондон, Москва, Вашингтон) Тэнгис, далайн ёроол, түүний хөрсөн дор цөмийн болон үй олноор хөнөөх бусад зэвсэг байрлуулахыг хориглох тухай гэрээ	1971	Бж
1972	(Парис) Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенци	1990	Хү
1972	(Лондон) Далай тэнгисийг хог хаягдал болон бусад бодисоор бохирдуулахаас сэргийлэх тухай конвенци		
	1996 (Лондон) Протокол		
1972	(Лондон, Москва, Вашингтон) Бактериологийн (биологийн) болон хордуулагч зэвсэг боловсруулах, үйлдэвэрлэх, нөөцлөхийг хориглох, тэдгээрийг устгах тухай конвенци	1972	Бж
1972	(Лондон) Далайд хөлөг онгоц мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх олон улсын дүрмийн тухай конвенц	2002	Нэ
1972	(Женев) Чингэлгийн аюулгүй байдлын тухай олон улсын конвенци		
1973	(Вашингтон) Зэрлэг амьтдын ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци	1996	Нэ
	1979 (Бонн) Нэмэлт, өөрчлөлт	1996	Хү
	1983 (Габарон) Нэмэлт, өөрчлөлт		
1973	(Лондон) Далайг усан онгоцноос бохирдуулахаас сэргийлэх тухай конвенци		
	1978 (Лондон) Хавсралт 1. Газрын тосноос үүдсэн бохирдлоос сэргийлэх журам болон нэгдсэн тайлбар	2003	Нэ
	1978 (Лондон) Хавсралт 2. Шингэн хортой бодис бөөнөөр далайд асгаж, бохирдуулахаас хяналт тавих тухай дүрэм	2003	Нэ

Нэ – Нэгдэх; Мө – Мөрдөх; Ба – Батлах; Хү – Хүлээн авах; Та – татгалзах; Гү-гарын үсэг зурах; Бж -Батламжлах

Он		Монгол улс	
		Он	Төлөв
	1978 (Лондон) Хавсралт 3. Баглаа, боолттой хэлбэрээр тээвэрлэх хортой бодисоор бохирдуулахаас сэргийлэх тухай журам	2003	Хү
	1978 (Лондон) Хавсралт 3. Баглаа, боолттой хэлбэрээр тээвэрлэх хортой бодисоор бохирдуулахаас сэргийлэх тухай журам	2003	Хү
	1978 (Лондон) Хавсралт 4. Хөлөг онгоцноос гарсан бохир усаар бохирдуулахаас сэргийлэх тухай журам	2003	Хү
	1978 (Лондон) Хавсралт 5. Хөлөг онгоцноос гарсан хог, хаягдлаас үүдсэн бохирдлыг хянах тухай журам	2003	Бж
	1997 (Лондон) Хавсралт 5. Агаарыг хөлөг онгоцноос үүдэлтэй бохирдлоор бохирдуулахаас урьдчилан сэргийлэх тухай журам	2007	Нэ
1973	(Женев) Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай конвенци (Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 138 дугаар конвенци)	2002	Бж
1974	(Женев) Хорт хавдар үүсгэгч бодисоос үүсэлтэй ажлын байрны аюул гамшгийг хянах, сэргийлэх meha конвенци (Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 139 дугаар конвенци)		
1977	(Женев) Агаарын бохирдол, дуу чимээ ба чичирхийлэлтэй холбоотой ажлын байрны аюул гамшгийг хянах, сэргийлэх тухай конвенци (Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 148 дугаар конвенци)		
1979	(Бонн) Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц	1999	Бж
1980	(Нью-Йорк, Вена) Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц	1986	Бж
1981	(Женев) Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай конвенци (Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 155 дугаар конвенци)	1998	Бж
1982	(Монтего-Бей) Далайн эрх зүйн тухай конвенци	1996	Бж
	1994 (Нью-Йорк) Уг конвенцийн Хэсэг XI-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой хэлэлцээр	1996	Бж
	1995 (Нью-Йорк) Олноор сүрэглэсэн болон нүүдлийн загасны нөөцийг хамгаалах болон менежменттэй холбоотой 1982 оны 12 сарын 10-ны өдрийн Далайн тухай хуулийн тухай НҮБ-ын конвенцийн үүргийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр		
1985	(Женев) Ажлын байрны эрүүл мэндийн үйлчилгээний тухай конвенци (Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 161 дүгээр конвенци)		
1985	(Вен) Озоны үе давхаргыг хамгаалах тухай конвенци	1996	Нэ
	1987 (Монреал) Озоны үе давхаргыг устгадаг бодисын тухай Монреалийн протокол	1996	Нэ
	1990 (Лондон) Протоколын нэмэлт, өөрчлөлт	1996	Нэ
	1992 (Копенгаген) Протоколын нэмэлт, өөрчлөлт	1996	Нэ
	1997 (Монреал) Протоколын нэмэлт, өөрчлөлт	2002	Бж
	1999 (Бээжин) Протоколын нэмэлт, өөрчлөлт	2008	Бж
	2016 (Кигал) Протоколын нэмэлт, өөрчлөлт		
1986	(Женев) Шөрмөсөн чулуу (асбест)-ыг ашиглах үеийн аюулгүй байдлын тухай конвенци (Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 62 дугаар конвенци)		
1986	(Вена) Цөмийн ослын талаар шуурхай мэдээлэх тухай конвенци	1987	Бж
1986	(Вена) Цөмийн болон цацрагийн аюултай байдал бий болсон тохиолдолд тусламж үзүүлэх тухай конвенци	1987	Бж
1989	(Базел) Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай конвенци	1997	Нэ
	1995 Баны нэмэлт өөрчлөлт		
	1999 (BASEL) Хүлээн өвшөөрөх болон нөхөн төлбөр олгох тухай протокол		
1990	(Женев) Ажлын нөхцөлд химийн бодис ашиглах үеийн аюулгүй байдлын тухай конвенци (Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 170 дугаар конвенц)		
1990	(Лондон) Газрын тосны бохирдол, бэлэн байдлыг хангах болон хамтран ажиллах тухай конвенци		
1992	(Рио Де Жанеро) Биологийн олон янз байдлын тухай конвенц	1993	Бж

Нэ – Нэгдэх; Мө – Мөрдөх; Ба – Батлах; Хү – Хүлээн авах; Та – татгалзах; Гү-гарын үсэг зурах; Бж -Батламжлах

Он		Монгол ул	
		Он	Төлөв
	2000 (Монреал) Биоаюулгүй байдлын тухай Картагены протокол	2003	Нэ
	2010 (Нагоя) Генетикийн нөөцийг ашиглах, тэдгээрийг ашигласны үр шимийг шударгаар, тэгш хувиарлах тухай протокол	2013	Бж
	2010 (Нагоя – Куала Лумпур) Биоаюулгүй байдлын тухай Картагений протоколын Хариуцлага хүлээх болон нөхөн төлбөрийн тухай нэмэлт протокол	2013	Бж
1992	(Нью-Йорк) Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенци	1993	Бж
	1997 (Киото) Киотогийн протокол	1999	Нэ
	2012 (Доха) Киотогийн протоколын Дохагийн нэмэлт, өөрчлөлт		
	2015 (Парис) Парисын хэлэлцээр	2016	Бж
1993	(Ром) Задгай их далайд усан онгоцоор загасчлах явцад олон улсын хэмжээнд хамгаалах болон менежментийн арга хэмжээг мөрдөх явдлыг дэмжих хэлэлцээр		
1993	(Парис) Химийн зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөх болон хэрэглэхийг хориглох, түүнийг устгах тухай конвенци	1995	Бж
1994	(Лиссабон) Эрчим хүчний хуулийн хэлэлцээр	1999	Бж
	1994 (Лиссабон) Эрчим хүчний хэмнэлт болон холбогдох байгаль орчны асуудлын тухай протокол	1999	Бж
	1998 Эрчим хүчний хуулийн хэлэлцээрийн хүрээний худалдаатай холбоо бүхий үүргийн тухай нэмэлт өөрчлөлт	1999	Бж
1994	(Вена) Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенци		
1994	(Парис) Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын конвенци	1996	Бж
1995	(Женев) Уурхайн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай конвенци (Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 176 дугаар конвенци)	2015	Бж
1997	(Вена) Ашигласан түлшний болон цацраг идэвхит хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай конвенци		
1997	(Нью-Йорк) Олон улсын усны эх үүсвэрийг навигацгийн бус зорилгоор ашиглах хуулийн тухай конвенци		
1997	(Вена) Цөмийн аюулын хохиролыг нэмж барагдуулах тухай конвенци		
1998	(Роттердам) Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай конвенц	2001	Бж
1999	(Женев) Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай конвенци (Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенци)	2001	Бж
2001	(Стокгольм) Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай конвенц	2004	Бж
2001	(Лондон) Хөлөг онгоцны бункерийн тосны бохирдлоос учирсан хохирлын төлөө хүлээх иргэний хариуцлагын тухай олон улсын конвенци	2011	Ас
2003	(Женев) Дэлхийн эрүүл мэндийн байгууллага - Тамхины хяналтын суурь конвенци	2004	Ра
2004	(Лондон) Хөлөг онгоцны тэнцвэржүүлэгч ус болон хурдасын хяналт болон менежментийн тухай конвенци	2011	Ас
2013	(Кумамото) Мөнгөн усны тухай Минаматагийн конвенц	2015	Ра

Нэ – Нэгдэх; Мө – Мөрдөх; Ба – Батлах; Хү – Хүлээн авах; Та – татгалзах; Гү-гарын үсэг зурах; Бж -Батламжлах





*Хавсралт II****БАЙГАЛЬ ОРЧИНТОЙ ХОЛБООТОЙ ГОЛ  
ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ЖАГСААЛТ*****НЭГ.БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН СУУРЬ ХУУЛИУД БОЛОН БУСАД ХУУЛИУДЫН ЖАГСААЛТ**

Монгол Улсын үндсэн хууль	1992.01.13
Газрын хэвлийн тухай хууль	1988.11.29
Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль	1992.05.29
Монгол Улсын Засгийн газрын тухай хууль	1993.05.06
Улсын хилийг хамтран шалгахад баримтлах чиглэлийн тухай хууль	1993.07.09
Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль	1993.12.20
